


ЗАМ ТЭЭВЭР, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

# БАРУУН БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ

- БАРУУН БҮСИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ОДООГИЙН БАЙДАЛ
- БАРУУН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Улаанбаатар хот  
2009 он



ЗУРАГ ХАЙГУУЛЫН МЭРГЭЖЛИЙН  
БАЙГУУЛЛАГА “ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ”  
ХХК

Энхтайвны өргөн чөлөө 9 е/1  
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо  
Улаанбаатар-38/789, Монгол улс  
Утас: 976-11-322804, 99125974,  
99095839  
Факс: 976-11-70112804  
Веб: [www.geo-mongol.mn](http://www.geo-mongol.mn)  
E-mail: baruun\_bus@yahoo.com

© **GZB-08-01**

Баруун бүсийн хөгжлийн төслийн талаархи санал хүсэлтээ  
“Инженер Геодези” ХХК-ны хаягаар ирүүлнэ үү.

**ГАРЧИГ**

**ХЭСЭГ I . БАРУУН БҮС НУТГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ОДООГИЙН БАЙДАЛ**

|  |     |
|--|-----|
| Оршил  | 8   |
| Баруун бүс нутгийн ерөнхий мэдээлэл  | 10  |
| <b>Бүлэг 1. БАРУУН БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ, ЦАГ УУР, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ</b> |     |
| 1.1 Байгаль, цаг уурын нөхцөл  | 14  |
| 1.1.1 Газрын гадарга, нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөл                          | 14  |
| 1.1.2 Инженер геологийн нөхцөл   | 16  |
| 1.1.3 Уур амьсгал  | 19  |
| 1.1.4 Хөрс   | 24  |
| 1.1.5 Ургамал  | 30  |
| 1.1.6 Ан амьтан  | 33  |
| 1.2 Нийгэм, эдийн засгийн нөхцөл   | 35  |
| 1.2.1 Хүн ам, байршил, ястан үндэстний суурьшил                                  | 35  |
| 1.2.1.1 Баруун бүсийн хүн амын цэвэр өсөлт                                       | 37  |
| 1.2.1.2 Баруун бүсийн нас, хүйсийн бүтэц   | 38  |
| 1.2.1.3 Баруун бүс нутгийн хүн амын байршил                                      | 39  |
| 1.2.1.4 Баруун бүсийн хүн амын нягтшил   | 39  |
| 1.2.1.5 Баруун бүсийн хүн амын үндэстэн, ястны бүрэлдэхүүн                       | 40  |
| 1.2.1.6 Баруун бүсийн хүн амын шилжилт хөдөлгөөн                                 | 41  |
| 1.2.1.7 Хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдэл  | 42  |
| 1.2.2 Нийгэм, эдийн засгийн тулгуур нөхцөл                                       | 43  |
| 1.2.2.1 Нийгмийн тулгуур нөхцөл  | 43  |
| 1.2.2.2 Эдийн засгийн тулгуур нөхцөл   | 45  |
| 1.3 Нийгэм соёлын салбарын хөгжил  | 53  |
| 1.3.1 Боловсрол соёл, урлаг  | 53  |
| 1.3.2 Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал   | 56  |
| <b>Бүлэг 2. ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ХӨГЖИЛ</b>                                   |     |
| 2.1 Үйлдвэржилт  | 57  |
| 2.1.1 Уул уурхайн үйлдвэр  | 57  |
| 2.1.1.1 Баян-Өлгий аймаг   | 64  |
| 2.1.1.2 Ховд аймаг   | 69  |
| 2.1.1.3 Говь-Алтай аймаг   | 75  |
| 2.1.1.4 Завхан аймаг   | 79  |
| 2.1.1.5 Увс аймаг  | 83  |
| 2.1.2 Хөнгөн үйлдвэр   | 87  |
| 2.2 Хөдөө аж ахуй  | 101 |
| 2.2.1 Газар тариалан   | 101 |
| 2.2.2 Мал аж ахуй  | 107 |
| 2.2.2.1 Баян-Өлгий аймаг   | 115 |
| 2.2.2.2 Ховд аймаг   | 118 |
| 2.2.2.3 Увс аймаг  | 121 |
| 2.2.2.4 Завхан аймаг   | 123 |
| 2.2.2.5 Говь-Алтай   | 126 |
| <b>Бүлэг 3. ДЭД БҮТЭЦ, ХОТ СУУРИН</b>  |     |
| 3.1 Дэд бүтцийн хөгжил   | 129 |
| 3.1.1 Цахилгаан эрчим хүч  | 129 |
| 3.1.2 Холбоо мэдээллийн систем   | 138 |
| 3.1.2.1 Баян-Өлгий аймаг   | 138 |
| 3.1.2.2 Увс аймаг  | 139 |
| 3.1.2.3 Ховд аймаг   | 139 |
| 3.1.2.4 Завхан аймаг   | 140 |
| 3.1.2.5 Говь-Алтай аймаг   | 140 |
| 3.1.3 Ундны усны хангамж   | 142 |
| 3.1.3.1 Ус хэрэглээний одоогийн байдал, ашиглалт, хамгаалалт                     | 142 |
| 3.1.3.2 Хүн амын усан хангамжийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал          | 144 |
| 3.1.3.3. Ариун цэврийн байгууламжийн ашиглалтын байдал                           | 145 |
| 3.1.4 Цэвэрлэх байгууламж  | 149 |
| 3.1.4.1 Алтай хот  | 149 |
| 3.1.4.2 Улаангом хот   | 150 |
| 3.1.4.3 Улиастай хот   | 150 |
| 3.1.4.4 Ховд хот   | 151 |
| 3.1.4.5 Өлгий хот  | 151 |
| 3.2 Хот суурин газрын хөгжил   | 155 |

|         |   |     |
|---------|---|-----|
| 3.2.1   | Орон нутгийн хөгжлийн хот Өлгий                               | 155 |
| 3.2.1.1 | Үйлдвэр аж ахуй   | 157 |
| 3.2.1.2 | Хилийн боомтууд   | 158 |
| 3.2.1.3 | Хүн ам, хөдөлмөрийн нөөц                                      | 159 |
| 3.2.2   | Орон нутгийн хөгжлийн хот Алтай                               | 161 |
| 3.2.2.1 | Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарьлалт зохион байгуулалт | 161 |
| 3.2.2.2 | Үйлдвэрийн аж ахуй  | 163 |
| 3.2.2.3 | Хилийн боомт  | 164 |
| 3.2.2.4 | Хүн ам, хөдөлмөрийн нөөц                                      | 165 |
| 3.2.3   | Орон нутгийн хөгжлийн хот Улаангом                            | 166 |
| 3.2.3.1 | Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарьлалт зохион байгуулалт | 166 |
| 3.2.3.2 | Үйлдвэр аж ахуй   | 167 |
| 3.2.3.3 | Хилийн боомтууд   | 169 |
| 3.2.4.  | Баруун бүсийн тулгуур төв Улиастай                            | 170 |
| 3.2.4.1 | Хүн ам, хөдөлмөрийн нөөц                                      | 170 |
| 3.2.4.2 | Хилийн боомт  | 171 |
| 3.2.5   | Баруун бүсийн тулгуур төв Ховд                                | 172 |
| 3.2.5.1 | Хүн ам, хөдөлмөрийн нөөц                                      | 173 |
| 3.2.5.2 | Үйлдвэр аж ахуй   | 174 |
| 3.2.5.3 | Хилийн боомтууд   | 175 |

**Бүлэг 4. БАЙГАЛЬ ОРЧИН, ЭКОСИСТЕМИЙН НӨХЦӨЛ**

|       |   |     |
|-------|---|-----|
| 4.1   | Ойн сан бүхий газар   | 176 |
| 4.1.1 | Монгол орны ойн тархалт   | 176 |
| 4.1.2 | Завхан аймаг  | 177 |
| 4.1.3 | Увс аймаг   | 179 |
| 4.1.4 | Баян-Өлгий аймаг  | 179 |
| 4.1.5 | Ховд аймаг  | 179 |
| 4.1.6 | Говь-Алтай аймаг  | 180 |
| 4.1.7 | Ойн цэвэрлэгээ  | 181 |
| 4.2   | Усан сан бүхий газар  | 184 |
| 4.3   | Амралт, рашаан сувиллын газар                                     | 191 |
| 4.3.1 | Баруун бүсийн аялал жуулчлалын төлөв байдал                       | 191 |
| 4.3.2 | Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар төрөөс баримталж байгаа бодлого | 194 |
| 4.3.3 | Монголын аялал жуулчлалын хөгжлийн одоогийн төлөв байдал          | 195 |
| 4.3.4 | Агаарын тээвэр аялал жуулчлалд                                    | 197 |
| 4.4   | Байгаль орчны хамгаалал   | 201 |
| 4.4.1 | Ус, агаар мандлыг хамгаалах талаар                                | 201 |
| 4.4.2 | Хөрс хамгаалах талаар   | 204 |
| 4.4.3 | Ургамал, ан амьтныг хамгаалах талаар                              | 205 |
| 4.5   | Баруун бүс нутгийн экосистем                                      | 207 |
| 4.5.1 | Монголын баруун бүс нутгийн газарзүйн байршил ба хил зааг         | 208 |
| 4.5.2 | Алтай Соёны бүс нутагт хэрэгжсэн Цоохор ирвэс хамгаалах төсөл     | 214 |
|       | Дүгнэлт   | 215 |

**ХЭСЭГ II . БАРУУН БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ-ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ**

**Бүлэг 5. БАРУУН БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ-ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ**

|         |   |     |
|---------|---|-----|
|         | Оршил   | 217 |
| 5.1     | Баруун бүс нутгийн нийгэм-эдийн засгийн нөхцлийн ерөнхий үнэлгээ  | 218 |
| 5.1.1   | Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүтэц зохион байгуулалт          | 218 |
| 5.1.2   | Баруун бүс нутгийн хот суурины гүйцэтгэх үүрэг                    | 219 |
| 5.1.3   | Нийгэм эдийн засгийн хөгжлийн түвшин                              | 220 |
| 5.1.4   | Баруун бүс нутгийн дэд бүтцийн сүлжээний хөгжил                   | 221 |
| 5.1.5   | Хүн ам, хөдөлмөрийн нөөц  | 223 |
| 5.1.6   | Хөдөө аж ахуй, хүнсний хангамж                                    | 223 |
| 5.1.7   | Аж үйлдвэр, барилга   | 225 |
| 5.1.8   | Нийгмийн дэд бүтэц  | 225 |
| 5.2.    | Баруун бүс нутгийн байгаль-экологийн хүчин зүйлсийн үнэлгээ       | 227 |
| 5.2.1   | Цэвдэг хөрсний тархалт  | 229 |
| 5.2.2   | Элсний нүүлтэд өртөж байгаа газар нутаг                           | 230 |
| 5.3.    | Баруун бүсийн нутаг дэвсгэрийн экологи-хот байгуулалтын үнэлгээ   | 232 |
| 5.3.1   | Баруун бүс нутгийн экологи-хот байгуулалтын ерөнхий үнэлгээ       | 232 |
| 5.3.1.2 | Баруун бүс нутагт барилга байгууламж барих уур амьсгалын мужлалт  | 232 |
| 5.3.1.1 | Бүс нутгийн хот, суурингууд далайн түвшнээс дээш өргөгдсөн байдал | 234 |

|         |   |     |
|---------|---|-----|
| 5.3.1.3 | Бүс нутгийн хот суурингуудын эдэлбэр газрын налуу /хэвгий/                          | 234 |
| 5.3.1.4 | Бүс нутгийн хот суурингуудын үер, ус, салхи шуурга элсний нөлөөнд автах байдал      | 234 |
| 5.3.1.5 | Бүс нутгийн хот суурингуудын хөрсний усны түвшин олон жилийн цэвдэг хөрсний тархалт | 238 |
| 5.3.1.6 | Бүс нутгийн ул хөрсний төрөл  | 238 |
| 5.3.1.7 | Бүс нутгийн газар чичирхийллийн төлөв байдал  | 239 |
| 5.3.2   | Бүсийн нутгийн хотуудын экологи хот байгуулалтын үнэлгээ                            | 241 |
| 5.3.2.1 | Баруун бүсийн тулгуур төв Ховд хотын хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ              | 242 |
| 5.3.2.2 | Баруун бүсийн тулгуур төв Улиастай хотын хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ          | 243 |
| 5.3.2.3 | Баруун бүсийн хөгжлийн төв Алтай хотын хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ            | 244 |
| 5.3.2.4 | Баруун бүсийн хөгжлийн төв Улаангом хотын хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ         | 244 |
| 5.3.2.5 | Баруун бүсийн хөгжлийн төв Өлгий хотын хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ            | 245 |
|         | Дүгнэлт   | 247 |

**ХЭСЭГ III . БАРУУН БҮС НУТГИЙН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВЛӨЛТ**

|           |  |     |
|-----------|--|-----|
|           | Оршил  | 249 |
|           | <b>Бүлэг 6. БАРУУН БҮС НУТГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВЛӨЛТ</b>             | 250 |
| 6.1       | Бүсийн тогтолцоо, улс, бүсийн дэд бүтцийн төлөвлөлт                            | 250 |
| 6.1.1.    | Бүс нутгийн тогтолцоо, хөрш орнуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэх ирээдүй       | 250 |
| 6.1.2.    | Улс хоорондын дэд бүтцийн сүлжээ, худалдааны хөгжил                            | 252 |
| 6.1.2.1   | Гадаад худалдааны хөгжлийн төлөв   | 260 |
| 6.1.3.    | Хил, гаалийн үйл ажиллагаа, чөлөөт бүсийн хөгжил                               | 263 |
| 6.1.3.1   | Гаалийн үйл ажиллагааны чиглэл   | 267 |
| 6.1.3.2   | Чөлөөт бүсийн хөгжлийн төлөв   | 269 |
| 6.1.3.3   | Гадаад харилцаа, бүс нутгийн зөвлөл  | 271 |
| 6.1.4     | Дэд бүтцийн сүлжээний төлөвлөлт  | 274 |
| 6.1.4.1   | Цахилгаан эрчим хүч  | 276 |
| 6.1.4.2   | Холбоо мэдээллийн систем, төлөвлөлт  | 276 |
| 6.1.4.3   | Унд ахуйн усан хангамж   | 280 |
| 6.1.4.4   | Түлш дулааны хангамж   | 291 |
| 6.1.4.5   | Авто болон төмөр зам, агаарын замын сүлжээ                                     | 296 |
| 6.1.4.5.1 | Авто замын төлөвлөлт   | 296 |
| 6.1.4.5.2 | Төмөр замын төлөвлөлт  | 304 |
| 6.1.4.5.3 | Агаарын замын төлөвлөлт  | 315 |
|           | <b>Бүлэг 7. БҮС НУТГИЙН ЭРЧИМТЭЙ ТАТАЛЦАЛ. НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ТӨЛӨВЛӨЛТ</b>     | 317 |
| 7.1       | Бүс нутгийн нутагшилтын тогтолцоо  | 317 |
| 7.1.1     | Баруун бүс нутгийн хот суурин газрын төлөвлөгөө                                | 317 |
| 7.1.1.1   | Бүсийн хөгжлийн тулгуур төв Ховд хот   | 321 |
| 7.1.1.2   | Орон нутгийн хөгжлийн хот Өлгий  | 326 |
| 7.1.1.3   | Бүсийн хөгжлийн тулгуур төв Улаангом хот                                       | 330 |
| 7.1.1.4   | Бүсийн хөгжлийн тулгуур төв Улиастай хот                                       | 334 |
| 7.1.1.5   | Орон нутгийн хөгжлийн хот Алтай  | 338 |
| 7.1.1.6   | Сутай хотыг байгуулах санал  | 344 |
| 7.1.2     | Хүн амын суурьшлын төвлөрөл  | 351 |
| 7.1.2.1   | Нийгэм эдийн засгийн тулгуур нөхцөл  | 351 |
| 7.1.2.2   | Хүн амын прогноз   | 354 |
|           | <b>Бүлэг 8. ҮЙЛДВЭР ХӨДӨӨ АЖ АХУЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨЛТ</b>                     | 362 |
| 8.1       | Геологийн эрэл хайгуулын төлөвлөлт   | 366 |
| 8.1.1     | Баруун бүс нутгийн зэсийн бүлэг орд илрэлүүдийн эрэл хайгуулын төлөвлөлт       | 366 |
| 8.1.2     | Баруун бүс нутгийн нүүрсний орд, илрэлүүдийн нарийвчилсан нөөцийн эрэл хайгуул | 367 |
| 8.2       | Уул уурхайн хөгжлийн төлөвлөлт   | 372 |
| 8.3       | Барилга, барилгын материалын төлөвлөлт   | 377 |
| 8.4       | Хөнгөн үйлдвэрийн хөгжлийн төлөвлөлт   | 383 |
| 8.5       | Хөдөө аж ахуйн хөгжлийн төлөвлөлт  | 388 |
| 8.5.1     | Газар тариалангийн хөгжлийн төлөвлөлт  | 388 |
| 8.5.2     | Мал аж ахуйн хөгжлийн төлөвлөлт  | 392 |
| 8.5.2.1   | Мал сүргийн тоо толгойн өсөлтийн прогноз                                       | 401 |

|  |     |
|--|-----|
| 8.6 Баруун бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэл боломжууд  | 423 |
| <b>Бүлэг 9. ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ</b>   | 426 |
| 9.1 Бүс нутгийн нутагшилтын түүхэн хөгжил  | 426 |
| 9.2 Бүс нутгийн аймгийн нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын төлөвлөлт   | 432 |
| 9.2.1 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг шинэчлэх байгаль, нийгэм эдийн засгийн хүчин зүйл                   | 432 |
| 9.2.2 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь эдийн засгийн бүсэд хуваагдсан байдал   | 434 |
| 9.2.3 Баруун бүс нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчилсэн хуваарь нь монгол улсын хөгжлийн стратегитэй холбогдох нь | 439 |
| 9.3 Бүс нутгийн сумын нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын төлөвлөлт   | 441 |
| 9.3.1 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн өөрчлөлтийг зөв хэрэгжүүлэх талаар  | 442 |
| 9.3.2 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг өөрчилснөөр гарах үр дүн  | 443 |
| 9.4 Засаг захиргаа удирдлагын бүтэц зохион байгуулалт  | 444 |
| <b>Бүлэг 10. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ ТҮҮНИЙ ТӨЛӨВЛӨЛТ</b>  | 445 |
| 10.1 Хөрс, ус, ан амьтныг хамгаалах төлөвлөлт  | 445 |
| 10.1.1 Хөрс хамгаалах талаар   | 445 |
| 10.1.2 Усны нөөц хамгаалах талаар  | 447 |
| 10.1.3 Ан амьтныг хамгаалах талаар   | 451 |
| 10.2 Агаар мандал, ургамлан нөмрөгийг хамгаалах төлөвлөлт  | 452 |
| 10.2.1 Агаар мандлыг хамгаалах   | 452 |
| 10.2.2 Ургамлан нөмрөгийг хамгаалах талаар   | 452 |
| 10.2.2.1 Ойн зурвас байгуулах талаар   | 454 |
| <b>ХЭСЭГ IV . БАРУУН БҮС НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ</b>  |     |
| Оршил  | 462 |
| <b>Бүлэг 11. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ</b>   | 462 |
| 11.1 Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох  | 462 |
| 11.2 Нийгмийн тогтвортой хөгжүүлэх төлөвлөлт эдийн засгийн тооцоо  | 466 |
| 11.2.1 Баруун бүсийн эдийн засгийн макро түвшний шинжилгээ ( <i>эхний хувилбар</i> )   | 466 |
| 11.2.2 Дотоодын нийт бүтээгдэхүүний прогноз  | 475 |
| 11.2.3 Баруун бүсийн эдийн засгийн макро түвшний шинжилгээ ( <i>шинэчилсэн хувилбар</i> )                                      | 480 |
| 11.3 Баруун бүс нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт   | 519 |
| Дүгнэлт  | 520 |
| Ашигласан материал   | 523 |
| Зохиогчдын бүрэлдэхүүн   | 528 |
| Баруун бүсээс санал өгч оролцсон хүмүүс  | 529 |

ХЭСЭГ I

БАРУУН БҮСИЙН НИЙГЭМ  
ЭДИЙН ЗАСГИЙН ОДООГИЙН БАЙДАЛ

## ОРШИЛ

“Баруун бүсийн хөгжлийн төсөл”-ийн одоогийн байдлын судалгааны материалуудыг баруун бүсийн 5 аймаг, 92 сум, 461 багийг багтаасан 415.3 мян.кв.км нутаг дэвсгэрийн нийгэм эдийн засгийн суурь судалгаа, статистик динамик төлөвлөлт хийхэд зориулан цуглуулсан мэдээллүүдийн эмхэтгэлийг ашиглан гүйцэтгэв. Баруун бүсийн хөгжлийн төслийн одоогийн байдлын судалгаанд 2007 оны жилийн эцсийн тоон ба зурган мэдээллүүд хамаарагдсан болно.

Монгол улс 4 бүсээр хөгжих үзэл баримтлалын дагуу бүсчилсэн хөгжлийн удирдлага бүтэц зохион байгуулалтын хүрээнд баруун бүсийн зөвлөл үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол улсын засгийн газрын 2005 оны 202-р тогтоолоор баруун бүсийн хөгжлийн хөтөлбөрийг баталсан байна.

**Бүсчилсэн хөгжлийн үндэсний хороо нь** Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагааг зохицуулах, бүсчилсэн хөгжлийн талаарх Засгийн газрын ерөнхий стратегийг тодорхойлох чиг үүрэгтэй бөгөөд Ерөнхий сайдын дэргэд ажиллана.

**Үндэсний хорооны дарга нь** Ерөнхий сайд орлогч дарга нь бүс нутгийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн байх бөгөөд хорооны бүрэлдэхүүнд Засгийн газрын хэрэг эрхлэх дарга, Байгаль орчин, Зам тээвэр, аялал жуулчлал, Барилга хот байгуулалт, Түлш эрчим хүч, Хүнс хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд, бусад яамдын төрийн нарийн бичгийн дарга, бүсийн зөвлөлийн дарга орно. Үндэсний хороо нь ажлын албатай байх бөгөөд энэ үүргийг Шадар сайдын ажлын алба хэрэгжүүлнэ.

**Бүсийн зөвлөл нь** Бүс нутгийн хөгжлийн талаарх төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бүсийн нийгэм эдийн засгийн асуудлыг зохицуулах чиг үүрэг бүхий байгууллага юм. Бүсийн зөвлөлийн бүрэлдэхүүнд Зөвлөлийн дарга тухайн бүсэд багтаж буй аймгийн засаг дарга, бүсийн тулгуур төв хотын захирагч нарыг болон аймгийн ИТХ, төрийн бус байгууллага, томоохон хөрөнгө оруулагч байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөллийг оруулж байгуулна.

Зөвлөлийн даргын бүрэн эрхийг тухайн бүсэд багтах аймгийн засаг дарга нарыг Монгол улсын Ерөнхий сайдын томилсон Засаг дарга нар хэрэгжүүлнэ. Зөвлөлийн даргын саналыг үндэслэн зөвлөлийн бүрэлдэхүүнд орох гишүүдийг ерөнхий сайд батална.

**Бүсийн зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлж байна.**

- Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүсийн хэмжээнд зохион байгуулж, үр дүнг жил бүр Үндэсний хороонд тайлагнах.
- Бүс нутгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тухайн бүсийг хөгжүүлэх зорилт арга хэмжээг тодорхойлж эдийн засаг нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, дунд хугацааны хөтөлбөрт тусгуулах арга хэмжээ авах
- Тухайн бүсийн хэмжээнд төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн ажлыг нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах
- Тухайн бүсийн хөгжлийн асуудлаар холбогдох төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах
- Бүс нутгийн хөгжлийн асуудлаар нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, иргэн хуулийн этгээдээс тавьсан санал хүсэлтийг судалж холбогдох арга хэмжээг авах.
- Тухайн бүсийн хэмжээнд бүс нутгийн хөгжлийн асуудлаар бүсчилсэн зөвлөгөөн, уулзалт, үзүүлэх сургалт зохион байгуулах
- Тухайн бүсийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх талаар иргэн аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллагаас тавьж буй, санаачлагыг дэмжин зохион байгуулалтын удирдлагаар хангах
- Бүс нутгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас боловсруулсан аргачлал зааврийн дагуу бүсийн хөгжлийн талаарх судалгаа, мэдээллийг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх
- Бүсийн тэжээл тариалах, хадлан хадах болон бэлчээр нутгийг тодорхойлох, байгалийн гамшгаас мал сүргийг урьдчилан сэргийлэх, хамгаалах, бүс нутгийн сүлжээ бүрдүүлэх
- Бүсийн онцлогтой холбогдсон эдийн засгийн бодлогын асуудлаар саналаа Засгийн газарт тавих
- Бүсийн дэд бүтцийг байгуулах, ашиглах асуудлыг хэрэгжүүлэх

**Аймгийн ИТХ нь бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**



- Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан нутаг дэвсгэрийн эдийн засгийн, нийгмийн хөгжлийн байдал, хэтийн төлөвийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх
- Бүс нутгийн хөгжлийн асуудлаар Засаг даргын тайланг хэлэлцэх
- Бүсийн хөгжлийн нийтлэг асуудлааруусад аймгийн ИТХ-тай хамтран ажиллах
- Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд иргэн аж ахуй нэгж байгууллагын хамтын оролцоог дэмжин чиглүүлэх
- Хууль тогтоомжид заасан бусад эрхийг хэрэгжүүлэх

**Аймгийн Засаг дарга бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ**

- Тухайн бүс нутгийн хөгжлийн асуудлаар Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, түүний үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлэх
- Бүс нутгийн хөгжилд улсын төсвөөс оруулж буй хөрөнгө оруулт болон санхүүгийн бусад дэмжлэгийг зориулалтынх нь дагуу үр ашигтай ашиглах
- Бүс нутгийн хөгжлийн талаар хийж буй ажлын үр дүнг бүсийн зөвлөлд тайлагнах
- Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ

Баруун бүсийн зөвлөлийн төв нь Ховд хотод төвлөрч Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Говь-Алтай аймгийн ИТХ, засаг даргын тамгын газартай хамтарч үйл ажиллагаагаа явуулж байна.

Баруун бүсийн зөвлөл бусад бүсүүдтэй харьцуулахад удирдлага зохион байгуулалтын хувьд өндөр түвшинд ажиллаж, Баруун бүсийн хөгжил, нэг суурин- нэг бүтээгдэхүүн номыг 2007 онд гаргасан.

МУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газраас 2008.06.20-нд “Баруун бүсийн ХАА-н түүхий эдэд суурилсан жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх нь” сэдэвт баруун бүсийн IV зөвлөгөөнийг зохион байгуулж Ерөнхийлөгч, Яам, агентлаг аймгуудын удирдлага, иргэд аж ахуй нэгжүүдийг хамарсан өргөн хүрээтэй арга хэмжээ боллоо. Барилга хот байгуулалтын яамны хот байгуулалтын бодлого зохицуулалтын газраас бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх үүднээс нарийвчилсан зураг, эдийн засгийн тооцоо судалгаанд тулгуурлан Монгол улсын хөгжлийн үзэл баримтлалын нэгээхэн хэсгийг хэрэгжүүлэх шаардлагын хүрээнд “Баруун бүсийн хөгжлийн төсөл”-ийг хийж байна.

Баруун бүс нутгийн байгаль, цаг уур, нийгэм, эдийн засгийн нөхцөл, үйлвэр, хөдөө аж ахуйн хөгжил, дэд бүтэц, хот суурины хөгжил, байгаль орчин, экосистемийн нөхцлүүдийг судлахын зэрэгцээ инженерийн дэд бүтэц, нийгмийн дэд бүтцийн судалгаа, геологи хайгуулын хөгжлийн ирээдүй, статистик динамик түвшний үзүүлэлтүүдийг илүү их анхаарч судлав.

Бүс нутгийн үйл ажиллагааны талаар холбогдох материал судалгаа гаргаж ирүүлсэн баруун бүсийн зөвлөл, аймаг орон нутгийн удирдлага, яам газрууд хамтран ажилласан бүхэнд талархал илэрхийлье.

Баруун бүс нутгийн хөгжлийн төслийг хэрэгжүүлж, монгол улсаа хөгжүүлцгээе.

*Баруун бүсийн хөгжлийн төсөлтэй холбоотой санал хүсэлтээ:*

*E-mail: [baruun\\_bus@yahoo.com](mailto:baruun_bus@yahoo.com)*

*Fax: 976-70112804*

*Утас: 976-99125974*

*[www.geo-mongol.mn](http://www.geo-mongol.mn) хаягуудаар ирүүлнэ үү?*

*Хамтран ажилласан та бүгдэд баярлалаа.*

**БАРУУН БҮСИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

**Баруун бүс дэх томоохон уулс / Хүснэгт 1 /**

| Газарзүйн муж ба нэр | Geographical region and name | Өндөр, м<br>height, m |
|----------------------|------------------------------|-----------------------|
| Монгол алтайн нуруу  | Range of Mongolian Altai     |                       |
| Хүйтэн               | Khuiten                      | 4374                  |
| Цамбагарав           | Tsambagarav                  | 4195                  |
| Мөнххайрхан          | Munkhkhairkhan               | 4204                  |
| Сутай                | Sutai                        | 4090                  |
| Хархираа             | Kharkhiraa                   | 4037                  |
| Түргэн               | Tyrgen                       | 3965                  |
| Говь-Алтайн нуруу    | Range of Govi Altai          |                       |
| Их богд              | Ikh bogd                     | 3957                  |
| Аж богд              | Ajbogd                       | 3802                  |
| Хангайн нуруу        | Range of Khangai             |                       |
| Отгонтэнгэр          | Otgontenger                  | 4021                  |
| Соёны нуруу          | Range of Soyon               |                       |
| Мөнхсарьдаг          | Munkhsaridag                 | 3491                  |

**Баруун бүс дэх томоохон гол / Хүснэгт 2 /**

| Нэр    | Name    | Урт, км<br>Length of trunk river, km |
|--------|---------|--------------------------------------|
| Завхан | Zavkhan | 808                                  |
| Ховд   | Khovd   | 593                                  |
| Тэс    | Tes     | 568                                  |
| Идэр   | Ider    | 452                                  |

**Баруун бүс дэх томоохон нуур / Хүснэгт 3 /**

| Нэр    | Name     | Талбай, км <sup>2</sup><br>Area, km <sup>2</sup> |
|--------|----------|--|
| Увс    | Uvs      | 3350   |
| Хар ус | Khar us  | 1852   |
| Хяргас | Khyargas | 1407   |
| Хар    | Khar     | 575  |

**Баруун бүсийн хамгийн өндөр, хамгийн бага үзүүлэлтүүд**

Хүн амын нягтрал нь нэг кв.км-т Говь-Алтай аймаг 0.4 хүн ноогддог бол 1000 хүнд ноогдох төрөлтөөрөө Увс аймаг 8.9 хүн, Баян-Өлгий 8.7 хүн төрж байгаа нь өндөр үзүүлэлт юм.

Харин 1000 хүнд ноогдох нас баралт нь Ховд, Баян-Өлгий, Завхан аймгууд 1.2-1.6 хүн байгаа нь улсын дунджаас хамгийн бага бөгөөд сайн үзүүлэлт юм.

Хөдөлмөрийн насны 1000 хүнд ноогдох ажилгүйчүүдийн тоо нь Завханд 334.0 хүн байгаа нь улсын дунджаас 1.7 хувиар дээгүүр байна.


Мөн 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөлт нь Ховд, Баян-Өлгийд 17-20 хүн байгаа нь улсын хэмжээнд хамгийн бага үзүүлэлт болж байна.

Харин төрсөн эхийн эндэгдэл Ховдод хамгийн их, Баян-Өлгийд хамгийн бага байна. Увс аймагт орон нутгийн төсвийн зарлага 161.1 хувь байгаа нь хамгийн их үзүүлэлт болж байна

**Засаг захиргааны нэгж ба нутаг дэвсгэрийн хэмжээ, хоорондын зай / Хүснэгт 4 /**

| Аймаг                       | Аймгийн төв | Засаг захиргааны нэгжийн тоо |             | Нутаг дэвсгэрийн хэмжээ мян.кв.км | Аймгийн төв хоорондын замын урт /км/-ээр |             |             |             |             |
|-----------------------------|-------------|------------------------------|-------------|-----------------------------------|--|-------------|-------------|-------------|-------------|
|                             |             | Сум                          | Баг         |                                   | Өлгий                                    | Алтай       | Улиастай    | Улаангом    | Ховд        |
| Баян-Өлгий                  | Өлгий       | 14                           | 84          | 45.7                              | Х  | 672         | 725         | 291         | 222         |
| Говь-Алтай                  | Алтай       | 18                           | 83          | 141.4                             | 672                                      | Х           | 195         | 693         | 450         |
| Завхан                      | Улиастай    | 24                           | 113         | 82.5                              | 725                                      | 195         | Х           | 529         | 503         |
| Увс                         | Улаангом    | 19                           | 92          | 69.6                              | 291                                      | 693         | 529         | Х           | 243         |
| Ховд                        | Ховд        | 17                           | 91          | 76.1                              | 222                                      | 450         | 503         | 243         | Х           |
| Бүсийн дүн                  |             | <b>92</b>                    | <b>463</b>  | <b>415.3</b>                      | <b>1910</b>                              | <b>2010</b> | <b>1952</b> | <b>1752</b> | <b>1418</b> |
| <b>Улсын нийт дүн</b>       |             | <b>331</b>                   | <b>1543</b> | <b>1564.1</b>                     | -  | -           | -           | -           | -           |
| <b>Нийт дүнд эзлэх хувь</b> |             | <b>27.8</b>                  | <b>29.9</b> | <b>26.6</b>                       | -  | -           | -           | -           | -           |

Бүсийн аймгуудын Улаанбаатараас алслагдсан байдал /км/ / График 1 /



**Баруун бүсийн бусад үзүүлэлтүүд /Статистикийн эмхэтгэл, 2007 оны байдлаар/**

- Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн дөрөвний нэг гаруй буюу 26.6 хувийг
- Монгол улсын бүх нуур тойрмын талбайн 59 хувийг
- Монгол орны гол мөрний усны нийт талбайн 49 хувийг
- Монгол орны мөнх цас, мөсөн голын талбайн 100 хувийг
- Монгол орны усны нөөцийн 29 хувийг
- Монгол орны ойн (заг) сангийн газрын 21 хувийг
- Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн 45.8 хувийг тус тус эзэлнэ.
- Баруун бүс нь ашигт малтмалын 300 гаруй орд, илрэлтэй.
- Монгол улсын улаан номонд орсон 60 гаруй зүйл амьтан, олон зүйлийн ургамалтай.
- Баруун бүс нутагт 18 ястан, үндэстэн оршин амьдардаг.
- Монгол улсын нийт хүн амын 16 хувь нь оршин суудаг.
- Баруун бүсийн малын тоо нь улсын нийт малын тоотой харьцуулахад
  - Нийт малын 31.4 хувийг
  - Нийт мах бэлтгэлийн 23.3 хувийг
  - Тэмээний ноосны 27.7 хувийг
  - Хонины ноосны 30.6 хувийг
  - Ямааны ноолуурын 35.1 хувийг
  - Бодын ширийн 21 хувийг
  - Богийн арьсны 35.7 хувийг бэлтгэж гадаадад гаргаж байна.
- Баруун бүсийн дэд бүтцийг хөгжүүлэхэд улсын сангаас 60 орчим тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.
- Баруун бүст 2007 онд 2200 км цахилгаан дамжуулах агаарын шугам барьсан байна.

- Баруун бүсийн зам гүүр барих ажилд 2006-2008 онд 21.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна .
- Баруун бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүн 260 гаруй тэр бум төгрөгөөр тооцогдож байна.
- Баруун бүсийн нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 830.4 мянган төгрөг байна.
- Баруун бүст нутагт 12.3 сая толгой мал тоологдсон байна.
- Баруун бүст төмс хүнсний ногоо дунджаар 2842.9га-д тариалт хийсэн байна
- Баруун бүст үйл ажиллагаараа “Увс хүнс” ХХК, “Тэсийн гол” ХХК, “Баялаг групп” ХХК, “Аватекс Кайнар” ХХК , “Ганбарс” ХХК, “Тулга-Алтай” ХК , “Энтүм” ХХК, “Баруун Монгол интернейшнл” ХХК, “Нью прогресс” групп зэрэг аж ахуй нэгжүүд толгойлж байна.

**Баруун бүс дэх улсын тусгай хамгаалалттай газрууд / Хүснэгт 5 /**

| №                                 | УТХГН-ийн ангилал, нэр | УТХГН-ийн талбай (га) | Хамгаалалтанд авсан он |
|-----------------------------------|------------------------|-----------------------|------------------------|
| <b>Дархан цаазат газар</b>        |                        |                       |                        |
| 1                                 | Говийн их дархан газар | 5311730               | 1975                   |
| 2                                 | Хөх сэрхийн нуруу      | 65920                 | 1977                   |
| 3                                 | Хасагт хайрхан         | 27448                 | 1965                   |
| 4                                 | Алтан элс              |                       |                        |
| 5                                 | Отгон тэнгэр           | 95510                 | 1992                   |
| 6                                 | Увс нуурын ай сав      | 712545                | 1993                   |
| <b>Байгалийн цогцолборт газар</b> |                        |                       |                        |
| 1                                 | Алтай таван богд       | 636161                | 1996                   |
| 2                                 | Хангайн нуруу          | 888455                | 1996                   |
| 3                                 | Хар ус нуур            | 850272                | 1997                   |
| 4                                 | Ханхөхий-Хяргас нуур   | 553350                | 2000                   |
| 5                                 | Цамбагарав уул         | 110960                | 2000                   |
| <b>Байгалийн нөөц газар</b>       |                        |                       |                        |
| 1                                 | Шарга-Манхан           | 390071                | 1993                   |
| 2                                 | Алагхайрхан уул        | 36400                 | 1996                   |
| 3                                 | Бурхан буудай уул      | 52110                 | 1996                   |
| <b>Дурсгалт газар</b>             |                        |                       |                        |
| 1                                 | Ээж хайрхан уул        | 22475                 | 1995                   |

**БАРУУН БҮСИЙН АЙМГУУДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**  
**Баян-Өлгий аймаг**

Баян-Өлгий аймаг нь 1940 онд байгуулагдсан дэлхийн цагийн 6-р бүсэд багтдаг бөгөөд дэлхийн бөмбөрцгийн 48 ба 50 градус уртраг, 88 ба 92 градус өргөрөгт багтдаг.

Монгол улсын баруун хязгаарын Алтайн нурууны хамгийн уулархаг бүсэд оршдог. 45805 орчим хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй. Аймаг 95 мянган хүн амтай. Нийт хүн амын 92% нь казакууд ба үлдсэн нь урианхай, дөрвөд, тува ястнууд эзэлдэг. Улаанбаатар хотоос 1760 км алслагдсан ч хойд талаараа орос улсын алтай хязгаарын Хош-Агач мужтай, урьд талаараа БНХАУ-ын ШУӨЗО-ны Алтай аймагтай газар нутгийн хувьд хиллэсэн нь гадаад зах зээлд ойрхон хил орчмын худалдаа, үйлдвэрлэл хөгжүүлэх боломжтой юм. Өлгий хотод 29 мянга орчим, хөдөө сумдад 2.8-8.7 мянга орчим хүн ам оршин суудаг. Тус аймаг 13 сум, 84 баг, 1 тосгоноос бүрдсэн засаг захиргааны нэгжтэй. Алтай Таван Богд, Цамбагарав, Мөнххайрхан, Цаст, Тахилт зэрэг сүрлэг өндөр уултай, Потанины, Александр, Гранегийн мөсөн гол, Асгатын мөнгө, Ховд гол, Улаан уул, Усай, Нуурын голын гянт болд, Хөх адыр, Дулаан харын зэс холимог металл, Хотгорын нүүрсний уурхай болон байгалийн бусад баялаг үзэсгэлэнт төгөлдөр тогтоц бүхий газрууд олон байгаа нь нутгийн брэнд, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, шилдэг үйлчилгээ аялал жуулчлал хөгжүүлэх боломж бүрдсэн гэж үздэг.

**Говь-Алтай аймаг**

Говь-Алтай аймаг нь 142.2 мянган хавтгай дөрвөлжин километр газар нутагтай. Газарзүйн байршлын хувьд Алтайн уулархаг мужид багтдаг.

Мөнх цаст Сутай /4226м/, Алаг хайрхан, Бага хайрхан, Хасагт хайрхан, Бурхан буудай зэрэг өндөр уулс, Хар азарга, Дарви, Хантайшир, Ажбогд, Таян, Эдрэн, Хөвчийн нуруунууд, Шарга, Хүйс, Хонин

ус, Цэнхэр номин, Захуй, Зармангийн говиуд, Бигэр, Халиун, Улаан шал, Төхөм зэрэг өргөн уудам хоолойнуудтай.

Байгаль цаг уурын хувьд эрс тэс уур амьсгалтай. Тус аймаг нь байгалийн үзэсгэлэнт газруудаар элбэг бөгөөд шар алт, цагаан алт, мөнгө, зэс, хөнгөн цагаан, хар төмөрлөг, цайр, хар тугалга, никель, кобальт, цементийн түүхий эд /гипс, гөлтгөнө, шохойн чулуу/, чулуун нүүрс, өнгөлгөөний чулуу, эрдэнийн чулуу /анар, мана, усан болор, пийцүү, хаш, оюу/ мөн төрөл бүрийн металл бус магнезит, асбест, цэрд зэрэг ашигт малтмалууд болон нөөц нь тогтоогдоогүй ашигт малтмалын ордууд ихтэй.

Говь-Алтай аймгийн засаг захиргааны нэгж нь 18 сумтай, 2007 оны байдлаар 60.2 мянган хүн амтай. Аймгийн төв Алтай хотод 20.1 мянган хүн амьдардаг.

Аймгийн хэмжээнд нийтдээ 10800 өрхтэй, хөдөлмөрийн насны 39.6 мянган хүн байгаагийн 30.8 мянга нь эдийн засгийн идэвхитэй хүн ам байна.

### Завхан аймаг

Завхан аймаг нь байгалийн бүх бүс бүслүүрийг хамарсан 82.4 мянган хавтгай дөрвөлжин нутагтай, хангай, говь, хээр тал хосолсон байгалийн өвөрмөц газрууд, түүх соёлын дурсгал, өв уламжлал олонтой.

Аймгийн нутгийн зохилох хэсэгт Хангайн нуруу ноёлох ба салбар уулс үргэлжилж, түүний ноён оргил Отгонтэнгэр уул далайн түвшинээс дээш 4031м-т өргөгдсөн байдаг.

Өндөр уулсаас эх авсан түргэн урсгалт Буянт, Идэр, Ширээ, Завхан зэрэг 189 гол горхитой, 40 гаруй, халуун, хүйтэн рашаантай, Баяннуур, Хар нуур, Бүст, Ойгон, Тэлмэн зэрэг 91 нууртай, вансэмбрүү, алтан гагнуур бэрээмэг, хонин арц зэрэг эмийн болон нэн ховор ургамалтай, буга, аргал, янгир, хүдэр, шилүүс зэрэг ховор ан амьтадтай.

Байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газрууд, арвин уст гол нуур, ховор рашаан ус, ойн нөөцийг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлж, амралт, сувилал, жуулчны баазуудыг байгуулах нь аймгийн өөрийгөө тэтгэн хөгжүүлэх чадавхийг сайжруулахад чухал юм.

81.1 гаруй мянган хүн амтай, засаг захиргааны 24 сум, 113 багтай, хойд талаараа ОХУ-тай хиллэн, Ховд, Увс, Баян-Өлгий аймгуудаас 540-850км-ын зайд буюу баруун бүсийн төв хэсэгт, Хангайн уулархаг нутаг, Их нууруудын хотгорын хооронд оршдог.

### Увс аймаг

Увс аймаг нь Монгол улсын баруун хязгаарт их нууруудын хотгорт оршдог бөгөөд ОХУ-тай 575 км газраар хиллэдэг. 69.6 мянган ам дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй. Аймгийн нийт хилийн урт 1267км.

2007 оны байдлаар 19 сум, 92 баг, 19 мянган өрх, 80.4 мянган суурин хүн амтай. Аймгийн төв Улаангом 25.3 мянган оршин суугчидтай, нийслэл Улаанбаатар хотоос 1336км алсад далайн түвшнээс дээш 936 метрт оршдог.

Тус аймгийн нутагт далайн түвшнээс 2400-4126м өндөр мөнх цаст сүрлэг өндөр уулс, 9200 ам дөрвөлжин км талбайтай, Увс, Хяргас, Ачит, Үүрэг, Айраг зэрэг Монголын томоохон нуурууд, Тэс, Ховд, Хархираа, Завхан зэрэг том голууд байдаг бөгөөд алтай, хангай, говь хосолсон байгалийн үзэсгэлэн бүрдсэн баян тансаг нутагтай. Байгаль цаг агаарын эрс тэс уур амьсгалтай, өвөл зундаа 40-50 буюу +40-50 хэм хүртэл халж хөрдөг, хүйтний улирлын үргэлжилэх хугацаа урт, цасан бүрхүүлтэй байх хоногийн тоо олон зэрэг онцлогтой.

Тус аймгийн өндөр уул, ой тайга, өргөн тал, говь, олон нуур, гол горхи зэрэг байгаль газарзүйн олон янзын онцлог нь тохирсон төрөл бүрийн ургамал ан амьтан элбэг байдаг.

Аймгийн голлох салбар нь мал аж ахуй, газар тариалан бөгөөд хөнгөн, хүнс, уул уурхайн үйлдвэр хөгжиж байна. 2007 оны байдлаар 2400.9 мянган толгой малтай. үүнд тэмээ 16.1, адуу 80.2, үхэр 119.9 хонь 1164.8, ямаа 1019.7 мянган толгой болж, таван төрөлдөө өссөн бөгөөд энэ нь 1933 оноос хойшхи хамгийн өндөр үзүүлэлт юм.

### Ховд аймаг

Ховд аймаг нь 1931 онд байгуулагдсан, 76.1мянган кв км нутаг дэвсгэртэй, Улаанбаатар хотоос 1425км алслагдсан.

Ховд аймаг засаг захиргааны нэгжийн хувьд 17 сум, 91 багтай, 92395 хүн амтай. Хүн амын 35.5% нь аймгийн төв Ховд хот буюу Жаргалан суманд, бусад нь хөдөө орон нутагт ажиллаж

амьдарч байна. Монгол Алтайн мөнх цаст сүрлэг өндөр уулс, их нуурын хотгорын уудам хөндий, Алтайн өвөр говийн элсэн манхан, говь цөлийн байгалийн үзэсгэлэн хослосон 76.1 мянган кв км нутагтай.

Хамгийн их нутаг дэвсгэртэй Алтай сум аймгийнхаа нутаг дэвсгэрийн 17.3% буюу 13144 кв.км-т байхад хамгийн бага нь Дуут сум нь үүнээс 6.1 дахин бага 2147кв.км нутагтай байна. Хамгийн олон хүн амтай Булган сум 9582 хүнтэй бол хамгийн цөөн хүнтэй дуут сум түүнээс 4.7 дахин бага хүнтэй юм. Хөдөөгийн багуудаас Булган сумын Баянсудал баг 365 өрхтэй, 2033 хүнтэй байхад Мянгат сумын Гахайт баг 66 өрх, 345 хүн амтай.

“Нэг суурин- нэг бүтээгдэхүүн” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн төр захиргааны болон төрийн бус, төслийн байгууллагуудын удирдах ажилтан, мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачид, бизнесмэнүүдийг оролцуулан аймаг орноо хөгжүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөн ажлын байрыг шинээр нэмэгдүүлэх талаар тэдний санаа бодлыг сонсон хамтран ажиллах чиглэлээр хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

## **Нэг. БАРУУН БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ, ЦАГ УУР, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ**

### **1.1 БАЙГАЛЬ ЦАГ УУРЫН НӨХЦӨЛ**

Газарзүйн байрлал Баруун бүсэд Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг багтах бөгөөд тус бүс хойт талаараа ОХУ-ын Уулын Алтайн Бүгд Найрамдах Улс, Автономит Тува улстай, урд талаараа БНХАУ-ын Шинжаан-Уйгарын Өөртөө Засах оронтой тус тус хиллэнэ. Бүсийн нийт талбай 415.3мян.км<sup>2</sup> буюу Монгол Улсын нутгийн 26.5%-ийг эзэлнэ. Баруун бүсийн хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 4374м өргөгдсөн Алтайн Таван Богдын оргил Хүйтэн уул, хамгийн нам газар нь 759м өндөрт орших Увс нуурын хотгор юм. Засаг захиргааны нэгжийн хувьд 5 аймгийн 92 сумтай. Үүнээс: Баян-Өлгий аймаг 14 сумтай, 45.7мян.км<sup>2</sup> нутагтай, төв нь Өлгий-Улаанбаатараас 1709км зайтай. Говь-Алтай аймаг 18 сумтай, 141.4мян.км<sup>2</sup> нутагтай, төв нь Алтай-Улаанбаатараас 1037 км зайтай. Завхан аймаг 24 сумтай, 82.5мян.км<sup>2</sup> нутагтай, төв нь Улиастай-Улаанбаатараас 1023км зайтай. Увс аймаг 19 сумтай, 69.6мян.км<sup>2</sup> талбайтай, төв нь Улаангом-Улаанбаатараас 1417км зайтай. Ховд аймаг 17 сумтай, 76.1мян.км<sup>2</sup> талбайтай, төв нь Ховд-Улаанбаатараас 1487км зайтай. Баруун бүс бүхэлдээ улсын нийслэлээс хамгийн алслагдсан байрлалтай бөгөөд Улаанбаатар хоттой автозамын болон агаарын тээврээр холбогдоно.

#### **1.1.1 Газрын гадарга, нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөл**

Тус бүсэд 1) Монгол Алтайн нуруу, 2) Хангайн уулт өндөрлөгийн баруун хэсэг, 3)тэдгээрийн хооронд орших Их Нууруудын хотгор, 4) Алтайн чанад дахь говь маягийн уулсаар тусгаарлагдсан хотгорууд гэсэн гадаргын нөхцлөөр хоорондоо ялгаатай 4 хэсэг нутаг бий.

Монгол Алтайн гол нуруу Таван Богдын (4082м) бүлэг уулсаас зүүн урагшаа 800 гаруй км үргэлжилж Гичгэний нуруугаар төгсгөл болох бөгөөд уг гол нурууг дагаж Хүйтэн (4374м), Алаг зэл (3628м), Мааньт (3244м), Цагаан Хайрхан (3628м), Рашаан (3668м), Битүү (3654м), Дөнгөрөх (3131м), Хулагаш (3571м), Жалт (3301м), Өвчүү (3575м), Шар говийн даваа, Цагаан (3556м), Цал Буурал (3347м), Ташуу (3662м), Асгат (3404м), Цагаан Чулуут (3347м), Хөх Өндөр (3586м), Буурал Хайрхан (3705м), Мөст (3934м), Мөнх Хайрхан (4204м), Хар Бөөрөг (3902м), Бугат (4091м), Чангаст (3280м), Харгайт (3617м), Их, Бага Улаан даваа, Бараат (3567м), Улаан Сундуй (3752м), Даянпангийн даваа, Мянган Угалзат, Ар Булаг (3413м), Цагаан Чулуут (3228м), Тахидаг (3201м), Ур Уст (3151м), Тамчийн Даваа, Хүнхэрийн Ирмэг (3394м), Хөх Оно (3167м), Алаг Хайрхан (3739м), Буга-Хайрхан (3556м), Өлийт Хөтлийн даваа, Улаан-Хайрхан (2937м), Асгат Улаан (2700м), Их Хүрэн (3209м), Цагдуулт (2875м), Баян-Өндөр (2999м), Могой (2870м), Хөхтийн Хоолойн Уул (2967м), Бурхан Буудай (3765м), Төгөл-Хайрхан (3082м), Мянгат (3441м), Дөтийн даваа, Гичгэний нуруунд хамаарах Хаалгын Цахир (3670м), Ар Ягаан Чулуут (3511м), Урд Хөх (3469м), Баян-Цагаан (3051м), Алаг Хайрхан (3149м), Хан Хайрхан (3191м), Өлийн Овоо (3359м) зэрэг өндөр сүрлэг уулс Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай аймгийн нутгаар дамнан цуварч тогтжээ.

Монгол Алтайн нурууны баруун хойт хэсэг нь нилээн өргөн (350км хүртэл), уул нурууд нь хоорондоо шахуу байрлалтай, уулсын ян оргилууд нь ихэвчлэн мөнх цас мөсөн голтой, эртний мөстлөгийн нөлөөгөөр үүссэн тэвшин хөндий олонтой, уулс хоорондын хөндий хотгорууд нь өргөн биш тэгээд бас голдуу 2000м-ээс дээш өндөрт оршино.

Баруун бүсэд Алтай Таван Богдын бүлэг уулсаас зүүн тийш салаалсан богиновтор Баянгийн нуруу (3624, 3442м), түүнээс урд руу Алтайн гол нуруутай зэрэгцээ байрлалтай нэгдэх эгнээ уулс болох Цэнгэл-Хайрхан (3943м), Цагаан Асгат (3575м), Хөх Сайн (3534м), Буянт (3662м), Хөш (3477м),

Далайн Хөл (3297м), тэдгээрээс зүүн тийш хоёр дахь эгнээ уулс болох Улаан Сайр (3820м), Хүнгүй Хайрхан (3692м), Хатуугийн Эхэн (3500м), Сайр (3984м), Цамбагарав (4165м), Цаст (4193м), Таван Бэлчир (3658м), Хөх Сэрхийн нуруу (3750, 3776м), Бүргэдтэй Хайрхан (3740м) зэрэг уулс оршино.

Монгол Алтайн баруун хойт хэсгийн уул нурууд нилэнхүйдээ хавтгайдуу оройтой боловч шовх оргилууд цөөнгүй, хажуунууд нь эгц цавчим, хад асга, хавцал маягийн нарийн хөндий элбэгтэй, уулсын хоорондох хотгоруудад 2070- 2940м үнэмлэхүй өндөрт мөстлөгийн голдуу гаралтай цэнгэг уст олон нуур (Толбо, Хотон, Хоргон, Даян, Тал, Их Хар, Тугал, Чигэртэй, Хулагаш, Баян, Дөрөө нуур г.м.) тогтжээ. Голын хөндий зарим хэсэгтээ нилээн тавиу өргөн байдаг бол зарим газар урсгал нь хашигдаж нарийн хавцал дундуур урсах ч бий.

Жишээлбэл: Ховд голын дээд эх Цагаан-Усны гол 8м гүн, 20км орчим урт хад чулуун хавцлаар урсаж байгаад Хотон, Хоргон нуурын орчим хөндий нь овоо тэлж өргөн болсноо Цагаан-голын цутгалаас доохнотой Ховд голын хөндийн дахин нарийсч 7-8км урт, 700-750м гүн хавцал дундуур өнгөрдөг. Тэндээс уруудаад Ховдын цутгал Согоо, Сагсай голуудын бэлчир орчмоор (Баян-Өлгий аймгийн Улаанхус, Сагсай сумын төвийн ойролцоо) голын хөндий 4-7км өргөн болж, уг хөндийн захаар эртний нуурын дэнжүүд (25-30м) ажиглагдана. Түүнээс доош Ховд голын хөндий бас нарийсч давчуухан болсноо Баян-Өлгий аймгийн төв Өлгий хотын орчим дахин өргөн талбиу болж ирнэ. Энэ мэтчилэн нэг голын хөндий эхнээсээ адгаа хүртэл хэдэн удаа нарийн хавцал маягтай, хэдэн удаа өргөн тавиу байдалтай болж өөрчлөгддөг ажээ. Түүнчлэн Буянт голын эхэн орчмын Дэлүүний хөндий зарим хэсэгтээ 25-30км өргөн байна. Ёроолдоо голтой эгц цавчим хадан хавцлууд 10-20км-ээс илүү урттай байх нь цөөн. Монгол Алтайн нурууны энэ хэсэг дэх голын хөндийнүүд ихэнхдээ 2000-2200м-ээс дээш үнэмлэхүй өндөрт байрладаг.

Мөнх Хайрхан уулаас зүүн тийш Их, Бага-Улаан давааны орчмоос эхлээд Монгол Алтайн нурууны төрх байдал үлэмж өөрчлөгдөж, ерөнхийдөө нарийвтар (150км хүртэл) зурвасыг хамрахаас гадна 3500-3700м-ээс дээш өндөр оргилууд цөөрч Цаст Богд-Сутай Хайрханаас өөр мөнх цаст уул үл үзэгдэнэ. Энэ орчимд Монгол Алтайн гол нурууны зүүн талаар түүнтэй зэрэгцээ байрлалтай хоёр эгнээ уулс хөшиглөн тогтжээ. Тухайлбал, Алтайн гол нуруунаас Мөст, Цэцэг, Тонхилын хонхороор тусгаарлагдсан Сутай Хайрхан (Сутай, 4090м; Цаст Богд, 3725м; Налуу, 3210м; Хүрэн Үзүүр, 2124 м), Баатар Хайрханы (Эхэн-Бурхад, 3646м; Баатар Хайрхан, 3984; Баажиг, 3475м) нуруу нэгдэх эгнээ болон цуварчээ. Түүнээс зүүн хойш Зэрэгийн хоолой, Ихэс нуурын хотгороор тусгаарлагдсан Жаргалант Хайрхан (3797м), Бумбат Хайрхан (2969м), Дарвийн нуруу (Тахилгат, 2565м; Гүнгээгийн Шовх, 2684м; Хөх Уул, 2439м) хоёр дахь эгнээг үүсгэн байрлажээ. Эндээс зүүн тийш Монгол Алтайн гол нуруунаас Шаргын Говийн хотгор, Халиун, Бигэр нуурын хонхороор зааглагдсан Хасагт Хайрхан (3578м), Хан-Тайширын нуруу (Цагаан-Өндөр, 3008м; Хөндлөн 3070м; Баян Буурал, 3045м; Сэрх, 3165м) оршино. Дээрх зэрэгцээ байрлалтай уул нурууд нь Их Нууруудын Хотгор руу нэлээн түрж орсон байдалтай бөгөөд тэдгээрийн хоорондох хотгор, хонхор, хоолойнууд нь ихэнхдээ 1000-аас 1600м үнэмлэхүй өндөрт, зарим нуурын хонхор 2000м-ээс дээш өндөрт оршдог.

Алтай Таван Богдын бүлэг уулсаас зүүн хойшоо Сийлхэмийн нуруу (3530м), Их-Түргэн (4029м), Цагаан-Шувуут (3469м) уул салбарлаж, түүнээс зүүн урд руу Байрам (2960м), Түргэн (3965м), Хархираа (4037м), Алтан-Хөхий (3351м) уулс сүндэрлэнэ. Эдгээр хэдэн уул нуруудын хооронд Ачит, Үүрэг нуурын томоохон хотгорууд, Бөхмөрөн голын 30-40км (зарим газраар 60-70км хүрэх) өргөн хөндий орших бөгөөд эдгээр нуур, голын түвшин 1400 гаруй метрийн үнэмлэхүй өндөрт байна. Их-Түргэн, Хархираа, Түргэний уулсын оргилд мөнх цас, мөсөн голууд бий.

Монгол Алтайн нуруунаас зүүн тийш Хангайн уулт өндөрлөг хүртэл Их Нууруудын хотгор хэмээх тус тусдаа орших хэд хэдэн хотгороос тогтсон өргөн уудам хотос газар байдаг. Түүний хамгийн хойно нь Увс нуурын хотгор орших ба үнэмлэхүй өндөр нь нуурын эрэгт 759м, түүнээс тал бүр тийшээ өндөрсөөр 1500 гаруй метр хүрнэ. Гадаргын хувьд нуур руу хэвийсэн хэвгий талын шинжтэй, эргэн тойрны уулсаас нуур руу чиглэж урссан голуудын салаа гольдрол, сайр садрага олонтой, нуурын эрэг орчим бичил буурц хонхор, овон товон, элсэн хуримтлал элбэгтэй. Увс нуурын эргээс зүүн тийш Бөөрөг-Дэлийн-Элс хэмээх томоохон (4мян.гаруй км<sup>2</sup> талбайтай) элсэн тарамцаг үргэлжилнэ. Увс нуурын хотгорыг урд талаар нь Тогтохын Шил, Хан-Хөхийн нуруу зааглан тусгаарлажээ. Тэрхүү уулсаас урагш Хяргас (үн.өндөр нь 1028м), Хар-Ус (үн.өндөр нь 1157м), Хар (1132м), Айраг, Дөргөн нуурын хотгор орших ба эдгээр нуурууд нь хоорондоо хоолой, голуудаар холбогдсон байна. Хамгийн урд захад Хүйсийн говийн хуурай хотгор байрлана.

Их Нууруудын хотгорын үнэмлэхүй өндөр 1028м-ээс 1600 гаруй метр хүртэл хэлбэлзэх ба гадаргын төрх байдлын хувьд ерөнхийдөө нуурууд руу хэвийсэн талархуу шинжтэй боловч харьцах өндөр багатай (30-40м-ээс 100м хүртэл) нам уулс, оорцог толгод, хад цохио энд тэндгүй элбэг үзэгдэнэ. Хотгорын зүүн хагаст хэдэн том элсэн тарамцаг тогтжээ. Тэдгээрийг дурьдвал: 2.7мян.км<sup>2</sup>

талбайтай Монгол Элс; 2.5мян.км<sup>2</sup> талбайтай Бор Хярын Элс; 1.2мян.км<sup>2</sup> талбайтай Бага-нуурын урд элс; 1.6мян.км<sup>2</sup> талбайтай Аарцагийн Элс зэрэг болно. Их Нууруудын хотгор дахь элсэн тарамцагууд нь довцог, зоо, манхан, цац манхан элсүүдээс бүтэх бөгөөд хүчтэй салхины нөлөөгөөр элс хийсч зөөгдөх үйл явц түгээмэл ажиглагдана. Ялангуяа хотгоруудын хамгийн нам төв хэсэгт салхины үйл ажиллагаа нэн хүчтэй илэрдэг онцлогтой.

Их Нууруудын хотгороос зүүн тийш Завхан аймгийн нутагт Хангайн уулт өндөрлөгийн баруун хэсгийн уул нурууд зонхилох бөгөөд тухайлбал: Отгон-Тэнгэр (4021м), Цагаан-Хайрхан (3369м) орчмын бүлэг уулс, Тарвагатайн нурууны (3227м) баруун, баруун хойт, Булнайн нурууны (2619м) өмнөт, баруун өмнөт салбар уулсаас гадна түүнээс баруун тийш салангид байдалтай орших Хан-Жаргалант (2884м), Түдэвтэй (2916м), Сонгино-Хайрхан (2337м) зэрэг уулсыг дурьдах хэрэгтэй. Хангайн уулт өндөрлөгийн хамгийн баруун хойт үзүүр болох Тогтохын Шил (2357м), Хан-Хөхийн нуруу (2928м, 2591м) өргөрөгийн дагуу баруун тийшээ сунаж Их Нууруудын хотгор руу гүн түрж орсон байна. Хангайн нурууны дээрх уулс нэлэнхийдээ бөмбөгөрдүү хавтгай оройтой, хажуунууд нь их эгц биш, уулсын хоорондох хөндий хотгорууд 1650-1700 м-ээс дээш үнэмлэхүй өндөрт орших боловч голын хөндийнүүд нэлээн өргөн тавиу шинжтэй, талархуу гадаргатай хотгоруудад Тэлмэн, Ойгон, Улаагчины-Хар зэрэг томхон нуурууд тогтжээ.

Монгол Алтайн нурууны цаадах Ховд, Говь-Алтай аймгийн өмнөт хэсэгт Монгол Алтай, Тянь - Шаний салбар уулсаар зааглаж тусгаарлагдсан хэвгий талархаг гадаргатай томоохон хотгорууд зонхилно. Хамгийн баруун өмнөт захад улсын хилийн дагуу эмжээрлэн тогтсон Байтаг-Богд (3290м), Их-Бага Хавтаг (2912м), Тахийн-Шар нуруу (2740м)-наас хойш Монгол Алтайн өвөр хажуу хүртэл Баруун-Хуурайн хотгор, Хонин-Усны хоолой хэмээх 100 гаруй км өргөн, 300 орчим км урт уудам тэнүүн хотос газар оршино. Баруун бүсийн үнэмлэхүй өндөр ихэнхдээ 1000-аас 1500м хүртэл хэлбэлзэх бөгөөд гадарга нь тэгш биш, цав толгод, намавтар шил, гүвээ, буурц хонхор, шал тойром элбэгтэй. Үүнээс зүүн тийш Монгол Алтайн салбар Аж-Богдын нуруу (3802м), Таянгийн-нуруу (3234м), тэдгээрийн хооронд болон өмнө талд нь орших Алаг нуурын хотгор, Ажийн тал, Шар Тооройн тал, Хар-Сайрын хөндий, Цэнхэрийн Хоолой зэрэг хотгорууд бий. Тэдгээрийн гадарга сайр чулуурхаг бөгөөд хуурай сайруудаар багагүй хэрчигдсэнээс гадна зарим газар үнэмлэхүй өндрийн түвшин 700м хүртэл (Цэнхэрийн хоолойд) намсч ирнэ.

Монгол Алтайн Гичгэний нуруунаас урагш хоёр эгнээ уулс орших бөгөөд нэгдэх эгнээ нь Эдрэнгийн нуруу (2076м), хоёрдох эгнээ нь түүнээс нэлээн урд руу улсын хилийн ойролцоо байрлах Атас-Богд (2695м), Чингис (2114м) уулууд юм. Эдрэнгийн нурууны араар Захуй-Зармангийн говь, урдуур нь Номингийн говь, Шаргын говь гэх мэт хуурай сайруудаар хэрчигдсэн, чулуурхаг гадаргатай хонхор хотгорууд 800-1500м үнэмлэхүй өндөрт байрлана. Дээр өгүүлснээс үзэхэд Баруун бүсийн нутаг өндөр уул, хонхор хотгор хосолсон, манай орны хамгийн уулархаг хэсэг болох нь тодорхой байна.

### 1.1.2 Инженер геологийн нөхцөл

Баруун бүсийн хотгор гүдгэрийн олон хэв шинжит байдлаас улбаалан хурдас чулуулгийн хуримтлал ч бас маш жигд биш байна. Өндөр уулын хотгор гүдгэр зонхилсон Монгол Алтайн гол нуруу болон түүнтэй зэрэгцэн эгнээлж тогтсон салбар уулс, Сийлхэм, Хархираа-Түргэн, Отгон-Тэнгэр, Тарвагатайн нурууны ноёлох өндөрлөгүүдэд дөрөвдөгчийн сэвсгэр хурдас бараг байхгүй, харин боржин, лейкоборжин, плагиоборжин, диорит, гранодиорит, сиенит, граносиенит, талстат занар, элсэн чулуу, алевролит, аргиллит мэтийн хатуу суурь чулуулгаас бүтсэн хад чулуу, асга нуранги бүхий хадан ул хөрс давамгайлна. Тэрхүү ноёлох өндөрлөгүүдээс арай доод түвшинд эртний мөстлөгийн гаралтай тэвшин хөндий, хунх, хөнгий, өлгүү хөндий, ирмэг мөрөгцөг, морены далан, толгод цөөнгүй бий бөгөөд тэдгээрт мөсөн голын үүсэлтэй (элс, элсэнцэр, шавранцар дүүргэгчтэй хэмхдэс чулуу, хайрга, бул чулуун) хурдас багагүй бөөгнөрчээ. Мөн Монгол Алтайн баруун хойт хэсэг дэх мөсөн голын гаралтай нууруудын хотгорт нуур-мөсөн голын үүсэлтэй элс, элсэнцэр, шаварлаг хурдас тогтсон байна. Өндөр уулсын хажуунуудаар гулсалт, коллювий, делювийн гаралтай элсэнцэр, шавранцар дүүргэгч бүхий хэмхдэс чулуу, сайр голлосон хурдас түгээмэл тархжээ.

Тарвагатай нурууны баруун хойт салбар, Хан-Хөхий, Тогтохын Шил, Булнайн нуруу, Хангайн баруун хэсэг, Монгол Алтайн захын дундаж өндөр уулсын хавтгайдуу орой, хажуу биеэр элюви, делювийн гаралтай, үйрмэг ба сайр чулуу их бага хэмжээгээр агуулсан шавранцар-элсэнцэр ширхэгтэй хурдас нийтлэг байдалтай байна. Уулын бэл, хормой, уулс хоорондын ам хөндий, хуурай хотгор, хоолойнуудад делюви-пролювийн ба пролювийн гаралтай, хайрга, хайрганцар, үйрмэг ба сайр чулуу багагүй агуулсан тоосорхог шавранцар, элсэнцэр хурдас их хэмжээгээр хуримтлагдсан байх бөгөөд тэдгээр нь заримдаа суулт үүсгэх шинжтэй байна. Ялангуяа карбонат, гөлтгөнө, хялбар уусах давс агуулсан сэвсгэр хурдас суулт үүсгэх нөхцөл илүүтэй байдаг.



Алтайн арын Хүйсийн Говь, Шаргын Говь, Бигэрийн хотгор, Алтайн цаадах Баруун-Хуурай, Алаг-нуур, Захуй-Зармангийн Говь зэрэг хотгор хонхруудын ёроолд нуур-пролювийн гаралтай, салаавчлан тогтсон элс, шавар, хайрга, хайрганцар үеүүд бүхий давсархаг голдуу шинжтэй шавранцар, элсэнцэр хурдсууд тогтжээ. Хангайн нуруунаас эх авдаг Завхан, Хүнгүй, Идэр, Тэс, Алтайн нуруунаас эх авдаг Ховд, Согоо, Буянт, Булган, Бодонч, Үенч, Цэнхэр зэрэг голуудын хөндий татам дагуу голын урсгал усны үйлчлэлээр үүссэн аллювийн хурдас нэн түгээмэл. Тэрхүү аллювийн хурдас нь нимгэн үеүдээр салаавчлан үелж тогтсон янз бүрийн ширхэгтэй элс, элсэнцэр, шавар, шавранцар, хайрга, хайрганцар материалаас бүрдэх бөгөөд дарагдмал хөрсний давхарга, хүлэрлэг үеүдтэй байх ч бий. Нууруудад цутгадаг голуудын адаг орчмоор тухайлбал: Ховд голын адаг Хар-Ус нуурын баруун хойт хэсэг, Тэсийн голын адаг Увс нуурын хотгорын зүүн хэсэг, Сагил, Хархираа голуудын адаг Увс нуурын баруун хэсэг, Завхан, Хүнгүй голуудын адаг болох Хяргас, Айраг нуурын өмнөт хэсэг, мөн Ачит нуурын хотгор дахь Бөхмөрөн голын хөндий зэрэг газруудад нуур-голын гаралтай хурдас нэлээд их талбайг хамран тархжээ. Нуур-голын эдгээр хурдас дан хайрга-хайрганцар, үелэн тогтсон элс-хайрга, салаавчлан тогтсон элс-хайрганцар үеүд бүхий шавранцар, заримдаа шаварлаг материалаас бүтсэн байна.

Бүх нууруудын эргэн тойронд, түүнчлэн Хүйсийн Говийн хотгорт салаавчлан тогтсон тоосорхог элс, дунд ширхэгтэй элс, жижиг хайрга, элсэнцэр үеүд бүхий шавар ба шавранцар материалаас бүрдсэн нуурын хурдас тогтжээ. Нуурын хурдсанд ургамлын үлдэгдэл, хүлэржсэн үеүд цөөнгүй тохиолдоно. Их Нууруудын Хотгорын зүүн хагаст салхиар хурж тогтсон элсэн хурдас багагүй талбайг эзэлнэ. Тэрхүү элсэн тарамцагууд нь дунд ширхэгтэй элс, тоосорхог элснээс голчлон бүтэх бөгөөд гүнд нь шавар-шавранцар үеүд мэр сэр хавчуулагдан үлдсэн байна.


Их Нууруудын хотгорыг баруун талаар нь эмжээллэн тогтсон Хархираа-Түргэн, Бумбат-Хайрхан, Баатар-Хайрхан, Дарвийн нуруу, Шаргын говь ба Бигэрийн хотгорын урд талын цувраа нурууд, мөн Хан-Тайшир, Хасагт-Хайрханы нуруу, Хяргас нуурын хотгорыг хойт ба зүүн талаар нь хүрээлсэн уулс, Алтайн чанадахь Эдрэнгийн нуруу, түүнчлэн Баруун-Хуурайн хотгорыг хойт, урдаас нь хүрээлсэн уул нурууд зэрэг олон газар галт уул-тив гарлын үүсэлтэй карбонатлаг чулуулаг (андезит, диабаз, силит, андезит-хүрмэн чулуун порфирит, ногоон элсэн чулуу, конгломерат, шохойн чулуу) нэн элбэг тархаж хад чулуун ул хөрсийг бүрдүүлж бий болгожээ.

Баруун бүс нутаг гидрогеологийн нөхцөлөөр нэлээд өвөрмөц. Газрын доорх усыг сэвсгэр хурдаст агуулагдах нүх сүвийн ус, хатуу суурь чулуулагт агуулагдах ан цавын ус гэж хоёр ангилдаг. Нүх сүвийн ус уулсын хоорондох хөндий, хотгоруудад дөрөвдөгчийн сэвсгэр хурдсын дотор голчлон агуулагдах ба Хяргас, Шаргын Говь, Бигэрийн хотгор зэрэг зарим хотост палеоген-неогенийн хурдсын ус, Алтайн чанадахь Номингийн говьд дунд төрмөлийн хурдсын ус багашиг хэмжээгээр тархжээ. Уулархаг нутгаар орших ан цавын ус голчлон гүний шургамал чулуулгийн, эрт төрмөлийн тунамал ба бялхмал чулуулгийн, доод эрт төрмөлийн хувирмал чулуулгийн дотор агуулагдана. Газрын доорхи усны эрдэсжилт ерөнхийдөө дунд зэрэг, 0.5-1 г/л орчим байна.

Их Нууруудын хотгорын усны нөөцийг иж бүрэн ашиглах, хамгаалах ерөнхий схем боловсруулах судалгааны (1983) хүрээнд тус хотгорт хамаарах нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын доорх усны нөөцийг нуур, голын ай сав тус бүрээр тодорхойлох ажлыг гүйцэтгэжээ.

# ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ

1:1500000



## Таних тэмдэг

- Аймгийн төв
- Газар чичирхийлэл баллаар
- Олон жилийн цэвдгийн бөөрөг
- Туфур
- Дов бөөрөг
- Хөрс гулгалт ба гулгалтаар үүссэн дэнж
- Хадархаг ул хөрс
- Хадан ул хөрс
- Хайрга сайр чулуу: Элстэй, элсэнцэр-шавранцар дүүргэгчтэй
- Элсэнцэр-шавранцар дүүргэгчтэй хэмхдэс ба сайр чулуу, хайрга
- Хайрганцар
- Цэвдгийн бүс бүслүүрийн хил
- Гол
- Нуур
- Шургамал чулуулаг: Боржин, шүлтлэг боржин, адамелит, нефелит сиенит, граносиенит-порфир
- Тив гарлын чулуулаг: Элсэн чулуу, бөсөл элсэн чулуу, аргиллит алевролит, конгломерат
- Салхиар тогтсон/Дунд ширхэгтэй тоосорхог элс зохилно. Шавранцар ба шаврын зүйл нимгэн үе, мэшил байдлаар тохиолдоно.
- Галт уул-тив гарлын карбонатлаг чуулаг: Андезит, диабаз, силит андезит-хүрмэн чулуут порфирит, липаритат, порфирит, ногоон өнгөтэй элсэн чулуу, конгломерат, шохойн чулуу / доод моласс/
- Нуурын: Салаавчлан тогтсон элс, дунд ширхэгтэй элс, элсэнцэр элсэн дүүргэгчтэй жижиг-хайрган үе бүхий шавар ба шавранцар ургамлын үлдэгдэлтэй, зарим хэсэгтээ хүлэржсэн
- Нуур-голын хайрганцар: Хайрганцар үетэй элс, салаавчлан тогтсон хайрганцар, элсэн үе бүхий шавранцар ба элсэнцэр, салаавчлан тогтсон хайрганцар ба элсэн үе, бор өнгийн алевритбүхий элс элсэнцэр, шавранцар ба хааяа шавар
- Голын: Салаавчлан тогтсон янз бүрийн ширхэгтэй элс, элсэнцэр шавранцар хааяа элсэнцэр, шавранцар дүүргэгчтэй. Жижиг хайрга хайрганцар, шавранцар, шаварлаг хурдас нь ургамлын үлдэгдэлтэй зарим хэсэгтээ ялимгүй хүлэржсэн, бор өнгийн элс, шавранцар, шавар
- Элюви-делювийн: Элсэнцэр, шавранцар, хааяа элсэн дүүргэгчтэй үйрмэг ба сайр чулуу, үйрмэг ба сайр чулуу янз бүрийн хэмжээгээр агуулсан элсэнцэр, шавранцар, элс, шавар
- Шургамал чулуулаг: Боржин, шүлтлэг боржин, сиенит

- Нуур-мөсөн голын: Элс, элсэнцэр, шавранцар, туузан шавар
- Хувирмал чулуулаг: Хувирсан элсэн чулуу, талстат занар кварцит, амфиболит, гнейс, боржинт-гнейс
- Ус-мөсөн голын: Жижиг хайрга, элс ба элсэнцэр дүүргэгчтэй бул хайрга чулуу, жижиг хайрга бүхий элсэн мэшил
- Элювийн ба гулсалтын: Үйрмэг чулуурхаг элсэнцэр-шавранцар ба дан элсэнцэр-шавранцар дүүргэгчтэй хэмхдэс ба сайр чулуу
- Шургамал чулуулаг: Габбро, габбро-диорит, плагиоборжин, банатитат гранодиорит, гнейсэрхүү боржин, боржинт гнейс, гранодиорат-гнейс
- Нуур-пролювийн: Салаавчлан тогтсон элсэнцэр, шавранцар, үе бүхий сайр чулуутай элс, хайрганцар, давсархаг голдуу, шавар, шавранцар, элсэнцэр
- Проловийн: Янз бүрийн дүүргэгчтэй жижиг хайрга ба хайрганцар хааяа сайр чулуу, тоосорхог элсэнцэр нь заримдаа султ үүсгэх шинжтэй.
- Гулсалт делювийн: Сайр ба хэмхдэс чулуу, элсэнцэр, шавранцар
- Делюви-пролювийн: Элсэнцэр шавранцар дүүргэгчтэй үйрмэг ба сайр чулуу, жижиг хайрга бүхий тоосорхог шавранцар, элсэнцэр, янз бүрийн ширхэгтэй элс шавар, жижиг хайргын зүйл мэшил
- Моласс-галт уулын чулуулаг: хүрмэн чулуу-андезит, липарит, бөсөл элсэн чулуу, алевролит, конгломерат, брекчи
- Тив гарлын ба тив гарлын карбонатлаг: Элс-шаварлаг, хайрганцар ба карбонатлаг хурдас, хааяа хүрмэн чулуу тогтсон байна

Џодддд 1.1

Энэ судалгааны үр дүнгээс харахад Их Нууруудын хотгор дахь гүний усны бүх нөөцийг 4939 сая м<sup>3</sup>/ жил гэж тооцоолжээ. Үүнийг дотоодын жижиг ай сав тус бүрээр ялгаж үзвэл: Тэсийн – голын эхэн хэсгийн районд 425.7 сая м<sup>3</sup>/жил, Увс нуурын хотгорт 497.3 сая м<sup>3</sup>/жил, Үүрэг нуурын хотгорт 18.4 сая м<sup>3</sup>/жил,

Ховд голын ай савд 1248.8 сая м<sup>3</sup>/жил, Хар-Ус, Хар, Дөргөн нуурын хотгорт 177.9 сая м<sup>3</sup>/жил, Завхан голын ай савд 835.7 сая м<sup>3</sup>/жил, Хүнгүйн голын ай савд 580.3 сая м<sup>3</sup>/жил, Хяргас нуурын хотгорт 227.4 сая м<sup>3</sup>/жил, Хархираа, Алтан-Хөхийн хоорондох Намирын Хар-Ус нуурын хотгорт 81.4 сая м<sup>3</sup>/жил, Ойгон нуурын районд 117.3 сая м<sup>3</sup>/жил, Манхан, Зэрэг, Мөст, Тонхил, Дарвийн районд 277.2 сая м<sup>3</sup>/жил, Хүйс-Шаргын говийн хотгорт 295.8 сая м<sup>3</sup>/жил, Бигэр-Үнээн Усны районд 145.7 сая м<sup>3</sup>/жил гэсэн газрын доорх усны нөөцтэй байна.

Газрын доорх усны энэ их нөөцийг асар урт удаан хугацааны турш ашиглахад хүрэлцээтэй юм. Одоогийн байдлаар Баруун бүсэд газрын доорхи усны бүх ашиглалтын нөөцийн дөнгөж 0.3 орчим хувийг л хэрэглэдэг ажээ. Газрын доорхи усны байрлах гүнийг тодорхойлж тойм зураглал (M1:3000000) үйлдсэнээс харахад нуур бүхий хотгорууд болон голын татам хөндийд гүний усны түвшин 0-5м гүнд, уг хөндий хотгоруудын зах хаягаар 5-25м гүнд, уулсын хоорондох хуурай ам хөндий, цав толгодорхог газраар 25-50м буюу түүнээс доош гүнд оршдог байна. Олон жилийн ба улирлын цэвдгийн талаар дурьдахгүй байж болохгүй нь тодорхой. Баруун бүсийн хэмжээнд цэвдгийн тархалтын 4 бүслүүр тод ялгарна. Үүнд:

1) Олон жилийн цэвдэг чулуулаг үргэлжлэн ба алаг цоог тархсан бүсэд 2800-2900м-ээс дээш өргөгдсөн Монгол Алтайн нурууны (Говь-Алтай аймгийн Бугат сум хүртлэх) үндсэн хэсэг, Сийлхэм, Хархираа, Түргэний уулс, 2400-2500м-ээс дээш өндөртэй Отгонтэнгэр, Тарвагатайн нурууны баруун хойт болон Булнайн нурууны салбар уулс хамрагдана. Энэ бүсийн доторхи нутгийн 40-80% нь мөнх цэвдэгтэй байж болох ба цэвдэгт давхаргын зузаан нь 50-100м буюу түүнээс илүү, зуны улиралд гэсэх гүн нь 1-2.5м орчим байна.

2) Олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог тархсан бүсэд 2400-2500м-ээс дээш өндөртэй Монгол Алтайн нурууны захын уулс, 2000-2100м-ээс дээш өргөгдсөн Хангайн уулт өндөрлөгийн баруун хэсэг хамрагдана. Энэ бүсийн доторхи нутгийн 1-40% – нь олон жилийн цэвдэгтэй байх магадлалтай, цэвдэгт давхаргын зузаан нь 10-50м буюу заримдаа түүнээс илүү, зуны улиралд гэсэх гүн нь 1.5-3.5м орчим байна.

3) Олон жилийн цэвдэг тохиолдлын байдалтай тархсан бүсэд Их Нууруудын хотгор болон Монгол Алтайн өвөр хажуугийн бэсрэг уулс хамрагдах бөгөөд нутгийн 1 орчим хувьд нь мөнх цэвдэгтэй байх магадлалтай. Энэ бүс дэх цэвдэгт давхаргын зузаан 5-10м-ээс үл хэтэрнэ.

4) Олон жилийн цэвдэг байхгүй, зөвхөн улирлын цэвдэгтэй бүсэд Шаргын Говь, Бигэрийн хотгор болон Алтайн чанадахь говь нутаг хамрагдана. Ер нь аль ч нутагт олон жилийн цэвдэгтэй эсэхийг цэвдгийн дов бөөрөг, ан цав, халиа, хөрсний гулсалт, суулт, чулуун хүрээ, асга чулууны ялгарал зэрэг цэвдэгт үзэгдлүүдийн үүсч илэрсэн байдлаар хялбархан таньж болно. Баруун бүсийн олон жилийн цэвдэг чулуулаг тархаагүй бүх нутагт хөрсний улирлын хөлдөлт явагдаж жилийн хүйтэн үеийн туршид улирлын цэвдэг үүснэ. Хөрсний улирлын хөлдөлтийн гүн хойт талын нутгаар 3-5м, төв хэсгээр 2.5-4м, өмнөт хэсгээр 1.5-3м орчим байна.

Баруун бүс бүхэлдээ газар чичирхийллийн идэвхтэй мужид багтах бөгөөд энд (MSK – 64 шатлалаар) 7-9 балл буюу түүнээс илүү хүчтэй газар хөдлөлт болох магадлалтай. 1905 онд Булнайн нурууны орчимд ( Рихтерийн шатлалаар ) 8 –аас дээш магнитудын хүчтэй газар хөдлөлт болсны улмаас 300 шахам км урт, 4м-ээс 20м хүртэл өргөнтэй газар хагарлын томоохон ан цав үүсчээ. Сүүлийн 100 жилд Баруун бүс болон улсын хилийн ойролцоох нутагт 5-аас дээш магнитудын (  $M_w$  – 5.0-8.4 ) хүчтэй газар хөдлөлт 20 гаруй удаа тохиолдсон явдал Монгол орны бусад аль ч бүс нутгаас өндөр үзүүлэлт юм. Тэрхүү хүчтэй газар хөдлөлтийн төвүүд нь Монгол Алтай, Хархираа-Түргэний уулс, Булнайн-Хан Хөхийн нуруу болон Аж Богдын нуруунаас баруун тийш орших Хөвийн нуруу-Хонин усны говьд тус тус тэмдэглэгджээ. Газар чичирхийллийн энэ хүчин зүйлийг хот байгуулалт, зам барилгын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд зайлшгүй харгалзаж байвал зохино.

### 1.1.3 Уур амьсгал

Уур амьсгал бүрдүүлэгч гол хүчин зүйлийн нэг нь нарнаас ирэх цацрагийн хэмжээ байдаг. Баруун бүсэд нарны нийлбэр цацрагийн жилийн дундаж хэмжээ өндөр уулархаг нутгаар 1200 квт.цаг/м<sup>2</sup> буюу түүнээс бага, Их Нууруудын хотгорын төв хэсэг ба Алтайн өвөр говьд 1400 квт.цаг/м<sup>2</sup> буюу түүнээс их, бусад нутгаар энэ хоёр хэмжигдэхүүний хооронд өндрийн түвшин дээшлэхэд буурах

хандлагатайгаар хэлбэлзэнэ. Нарны гийгүүлэх хугацаа бүсийн хойт хэсэг-Увс, Үүрэг нуурын хотгорт жилд 2700 цаг буюу түүнээс богино, төв хэсэг-Ховд голын ай сав, Их Нууруудын хотгор, Хангайн баруун нутгаар жилд 2700-3000 цаг, түүнээс урагших нутгаар 3000-3200 цаг, хамгийн өмнөт хэсэг-Алтайн чанадахь говьд жилд 3200-3400 цаг үргэлжилдэг явдал нарны эрчим хүчийг аж ахуйн зориулалтаар ашиглах таатай боломжийг бүрдүүлдэг байна. Агаарын жилийн дундаж температур Хангайн уулст  $-4^{\circ}\text{C}$  -  $-8^{\circ}\text{C}$ , Монгол Алтайн уулс болон Увсын хотгорт  $-2^{\circ}\text{C}$  -  $-5^{\circ}\text{C}$ , Их Нууруудын хотгорын төв хэсэгт  $0^{\circ}\text{C}$  -  $+1^{\circ}\text{C}$ , уг хотгорын захаар  $0^{\circ}\text{C}$  -  $-2^{\circ}\text{C}$ . Алтайн цаадах говьд  $+2^{\circ}\text{C}$  -  $+8^{\circ}\text{C}$ , Баруун Хуурайн хотгор, Булган голын адгаар  $0^{\circ}\text{C}$ -  $+4^{\circ}\text{C}$  орчим байна. Хамгийн хүйтэн 1-р сарын агаарын дундаж температур Увсын хотгорт  $-35^{\circ}\text{C}$  ба түүнээс доош, Хархираа-Түргэн, Хангайн уулст  $-30^{\circ}\text{C}$  ба түүнээс ялимгүй доош, дээш, Монгол Алтайн уулс, Их Нууруудын хотгорт  $-20^{\circ}\text{C}$  -  $-25^{\circ}\text{C}$ , Алтайн цаадах нутагт  $-15^{\circ}\text{C}$  -  $-20^{\circ}\text{C}$  орчим байна. Үнэмлэхүй хамгийн бага температур Увсын хотгорт  $-50^{\circ}\text{C}$  (Улаангом, Баруунтуруун), Тэсийн голын хөндийд  $-52^{\circ}\text{C}$  (Баянтэс), Идэр голын хөндийд  $-53^{\circ}\text{C}$  (Тосонцэнгэл) хүрнэ.

7-р сарын агаарын дундаж температур Монгол Алтай, Хангайн уулст  $+10^{\circ}\text{C}$  -  $+15^{\circ}\text{C}$ , бусад нутгаар  $+15^{\circ}\text{C}$  -  $+20^{\circ}\text{C}$ , Алтайн чанадахь нутагт  $+20^{\circ}\text{C}$ -аас дээш байна. Үнэмлэхүй хамгийн их температур Алтайн өвөр говьд  $+40^{\circ}\text{C}$  (Захуй) хүрнэ. Агаарын температур -  $30^{\circ}\text{C}$  ба түүнээс доош байх их хүйтэн өдрийн тоо Увсын хотгор, Тэс, Идэр голын хөндийд жилд 50-70 буюу түүнээс олон, Монгол Алтай, Их Нууруудын хотгор, Хангайн баруун хэсэгт 30-50, Алтайн чанадахь нутагт 30-10 хоног байна. Агаарын температур  $+30^{\circ}\text{C}$  буюу түүнээс дээш байх их халуун өдрийн тоо уулархаг нутгаар 10-аас цөөн, Их Нууруудын хотгорт 10-20, Шаргын Говийн хотгорт 20-оос олон, Алтайн цаадах нутагт 20-40 хоног байна.

Баруун бүсийн ихэнх нутаг хур тунадас багатай, уулархаг газраар жилд дунджаар 200-400 мм, бусад нутгаар 100-200 мм, Ачит, Увс, Их Нууруудын хотгорт 100 мм-ээс бага, Хүйс, Шаргын говь, Баруун Хуурайн хотгор, Алтайн Өвөр говьд 50 мм-ээс бага тунадас унадаг.

Жилийн хур тунадасны 70-80%-нь дулааны улиралд орох тул өвөл цас багатай, тогтвортой цасан бүрхүүл Увсын хотгор болон уулархаг нутгаар 100-150 хоног, бусад хотгоруудад 100-50 хоног буюу түүнээс ч цөөн үргэлжилнэ. Зуны улиралд хур бороо орохгүй ган гачиг цөөнгүй тохиолдох бөгөөд ялангуяа Ачит нуур, Их Нууруудын хотгорт гангийн давтагдал 35%-иас дээш, бусад хотгоруудад 30-35% байна.

Баруун бүсийн хотгоруудад салхины үйл ажиллагаа идэвхтэй илэрнэ. 15м/сек хурдтай буюу түүнээс хүчтэй салхитай өдрийн тоо Баруун Хуурайн хотгор болон Их Нууруудын хотгорын захаар жилд дунджаар 10-20, Их Нууруудын хотгорын төв хэсэг болон Алтайн Өвөр говьд 20-30 хүрч, жилд 20-40 хоног шороон шуургатай байна.

Тус бүсэд Монгол орны бусад нутгийн нэгэн адил жилийн 4 улирлын ялгаа, тэдгээрийн үргэлжлэх хугацааг тод зааглаж болно. Өвлийн улирал хоногийн агаарын дундаж температур  $-5^{\circ}\text{C}$  хүрч хүйтрэх намрын сүүл үеэс, мөн температур  $-5^{\circ}\text{C}$  –аас дээшилж дулаарах хаврын эхэн үе хүртэл үргэлжлэх ба баруун бүсийн доторхи нутгуудад өвлийн улирал 15/X-наас 30/XI-ны хооронд эхэлж дунджаар 152 хоног үргэлжилнэ.


Хамгийн урт өвөл (178 хоног) Хангайн уулт өндөрлөгийн баруун хойт хэсэг-Завхан аймгийн зүүн, зүүн хойт сумууд болон Монгол Алтайн нурууны баруун хойт хэсэг- Баян-Өлгий аймгийн олонхи сумуудад ажиглагддаг бол хамгийн богино өвөл (102 хоног) Алтайн өвөр говь, Говь-Алтай аймгийн нутгийн урд захаар ажиглагдана. Өвлийн улирал урт, хахир ширүүн, их хүйтэн байдгаараа онцлог.

Хаврын улирал хоногийн агаарын дундаж температур  $-5^{\circ}\text{C}$ -ыг давж дээшлэх өвлийн сүүл үеэс мөн температур  $+10^{\circ}\text{C}$  хүрч дулаарах зуны эхэн үе хүртэл үргэлжлэх ба баруун бүсийн доторхи янз бүрийн нутагт хаврын улирал 6/III-наас 10/IV-ны хооронд эхэлж дунджаар 51 хоног үргэлжилдэг. Хамгийн урт хавар (68 хоног) Монгол Алтайн нуруунд-Баян-Өлгий аймгийн Алтай суманд, хамгийн богино хавар (35 хоног) Увс нуурын хотгорт (Улаангомд) ажиглагддаг.

Хаврын улирал богино, хүчтэй салхи, шороон шуурга байн байн тохиолддог, хур тунадас багатай, их хуурай байдгаараа онцлог. Зуны улирал хоногийн агаарын дундаж температур  $+10^{\circ}\text{C}$ -аас давж дулаарах хаврын сүүл үеэс мөн температур  $+10^{\circ}\text{C}$ -аас доошилж буурах намрын эхэн үе хүртэл үргэлжлэх ба баруун бүсийн доторхи нутгуудад зуны улирал 22/IV-ноос 11/VI –ны хооронд эхэлж дунджаар 110 хоног үргэлжилнэ.

АГААРЫН ТЕМПЕРАТУР

М 1:1500000



Зураг

Хамгийн богино зун (65 хоног) Монгол Алтайн гол нуруу, Сийлхэм, Хан-Хөхийн нуруу, Тэсийн голын хөндийд ажиглагддаг бол хамгийн урт зун (169 хоног) Алтайн Өвөр говь-Захуй орчимд ажиглагдана. Зуны улиралд хур бороо элбэг, уулын голууд үерлэх аюултайгаас гадна говь нутгаар ган гачиг тохиох нь цөөнгүй.

Намрын улирал хоногийн агаарын дундаж температур  $+10^{\circ}\text{C}$ -аас доошилж буурах зуны сүүл үеэс мөн температур  $-5^{\circ}\text{C}$ -аас давж хүйтрэх өвлийн эхэн үе хүртэл үргэлжлэх ба баруун бүсийн доторхи янз бүрийн нутагт намрын улирал 19/VIII-нөөс 30/IX –ны хооронд эхэлж дунджаар 52 хоног үргэлжилдэг.

Хамгийн урт (65 хоног) намар хойт талын нутгаар, хамгийн богино намар (39 хоног) өмнө зүгийн нутгаар ажиглагдана. Намрын улирал хавартай адил богино, гэнэт хүйтэрч өвөлд огцом шилждэг.

Цаг уурчдын судалгаанаас үзэхэд сүүлийн 40 гаруй жилийн дотор Баруун бүс дэх жилийн 4 улирлын эхлэх, дуусах, үргэлжлэх хугацаа багагүй өөрчлөгджээ. Үүнд:

1) Өвлийн улирлын эхлэх хугацаа дунджаар 6 хоногоор хойшилж, дуусах хугацаа нь 3 хоног урагшилснаас болж өвлийн улирлын үргэлжлэх хугацаа 9 хоногоор богиноссон байна.

2) Хаврын улирлын эхлэх, дуусах хугацаа тус бүр 3-4 хоногоор урагшилж, харин үргэлжлэх хугацааны хувьд бараг өөрчлөлт ороогүй байна.

3) Зуны улирлын эхлэх, дуусах хугацаа тус бүр 4-5 хоног урагшилж, харин үргэлжлэх хугацаа нь төдий л өөрчлөгдөөгүй байна.

4) Намрын улирлын эхлэх хугацаа 4-5 хоногоор урагшилж, дуусах хугацаа нь 6 хоногоор хойшилсон тул нийт үргэлжлэх хугацаа нь 10 хоногоор уртассан байна.

Үүний гол учир шалтгаан нь дэлхий нийтийн дулаарлын үйл явцтай холбоотой гэдэг нь тодорхой.

Баруун бүсэд байрладаг цаг уурын 30 станц, 10 орчим харуулын сүүлийн 30-50 жилийн ажиглалтын материалд боловсруулалт хийсний дүнд 5 аймаг тус бүрийн уур амьсгалын өөрчлөлтийн талаар тодорхой тоо баримттай болж чадсан байна.

Тухайлбал: Увс аймагт 1952 оноос хойш агаарын жилийн дундаж температур  $2.03^{\circ}\text{C}$ -аар нэмэгдсэн бөгөөд тэгэхдээ зуны улиралд  $0.78^{\circ}\text{C}$ -аар, өвлийн улиралд  $1.68^{\circ}\text{C}$ -аар тус тус дулаарсан байна. Үүний хамт хур тунадасны хэмжээ ялимгүй өсөх хандлага ажиглагдав.

Завхан аймагт 1960 оноос хойш агаарын жилийн дундаж температур  $1.4^{\circ}\text{C}$ -аар дулаарсан бөгөөд тэгэхдээ дулааны улиралд  $0.9^{\circ}\text{C}$ -аар, хүйтний улиралд  $1.3^{\circ}\text{C}$ -аар тус тус дулаарчээ. Үүнийг дагаад хур тунадасны хэмжээ бас ялимгүй нэмэгдэх хандлага ажиглагдав.

Говь-Алтай аймагт 1973 оноос хойш агаарын жилийн дундаж температур  $1.08^{\circ}\text{C}$ -аар дулаарсан бөгөөд хур тунадасны хэмжээ бага зэрэг өссөн, ялангуяа өвлийн улиралд илүү нэмэгдсэн тал ажиглагдав.

Баян-Өлгий аймагт 1964 оноос хойших хугацаанд агаарын жилийн дундаж температур  $0.6^{\circ}\text{C}$ -аар дулаарснаас дулааны улиралд  $0.28^{\circ}\text{C}$ -аар, хүйтний улиралд  $0.55^{\circ}\text{C}$ -аар нэмэгджээ. Харин хур тундасны хэмжээ өссөн байдал ажиглагдаагүй байна.


Ховд аймагт агаарын жилийн дундаж температур 1983 оноос хойш  $2.1^{\circ}\text{C}$ -аар дулаарч, хур тунадасны хэмжээ 1965 оноос хойших хугацаанд ялимгүй өссөн хандлагатай байна. Дээр дурьдсанаас үзэхэд Баруун бүсэд манай орны бусад нутгийн адил уур амьсгалын дулаарал илт мэдэгдэж байна.

Бүсийн хэмжээгээр бүхэлд нь авч үзвэл сүүлийн 40 гаруй жилд агаарын жилийн дундаж температур  $1.64^{\circ}\text{C}$ -аар дулаарсан байдал ажиглагдаж байна.

Тэгэхдээ хүйтний улиралд илүү эрчимтэй буюу  $1.17^{\circ}\text{C}$ -аар, дулааны улиралд арай сул  $0.65^{\circ}\text{C}$ -аар дулаарсан байна. Уур амьсгал дулаарахын сацуу жилийн хур тунадас ялимгүй өсөх хандлагатай байгаа хэдий ч ууршуулах чадвар мөн нэмэгдэх тул бодит чийгийн хангамж өөрчлөгдөхгүй, харин ч цөлжих үйл явц өргөжих магадлал өндөр байгааг тэмдэглэх хэрэгтэй. Зарим судлаачдын урьдчилан тооцсоноор Баруун бүсийн уур амьсгалын дулаарал 2020 онд  $2.1^{\circ}\text{C}$ , 2050 онд  $3.5^{\circ}\text{C}$ -аар нэмэгдэх төлөвтэй байна.



НАРНЫ НИЙЛБЭР ЦАЦРАГ, жилээр

1:3,000,000



Агаарын температурын жилийн дундаж хэм /Диаграмм 1.1/

Хур тунадасны нийлбэр, тунадастай өдрийн тоо /Диаграмм 1.2/



**1.1.4 хөрс**

Баруун бүсэд өндөр уул нуруу, өргөн хотгор, хонхор зонхилох тул газрын хөрсний тархалт, нэгдүгээрт, уулын босоо бүсшилийн зүй тогтолд, хоёрдугаарт, Монгол оронд тод ажиглагдах хотгорын бүсшилийн зүй тогтолд захирагдана. Уул нуруудын байршил, үнэмлэхүй өндрөөс шалтгаалан уулын хөрсний босоо бүслүүрийн бүтэц газар газар өөр байна.

Монгол Алтайн нурууны баруун хойт хэсэгт 3000-3200м-ээс дээш үнэмлэхүй өндөрт уулын тундрын ухаа шороон хөрс, 2600-3000м өндөрт уулын ар хажуугаар өндөр уулын нугын бараан ба бор шороон, нугат-хээрийн нарийн ялзмагт хөрс, бусад хажуунуудаар өндөр уулын хүйтсэг толбот (дэгнүүлт) хээрийн бүдүүн ялзмагт өвөрмөц маягийн хөрс, түүнээс доош түвшинд уулын хуурай хээрийн хүрэн, уулын бэл хормойгоор цайвар хүрэн хөрс тус тус тархаж хөрсний босоо бүслүүрүүд үүсгэнэ. Уулын тайгын цэвдэгт ба ширэгт хөрс зөвхөн Хархираа-Түргэний уулсын ар хажуу болон Хотгон, Хоргон, Даян нуурын урд талын уулсын ар хажуугаар хэсэгхэн газар тархжээ.

Монгол Алтайн нурууны зүүн өмнөт хэсэг буюу Алаг-Хайрханаас зүүн тийшэх уулс цөлийн нөлөөгөөр үлэмж хуурай шинжтэй болж 3000м-ээс дээш өндөрт уулын нугын ба нугат-хээрийн хөрс алаг цоог тархаж, түүнээс доош өндөр уулын хүйтсэг хээрийн бүдүүн ялзмагт хөрс, хуурай хээрийн хүрэн, цайвар хүрэн, бэл хормойгоор нь заримдаг цөлийн бор хөрс тус тус дараалан тогтжээ. Алтайн чанадах уулст 2500-2600м-ээс дээших оройн хэсгээр нь хуурай хээрийн хүрэн, цайвар хүрэн, 2000-2500м өндөрт заримдаг цөлийн бор, 1800-2100м өндөрт цөлийн бор саарал хөрс тус тус тогтворжиж өндрийн бүслүүрүүд үүсгэдэг байна.

Хангайн нурууны баруун хойт хэсэгт 2500-2600м-ээс дээш өндөрт өндөр уулын нугын бараан, өндөр уулын нугын хүлрэнцэр хөрс тархаж түүнээс доош түвшинд уулын ар, өвөр хажуугийн хөрс эрс тэс ялгаатай болж ар хажууд нь дээрээс доошооноо уулын тайгын цэвдэгт, уулын тайгын ширэгт, уулын харшороон хөрсний бүслүүр дараалан оршино. Харин өвөр хажууд нь ой тайгын хөрс огт байхгүй, уулын хээрийн хар шороон, хар хүрэн хөрс дагнан тархжээ. Хан-Хөхийн нуруу Их Нууруудын хотгорын хуурайшлын нөлөөнд илүү автсан тул бэл хормойгоор нь хуурай хээрийн хүрэн, цайвар хүрэн хөрс дээшээ нилээд өгсөж тархсан байна.

Хөрсөн бүрхэвчийн тархалтад уул нуруудын хоорондох томоохон хотгоруудын хуурайшуулах нөлөө чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, Монгол орны төв хэсгийн талархаг нутагт хуурай хээрийн хүрэн хөрсний тархалтын хойт захын хил хойт өргөргийн 47°, цайвар хүрэн хөрснийх х.ө 46°-46°20', заримдаг цөлийн бор хөрснийх х.ө 45°20' -45°40', заримдаг цөлийн цайвар бор хөрснийх х.ө 44°20' -44°40', цөлийн бор саарал хөрсний хойт хил х.ө 44° орчмоор тус тус өнгөрдөг байтал Их Нууруудын хотгорт хүрэн хөрс х.ө 50°45', цайвар хүрэн хөрс х.ө 50°25', заримдаг цөлийн бор хөрс х.ө 50°20', заримдаг цөлийн цайвар бор хөрс х.ө 48°30', цөлийн бор саарал хөрс х.ө 46°20' хүртэл тус тус хойт зүг рүү гүн нэвтэрч орж тархсан байна.

Ийнхүү өмнөт өргөрөгт байрладаг хөрс хойт өргөргүүдэд гүн нэвтэрч тархсан нь хотгорын нөлөөтэй шууд холбоотой. Хотгоруудын төв хэсэгт эргэн тойрноосоо ямагт илүү хуурай, илүү халуун уур амьсгалтай байдаг тул тэрхүү төвийг тойрч бүсэлсэн хөрсний бүслүүрүүд үүсдэг ажээ. Ийм (хөрсөн бүрхэвчийн) хотгорын бүсшил Шаргын-Говийн хотгорт хамгийн сонгодог хэлбэрээр



илэрчээ. Тус хотгор баруунаас зүүн тийш 150-160км урт, хойноос урагшаа 70-80км өргөн, хотгорын төвд байрлах хамгийн нам газар далайн түвшнээс дээш 963м, эргэн тойрны уулсаар хүрээлэгдсэн хотгорын хаяа 1700-2100м үнэмлэхүй өндрийн шугамаар зааглагдана. Ийнхүү хотгорын төв ба захын хэсгийн хоорондох харьцах өндрийн зөрөө даруй 800-1100м хүрэх бөгөөд хотгор доторхи өндөршлийн энэ үлэмж өөрчлөлт нь хотгорын төвийг тойрсон хөрсний хэд хэдэн цагираган бүслүүр үүсэх нөхцөлийг бүрдүүлжээ. Тийнхүү хотгорын төв дэх хамгийн нам, хамгийн хуурай хэсэгт цөлийн бор саарал хөрс тогтворжиж, түүнийг тойрч хээржүү цөлийн цайвар бор, түүний гадуур цөлөрхөг хээрийн бор, хамгийн гадна талаар хуурай хээрийн цайвар хүрэн хөрс тус бүртээ 5-15км өргөн цагирган хэлбэртэй зурвасууд үүсгэн тархжээ.

Үүнээс харахад хотгорын төвөөс гадагшлах тутам хөрсний чийгийн хангамж аажмаар нэмэгдэж хүрээлэн буй уулсын хажуунуудад хээрийн хүрэн хөрстэй байна. Хөрсний хотгорын бүсшилийн ийм дүр зураг Увс нуурын, Ачит нуурын, Баруун Хуурайн, Их Нууруудын хотгор болон Алтайн Өвөр говийн хотгоруудад нэн түгээмэл шинжтэй юм. Тэгэхдээ хөрсөн бүрхэвчийн бүрдэл, цагирган бүслүүрийн тоо, хэлбэр дүрс харилцан адилгүй байна. Жишээ нь: Ачит нуурын хотгорт цөлөрхөг хээрийн бор, түүний гадна талаар цайвар хүрэн хөрстэй байдаг бол Увс нуурын хотгорт цөлөрхөг хээрийн бор, түүний гадуур цайвар хүрэн, хамгийн гадна талын харьцангуй өндөрлөг хэсгээр хүрэн хөрстэй байна.

Алтайн чанад дахь Баруун Хуурайн хотгорын төв хэсэгт хэт хуурай цөлийн борзон хөрс, түүнээс гадагшаа цөлийн бор саарал, хээржүү цөлийн цайвар бор, цөлөрхөг хээрийн бор хөрс тус тус зурваслан дугуйрч тогтсон байна. Алтайн Өвөр говийн хотгоруудад мөн хамгийн нам хэсгээр нь хэт гандуу цөлийн борзон хөрс, түүнээс дээшлэх тутам цөлийн бор саарал, хээржүү цөлийн цайвар бор хөрс дараалан байрлажээ.

Хотгоруудын хөрсөн бүрхэвчийн нэг онцлог бол нууртай байвал түүний эргэн тойронд нугын ба нугат - намгийн давсархаг хөрс тогтсон байдаг. Харин нууртай ч байсан, нуургүй ч байсан хотгоруудын төвд сул элсний хуримтлал их бага хэмжээгээр заавал үүссэн байдаг нь нэгдүгээрт, хотгорын төвд илүү хуурай байдгийн илэрхийлэл, хоёрдугаарт, тэнд хуйлпраа салхины үйл ажиллагаа нэн идэвхтэй байдгийн нотолгоо юм. Шороон шуурга үүсдэг үндсэн голомт газрууд хотгоруудын төв хэсэгт байдаг гэдгийг байнга санаж хөрсний өнгөн үе салхинд хийсч эвдрэхээс ямагт сэргийлж байвал зохино.

Монгол орны хөрс ашиглалтын 1:1000000 масштабтай зургийг үндэслэн Баруун бүс дэх 5 аймаг тус бүрийн хөрсний нөөц хэмжээг тодорхойлж, улмаар бүсийн хэмжээгээр нэгтгэн дүгнэх ажлыг хийв. Үүнээс үзэхэд Баруун бүсийн нийт нутаг дэвсгэрийн 41.47%-ийг (172.1мян.км<sup>2</sup>) уулын хөрс, 8.27%-ийг (34.3мян.км<sup>2</sup>) нам уул, ухаа толгодын хөрс, 47.79%-ийг (198.3мян.км<sup>2</sup>) тал хөндийн хөрс эзэлдэг байна. Хөрсний хэвшинжүүдээр авч үзвэл уул, толгод, талархаг нутгийн алинд нь ч хуурай хээрийн хүрэн хөрс давамгайлах (154.2мян.км<sup>2</sup>) бөгөөд тэр дундаа цайвар хүрэн (74.3мян.км<sup>2</sup>), жинхэнэ хүрэн хөрс (57.4мян.км<sup>2</sup>) хоёр голлож хархүрэн хөрс харьцангуй бага (22.5мян.км<sup>2</sup>) байна.

Ялангуяа хөндий хотгоруудаар хархүрэн хөрс бүр ч бага (4.6мян. км<sup>2</sup>) тохиолдоно. Харшороон хөрс зөвхөн Завхан, Увс аймгийн нутагт уулархаг нутгаар бага зэрэг (14.3мян. км<sup>2</sup>) байх бөгөөд тал хөндийд маш ховор ( 0.5мян. км<sup>2</sup>) үзэгдэнэ.

Заримдаг цөлийн бор хөрс ( 51.0мян. км<sup>2</sup>) бүх аймгуудад тохиолддог бол цөлийн бор саарал ( 38.6мян. км<sup>2</sup>), хэт хуурай цөлийн борзон ( 26.1мян. км<sup>2</sup>) хөрс зөвхөн Ховд, Говь-Алтай аймгийн нутагт бий. Хөндий хотгорын ёроол, нам дор газраар орших нуга-намгийн хөрс ( 2.3мян. км<sup>2</sup>), хужир, марз, мараа, шал тойром бүхий давсархаг хөрс (10.2мян. км<sup>2</sup>), голын татмын нугархаг хөрс (11.6мян. км<sup>2</sup>) бүх аймгуудад тархжээ.


Баруун бүсийн хөрсөн бүрхэвчийн онцлог бол нэгд, том том элсэн хуримтлал (14.7 мян. км<sup>2</sup>) элбэгтэй; хоёрт, зөвхөн Монгол Алтайн нуруунд тогтворжсон өндөр уулын дэгнүүлт хээрийн өвөрмөц маягийн бүдүүн ялзмагт хөрс (29.7мян.км<sup>2</sup>)-тэй.

Уулын тундрын хөрс ( 11.3мян. км<sup>2</sup>) Завханаас бусад аймагт, уулын ой-тайгын хөрс (10.2мян. км<sup>2</sup>) Ховдоос бусад аймагт, өндөр уулын нугын ба нугат-хээрийн хөрс ( 30.3мян. км<sup>2</sup>) бүх аймагт тархсан байна

# Хөрс

М 1: 1 500 000

Зураг 1.4



## Таних тэмдэг

- Аймгийн төв
- Улсын хил
- Аймгийн хил
- Тундрын хөрс
- Өндөр уулын хээрийн дэгнүүлт хөрс
- Өндөр уулын хээрийн бүдүүн ялзмагт
- Уулын хуурай хээрийн бүдүүн ялзмагт
- Уулын нугын хөрс
- Уулын нугын цэвдэгт хөрс
- Уулын-нугат хээрийн хөрс
- Цэвдэгт тайгын өнгөнөөсөө төмрийн исэлжилттэй
- Цэвдэгт-тайгын хөрс
- Чандруулаг хөрс
- Ширэгт тайгын гүндээ цэвдэгтэй хөрс
- Ширэгт тайгын чандруулаг гүндээ цэвдэгтэй хөрс
- Нунтаг карбонатлаг шайвар хурьт хөрс
- Нунтаг карбонатлаг маралаг шайвар хурьт хөрс
- Нунтаг карбонатлаг нилгэн шайвар хурьт хөрс
- Өнгөнөөсөө карбонатлаг хурьт хөрс
- Оян хөгжигтэй элсэн хурьт хөрс
- Нунтаг карбонатлаг нугат хурьт хөрс
- Нунтаг карбонатлаг хэрэмж нугат хурьт хөрс
- Мирамалг нугат хурьт хөрс
- Нунтаг давсарлаг хөрс
- Нунтаг карбонатлаг хар хурьт хөрс
- Уламсал карбонатлаг хар шороон хөрс
- Нунтаг карбонатлаг маралаг хурьт хөрс
- Нунтаг карбонатлаг ба карбонатгүй нилгэн шар хурьт хөрс
- Нунтаг карбонатлаг доод ямат нугатлаг шилжтэй хар хөрс
- Нунтаг карбонатлаг үршилт нугатлаг шилжтэй сар хурьт хөрс
- Нунтаг карбонатлаг хурьт хөрс
- Нунтаг карбонатлаг маралаг хурьт хөрс
- Нунтаг карбонатлаг нилгэн шар хөрс
- Нунтаг карбонатлаг үршилт нугатлаг шилжтэй үршилт хөрс
- Карбонатгүй хар шороон хөрс
- Нилсн карбонатлаг хар шороон хөрс
- Нилсн карбонатлаг нилгэн шар шороон хөрс
- Нилсн карбонатлаг доод ямат нугатлаг шилжтэй хар шороон хөрс
- Оулан хөгжигтэй нилсн шар шороон хөрс
- Гүн элсэлтийн эрэгт хар шороон хөрс
- Нунтаг доорлоон хөрс
- Нилсн давсарлаг гүндээ цэвдэгтэй хөрс
- Цөвөрлөг хээрийн бор хөрс
- Цөвөрлөг хээрийн маралаг бор хөрс
- Цөвөрлөг хээрийн нилгэн бор хөрс
- Цөвөрлөг хээрийн салбардүүссэн хучмал үетэй бор хөрс
- Цөвөрлөг хээрийн үршилт нугатлаг шилжтэй бор хөрс
- Хөрхүү шилжтэй бор хөрс
- Хөрхүү шилжтэй маралаг бор хөрс
- Хөрхүү шилжтэй нилгэн бор хөрс
- Сул хөгжигтэй элсэн бор хөрс
- Цэцгийн бор с арал хөрс
- Цэцгийн маралаг бор с арал хөрс
- Цэцгийн галт нилгэн бор с арал хөрс
- Цэцгийн нилгэн бор с арал хөрс
- Хот хуурай цэцгийн өнгөнөөсөө палтгоотой болсон хөрс
- Хот хуурай цэцгийн өнгөнөөстэй нилгэн бор хөрс
- Нугат бор хөрс
- Мирамалг нугат бор хөрс
- Шатрагуу хөрс
- Ууулан хэлбэрийн марал
- Нунтаг маралаг марал
- Хүснэгт хөрс
- Нугат нилгэн цэвдэгт хөрс
- Нугат нилгэн давсарлаг цэвдэгт хөрс
- Нугат нилгэн давсарлаг хөрс
- Нилгэн цэвдэгт хөрс
- Татман хөрс
- Сайран хөрс

Баруун бүсийн аймгуудын хөрсний нөөцийн нэгдсэн дүн / Хүснэгт 1.1 /

| Хөрсний нэр                                   | БАЯН-ӨЛГИЙ                                      |       | ХОВД            |       | УВС             |       | ЗАВХАН          |       | ГОВЬ-АЛТАЙ      |       | ДҮН             |        |       |
|---|---|-------|-----------------|-------|-----------------|-------|-----------------|-------|-----------------|-------|-----------------|--------|-------|
|   | км <sup>2</sup>                                 | %     | км <sup>2</sup> | %     | км <sup>2</sup> | %     | км <sup>2</sup> | %     | км <sup>2</sup> | %     | км <sup>2</sup> | %      |       |
| А   | 1   | 2     | 3               | 4     | 5               | 6     | 7               | 8     | 9               | 10    | 11              | 12     |       |
| <b>I. Уулын хөрс</b>                          |   |       |                 |       |                 |       |                 |       |                 |       |                 |        |       |
| 1   | Уулын тундрын                                   | 7720  | 16.78           | 1510  | 1,99            | 1830  | 2.65            |       |                 | 300   | 0.21            | 11360  | 2.74  |
| 2   | Өндөр уулын нугын ба нугат хээрийн              | 9450  | 20.54           | 5640  | 7.42            | 2560  | 3.71            | 10510 | 12.8            | 2110  | 1.49            | 30270  | 7.29  |
| 3   | Өндөр уулын хээрийн                             | 17200 | 37.39           | 8040  | 10.58           | 940   | 1.36            |       |                 | 3480  | 2.45            | 29660  | 7.15  |
| 4   | Уулын цэвдэгт тайгын, ширэгт тайгын, ойн бараан | 500   | 1.09            |       |                 | 1330  | 1.93            | 8350  | 10.2            | 60    | 0.04            | 10240  | 2.47  |
| 5   | Уулын хар шороон                                | -     |                 |       |                 | 1090  | 1.58            | 12380 | 15.1            |       |                 | 3470   | 3.25  |
| 6   | Уулын хар хүрэн                                 | 20    | 0.04            | 490   | 0.64            | 4650  | 6.74            | 9300  | 11.3            | 1810  | 1.27            | 16270  | 3.92  |
| 7   | Уулын хүрэн                                     | 1700  | 3.70            | 8240  | 10.84           | 9110  | 13.20           | 5220  | 6.37            | 9350  | 6.58            | 33620  | 8.10  |
| 8   | Уулын цайвар хүрэн                              | 210   | 0.46            | 5290  | 6.96            | 1110  | 1.61            | 210   | 0.26            | 10230 | 7.20            | 17050  | 4.11  |
| 9   | Уулын цөлөрхөг хээрийн бор                      | -     |                 | 2040  | 2.68            |       |                 |       |                 | 5620  | 3.96            | 7660   | 1.85  |
| 10  | Уулын цөлийн бор саарал                         |       |                 | 730   | 0.96            |       |                 |       |                 | 1780  | 1.25            | 2510   | 0.60  |
| ДҮН   |   | 36800 | 80.0            | 31980 | 42.08           | 22620 | 32.78           | 45970 | 56.1            | 34740 | 24.46           | 172110 | 41.47 |
| <b>II. Ухаа, гүвээ, нам уул толгодын хөрс</b> |   |       |                 |       |                 |       |                 |       |                 |       |                 |        |       |
| 11  | Хар шороон                                      | -     |                 |       |                 | 300   | 0.43            | 530   | 0.65            |       |                 | 830    | 0.20  |
| 12  | Хар хүрэн                                       | -     |                 |       |                 | 550   | 0.80            | 1050  | 1.28            |       |                 | 1600   | 0.39  |
| 13  | Хүрэн   | 370   | 0.80            | 760   | 1.00            | 1580  | 2.29            | 3490  | 4.26            | 630   | 0.44            | 6830   | 1.65  |
| 14  | Цайвар хүрэн                                    | 70    | 0.15            | 1970  | 2.59            | 2560  | 3.71            | 750   | 0.91            | 2660  | 1.87            | 8010   | 1.93  |
| 15  | Цөлөрхөг хээрийн бор                            | 80    | 0.17            | 1310  | 1.72            | 340   | 0.49            | 140   | 0.17            | 1940  | 1.37            | 3810   | 0.92  |
| 16  | Цөлийн бор саарал                               | -     |                 | 2820  | 3.71            |       |                 |       |                 | 10820 | 7.62            | 13640  | 3.29  |
| ДҮН   |   | 520   | 1.13            | 6860  | 9.03            | 5330  | 7.72            | 5960  | 7.27            | 15650 | 11.02           | 34320  | 8.27  |
| <b>III. Тал хөндийн хөрс</b>                  |   |       |                 |       |                 |       |                 |       |                 |       |                 |        |       |
| 17  | Хар шороон ба нугат хар шороон                  | -     |                 |       |                 | 370   | 0.54            | 140   | 0.17            |       |                 | 510    | 0.12  |
| 18  | Хар хүрэн                                       | 40    | 0.09            | 50    | 0.07            | 90    | 0.13            | 4400  | 5.37            | 30    | 0.02            | 4610   | 1.11  |
| 19  | Хүрэн   | 2040  | 4.43            | 2160  | 2.84            | 7050  | 10.22           | 4130  | 5.04            | 1590  | 1.12            | 16970  | 4.09  |
| 20  | Цайвар хүрэн                                    | 2830  | 6.15            | 6360  | 8.37            | 12700 | 18.41           | 7890  | 9.62            | 19410 | 13.67           | 49190  | 11.85 |
| 21  | Цөлөрхөг хээрийн бор                            | 20    | 0.04            | 12630 | 16.62           | 5650  | 8.19            | 2610  | 3.18            | 18670 | 13.15           | 39580  | 9.54  |
| 22  | Цөлийн бор саарал                               |       |                 | 2760  | 3.63            | 100   | 0.14            |       |                 | 19610 | 13.81           | 22470  | 5.41  |
| 23  | Хэт хуурай цөлийн борзон                        | -     |                 | 3620  | 4.76            |       |                 |       |                 | 22440 | 15.80           | 26060  | 6.28  |
| 24  | Нугын ба нугат намгийн цэвдэг                   | 580   | 1.26            | 10    | 0.01            | 410   | 0.59            | 1280  | 1.56            | 20    | 0.01            | 2300   | 0.55  |
| 25  | Хужир, марз, мараа, шал                         | 260   | 0.57            | 3250  | 4.28            | 1920  | 2.78            | 240   | 0.29            | 4580  | 3.23            | 10250  | 2.47  |

|                          |                            |       |       |       |       |       |       |       |       |        |       |        |       |
|--------------------------|----------------------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|--------|-------|--------|-------|
| 26                       | Элс                        | -     |       | 500   | 0.66  | 3720  | 5.39  | 6780  | 8.27  | 3730   | 2.63  | 14730  | 3.55  |
| 27                       | Голын татмын нугат намгийн | 2040  | 4.43  | 2720  | 3.58  | 3460  | 5.01  | 1970  | 2.40  | 1450   | 1.02  | 11640  | 2.80  |
| ДҮН                      |                            | 7810  | 16.98 | 34060 | 44.82 | 35470 | 51.41 | 29440 | 35.90 | 91530  | 64.46 | 198310 | 47.79 |
| 28                       | Нуурын усны талбай         | 870   | 1.89  | 3100  | 4.08  | 5580  | 8.09  | 630   | 0.77  | 80     | 0.06  | 10260  | 2.47  |
| <b>БАРУУН БҮСИЙН ДҮН</b> |                            | 46000 | 100.0 | 76000 | 100.0 | 69000 | 100.0 | 82000 | 100.0 | 142000 | 100.0 | 415000 | 100.0 |

Хөрсний нөөцийг бүхэлд нь дүгнэж үзвэл Баруун бүсийн нийт нутгийн 37.15%-ийг хуурай хээрийн хүрэн хөрс (хархүрэн-5.42%, жинхэнэ хүрэн-13.84%, цайвар хүрэн-17.89%), 12.31%-ийг заримдаг цөлийн бор хөрс, 9.30%-ийг цөлийн бор саарал хөрс, 6.28%-ийг хэт хуурай цөлийн борзон хөрс, 3.57%-ийг харшороон хөрс, 2.47%-ийг уулын ой-тайгын хөрс, 7.15%-ийг өндөр уулын дэгнүүлт хээрийн хөрс, 7.29%-ийг өндөр уулын нугын ба нугат-хээрийн хөрс, 2.74%-ийг уулын тундрын хөрс, мөнх цас, мөсөн голын хамт, 0.55%-ийг нуга намгийн хөрс, 2.47%-ийг хужир, марз, мараа, шал тойром бүхий давсархаг хөрс, 3.55%-ийг элс тус тус эзэлнэ. Эдгээрээс бараг 75 хувь нь малын бэлчээрт ашиглагдах бөгөөд зөвхөн голын татам, нуур усны эрэг хөвөө орчмын нуга, намгийн чийглэг хөрстэй газраас бага боловч хадлан авах боломж бий. Хадлангийн талбайг усжуулах, бордох, цас тогтоох зэргээр өвсний гарцыг нэмэгдүүлэх аргыг өргөн хэрэглэх нь чухал. Үүнийг хажуугаар нь зун, намрын цагт бог малыг бэлчээрт нь өнжөөж хээр хөдөө хотлуулах маягаар хадлан, тариалангийн талбайг бордож сайжруулдаг арга байдгийг ч туршиж нэвтрүүлэх хэрэгтэй.

Баруун бүсэд эртнээс нааш гар усалгаатай ардын уламжлалт тариалан үе дамжин хөгжиж ирсэн түүхтэй. Энэ нутгийн голууд ихэнхдээ өндөр уулын мөнх цас, мөсөн голоос эх авч тэжээгддэг учраас дулаан улирлын туршид ус арвинтай, урсац ихтэй байдаг нь голын хөндий дагуу усалгаатай тариалан эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлдэг ажээ.

Ховд, Буянт, Хархираа, Булган, Бодонч, Үенч, Цэнхэрийн голын дагуух усалгаатай тариалангийн газрууд үүнийг гэрчилнэ. Нөгөөтэйгүүр эдгээр голын хөдийд +10°C-аас дээш агаарын хоногийн дундаж температурын нийлбэр жилд -2000-2600°, таримал ургамлын ургах хугацаа 115-150 өдөр байдаг нь дулааны хангамж хүрэлцээтэйг нотолж буй үзүүлэлт юм.

Ийм уур амьсгалтай нөхцөлд усалгаатай талбайгаас дунд ба эрт болцтой таримлын тогтвортой ургац авах боломж бий. Гагцхүү агротехнологийн горимыг чанд сахиж тариалангийн соёлыг өндөр байлгах хэрэгтэй.


Баруун бүсэд 1990-ээд оны үед нийтдээ 164.7мян.га тариалангийн талбайтай байсан бол 2001 онд 120.7мян.га болж тариалангийн талбайн хэмжээ 44мян.га-гаар багасчээ. Түүгээр ч барахгүй одоо байгаа талбайнхаа дөнгөж 26.9 хувьд нь тариалж бусдыг нь (88,3мян.га талбайг) атаршуулж орхисон байна.

Тариалангийн талбайн ихэнх нь Завхан (63.2мян.га), Увс (45.4мян.га) хоёр аймагт байдаг бөгөөд өнөөгийн байдлаар эдгээр талбайн 76-79% нь атаршжээ. 1994 онд явуулсан хөрсний эвдрэлийн судалгаагаар энэ 2 аймагт дунд зэрэг болон хүчтэй эвдэрсэн тариалангийн талбай 9.3мян.га гэж тогтоожээ. Үүнийг эргэлтээс хасна гэж үзвэл энэ бүсэд одоо 100-110 мян.га талбайг тариаланд ашиглах нөөц байна. Өөрөөр хэлбэл одоогийн тариалснаас (32.4мян.га) гурав дахин их талбайд тариалах боломж байгаа аж. Ялангуяа Завхан, Увс, Баян-Өлгий аймагт тариалангийн эдэлбэр газрын ашиглалт маш доогуур түвшинд байна.

Тухайн бүс нутагт газар тариалангийн үйлдвэрллийг өмнөх үеийн түвшинд, түүнээс ч өргөн хэмжээтэй хөгжүүлэх хөрсний нөөц хангалттай бий. Одоогийн тариаланд ашиглаж байгаа талбай гол төлөв хархүрэн, нугархаг хүрэн, нугын хөрстэй. Харин усалгаатай тариаланд голын татмын нугархаг хөрс, цайвар хүрэн, цөлөрхөг хээрийн бор, нугат-бор, нугын давсархаг хөрс нилээд хэмжээгээр ашиглагддаг.

УЛААН НОМОНД ОРСОН УРГАМАЛЫН ТАРХАЦ

Зураг



### 1.1.5 Ургамал

Баруун бүсийн ургамалжилт, ургамлан нөмрөгийн төлөв байдал мөн л уулын босоо бүшил болон хотгорын бүшилийн зүй тогтлыг дагана. Монгол Алтай, Сийлхэм, Хархираа-Түргэний уулын ноёлох оргилуудаар хаг, хаг-хөвд, улалж-хөвдөт өндөр уулын тундр, түүнээс арай доор түвшинд хүйтсэг-чулуусаг бүлгэмдэлтэй хосолсон өндөр уулын бушилзат ба улалжит нуга, түүнээс доош бушилзат, улалжит бүлгэмдэлтэй хосолсон дэгнүүлэн алаг өвс-ботуульт өндөр уулын өвөрмөц маягийн толбот хээр тус тус тархжээ.

Монгол Алтайн нурууны зүүн өмнөт хэсэг- Алаг Хайрханаас зүүн тийшэх уулсын оройгоор тундрын ургамалшил үзэгдэхээ больж бушилзат ба улалжит өндөр уулын нугаас гадна бушилз бүхий хүйтсэг-чулуусаг алаг өвс-ботууль-ерхөгт өндөр уулын хээр нэлээд нийтлэг шинжтэй болж ирнэ.



Монгол Алтайн нурууны захаар байрлах дундаж өндөр уулст чулуусаг алаг өвс бүхий ерхөгт ба ерхөг-ботуульт хуурай хээрийн ургамалшил нэн түгээмэл юм. Монгол Алтайд ойн ургамалшил ховор, зөвхөн Хархираа-Түргэний уулсын ар хажуу болон Хотон, Хоргон, Даян нуур орчмын уулст алаг өвс, улалж, ботууль, бушилз бүхий хөвдөт шинэсэн ой хэсэг хэсэгхэн газар ургаж, заримдаа хуш, гацуур мэр сэр тааралдана.

Монгол Алтайн голуудын өргөндүү хөндий болон уулсын хоорондох хотгоруудад баглуур, тэсэг, заримдаа бунгийн харгана бүхий сайрын хялганат цөлөрхөг хээр давамгайлна.

Хангайн нурууны баруун хойт хэсгийн ургамалшил Монгол Алтайнхаас эрс ялгаатай. Тэндхийн уул нуруудын оройгоор хүйтсэг-чулуусаг бүлгэмдэл бүхий бушилзат, улалжит өндөр уулын нуга, сөөг-сөөгөнгөрт намгархаг нуга голлож, уулын ар хажуу нилдээ ойн ургамлаар бүрхэгдсэн байна.

Тэгэхдээ уул нуруудын ар хажуугийн дээд биеэр боролж, ботууль, бушилз бүхий хөвдөт шинэсэн ба хуш-шинэсэн ой голлож ургадаг бол доод талаар нь алаг өвс, алирс, улалж бүхий ритидиум хөвдөт шинэсэн ой ихээхэн дэлгэрчээ. Уул нуруудын өвөр хажуу болон ой модгүй бусад хажуунуудаар алаг өвс- жижиг бутлаг үетэн-ботуульт, алаг өвс-жижиг бутлаг үетэнт, сөөгөн ширэнгэ (чаргай, тошлой) бүхий үетэн-улалж-ботуульт хээр түгээмэл тархжээ.



Хан-Хөхийн нурууны ар хажууд алаг өвс, сорвоо бүхий ногоон хөвдөт шинэсэн ба хуш-шинэсэн ой, түүнээс арай доогуур түвшинд улалж-алаг өвст шинэсэн ой нэлээд талбайг хамарч, бусад хажуугаар нь баялаг алаг өвс-улалж-бутнуурт, алаг өвс- бутнуурт, сөөгт, чулуусаг алаг өвс-үетэнт болон алаг өвс-жигжиг бутлаг үетэн-ботуульт хээр үргэлжилнэ. Хангайн баруун хэсгийн дундаж өндөр ба нам уулсаар алаг өвс-жигжиг бутлаг үетэн-ботуульт, алаг өвс-дааган сүүлт хээр, тэдгээрийн хоорондох хөндий хотгорт харгана бүхий шарилж-үетэн-хялганат, элссэг алаг өвс ба харгана бүхий жигжиг бутлаг үетэн-хялганат, хазаар өвст, чулуусаг алаг өвс-үетэнт хуурай хээр нийтлэг байдалтай юм.

Увс нуурын хотгорын төв хэсэгт үетэн-таарт, элссэг ба хэт элссэг алаг өвс бүхий үетэн-сайрын хялганат, харганат, шарилжит цөлжүү хээр зонхилж, түүний гадна талаар ботууль-хялганат, харгана бүхий агь-ерхөг-хялганат, элссэг алаг өвст, шарилжит, үетэнт, харганат, хэт элссэг алаг өвс бүхий жигжиг бутлаг үетэн-хялганат, хазаар өвст болон чулуусаг алаг өвс-хялганат (баруун талын нам уулсаар) хуурай хээрийн ургамалшил хүрээлэн тархжээ. Хархираа, Түргэний голын адаг Увс нуурын баруун урд эрэг орчмоор давссаг алаг өвс-үетэнт ба улалжит нуга, Увс нуурын зүүн хойт эрэг Тэс голын адаг орчмоор бургас, улиасан сөөг бүхий үетэнт-алаг өвст нуга бий.

Тэс голын татам дагуу сөөг, улалжит нуга, гацууран ой байдаг бол Идэр голын хөндийд шинэсэн ой бүхий сөөг, улалжит намгархаг нуга, үетэн-алаг өвст нуга элбэг тохиолдоно. Ховд, Бөхмөрөн голын хөндийд мөн бургасан сөөг, үетэн-алаг өвст, алаг өвс-үетэнт нугатай. Хар-Ус нуурын хойт урд эрэг дагуу зэгс шагшуурга, давссаг алаг өвст ба үетэнт бүлгэмдэл бүхий нугархаг газар бий. Завхан голын хөндийн Тайшир орчмын тохойрсон хэсэгт бургас бүхий давссаг алаг өвст, үетэнт ба улалжит нуга үүсчээ.

Их нууруудын хотгорын хамгийн нам, төв хэсгээр элссэг алаг өвс бүхий хялгана-шарилжит, азар бүхий элссэг үетэнт, шарилжит (бөнгөр шарилж, бөндгөр шарилж), тэсэгт, сайрын хялгана-баглуурт, давсархаг хөрстэй газраар улаан бударгана-баглуурт, толгодорхог газраар чулуусаг алаг өвс-сайрын хялгана-баглуурт, чулуусаг ургамал бүхий үетэн-заримдаг сөөгөнцөрт цөлийн ургамалшил давамгайлдаг бол түний гадна талаар хотгорын зах руу элссэг үетэнт, заримдаг сөөгөнцөрт (сөөгөн шимэрс), шарилжит (бор шаваг, бөндгөр шарилж), бунгийн харганат, толгодорхог газраар чулуусаг ургамал бүхий заримдаг сөөгөнцөр-сайрын хялганат ба ерхөгт, харгана-сайрын хялганат, баглуур-сайрын хялганат, элссэг ургамал бүхий сайрын хялганат хээржүү цөл зонхилно. Түүний гадуур Их Нууруудын хотгорын зүүн, баруун, хойт урд захын хаяа уулс, толгодорхог болон талархаг газраар тэсэг, харгана бүхий үетэн-сайрын хялганат, сайрын хялгана-хазаар өвст, элссэг алаг өвст-үетэнт, чулуусаг алаг өвс-үетэнт, агь-үетэнт, хазаар өвс-хялганат цөлжүү хээрийн ургамалшил голлон тархжээ.

Шаргын Говийн хотгорын төв хэсэгт баглуурт цөл нилээд их талбайг хамарч, түүнийг хүрээлэн хээржүү цөлийн ба цөлжүү хээрийн бүслүүр давхарлан тогтжээ. Зэргийн хоолой, Цагаан нуур (Ховдын Дарви), Цэцэг нуур, Ихэс нуур (Говь-Алтайн Дарви), Хүйсийн Говь, Шаргын Говь, Бигэр нуурын хотгор, Их Нууруудын хотгорын зүүнтээх Цагаан-Тахилт нуурын хоолой зэрэг хужир, марзтай хонхруудаар дэрст, бадарганат, улаан бударганат давссаг бүлгэмдэл элбэг тааралдана.

Алтайн цаадах Баруун Хуурайн хотгорын төв хэсэг болон Алтайн Өвөр говийн өмнөт хэсгээр зөвхөн сайр дагасан заг, зээргэнэ, баглуур, будраа, хотирт бүлгэмдэл бүхий сайр хоорондын хэт хуурай чулуурхаг цөл нэн түгээмэл бөгөөд Баруун Хуурайн хотгорын захаар цагаан шарилж-загт, цагаан шарилж-улаан бударгана-тэсэгт, баглуурт, бэсрэг ба давжаа загт, сайрын хялгана-таарт жинхэнэ цөл багагүй талбайг эзэлнэ. Алтайн Өвөр говийн хойт хэсэг, Аж Богд, Эдрэнгийн нуруу орчмын хотгор хонхруудаар баглуурт, бэсрэг ба давжаа загт, зээргэнэт, шар модот цөл зонхилж Алтайн нурууны урд бэл хормойгоор тэсэгт, харгана бүхий агь-хиагт цөлжүү хээр, харгана-тэсэг-сайрын хялганат, баглуур-таана-говийн хялганат, чулуусаг алаг өвс-баглуур-говийн хялганат хээржүү цөлийн ургамалшил тус тус нарийвтар бүслүүр үүсгэн тархжээ. Мөн нугархаг шинжтэй хужирлаг хонхруудын ёроолд бадарганат бүлгэмдэл, улаан бударгана бүхий заг, сухай, зэгс, тооройн тармаг төгөл хаяа тохиолдоно.

Баруун бүсэд тухайн нутгийн уугуул гаралтай унаган ургамал хэд хэд бий. Жишээ нь: Монгол Алтайн нуруунд дэгнүүлт ажигана, Монгол Алтайн захын уулс болон Их Нууруудын хотгор иконниковын гичгэнэ, Бор Хярын элс, Монгол элс, Увсын хотгорт үсхий суль, Хасагт-Хайрхан ба Бурхан Буудай ууланд хэврэг навчит ортууз, Хасагт Хайрхан, Хан Тайширын нуруунд бунгийн ортууз, Хяргас нуурын хотгорын зүүн хэсгээр бунгийн цахилдаг, Алтай чанадахь Баруун Хуурайн хотгорт говийн хунчир, Тэс голын хөндийд хоёр цэцэгт ортууз гэх мэт ургамлыг нэрлэж болно. Түгээмэл хэрэглэгддэг эмийн ургамлуудаас урал чихэр өвс (Увсын хотгорын баруун, Их Нууруудын хотгорын төв хэсэг болон Булган, Бодонч, Үенч голын адгаар), өргөст сарнай (Хархираа, Баатар-



Хайрхан, Хан-Хөхийн нуруу болон Увс нуурын баруун хойт талын нам уулс, Цээл-Бурхан Буудай, Хангайн баруун хэсгийн уулсаар), ягаан цээнэ (Хан-Хөхий, Тарвагатай нурууны ар хажуугаар), юлдэн тарваган шийр (Тэс голын эхэн, Тэлмэн, Сонгино орчмын хөндий хотгор, Хан Тайширын нурууны ар хажуугаар), говийн ганга (Хан-Хөхий, Хан-Тайширын нурууны ар, Яруу, Ширээ, Борх (Шураг) голын бэлчир орчмоор), үнэгэн сүүлхэй лидэр (Үенч голын адгаар) тус тус тааралдана. Зэрлэг жимсгэнээс Тарвагатай, Булнайн нурууны арын ойд алирс, нэрс элбэг ургахаас гадна Хан-Хөхийн нуруунд алирс, үхрийн нүд, Тэс, Ховд, Булган голын хөндийн эхэн хэсгээр улаалзгана, Монгол Алтай, Хархираа, Түргэний уулст үхрийн нүд, тошлой, хад, Хангайн баруун хойт захын уулсаар тошлой бага сага бий.

Баруун бүс дэх өндөр уулын тундр, хад асга, чулуун нуранги, мөнх цас, мөсөн гол, Алтайн өвөр говийн чулуурхаг цөлөөс бусад бүх нутаг малын бэлчээрт өргөн ашиглагддаг. Өндөр уулын нуга, хээр, ой, голын татам, нуурын хөвөө орчмын бэлчээрийг зун-намрын улиралд, дундаж өндөр ба нам уул, талархаг газрын хуурай хээр, заримдаг цөлийн ургамалшил бүхий бэлчээрийг жилийн дөрвөн улиралд, цөл нутгийн ба элсний бэлчээрийг өвөл-хаврын улиралд ашиглахад илүү тохиромжтой. Бэлчээр талхлагдах, ургамлын нь зүйлийн бүрэлдхүүнд ашиг шим багатай зүйлийн оролцоо нэмэгдэх, нэлэнхийдээ бэлчээр доройтох явдал сүүлийн жилүүдэд идэвхжиж газар сайгүй ажиглагдах боллоо.

Зарим судалгааны дүнгээс үзэхэд уулархаг нутгийн ургамлан нөмрөгийн 25%-нь хүчтэй, 50%-нь дунд зэрэг, талархаг хээрийн ба заримдаг цөлийн ургамлан нөмрөгийн 60% гаруй нь хүчтэй ба дунд зэрэг хэмжээнд талхлагдаж, бэлчээрийн доройтол үнэхээр хямралын түвшинд хүрээд байна. Ялангуяа худаг, булаг шанд, уст цэгийн ойролцоо, гол, нуурын эрэг хөвөө орчимд, төв суурин газрын эргэн тойронд, мөн авто замын дагууд бэлчээрийн ургамлын талхагдал, хөрсний эвдрэл нэн хүчтэй илэрч буй нь анхаарал татахгүй байхын аргагүй юм.

### 1.1.6 Ан амьтан

Баруун бүсийн амьтны аймгийн тухай товч тодорхойлотыг өгөхдөө хөхтөн, шувуу, загас, хоёр нутагтан ба мөлхөгчид гэсэн нийтлэг анги бүлгүүдээр авч үзэх нь зүйтэй байх. Хөхтөн амьтдыг өндөр уулын, ойн, хээрийн, цөлийн гэсэн 4 гол бүлгэмдэлд хуваадаг. Өндөр уулын хөхтний бүлгэмдлээс Монгол Алтай, Хархираа-Түргэний уулст оготно, огдой зонхилохын хамт тагийн огдой, монгол тарвага, хадны барагчин, янгир ямаа, аргаль хонь элбэг байх ба харин Хангайн баруун хэсгийн өндөр уулст өөдсөн атаахай, цармын атаахай, тагийн огдой, хадны барагчин, саяаны барагчин, янгир элбэг үзэгдэнэ. Ойн хөхтөн Хангайн нурууны ой тайгад өргөн тархалттай бөгөөд түүний дотор дааган атаахай, өөдсөн атаахай, цармын атаахай, жирх, ойн хүрэн оготно, мэхээрч огтоно, бор гөрөөс голлох суурийг эзэлж асганы огдой, бэсрэг атаахай, тавшгар атаахай, ойн солонго, шилүүс, марал буга цөөн тохиолдоно.

Монгол Алтайн нурууны хэсэг хэсэг ойд дээрх амьтдаас гадна ойн булга, Хотон нуурын эх – Цагаан Усны гол, мөн Сагсай голын эх орчмын ойд хүрэн баавгай цөөн тааралдана. Монгол Алтайн нурууны баруун хойт хэсгийн уулст алтайн тарвага, монгол огдой, дагуур огдой, урт сүүлт зурам, хэргэлзэй оготно, цагаан үен мэтийн хээрийн хөхтөн амьтад харьцангуй элбэг, харин монгол тарвага, орог зусаг, хярс цөөвтөр байна. Монгол Алтайн нурууны бусад уулс болон Хархираа-Түргэн, Хасагт-Хайрхан, Хан-Тайшир, Жаргалант-Бумбат Хайрхан, Дарвийн нуруунд монгол тарваганы тоо элбэгшихээс гадна сахалт багваахай, монгол чичүүл цөөн боловч тохиолдоно. Хангайн нурууны баруун хойт хэсгийн дундаж өндөр уулс, Тэс, Идэр голын хөндий, Ойгон, Тэлмэн нуурын хотгор орчмын нутгаар хээрийн хөхтөн: дагуур огдой, монгол тарвага, орог зусаг, дорнодын шишүүхэй, дагуурын сохор номин, хэргэлзэй оготно, үлийн цагаан оготно, монгол чичүүл, хярс нилээд байхаас гадна сахалт багваахай, дагуур зурам цөөн үзэгдэнэ.

Тэндээс урагшаа Хангайн нурууны баруун талын уулс болон уул хоорондын хөндий, хотгоруудад дээрх хөхтөн амьтдын ихэнх нь байх боловч дагуур зурам, дорнодын шишүүхэй, дагуур сохор номин, өндөр уулсаар үлийн цагаан огтоно үзэгдэхээ больж харин монгол огдой, урт сүүлт зурам, өндөр уулсаар цагаан үен шинээр нэмэгдэж цөөнгүй тархжээ. Увс, Ачит нуурын хонхор, Их Нууруудын хотгор, Шаргын Говь, Бигэрийн хотгор болон Алтайн чанадахь нийт нутгаар цөлийн хөхтөн амьтад түгээмэл юм. Тэдгээрээс бозлог зурам, орог зусаг, монгол чичүүл, сибирийн алагдаага, савгадаахай мэтийн жижиг мэрэгчид голлох үүрэгтэйгээс гадна элсний зусаг, шар чичүүл, говийн алагдаага, атигдаахай, янгир ямаа цөөвтөр үзэгдэнэ. Их Нууруудын хотгорын зүүн хагасын элсэн (Бөөрөг-Дэл, Бор-Хяр, Монгол Элс) тарамцагуудаар дээрх амьтадын зарим нь (бозлог, говийн алагдаага, атигдаахай, янгир) үл тохиолдоно. Шаргын говийн хотгорт монгол чичүүл, шар чичүүл, морин чичүүл, алтайн өврийн алагдаага, савгадаахай харьцангуй элбэг, харин бозлог зурам, элсний зусаг, сибирийн алагдаага, говийн алагдаага, атигдаахай, өөхөн сүүлт атигдаахай ховор тохиолдоно. Баруун-Хуурайн хотгорт дээрх амьтдаас бозлог, говийн алагдаага,

алтайн өврийн алагдаага гурваас бусад нь бий бөгөөд харин төвд туулай энд нэлээн байна. Гэтэл Алтайн Өвөр говьд элсний зусаг, бор шишүүхэй, шар чичүүл, морин чичүүл, сибирийн алагдаага, алтайн өврийн алагдаага, савгадаахай, атигдаахай, өөхөн сүүлт атигдаахай, төвд туулай нэлээн элбэг байх ба тэдгээрээс бусад цөлийн хөхтөн үл үзэгдэнэ. Харин тэндхийн уул толгодоор янгир ямаа цөөнгүй бэлчээрлэнэ. Заримдаг цөлийн ба цөлийн бүс дэх ус орчмын чийглэгдүү газраар дэлдэн зараа, хонин малтаахай, түвд туулай, бор шишүүхэй, чийгч оготно, сухайн чичүүл, гэрий хулгана мэтийн жижиг хөхтөн элбэгшинэ.

Зэрлэг туурайтан амьтдаас Хангайн нурууны баруун хойт ба баруун хэсгийн ой тайга, Хархираа-Түргэн, Монгол Алтайн ой бүхий газраар марал буга, сибирийн бор гөрөөс, Увс нуур, Их Нууруудын хотгорын төв хэсэг болон Хангайн нурууны баруун хойт хэсэг Тэс, Идэр голын савд зэрлэг гахай, Монгол Алтайн нуруу, түүний салбар уул болон Хангайн уулт өндөрлөгийн баруун хэсгээр аргаль, янгир, Их Нууруудын хотгор, Алтайн чанадахь говьд хар сүүлт зээр нэлээд элбэг тархжээ. Махан идэшт агнуурын том амьтдаас үнэг, чоно, хярс, мануул бараг газар сайгүй байхаас гадна өндөр ууланд шилүүс, ойд нохой зээх цөөнгүй бий. Махан идэшт агнуурын жижиг амьтдаас өмхий хүрэн бараг газар сайгүй тааралдах ба Монгол Алтайн уулс, Хангайн уулт өндөрлөгийн баруун захгаар хадны суусар, Монгол Алтайн гол нуруу, Хархираа-Түргэний уулс, Хангайн уулт өндөрлөгийн баруун хойт хэсгээр цагаан үен, Увс нуур, Их Нууруудын хотгорын төв хэсгээр солонго, Идэр, Тэс голын сав нутгийн ой бүхий газраар ойн солонго тус тус тархжээ. Агнуурын мэрэгчид ба туулай хэлбэртнээс Монгол Алтайн баруун хойт хэсэгт алтайн тарвага, бусад уулархаг нутгаар монгол тарвага, урт сүүлт зурам, Их Нууруудын хотгор, Ачит нуур, Шаргын говь, Бигэрийн хотгорт бозлог, Алтайн цаадах говь, цөлд түвд туулай, түүнээс бусад нутгаар бор туулай, Завхан голын адаг, Ачит нуур, Ховд гол, Хар-Ус, Хар, Увс нуурын эрэг хөвөө орчмоор ондоотор цөөнгүй тохиолдоно.

Ховор хөхтөн амьтдаас Монгол Алтайн нурууны захын уулс, Хархираа-Түргэн, Хангайн нурууны ноёлох өндөрлөгөөр ирвэс, Алтайн чанадахь говь цөл нутагт хулан, хавтгай, цөөвөр чоно, мазаалай, козловын атигдаахай, Шаргын говийн хотгор, Хар-Ус нуурын орчим бөхөн гөрөөс, Ховд, Булган голын адагт голын минж, Даян нуур, Сагсай голын эхээр халиу, Булган голын адагт ойн унтаахай тус тус байдаг.

Монгол оронд нийтдээ 130 орчим зүйлийн хөхтөн амьтад байдгаас Баруун бүсэд оршдог 90 орчим зүйл амьтадын талаар бид дээр товч өгүүлэв. Харин манай оронд 450 гаруй зүйлийн жигүүртэн шувууд байнга ба түр хугацаагаар амьдардаг бөгөөд тэдгээрийн дийлэнх олонхи нь Баруун бүсэд бий. Эхлээд агнуурын шувуу, ховор шувуудын тухай, дараа нь түгээмэл тархалттай бусад шувуудын талаар товч дурьдая.

Агнуурын шувуудаас уулархаг нутагт дагуурын ятуу, ноёлох өндөр оргилуудаар цагаан ятуу, цэвдгийн цагаан ятуу, Монгол Алтайн нуруу болон түүний салбар уулсаар хахилаг, Хангайн уулт өндөрлөгийн баруун, баруун хойт хэсгийн дундаж өндөр уулст хур, нургийн сойр, Их Нууруудын хотгор, Алтайн чанадахь Баруун-Хуурайн хотгор, Алтайн өврийн говь цөл нутагт ногтруу шувуу голлох суурийг эзэлнэ. Баруун бүсэд Монголд байдаг бараг бүх ховор шувууд бий. Тухайлбал, Монгол Алтайн уулс болон Тарвагатай, Булнайн нурууны оройд алтайн хойлог, Их Нууруудын хотгорын зүүн хэсэг, Завхан голын хөндийд козловын хайруулдай, Тэс голын хөндий, Хан-Хөхийн нурууны ар, Увс нуурын зүүнтэйх Нарийн голын хөндий, Завхан голын хөндийн дунд ба эхэн хэсэг, Хар-Ус нуурын урд талаар тоодог, Хяргас нуураас баруун хойших болон Хар-Ус, Хар нуурын хоорондох талархаг газар, Ховд голын хөндийн Алтан-Хөхийн уулын өмнөх хэсэг, Булган, Үенч, Бодонч голын адаг орчим болон Эдрэнгийн нурууны арын хөндийд жороо тоодог, Увс нуурын зүүн ба хойт эргээр халбаган хушуут, хошуу галуу, ямаан сүүлт нугас, хээрийн галуу, гангар хун, Үүрэг нуурын хотгорт хээрийн галуу, Ачит нуурт гангар хун, усны нөмрөг бүргэд, Завхан, Хүнгүй голын адаг Хяргас нуурын эрэг орчмоор халбаган хушуут, ямаан сүүлт нугас, хошуу галуу, гангар хун, Хар-Ус нуурт борцгор хотон, Ховд голын адаг, Хар-Ус, Хар нуурын хотгорт гангар хун, халбаган хошуут, усны нөмрөг бүргэд, усны цагаан сүүлт бүргэд, хошуу галуу, хээрийн галуу, Ховд голын адаг болон Цэнхэрийн голын адаг-Зэрэгийн хоолойд гургуул, Булган голын адаг орчимд үлдмэл цахлай, усны нөмрөг бүргэд, хошуу галуу, явлаг сар, Үенч, Бодонч, Цэнхэрийн голын эхэн орчимд үлдмэл цахлай, өгөөлэй шулганаа, хээрийн галуу, Ховд голын эх орчимд явлаг сар, хар өрөвтас, хээрийн галуу, Ховд, Буянт голын усны хагалбар болон Хасагт-Хайрханы нуруунд өгөөлэй шулганаа, Тэс голын хөндий, Ойгон нуурын хотгорт хээрийн галуу, Тэлмэн нуурт хошуу галуу, Завхан голын эх, Яруугийн гол, Улиастай орчимд хар өрөвтас, хээрийн галуу зэрэг ховор шувуу цөөн үзэгдэнэ.

Түгээмэл тархалттай шувуудаас өндөр ууланд шоорон алаг болжмор, харзын шийхнүүхэй, хад асгатай газраар ёл, тагийн ба гимлайн хайруулдай, хөөндий, гал сүүлт, цахир бужирга элбэг

байна. Тарвагатайн нурууны арын хөвч тайгад хөхөө, бэгбаатар, хар ба алаг тоншуул, бөртөт шийхнүүхэй, ухаа дунхай, дүүдүүш, их хөх бух, хад асгатай газраар цармын бүргэд, улаан хошуут, монгол хараацай цөөнгүй тохиолдоно. Ойт хээрийн бүсэд сохор элээ, хон хэрээ, шилийн сар, шуумал шонхор, хөхөө, бэгбаатар, алаг ба хар тоншуул, боролзой болжмор, бөртөт шийхнүүхэй, их хөх бух, гол нуур-ус орчмоор ангир, тураг гогой, зэрлэг нугас, алаг шунгаач, их охил бялзуухай, сахалт хөх бух, хад асгатай газраар улаан хошуут, хөөндий зэрэг шувууд элбэг тархжээ. Их Нууруудын хотгор ба Алтайн чанадахь заримдаг цөл, цөл нутагт цөлийн чогчоохой, монгол хулан жороо, цөлийн зэржигэнэ, согсоот болжмор, зэвэн хиазат, нуур ус –ус орчмын газраар тураг гогой, бор галуу, ангир, зэрлэг нугас, халзан түнжүүр, ахууна, цагаан дэглий, анхидал, намгийн цагаан элэгт, хад асгатай газраар цармын бүргэд, ёл, хотны бүгээхэй, цөлийн бужирга, баян бүрдүүдэд сохор элээ, идлэг ба шуумал шонхор, шилийн сар, дууч шувуун, оронгийн ба загийн бор шувуу зэрэг шувууд элбэг байна. Баруун бүсэд нүүдлийн галуу, нугас олноороо ирж Хар-Ус, Хар, Увс, Ачит, Үүрэг, Айраг, Хотон, Толбо, Намирын Хар-Ус нуур болон Завхан, Булган голын хөндийн зарим хэсэгт цугларч зусдаг байна.

Баруун бүсийн нуур, голуудад арав гаруй зүйлийн загастай. Хамгийн олон зүйлийн загастай нь Булган гол бөгөөд тэнд сибирь хадран, улаан нүдэн, сибирь сугас, хэлтэг, алгана мэтийн олборлолт, спорт-агнуурын ач холбогдолтой загас, нүцгэн жараа, гүрц, сахалт эрээлж, сибирийн шанаган загас мэтийн төдий л элбэг биш тохиолдох загас байдгаас гадна хамгаалтад авбал зохих ховор зүйл-үхэрдээ загас бий. Их Нууруудын хотгорын нуур, голуудад 5 зүйлийн загас байдгаас монгол хадран, алтайн сугас мэтийн олборлолт, спорт-агнуурын ач холбогдолтой загас, сибирь хадран, пельд, сахалт эрээлж мэтийн элбэг биш тохиолдох загасыг нэрэлж болно. Тэс гол, Увс нуурын савд монголын эрээн жараа, агнуурын ач холбогдолтой алтайн сугас гэсэн ердөө хоёр зүйлийн загастай. Сүүлийн жилүүдэд угаасаа загасгүй байсан Улаагчны Хар нуурт загас нутагшуулж үржүүлэх ажил амжилттай явагдаж спорт-агнуурын нөөцтэй болоод байна.

Эцэст нь хоёр нутагтан, мөлхөгч амьтадын талаар товч өгүүлье. Тарвагатай, Булнайн нурууны арын ойд монгол бах, бамбай хоншоорт могой, Хангайн баруун хойт ба баруун талын уулын хээр, уул хоорондын хөндий хотгорт монгол бах, монгол гүрвэл, рашааны могой, бамбай хоншоорт могой, Их Нууруудын хотгорт хонин гүрвэл, могой гүрвэл, рашааны могой, бамбай хоншоорт могой, Бөөрөг-Дэл, Бор-Хяр, Монгол элс зэрэг элсэн тарамцагуудад хонин гүрвэл, говийн гүрвэл, могой гүрвэл, бамбай хоншоорт могой, Монгол Алтайн уулст хонин гүрвэл, рашааны могой, бамбай хоншоорт могой, Булган, Үенч, Бодонч голын адаг, Баруун-Хуурайн хотгорт ногоон бах, замба гүрвэл, хонин гүрвэл, төмөр гүрвэл, могой гүрвэл, толбот гүрвэл, бамбай хоншоорт могой, Алтайн өвөр говь, цөлд замба гүрвэл, хонин гүрвэл, нохой гүрвэл, говийн нүцгэн хуруут геккон, төмөр гүрвэл, говийн гүрвэл, могой гүрвэл, загалт гүрвэл, тэмээн сүүлт могой, сум могой, нарийн могой зэрэг амьтад зарим газар элбэг, зарим газар ховор тархан нутагшжээ. Түүнээс гадна Монгол Алтайн Хотон, Хоргон нуурын хотгорт хээрийн загалмайт могой хэмээх нэгэн зүйлийн могой ганц нэгээр олдсоныг судлаачид тэмдэглэсэн байдаг.

Дээр өгүүлснээс үзэхэд Баруун бүсэд загасны зүйл харьцангуй цөөн, бусад амьтад зүйлийн бүрэлдэхүүний хувьд баялаг, ялангуяа өндөр уул, хээр, заримдаг цөл, цөлийн амьтны бүлгэмдэл давамгайлах шинжтэй байна.

## 1.2 НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ

### 1.2.1. Хүн ам, байршил, ястан үндэстний суурьшил

Баруун бүсийн 5 аймагт 2007 оны байдлаар манай улсын бүх хүн амын 15,6% буюу 411,1 мянган хүн ам байнга оршин сууна. Үүнээс Баян-өлгий аймагт 100.8 мян. хүн ам, Увс аймагт 80.4 мян. хүн ам, Ховд аймагт 88.6 мян. хүн ам, Говь-алтай аймагт 60.2 мян. хүн ам, Завхан аймагт 81.1 мян. хүн ам (хүснэгт-1) тус тус оршин сууна.

Баруун бүсийн нутаг дэвсгэр, хүн амын тоо /Хүснэгт 1.1/

| № | Аймгийн нэр | Сум дүүргийн тоо | Нутаг дэвсгэрийн хэмжээ мян. км <sup>2</sup> | Хүн амын тоо (мян. хүн) | Хүн амын нягтшил (хүн/км <sup>2</sup> ) | Аймгийн төвүүд |
|---|-------------|------------------|--|-------------------------|---|----------------|
| 1 | Баян-өлгий  | 14               | 45.7   | 100,8                   | 2.21                                    | Өлгий          |
| 2 | Ховд        | 17               | 76.1   | 88,6                    | 1.16                                    | Ховд           |

|             |            |           |              |              |             |          |
|-------------|------------|-----------|--------------|--------------|-------------|----------|
| 3           | Увс        | 19        | 69.6         | 80,4         | 1.16        | Улаангом |
| 4           | Говь-алтай | 18        | 141,4        | 60,2         | 0.43        | Алтай    |
| 5           | Завхан     | 24        | 82,5         | 81,1         | 0.98        | Улиастай |
| <b>Нийт</b> |            | <b>92</b> | <b>415,3</b> | <b>411,1</b> | <b>0,99</b> |          |

Эх сурвалж: 2007 оны статистикийн эмхэтгэл, 2008

Баруун бүсийн хамгийн олон хүн амтай 5 суманд суманд (Хүснэгт-2) Завхан аймгийн Тосонцэнгэл, Ховд аймгийн Булган, Баян-Өлгий аймгийн Улаанхус, Цэнгэл, Дэлүүн сумууд орох бөгөөд бүсийн хамгийн цөөн хүн амтай 5 суманд Завхан аймгийн Асгат, Завханмандал, Цагаанчулуут, Ургамал, Говь-Алтай аймгийн Тайшир сумууд орох бөгөөд 1165-1718 хүн оршин суудаг.

Баруун бүсдээ хамгийн том нутаг дэвсгэртэй 5 суманд Говь-Алтай аймгийн Эрдэнэ, Алтай, Цогт, Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Дэлүүн орох бөгөөд хүн амын нягтшилаар ч хамгийн бага сумууд юм. Хамгийн бага нутаг дэвсгэртэй 5 суманд суманд Завхан аймгийн Асгат, Тэс, Баян-Өлгийн Алтанцөгц, Буянт, Ховд аймгийн Дуут сумууд орох бөгөөд 654-2146,71км<sup>2</sup> нутагтай.

Баруун бүсийн хүн ам, нутаг дэвсгэрийн хамгийн их, бага үзүүлэлт /Хүснэгт 1.2/

| Д/д | Хамгийн их   |              |       |                                  |           |          |
|-----|--------------|--------------|-------|----------------------------------|-----------|----------|
|     | Хүн ам       |              |       | Нутаг дэвсгэр (км <sup>2</sup> ) |           |          |
| 1   | Завхан       | Тосонцэнгэл  | 10048 | Говь-Алтай                       | Эрдэнэ    | 25066.26 |
| 2   | Ховд         | Булган       | 9634  | Говь-Алтай                       | Алтай     | 20256.12 |
| 3   | Баян-Өлгий   | Улаанхус     | 8625  | Говь-Алтай                       | Цогт      | 16618.04 |
| 4   | Баян-Өлгий   | Цэнгэл       | 8079  | Ховд                             | Алтай     | 13144.26 |
| 5   | Баян-Өлгий   | Дэлүүн       | 8032  | Говь-Алтай                       | Бугат     | 9920.862 |
| Д/д | Хамгийн бага |              |       |                                  |           |          |
|     | Хүн ам       |              |       | Нутаг дэвсгэр (км <sup>2</sup> ) |           |          |
| 1   | Завхан       | Ургамал      | 1718  | Ховд                             | Дуут      | 2146.71  |
| 2   | Говь-Алтай   | Тайшир       | 1575  | Баян-Өлгий                       | Буянт     | 1845.67  |
| 3   | Завхан       | Цагаанчулуут | 1505  | Баян-Өлгий                       | Алтанцөгц | 1786.10  |
| 4   | Завхан       | Завханмандал | 1331  | Завхан                           | Тэс       | 872.29   |
| 5   | Завхан       | Асгат        | 1165  | Завхан                           | Асгат     | 654.00   |


Эх сурвалж: 2007 оны статистикийн эмхэтгэл, 2008

**Баян-өлгий аймаг** 2007 оны байдлаар 100,8 мянган хүн амтай бөгөөд хүн амынхаа тоогоор 21 аймгийн дотроос гуравдугаарт, баруун бүсийн хэмжээнд нэгдүгээрт ордог. Монгол улсын нийт хүн амын 3,8%, баруун бүсийн хүн амын 24,5% нь тус аймагт оршин суудаг. 1979-1989 онд тус аймгийн хүн амын өсөлтийн хурд 27,3% байсан бол (Диаграмм-1) 1989-2000 онд өсөлтийн хурд эрс бууран 0,3%-д хүрсэн ба харин сүүлийн жилүүдэд бага зэрэг (2000-2007 онд 10,7%) нэмэгдэж, тогтворжих хандлага ажиглагдаж байна.

Хүн амын энэхүү бууралт нь төрөлтийн бууралттай холбоотой боловч казак үндэстний гадаад шилжих хөдөлгөөнтэй холбоотой хүн амын тоо ихээхэн буурсан. Хүн амын байршилтыг сумуудаар авч үзвэл аймгийн төв буюу Өлгий суманд аймгийн нийт хүн амын 29,6%, Улаанхус-9,1%, Цэнгэл сум-8,6%, Дэлүүн сум-8,5%, Ногооннуур сум-7,1-ийг тус тус эзлэх бөгөөд аймгийн нийт хүн амын 62,9%-ийг бүрдүүлдэг.

**Ховд аймаг** нь эдийн засгийн баруун бүсийн төв бөгөөд хүн амынхаа тоогоор 21 аймгийн дотроос Хөвсгөл, Өвөрхангай, Баян-Өлгий, Сэлэнгэ, Архангай аймгуудын дараа зургаадугаарт, баруун бүсийн хэмжээнд Баян-Өлгий аймгийн дараа хоёрдугаарт ордог. Тус аймгийн хүн амын онцлог нь угсаатны бүтцийн хувьд олон янз, 10 гаруй угсаатны төлөөлөгчид амьдран суудаг.

Баруун бүсийн аймгуудын хүн амын өөрчлөлт, мян.хүн /Диаграмм 1.3/



1979-1989 онд Ховд аймгийн хүн амын өсөлтийн хурд 21,5%-иар өсч байсан бол (Диаграмм-1) 1989-2000 онд 14,1%-иар, 2000-2007 онд 2,1%-иар өссөнөөс үзэхэд өсөлтийн хурд эрс буурсан нь ажиглагдаж байна. Ховд аймгийн 17 сумдаас хүн амынхаа тоогоор хамгийн олон нь аймгийн төв буюу Жаргалант суманд нийт хүн амын 32,8%, Булган суманд 10,8% нь амьдран суудаг бол хамгийн цөөн хүн амтай Дуут суманд 2,1 мянган хүн ам оршин суудаг.

**Увс аймаг** нь 2007 оны байдлаар 80,4 мянган хүн амтай бөгөөд 21 аймгийн дотроос хүн амынхаа тоогоор аравдугаарт, баруун бүсийн хэмжээнд дөрөвдүгээрт ордог. 1979-1989 тус аймгийн өсөлтийн хурд 16,2%-иар, 1989-2000 онд өсөлтийн хурд буурсаар 7,5%-иар өссөн бол 2000 оноос хойш хүн амын өсөлт тасралтгүй буурсаар өсөлтийн хурд 10,6%-иар буурсан байна. Ийнхүү Увс аймгийн хүн амын сүүлийн жилүүдийн тасралтгүй бууралт нь төрөлт төдийлөн нэмэгдэхгүй, нас баралт буурахгүй байгаатай холбоотой боловч хүн амын механик хөдөлгөөн болох Төвийн бүс рүү шилжих хөдөлгөөн саарахгүй байгаагаас аймгийн хүн амын тоо буурсаар байна. Увс аймаг нь 19 сумтай бөгөөд нийт хүн амын 30,3% буюу 24000 гаруй хүн аймгийн төв буюу Улаангомд, 7,6% нь Тэс суманд, 6,2% нь Наранбулаг суманд, 5,6% нь Өмнөговь суманд оршин суудаг бол хамгийн цөөн хүн амтай Давст сум нь 1,8 мянган хүн амтай.

**Говь-Алтай аймаг** 60,2 мянган хүн амтай бөгөөд баруун бүсийн хамгийн цөөн хүн амтай аймаг юм. 1979-1989 онд тус аймгийн хүн амын өсөлтийн хурд 12,3%-иар, 1989-2000 онд 1,4%-иар өсч байсан бол 2000-2007 онд 5,4%-иар өсөлтийн хурд буурсан байна. Энэ нь Баруун бүсээс Улаанбаатар хот болон Төвийн бүс рүү шилжигчдийн дийлэнхи нь Увс, Завхан, Говь-Алтай аймгийнхан давамгайлж байдгаас хүн амын тооны өөрчлөлтөнд сөргөөр нөлөөлж байна. Тус аймаг нь нийт 18 сумтай бөгөөд аймгийн төв буюу Есөнбулаг суманд нийт хүн амын 30,3% буюу 17000 гаруй хүн, 6,8% нь Цогт суманд, 5,3% нь Дэлгэр, 5,1% нь Баян-Уул суманд суманд оршин суудаг бол хамгийн цөөн хүн амтай Төгрөг, Дарви сумууд нь тус тус 1,8 мянган хүн амтай.

### 1.2.1.1 Баруун бүсийн хүн амын цэвэр өсөлт

2007 онд хүн амын жилийн дундаж өсөлт улсын дунджаар 1.6% бөгөөд хүн амын жилийн дундаж өсөлт нь Завхан, Баян-Өлгий аймгуудад 0,6-0,7%, Ховд аймагт 0,1%-иар өсч байгаа бол Увс, Говь-Алтай аймгуудад 0,1-0,2%-иар буурсан байна. Бүс нутгийн хүн амын жилийн дундаж өсөлтийг нь харьцуулж үзвэл 1979-1989 онуудад 1.1-2.7 хувиар өссөн бол 1989-2000 онд өмнөх 10 жилийнхээсээ эрс буурч 0.1-1,4 хувиар, 2000-2007 онд Ховд, Баян-Өлгий аймгуудын жилийн дундаж өсөлт 0,1-0,9%-иар өсч, харин Говь-Алтай, Завхан, Увс аймгуудын жилийн дундаж өсөлт 0,8-1,1%-иар тус тус буурсан байна. Ийнхүү хүн амын жилийн дундаж өсөлт буурсан нь хөдөөгийн хүн амд учирч буй нийгэм эдийн засгийн бэрхшээл, үр хөндөлт нэмэгдэж буй зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой сүүлийн жилүүдэд төрөлт эрс буурч, шилжих хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотой хүн амын өсөлт буурсан хэдий ч тус баруун бүсийн хүн амын цэвэр өсөлт улсын дунджаас дээгүүр хадгалагдаж байна.

Баруун бүсийн хүн амын цэвэр өсөлт /Хүснэгт 1.3/

| №                    | Аймгийн нэр | Хүн амын цэвэр өсөлт |                            |
|----------------------|-------------|----------------------|----------------------------|
|                      |             | Бодит тоогоор        | 1000 хүнд оногдох байдлаар |
| 1                    | Баян-өлгий  | 2082                 | 19.3                       |
| 2                    | Ховд        | 1534                 | 17.3                       |
| 3                    | Увс         | 1389                 | 17.3                       |
| 4                    | Говь-алтай  | 801                  | 13.3                       |
| 5                    | Завхан      | 1129                 | 14.0                       |
| Баруун бүсийн дундаж |             |                      | 16.9                       |

Эх сурвалж: 2007 оны статистикийн эмхэтгэл, 2008

Тухайлбал 2007 оны байдлаар 1000 хүн амд ногдох цэвэр өсөлт Баян-Өлгий аймагт 19.3, Говь-Алтай аймагт 13,3, Завхан аймагт 14,0, Увс аймаг , Ховд аймагт 17,3, (хүснэгт-3) байгаа нь Баян-Өлгий,Увс, Ховд аймгууд нь улсын дунджаас 1,9-3,9 пунктээр их, Завхан, Говь-Алтай аймгууд нь 1,4-2,1 пунктээр буурсан байна. Гэвч Баруун бүсийн 1000 хүнд оногдох хүн амын цэвэр өсөлтийн дундаж 16.9 байгаа нь бусад бүсүүд болон Монгол улсын (15,4) дунджаас 1,5 пунктээр өндөр байна. 1000 хүнд ногдох төрөлт Ховд, Увс, Баян-Өлгий аймгуудад 0,7-2,4 пунктээр илүү бол Завхан, Говь-Алтай аймгуудад улсын дунджаас (1,5-2,8) бага, нас баралт Баян-Өлгий аймагт 4,8, Говь-Алтай аймагт 5,6, Ховд аймагт 5,0, Завхан аймагт 6,2 байгаа нь улсын дунджаас бага байгаа бол Увс аймагт 6,5 байгаа нь дунджаас ялимгүй их байна.Хүн амын өсөлтийн хурдны бууралт нь төрөлтийн түвшний бууралттай холбоотойгоор тайлбарлагдана. Хүн амын төрөлтийн сүүлийн жилүүдийн байдлыг аймгуудаар авч үзвэл дараах дүр зураг харагдаж байна. Нийгэм эдийн засгийн өөрчлөлттэй уялдаж, 1990оноос хойш хүн амын төрөлт эрс буурсан билээ. Энэхүү бууралт нь баруун аймгуудыг (Хүснэгт) нэгэн адил хөндсөн юм. Тус бүс нутгийн хүн амын 2007 оны төрөлтийг 1990 онтой харьцуулбал Ховд аймаг 34,0%-иар, бусад аймгууд 41,4- 45,4%-иар тус тус буурсан байна.

Баруун бүсийн төрсөн хүүхдийн тоо / Хүснэгт 1.4/

| №  | Аймгийн нэр | 1990 | 2000 | 2007 | Өөрчлөлт 1990-2007 онд (хувиар) |
|----|-------------|------|------|------|---------------------------------|
| 1. | Баян-өлгий  | 4386 | 2801 | 2570 | -41,4                           |
| 2. | Говь-алтай  | 2149 | 1541 | 1139 | -46,9                           |
| 3. | Завхан      | 2946 | 2206 | 1632 | -44,6                           |
| 4. | Увс         | 3504 | 2482 | 1913 | -45,4                           |
| 5. | Ховд        | 3000 | 2379 | 1980 | -34,0                           |


Эх сурвалж: Монгол улсын хүн ам, 1994, 2007 оны статистикийн эмхэтгэл, 2008

Хүн амын төрөлтийн түвшин буурч, нас баралтын түвшин төдийлөн сайн буурахгүй байгаагаас хүн амын ердийн өсөлт буурах хандлагатай байна. Баруун бүсийн төрөлтийн бууралт нь (Диаграмм) 1990-ээд оноос эхэлсэн эдийн засгийн хямралаас ард түмний амьжиргааны түвшин доошилсноос аль болох цөөхөн хүүхэдтэй байхыг эрхэмлэх болсон, мөн үр хөндөлтийг чөлөөтэй болгосон зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой юм. Гэвч 1000 хүнд ногдох төрөлтөөр Баян-Өлгий, Увс, Ховд аймгууд нь улсын хэмжээнд нэг, хоёр, гуравдугаар байранд ордог.

1.2.1.2 Баруун бүсийн нас, хүйсийн бүтэц

Баруун бүсийн хүн ам дотроос Баян-Өлгий, Увс, Ховд аймгуудын хүн амын цэвэр өсөлт өндөр байгаатай уялдан нийт хүн амын насны бүтцэд ихээхэн өөрчлөлт гарч, 15-аас доош насны хүүхдийн эзлэх хувийн жин 40-ээс дээш хувь байгаа нь ихээхэн эерэг үзүүлэлт юм. Тухайлбал, Баян-Өлгийд 43,3%, Увсад 41,9%, Ховдод 41,4% байгаа нь улсын дунджаас ихээхэн өндөр үзүүлэлт юм. Улсын хэмжээнд тус бүсийн аймгууд нь хөдөлмөрийн нөөц хангалттай аймгуудын тоонд одог бөгөөд нийт хүн амын 51.5-57.4% нь 15-59 насны хүн ам эзэлдэг бөгөөд сүүлийн жилүү-

Баруун бүсийн 1000 хүн амд ноогдох төрөлт /Диаграмм 1.4/



дэд Улаанбаатар хот, Төвийн бүс, Казакстан руу шилжих явдал нэмэгдсэнтэй холбоотой хүн амын тоонд механик хөдөлгөөн ихээхэн гарч, хүн амын өсөлтөнд сөргөөр нөлөөлж байна.Хүйсийн бүтцийн хувьд Баян-Өлгий, Говь-Алтай, Увс аймгуудын нийт хүн амын

49,4-49,9%-ийг эрэгтэйчүүл, Завхан, Ховд аймгуудын нийт хүн амын 48,5-48,6%-ийг эрэгтэйчүүл эзэлж байгаас үзэхэд хүйсийн бүтцийн хувьд тус бүс нутаг зохистой байгааг илэрхийлж байна.

### 1.2.1.3 Баруун бүс нутгийн хүн амын байршил

Тус бүс нутгийн хүн амын 71.9-ээс дээш хувь нь хөдөө мал аж ахуй эрхэлж амьдарч байна. Баян-өлгий аймгийн хувьд 70.2 %, Говь-Алтай аймгийн 69,3%, Завхан аймгийн 79,6%, Увс аймгийн 72,7%, Ховд аймгийн нийт хүн амын 67,9 %-ийг (Хүснэгт) хөдөөгийн хүн ам, үлдэх хувийг аймгийн төв болон суурин газар амьдрагсад эзэлнэ.

Хот, хөдөөгийн хүн амын суурин хүн амд эзлэх хувь /Хүснэгт 1.5/

| № | Аймгийн нэр | 1989 |       | 2000 |       | 2007 |       |
|---|-------------|------|-------|------|-------|------|-------|
|   |             | Хот  | Хөдөө | Хот  | Хөдөө | Хот  | Хөдөө |
| 1 | Баян-өлгий  | 33,7 | 66,3  | 30,8 | 69,2  | 29,8 | 70,2  |
| 2 | Говь-алтай  | 30,7 | 69,3  | 28,3 | 71,7  | 30,7 | 69,3  |
| 3 | Завхан      | 34,7 | 65,3  | 27,0 | 73,0  | 20,4 | 79,6  |
| 4 | Увс         | 28,5 | 71,7  | 29,2 | 70,7  | 27,3 | 72,7  |
| 5 | Ховд        | 32,9 | 67,1  | 30,0 | 70,0  | 32,1 | 67,9  |

Эх сурвалж: Монгол улсын хүн ам, 1994, 2000, 2007 оны статистикийн эмхэтгэл

Тус бүс нутгийн 2007 оны хөдөөгийн хүн амыг 1989 онтой харьцуулж үзвэл бүх аймгуудын хөдөөгийн хүн ам Завхан аймагт 21,8%-иар, Говь-Алтайгаас бусад аймгуудад 1,8-5,8%-иар өссөн нь зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үед үйлдвэр аж ахуйн газрууд олноор хаагдаж, ажилгүй болсон иргэд хөдөөд гарсантай холбоотой. Тус бүс нь 2007 оны байдлаар нийтдээ 92 сумтайгаас 17 сум нь 2000 хүртэл хүн амтай, 32 нь 2000-3000, 26 сум нь 3000-5000, 10 сум нь 5000-10000, 3 сум нь 10-20000, 4 сум нь 20000-аас дээш хүн амтай сумууд байна. Баруун бүсээс хамгийн олон хүн амтай суурин газар нь Ховд аймгийн төв Жаргалант сум бөгөөд Баруун бүсийн аж үйлдвэр, эрүүл мэнд, соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарын хөгжлийн тулгуур төвүүдийн нэг юм. Тус суманд нийт хүн амын 32,8% буюу 6460 гаруй өрхийн 29 мянган хүн оршин суудаг.

### 1.2.1.4 Баруун бүсийн хүн амын нягтшил

Баруун бүсэд оршин суух хүн амын нягтшилыг бусад бүсийн хүн амын нягтшилтай харьцуулж үзвэл Хангайн бүсийн дараа орох бөгөөд 1 км<sup>2</sup> нутаг дэвсгэрт 0.99 хүн оршин сууж байна. Энэ нь Монгол улсын хүн амын (ҮСХ, 2008) дундаж нягтшилаас 0.69 пүнктээр бага байгаа юм. Гэхдээ бүс нутгийг аймгуудаар авч үзвэл хүн амын нягтшил харилцан адилгүй байгаа нь харагдана. Баян-Өлгий аймаг нь энэ бүсдээ хамгийн өндөр үзүүлэлттэй бөгөөд 1 км<sup>2</sup> нутаг дэвсгэрт 2.21 хүн оршин суудаг. Хамгийн бага нягтшилтай аймагт Говь-алтай аймаг 1 км<sup>2</sup> нутаг дэвсгэрт 0,43 хүн оршин суудаг үзүүлэлтээр орох бөгөөд бусад аймгууд нь 0.98-1.16 хүн/ км<sup>2</sup> нягтшилтай болно. Бүс нутгийн хэмжээнд хүн амын нягтшилыг сумуудаар авч үзвэл харилцан адилгүй байдаг. Хүн амын хамгийн их нягтшилтай сум нь Завхан аймгийн Тэс сум бөгөөд ба 1 км<sup>2</sup> нутаг дэвсгэрт 4.1-ээс дээш тооны хүн оршин сууна. Баян-Өлгий аймгийн Баяннуур 2,32 хүн, Увс аймгийн Тэс, Завхан аймгийн Тосонцэнгэл, Асгат, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сум нь нь 1 км<sup>2</sup> нутаг дэвсгэрт 1,73-1,96 хүн оршин сууж байгаа үзүүлэлтээр дараагийн ангилалд хамрагдана. Завхан аймгийн Дөрвөлжин, Завханмандал, Говь-Алтай аймгийн Тонхил, Шарга сумуудад хүн амын нягтшил харьцангуй бага буюу 1 км<sup>2</sup> нутагт 0.1- 0.2 хүн оршин сууна. Харин Говь-Алтай аймгийн Эрдэнэ, Алтай, Цогт, Бугат, Ховд аймгийн Алтай сумуудад хүн амын нягтшил хамгийн бага буюу 1 км<sup>2</sup> нутаг дэвсгэрт 0.09 - 0.25 хүн оршин суудаг байна. Бусад нутгуудын хүн амын нягтшил нь 0.3-1.6 хүн оршин сууж байна. Баян-Өлгий аймаг нь хүн амын нягтшилаар 21 аймгийн дотроос Орхон, Дархан-Уул, Говь-Сүмбэр, Сэлэнгэ аймгуудын дараа эхний тавд, баруун бүсийн хэмжээнд хамгийн ихтэй аймагт (1 км<sup>2</sup> нутагт 2.21 хүн) ордог. Гэвч 1 км<sup>2</sup> нутаг дэвсгэрт ногдож байгаа хүний тоогоор бусад сумуудаар ихээхэн ялгаатай байдал ажиглагдана. Тухайлбал, энэ үзүүлэлтээр Баяннуур (2.32), Алтанцөгц (1.73), Бугат (1.65), Сагсай(1,63), Буянт (1,56) зэрэг сумдууд тэргүүлдэг бол Алтай (1,14), Булган (1,15), Цэнгэл (1,25), Ногооннуур (1,28) зэрэг сумдад харьцангуй доогуур байгаа нь нутаг дэвсгэр харьцангуй томтой холбоотой юм.

Ховд аймагт 1 км<sup>2</sup> нутаг дэвсгэрт 1,16 хүн ногдох бөгөөд улсын хэмжээнд авч үзвэл дунд зэргийн нягтшилтай аймгуудын тоонд багтах бөгөөд бүсийн хэмжээнд Баян-Өлгий аймгийн дараа орно. Ховд (1,63), Зэрэг (1,22), Эрдэнэбүрэн (1,22), Булган (1,19), Мянгад (1,12) зэрэг сумууд хамгийн их нягтшилтай бөгөөд Алтай (0,25), Дарви (0,46), Чандмань (0,52), Үенч (0,64) зэрэг сумууд нь хамгийн бага нягтшилтай юм.

Увс аймаг нь хүн амын нягтшилаар Ховд аймагтай ижил үзүүлэлттэй (1.16) бөгөөд Тэс, Тариалан, Өмнөговь, Өлгий сумууд хамгийн их нягтшилтай буюу 1 км<sup>2</sup> нутагт 1,96-1,12 хүн ногддог. Хамгийн бага нягтшилтай сумуудад Завхан, Давст, Бөхмөрөн, Сагил сумууд орох бөгөөд 0,30-0,62 хүн ногддог.

Завхан аймагт 1 км<sup>2</sup> нутагт 0,98 хүн ногдож байгаа нь улсын дунджаас 0,7 пунктээр доогуур байна. Баруун бүсийн хэмжээнд хүн амын нягтшилаараа Баян-Өлгий, Увс, Ховд аймгуудын дараа дөрөвдүгээрт ордог.

Хамгийн их нягтшилтай сумуудад Тэс, Тосонцэнгэл, Асгат, Их-Уул сумууд орох бөгөөд 1 км<sup>2</sup> –т 4,05-1,56 хүн оршин сууна. Хамгийн бага нягтшилтай сумуудад Дөрвөлжин, Завханмандал, Эрдэнэхайрхан, Ургамал сумууд орох бөгөөд 1 км<sup>2</sup> нутаг дэвсгэрт 0,31-0,49 хүн оршин суудаг.

Говь-Алтай аймагт 1 км<sup>2</sup> нутаг дэвсгэрт 0.43 хүн ногддог тул хүн амын нягтшилаар баруун бүсийн хэмжээнд хамгийн бага нягтшилтай аймгийн тоонд ордог төдийгүй улсын хэмжээнд хамгийн бага нягтшилтай Өмнөговь аймгийн дараа ордог, хүн ам хамгийн сийрэг оршин суудаг аймгийн нэг юм. Хамгийн их нягтшилтай сумууд болох Баян-уул, Жаргалан, Дэлгэр, Бигэр сумуудад 1 км<sup>2</sup> –т 0,51-0,64 хүн оршин суух бөгөөд нийт сумын 70-аас дээш хувьд нь хүн ам хамгийн сийрэг буюу 0,5-аас цөөн хүн оршин суудаг.

### 1.2.1.5 Баруун бүсийн хүн амын үндэстэн, ястны бүрэлдэхүүн

Тус бүс нутагт 18 орчим ястан, үндэстэн оршин суудаг. Эдгээрийн 52.7 %-ийг халх ястан, 16.7 %-ийг казак үндэстэн, 7.8 %-ийг дөрвөд ястан, 6.0 %-ийг баяд ястан эзэлж, үлдэх хувьд мянгад, өөлд, урианхай, тува, торгууд (хүснэгт-6) зэрэг олон ястан хамрагдана.

**Ястан үндэстний байршлыг аймаг бүрээр авч үзвэл ихээхэн ялгаатай байдал ажиглагдана. Баян-өлгий аймагт 21 үндэстэн, ястны төлөөлөгч оршин сууна. Аймгийн нийт хүн амын 88.7 хувийг казак үндэстэн (Хүснэгт-7) эзлэх бөгөөд энэ нь Монгол улсад амьдардаг казак иргэдийн 78.4 % болно. 7.2 %-ийг урианхай ястан эзлэх бөгөөд үлдсэн хувийг тува, дөрвөд, чантуу, захчин, торгууд, баяд, халх зэрэг ястан эзэлнэ.**

Увс аймагт 20 орчим үндэстэн, ястны төлөөлөгч оршин сууна. Аймгийн нийт хүн амын 40.2%-ийг дөрвөд, 35.2%-ийг баяд, 15.3%-ийг халх, 7.1%-ийг хотон, 1,2%-ийг сартуул ястан эзэлнэ. Үлдэх хувийг мянгад, урианхай, казак, захчин, өөлд, элжигэн, торгууд, тува зэрэг ястнууд эзэлж байна.

Ховд аймгийн бусад аймгуудаас ялгагдах нэг онцлог нь угсаатны бүтцийн хувьд алаг цоохор, 20 гаруй үндэстэн, ястны төлөөлөгчид оршин сууна.

Аймгийн нийт хүн амын 27.4 %-ийг халх, 24.9 %-ийг захчин, 11.5 %-ийг казак үндэстэн, 4.9– 8.1 %-ийг мянгад, урианхай, өөлд, дөрвөд, торгууд ястнууд тус тус эзлэх ба үлдэх хувийг тува, баяд, узбек, хошууд зэрэг ястнууд эзэлж байна.

Завхан аймагт 10 гаруй ястан, үндэстний төлөөлөгчид оршин амьдарна.

Аймгийн нийт хүн амын 99.3%-ийг халх ястан, 0.2%-ийг өөлд, 0.2%-ийг дөрвөд, 0.1%-ийг хотгойд ястан эзэлнэ.

Говь-алтай аймагт 10 гаруй ястан, үндэстний төлөөлөгчид оршин амьдардаг бөгөөд аймгийн нийт хүн амын 99.5 %-ийг халх ястан, 0,2%-ийг өөлд, үлдсэн хувийг нь казак, захчин, дөрвөд, торгууд, баяд зэрэг ястан эзэлнэ. Энэ бүс нутагт амьдрах хүн амын албан ёсны хэл нь Алтай-Түрэг хэлний бүлэгт багтах монгол хэл болно. Казак үндэстнүүд өөр хоорондоо, буюу аймаг дотроо казак хэлээр ярилцаж, орон нутгийн хэвлэл мэдээлэл, ерөнхий боловсролын сургууль казак хэлээр сургалтаа явуулах боловч албан бичгийн хэл нь монгол хэл болно. Бараг бүх ястнууд өөрийн өөрийн хэлний аялгатай байдаг.

Баруун бүсийн хүн амын ястан, үндэстний байдал, аймгийн түвшинд, % /Хүснэгт 1.6/

| №  | Ястан, үндэстэн | Баян-Өлгий | Ховд  | Увс  | Говь-Алтай | Завхан |
|----|-----------------|------------|-------|------|------------|--------|
| 1  | Халх            | 0.44       | 27.5  | 15.3 | 99.5       | 99.3   |
| 2  | Казак           | 88.7       | 11.52 | 0.1  | 0.1        | 0.0    |
| 3  | Дөрвөд          | 1.53       | 6,04  | 40.2 | 0.1        | 0.2    |
| 4  | Баяд            | 0.03       | 0.4   | 35.2 | 0.0        | 0.08   |
| 5  | Мянгад          | -          | 4.9   | 0.2  | -          | -      |
| 6  | Өөлд            | 0.02       | 7.5   | 0.1  | 0.2        | 0.2    |
| 7  | Захчин          | 0.04       | 24.9  | 0.1  | 0.1        | 0.03   |
| 8  | Урианхай        | 7.2        | 7.6   | 0.1  | 0.0        | 0.01   |
| 9  | Тува            | 1.8        | 0.8   | 0.03 |            | -      |
| 10 | Торгууд         | 0.03       | 8.1   | 0.08 |            | 0.01   |
| 11 | Узбек           | 0.04       | 0.3   | -    |            | -      |



|    |          |      |     |     |      |      |
|----|----------|------|-----|-----|------|------|
| 12 | Хотон    | -    | -   | 7,1 | -    | -    |
| 13 | Харчин   | 0.03 | -   | -   | -    | -    |
| 14 | Хамниган | 0.02 | -   | -   | -    | -    |
| 15 | Бусад    | 0.14 | 0.4 | 0.1 | 0.07 | 0.22 |

Эх сурвалж: Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Хөвсгөл, Говь-алтай аймгуудын хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын дүн, МУУСГ, 2001

### 1.2.1.6 Баруун бүсийн хүн амын шилжилт хөдөлгөөн

Баруун бүсийн хэмжээнд дэд бүтцийн сул хөгжил, нийгэм, соёлын үйлчилгээ хангалтгүй, төв суурин газраас алслагдсан зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой Төвийн бүс болон Улаанбаатар, Дархан-Уул, Орхон аймгууд руу шилжих шилжилт хүчтэй явагдсан. 1990 оноос хойш хүн амын дотоод шилжилт хөдөлгөөн сүүлийн жилүүдэд ихээхэн нэмэгдэж, тус бүсэд хүн амын шилжих хөдөлгөөний сөрөг урсгал, өөрөөр хэлбэл, тухайн аймаг, сумаасаа өөр аймаг, хот улс руу шилжих явдал ихэссэн (хүснэгт-7) нь харагдана. Ийнхүү баруун бүсэд шилжин ирэгчдээс явагчид нь давамгайлж, сөрөг (-) үр дүн гарч байгаа бөгөөд энэ нь тус бүсийн хүн ам, ажиллах хүчин, ялангуяа өндөр мэргэжил, боловсролтой боловсон хүчний хангамжид муугаар нөлөөлж байна. Ялангуяа гол төлөв залуучууд болон өндөр мэргэжил боловсролтой боловсон хүчин Улаанбаатар хот болон төвийн бүс рүү шилжин суурьших явдал нэмэгдсэн нь тухайн бүсийн нийгэм эдийн хөгжилтэнд ч сөрөг нөлөөтэй юм.

#### Баруун бүсийн хүн амын шилжилт хөдөлгөөн, аймгаар /Хүснэгт 1.7/

| Аймаг      | Шилжих хөдөлгөөний хугацаа | Шилжин ирэгчид | Шилжин явагчид | Цэвэр шилжих хөдөлгөөн |
|------------|----------------------------|----------------|----------------|------------------------|
| Баян-Өлгий | 1.1990-2000                | 24192          | 55079          | <b>-30887</b>          |
|            | 2.2001-2007                | 1532           | 10044          | <b>-8512</b>           |
| Говь-Алтай | 1.1990-2000                | 12073          | 19804          | <b>-7731</b>           |
|            | 2.2001-2007                | 4627           | 12449          | <b>-7822</b>           |
| Завхан     | 1.1990-2000                | 22724          | 32917          | <b>-10193</b>          |
|            | 2.2001-2007                | 9611           | 20669          | <b>-11058</b>          |
| Увс        | 1.1990-2000                | 13328          | 38363          | <b>-25035</b>          |
|            | 2.2001-2007                | 9176           | 18773          | <b>-9597</b>           |
| Ховд       | 1.1990-2000                | 10743          | 17884          | <b>-7141</b>           |
|            | 2.2001-2007                | 5094           | 12554          | <b>-7460</b>           |

Эх сурвалж: МУУСХ, 2007

Баян-өлгий аймгийн хүн амын шилжилт хөдөлгөөнийг авч үзэхэд 1990-2000 онд 24192 хүн шилжин ирж, 55000 гаруй хүн шилжин явсан байна. Энэ нь тухайн жилүүдэд Баян-Өлгий, Ховд аймгийн уугуул 11 мянга гаруй өрхийн 50 гаруй мянган казак иргэн Казахстан руу шилжин явсантай холбоотой боловч хөдөлмөрийн гэрээгээр Казахстан улс руу явсан олон казак иргэд нутагтаа эргэн ирсэн. Тус аймагт шилжин ирэгсдийн 70 гаруй хувийг гадаадаас Казахстан улсаас, цөөн хувь нь Увс, Ховд аймгаас шилжин ирэгчид эзэлнэ.

Харин шилжин явагчдын 45.1 хувь нь Улаанбаатар хот, 20 гаруй хувь нь Ховд аймаг руу, 6-7 хувийг Орхон, Дархан-уул аймаг руу шилжигчид тус тус эзэлж байна. Харин 2001-2007 онуудад шилжин явагчдын хэмжээ өмнөх 10 жилийнхтэй харьцуулбал 5,3 дахин багасчээ. Увс аймгийн хүн амын шилжилт хөдөлгөөнийг авч үзвэл 2001-2007 онд Улаанбаатар, бусад суурин газар, аймаг руу 18773 хүн шилжин явсанаас үзэхэд өмнөх 10 жилээсээ 2 дахин буурсан эерэг үзүүлэлт ажиглагдаж байна. Гэвч тус аймаг нь нийт шилжин явагчдын тоогоор тус бүсийн аймгуудын дотор хамгийн өндөр аймгуудын тоонд багтсан хэвээр байна. Шилжин явагчдын 80-аас дээш хувь нь Улаанбаатар болон төвийн бүсийн аймгуудад шилжсэн шилжилт эзлэх бөгөөд тус аймаг нь шилжилт хөдөлгөөний сөрөг урсгалын хэмжээ маш өндөр, голдуу төвийн бүс рүү чиглэсэн гэж дүгнэж болно.

Ховд аймгийн хүн амын шилжилт хөдөлгөөний мэдээнээс цэвэр шилжих хөдөлгөөний зөрөө хамгийн бага аймгийн тоонд орж байна. Шилжин ирэгчдийн дотор Улаанбаатар хот, Увсаас шилжин ирэгчид тус тус 20 гаруй хувь, 20 орчим хувь нь Баян-Өлгий, Говь-Алтай аймгаас шилжин ирж байгаагаас дүгнэхэд Баруун бүсийн тулгуур төв тус аймагт тус бүсийн бусад аймгуудаас шилжин ирэгчид их байна. Шилжин явагчдын 70 гаруй хувь нь Улаанбаатар хот болон Дархан-Уул аймаг руу шилжсэн байна.

Завхан аймгийн хүн амын шилжилт хөдөлгөөнийг авч үзэхэд 2001-2007 онд Улаанбаатар, бусад суурин газар, аймаг руу шилжин явагчид, шилжин ирэгчдээс олон буюу нийт 20669 хүн шилжин

явж, 9680 хүн шилжин ирсэн байгаа нь шилжин явах нь ирэхээсээ 2.1 дахин их байна. Ийнхүү хүн амын шилжих хөдөлгөөнийг захиргааны аргаар зохицуулж байсан систем өөрчлөгдсөний дараах өнөө үед нийт шилжин явагчдын тоо Ховд, Увс, Завхан, аймгуудад хамгийн их буюу 2001-2007 онд 12,5-20,6 мянган хүн байгаа бөгөөд эдгээр аймгуудын бүх хүн амд шилжин явагчид 15-30%-ийг эзэлж байна. Шилжин явагчид хамгийн олонтой дээрх аймгуудад шилжин ирэгчид бага байгаа тул хүн амын өсөлт, нягтшил, ажиллах хүчний хангамж, орон нутгийн цаашдын хөгжилд нөлөөлөх хүн ам зүйн хандлага зэрэгт сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

Ийнхүү тус бүсийн хүн амын дотор сүүлийн жилүүдэд тухайн аймаг сумаасаа гадагш, Улаанбаатар хот болон төвийн бүсийн аймаг, хот руу шилжин явах нь ихэссэн бөгөөд хамгийн өндөр сөрөг урсгал бүхий шилжилт хөдөлгөөнтэй аймагт Завхан, Увс, Ховд, Говь-Алтай аймгууд болно. Хүн амын шилжилт хөдөлгөөн нь дараах үндсэн шалтгаануудтай нөхцөлдөнө. Үүнд:

- Ажлын байр хүрэлцээгүй
- Дэд бүтцийн хөгжил муу
- Амьжиргааны түвшин хөдөөд доройтсон
- Төвлөрсөн зах зээлд ойртох
- Чанартай сургуульд хүүхдээ сургах, эмнэлэгт эмчлүүлэх
- Ах дүү хамаатнаа, үр хүүхдээ бараадаж амьдрах гэх мэт шалтгаанууд голлож байна.

### 1.2.1.7 Хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдэл

2007 оны байдлаар Баруун бүсийн нийт хүн амын 170,7 мянган хүн эдийн засгийн идэвхитэй хүн амд тооцогдож байгаа бөгөөд үүнээс ажиллагчдын тоо 164,6 мянга байгаа бөгөөд эрүүл мэнд, боловсрол, худалдаа, үйлчилгээ, санхүүгийн салбарт ажиллагсдын дийлэнхи нь эмэгтэйчүүд эзэлж байна.


Баян-Өлгий аймгийн нийт ажиллагсдын 71.9 хувь нь хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт, 20,4 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгмийн даатгал, эрүүл мэнд, боловсрол, бөөний болон жижиглэн худалдааны салбарт ажиллана. Ховд аймгийн нийт ажиллагсдын 70.8 хувь нь хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт, 20.1 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгмийн даатгал, эрүүл мэнд, боловсрол, бөөний болон жижиглэн худалдааны салбарт ажиллана. Увс аймгийн хэмжээнд нийт ажиллагсдын 73.3 хувь нь хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт, 18.0 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгмийн даатгал, эрүүл мэнд, боловсрол, бөөний болон жижиглэн худалдааны салбарт ажиллана.

Завхан аймгийн хэмжээнд нийт ажиллагсдын 76.9 хувь нь хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт, 15.8 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгмийн даатгал, эрүүл мэнд, боловсрол, бөөний болон жижиглэн худалдааны салбарт ажилладаг бол Говь-алтай аймгийн нийт ажиллагсдын 76.8 хувь нь хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт, 16.1 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгмийн даатгал, эрүүл мэнд, боловсрол, бөөний болон жижиглэн худалдааны салбарт ажиллаж байгаагаас үзвэл баруун бүсийн нийт ажиллагсдын 74.0 хувь нь хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт ажиллаж байгаа нь улсын дундажтай харьцуулахад 2 дахин их, харин төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгмийн даатгал, эрүүл мэнд, боловсрол, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 18.0 хувь нь ажиллаж байгаа нь улсын дунджаас 1.7 хувиар бага үзүүлэлт юм.

Баруун бүсийн хүн амын 2007 оны ажил эрхэлж буй хүний тоог 2000 онтой харьцуулбал Баян-өлгий аймаг 6.4 мянган хүнээр, Ховд аймаг 7,1 мянган хүнээр Завхан аймаг 3,9 мянган хүнээр, Увс аймаг 2,9 мянган хүнээр тус тус нэмэгдсэн бол Говь-алтай аймаг 1.3 мянган хорогдож, ажил эрхлэлтийн түвшин тус аймагт буурсан сөрөг хандлага ажиглагдаж байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо болон ажилгүйдлийн түвшин тогтмол буурч байгаа боловч аймгуудаар харилцан адилгүй байна. Баян-Өлгий аймагт ажилгүйдлийн түвшин 0,6 пунктээр, ажилгүйчүүдийн тоо 0,5 мянган хүнээр тус тус нэмэгдсэн бол бусад аймгуудын ажилгүйдлийн түвшин 2-3,7 пунктээр (Диаграмм-3) буурсан эерэг үзүүлэлт ажиглагдаж байна.

Баруун бүсийн ажилгүйдлийн тоо, ажилгүйдлын түвшин /Диаграмм 1.5/



### 1.2.2 Нийгэм, эдийн засгийн тулгуур нөхцөл

Үндэслэл : 2007 оны байдлаар ажилгүйдлийн түвшин улсын дундаж 2.8 хувь байхад Баруун бүсэд 3.5 хувь байна.


Энэ нь баруун бүсийн эдийн засгийн хөгжлийн түвшин бусад бүсээс харьцангуй доогуур байгаатай шууд холбоотой. Шилжилтийн эхний жилүүдэд улсын хэмжээгээр үндэсний орлого огцом буурч, ажилгүйдэл ихсэн, инфляци огцом өсөж, нийгмийн салбарын санхүүжилт буурснаар ядуурал газар авсан билээ. Өмнөх тогтолцооны үед бий болсон ажлын байрууд үгүй болж, тэндээс амжиргаагаа залгуулж байсан хүмүүсийн ихэнх нь ажилгүйдлийн эгнээнд шилжиж орсон ба нилээд хэсэг нь нутаг орноо орхин нүүжээ.

Нөгөө талаар зах зээлийн тогтолцооны нөхцөлд иргэд бизнес эрхлэж биеэ даан амьдрах мэдлэг, дадлага туршлага дутмаг, бэлэнчлэх сэтгэлгээнээс салж чадахгүй байгаагаас ажилгүйдлийг дагасан ядуурал өсч байна. Баруун бүсэд сүүлийн жилүүдэд жил дараалан тохиолдсон ган, зудад нэрвэгдсэн олон айл өрх малгүй болж, сум, аймгийн төв болон хот суурин газрыг барааджээ.

#### 1.2.2.1 Нийгмийн тулгуур нөхцөл

2002-2003 оны өрхийн орлого зарлага, амжиргааны түвшний судалгааны дүнгээр Баруун бүсэд ядуурлын хамралтын хүрээ 51.1%, ядуурлын гүнзгийрэлт 14.6%, ядуурлын мэдрэмж 5.7%-тай тэнцүү байна. Судалгаагаар малчин өрхийн нэг хүнд ноогдох малын тоо 20 бодоос дээш байх боломжтой, Гэтэл Баруун бүсийн олонх малчин өрхийн нэг хүнд ноогдох малын тоо 20 бодоос доогуур байна. Иймд ажилгүйдлийн түвшинг энэ бүс нутагт эрс бууруулж, хүн амын ядуурлаас гаргах талаар дорвитой алхмууд хийх шаардлагатай байна.

Нэг худалдааны цэгт ноогдох хүний тоо /Диagramм 1.6/



Баруун манай улсын нийт газар нутгийн 26,6 хувь нь ногдож, нийт хүн амын 15,6% нь оршин суудаг. Тус бүсийн хүн амын өсөлт 1990 оноос хойш ихээхэн буурч (Хүснэгт-8) байна. 2000 оныг 1990 онтой харьцуулахад хүн ам 0,8%-иар буурсан бол 2007 онд 2000 оноос 2,1%-иар буурсан байна. Энэ нь бүсэд

хүн амын төрөлт буурсан, мөн шилжих хөдөлгөөнөөс үүдэлтэй тухайн бүс нутгийн хүн амын өсөлт буурсаар байна.

**Баруун бүсийн хүн ам, мянган хүн / Хүснэгт 1.8/**

| Он                   | 1990  | 2000  | 2005  | 2006  | 2007  |
|----------------------|-------|-------|-------|-------|-------|
| Баруун бүсийн хүн ам | 423,4 | 420,0 | 409,0 | 410,0 | 411,1 |

Баруун бүсийн тэр дундаа захын аймгуудад гадагш шилжих хөдөлгөөн өндөр байгаа нь тухайн бүсийн нийгмийн үзүүлэлтүүд (жишээ нь эх, нялхсын эндэгдэл өндөр) доогуур байгаатай холбоотой юм. Мөн хөдөө орон нутагт эдийн засгийн бүтцийн хувьд хөдөлмөрийн бүтээмж багатай мал аж ахуй, худалдаа, үйлчилгээний салбар давамгайлж, хөдөлмөр эрхлэх нөхцөл бололцоо хязгаарлагдмал байгаагаас зах зээлээ даган төв рүү чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн төдийлөн саарахгүй байна. Иймээс засгийн газар энэ бүс нутгаас гадагш шилжих хөдөлгөөний урсгалыг сааруулахын тулд баруун бүс нутгийг хөгжүүлэх асуудлаар яаралтай арга хэмжээ авах шаардлагатай юм.

2007 оны байдлаар ажилгүйдлийн түвшний улсын дундаж 2,8 байхад тус бүсэд 3,5 буюу 0,7 пунктээр өндөр байгаа нь тус бүсийн эдийн засгийн хөгжлийн түвшин бусад бүсээс харьцангуй доогуур байгаатай холбоотой. Ажилгүйдлийн түвшинг аймгаар авч үзвэл Баян-Өлгий аймаг хамгийн их 5,3 байгаа нь улсын хэмжээнд хамгийн өндөрт орно.

Хүн амын эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж алслагдсан бүс нутагт ихээхэн ялгаатай байна. Тус бүсэд нэг их эмчид ногдох хүний тоо жил бүр буурч байгаа боловч 2007 оны байдлаар нэг их эмчид ногдох хүний тоогоор (646 хүн) бусад бүсээс хамгийн өндөр байна. Завхан, Ховд аймгуудад нэг их эмчид 700-аас дээш хүн ногдож байгаа нь улсын хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлт юм. Энэ нь эмнэлгийн үзлэг, үйлчилгээний чанарт ч сөргөөр нөлөөлж байгаа нь тодорхой. Тухайлбал, амьд төрсөн 1000 хүүхэд тутамд ногдох нялхсын эндэгдэлийн улсын дундаж 17,8 байхад тус бүс бусад бүсүүдээс хамгийн өндөр (23,2), Төвийн бүсээс 2 дахин их байгаагаас харагдана. Говь-Алтай, Увс аймгуудад нялхсын эндэгдэл улсын хэмжээнд хамгийн өндөр буюу 32,5-32,9 байна. Мөн төрөхийн улмаас эндсэн эхийн тоогоороо ч тус бүс бусад бүсээс тэргүүлж байгаа бөгөөд Баян-Өлгий, Говь-Алтай аймгуудад эхийн эндэгдэл хамгийн их байна.

Боловсролын үйлчилгээний хүртээмж ч ихээхэн ялгаатай байна. Ерөнхий боловсролын сургуулийн тоогоор ч (154) бусад бүсээс цөөн бөгөөд нэг багшид ногдох сурагчдын тоогоор (29.6) Хангайн бүсийн дараа орж байгаа нь сургалтын чанарт ч сөргөөр нөлөөлж байна.

Мэдээллийн үйлчилгээний хүртээмж ч ялгавартай байна. Суурин телефон цэгийн тоогоор Төвийн бүсээс 2 дахин бага, Хангай бүсээс 1,7 дахин бага хангагдсанаас үзэхэд алслагдсан бүс нутгийн мэдээллийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах шаардлагатай юм. Баруун бүсдээ Завхан, Ховд аймгууд нь суурин телефон цэгийн тоогоор хамгийн бага хангагдсан байна.

**1.2.2.2 Эдийн засгийн тулгуур нөхцөл**

Алслагдсан баруун бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн түвшин бусад бүсээс харьцангуй доогуур түвшинд байна. Боловсруулах аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дөнгөж 1,8 % нь баруун бүсэд ногдож байна. Түүнчлэн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтаар хамгийн бага (0,6) хувийг эзэлж байгаагаас үзэхэд тус бүсэд аж үйлдвэрийн салбар болон жижиг, дунд үйлдвэрлэл нэн сул хөгжсөнийг илэрхийлнэ. Ховд, Завхан аймгууд нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтаар бүсдээ хамгийн бага (10,7-16,9) хувийг эзэлж байна. Иймд бүсийн эдийн засгийн өсөлтийн гол тулгуур хүчин зүйл болох жижиг, дунд үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх явдал чухал байна. Тус бүс нутгийн мал аж ахуйн гаралтай түүхий эдийн арвин нөөц дээр тулгуурлан арьс шир, ноос ноолуур, мах, сүү зэрэг мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах хөнгөн, хүнсний жижиг, дунд үйлдвэрлэл болон бүсийн хөгжилд нөлөө бүхий өмнө ажиллаж байсан үйлдвэрүүдийг сэргээх, хүчин чадлыг нэмэгдүүлэх өргөтгөх, шинээр үйлдвэр байгуулахад дараах чиглэлийг баримтлах бололцоотой юм. Тухайлбал Баян-Өлгийд Өлгийн ноос угаах үйлдвэр, Завханд Тосонцэнгэлийн барилгын болон модон эдлэлийн үйлдвэр, Увсад малын тэжээл, чацаргана боловсруулах үйлдвэр, Ховдод Цементийн үйлдвэрийг сэргээж, мөн зарим аймгуудад уул уурхайн үйлдвэр болон хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэр, хүнс, өргөн хэрэглээний барааны үйлдвэрүүдийг байгуулснаар ажилгүйдлийг багасган улмаар амьжиргааны түвшнийг дээшлүүлэх бүрэн боломжтой юм. Гадаргын усны нөөцийн 22,8%, газрын доорх усны 23,1% нь баруун бүсэд байна. Мөн ашигт малтмалын нийт орд, илэрцийн 15,7% нь тус бүсэд байдаг. Бүсийн хэмжээнд 15 төрлийн ашигт малтмалын 300 шахам объект байгаагийн 39 нь 8

төрлийн ашигт малтмалын орд, бусад нь илрэлүүд байгаа бөгөөд тус бүсэд алт, алт-холимог металл, мөнгө, фосфорит, гянтболдын орд газрууд тогтоогдсон бөгөөд ашигт малтмалын хувьд улсын батлагдсан нөөцийн багахан хувийг эзэлдэг сул талтай. Ашигт малтмалын ордуудаас Баян-Өлгийн Асгатын мөнгөний орд, Улаан уулын гянтболдын, Завхан аймагт Баян-Айргийн зэс, алт, фосфоритын, Ховдын Мянгадын Халзан Бүргэтэйн ховор металлын ордуудыг ашиглалтанд яаралтай ашиглалтанд оруулах нь чухал ач холбогдолтой юм. 2007 оны байдлаар Баруун бүсийн ДНБ-д хөдөө аж ахуйн салбар 71,8 хувь, аж үйлдвэр, барилгын салбар 5,4 хувь, үйлчилгээний салбар 22,8 хувийг тус тус эзэлж байгаа нь тус бүсийн эдийн засагт бусад бүсээс илт давуу мал аж ахуйн салбар голлох үүрэг эзэлдгийг илэрхийлнэ. 2007 оны байдлаар нийт малын 30,6% нь баруун бүсэд байна. Нийт малын тоогоор улсын хэмжээнд Завхан аймаг гуравт, Увс аймаг тавд, хонин сүргийн тоо толгойгоор Завхан аймаг нэгд, ямааны тоо толгойгоор Говь-Алтай аймаг нэгд, Ховд аймаг гуравт тэргүүлж байна. Мал аж ахуйн гол үйлдвэрлэгчид нь өрхийн аж ахуй юм. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг (ноос, ноолуур, арьс шир гэх мэт) ямар нэгэн боловсруулалтгүйгээр экспортлож байгаагаас ашиг орлогоо нэмэгдүүлэх ихээхэн нөөц боломжоо алдаж байна. Иймд мал аж ахуйн гаралтай түүхий эдийг шууд экспортлохыг бууруулах замаар эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрүүдийг олноор байгуулан төрөөс эдийн засгийн аргаар дэмжсэн хөшүүргийг хэрэглэх шаардлагатай юм. Махны 28,7 хувь, сүүний нөөцийн 19,9 хувийг, ноос, ноолууран түүхий эдийн 40 шахам хувь, арьс, ширэн түүхий эдийн 36,5 хувийг баруун бүсээс бэлтгэж байна. Баруун бүс нутаг 7-9 тонн мах экспортын зориулалтаар, хонины ноосны 30%, ямааны ноолуурын 34%, ямааны ноосны 35%, адуу, үхрийн хөөврийн 20 шахам хувийг бэлтгэх боломж, чадавхитай. УИХ-аас баталсан “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д Баруун бүсэд Увсын Баяд үүлдрийн хонь, Говь-Алтай үүлдрийн хонь, Завханы Сартуул хонь, Торгууд, Керей хонь, нарийн ноолуурт Өлгийн улаан ямаа, Дөрвөлжний буурал, Алтайн улаан ямаа, Тэсийн адууны цөм сүрэг бүрдүүлж, нутгийн үхрийг махны чиглэлээр үржүүлэн махны экспортыг нэмэгдүүлэх өргөн боломжтой гэж үзжээ. Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлснээр улсын төсөвт орох татварын хэмжээ нэмэгдэхээс гадна малыг эргэлтэнд оруулж, малчдын орлогыг нэмэгдүүлэх улмаар амьжиргааны түвшин дээшлэх чухал ач холбогдолтой юм. Баруун бүсийн нийт тариалсан талбай 1989 оны түвшингээс 91 хувиар буурч, нийт тариалсан талбайн 4,3% нь баруун бүсэд ногдож байгаа зэргээс үзэхэд газар тариалангийн салбар маш сул хөгжсөн болно. Завхан аймагт 98 хувиар, Увс аймагт 90 хувиар тариалсан талбайн хэмжээ буурсан байна. Иймд Ховд, Улиастай хот орчим, Говь-Алтай аймгийн Гуулин, Тахийн тал, Баянтоорой, Увсын Баруунтуруун зэрэг аж ахуйн газруудын олон жилийн баялаг туршлагыг сэргээн үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамлын усалгаатай болон усалгаагүй тариалалтын хэмжээг нэмэгдүүлснээр баруун бүсээ хангах бүрэн бололцоотой юм.

Үйлдвэрлэлийн дэд бүтцийн хөгжлийн түвшний ялгаа ч их байна. Баруун бүс нь төмөр зам болон хатуу хучилттай замын сүлжээ байхгүйгээс төрөл бүрийн замын сүлжээний үнэлгээгээр тус бүс нь хамгийн доогуур үзүүлэлттэй байна.

Иймд баруун бүсийн нутаг дэвсгэр дэх “Мянганы зам”-ын хөндлөн тэнхлэг, босоо тэнхлэгийн хатуу хучилттай авто замыг ойрын хугацаанд барьж дуусгах нь тус бүсийн эдийн засагт чухал ач холбогдолтой юм. Баруун бүсийн цахилгаан эрчим хүчний сүлжээний хангамж улсын дунджаас ихээхэн доогуур байна. Баруун бүсийн Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн төв болон зарим сумууд ОХУ-ын Красноярскийн эрчим хүчний нэгдсэн системээс эрчим хүчээр хангагдаж байгаа бөгөөд тус бүсийг ойрын хугацаанд өөрийн орны эрчим хүчний нэгдсэн системд холбох нь онцгой чухал ач холбогдолтой юм. Баян-Өлгий аймгийн 5 сум, Увс аймгийн 7 сум, Ховд аймгийн 5 сум ББЭХС-д холбогдоод байна. Эрчим хүчний төвлөрсөн хангамжинд холбогдоогүй Завхан, Говь-Алтай аймгууд нь тус бүсдээ эрчим хүчний хангамжаар доогуур түвшинд байна. Эдгээр аймгуудад өндөр зардалтай дизель цахилгаан станц зонхилж байна. Эрчим хүчний нэгдсэн системд холбох боломжгүй алслагдсан хөдөөгийн сууринд нүүрсээр ажилладаг ДЦС, малчдыг сэргээгдэх эрчим хүчээр бүрэн хангах нь чухал байна. Говь-Алтай аймагт 11мвт хүчин чадалтай Тайширын усан цахилгаан станцын ажилд орж, эрчим хүчээр хангагдах найдвар эхлэж байна.

Баруун бүсийн аймгууд нь ОХУ, БНХАУ, Казакстан зэрэг улсуудтай хил залган ойр оршиж байгаа газарзүйн давуу байршлаа ашиглан хөрш зэргэлдээ улс, муж, хязгаар нутагтай худалдаа, эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэлбэрүүдийг өргөтгөж байна. Тухайлбал, ОХУ-лстай Цагааннуур-Ташанта, Боршоо-Тээл Таргалыг, Тэс-Шар суурь, Арцсуурь-Цагаан толгой боомтуудаар, Хятад улстай Бургастай-Лаомяо, Байтаг-Улиастай, Булган-Такашикен, Даян-Хуншаньзюй хилийн боомтуудаар хамгийн дөт замаар нэвтэрч, цаашид худалдаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх бүрэн бололцоотой. 2007 онд дээрхи боомтуудаар нийтдээ 81195 хүн гарч, 53223 хүн орсон байна. Ийнхүү баруун бүсийн аймгуудын эдийн засгийн хамтын ажиллагаанд хил худалдаа зонхилж байна. Хил худалдаанд гаднаас өргөн хэрэгцээний бараа бүтээгдэхүүн

голлож, манай талаас мал аж ахуйн түүхий эд, мөн сүүлийн жилүүдэд мах экспортлох нь нэмэгдэж байна. Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн түвшний ихээхэн ялгаатай байдал нь нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хэмжээ аймгуудаар харилцан адилгүй байгаагаас харагдана. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн(ДНБ)-ий хэмжээгээр баруун бүсийн аймгууд улсын дунджаас 1,8-2,3 дахин бага байгаа бөгөөд Хүний хөгжлийн индексийн эрэмбээр Баян-Өлгий аймаг наймдугаарт, Ховд аймаг арваннэгд, Завхан аймаг арвандөрөвт, Увс аймаг арванзургаад, Говь-Алтай аймаг хорьдугаар байранд байна. Эндээс дүгнэж үзэхэд тус бүсийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн ерөнхий түвшин харьцангуй доогуур байна. Иймд баруун бүсийн түүхий эдийн нөөц, боломжид тулгуурлан хүнсний болон өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийг аймаг, сумдад, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бүсийн тулгуур төвд түшиглүүлэн хөгжүүлж, хөдөөгийн хүн амын ажил эрхлэлтийг нэмэгдүүлснээр амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах нь чухлаар тавигдаж байна.


Баруун бүс нутгийн статистикийн гол үзүүлэлтүүдийг график болон хүснэгтээр доор үзүүлэв.

/Эх сурвалж, 2007 оны Статистикийн эмхэтгэл /

Суурин хүн амын тоо /Хүснэгт 1.9/

| Аймаг      | 2003  | 2004  | 2005 | 2006  | 2007  |
|------------|-------|-------|------|-------|-------|
| Бүгд       | 414.5 | 411.6 | 409  | 410   | 411.1 |
| Баян-Өлгий | 100.8 | 101.2 | 100  | 100.1 | 100.8 |
| Говь-Алтай | 61.4  | 60.9  | 60.4 | 60.3  | 60.2  |
| Завхан     | 82.9  | 80.7  | 80.1 | 80.6  | 81.1  |
| Увс        | 81.9  | 81    | 80.6 | 80.5  | 80.4  |
| Ховд       | 87.5  | 87.8  | 87.9 | 88.5  | 88.6  |


Баруун бүсийн суурин хүн амын тоо, оны эцэст, мян.хүн /Диаграмм 1.7/



Суурин хүн амд хот, хөдөөгийн хүн амын эзлэх хувь, /Хүснэгт 1.10/

| Аймаг      | 2003 |       | 2004 |       | 2005 |       | 2006 |       | 2007 |       |
|------------|------|-------|------|-------|------|-------|------|-------|------|-------|
|            | Хот  | Хөдөө | Хот  | Хөдөө | Хот  | Хөдөө | Хот  | Хөдөө | Хот  | Хөдөө |
| Бүгд       | 29.5 | 70.5  | 29.4 | 70.6  | 29.3 | 70.7  | 29.2 | 70.8  | 28.1 | 71.9  |
| Баян-Өлгий | 30.4 | 69.6  | 30.9 | 69.1  | 30.1 | 69.9  | 30.4 | 69.6  | 29.8 | 70.2  |
| Говь-Алтай | 31.9 | 68.14 | 32.2 | 67.8  | 32   | 68    | 31.9 | 68.1  | 30.7 | 69.3  |
| Завхан     | 22.6 | 77.4  | 21.4 | 78.6  | 20   | 80    | 20.3 | 79.7  | 20.4 | 79.6  |
| Увс        | 29.5 | 70.5  | 27.8 | 72.2  | 29.6 | 70.4  | 28.6 | 71.4  | 27.3 | 72.7  |
| Ховд       | 33.5 | 66.5  | 34.4 | 65.6  | 34.8 | 65.2  | 34.6 | 65.4  | 32.1 | 67.9  |


Баруун бүсийн хотын хүн амын суурин хүн амд эзлэх хувь, мян.хүн /Диаграмм 1.8/



Баруун бүсийн өрхийн тоо, оны эцэст, мян.өрх /Диаграмм 1.9/

Өрхийн тоо /Хүснэгт 1.11/


| Аймаг      | 2003  | 2004 | 2005 | 2006 | 2007 |
|------------|-------|------|------|------|------|
| Бүгд       | 96.2  | 95.9 | 95.6 | 97.3 | 96.4 |
| Баян-Өлгий | 21.8  | 22   | 21.3 | 21.4 | 21.1 |
| Говь-Алтай | 15.2  | 15.1 | 15.5 | 15.6 | 15.2 |
| Завхан     | 20.2  | 19.9 | 19.9 | 20.3 | 20.5 |
| Увс        | 19.8  | 19.6 | 19.8 | 20.1 | 19.9 |
| Ховд       | 19.21 | 19.3 | 19.4 | 19.9 | 19.7 |




1000 хүнд ноогдох төрөлт, нас баралт, гэрлэлт, цуцалт, үрчлэлт /Хүснэгт 1.12/

| Аймаг      | Төрөлт | Нас баралт | Цэвэр өсөлт | Гэрлэлт <sub>1</sub> | Цуцлалт <sub>1</sub> | Үрчлэлт |
|------------|--------|------------|-------------|----------------------|----------------------|---------|
| Бүгд       | 22.5   | 5.6        | 16.9        | 22.3                 | 0.2                  | 1.2     |
| Баян-Өлгий | 24.1   | 4.8        | 19.3        | 32.7                 | 0.2                  | 1.7     |
| Говь-Алтай | 18.9   | 5.6        | 13.3        | 23                   | 0.2                  | 0.9     |
| Завхан     | 20.2   | 6.2        | 14          | 26.4                 | 0.2                  | 1       |
| Увс        | 23.8   | 6.5        | 17.3        | 21.7                 | 0.2                  | 0.8     |
| Ховд       | 22.4   | 5          | 17.3        | 15.7                 | 0.3                  | 1       |

Хүн амын дундаж наслалт, мян.хүн /Диаграмм 1.10/




1000 Хүнд ноогдох төрөлт/мян.хүн/ /Диаграмм 1.11/



Ажиллах хүч  
Эдийн засгийн идэвхитэй хүн ам/Хүснэгт 1.13/

| Аймаг      | 2003 | 2004   | 2005  | 2006 | 2007  |
|------------|------|--------|-------|------|-------|
| Бүгд       | 175  | 172.6  | 173.8 | 176  | 170.7 |
| Баян-Өлгий | 35.3 | 35.369 | 34.2  | 34.8 | 34.6  |
| Говь-Алтай | 30.4 | 30.6   | 30.8  | 31.3 | 26.3  |
| Завхан     | 39.8 | 36.5   | 37.7  | 37.9 | 38.8  |


Эдийн засгийн идвэхтэй хүн амын тоо, мян.хүн, /Диаграмм 1.12/



Ажиллагчдын тоо, мян.хүн /Хүснэгт 1.14/

| Аймаг      | 2003  | 2004  | 2005  | 2006  | 2007  |
|------------|-------|-------|-------|-------|-------|
| Бүгд       | 166.8 | 163.5 | 165.3 | 167.6 | 164.6 |
| Баян-Өлгий | 32.9  | 32.7  | 32    | 32.6  | 32.7  |
| Говь-Алтай | 29.3  | 29.3  | 29.8  | 30.2  | 25.3  |
| Завхан     | 38    | 34.6  | 35.8  | 36.2  | 37.3  |
| Увс        | 32.8  | 32.6  | 32.6  | 32.5  | 32.7  |
| Ховд       | 33.8  | 34.3  | 35.1  | 36.1  | 36.6  |


Ажиллагчдын тоо, мян.х /Диagramм 1.13/



Ажилгүйдлийн түвшин, / Хүснэгт 1.16/

| Аймаг      | 2003 | 2004 | 2005 | 2006 | 2007 |
|------------|------|------|------|------|------|
| Бүгд       | 4.7  | 5.3  | 4.9  | 4.8  | 3.5  |
| Баян-Өлгий | 6.8  | 8.1  | 6.5  | 6.4  | 5.3  |
| Говь-Алтай | 3.5  | 4.2  | 3.3  | 3.4  | 3.9  |
| Завхан     | 4.6  | 5.2  | 5    | 4.5  | 3.7  |
| Увс        | 4.4  | 4.7  | 5.6  | 5.5  | 2.3  |
| Ховд       | 3.9  | 3.9  | 4.1  | 4    | 2.1  |

Ажилгүйдлийн түвшин, /Диagramм 1.15/




Бүртгэлгүй ажилгүйчүүдийн тоо, хүйс, боловсролын түвшингээр /Хүснэгт 1.17/


| Аймаг                    | 2003 | 2004 | 2005 | 2006 | 2007 |
|--------------------------|------|------|------|------|------|
| Бүгд                     | 8166 | 9155 | 8568 | 8390 | 5985 |
| Баян-Өлгий               | 2406 | 2923 | 2216 | 2218 | 1841 |
| Говь-Алтай               | 1053 | 1329 | 1025 | 1056 | 1028 |
| Завхан                   | 1833 | 1901 | 1890 | 1701 | 1419 |
| Увс                      | 1504 | 1583 | 1918 | 1894 | 880  |
| Ховд                     | 1370 | 1419 | 1519 | 1521 | 790  |
| <b>Үүнээс Эмэгтэй</b>    |      |      |      |      |      |
| Бүгд                     | 3973 | 4482 | 4232 | 4237 | 3099 |
| Баян-Өлгий               | 902  | 1182 | 834  | 892  | 743  |
| Говь-Алтай               | 564  | 716  | 552  | 594  | 580  |
| Завхан                   | 1101 | 1145 | 1142 | 1023 | 831  |
| Увс                      | 819  | 840  | 989  | 1026 | 507  |
| Ховд                     | 587  | 599  | 715  | 702  | 438  |
| <b>Дээд боловсролтой</b> |      |      |      |      |      |
| Бүгд                     | 639  | 776  | 857  | 926  | 861  |
| Баян-Өлгий               | 140  | 164  | 145  | 150  | 145  |




Дотоодын нийт бүтээгдэхүүн, /Диаграмм 1.16/




Орон нутгийн төсвийн орлого, /Диаграмм-1.17 /




Орон нутгийн төсвийн зарлага, /Диаграмм 1.18 /




Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, сая.төг /Диаграмм 1.19/




Малын тоо, мян.толгой,  
/Диagramм 1.20/




Тэмээний тоо, мян.толгой,  
/Диagramм 1.21/



Хонь тоо, мян.толгой, /Диagramм 1.22/



Ямаа тоо, мян.толгой, /Диagramм 1.23/



Адуу тоо, мян.толгой,

Үхэр тоо, мян.толгой, /Диagramм 1.25/

Тогтвортой амжиргаа төслийн хүрээнд Эрүүл мэнд, Боловсрол  
Дэд бүтцийг сайжруулах чиглэлээр хийсэн хөрөнгө оруулалт, /Хүснэгт 1.18/

| Боловсрол  |                          |            |                          |            |                          |            |                          |            |                          |            |
|------------|--------------------------|------------|--------------------------|------------|--------------------------|------------|--------------------------|------------|--------------------------|------------|
| Аймаг      | 2003                     |            | 2004                     |            | 2005                     |            | 2006                     |            | 2007                     |            |
|            | Хэрэгжүүлсэн төслийн тоо | Санхүүжилт | Хэрэгжүүлсэн төслийн тоо | Санхүүжилт | Хэрэгжүүлсэн төслийн тоо | Санхүүжилт | Хэрэгжүүлсэн төслийн тоо | Санхүүжилт | Хэрэгжүүлсэн төслийн тоо | Санхүүжилт |
| Бүгд       | 10829                    | 433.8      | 67                       | 283.1      | 128                      | 572.3      | 89                       | 352.4      | 58                       | 272.4      |
| Баян-Өлгий | 29                       | 81.8       | 24                       | 81.2       | 22                       | 116.1      | 22                       | 90.8       | 15                       | 85.8       |
| Говь-Алтай | 16                       | 70.8       | 10                       | 39.2       | 9                        | 32.5       | 8                        | 24.1       | 2                        | 6          |
| Завхан     | 25                       | 94.3       | 9                        | 49.6       | 47                       | 166.5      | 25                       | 93.9       | 15                       | 63.1       |
| Увс        | 18                       | 111.4      | 10                       | 69.1       | 24                       | 195.6      | 19                       | 104.6      | 16                       | 82.5       |
| Ховд       | 20                       | 75.4       | 14                       | 44.1       | 26                       | 61.6       | 15                       | 38.9       | 10                       | 35         |

Эрүүл мэнд  
Ерөнхий боловсролын сургуулийн нэг багшид ноогдох сурагчид, /Хүснэгт 1.19/

| Аймаг      | 2003 |      | 2004 |       | 2005 |         | 2006 |      | 2007 |      |
|------------|------|------|------|-------|------|---------|------|------|------|------|
|            | Бүгд | Бага | Бүгд | Бага  | Бүгд | Бага    | Бүгд | Бага | Бүгд | Бага |
| Баян-Өлгий | 17   | 41.3 | 13   | 40    | 18   | 104.6   | 5    | 42.4 | 6    | 36.1 |
| Бүгд       | 25   | 25.8 | 24.7 | 23.3  | 22.4 | 31.8    | 11   | 35.2 | 12   | 29.6 |
| Говь-Алтай | 8    | 45.4 | 4    | 20.4  | 7    | 21.7    | 11   | 20.7 | 38   | 56   |
| Баян-Өлгий | 23.9 | 71.8 | 22.1 | 21.3  | 29.1 | 93.6    | 15   | 32.9 | 35.8 | 27.2 |
| Завхан     | 24   | 23.7 | 23.2 | 22.2  | 23.1 | 45.0    | 9    | 32.4 | 18.3 | 14.2 |
| Говь-Алтай | 24.4 | 48.8 | 27.7 | 78.24 | 21.5 | 40.70.1 | 19   | 38.9 | 74.5 | 36.8 |
| Увс        | 25.6 | 27.2 | 26.2 | 24.3  | 23.3 | 32.3    | 9    | 35.4 | 18.3 | 10.7 |
| Ховд       | 26.8 | 27.4 | 26.1 | 25.3  | 24.8 | 34.6    | 9    | 38.7 | 34.1 | 33.5 |

| Аймаг      | Бүгд      |           |           |           |           | Бага      |           |           |           |           |
|------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
|            | 2003-2004 | 2004-2005 | 2005-2006 | 2006-2007 | 2007-2008 | 2003-2004 | 2004-2005 | 2005-2006 | 2006-2007 | 2007-2008 |
| Баян-Өлгий | 17        | 41.3      | 13        | 40        | 18        | 104.6     | 5         | 42.4      | 6         | 36.1      |
| Бүгд       | 25        | 25.8      | 24.7      | 23.3      | 22.4      | 31.8      | 11        | 35.2      | 12        | 29.6      |
| Говь-Алтай | 8         | 45.4      | 4         | 20.4      | 7         | 21.7      | 11        | 20.7      | 38        | 56        |
| Баян-Өлгий | 23.9      | 71.8      | 22.1      | 21.3      | 29.1      | 93.6      | 15        | 32.9      | 35.8      | 27.2      |
| Завхан     | 24        | 23.7      | 23.2      | 22.2      | 23.1      | 45.0      | 9         | 32.4      | 18.3      | 14.2      |
| Говь-Алтай | 24.4      | 48.8      | 27.7      | 78.24     | 21.5      | 40.70.1   | 19        | 38.9      | 74.5      | 36.8      |
| Увс        | 25.6      | 27.2      | 26.2      | 24.3      | 23.3      | 32.3      | 9         | 35.4      | 18.3      | 10.7      |
| Ховд       | 26.8      | 27.4      | 26.1      | 25.3      | 24.8      | 34.6      | 9         | 38.7      | 34.1      | 33.5      |

Төрийн болон боловсрол, эрүүл мэндийн байгууллагууд /Хүснэгт 1.20/

| №  | Байгууллага аж ахуйн нэгж, төслийн нэр | Зорилго үйл ажиллагааны чиглэл                                      | Байршил    |
|----|--|---|------------|
| 1  | Баруун бүсийн зөвлөл                   | Бүс нутгийг хөгжүүлэх төр засгийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх. | Ховд       |
| 2  | Бүсийн оношлогоо эмчилгээний төв       | Хүн амд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх                             | Ховд       |
| 3  | “Ховд” их сургууль                     | Дээд мэргэжлийн багш, эдийн засагч, хуульч бэлтгэх                  | Ховд       |
| 4  | ХААИС-ийн Алтай бүсийн салбар          | ХАА-н мэргэжилтэн болон мэргэжлийн ажилчид бэлтгэх                  | Ховд       |
| 5  | “Эрдэм” дээд сургууль                  | Эдийн засаг, бизнесийн чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх                | Ховд       |
| 6  | Хөдөлмөрийн дээд сургууль              | Эдийн засаг, нийгмийн чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх                 | Увс        |
| 7  | “Улаангом” коллежи                     | Хүнс хөдөө аж ахуйн мэргэжилтэн бэлтгэх                             | Увс        |
| 8  | Эдийн засгийн дээд сургууль            | Санхүү эдийн засгийн мэргэжилтэн бэлтгэх                            | Завхан     |
| 9  | Хөгжим бүжгийн коллежи                 | Соёл урлагийн мэргэжилтэн бэлтгэх                                   | Завхан     |
| 10 | “Орхон” дээд сургуулийн салбар         | Гадаад хэлний мэргэжилтэн бэлтгэх                                   | Завхан     |
| 11 | Анагаах ухааны коллежи                 | Хүний бага эмч, сувилагч бэлтгэх                                    | Говь-Алтай |
| 12 | Багшийн коллежи                        | Бага ангийн багш бэлтгэх  | Баян-Өлгий |
| 13 | Монгол-Туркийн хамтарсан дунд сургууль | Англи хэлний мэдлэгтэй ерөнхий боловсрол эзэмшүүлэх                 | Баян-Өлгий |

1.3 НИЙГЭМ СОЁЛЫН САЛБАРЫН ХӨГЖИЛ

1.3.1 Боловсрол соёл, урлаг

Завхан аймаг

2007-2008 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 33 сургууль үйл ажиллагаа явуулж байна. Үүнд ХБК орсон болно. ЕБС-ийн тоог өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад тооны хувьд өөрчлөлт ороогүй байна.

ЕБС-иудын 66,6 хувь буюу 22 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. ЕБС-иудыг өмчийн хэлбэрээр авч үзвэл, нийт сургуулийн 93,9 хувь нь төрийн өмчийн, 6,1 хувь нь төрийн бус өмчийн сургууль байна.

2007-2008 оны хичээлийн жилд үйл ажиллагаа явуулж байгаа ЕБС-иудыг хэрхэн шинээр авч үзвэл, нийт сургуулийн 63,6 хувь буюу 21 нь 1-11 дүгээр анги бүхий ахлах сургууль, 3 хувь буюу 1 нь 10-11 дүгээр анги бүхий ахлах сургууль, 3 хувь буюу 1 нь 5-11 дүгээр анги бүхий мэргэжлийн сургууль, 27,2 хувь буюу 9 нь 1-9 дүгээр анги бүхий дунд сургууль, 3 хувь буюу нь 1-5 дугаар анги бүхий бага сургууль байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн 31 сургууль 9,6 хувь буюу 3 нь цогцолбор сургууль, төрийн бус өмчийн 2 сургууль ахлах сургуулийн хэв шинжээр үйл ажиллагаа явуулж байна.

Сургуулийн тоо /Хүснэгт 1.21/

|                   | Нийт | Ахлах сургууль | Дунд сургууль | Бага сургууль |
|-------------------|------|----------------|---------------|---------------|
| БҮГД              | 33   | 23             | 9             | 1             |
| Төрийн өмчийн     | 31   | 21             | 9             | 1             |
| Төрийн өмчийн бус | 2    | 2              | 0             | 0             |

ЕБС-ийн 607 бүлэгт 17756 суралцагч өдрөөр суралцаж байна. Суралцагчид болон бүлгийн тоог өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад суралцагчдын тоо 47-оор, бүлгийн тоо 3-аар тус тус нэмэгджээ.

Суралцагчдын тоо /Хүснэгт 1.22/

|                  | Бүгд  |      | I    | II   | III  | IV   | V    | VI   | VII  | VIII | IX   | X    | XI   |
|------------------|-------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|
| 2006-2007        | 17709 |      | 1789 | 1756 | 112  | 1287 | 1891 | 1824 | 1689 | 1842 | 1730 | 1380 | 1401 |
| 2007-2008        | 17756 | I    | II   | III  | IV   | V    | VI   | VII  | VIII | IX   | X    | XI   | -    |
|                  |       | 1957 | 1774 | 1733 | 1088 | 1283 | 1838 | 1790 | 1674 | 1809 | 1348 | 1437 | -    |
| Өсөлт<br>Бууралт | 47    |      | -15  | -23  | -32  | -4   | -53  | -34  | -15  | -33  | -382 | 57   | -    |

ЕБС-д суралцагчдын 68,2 хувь болох 12126 нь хөдөө орон нутагт, 31,7 хувь болох 5630 нь аймгийн төвд суралцаж байна. Суралцагчдын тоо өнгөрсөн жилийнхээс Тэс/21/, Шилмүүс/29/, Улиастай Чандман эрдэнэ цогцолбор /60/-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Суралцагчдын 44,2 хувь бага ангид, 40 хувь нь дунд анги, 15,6 хувь нь ахлах ангид ноогдож байна. Суралцагчдын тоог өнгөрсөн онтой харьцуулахад бага анги 17-оор, дунд анги 26, ахлах анги 4-өөр тус тус нэмэгдсэн байна. Нийт суралцагчдын 1,1 хувь нь төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 2 сургуульд суралцаж байна. Суралцагчдын 49,5 хувь нь эмэгтэй суралцагч байна. Суралцагчдын хүйсийн харьцаа бага дунд ангийн түвшинд ялгаа бага, харин ахлах ангид охид давамгайлах хандлага ажиглагдаж байна.

ЕБС-д өдрөөр суралцагчдын 11 хувь нь I ангид элсэн суралцагчдын дотор 5-аас доош настай 15, 5 настай суралцагч 12 байгаа нь нийт суралцагчдын 0,2 хувь, I ангид элсэн суралцагчдын 1,4 хувь байна. 6 настай суралцагч 627 буюу 32 хувь, 7 настай суралцагч 1188 буюу 60,7 хувь, 10 настай суралцагч 6 буюу 0,3 хувь байна. 7 настай нийт /1701/ хүүхдийн 90,4 хувь нь ерөнхий боловсролын сургуульд суралцаж байна. X ангид 1348 хүүхэд сурч байгаа нь өмнөх хичээлийн жилийнхтэй харьцуулахад 32-оор буурчээ. Энэ хичээлийн жилд IX анги төгсөгчдийн 77,9 хувь нь X ангид элсэн суралцаж байна.

2007-2008 оны хичээлийн жилд нийт ЕБС-д 1517 багш ажиллагсад ажиллаж байна. Тэдний 54,8 хувь буюу 831 нь үндсэн багш нар байна. Үндсэн багшийн 79,8 хувь буюу 663 нь эмэгтэй бөгөөд өнгөрсөн хичээлийн жилийнхээс багшийн тоо 33 багшаар нэмэгдсэн байна. Аймгийн хэмжээнд дутагдалтай багш 7 байна. Нийт үндсэн багш нарын 31,9 хувь нь бага анги, 42,1 хувь нь дунд анги, 26 хувь ахлах ангийн багш нар байна. Мөн 33 цэцэрлэгийн 114 бүлэг 119 багш хүмүүжүүлэгч ажилтан 3286 хүүхэд хүмүүжүүлж байна.

Монгол Улсын Их сургуулийн Завхан дахь эдийн засгийн салбар сургууль 5 мэргэжлээр 206 оюутан, бакалаврын эчнээ сургалтанд 50 хүн элсэж, өдрийн ангиар 95 оюутан 4 мэргэжлээр төгссөн, одоо 725 суралцагчидтай боллоо.

Орхон гадаад хэлний дээд сургууль нь 16 оюутныг 2-р курсыг төгссөн Улаанбаатарын салбарт шилжүүлэн, одоо 1, 2-р курс 31 оюутан суралцаж байна. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 9 мэргэжилээр 107 хүүхэд, түр сургалтаар 236 хүн төгссөн, энэ онд 10 мэргэжилээр 220 хүүхэд элсүүлэн авч, дотуур байранд 140 хүүхэд амьдардаг

### Ховд аймаг

2007-2008 оны хичээлийн жилд 24 сургуулийн 662 бүлэгт 21.8 мянган хүүхэд суралцаж 27 цэцэрлэгийн 92 бүлэгт 2.8 мянган хүүхэд хүмүүжиж байна. ЕБС-ын сургуульд 881 багш сурган хүмүүжүүлэгч, нийт 1460 хүн ажиллаж байна. Багш нарын дунд магистр 100, зөвлөх 17, тэргүүлэх 204, арга зүйч 232 байгаа нь нийт багш нарын 62.7 хувийг эзэлж байна. Аймгийн хэмжээнд анги дүүргэлт 33, нэг багшид ногдох хүүхдийн тоо 24 байна. Энэ хичээлийн жилд аймгийн хэмжээнд 17 дотуур байранд нийт 2165 хүүхэд амьдарч байна. Шинээр 1-р ангид 2575 хүүхэд элсэн орж үүний 82.3 хувь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан, 458 буюу 17.7 хувь нь 6 ба түүнээс доош насны хүүхэд байна.

Сурагчдын тоогоор хамгийн олон сурагчидтай нь Жаргалант сумын 1-р 11 жилийн сургуульд 2004, хамгийн цөөн хүүхэдтэй нь Дуут сумын 11 жилийн сургуульд 311 хүүхэд тус тус суралцаж байна.

Багш сурагчид улсын олимпиадаас 9 медаль, бүсийн олимпиадаас 11, нийт 20 медаль хүртэж, заах арга ур чадвар, сурган хүмүүжүүлэх илтгэлийн уралдаанд оролцсон багш нар 3-р байр эзэлсэн байна. 24 сургууль, хүүхдийн 27 цэцэрлэг, 16 соёлын төвийн ажилд зөвлөн туслах баг ажиллуулж, давхардсан тоогоор 597 багшийн ажилтай танилцаж, 9230 суралцагчийн мэдлэгийн түвшин тогтоов. Ерөнхий шалгалтанд нийт 1694 хүүхэд бүртгэгдэж уралдаант шалгалт өгч нийт шалгуулагчдын 80 хувь нь их дээд сургуульд элсэн суралцаж байна. Их дээд 3 сургуульд 2.7


мянган оюутан суралцаж, 152 багш сурган хүмүүжүүлэгч ажиллаж байна. Соёл урлагийн байгууллагын ажилтнууд аймаг бүс болон улсын чанартай уралдаан тэмцээнээс нийт 35 медаль хүртсэн байна. ХДТеатр шинээр 4 уран бүтээл тавьж 194 удаагийн тоглолт хийж 7.8 мянган үзэгчдэд үйлчилжээ. Өнгөрсөн онтой харьцуулахад үзэгчид, орлого нь 2.6-26.8 %-иар өссөн байна. ОНСМузей нийт 3.2 мянган үзмэрээр 3.6 мянган хүнд үйлчилж, 51 үзмэрээр баяжуулалт хийсэн байна. Өнгөрсөн онтой харьцуулахад үзэгчид 1.4 мянган хүн буюу 63.6 %-иар нэмэгдсэн байна. Нийтийн номын сан 805 номоор фондоо баяжуулж 3.7 мянган уншигчдад 70.0 мянган номоор үйлчилжээ. Урьд оноос 27 номоор, 0.8 мянган уншигчид нэмэгдсэн байна.

**Баян-Өлгий аймаг**

2007-2008 оны хичээлийн жилийн эхэнд ерөнхий боловсролын сургуульд суралцагсдын тоо 23.8 мянга болж, өнгөрсөн оныхоос 523 хүүхдээр их буюу 2.2 хувиар нэмэгдлээ. 1-р ангид элсэгчдийн тоо өнгөрсөн оныхоос 11.1 хувиар өссөн байна. Ерөнхий боловсролын сургуулийн 9.11-р ангийг 3552 хүүхэд, мэргэжлийн анхан дунд шатны боловсролыг 144, их дээд сургууль коллежийг 134 хүүхэд төгссөн байна

**Увс аймаг**

2007-2008 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 2 цогцолбор, 10 ахлах, 9 дунд, 6 бага сургуулийн өдрийн ангид 20.5 мянган хүүхэд суралцаж байна. 2006 оноос суралцагчдын тоо аймгийн дүнгээр 1.4 хувиар буюу 291 хүүхдээр буурсан байна. Зүүнговь, Малчин, Өлгий, Өндөрхангай, Тэс, Ховд, Хяргас сумдын суралцагчдын тоо 13-54 хүүхдээр нэмэгдэж бусад бүх сумдад буурсан байна. Улаангом сумын суралцагчдын тоо 2006 оноос 194 хүүхдээр буурлаа.



2006-2007 оны хичээлийн жилд бүх шатны сургуулийг 3672 хүн төгссөнөөс ерөнхий боловсролын сургуулийг 3.3 мянган охид, хөвгүүд, / 9-р ангийг 2013, 11-р ангийг 1316 / мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг 264, дээд сургуулийг 79 хүүхэд тус тус төгсчээ. 2006 оноос төгсөгчдийн тоо 150 хүүхдээр нэмэгдсэн байна.




|                 | 2004-2005 | 2005-2006 | 2006-2007 | 2007-2008 |
|-----------------|-----------|-----------|-----------|-----------|
| Улаангом коллеж | 968       | 961       | 1002      | 1131      |
| ХДС салбар бүгд | 176       | 175       | 167       | 175       |

2007-2008 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 1-р ангид 2280 хүүхэд элсэж орсон нь өмнөх хичээлийн жилээс 27 хүүхдээр цөөн байна. Дээд сургууль, коллежид 1453 оюутан суралцаж байгаа нь 2005-2006 оны хичээлийн жилийнхээс 137 хүнээр нэмэгдсэн байна. ЕБС-д 895 багш ажиллаж нэг багшид дунджаар 23 хүүхэд ноогдож байгаа нь өмнөх хичээлийн жилийнхээс 1 хүүхдээр буурсан байна. 2007 онд 2365 ортой

ЕБС-д өдрөөр суралцагчид багшлах боловсон хүчний тоо

| Сургуулийн хэв шинж | Бүгд  | Эмэгтэй | Багшийн тоо | Үүнээс эмэгтэй |
|---------------------|-------|---------|-------------|----------------|
| цогцолбор           | 7884  | 4097    | 328         | 247            |
| ахлах               | 8005  | 4163    | 347         | 257            |
| дунд                | 4155  | 2074    | 189         | 154            |
| бага                | 503   | 229     | 31          | 24             |
| ДҮН                 | 20547 | 10563   | 895         | 682            |
| ӨОМУГ               | 20838 | 10748   | 867         | 658            |

хүүхдийн дотуур байранд 3423 хүүхэд амьдарч байгаа бөгөөд үүний 95.6 хувь нь малчдын хүүхэд байна. Энэ хичээлийн жилд сургуулийн өмнөх 158 бүлэгт 5.1 мянган хүүхэд



хамрагдсаны 2.7 мянга нь эмэгтэй хүүхэд байна.

үзэгчдийн тоо 7.4, орлого нь 27.8 хувиар өсчээ. Төв номын сан 3.1 мянган байнгын уншигч, 21.9 ирэгсдэд 34.4 мянган номоор үйлчилж 544.1 мянган төгрөгийн орлоготой ажилласан ба өнгөрсөн оны мөн үеэс уншуулсан ном 0.3 хувиар буурч, орлого нь 42.8 хувиар өсчээ.

**1.3.2 Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал**

**Завхан аймаг : Хөдөлмөр, халамж, нийгмийн даатгал**

Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүд 1419 хүн, ажлын байраар 2031 хүн хангагдаж 39,8 мянган хүн хөдөлмөр эрхэлж, ажилгүйдлийн түвшин 3,7 хувь болж өнгөрсөн оноос 0,8 хувиар буурсан байна. Хөдөлмөр эрхлээгүй 770 хүнийг сургалтанд хамруулж, сургалтанд хамрагдсан хүний 49,9 хувь нь ажлын байртай боллоо.

2007 онд 31516 хүүхэд мөнгөн тэтгэмж 1053,1 сая төгрөг, шинээр төрсөн 1343 хүүхэд 177,3 сая төгрөгний мөнгөн тусламж, 1843 хүнд 576,6 сая төгрөгний халамжийн тэтгэвэр нийт 55353 хүнд 6605,6 сая төгрөгний халамжийн тэтгэвэр, хөнгөлөлт үзүүллээ.

Нийгмийн даатгалын хэлтэс нь тэтгэвэрийн даатгалын санд 1812,3 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын санд 187,5 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын санд 2 тэр бум 986,6 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 107,2 хувиар биелүүллээ. Тэтгэвэрийн 9701 хүнд 6124,1 сая төгрөгний тэтгэвэр, 593 хүнд 116,8 сая төгрөгний тэтгэмж олгож, эрүүл мэндийн даатгалд 48354 хүн, сайн дураар 831 хүнийг хамрууллаа.

**Ховд аймаг : Нийгмийн халамж, даатгал**

Аймгийн дүнгээр 64.3 мянган хүнд 8.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт олгосноос 51 хүнд 21.1 сая төгрөгийн нөхөн олговор, 6013 хүнд 4710.8 сая төгрөгийн өндөр насны тэтгэвэр, 1631 хүнд 470.8 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, 37 ахмад настанд 5.7 сая төгрөгийн хөнгөлөлт, 2830 жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд 468.5 сая төгрөг, шинээр гэр бүл болсон 1500 хүнд 750.0 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй 223 хүнд 14.1 сая төгрөгийн тусламж, 37.8 мянган хүүхдэд 1293.0 сая төгрөгийн хүүхдийн мөнгөн тусламж зэрэг тэтгэвэр, халамж үйлчилгээ, хөнгөлөлтүүдийг олгосон байна.


Эрүүл мэндийн байгууллагууд 352.6 мянган хүнд үзлэг хийснээс 27.4 хувийг нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, 168.2 мянган ор хоногоор үйлчилж, 2012 эхийг амаржуулж 2020 хүүхэд эх барьж авсан байна. Өнгөрсөн оноос нийт үзлэг 3.5 %-иар буурсан байна.

Нийт эмнэлэгт 391 хүн нас барсны 9.7% нь 0-1 насны хүүхэд, 2.3 % нь 1-5 насны хүүхэд эзэлж байна. Өнгөрсөн оноос нийт нас баралт 64 хүн буюу 14.1 %-иар буурч, эхийн эндэгдэл 2 гарсан байна.

Халдварт өвчнөөр бүгд 416 хүн өвчилсны 92 буюу 212.1 % нь халдварт шар, 10.3 % буюу 43 нь сүрьеэ, 45.4 % буюу 189 нь бэлгийн замын халдварт өвчнөөр /заг хүйтэн, тэмбүү, трихомониаз,/ 5.5% буюу 23 нь салхин цэцэг, 8.6 % буюу 365 нь мөөгөнцөр, 4.8% буюу 20 нь цусан суулга, 3.1% нь бусад халдварт өвчнөөр өвчилсэн байна. Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид урьд оноос 60.0%-иар буюу 277 тохиолдлоор буурсан байна.

**Увс аймаг : Эрүүл мэнд**

Энэ оны эцэст 1794 хүүхэд амьд төрсөн нь 2006 оныхоос 0.8 хувь буюу 14-өөр буурлаа. Амаржсан эхчүүдийн тоо аймгийн хэмжээгээр 2007 онд 1792 болж 1.0 хувиар буюу 18-аар буурсан байна. Төрөлт 2006 оноос Давст, Улаангом сумдад нэмэгдэж бусад сумдад буурсан байна. Гэрийн төрөлт 21 гарсан нь өнгөрсөн оноосоо 14 гаралтаар нэмэгдсэн, 22 хүүхэд амьгүй төрсөн нь өнгөрсөн оноос 2 тохиолдлоор бага байна. 100000 амьд төрөлтөнд ноогдох эхийн эндэгдэл 2007 онд 2006 оныхоос 0.4 пунктээр нэмэгдэж, 1 эх эндлээ. Хүн амын нас баралт 443 гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 7.7 хувиар бага байна.




Нэг хүртэлх насандаа 63 хүүхэд эндэж, 2006 оныхоос 24 хүүхдээр нэмэгдэж, 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо 9 болж өнгөрсөн оны түвшинд байна. Аймгийн дунджаар амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 35 нь нэг хүртэл насандаа эндэсний дотор Тариалан / 125/, Бөхмөрөн / 120 /, Ховд / 104 /, Завхан / 83 /, Цагаанхайрхан / 80 /, Малчин / 71/, Өлгий / 56/, зүүнговь / 48/, Тэс / 40/, Өндөрхангай / 38 / сумуудад аймгийн дунджаас дээгүүр байна.

Нийт нас баралтын 19.9 хувийг эмнэлгийн нас баралт, 4.7 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна. Осол гэмтлийн улмаас 55, хорт хавдрын улмаас 109, халдварт өвчний улмаас 6 хүн нас баржээ. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 731 болж 2006 оныхоос 12.8 хувиар буюу 83 хүнээр нэмэгдлээ. Аймгийн дунджаар 10.0 мянган хүн тутамд ноогдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 90 болж 2006 оныхоос 10 хүнээр нэмэгдсэн байна. 10000 хүнд ноогдох халдварт өвчний гаралтаар Давст, Тариалан, Улаангом, Өлгий сумдууд аймгийн дунджаас дээгүүр бусад сумдад доогуур байна.

Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 28.6 хувь нь гепатит, 35.8 хувь нь БЗХӨ, 7.0 хувь нь сүрьеэгээр, 1.4 хувь нь мөөгөнцрөөр, 7.5 хувь нь гахайн хавдраар, 19.7 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчлөгчид эзэлж байна. 10000 хүнд ноогдох сүрьеэгийн өвчлөл Улаангом, Зүүнговь, Малчин, Түргэн, Тэс, Цагаанхайрхан сумдад аймгийн дунджаас дээгүүр, бусад сумдад доогуур байна.

2006 онтой харьцуулахад хамуу гаар өвчлөгчдийн тоо 11 дахин, хүйтэнээр өвчлөгчдийн тоо 2.5 дахин, тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 2.2 дахин, гахайн хавдраар өвчлөгчдийн тоо 17.0 хувиар, улаанууд өвчнөөр өвчлөгчдийн тоо 100 хувь, цусан суулгаар өвчлөгчдийн тоо 40.0 хувиар, салхинцэцэгээр өвчлөгчдийн тоо 68 хувиар тус тус өсч, харин гепатитаар өвчлөгчдийн тоо 30.8 хувиар, сүрьеэгээр өвчлөгчдийн тоо 10.5 хувь, бруцеллэзоор өвчлөгчдийн тоо 29.2 хувиар, мөөгөнцрөөр өвчлөгчдийн тоо 58.3 хувь, боом өвчнөөр өвчлөгчдийн тоо 50 хувиар тус тус буурч, суулгалт халдвар, мэнэн өвчнүүд гараагүй байна.

Хувийн хэвшлийн эмнэлгүүд 13.2 мянган хүнд үзлэг эмчилгээ, оношлогоо, шинжилгээ хийж 29.1 сая төгрөгийн төлбөртэй үйлчилгээ үзүүлж 2006 онтой харьцуулахад үйлчлүүлсэн хүний тоо 5 мянгаар, төлбөрт үйлчилгээний орлого нь 8.6 саяар нэмэгдсэн байна. Амбулаториор 362.6 мянган хүнд үзлэг хийгдэж, стационариар 18.3 мянган хүн эмчлэгдсэн байна



**Баян-Өлгий аймаг : Нийгмийн үзүүлэлт**

Нийгмийн даатагалын шимтгэлийн төлөвлөгөө 13.1 хувиар буюу 358.5 сая төгрөгөөр давж биелэгдсэн нь урьд оныхоос 46.8 хувиар нэмэгдсэн байна. Авлага өнгөрсөн оноос 40.6 хувиар буурсан ба эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэл 48.5 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 52.6 хувиар өссөн байна. 2007 оны нийгмийн халамжийн сангаас 66262 хүнд үйлчилгээ үзүүлсний дотор 2923 хүнд хүүхэд асарсны тэтгэмж, 44054 хүүхдэд хүүхлийн мөнгөн тэтгэмж, 2610 хүүхэд нүдний болорын болон шилний хөнгөлөлт, 226 хүнд рашаан сувилалын хөнгөлөлт үзүүлсэн байна.

**Баян-Өлгий аймаг : Эрүүл мэнд**

Эрүүл мэндийн байгууллагууд ор хоногийн төлөвлөгөөг 6.2 хувиар тасалж, амбулаторын үзлэгийг 9.1 хувиар нэмэгдүүлсэн байна. Төрсөн эхийн тоо 2520 болсон нь өнгөрсөн оныхоос 115 хүнээр их байна. Эхийн эндэгдэл өнгөрсөн оныхоос 2 дахин их буюу 3 хүнээр нэмэгджээ. 0-1 насны хүүхдийн эндэгдэл 46 болж өнгөрсөн оныхоос 12.2 хувиар, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 19 болж өнгөрсөн оныхоос 11.8 хувиар тус тус өссөн байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 455 болж өнгөрсөн оныхоос 51 хүнээр буюу 12.6 хувиар өссөн байна.

**Хоёр. ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ХӨГЖИЛ**

**2.1 ҮЙЛДВЭРЖИЛТ**

**2.1.1 Уул уурхайн үйлдвэр**

Баруун бүсийн хэмжээнд нийт 15 төрлийн ашигт малтмалын 294 объект байгаагаас 39 нь 8 төрлийн ашигт малтмалын орд, бусад нь илрэлүүд байна. Үүнд: алтны 12, алт-холимог металлын 2, мөнгөний 1, зэсийн 2, мөнгө-холимог металлын 1, гянт болдын 3, газрын ховор элемент, төмөр ба фосфоритын тус бүр 1, нүүрсний 15 орд тус тус судлагджээ.

Эдгээр ордуудад 0.5 тонн алт (Монгол улсын бодогдсон нийт нөөцийн 0.35%), 2850.0 тн мөнгө (33.0%), 124.9 мян.тн зэс (2.0%), 33.6 мян.тн гянтболд (20.0%), 94.6 сая тн нүүрс (1.0%), 31.6 сая тн фосфорит (11.0%) агуулагдаж байна.

Дээр дурдсан нөөц баялгийг үндсэндээ 1990 оноос өмнө улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн бөгөөд 1990 оноос хойш улс орны эдийн засаг уналтанд орж, зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үе сунжирсантай холбоотойгоор алтны ордуудын болон мөнгөний зарим (Асгат, Тавт) ордын нөөцийг шинээр нэмэгдүүлснийг эс тооцвол бусад ашигт малтмалын төрлөөр үйлдвэрлэлийн зэргээр нөөц бэлтгэх ажил хийгдээгүй байна.

Харин 1997 онд “Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль” батлагдан, мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор АМХЭГ-ыг байгуулж, Монгол орны геологийн судалгаа, уул уурхайн



асуудлыг хариуцуулснаар ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлыг гүйцэтгэх үйл явцад зарчмын өөрчлөлт гарч, эрчимжиж байна.

Монголын баруун бүсийн Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий аймгуудын нутаг дэвсгэр дээр нийт 104 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 61 аж ахуйн нэгж 20200 га табайд үйл ажиллагаа явуулж байгаагаас алт 39, нүүрс 33, барилгын материал 8 болон давс, бусад металл олборлон үйл ажиллагаа үзүүлж байна. Нийт 39 алтны тусгай зөвшөөрөл байгаагаас 17 нь буюу 66% нь Увс аймгийн нутаг дэвсгэр дээр байна.

Увс аймгийн нутагт үйл ажиллагаа явуулдаг Дацантрейд компани 2006 онд 7,45кг, 2007 онд 6,72кг алт олборлосон бол 2008 онд 52,5кг болтлоо өссөн байна.

Баян-Өлгий аймгийн нутагт үйл ажиллагаа явуулдаг СС Монголия компани 2006 онд 0.14 тн, 2007 онд 62.5 тн, 2008 онд 100 тн гянтболд тус тус олборложээ. Говь-Алтай аймгийн нутагт үйл ажиллагаа явуулдаг Гоби Коул анд Энержи компани 2006 онд 3 мян.тн, 2007 онд 4 мян.тн нүүрс тус тус олборлосон байна.

Монголд орны баруун бүсийн Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий аймгууд нь Геологи уул уурхайн салбарт томоохон байр суурь эзэлдэг бөгөөд Монгол орны хэмжээнд 1100 гаруй ашиглалтын тусгай зөвшөөрөл байгаагаас 104 нь тус аймгуудын нутаг дэвсгэрт байна. Баруун бүсийн аймгуудаар геологи хайгуулын ажил эрчимтэй хийгдэж байгаа бөгөөд цаашид ашигт малтмал үйлдвэрлэлийн хэмжээ өсөх хандлагатай байна.

Үйлдвэрлэлийн зэргээр бэлтгэгдсэн нөөцийг улсын хэмжээгээр нэгтгэн, ашигт малтмалын төрлүүдээр дүгнэж үзвэл:

**Зэс** - Монгол орны нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн зураглал, эрэл үнэлгээ, хайгуулын шат дараалсан ажлын үр дүнд нийт 7.7 сая тонн (урьдчилан үнэлсэн ба таамагласан эрдсийн баялагтайгаа нийт 15,0 сая тонн орчим) зэсийн нөөц бүхий зэс, зэс-молибдений 6 орд, олон тооны илрэлүүдийг тогтоосноос Эрдэнэтийн овоо (6.2 сая тн), Цагаан суваргын (1.3 сая тн) ордуудын нарийвчилсан хайгуулын ажлыг хийж, нөөцийг баталгаажуулсан байна.

Оюу толгойн алт-зэсийн илрэл нь өнөөдрийн хийж буй судалгааны ажлын тоймоос үзэхэд дээрх ордуудын ижил орд болох магадлалтай байгаа бөгөөд хайгуулын ажлыг эрчимтэй гүйцэтгэн 2004 онд ордын геологийн нөөцийн ерөнхий үзүүлэлтүүд тодорхой болно.

**Молибден** - Молибдений 7 ордод 389.6 мян.тн нөөц батлагдсан бөгөөд дайвар бүтээгдэхүүн хэлбэрээр буюу хам баяжмалаар гаргах боломжтой хэд хэдэн орд, илрэлүүд байгаагаас Эрдэнэтийн овоо (173.3 мян.тн), Цагаан суваргын (43.6 мян.тн), Югзэрийн (12.3 мян.тн) ордуудын нарийвчилсан хайгуулын ажлыг хийж, нөөцийг баталгаажуулсан байна.

**Гянт болд** - Гянтболдын 26 ордод 116,7 мян.тн гянтболдын ислийн нөөцийг тогтоосон бөгөөд томоохон нь Улаан уул (Кызыл тау), Цүнхэг, Ховд голын (баруун бүс), Онгон хайрхан, Цагаан даваа, Оорцог уулын (төвийн бүс), Югзэр, Салаа, Модотын бүлэг, Хужхааны бүлэг, Ононгийн бүлэг, Дээд кумырийн бүлэг (зүүн бүс) зэрэг болно.

**Цагаан тугалга** - Цагаан тугалганы нөөцийг тогтоосон 18 орд байгаагаас (нийт нөөц нь 47.5 мян.тн) Элстийн бүлэг, Жанчивлангийн бүлэг, Авдарантын бүлэг, Хар морьтын бүлэг, Хар овоогийн бүлэг (төвийн бүс), Модотын бүлэг, Хужхааны бүлэг, Ононгийн бүлэг, Дээд Кумырийн бүлэг (зүүн бүс) зэрэг шороон ордууд нь дэд бүтэц, уул геологийн нөхцөл сайтай байрлалтай. Нийт нөөцийн 87% нь төвийн, 13% нь зүүн бүсэд байршина.

**Холимог металл (цайр, хар тугалга)** - Холимог металлын орд 19, олон тооны илрэл тогтоогдсоны ихэнх нь зүүн бүсэд байгаа бөгөөд эдгээрээс Улаан, Төмөртийн овоо, Салхит, Цав, Баяндун-1, Мухар, Мөнгөн өндөр (зүүн бүс) зэрэг ордуудад хайгуул хийж, нөөц тогтоосон, дэд бүтэц, байршлын хувьд ашиглахад тохиромжтой.

Зүүн бүсийн холимог металлын хүдрийн бэлэн нөөц нийтдээ 60 гаруй сая тонн бөгөөд тэдгээрт хар тугалга 1864.1 мян.тн, цайр 2563.6 мян.тн, алт 7,1 тн (Улаан), мөнгө 5669.9 тн (Цав, Мөнгөн өндөр) агуулагдсан байна. Төвийн бүсийн Билүүт, Хар толгой, Хараат уул, Төмөртэй, Далан ухаа, баруун бүсийн Нүхний нуруу, Дулаан хар уул, Боорж зэрэг ордуудад хайгуул хийгээгүй, эрдсийн баялгийг тоймлон тодорхойлсон байна.

**Хөнгөн цагаан** - Хангайн (Дөшийн гол, Өвөр мараат, Дунд хэм гол, Бэлтэсийн гол зэрэг) ба төвийн (Жаргалант, Төмөрлөг оройвч, Даваа, Сэртэн номгон, Шүтээн зэрэг) бүсүүдэд хөнгөн цагааны түүхий эдийн хэтийн төлөв бүхий 20 гаруй илрэл тэмдэглэгдсэн. Хайгуул хийсэн орд байхгүй, зөвхөн эрдсийн баялгийг тоймлон тодорхойлсон байдаг.

**Алт** - 2001 оны балансад тусгагдсанаар үйлдвэрлэлийн зэргээр батлагдсан алтны нөөцийн хэмжээ 143.8 тн, үүнээс үндсэн ордын нөөц 60 гаруй тонн байна. Нөөцийн дундаж өсөлт одоогийн түвшинд байна гэж үзвэл алтны шороон ордын бэлтгэгдсэн нөөцийг одоогийн хурдцаар 20 орчим жил ашиглах боломжтой.

Алтны үндсэн ордын тойм судалгаа, геологийн зураглал, эрлийн ажлын явцад нийтдээ алтны орд, илрэлийн урьдчилан үнэлсэн болон таамагласан эрдсийн баялгийг 2000 тн орчим гэж баримжаалсан бөгөөд хайгуулын шатанд Бороогийн ордод 43.8 тн, Олон овоотод 1.1 тн (төвийн бүс), Улааны алт-холимог металлын ордод 7.1 тн (зүүн бүс), Тавтын ордод 2,9 тн нөөц бэлтгэгдсэн.

**Мөнгө** - Мөнгөний үйлдвэрлэлийн зэргээр бэлтгэгдсэн нөөц нь Цав (1184,7 тн), Мөнгөн өндөр (4485,2 тн), Салхитын (233,8 тн) мөнгө-холимог металлын (зүүн бүс), Асгатын мөнгөний (2850.0 тн – баруун бүс) ба Оорцог овооны мөнгө-цагаан тугалганы (12.1 тн- төвийн бүс) ордуудад төвлөрсөн байна. Тавтын алт-мөнгө-зэсийн ордод (хангайн бүс) 11,9 тн мөнгөний нөөц бэлтгэгдсэн.

**Цагаан алт** - Өнөөгийн байдлаар Монголд цагаан алтны орд тогтоогдоогүй, цөөн тооны илрэл л мэдэгдэж байна. Гэвч орд илрүүлэх боломж, хэтийн төлөв өндөр байгааг сүүлийн үеийн геологийн зураглал, эрэл хайгуулын ажлын үр дүнд тодруулж байна. Тухайлбал: 1990-ээд оны сүүлчээс эхлэн Увс нуурын баруун талаар Цагаан шивээтийн бүсийг даган, мөн Хан хөхийн нурууны орчмын (баруун бүс) болон Баянхонгорын офиолитын комплексын орчинд буюу Өлзийт, Байдрагийн голуудын савыг (хангайн бүс) дагасан алтны шороон ордуудад дагалдах хэлбэрээр цагаан алт ихээр гарч байна.

Энэ нь манай улсад цагаан алтны шинжилгээ хийдэггүй, өмнөх судалгааны үе шатанд анхаарал хандуулж байгаагүйтэй шууд холбоотой бөгөөд цагаан алтны хүдэржилтийн шууд (цагаан алт гарч буй уурхайнууд) ба шууд бус (офиолит комплексуудтай холбоотой хэт суурилаг болон суурилаг чулуулгууд тархсан талбай, хромитын хүдэржилт бүхий илрэлүүд г.м.) шалгууруудыг тулгуурлан сэдэвчилсэн судалгааны ажил гүйцэтгэвэл шинээр орд, илрэлүүдийг илрүүлэх магадлал өндөр юм.

**Төмөр** - Төмрийн хүдрийн 12 орд тэмдэглэгдээд байгаагаас сайн судлагдсан ордууд нь төвийн (Төмөртэй, Төмөр толгой, Баян гол, Хонгор /Дарцагт/, Эрээн, Чандмань уул - нийт нөөц нь 420.3 сая тн) ба зүүн (Баргилт, Навчит гол – нийт нөөц нь 354.2 сая тн) бүсүүдэд, үндсэндээ хүдрийн хоёр бүсэд оршино. Үүнд: Төмөртэй, Төмөр толгой, Баян голын ордууд орших Сэлэнгэ-Дарханы бүс, Хонгор /Дарцагт/, Эрээн, Чандмань уул, Баргилтын ордууд орших Дундговь-Дорноговийн бүс.

Эдгээрээс зонхилох нөөц нь (364.2 сая тн) дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн Сэлэнгэ, Дарханы районд төвлөрнө. Дээрх ордуудаас хүдрийн нөөц, агуулга, чанараар бусдаас давуутай, хамгийн сайн судлагдсан нь Төмөртэйн орд бөгөөд 229.3 сая тн нөөцтэй, хүдрийн нөөцийн 40% нь исэлдсэн буюу хүхэр багатай, агуулга ихтэй (51.64%), металлургийн үйлдвэрлэлд тохиромжтой сайн чанарын хүдэр юм. Улсын хэмжээнд үйлдвэрлэлийн зэргээр батлагдсан 774.5 сая тн нөөцтэй.

**Мангаан** - Одоогоор хангайн бүсэд орших Сайхан голын төмөр-мангааны орд дээр л 65.6 сая тн мангааны урьдчилан үнэлсэн баялаг бодогдсон бөгөөд, Хатгал (хангайн бүс), Хаалгын нуруу (төвийн бүс), Хаг нуур (баруун бүс) зэрэг ирээдүй сайтай илрэлүүд бий.

**Хром** - Өнөөдрийн байдлаар муу судлагдсан бөгөөд хромын цөөн тооны үндсэн болон шороон илрэлүүдэд эрдсийн баялгийг тооцсон байна. Цагаан алттай хамтад нь сэдэвчилсэн судалгааны аргаар судалбал зохилтой.

**Газрын ховор элемент** - Газрын ховор элементийн 4 орд тогтоогдсоны 3 нь төвийн бүсэд (Лүгийн гол, Мушгай худаг, Баян хошуу), 1 нь баруун бүсэд (Халзан бүргэтэй) оршино. Зөвхөн Лүгийн голын орд дээр үйлдвэрлэлийн зэргээр нөөц бодсон байна.

**Нүүрс** - Нүүрсээр Монгол орон баялаг бөгөөд хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон 77 орд нь бүх бүсүүдэд харьцангуй жигд тархсан боловч төвийн бүсэд нийт нөөцийн дийлэнх их нь буюу 91% нь төвлөрсөн байна. Төвийн бүсэд 7031,0 сая тн, зүүн бүсэд 537.4 сая тн, баруун бүсэд 94.6 сая тн ба хангайн бүсэд 69.3 сая тн нөөц тус тус бүртгэгджээ.

**Хайлуур жонш** - Монгол улс хайлуур жоншны нөөцөөр баянд тооцогдох ба сүүлийн 40 гаруй жилийн турш их хэмжээний сайн чанарын хүдрийг олборлон, дийлэнхийг нь хуучин ЗХУ болон ОХУ-д гаргаж ирсэн, дэлхийд томоохон экспортлогчийн тоонд (2001 оны дүнгээр дэлхийд 4-рт) ордог.

Хайлуур жоншны нөөц үндсэндээ Хэрлэн голын дагуу түүний хойт ба өмнөд бүсэд оршдог 48 ордод (төвийн ба зүүн бүс) тархсан байх ба үйлдвэрлэлийн зэргээр батлагдсан нөөц нь төвийн бүсэд 6.6


сая тн (23 орд), зүүн бүсэд 11.7 сая тн (25 орд) байна. Хангайн бүсэд 1 жижиг орд (Жаандай) тогтоогдсон.

**Фосфорит** - Монгол орон фосфоритоор маш баян бөгөөд хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон 23 ордын 22 нь Хөвсгөлийн фосфоритын сав газар (хангайн бүс) оршино. Үйлдвэрлэлийн зэрэглэлээр бодсон нөөцийн 89.0% буюу 258.9 сая тн фосфорын ислийн нөөц хангайн бүсэд 11.0% буюу 31.6 сая тн нь баруун бүсэд тус тус батлагдсан.


Бид Монгол оронд тархсан ашигт малтмалын нөөц баялаг, нийт нутаг дэвсгэрийн геологийн судалгааны болон уул уурхайн салбарын өнөөгийн байдал, цаашид геологийн судалгаа, уул уурхайн салбарыг хэрхэн үр өгөөжийг нь дээшлүүлэх тухай товчхон авч үзлээ. Ингээд цаашдын бүс нутгийн хөгжилд уул уурхайн салбарын гүйцэтгэх үүргийг өсгөхийн тулд бүс тус бүрд ашигт малтмалын ямар төрлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг зорих, ер нь голлох төрлийн ашигт малтмалын нөөцийг өсгөх, олборлох ба боловсруулах талаар баримтлах бодлогыг тодорхойлох үндэслэлийг авч үзье.

**Баруун бүсэд уул уурхайн салбарыг хөгжүүлэхийн тулд юуны өмнө алт, алт-холимог металл, мөнгө, мөнгө-холимог металл, гянт болд, газрын ховор элементийн орд газруудыг ашиглах, энэ чиглэлээр хийх эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэх, дэмжих хэрэгтэй. Тухайлбал:**


1. Алтны олборлолтыг нэмэгдүүлэх бүрэн боломж, потенциал бий. Үүний тулд алтны шороон болон хүдрийн ордын эрэл хайгуулын ажлыг өргөтгөх, нөөцийг нэмэгдүүлэх ажлыг гүйцэтгэж буй лиценз эзэмшигчдийг дэмжих, ялангуяа томоохон үндсэн орд, илрэлүүдийн эрэл хайгуулын ажлыг түргэтгэх талаар анхаарах, Нүхний нурууны алт-холимог металлын, Сум дайрга, Сухайт, Барлаг голын алтны илрэлүүд, Бооржийн мөнгө-холимог металлын орд г.м. хэтийн төлөв сайтай объектуудын хайгуулын ажилд онцгой анхаарч, хөрөнгө оруулагчдад санал болгох, сурталчилах, уул уурхайн үйлдвэр байгуулан ашиглахад тал бүрийн дэмжлэг үзүүлэх,
2. Асгатын мөнгөний ордыг түшиглэсэн жилд 350 тн хүдэр олборлон боловсруулах үйлдвэрийг 2003-2006 онд байгуулах ажлыг яаралтай гүйцэтгэж, дэд бүтцийг нь сайжруулан, ашиглалтанд оруулах боломжийг бүрдүүлэх,
3. Одоо ашиглаж буй гянт болдын Цүнхэг, Ховд голын ордууд болон Улаан уулын ордыг ашиглах, олборлолтыг нэмэгдүүлэх,
4. Халзанбүргэтэйн газрын ховор элементийн ордын хайгуулын ажлыг гүйцэтгэж, нөөцийг үйлдвэрлэлийн зэргээр тогтоон, олборлолт хийхэд дэмжлэг үзүүлэх,
5. Алагийн даваа, Цахир уулын фосфоритын ордыг түшиглэсэн үйлдвэр байгуулж, байгаль орчинд сөрөг нөлөө багатай ашиглах асуудлыг хөрөнгө оруулагч нарт тавьж, шийдвэрлэх,
6. Нүүрсний орд газруудыг жигд ашиглах асуудлыг шийдвэрлэж, бүсийн түлш эрчим хүчний нүүрсний хэрэгцээг дотроосоо хангадаг болох.
7. Цагаан алт, хромитын орд илрэлийн эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэх, орд, илрэл нээн, ашиглах хэтийн зорилго тавин ажиллах.



БАРУУН БҮСИЙН  
АШИГТ МАЛТМАЛЫН  
ОРД, ИЛРЭЛИЙН  
ТАРХАЛТ БАЙРШЛЫН  
ЗУРАГ




БАРУУН БҮСЭД  
ХИЙГДСЭН 1:50000-  
НЫ ГЕОЛОГИЙН  
ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ  
ЭРЛИЙН АЖИЛ




Зураг 2.3

Зураг 2.4



Áàðóóí á¿ñýä î ëã äãñî í  
 õàéäóóëùí áí ëí í  
 àø èäæàèöùí òòñææé  
 çº âø ºº ë î ëã äãñî í






1970-д оноос эхлээд Монгол-Алтайн атираат муж нь Зөвлөлт-Монголын геологийн эрдэм шинжилгээний хамтарсан экспедицийн судалгааны талбар болсон юм. Энэ экспедицийн эрдэм шинжилгээний ажилтнууд, тухайлбал, Б.Лувсанданзан, В.А.Амантов, А.Б.Дергунов ба бусад олон судлаачдын ажлын үр дүнд тус мужийн геологийн тогтоц, давхарга зүй, магматизм, тектоник ба ашигт малтмалын талаар асар их баримт материал чуглуулж тэднийг нэгтгэн дүгнэсэн олон тооны эрдэм шинжилгээний бүтээлүүд туурвигдаж, шинжлэх ухааны үндэслэлийг гаргаж 1:500000 масштабын геологийн зургийг зохиож хэвлэсэн юм.

1988 оноос хойш тус аймгийн нутаг дэвсгэрийн 50%-г 1:50000 масштабын геологийн бүлэгчилсэн зураглалын ажлаар ЗХУ-ын Баруун Монголын геологийн цогцолбор экспедицийнхэн бүрэн бүрхсэн байна. Тэдгээр ажлын үр дүнд давхарга зүй, магматизм тектоникийг нарийвчилан ялгаж, ашигт малтмалаас төмөр, зэс, хар тугалга, цайр, гянтболд, ховор ба үнэт металлууд болон металл бус ашигт малтмалын олон тооны илрэл, эрдэсжсэн цэг, сарнилын хүрээг илрүүлж, тэдний тархалтын зүй тогтол, байрлалыг тодруулан, олон тооны хүдрийн талбай, хэсгийг ялгаж цаашдаа хийх геологи-хайгуулын ажлын дэс дарааллын талаар тодорхой чиглэл ба зөвлөгөө өгсөн байна.

Мөн түүнчилэн Асгатын мөнгөний орд, Кызыл таугийн гянтболдын орд, Хуурай салааны алтны ордод нарийвчилсан хайгуулын ажил хийж ашиглаж байгаа юм.



**Геологийн тогтоц:** Баян-Өлгий аймгийн дэвсгэр нутаг дахь геологийн тогтоц нь протерозойн хувирмал чулуулгаас хожуу палеозойн эх газрын тунамал вулканогений чулуулаг болон кайнозойн хурдас хуримтлалаас тогтоно. Стратиграфийн товч ойлголтыг бичвэл венд-доод кембрийн ангилаагүй хурдас хүрэм, бөсөл, спилит, кератофир, шохойжин, дундкембрий-доод ордовикийн ангилаагүй хурдасны доод зузаалаг ногоон өнгийн хувирмал элсжин, хувирмал алевролит, цахир-хлоритот занар, дунд кембрий доод ордовикийн дээд зузаалгийн алаг өнгийн гравелит, элсжин, алевролит, аргиллит, хас, цахиржин доод дунд ордовикийн ангилаагүй хурдас андези хүрэм, андезит, риолит, тэдгээрийн бөсөл, бөсөл хөрзөн, бөсөл-элсжин, дунд дээд ордовикийн Бахилгын свитийн элсжин алевролит, хөрзөн, бөсөл-элсжин, шохойжин, Ачит нуурын свитийн элсжин, гравелит, хөрзөн, алевролит, мергель, шохойжин, дээд ордовикийн Эрдэнэ бүрэнгийн свитийн элсжин, зануу элсжин, графтолит бүхий шаварлаг занар алевролит, доод силурын Шарговийн свитийн брахипод, гастропод бүхий элсжин, алевролит, шохойжин, хөрзөн, доод дунд силурын Цагаан голын свитийн амьтны үлдэгдэл бүхий элсжин, алевролит, аргеллит, шохойжин, хөрзөн доод девоны Улаан хусын свитийн элсжин, гравелит, ховроор риолит, хөрзөн, шохойжин, доод дунд девоны: Ойгуурын свитийн хүрэм, андези хүрэм, андезит, бөсөл, бөсөл элсжин, том субвулкан

биет риолит, трахиролит, риодацит, ангилаагүй хурдас цахиурлаг алевролит, элсжин, хөрзөн, дунд девоны: Бардам голын свитийн элсжин хөрзөн, шохойжин, дацитын бөсөл, Хатуу голын свитийн элсжин, алевролит, амьтан ургамлын үлдэгдэлтэй зануу элсжин, Халзатын свитийн элсжин, алевролит, шохойжин, дунд-дээд девоны настай ангилаагүй хурдас. Элжин, алевролит, шаварлаг



занар, гравелит, Цагаан шивээгийн свитийн элсжин, алевролит, хайргажин, занар, Хөх уулын свитийн трахихүрэм, трахиандезит, дацит, риодацит, бөсөл, доод карбоны настай ангилаагүй хурдас. Хөрзөн, элсжин, алевролит, шаварлаг ба нүүрслэг занар-нүүрс. Дунд дээд дөрөвдөгчийн элс, элсэнцэр, шавар, хайрга, сайрга, шавранцар, бул чулуу зэрэг чулуулгаас тогтсон. Интрузив чулуулаг нь аймгийн дэвсгэр нутгийн Б, БУ, Х, З урд хэсгээр өргөн тархах бөгөөд БХ, ховроор уртрагийн чиглэлтэй хагарлын хэмжээнд БХ чигтэй сунаж байрласан том ботолит байдлаар оршино. Интрузив нь нас тогтоц, байрлалын байдлаараа доод палеозой бүхэлдээ хамаарна. Үүнд: дээд ордовикийн ангилаагүй бүрдэл плагиоклазит, биотитот, биотит-эвэр хуурмагт боржин-диорит, боржин, дунд силурын Ховдын бүрдэлийн боржин-диорит, боржин, лейкократ боржин, дээд девоны Алтайн бүрдлийн биотитот гнейс маягийн шигтгээлэг ердийн боржин. Дээд карбоны настай Индэртийн бүрдлийн ердийн лейкократит биотит, хоёр гялгануурт боржин, ховроор адамеллит чулуулгаас бүрдэнэ.

**Тектоник:** Аймгийн нутаг нь Монгол Алтайн атираат мужийн Алтайн, Баян-Өлгийн структур-формацийн бүсэд, багахан хэсэг нь Делюн-Сагсайн хотгорт оршино. Алтайн антиклинори бүс нь түүнийг бүрдүүлэгч структур формацийн цогцолборуудын онцлогоор Баруун монголын хожуу каледоны геосинклиналь бүтцэд хамаарагдана. Алтай бүс нь зүүн талаараа Баян-Өлгийн структур формацийн бүсээс Толбо нуурын гүний хагарлаар өмнөд ба баруун өмнөд талаараа Өмнөд Монгол ба Зайсаны бүсээс Булганы гүний хагарлаар тус тус зааглагдаж заадас (шов) маягийн бүтэц үүсгэнэ. Хойт хэсэгт ОХУ, Хятад ба Казакстаны нутагт үргэлжилнэ. Алтайн структур-формацийн бүс нь Цагаан гол болон Дээд Сагсайн хөндлөн хагарлууд болон Булганы гүний хагарлын бүсийн нэг гол салбар болох Алтайн хагарлаар тус тус хэрчигдсэн хэд хэдэн томоохон хэмжээний тектоник блокуудад хуваагдсан байна. (А.Н.Демин ба бусад. 1988 он) Аймгийн хэмжээнд геосинклиналь, ороген, эпиплатформ, идэвхижилтийн үе шатны структур формацын комплекс, структурын ярус ялгагдана.



Содaa 2.8 Оaаaбoбeйт aтeй aфeбeдeдoйи eдoдaйцoдe дaдeдae

Геосинклиналь үе шатны структур формацын комплекс нь дунд-дээд кембри, ордовик, силурын гэсэн яруст ялгагдана. Уг ярусын чулуулаг нь Алтайн комплексын боржинлог чулуулгаар зүсэгдэж, хил заагийн хэсэгт хүчтэй, жигд тархалттай эвдрэлд автсан зарим хэсэг нь филлит, ногоон занарын метаморфжилт ажиглагдана. Энд цахир вулканы формацын Уул-Алтайн серийн чулуулаг онцлог юм. Уг яруст голоморф атираажилт голлох бөгөөд изоклиналь, дэвүүр хэлбэрт ховроор хөнтрүү атираажилт илэрнэ.

Атирааны сунал нь ЗХ-с уртрагийн чиглэлтэй байна. Ордовикийн структурын ярус нь флиш маягийн элсэн чулуу-алевролитын чулуулгаас тогтоно. Уг ярусын зарим хэсэгт дунд-дээд кембрийн ярусын зарим онцлог шинжүүд илэрдэг. Силурын ярус нь фаун бүхий карбонат чулуулгийн нарийн үеийг агуулсан. Моласс маягийн туфоген-терриген давхацмал хуримтлал тогтоогдсон. Уг яруст синклиналь болон орогений төрлийн давхацмал мультструктур ажиглагдана. Сунал нь өргөргийн чигтэй. Орогений үе шатны структур формацын комплекс нь девоны ярусын вулканоген-молассын ба туфоген-терриген цоохор өнгийн формац, вулканы маягийн чулуулаг, Алтайн ба Толбо нуурын интрузив комплекст хамаарна. Девоны ярусыг доод-дунд, дунд, дээд девоны болон дээд девон-доод карбоны гэсэн 4 дэд яруст ялгана.

Эдгээр дэд ярусууд нь ордовик, силурын чулуулаг дээр үл нийцлэгээр байрлана. Структур нь ижил хэмтэй, бага зэргийн сунасан брахисинклиналь, давхацмал мульд байна. Мезозойн идэвхижилтийн структур нь юрын эх газрын молассын формац тархах бөгөөд уртрагийн чиглэлтэй нарийн грабен маягийн прогиб илэрнэ. Структурын зарим хэсэгт идэвхижилтийн үе шатны тогтворжоогүй мужийн онцлогтой региональ хагарлын дагуух лампорпирын дэл судал ба жижиг биет тогтоогдоно. Кайнозойн идэвхижилтийн эпиплатоформын үе шатны структур формацын комплекс нь аймгийн хэмжээнд өргөн тархсан бөгөөд дөрөвдөгчийн орогений ярус тогтоогдоно. Энд эх газрын моласс маягийн формацын саарал өнгийн сэвсгэр, том хэмхдэс хуримтлалууд гол, нуурын болон уулс хоорондын хөндийг дүүргэнэ. Уг ярус нь томоохон хагарал, горст-антиклиналь өргөгдлийн захын дагуу байрлана. Баян-Өлгийн (Дэлүүн Сагсайн дахин идэвхижсэн хотойлт) бүс нь Алтайн уулсын дорнод хэсгээр сунаж үргэлжилсэн, дөрвөн давхарга (ярус) тогтоцтой.

Доод ярус нь кембрийн өмнөх насны тарамцагууд бүхий венд-кембрийн суурилаг хэт суурилаг хурдасны хашжилтаас (ассоциация) тогтох ба түүнээс дээш кембрий-ордовикийн настай турбидит хурдасны, 3-р ярус (давхаргадас) нь Ордовик-силурын, силурын настай эх газрын эргийн хурдасны тогтоц юм. Мөн түүнчилэн түрүү девоны настай галт уулын чулуулаг, ерөнхийдөө эх газрын шинжтэй хуримтлал давхаргадсын дээд хэсэгт давамгайлах хандлагатай болж ирдэг юм. Хамгийн дээд талын дөрөвдүгээр давхаргадас нь рифт үүсэлтийн шинэ үеийг илэрхийлэх бөгөөд дундат, хожуу девоны хар занарын гэж нэрлэгддэг элсжин ба занарын формацаас тогтоно. Энэ давхаргадас нь Баян-Өлгийн бүсийн тэнхлэгийн дагуу сунаж тогтсон, цаашдын үеүүдэд ч хурдасжил энэ тэнхлэгийн дагуу галав дамжин залгамжлагдах шинжтэй байсны нэг тод жишээ нь энд юрагийн настай уулс хоорондын заримдаа нүүрсжил бүхий хурдас тохиолдох явдал юм.

Энэ бүсийн хүрээнд бага, мөн түүнчлэн судлын чулуулаг түгээмэл зонхилох онцлогтой. Тэдгээрийн дүнд түрүү палеозой боржин габброид, карбоны настай габброид-диорит-диабазит, хожуу палеозой-мезозойн настай аляскит боржингийн формацийн түрэлтүүдийг тогтоосон. Аймгийн хэмжээнд БХ чиглэлтэй хагарал, ЗХ ба өргөргийн чиглэлтэй систем хагарлууд байрлана. Өргөргийн чиглэлтэй систем хагарлууд нь бие даасан ач холбогдол багатай байна. Хамгийн эртний тасралтат эвдрэл, Толбо нуурын региональ гүний систем хагарлын төрөл нь кембри-ордовикийн комплекст, залуу нь эхэн герциний орогений үе шатны мультын девон, силур,-девоны вулканоген-терриген-молассын комплекст илэрнэ. Мөн Цагаан гол, Сагсайн, Ойгорын, Алтайн гэх мэт олон томоохон хагарлууд ялгагдана.

**Металлогений онцлог** : Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэр нутагт Алтайн Дэлүүн-Естийн, Ховдын металлогений бүсүүдийн Ховд гол, Хуримт, Нуурын гол, Естийн, Улаан уул, Өлгийн, Толбо нуур, Алтанцөгцийн гэсэн 8 хүдрийн дүүрэг ялгасан байна. Тус дүүргүүдийн товч бичлэгийг хүснэгт №2-т үз. Ашигт малтмалын хувьд тус аймагт 2002 оны байдлаар нийтдээ 34 орд, 203 илрэл, ирээдүйтэй 15 эрдэсжсэн цэг, олон тооны геохимийн шлихийн сарнилын хүрээ, геофизикийн аномалууд тэмдэглэгдсэн байна.

Вольфрамын хүдэржилт давамгайлсан Монгол Алтайн бүсийг дотор нь Алтайн, Баян-Өлгийн дэд бүсүүдэд үүссэн байдлаар нь хоёр хэсэгт ангилан авч үздэг юм. Алтай бүсэд нуурын гол, Ховд гол, Мушгиа, Сагсай, Хүйтэн Салаагийн вольфрам, молибдений эрдсийн төрөл, Баян-Өлгийн бүсэд Ховдын гүний хагарлын хажууд орших нарийн нуруу, улаан уулын хүдрийн зангилаа үүсчээ. Алтайн вольфрамын хүдрийн дэд бүсийн нийт урт нь 300 км, өргөн нь хойт хэсэгтээ 100-д км, өмнд хэсэгт 30-40 км болж нарийсна. Вольфрамитын хүдэржилт нь Хаалгатын дээд юрагийн настай гэж тодорхойлогдсон. (Оболинский 1987) цайвар боржинтой цогцолбортой вольфрамын хүдэржилтийг холбоотойгоор авч үзсэн байна. Баян-Өлгийн хүдрийн дэд бүсийн урт нь 500-600 км, хойт хэсэгт бүсийн зузаан 60-70 км, өмнөд хэсэгт 20-30 км болж нарийссан. Баян-Өлгийн бүс дэх үйлдвэрийн ач холбогдолтой хоёр орд газар нь Улаан уул, Цүнхэгийн орд юм. Улаан уулын ордын нөөцийг түшиглэн хайгуул ашиглалтын үйлдвэр ажилладаг.

Улаан уулын орд Өлгий хотоос зүүнтээ 60 км-т оршино. Орд нь цайвардуу (лейкократ) боржингийн дотор үүссэн, вольфрамтай 60 гаруй судлаас тогтдог. Судлуудын зузаан нь 0.1-1.2м,  $WO_3$ -н агуулга 0.1-30-40% хүртэл хэлбэлздэг. Судлуудын урт 50-500 м, зарим нь 1.5 км хүртэл урт, дундаж агуулга нь 2.0%, зузаан нь 0.5 м бөгөөд ордын нөөцийг 3000 тонн нэж тогтоосон. Орд нь дунд түвшинд хүртэл элэгдсэн, вольфрамаас гадна Mb (0.02), Y (0.002-1%), Be (0-1%), Bi (0.05%). Эдгээр элементүүд нь вольфрамтай хамт баяжигдана. Ордын бүх нөөцийг хэвтээ малталтын системээр бүрэн ашиглаж болох тийм уул техникийн нөхцөлд оршдог. Тус нутаг дэвсгэрт тархсан вольфрам, бериллийн, молибден ба бусад ховор металлуудын хүдэржилтийг гаралд үүслийн хувьд девон болон хожуу палеозойн настай боржингийн цогцолбортой холбож авч үздэг. Зэсийн хүдэржилтийн хувьд тус аймагт гидротермаль, кварцын судалд ашиглагдах бөгөөд нийтдээ 2 орд, 51 илрэл, 3 эрдэсжсэн цэг тогтоогдсон.

Хөх-Адарын холимог металлын орд нь Толбо сумын төвөөс зүүн урагш 14 км-т оршино. Энд ордовик, девоны хувирмал занар дотор зэсийн ногоон түрхэц бүхий гидротермаль хувирлын бүсүүд нь хүдэржилт агуулна. Хүдэржилттэй бүсийн нийт урт 1800м, зузаан 5-30м,  $C_2+P_1$ -р Cu-96700 тн, Zn-18200 тн, Pb-43150 тн,  $P_1$ -р Ag-11.0 тн, Cd-7.0 тн гэж нөөцийг тооцсон байна. Зэсийн хувьд хэтийн төлөвтэй байж болох 6 талбайг ялгасан. Үүнд: Уйгуур-1, Уйгуур-2, Цэнгэл, Буянт, Хөх Адар, Алтанцөгцийн гэсэн. Эдгээр талбайнуудад цаашид нарийвчилсан судалгаанууд хийх шаардлагатай.

Баян-Өлгий аймгийн хувьд мөнгөний хольц өндөр, үйлдвэрлэгчдийн сонирхлыг татах 1 орд, 16 илрэл тогтоогдсон. Мөнгө нь сульфодавс (зэсийн б?дэг хүдэр) хорголж цайрын, сульфидын зэсийн хүдэрт өндөр агуулга заана. Толбо-Ховдын гүний хагарлуудын хоорондох зурвас Баян-Өлгий бүсэд

мөнгөний өндөр агуулга заах нь эдгээр орд илэрцүүд нь тодорхой элементүүдийн бүлэг илүү хүчтэй хуримтлагдсаных юм.

Энэхүү бүсийн дагуу Асгатын мөнгөний орд, Цүнхэгийн мөнгөний илэрц, Буянтын мөнгөний хүдэржилттэй талбай, Цагаан бургас, Шар бүүрэг, Боорчийн илэрцүүд томоохонд орно. Асгатын мөнгөний орд нь Ногоон нуур сумын нутагт Асгатын голын мөнх цаст Түргэний өндөр уулсыг дамжин тогтсон, зүүн хойд жигүүр нь Орос улсын хилд тулж очсон байдаг. Ордын талбайд карбонь настай элсжин, алевролитын хурдас боржингийн биетээр огтлогдсон тогтоцтой бөгөөд нилээд нумарсан байрлал бүхий тектоник хагарлын бүсүүдийг бага температурын судлын биетүүд эзэлж оршино. Урьдчилсан хайгуулын судалгаанд хамрагдсан хүдрийн биетүүдийн урт нь 2-6 км, зузаан нь 1-10 м. Ордын хэмжээнд дунджаар Ag-53.7-3844.8 г/т, Cu-0.001-9.34%, Pb-0.0-2.0%, Zn 0.3%, Bi-0.005-0.83%, Sb-0.01-8.03% тус тус агуулагдана. Ордын нөөцийг Ag-7700, Cu-238.2, Bi-12.2, Sb-106.6 тн, Fe-14 сая тонн гэж тооцож болно. Нөөцийн тооцоонд орсон хүдрийн үлдсэн хэсэг буюу, хүхрийн хэмжээ бөгөөд энэ чанараараа Асгатын ордод хаях зүйл байхгүй нь ойлгомжтой. Монголд хаягдалгүй технологоор ажиллах үйлдвэр баригдах ёстой анхны объектуудын нэг нь юм. Асгатын ордын хүдрийн биетүүд нь 2600-3500 м өндөр уулсын түвшинд байрлах ба 2500 м хүртэлх түвшинд хэвтээ малталтын системээр уурхайжилт явуулж бараг ордын бүх нөөцийг ийм аргаар эзэмших боломжтой. Баян-Өлгий аймагт алтны хувьд ашиглаж байгаа нэг шороон ордоос гадна Баян-Өлгий аймагт алтны хувьд 3 орд 26 илрэл тогтоогдсон. Харин цаашид судалгаа хийх ирээдүй бүхий хэд хэдэн талбай, хүдрийн дүүрэг ялгажээ. Үүнд: Зуланбулаг, Доод Сагсайн, Хүрэмтийн талбай, Боосын нуруу, Дээд Булганы алтны хүдрийн дүүрэг орно. Улаан хус сумын нутагт орших Зуслан булагийн алттай талбайд алтны үндсэн илрэлийн 3 хэсэг тогтоогдсон. 1-р хэсэг Гурван байшин уулаас 9 км-т 80°-ын азимутаар орших бөгөөд уулын алтайн серийн элсжин занарын хурдсын дотор кварцын, кварц баритийн 20-25 см-н зузаантай судлуудын дотор алтны агуулга нэг дээжинд 3 г/т заажээ. 2-р хэсэг нь эхнийхээс баруун урагш 6.4 км-т оршино. Ордовикийн бутарсан занарлаг хурдсан дотор баруун хойшоо суналтай кварцын судлуудын бүсэнд зэсийн хүдэржилт ажиглагдана. Штуфийн сорьцонд хийсэн шинжилгээгээр алтны агуулга 3 г/т зэсийн агуулга 1%. 3-р хэсэг нь Шагайт уулын ойролцоо байрлана. Занарлаг хурдсан дотор 0.2м зузаантай кварц карбонатын судлаас авсан сорьцонд алтны агуулга 3 г/т заажээ. Мөн түүнчилэн Бага булаг, Зуслан булагийн ойролцоо шилхэд алтны урсац сарнисан байдаг. Энэ сарнил нь доод палеозойн настай элсжин, алевролитын хурдас тархжээ. Эллипис хэлбэртэй 3.5x1.5 км хэмжээтэй энэхүү сарнилын сорьцонд 1-8 алтны ширхэг ажиглагдана. Сарнилыг нарийвчилан судалж, алтны шороон илэрц илрүүлэх боломжтой байж болох юм. Доод Сагсайн талбай нь Сагсай сумын төвөөс баруун урагш голын доод хүндийд оршино. Энд Эрдэнэ бүрэнгийн свитийн төрриген тунамал хурдас дотор 21 кварцын судал, хэд хэдэн сульфидын эрдэсжилттэй цэгүүд мөн алтны 4 үндсэн илэрцийг илүүлсэн ба нийт талбайн 9.5 км<sup>2</sup>, алтны агуулга нь 0.1-63 г/т. Хүрэмтийн талбайд Богинын гол ба Ёлтын голын сав газарт байрлах алтны шороон ордын өлгийг авч үздэг. Үүнд: Дээд Ямаатын, Ямаатын, Ёлтын, Замбага голын шороон орд илэрцүүд хамаарна. Уг орд илэрцүүдэд, дээр үед ашиглалт явуулж байсан ба алтны үе нь нилээд гүнд байрладаг бололтой. Боосын нурууны алтны хүдрийн зангилаа Алтанцөгц сумын нутагт оршино. Энд алтны 4 илэрцийг илрүүлсэн. Эдгээрийн илэрцүүдэд Оросын экспедиц эрэл үнэлгээний ажил явуулж, алтны агуулгыг дунджаар 40 г/т, судлуудын урт нь 10-200м, өргөн нь 1-2 м гэж тодорхойлжээ. Дээд Булганы алтны хүдрийн дүүрэг нь Булган сумын нутагт орших ба Булган голын баруунтаах цутгалангуудад хэрчигдсэн, Хүрэмтийн алтны бүсийн үргэлжлэл байхаар, Булган голын эхэн хэсэгт хилийн чандаас орж ирдэг беризитжсэн занарын өргөн бүс, тектоник тогтоцын хувьд түргэний хагарлын байрлалаар хянагдана. Алтны хүдэржилт хувирсан занарын дотор заахаас гадна, алттай кварцын судлуудын энэ хагарлын дагуу сунасан биетүүд үүсгэнэ. Энд дан пиритийн бас хорголжны хүдэржилттэй судлууд үүссэн нь элбэг юм. Судлуудад алтны агуулга жигд бус ихэвчилэн исэлдсэн сульфидын агуулгатай шууд шүтэлцээтэй байхад, беризитжсэн занар дотор, түүний агуулга бага боловч жигд заадаг. (Дандар 1992 он)

Тус хүдрийн дүүрэгт үндсэн илэрцээс гадна, тэдгээрийн элэгдлээс шороон орд үүссэн байдаг. Энд шороон орд нэг, шлихийн сарнилын урсгал 8 тогтоогдсон бөгөөд 5-6 км өргөн зурвас тогтоц Алтайн цогцолборын гадаад хилийг барьж, зуу гаран км үргэлжилнэ. Хуурай салааны шороон орд нь Булган сумын нутагт, Их Жаргалантын голын Хуурай салаа гэдэг хойноос ирэх цутгаланд үүссэн. Шороон орд нь 4.5 км урт, 20-60 м өргөн, алтны агуулга дунджар 1-2 г/шоо м, торфийн зузаан ордын адагт 2-3.5 м, эхэнд 0-1.0 м. Урьдчилсан хайгуулаар нөөц нь  $C_1=169.6$  кг-аар тогтоогдсон. Тус ордод "Алтны" ХК ашиглалт явуулж байгаа бөгөөд 1998 оны байдлаар 63 кг алт үлдсэн гэсэн мэдээ байна. Хар төмөрлөгийн хувьд Баян-Өлгий аймагт Бортын титаны, Хромитын Хавцлын, Бор хагийн илрэлүүдийг нэрлэж болох юм. Бортын титаны илэрцэн Толбо сумын нутагт, Толбын гүний хагарлын дагуу үүссэн. Энд хагарлын бүсийг дагаж гүр, соронзон гүр, ильменитийн судлууд мөн түүнчилэн ильменит, соронзон гүрийн шигтгээ хүдэржилт бас ажиглагдана. Титаны хүдэржилттэй


нэг судлаас авсан сорьцонд  $TiO_2$ -46% заасан, цаашид бортын голын сайрыг дагаж ийм хүдрийн асгаргууд их хэмжээтэй бууж ирсэн байдаг. Судлын уртыг 200м, өргөн нь 1м, гүнд 100 м үргэлжилнэ гэж үзвэл титаны нөөц 10000 тн. Бортын титаны илэрцийг түшиглэж титаны баяжмал гаргаж ашиглах боломжтой.

Гүний хагарлуудыг дагаж хромитын хүдэржилттэй гипербазитын биетүүд элбэг тархжээ. Эдгээрийн дотроос хавцлын, Бор хагийн илэрцүүдэд хромитын агуулга 30-50 % хүрнэ. Баян агуулгатай хүдэржилтийн коэффициент 0.4-0.5 орчим бөгөөд хромитын нөөц 100000 тн орчим гэж барагцаалж болно. Металл бус ашигт малтмалын 19 орд, 24 илрэл, хэтийн төлөв нь тодорхойгүй 20-аад эрдэсжсэн цэг байгаагаас шаврын 6, элс хайрганы 4, барилгын чулууны 2, шохойн чулууны 2, өнгөлгөөний чулууны 2, нүүрс, барилгын элс, эрдсийн будгийн тус тус 1 орд байна. Барилгын материалын ордууд ихэнх нь ашиглагдаж байгаа ордын бүртгэлд байдаг. Тус аймгийн нутагт байрлах бүх төрлийн ашигт малтмалын орд илрэл, эрдэсжсэн цэгийн биетийн хэлбэр, хэмжээ, агуулга, нөөц, судлаачдын өгсөн хэтийн төлөв судалгааны цаашдын чиглэлийг хүснэгт 3-с үзэж болно.

### Дүгнэлт

Баян-Өлгий аймгийн нутагт геологийн 1:50000-ны масштабын судалгаа 50% хийгдсэн нь цаашид тодорхой төрлийн ашигт малтмалд эрэл-хайгуул хийх чиглэлийг тогтоож өгсөн. Тус аймгийн хувьд мөнгө, алт, гянтболд, мөнгөн ус, зэсийн хүдэржилт нь ирээдүйтэй тул цаашид гол анхаарлаа эдгээр ашигт малтмалуудад хандуулж судалгаа явуулах шаарлагатай. Баян-Өлгий аймаг нь хүн ам нилээд нягт сууршилттай, ажиллах хүчний нөөц бололцоо их, бас аж үйлдвэр бараг хөгжөөгүй, иймд тус нутагт Асгат, Улаан-уул, Толбо, Өлгийд олон жилийн тогтвортой үйл ажиллагаатай, Цэнгэл, Сагсай, Булган, Алтанцөгц сумдын нутагт улирлын чанартай вольфрам, мөнгө, алт, зэсийн олборлох үйлдвэрийн бүтцүүд буй болгож болох юм. Мөн Ногоон нуур сумын нутгаас титаны баяжмал, Баяннуур сумын нутгаас хайлуур жоншны хүдрийг бага хэмжээтэйгээр хялбар аргаар олборлох боломжтой.

#### 2.1.1.2 Ховд аймаг



Содaa 2.9 Аaгeйaдeй cодaa

Уул зүйн хувьд Монгол Алтайн уулархаг мужийн урд хэсэгт, Алтайн өвөр говийн мужийн баруун хуурайн дэд мужид оршдог хамгийн өндөр уулс нь Бугатын уул (4041 м), Буурал хайрхан (3705м) Цахир уул (3643 м), Их буурал уул (3796 м). Хамгийн нам дор хэсэг нь Хүрэн уул (1698м) Майхан хар уул (1606м) Эрээн толгой (1146 м) Харьцангуй өндөр нь 800-1000 м. Тус аймгийн нутагт гадаргуугийн усан сүлжээ сайн хөгжсөн бөгөөд хур тундасны тэжээгдэлтэй, ихэнх нь байнгын устай байна. Томоохон голууд нь Үенч, Бодонч, Барлаг, дунд хойд Цэнхэр гол, Нүцгэний, Харгайт, Цахирын голууд орно. Эх газрын эрс тэс уур амьсгалтай тул жилийн болон хоногийн агаарын температурын хэлбэлзэл маш өндөр, дулааны болон хүйтний өөрчлөлт шилжилт огцом. 1-2 сард  $-25-35^{\circ}C$  хэм хүйтэн, зун нь  $+20+39^{\circ}C$  хэм халуун болдог байна. Нийт нутагт өвөлдөө цас бага унадаг боловч 3300м-с дээш өндөр уулс, нурууд нь ихэвчилэн жилийн турш цасан бүрхүүлтэй байдаг. Жилд унах хур тунадасны хэмжээ нь 100-150мм, 7,11-р саруудад хур тунадасны 60-70 % нь унадаг.

Салхи нь ихэвчилэн баруун хойноосоо салхилах ба хавар , намарт салхины хүч нэмэгддэг. Салхины урсгалын хурд нь ердийн үед 8-10 м/сек байх ба хааяа 20-25 м/сек хүртэл нэмэгдэж шороон ба цасан шуурга болдог байна. Ургамлын бүрхэвч сийрэг, харин Улиастай, Харгайт голын эх хэсгүүд нь хар шороон хөрстэй тул ургамшилт харьцангуй баялаг юм. Ан амьтны хувьд өндөр уулсаар янгир ямаа, ирвэс, шилүүс, суусар, уулын аргал, угалз, үнэг, чоно, тарвага элбэг тохиолдоно. Мөн могой, гүрвэл, мэлхий элбэг байдаг ба жигүүртнээс уулсаар тас, ёл, бүргэд, хойлог, ятуу элбэг тохиолдоно.



болон металл бус ашигт малтмалын олон тооны орд, илрэл, эрдэсжсэн цэг сарнилын хүрээг илрүүлж тэдний тархалтын зүй тогтоол, байршил, гарал үүслийг тодруулж хүдрийн талбай, хэсгийг ялгаж цаашдаа хийх эрэл-хайгуулын ажлын дэс дарааллын талаар тодорхой чиглэл ба зөвлөмж өгсөн байна. Түүнээс гадна Жаргалантын, Зүлэгтэйн нүүрсний орд, барилга материалын ордууд, давсны орд, Их хар чулуут, Ганц модны амны алтны шороон ордод хайгуулын ажил хийж нөөцийг тогтоожээ. Мөн түүнчилэн тус аймгийн нутагт Монгол-Оросын хилийн дагуу 100 км-н зурваст Оросын Өлгийт анги, Шубаны удирдлагын дор ажиллаж, Монгол-Алтайн нуруу болон түүний салбар уулсын геологийн тогтоц, металлогений онцлогийг тодорхойлсон байна.

1987-90 онд ОУГЭ-н шугамаар Ю.А.Борзоковский, О.Д.Суетенко нар Баруун Монголын геологийн 1:500000-ны масштабын зураг зохиох явцдаа Бодонгийн талбайн давхарга зүй, гүний бүрдлийн холбогдолтой шинэ мэдээ сэлтийг бүрдүүлсэн байна.

**Геологийн тогтоц:** Ховд аймгийн дэвсгэр нутагт геологийн тогтоц нь архей-протерозойн хувирмал чулуулгаас палезой, мезозойн эх газрын тунамал вулканоген чулуулаг болон кайнозойн хурдас хуримтлалаас тогтоно. Стратиграфийн товч ойлголтыг бичвэл: Дунд архей-доод протерозойн ангилаагүй хурдас:биотитот, анар-биотитот гнейс, занар, венд-доод кембрийн цул уулын свит хүрэм, спилит, андезит,-хүрэм, дунд кембрий-доод ордовикийн Уулын алтайн свит элсжин, алевролит, цахир, доод дунд ордовикийн ангилаагүй хурдас андези хүрэм, андезит, риолит, цахир дунд-дээд орд овикийн.

Ачит нуурын свит: элсжин, гравелит, хөрзөн. Ордовик-силурын ангилаагүй хурдас биотит-амфиболт, анар-биотитот занар, гнейс, доод силурын ангилаагүй хурдас элсжин, хөрзөн, гравелит, доод-дунд силурын Үенчийн свит алевролит, элсжин, шаварлаг, цахиурлаг занар, доод девоны ангилаагүй хурдас хүрэм, дацит, риолит, доод-дунд девоны ангилаагүй хурдас цахиурлаг алевролит, элсжин, хөрзөн, доод-дунд девоны Байтаг, Баарлан, Хүрэм дөшийн свитүүд, андезит, хүрэм, риолит, шохойжин, трахихүрэм, андези хүрэм, дунд девоны ангилаагүй хурдас хөрзөн, элсжин, алевролит, дунд -дээд девоны баруун хуурайн свит дацит, андезит, дацит, Дээд девоны Хавтагийн свит цахиурлаг алевролит, элсжин, гравелит, дээд девон-доод карбоны субвулкан биет, боржин порфир, риодацит, мөн ангилаагүй хурдас андезит, дундаж ба хүчиллэг бөсөл, элсжин доод карбоны настай Хүрэн гол, Таннайн, Нүхний нуруу, Олон булагийн свитүүд хөрзөн, гравелит, андезит, тэдгээрийн бөсөл, элсжин, алевролит, зануу-элсжин, шохойжин. Дунд дээд карбоны субвулкан биет трахириолит, боржин,-порфир, Хөлөм нуурын свит цахиурлаг аргиллит, андезит, риолит дээд юрагийн ихэс нуурын свит хөрзөн, гравелит, шавар, элсжин ангилаагүй хурдас хайрга, хөрзөн, элсжин, доод цэрдийн Гурван Эрээний свит занар, шавар, филлит, палеогений ангилаагүй хурдас шавар, шаварлаг занар, элс, доод неогений Оошийн свит элсжин, шавар, элс, дунд неогений Алтантээгийн свит элс, элсжин, хайрга, хөрзөн, ангилаагүй хурдас. Элс, алевролит шавар, хайрга, үйрмэг, дунд-дээд дөрөвдөгчийн элс, элсэнцэр, шавар, хайрга ,сайрга, шавранцар, бул чулуу зэрэг чулуулгаас тогтсон байна.

Интрузив чулуулаг нь аймгийн дэвсгэр нутгийн Х, БХ, Б, ЗУ хэсгээр өргөн тархах бөгөөд БХ, ховроор уртрагийн чиглэлтэй хагарлын хэмжээнд БХ чиглэлд сунаж байрласан том ботолит, байдлаар оршино. Интрузив нь нас тогтоц, байрлалын байдлаараа рифей, палеозой бүхэлдээ хамаарна. Үүнд: Дээд рифейн Бодонгийн бүрдэл биотитот, хоёр гялтгануурт мусковит, ангилаагүй бүрдэл биотит-эвэр хуурмагт, биотитот гнейс маягийн тоналит, дунд-хожуу кембрийн тогтохын шилийн бүрдэлийн II, III фаз биотит-эвэр хуурмагт ховроор хоёр гялтгануур боржин, боржин-диорит, дунд хожуу ордовикийн.

Ангилаагүй бүрдэл I, II, III фаз-биотит, эвэр хуурмагт боржин-диорит, их төлөв шүлтлэгдүү лейкократ боржин. Хожуу силурын Ховдын бүрдлийн I, II, III фазын биотит хэр хуурмагт, биотитот боржин диорит, пироксен- эвэр хуурмагт габбро-диорит, хожуу девоны ангилаагүй бүрдэл пироксен- эвэр хуурмагт габбро, габродиорит, ердийн ховроор боржин-сиенит, биотитот гнейс, маягийн шигтгээлэг ердийн боржин, плагиоклазт, биотит-эвэр хуурмагт биотитот тогалит, боржин диорит, түрүү дунд карбоны баруун хуурай бүрдэл. Биотит-биотит-эвэр хуурмагт ердийн ба шүлтлэгдүү лейкократ боржин, хожуу карбон-түрүү пермийн индэртийн бүрдэл ердийн лейкократат, биотитот, хоёр гялтгануурт боржингуудаас бүрдэнэ.

**Тектоник:** Ховд аймаг нь тектоник бүтцийн мужлалын хувьд Монголын атираат тогтолцооны нуурын бүс, Монгол-Алтайн атираат тогтолцооны ховд (хархираа) бүсүүд, Зүүн гарын варисын атираат тогтолцооны хувьд Байтаг, Баруун хуурайн өмнөд умард бүсүүдээс тогтоно.

**Нуурын хэлбэршлийн бүс:** Цагаан шивээт-Их богдын гүний хагарлыг даган түүний хойт хэсэгт байрладаг баруунаас зүүн урагш сунасан байна. Нуурын бүсийг бүрдүүлэгч хурдасны

байдал бие биенээсээ тектоник хагарлаар зааглагдсан зэргийг үндэслэн Баатарын, Хяргас нуурын гэсэн хоёр дэд бүсэд ангилжээ.

Баатарын дэд бүс нь Ховд аймгийн нутаг дэвсгэрт баруун хойноос зүүн урагшаа 28 км сунаж Цагаан шивээт-Их богдын гүний хагарлаар ховдын бүстэй урд талаараа хиллэн хойт тал нь Баатарын нуурын хагарлаар хяргас нуурын дэд бүсээс тусгаарлагдана. Энэ бүсэнд тархсан доод кембрийн хурдсыг арлан нумын, доод карбоны нүүрс агуулсан хөрзөн-элсжингийн дунд-хожуу кембрийн габбро- плагио-боржингийн, доод пермийн цахирт сиенитийн хэлбэршилд тус тус ангилжээ. Хяргас нуурын дэд бүс нь Жаргалантын нурууг эзлэн тогтсон. Энэ бүс нь венд-кембрийн хүрмэн, андезит, хүрэм, андезитийн лавууд, хуурмагжин болон цахиурлаг аргиллит, алевролит, шохойжингийн үеүдээс тогтоно.

Ховдын бүтцийн хэлбэршлийн бүс. Тус бүс нь Цээл сум хүртэл үргэлжилсэн Монгол Алтайн каледоны атираат тогтолцооны хүрээг хамарсан 320 гаруй км урт, 40-50 км өргөн хойт зүүн хойт талаараа Цагаан шивээт-Их богдын гүний хагарлаар нуурын бүстэй, өмнө талаараа Алтайн өврийн гүний хагарлаар өмнөт Монголын бүстэй тус тус хиллэгддэг том бүсийн нэг юм. Уг бүс нь дотроо зүүн баруун гэсэн 2 хэсэг болж хуваагдах боловч хурдас хуримтлалын онцгой ялгаа байхгүй, зөвхөн чулуулгийн хувирлын зэрэг ялгаатай. Тус бүсэд доод дунд, дээд ордовикийн органик үлдэгдэлтэй хурдас, доод силур болон арлын нумын төрхтэй шохойлог бялхмал хурдас, хожуу силурын базитын төрлийн габбройд, хожуу силур-түрүү девон, хожуу девон-түрүү карбон, дунд-хожуу карбоны боржингийн хэлбэршлүүдийг тус тус ялгав. Эдгээр хурдсууд нь эх нуурын захын өргөгдөл дээр захын тэнгисийн нөхцөлд хуримтлагджээ.

Алтай бүтэц хэлбэршлийн бүс нь баруун урд захаар баруун хойшоо суналтай түргэний хагарлаар бусад бүтэц-хэлбэршлийн бүстэй зааглагддаг. Урд талаараа Булганы хагарлаар хязгаарлагддаг. Алтайн бүс нь атираат-тасралтай бүтэцтэй, түүний тогтоцын үндсэн хэв шинж баруун хойшоо суналтай, давхацсан монклиналь атираа зонхилсон тектоникийн шаантаг, ялтас ихээр хөгжсөн ерөнхийдөө баруун талын шилнээс хөдөлгөөн зонхилсон тектоник хагарлаар хэрчигдсэн бүс юм. Тус бүсийн хэмжээнд дунд кембрий-доод ордовикийн элсжин-занарын, хожуу карбон-түрүү пермийн шүлтлэгдүү боржингийн хэлбэршлүүдийг ялгажээ.

Байтагийн бүтэц-хэлбэршлийн бүс нь хойд талаараа баруун хуурайн өмнөд бүстэй Байтагийн хагарлаар хиллэх бөгөөд өмнөд талаараа Хятадын нутагт хармайлан офиолитын бүсээр зааглагдана. Энд баруун хойшоо чиглэлтэй огшоос, төхрөл хагарлуудаар зааглагдсан тектоникийн хучаас, шаантаг цулдан бүтцүүд бий. Эдгээр бүтцийг бүрдүүлж байгаа девон, карбоны тунамал, бялхмал чулуулаг нь дагуу ба хөндлөн хагарлаар хэрчигдсэн антиформ, синформ атираа болон тохролтот моноклиналь үүсгэнэ. Тус бүсийн хэмжээнд доод дунд девоны этгүн бөслийн, андезит-базальтын цахиурлаг-этгүн, дунд девоны базальт-андезит-дацитын, дунд-дээд девоны андезит-дацит-риолитын дээд девоны шохойжин-элсжин-туффитын, доод карбоны нүүрс агуулсан хөрзөн элсжингийн хэлбэршлүүдийг тус тус ялгажээ.

Баруун хуурайн өмнөд бүтэц-хэлбэршлийн бүс нь ерөнхийдөө атираат-тасралтат, атираат тохролтот тогтоцтой, баруун хойшоо суналтай томоохон зэрэгцээ хагарлууд, тэдгээрийг огтолсон зүүн хойшоо чигтэй богинохон шилмээсүүд болон цулдмын хэмжээнд антиклиналь, синклиналь шахагдмал атираас ялгагдах бөгөөд занаржилт, кваржилтын үзэгдэл нилээд өргөн талбайг хамарсан байна. Тус бүсийн хэмжээнд доод девоны элсжин-хас-эффузивийн дунд девоны базит-дацитын дунд-дээд девоны эффузив бөсөл-элсжингийн, дээд девоны шохойжин-элсжин-туффитын, доод карбоны бялхмал бөслийн, элсжин-туффитын хар өнгийн цахиурлаг-этгүн, шохойжингийн, доод-дунд карбоны хөрзөн элсжингийн, дунд дээд карбон элсжин-хүчиллэг эффузивийн тунамал бялхмал хэлбэршлүүдийг ялгаж, гүний шургамал бүрдлийг дунд-дээд карбон моноцит-боржин сиенит-боржингийн, боржин-шүлтлэгдүү боржингийн ба дээд карбоны боржин-боржин сиенитийн хэлбэршилд тус тус хамааруулжээ. Баруун хуурайн умарт бүтэц-хэлбэршлийн бүс нь баруунаасаа зүүн тийш 200 км гаруй үргэлжлэхдээ урд талаараа Баруун хуурайн өмнөд бүстэй мэргэний хагарлаар хиллэж, зүүн хойд талаараа Булганы хагарлаар зааглагдана. Энэ бүсэд доод дунд девоны бялхмал-бөслийн, дунд девоны шохойжилт-латитын, доод карбоны трахиодезит-бөслийг дунд-дээд карбоны монцит-боржинсиенит-боржингийн, боржин-шүлтлэгдүү боржингийн дээд карбоны боржин-боржинсиенитийн хэлбэршилд тус тус ангилжээ.

Тус аймгийн нутгийн хэмжээнд илэрсэн томоохон хагарлуудаас нэрлэвэл Булган, Ховд, Мэргэний, Байтагийн нүхний нурууны, Баруун хуурайн, Хасагтын Баатарын нурууны, түргэний, Бодонгийн гэх мэт олон хагарлуудыг дурдаж болох юм.

**Металлогений онцлог** : Ховд аймгийн дэвсгэр нутагт Ховд, Нуурын, Монгол-Алтайн, Баруун хуурайн гэсэн металлогений 4 бүсэд Ховд, Алтан хөхий, цэцэг, Чигэртэйн, Жаргалант-

Хайрхан уул, Баатарын нуруу Бодонч, Ар булаг, Булган, Барлаг гол, Байтаг, Цагаан толгой гэсэн 12 хүдрийн дүүрэг ялгажээ. Тус дүүргүүдийн товч бичлэгийг хүснэгт №2-т үз. Ашигт малтмалын хувьд тус аймагт 2002 байдлаар нийтдээ 37 орд, 175 илрэл, ирээдүйтэй 24 эрдэсжсэн цэг, олон тооны геохимийн шлихийн сарнилын хүрээ, геофизикийн аномалууд тэмдэглэгдсэн байна.

Тус аймгийн хувьд ирээдүйтэй ашигт малтмал нь алт, холимог металл, оптикийн түүхий эд, нүүрс, барилга материалын юм. Ховд аймгийн нутагт алтны хүдэржилт өргөн тархсан 3 орд, 32 илрэл, 3 эрдэсжсэн цэг олон тооны шлихийн геохимийн сарнилын хүрээ тогтоогдсон бөгөөд цаашид судалгаа хийх ирээдүй бүхий хэл хэдэн талбай, дүүрэг, зангилаа ялгажээ. Үүнд: Эрдэнэбүрэнгийн алтжилттай талбай, Ургаатын алттай зэсийн хүдрийн талбай, Мянгадын алтны хүдрийн зангилаа, Жаргалантын голын алтжилттай талбай орно.

Эрдэнэбүрэнгийн ашигтай талбай нь Эрдэнэбүрэн Ховд, Буянт, Мянгад сумуудын нутаг хамаарах бөгөөд геологийн тогтоцын хувьд Толбо нуурын, Шивээн голын болон Ховдын түрмэл чулуулгаар хязгаарлагдсан үелмэл-терриген хурдсаас тогтоно. Тус талбайд 5 хүдрийн илэрц, 8 эрдэсжсэн цэг, 3 томоохон шлихийн сарнилын хүрээ илэрсэн. Алттай кварцын судал нь ихэнх тохиолдолд чулуулгийн үелэлийн дагуу байх ба хааяа тэдгээрийг огтолсон байна. Судлын хэмжээ маш их хэлбэлзэлтэй бөгөөд урт нь 10-100 м, зузаан нь 4м хүрнэ. Алтны агуулга 0.006-0.8 г/т, хааяа өндөр заана. Мөн Эрдэнэбүрэн, Ховд сумын нутагт өргөн тархсан элсжин занарын доод палеозойн хурдас, түүнийг огтолсон суурилаг найрлагын түрээлүүдийн хил заагийн хувиралд скарн, кварцын судлуудад алтжилтын шинж өргөн ажиглагдана. Ургаатын алттай зэсийн хүдрийн талбай нь Дөргөн сумын нутагт орших бөгөөд 2.4х14 км уртрагийн дагуу сунасан тогтоцод зэсийн хүдэржилт бүхий 10 гаруй илэрц тогтоогджээ. 0.2х10-20м-н кварц-кальцитын 3 судалд алтны агуулга 10 г/т заажээ. Мянгадын алтны хүдрийн зангилаанд Цагаан толгойн орд хамаардаг.

Ордын талбайд дунджуу ширхэгт сарлагжингийн түрэлт венд кембрийн талст занарыг огтолж тогтсон ба боржингийн нилээд хожуу настай жижигхэн биетүүд ажиглагдана. Янз бүрийн зузаантай 10 гаруй кварц судал ихэнх тохиолдолд зүүн хойш чиглэж тогтсон. Алтны хүдэржилт жигд биш, дундач агуулга зарим биетэд 7-10 г/т хүрдэг. (Аюуш 1988), алтны нөөцийн хэмжээг 1.5 т гэж багцаалсан байхад 1991 онд Минигийн дахин үнэлсэн тооцоогоор алтны хэмжээг 15 тн, хүдрийн зангилаанд 18 тн гэж үзэж байна.

Баруун хуурайн алттай холимог металлын хүдрийн дүүрэгт алтны үндсэн 2 илрэл, алт мөнгөтэй холимог металлын 1 орд, мөн хэд хэдэн илэрцүүд тэмдэглэсэн байна. Халтар уул-1 илэрц нь ЗУ-с БХ чиглэж 1-2 км өргөн зурвас 7 км үргэлжлэх бөгөөд геологийн тогтоц нь аргиллит, туф элсжингийн үүсэлтүүд зонхилно. Эдгээр чулуулгуудын дунд кварцын 200 илүү судал үүсчээ. Хэмжээ нь харилцан адилгүй том судлууд 1.5-2.0 (5.0м) зузаан, 350 м хүртэл урт алтны агуулга дунджаар 3.3 г/т нөөц нь 1138.5 кг гэж үзжээ.

Халтар-Уул 2 илэрц нь 2х5 км харьцаатай талбайд тархсан. Энд кварцын 75 судал тэмдэглэсэн ихэнх судлууд 0.5-1.0 м зузаан, 30-130 м урт, Энд 2-р судлын биетээр алтны нөөцийг 345.7 кг гэж үзэж байна. Баруун хуурайн алт, холимог металлын хүдрийн дүүрэгт кварцын судлуудын нийт тоо 500-600 орчим байгаа нь цаашид ирээдүйгүйтэй болохыг харуулж байна. Булганы хагарлын дагуу Үенч, Бодонч, Ангиртын голдуу, тэдгээрийн салбар жалгуудад алтны агуулгатай шороон хуримтлал үүсэх боломжтой.

Бооржийн хүдрийн дүүрэг нь Ховдын гүний хагарал, Цэцэгийн хагарлын хоорондох бүс нутагт хамрана. Энэ дүүрэгт урд зуунаас эхлэн ашиглаж байсан Бооржийн хар тугалга-мөнгөний орд, Тэмээт Улаан уулын алт-зэсийн илрэл, зэс, алтны эрдэсжсэн цэгүүд оршдог. Хүдэржилтийн гол онцлог нь гидротермаль-судлын биет бөгөөд энэ нь гүний хагарлын бүс дагасан байдалтай илэрэг.

Тус дүүрэгт ялангуяа Ховдын хагарлын бүстэй холбоотой гидротермаль судлын болон хожуугийн тектоник хөдөлгөөний улмаас давхацсан гидротермаль хувирлын биеттэй холбоотой алт, мөнгө, хар тугалга, зэсийн өндөр агуулгатай илрэл олдох бүрэн боломжтой. Мөн дунд-хожуу карбоны шүлтлэг боржинтой холбоотой тантал-ниобат, цацраг идэвхт цирконий сарнилын хүрээ нягт холбоотой байдаг нь сонирхол татахуйц юм. Тус дүүрэгт цаашид 1:50000 масштабын эрэл-зураглал хийх. Байтагийн хүдрийн дүүргийн хэмжээнд Цахир толгой, Байтагийн гэсэн хүдрийн 2 зангилаанууд багтсан. Цахир толгойн хүдрийн зангилаанд Цахир толгойн зэсийн илрэл, нарийн харын холимог металлын эрдэсжсэн цэг, Алаг нохойн худгийн зэсийн эрдэсжсэн цэг, Өвхөөдөг уулын болорын орд багтана.

Тус хүдрийн зангилааны хэмжээнд тохиолдох дунд-дээд девоны настай баруун хуурайн давхаргадсын бялхмал бөсөлт-этгүн хурдас нь алт, зэс холимог металл, никелийн хүдэржилтийн хувьд үүсэн бүрэлдэх нөхцөлтэй, хэтийн төлөвтэй байж болох үндэстэй. Байтагийн хүдрийн



зангилаанд нь Байтаг богдын нурууны ар бэлд орших бөгөөд холимог металлын 3 орд, 3 илрэл, төмөрийн 1 алтны 1 илрэл, хар тугалга, цайр, зэсийн хэд хэдэн сарнилын хүрээ багтана. Гол хүдэр агуулагч структур нь энэ хүдрийн зангилааны хэмжээнд нарийн харын хагарлын бүс бөгөөд чулуулгууд нь хуурмагжсан, кварцжсан, төмөржсөн өнгөржсөн байна.

Барлагийн голын хүдрийн дүүрэг нь хойд талаараа Булганы гүний хагарлаар Монгол Алтайн металлогений мужаас тусгаарлагдана. Тус дүүрэгт олон тооны зэсийн холимог металл, төмрийн илрэл, эрдэсжсэн цэгүүд тогтоогдсон. Энэ дүүргийн хэмжээнд зэс-холимог металлын хүдэржилт нь судлын ба кварц-судлын хэлбэршилд хамаарах ба эрдэсжилт, хүдэржилт нь голлон хагарал, бутарлын бүсийн дагуу болон боржингийн төрлийн чулуулгууд агуулагч чулуулгийн хил зааг орчимд тохиолддог. Тус дүүрэгт цаашид үйлдвэрлэлийн ач холбогдолтой зэс-холимог металл, алтны хүдэржилт илрүүлэх зорилгод судалгаа хийх шаардлагатай.

Баатарын нурууны хүдрийн дүүрэг нь тектоникийн мужлалын хувьд Баатар, Хяргас нуур, Баян цагааны бүсүүдэд хамаарагдана. Дүүргийн ашигт малтмалын хүдэржилтийн агууламж өндөр байгаа нь магма, давхарга зүйн хувьд геодинамикийн нөхцлөөр арлын нумын өргөгдөл хэсэгт үүссэн дээд рифей-вендийн дундлаг, суурилаг бялхмал чулуулагтай холбоотой бөгөөд дунд-хожуу кембрийн геохимийн токалит-гранодиоритын эгнээний интрузив чулуулгаар зүсэгдэж байдаг. Уг дүүргийн хэмжээнд дээрх хурдас чулуулагтай холбоотой зэс, алт, зэс-холимог металлын хүдэржилт, судлын ба вулканоген-тунамал гидротермаль алт, зэсийн хүдэржилт зонхилох байр суурь эзэлдэг.

Баатар нурууны хүдрийн дүүрэг нь 1500 ам.км талбайтай, хөшөөтийн нүүрсний уурхай, илрүүлэгдсэн байдаг ба шатах ашигт малтмалын хэтийн төлөвтэй илрэлүүд Сутай уулын, Даривийн илрэл, вулканоген-гидротермаль-тунамал алт, зэс, мөнгөний колчеданы цахир-судлын илрэлүүд. Алт мөнгө зэсийн илрэл, алт сурьма-мышьякийн хүдэржилт агуулах бүрэн боломжтой. Тектоник хагарлын хувирлын бүс: Газрын ховор махбодь болон ховор металл агуулсан шүлтлэг боржингийн массив илэрсэн байдаг. (Д.Тогтох 1995)

Металл бус ашигт малтмалын 26 орд 42 илрэл хэтийн төлөв нь тодорхойгүй 20-аад эрдэсжсэн цэг тогтоогдсон бөгөөд тус орд илрэлүүдийг голдуу ашиглаж байгаа юм. Тус аймгийн нутагт байрлах бүх төрлийн ашигт малтмалын орд, илрэл эрдэсжсэн цэгийн биетийн хэлбэр, хэмжээ, агуулга, нөөц, судлаачдын өгсөн хэтийн төлөв, судалгааны цаашдын чиглэлийг хүснэгт № 3 -аас үзнэ үү.

### Дүгнэлт

Ховд аймгийн нутагт геологийн 1:50000-ны масштабын судалгаа Үенч-Бодончийн сав газраас бусад хэсэгт нь хийгдээгүй учир цаашид 1:50000-ны зураглал, ерөнхий эрлийн ажлыг явуулах шаардлагатай.

Тус аймгийн хувьд алт, холимог болон ховор металл, нүүрс, оптикийн түүхий эдийн хүдэржилт нь ирээдүйтэй тул цаашид гол анхаарлаа эдгээр ашигт малтмалуудад хандуулж судалгаа хийх.Булганы хагарлын дагуу Үенч, Бодонч, Ангиртын голууд, тэдгээрийн салбар жалгуудад алтны агуулгатай шороон хуримтлал үүсэх боломжтой.

#### 2.1.1.3 Говь-Алтай аймаг

**Газарзүйн байрлал:** Говь-Алтай аймаг нь хойд талаараа Увс, Завхан, баруун талаараа Ховд, зүүн талаараа Баянхонгор аймагтай, урд талаараа Хятад улстай тус тус хиллэн оршино. Хойд өргөргийн 42°40'-47°40' баруун уртрагийн 90°10'-98°30' сольбицолд нийтдээ 142 мян км<sup>2</sup> талбайг эзэлнэ.

**Уул зүйн хувьд:** Монгол Алтайн нурууны төгсгөл хэсэгт орших бөгөөд хамгийн өндөр уулс нь Аж богд уул /3802м/, Бурхан буудай уул /3765м/, Гичгэний нуруу /3769 м/, Хасагт хайрхан уул /3578 м/. Хамгийн нам дор газар нь Халхын баруун Өмнө овоо /1667 м/, Талын шовош уул /1382 м/, Зангат уул /1246 м/, Хар уул /1044 м/. Харьцангуй өндөр нь 800-1000 м. Тус аймгийн нутагт гадаргуугийн усан сүлжээ харьцангуй муу хөгжсөн




Содод 2.13 Аймгийн судалгаа



**Геологийн тогтоц:** Говь-Алтай аймгийн дэвсгэр нутагт геологийн тогтоц нь архей-протерозойн хувирмал чулуулгаас палезой, мезозойн эх газрын тунамал вулканоген чулуулаг болон кайнозойн хурдас хуримтлалаас тогтоно. Стратиграфийн товч ойлголтыг бичвэл: Дунд архей-доод протерозойн ангилаагүй хурдас: биотитот, анар-биотитот, биотит-анар-эвэрхуурмагт, хоёр гялтгануурт занар, гнейс, доод протерозойн ангилаагүй хурдас: силлиманитот, анар-биотитот, биотит-аэвэрхуурмагт, хоёр гялтгануурт талст занар, доод-дунд-дээд рифейн Жаргалант, Завхан, Хантайширийн свитүүд: мета-элсжин, мета-алевролит, гялтгануурлаг цахиржин, риолит, риодацит, дацит, хүрэм, диабаз, андезит, вендийн Цагаан цахир уулын, Цагаан оломын свит хөрзөн, элсжин, алевролит, бадмар, бадмаржсан ба битумжсан онколит бүхий шохойжин, венд-доод кембрийн Хурайн, Улаан шандын, Дагаан дэлийн свитүүд: филлит, шаварлаг ба цахиурлаг занар, алевролит, хүрэм, андези-хүрэм, цахиурлаг чулуулаг, онколит, кембрийн Баян гол, Нарангийн свитүүд: элсжин, алевролит, аргиллит, шаварлаг занар, доод-дунд ордовик Алаг уул, Төгрөгийн свит: алевролит, аргиллит, элсжин, хүрэм, андези хүрэм, андезит, ордовик-силурийн ангилаагүй хурдас: шаварлаг ба цахиурлаг занар, алевролит, элсжин, хас, дээд силур-доод девоны Бэрх уул, Төмөртэйн свит: бөсөл, вулканомикт элсжин, элсжин, алевролит, цахир-хлорит-серецитэт занар, доод-дунд-дээд девоны Эхийн гол, Гичгэний, Өөлгийн, Байтагийн, Тогоотын, Баруун хуурайн, Хүрэн уулын свитүүд: шаварлаг ба цахиурлаг занар, хас, алевролит, аргиллит, элсжин, хүрэм, андези-хүрэм, риолит, риодацит, дацит, бөсөл, хөрзөн, гравелит, доод-дунд-дээд карбоны Сайрын шанд, Таннайн, Нүхний нурууны, Цахирын нурууны, Их толь булагийн,

Хүрэн голын, Хөлөм нуурын свитүүд: бөсөл элсжин, бөсөл алевролит, андезит, тэдгээрийн бөсөл, элсжин алевролит, шохойжин, хөрзөн, гавелит, арпшлит, шаварлаг ба нүүрслэг занар, риолит, трахириолит, хүрэм, андцзихүрэм, андезит, дацит, дунд пермийн Дэлийн шанд худагийн свит: алевролит, аргиллит, элсжин, хөрзөн, нүүрсний үе, дунд-дээд юрагийн Шар тээг, Даривын свитүүд: аргиллит, алевролит, элсжин, гравелит, хөрзөн, мергель, шохойжин, доод-дээд цэрдийн өндөр ухаагийн, Гурван эрээний, Зэргийн, Хүрэм цавын, Төгрөгийн, Нэмэгтийн свитүүд: элсжин, аргиллит, алевролит, хөрзөн, гравелит, занар, шавар, филлит, мергель, шохойжин, дээд палеогений Шанд голын свит: шавар, зануу, гравелит, элс, хөрзөн, доод-дээд неогений ийшийн, Хяргас нуурын, Түйн голын свитүүд: элсжин, шавар, зануу, элс, мергель, гравелит, дунд-дээд дөрөвдөгч хурдас: элс, бул ба үхэр чулуу, хайрга, сайрга, дайрга, шавранцар, шавар зэрэг чулуулагаас тогтсон байна.

Интрузив чулуулаг нь аймгийн дэвсгэр нутгийн Х, ЗХ, Б, У хэсгээр өргөн тархах бөгөөд БХ ба ховроор өргөргийн чиглэлтэй хагарлын хэмжээнд Б, БХ чиглэлд сунаж байрласан том ботолит байдлаар оршино. Интрузив нь нас тогтоц, байрлалын байдлаараа протерозой, палеозой бүхэлдээ хамаарна. Үүнд: доод протерозойн ангилаагүй бүрдэл: плагиоклазт, биотитот, хоёр гялтгануурт гнейсжлэгдсэн ердийн боржин, дээд рифейн ангилаагүй бүрдэл: серпентенит, серпентенитжсэн, гарцбургит, дунит, лерцолит, пироксэн-эвэрхуурмагт, эвэрхуурмагт гнейс маягийн габбро, лейкократ, боржин, боржин-гнейс ховроор адамеллит, тоналит, вендийн ангилаагүй бүрдэл: пироксент- эвэрхуурмагт, оливин-пироксент габбро-габбронорит, габбро, дунд-дээд кембрийн Тогтохын шилийн бүрдэл: II-р фазийн биотит- эвэрхуурмагт, биотитот тоналит, цахирт диорит, ховроор хоёр гялтгануурт боржин, дунд силурийн Ховдын бүрдэл: биотитот, хоёр гялтгануурт лейкократ боржин, пироксэн-эвэрхуурмагт габбро-диорит, пироксэн-эвэрхуурмагт диорит, дээд девон Говь-Алтайн бүрдэл: ердийн лейкократ биотитот ховроор хоёр гялтгануурт боржин, доод-дунд-дээд карбоны Хөх толгойн, Алтайн чандын, Баян булагийн, Нуурын, Суманхайрханы, Хангайн бүрдэлүүд: биотитот, гнщйслэг плагиоборжин, габбродиорит, габбро, энгийн ба шүлтлэгдүү лейкократ боржин, биотит-эвэрхуурмагт, эгирин-рибекит бүхий шүлтлэг ба ердийн



Çóäå 2.15 Õàéåóóéíí  
åíéíí àíéåéäéðüíí  
ðõñåå éðõåíçúýé äàéååé



**Нарангийн сүбтеррейн** нь Хан Тайширын нурууны өмнөт энгэрийг дагаж өргөргийн дагуу баруун хойш 52 км хүртэлх урт зайд дундчаар 8 км-ийн өргөнтэйгээр сунаж тогтсон шугаман хэвшинжийн хучааст-атриат бүсээр илрэх бөгөөд хойт талаасаа Хантайширын тохоосоор, өмнөт талаасаа Умарт Сатируулын хаглаар зааглагдана. Еринхий тогтцын хувьд тус сүбтеррейн нь автохтон ба Арбулагийн аллохтон бүтэцүүдэд хуваагджээ. Автохтон нь сүбтеррейний ихэнхи талбайг эзэлж тархсан нарангийн давхаргадасын карбонат-этгүн флишээр илэрнэ.

Автохтоны өнөөгийн бүтэцбэр нь олон тооны тектоник хагарлаар зааглагдсан янз бүрийн хэмжээний шаантаг маягийн блокуудын цогцолбороор тодорхойлогдох бөгөөд шаантаг тус бүрийн дотор нараншн флиш шугаман шахмал атрианууд үүсгэж, зарим хэсэгтээ хүчтэй занаржиж, төмөржсөн нь тодорхой ажиглагдана. Арбулагийн аллохтон автохтоныг зүн хойт талаас нь хучиж, Баруун хойш 18 км урт, 1-3,8 км өргөн сунаж тогтсон ба түүний формацийн эгнээ нь гагцхүү венд-түрүү кембрийн арбулагийн давхаргадсаар ялгагдсан хүрмэн-андезитын эвшлээс тогтох бөгөөд дотоод бүтэцбэр нь блоклог-ялтаслаг шинжтэй ажээ.

**Улааншандын сүбтеррейн** нь Улааншандын нурууг бүхэлд нь хамарч, Сатируулын хагарлаас урагш өргөргийн дагуу суналтай 60 км x 15 км хэм жээний талбайг эзэлсэн Нуурын арланнумын террейний бас нэгэн нэн нийлмэл тогтоцтой хэсэг юм. Түүний өнөөгийн бүтэцбэрт, хойноос урагш: Умарт, Төвийн ба өмнөд тектоник блокууд тод ялгарна.

**Умарт тектоник блок** нь Умарт ба Өмнөт Сатируулын хагарлуудын хооронд хавчуулагдсан нарийвтар бөгөөд янз бүрийн хэсэгтээ 0-4 км хүртэл өргөнтэй тектоник шаантаг маягийн бүтэцбэр бөгөөд нийтдээ 60 км урт зайд үргэлжилнэ. Тэрээр хожуу венд-түрүү кембрийн сатируулын давхаргадаст хамаарагдах этгүн-карбонат формациар үүсчээ.

Төвийн блок нь сүбтеррейний баруун хойт шувтарганд орших Сувраа, Адуунчулууны голуудын сав газрыг хамарч, БХ 26 км зайд 2-6 км-ийн өргөнтэйгээр сунаж тогтжээ. Тэрээр адуунчулууны давхаргадаст хамааруулсан доод-дунд кембрийн олиостромт флишийн формациар илрэх бөгөөд блоклог-атриат бүтэц болно. Өмнөт блок нь сүбтеррейний нийт өмнөт захын 15 км хүртэл өргөнтэй томоохон хэсгийг эзлэж, баруун хойт жигүүрээрээ Төвийн тектоник блокийн өмнөөс тохож, зүүн хойт талд Өмнөт Сатируулын хагарлаар Умарт тектоник блоктой шууд хиллэнэ.

Түүний формацийн эгнээ нь бусад дээр тодорхойлогдсон хоёр тектоник блокийнхоос нилээд өргөн хүрээтэй бөгөөд түрүү вендээс дунд кембрийг хүртлэх насны формациудыг багтаана.

Тус аймгийн нутгийн хэмжээнд илэрсэн томоохон хагарлуудаас нэрлэвэл Хантайширын, Их богдын, Залаатын, Тахийн шарийн, Гурванхайрханы гэх мэт олон хагарлуудыг дурьдаж болно.

**Металлогений онцлог:** Говь-Алтай аймгийн дэвс гэр нутагт Ховд, Нуурын, Монгол-Алтайн, Ургамал, Говь-Алтайн, Эдрэнгэ-Номгон гэсэн металлогений 6 бүсд Цэцэг, Баянхошуу-Төгрөг, Цогт-Цээл, Шар хоолойн, Жаргалант, Дунд шарын, Дарив, Цогт овоо, Эрдэнэ, Сэнжит хяр хөх дэл, Эдрэнгэ гэсэн 11 хүдрийн дүүрэг ялгажээ. Тус дүүргүүдийн товч бичлэгийг хүснэгт № 2-т үз.

Ашигт малтмалын хувьд тус аймагт 2002 оны байдлаар нийтдээ 40 орд, 304 илрэл, олон тооны эрдэсжсэн цэг, геохимийн, шлихийн, сарнилын хүрээ, геофизикийн аномалууд тэмдэглэгдсэн байна.

Тус аймгийн хэмжээнд алт, цагаан алт, хром, гоёл чимэглэлийн чулуу, нүүрс, барилгын материал, төмөр, зэс зэрэг ашигт малтмалууд ирээдүйтэй тул цаашид судалгаа хийх шаардлагатай. Тус аймагт байрлах бүх төрлийн ашигт малтмалын орд, илрэлийн байршил, биетийн хэлбэр, хэмжээ, агуулга, нөөц, судлаачдын өгсөн хэтийн төлөв, судалгааны цаашдын чиглэлийг хүснэгт № 3-аас үзнэ үү.


### **Дүгнэлт**

Говь-Алтай аймгийн нутагт геологийн 1:50000-ны масштабын судалгаа Хан Тайширын районаас бусад хэсэгт нь хийгдээгүй учир цаашид 1:50000-ны зураглал, ерөнхий эрлийн ажлыг эрчимтэй явуулах шаардлагатай. Тус аймгийн хувьд алт, нүүрс, хром, гоёл чимэглэлийн чулуу, цагаан алт, зэс, төмөрын хүдэржилт ирээдүйтэй тул цаашид гол анхаарлаа эдгээр ашигт малтмалуудад хандуулж судалгаа хийх.

**2.1.1.4 Завхан аймаг**


**Газарзүйн байрлал:** Завхан аймгийн нутаг нь зүүн, зүүн хойд хэсгээрээ тайгын муж, хойд болон зүүн төв хэсгээрээ ойт хээрийн муж, баруун хэсгээрээ хээр цөлийн мужид хамаарагддаг. Хойд өргөргийн 46°20'-50°00' зүүн уртрагийн 93°15'-99°10' -н солбилцолд 82 мян км<sup>2</sup> талбайг эзлэн оршдог.

**Геологийн судалгааны түвшин:** Завхан аймгийн нутагт хийгдсэн геологийн ажлуудыг шинж, чанар, шаардлага, жишиг, масштабаар геологийн маршрутын судалгаа, жижиг (1:1000000), дунд (1:200000, 1:1000000) масштабын геологийн зураглал, сэдэвчилсэн судалгаа, сорьцлолт эрлийн ажил, эрэл үнэлгээ хайгуулын ажлын төрөлд хувааж (зураг 2.17) болно.



Содоо 2.17 Аайтйаеи содоа

**а). Геологийн маршрутын судалгаа:**




Содоо 2.18 Ареао йаеидаеи ида, еедэе; аеи дадбае

ТОГТООЖЭЭ.

**б). Жижиг масштабын геологийн зураглал:** 1952-1953 онд В.А.Амантов 1:1000000-ны геологийн судалгааны ажил явуулсан. 1953 онд В.В.Игнатъев 1:500000-ны аэрогамма-соронзон зураглалын ажлыг явуулж соронзон гажгийн зураг зохиосон нь геологийн ашигт малтмалын эрлийн цаашдын судалгаанд зохих үр дүнгээ өгсөн байна. 1959 онд В.В.Беззубцевын удирдлагаар Зөвлөлт-Монголын хамтарсан

1878-79 онд М.В.Певцов Ховд хот-Хөх хот-Хаалган-Улиастай хотын чиглэлээр нүдэн баримжааны геологийн зураглал хийсэн. 1894-96 онд Д.А.Клеменц Төв Монголд судалгааны ажил явуулсан. Энэ судалгаагаар Хангайн нурууны төв хэсэгт кристаллаг занар, гнейс, зүүн өмнөд хэсэгт эртний занарын зузаалгийг хучсан хүрмэн чулууны илэрцийг олж тогтоожээ. 1926-27 онд Ч.П.Рачковский нар Хангайн нурууны төгсгөл, Хасагт Хайрхан, Хантайшир ууланд геологийн судалгаа явуулсан. Судалгаагаар кембрий, силур, девон, карбон, юра, цэрд, миоцен, доод плиоцены хурдсыг амьтан, ургамлын үлдэгдлийн тусламжтайгаар насыг нь




Содоо 2.19 Аайтйаеи содоа, ад'юеэ үдееи аеэ

экспедицийн геологийн ангиуд 1:1000000-ны хураангуйлалттай зураглалын ажлууд явуулсан. Энэ ажлаар анх удаа доод кембрийн настай Завханы свит (эффузив), Цагаан оломын свит (карбонат), Баянголын свит (тунамал-карбонат) ба доод дунд девоны настай тунамал-вулканоген зузаалгийг ялгасан. 1965 онд В.А.Благонравов нар болон Чехийн геологийн экспедицийн 1:1000000 хураангуйлалттай геологийн судалгааг явуулсан бөгөөд давхарга зүйн хувьд хурдсуудыг свит, зузаалагт хуваасан бөгөөд эртний настай хурдсуудыг найдвартай баримтад тулгуурлан ангилаагүй. 1964-65 онд В.В.Беззубцев, В.И. Гольденбергийн удирдлагаар 1:1000000 геологийн зураглал явуулж харилцан нягт уялдаатай зохиосноор стратиграфийн нэгж ялгах, районы металлогений талаар нилээд үр дүнд хүрчээ.

Мөн PR-н хурдсыг 3 зузаалагт хуваасан. Дээд R-н Завханы свит, R3-V-н цагаан оломын свит зэргийг ялгасан. Интрузив чулуулгийн нас найрлагыг нь доод протерозойгоос перм-триас хүртэл өргөн ялгасан. Анх удаа дайк судлуудыг тодорхой ялгаж бичсэн байна. Л.Гомбо, Г.К. Еникеев нар 1971 онд 1:1000000 зураглалын ажлаар давхарга зүйн нэгжүүдийг ялгаснаас гадна интрузив бүрдлүүдийг фазад ялгасан. Судалгааны явцад олон тооны ашигт малтмалын илрэлүүд олж тогтоосон ба ашигт малтмалын (хүдрийн) хувьд ирээдүй муутай, хүдрийн ордын эрлийн ажилд ирээдүй бүхий гэж дүгнэснээс гадна районы хэмжээнд барилгын материалын янз бүрийн комплексыг илрүүлж улсад ашигтай усны эх үүсвэрийг олж тогтоосон.

1981 онд Баянхонгорын экспедиц геологи-гидрогеологийн судалгаа явуулж үүний үр дүнд 1:500000 масштабтай хураангуйлсан геологи-гидрогеологи, ашигт малтмал, эрлийн геохимийн зургуудыг зохиосон.

Зураглалын явцад төмөр, мөнгө, талькийн илрэлүүдийг олж тогтоосон. Усны нөөц үнэлгээг талбайн хэмжээнд өгсөн.



**в). Дунд масштабын геологийн зураглал болон сэдэвчилсэн судалгаа:**

1976 онд М-XXX листийн урд хагаст Ж.Даваасамбуу нарын судлаачид 1:200000-ны зураглалын ажлыг явуулж давхарга зүйн хувьд шинээр доод протерозойн хувирмал хурдсыг 3 зузаалагт хуваасан. Анх удаа дээд пермийн вулканоген хурдсыг амьтны үлдэгдлээр тогтоожээ. Түрүү протерозойн хэт суурилаг чулуулгаас ялгагдах түрүү кембрийн гипербазитын бүрдлийг ялгасан. Дунд протерозойн бүрдлийг 2 фазад ялгасан. Үүнд: 1. Габбро, 2. Гранит 1976-77 онд Д.Тогтох, 3. Гансүх нарын судлаачид Онгон нуурын районд (М-47-XXV) 5500 кв.км талбайд 1:200000 зураглалын ажил явуулж докембрийн хувирмал хурдсыг 2 свитэд ялгасан. Үүнд:

- 1. Хонгилцагийн свит (кварцит-

- карбонатын)
- 2. Тэсийн свит (занар-гнейсийн)

Районы хэмжээнд анх удаа түрүү палеозойн интрузив дээр үл нийцлэгээр хучдаг доод девоны вулканоген хурдсыг ялгасан. Дээд пермийн вулканоген бүрдлийг 3 зузаалагт хуваасан ба энэ нь дундлаг-суурилаг, хүчиллэг, тунамал-вулканоген зузаалагт ялгасан. Анх удаа районд доод-дунд юрагийн нүүрс агуулсан хурдсыг тогтоосон.

1979-80 онд В.В.Коток 1:200000-ны хураангуйлалтай агаарын соронзон зураглалын ажлыг явуулсан. 1978-81 онуудад Мөрөнгийн бүлэгчилсэн зураглалын анги 1:200000-ны хураангуйлалтай судалгааны ажлыг явуулж Завханы бүсэд доод протерозойн, доод-дунд рифейн хувирмал чулуулаг, түүнийг үл нийцлэгээр хучиж байгаа идэвжлийн болон субплатформ-эх газрын дээд рифейн, дээд рифей-вендийн, доод кембрийн, доод пермийн, мезозойн настай тунамал, карбонат-вулканоген хурдсуудыг ялгасан байна.

**г). Том масштабын геологийн зураглал болон эрэл-шалгалт, эрэл-үнэлгээний ажлууд:**

Д.Баадай нарын судлаачид 1:50000-ны эрэл-зураглалын ажлыг Хан Хөхийн нурууны БУ хэсэгт явуулж доод кембрийн вулканоген-тунамал хурдсыг дотор нь Ичитийн вулканоген свит, Байцат уулын тунамал-карбонат болон цахиурлаг свитэд ялгажээ. Дээд протерозойн хурдсыг амфиболит-карбонатын Хонголцагийн свит, гнейс-занар-кварцитын Тэсийн свитэд ялгасан. Формацийн түвшингээрээ доод кембрийн терриген вулканоген хурдсыг Хан Хөхий, Ичитийн, Байцат уулын свитүүдэд ялгаснаас гадна дотор нь дэд свитүүдэд ангилсан. Судалгааны явцад хүрэн нүүрсний 2 илрэл, төмрийн нэг илрэл зэргийг илрүүлснээс гадна сонирхол татахуйц олон зэсийн илрэлийг тогтоосон. Доод кембрийн Хан Хөхийн свитийг (вулканоген-тунамал) амьтны үлдэгдлээр насыг баталгаажуулжээ. 1991-92 онд Н.Амитан нар Баруун Монголын нутагт явуулсан эрэл шалгалтын ажлаар Шувуун хар уул, Бага Баян-Айраг уулын алтны хүдрийн зангилаануудад ажиллаж зохих үнэлэлт дүгнэлтийг өгчээ. Эдгээр алтны хүдрийн зангилаа нь Шувууны свитийн занар дотор хөгжсөн алт агуулсан кварцитын үетэй холбоотой үүсчээ. Уг ажлаар алтны нөөцийг РЗ зэрэглэлээр тогтоожээ.

1994-1995 онд Д.Эрхчөлөө нар Шувуун хар уул, Зүүн шувуун уулын хүдрийн зангилаанд эрэл-үнэлгээний ажлыг явуулсан бөгөөд уг ажлаар алтны шороон хуримтлал үүсэх нөхцөл боломжийг судалсан байна. 1994-1995 онд С.Эрдэнэцогт нар 1:50000 эрэл зураглалын ажлыг аргачлалын дагуу явуулж олон тооны материалыг шинээр цуглуулж, үнэлэлт дүгнэлт өгсөн. 1993-1995 онуудад Ж.Даваасүрэн нар 1:50000 ны геологийн зураглалын ажлыг явуулж талбайн давхарга зүй, гүний чулуулаг, ашигт малтмалын талаар өөрсдийн хийсэн судалгаа болон шинээр цуглуулсан баримт, материалуудыг өмнөх судлаачдын материалуудтай харьцуулан нэгтгэн боловсруулж тайланд тусгасан. 1996 онд С.Ганбаатар нар Дөрвөлжин сумын Баян Айрагийн хүдрийн талбайд явуулсан 1:10000 ны эрлийн ажлын үр дүнд алтны хүдэржилттэй хувирлын бүс ( хүдрийн бие)-үүд ялгагдан, тэдгээрийн хэмжээг тогтоох, сорьцлох зорилгоор нэвтэрсэн сувгийн ул болон гадаргуугийн хадан гаршнаас авагдсан ховилон сорьцны алтны болон химийн шинжилгээний үр дүнгээр таамаг нөөц бодогдсон.

**Геологийн тогтоц:** Завхан аймгийн нутаг дэвсгэр нь хойд хэсгээрээ Төвийн Монголын массивын Сонгино Тарвагатайн өргөгдөл, Хойд Монголын атираат системийн Идэрийн структур-формацын бүсэд хамаарагдана. Тус аймгийн геологийн тогтоцын хувьд архейн хувирмал чулуулгаас хожуу мезозойн эх газрын тунамал-вулканоген чулуулаг хүртэлх урт хугацааны насыг хамаарна. Стратиграфийн нэгжийг сери, свитийн түвшинд тусгасан болно. Чулуулгийн тархалт, нэр, найрлага, бүрдэл зэргийн мэдээллийг (Зураг №2) түүний таних тэмдгээс үзэж болно. Интрузив чулуулаг нутгийн 80%-д тархах бөгөөд түрүү протерозойн (ангилаагүй бүрдэл), дунд рифейн (ангилаагүй бүрдэл), хожуу рифейн (завханы бүрдэл), вендийн (ангилаагүй бүрдэл), түрүү кембрийн (ангилаагүй бүрдэл), дунд-хожуу кембрийн ( тэлмэний бүрдэл), хожуу девоны ( тэсийн бүрдэл), хожуу карбоны (хангайн бүрдэл), түрүү пермийн (улаагчийн бүрдэл), хожуу пермийн (булнайн бүрдэл), хожуу перм-түрүү триасын ( шар ус голын бүрдэл), хожуу триас-түрүү юрагийн (шувуутын бүрдэл) бүрдлүүдийн гүний чулуулаг, түрүү девон, түрүү пермийн субвулкан биетүүд тархжээ. Интрузив чулуулгийн бусад мэдээллийг геологийн зураг, түүний таних тэмдгээс үзэж болно.

**Металлогений онцлог:**Завхан аймгийн нутагт ялгасан металлогений онцлогийг дараахь хүснэгтээр харуулав.

Завхан аймгийн нутаг дахь металлогений онцлог, /Хүснэгт 2.1/

| Муж    | Металлогений бүс | Лист | Хүдрийн дүүрэг     | Металлогений төрөлжилт   |
|--------|------------------|------|--------------------|--|
| Умард  | Хүнгүйн (Хү)     | М-46 | Завхан Мандал (ЗМ) | Пермийн настай шүлтлэгдүү боржин боржин-сиенит-боржиндиоритын хэлбэршилтэй холбоотой холимог металлын, скарны хэлбэршлийн хүдэржилт тархдаг. |
| Монгол | Нуурын( НУ)      | М-46 | Ханхөхий (ХХ)      | V-E1 настай гипербазитын хэлбэршилтэй холбоотой Ti-Mg-ын дунд-дээд кембрийн  |



|  |              |        |                 |   |
|--|--------------|--------|-----------------|---|
|  |              |        |                 | настай габбро-диорит-боржин-диорит-боржингийн хэлбэршилтэй холбоотой зэсийн колчедан, зэс-кварц-сульфидын, зэс холимог металлын скарны, алт-лиственитийн девоны шүлтлэг габбро-сиенит-боржингийн хэлбэршилтэй холбоотой шүлтлэг сиенит, нефелин сиенит дэх ховор шороон төмрийн хэлбэршлийн хүдэржилттэй.   |
|  |              |        | Дааган дэл (ДД) | Түрүү палеозойн настай габбродиорит-боржин диорит-боржингийн хэлбэршилттэй холбоотой зэс-кварц-сульфидын зэсийн скарны хэлбэршлийн хүдэржилт тархдаг.   |
|  | Ургамал (УР) | (М-46) | Морьт уул (МУ)  | Дунд рифейн настай шувууны свитийн шохойлог терриген хурдасны хэлбэршилтэй холбоотой магнетит-гематит-кварцитын, алт-кварцитын, дунд дээд кембрийн тогтохын шилийн бүрдэлтэй холбоотой вольфрамын грейзений, зэсийн-сульфидын, девоны настай цайвар боржингийн хэлбэршилттэй холбоотой вольфрамын грейзений, зэсийн-сульфидын никелийн төрлийн хүдэржилт тархдаг. |

### 2.1.1.5 Увс аймаг

**Газарзүйн байрлал:** Их нууруудын хотгорт орших Увс аймаг нь хойд талаараа Орос улстай, баруун талаараа Баян-Өлгий, урд талаараа Ховд, зүүн талаараа Завхан аймагтай тус тус хиллэн оршино. Хойд өргөргийн 90°00'- 96° 00', зүүн уртрагийн 48°30'-50°50' солбицолд нийтдээ 69 мян. кв км талбайг эзэлнэ.

Уул зүйн хувьд Хан Хөхийн нуруу бүхэлдээ орших бөгөөд хамгийн өндөр уулс нь Хархираа уул /4037 м/, Түргэн уул /3965 м /, Цагаан шувуут уул / 3496 м /, Байрам уул /2960 м /, Дуулга уул /2928 м /, хамгийн нам дор хэсэг нь Үнэгэдийн уул /1416 м /, Тас уул / 1472 м /, Жаргалантын овоо / 806 м /. Харьцангуй өндөр нь 600-800 м.

Тус аймгийн нутагт гадаргуугийн усан сүлжээ сайн хөгжсөн бөгөөд хур тунадасны тэжээгдэлтэй ихэнх нь байнгын устай байна. Томоохон голууд нь Ховд, Тэс, Нарийн, Зүүн ба баруун туруун, Завхан, Хархираа голууд орно. Мөн томоохон нуур цөөрөм ихтэй үүнд Увс, Хяргас, Үүрэг, Ачит, Айраг, Хар ус нуур орно.


Эх газрын эрс тэс уур амьсгалтай тул жилийн болон хоногийн агаарын температурын хэлбэлзэл маш өндөр, дулааны болон хүйтний өөрчлөлт шилжилт огцом. 1-2-р сард -30°-40° хэм хүйтэн, зун нь + 20°+35° хэм халуун болдог байна. Нийт нутагт өвөлдөө цас бага унадаг, жилд унах хур тунадасны хэмжээ нь 200 мм, 7-8-р сард ихэнх нь унадаг байна. Салхи нь ихэвчлэн баруун хойноосоо салхилах ба хавар, намарт салхины хүч нэмэгддэг. Салхины урсгалын хурд нь ердийн үед 7-9 м/сек байх ба хааяа 18-25 м/сек хүртэл нэмэгдэж шороон ба цасан шуурга болдог байна.

Амьтан ургамлын хувьд тархалт байршил нь уулзүй болон цаг уурын нөхцөлтэй шууд хамааралтай байдаг. 2000 м-ээс дээш өндөрлөгтэй уулсаар жинхэнэ өндөр уулын бүсийн тачирхаг өвс ургамал ургах ба уулсын хажуу бэл, нуурын хотгороор тал хээрийн бүсийн ургамал ургана. Бага хэмжээний талбайд шилмүүст ойтой. Амьтны аймгаар баялаг. Энд туурайтнаас буга, аргал угалз, янгир зэрэг амьтад их бага ямар нэг хэмжээтэй тархсан. Мэрэгчдээс тарвага, зурам, төрөл бүрийн хулгана, туулай, үслэг амьтдаас хадны суусар, үнэг, хярс, араатнаас чоно, шилүүс, ирвэс, жигүүртнээс хойлог, ятуу, хөхөө, бүргэд, шар шувуу, зуны улиралд усны шувууд нүүдлэллэн ирэх ба нуурт загас элбэгтэй.


**Хүн ам, эдийн засаг, зам харилцаа:** Тус аймагт хүн амны нягтаршил жигд биш, дөрвөд, захчин, торгууд, халх, өөлдүүд амьдрах бөгөөд мал аж ахуй, газар тариалангийн болон багахан хэмжээгээр уул уурхайн олзворлолтын ажил эрхлэн амьдардаг. Аймаг сумын төвд хүн амын суурьшил арай нягт, энд засаг захиргаа, банк, холбоо, сургууль, эмнэлэг, орон нутгийн чанартай хүнс ба ахуйн жижиг үйлдвэрүүд ажилладаг. Сумын төвүүд нь аймгийн төв, багуудтай авто тээврийн хөрсөн болон сайжруулсан шороон замаар холбогдоно. Орос улсаас цахилгаан экспортоор авдаг. Эдийн засгийн үндсэн салбар нь нүүдлийн мал аж ахуй, багахан газар усалгаатай тариалан эрхэлнэ.

**Геологийн судалгааны түүх:** 19-р зууны төгсгөл, 20-р зууны эхээр Оросын газар зүйн нийгэмлэгийн жуулчид, судлаачид Төв Азийн газар зүй, ургамал амьтны аймгийн онцлог, бүтцэд судалгаа хийж эхэлсэн бөгөөд энэ ажлын явцад тухайн нутгийн геологийн тогтоц, ашигт малтмалын талаар замын тэмдэглэл хөтлөж, үндсэн дүгнэлт өгч байсан нь анхны геологийн судалгааны эхлэл болсон байна.

П.Н.Потанин, И.Д.Клеменцын нар анх Улаан даваа, Улаан мөргөний конгломератыг тодорхойлж, мөн Хар Тарвагатайн нүүрсний, чулуун давсны ордуудын тухай бичиглэл хийж, карбоны хурдсаас ургамлын үлдэгдлийг олж тогтоосон байна. И.П.Рачковский энд геологийн ажил явуулж анх кембрий, ордовик, силур, девоны настай хурдсуудыг ялгасан. 1941 онд И.Э.Турищев тус аймгийн нутагт 1:1000 000 масштабын геологийн зураглал, шалгалтын маршрутын ажил явуулж зэс төмрийн орд нээгдэх боломжтой гэж үзээд төрөл бүрийн ашигт малтмалын 42 мэдээллийг шалгасан байна. 1952 онд К.Л.Волочкович мөн 1:1000 000 масштабын геологийн эрэл-зураглалын ажил явуулж, геологи давхрага зүй, түрмэл чулуулгуудыг ангилж Байрамын нуруу, Түргэний голын дагуу шлихийн дээжинд алтны ганц нэг ширхэгүүд байгааг тогтоожээ. 1961 онд К.Н.Совосин, И.А.Орехов нар Нүүрст хотгор, Хартарвагатай, Явар зэрэг нүүрсний ордуудад эрэл хайгуулын ажил явуулж, тус ордын геологийн зургийг зохиож, чулуун нүүрсний нөөцийг үйлдвэрийн зэргээр тооцсон байна. 1967-1970 онуудад Б.Лувсанданзан, А.Б.Дергунов нар Үүрэг нуурын орчимд судалгаа явуулж, энэ нутгийн давхрага зүйн схемийг боловсруулж, анх Үүрэг нуурын афонитын дайкийн комплексийг ялгасан байна. 1970-аад оноос эхлэж тус аймгийн нутагт 1:500 000-ны геологи-гидрогеологийн зураглалын ажлаар бүрэн бүрхэгдсэн болно. Тус ажлаар геологийн тогтоц, ашигт малтмалын төрөл зүйг тогтоосон байна. 1964 оноос эхлэж 1:200 000-ны геологийн зураглалын ажлаар тус аймгийн нутгийг бүрэн бүрхсэн бөгөөд дээрхи ажлуудын үр дүнд геологийн тогтоц, ашигт малтмалын гарал үүсэл, тархалтын онцлог зэргийг нарийвчлан судалж, хэтийн төлөв сайтай хүдрийн бүс, талбай болон хэсгүүдийг ялгаж үнэлгээ өгсөн байна. Мөн давхрага зүйг бүхэлд нь сери, давхрага, свит, ярус хүртэл ялгаж нарийвчлан ангилсан байна. Мөн интрузив чулуулгуудын насыг нарийвчлан тогтоож, петрографи, петрохими, геохимийн судалгаа хийжээ. 1977 оноос хойш 1:50 000-ны масштабын геологийн эрэл зураглалын ажлаар дэвсгэр нутгийн дөрвөний нэг хувийг бүрхсэн бөгөөд тэдгээр ажлын үр дүнд давхрага зүй, магматизм, тектоникийг нарийвчлан ялгаж ашигт малтмалаас зэс, нүүрс, алт, цайр, гянтболд, металл бус ашигт малтмалын орд илрэлүүдийг илрүүлж тэдний тархалтын зүй тогтол, байршил, гарал үүслийг тодруулж хүдрийн талбай хэсгийг ялгаж цаашид хийх эрэл хайгуулын ажлын талаар тодорхой чиглэл ба зөвлөмж



Соддаа 2.21 Өгөөд илгөддөөт иддә дөдүй; үддөй дөддөд



Соддаа 2.22 Үддөддөдөй соддаа



ангилаагүй бүрдэл-пироксент, пироксен- эвэрхуурмагт, оловин-пироксент, габбро-габбронорит, дунд-хожуу кембрийн ангилаагүй бүрдлүүд- тоналит, боржин, плагиокласт биотит- эвэрхуурмагт ердийн боржин, биотит- эвэрхуурмагт, биотитот тоналит, цахирт диорит, хоёр гялтгануурт боржин, дунд-хожуу ордовикийн ангилаагүй бүрдэл-биотитот, хааяа биотит- эвэрхуурмагт их төлөв шүлтлэгдүү лейкократ боржин, биотит- эвэрхуурмагт диорит, цахирт диорит, биотит, эвэрхуурмагт боржин-диорит, дунд ордовикийн Түргэний бүрдэл биотит- эвэрхуурмагт цахирт диорит, диорит, дунд силурын Ховдын бүрдэл пироксен- эвэрхуурмагт габбро-диорит, биотит- эвэрхуурмагт диорит, хожуу девоны Хархираа, Тэсийн бүрдэл-биотитот хааяа биотит- эвэрхуурмагт ердийн ба шүлтлэгдүү лейкократ боржин, ердийн ховроор боржин-сиенит, ердийн шүлтлэг лейкократ боржин, түрүү пермийн Улаагчийн бүрдэл-шүлтлэгдүү, лейкократот, ховроор ердийн биотитот боржин, хожуу пермийн Булнайн бүрдэл-шүлтлэгдүү, шүлтлэг, лейкократот ховроор ердийн боржингуудаас бүрдэнэ.

**Тектоник:** Увс аймаг нь тектоник бүтцийн мужлалын хувьд Монгол Алтайн атриат системийн Цагаан шивээтийн, Хархираагийн, Ямаатын, Нуурын, Завханы структур формацийн бүсэд хамаарагдах ба олон үе шатны атираажилтанд хүчтэй автагдсан нилээд нийлмэл тектоникийн бүтэцтэй. Хархираагийн бүс Ачит нуурын хотгор, Алтайн нурууны зүүн бэлдүү нутгийг эзэлсэн, баруун хил нь Ховдын гүний хагарал бөгөөд зүүн хойгуураа Ачит нуурын, зүүн урдуураа Цагаан шивээтийн региональ хагарлуудаар хиллэнэ. Энэ бүсийн тогтоц нь дундад, хожуу кембрийн настай хурдсан дээр суурилагдсан. Түүний дээр ордовик-силурын настай эх газрын, вулканаген эх газрын, шохойн хурдсуудын давхардас тогтжээ. Тэдгээрийн дээр нэмүүссэн девон, карбоны тогтоцууд тохиолдох ба энд Хархираа, Ховдын комплексын боржингийн түрэлтүүд энэ бүсийн геологийн тогтцонд шийдвэрлэх үүрэгтэй юм. Ямаатын структур-формацийн бүсийг сүүлийн үеийн судалгаагаар ангилан авч үзэх болсон / Волочкович,1987 /. Түрүү үеийн судалгааны материалуудад өмнөт хэсгийг нь тонхилын синклиналь, хойт хэсгийг нь Байрамын моноклиналь гэж тус тусад нь авч үздэг байв. Энэ тогтоц ордовик, силурын хурдаснаас бүрддэг, атриашилт, эвдрэл багатай.

Түүний төв болон өмнөд хэсгүүдэд девоны үед нэмүүссэн хавтагшуу дүрэг муульдууд ажиглагдаж эхэлдэг. Энэ бүсийн зүүн, зүүн-хойт хилийг дагаж нүүрс бүхий карбоны хурдасны муульдууд элбэг тохиолдоно. Цагаан шивээтийн бүс нь мөн ийм нэртэй гүний хагарлаар нуурын бүсээс зүүн талаараа тусгаарлагддаг бол, Байрамын хагарлаар Хархираагийн бүсээс, Ховдын хагарлаар Баян-Өлгийн бүсээс тусгаарлагдана. Ерөнхийдөө хүчтэй өлийж өргөгдсөн антиклиналь тогтоц бөгөөд түүний төвд кембрийн өмнөх насны талстлаг занарын комплекс илэрдэг. Кембрийн хурдас нь гантигийн жижиг биетүүд агуулах ба ногоон занарын аймагт орох хэмжээнд хүртэл хүчтэй хувирсан, шахагдсан шугаман атриашилтууд үүсгэнэ. Ордовикийн хурдас өнцгийн хувьд тохироогүй давхардас үүсгэж Цагаан шивээтийн бүсийн тэнхлэгийн дагуу хэмжээгээрээ томгүй хотойлтууд дүүргэнэ.Ордовикаас залуу үүсэлтүүд тухайлбал /хожуу ордовик, силур, түрүү девон, юра /-ийн настай хурдсууд нь хожуу үеийн уулс хоорондын хотгорыг дүүргэж тогтсон байна.

Нуурын бүс их нууруудын хотгорыг эзэлж оршино. Баруутаа Цагаан шивээтийн гүний хагарал, зүүнтээ Завханы хагарлаар тус тус хиллэдэг. Нуурын бүсэнд офиолитын спилит- диабаз-базальтын найрлага бүхий тогтоцонд суурилагдах бөгөөд түүний дээр арай хүчиллэг андезит-базальт, андезитын давхарга хучиж тогтоно. Эдгээр нь венд-кембрийн настай юм. Түүнээс дээш 600 м-ээс ихгүй зузаантай ордовик, силурын молассын хурдас үүссэн. Түрмэл тогтоцуудын дотор гипербазитын биетүүд элбэг тархсан. Интрузивээс Тогтохын шилийн цогцолбор түрмэлүүд, боржин-шүлтлэгдүү боржингийн Хархираагийн цогцолбор зонхилно. Атриашилт нь баруун хойш чиглэсэн шугаман хунираанууд үүсгэнэ. Завханы бүсийн зөвхөн дээд хэсэг нь хамрагдана.

Завханы гүний хагарлаар нуурын бүстэй хиллэнэ. Энд хувирмал чулуулгийн хоёр төрлийн цогцолбор, ангилан авч үздэг.Үүнд: дундлаг юмуу хүчиллэг найрлагатай нь зонхилсон суурилаг найрлагатай нь бага тархсан хуурай газрын бялхмал чулуулгийн аймаг, түүнээс дээш терриген шохойжин, конгломератын цогцолбороос тогтоно. Энэ цогцолборыг венд доод кембрийн настай гэж үздэг. Атриашилтийн дараа девон, пермийн хурдсуудаар хучигдсан байна. Тус аймгийн нутгийн хэмжээнд илэрсэн томоохон хагарлуудаас нэрлэвэл Цагаан шивээт, Хангай, Хархираа, Байрамын, Завхан, Үүрэг нуур, Бургастайн голын гэх мэт олон хагарлуудыг дурдаж болох юм.

**Металлогений онцлог:** Увс аймгийн дэвсгэр нутагт Ховд, Цагаан шувуутын, Тува-Монгол, Нуурын, Ургамлын гэсэн металлогений 5 бүсэд Ачит нуур, Үүрэг нуур, Бургастайн гол, Туруун, Хан хөхийн, Хандгайт, Харгант, Чигэртэйн, Дааган дэл, Морьт уул гэсэн 10 хүдрийн дүүрэг ялгажээ.

Ашигт малтмалын хувьд тус аймагт 2002 оны байдлаар нийтдээ 41 орд, 255 илрэл, ирээдүйтэй 26 эрдэсжсэн цэг, олон тооны геохимийн, шлихийн сарнилын хүрээ, геофизикийн аномалууд тэмдэглэгдсэн байна.

**Хэтийн төлөв:** Увс аймгийн нутаг дэвсгэрт нилээд олон орд, илрэл тогтоогджээ. Аймгийн нутаг дэвсгэр нь бүхэлдээ 1:200 000 масштабтай геологийн зураглалын ажлаар бүрхэгдсэн бөгөөд нутгийн баруун, зүүн өмнөд хэсгээр 1:50 000 зураглал-ерөнхий эрлийн ажил хийгдсэн нь нутгийн зөвхөн 30 орчим хувь болж байгаа нь цаашид нутаг дэвсгэрийг бүхэлд бүрхэх шаардлагатай. Тус аймаг нь алт, зэс, ховор металл, гоёл чимэглэлийн чулуу, шатах малтмалын хувьд ирээдүйтэй тул цаашид хийх судалгааг дээрх ашигт малтмалуудад хандуулж явуулах шаардлагатай.

Орд, илрэл, дүүргийн талаар тодорхой мэдээллийг хүсвэл АМХЭГ-ийн Геомэдээллийн төв /УГФ/-д захиалга өгвөл таны хүссэн хугацаанд гаргаж өгнө.

### Дүгнэлт

Монголын баруун бүсийн Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий аймгуудын нутаг дэвсгэр дээр нийт 104 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 61 аж ахуйн нэгж 20200 га талбайд үйл ажиллагаа явуулж байгаагаас алтны 39, нүүрсний 33, барилгын материалын 8, давс болон бусад төрлийн ашигт малтмал олборлох зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

### 2.1.2 Хөнгөн үйлдвэр

Зах зээлийн эдийн засагт шилжсэн он жилүүдэд манай орны Баруун бүсийн аймгуудын хүн ард өөрсдийн амьжиргаа, өдөр дутмын хэрэгцээгээ хангахын тулд мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийг арилжаалах төдийхнээр амьдралаа зогоож байна.

Төр, засгийн зүгээс жижиг дунд бизнесийг хөгжүүлэх талаар арга хэмжээнүүдийг төлөвлөж байгаа боловч төдийлэн үр дүнд хүрсэнгүй, ажилгүйдлийн төвшин өндөр хэмжээнд хэвээр байна. Цаашид Баруун бүсийг үйлдвэржүүлэх явдал нь бусад бүсийн хөгжлөөс хоцрохгүй байх, ажилгүйдлийг бууруулж, амьдралын түвшинг дээшлүүлэх нэг гол нөхцөл болно. Улсын хэмжээнд ажилгүйдлийн төвшин 2.8, хүний хөгжлийн индекс 0.718 байгаагаас Баруун бүсэд хүний хөгжлийн индекс 0.676, ажилгүйдлийн төвшин 4.8 хувь, амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур орлоготой айл өрх олон байна.

Аймгуудын хүний хөгжлийн индекс, ажилгүйдлийн түвшин, /Хүснэгт 2.2/

| Аймгийн нэр   | Хүний хөгжлийн индекс | Аймгууд дунд эзэлж буй байр | Ажилгүйдлийн төвшин |
|---------------|-----------------------|-----------------------------|---------------------|
| Улсын дундаж  | 0.718                 |                             | 2.8                 |
| Баян-Өлгий    | 0.690                 | 8                           | 6.4                 |
| Ховд          | 0.686                 | 11                          | 4.0                 |
| Завхан        | 0.676                 | 14                          | 4.5                 |
| Увс           | 0.672                 | 16                          | 5.5                 |
| Говь-Алтай    | 0.657                 | 20                          | 3.4                 |
| Бүсийн дундаж | 0.676                 |                             | 4.8                 |

Баруун бүсийн аймгуудаас Баян-Өлгий аймаг ажилгүйдлийн төвшнөөр улсын хэмжээнд хамгийн өндөр 6.4 хувьтай, Ховд, Завхан, Увс, Говь-Алтайд 3.4-5.5 хувь байна. Тус бүсийн хөдөлмөрийн насны хүн амын дийлэнх нь хөдөлмөр эрхлэхгүй байгаагийн улмаас ажилгүйдэл дагасан ядуурал буурахгүй байгаа юм. Дээрх аймгуудад гурил, гурилан бүтээгдэхүүн, архи, ундаа, зайрмаг, барилгын материал, худалдаа, нийтийн хоолны жижиг нэгж, цехүүд ажиллаж байгааг эс тооцвол томоохон үйлдвэрлэл цөөн байна. Иймээс аймаг, сумын ...Үндсэн хэрэгцээг хангах үзэл баримтлалын үндсэн дээр хөдөөгийн үйлдвэржүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлж, жижиг дунд, үйлдвэрүүдийг хөгжүүлэх...”, “Бренд” бүтээгдэхүүнийг тодруулан сурталчлах үзэсгэлэн худалдааг тогтмол зохион байгуулж, тэдний үйл ажиллагаа, зах зээлийг нь өсгөх, түншийн холбоог тогтоох, бүтээгдэхүүнээ сурталчлахад нь орон нутгийн зүгээс дэмжлэг, санхүүгийн туслалцаа үзүүлэх шаардлагатай байна.

Цаашдаа Баруун бүсийн аймгуудад үйлдвэржүүлэлтийн бодлого доорх төрөл, чиглэлүүдээр хэрэгжих боломжтой юм. Үүнд:

1. Аймаг, бүс нутгийн зах зээлд баримжаалсан, тэдгээрийн тэлэлт, гүнзгийрэлт, төрөлжилтийг хангахад чиглэгдсэн, аймгуудын газрын дээрх болон доорх нөөц, боломжид суурилсан, үндсэн хэрэгцээг хангах, тодорхой хэмжээгээр импортыг орлох, экспортын баримжаатай хөдөөгийн үйлдвэржүүлэлт. Энэ нь их төлөв жижиг, дунд үйлдвэрлэл байна.

2. Хөдөө орон нутгийн иргэдийн үндсэн хэрэгцээг хангах, мал аж ахуй, газар тариалангийн анхдагч бүтээгдэхүүн, нэмэгдсэн өртөг үйлдвэрлэх чиглэлтэй, өрхийн болон бичил аж ахуй дээр суурилсан “бичил үйлдвэржүүлэлт”.

3. Өргөн хэрэгцээний түүний дотор удаан хэрэглээний бүтээгдэхүүн, тодорхой салбаруудын эцсийн бүтээгдэхүүн болон завсрын бүтээгдэхүүн, зарим капитал багтаамж ихтэй бүтээгдэхүүн зэргийн импортыг орлох, импорттой өрсөлдөх үйлдвэржүүлэлт.

4. Органик хөдөө аж ахуй, цэвэр байгаль орчны хосолсон хөгжил дээр үүссэн, цэвэр бүтээгдэхүүн, мэдээллийн технологийн outsourcing дээр түшиглэсэн экспортын диверсификац, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үе шат бүр дээр суурилсан бүтээгдэхүүний хөгжлийн үндсэн дээр бий болох уламжлалт бус, шинэ бүтээгдэхүүний экспортын баримжаатай үйлдвэржүүлэлт /уламжлалт экспортын зах зээлийн өргөжилт болон өртөг нэмж бүтээх үйл явц зэрэгцэн явагдана/.

5. Аялал жуулчлалын сектор дахь нэмэгдсэн өртөг бүтээх үйл явц, үйлчилгээний секторын орчин үеийн технологи дээр суурилсан, энэ секторын улирлын шинж чанарыг хамгийн бага болгоход чиглэгдсэн аялал жуулчлалын үйлдвэржүүлэлт.

6. Эрдэс баялгийн салбарын анхдагч бүтээгдэхүүний гүнзгий боловсруулалт, стратегийн том ордуудын ашиглалт, хөгжлийг дагалдан үүсэх субконтрактын харилцаан дээр үүсэж бий болох болон био-, нано-, hitech дээр суурилан хөгжих капиталын болон мэдлэгийн багтаамж ихтэй үйлдвэржүүлэлт.

7. Гадаадын орнуудад ажиллаж амьдарч байгаа монголчуудынхаа, ялангуяа үйлдвэржүүлэлтийг амжилттай хэрэгжүүлсэн улс орнуудад ажиллаж буй монголчуудынхаа мэдлэг, мэргэжил, туршлага, дадлагыг ашиглах үндсэн дээр тэдэнд зориулсан аж үйлдвэрийн тусгай парк байгуулах замаар хэрэгжүүлж болох үйлдвэржүүлэлт


Аймгуудад явуулсан судалгааны дүнгээс үзэхэд дараах чиглэлийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх боломжтой гэсэн саналыг гаргаж байлаа. Үүнд:

1. Ноос ноолуур боловсруулах үйлдвэр
2. Ангийн үс, үслэг эдлэлийн үйлдвэр
3. Арьс шир боловсруулах үйлдвэр
4. Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр
5. Мах боловсруулах үйлдвэр (Нядалгааны цех)
6. Талх нарийн боовны үйлдвэр
7. Жимс жимсгэний аж ахуй
8. Цэвэр ус, рашаан савлах үйлдвэр
9. Гурилын үйлдвэр, арвайн гурилын үйлдвэр
10. Хөргөлтийн зоорь
11. Оёмол сүлжмэлийн үйдвэр
12. Эсгий, эсгий гутлын үйлдвэр
13. Яс боловсруулах үйлдвэр
14. Мод боловсруулах үйлдвэр
15. Шахмал түлшний үйлдвэр
16. Барилгын дээвэр, ханын материалын үйлдвэр
17. Цемент шохойн үйлдвэрлэл
18. Чулуу боловсруулах үйлдвэр (Чулуун давс боловсруулах үйлдвэр)
21. Шилний үйлдвэр

- 22. Малын тэжээлийн үйлдвэр
- 23. Эмийн ургамал боловсруулах, хүлэмжинд тариалах үйлдвэр
- 24. Махны чиглэлийн үхрийн ферм
- 25. Сүүний чиглэлийн үнээний ферм
- 26. Туслах аж ахуй /гахай, шувуу/
- 27. Зөгийн аж ахуй
- 28. Хогийг ангилан ялгаж боловсруулах үйлдвэр
- 29. Хүнсний ногоо боловсруулах үйлдвэр
- 30. Жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэр
- 31. Ариун цэврийн цаас салфетканы үйлдвэр
- 32. Угаалгын нунтаг савангийн үйлдвэр
- 33. Хэвлэлийн үйлдвэр
- 34. Сав баглаа боодлын үйлдвэр
- 35. Хаягдал гялгар уут, хуванцар дахин боловсруулах үйлдвэр

Баруун бүсийн аймгууд нь Орос, Хятад улстай хилийн боомтоор дамжин зорчих, худалдаа, үйлдвэрлэл явуулах боломжтой учраас хөнгөн аж үйлдвэрлэл хөгжүүлэх давуу нөхцөл гэж үзэх үндэстэй.


Регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж,байгууллагын тоо /Диagramм 2.1/



Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж,байгууллагын тоо /Диagramм 2.2/

Хөнгөн үйлдвэр хөгжүүлэх талаар орон нутгийн санал /Зураг 2.25/





**Орон нутгийн нөөц буюу эрэлтэд тусгуурагсад**

- Сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах
- Мах боловсруулах үйлдвэр (Мал нялцалтааны пах)
- Талх нарийн боовны үйлдвэр
- Жимс жимсгийн аж ахуй
- Рашаал савлах үйлдвэр
- Гуриман үйлдвэр, арвайг гуриман үйлдвэр
- Хорголтийн зөөрч
- Оёмол суламзалийн үйлдвэр
- Эсгий, эсгий гуталын үйлдвэр
- Яс боловсруулах үйлдвэр
- Мод боловсруулах үйлдвэр
- Шахмал түрлийн үйлдвэр
- Баримтан дээвэр, хамтан материалын үйлдвэр
- Цөмөг шохийн үйлдвэрлэл
- Төмрийн үйлдвэр
- Гөлтгөний үйлдвэр
- Чулуу боловсруулах үйлдвэр (Чулуун давс боловсруулах үйлдвэр)
- Шилний үйлдвэр
- Милын төлөлийн үйлдвэр
- Эмийн ургамал боловсруулах, хүрэмжэнд таринах үйлдвэр
- Махны чиглэлийн үхэр гахайн ферм
- Сүүний чиглэлийн үзэсний ферм
- Туслалх аж ахуй /гахай, пунуу/
- Зөгийн аж ахуй
- Авто замын үйлдвэр

**Импортог орлох**

- Хөгийг ашиглан янзгаж боловсруулах үйлдвэр
- Хүнсний ногоо боловсруулах үйлдвэр
- Жимс жимсгийн боловсруулах үйлдвэр
- Арван намрын цэвэр шилжүүлэн үйлдвэр
- Угаалгийн нунтаг савангийн үйлдвэр
- Хөвсгөний үйлдвэр
- Сан бичилж бичилж үйлдвэр
- Хаягдал хөнгөр ууг, хуванцар дахин боловсруулах үйлдвэр
- Салхины эрвэн хүний үүсгүүрийн үйлдвэр
- Нарны шилжүүлэн үүсгүүрийн үйлдвэр
- Эхээр өвчлөлтэй ашигын хөлийн үйлдвэр
- Божин хуванцар гурвал бэлтгэх үйлдвэр
- Хөлийн үйлдвэр дахин боловсруулах үйлдвэр

**Экспортын чиглэлийн**

- Төмөр бетон, ган тэс, хуванцар хоолойн үйлдвэр
- Дал сүүдэр багс, биёр, утас хийх үйлдвэр
- Зөв мөбиль утас, прозомийн үйлдвэр
- Ноос ноодуур боловсруулах үйлдвэр
- Ангийн үе, үзлэг эдлэлийн үйлдвэр
- Арван намр боловсруулах үйлдвэр
- Архатур ган хийн эдлэлийн үйлдвэр
- Галт шилжүүлэн буй өргөлтийн өсөөр хөлийн аж ахуй үйлдвэр
- Уул уурхайн том төсүүдийн алан хэрэгжүүлэх аж үйлдвэр

## Барилгын материалын томоохон орд газрууд

### Ховд аймаг дахь барилгын материалын томоохон орд газрууд /Хүснэгт 2.3/

| Ордын нэр           | Байршил                     | Солбилцол              | Ашигт малтмалын хэлбэр  | Агуулга   | Нөөц   | Хэтийн төлөв  |
|---------------------|-----------------------------|------------------------|---|---|--|---|
| Сүүн толгойн илрэл  | Алтай сумаас БУ 65 км-т     | 45°14'40"<br>92°00'40" | 3-4м зузаан, 700м урттай 37 соронзон гүрийн мишел биетүүд тогтоогдсон   | /Fe <sub>2</sub> O <sub>3</sub> +FeO/ төмрийн нийлбэр дундаж агуулга нь 57.8%, Au 0.1-20 г/т, Cu 0.015=1%                               | P=85500 тн   | Цаашид судлах шаардлагатай                            |
| Цагаан түнгийн орд  | Үенч сумаас БУ 24км-т       | 45°51'45"<br>91°47'40" | Мишел маягын хэлбэртэй 1.6x0.7 км талбай бүхий хэвтэшийн ашигтай зузаалгын зузаан нь 0.3-2.8м тоосгоны шаврын орд   | Шавар нь 900°-т шатаахад усаа алдах чанар нь 19.7%, шахмал ба бат бөх нь 124.8 кг/см <sup>2</sup> , гулзайлт нь 25.7 кг/см <sup>2</sup> | A+B+C= 668285тн  | Одоогоор ашиглагдаж байгаа.                           |
| IV-2-5 илрэл        | Ховд сумаас ЗХ 8км-т        | 48°09'15"<br>91°28'20" | 2 км <sup>2</sup> талбайд 2-5м зузаантай шаврын үе тархсан.   |   |  | Цаашид судлах шаардлагатай                            |
| IX-29-B-29 илрэл    | Манхан сумаас БУ 32км-т     | 47°09'30"<br>92°07'30" | Шохойжингийн 300-450м зузаан, 5км урт гарш нь зүүн хойш 60-75° -ын налуу байрлалтай.                                |   |  | Цаашид судлах шаардлагатай.                           |
| Ховдын орд          | Ховд хотоос зүүн тийш 8км-т | 48°00'30"<br>91°45'30" | 100-500м зузаантай 18км урттай шохойн чулууны гарш хайгуул хийсэн нь 150м урт, 35-120м зузаантай шохойн чулууны үе. | CaCO <sub>3</sub> дундаж агуулга нь 95%-аас их, MgCO <sub>3</sub> 2.2-6.0%  | P=132сая.тн<br>B+C=1295.1 мян.тн   | Одоогоор ашиглаж байгаа                               |
| Цагаан үнэгтийн орд | Дөргөн сумаас БХ 47км-т     | 48°23'30"<br>92°13'00" | 4км урт, 1км өргөнтэй шохойн чулууны гарш   | CaCO <sub>3</sub> 98.93%  | 500сая.тн  | Нөөц өсгөх боломжтой                                  |
| Ховд-1 орд          | Ховд хотоос БУ 5км-т        | 48°01'00"<br>91°30'00" | 1.2км урттай, 600м өргөн, 2м зузаантай элс хайрганы хольц бүхий зузаалаг  | "300" маркийн хүнд бетон үйлдвэрлэхэд тохиромжтой   | Хайрга<br>B=48.6,<br>C <sub>1</sub> =164.49,<br>C <sub>2</sub> =166.5мян.<br>м <sup>3</sup> , Элс<br>B=329.41,<br>C <sub>1</sub> =1023.658,<br>C <sub>2</sub> =1049.68мян.<br>м <sup>3</sup> | Нөөцийг өсгөх боломжтой                               |
| Буянтын орд         | Ховд хотоос БУ 4 км-т       | 47°59'35"<br>91°36'00" | 1.5км урт, 500-800м өргөн 1.3-3.5м зузаантай хайрга элсний хольц бүхий үе   | Хайрга 41.77-77.12%, элс 22.88-58.23% "300" маркийн хүнд бетон үйлдвэрлэхэд тохиромжтой   | A+B+C <sub>1</sub> =319<br>1<br>мян.м <sup>3</sup>   | Нөөцийг 5-6 сая.м <sup>3</sup> хүртэл өсгөх боломжтой |
| Придорожные орд     | Ховд хотоос ЗХ 7км-т        | 48°02'30"<br>91°40'30" | 200x300м талбайд 0.6-0.9м зузаантай элсний давхарга   | "300-400" маркийн бетон үйлдвэрлэхэд тохиромжтой  | B=35.6<br>мян.м <sup>3</sup> ,<br>C <sub>1</sub> =65.78мян.<br>м <sup>3</sup>  |   |
| Рашааны орд         | Ховд хотоос БУ 2.5км-т      | 48°00'30"<br>91°40'20" | 700x370м хэмжээтэй изометрлэг хэлбэртэй боржингийн биет   | Зузаан нь 1.2м, эзэлхүүн жин нь 2.51-2.90т/м <sup>3</sup> , ус шингээлт нь 0.6-1.3%   | C <sub>1</sub> =14480мян.<br>м <sup>3</sup>  | Урьд нь ашиглаж байсан                                |

Увс аймаг дахь барилгын материалын томоохон ордууд /Хүснэгт 2.4/

| Ордын нэр              | Байршил                              | Солбилцол              | Ашигт малтмалын хэлбэр   | Агуулга   | Нөөц   | Хэтийн төлөв                |
|------------------------|--------------------------------------|------------------------|--|---|--|-----------------------------|
| Харгантын орд          | Улаангом хотоос ЗУ 45км-т            | 49°37'00"<br>92°11'00" | 1200м урт, 3-7м-ээс 12-30м зузаантай магнетитын 2 хүдрийн биет тогтоогдсон.                          | Fe 25.1-67.5%,<br>Ti 0.33%,<br>Cu 0.17%, Zn 0.1%, Sn 0.01%  | P <sub>2</sub> = 4сая,<br>P= 100сая  | Цаашид судлах шаардлагатай  |
| МАН-14 илрэл           | Өлгий сумаас баруун тийш 32км-т      | 49°05'30"<br>92°10'50" | 38500м <sup>2</sup> талбайд магнетитын хүдэржилттэй  |   | P= 1.5сая.тн   | Цаашид судлах шаардлагатай  |
| Хийморийн илрэл        | Бөх мөрөн сумаас БУ 40км-т           | 50°04'00"<br>91°33'00" | 10х20м-ээс 100х30м хэмжээтэй 4 хүдрийн биет  | Fe 10-60%,<br>Ni 0.1%   | P <sub>1</sub> =933.2 Fe,<br>P <sub>1</sub> =2.9 Ni  | Цаашид судлах шаардлагатай  |
| Чандманы орд           | Улаангом хотоос урагш 2км-т          | 49°57'00"<br>92°03'00" | Жижиг ширхэгтэй боржин   | Эзэлхүүн жин нь 1.81-2.83г/м <sup>3</sup> , хувийн жин нь 2.56-2.64г/м <sup>3</sup> , ус шингээлт 0.7-1.3%                                    |  |                             |
| Нэргүй орд             | Өмнөговь сумаас БУ 54км-т            | 48°40'40"<br>91°23'00" | 1.3км урт, 100м зузаантай гантигийн хоёр зузаалаг тогтоогдсон.                                       |   |  | Цаашид судлах шаардлагатай  |
| Гашуун голын орд       | Улаангом хотоос ЗУ 3км-т             | 49°58'00"<br>92°07'00" | Боржингийн чулууны орд   | "300-400" маркийн бетон үйлдвэрлэхэд тохиромжтой  | A=159.4мян.м <sup>3</sup> ,<br>B=298.3мян.м <sup>3</sup> ,<br>C <sub>1</sub> =765.8мян.м <sup>3</sup> ,<br>C <sub>2</sub> =366.6мян.м <sup>3</sup> , | Одоо ашиглаж байгаа         |
| Улааны илрэл           | Ховд сумаас зүүн тийш 35км-т         | 49°17'29"<br>91°23'58" | 110х100м талбайд порфир маягын боржингийн гарш илэрсэн. Блоктын хэмжээ нь 0.2х3х4м-ээс1.2х6м хүртэл. |   | P <sub>2</sub> =30сая.м <sup>3</sup>   | Одоо ашиглаж байгаа         |
| Цагаан чулуутгийн орд  | Улаангом хотоос баруун тийш 20км-т   | 50°00'00"<br>91°47'00" | 190м урт, 1.5-4.4м зузаантай шохойн чулууны зузаалаг.  | CaCO <sub>3</sub> 92.7%,<br>MgCO <sub>3</sub> 2.13-3.25%,<br>н.о 3.86-4.65%,<br>ГОСТ-5331-63д тохирно.  | B+C <sub>1</sub> =<br>192.5мян.тн  | Одоогоор ашиглаж байгаа.    |
| Майхан дэл уулын илрэл | Дарьтын орой уулнаас зүүн тийш 9км-т | 50°00'59"<br>90°28'00" | 320м зузаантай гантигжсан шохойн чулууны зузаалаг  | CaO 48.6%,<br>CO <sub>2</sub> 35.79%,<br>MgO 6.59%,<br>SiO <sub>2</sub> 5.86%   |  | Цаашид судлах шаардлагатай. |
| Гэсэр уулын илрэл      | Ховд сумаас хойш 30км-т              | 49°32'52"<br>91°54'15" | 1.2х2.2км <sup>2</sup> талбайд 200м зузаантай шохойн чулууны зузаалаг.                               | CaO 51.86-53.49%,<br>Al <sub>2</sub> O <sub>3</sub> 0.36-0.52%,<br>Fe <sub>2</sub> O <sub>3</sub> 0.03-0.05%,<br>SiO <sub>2</sub> 1.64-3.71%. | P <sub>2</sub> =260-350сая.тн  | Цаашид судлах шаардлагатай. |
| 78-В-Ш-4-19 илрэл      | Хар хэрц уулын орой хэсэгт           | 49°43'24"<br>92°41'58" | 1100м урт, 108м зузаантай гантигжсан шохойн чулууны мишел нь 380°-ийн уналтай.                       | Барилгын шохойн үйлдвэрлэлд тохиромжтой   | P=16сая.тн   | Цаашид судлах шаардлагатай  |
| Зосын хар толгойн орд  | Зосын хар толгойгоос БХ 1.1км-т      | 49°32'51"<br>92°32'09" | Шохойн биет нь зүүн хойш 55-60 хэмийн уналтай, 3км урт, 150-   | CaO 53.34-54.06%,<br>MgO0.39-0.66%,   | 68.8сая.тн   | Цаашид судлах шаардлагатай  |

|                    |                                    |                         |   |  |  |                      |
|--------------------|------------------------------------|-------------------------|---|--|--|----------------------|
|                    |                                    |                         | 180м зузаантай шохойн чулууны мишел.  |  |  |                      |
| Улаангом орд       | Улаангом хотоос баруун тийш 1.5км  | 49°59'00"<br>92°02'00"  | 0.4-2.1м зузаантай шаврийн хэвтээш.   | "50"-“75” маркийн тоосго үйлдвэрлэхэ тохиромжтой.                        | $C_1=462.6$ мян.м <sup>3</sup>   | Ашиглагдаж байгаа    |
| Хяргасын орд       | Наранбулаг сумаас зүүн тийш 21км-т | 49°22'00"<br>92°54'30"  | 400-500м өргөн, 500м урт, 15м зузаантай шаврын хэвтээш.                             | "75” маркийн тоосго үйлдвэрлэхэд тохиромжтой. Мөн ГОСТ 530-71-д тохирно. | A=198.3мян.тн,<br>B=480.9мян.тн,<br>C <sub>1</sub> =968мян.тн                                    | Одоо ашиглаж байгаа. |
| Малчин-1 илрэл     | Малчин сумаас БХ 1км-т             | 49°45'00"<br>93°15'00"  | 0.8-2.7м зузаантай шаврын хэвтээш.  | "75” маркийн тоосго үйлдвэрлэхэд тохиромжтой. ГОСТ 530-71-д тохирно.     |  | Цаашид судлана.      |
| Орлогын голын орд  | Өмнөговь сумаас хойш 25км-т        | 49°15'00"<br>91°41'00"  | Шаврын хэвтээш  | "150"-“200” маркийн тоосго үйлдвэрлэхэд тохиромжтой.                     | A=2492.3мян.тн,<br>B=3518.6мян.тн,<br>C <sub>1</sub> =10342.2мян.тн                              | Одоо ашиглаж байгаа. |
| Хархираа голын орд | Улаангом хотоос урагш 9км-т        | 49°53'00"<br>92°04'00"= | 1км <sup>2</sup> талбайд 1.8-4.2м зузаантай элс хайрганы давхарга хэлбэрийн хэвтээш | "100"-“250” маркийн хүнд бетон дүүргэгчид тохиромжтой.                   | A=329мян.м <sup>3</sup> ,<br>B=744мян.м <sup>3</sup> ,<br>C <sub>1</sub> =1925мян.м <sup>3</sup> | Ашиглаж Байгаа       |
| Тэсийн голын орд   | Тэс сумаас 3Х 3км-т                | 50°31'00"<br>93°35'00"  | 300х400м талбайд 1м зузаантай элс хайрганы хоёр линз хэлбэрийн хэвтээш              | "300” маркийн хүнд бетон дүүргэгчид тохиромжтой.                         |  | Одоо ашиглаж байгаа. |

**Баян-Өлгий аймаг дахь барилгын материалын томоохон ордууд /Хүснэгт 2.5/**

| Ордын нэр                | Байршил                                      | Солбилцол              | Ашигт малтмалын хэлбэр  | Агуулга   | Нөөц   | Хэтийн төлөв               |
|--------------------------|--|------------------------|---|---|--|----------------------------|
| Цахир уулын илрэл        | Баян-Өлгий аймгийн төвөөс 3Х 35км-т          | 49°12'00"<br>90°10'00" | Аэромагнитын гажигын өргөн нь 350м, урт нь 900м                 | Fe 58.35%   | P= 3-55сая.тн  | Цаашид судлах шаардлагатай |
| Бугатын элс хайрганы орд | Өлгий хотоос зүүн тийш 4км-т                 | 48°58'00"<br>90°01'00" | Элс хайрганы давхаргын зузаан нь 0.8-2.85м                      | "200” ба "300” маркийн хөнгөн бетон үйлдвэрлэхэд тохироно.                                    | B+C <sub>1</sub> =175.6;<br>C <sub>2</sub> =776.7мян.м <sup>3</sup>                                      | Ашиглаж байгаа             |
| Баян-Өлгий орд           | Өлгий хотоос баруун тийш 3км-т               | 48°57'50"<br>89°58'49" | Элс хайрганы пласт хэлбэрийн оршидосын зузаан нь 1.5-3.2м.      | "300” маркийн хүнд бетон үйлдвэрлэхэд тохироно.   | A=216.8мян.м <sup>3</sup> ,<br>B=759.0мян.м <sup>3</sup> ,<br>C <sub>1</sub> =1683.0мян.м <sup>3</sup>   |                            |
| 294-р орд                | Цэнгэл сумаас БУ 57км-т                      | 48°35'40"<br>88°53'34" | Нийтдээ 10км <sup>2</sup> талбайд тархсан. 10м зузаантай.       |   | 100сая.м <sup>3</sup>  | Цаашид судлах              |
| 14-А-1-5 хайрганы орд    | Төгрөг голын ганц модны голд цутгасан хэсэгт | 48°38'40"<br>90°40'50" | 500м урт, 20м өргөн, 3м зузаантай хайрганы давхарга тогтоогдсон | Хайрганы гранулометрийн найрлага нь 40-30мм 5%, 30-20мм 30%, 20-10мм 20%, 10-5мм 10%, 2мм 15% | P <sub>1</sub> =52500тн,<br>P <sub>2</sub> =337500тн<br>Бетоны үйлдвэр, авто замын даланд ашиглаж болно. |                            |
| Хатуугийн голын илрэл    | Өлгий хотоос 3У                              | 48°54'10"<br>90°14'30" | 10-24м зузаан, 250-300м   | Хөнгөн бетоны дүүргэгчид  | P <sub>2</sub> =250-300мян.м <sup>3</sup>  | Цаашид судлах              |

|                                 |                                   |                     |   |   |   |                            |
|---------------------------------|-----------------------------------|---------------------|---|---|---|----------------------------|
|                                 | 20км-т                            |                     | урттай алевролитын хоёр давхарга тогтоогдсон  | тохирно   |   | шаардлагатай               |
| Сайр илрэл                      | Толбо сумаас 3У 16км-т            | 48°21'40" 90°29'10" | 3км <sup>2</sup> талбайд порфирлог боржин   |   | P <sub>2</sub> =30сая.м <sup>3</sup>  | Цаашид судлах шаардлагатай |
| 113-р орд                       | Цэнгэл сумаас 3Х 3км-т            | 48°58'30" 89°09'00" | 2.5км <sup>2</sup> талбайд тархсан элсэн чулуу 5х10х20см-ээс 20х30х70см хэмжээтэй   |   |   | Цаашид судлах шаардлагатай |
| Баян-Өлгийн тоосгоны шаврын орд | Өлгий хотоос 3У 2-3км-т           | 48°58'00" 89°58'00" | Элс хайрганы давхаргын зузаан нь 1.5-3.2м. "400" маркийн бетон үйлдвэрлэхэд тохирно. Тоосгоны шаврын зузаан нь 0.4-3.3м. ГОСТ-9169-75-д тохирно | Хайрга 35.5-76.4%, элс 23.6-65.5% . "100"- "150" маркийн тоосго үйлдвэрлэхэд тохирно.                         | Тоосгоны шавар C <sub>1</sub> +C <sub>2</sub> =218.75мян.м <sup>3</sup> , Хайрганы хольц A+B+C <sub>1</sub> =2658мян.м <sup>3</sup> | Одоо ашиглаж байгаа        |
| Цагаан нуурын орд-1             | Өлгий хотоос БХ 80км-т            | 49°30'00" 89°48'00" |   | "50"- "100" маркийн тоосго үйлдвэрлэхэд тохирно. ГОСТ-9169-75   | C <sub>2</sub> =160.0мян.м <sup>3</sup> балансын бус  |                            |
| Баян-Өлгий шавранцрын орд       | Өлгий хотоос баруун тийш 3-4км    | 48°57'50" 89°58'49" | Шавранцрын үеийн зузаан нь 1.5-3.2м   | Тоосго үйлдвэрлэхэд тохирно.  | C <sub>1</sub> =103950м <sup>3</sup> , C <sub>2</sub> =114830м <sup>3</sup>   |                            |
| Хагийн орд                      | Өлгий хотоос урагш 15км           | 48°50'00" 90°59'20" | 0.05км <sup>2</sup> талбайг эзэлнэ.   | "100" маркийн тоосго үйлдвэрлэхэд тохирно.  | P <sub>1</sub> =25.0мян.м <sup>3</sup> ,  |                            |
| Бугатын тохойн илрэл            | Өлгий хотоос 3У 8км               | 48°55'00" 90°05'20" | 800м урт, 200м өргөнтэй, 0.5-1.5м зузаантай шаврын зузаалаг   | "50"- "100" маркийн тоосго үйлдвэрлэхэд тохирно. ГОСТ-9169-75   | C <sub>1</sub> +C <sub>2</sub> =151.3мян.м <sup>3</sup>   | Цаашид судлах шаардлагатай |
| Толбо нуурын орд                | Өлгий хотоос 3У 55км              | 48°34'24" 90°06'42" | 2000м урт, 800м өргөн, 1-4.5м зузаантай шаврын линз хэлбэрийн зузаалаг  | ГОСТ-9169-75 тохирно.   |   | Цаашид судлах              |
| Хамар толгойн орд               | Хамар толгойноос баруун тийш 500м | 48°33'30" 88°28'20" | 1.0х1.0км талбайд хөхөвтөр саарал өнгөтэй, нягт, зуурамтгай чанартай, ямар нэгэн хэмхдэс агуулдаггүй. 3.1-8.0м зузаантай шаврын үе.             | Тус шаврыг протланд цементийн ба керамзитын үйлдвэрт ашиглаж болно.   | P <sub>1</sub> +P <sub>2</sub> =1198.8мян.тн  | Цаашид судлах шаардлагатай |
| Даянгийн орд                    | Хар модны уулнаас 3Х 2.5км        | 48°17'00" 88°52'30" | 3х0.5км хөхөвтөр саарал өнгөтэй, маш зуурамтгай, нягт 6.5-17м зузаантай шаврын үе.  | Өрмийн бентонит шаварт тохирно.   | P <sub>1</sub> =25.0мян.тн  | Цаашид судлах шаардлагатай |
| Барууны шохойны орд             | Өлгий хотоос 3Х 12км              | 49°04'00" 90°00'00" | 680м урт, 140-160м өргөн, мөн 160м урт, 50м өргөнтэй  | SiO <sub>2</sub> 1.68-6.88%, Al <sub>2</sub> O <sub>3</sub> 4.46%, Fe <sub>2</sub> O <sub>3</sub> 0.38-1.38%, | C <sub>1</sub> =713.0мян.тн, C <sub>2</sub> =185.0мян.тн  | Одоо ашиглаж байгаа.       |

|                     |                           |                     |  |   |                            |                            |
|---------------------|---------------------------|---------------------|--|---|----------------------------|----------------------------|
|                     |                           |                     | шохойн чулууны линз хэлбэрийн хоёр биет тогтоогдсон            | CaO 42.56-52.64%, MgO 0.4%  |                            |                            |
| Өлгийн илрэл        | Өлгий хотоос БУ 40км      | 48°55'10" 89°52'00" | 100-170м өргөн, 1км урттай линз хэлбэрийн шохойн чулууны биет. | ГОСТ-9179-77д тохирно.  | P <sub>2</sub> =13.0сая.тн | Цаашид судлах шаардлагатай |
| Ямаатын орд         | Ямаа нисдэг уулаас БХ 1км | 48°04'20" 89°04'30" | 1-1.5м өргөнтэй боржингийн том том блокууд тогтоогдсон.        | 1м <sup>3</sup> боржингийн блокоос 8-9м <sup>2</sup> өнгөлгөөний жижиг хавтан гаргаж болно. | Хэдэн 10сая.м <sup>3</sup> | Цаашид судлах шаардлагатай |
| Улаан толгойн илрэл | Өлгий хотоос ЗУ 52км      | 48°35'30" 90°14'40" | 3-5м-ээс 10м хүртэл зузаан, 1км хүртэл урттай конгломератын үе |   | P=3сая.м <sup>3</sup>      | Цаашид судлах шаардлагатай |

**Говь-Алтай аймаг дахь барилгын материалын орд /Хүснэгт 2.6/**

| Ордын нэр              | Байршил                       | Солбилцол           | Ашигт малтмалын хэлбэр   | Агуулга  | Нөөц   | Хэтийн төлөв        |
|------------------------|-------------------------------|---------------------|--|--|--|---------------------|
| Эрдсийн будгийн илрэл  | Бугат сумаас БУ 35км          | 45°25'30" 93°55'30" | 15-20м өргөн, 50-60м урттай, хувирлын бүс тогтоогдсон  | Хурц улаан, улаан хүрэн, шар өнгийн зос  |  | Одоо ашиглаж байгаа |
| Чандманы орд           | Чандмань сумаас ЗХ 25км       | 45°32'00" 98°07'00" | Шохойн зузаан нь 1.8-9м  | CaCO <sub>3</sub> 90.5%, MgCO <sub>3</sub> 3%8, Fe <sub>2</sub> O <sub>3</sub> 1.3% ГОСТ 1498-64д тохирно.             | C <sub>1</sub> =512.7мян.тн<br>C <sub>2</sub> =145.6мян.тн   | Ашиглаж байгаа      |
| Цагаан оломын орд Уч-2 | Тайшир сумаас баруун тийш 4км | 46°42'25" 96°34'30" | Бага зэрэг мөлгөржсөн, хар саарал, цайвар-саарал өнгөтэй шохойн чулууны 3 үе тогтоогдсон. Нийт зузаан нь 5-63м.                  | CaO 51.71-54.07%, MgO 0.40-0.75%, н.о 2-5.195  | A=1104.06мян.тн,<br>C <sub>1</sub> =1781.55мян.тн  | Ашиглаж байгаа      |
| Цагаан оломын орд      | Тайшир сумаас зүүн тийш 12км  | 46°43'30" 96°41'00" | 0.5км <sup>2</sup> талбайд шаврын хэвтээш тогтоогдсон. Дундаж зузаан нь 1.25км. "75"- "100" маркийн тоосго үйлдвэрлэхэд тохирно. | SO <sub>3</sub> 48.44-58.79%, шаварлаг хэсэгт 13.5-15.48%, CaO 5.67-12.11%, MgO 2.38-5.81%, R <sub>2</sub> O 3.4-4.37% | B=1744мян.м <sup>3</sup>   | Ашиглагдаж байгаа   |
| Участок №2 орд         | Тайшир сумаас ЗХ 3.5 км       | 46°43'27" 96°34'24" | 35-40га талбайд 1.7-2м зузаантай шаврын үе тогтоогдсон   | "75"- "100" маркийн тоосго үйлдвэрлэхэд тохирно  | A+C <sub>1</sub> =2885мян.м <sup>3</sup>   | Ашиглаж байгаа      |
| Тайширын орд           | Тайшир сумаас хойш 2.5км      | 46°41'15" 96°31'15" | 60-70га талбайд 1.8-2.5м зузаантай шаврын үе тогтоогдсон   | "75"- "100" маркийн тоосго үйлдвэрлэхэд тохирно  | A=297.0мян.м <sup>3</sup> ,<br>B=1062.0мян.м <sup>3</sup> ,<br>C <sub>1</sub> =755.0мян.м <sup>3</sup> | Ашиглаж байгаа      |
| Сухийн хоолойн орд     | Алтай хотоос хойш 2км         | 42°22'15" 96°15'10" | 1200х600м талбайд 6.8-34.3м зузаантай шаврын үе  | "150" маркийн тоосго үйлдвэрлэхэд тохирно.   | A+B+C <sub>1</sub> =4061.3мян.м <sup>3</sup><br>C <sub>2</sub> =250.0мян.м <sup>3</sup>                | Ашиглаж байгаа орд  |

|                     |                             |                        |   |  |   |   |
|---------------------|-----------------------------|------------------------|---|--|---|---|
|                     |                             |                        | ТОГТООГДСОН   |  |   |   |
| Шавартын орд        | Баян-Уул сумаас БХ 3.3км    | 47°02'18"<br>95°21'05" | Неогений жижиг мульт бүтэцтэй холбоотой 120x150м хэмжээтэй, дунджаар 9м зузаан хар саарал өнгийн шавар  | "200"- "250" маркийн тоосго үйлдвэрлэхэд тохирно.  | $C_1=229115\text{м}^3$ ,<br>$C_2=85603\text{м}^3$                                 | Ашиглаж байгаа                                    |
| Завхан голын орд    | Тайшир сумаас БХ 30км       | 46°51'40"<br>96°15'37" | 1.3км <sup>2</sup> давхарга маягын элс хайрганы хэвтэш, дундаж зузаан нь 0.90-2.80м   | Бетон үйлдвэрлэхэд тохирно   | $A=248.06\text{мян.м}^3$<br>$B=659.3\text{мян.м}^3$<br>$C_1=1066.8\text{мян.м}^3$ | Ашиглаж байгаа                                    |
| Тайширийн орд       | Тайшир сумаас БУ 1.2км      | 46°43'40"<br>96°32'00" | 0.6x2.5км <sup>2</sup> давхарга маягын элс хайрганы хэвтэш, дундаж зузаан нь 1.74м  | "100"- "300" маркийн хүнд бетон үйлдвэрлэхэд тохирно   | $A+B+C=1917.5\text{мян.м}^3$<br>Элс нь 885.0мян.м <sup>3</sup>                    | Ашиглаж байгаа                                    |
| Дөрвөлжин-1 орд     | Тайшир сумаас БУ 9км        | 46°38'30"<br>96°29'00" | 45м зузаантай шаварлаг занарын үе тогтоогдсон.  | SiO <sub>2</sub> 60.65%;<br>Al <sub>2</sub> O <sub>3</sub> 17.24%;<br>Fe <sub>2</sub> O <sub>3</sub> 7.19%;<br>Ca <sub>2</sub> O 2.35%;<br>MgO 2.32%;<br>TiO <sub>2</sub> 0.85%;<br>R <sub>2</sub> O 3.81%;<br>nnn 5.08% | $V=200\text{мян.тн}$ ,<br>$C_1=7366.8\text{мян.тн}$                               | Цементийн түүхий эд болгож ашиглахад тохиромжтой. |
| Говь-Алтайн орд     | Тайшир сумаас БУ 1.2км      | 46°24'10"<br>96°11'08" | 0.6x2.5км <sup>2</sup> давхарга маягын элс-хайрганы хэвтэш, дундаж зузаан нь 1.74м  | "100"- "300" маркийн хүнд бетон үйлдвэрлэхэд тохирно.  |   | Ашиглаж байгаа                                    |
Тэжээлийн ургамал, хураасан ургац, га-аар /Диagramм 2.7/



Байгалийн хадлан, мян.тонн /Диagramм 2.8/




### 2.2.2 Мал аж ахуй

Баруун бүс нь тус улсын мал аж ахуйн үндсэн бүсүүдийн нэг болох нь дараах баримтаас тодорхой байна. Энэ бүс улсын нийт малын 30.6 хувь (2007 онд), үүнээс тэмээний 28.0 хувь, адууны 19.7 хувь, үхрийн 21.8 хувь, хонины 29.8 хувь, ямааны 33.7 хувь, нийт хээлтэгч малын 30.2 хувь, нийт бойжсон төлийн 31.4 хувийг тус тус эзэлнэ. Баруун бүсээс 2007 онд Увс аймаг бүх малын тоогоор улсад 5-рт, Завхан аймаг үхрээр 5-рт, хониор 1-рт, Говь-Алтай аймаг ямаагаар 1-рт, Ховд аймаг 3-рт тус тус оржээ. Сумуудаас Увс аймгийн Тэс сум 2007 онд хониор улсад 1-рт, ямаагаар Ховд аймгийн Булган сум улсад 1-рт (168.8мян), Манхан сум 3-рт (133.1 мян) тус тус оржээ. Мал аж ахуй дээр байнга ажилладаг малчийн өрхийн 29.0 хувь, малчдын 29.7 хувийг Баруун бүс эзэлнэ. Малчин өрхийн ахуйн хэрэглээний үндсэн үзүүлэлтүүдээр Баруун бүсийн малчид улсын хэмжээнд Хангай бүсийн дараа орох ба заримаар нь улсад тэргүүлнэ. Дэд бүтэц сайн хөгжсөн Төвийн бүсийн аймаг сумуудаас хавьгүй илүү. Энэ нь Баруун бүс эдийн засаг, нийгмийн хувьд харьцангуй бие даан хөгжиж байгаа, төвөөс зарим нэг хэмжээгээр хараат бус болсныг харуулж байна.



Масштаб М1:5 000 000

Баруун бүс: Бүх малын тоо, төрөл



1 га бэлчээрт ногдох малын тоо  
(хонин толгойд шилжүүлснээр)

- 0,50-аас бага
- 0,51 - 1,00
- 1,01 - 1,50
- 1,51 - аас их


Баганын өндрийн 1мм - 20 мян. хонин толгой малтай тэнцэнэ.

| Малын төрөл   | Малын тоог хонин толгойд шилжүүлэх коэффициент |
|---|--|
| <span style="display: inline-block; width: 15px; height: 15px; background-color: #ff0000; border: 1px solid #ccc; margin-right: 5px;"></span> Тэмээ | Тэмээ - 9                                      |
| <span style="display: inline-block; width: 15px; height: 15px; background-color: #ffff00; border: 1px solid #ccc; margin-right: 5px;"></span> Адуу  | Адуу - 7                                       |
| <span style="display: inline-block; width: 15px; height: 15px; background-color: #ffcc00; border: 1px solid #ccc; margin-right: 5px;"></span> Үхэр  | Үхэр - 5                                       |
| <span style="display: inline-block; width: 15px; height: 15px; background-color: #00bfff; border: 1px solid #ccc; margin-right: 5px;"></span> Хонь  | Хонь - 1                                       |
| <span style="display: inline-block; width: 15px; height: 15px; background-color: #00ff00; border: 1px solid #ccc; margin-right: 5px;"></span> Ямаа  | Ямаа - 2                                       |

Зохиогчид: С.Шийрэв-Адъяа  
Ц.Нандин-Эрдэнэ  
ШУА-ийн Газарзүйн Хүрээлэн  
2008 он

Масштаб М1:5 000 000

Баруун бүс: Тэмээ (нийт тоо)



100 га бэлчээрт ногдох тэмээний тоо

- 0.1 - аас доош
- 0.11 - 0.30
- 0.31 - 0.50
- 0.51 - аас дээш

Тэмээний тоо


- 1 цэг - 200 толгой
- 1 зураас - 100 -аас бага толгой

Зохиогчид: С.Шийрэв-Адъяа  
Ц.Нандин-Эрдэнэ  
Ц.Наранцацрал

ШУА-ийн Газарзүйн Хүрээлэн  
2008 он

Масштаб М1:5 000 000

Баруун бүс: Ямаа (нийт тоо)




Зохиогчид: С.Шийрэв-Адъяа  
 Ц.Нандин-Эрдэнэ  
 Ц.Наранцацрал

ШУА-ийн Газарзүйн Хүрээлэн  
 2008 он

Масштаб М1:5 000 000

Баруун бүс: Үхэр (нийт тоо)




Зохиогчид: С.Шийрэв-Адъяа  
Ц.Нандин-Эрдэнэ  
Ц.Наранцацрал

ШУА-ийн Газарзүйн Хүрээлэн  
2008 он

Масштаб М1:5 000 000

Баруун бүс: Хонь (нийт тоо)




Зохиогчид: С.Шийрэв-Адъяа  
 Ц.Нандин-Эрдэнэ  
 Ц.Наранцацрал

ШУА-ийн Газарзүйн Хүрээлэн  
 2008 он



Масштаб М1:5 000 000

Баруун бүс: Адуу (нийт тоо)



Зохиогчид: С.Шийрэв-Адъяа  
 Ц.Нандин-Эрдэнэ  
 Ц.Наранцацрал

ШУА-ийн Газарзүйн Хүрээлэн  
 2008 он

2.2.2.1 Баян-Өлгий аймаг

Монгол Алтайн өндөр уулын бүсийн үржил шим багатай чулуурхаг хөрс, эрс тэс уур амьсгал бүхий нөхцөлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээр аймгийн хүн амыг мах, сүү, тэдгээрийн бүтээгдэхүүнээр бараг бүрэн, төмс, Хүнсний ногооны хэрэгцээний тодорхой хэсгийг хангаж байна. Эдийн засгийн гол салбар уламжлалт бөгөөд орон нутгийн байгаль, уур амьсгалын нөхцөлд зохицсон мал аж ахуй, 2007 оны байдлаар 1597.4 мянган малтай байна.


Малын тоо /Хүснэгт 2.21/

|                | 1996   | 2007   |
|----------------|--------|--------|
| Нийт мал (мян) | 1405.8 | 1597.4 |
| үүнээс: тэмээ  | 8.4    | 4.3    |
| Адуу           | 84.3   | 65.7   |
| Үхэр           | 128.6  | 94.8   |
| Хонь           | 701.2  | 641.0  |
| Ямаа           | 483.3  | 791.6  |
| Хээлтэгч (мян) | 586.2  | 681.5  |
| үүнээс: ингэ   | 2.1    | 1.1    |
| Гүү            | 21.4   | 18.9   |
| Үнээ           | 44.2   | 38.9   |
| Эм хонь        | 308.8  | 283.5  |
| Эм ямаа        | 209.7  | 339.2  |


Мал аж ахуйгаас жилд хонины ноос 850-900 тн, ямааны ноолуур 130 тн, тэмээний ноос 45 тн, хонины нэхий 210 мянга, ямааны арьс 70 мянга, бодын шир 25 мянга мөн түүнчлэн 95-100 мянган малыг хүнсэнд бэлтгэж, дотоодын хэрэгцээнд нийлүүлэх замаар жилд 6.7 тэр бум төгрөгийн орлого олж байна. Аймгийн экспортыг дан ганц мал аж ахуйн гаралтай түүхий эд бүрдүүлж байна.

Сүүлийн жилүүдэд сүргийн бүтэц муудаж, хээлтэгчийн хувийн жин буурч, ямааны тоо өссөн ба нутгийн мал ашиг шим багатай, мал аж ахуйн салбар байгалиас хэт хараат байна. Сүүлийн 10 гаруй жилд ямаанаас бусад бүх малын тоо, хээлтэгчийн тоо буурчээ.

Сүргийн бүтэц, 1996 он  
/Диаграмм 2.9/





Сүргийн бүтэц, 2007 он  
/Диаграмм 2.10/



Малын бэлчээрийн даац 100 га-д ногдох дундаж хонин толгойгоор 6.5 дахин хэтэрч, эмчилгээ, үржлийн бодлого алдагдан, түүнийг орлох зах зээлийн харилцаанд зохицсон тогтолцоо бүрдэж чадаагүй байна.

Мал аж ахуйд 11102 өрхийн 23682 малчин ажиллаж, эдгээр өрхөд нийт хун амын 51 гаруй хувь буюу 51.3 мянган хүн амьдарч, мал аж ахуйд ажиллаж буй нэг өрхөд 144 толгой мал ногдож байна. Малчид хөдөлмөрөө хорших замаар малчдын бүлэг, хоршоо байгуулах ажил эхлэл төдий, фермерийн аж ахуйн хэлбэрээр эрчимжсэн аж ахуй эрхлэх, зах зээлд ойртох нөхцөл бараг бүрдээгүй байна.

Баян-Өлгий аймгийн малын тооны өөрчлөлт /Диаграмм 2.11/



Аймгийн нийт малын 97 хувь нь хувийн секторт шилжиж, газар тариалан эрхэлж байсан нэгдэл, сангийн аж ахуйнууд бүрэн хувьчлагдан хөдөө аж ахуйд хувийн сектор дангаар үйл ажиллагаа явуулж байна. Сүүлийн гурван жилд мал сүрэг 300 гаруй мянгаар, газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 10.1 хувиар өссөн.

Газар тариалан эрхэлж байсан Баяннуурын сангийн аж ахуй хувьчлагдан олон жижиг аж ахуй үүссэн ч тэдгээр нь үйлдвэрлэл явуулах мөнгө хөрөнгөгүй, орчин үеийн техник технологигүй байгаагийн зэрэгцээ байгаа техникээ худалдан үгүй хийж, усалгааны 10 систем тоногдон ажилгүй болсон байна.

Уламжлалт аргаар малаа өсгөн үржүүлэхэд бэлчээрийн даац хүрэхгүй болсон явдал малын үүлдэр угсааг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлэх, их ургацтай, нутагшсан сорт гаргаж авах, шинэ технологи өргөн нэвтрүүлэхийг зүй ёсоор шаардаж байна.

Энэ аж ахуйн нь Баруун бүсийн 3 аймаг (Баян-Өлгий, Увс, Ховд)-ийн малын тэжээлийн хэрэгцээг хангахад их үүрэг гүйцэтгэж байв. Аймаг үр тариа тариалахгүйгээр гурилын хэрэгцээгээ

хангаж чадахгүйд дүгнэлт хийж, хөрөнгө, технологийн чадвар бүхий үр тарианы аж ахуй эрхлэх, гурилын үйлдвэрийн цогцолбор байгуулах хөгжүүлэх асуудлыг онцгойлон үзэж, дэс дараатай хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд эндээс малын тэжээлийн хангамжид нааштай нөлөө үзүүлэх юм.

Тус аймгийн хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуйн үйлдвэрлэл нь өндөр уулын эрс тэс уур амьсгал, хөрсний үржил шим багатай нөхцөлд явж, эрсдэл өндөр байдаг. Ган, зуд, үер, аадар бороо, гоц халдварт өвчин үе үе тохиолдож ихээхэн гар хохирол учруулсаар байна.

Тухайлбал, хамгийн их зудтай байсан 1966 онд 169 мянга, 1977 онд 84 мянга, 1991 онд 82.2 мянган толгой мал тус тус хорогдож байсан бол 1993, 1994 оны их бороотой жилийн үерт төмс, Хүнсний ногооны бараг бүх ургацаа алдсан байна.

Хөрсний үржил шим муу, тариаланд тохиромжтой талбай зөвхөн голуудын ай савыг дагасан байршилтай байдаг учир ган, их борооны аль аль нь газар тариаланд их хохирол үзүүлдэг онцлогтой. Байгалийн эдгээр үзэгдлийн урьдчилан сэргийлэх мэдээг хүн амд шуурхай хүргэж, шаардалагатай арга хэмжээг зохион байгуулж, гарах хохирлыг багасгах нь чухал юм.

Малын халдварт өвчин үе үе гардаг ба урьдчилан сэргийлэх арга хэмжээний чанар сүүлийн үед муудсан учир үүнд анхаарал тавьж, мал сүргийг халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулах нөхцөл бүрдүүлэх шаардлагатай байна.

Бэлчээрийн усан хангамж зун, намар нь хүрэлцээтэй боловч өвөл, хаврын улиралд дутагдаж, Алтанцөгц, Баяннуур, Бугат сумдын өвөлжөө, хаваржаанд 40 гаруй өрөмдмөл худаг нэмж шаардагдан, өвс, тэжээлийн нөөц, түүнийг бүрдүүлэх хөрөнгийн эх үүсвэргүй байна.

Иргэд мал сүргээ даатгуулаагүй, экспорт, импортын Хүнсний бүтээгдэхүүний чанарт тавих хяналт зохих түвшинд хүрээгүй байна. Мал аж ахуй, газар тариаланд тохиолддог эрсдэлийг бууруулах асуудал төр, засгийн бодлогын хэмжээнд тавигдаагүй, байгалийн гамшгийн аюулын хэмжээ, зэрэглэлийг нарийн судлан тогтоогоогүй байна.

Хөдөө аж ахуйн салбарыг удирдлагаар хангаж байсан нэгдэл, сангийн аж ахуй тарж, малын 99.7 хувь, газар тариалангийн салбарын үйлдвэрийн хэрэгсэл бүрэн хувьчлагдсан боловч мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл дорвитой өсөхгүй, газар тариалан уналтад орсон нь хөдөө аж ахуйд зах зээлийн нөхцөлд зохицсон удирдлага, зохион байгуулалт үгүйлэгдэж байгааг гэрчилж байна.

Зах зээлийн нөхцөлд нийцсэн, мал аж ахуйн түүхий эд бэлтгэлийн тогтолцоо бий болоогүйгээс мал аж ахуйн салбар зах зээлгүй болж, бараа солилцооны эртний арга дэлгэрч, бүтээгдэхүүний үнэ нь төдийлөн өсөхгүй, хөдөө аж ахуйн удирдлага, зохион байгуулалт үгүйлэгдэх боллоо. Аймгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл явуулж байгаа эдүгээ байдал нь хувиа аргацаасан, өрхийн аж ахуйтны хэлбэртэй байна.

Малчид, тариаланчид сайн дураараа хөдөлмөрөө хоршиж үйлдвэрлэлээ өргөтгөх шаардлага амьдралаас харагдаж байгаа боловч тийм хэлбэрт хараахан орж чадаагүй, учраа олохгүй байгаа нь ажиглагдаж байна.

Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын ихэнх хэсгийг бэлчээр эзэлдэг. Зөвхөн 3600 га талбайг газар тариаланд ашиглах боломжтой бөгөөд малын тэжээл тарихад зохицсон 5100-5400 га талбай бий. Тариалангийн талбайн хөрс нь 3 ба 4-р агрогруппэд ордог, ялзмагт давхарга нимгэнтэй, үржил шим багатай чулуурхаг юм.

Нийт 12600 орчим га хадлангийн талбайтай бөгөөд түүний 46 хувь нь Ногооннуур сумын нутаг, Бөхмөрөн голын сав, Ачит нуурын хөвөөгөөр байдаг. Газрыг урт хугацаагаар, үр дүнтэй, оновчтой ашиглахын тулд түүнийг тал бүрээс нь судлах, экологийн төлөв байдлыг үнэлэх, тогтцын онцлогийг илрүүлж, шинжлэх ухааны үндэстэй ашиглах бодлого боловсруулах шаардлагатай боловч үүнд чиглэсэн судалгаа шинжилгээ дорвитой хийгдээгүй байна.

1990-ээд оны эхэн үед малын тэжээл, төмс, Хүнсний ногоо тариалж байсан 5100-5400 га тариалангийн талбай сүүлийн жилүүдэд атаршиж 2007 онд ердөө 18 га-д төмс, Хүнсний ногоо тариалсан байна. Үүнээс үзэхэд тус аймагт газрыг зөвхөн хөдөө аж ахуй, үүний дотор зөвхөн бэлчээрт зориулан ашиглаж ирсэн уламжлалтай бөгөөд сүүлийн үед газрын хэвлийн баялгийг ашиглах явдал өсөж, тусгай хамгаалалттай газрын эзлэх хэмжээ 21 хувьд хүрч нэмэгдэв.

Малын бэлчээрийг зун-намар, өвөл-хавар гэсэн уламжлалт аргаар хуваан ашиглаж, дулааны улиралд бэлчээрийн усан хангамж сайтай, хүйтний улиралд мууддаг онцлогтой. Хот суурингийн эдэлбэр газар хог, хаягдлаар бохирдож, автомашины шороон зам газрын гадаргууг ихээхэн эвдэж байна. Малын тоо бэлчээрийн даацаас хэтэр, бэлчээр усжуулалтын түвшин буурснаас талхлагдал эрчимжиж улмаар цөлжилт явагдаж байна.

Өндөр уулын мөнх цас, мөсөн гол, хад асга зонхилсон Алтайн уулын бүсийн онцлогийг бүрэн судалж хараахан дуусаагүй, газар ашиглалтын шинжлэх ухааны үндэстэй горимыг тогтоогоогүй байна.

### 2.2.2.2 Ховд аймаг

Ховд аймгийн байгалийн өвөрмөц нөхцөлд аж төрдөг олон ястнууд жилийн дөрвөн улиралд хэрэглэдэг хувцас хунар, гэр ахуй, амьдралын бүхий л өргөн хэрэглээний эд зүйлээ малын арьс нэхий, ноос ноолуур зэрэг түүхий эдээр өөрсдөө бэлтгэхийн зэрэгцээ цай, даалимба, торго, дурдан, гурил будаа, чихэр зэрэг зарим шаардлагатай эд зүйлээ мөн л мал, түүний түүхий эдээр худалдан авч төлбөрийн хэрэгсэл болгон амьдарч ирсэн түүхэн уламжлалтай.

Түүнчлэн мал сүргийг унаа, тээврийн хэрэгсэл, зүтгэх хүч болгон ашиглаж, мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаа нь ард түмний ихэнх хэсгийн өдөр дутмын ахуй амьдралын үндсэн хөдөлмөр болж ирсэн байна.

Одоо ч малчдаас гадна үйлдвэрлэгчид, бизнесмэнүүд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид зэрэг аймгийн эдийн засгийн гол цөм болсон олон байгууллага, аж ахуйнуудын нилээд хэсэг нь мал, түүний түүхий эд, бүтээгдэхүүнээр ашиг орлогоо олж байна.


Ийнхүү мал сүрэг нь зөвхөн малчид төдийгүй хот сууринд амьдрагчид, Ховдын олон ястны бүхий л хэрэглээг хангаж ирсэн эдийн засгийн үндсэн салбар юм.

Ховд аймаг нь мал аж ахуйд зориулан байгалийн мужлалаар хонь-ямааны аж ахуй эрхлэхэд тохиромжтой Алтай-Ханхөхийн уулт хээрийн муж, хонь-сарлагийн аж ахуй хоршин эрхлэхэд тохиромжтой Монгол Алтайн дэд муж, тэмээ-ямааны аж ахуй хоршин эрхлэхэд тохиромжтой Их Нууруудын Хотгорын дэд мужуудад хамрагдана. (Г.Нямдаваа. 2003)


2007 оны жилийн эцэст тэмээ 18.1 мянга, адуу 92.2 мянга, үхэр 115.2 мянга, хонь 907.2 мянга, ямаа 1431.6, бүгд 2564.3 мянган малтай байна [Статистикийн эмхэтгэл, 2007]. Мал сүргийн тоо, өсөлт нь байгаль цаг уурын нөхцөлөөс гадна энэ салбарын талаар тухайн үеийн төр засгаас явуулж байгаа бодлого, арга хэмжээний үр дүнгээс хамаарч ирсэн нь ажиглагддаг.

Сүүлийн 10 жилд тус аймгийн малын тоо (1997:2007) 637.8 мянган толгой буюу 33.1 хувиар өссөн байна. Гэвч, энэ өсөлтийн дийлэх хувийг ямаа эзэлж байна. Харин бүх малын тоонд малын төрөл тус бүрийн эзлэх хувийг авч үзвэл ямааны эзлэх хувь өсөж бусад малын эзлэх хувь буурсан байна.

Сүргийн бүтэц, 1996 он  
/Диаграмм 2.12/



Сүргийн бүтэц, 2007 он  
/Диаграмм 2.13/



Ховд аймагт сүүлийн 3 жилийн байдлаар жилд дунджаар хонины ноос 22 тонн, бодын хөөвөр 66 тонн, тэмээний ноос 90.2 тонныг тус тус бэлтгэсэн байна. Улсын хэмжээд авч үзвэл хонины уртын ноосны 3.9%, ямааны ноолуурын 7.2%, бодын хөөврийн 6.8%, тэмээний ноосны 5.4% нь тус аймагт ногдож байна. Баруун бүсийн хэмжээнд хонины ноос бэлтгэлийн 13.5%, ямааны ноолуур бэлтгэлийн 20%, тэмээний ноосны 20%, бодын хөөврийн 25% нь тус аймагт ногдож байна.

Ховд аймаг жилд дунджаар 500-600 тонн хонины мах, 350-420 тонн ямааны мах, 760-930 тонн үхрийн ма, 490-560 тонн адууны мах, нийт 2100-2500 тонн махыг экспортын зориулалтаар бэлтгэж гадаад зах зээлд нийлүүлэх бололцоотой юм.

Нэг суманд дунджаар нийт мал сүргийн 5.9 хувь нь ноогдох боловч Манхан, Чандмань сумдад 10-8.8 буюу дунджаас харьцангуй их, Мянгад, Ховд, Эрдэнэбүрэн, Дарви, Булган, Мөст, Зэрэг, Үенч, Буянт, Алтай сумдад дунджийн ойролцоо буюу 6.6-5.0% нь, Дөргөн, Цэцэг, Мөнххайрхан, Жаргалант, Дуут сумдад дунджаас бага буюу 4.9-3.7 хувь нь ногдож байна.

Малын байршлыг тодорхойлоход дээрх үзүүлэлт хангалтгүй бөгөөд бэлчээр нутгийн хэмжээнд харьцуулсан үзүүлэлт буюу нягтшилаар тодорхойлох шаардлагатай болдог. /Хавсралт зургийг үзнэ үү/

Эрдэнэбүрэн, Дуут, Мөст, Зэрэг, Манхан зэрэг нутаг бэлчээрийн талбай багатай, олон толгой малтай сумуудад бэлчээрийн 100 га талбайд ноогдох малын нягтшил бусдаас их байхад, Алтай, Үенч, Дарви, Дөргөн сумуудад хамгийн сийрэг нягтшилтай байна. Аймгийн хамгийн их нягтшилтай малтай сум болон нэгж га бэлчээрт хамгийн цөөн мал оногдож байгаа сумуудын хооронд бараг 3 дахин их ялгаа гарч байна.

Гэхдээ малын сүргийн ихээхэн сийрэг байршилтай, нутаг бэлчээрийн талбайн хүрэлцээ сайтай гарч байгаа сумуудад бэлчээрийн усан хангамж дутагдалтай улмаас бүрэн ашиглагддаггүй говь, цөлөрхөг нутгийн талбай багагүй хувийг эзэлдэг. Аймгийн нийт малын 2.1 хувийг эзэлдэг Жаргалант суманд одоогоор өөрийн гэсэн тодорхой нутаг бэлчээргүйн улмаас хил залган орших Буянт, Ховд, Эрдэнэбүрэн сумын нутаг дэвсгэрт малаа тавиул байдлаар, эсвэл малчид нь дураар нутаг бууц сонгон нутаглаж бэлчээрийг хуваарьтай ашиглах явдлыг хүндрүүлж байна.

Тэмээ. Аймгийн хэмжээнд 1960 онд 50 шахам мянгаар тоологдож байсан тэмээний тоо толгойн өөрчлөлтийг харахад 1960-1990 онд жилд дунджаар 2.5 хувиар хорогдож байснаа 1990-1995 онд 28.6%-иар, 1995-2000 онд 23.6%-иар, 2000-2003 онд 17.4%-ийр тус тус хорогдсоны жилийн дундаж хорогдлыг хувь 5.4 хувь болж 43 жилийн дунджаасаа 3.95-иар хурдассан байна. Хэрэв цаашид энэ хурдаар тэмээний тоо хорогдсоор байвал 15.6 жилийн дараа нэг ч тэмээгүй болж мэдэх тооцоо гарч байна.

Тэмээний хорогдлын үндсэн шалтгаан нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж буй өрх бүр мал хувийн өмчлөлд шилжсэнээс хойш ачааны болон суудлын автомашинтай болж, тэмээний махны гарц ихтэйгээс Хүнсний зориулалтаар зах зээлийн эрэлт ихтэй байдаг, малчдын орлого багатай үед олон тооны бог мал зарлагдсанаас цөөн тэмээ борлуулж санхүүгийн тулгамдсан хэрэгцээг хангадаг, малын хулгай нэмэгдэж, бод мал адуулж маллахад бэрхшээлтэй болсон зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой юм.

Иймд аймаг, улс орны төдийгүй дэлхийн хэмжээнд ховорд тооцогдох онцлог амьтан болох тэмээний хорогдлыг зогсоож, тоо толгойг өсгөхийн тулд түүний ашиг орлогыг нэмэгдүүлэх, тэмээчдийн хөдөлмөрийн үр дүнг урамшуулах, тэмээн поло спорт, аялал жуулчлал зэрэг шинэ чиглэлийн үйл ажиллагааг хөгжүүлэх зэрэг олон төрлийн арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ховд аймгийн тэмээн сүргийн байршлыг авч үзэхэд Булган, Дөргөн, Манхан, Чандмань, Үенч сумд тэргүүлж байна.

**Адуу.** Адуун сүргийн байршил тус аймагт жигд тархалттай бөгөөд аймгийн нийт малын 4.3 хувь, улсын нийт адууны 3.17%, Баруун бүсийн нийт адууны 20.17%-ийг эзлэх ба адууны тоогоор Булган, Эрдэнэбүрэн, Мянгад, Ховд, Буянт сумд эхний байруудад, харин Дөргөн, Дарви, Дуут, Мөнххайрхан сумд адуу багатайд орно.

Тус аймагт 1995 онд 116.6 мянган адуу тоологдож байсан бол 2000 онд 99.6 мянга, 2005 онд 77.1 мянган адуу тоологдсоноос үзэхэд сүүлийн 10-аад жилд 1.7 дахин буурсан байна /зураг/. Энэ нь зудны хохирлыг амсаж, олон тооны адуу хорогдон, зарим багт малчид уналгын морьгүй болсон, адуу нь хурдан хөлтэй, байнгын бэлчээрийн маллагаагүй улмаас хулгайд өртөх нь илүү, хөдөөд машин, мотоциклыг уналгад их хэрэглэх нь нэмэгдсэн зэрэг шалтгаантай холбоотой. Иймд адуун сүргийн тоо толгойг олшруулахын хамт түүний генофондыг хадгалж, аж ахуйн дотоод тээвэр, уналгад өргөн хэмжээгээр ашиглах шаардлагатай байна.


**Үхэр.** Үхрийн аж ахуй нь тус аймгийн мал аж ахуйн мах, сүүний бүтээгдэхүүний үйлдвэрлэлд чухал суурийг эзэлдэг. Ховд аймагт улсын нийт үхрийн 3.84%, Баруун бүсийн нийт үхрийн 21.2% нь байршиж байна.

Монгол Алтайн өндөр уулсын бүсийн сумуудад сарлаг, монгол үхэр, тэдгээрийн эрлийз байх боловч монгол үхэр гол суурийг эзэлнэ.

Тус аймгийн Булган, Мянгад, Мөст, Буянт, Үенч сумд үхрээр аймагтаа тэргүүлэх бөгөөд Манхан, Эрдэнэбүрэн, Дөргөн, Дарви сумд харьцангуй цөөн үхэртэй.

Сүүлийн жилүүдийн дунджаар 2113.4 тонн үхрийн мах бэлтгэж, 3500.0 мянган литр сүү, 230.1 тонн цөцгийн тос зах зээлд нийлүүлэгдэж байна. Үхэр сүргийн тоо толгойн сүүлийн 70 гаруй жилийн өөрчлөлтөөс харахад 1940 онд 163.0 мянга байснаа 1995 онд 179.7 мянга хүрч өсөж байсан бол 2000 онд 137.3 мянга, 2005 онд 94.6 мянга болтлоо хорогдож, аймгийн нийт малын 4.8 хувийг эзлэх болжээ. Ийнхүү үхрийн тоо 10-аад жилийн дотор 2.4 дахин буурсан гол шалтгаан нь сүүлийн жилүүдийн зуднаар ихэвчлэн бод, түүний дотор үхэр ихээр хорогдсон, Улаанбаатар, Дарханы махны үйлдвэрүүд тус аймгаас их хэмжээний үхрийг бэлтгэж авах болсон, ОХУ-д үхрийн ма экспортлогддог болсон зэрэг шалтгаатай холбоотой.

Ховд аймгийн малын тооны өөрчлөлт /Диagramм 2.14/



**Хонь.** Тус аймгийн нутаг дундаа хонин сүргийн тоо толгойн сүүлийн 70 гаруй жилийн өөрчлөлтөөс харахад хонин сүрэг нь бэлчээрээр өсгөхөд нэн тохиромжтой, байнгын хариулга маллагаанд байдаг мал юм. Хонины аж ахуйгаас сүүлийн 10 жилийн дунджаар ахрын ноос 210 тн, уртын ноос 1050,3 тн, 5471,9 тн мах зах зээлд нийлүүлэгдэж байгаа тоо толгой, эдийн засгийн ач холбогдлоороо ямааны аж ахуйн дараа орох мал аж ахуйн үндсэн салбарын нэг юм.

Хонин сүрэг нь тус аймгийн нийт малын дотор 36,5 хувийг эзлэх бөгөөд түүний толгойн тоогоор тус аймагт Чандмань, Эрдэнэбүрэн, Манхан, Мөст, Булган сумууд тэргүүлэх бөгөөд Мөнххайрхан, Зэрэг, Дуут, Буянт сумууд харьцангуй цөөн хоньтой байна.

Ховд аймагт 1995 онд 930,9 мянга, 2000 онд 782,0 мянга, 2003 онд 562,1 мянган хонь тоологдсон нь 1995 оныхоос 39,6 хувиар буурсан байна. Энэ нь ган, зудад хорогдсон болон хонины

аж ахуйн таваарлаг чанар илүү учир зах зээлд ихээр нийлүүлсэн малчид болон мөнгөний оронд төлбөрийн хэрэгсэл болгон хэрэглэх болсон зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой юм.

Ховд аймагт эрдэм шинжилгээний байгууллагууд мал аж ахуйн ашиг шимийг дээшлүүлэх, тодорхой чиглэлээр олон жил ажилласны үр дүнд Торгууд үүлдрийн хэсгийн хонь, Сутай омгийн хонь гарган сүргийн үүлдэр, угсаа сайжруулах чиглэлээр ашиглаж байна.

Торгууд үүлдрийн хэсгийн хонины ашиг шимийн үндсэн үзүүлэлт /Хүснэгт 2.22/

| Торгууд үүлдрийн хонины тоо |       |        | Нас, хүйс  | Амьдын жин /кг/ |       | Ноосны гарц /кг/ |
|-----------------------------|-------|--------|------------|-----------------|-------|------------------|
| Он                          | Цэвэр | Эрлийз |            | хавар           | намар |                  |
|                             |       |        | Эм хонь    | 42              | 60    | 2                |
| 2000                        | 10260 | 29430  | Охин төлөг | 32              | 48    | 1,5              |
| 2001                        | 7620  | 25458  | Бүдүүн хуц | 55              | 78    | 2,5              |
| 2003                        | 8456  | 26801  | Төлгөн хуц | 35              | 52    | 1,7              |

**Ямаа.** Зах зээлд ноолуурын үнэ нэмэгдсэнтэй холбоотой ямаан сүргийн тоо толгой сүүлийн 10 гаруй жилд хурдацтай өсөж, 2007 оны байдлаар аймгийн нийт малын 55,8 хувийг эзлэх болсноор эдийн засгийн ач холбогдлоороо тэргүүлж байна.

Тус аймгийн нутаг дэвсгэрийн ихэнх нь ямааны аж ахуйн нэн зохистой ба зохистой байршлын бүсэд багтдаг. Ямааны нэн зохистой байршлын бүсэд тус аймгийн нутаг дэвсгэрийн Монгол Алтайн гол нуруу, тэдгээрийн салбар уулсын цөлөрхөг хээр, уулын хээрийн бүс бүхий нутаг, зохистой байршлын бүсэд Их нууруудын хотгор, Алтайн өвөр говийн цөлөрхөг хээр, цөлийн бүсийн нутаг дэвсгэр хамрагдана.

Сумдын малд ямааны эзлэх хувийг авч үзэхэд Дөргөн, Ховд, Булган, Манхан сумуудад 57-59% буюу бусдаас их, Алтай, Үенч, Эрдэнэбүрэн, Мянгад сумуудад 45-50% буюу дундаж хэмжээнд, бусад сумдад 40-50% буюу бага байна.


2.2.2.3 Увс аймаг

Эдийн засагт мал аж ахуй зонхилдог бөгөөд эрчимгүй бэлчээрийн мал аж ахуйтай учраас үр ашиг багатай, байгалиас хараат, эрсдэл ихтэй юм.


Байгаль, цаг уурын тааламжтай нөхцөлтэй үед малын тоо өсөж, тааламжгүй үед эрс хорогддог нь малын төрөл тус бүрийн тооны сүүлийн 70 жилийн өөрчлөлтөөс харагдаж байна. 2007 оны эцэст байгаа 2653.5 мянган малд тэмээ 0.6%, үхэр 4.9%, хонь 48.2%, ямаа 43.1%-ийг эзэлж байна.

Сүүлийн 20 жилээр авч үзвэл ямаа 16, үхэр 15, адуу 11 жилд нь өсөж, хонь 10, тэмээ 12 жилд нь хорогджээ. 1990 онтой харьцуулахад 1996 онд 1-50 хүртэл малтай өрхийн эзлэх хувь 2.7-22.5 пунктаар буурч, 51-200 малтай өрхийн эзлэх хувь 9.2-18.1 пунктаар нэмэгдсэн.

Сүргийн бүтэц, 1996 он /Диаграмм 2.15/




Сүргийн бүтэц, 2007 он /Диаграмм 2.16/





2007 онд аймгийн нийт өрхийн 10.3% нь малгүй, малтай өрхийн 68.2% нь 100 хүртэл толгой малтай, амиа аргацаасан шинжтэй, 20.8% нь 200 хүртэл малтай, хуримтлал бий болгох чадваргүй байна. Тус аймаг зун, намрын улиралд хонин толгойд шилжүүлснээр 4870.2 мянган малын, өвөл, хаврын улиралд 3135 мянган толгой малын бэлчээрийн даацтай юм. 1996 оны эцэст хонин толгойд шилжүүлснээр 3442 мянган малтай байв. 1991-1996 оны дунджаар тухайн төрлийн нийт малд ингэ 27.9%, гүү 24.8%, үнээ 37.5%, эм хонь 48.2%, эм ямаа 44.4%-ийн эзэлж байсан.

Увс аймгийн малын тооны өөрчлөлт  
/Диagramм 2.17/



Сүүлийн 10 жилд улсын хорогдлын эзлэх хувь харьцангуй тогтвортой, хонь, ямааны хээлтэйг эзлэх хувийн жил, улс, орон нутгийн бэлтгэл, аж ахуйн дотоод хэрэгцээ, зах зээлд нийлүүлсэн зэрэг зарлага буурах хандлагатай болов. Нэг малаас ашигласан хонь, тэмээний ноос, ямааны ноолуур харьцангуй тогтвортой, ямааны хялгас, бодын хөөвөр, хялгас 43.5-33.2 хувиар буурчээ. Мал аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэрүүд мана улсын төвийн бүс нутагт байршсан нь аймгийн түүхий эдийн үнэ, өртөг, борлуулалтад муугаар нөлөөлж байна. 1991, 1992 оноос урьд хөдөө аж ахуйн нэгдэл 18, сангийн аж ахуйн, нэгдэл дундын үйлдвэр тус бүр нэг ажиллаж байв. Сүүлийн 16 жилд хөдөө аж ахуйн чиглэлтэй аж ахуйн олон нэгжийг шинээр байгуулж, зарим нь дахин салах, нийлэх, татан буугдах зэргээр өдий хүрлээ. 2007 оны 4 дугаар улирлын байдлаар тус аймагт хөдөө аж ахуйн үйлдвэрлэл голлон эрхлэх чиг үүрэгтэй хувьцаат компани 2, хязгаарлагдмал хариуцлагатай компани 29, нөхөрлөл 6, хоршоо, бүлэг 28 үйл ажиллагаа явуулж байлаа. Бөхмөрөн, Завхан, Зүүнговь, Наранбулаг, Өндөрхангай, Цагаанхайрхан суманд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг, улсын бүртгэлтэй аж ахуйн нэгжгүй. Мал аж ахуйн салбар дахь хувиа аргацаасан, тархай, бутархай хувийн жижиг нэгж нь иргэдийн өсөн нэмэгдэж буй эрэлт, хэрэгцээг хангаж чадахгүй байгаа тул тэдгээрийг хүч хөдөлмөрөө хорших, хамтрах

хэлбэрээр хөгжүүлэх шаардлага амьдарлаас урган гарч байна. Хэдийгээр аж ахуйн нэгжийн тоо ихээхэн өссөн боловч дээрх компани, хоршоо, нөхөрлөлийн дийлэх нь хувиа аргацаасан шинжтэй, үйл ажиллагаа нь хязгаарлагдмал, өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулах хэмжээнд хүрээгүй, аймаг, сумын төсөвт бодитой хувь нэмэр оруулах, хөдөөгийн иргэдэд мэдэгдхүйц тусламж үзүүлэх чадваргүй байна. Ялангуяа малчдад үйлчлэх, зуучлах үүрэг хүлээж зах зээлд өрсөлдөж чадахуйц аж ахуйн нэгж ихээхэн үгүйлэгдэж байна.

#### 2.2.2.4 Завхан аймаг

**Мал аж ахуй:** Аймгийн эдийн засгийн гол салбар нь өнөөгийн байдлаар нүүдлийн мал аж ахуй хэвээр байна. Мал аж ахуйд хонь, ямааны аж ахуй зонхилж, дараа нь үхэр, адууны аж ахуй ордог. Завхан аймаг нийт малын тоогоороо, түүний дотор хонины тоогоор улсын хэмжээнд Өвөрхангай аймгийн дараа хоёрт, бүс дотроо тэргүүлж байна. Харин үхрийн тоогоор улсад дөрөвт ордог. Аймгийн нийт хүн амын 53%-ийнх нь ажил амьдралд мал аж ахуй голлох үүрэгтэй байдаг. Малчдын тоогоор улсын хэмжээнд дөрөвт орж байна. Аймгийн нийт өрхийн дотор малтай өрхийн эзлэх хувийн жин жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд энэ нь мал аж ахуй дээр ажиллах иргэдийн сонирхол ямар нэг хэмжээгээр өсөж байгааг харуулж байгаа юм. Тус аймаг 2007 оны жилийн эцсийн байдлаар 2999.9 мянган толгой малтай байгаагийн дотор 48.8%-ийг хонь, 41.9%-ийг ямаа, 4.9%-ийг үхэр, 4.2%-ийг адуу, 0.2%-ийг тэмээ эзэлж байна.

Улсын хэмжээнд авч үзвэл нийт малын 7.9%, үүний дотор хонины 9.2%, ямааны 6.8%, үхрийн 7.6%, адууны 6.7%, тэмээний 3.1% тус аймагт ноогдож байна. Өрнөд бүсийн хэмжээнд авч үзвэл бүсийн нийт мал сүргийн 24.3%, хонины 29.5%, ямааны 2.5%, үхрийн 34.7%, адууны 32.9%, тэмээний 10.7% тус аймагт байна. Өрнөд бүсэд нийт малаараа, түүний дотор хонь, үхэр, адууныхаа тоогоор эхний байранд ордог.

Аймгийн нийт малын 6.3% Алдархаан, 5.8% Дөрвөлжин, 5.6% Яруу, 5.5% Тосонцэнгэл, 5.4% Их-Уул, Сантмаргац, 4.5% Цэцэн-уул, 4.4% Ургамал, 4.0% Завханмандал 3.8% Нөмрөг, тус бүр 3.7% Цагаанчулуут, Шилүүстэй, 3.5% Улиастай, тус бүр 3.4% Идэр, Баянтэс, 3.2% Баянхайрхан, 3.1% Түдэвтэй, 3.0% Тэс, 2.7% Цагаанхайрхан, 1.1% Асгат суманд тус тус ноогдож байна. Малын тоо харьцангуй ихтэй Алдархаан, Дөрвөлжин, Яруу, Тосонцэнгэл, Тэлмэн, Отгон, Эрдэнэхайрхан зэрэг 7 суманд аймгийн нийт малын 40.0 шахам хувь нь байгаа юм.

Аймгийн 24 сумаас хонины тоогоор Яруу, Тэлмэн, Эрдэнэхайрхан, Алдархаан, Цэцэн-Уул, Сантмаргац сумд тэргүүлж байна. Эдгээр 6 суманд аймгийн нийт хонины гуравны нэг гаруй нь буюу 34.5 хувь ноогдож байгаа юм. Ямаа олонтой Дөрвөлжин, Алдархаан, Ургамал, Завханмандал, Баянтэс, Сантмаргац, Отгон сумдад ямаан сүргийн 46.1% байна. Дээрх сумдад хонь, ямаанд тохиромжтой сайргархаг хар шороон ба нунтаг карбонатлаг хар хүрэн хөрстэй алаг өвс-ботуульт хээрийн бэлчээр, нунтаг карбонатлаг хүрэн, хар хүрэн хөрстэй хазаар өвс-харгана хялганат мөн жижиг бутлаг үетэй хялганат бэлчээр, чулуурхаг хар хүрэн ба уулын хүрэн хөрстэй чулуулаг алаг өвс-ерхөг-хялганат, ерхөгт бэлчээр, цөлөрхөг хээрийн бор хөрстэй бударганат жижиг хялганат, жижиг хялгана-бударганат, харгана, баглуур-жижиг хялганат бэлчээр, хуурай хээрийн ба цөлөрхөг хээрийн харганат, үетэн харганат ба цөлөрхөг хээрийн харганат карбонатлаг цайвар хүрэн ба цөлөрхөг хээрийн бор хөрстэй шарилж жижиг хялганат бэлчээр тус тус зонхилно.



Үхэр сүргийн тоогоор Их-Уул (19%), Тосонцэнгэл (11%), Отгон (6.5%), Идэр (6.2%), Яруу (6.1%), Тэлмэн (6.0%) сумд эхний байранд ордог ба нийт үхрийн 47.5% нь дээрх 6 суманд байна. Эдгээр сумын уулын нугын хөрстэй бушилз ботуульт бэлчээр, боролжит болон бусад сөөг, сөөгөнцөрт тундр бүхий уулын нугын ялзмагт хөрстэй бэлчээр нь үхэр, түүний дотор сарлагт тохиромжтой юм. Аймагтаа хамгийн олон адуутай сумдын тоонд Тосонцэнгэл (8.0%), Их-Уул (7.3%), Нөмрөг (6.2%), Отгон (5.9%), Алдархаан (5.79%), Яруу (5.7%) сумд орох ба эдгээр сумдад нийт адууны 38.8% нь байна. Дээрх сумдын Нутаг дахь нунтаг карбонатлаг хар хүрэн ба хар шороон хөрстэй алаг өвс-цагаан сүүлт хээрийн бэлчээр, сайргархаг хар шороон ба нунтаг карбонатлаг хар хүрэн хөрстэй алаг өвс-ботуульт хээрийн бэлчээр, нунтаг карбонатлаг хүрэн хөрстэй хазаар-өвс хялганат бэлчээр нь адуун сүрэгт нэн тохиромжтой байдаг. Аймаг дотроо Дөрвөлжин (16.3%), Ургамал (9.7%), Отгон (8.2%), Шилүүстэй (7.6%), Цагаанчулуут (7.0%), Тэлмэн (6.7%), Эрдэнэхайрхан (6.6%) сумд тэмээгээр тэргүүлэх ба эдгээр сумдын нутагт нийт тэмээний 62.1% нь байна. Эдгээр сумдын нутаг дахь цөлөрхөг хээрийн бор хөрстэй баглуур-жижиг хялганат бэлчээр, цөлийн бор саарал хөрстэй баглуурт бэлчээр, хуурай хээрийн ба цөлөрхөг хээрийн харганат, үетэн харганат, шарилжит бэлчээр зонхилсон нутгууд тэмээ өсгөхөд тохиромжтой юм.

Завхан аймгийн сумдын малын ноос ноолуур,  
хөөвөр бэлтгэл ,хувиар, 1998 он /Хүснэгт 2.23/

| Д/д | Сумдын нэр    | Хонины ноос | Ямааны ноолуур | Ямааны хялгас | Бодын хөөвөр | Бодын хялгас | Тэмээний ноос |
|-----|---------------|-------------|----------------|---------------|--------------|--------------|---------------|
| 1   | Алдархаан     | 5,1         | 7,6            | 6,4           | 7            | 3,4          | 4,8           |
| 2   | Асгат         | 1           | 1,1            |               | 0,7          | 0,5          | 0,2           |
| 3   | Баянтэс       | 3,1         | 5,8            |               | 1,4          | 1,7          | 3,3           |
| 4   | Баянхайрхан   | 4           | 2,6            |               | 3,5          | 3,2          | 1,3           |
| 5   | Тосонцэнгэл   | 4,2         | 3,5            | 6,3           | 8,1          | 13,5         | 0,8           |
| 6   | Дөрвөлжин     | 4,9         | 12,9           | 2,8           | 1,7          | 2,5          | 19,1          |
| 7   | Завханмандал  | 4,8         | 6,9            | 10,5          | 1,6          | 1,7          | 12,7          |
| 8   | Идэр          | 3           | 1,3            | 3,5           | 4,4          | 0,3          | 0,4           |
| 9   | Их-Уул        | 3,7         | 2,9            | 4,9           | 1,1          | 4,4          | 1,5           |
| 10  | Нөмрөг        | 4           | 1,4            | 3,6           | 4,1          | 6,7          | 0,2           |
| 11  | Отгон         | 4,5         | 5              | 8,4           | 7,4          | 9,8          | 7,1           |
| 12  | Сантмаргац    | 4,6         | 3,7            | 2,1           | 0,2          | 0,5          | 5             |
| 13  | Сонгино       | 5,3         | 3,1            | 6,3           | 5,8          | 4,4          | 0,6           |
| 14  | Түдэвтэй      | 3,3         | 1,3            | 3,6           | 4,4          | 6,4          | 0,6           |
| 15  | Тэс           | 2,7         | 3,4            | 0,7           | 0,7          | 0,5          | 1,3           |
| 16  | Тэлмэн        | 4,6         | 1,8            | 0,2           | 0,9          | 2,2          | 3,1           |
| 17  | Ургамал       | 3,8         | 7              | 7             | 2,3          | 3,4          | 7,7           |
| 18  | Улиастай      | 4,9         | 5,2            | 6,3           | 4,6          | 4,7          | 0,2           |
| 19  | Цагаанхайрхан | 2,5         | 2,6            | 7,8           | 0,2          | 0,3          | 2,1           |
| 20  | Цагаанчулуут  | 4,2         | 4,7            | 4,7           | 4,2          | 4,5          | 6,7           |
| 21  | Цэцэн-Уул     | 5,6         | 4              | 4,9           | 3            | 3,9          | 4,6           |
| 22  | Шилүүстэй     | 3,8         | 3,7            |               | 2,8          | 5,4          | 4,6           |
| 23  | Эрдэнэхайрхан | 5,9         | 5,1            | 13,2          | 7,6          | 3,4          | 6,4           |
| 24  | Яруу          | 6           | 3              | 6,1           | 11,7         | 13,5         | 3,5           |
|     | Дүн           | 100         | 100            | 100           | 100          | 100          | 1000          |

Сүүлийн арваад жилд аймгийн нийт малын тоо 30 гаруй хувиар өсөж бэлчээрийн даац зарим талаар алдагдах болсон байна. Иймд Завхан аймагт Өрнөд бүсийн бусад аймгуудын нэгэн адил сүргийн бүтэц, чанарыг сайжруулахад анхаарах учиртай. Энэ үүднээс нутгийн монгол малын доторх шилдэг омгийн малыг малын ашиг шимийг сайжруулах зорилгоор үржил-селекцийн ажилд өргөн ашиглах шаардлагатай юм /Төмөржав.М., (1989)/. Тус аймагт нутгийн монгол хонины ашиг шимийг дээшлүүлэхэд Эрдэнэхайрхан, Завханмандал, Дөрвөлжин, Ургамал сумдад нилээд тооны байдаг сартуул омгийн хонийг ашиглах боломжтой. Түүнчлэн нутгийн монгол үхрийн ашиг шимийг сайжруулах зорилгоор “саран” болон “наран” хайнаг гаргаж авдаг туршлагыг ч анхаарах шаардлагатай юм.

Завхан аймгийн малын тооны өөрчлөлт /Диаграмм 2.18/



Сүүлийн 30 жилийн байдлаар Завхан аймагт ойролцоогоор жилд хонины ноос 1600 гаруй тн, ямааны ноолуур 190 гаруй тн, ямааны хялгас 60 гаруй тн, бодын хөөвөр 90 гаруй тн, бодын хялгас 70 гаруй тн, тэмээний ноос 50 гаруй тн-ыг тус тус бэлтгэсэн байна. Үүнийг Өрнөд бүсийн аймгуудтай харьцуулбал хонины ноосны 30 орчим хувь, ямааны ноолуурын 20 орчим хувь, ямааны хялгасны 25 хувь, бодын хөөврийн 3.5 хувь, тэмээний ноосны 10 гаруй хувийг тус аймаг бэлтгэжээ. Улсын хэмжээнд авч үзвэл хонины ноосны 9.0%, ямааны ноолуурын 6.9%, бодын хөөврийн 10.0%, бодын хялгасны 11.8%, тэмээний ноосны 2.9%-ийг тус аймаг бэлтгэсэн байна. Ер нь Завхан аймаг 1900 орчим тн хонины уртын ноос, 190 гаруй тн ямааны ноолуур, 60 гаруй тн тэмээний ноос, 120 орчим тн бодын хөөвөр бэлтгэн зах зээлд нийлүүлэх боломжтой.

Сумдаас 1998 оны байдлаар хонины ноос бэлтгэлээр Яруу, Эрдэнэхайрхан, Сонгино, Алдархаан, Цэцэн-Уул зэрэг сумд (28%), ямааны ноолуур бэлтгэлээр Дөрвөлжин, Алдархаан, Завханмандал, Баянтэс, Ургамал зэрэг сумд (40.2%), тэмээний ноос бэлтгэлээр Дөрвөлжин, Завханмандал, Ургамал сумд (39.5%) тус тус тэргүүлж байна. Ноос ноолуур бэлтгэлд тухайн төрлийн малын тоо толгой голлох үүрэгтэйгээс гадна малчдын хичээл зүтгэл, идэвх санаачилга, зах зээлийн эрэлт, хэрэгцээ чухал нөлөө үзүүлж байна.

Завхан аймагт өнөөгийн байдлаар Жилд дунджаар 52 мян.ширхэг бодын шир, 400 гаруй мян.ширхэг богийн арьс бэлтгэж байна. Арьс шир бэлтгэлээр олон малтай сумд, ялангуяа үхэр, хонь олонтой Их-Уул, Тосонцэнгэл, Яруу, Тэлмэн, Алдархаан зэрэг сумд тэргүүлж байгаа юм. Тус аймаг дотоодын хэрэгцээг оруулахгүйгээр жилд дунджаар хонины мах 900-1100 тн, үхрийн мах 1400-1800 тн, ямааны мах 350-450 тн, адууны мах 950-1100 тн, нийт 3650-4400 тн махыг экспортын зориулалтаар бэлтгэж гадаад зах зээлд нийлүүлэх боломжтой.


### 2.2.2.5 Говь-Алтай

Хөдөө аж ахуйн салбарт мал аж ахуй, газар тариалан голлодог билээ. 2008 онд 2486.6 мянган малтай. Нийт мал сүрэгт тэмээ 1.8 хувь, адуу 5.2 хувь, үхэр 4.6 хувь, хонь 43.6 хувь, ямаа 44.8 хувийг тус тус эзэлж байна. Мал сүрэгт өсвөр мал 32.5, хээлтэгч 41.2 хувийг тус тус эзэлж байгаа ба сүргийн дотор хээлтэгчийн зохистой харьцаа сүүлийн жилүүдэд алдагдаж байна.


2008 оны байдлаар аймгийн нийт өрхийн 50 гаруй хувийг малчин өрх эзэлж байна. Малчдын тоо 2007 оны байдлаар 1996 оноос 1.3 дахин, өмнөх онтой харьцуулахад 1.2% өсжээ.

Улсын хэмжээнд авч үзвэл тус аймагт нийт малын 6.4%, үүний дотор ямааны 9.3%, хонины 5.8 %, адууны 3.5%, үхрийн 2.3%, тэмээний 9.9% тус тус ногдож байна. Баруун бүсийн хэмжээнд авч үзвэл бүсийн нийт малын 21.6%, үүнээс ямааны 28.1%, хонины 18.6%, адууны 17.1%, үхрийн 10.5%, тэмээний 34% тус аймагт байдаг.

Сүргийн бүтэц, 1996 он  
/Диаграмм 2.19/



Сүргийн бүтэц, 2007 он  
/Диаграмм 2.20/



Аймгийн малын тоо сүүлийн 20 жилийн байдлаар 1989-1995 онд өсөж, 1996 онд 0.7% буурч, 1997 онд 1.2%, 1998 онд 0.03% өссөн байна. 2000-2001 онд буурч сүүлийн 6 жил дараалах өсжээ. Нийт малын тоог 1989 оныхтой харьцуулбал даруй 40 орчим хувиар өсжээ. Аймгийн нийт малын 8.4% нь Цогт, 7.4% нь Тонхил, 6.8% нь Баян-Уул, 6.7% нь Есөнбулаг, 6.5% нь Дэлгэр, 6.3% нь Халиун, 6.3% нь Цээл, 5.5% нь Эрдэнэ, 5.2% нь Жаргалан, 5.1% нь Бугат, 4.9% нь Бигэр, 4.8% нь Дарви, 4.7% нь Төгрөг, 4.7% нь Шарга, 4.5% нь Хөхморьт, 4.4% нь Чандмань, 4.2% нь Алтай, 3.4% нь Тайшир суманд тус тус ногдож байна. Харьцангуй олон малтай суманд Цогт, Тонхил, Баян-Уул, Есөнбулаг, Дэлгэр, Халиун, Цээл сумд ордог бөгөөд эдгээр 7 сумдад аймгийн нийт малын 50 орчим хувь нь ногдож байна. Хонины тоогоор Тонхил, Баян-Уул, Цогт, Халиун, Есөнбулаг, Дэлгэр, Цээл сумд тэргүүлж байна. Эдгээр 7 суманд аймгийн нийт хонины тал хувь нь ногдож байна.

Ямааны тоогоор Цогт, Цээл, Дэлгэр, Эрдэнэ, Есөнбулаг, Баян-Уул сумд тэргүүлдэг бөгөөд энэ 6 суманд нийт ямааны 42% бий. Дээрх сумдын нутагт бог малд тохиромжтой хүрэн ба хар хүрэн, бор хөрстэй уулын ба хээрийн алаг өвс-улалж, бударгана, ерхөг-хялганат бүхий уулын ба говь хээрийн бэлчээр зонхилж буй нь үүнд нөлөөлжээ. Үхрийн тоогоор аймагтаа Есөнбулаг, Жаргалан, Халиун, Цогт, Тонхил, Хөхморьт, Бигэр сумд тэргүүлдэг бөгөөд энэ 7 суманд нийт үхрийн 50% нь байна. Эдгээр сумдын нутаг нунтаг карбонатлаг, сайргархаг, хүрэн хөрстэй алаг өвс-хялганатай уулын хяр бэл, хажуу болон ухаа толгодын хоорондох зөөлөн хөрстэй хиаг, ерхөг, согоовор зэрэг өвс ургамалтай бэлчээртэй байдаг нь үхэр сүргийн байршилтанд голлон нөлөөлжээ.

Адууны тоогоор Баян-Уул, Тонхил, Хөхморьт, Есөнбулаг, Дэлгэр, Жаргалан, Халиун сумд тэргүүлдэг бөгөөд энд бог мал төдийгүй адуунд тохиромжтой бэлчээр зонхилдог нь адуун сүргийн байршилтад нөлөөлжээ. Тэмээний тоогоор Алтай, Бигэр, Төгрөг, Халиун, Цогт, Шарга, Цээл сумд тэргүүлдэг ба энэ 7 суманд нийт тэмээний 60 орчим хувь нь бий. Эдгээр сумдын нутгийн ихэнх хэсгийг баглуур бударганат бэлчээр бүхий говь нутаг эзэлдэг нь тэмээн сүргийн байршилтанд голлон нөлөөлсөн байна.

Сүүлийн арваад жилд 2000-2007 онд нийт малын тоо 30 орчим хувиар, ялангуяа ямаа нилээд өссөнөөс үүдэн бэлчээр дутагдаж бэлчээрийн даац алдагдах явдал гарах болжээ. Иймд цаашид малын тоо толгойг тогтвортой байлгаж, сүргийн бүтэц, чанарыг сайжруулах явдалд ихээхэн анхаарах шаардлагатай. Энэ зорилгоор нутгийн монгол малын доторх шилдэг омгийн малыг малын ашиг шимийг сайжруулах, үржил-селекцийн ажилд өргөн ашиглах шаардлагатай [Төмөржав.М 1989] байгаа юм. Тухайлбал, тус аймгийн Бугат, цээл, Тонхил сумдад голлон үржүүлдэг Говь-Алтай хонийг нутгийн монгол хонины ашиг шимийг сайжруулахад, Халиун сумын

Говь Гурван сайхан ямааг нутгийн монгол ямааны зарим ашиг шимийг нэмэгдүүлэхэд ашиглаж болно.

Говь-Алтай аймаг сүүлийн 3 жилийн байдлаар ойролцоогоор жилд хонины уртын ноос 1500 гаруй тонн, ямааны ноолуур 340 тонн, тэмээний ноос 200 гаруй тонн, бодын хөөвөр 40 орчим тонныг тус тус бэлтгэсэн байна. Үүнийг улсын хэмжээнд авч үзвэл хонины уртын ноосны 6 орчим хувь, ямааны ноолуурын 10 гаруй хувь, тэмээний ноосны 8 гаруй хувь тус аймагт ногдож байна. Ер нь Говь-алтай аймаг 1700 орчим хонины ноос, 400 гаруй тонн ямааны ноолуур, 330 орчим тонн ямааны хялгас, 210 гаруй тонн тэмээний ноос, 50 шахам тонн бодын хөөвөр бэлтгэх боломжтой. Хонины ноос бэлтгэлээр Тонхил, Цогт, Баян-Уул сумд тэргүүлж энэ 3 сум нийт ноосны 1/4-ийг бэлтгэж байна. Ямааны ноолуур бэлтгэлээр Цогт, Цээл, Дэлгэр сумд тэргүүлдэг. Энэ 3 сум нь ямааны ноолуурын 26%-ийг бэлтгэжээ.



Аймгийн нийт тэмээний ноосны 35 орчим хувийг Алтай, Бигэр, Цогт, Шарга 4 суманд бэлтгэж байгаа бөгөөд эдгээр 4 сум тэмээний тоогоор аймагтаа тэргүүлдэг юм.

Тус аймагт сүүлийн 3 жилийн байдлаар жилд ойролцоогоор 170 мянга шахам хонины арьс, 10 мянга орчим үхрийн шир, 5 мянга шахам адууны шир, 2 мянга илүү тэмээний шир, 110 мянга орчим ямааны арьс бэлтгэж байна. Арьс шир бэлтгэлээр сумдыг авч үзвэл хонины арьс бэлтгэлээр Халиун, Эрдэнэ, Цогт сумд тэргүүлж байна.

Говь-Алтай аймгийн сумдын ноос, ноолуур, хөөвөр бэлтгэл хувиар, 1998 он /Хүснэгт 2.24/

| д/д | Сумдын нэр | Хонины ноос | Ямааны ноолуур | Ямааны хялгас | Бодын хөөвөр | Бодын хялгас | Тэмээний ноос |
|-----|------------|-------------|----------------|---------------|--------------|--------------|---------------|
| 1   | Алтай      | 2.8         | 4.8            | 5.2           | 2.5          | 0.8          | 8.6           |
| 2   | Баян-Уул   | 7.0         | 6.6            | 6.8           | 11.2         | 4.1          | 5.1           |
| 3   | Бигэр      | 4.0         | 5.1            | 5.7           | 3.2          | 4.7          | 9.4           |
| 4   | Бугат      | 5.2         | 4.8            | 5.4           | 6.4          | 4.4          | 6.1           |
| 5   | Дарви      | 5.4         | 5.5            | 6.0           | 3.2          | 3.8          | 4.3           |
| 6   | Дэлгэр     | 6.6         | 7.4            | 8.0           | 6.4          | 4.9          | 4.1           |
| 7   | Жаргалан   | 5.0         | 4.8            | 5.1           | 4.1          | 5.8          | 2.1           |
| 8   | Тайшир     | 4.8         | 2.5            | 2.5           | 4.1          | 6.3          | 2.0           |
| 9   | Тонхил     | 10.8        | 5.5            | 5.3           | 7.0          | 10.2         | 4.5           |
| 10  | Төгрөг     | 5.2         | 5.9            | 5.8           | 4.0          | 5.2          | 7.6           |
| 11  | Халиун     | 6.0         | 5.5            | 5.6           | 8.2          | 6.6          | 6.6           |
| 12  | Хөх морьт  | 4.8         | 3.3            | 3.5           | 2.3          | 1.1          | 5.6           |
| 13  | Цогт       | 7.2         | 11.0           | 11.3          | 17.6         | 14.9         | 8.6           |
| 14  | Цээл       | 6.0         | 7.4            | 7.3           | 3.2          | 4.1          | 7.1           |
| 15  | Чандмань   | 4           | 4.4            | 4.5           | 7.2          | 10.4         | 1.9           |
| 16  | Шарга      | 4.0         | 5.1            | 5.6           | 8.1          | 9.9          | 8.4           |
| 17  | Эрдэнэ     | 4.0         | 7.0            | 6.5           | 2.0          | 3.3          | 5.5           |
| 18  | Есөнбулаг  | 4.4         | 4.4            | 5.0           | 0.2          |              | 1.6           |
|     | ДҮН        | 100.0       | 100.0          | 100.0         | 100.0        | 100.0        | 100.0         |

Говь-Алтай аймгийн малын тооны өөрчлөлт /Диagramм 2.21/



Тус аймаг дотоодын хэрэгцээг оруулахгүйгээр жилд дунджаар хонины мах 570-680 тн, үхрийн мах 450-540 тн, ямааны мах 470-560 тн, адууны мах 500-560 тн, нийт 1980-2350 тн махыг экспортын зориулалтаар бэлтгэж, гадаад зах зээлд нийлүүлэх боломжтой.

Аймгийн нутаг дэвсгэрийн 65.9 хувь буюу 9495.1 мянган га газар хөдөө аж ахуйн эдэлбэр газар юм. Энэ эдэлбэр газрын 43.3 хувийг уулын хээр, 2 хувийг өндөр уулын бүс, 50.2 хувийг говь, цөлийн бүс, 4.5 хувийг бэлчээр, 0.02 хувийг хадлан, 0.06 хувийг тариалан, жимс, жимсгэнийн талбай, 0.02 хувийг атаржсан газар эзэлж байна.

Аймгийн нутагт өндөр уул, уулын хээр, уулын цөлийн хээр, цөлийн хээр, цөлийн бэлчээр голлодог. Бэлчээрийн эдэлбэр газрын 5 хувь буюу 459.7 мянган га талбай талхлагдаж, 1 хувь буюу 9.2 мянган га талбайд үлийн цагаан оготно тархаж, 300 гаруй га талбай ахуйн хог, хаягдалд дарагдаж, бэлчээрийн зориулалтаар ашиглах боломжгүй болсон байна.

Тариалангийн талбайн 10 гаруй хувь нь атаршиж, 3 хувь нь хөрсний эвдрэлд орсон юм.

Аймгийн нутаг дэвсгэрт газрыг зүй зохистой ашиглах эрх зүйн үндэс бүрдээгүй, сүүлийн жилүүдэд газар зохион байгуулалтын ажил хийгээгүй, газрыг шавхагдашгүй нөөц, баялагтай мэтээр ойлгох явдал нийтлэг болсноос бэлчээрийн талхлагдал, хөрсний эвдрэл нэмэгдэх хандлагатай болов. Газрын хэвлийн нөхөн сэргэлтийн ажил ашиглалтаас хоцорч, уурхайн эдэлбэр болон хайгуулын талбайд сэргээлт хийх, суманд хүлээлгэн өгөх ажил хангалтгүй байна.

Байгальтай уялдан зохицсон, газрыг дэмжих, тэтгэхэд чиглэсэн экологийн хувьд тогтвортой, эдийн засгийн хувьд үр ашигтай газар ашиглалтын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх шаардлагатай боллоо.

## **Гурав. ДЭД БҮТЭЦ, ХОТ СУУРИН**

### **3.1 ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ**

#### **3.1.1 Цахилгаан эрчим хүч**

Монгол улс шинэ зуунд хөгжил дэвшлээ хурдасгаж, ард түмнээ орчин цагийн соёлт улс орны түвшинд аж төрөх бололцоо нөхцлөөр хангах чиглэлээр 1999 онд Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2001 онд Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай болсон.

Монгол улсын бүсчилсэн хөгжлийн хөгжлийн үзэл баримтлалын зорилго нь шинэ зуунд тус улсын газар, түүний нөөц баялагийг оновчтой ашиглах үндсэн дээр хот хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах, аймаг бүс нутгийн хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг арилгах, үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэхнутаг дэвсгэрийн бүтэц, зохион байгуулалтын дотоод, гадаад таатай орчин бүрдүүлэхэд оршино.

Монгол улсын засгийн газрын 1995 оны 90 тоот тогтоолоор Увс, Ховд, Баян-Өлгий, аймгийн ОХУ-ын эрчим хүчний системтэй өндөр хүчдэлийн шугамаар холбох хэрэглэгчдийг цахилгаанаар хангах үйл ажиллагаа эрхлэх “Баруун бүсийн эрчим хүчний систем” /ББЭХС/-ийг 1995 оны тавдугаар сарын нэгнээс Улаангом сум /хот/-д баруун аймгуудын эрчим хүчний системийн ашиглалтын өмнөх захиргааг Увс аймгийн Эрчим хүчний нэгдсэн үйлдвэртэй нэгтгэн байуулж ажилуулсан юм. Тус системд мөн оны 12-дугаар сарын 18-нд Улаангом хотыг, 1997 оны нэгдүгээр сарын 19-нд Баян-Өлгийн Өлгий хотыг, 1997 арванхоёрдугаар сарын 10-нд Ховдын Жаргалант хотыг өндөр хүчдэлийн шугамд холбож, импортын цахилгаан эрчим хүчээр хангаж эхэлсэн бөгөөд Увсын Тариалан / 1995-12-22/, Өмнөговь/1995-12-30/, Түргэн /1997-12-10/, Өлгий /1997-12-04/, Баян-Өлгий аймгийн Бугат / 1997-1-19/, Ховд аймгийн Ховд /1997-10-10/, Мянгад /1997-10-10/ сумдыг, 1998 онд Ховдын Буянт /11-17/, Баян-Өлгийн Сагсай /12-30/, сумдыг, 2000 онд Увсын Сагил/6-04/, Баян-Өлгийн Улаанхус /4-24/, Цэнгэл /9-14/, Ховдын Эрдэнэбүрэн /7-р сард/, сумдыг манай системийн цахилгаан шугам сүлжээнд холбоод байна. Аймаг сумдын дэд станцын хүчин чадал, цахилгаан дамжуулах шугамын хүчдэл, уртыг дараахь хүснэгтүүдээс үзнэ үү.

Баруун бүсийн 110кВ-ын ЦДАШ, дэд станц /Хүснэгт 3.1/

| №   | Шугамын эхлэл | Шугамын төгсгөл | Шугамын урт, км | Шугамын төгсгөл дэх дэд станцын хүчдлийн түвшин | Трансформаторын тоо, хүчин чадал |
|---|---------------|-----------------|-----------------|---|----------------------------------|
| 1   | ОХУ-Чадан     | Хандгайт        | 85              |   |                                  |
| 2   | Хандгайт      | Улаангом        | 10.1            | 110/35/10кВ                                     | 2*10000 кВА                      |
| 3   | Улаангом      | Өмнөговь        | 2*117.5         | 110/35/10кВ                                     | 6300 кВА                         |
| 4   | Улаангом      | Малчин          | 101             | 110/35/10кВ                                     | 6300кВА                          |
| 5   | Өмнөговь      | Баян-Өлгий      | 148             | 110/35/10кВ                                     | 2*16000 кВА                      |
| 6   | Өмнөговь      | Мянгад          | 99              | 110/35/6кВ                                      | 2*10000 кВА                      |
| 7   | Баян-Өлгий    | Алтанцөгц       | 6.4             | 110/10кВ  | 1000кВА                          |
| 8   | Мянгад        | Манхан          | 93.3            | 110/35/10кВ                                     | 6300 кВА                         |
| 9   | Мянгад        | Дэргэн УЦС      | 72              | 110/6кВ   | 10000 кВА,<br>5000 кВА           |
| 10  | Тайшир        | Улиастай        | 135             | 110/35/10кВ                                     | 2*6300 кВА                       |
| 11  | Улиастай      | Тэлмэн          | 124             | 110/35/10кВ                                     | 2*6300 кВА                       |
| 12  | Хөшөөт        | Сутай           | 110             | 110/35/10кВ                                     | 6300 кВА                         |
| Нийт шугамын урт, дэд станцын хүчин чадал |               |                 | 1309.7          | 110/35/10кВ                                     | 132.1 МВА                        |

Баруун бүсийн 35кВ-ын ЦДАШ, дэд станц /Хүснэгт 3.2/

| №          | Шугамын эхлэл | Шугамын төгсгөл | Шугамын урт, км | Шугамын төгсгөл дэх дэд станцын хүчдлийн түвшин | Тр-рын тоо, хүчин чадал | Тайлбар |
|------------|---------------|-----------------|-----------------|---|-------------------------|---------|
| Увс аймаг  |               |                 |                 |   |                         |         |
| 1          | Малчин        | Хяргас          | 51              | 35/0.4кВ  | 630кВА                  |         |
| 2          | Хяргас        | Баруунтуруун    | 47.5            | 35/15кВ, 15/0.4кВ                               | 1000кВА<br>2*160кВА     |         |
| 3          | Улаангом      | Сагил           | 40.2            | 35/0.4 км                                       | 400кВА                  |         |
| Ховд аймаг |               |                 |                 |   |                         |         |
| 4          | Манхан        | Зэрэг           | 65.6            | 35/10кВ, 10/0.4кВ                               | 630кВА<br>100, 160кВА   |         |
| 5          | Зэрэг         | Дарив           | 61.4            | 35/10кВ, 10/0.4кВ                               | 630кВА<br>100, 160кВА   |         |
| 6          | Такашкент     | Булган          |                 | 35/0.4кВ  | 400кВА                  |         |



Тус хотод мах бэлтгэх, боловсруулах чиглэлээр хэд хэдэн компани ажиллаж байгаа ба аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 30 орчим хувийг Оросын холбооны улс руу гаргаж буй махны экспорт эзэлдэг. Мөн өлөн гэдэсний хэд хэдэн цех ажилладаг.

Өлгий хотод баруун бүсийн аймгуудаас түүхий эдээ авч, бүтээгдэхүүнээ ЗХУ /хуучин нэрээр/ -д гаргадаг жилд 2000 тн ноос угаах үйлдвэр, хивсний үйлдвэр, 6 мян.квт хүчин чадалтай дулааны цахилгаан станц болон төмөр бетон, хавтан хийц, бетон зуурмагийн үйлдвэр, 5 сая ширхэг тоосго үйлдвэрлэх хүчин чадалтай тоосгоны үйлдвэр зэрэг үйлдвэр аж ахуйн газрууд ажиллаж байсан бөгөөд одоо шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээл, техник технологийн хоцрогдлоос болж үйлдвэрийн газрууд нь хүчин чадлынхаа 20 гаруй хувийг ашиглаж байна.

2001 оны байдлаар хотын хэмжээнд 2445.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.

Алслагдсан байршил, үйлдвэр, дэд бүтэц хөгжөөгүйтэй холбоотой бараа таваарын үнэ УБ хот болон төвийн бүсээс 0.5-1.0 дахин өндөр, мал аж ахуйн түүхий эдийн үнэ харьцангуй хямд байгаа нь амьжиргааны өртгийг тэр хэмжээгээр өндөрсгөж байна.Цахилгаан эрчим хүч, шатахууны бүх хэрэгцээг импортоор, нүүрсний бүх хэрэгцээг 140 км зайд Увс аймгийн нутагт орших Нүүрстхотгорын нүүрсний уурхайгаас хангадаг.Тус аймгийн нутагт Өлгий хотоос 100 орчим км зайд орших Улаанбайшинтын боомт хот, аймгийн төдийгүй бүсийн хүн амын амьжиргаа, худалдаа үйлдвэр, үйлчилгээнд багагүй нөлөө үзүүлж байна. Тус хотод Хүнс, барааны зах ажиллаж өргөн хэрэглээний бараа, бензин шатахууны ихэнх хувийг ОХУ –аас хангаж байна.

Аймгийн хэмжээнд Кешелик, Улан, Жол, Кектас, Агайн, Керкем, Мурал, Тулек, Зейн, Нур-Едил зэрэг 10 орчим байгууллага, аж ахуйн нэгжүүд барилга угсралтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшин үйл ажиллагаа явуулж 571.3 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оныхоос 5 дахин, урьдах 5 жилийн дундажаас 3 дахин их байна. Жилд 500 мян.ш тоосго үйлдвэрлэх хүчин чадалтай тоосгоны үйлдвэр ажиллаж байна.

2000 онд Өлгий хотод 253.1 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэний 30 гаруй хувийг аймаг, орон нутгийн хөрөнгөөр, 10 орчим хувийг хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн байна.

**Баруун бүс нутгийн тулгуур төв хот, орон нутгийн хөгжлийн хотуудад нийгэм эдийн засгийн чухал үүрэг гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалт хийн хотын хөгжлийг шийдвэрлэж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн жагсаалт /Хүснэгт 3.21/**

|    |                               |   |
|----|-------------------------------|---|
| 1  | “Аватекс Кайнар” ХХК          | Ноос, ноолуур угааж экспортлох            |
| 2  | “Намуу тариа” гурилын үйлдвэр | Иоджуулсан улаан буудайн гурил үйлдвэрлэх |
| 3  | “Мөнгөн-Алтай” ХХК            | Мах боловсруулах                          |
| 4  | “Нүүрст хотгор” ХХК           | Нүүрс олборлох                            |
| 5  | Радио нэвтрүүлгийн станц      | Казак хэлний нэвтрүүлгийг алсад дамжуулах |
| 6  | “Уян санаа” ХХК               | Хүнс, адууны утсан мах                    |
| 7  | “Алтай –керей графт” ХХК      | Оёдол, нэхмэл                             |
| 8  | “Кумыс” ХХК                   | Сүү, сүүн бүтээгдэхүүн                    |
| 9  | “Уян санаа” ХХК               | Махан бүтээгдэхүүн                        |
| 10 | “Уян санаа” ХХК               | Гурилан бүтээгдэхүүн                      |
| 11 | “Намуу тариа” ХХК             | Гурилан бүтээгдэхүүн                      |
| 12 | Насосны үйлдвэр               | Эсгий эдлэл                               |
| 13 | Нурдхаан /иргэн/              | Шир савхин эдлэл                          |
| 14 | Телейбуй /Иргэн/              | Модон эдлэл                               |
| 15 | Бадыл /иргэн/                 | Модон эдлэл                               |
| 16 | “Ган барс” ХХК                | Төмөр эдлэл                               |

Эдгээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хотын хөгжилд их хувь нэмэр оруулж нэг суурин нэг бүтээгдэхүүн баруун бүсийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр гарган ажиллаж байгаа юм.

Төрийн болон боловсрол, эрүүл мэндийн байгууллагууд /Хүснэгт 3.22/

|   |   |   |
|---|---|---|
| 1 | Багшийн коллеж                          | Бага ангийн багш бэлтгэх                            |
| 2 | Монгол –Туркийн хамтарсан дунд сургууль | Англи хэлний мэдлэгтэй ерөнхий боловсрол эзэмшүүлэх |

Төсөл хэрэгжүүлэгч нэгж болон төрийн бус байгууллагууд /Хүснэгт 3.23/

|   |                                       |                            |
|---|---------------------------------------|----------------------------|
| 1 | Баруун бүсийн аялал жуулчлалын холбоо | Аялал жуулчлалыг хөгжүүлэх |
| 2 | Урианхайн сурын харвааны холбоо       | Сурын харвааг хөгжүүлэх    |

**3.2.1.2 Хилийн боомтууд**

**“Өлгий” олон улсын агаарын замын боомт**

“Өлгий” олон улсын агаарын тээврийн боомт нь БНКаЗУ-ын Зам тээврийн яам, Монгол Улсын МИАТ компаний хооронд 1992 оны 12 дугаар сарын 12-нд Өлгий хотод байгуулсан хэлэлцээрийн үндсэн дээр байгуулагдсан.

Энэхүү хэлэлцээр Казакстаны онгоцыг Алма-Ата-Устькаменогорск-Бийск-Кош Агач- Өлгий гэсэн маршрут бүхий олон улсын агаарын замаар нисгэж, улсын хилийг хойд өргөрөгийн 49°36', зүүн уртрагийн 89°26' солбилцлоор нэвтэрч байхаар тохиролцсон.

Тус боомт нь аймгийн нисэх буудлыг түшиглэн абйгуулагдсан бөгөөд Өлгий хотоос 12 километрт оршдог. БНКаЗУ-ын талын боомт нь Устькаменогорск хотын нисэх буудалд байрладаг.

Өлгий хотын нисэх буудлын барилга 2004 онд ашиглалтанд орсон, гаалийн үзлэг, шалгалтын зааланд зорчигчидын ачаа тээшинд үзлэг шалгалт хийх зориулалттай рентген аппарат суурилуулж, хилийн шалгалт явуулах тусгайлан төхөөрөмжилсөн кабинтай.

**Цагааннуур-Ташанта авто замын боомт**

Цагааннуур авто замын боомт нь Монгол Улсын Баян-Өлгий аймгийн Цагаан нуур сум, ОХУ-ын Алтайн БНУ-ын Кош-Агач район хиллэдэг хэсэгт, хилийн 55 дугаар тэмдэгтийн чиглэлд хилээс 5 километр, Баян-Өлгий аймгийн төвөөс 100 километрт оршино.

Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын “Хилийн боомт болон Монгол, Орос хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай хэлэлцээр”-ийн дагуу хоёр талын зорчигч, ачаа тээврийн харилцааны зориулалтаар байнга ажилладаг.

ОХУ-ын талын боомт нь Ташанта, хилийн 55 дугаар тэмдгийн эсрэг хилээс 22 километрт, Кош-Агач районы нутагт байдаг.

Цагааннуур боомтод хил хяналтын байгууллагууд үйл ажиллагаа явуулах шалган нэвтрүүлэх цогцолбор 2005 оны 8 дугаар сард ашиглалтанд орсон.

Тус боомт Азийн авто замын сүлжээний тухай хэлэлцээрт заасан хурдны зам /АН4/, Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын Засгийн газар хооронд байгуулах “ Дамжин өнгөрөх тээврийн хэлэлцээр”-т Монголоор дамжин өнгөрөх чиглэлд тус тус хамрагдаж байгаа, мөн “Цагаан-нуур” худпалдааны чөлөөт бүс байгуулах болсон зэргээс шалтгаалан зорчигч, тээврийн хэрэгслийн урсгал хөдөлгөөн улам бүр нэмэгдэх төлөвтэй байна.

Цаашид дээрхи нөхцөл байдлыг харгалзан боомтын шалган нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, хилийн боомтын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, байр орон сууцаар хангах шаардлагатай.

**Даян-Хуншаньзюй авто замын боомт**

Даян авто замын боомт нь Монгол Улсын Баян-Өлгий аймгийн Сагсай сум, БНХАУ-ын ШУӨЗО-ны Алтайн районы Фунхай сум хиллэдэг хэсэгт, хилийн 17 дугаар тэмдэгийн чиглэлд хилээс 1.8 километрт оршдог.

“Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” –ийн дагуу хоёр талын зорчигч, ачаа тээвэрлэх зориулалтаар 6 сарын 21-нээс 7 дугаар сарын 5, 8 дугаар сарын 1-20, 9 дүгээр сарын 1-15-ны өдрүүдэд ажилладаг.

БНХАУ-ын талын боомт нь Хуншаньзюй, Монгол, Хятадын хилийн 17 дугаар тэмдэгийн эсрэг хилээс 1 километрт ШУӨЗО-ны Алтайн районы Фунхай сумын нутагт байдаг.

Даян боомтод шаардлагатай дэд бүтэц бүрдээгүй, хилийн шалган нэвтрүүлэх албаны үйл ажиллагаа явуулах ажлын байр, ажилчидын орон сууц байхгүй.

Цаашид боомтод хил хяналтын байгуулгуудын үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлж, ажлын байр, ажилчидын орон сууц барих асуудлыг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай.

**Хилийн боомтууд /Хүснэгт 3.24/**

|   |             |  |
|---|-------------|--|
| 1 | Цагаан нуур | -ОХУ-д гарцтай<br>-Байнгын ажиллагаатай<br>-Хилийн худалдаа<br>-Зорчигч тээвэр |
| 2 | Даян        | -БНХАУ –д гарцтай<br>-Улирлын чанартай<br>-Хилийн худалдаа<br>-Зорчигч тээвэр  |

**3.2.1.3 Хүн ам, хөдөлмөрийн нөөц**

2007 оны жилийн эцсийн байдлаар аймгийн нийт хүн амын тоо 94.3 мянга болж урьд оныхоос 0.9 хувиар буурсан байна. 1000 хүнд ноогдох төрөлт 26.2, нас баралт 5.2, цэвэр өсөлт 21.0 болсон нь төрөлт өмнөх оныхоос 3.4, нас баралт 3.2 пунктээр тус тус өсч, цэвэр өсөлт 0.8 пунктээр нэмэгдэж, урьд оныхоос 4.0 хувиар өссөн байна. Хүн амын 39.3 хувийг 16 хүртэлх насны хүүхдүүд, 5.1 хувийг 60-аас дээш насны ахмад хүмүүс эзэлж байна. Аймгийн хүн амын 55.6 хувь нь 16-59 насны хүмүүс байгаа нь хөдөлмөрийн хангалттай нөөц байгааг харуулж байна.

Хөдөлмөрийн насны хүн амын 62.6 хувь нь албан ба албан бус хөдөлмөр эрхлэж, 14.8 хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй, 3.5 хувь нь бүртгэлтэй ажилгүйчүүд, 12.3 хувь нь суралцагсад, 7.2 хувь нь хөдөлмөрийн чадваргүй хүмүүс байна. Аймгийн нийт ажиллагсадын 69.3 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 15.4 хувь буюу 4040 төрийн албан хаагч буюу төсвийн байгууллагын ажиллагсад, үүний 2.7 хувь нь улс төрийн албанд, 8.3 хувь төрийн захиргааны албанд, 4.3 хувь төрийн тусгай албанд, 84.7 хувь нь төрийн үйлчилгээний албанд ажиллагсад эзэлж байна. Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс болон сумдын засаг даргын тамгын газарт бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1841 байгаа нь урьд оныхоос 17.0 хувиар буурсан байна. 2007 оныг их бүтээн байгуулалт, шинэ ажлын байр бий болгох жил болгон зарласантай холбогдуулан 1797 ажлын байр бий болсны 56.0 хувь нь байнга, 16.1 хувь нь түр, 17.9 хувь нь улирлын чанартай ажлын байр байна.

**Хүн амын тоо, сумаар /Хүснэгт 3.25/**

| №  | Сумын нэр  | 2000  | 2003  | 2004  | 2005  | 2006  | 2007  | 2007%/2006 |
|----|------------|-------|-------|-------|-------|-------|-------|------------|
| 1  | Алтай      | 4016  | 3965  | 4010  | 3914  | 3943  | 3612  | 91.6       |
| 2  | Алтанцөгц  | 3168  | 3430  | 3460  | 3038  | 3028  | 3091  | 102.1      |
| 3  | Баяннуур   | 5140  | 5314  | 5411  | 5320  | 5364  | 5424  | 101.1      |
| 4  | Бугат      | 3541  | 3688  | 3652  | 3604  | 3464  | 3537  | 102.1      |
| 5  | Булган     | 5916  | 6034  | 5980  | 5901  | 5827  | 5732  | 98.4       |
| 6  | Буянт      | 3060  | 3239  | 3127  | 3002  | 2858  | 2872  | 100.5      |
| 7  | Дэлүүн     | 8347  | 8311  | 8303  | 8183  | 8104  | 8032  | 99.1       |
| 8  | Ногооннуур | 7094  | 7176  | 7077  | 6539  | 6548  | 6706  | 102.4      |
| 9  | Сагсай     | 4876  | 5065  | 5247  | 5185  | 5096  | 5113  | 100.3      |
| 10 | Толбо      | 4773  | 4724  | 4645  | 4260  | 4104  | 4209  | 102.6      |
| 11 | Улаанхус   | 8437  | 9008  | 9075  | 8672  | 8703  | 8625  | 99.1       |
| 12 | Цэнгэл     | 8110  | 8322  | 8298  | 8364  | 8216  | 8079  | 98.3       |
| 13 | Өлгий      | 25763 | 28552 | 29201 | 28248 | 28512 | 27929 | 98.0       |
| 14 | Цагааннуур | 1853  | 1621  | 1626  | 1528  | 1459  | 1437  | 98.5       |

|     |       |       |       |       |       |       |      |
|-----|-------|-------|-------|-------|-------|-------|------|
| Дүн | 94094 | 98449 | 99112 | 95758 | 95226 | 94398 | 99.1 |
|-----|-------|-------|-------|-------|-------|-------|------|


Хүн амын тоо, насны бүлгээр /Хүснэгт 3.26/

| Насны бүлэг | 2000  | 2003  | 2004  | 2005  | 2006  | 2007  | Насны бүтэц, хувиар |      |      |      |       |
|-------------|-------|-------|-------|-------|-------|-------|---------------------|------|------|------|-------|
|             |       |       |       |       |       |       | 2003                | 2004 | 2005 | 2006 | 2007  |
| 0-15        | 41877 | 41935 | 41305 | 38330 | 37641 | 37065 | 42.6                | 41.7 | 40.0 | 39.5 | 39.26 |
| 16-19       | 8078  | 9023  | 8914  | 8795  | 9178  | 9115  | 9.2                 | 9.0  | 9.2  | 9.6  | 9.7   |
| 20-24       | 8956  | 8895  | 9117  | 8856  | 9165  | 9037  | 9.0                 | 9.2  | 9.2  | 9.6  | 9.6   |
| 25-29       | 7553  | 7983  | 7869  | 7923  | 7746  | 7795  | 8.1                 | 7.9  | 8.3  | 8.1  | 8.3   |
| 30-34       | 6303  | 7056  | 7195  | 7357  | 7114  | 7070  | 7.2                 | 7.3  | 7.7  | 7.5  | 7.5   |
| 35-39       | 5491  | 6056  | 6166  | 6112  | 6184  | 6004  | 6.2                 | 6.2  | 6.4  | 6.5  | 6.4   |
| 40-44       | 4163  | 4933  | 5155  | 5110  | 5094  | 5039  | 5.0                 | 5.2  | 5.3  | 5.3  | 5.3   |
| 45-49       | 2739  | 3574  | 3818  | 4038  | 3924  | 4010  | 3.6                 | 3.9  | 4.2  | 4.1  | 4.2   |
| 50-54       | 2161  | 2259  | 2587  | 2474  | 2554  | 2716  | 2.3                 | 2.6  | 2.6  | 2.7  | 2.9   |
| 55-59       | 2171  | 1791  | 1915  | 1852  | 1800  | 1772  | 1.8                 | 1.9  | 1.9  | 1.9  | 1.9   |
| 60+         | 4602  | 4991  | 5071  | 4911  | 4826  | 4775  | 5.1                 | 5.1  | 5.1  | 5.1  | 5.1   |

Хүн амын шилжих хөдөлгөөн /Хүснэгт 3.27/

|                      | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 | 2007 |
|----------------------|------|------|------|------|------|------|
| Шилжин ирэгсэд бүгд  | 91   | 25   | 28   | 5    | 31   | 29   |
| Үүнээс: Казакстанаас | 59   | -    | -    | -    | -    | -    |
| Шилжин явагсад       | 364  | 408  | 1655 | 3068 | 2073 | 1385 |
| Үүнээс: Казакстанд   | 86   | 135  | 1294 | 2448 | 1758 | 1026 |

Хүн амын цэвэр өсөлт /Диаграмм 3.8/



Ажиллагсад эдийн засгийн салбарын ангиллаар /Хүснэгт 3.28/

| № | Эдийн засгийн салбарууд      | 2000  | 2002  | 2003  | 2004  | 2005  | 2006  | 2007  | 2007%/2006 |
|---|------------------------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|------------|
| 1 | ХАА, ан агнуур, ойн аж ахуй  | 21863 | 24646 | 24815 | 24139 | 22825 | 23178 | 22679 | 97.8       |
| 2 | Загас агнуур                 | 34    | 21    | 21    | 14    | 10    | 10    | 11    | 110.0      |
| 3 | Уул уурхай                   | 195   | 115   | 133   | 144   | 148   | 212   | 248   | 117.0      |
| 4 | Боловсруулах үйлдвэр         | 227   | 429   | 454   | 480   | 516   | 548   | 537   | 98.0       |
| 5 | Цахилгаан, дулааны эрчим хүч | 264   | 264   | 274   | 287   | 270   | 271   | 285   | 105.2      |



|    |  |      |      |      |      |      |      |      |       |
|----|--|------|------|------|------|------|------|------|-------|
| 6  | Барилга  | 310  | 380  | 393  | 414  | 389  | 404  | 412  | 102.0 |
| 7  | Бөөний ба жижиглэн худалдаа                                      | 1252 | 1575 | 1766 | 1903 | 2170 | 2191 | 2067 | 94.3  |
| 8  | Зочид буудал, зоогийн газар                                      | 49   | 114  | 125  | 143  | 149  | 205  | 178  | 86.8  |
| 9  | Тээвэр агуулах, холбоо   | 628  | 423  | 462  | 505  | 600  | 489  | 493  | 100.8 |
| 10 | Санхүүгийн байгууллага   | 105  | 141  | 158  | 166  | 184  | 202  | 216  | 106.9 |
| 11 | Үл хөдлөх хөрөнгө бизнес, түрээс                                 | 105  | 104  | 103  | 103  | 109  | 110  | 123  | 111.8 |
| 12 | Төрийн захиргаа, батлан хамгаалах                                | 972  | 1077 | 1081 | 1058 | 1090 | 1126 | 1342 | 119.2 |
| 13 | Боловсрол  | 1572 | 2064 | 1979 | 2125 | 2262 | 2337 | 2689 | 115.1 |
| 14 | Эрүүл мэнд   | 936  | 865  | 848  | 902  | 905  | 928  | 1024 | 110.3 |
| 15 | НАА, нийгэм, хүн амын үйлчилгээ                                  | 294  | 207  | 266  | 310  | 328  | 328  | 350  | 106.7 |
| 16 | Олон улсын байгууллагын, болон хөлсний ажилчинтай өрхийн аж ахуй |      |      |      |      |      | 17   | 58   | 341.2 |

### 3.2.4 Орон нутгийн хөгжлийн хот Алтай



Содой 3.15 Аёдаё бидүй аяаадүй содай


#### 3.2.2.1 Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарьлалт зохион байгуулалт

1923 онд томоохон аймгуудыг задлан шинээр 13 аймаг байгуулахад Хантайшир уулын аймгаас өмнөд хэсгээр нь Алтай аймгийг байгуулан нэг хэсэгтээ Цагаан оломд төвлөрүүлэв. Гэвч цөөн сумтай, харилцаа холбоо муу, боловсон хүчин дутагдалтай, төв нь нутгийнхаа захад бараг Завхан аймгийн нутагт байрласан зэрэг шалтгаан аймгийн хөгжилд сөргөөр нөлөөлж байсан учир 1934 онд Завхан аймагтай нийлүүлжээ.

Завхан аймаг өргөн уудам нутгийг хамарсан 37 сумтай болсон нь үйл ажиллагаа явуулахад ихээхэн хүндрэл учруулах болсон тул БНМАУ-ын ҮИИ их хурлын шийдвэрийн дагуу 1940 онд Бага Хурлын Тэргүүлэгчдийн 48 дугаар хурлаас Говь-Алтай аймгийг байгуулах шийдвэр гаргаснаар 1940 оны 11 дүгээр сард дахин байгуулагдав. Аймаг байгуулахдаа Завхан аймгаас: Баянцагаан, Баян-Өндөр, Баян, Бигэр, Дарви, Дэлгэрнаран, Тайшир, Томч, Тонхил, Төгрөг, Хасагт Жаргалант, Цогт, Чандмань, Эрдэнэ, Архангай аймгаас: Баацагаан гол, Буянцагаан гол, Хүрээмарал зэрэг нийт 20 сумын 130 баг, 11863 өрх, 43374 хүн ам, 1.7 сая малыг таслан олгожээ.

1941 онд Баянхонгор аймгийг Архангай аймгаас тасалж байгуулахад Баян-Өндөр, Баянцагаан гол, Буянцагаан гол, Хүрээмарал зэрэг сумдыг буцаан шилжүүлсэн байна. Харин Завхан аймгаас хожим 1942 онд Баян-Уул, 1954 онд Хөхморьт, Жаргалан сумдыг Говь-Алтайд шилжүүлжээ.

Аймгийн төв эхэндээ Олоннуур хэмээх газар төвлөрөөд одоогийн Есөнбулагт шилжин байрлажээ. БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1961 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 136-р зарлигийн дагуу 1961 оноос Есөнбулагийг хот гэж нэрлэж байсан боловч, 1994 онд УИХ-ын 66 дугаар тогтоолоор Есөнбулаг сум болгож, төвийг Алтай гэж нэрлэх болов.



Зураг 3.16

1931 онд тус аймгийн 13 сум Хантайшир уулын аймгаас үүссэн байна. Бүхайрхан уулын хошуунаас Цогт, Тонхил, Бугат, Төгрөг сум бүтнээр үүсч, Дарви, Цээл, Алтай сумдын зарим хэсэг оров. Хантайшир уулын хошуунаас Тайшир, Дэлгэр, Халиун сумд бүтнээрээ үүсч, Гуулингийн хагас нутаг оров. Жавхлантай уулын хошууны суурин дээр Эрдэнэ, Чандмань сум, Мөнх-Өлзий дэлгэр уулын хошуу, Бат хайрхан уулын хошууд нэгдэж үүссэн Гурвансайхан, Жаргалант сумын, хошууны суурин дээр Хөхморьт, Баян-Уул, Жаргалан, Шарга сумд байгуулагдав. Сутай хайрхан уулын хошууны хагасаар Дарви сум “Бигэрийн номын хутагтын шавь” нутгаар одоогийн Бигэр сум байгуулагдав.

Эдгээр сумдаас Алтай сумыг 1943 онд Цээл сумаас тасалж, Бугат сумын 1959 онд Биж-Алтай сумын хагасаар, Халиун сумыг 1959 онд Баян, Наран сумыг нэгтгэх замаар, Шарга сумыг 1959 онд Хасагт Жаргалант сумаар тус тус байгуулсан болно.

Орон нутгийн хөгжлийн тулгуур төвөөр Алтай хот төлөвлөгдөж байгаа бөгөөд орон нутгийн хөгжлийн тулгуур төвд орон

нутгийн хот, бүлэг суурингийн төвүүдийг хамруулж байна. Бүлэг суурингийн

- Алтай хотын
- Жаргалангийн
- Шаргын
- Төгрөгийн
- Алтайн
- Бигэрийн

нийт 6 тогтолцоог үүсгэн цаашид хэтийн хөгжлийн стратегийг тодорхойлон хөгжих юм.

### 3.2.2.2 Үйлдвэрийн аж ахуй

Аймгийн эдийн засагт аж үйлдвэр, барилгын салбарын гүйцэтгэх үүрэг жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа ч энэхүү хэрэгцээг өнөөгийн салбар төдийлөн хангаж чадахгүй байна. Одоогийн байдлаар тус аймагт хөнгөн, хүнсний чиглэлийн салбар голчлон ажиллаж байна. 2002 оны байдлаар 2407.2 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, 2027.68 мянган төгрөгийн бүтээгдэхүүн борлуулжээ. Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн борлуулалтын 80.0 хувь нь уул уурхайн; 12.8 хувь нь хүнсний; 7.2 хувь өргөн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт ногдож байна.

Одоогийн байдлаар тус аймаг жилд 1200 тн ноос угаах үйлдвэр; хоногт 20 тн талх, нарийн боов, жилд 300.0 мян.л сүү боловсруулах хшчин чадалтай хүнсний үйлдвэр; 100.0 мян.тн нүүрс

олборлох Зээгийн нүүрсний уурхай; хоногт 2.8 мян.дм торгон савхи боловсруулах үйлдвэр; хоногт 250 м<sup>2</sup> эсгий үйлдвэрлэх хүчин чадалтай эсгийний цех ажиллаж байна. Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй “Алт” хөтөлбөрийн хүрээнд 1990 оноос эхлэн 2 компани байгуулагдан ажиллаж байна.

Алтай хотод ажиллаж байгаа үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн нь орон нутгийн хэрэгцээг хангахад чиглэгдэж байна. Аймгийн гол үйлдвэр болох Эрчим хүчний үйлдвэр нь жилд 217.6 сая кВт.цаг цахилгаан энерги үйлдвэрлэж байна. Мөн хүнсний “Тулга-Алтай” компани жилд дунджаар 22.4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Говь-Алтай аймаг байгалийн асар их нөөц баялагтай бөгөөд түүний дотор барилгын материалын нилээд олон орд илрэлүүд тогтоогдоод байна. Тус аймагт одоогийн байдлаар асбестийн 215.0 мян.тн нөөц бүхий Алаг уул, Тайширын орд; 50.0 сая тн хүдрийн нөөц бүхий Бидэрийн голын магнезитын орд; 2543.9 мян.м<sup>3</sup> нөөц бүхий Цагаан олон, Чандманий шохойн орд; 30.9 мян.тн нөөц бүхий Алтан худагийн альмандины орд; 200.4 мян.тн эрдэс будгийн нөөц бүхий Буубарнагийн орд зэрэг барилгын материалын ордууд байгаагийн зэрэгцээ хайрга шаврын түүхий эд элбэгтэй юм.

Тус аймагт барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр байгуулагдсан 16.0 сая тоосго боловсруулах Ханын материалын үйлдвэр; жилдээ 310.0 мян.м<sup>3</sup> бетон эдлэл хийх хүчин чадалтай Барилгын материалын үйлдвэр (үндсэндээ ашиглалтанд орсноос хойш ажиллаагүй) ашиглалтгүй байна.

Аж үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн хүчин чадал доройтож, техник технологи хоцрогдсон; бүтээгдэхүүн нь стандартад тохироогүй; эрэлт хэрэгцээг хангахгүй байгаа зэрэг нь тухайн салбарын хэтийн хөгжлийг тодорхойлохын өмнө шийдвэрлэх чухал асуудал болно.

Ашигт малтмалын нөөц баялгийг ашиглахын зэрэгцээ аялал жуулчлалын болон байгалийн нөөц, мал сүргээр баялаг аймаг, орон нутгийн газар нутагт орон нутгийнх нь хүн амын хүнс ба ахуйн хэрэглээ, хэрэгцээнд нь түшиглэсэн жижиг, дунд үйлдвэрийг төслийн төлөвлөлтийн үе шатуудад орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль газарзүйн онцлог, хүн ардын зан заншил, нутагшилт, хот байгуулалтын бодлоготой уялдуулан, орчин үеийн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх замаар тухайн нутаг дэвсгэрийн:

- ✓ мал аж ахуй хөгжсөн сумдад малын ашиг шимийг ашиглах, арьс ширэнд анхан шатны боловсруулалт хийх, сүү цагаан идээ боловсруулах, ноос угаах бага оврын үйлдвэр;
- ✓ газар тариалан эрхэлдэг сумдад үр тарианы болон тэжээлийн агуулах, бага оврын гурилын тээрэм;
- ✓ тухайн нутаг орны хүн амын заншлыг дагаж, бор гурил, арвайн гурил (болсон гурил)-ын жижиг үйлдвэр;
- ✓ ан амьтнаар баялаг сум сууринд үслэг эдлэлийн, тарвага, зээр, гөрөөсний гаралтай бүтээгдэхүүн хийх жижиг дунд үйлдвэр;
- ✓ рашаан усаар баялаг газар оронд рашаан савлах жижиг дунд үйлдвэр;
- ✓ эмийн ургамлаар баян тухайн бүс нутгийн хувьд эмийн ургамлын жижиг үйлдвэрийг байршуулах зэргээр түүхий эдийг түшиглэн аж үйлдвэрийг байгуулан хөгжүүлэх нь тээврийн зардал хэмнэгдэж, эдийн засгийн хувьд хямд төсөр, орон нутгийн хэрэглэгчдэд ч ойр дөт байна.

Үйлдвэрлэлийн цаашдын хөгжлийн стратеги нь байгаль орчинд үзүүлэх хор хөнөөл багатай, эдийн засгийн хүчирхэг, оновчтой технологи, орчин үеийн тоног төхөөрөмж бүхий, хүн амын өдөр тутмын хэрэгцээг аль болох ойр зайнаас хангахад чиглэгдсэн бүтцийг бий болгоход оршино.

Баруун бүс нутгийн тулгуур төв хот, орон нутгийн хөгжлийн хотуудад нийгэм эдийн засгийн чухал үүрэг гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалт хийн хотын хөгжлийг шийдвэрлэж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн жагсаалт /Хүснэгт 3.29/

|   |                          |  |
|---|--------------------------|--|
| 1 | “Ентүм” ХХК              | Хүнсний бүтээгдэхүүн, ноос угаах, эсгий үйлдвэрлэх         |
| 2 | “Тулга Алтай” ХХК        | Хүнсний бүтээгдэхүүн барилгын материал, шатахуун нийлүүлэх |
| 3 | Радио өргөн нэвтрүүлгийн | Монголын үндэсний радиогийн нэвтрүүлгийг алсад             |

|    | станц                       | дамжуулах              |
|----|-----------------------------|------------------------|
| 4  | “Халтар арвай” ХХК          | Хүнс                   |
| 5  | “Бураат булаг” ХХК          | Сүү, сүүн бүтээгдэхүүн |
| 6  | Есөнбулаг сум               | Сүү, сүүн бүтээгдэхүүн |
| 7  | “Баярт өлөн” ХХК            | Махан бүтээгдэхүүн     |
| 8  | “Баян торой” ХХК            | Гурилан бүтээгдэхүүн   |
| 9  | “Ентүм” ХХК                 | Жимс, жимсгэнэ         |
| 10 | “Галын хүч” ХХК             | Шир савхин эдлэл       |
| 11 | “Арвин бэлт” ХХК            | Барилгын материал      |
| 12 | “Айргийн хад” ХХК           | Төмөр эдлэл            |
| 13 | Үйлдвэрийн хоршоодын холбоо | Оёдол                  |

Эдгээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хотын хөгжилд их хувь нэмэр оруулж нэг суурин нэг бүтээгдэхүүн баруун бүсийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр гарган ажиллаж байгаа юм.

### 3.2.2.3 Хилийн боомт

#### ***Бургастай- Лаоомяогийн авто замын боомт***

Бургастай авто замын боомт нь Монгол Улсын Говь-Алтай аймгийн Алтай сум, БНХАУ-ын ШУӨЗО-ны Хами районы Баликунь сум хиллэдэг хэсэгт, хилийн 354 дүгээр тэмдэгийн чиглэлд улсын хилээс 54, аймгийн төвөөс 400 километрт оршдог.

“Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” –ийн дагуу хоёр талын зорчигч, ачаа тээвэрлэх зориулалтаар 2, 4, 6, 8, 10, 12 дугаар саруудын 11-30-ны өдрүүдэд ажилладаг.

БНХАУ-ын талын боомт нь Лаоомяо, Монгол, Хятадын хилийн 354 дүгээр тэмдэгийн эсрэг талд хилээс 5.8 километрт ШУӨЗО-ны Хами районы Баликунь сумын нутагт байдаг. Бургастай боомтын барилгыг Гаалийн хөрөнгө оруулалтаар 1996 онд барьсан боловч шаардлага хангахгүй, халаалтгүй учраас хүйтний улиралд үйд ажилгаа явуулах боломжгүй.

Зам харилцаа муу, боомтоос Алтай сум, аймгийн төв хүртэл ердийн шороон замтай.

Цаашид дэд бүтэц болон хилийн хяналтын байгуулгуудын ажиллах нөхцөл бүрдүүлэх шаардлагатай. Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн “Хилийн боомтуудын талаар баримтлах үйл ажиллагааны чиглэл батлах тухай” 212 дугаар тогтоолоор Бургастай боомтыг улсын хилд ойртуулан шилжүүлж, хэлэлцээрт заасан зориулалт, хуваарын дагуу ажиллуулахаар заасан.

3.2.2.4 Хүн ам, хөдөлмөрийн нөөц

Одоогоор Говь-Алтай аймаг 75.0 орчим мянган хүн амтай, Алтай хот 15.6 мянган хүн ам, 3.1 мянган өрхтэй. Хүн амын 45.3 хувь нь хүүхэд; 50.4 хувь нь хөдөлмөрийн насны; 4.3 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна.

Хүснэгт 3.30

| Аймаг,<br>сумаар | Бүх хүн ам |         |         | Үүнээс                |         |         |              |          |          |            |         |         |        |         |         |
|------------------|------------|---------|---------|-----------------------|---------|---------|--------------|----------|----------|------------|---------|---------|--------|---------|---------|
|                  | Бүгд       | Эрэгтэй | Эмэгтэй | Нийслэл, аймгийн төвд |         |         | Хот, тосгонд |          |          | Сумын төвд |         |         | Хөдөөд |         |         |
|                  |            |         |         | Бүгд                  | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд         | Эрэг-тэй | Эмэг-тэй | Бүгд       | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд   | Эрэгтэй | Эмэгтэй |
| Алтай            | 2386       | 1295    | 1091    | 0                     | 0       | 0       | 0            | 0        | 0        | 1125       | 644     | 481     | 1261   | 651     | 610     |
| Баян-Уул         | 2953       | 1504    | 1449    | 0                     | 0       | 0       | 0            | 0        | 0        | 614        | 312     | 302     | 2339   | 1192    | 1147    |
| Бигэр            | 2460       | 1205    | 1255    | 0                     | 0       | 0       | 0            | 0        | 0        | 494        | 228     | 266     | 1966   | 977     | 989     |
| Бугат            | 2461       | 1206    | 1255    | 0                     | 0       | 0       | 0            | 0        | 0        | 419        | 198     | 221     | 2042   | 1008    | 1034    |
| Дарви            | 1877       | 941     | 936     | 0                     | 0       | 0       | 0            | 0        | 0        | 401        | 201     | 200     | 1476   | 740     | 736     |
| Дэлгэр           | 3066       | 1540    | 1526    | 0                     | 0       | 0       | 724          | 370      | 354      | 460        | 230     | 230     | 1882   | 940     | 942     |
| Жаргалан         | 1885       | 978     | 907     | 0                     | 0       | 0       | 0            | 0        | 0        | 315        | 163     | 152     | 1570   | 815     | 755     |
| Тайшир           | 1575       | 795     | 780     | 0                     | 0       | 0       | 0            | 0        | 0        | 364        | 173     | 191     | 1211   | 622     | 589     |
| Тонхил           | 2388       | 1204    | 1184    | 0                     | 0       | 0       | 0            | 0        | 0        | 564        | 268     | 296     | 1824   | 936     | 888     |
| Төгрөг           | 1871       | 933     | 938     | 0                     | 0       | 0       | 0            | 0        | 0        | 481        | 235     | 246     | 1390   | 698     | 692     |
| Халиун           | 2546       | 1315    | 1231    | 0                     | 0       | 0       | 0            | 0        | 0        | 357        | 177     | 180     | 2189   | 1138    | 1051    |
| Хөхморьт         | 2404       | 1224    | 1180    | 0                     | 0       | 0       | 564          | 279      | 285      | 468        | 221     | 247     | 1936   | 1003    | 933     |
| Цогт             | 3950       | 1948    | 2002    | 0                     | 0       | 0       | 0            | 0        | 0        | 607        | 282     | 325     | 2779   | 1387    | 1392    |
| Цээл             | 2235       | 1106    | 1129    | 0                     | 0       | 0       | 0            | 0        | 0        | 404        | 194     | 210     | 1831   | 912     | 919     |
| чандмана         | 2024       | 999     | 1025    | 0                     | 0       | 0       | 0            | 0        | 0        | 499        | 242     | 257     | 1525   | 757     | 768     |
| Шарга            | 1930       | 949     | 981     | 0                     | 0       | 0       | 0            | 0        | 0        | 707        | 351     | 356     | 1223   | 598     | 625     |
| Эрдэнэ           | 2280       | 1162    | 1118    | 0                     | 0       | 0       | 0            | 0        | 0        | 315        | 150     | 165     | 1965   | 1012    | 953     |
| Есөнбулаг        | 17527      | 8278    | 9249    | 16485                 | 7751    | 8734    | 0            | 0        | 0        | 0          | 0       | 0       | 1042   | 527     | 515     |
| Дүн              | 57818      | 28582   | 29236   | 16485                 | 7751    | 8734    | 1288         | 649      | 639      | 8594       | 4269    | 4325    | 31451  | 15913   | 15538   |

### 3.2.3 Орон нутгийн хөгжлийн хот Улаангом



Зураг 3.17 Улаангом хотын агшрын зураг

Улаангом сум Увс аймгийн төв бөгөөд нийт 260.0 гаруй мян.га нутаг дэвсгэрийг эзлэн оршдог, 1992 онд батлагдсан Монгол улсын Үндсэн хуулиар сумын статустай болсон. Одоо засаг захиргааны 9 багаас бүрдсэн нийт 25.4 мянган хүн ам, 5.92 мянган өрхтэй. Үүнээс 51.2 хувийг эмэгтэйчүүд; 41.8 хувийг 16 хүртэлх насны хүүхэд; 53.3 хувийг хөдөлмөрийн насны хүн ам; 73.9 хувийг 35 хүртэлх насны хүүхэд залуучууд; 4.7 хувийг 60 ба дээш насны хүн ам эзэлж байна. 2001 оны байдлаар 589 хүүхэд төрж, 149 хүн нас барсан бөгөөд 221 өрхийн 987 хүн шилжин явж, 77 өрхийн 636 хүн шилжин иржээ.

#### 3.2.3.1 Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарьлалт зохион байгуулалт


1920-оод оны эхээр засаг захиргааны шинэ зохион байгуулалт хийж эхлэх үед Дөрвөд Далай ханы аймаг, Зоригт ханы аймгийг нэгтгэж 1925 онд Чандмань уулын аймгийг байгуулж, Улаангомд төвлөрүүлэв. Тэр үед Дөрвөд далай ханы аймагт захирагдсан баядын 10 хошуу, Зоригт ханы аймагт захирагдсан баядын Ерөөлт бэйсийн нэг хошуутай нэгдэн Баянмандал уулын хошуу 10 сумтай болов. Зоригт ханы аймгийн дөрвөдийн үлдсэн 3 хошуугаар 3 сумтай Баянчандмань уулын хошууг байгуулаад Чандмань уулын аймагт захируулжээ.

1931 оны 2 сард БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 7 дугаар хурлын протоколоор хошуудыг өөрчлөх үед буюу мөн оны тэргүүн хагаст Чандмань уул аймаг хоёр аймагт хуваагдаж, Увс аймгийн анхны их хурлаар Дөрвөд аймаг нэртэй байгуулагдаад 1934 оноос Увс нуур аймаг болж, төвөөр Улаангом хотыг тогтоосон байна.

Чандмань уулын аймгийн Баянмандал уулын хошуунаас одоогийн Увс аймгийн Хяргас, Малчин, Тэс, Зүүнговь сумд байгуулагдав.

Эдгээрээс гадна Төгсбуянт уулын хошуунаас Бөхмөрөн, Сагил, Түргэн сумд бүтнээр, Давст сумын хагас нутаг, мөн Хантайшир уулын аймгийн Ханхөхүй уулын Баруунтуруун хошуу, зүүн Хөхүй уулын хошуу, Цэцэн сартуулын хошуунаас зарим сумын нутаг орох болов.

Ингээд Увс аймгийн одоогийн нутаг дэвсгэр нь Сайнзаяатын зүүн гарын Далай ханы аймаг, баруун гарын Зоригт ханы аймгийн нутгийн дийлэнх, Засагт хан аймгийн Чин ачит



Зураг 3.18

вангийн хошуу, Зоригт засгийн хошуу, Цэцэн сартуулын хошууны нутгийн хэсгээс бүрдэл болжээ.

### 3.2.3.2 Үйлдвэр аж ахуй

Одоогоор Улаангом хот сүү, цагаан идээ, махаар өөрийн аймгийн сум, сууринг хангаж байгаа бөгөөд нүүрсийг Улаангом хотоос 90 км-т орших Хар тарвагатайн нүүрсний уурхайгаас, түлшний модыг 268 км-т орших Цагаанхайрхан сумаас тус тус татан авч байна. Улаангом суманд нийт 240 гаруй аж ахуйн нэгж, үйл ажиллагаа явуулж, 300 гаруй сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлж байна.

Одоогоор Увс аймгийн төв Улаангом хотод ажиллаж байгаа үйлдвэрүүд:

- 1.Эрчим хүчний нэгдсэн үйлдвэр;
- 2.Хүнсний үйлдвэр (хоногт 8 тн талх, 3.0 мян.тн гоймон, 5 тн нарийн боов, жилд 1500 тн сүү, цагаан идээ, 300.0 мян.л архи, 300.0 мян.л ундаа боловсруулах төслийн хүчин чадалтай);
- 3.Гурилын үйлдвэр (жилд 8.0 мян.тн гурил, 350 тн арвайн гурил, 2.0 мян.тн тэжээл, 350.0 мян.ш шуудай үйлдвэрлэх төслийн хүчин чадалтай; одоогоор ашиглалтгүй);
- 4.Мод боловсруулах үйлдвэр (одоогоор ашиглалтгүй);
- 5.Хэвлэх үйлдвэр;
- 6.Барилга угсралтын трест;
- 7.Барилгын материалын үйлдвэр (3.0 сая ш тоосго үйлдвэрлэх төслийн хүчин чадалтай, одоогоор ашиглалтгүй);
- 8.Ахуйн үйлчилгээний комбинат (одоогоор хэсэгчлэн үйл ажиллагаа явуулж буй);
- 9.Чацарганы аж ахуй (одоогоор ашиглалтгүй);
- 10.Нисэх (25 ажиллагсадтай), авто аж ахуй (600 орчим ажиллагсадтай) үйл ажиллагаа явуулж байна.


Аж үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн хүчин чадал доройтож, техник технологи хоцрогдсон; бүтээгдэхүүн нь стандартад тохироогүй; эрэлт хэрэгцээг хангахгүй байгаа зэрэг нь тухайн салбарын хэтийн хөгжлийг тодорхойлохын өмнө шийдвэрлэх чухал асуудал болно.

Ашигт малтмалын нөөц баялгийг ашиглахын зэрэгцээ аялал жуулчлалын болон байгалийн нөөц, мал сүргээр баялаг аймаг, орон нутгийн газар нутагт орон нутгийнх нь хүн амын хүнс ба ахуйн хэрэглээ, хэрэгцээнд нь түшиглэсэн жижиг, дунд үйлдвэрийг төслийн төлөвлөлтийн үе шатуудад орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль газарзүйн онцлог, хүн ардын зан заншил, нутагшилт, хот байгуулалтын бодлоготой уялдуулан, орчин үеийн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх замаар тухайн нутаг дэвсгэрийн:

- ✓ мал аж ахуй хөгжсөн сумдад малын ашиг шимийг ашиглах, арьс ширэнд анхан шатны боловсруулалт хийх, сүү цагаан идээ боловсруулах, ноос угаах бага оврын үйлдвэр;
- ✓ сарлаг хайнаг олонтой сумдад сүү тосны жижиг үйлдвэр;
- ✓ газар тариалан эрхэлдэг сумдад үр тарианы болон тэжээлийн агуулах, бага оврын гурилын тээрэм;
- ✓ тухайн нутаг орны хүн амын заншлыг дагаж, бор гурил, арвайн гурил (болсон гурил)-ын жижиг үйлдвэр;
- ✓ ойн нөөцтэй нутагт ой цэвэрлэх аж ахуй, шингэн саван, үнэртэн давирхайн болон мөөг, жимс жимсгэнэ боловсруулах, савлах жижиг дунд үйлдвэр;
- ✓ загасаар баялаг нуур цөөрөм, гол мөрөн бүхий хот, сум сууринд загас боловсруулах, нөөшлөх жижиг үйлдвэр,
- ✓ ан амьтнаар баялаг сум сууринд үслэг эдлэлийн, тарвага, зээр, гөрөөсний гаралтай бүтээгдэхүүн хийх жижиг дунд үйлдвэр;
- ✓ рашаан усаар баялаг газар оронд рашаан савлах жижиг дунд үйлдвэр;
- ✓ эмийн ургамлаар баян тухайн бүс нутгийн хувьд эмийн ургамлын жижиг үйлдвэрийг байршуулах зэргээр түүхий эдийг түшиглэн аж үйлдвэрийг байгуулан хөгжүүлэх нь тээврийн зардал хэмнэгдэж, эдийн засгийн хувьд хямд төсөр, орон нутгийн хэрэглэгчдэд ч ойр дөт байна.

Үйлдвэрлэлийн цаашдын хөгжлийн стратеги нь байгаль орчинд үзүүлэх хор хөнөөл багатай, эдийн засгийн хүчирхэг, оновчтой технологи, орчин үеийн тоног төхөөрөмж бүхий, хүн амын өдөр тутмын хэрэгцээг аль болох ойр зайнаас хангахад чиглэгдсэн бүтцийг бий болгоход оршино.

Улаангом хот одоогийн байдлаар 25.4 мянган хүнтэй, Увс аймгийн төв, орон нутгийн хөгжлийн тулгуур төвийн статусаар хөгжих хэтийн чиг хандлагатай байгаа нь аймгийн бүлэг суурингийн хөгжлийн тогтолцоо, хүн амын нутагшилтын тогтолцоог бүрдүүлэх, аймаг, хотын хөгжлийн стратегийг тодорхойлох, эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх салбарыг тогтоох асуудлыг эхний ээлжинд тодорхойлох шаардлагатай юм.



Орон нутгийн хөгжлийн төвд бүлэг суурингийн төвүүд Бүлэг суурингийн Улаангом хотын (Түргэн, Тариалан); Сагил сумын (Бөхмөрөн, Давст); Өмнөговь сумын (Ховд, Өлгий); Наранбулаг сумын (Завхан); Зүүнговь сумын (Тэс, Малчин, Хяргас); Баруунтуруун сумын (Цагаанхайрхан, Өндөрхангай, Зүүнхангай) нийт 6 тогтолцоог үүсгэн, бүсийн тулгуур төв Ховд хотод татагдан цаашид хэтийн хөгжлийн стратегийг тодорхойлон хөгжих юм.

Орон нутгийн хөгжлийн тулгуур төв Улаангом хотод түшиглэн орчин үеийн эрчим хүч, харилцаа холбоо, мэдээллийн нэгдсэн сүлжээ бүрдүүлнэ. Сумдын малчдын суурийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, хөдөлгөөнт холбооны үйлчилгээгээр бүрэн хангана.

Нийгмийн дэд бүтцийн хүрээнд их, дээд, дунд сургууль, орчин үеийн эмчилгээ оношлогооны төв, соёл урлагийн байгууллагуудыг Улаангом хот, бичил бүсүүдээр оновчтой байршуулан хөгжүүлж, үйлчилгээний чанарыг нь орчин үеийн шаардлагад хүргэн, хөдөөгийн хүн амд ойртуулна.

Баруун бүс нутгийн тулгуур төв хот, орон нутгийн хөгжлийн хотуудад нийгэм эдийн засгийн чухал үүрэг гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалт хийн хотын хөгжлийг шийдвэрлэж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн жагсаалт /Хүснэгт 3.31/

|    |   |   |
|----|---|---|
| 1  | “Баруун бүсийн эрчим хүчний систем” компани | ОХУ –аас импортын цахилгаан эрчим хүч дамжуулах |
| 2  | Түлш дулааны нэгдэл                         | Дулаан үйлдвэрлэх, нүүрс олборлох               |
| 3  | “Увс-хүнс” групп                            | Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл               |
| 4  | “Шинэ зуун март” ХХК                        | Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл               |
| 5  | “Хар тэрмэс” амралт, рашаан сувилал         | Амралт, рашаан сувилалын үйлчилгээ              |
| 6  | “Зэл говь” ХХК                              | Хүнс  |
| 7  | “Цахир” хоршоо                              | Гурилан бүтээгдэхүүн                            |
| 8  | “Өнгөлөг” трейд                             | Сүү, сүүн бүтээгдэхүүн                          |
| 9  | “Увс гурил” ХХК                             | Гурилан бүтээгдэхүүн                            |
| 10 | “Өнхрүүш” хоршоо                            | Гурилан бүтээгдэхүүн                            |



|    |                             |                                 |
|----|-----------------------------|---------------------------------|
| 11 | “Ус-Эрдэнэ” ХХК             | Жимс, жимсгэнэ                  |
| 12 | “Уран зурвас” хоршоо        | Жимс, жимсгэнэ                  |
| 13 | Эрдэм шинжилгээний хүрээлэн | Жимс, жимсгэнэ                  |
| 14 | “Баруун загвар” ХХК         | Шир савхин эдлэл                |
| 15 | “Улаангом” коллеж           | Эсгий эдлэл, модон эдлэл, оёдол |
| 16 | “Шинэ ирээдүй” хоршоо       | Эсгий эдлэл                     |
| 17 | Хүдэнгийн уурхай            | Барилгын материал               |
| 18 | Сарантуяа /иргэн/           | Оёдол                           |

Эдгээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хотын хөгжилд их хувь нэмэр оруулж нэг суурин нэг бүтээгдэхүүн баруун бүсийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр гарган ажиллаж байгаа юм.

### 3.2.3.3 Хилийн боомтууд

#### **Боршоо-Хандгайт авто замын боомт**

Боршоо авто замын боомт нь Монгол Улсын Увс аймгийн Сагил сум, ОХУ-ын Тува Улсын Өвөр Хошууны Хандгайт тосгон хиллэдэг хэсэгт хилийн 126 дугаар тэмдэгтийн чиглэлд улсын хилээс 100 метр, Давст сумаас 28, Сагил сумаас 65, аймгийн төвөөс 120 километрт оршдог.

Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын “Хилийн боомт болон Монгол, Орос хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай хэлэлцээр”-ийн дагуу хоёр талын зорчигч, ачаа тээврийн харилцааны зориулалтаар байнга ажиллаж, Монгол Улсын баруун бүсийн аймгуудыг Орос улстай холбодог.

ОХУ-ын талын боомт нь Хандгайт, хилийн 126 дугаар тэмдгийн эсрэг хилээс 100 метрт Тува улсын Өвөр Хошууны Хандгайт тосгоны нутагт байдаг.

Боомтын барилга байгууламжийг 1996 онд гаалийн байгууллагын хөрөнгө оруулалтаар барьсан, 2001 онд барилга байгууламж, хяналт шалгалтын талбайг өргөтгөж, 2004 онд их засвар хийсэн. Боомтоос Улаангом хот, Сагил сумын хооронд сайжруулсан засмал замтай, Давст сумын хооронд ердийн замтай.

Боршоо боомтыг олон улсын зориулалттай болгох талаар 2007 онд ОХУ-тай дипломат шугамаар тохирлцсон боловч одоогоор хоёр талын иргэд зорчиж байгаа бөгөөд цаашид уг боомт баруун бүсэд Мянганы замын босоо тэнхлэгийн гол гарц болно.

#### **Тэс-Шар суурь авто замын боомт**

Тэс боомт нь Монгол Улсын Увс аймгийн Тэс сум, ОХУ-ын Тува Улсын Тесхемийн районы Цагаан эргийн хамтрал хиллэдэг хэсэгт хилийн 200 дугаар тэмдэгтийн чиглэлд хилээс 100 метр, сумаас 55, аймгийн төвөөс 210 километрт оршдог.


Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын “Хилийн боомт болон Монгол, Орос хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай хэлэлцээр”-ийн дагуу хоёр талын зорчигч, ачаа тээврийн харилцааны зориулалтаар байнга ажилладаг.

ОХУ-ын талын боомт нь Шарсуурь хилийн 200 дугаар тэмдгийн эсрэг хилээс 1, Тува улсын Тесхемийн районы Цагаан-Эрэгийн хамтралын нутагт, хамтралаас 25 километрт байдаг.

Гаалийн байгууллагын хөрөнгө оруулалтаар 1995-1998 онл хил, гаалийн хяналт шалгалтын талбай, ажлын байр, агуулах, хашаа барьж, дизель станц суурилуулсан. Боомтод хилийн шалган нэвтрүүлэх ажилын байр, ажилчдын орон сууц байхгүй тул хил хамгаалалтыг зохион байгуулахад хүндрэлтэй. Зам харилцаа муу, боомтоос Тэс сум, аймгийн төв хүртэл ердийн шороон замтай. Цаашид зам харилцааг сайжруулах, шалган нэвтрүүлэх албаны ажилын байр, ажилчдын орон сууц барих шаардлагатай.

|   |           |  |
|---|-----------|--|
| 1 | Боршоо    | ОХУ –д гарцтай<br>-Байнгын ажиллагаатай<br>-Хилийн худалдаа<br>-Зорчигч тээвэр |
| 2 | Шар суурь | ОХУ –д гарцтай<br>-Байнгын ажиллагаатай<br>-Хилийн худалдаа<br>-Зорчигч тээвэр |

### 3.2.5. Баруун бүсийн тулгуур төв Улиастай



Зураг 3.20 Улиастай хотын агаарын зураг

Улиастай хот нь 1924 оноос эхлэн барилгажиж, өнгөрсөн 80-аад жилийн түүхэнд олон тооны барилга байгууламжтай болж, Баруун бүсийн хөгжлийн тулгуур төвийн статустай болтлоо хөгжсөн байна. Улиастай хотын хөгжлийн өмнөх ерөнхий төлөвлөгөөг 1963, 1969, 1983 онд 20 жилийн дараахи хөгжлийн хэтийн төлөвийг урьдчилан харж төлөвлөж ирсэн байна. Сүүлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулснаас хойш тус хотын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаа үндсэндээ дууссан байна. Монгол улс нийтээрээ 1990-ээд оны эхэн үеэс нийгэм-

эдийн засгийн өөр тогтолцоонд шилжих шилжилтийн үе эхэлснээс шалтгаалан өмнөх ерөнхий төлөвлөгөө (1983 оны) үндсэндээ хэрэгжсэнгүй. Хүн амын тоо одоогийн байдлаар төлөвлөсөн хүн амынхаа 65.0-75.0 (хотын болон аймгийн хүн ам) хувьд байна. Түүнчлэн эхний ээлжинд хотын хүн амын 16.0 хувь инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд оршин суухаар тооцсон боловч хэрэгжээгүй, өнөөдөр хүн амын 6.6 хувь инженерийн дэд бүтэц бүхий тохилог сууцанд сууж байна. Орон сууцны хангамж муу, барилга байгууламжийн чанар муу, орчны тохижилт хийгдээгүй, замын хучилт муу зэргээс орчны бохирдолт, байгаль экологийн сөрөг нөлөө, хөрсний эвдрэл бий болсноос 1985 онд батлагдсан ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэнд муугаар нөлөөлсөн байна.

*Бүс нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл нь:*

- Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, түүхий эдээ дотооддоо боловсруулах;
- Эрдсийн түүхий эд олборлох (зэс, гантиг, фосфорит), боловсруулах, геологи хайгуулын ажлыг эрчимжүүлэх;
- Усны эрчим хүчийг ашиглах, эрчим хүчний үйлдвэр байгуулах;
- Байгалийн нөхцөл, нөөцийг бүрэн ашиглах зорилгоор ой-хими, цаас, целлойд, бордоо, үнэртний жижиг, дунд үйлдвэр байгуулах;
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- Бүс нутгийн хөгжлийн тулгуур төвөөр хөгжүүлэхээр шийдвэрлэж буй Улиастай хотыг хот байгуулалтын үндсэн шийдлийн дагуу хөгжүүлж, ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх

#### 3.2.4.1 Хүн ам, хөдөлмөрийн нөөц

2007 оны эцэст 20490 өрхийн 79526 хүн амтай болж өнгөрсөн оноос 521 хүнээр өсч, нийт хүний 48.5 хувь нь эрэгтэй, 51.5 хувь нь эмэгтэйчүүд, 16 хүртэлх насны хүүхэд 31.7 хувь, 16-35 насны залуучууд 38.3 хувь, 90 –ээс дээш насны 61 хүн байна. Хүн амын 20.4 хувь нь аймгийн төвд, 24.6 хувь нь сумын төвд, 55.0 хувь нь хөдөөд амьдарч байна. Энэ онд 1632 хүүхэд төрж, 479 хүн нас барж, 1301 хүн гэрлэлтээ бүртгүүлж, 77 хүүхэд үрчлэгдэж, 8 хүн гэрлэлтээ цуцлуулсан байна. Төрөлтийн ерөнхий коэффициент 18.3, нас баралтын коэффициент 5.3, хүн амын ердийн өсөлт 1153 байна. Бүтэн өнчин хүүхэд 154, хагас өнчин хүүхэд 1455, 16

хүртэл насны хүүхэдтэй гэр бүлгүй 1460 хүн, тахир дутуу 3355 хүн, 8 ба түүнээс дээш ам бүлтэй өрх 401, 16 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх 1281, өндөр настай ганц бие өрх 1240, тэтгэвэр тэтгэмж тогтоогдоогүй өндөр настан 14 тус тус байна.

Баруун бүс нутгийн тулгуур төв хот, орон нутгийн хөгжлийн хотуудад нийгэм эдийн засгийн чухал үүрэг гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалт хийн хотын хөгжлийг шийдвэрлэж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн жагсаалт /Хүснэгт 3.33/

|    |                                     |   |
|----|-------------------------------------|---|
| 1  | “Отгонтэнгэр” амралт рашаан сувилал | Амралт рашаан сувилалын үйлчилгээ                                   |
| 2  | “Тэсийн гол” ХХК                    | Хүнсний бүтээгдэхүүн, ноос угаах, амралт аялал жуулчлалын үйлчилгээ |
| 3  | “Ойн баялаг” ХХК                    | Модон эдлэл, зүсмэл материалын үйлчилгээ                            |
| 4  | “Баялаг” групп                      | Хүнсний бүтээгдэхүүн  |
| 5  | “Жаргалант” хоршоо                  | Хүнс  |
| 6  | Хүнс хөдөө аж ахуйн газар           | Эсгий, ноос   |
| 7  | “Мөнхөд мандаг” ХХК                 | Хүнс  |
| 8  | “Батбаян өргөө” ХХК                 | Мах махан бүтээгдэхүүн, утсан хиам                                  |
| 9  | “Балбарай” ХХК                      | Жимс, жимсгэнэ  |
| 10 | У.Жаргалсайхан                      | Жимс, жимсгэнэ  |
| 11 | “Завхан баялаг” ХХК                 | Эрдэс, түүхий эд  |

Эдгээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хотын хөгжилд их хувь нэмэр оруулж нэг суурин нэг бүтээгдэхүүн баруун бүсийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр гарган ажиллаж байгаа юм.

Завхан аймаг нь хүн амын дундаж наслалт, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, боловсрол, ажилгүйдлийн түвшин, төрөл бүрийн замын сүлжээний хангамжийн коэффициент зэрэг үзүүлэлтүүдийг тооцон гаргасан Монгол улсын аймаг, хотуудын эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшний нэгдсэн үнэлгээгээр улсын хэмжээнд сүүлчийн байранд орж байгаа нь Улиастай хотын хэтийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх юм.

Улиастай хот одоогийн байдлаар 24.1 мянган хүнтэй, Завхан аймгийн төв төдийгүй, Баруун бүсийн хөгжлийн тулгуур төвийн статусаар хөгжих хэтийн чиг хандлагатай байгаа нь аймгийн бүлэг суурингийн хөгжлийн тогтолцоо, хүн амын нутагшилтын тогтолцоог бүрдүүлэх, аймаг, хотын хөгжлийн стратегийг тодорхойлох, эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх салбарыг тогтоох асуудлыг эхний ээлжинд тодорхойлох шаардалагатай юм.

Төрийн болон боловсрол, эрүүл мэндийн байгууллагууд /Хүснэгт 3.34/

|   |                                |   |
|---|--------------------------------|---|
| 1 | Эдийн засгийн дээд сургууль    | Санхүүэдийн засгийн мэргэжилтэн бэлтгэх |
| 2 | Хөгжим бүжгийн коллеж          | Соёл урлагийн мэргэжилтэн бэлтгэх       |
| 3 | “Орхон” дээд сургуулийн салбар | Гадаад хэлний мэргэжилтэн бэлтгэх       |

### 3.2.4.2 Хилийн боомт

#### Арцсуурь-Цагаан толгой авто замын боомт

Арцсуурь авто замын боомт Монгол Улсын Завхан аймгийн Тэс сум, ОХУ-ын Тува улсын Эрзин районы Нарийн хамтрал хиллэдэг хэсэгт, хилийн 244 дүгээр тэмдэгийн чиглэлд хилээс 50 метр, сумаас 45, Улиастай хотоос 360 километр оршдог.

Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын “Хилийн боомт болон Монгол, Оросын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай хэлэлцээр” –ийн дагуу хоёр талын зорчигч, ачаа тээврийн харилцааны зориулалтаар байнга ажилладаг.


ОХУ-ын талын боомт нь Цагаан-толгой хилийн 244 дүгээр тэмдэгийн эсрэг хилээс 50 метр, Тува улсын Эрзин районы Нарийн хамтралын нутагт, тус хамтралаас 45 километр байдаг. Боомтоор Монгол, Тува иргэд худалдаа арилжааны зорилгоор харилцан зорчиж, ОХУ-

руу бүх төрлийн хятад бараа, мах, загас, малын түүхий эд экспортлож, Монголд шатахуун, гурил болон бусад хүнсний бүтээгдэхүүн оруулдаг.

Хоногт дунджаар 100-150 зорчигч, 10-20 тээврийн хэрэгсэл нэвтэрдэг бөгөөд 2008 оны эхний 6 сарын байдлаар 2 орны 12167 зорчигч, 1156 тээврийн хэрэгсэл нэвтэрсэнийг 2007 оны мөн үетэй харьцуулбал 20 орчим хувиар өссөн байна.

Арцсуурь боомтын дэд бүтэц шаардлагын хэмжээнд бүрдээгүй, хилийн шалган нэвтрүүлэх албаны үйл ажиллагаа явуулах ажилын байр, ажилчидын орон сууц байхгүй. Цаашид боомтод хил хяналтын байгуулгуудын үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлж, ажилын байр, ажилчидын орон сууц барих асуудлыг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай.

### 3.2.6 Баруун бүсийн тулгуур төв Ховд



Зураг 3.21 Ховд хотын агаарын зураг

Ховд аймаг нь 76 мян.км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй, аймгийн төв Ховд хот нь Буянт голын хөндийд далайн түвшнээс дээш 1405 м өндөрт Улаанбаатраас 1425 км зайтай оршино. Урд хэсгээрээ БНХАУ –тай хиллэнэ. Ховд аймаг нь Баруун бүсийн бусад 4 аймагтай хиллэдэг, газар зүйн байрлалын хувьд Баруун бүсийн бараг төв хэсэгт нь байрладаг онцлогтой.

Аймгийн төв хэсэгт Алтайн өндөр уулс,

хойд болон урд талаараа нам доор, говь цөлийн бүс зонхилно. Говь цөлийн бүс нилээд их талбай эзлэх бөгөөд Баруун бүсийн 5 аймаг дотроос Говь-Алтай аймгийн дараа орно. Ховд аймагт Мөнх хайрхан, Таван хумст, Хөх сэрх, Сутай зэрэг 4000 м өндөр уулууд олон бий.

Ховд аймгийн төв хэсэгт Алтайн уулсын нуруу болон урд талаараа нам дор газар, говь цөлийн бүс зонхилно. Иймд баруун бүсийн тулгуур төв Ховд хот орчмын бүсийг хөгжүүлэх ажил нь газрын гадрага, тогтцоос ихээхэн шалтгаалах нь тодорхой юм. Аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд аймаг хөгжүүлэх төслийг шинжилгээ судалгааны үндсэн дээр хотын ерөнхий төлөвлөгөөтэй хамтад нь иж бүрнээр шийдвэрлэх шаардлагатай бөгөөд бид өмнө нь хийж байсан төлөвлөлтийн ажлуудыг ийм зарчмаар хийж ирсэн юм.

Ховд төвтэй Хар нуур, Хар-Ус нуур орчмын нутаг. Энд Ховд хот, Дөргөн, Ховд, Буянт, Мянгад, Эрдэнэбүрэн зэрэг сумууд орох бөгөөд уламжлалт мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлж, усалгаатай газар тариаланг дэмжин, сэргээж хөгжүүлэх эдгээрт чиглэсэн боловсруулах жижиг дунд үйлдвэрүүдийг дээрх сумдуудад байгуулах нь зах зээлийн өнөө үеийн шаардлагад нийцнэ гэж үзэж байна. Байгалийн үзэсгэлэнт олон нуур, байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэн байгалийн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх бүрэн боломжтой юм. Аймгийн нутагт том жижиг гол мөрөн нууртайгаас гадна аймгийн нутгийн үлэмж хэсгийг говь цөл эзэлнэ. Иймд Ховд аймгийг аялал жуулчлалын нэг нь төрөл болох уулын спорт, ан агнуур, усан аялал хөгжүүлэхэд нэн тохиромжтой нутаг юм.

Зураг 3.22 Ховд аймгийн бүлэг суурингийн тогтолцоо



| Бүлэг суурингийн төвийн нэр   | Хамрагдах сум   |
|-------------------------------|---|
| Ховд хотын Бүсийн тулгуур төв | 1. Мянгад<br>2. Буянт<br>3. Ховд<br>4. Дөргөн<br>5. Эрдэнэбулган<br>6. Дуут |
| Мөнххонгор                    | 1. Мөнххонгор   |

*Ховд аймгийн бүлэг суурингийн  
тогтолцоо /Хүснэгт 3.35/*

### 3.2.5.1 Хүн ам, хөдөлмөрийн нөөц

Оны эцэст аймгийн нийт хүн 89.0 мянга, өрх 19.6 мянгад хүрч, өнгөрсөн оноос хүн амын тоо 3.7 өрхийн тоо 0.9 хувиар буурчээ. Нийт хүн амын 35.4 хувийг 0-15 насны хүүхэд, 59.3 хувийг 16-59 насны, 5.3 хувийг 60 ба түүнээс дээш насны хүн ам эзэлж байна.

Нийт хүн амын 48.6% буюу 43293 нь эрэгтэй, 51.4% буюу 45747 нь эмэгтэйчүүд байна. Хүн амын 32.1 % нь аймгийн төвд, 17.6 % нь сумын төвд, 50.3 хувь нь хөдөө суурьшин амьдарч байна. Төрсөн 1980 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн, нас барсан 415 хүнийг иргэний бүртгэлээс хасч, 869 гэрлэлтийг бүртгэн, 19 хос гэрлэлтээ цуцлуулж, 92 хүүхэд үрчлэгдсэн байна. өнгөрсөн оноос үрчлэгдсэн хүүхдийн тоо 9.5 % -иар, төрсөн хүүхдийн тоо 7.9 хувиар, цуцлалт 35.7% -иар, үрчлэлт 4.5 % -иар нэмэгдэж, нас барсан хүний тоо 14.9 % -иар, гэрлэлт 65.1 % -иар буурсан байна. Жилд 162 өрхийн 2100 хүн шилжин явж, 94 өрхийн 638 хүн шилжин ирж суурьшсан байна.

Суурин хүн амын тоо, хот, хөдөөгөөр оны эцэст /Хүснэгт 3.36/

| Үзүүлэлтүүд | 2002  | 2003  | 2004  | 2005  | 2006  | 2007  |
|-------------|-------|-------|-------|-------|-------|-------|
| Аймаг       | 28968 | 30527 | 32332 | 31596 | 31998 | 28601 |
| Сум         | 18029 | 18052 | 16667 | 19603 | 15547 | 15692 |
| Хөдөө       | 42667 | 42596 | 42771 | 40154 | 44850 | 44747 |

### 3.2.5.2 Үйлдвэр аж ахуй

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт жилийн эцэст 1595.9 сая төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэж 2335.1 сая төгрөгний борлуулалт хийжээ. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг өнгөрсөн онтой харьцуулахад үйлдвэрлэлт 12.7 хувь буюу 231.7 сая төгрөгөөр буурч, борлуулалт 6.6% буюу 146.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Баруун бүс нутгийн тулгуур төв хот, орон нутгийн хөгжлийн хотуудад нийгэм эдийн засгийн чухал үүрэг гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалт хийн хотын хөгжлийг шийдвэрлэж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн жагсаалт /Хүснэгт 3.37/

|    |                                 |   |
|----|---------------------------------|---|
| 1  | “Алтай трест” ХК                | Цахилгаан дамжуулах шугам, барилга угсралтын ажил |
| 2  | “Баруун монгол интернейшнл” ХХК | Мах боловсруулах, бөөний худалдаа                 |
| 3  | “Ховдын тулга” ХХК              | Барилга угсралт барилгын материалын үйлдвэрлэл    |
| 4  | “Ховдын өргөө” ХХК              | Барилга угсралт барилгын материалын үйлдвэрлэл    |
| 5  | “Алтайн зам” ХХК                | Зам, гүүрийн барилгын үйлдвэрлэл                  |
| 6  | “Айбол” ХХК                     | Эсгий эсгий гутлын үйлдвэрлэл                     |
| 7  | Нисэх буудал                    | Олон  |
| 8  | “РМПК” ХХК                      | Хүнс  |
| 9  | М.Пагваа                        | Хүнс, зөгийн бал                                  |
| 10 | “Бамбар” хоршоо                 | Сүү, сүүн бүтээгдэхүүн зайрмаг                    |
| 11 | Цэнгэл                          | Сүү, сүүн бүтээгдэхүүн ааруул, шар тос            |

|    |                            |                         |
|----|----------------------------|-------------------------|
| 12 | “Мөнгөн хундага”           | Шар сүүний бүтээгдэхүүн |
| 13 | “Баруун дээр” хоршоо       | Жимстэй тарга           |
| 14 | “ХАН жаргалант” ХХК        | Хиам, савласан мах      |
| 15 | “Алтайн буян” ХХК          | Нөөшилсөн загас         |
| 16 | “Баянбулаг” ХХК            | Нарийн боов             |
| 17 | З.Энхтайван                | Арвай гурил             |
| 18 | “Наран бейкери” төв        | Нарийн боов             |
| 19 | “Очир сүлд” хоршоо         | Хар талх                |
| 20 | “Хан тунгалаг” хоршоо      | Хүнсний ногоо           |
| 21 | Төлөөгөн /иргэн/           | Жимс, жимсгэнэ          |
| 22 | “Амттаны ундрага” хоршоо   | Жимс, жимсгэнэ          |
| 23 | “Үр жимс” хоршоо           | Жимс, жимсгэнэ          |
| 24 | Шарав /иргэн/              | Шир савхин эдлэл        |
| 25 | Чакерман /Иргэн/           | Эсгий эдлэл             |
| 26 | А.Цэнд-Аюуш                | Эсгий эдлэл             |
| 27 | “Ховдын тулга” ХХК         | Барилгын материал       |
| 28 | “ОДЦЭ” ХХК                 | Барилгын материал       |
| 29 | “Баярдэлгэрэх” ХХК         | Барилгын материал       |
| 30 | “Дөргөн дэлгэрэх” нөхөрлөл | Төмөр эдлэл             |
| 31 | “Буянт үйлийн шим” хоршоо  | Оёдол                   |
| 32 | Баянжаргал /иргэн/         | Оёдол                   |
| 33 | “Эрдэнэ өлзий” ХХК         | Эрдэс, түүхий эд        |
| 34 | “Цэвэрлэх булаг” хоршоо    | Эрдэс, түүхий эд        |

Эдгээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хотын хөгжилд их хувь нэмэр оруулж нэг суурин нэг бүтээгдэхүүн баруун бүсийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр гарган ажиллаж байгаа юм.

**Төрийн болон боловсрол, эрүүл мэндийн байгууллагууд /Хүснэгт 3.38/**

|   |                                  |  |
|---|----------------------------------|--|
| 1 | Баруун бүсийн зөвлөл             | Бүс нутгийг хөгжүүлэх төр засгийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх |
| 2 | Бүсийн оношлогоо эмчилгээний төв | Хүн амд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх                            |
| 3 | “Ховд” их сургууль               | Дээд мэргэжилтэн багш, эдийн засагч, хуульч бэлтгэх                |
| 4 | ХААИС –ийн Алтайн бүсийн салбар  | ХАА-н мэргэжилтэн болон мэргэжлийн ажилчид бэлтгэх                 |
| 5 | “Эрдэм” дээд сургууль            | Эдийн засаг, бизнесийн чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх               |

**Төсөл хэрэгжүүлэгч нэгж болон төрийн бус байгууллагууд /Хүснэгт 3.39/**

|   |   |  |
|---|---|--|
| 1 | НҮБ –ийн хүн амын сангийн бүсийн төлөөлөгчийн газар             | Хүн амын эрүүл мэндийг хамгаалах                   |
| 2 | Алтай-Соёны эко-бүсийн биологийн төрөл зүйлийг хамгаалах төсөл  | Эко бүсийн төрөл зүйлийг иргэдийн оролцоотойгоор   |
| 3 | НҮБ –ийн хүүхдийн сангийн “Нийгмийн цогц суурь үйлчилгээ” төсөл | өрхийн амьжиргааг чадваржуулахыг дэмжих            |
| 4 | “Ирвэс-3” баг   | Хууль бус ан агнууртай тэмцэх                      |
| 5 | Баруун Монголын соёлын нийгэмлэг                                | Соёл урлагийг хөгжүүлэх                            |
| 6 | Баруун бүсийн мэдээлэл сургалтын төв                            | үйлдвэрчин, хоршоодын байгууллагын сургалт явуулах |

**3.2.5.3 Хилийн боомтууд**

**Ховд аймгийн нисэх буудалд нээхээр төлөвлөж буй олон улсын агаарын замын боомт**

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор Ховд аймгийн онгоцны буудлыг олон улсын нислэг үйлдэх боомт болгох чиглэлээр хөрш орнуудтай байгуулсан хэлэлцээрт нэмэлт оруулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх, олон улсын нислэгийн үед буудалд хил, гааль, хилийн хяналтын болон гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх албаны хяналтыг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх, шаардлагатай барилга байгууламж, талбай, тоног төхөөрөмжөөр хангах талаар шаардлагатай бэлтгэл арга хэмжээ авахыг холбогдох яамдуудын сайд нарт үүрэг болгосон.

Засгийн газрын 69 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж бэлтгэл ажилыг хангах, нисэх буудалд хилийн хяналт шалгалт явуулах нөхцлийг бүрдүүлэх талаар ХХЕГ, ИНЕГ, ГЕГ, УМХГ-аас 2007 оны 5 дугаар сард 343/ 323/ 206/ 06 тоот хамтарсан тушаал гарган ажиллаж байна.

Хил хамгаалах байгууллага Ховд аймгийн Үенч сум дахь харьяа хилийн отрядын орон тоонд нисэх буудалд хилийн хяналт, шалгалт явуулах ШНА-ны тасгийн орон тоог шинээр нэмсэн.

Ховд аймаг дахь хилийн отряд нь аймгийн төвөөс 350 километр Үенч суманд байрладаг тул аймгийн төвд хилийн хяналт шалгалт явуулах салбар байгуулах, үйл ажиллагаа ажлын байр, ажилтнуудын орон сууцны асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

### **Булган-Такашикэн авто замын боомт**

Булган-Такашикэн авто замын боомт нь Монгол Улсын Ховд аймгийн Булган сум, БНХАУ-ын ШУӨЗО-ны Алтай районы Цинхэ сум хиллэдэг хэсэгт, хилийн 124 дүгээр тэмдэгийн чиглэлд улсын хилээс 50 метр, аймгийн төвөөс 455 километрт оршдог.

Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд 2004 онд шинэчлэн байгуулсан “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай хэлэлцээр” –т Булган-Такашикэн боомтыг олон улсын зориулалтаар байнга ажиллахаар заасан хэдий ч шаардлагатай дэд бүтэц болон хилийн хяналтын байгууллагуудын ажиллах нөхцөл бүрдээгүй тул 1991 оны хэлэлцээрийн дагуу хоёр талын зорчигч, ачаа тээврийн зориулалтаар 4-12 дугаар саруудын 15-30-ны өдрүүдэд ажиллаж байна.

БНХАУ-ын талын боомт нь Такашикэн, Монгол, Хятадын хилийн 124 дүгээр тэмдэгийн эсрэг хилээс 16.5 километрт ШУӨЗО-ны Алтай районы Цинхэ сумын нутагт байдаг.

“Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн хоорондын хэлэлцээр” –ийн хэрэгжилтийн тухай хоёр улсын Гадаад хэргийн яамны 2007 оны зөвлөлдөх уулзалтаар Булган боомтыг 2008 онд багтаан олон улсын зорчигч, ачаа тээвэрлэлтийн зориулалтаар байнгын ажиллагаанд шилжүүлэх, нээх хугацааг хоёр талд дэд бүтцийг бүрдүүлсэний дараагаар дипломат шугамаар тохиролцохоор тогтсон.

Булган боомтын байрлалд 2007 онд Хятадын талаас өндөр хүчдэлийн шугам татаж ашиглалтанд оруулсан. Одоо хилийн хяналт шалгалтын шинэ цогцолбор мөн гаалийн байгууллагын хөрөнгөөр баригдаж байгаа бөгөөд 2008 онд ашиглалтанд өгөхөөр төлөвлөсөн.

Булган боомт нь Азийн авто замын сүлжээний тухай хэлэлцээрт заасан хурдны зам /АН4/, Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын Засгийн газар хооронд байгуулах “Дамжин өнгөрөх тээврийн хэлэлцээр”-т Монголоор дамжин өнгөрөх чиглэлд тус тус хамрагдаж байна. Булган боомтод ажиллаж буй хилчид амьдрах орон сууцгүй, түр хугацаагаар гэр, вагончикт амьдарч байгаа бөгөөд цаашид хэрэхх нь тодорхойгүй байгаа тул хилчидийн орон сууцны асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

“Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн хоорондын хэлэлцээр” –ийн дагуу олон улсын зэрэглэлээр 2008 онд багтаан байнгын ажиллагаанд шилжүүлэх чиглэл баримталж байна.

### **Байтаг-Улиастайн авто замын боомт**

Байтаг-Улиастайн авто замын боомт нь Монгол Улсын Ховд аймгийн Булган сум, БНХАУ-ын ШУӨЗО-ны Цонжийн Хотон үндэстэний өөртөө засах тойргийн Чита сум хиллэдэг хэсэгт, хилийн 163 дугаар тэмдэгийн чиглэлд улсын хилээс 2 километрт оршдог

“Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” –ийн дагуу хоёр талын зорчигч, ачаа тээвэрлэх зориулалтаар 3, 6, 9 дүгээр сарын 16-20-ны өдрүүдэд ажилладаг бөгөөд өдөрт дунджаар 30-50 зорчигч, 10-15 тээврийн хэрэгсэл шалган нэвтрүүлдэг.

БНХАУ-ын талын боомт нь Улиастай, Монгол, Хятадын хилийн 163 дугаар тэмдэгийн эсрэг хилээс 5.8 километрт ШУӨЗО-ны Цонжийн Хотон үндэстэний өөртөө засах тойргийн Чита сумын нутагт байдаг.

Гаалийн болон хилийн мэргэжлийн хяналтын албадын ажилын байрыг 2000 онд төсвийн хөрөнгөөр барьсан. Хилийн шалган нэвтрүүлэх албаны байрыг Ховд аймаг дахь хилийн отряд өөрийн дотоод орлого, аж ахуйн аргаар 2000 онд бариж ашиглалтанд оруулсан. Түр хугацаагаар нээ нөхцөлд алба үйл ажиллагаа явуулахад боломжтой амьдрах ахуй нөхцлөөр зохих хэмжээгээр хангагдсан .


Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн “Хилийн боомтуудын талаар баримтлах үйл ажиллагааны чиглэл батлах тухай” 212 дугаар тогтоолоор Булган боомтыг байнгын ажиллагаатай болсон тохиолдолд хаах чиглэл баримтлахаар заасан.

## Дөрөв. БАЙГАЛЬ ОРЧИН, ЭКОСИСТЕМИЙН НӨХЦӨЛ

### 4.1 ОЙН САН БҮХИЙ ГАЗАР

#### 4.1.1 Монгол орны ойн тархалт

Манай улсын ойн талбай нь 19,3 сая га, үүнээс ой модоор бүрхэгдсэн талбай нь загийг оролцуулахгүйгээр 10,6 сая га буюу нийт нутаг дэвсгэрийн дөнгөж 6,7 хувь байгаа нь НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас гаргасан жишгээр ойн нөөц хомс орны тоонд хамрагддаг.



Зураг 4.1 Монгол орны ойн тархалт

Сүүлийн 30 гаруй жилд мод бэлтгэлийн ажлыг эмх замбараагүй явуулсан, ойн түймэр, хөнөөлт шавжинд их хэмжээний талбай нэрвэгдсэн зэрэг шалтгаанаар байгалийн ойн талбай 1,0 сая га-гаар хорогдсон тооцоо байна.

Харин энэ хугацаанд тармаг ой, огтолсон талбайн хэмжээ 10-15 дахин, шатсан ойн талбайн хэмжээ 3-4 дахин нэмэгдсэн

байна. Ер нь дээрх харьцуулсан дүнгээс харахад тармаг ой, шатсан ой, огтолсон талбай, ойжих талбай зэрэг гадны нөлөөнд өртсөн ойн талбайн хэмжээ байнга нэмэгдэж байгаа нь харагдаж байна. Монгол орны ой нь Төв Азийн эрс тэс уур амьсгалтай нөхцөлд ургадаг учир байгалийн жамаар нөхөн сэргэх чадавхиар нэн хязгаарлагдмал, түймэр, хөнөөлт шавьж болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд хялбархан өртөмтгий чанартай.

Манай орны ой 140 гаруй зүйлийн мод, сөөгөөс бүрдэх бөгөөд шинэс, нарс, хуш, гацуур, жодоо зэрэг нь шилмүүст мод, хус, улиас, улиангар, хайлаас, бургас, сөөг нь навчит мод гэж 2 үндсэн ангид хуваагдана. Ойг бүрдүүлэгч моддын эзлэх хувь хэмжээнээс харахад ойд зонхилогч гол мод нь шинэс байна.

Монгол орны ойг хамгаалалт, ашиглалтын хэлбэр, экологи-эдийн засгийн ач холбогдлыг нь харгалзан дараах 2 бүсэд ангилна. Үүнд:

1. Ашиглалтын бүсийн ой
2. Хамгаалалтын бүсийн ой

Монгол орны ойн экосистемд сөрөг нөлөөлдөг нэгэн хүчин зүйл нь ойн түймэр юм. Энэ бүс нутагт түймэрт өртсөн ойн талбай 125729 га байна. Олон удаагийн давтан түймрээс болж ой-ургамалжилт хөнөөгдөх, голын урсац алдагдах, уулын ойн хөрс элэгдэл, эвдрэлд орох, ой моддын галд тэсвэрлэх чадавхи доройтох зэрэг ойн орчин зүйд нөлөөлөх түүний сөрөг үр дагавар улам ихэслээ.

#### 4.1.2 Завхан аймаг



Хангай Хэнтийн их мужийн Хангайн мужид хамаарах ба Хангайн гол нуруу ерөнхийдөө баруун хойноос зүүн урагш сунаж тогтсон бөгөөд баруун талдаа Цэцэн уулаас зүүн талын Дэлгэрхаан уул хүртэл 700км үргэлжилнэ. Үнэмлэхүй дундаж өндөр нь 3000м бөгөөд хамгийн өндөр оргил Отгонтэнгэр уул 4031м, Улиастай хотоос зүүн тийш 56км-т оршино. Хангайн гол нуруунаас нилээн олон нурууд салбарлана.



Зураг 4.2 Завхан аймгийн нутаг

Хангайн нурууны гол салбар нь Идэрийн гол, Тэрхийн гол хоёрын хооронд байх Тарвагатайн нуруу юм. Энэ нь Дулаан хар гэдэг уулаас эхлэн зүүн хойш салбарласан нилээд өндөр нуруу бөгөөд хамгийн өндөр оргил нь Совдон уул/3240м/ юм. Тарвагатайн нуруунаас хойш Тэс, Дэлгэр мөрний савыг тусгаарласан баруунаас зүүн тийш сунаж тогтсон Булнай нуруу оршино.

Тус нутагт мөнх цэвдэгт тайгын хөрсний онцгой хэв шинж болох уулын ойн мөнх цэвдэгт бүдүүн ялзмагт хөрс зонхилох ба дотроо 2 дэд хэв шинжид хуваагдана. Үүнд:

- а/ уулын ойн мөнх цэвдэгт бүдүүн ялзмагт хэв шинжит хөрс
- б/ уулын ойн мөнх цэвдэгт бүдүүн ялзмагт хээржсэн хөрс

Уулын ойн мөнх цэвдэгт бүдүүн ялзмагт хэв шинжит хөрс гол төлөв хуурамч тайгын өвслөг хөвд, өвслөг бут сөөг, хөвдөн бүрхүүлтэй шинэсэн ойд тохиолдоно.

Завхан аймагт улсын томоохон үйлдвэрийн нэг болох Тосонцэнгэлийн мод боловсруулах үйлдвэр ажиллаж Говь-Алтай, Ховд, Увс, Баян-Өлгий зэрэг аймгуудын ард иргэд, албан байгууллагуудын хэрэгцээг мод, модон материал, зүсмэл бэлэн бүтээгдэхүүн, түлшний модоор хангаж үйлдвэрлэлээ явуулж байсан.


Тосонцэнгэлийн мод боловсруулах үйлдвэр нь мод бэлтгэж, тээвэрлэх ажлаа Их-Уул, Булнай сумдын нутаг дэвсгэрт явуулж байсан байна. Их-Уул, Булнай, Идэр, Тэлмэн сумд нь Завхан аймгийн модны гол нөөц бүхий сумдууд юм.

Ойн талбай, нөөц, модны төрлөөр /Хүснэгт 4.1/

| Д.д | Модны нэр | Талбай /мян.га/ | Нөөц /мян.м³/ | Эзлэх % |
|-----|-----------|-----------------|---------------|---------|
| 1   | Шинэс     | 426.6           | 55410.2       | 96,6    |
| 2   | Хуш       | 3.1             | 436.7         | 2,3     |
| 3   | Гацуур    | 6.7             | 941.9         | 1,0     |
| 4   | Улиангар  | 0.4             | 1.9           |         |
| 5   | Бургас    | 6.2             | 115.5         | 0,1     |
|     | Дүн       | 442.5           | 56906.3       | 100%    |


Завхан аймагт ойн ургаж буй далайн төвшний доод хязгаар 1800-1900м заримдаа голын сав дагуу 1600-1700м, дээд хязгаар нь 2500-2600м-т тохиолдоно. Тал хээр зонхилсон баруун,

баруун хойд зүгийн нутгаар ойн тархалт сийрэг 2-3-га-с 30-50 га хэмжээтэй төгөл төгөлөөр тархсан байна. Ой үүсгэгч үндсэн төрлийн мод нь шинэс, бага хэмжээний хуш ургана.



Завхан аймгийн ойн сангийн нийт талбай 778.4 мян.га бөгөөд байгалийн ойн 493.8 мян.га байна. Ойн талбай, нөөц нь шинэс -426.6 мян.га, 55410.2мм<sup>3</sup>, хуш -3.1 мян.га, 436.7 мм<sup>3</sup>, гацуур -6.7 мян.га, 941.9 мм<sup>3</sup>, улиангар -0.4 мян.га, 1.9 мм<sup>3</sup>, бургас -6.2 мян.га, 115.5 мм<sup>3</sup>, нийт талбайн 442.5 мян.га, наац нь 56906.3 м<sup>3</sup> байна. Тооцоогоор Завхан аймгийн ойн сангийн шатсан ойгоос 6,9 мян.м<sup>3</sup> түлшний мод, ашиглалтын бүсийн ойгоос 35,1 мян.м<sup>3</sup> түлшний мод, арчилгаа цэвэрлэгээний огтлолтоос 3,5 мян.м<sup>3</sup> түлшний мод, нийтдээ 45,5 мян.м<sup>3</sup> түлшний мод тус тус бэлтгэх боломжтой байна.


**4.1.3 Увс аймаг**



Ойн сангийн нийт талбай 185.5 мян.га, ойгоор бүрхэгдсэн талбай 139.6 мян.га, ойгоор бүрхэгдээгүй талбайн 160,2 га, Ойн талбайгаас шинэс -127.9 мян.га, 18413.1мм<sup>3</sup>, хуш 1.4 мян.га, 241.3 мм<sup>3</sup>, гацуур 0.2 мян.га, 18.6 мм<sup>3</sup>, хус 1.1 мян.га, 20.1мм<sup>3</sup>,улиас 5.9 мян.га, 459.0мм<sup>3</sup> ойн талбайн нийт-136.2 мян.га, 19152.1мм<sup>3</sup> байна.


#### 4.1.4 Баян-Өлгий аймаг

Ойн сангийн нийт талбай 42.9 мян.га , ойн талбай нь 39.1 мян.га Шинэс -30.4 мян.га, 3492.3 мм<sup>3</sup>, улиас -3.8 мян.га, 457.9 мм<sup>3</sup> байна.ойн талбайн 34.2 мян.га, 3950.2 мм<sup>3</sup> байна.



#### 4.1.5 Ховд аймаг

Ойн сангийн нийт талбай 644.3 мян.га заган ой ургадаг. Заган ой 241.4 мян.га. Аймгийн урд талаар заг тархан ургах бөгөөд хойт талаараа шинэс армаг тармаг байдалтай маш бага талбайд ургадаг. Шинэс, улиас бургас, бут, сөөг бүхий талбайн 40-иод мянган га талбайтай гэж үздэг. Шинэс ургасан газарт нарийвчилсан судалгаа хийгдээгүй болно. Иймд цаашид судалгаа зайлшгүй хийх шаардлагатай юм. Шинэс мод нь нутгийн баруун хойт хэсгээр өндөр уулын бэлээр тархан ургадаг юм. Ургах орчин маш муу бөгөөд нөхөн төлжилт удаан байдаг нь ажиглагддаг юм. Ховд голын дагуу цагаан бургас ургадаг.



#### 4.1.6 Говь-Алтай аймаг

Говь-Алтай аймгийн шинэсэн ой 8.8 мян.га ойн талбайн 8.6 мян.га үүнээс шинэс -6.1 мян.га, 474.2 мм<sup>3</sup>, улиас 36 га, 2.5 мм<sup>3</sup> байна. Говь-Алтай аймаг нь заган ойгоор улсын хэмжээнд хамгийн их тархан ургадаг бөгөөд заган ойн нийт талбай 1925.7 мян.га багаад үүнээс заган ойн ойгоор бүрхэгдсэн талбай 535.1 мян.га байна.

Баруун бүсийн ой: Хангайн ой-ургамалжилтын мужын –баруун ба төв Хангайн хошуу, Төв Азийн ой-ургамалжилтын мужын Монгол Алтайн хошуунд багтах бөгөөд байгалийн бараг бүх бүс бүслүүрийг төлөөлнө.Үүнд: Өндөр уулын бүслүүр, Уулын тайгын бүслүүр, Ойт хээрийн бүс, Хээрийн бүс тохилдоно. Баруун бүс нутаг нь далайн түвшинээс өндөрт өргөгдсөн уулархаг бүс нутаг буюу уур амьсгал эрс тэс, агаарын олон жилийн дундаж -1.9 -3.8С, хур тундасны жилийн дундаж нийлбэр 217-228мм байна.

Томоохон ус хагалбар ихтэй бөгөөд голуудын усны тэжээгч эх үүсвэр нь хурын ус 40-65% байдаг. урсгал хурдан зарцуулалт их юм. Хөрсний хэв шинж: уулын цэвдэг-тайга, ширэгт-тайга, нуга-ойн цэвдэг, цэвдэг бүдүүн ялзмагт хөрс зонхилно. Цэвдэг нь ой модон дор хадгалагдан бэрх хуурай хавар, зуны эхэн үед ой модыг хөрсийг чийгээр тэжээнэ.

#### 4.1.7 Ойн цэвэрлэгээ

Ойн цэвэрлэгээ хийх талбай – эхний ээлжинд: -Завхан аймагт 10391га, 373.6 мм<sup>3</sup>, Увс аймагт 930га, 37.2 мм<sup>3</sup> байна. 2008 онд: ойн цэвэрлэгээгээр Завхан аймагт8000 м3 хэрэглээний мод 100000м3 түлшний мод , Увс аймагт 3000 м3 хэрглээний мод, 37000 м3 түлшний мод бэлтгэх нөөцтэй гэж тооцоо гарсан байна. Энэ бүс нутагт ойн дагалт баялаг элбэг байдаг. Үүнд: Ойгоос жимс самар түүх, үр боргоцой, хүнсний мөөг, эмийн ургамал, түүхий эд, хүнсний ургамал, техникийн ургамал, түүхий эд, ангийн олзвор, олдвор, холтос хөвх бэлтгэх, шүүс давирхай авах, ан амьтан, шувуу, зөгий үржүүлэх, мал бэлчээх, өвс хадах зэрэг байна.

Энэ бүс нутагт 600 гаруй зүйл эмийн ургамал, 1000 гаруй зүйл тэжээлийн, 200 гаруй зүйл хүнсний, 200 гаруй зүйл техникийн ургамал ургадаг бөгөөд ихэнх хэсэг нь ой дотор байдаг.

Ой ашиглалт: Энэ бүс нутагт 1995 оноос өмнө Увс аймгийн Цагаанхайрхан, Завхан аймгийн Тосонцэнгэл суманд мод бэлтгэлийн ажил их хэмжээгээр хийж баруун бүс нутгийн хэрэгцээний болон түлшний модоор хангаж байсан юм. Харин 1990 –иод оны дундаас мод бэлтгэл зогсож бэлтгэл бараг хийхээ байсан юм. Жилд 20-30 мянган шоометр мод бэлтгэж байсан байна.

Баян-Өлгий аймагт 1960 оны сүүлээс эхлэн нэгдэл дундын үйлдвэр, модны үйлдвэр Алтай таван богд уулын өврөөс жилд 10 гаруй мянган шоометр модыг бэлтгэн ашигладаг байсан бөгөөд 1984 оноос эхлэн мод бэлтгэх ажлыг бүрэн зогссон юм. Одоо Баян-Өлгий, Увс, Завхан аймагт хулгайгаар мод бэлтгэх явдал үзэгдсээр байна. Баруун бүс нутагт ойг нөхөн сэргээх, ойжуулалт, ногоон хэрэм ургуулах талаар хийсэн ажлын одоогийн байдлыг доорх хүснэгтээр гаргаж харуулав.

Баруун бүсийн аймгуудын ойг нөхөн сэргээх, ойжуулах ажлын гүйцэтгэл / Хүснэгт 4.2/

| Д/д | Аймгийн нэр | 2003 оны гүйцэтгэл | 2004 оны гүйцэтгэл | 2005 оны гүйцэтгэл | 2006 оны гүйцэтгэл | 2007 оны гүйцэтгэл | 2008 оны гүйцэтгэл | 2009 оны Төлөвлөгөө |
|-----|-------------|--------------------|--------------------|--------------------|--------------------|--------------------|--------------------|---------------------|
| 1   | Баян-Өлгий  | 186                | 312                | 109                | 114                | 160                | 300                | 320                 |
| 2   | Говь-Алтай  | 74                 | 100                | 34                 | 50                 | 50                 | 100                | 120                 |
| 3   | Завхан      | 485                | 532                | 190                | 240                | 349                | 600                | 700                 |
| 4   | Увс         | 225                | 326                | 180                | 110                | 313                | 410                | 450                 |
| 5   | Ховд        | 190                | 235                | 197                | 75                 | 60                 | 360                | 380                 |
|     | Дүн:        | 1160               | 1505               | 710                | 589                | 932                | 1770               | 1970                |

Дээрх хүснэгтээс Баруун бүсийн нутагт 2003 онд 1160 га, 2004 онд 1505 га, 2005 онд 710 га, 2006 онд 589 га, 2007 онд 932 га талбайд ойг нөхөн сэргээх, ойжуулалтын ажлыг гүйцэтгэсэн байна. 2003-2007 онуудад нийт 6666 га талбайд хийсэн байна.

Баруун бүс нутагт Монгол оронд хэрэгжүүлж байгаа Ногоон хэрэм хөтөлбөрийн хэрэгжилтийг доорх хүснэгтэнд харуулав. Ногоон хэрэм байгуулах ажил баруун бүс нутагт 2005 оноос эхэлсэн бөгөөд одоо эхлэлийн шатандаа явж байна. Хамгийн гол нь ногоон хэрэм байгуулах ажил нь талбайг зөв сонгох, ямар ажил хийж гүйцэтгэх зэргийг тусган харуулсан талбайн зураг, төсөл байх хэрэгтэй юм.

Баян-Өлгий аймагт Ногоон хэрэм үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтээс /Хүснэгт 4.3/

| № | Он                  | Сумын нэр  | Гүйцэтгэсэн аж ахуйн нэгж | Талбай хэмжээ /га/ | Амьдралтын хувь | Нийт санхүүжилт /мян.төг/ |
|---|---------------------|------------|---------------------------|--------------------|-----------------|---------------------------|
| 1 | 2005                | Дэлүүн сум | ЗДТГ                      | 8                  | 80              | 7 040.0                   |
|   |                     |            | Иргэн З.Кебекеи           | 2                  | 80              | 1 760.0                   |
|   |                     |            | Иргэн А.Меденим           | 1                  | 95              | 880.0                     |
|   |                     |            | Дэлүүн сумын иргэд        | 1                  | 90              | 880.0                     |
|   |                     |            | Дүн                       | 12                 |                 | 10 560.0                  |
| 2 | 2006                | Дэлүүн сум | Алтанцөгц сумын ЗДТГ      | 18                 | 80              | 15 810.0                  |
|   |                     |            | Жаркын ТББ                | 6                  | 76.7            | 5 280.0                   |
|   |                     |            | Дүн                       | 24                 |                 | 21120.0                   |
| 3 | 2007                | Алтанцөгц  | Байгаль орчны алба        | 5                  | 76              | 4 400.0                   |
|   |                     | Дэлүүн     | Байгаль орчны алба        | 5                  | 85              | 4 400.0                   |
|   |                     | Дүн        |                           | 10                 |                 | 8 800.0                   |
| 4 | 2008 оны төлөвлөгөө | Дэлүүн     | Кэй Ти Эс ХХК             | 4                  |                 | 3520.0                    |
|   |                     | Өлгий      | Байгаль орчны алба        | 6                  |                 | 5280.0                    |
| 5 |                     |            | Дүн                       | 10                 |                 | 8 800.0                   |
| 6 |                     |            | Бүгд                      | 56                 |                 | 49 280.0                  |

Завхан аймагт Ногоон хэрэм үндэсний

хөтөлбөрийн хэрэгжилтээс /Хүснэгт 4.4/

| № | Он                  | Сумын нэр    | Гүйцэтгэсэн аж ахуйн нэгж | Талбай хэмжээ /га/ | Амьдралтын хувь | Нийт санхүүжилт /мян.төг/ |
|---|---------------------|--------------|---------------------------|--------------------|-----------------|---------------------------|
| 1 | 2005                | Ургамал      | Ургамал сумын ЗДТГ        | 10                 | 75              | 8 800.0                   |
|   |                     |              | Дүн                       | 10                 |                 | 8 800.0                   |
| 2 | 2006                | Улиастай     | Дядан ХХК                 | 7                  | 84              | 6160.0                    |
|   |                     | Завханмандал | Ээлтэй нутаг хоршоо       | 15                 | 78              | 13200.0                   |
|   |                     |              | Шилүүстэй сумын ЗДТГ      | 2                  | 77              | 1760.0                    |
|   |                     | Дүн          | 24                        |                    | 21120.0         |                           |
| 3 | 2007                | Завханмандал | Дядан ХХК                 | 10                 | 75              | 8 800.0                   |
|   |                     |              | Дүн                       | 10                 |                 | 8 800.0                   |
| 4 | 2008 оны төлөвлөгөө | Завханмандал | Дядан ХХК                 | 20                 |                 | 17 600.0                  |
|   |                     |              | Дүн                       | 20                 |                 | 17 600.0                  |
| 5 |                     |              | Бүгд                      | 64                 |                 | 56 20.0                   |

Ховд аймагт Ногоон хэрэм үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтээс /Хүснэгт 4.5/

|   | Он                  | Сумын нэр     | Гүйцэтгэсэн аж ахуйн нэгж  | Талбай хэмжээ /га/ | Амьдралтын хувь | Нийт санхүүжилт /мян.төг/ |
|---|---------------------|---------------|----------------------------|--------------------|-----------------|---------------------------|
| 1 | 2005                | Зэрэг         | Ховд сафари ХХК            | 10                 | 90              | 8 800.0                   |
|   |                     | Чандмань сум  | Үр жимс хоршоо             | 10                 | 88              | 8 800.0                   |
|   |                     |               | Ногоон байгууламж нөхөрлөл | 5                  | 92              | 4 400.0                   |
|   |                     |               | Уурхайн ЗГБХ нөхөрлөл      | 13                 | 87              | 11 440.0                  |
|   |                     | Дарви сум     | Байгаль орчны алба         | 7                  | 91              | 6 160.0                   |
|   |                     | Дүн           | 45                         |                    | 39 600.0        |                           |
| 2 | 2006                | Чандмань      | Үр жимс ХХК                | 10                 | 75              | 8 800.0                   |
|   |                     |               | Ховд сафари ХХК            | 20                 | 78              | 17 600.0                  |
|   |                     |               | Дүн                        | 30                 |                 | 26 400.0                  |
| 3 | 2007                | Цэцэг         | “Үр жимс” хоршоо           | 5                  | 90              | 4 400.0                   |
|   |                     | Мөст          |                            | 5                  |                 | 4 400.0                   |
|   |                     | Манхан        | “Ховд сафари” ХХК          | 15                 | 99              | 13 200.0                  |
|   |                     | Зэрэг         | “Ховд тур” ХХК             | 5                  | 86              | 4 400.0                   |
|   |                     | Зэрэг         | “Тээлийн төгөл” хоршоо     | 5                  | 75              | 4 400.0                   |
|   |                     | Чандмань      | “Бүдүүний өвөр” хоршоо     | 5                  | 84              | 4 400.0                   |
|   |                     |               | Дүн                        | 40                 |                 | 35 200.0                  |
|   | 2008 оны төлөвлөгөө | Манхан        | Үр жимс ХХК                | 10                 |                 | 8 800.0                   |
|   |                     | Манхан, Зэрэг | Ховд сафари ХХК            | 15                 |                 | 13 200.0                  |
|   |                     |               | Дүн                        | 25                 |                 | 22 000.0                  |
| 4 |                     |               | Бүгд                       | 140                |                 | 123 200.0                 |

Увс аймагт Ногоон хэрэм үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтээс /Хүснэгт 4.6/

| № | Он   | Сумын нэр    | Гүйцэтгэсэн аж ахуйн нэгж | Талбай хэмжээ /га/ | Амьдралтын хувь | Нийт санхүүжилт /мян.төг/ |
|---|------|--------------|---------------------------|--------------------|-----------------|---------------------------|
| 1 | 2005 | Чандмань     | Ургамал сумын ЗДТГ        | 12                 | 85              | 8 800.0                   |
|   |      |              | Дүн                       | 10                 |                 | 8 800.0                   |
| 2 | 2006 | Улиастай     | Дядан ХХК                 | 7                  | 84              | 6160.0                    |
|   |      | Завханмандал | Ээлтэй нутаг хоршоо       | 15                 | 78              | 13200.0                   |
|   |      |              | Шилүүстэй сумын ЗДТГ      | 2                  | 77              | 1760.0                    |
|   |      | Дүн          | 24                        |                    | 21120.0         |                           |
| 3 | 2007 | Нранбулаг    | “Бижийн булаг” хоршоо     | 5                  | 90              | 4 400.0                   |

|   |                     |            |                        |    |    |          |
|---|---------------------|------------|------------------------|----|----|----------|
|   |                     |            | “Увс байгаль” ХК       | 5  | 77 | 4 400.0  |
|   |                     |            | “Зургаан мичид” хоршоо | 5  | 90 | 4 400.0  |
|   |                     |            | Дүн                    | 15 |    | 13 200.0 |
| 4 | 2008 оны төлөвлөгөө | Завхан сум | “Бижийн булаг” хоршоо  | 10 |    | 8 800.0  |
|   |                     | Улаангом   | “Зургаан мичид” хоршоо | 5  |    | 4 400.0  |
|   |                     | Улаангом   | Хэт цах хоршоо         | 5  |    | 4 400.0  |
|   |                     | Улаангом   | Уран зурвас хоршоо     | 5  |    | 4 400.0  |
|   |                     | Улаангом   | МБОХХ-ны салбар зөвлөл | 5  |    | 4 400.0  |
|   |                     |            | Дүн                    | 30 |    | 26 400.0 |
| 4 |                     |            | Бүгд                   | 79 |    | 69 520.0 |

Говь-Алтай аймагт Ногоон хэрэм үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтээс /Хүснэгт 4.7/

| № | Он                  | Сумын нэр                  | Гүйцэтгэсэн аж ахуйн нэгж | Талбай хэмжээ /га/ | Амьдралтын хувь | Нийт санхүүжилт /мян.төг/ |
|---|---------------------|----------------------------|---------------------------|--------------------|-----------------|---------------------------|
| 1 | 2005                | Дэлгэр сум                 | Канал гуулин хоршоо       | 30                 | 90              | 26 400.0                  |
|   |                     |                            | Дүн                       | 30                 |                 | 26 400.0                  |
| 2 | 2006                | Дэлгэр сум                 | Канал гуулин хоршоо       | 15                 | 87              | 13 200.0                  |
|   |                     |                            | Аз-За ХХК                 | 5                  | 77              | 4 400.0                   |
|   |                     | Хөхморьт сум               | Их говийн нийгэмлэг       | 5                  | 78              | 4 400.0                   |
|   |                     | Тайшир сум                 | Баян-Улаан Тайшир ХХК     | 5                  | 77              | 4 400.0                   |
|   |                     |                            | Дүн                       | 30                 |                 | 26 400.0                  |
| 3 | 2007                | Дэлгэр сумын Гуулин тосгон | “Алтайн дээж” хоршоо      | 10                 | 87              | 8 800.0                   |
|   |                     | Тайшир                     | “Мон цульхир” ХХК         | 5                  | 83              | 4 400.0                   |
|   |                     |                            | Дүн                       | 15                 |                 | 13 200.0                  |
| 4 | 2008 оны төлөвлөгөө | Гуулин тосгон              | Алтайн дээж хоршоо        | 10                 | -               | 8 800.0                   |
|   |                     | Гуулин тосгон              | Канал гуулин хоршоо       | 10                 |                 | 8 800.0                   |
|   |                     | Гуулин тосгон              | Жимсгэнэ гуулин хоршоо    | 5                  |                 | 4 400.0                   |
|   |                     | Жаргалан                   | Уран байгаль хоршоо       | 5                  |                 | 4 400.0                   |
|   |                     | Бүгд                       |                           | 30                 |                 | 26 400.0                  |
| 5 |                     |                            | Бүгд                      | 75                 |                 | 92 400.0                  |

Баруун бүс нутагт ногоон хэрэм байгуулах ажлын хүрээнд Баян-Өлгий аймагт 2005-2007 онд 46 га, Завхан аймагт 44 га, Ховд аймагт 159 га, Говь-Алтай аймагт 75 га, Увс аймагт 49 нийт 373 га талбайд хийсэн байна. Энэ бүс нутагт одоогоор ойн аж ахуйн арга хэмжээ бусад арга хэмжээ авч явуулаагүй байна.

4.2 УСАН САН БҮХИЙ ГАЗАР

Баруун бүсэд Монгол Улсын бүх нуур тойрмын талбайн 59 хувийг эзэлж байна. Гол мөрний усан доорх талбайн 49 хувь, мөнх цас мөсөн голын доорх талбай 100 хувь энэ бүсэд оршино. Энэ бүсийн усны нийт нөөц Монгол Улсын усны нөөцийн 29%-ийг эзэлнэ. Гэтэд энэ бүсэд хүн ам, мал сүргийн усан хангамжийн хүрэлцээ муу байгаагийн улмаас олон сөрөг үр дагавар араасаа дагуулж байна. Баруун бүс нутагт усны бохирдол харьцангуй бага байгаа боловч, усны шинэ нөөц илрүүлэх, оновчтой ашиглах шаардлагатай байна. Цаашид бэлчээрийг усжуулах, усалгаатай газар тариалан эрхлэх, зарим төв суурин газрын ундны чанарыг сайжруулах зэрэг олон чухал асуудлыг шийдэх хэрэгтэй байна.

Баруун бүсэд 556 том жижиг гол, горхи бий. Тэдгээрийн нийлбэр урт 12479 км хүрнэ. Үүнээс 109 (3728км) нь Баян-Өлгий аймагт, 89 (1242км) нь Говь-Алтай аймагт, 189 (3139км) нь Завхан аймагт, 76 (2397км) нь Увс аймагт, 93 (1973км) нь Ховд аймагт тус тус байдаг. Нэг км<sup>2</sup> талбайд оногдох голын нийлбэр уртаар голын сүлжээний нягтшилыг илэрхийлдэг бөгөөд Баруун бүс дэх голын сүлжээний нягтшил харилцан адилгүй, Монгол Алтай, Хангайн нурууны нэн өндөрлөг хэсэг болон Увс нуурын хотгорт 0.2-0.3 км/км<sup>2</sup>, Монгол Алтайн зүүн ба зүүн

өмнөт, Хангайн баруун хэсгийн уулархаг нутгаар 0.1-0.2 км/км<sup>2</sup> байдаг бол Их Нууруудын хотгор, Алтайн чанад дахь нутагт 0.01-0.1 км/км<sup>2</sup> буюу түүнээс ч бага (<0.01км/км<sup>2</sup>) байна.

Баруун бүсийн голуудаас Баян-Өлгий аймгийн Даян нуураас урагш орших Хүрэмтэй гол (Хар Эрчис мөрний эх), Хангайн уулт өндөрлөгийн баруун хойт хажуугаас эх авч урсдаг Идэр гол цутгалуудынхаа хамт Хойт Мөсөн далайн ай савд багтах бөгөөд тэдгээрээс бусад бүх гол Төвийн Азийн гадагш урсгалгүй ай савын хотгоруудад усаа юүлдэг. Тухайлбал: Монгол Алтайн нурууны өврөөс эх авдаг Булган, Үенч, Бодонч гол, Алтайн араас эх авч урсдаг Буянт, Ховд, Цагаан, Согоо, Сагсай, Цэнхэр, Бөхмөрөн, Түргэн, Хархираа, Сагил гол, Хангайн нурууны баруун хойт хажуугаас эх авдаг Тэс, Хүнгүй, Завхан, түүний цутгал Богд, Чигэстэй голуудыг нэрлэж болно.



**Ховд гол-** Алтай Таван богд уулын зүүн өмнөт хажуугийн мөсөн голоос эх авч урсдаг Цагаан Ховд, Хар Ховд голоос эхэлж Хотон, Хоргон нууруудыг дамжин замдаа мөсөн голуудаас эх авсан Цагаан, Согоо, Сагсай, Бөхмөрөн, Өвдөг, Шивэр, Буянт зэрэг цутгал голуудаа нийлүүлэн Хар-Ус нуурт усаа юүлдэг. Ховд голын ус хураах талбай 58000км<sup>2</sup>, урт нь 516км юм.

*Зураг 4.7. Ховд аймаг.*

*Чоно Харайх голын орчинд*

Ховд голд Толбо, Даян, Тал, Ачит гэх мэт томхон нуурууд илүүдэл усаа нийлүүлдэг. Гольдиरोлын өргөн уруудах тутам нэмэгдсээр 80-130м хүрэх ба гүн нь 1.5-3м хүрнэ. Мөнх цас, мөсөн голын хайлсан усаар голчлон тэжээгдэх тул голын урсац 6-7 дугаар сард хамгийн их хэмжээндээ хүрч зуны турш усны түвшин, зарцуулга төдий л буурдаггүй онцлогтой. Ховд голын жилийн дундаж урсац Өлгий орчимд 58м<sup>3</sup>/сек, Баяннуур сумын дэргэд 63.2м<sup>3</sup>/сек, Мянгад сумын орчим 90 м<sup>3</sup>/сек хүрдэг ба хамгийн их зарцуулга 789м<sup>3</sup>/сек хүрч байжээ.

Ховд гол адаг хэсэгтээ 90 км орчим талархаг газраар урсаж Хар-Ус нуурт цутгахдаа маш олон салаа садарга үүсгэдэг.

**Булган гол-** Монгол Алтайн нурууны өмнө хажуугаас эх авч Монгол улсын нутагт 268км урт газрыг туулж БНХАУ-ын нутагт Өрөнгө голтой нийлж улмаар Өлөнгөр нуурт цутгана. Монголын нутаг дахь ус хураах талбай нь 9180км<sup>2</sup> хүрэх бөгөөд түүний цутгалуудаас Улиастай, Түргэн, Баян голыг нэрлэж болно. Булган голын гольдирил ихэнхдээ нарийхан, урсгал нь ширүүн байснаа баруун тийшээ тохойрон урсах үедээ урсгалын хурд саарч, салаа татуургууд үүсгэх ба үндсэн гольдирил нь 10-60м хүртэл өргөн болно. Голын усны гүн 0.5-1.5м, зарим цүнхээл тохойд 4м гүнзгий байна. Голын жилийн дундаж урсац Баян-Өлгий аймгийн Булган сумын дэргэд 6.1м<sup>3</sup>/сек, Ховд аймгийн Булган сумын орчим 9.6м<sup>3</sup>/сек байна.

**Бодонч, Үенч гол-** Монгол Алтайн Мөнх-Хайрхан уулын өвөр орчмоос эх авч гүнзгий хавцал дундуур урссаар Баруун Хуурайн хотгор руу ормогцоо газар доогуур шингэж замхардаг. Үенч голын ус хураах талбай 2841км<sup>2</sup>, урт нь 132км, жилийн дундаж урсац 1.24м<sup>3</sup>/сек, Бодонч голын ус хураах талбай 6104км<sup>2</sup>, урт нь 167км, жилийн дундаж урсац 1.26м<sup>3</sup>/сек байна.

Дээрх голуудаас гадна Ховд голын цутгал Буянт (урт нь 195км), Монгол Алтайн нурууны өвөр хажуугаас эх авч Баруун Хуурайн хотгор руу урсаж шингэдэг Барлаг (60км), Бажийн гол (70км), Хархираа уулаас эх авч Увс нуурт цутгадаг Хархираа гол (100км), Монгол Алтайн Мөнх-Хайрхан уулын зүүн урд сугаас эх авч Зэргийн хоолой руу урсаж газар доогуур шингэдэг Дунд Цэнхэрийн гол (135км) зэрэг томхон голуудыг дурьдаж болно.

Монгол Алтайн голуудын (Ховд, Сагсай, Буянт, Хархираа г.м.) жилийн урсацын 51-63%-ийг мөнх цас, мөсөн голын хайлсан ус, 31-40%-ийг ул хөрсний ус, 3-12%-ийг хур борооны ус бүрдүүлдэг тул усны горимын хувьд хавар-зуны шар усны үертэй байдаг онцлогтой. Монгол




Алтайн уулст цасны усны нөөц жилд 200-400 мм буюу түүнээс илүү, харин нэг хоногт орох хур борооны ус дунджаар 16-20 мм, хамгийн их нь 38-45 мм хүрнэ. Монгол Алтайн нурууны голуудад хавар 4-р сарын дунд үеэс эхэлсэн хаврын шар усны үер зуны шар усны ба хур борооны үертэй залгаж үргэлжилсээр 9-р сарын дунд үеээр дуусдаг байна.

Ийнхүү 120-150 хоног үргэлжилдэг их устай үерлэлтийн үеийн дараагаар голуудын хамгийн бага устай намрын гачиг үе залгаж 20-30 хоног үргэлжилнэ. Энэхүү гачиг үеийн урсацын модуль 0.1-1.5л/сек.км<sup>2</sup> байна. Намар 11-р сарын эхээр голууд хөлдөж эхлэх ба жилд дунджаар 140-180 хоног мөсөн бүрхүүлтэй байна. Голууд хадаалсны дараах мөсний зузаан дунджаар 20см байх ба хамгийн хүйтэн 1-2-р сард мөсний зузаан 80-120см хүрэх ч бий. Голуудын мөс адаг орчмоороо 3-р сарын сүүлчээс 4-р сарын эхний арав хоногт гэсч задардаг бол голын эхэн хэсгээр 4-р сарын сүүлчээс 5-р сарын дунд хүртэл мөс нь гэсэж дуусдаг байна. Монгол Алтайн голууд хамгийн цэвэр цэнгэг устай. Усны эрдэсжилтийн олон жилийн дундаж 117мг/л (Сагсай гол)-аас 302.8мг/л (Үенч гол) хүртэл хэлбэлзэнэ. Усны эрдэсжилтийн хэмжээ зарим голд (Ховд) өөрчлөлт багатай (38.3-121.0мг/л) байхад Үенч голд 103.8-883.3мг/л, Буянт голд 31.0-843.7мг/л хүртэл өөрчлөгдөж хэлбэлзэл ихтэй байдаг. Химийн найрлагын хувьд гидрокарбонатын ангид хамрагдах зөөлнөөс дунд зэрэг хатуулагтай ус давамгайлна.

Хангайн нурууны баруун хойт хажуугаас эх авч урсдаг хэдэн гол Завхан аймаг болон Их Нууруудын хотгор, Увс нуурын хотгорын зүүн хагасыг усаар хангадаг. Эдгээр Хангайн голуудын тухай товч өгүүлье.

**Завхан гол** - Отгонтэнгэр уулаас зүүн тийш Хангайн гол өндөрлөгийн өврөөс эх авсан Буянт, Шар-Усны гол хоёрын бэлчирээс эхэлж Хангайн уулт өндөрлөгийг баруун хормойгоор нь эмжээрлэн баруун хойшоо урсаж Айраг нуураар дамжин Хяргас нуурт цутгадаг. Голын урт нь 808км, ус хураах талбай нь 71210км<sup>2</sup> юм. Завхан гол эхэн хэсэгтээ өндөр уулын хавцал, хүрмэн чулуун бэгэлцэг дундуур урсаж гольдиरोлын нь өргөн 30-60м, гүн нь 0.6-2.0м орчим байдаг бол дунд хэсэгтээ Тайшир сумаас нэлээн доош Борх (Шураг) голын цутгал хүртэл 3-8 салаа гольдирилтой болж хөндий нь өргөсөн Ажиг, Эрээн нуурын орчимд үлэмж газрыг намагжуулна. Борх (Шураг) голын цутгалаас доош голын өргөн 100-350м хүртэл өргөсөж, гүн нь 0.7-1.5м хүрнэ. Тэндээс цааш Монгол Элсний манхан дундуур Айраг нуур хүртэл хэдэн зуун км урсахдаа Завхан голын урсацын 16.7% -нь алдагдах боловч зүүн гараас Татхан-Тээлийн хоолойгоор Хар-нуурын илүүдэл ус орж ирж нийлдэгийн ачаар голын урсац сэргэж урсгал нь саардаггүй байна. Завхан голын жилийн дундаж урсац Гуулингийн услалтын систем орчимд 12м<sup>3</sup>/сек, Дөрвөлжин сумын орчимд 15.6м<sup>3</sup>/сек, Айраг нуурт цутгахдаа 27.6м<sup>3</sup>/сек болж нэмэгдэх бөгөөд усны хамгийн их зарцуулга 522м<sup>3</sup>/сек хүрч байжээ.

Завхан голын томоохон цутгалууд болох Богд (Борх) голын ус хураах талбай 1520км<sup>2</sup>, урт нь 92км, жилийн дундаж урсац 7.61м<sup>3</sup>/сек, Чигэстэй голын ус хураах талбай 1050 м<sup>2</sup>, урт нь 28км, жилийн дундаж урсац 4.85м<sup>3</sup>/сек байна.



Зураг 4.8. Завхан аймаг. Завхан гол

**Хүнгүй гол** -Их Нууруудын хотгорын зүүн зах тушаа Бор Хярын элсний эхэн хэсгээс эх авч уг элсэн тарамцагийг урдуур нь эмжээрлэн урсаж Айраг нуурт цутгадаг өвөрмөц голын нэг юм. Уг голын ус хураах талбай 21693км<sup>2</sup>, урт 196км, жилийн дундаж урсац 2.34м<sup>3</sup>/сек байна. Хүнгүй гол бүхэлдээ заримдаг цөлийн бүсэд оршдог боловч жилийн турш урсац тасардаггүй

явдал уг голын тэжээлд хур борооноос гадна ул хөрсний ус чухал үүрэг гүйцэтгэдгийг нотолж байна. Тухайлбал, Бор Хярын элсэнд боогдож тогтсон Баян, Гүн, Улаагчны Хар нуурын ус элсэн ул хөрсөн дотуур шүүрч нэвчих замаар Хүнгүй голд усаа нийлүүлдэг аж.

**Тэс гол** - Булнайн нурууны арын жижиг голууд бүхий намгархаг газраас эх авч баруун тийш урсахдаа Бөөрөг Дэлийн элсний зүүн үзүүрээр хойшоо улсын хилээс гарч ОХУ-ын нутгаар урсаж байгаад дахин баруун тийшээ эргэж Увс нуурт цутгадаг. Энэ голын урт 568км, ус хураах талбай 33358км<sup>2</sup> юм. Тэс голд Тагнын нурууны өврөөс эх авсан олон гол цутгах тул адагтаа ус ихтэй болно. Үндсэн голын гольдирул эхэн хэсэгтээ 15-60м, урсгалын дунд хэсэгт 40-120м, адагтаа 200м хүрч өргөснө. Тэс голын жилийн дундаж урсац Завхан аймгийн Баянтэс сумын орчим 14.9м<sup>3</sup>/сек байснаа Увс нуурт цутгахдаа 60м<sup>3</sup>/сек болж эрс нэмэгддэг. Тэс гол Увс нуурын усны орлогын 57.4%-ийг бүрдүүлдэг.

**Идэр гол** - Хангайн нурууны ноён оргил Отгонтэнгэр уулын араас эх авч Тарвагатай, Булнайн нурууны хоорондох нэлээн давчуу хөндийгөөр зүүн тийш урсана. Голын урт 452км бөгөөд Баруун бүсийн Завхан аймгийн нутгаар 240 орчим км урсаж өнгөрнө. Голын гольдирул Тосонцэнгэл сумын төв хүртэл ихээхэн тахирлаж хэд хэд салаалдаг тул тэгтлээ өргөн биш, салаа нь 10-15м, үндсэн гол нь 40-60м өргөн байна. Харин Тосонцэнгэлээс доош салаалах нь багасч голын өргөн 80-100м, усны гүн 0.7-2м болно. Тарвагатайн нурууны араас эх авсан Хожуул, Зарт, Дээд-Доод Цэцүүх, Хөнжил зэрэг голууд Идэр голд цутгаж түүний усны горимд нөлөөлнө. Жилийн дундаж урсац Зүрх багт 36.4м<sup>3</sup>/сек, голын адагт 54.1м<sup>3</sup>/сек хүрнэ. Зуны үер борооны үеийн хамгийн их зарцуулга 131м<sup>3</sup>/сек, хаврын шар усны үерийн хамгийн их зарцуулга 228м<sup>3</sup>/сек хүрч байжээ.

Дээр дурьдсан Хангайн голуудын жилийн урсацын 25-35%-ийг цасны хайлсан ус, 15-30%-ийг ул хөрсний ус, 45-55%-ийг хур борооны ус бүрдүүлнэ. Иймээс Хангайн голууд нь усны горимын хувьд хаврын шар усны ба зуны хур борооны үертэй голууд юм. Хаврын шар усны урсац бүрдэхэд цас чухал үүрэгтэй. Хангайн нурууны өндөрлөг хэсгээр жилд дунджаар 140-150 хоног цасан бүрхүүлтэй байх ба цасны нөөц ус Хангайн нурууны хойт хажуугаар 20-30мм, өндөрлөг хэсгээр 60-80мм байна. Цасан бүрхүүл 4-р сарын эхээр задарч 35-40 өдөрт хайлж дуусах тул энэ үед голуудын шар усны үер болдог. Нэг хоногт 40-120мм буюу түүнээс их хэмжээтэй бороо орсон тохиолдолд голуудад хур борооны үер үүсдэг ажээ. Хангайн нурууны баруун хойт хажууд ихэвчлэн 7-р сарын дунд үеэс 8-р сарын дунд үе хүртэл аадар бороо байн байн орж нэг хоногт орсон борооны хамгийн их хэмжээ 75-110мм хүрдэг тул энэ үед голууд хур борооны усаар үерлэдэг байна. Шар усны үерийн төгсгөлөөс зуны хур борооны үерийн эхлэл хүртэл зуны гачиг үе үргэлжилнэ. Дараа нь зуны хур борооны үерийн төгсгөлөөс голын ус хөлдөж эхлэх хүртэл намрын гачиг үе болдог. Ийнхүү Хангайн голуудад дулааны улирлын 2 удаагийн гачиг үе нийтдээ 50-80 хоног үргэлжилдэг байна. Ихэнх голуудад 10-р сарын дундуур мөсний үзэгдэл эхэлж 11-р сарын дундуур хадаалж мөсөн бүрхүүл тогтоно. Хавар 4-р сарын сүүлчээр голууд гэсч цэлмэнэ. Ийнхүү жилд 160-180 хоног голуудад өвч мөсөн бүрхүүл тогтож, мөсний нь зузаан 0,5-1,2м, зарим хүйтэн өвөл 2,5-3м хүрэх ч бий. Жижиг голууд ёроолдоо тултал хөлдөж урсацгүй болдог. Голуудын ус маш цэнгэг, ерөнхий эрдэсжилтийн дундаж хэмжээ 162мг/л (Идэр гол) –аас 268,5мг/л (Тэс гол) хүртэл хэлбэлзэх ба химийн найрлагын хувьд гидрокарбонатын ангид хамрагдах зөөлөн устай.

Баруун бүс нуур олонтой. 0,1км<sup>2</sup> (10га) буюу түүнээс дээш талбайтай 616 нуур бий. Тэдгээр нууруудын нийлбэр талбай 9679,5км<sup>2</sup> хүрнэ. Үүнээс Баян-Өлгий аймагт 264 (нийлбэр талбай нь 521,8км<sup>2</sup>), Говь-Алтай аймагт 49 (130,3км<sup>2</sup>), Завхан аймагт 96 (552,6км<sup>2</sup>), Увс аймагт 123 (5639,9км<sup>2</sup>), Ховд аймагт 84 (2834,9км<sup>2</sup>) нуур байдаг. Эдгээр нуурын дийлэнх олонхи нь цэнгэг устай тул хүн амын ундны хэрэгцээг хангахад чухал ач холбогдолтой. Нуурт хотгоруудыг гарал үүслээр нь тектоникийн, мөсөн голын, гол- хөндийн, салхин хуримтлалын гэх мэтээр ялгадаг.

Тектоникийн гаралтай томоохон эрдэст нуурууд гэвэл: Увс аймгийн Увс (3350км<sup>2</sup> талбайтай, 22м гүн), Хяргас (1406.8км<sup>2</sup>, 40-92м), Үүрэг (327,6км<sup>2</sup>, 20-42м), Намирын Хар-Ус (62.6км<sup>2</sup>, 4-8м), Шаазгай (8,3км<sup>2</sup>), Цавдан (6,1км<sup>2</sup>), Ховд аймгийн Дөргөн (305км<sup>2</sup>, 27м), Цэцэг (17,7км<sup>2</sup>, 1,5м), Зэрэгийн Цагаан (5,8км<sup>2</sup>, 1,5м), Зүүн хоолой (5,8км<sup>2</sup>), Цагаан (1.4км<sup>2</sup>), Дарви сумын Цагаан (3,3км<sup>2</sup>), Баян-Өлгий аймгийн Баян (7,6км<sup>2</sup>), Говь-Алтай аймгийн Ихэс (19,2км<sup>2</sup>), Хулма (8,5км<sup>2</sup>), Тонхил (6,2км<sup>2</sup>, 1,6м), Шаргын Цагаан (15,7км<sup>2</sup>), Бигэр (7,4км<sup>2</sup>), Хутаг (8,1км<sup>2</sup>), Буур (10,6км<sup>2</sup>), Алаг (6,2км<sup>2</sup>), Тайган (4,1км<sup>2</sup>), Завхан аймгийн Тэлмэн (194км<sup>2</sup>, 27м), Ойгон (61,3км<sup>2</sup>, 8м), Бүст (21,9км<sup>2</sup>, 12м), Нөмрөг сумын Холбоо (14км<sup>2</sup>, 6м), Хөдөө (7,4км<sup>2</sup>, 7м), Сантмаргац сумын Холбоо (6,5км<sup>2</sup>, 2,5м), Цагаан (1,9км<sup>2</sup>), Цэгээн (7,7км<sup>2</sup>, 8м), Хаг (7,1км<sup>2</sup>, 2,8м) зэрэг нууруудыг дурьдаж болно. Харин тектоникийн гаралтай томоохон цэнгэг устай нуурууд гэвэл: Увс аймгийн Баян (30,8км<sup>2</sup>, 27м), Ачит (296, км<sup>2</sup>, 5м), Айраг (143,3км<sup>2</sup>, 10м),

Ховд аймгийн Хар-Ус (1852км<sup>2</sup>, 4,5м), Хар (575км<sup>2</sup>, 7м), Баян-Өлгий аймгийн Дөрөө (14,6км<sup>2</sup>, 14,5м), Булган сумын Баян (4,7км<sup>2</sup>), Их хаг (5,4км<sup>2</sup>), Могойтын эхний Хар (6,3км<sup>2</sup>), Дунд Цагаан (1,2км<sup>2</sup>), Цэнгэл сумын Хар (14,2км<sup>2</sup>, 38м), Нуурт Нуур (5,6км<sup>2</sup>), Цүнхэл (3,9км<sup>2</sup>) зэргийг нэрлэхэд хангалттай.

Мөсөн голын гаралтай нуурууд бүгд цэнгэг устай байх ба тэдгээрээс нэрэлбэл: Баян-Өлгий аймгийн Толбо (84км<sup>2</sup>, 12,6м), Хотон (50,1км<sup>2</sup>, 58м), Хоргон (71,0км<sup>2</sup>, 28м), Даян (67,2км<sup>2</sup>, 4,5м), Тал (31,9км<sup>2</sup>, 8,9м), Толбын Бага (3,5км<sup>2</sup>), Тугал (4,3км<sup>2</sup>), Дэлүүн сумын Чигэртэй (3,8км<sup>2</sup>), Алтай сумын Чигэртэй (5,3км<sup>2</sup>), Сагсайн голын Чигэртэй (2,1км<sup>2</sup>), Хулагаш (6,4км<sup>2</sup>), Хойт Бардам голын Хар (4,7км<sup>2</sup>), Сордог (Хар) нуур (7,8км<sup>2</sup>), Хоромдог (2,7км<sup>2</sup>), Хөх голын нуур (3км<sup>2</sup>), Онхот (3,2км<sup>2</sup>), Сагсаг (Баян) нуур (2,8км<sup>2</sup>), Бөөрөгийн Хар (2,6км<sup>2</sup>), Завхан аймгийн Хөх (11,0км<sup>2</sup>, 4,3м), Цагаан (3,1км<sup>2</sup>, 28м), Дуут (0,8км<sup>2</sup>), Нэргүй (2,1км<sup>2</sup>), Оломт (1,7км<sup>2</sup>), Таг (1,1км<sup>2</sup>), Онон (1,2км<sup>2</sup>) нуур зэрэг болно.

Салхины үйл ажиллагаагаар нүүж хурсан элсэн тарамцагуудын дундах хотгор хонхруудад боогдож тогтсон салхины хуримтлалын гаралтай нуурууд цөөнгүй байдаг. Жишээ нь: Бор Хярын элсний хаяагаар тогтсон Хүнгүй Хар буюу Баян (64,2км<sup>2</sup>, 50м), Улаагчины Хар (84,5км<sup>2</sup>, 47м), Бага нуур (6,9км<sup>2</sup>, 17м), Бөөрөг Дэл элсний ард орших Дөрөө (73км<sup>2</sup>) нуур, Увсын Зүүнговь сумын Бага нуур (2,6км<sup>2</sup>), Завхан голын хөндий дэх Эрээн нуур (4,0км<sup>2</sup>) зэрэг цэнгэг устай нууруудаас гадна Монгол элсний захаар орших Завханы Дөрвөлжин сумын Бага нуур (7,6км<sup>2</sup>), Бор-Хярын элсний ар хормойд орших Гүн нуур (2,8км<sup>2</sup>), Говь-Алтайн Хөхморьт сумын Сангийн Далай (15,5км<sup>2</sup>, 3,8м) зэрэг шорвог нуурууд ч бий.

Гол-хөндийн гаралтай томоохон нууруудын тоонд Хяргас нуурын урдаас залгаж орших цэнгэг устай Айраг нуур (143,3км<sup>2</sup>, 10м), Хар нуур, Дөргөн нуур хоёрыг холбосон цэнгэг устай Ногоон нуур (26,7км<sup>2</sup>, 2м), Ачит нуурын өмнөх цэнгэг устай Усан-Хоолойн нуур (4,5км<sup>2</sup>), Увс аймгийн Завхан сумын нутаг дахь шорвог устай Сангийн-Далай нуур (12км<sup>2</sup>) багтана. Үүнээс гадна Ховд голын адаг-олон салаа садраануудын дунд 20 орчим нуур, Завхан голын адагт 10-аад жижиг нуур, мөн Хархираа, Түргэн голын адгаар ч хэдэн нуур бий.

Цөмрөл-нуралтын гаралтай нуурууд олон жилийн цэвдгийн гэсэлтээс үүссэн дулааны хөндийлжийн хонхорт, мөн усанд уусамтгай шохойн чулуу, давсархаг хурдастай газраар тохиолдоно. Тийм цөмрөлтийн гаралтай хонхорт тогтсон нууруудаас Завхан аймгийн Түдэвтэй сумын нутаг дахь Хулгана (1,5км<sup>2</sup>, 3,5м), Зүүн Улаагчин (2,0км<sup>2</sup>, 3,5м), Баян-Өлгий Толбо сумын нутаг дахь Хонгор-Өлөнгийн нуурууд (0,2-0,7км<sup>2</sup>), Ногоон нуур сумын нутаг дахь Их-Цагаан (6,1км<sup>2</sup>), Говь-Алтайн Чандмань сумын нутаг дахь Хутаг (8,1км<sup>2</sup>), Олгой (1,9км<sup>2</sup>), Бага нуур (1,7км<sup>2</sup>) зэрэг нууруудыг дурьдаж болно.

Нуурын усны эрдэсжилтийн хувьсал өөрчлөлтийн байдлыг 2 эрдэст нуур (Увс, Хяргас), 2 цэнгэг нуурын (Хар-Ус, Хар) жишээгээр авч үзье. Увс нуурын ерөнхий эрдэсжилт ус ихтэй жил 7,8г/л байдаг бол ус багатай жил 21г/л хүртэл нэмэгдэж дунджаар 13,4г/л байх ба химийн найрлагын хувьд хлорт натрийн давс зонхилно. Хяргас нуурын эрдэсжилт ус ихтэй жил 3,5г/л, ус багатай жил 10,3г/л, олон жилийн дунджаар 8,4г/л байх ба химийн найрлагын хувьд гидрокарбонат- хлорт натрийн давс давамгайлна. Хар-Ус нуурын усны эрдэсжилт ус ихтэй жил 74мг/л, ус багатай жил 444мг/л, дунджаар 242-348мг/л, химийн найрлагын хувьд гидрокарбонатын ангийн кальцийн бүлгийн цэнгэг ус зонхилно. Хар нуурын эрдэсжилт ус ихтэй жил 231мг/л, ус багатай жил 275мг/л хүрч ерөнхийдөө тогтвортой байх ба химийн найрлагын хувьд гидрокарбонатат кальци, магнийн давс зонхилдог.

Нуурууд бол ундны болон хөдөө аж ахуйн усан хангамж, агнуур-спорт, аялал жуулчлал, эрчим хүч, эрдэс түүхий эд, рекреацийн ач холбогдол ихтэй байгалийн онцгой өвөрмөц экосистем юм.

Монгол оронд 262 уулын том жижиг мөсөн гол байдгаас 261 нь Баруун бүсийн өндөр уулст дунджаар 3490м-ээс дээш үнэмлэхүй өндөрт байрлах ба тэдгээрийн нийлбэр талбай 658,7км<sup>2</sup> хүрнэ. Мөсөн голуудын мөсний зузаан хамгийн нимгэн газраа 4,6м, хамгийн зузаан газраа 185м, дунджаар 30,3м байх ба мөсний нөөц усны нийт хэмжээ 62,5км<sup>3</sup> хүрнэ. Талбайн хэмжээгээр нь авч үзвэл 1км<sup>2</sup>-аас их талбайтай мөсөн гол 89, харин 4км<sup>2</sup>-аас дээш талбайтай мөсөн гол 36 байна. Мөсөн голуудын тархалтыг харвал Алтай Таван Богдын бүлэг уулст 88 мөсөн гол, нийлбэр талбай нь 182км<sup>2</sup>, Даян нуураас баруун тийшэх Өндөрхайрханы бүлэг уулст 40 мөсөн гол (43,3км<sup>2</sup>), Цэнгэл Хайрханы уулст 20 мөсөн гол (25км<sup>2</sup>), Цамбагаравын уулст 5 мөсөн гол (115,9км<sup>2</sup>), Сагсай голын эх Тахилт Дөш уулын оргилд 36 мөсөн гол (30,8км<sup>2</sup>), Мөнххайрханы уулст 13 мөсөн гол (77,2км<sup>2</sup>), Цаст Богд-Сутай Хайрханд 5 мөсөн гол (23,2км<sup>2</sup>), Их Түргэний уулст 27 мөсөн гол (39,4км<sup>2</sup>), Хархираа-Түргэний уулст 26 мөсөн гол (116,7км<sup>2</sup>), Отгонтэнгэр ууланд 1 мөсөн гол (0,3км<sup>2</sup>) тус тус байна. Мөсөн голуудыг

орших хотгор гүдгэрийн нөхцлөөр нь 1) Хөндийн, 2) Уулын хажуу, хунхын, 3) Уулын хавтгай оройн мөсөн гол гэж гурав ангилдаг. Хөндийн мөсөн голын хэвшинжид нийт мөсөн голын 9,2%-нь хамрагдах бөгөөд түүнээс хамгийн том нь Алтай Таван Богд ууланд байдаг Цагаан голын (буюу Потанины) мөсөн гол юм. Энэ мөсөн гол Хүйтэн уулын оргилоос (4374м) доошоо уруудаж 2850м-ийн түвшинд хүртэл 14км урт үргэлжилж 47,2км<sup>2</sup> талбайг эзэлнэ. Үүнээс гадна Түргэн уулын Цагаан Дэглийн мөсөн гол, бас Александрын мөсөн гол энэ хэвшинжид багтдаг. Уулын хажуу, хунхын мөсөн голын хэвшинжид нийт мөсөн голын 87%-нь хамрагдана. Энэ хэвшинжийн тод жишээ гэвэл Мөнххайрхан уулын Хунхын мөсөн гол, Цагаан Бөөрөгийн мөсөн гол юм. Уулын хавтгай оройн мөсөн гол Цамбагарав ууланд тод илрэх бөгөөд энэ хэвшинжийн мөсөн гол нийт мөсөн голын 3,8%-ийг хамарна.

Дэлхий нийтийн дулаарлын үйл явцын нөлөөгөөр мөсөн голын хэмжээ жилээс жилд багасах хандлага ажиглагдсаар байна. Жишээлбэл: Мөнххайрхан, Цамбагарав, Таван Богдын мөсөн голуудын шугаман хэмжээс жилд дунджаар 3-12м-ээр багасч байгааг судлаачид тэмдэглэжээ. Түүнчлэн сүүлийн 55 жилийн хугацаанд Хархираа уулын мөсөн голын талбай 14,05км<sup>2</sup> –аар, Түргэн уулынх 8,28км<sup>2</sup>-аар тус тус багассан болохыг тогтоожээ. Мөсөн голын энэхүү өөрчлөлтийг тогтмол хянах, түүний үр дагаварыг нарийвчлан судлах явдал маш чухал.

Эцэст нь тэмдэглэж хэлэхэд газрын доорхи ба мөсөн голын усны нөөц хангалттай их байдаг боловч удаан хугацаанд нөхөн сэлбэгдэх учраас ашиглаж болох нөөцийн хэмжээ тун бага юм. Харин голын ус богино хугацаанд, дунджаар 20 хоног тутам нөхөгддөг учраас ашиглахад нэн тохиромжтой.

Баруун бүсийн бүх голын усны нийт нөөц жилд дунджаар 7,908км<sup>3</sup> бөгөөд үүнээс Баян-Өлгий аймагт 2,39км<sup>3</sup>, Говь-Алтай аймагт 0,058км<sup>3</sup>, Завхан аймагт 3,16км<sup>3</sup>, Увс аймагт 1,20км<sup>3</sup>, Ховд аймагт 1,10км<sup>3</sup> ус оногдоно. Энэхүү голын усны нийт нөөцөөс ашиглаж болох нөөц нь Баян-Өлгийд 0,29км<sup>3</sup>, Говь-Алтайд 0,01км<sup>3</sup>, Завханд 0,20км<sup>3</sup>, Увст 0,12км<sup>3</sup>, Ховдод 0,19км<sup>3</sup> байх ба гадаргын усны нөөцөөр хамгийн хомс нь Говь-Алтай аймаг юм.

Баруун бүс нь нуур, тойром, гол мөрнөөр харьцангуй элбэг бөгөөд ялангуяа Монголын томоохон нууруудын ихэнх нь энд оршдог. Ховд, Завхан, Буянт, Тэс, Идэр зэрэг томоохон гол, Увс, Хяргас, Хар ус, Дөргөн, Хар нуур, Ачит зэрэг томоохон нуур энэ бүсийн нутагт байдаг тул усны сан бүхий газрын талбай нь бүсийнхээ нийт нутаг дэвсгэрийн 2.3 хувийг эзэлдэг. Өрнөд бүсийн усны нийт нөөц Монгол улсын усны нөөцийн 29%-ийг эзэлнэ. Усны нөөцийн дийлэнхи хувь нь Баян-Өлгий, Завхан аймгийн нутагт байх бөгөөд хамгийн бага усны нөөцтэй аймаг нь Говь-Алтай аймаг юм. Харин Говь-Алтай аймагт газрын доорхи усны нөөц нилээд бий.

Баруун бүсийн аймгуудын усны нөөц / Хүснэгт 4.8 /

| Аймаг      | Усны нийт нөөц | Үүнээс газрын доорхи | Өрнөд бүсийн усны нөөцөд эзлэх % |
|------------|----------------|----------------------|----------------------------------|
| Баян-Өлгий | 2.896          | 0.53                 | 30.55                            |
| Говь-Алтай | 0.809          | 0.20                 | 8.53                             |
| Завхан     | 2.932          | 0.47                 | 30.93                            |
| Увс        | 1.212          | 0.11                 | 12.79                            |
| Ховд       | 1.630          | 0.12                 | 17.20                            |
| Өрнөд бүс  | 9.479          | 1.43                 |                                  |

Баруун бүс нутаг нь бараг бүхэлдээ Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтдаг. Зөвхөн Завхан аймгийн зүүн хойд хэсгийн Идэрийн голын сав, Баян-Өлгий аймгийн Сонгинтын голын сав нь Хойд мөсөн далайн ай савд ордог. Завхан (808 км урт), Ховд (516 км урт), Тэс (430 км урт), Булган (250 км урт) зэрэг томоохон гол энэ бүсэд бий.

Хамгийн олон гол горхи, нууртай нь Завхан аймаг байхад гол горхины уртын хэмжээгээр Баян-Өлгий аймаг бүсдээ тэргүүлж байна. Хамгийн олон булаг шандтай нь говь, цөлийн бүс давамгайлсан Говь-Алтай аймаг болно. (Хүснэгт)

Алтайн уулсын голууд нь горимын хувьд хавар, зуны шар усаар үерлэдэг голуудад багтана. Голын тэжээлийн ихэнх (60%) хувийг өндөр уулсын мөнх цас эзэлнэ.

Томоохон нууруудын талбай /Хүснэгт 4.9 /

| Нуурын нэр | Талбай, км <sup>2</sup> |
|------------|-------------------------|
| Увс        | 3350                    |
| Хар ус     | 1852                    |
| Хяргас     | 1407                    |

|                             |     |
|-----------------------------|-----|
| Хар                         | 575 |
| Дөргөн                      | 305 |
| Ачит                        | 297 |
| Үүрэг                       | 238 |
| Тэлмэн                      | 194 |
| Айраг                       | 143 |
| Хар (Завхан, Эрдэнэхайрхан) | 89  |
| Толбо                       | 84  |
| Хурган                      | 71  |
| Даян                        | 67  |
| Баян                        | 64  |
| Хар ус (Увс, Өмнөговь)      | 63  |
| Ойгон                       | 61  |
| Хотон                       | 50  |

Монгол орны мөсөн голын ихэнх хэсэг нь Өрнөд бүсэд байдаг. Эдгээрээс томоохон нь Алтай Таван Богд орчим 107.9 км<sup>2</sup>, түүний дараа 86.6 км<sup>2</sup> талбайтай Цамбагарав, 56.9 км<sup>2</sup> талбайтай Хархираа, 47.2 км<sup>2</sup> талбайтай Түргэн, 46.8 км<sup>2</sup> талбайтай Мөнххайрхан оргилуудад байдаг. Нийт Монгол орны мөсөн голын талбай 539.59 км<sup>2</sup> бол өрнөд бүсэд 538.37 км<sup>2</sup> буюу 99.89 нь оршино.

Баруун бүсийн аймгуудын гол, горхи, булаг, шандын тоо / Хүснэгт 4.10 /

| Аймаг      | Гол, горхи |         | Нуур | Булаг, шанд |
|------------|------------|---------|------|-------------|
|            | Тоо        | Урт, км |      |             |
| Баян-Өлгий | 109        | 3728    | 67   | 199         |
| Говь-Алтай | 86         | 1242    | 28   | 630         |
| Завхан     | 189        | 3139    | 91   | 406         |
| Увс        | 76         | 2397    | 45   | 280         |
| Ховд       | 93         | 1973    | 23   | 321         |
| Өрнөд бүс  | 553        | 12479   | 254  | 1836        |

Баруун бүсийн уулсын голууд нь уналт ихтэй учраас усны эрчим хүч ашиглах нөөц бололцоо ихтэй юм. Баян-Өлгий, Завхан аймгууд голын усны эрчим хүчний нөөцөөр хамгийн ихтэй нь юм.

Баруун бүсийн усны эрчим хүчний нөөц / Хүснэгт 4.11 /

| Аймаг      | Голын тоо | Усны эрчим хүчний нөөц |             | Цах.станц байгуулах боломжтой |                  |
|------------|-----------|------------------------|-------------|-------------------------------|------------------|
|            |           | Мвт                    | Сая квт/жил | Газрын тоо                    | Нөөц сая квт/жил |
| Баян-Өлгий | 38        | 229                    | 2003        | 23                            | 71               |
| Завхан     | 14        | 73                     | 639         | 10                            | 12               |
| Увс        | 5         | -                      | 539         | 5                             | 10               |
| Ховд       | 14        | 26                     | 226         | 13                            | 9                |
| Өрнөд бүс  | 71        | 328                    | 3407        | 51                            | 102              |

Монгол орны гадаргын усны тооллогын нэгдсэн дүн /Хүснэгт 4.12 /

| Д/д | Аймаг нэр      | Гол, горхи |          | Булаг, шанд |          | Рашаан |          | Нуур,тойром |          |
|-----|----------------|------------|----------|-------------|----------|--------|----------|-------------|----------|
|     |                | нийт       | Ширгэсэн | Нийт        | ширгэсэн | нийт   | ширгэсэн | Нийт        | ширгэсэн |
| 1   | Архангай аймаг | 546        | 124      | 474         | 123      | 31     | 3        | 249         | 32       |
| 2   | Баян-Өлгий     | 293        | 17       | 736         | 42       | 13     |          | 1180        | 217      |
| 3   | Баянхонгор     | 299        | 61       | 837         | 55       | 22     |          | 104         | 38       |
| 4   | Булган         | 449        | 62       | 668         | 238      | 36     |          | 254         | 27       |
| 5   | Говь-Алтай     | 219        | 2        | 779         | 35       |        |          | 75          | 0        |
| 6   | Говьсүмбэр     | 3          | 0        | 19          | 1        | 2      |          | 1           | 0        |
| 7   | Дархан-Уул     | 21         | 4        | 27          | 13       |        |          | 4           | 2        |
| 8   | Дорноговь      | 0          | 0        | 345         | 50       | 4      |          | 1           | 0        |
| 9   | Дорнод         | 156        | 39       | 354         | 121      | 24     |          | 515         | 233      |
| 10  | Дундговь       | 1          | 0        | 187         | 15       | 5      |          | 12          | 0        |
| 11  | Завхан         | 217        | 19       | 444         | 18       | 15     |          | 118         | 2        |

|    |                    |      |     |      |      |     |    |      |     |
|----|--------------------|------|-----|------|------|-----|----|------|-----|
| 12 | Орхон              | 5    | 0   | 28   | 7    |     |    | 4    | 1   |
| 13 | Өвөрхангай         | 294  | 51  | 530  | 97   | 37  | 3  | 110  | 20  |
| 14 | Өмнөговь           | 2    | 1   | 559  | 20   | 5   |    | 18   | 0   |
| 15 | Сүхбаатар          | 35   | 22  | 368  | 41   | 6   |    | 55   | 4   |
| 16 | Сэлэнгэ            | 596  | 90  | 208  | 70   | 28  | 2  | 46   | 6   |
| 17 | Төв                | 537  | 94  | 413  | 103  | 17  | 1  | 235  | 72  |
| 18 | Улаанбаатар        | 72   | 22  | 106  | 22   | 20  | 1  | 4    | 1   |
| 19 | Увс                | 183  | 0   | 493  | 31   | 16  |    | 121  | 6   |
| 20 | Ховд               | 214  | 7   | 468  | 10   | 9   |    | 201  | 4   |
| 21 | Хөвсгөл            | 1233 | 70  | 969  | 193  | 78  |    | 642  | 30  |
| 22 | Хэнтий             | 246  | 17  | 588  | 179  | 6   |    | 247  | 65  |
| 23 | Аймгуудын нийт дүн | 5621 | 702 | 9600 | 1484 | 374 | 10 | 4196 | 760 |
| 24 | Улсын нийт дүн     | 5565 | 683 | 9600 | 1484 | 374 | 10 | 4193 | 760 |

### 4.3 АМРАЛТ, РАШААН СУВИЛАЛЫН ГАЗАР

Баруун бүсэд унаган төрхөөрөө байгаа онгон дагшин уулс, хангай, говь цөл хосолсон үзэсгэлэнт сүрлэг байгал, олон үндэстэн ястны өвөрмөц ахуй, зан үйл, түүх, соёлын эртний дурсгалууд зэрэг дотоод, гадаады зочид жуулчдыг татах ихээхэн нөөц боломж байна. “Аялал жуулчлалын 2015 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө “-нд Баруун бүсийг байгалийн аялал жуулчлал хөгжүүлэх сонирхол татахуйц бүс болгохоор тусгажээ. 1996 онд ЮНЕСКО-гоос Ховд хотын дэргэдэх Ямаат улаан гэдэг нүцгэн улаан буурал уул, Манхан сумын нутаг дахь Хойт Цэнхэрийн агуй, мөн Дархан цаазат Отгонтэнгэр уулыг “ Дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох нь” зэрэглэлээр дэлхийн соёлын өвд бүртгэж авсан байна. Мөн 1997 онд Увс нуурын ай савын дархан цаазтай газрыг дэлхийн шим мандлын нөөц газрын сүлжээнд хамруулан авчээ. Улаангом хотын Чандман улаан уулын археологийн олдвор нь эртний түүх, соёлын нандин өвд зүй ёсоор тооцогддог. Эдгээрийг дэлхий дахинд өргөн сурталчилж, жуудчдын сонирхлыг татах олон таль ажлын зохион байгуулах шаардлагатай байна.

Монгол орны үзэсгэлэнт байгал, баруун Монголын олон ястны амьдрал ахуй зэргийг сонирхуулах өргөн боломжтой. Зэгс, хулсан шагшуурга дунд завиар аялан, ховор жишүүртэн шувууд болон усны амьтдыг үзэх, загасчлах чиглэлээр Увс нуур, мөн Хар-Ус нуурын өмнөд эргээр аялал жуулчлалын бааз байгуулах нөөц байна. Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн Алтай-таван богд, Цамбагарав, Цэнгэлхайрхан, Мөнххайрхан Цагаан дэглий, Цагаан шувуут, Түргэний нуруу, Хархираа, Хангилцаг зэрэг түргэн урсгалт голуудаар, мөн Ховд аймгийн Хар-Ус нуурын хойд эргээр усан спорт хөгжүүлэх боломж бас байна. Баруун бүсэд түүх-археологийн болон шашин угсаатны зүйн чиглэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломж байна. Иймд Баруун бүсэд төрөл бүрийн аялал жуулчлалыг үндсэн ба туслах маршрутаар хөгжүүлэх эдийн засагт мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг салбар болгон хөгжүүлэх шаардлагатай байна.

#### 4.3.1 Баруун бүсийн аялал жуулчлалын төлөв байдал

2007 оны байдлаар баруун бүсийн таван аймгийн хэмжээнд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийг доорхи хүснэгтээр харуулав.

Баруун бүсэд аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжийн тоо /Хүснэгт 4.13/

| Аймгийн нэр                      | Тур оператор | Зочид буудал | Жуулчны бааз | Дэн буудал | Амралтын газар | Ангийн отог | Бүгд |
|----------------------------------|--------------|--------------|--------------|------------|----------------|-------------|------|
| Баян-Өлгий                       | 13           | 1            | 2            |            | 1              |             | 17   |
| Увс                              | 1            | 3            | 2            | 1          | 3              | 1           | 11   |
| Ховд                             | 3            | 6            | 2            |            | 1              | 1           | 13   |
| Нийт                             | 17           | 10           | 6            | 1          | 5              | 2           | 41   |
| Улсын хэмжээнд эзэлж байгаа хувь | 3,3          | 4,0          | 7,6          | 1,8        | 7,7            | 50,0        | 4,3  |

Тайлбар: ЗТАЖЯ-ын статистик эмхтгэлд Говь-Алтай аймаг хамрагдаагүй тул

*дээрх хүснэгтэнд орхигдсон болно.*

Хүснэгтээс харахад аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд бүсийн хэмжээнд төдийлөн олон биш байна. Улсын хэмжээнд авч үзэхэд тур операторын 3,3 хувь, зочид буудлын 4 хувь, жуулчны баазын 7,6 хувь нь оногдож байна.

Баруун бүс нь байгалийн унаган төрхөө хадгалан үлдсэн онгон дагшин уулс, хангай, говь, цөл хосолсон үзэсгэлэнт байгаль, олон үндэстэн ястны өвөрмөц ахуй, зан үйл, түүх, соёлын эртний дурсгалууд зэрэг гадаад, дотоодын зочид, жуулчдын сонирхолыг татахуйц ихээхэн нөөц бололцоо байна.

1966 онд Юнеско Ховдын “Ямаат–Улаан” хэмээх нүцгэн улаан буурал уул, Манхан сумын нутаг дахь Хойд Цэнхэрийн агуй, дархан цаазат Отгонтэнгэр уулыг “Дэлхийн гайхамшигт үнэт” зүйл ангиллаар дэлхийн соёлын өвд, 1997 онд Увс нуурын ай савын Дархан цаазтай газрыг дэлхийн шим мандлын нөөц газрын сүлжээнд хамруулсан байна. Улаангом хотын ойролцоох Чандмань улаан уулын археологийн олдвор нь эртний түүх, соёлын нандин өвд тооцоогддог байна. Баруун бүс нутгийн үзэсгэлэнт байгаль, олон ястны ахуй амьдралын онцлог, зан заншлыг дэлхий хэмжээнд өргөн сурталчилж чадвал байгалийн болон түүх-угсаатны зүйн чиглэлээр жуулчдын сонирхолыг татах боломж байна. Түүнчлэн усан аялал, тухайлбал зэгс, хулсан шагшуурга дунд завиар аялан ховор жигүүртэн шувууд, усны амьтдыг газар дээр нь үзэх, загасчилах, усан спортын арга хэмжээнүүдийг Увс нуур, Хар–Ус нуурын бүс нутагт зохион байгуулах өргөн боломж байна.

Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн Алтай Таван богд, Цамбагарав, Цэнгэл хайрхан, Мөнххайрхан, Цагаан дэглий, Цагаан шувуут, Түргэний нуруу, Хархираа зэрэг өндөр уулсад уулын спорт, Тэс, Түргэн, Хархираа, Ховд, Хангилцаг зэрэг боргио бүхий түргэн урсгал голуудад, Хар–Ус нуурын хойт эргийн дагуу төрөл бүрийн завь, спорт-загас агнуурын төрлийн жуулчлалыг хөгжүүлэх боломжтой байна. Баруун бүсэд түүх археологийн (хэрэгсүүр, хадны сүг зураг, хүн чулуу, чулуун зэвсгийн үеийн дурсгал, хүрлийн үеийн дурсгал, Хүннүгийн үеийн дурсгал, Түрэгийн дурсгал, эртний Торгон зам, Монголын нууц товчооны дурсгалт газрууд) шашин угсаатны зүйн төрлийн аялал жуулчлалыг дэлгэрүүлэн хөгжүүлэх сайхан боломжууд байна.

Монгол Улсын Баруун бүсийн аялал жуулчлалын хөгжлийн хөтөлбөрт 2006-2015 онд Мянганы замын хэвтээ тэнхлэгийн замыг, Улиастай, Ховд хотод цардмал зам тавих, Цагаан нуур - Өлгий - Ховд, Боршоо – Улаангом - Ховд, Ховд-Ярантай чиглэлээр гадаад худалдаа-тээврийн цогцолборуудыг байгуулах, Ховд-Улаангом-Хандгайт, Булган-Ярантайн чиглэлийн хатуу хучилттай замуудыг барих, аймгуудын онгоцны буудлын нисэх, буух талбайг бетонон зурвастай болгох, Ховд, Улиастайн нисэх буудлыг олон улсын статустай болгох зорилт дэвшүүлсэн.

Түүнчлэн Дөргөн, Тайширын УЦС-ыг ашиглалтанд оруулах, Дөргөн-Мянгад, Алтай-Тайшир-Улиастайг холбосон өндөр хүчдэлийн шугамыг байгуулах замаар бүс нутгийн эрчим хүчний хангамжийг сайжруулж, гадаад орны хамаарлаас гарах, бүс нутгийн нийт өрхийн дийлэх хэсгийг цахилгаан эрчим хүчээр хангах зорилт дэвшүүлсэн нь аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дэд бүтцийн талаар дэвшүүлсэн зорилтууд онцгой ач холбогдолтой болох юм.

Мэдээлэл, харилцаа холбооны салбарт дээрх онуудад холбооны үйлчилгээнд тоон системийг нэвтрүүлэх, хөдөлгөөнт холбоог ашиглан баг, сум, хот айл, малчдыг холбоожуулах, Ховд-Улаангомьн хуучин агаарын шугамыг өндөр хурдны шилэн кабелиар солих, улмаар холбооны үйлчилгээнд тоон системийг бүрэн нэвтрүүлэхээр заасан юм.

Дэд бүтцийн салбарт дэвшүүлсэн зорилтууд хэрэгжсэнээр бүсийн хэмжээнд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд Хангайн, Төвийн бүсүүдэд хүлээн авч буй 0,47сая орчим гадаадын жуулчдын 15-20–оос доошгүй хувийг Баруун бүсэд татах, хөрш зэргэлдээ хоёр орны жуулчдыг хилийн боомт газруудаар нэвтрүүлж, шууд хүлээн авах, тээвэр, зочид буудал, жуулчны баазууд, зоогийн газар үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, жуулчдын тав тух, аюулгүй байдлыг хангах, аялал, ажил үйлчилгээг шуурхай, оновчтой зохион байгуулах орчин ихээхэн сайжрах юм.

Нөгөө талаас гадаад, дотоодын жуулчдад үйлчлэх аж ахуйн нэгжүүдийг мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, давтан сургах, мэргэшүүлэх, чадварлаг хөтөч тайлбарлагч, орчуулагч бэлтгэх, музейн үзвэр, түүх соёл, байгалийн дурсгалт газруудыг тохижуулах, англи хэл дээр тайлбар, танилцуулгыг бэлтгэх, орон нутгийн онцлогтой бэлэг дурсгалын үйлчилгээ зохион байгуулах, боловсон бие засах, гар угаах, халуун усны газруудыг байгуулах, жуулчдад амрах, алжаалаа тайлах нөхцлийг бүрдүүлэх, жуулчдын сонирхол, чиглэлд

нийцүүлсэн аялалын маршрутыг төлөвлөх, соёлтой, найрсаг үйлчлэх явдал дээр дурьдсан хөрөнгө оруулалтаас дутахааргүй ач холбогдолтой болохыг анхаарах хэрэгтэй юм.

Түүнчилэн жуулчдын аюулгүй байдлыг хангах, яаралтай эмнэлгийн тусламж үзүүлэх асуудлыг орхигдуулж болохгүй. Тус бүсэд эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувиар бусад бүсүүдтэй харьцуулахад өндөр байна.


Энэ нь нөөц бололцоог аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд ялангуяа ангийн отог ажиллуулах, газарчлуулах, хүнс бэлтгэх, морин болон тэмээн аялал зохион байгуулах, ачаа тээш зөөх, жуулчдыг тээврийн хэрэгслээр үйлчлэх, жуулчны баазуудад хүнсний ногоо, жимс жимсгэнэ тарих, цагаан идээ бэлтгэх, нүүдлийн ахуй амьдралтай танилцуулах зэрэг маш олон сэдэв, хэлбэрээр зохион байгуулж түүнд шууд болон шууд бус маягаар татан оролцуулах хэрэгтэй юм. Одоогоор Баруун бүсийн ДНБ –нд аялал жуулчлалын салбарын эзлэх хувийг тогтоож гаргасан мэдээ байхгүй байна. Гэхдээ 2007 оны статистикийн мэдээнд зочид буудал зоогийн газрууд, жуулчны баазууд, тээврийн үйлчилгээний орлого бүсийн үйлчилгээний салбарын 22 орчим хувьд орж тооцогдсон гэж үзэх талтай юм.

Баруун бүс нутаг түүх, соёлын болон байгалийн үзэсгэлэнт газрууд элбэг, онгон дагшин байгалийн төрхөө хадгалан үлдсэн нь хүн ам цөөн, уул уурхай, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл бусад бүсүүдийг бодвол харьцангуй бага хөгжсөнтэй холбоотой бөгөөд энэ онцлог нь түүх-археологийн, соёл, шашны угсаатны зүйн, байгалийн, адал явдалт аялал, уулын болон авто, усан спортын чиглэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөц байгааг харуулж байна. Баруун бүсийн хэмжээнд байгаа түүх, соёлын дурсгалт газруудаас тоймлон авч үзье.

#### ***Баян-Өлгий аймаг***

Ламын гэгээний хүрээ, Хачин ламын дуган, Мандалын хийд, Амарбуяантын хүрээ, Сагсайн голын чулуун зэвсгийн дурсгал, Баян–энгэрийн, Урт харын, Халзан булгийн, Хар ямаагийн, Цагаан салаагийн хадны сүг зургууд, Мянган хонгорын, Хадан Сэрвэн уулын, Цагаан голын буган хөшөө,





Бага Харгайн, Битүүгийн, Хайртын голын, Хар Ямаатын голын, Хатуугийн амны, Цагаан хөшөөтийн хүн чулуу, Бага Ойгорын, Зүрх уулын, Олон нуурын өчүүхэн түрэг, Эрээн харгантын бичээс зэрэг түүх соёлын дурсгалт газрууд, Даян нуур, Доод асгат уул, Акшох уул, Асгат уул, Булган гол, Мөст уул зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудыг нэрлэж болох юм. Тус аймагт түүх, соёл, байгалийн болон спортын аялал жуулчлал хөгжүүлэх их нөөцтэй, ялангуяа түүх- архелогийн, спортын жуулчлалыг хослуулсан урт богино хэмжээний аялалын газрууд олон байна.

***Говь –Алтай аймаг***

Зүүн чойрын хийдийн туурь, Бичигт хадны, Доогийн ханангийн бууцны хадны, Молор толгойн хадны, Шаахар толгойн хадны зургууд, Бага усны, дунд нуурын, Танхилын буган хөшөөнүүд, Сүмийн дэнгийн, Тамчийн бэлчэрийн, Дэвэрхийн эхийн хөшөө чулуунууд, Хиргист хоолойн, Хар хараачийн булшнууд, Бигэрийн түрэг бичээс, Чандмань уулын овоо ба бунхан зэрэг түүх,соёлын дурсгалт газрууд, Сутай, Бурхан буудай, Алаг хайрхан, Хулд, Бүрэн, Ээж хайрхан

зэрэг үзэсгэлэнт уулсууд, Сангийн далай нуур, Хаяа, Захуй, Зарман, Шарга, Бигэр говиуд зэрэг байгалын үзэсгэлэнт газрууд олон байна.

### **Завхан аймаг**

Талын ухаагийн ацан хадны зураг, Дааган дэлийн буган хөшөө, Мөнгөн хясааны хөшөө, Хөшөөтийн амны хүн чулуу, Янживийн шилийн болон Яруугийн голын хн чулуунууд, Зүрийн овооны түрэг бичээс зэрэг түүх соёлын дурсгалт газрууд, Отгон тэнгэр уул, Цэцэрлэг уул, Бадархундага, Хөх, Улаагчин хар, Бүст, Ногоон, Цагаан, Баян хар, Тэлмэн зэрэг нуурууд, Их бөөрөг, Бор хярын элс, Хомын хоолой, Идэр, Завхан, Тэс гол зэрэг байгалын үзэсгэлэнт газрууд байна.

### **Ховд аймаг**

Ишгэн толгойн, Ховд хот орчмын, Хойт Цэнхэрийн агуйн, Хонгиогийн голын, Хөшөөтийн, Ямаан усны, Цамбагаравын хадны зэрэг хадны зургууд, Дээд улаан говийн амны буган хөшөө, Улаан говийн амны, Шуурхайн хөх нуурын хүн чулуунууд, Тахилтын голын хүннүүгийн булш, Сангийн хэрэм, Долоон нуурын улаан толгойн бичээс, Хадны түрэг бичээс, Харуул овоо, Ховдын шар сүмийн гэрэлт хөшөөний бичиг зэрэг түүх соёлын дурсгалт газрууд, Шарга-Манханы тал, Цамбагарав уул, Тооройн элс, Булган, Ховд голууд, Хар-Ус, Ногоон, Холбоо гурван, Долоон зэрэг нуурууд, Үенч, Бодонч, Тохойн хавцлууд, Цонж хад, Ямаатын хүрхэрээ, Мөнххайрхан, Жаргалант хайрхан уул зэрэг байгалын үзэсгэлэнт газрууд олон байна.

### **Увс аймаг**

Ганц харгайтын бичигт хадны, Зураагийн улаан хадны, Зүүн турагийн тэрэм, Их сарын, Могоогийн, Цахирын, Наранбулагийн, Үнхэлцэгийн, Тэхтийн давааны, Хад үзүүрийн, Цагаан усны, Цагаан өтөгийн, Шар булагийн онцын, Шовгор зэрэг хадны зургууд зэрэг түүх, соёлын газрууд, Цагаан дэглий, Мөст, Цагаан шувуут зэрэг мөнх цаст уулсууд, Увс, Хяргас, Ачит, Үүрэг зэрэг нуурууд, Жинс хадны болон Улаан чулууны агуйнууд, Гоожуур хүрхэрээ зэрэг байгалын үзэсгэлэнт газрууд байна. Баруун бүс нутагт Хар ус нуурын байгалын цогцолбор газарт Хар ус нуур орчмын УТХГ-ын хамгаалалтын захиргаа, Алтай Таван богдын байгалын цогцолбор газарт Монгол Алтайн нурууны УТХГ-ын хамгаалалтын захиргаа “Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай” хуулийн дагуу хүлээсэн үүрэгт ажлаа явуулж байна.

## **4.3.2 Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар төрөөс баримталж байгаа бодлого**

1950–аад оны дундуур “Жуулчин” товчоо байгуулагдаж гадаадын жуулчдад үйлчлэх болсноор монголын аялал жуулчлалын эхлэл тавигджээ.

Засгийн газрын 1995 оны 167 дугаар тогтоолоор “Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар 1995-2005 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг баталж энэ асуудлыг эрхлэн хариуцах төрийн захиргааны нэгжийг зохион байгуулсан нь төрөөс аялал жуулчлалын бодлогыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна. 1996 онд Засгийн газрын шийдвэрээр аялал жуулчлалын асуудлыг Дэд бүтцийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамааруулж, 1998 онд Засгийн газрын 192 дугаар тогтоолоор “Аялал жуулчлалын бодлого зохицуулах Үндэсний зөвлөл”-ийг, хожим “Аялал жуулчлалын газар” нэртэй засгийн газрын агентлага болгосон байна. 2004 оны Засгийн газрын тухай хуулиар тус агентлагийг татан буулгаж шинээр байгуулагдсан Зам, тээвэр аялал жуулчлалын яамны бүтцэд нэгтгэсэн байна. Өнөөдөр тус яаманд аялал жуулчлалын бодлого зохицуулах газар нь салбарын бодлого, зохицуулалт, хэрэгжилтийн асуудлыг хариуцан ажиллаж байна. Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжихэд аялал жуулчлалын үйл ажиллагаа цэвэр хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд шилжиж салбарын үйл ажиллагаанд хууль, эрх зүйн зохицуулалт нэн шаардлагатай болсон юм.

2000 онд УИХ-аар “Аялал жуулчлалын тухай” хууль батлагдсанаар салбарын хэмжээнд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулах хууль эрх зүйн үндэс тавигдсан юм.

Түүнчлэн “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай” зэрэг холбогдох бусад хуулиуд, “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Монгол улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги”, “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” зэрэг УИХ-аас баталсан урт хугацааны хөтөлбөрүүд, Засгийн газрын тогтоолоор

баталсан “Аялал жуулчлалын сан бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”, “Рашаан сувиллыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, “Монгол Улсын виз олгох журам”, Дэд бүтцийн сайдын баталсан “Жуулчдын тоо, салбарын орлого, зарлага тооцох журам”, “Дээд зэрэглэлийн зочид буудал, жуулчны баазад зэрэглэл тогтоох журам”, Байгаль орчны сайдын баталсан “Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал явуулах журам”, Зам тээвэр, аялал жуулчлалын сайдын “Хөтөч-тайлбарлагчийн ангилал, зэрэглэл тогтоох журам”, “Хятадын жуулчдыг Монгол Улсад бүлгээр аялахыг зохион байгуулах аялал жуулчдын байгууллагуудыг сонгох түр журам”, “Аялал жуулчлалын байгууллагын ангилал тогтоох журам”, “Зочид буудал, жуулчны баазын бүртгэл хөтлөх журам” зэрэг баримт бичгүүд нь салбарын үйл ажиллагааны эрх зүйн орчин болж байна.

2002 онд Дэд бүтцийн яам, Байгаль орчны яам, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага Жайкатай хамтран “Монголын экотуризмын хөгжил” сэдэвт үндэсний зөвлөгөөнийг зохион байгуулж, улмаар байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх шаардлага, тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалыг хэрхэн зохион байгуулах талаар засгийн газарт хандаж зөвлөмж гаргасан байна. БОЯ-наас тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал жуулчлал явуулах эрхийг 1 жилийн хугацаагаар олгодог болсон.

Япон улсын олон улсын хамтын ажиллагааны агентлаг Жайка “Монгол улсад үндэсний аялал жуулчлал хөгжүүлэх мастер төвлөгөө”-г 1999 онд боловсруулахдаа гол төлөв Улаанбаатар хот түүний орчны нутаг дэвсгэрт, Хархорин, Өмнөговь зэрэг гадаадын жуулчдад танил болсон бүс нутгийн хэмжээнд аялал, жуулчлалыг хөгжүүлэхэд гол анхаарлаа хандуулсан байна. Аялал жуулчлалыг хөгжүүлэх, ялангуяа эко жуулчлалын талаар тус мастер төвлөгөөнд дэвшүүлсэн санаа, зөвлөмжийг Баруун бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулахад ашигласан болно.

***“Мянганы зорилгод суурилсан Монгол Улсын үндэсний хөгжлийн цогц бодлого”-д аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгож улмаар “Аялал жуулчлал” үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ гэж заасан байна.***

### 4.3.3 Монголын аялал жуулчлалын хөгжлийн одоогийн төлөв байдал

Баруун бүсийн хэмжээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулахад Монголын аялал жуулчлалын салбарын одоогийн байдал, цаашдын хөгжлийн хандлагатай хэрхэн уялдуулах асуудлыг тусгах учраас энэ салбарын талаар сүүлийн үеийн тайлан, статистик мэдээнд үндэслэн тоймлон авч үзсэн болно.

Сүүлийн жилүүдэд аялал жуулчлал эрчимтэй хөгжиж манай улсад ирж байгаа гадаадын жуулчин, гийчдийн тоо жил бүр 15-20 хувиар өсч байна. 2007 оны байдлаар Монгол улсад 454 576 жуулчид ирсэн нь 2000 оныхоос 34,8 хувь буюу 296 371 жуулчнаар нэмэгдсэн байна. Манай улсад зочилж байгаа гадаадын жуулчдын 31,3 хувь нь албан ажлаар, 17,7 хувь нь хувийн шугамаар, 42,7 хувь нь амралтаараа, 13,4 хувь нь дамжин өнгөрөх зорилготой ирдэг байна. Ирж байгаа жуулчид, гийчдийг бүс нутгаар ангилж үзэхэд Зүүн Ази ба Номхон далайн орнууд, Европ, Америк тивийнхэн давамгайлж нийт жуулчдын 90 орчим хувийг эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн өсөлтийг 2000 онтой харьцуулахад жилд дунджаар 19,2 хувь болж байна. Гадаадын жуулчин гийчдийн 96 орчим хувь нь 30 хүртэл хоногоор үлдсэн хувь нь 90 ба түүнээс дээш хоногоор зочилдог байна. Харин эдгээр жуулчдаас чухам хэдэн хувь нь баруун бүсэд зочилж аялдаг талаар статистик үзүүлэлт нэгтгэгдэж гараагүй байна. Бүсийн аймгуудын аялал жуулчлалын аж ахуйн нэгжүүд, төрийн захиргааны энэ асуудлыг эрхэлсэн ажилтнуудын гаргасан (зарим оны болон хилийн боомтоор орж гарсан) үзүүлэлтүүдийг үндэслэн 7-9 орчим хувь оногдож байна. Энэ нь баруун бүсэд дэд бүтцийн үйлчилгээ муу, аялал жуулчлал эрхэлдэг аж ахуйн нэгжүүд цөөн, мэргэжлийн хүмүүс дутагдалтай, аялал жуулчлалын голлох бүс нутгаас алс хол, үйлчилгээний менежмент сул, сурталчилгаа бага хийгддэг, түүнчилэн агаарын болон авто тээврийн үйлчилгээ жуулчдын урсгалыг дааж чадахгүйтэй холбоотой байна.

Аялал жуулчлалын салбарт гарч байгаа нэг шинэлэг зүйл бол дотоодын аялал жуулчлал эрч хүчээ авч байгаа явдал юм. Ялангуяа хөдөө орон нутагт байгалийн үзэсгэлэнт газраар аялах, рашаан сувилалд амрах, байгалийн эмчилгээ хийлгэх, загас барих, ан хийх, авто-спорт ралли зэрэг олон хэлбэрээр хөгжих хандлагатай болж байна. Гэвч дотоодын аялал жуулчлалыг

дэмжин хөхүүлэх төрийн бодлого, хөгжүүлэх чиглэл одоогоор тодорхой бус статистик мэдээ төв болон орон нутагт ч нэгтгэгдэн гарахгүй байна.

ЗТАЖЯ-аас Монгол улсын аялал жуулчлалын салбарын орлого 2007 онд 301 сая ам.доллар буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 10,2 хувийг эзэлж байгааг тогтоосон байна. Зочид буудал, жуулчны баазын үйлчилгээний чанарын зэрэглэлийг MNS 4588:2004, MNS 4934:2002 стандартын дагуу тогтоож байна. 2007 оны байдлаар манайд 320 зочид буудал, 317 жуулчны бааз үйл ажиллагаа явуулж байгаагаас 55 зочид буудал одны зэрэглэлтэй, 65 жуулчны бааз цэцгийн зэрэглэлтэй нь нийт зочид буудлын 17 орчим хувийг, жуулчны баазын 20,5 хувийг тус тус эзэлж байна.

2007 оны гүйцэтгэлээр аялал жуулчлалын салбарын нийт үйлдвэрлэл 39,7 тэрбум төгрөг болсон нь өмнөх жилийнхээс 19,9 хувиар өссөн байна. Мөн салбарын хэмжээнд нийт 5 орчим мянган хүн ажиллаж байгаа нь 2006 оныхоос 757 хүнээр нэмэгджээ. ЗТАЖЯ-наас 2007 онд салбарын хэмжээнд статистик мэдээллийн сан байгуулах зорилгоор аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдийг хамруулсан үзлэгийг зохион байгуулсан байна. Энэ арга хэмжээнд нийт 911 аж ахуйн нэгжийн 956 үйлчилгээний газар, 22 иргэн хамрагдсан байна. Эдгээр аж ахуйн нэгжүүдийн 92,5 хувь нь хязгаармагдмал хариуцлагатай компаний хэлбэрээр, 91,8 хувь нь Монгол улсын иргэдийн хувийн аж ахуйн нэгжүүд байна. Салбарын хэмжээнд 41 гадаадын хөрөнгө оруулалттай компани үйл ажиллагаагаа явуулж байгаагаас БНСУ-ын хөрөнгө оруулалттай 11, БНХАУ, Япон улсын хөрөнгө оруулалттай тус бүр 6 компани, АНУ-ын хөрөнгө оруулалттай 5 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Үзлэгт орсон аж ахуйн нэгжүүдийн 65,6 хувь нь буюу 598 аж ахуйн нэгж 2001 оноос хойш үүсгэн байгуулагджээ.

Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 503 тур операторын 251 нь зочид буудлын, 79 нь жуулчны баазын, 54 нь дэн буудлын, 65 нь амралтын газрын, 4 нь ангийн отгийн үйл ажиллагаа эрхэлж байна. Эдгээр аж ахуйн нэгжүүдийн 82 орчим хувь нь улирлын чанартай ажиллаж байна. Зочид буудлууд ихэвчлэн аймгийн төвүүд, нийслэлд байрлаж байна.

Салбарын аж ахуйн нэгжүүд 2006 онд нийтдээ 11 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 72 орчим хувийг өөрийн хөрөнгөөр хийсэн байна. Нийт хөрөнгө оруулалтын 80 орчим хувийг барилга, байгууламж барихад, 12 орчим хувийг их засвар, өргөтгөлийн ажилд, 7 хувийг машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг шинэчлэхэд зарцуулсан байна.

Манай улсын агаарын тээвэр, төмөр зам, авто замын сүлжээ нь жуулчдын өсөн нэмэгдэж байгаа урсгалын хурдыг гүйцэхгүй болж байна. Европын орнууд түүнчлэн хөрш орнуудаас гэрээний дагуу жуулчин хүлээж авах, авсан хэдийгээ орон нутагт тодорхой маршрутаар аялуулахад тээврийн үйлчилгээнээс болж хүчин чадлынхаа тал хувийг л ашиглаж байна гэж аялал жуулчлалын компаниуд гомдоллож байдаг.

#### 4.3.2.1 Агаарын тээвэр аялал жуулчлалд

Монгол улсад олон улсын зэрэглэлд орсон 6 нисэх буудалтай. Үүнээс Чингис хаан, Өлгий нисэх буудлуудад олон улсын нислэг тогтмол хийгдэж байна. Монголын агаарын тээврийн “МИАТ” ХХК Улаанбаатараас Эрхүү, Москва (ОХУ), Берлин (ХБНГУ), Бээжин (БНХАУ), Сеул (БНСУ)-ийн чиглэлд, “Аэромонголиа” компани Тянжин, Хөх хот (БНХАУ), Эрхүү (ОХУ)-гийн чиглэлд тусгай хуваариар нислэг хийж байна.

Түүнчлэн ОХУ-ын “Аэрофлот” компани Москва хотоос, БНХАУ-ын “Эйрчайна” компани Бээжин хотоос, БНСУ-ын “Кореан Эйр” компани Сеул хотоос Улаанбаатар хот руу, Казакстан улсын “Скат” компани Усть-Каменогорск-Өлгийн чиглэлд тус тус нислэг хийж байна. Орон нутгийн хэмжээнд төрийн өмчийн МИАТ –Улаанбаатар-Даланзадгад, Ховд, Ховдын Булган сум, Мөрөн, Алтай-Баянхонгор, хувийн хэвшлийн “Аэромонголиа” ХХК, Ховд, Өлгий, Улаангом, Доной, “Изнис Эйрвэйз” ХХК, Даланзадгад, Ховд, Баянхонгор, Улаангом, Чойбалсан, Мөрөн-Өлгий, Доной-Тосонцэнгэл гэсэн чиглэлүүдэд Ан-26, Фоккер-100, Фоккер-50, СААБ 340 маркийн агаарын хөлгүүдээр тогтмол нислэг гүйцэтгэж байна. Харин захиалгат нислэгийг агаарын тээврийн Central Mongolian Airways хоёр Ми-8 нисдэг тэргээр, “Тэнгэрийн улаач” нэг нисдэг тэргээр, Blue Sky Aviation компани Чессна-208 маркийн агаарын хөлгөөр тус тус нислэг хийж байна. Монголын агаарын тээврээр олон улсын нислэгээр 2006 онд 417853 зорчигч, 2007 онд 472379 зорчигч, орон нутгийн шугамаар 2006 онд 137460 зорчигч, 2007 онд 120967 зорчигчид үйлчлүүлжээ.

Манай хөрш хоёр орнуудад дэлхийн аялал жуулчлалын 8 хувь оногддог. ӨМӨЗО-ны аялал жуулчлалын салбар сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж, жилдээ 1,2 сая гадаадын жуулчдыг хүлээн авдаг байна. 2007 оны сүүлчээр Улаанбаатар хотод Монгол улс, БНХАУ-ын хилийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудлыг хэлэлцэж хоёр орны хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.

### Төмөр зам

Монгол улсын нийт төмөр замын урт 1835 км юм. Үүнээс Сүхбаатар-Замын –Үүдийн 1100 км–ийн урт шугам гол үүрэг гүйцэтгэдэг юм. 2007 оны байдлаар нийт ачаа тээвэрлэлтийн 62,8 хувь, зорчигч тээвэрлэлтийн 2,3 (205,0 сая хүн) хувь нь төмөр замд оногдож байна. УБТЗ-ны зорчигчийн парк нийт 330 вагонтой ба 2008 онд 30 шинэ вагоноор нэмэгдсэн.

### Авто тээвэр

Авто тээвэрийг үндсэндээ хувийн хэвшлийнхэн буюу тээврийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүд, аялал жуулчлалын компаниуд үйлчилж байна. 2006 онд 190,7 сая хүнд, 2007 онд 205,9 сая хүнд үйлчилсэн байна.

Манай оронд гадаадын жуулчдын голлох урсгал Улаанбаатар хот, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий, Төв аймаг зэрэг аялал жуулчлалын дэд бүтцэд харьцангуй хөгжсөн аймгуудад чиглэгдсэн хэвээр байна. Улсын хилээр 2007 оны байдлаар байнгын болон улирлын ажиллагаатай 25 хилийн боомтоор 1,4 гаруй сая зорчигч нэвтэрсэн байна. Баруун бүсийн хилийн 9 боомтоор нэвтэрсэн зорчигчийн тухай мэдээллийг хүснэгтээр харуулав.

Баруун бүсийн хилийн боомтуудаар нэвтэрсэн зорчигчдын тоо /Хүснэгт 4.14/

| Боомтын нэр | Орсон                    |                |        |           |         |       |                        |                 |               | Гарсан |
|-------------|--------------------------|----------------|--------|-----------|---------|-------|------------------------|-----------------|---------------|--------|
|             | Зорчигч-дын тоо (хүнээр) | Аяллын зорилго |        |           |         |       | Аяллын хугацаа (хоног) |                 |               |        |
|             |                          | Албан          | Хувийн | Жуулч-лал | Дам-жин | Бусад | 30 хүртэл хоног        | 90 хүртэл хоног | 90-дээш хоног |        |
| Арц суурь   | 13146                    | 765            | 10553  | 0         | 0       | 1828  | 10030                  | 1288            | 1828          | 14186  |
| Боршоо      | 14240                    | 1650           | 6575   | 150       | 0       | 5865  | 6609                   | 1256            | 6375          | 14101  |
| Бургастай   | 1723                     | 938            | 193    | 0         | 0       | 592   | 1055                   | 76              | 592           | 1874   |
| Булган      | 28581                    | 1353           | 641    | 58        | 0       | 26529 | 1175                   | 877             | 26529         | 25817  |
| Байтаг      | 1603                     | 25             | 228    | 0         | 0       | 1350  | 253                    | 0               | 1350          | 1524   |
| Даян        | 394                      | 2              | 57     | 0         | 0       | 335   | 59                     | 0               | 335           | 432    |
| Цагаан нуур | 18989                    | 536            | 7020   | 1493      | 62      | 9878  | 7143                   | 2421            | 9425          | 19162  |
| Ханги       | 13333                    | 53             | 876    | 58        | 0       | 12346 | 961                    | 26              | 12346         | 13700  |
| Тэс         | 5932                     | 834            | 4697   | 0         | 0       | 398   | 5355                   | 164             | 413           | 6450   |
| Нийт        | 97941                    | 6156           | 30840  | 1701      | 62      | 59121 | 32640                  | 6108            | 59193         | 97246  |

Хүснэгтээс харахад 2007 онд баруун бүсийн 9 боомтоор манай улсад нийт 97941 зорчигч нэвтэрсэн нь улсын хэмжээнд нэвтэрсэн нийт зорчигчдын 7,5 хувийг эзлэж байгаа бөгөөд Булган, Цагаан нуур, Боршоо, Арц суурь, Ханги боомтоор хамгийн олон зорчигч орж гарсан байна. “Монгол улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги”-д Баруун бүсэд ОХУ-тай хил залгаа Цагааннуур (Баян-Өлгий), Боршоо (Увс), Арцсуурь (Завхан), БНХАУ-тай хил залгаа Булган (Ховд), Бургастай (Говь-Алтай)-н боомт, гарцыг эхний ээлжинд тохижуулж хоёр хөрш орны хилийн зэргэлдээх муж, өөртөө засах орнуудтай харилцан дэмжиж хамтдаа түргэн хөгжих орчин нөхцлийг сайжруулна гэж заасан байна.

Баруун бүсэд өнөөгийн байдлаар манай улсын нийт хүн амын 15,6 хувь буюу 411,1 мянган хүн оршин сууж байна. Хүн амын өсөлт 0,2% байгаа нь улсын дундаж үзүүлэлт 1,4 %-ээс ихээхэн бага байна. Бүсийн эдийн засгийн үзүүлэлт ч бусад бүсүүдээс доогуур байна. Нэг хүнд оногдох ДНБ 830,0мян.төг байгаа нь улсын дунджаас 2,1 дахин, Улаанбаатар болон Хангайн бүсээс 2,6 дахин, Зүүн бүсээс 67,7 хувиар, төвийн бүсээс 26,7 хувиар тус тус бага байна. Баруун бүсэд бэлчээрийн мал аж ахуйн түшиглэсэн хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь харьцангуй өндөр (71,8%) байна. Үлдсэн хувь нь бусад салбарт үлдэж байгаагаас харахад хоцрогдож буй салбарт жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Үүнээс үйлчилгээний салбарт аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх хэрэгтэй байна.

“Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого” зэрэг урт хугацааны хөгжлийн баримт бичгүүд батлагдсаны дагуу бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрүүд боловсрогдон гарч тэдгээрт аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээнүүд, хүрэх үр дүнг тодорхой тусган харуулав. 2004-2007 онд улсын хэмжээнд нийт хөрөнгө оруулалт өмнөх дөрвөн жилийнхээс 2,3 дахин өссөн бөгөөд түүний дийлэнх хувийг дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэгдсэн байна.

Түүнчлэн агаарын тээврийг эрчимтэй хөгжүүлэх, төмөр замын сүлжээг өргөтгөх, Монгол Улсын газар нутгийг олон улсын хамтын ажиллагааны бүс нутгуудтай холбох замаар эдийн засгийн өсөлтийн хурдцыг нэмэгдүүлэх, нутаг дэвсгэрийн дотоод тэнцвэрийг хангах шаардлагыг харгалзан авто тээврийн хөндлөн болон гол төмөр замын дагуух авто замыг тэргүүн ээлжинд сайжруулах, барьж байгуулах шаардлагатай гэж үзсэн байна.

Зах зээлийн тогтолцоонд шилжихээс өмнө улсын хэмжээнд болон баруун бүсийн аймгуудад улсын болон аймаг, орон нутгийн чанартай амралт, сувилал, хүүхдийн зуслан олноор ажиллаж тэдгээр нь гол төлөв дотоодын амрагчдад үйлчилж байсан. 1990 оноос манай улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих явцад дээрх амралт, сувиллын газрууд хувьчлагдсанаар өмнөх тогтолцооны үед үйлдвэрчний болон албан байгууллагын шугамаар ажиллаж байсан амралтын газрын сүлжээ үндсэндээ байхгүй болсон байна.

2007 онд аялал жуулчлалын салбарт хамрагдаж буй 65 амралтын газарт үзлэг явуулсан дүнгээс харахад нийт амралтын газрын 47 буюу 73,2 хувь нь хязгаармагдмал хариуцлагатай компани, өмчийн хэлбэрээр үзэхэд 82,0 хувь нь хувийн хэвшлийнх байна. Нийт амралтын газрын 69,2 хувь нь гол төлөв 6,7,8,9 саруудад амрагчдад улирлын чанартай үйлчилж байна.

Рашаан сувиллын газруудын үйл ажиллагаа зогсонги байдалд орж байсан ч 2002 онд Засгийн газрын 251 тоот тогтоолоор “Рашаан сувиллыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталж гаргасан нь дотоодын аялал жуулчлал, байгалийн эмчилгээ-сувилалын үйлчилгээг хөгжүүлэхэд ихээхэн түлхэц болсон байна. Одоогийн байдлаар насанд хүрсэн 1000 хүнд ногдох архаг өвчтэй нийт хүмүүс 36 орчим хувийг эзэлдэг бөгөөд өвчний төрлөөр авч үзэхэд хоол боловсруулах эрхтний өвчний 38 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчний 16 хувь, амьсгалын эрхтний өвчний 14,3 хувь, үе мөч, холбоос эдийн өвчний 12,5 хувь нь рашаан сувиллын эмчилгээ авах шаардлагатай болохыг харуулж байгаа ба рашаан сувиллын орны хэрэгцээ 1000 хүнд 4,7 болохыг судлаачид тооцоолон гаргасан байна. Иймээс баруун бүс нутгийн хэмжээнд рашаан сувиллын хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Монгол орон олон улсын рашааны үнэлэмж хангахуйц 90 гаруй ордтойгоос халуун рашааны орд 40, хүйтэн рашааны орд 52, байгалийн халуун уур бүхий орд 1, рашаан төст булаг 108, бичил орчин бүхий хүчин зүйлүүд байгаагаас гадна эмчилгээний лаг, наанги шавартай 40 орчим нуур, шаврын орд газрууд судлагдаад байна. Эдгээр ордуудын хүчин чадлыг нэмэгдүүлж чадвал гадаад, дотоодын жуулчид, аялагчдад байгалийн эмчилгээ үзүүлэх ихээхэн нөөц боломж байгааг харуулж байна.

Баруун бүсийн хэмжээнд ашиглаж байгаа рашааны орд газрууд /Хүснэгт 4.15/

|   | Рашааны нэр, байршил                              | Нөөц м <sup>3</sup> /хон | Рашааны үзүүлэлтүүд   | Ашиглалтын байдал   |
|---|---|--------------------------|---|---|
| <b>А. Бүсийн хэмжээнд ашиглаж байгаа</b>  |   |                          |   |   |
| 1   | Отгонтэнгэрийн рашаан Завхан аймаг, Алдархаан сум | 608                      | Сульфат-гидрокарбонат, карбонат-натрийн найрлагатай азотын халуун рашаан                          | Улирлын ажилла-гаатай, 180 ор-той, жилд дунд жаар 500-800 хүнд үйлчилдэг                              |
| <b>Б. Аймгийн хэмжээнд ашиглаж байгаа</b> |   |                          |   |   |
| 2   | Улаан хаалга рашаан Завхан аймаг, Алдархаан сум   | 172,8                    | Сульфат-гидрокарбонат-натрийн найрлагатай, фтор, цахиурын хүчилтэй азотын халуун рашаан           | Улирлын ажилла-гаатай, 100-200 ор-той, жилд 600 -800 хүнд үйлчил дэг                                  |
| 3   | Хар тэрмэсийн рашаан Увс аймаг, Хяргас сум        | 7,8                      | Сульфат-хлорид-натри-магнийн найрлагатай  | Улирлын ажилла гаатай. Нэг ээл-жиндээ 150-200 хүн хүлээн авах боломжтой, жилд 800-1000 хүнд үйлчилдэг |
| 4   | Ак-су рашаан Баян-Өлгий аймаг, Цэнгэл сум         | 259,2                    | Гидрокарбонат-карбо-нат-сульфат-натрийн найрлагатай, цахиурын хүчил, фтортой азотын халуун рашаан | Улирлын ажилла-гаатай, 30-50 ор-той, жилд 200-280 хүнд үйл-чилдэг                                     |
| 5   | Хүнхэр зуслан-гийн                                | 108                      | Хлорид-гидрокарбона-кальци-   | Улирлын ажиллагаатай,   |

|  |   |   |  |  |
|--|---|---|--|--|
|  | рашаан,<br>Говь-Алтай аймаг,<br>Жаргалант сум |   | магни-натрийн найрлагатай,<br>нүүрс-хүчлийн хийтэй хүйтэн<br>рашаан  |  |
| В. Сум, орон нутгийн хэмжээнд ашиглаж байгаа |   |   |  |  |
| 6.   | Индэртийн рашаан Ховд<br>аймаг, Булган сум    | - | Сульфат-гидрокарбо -нат-<br>хлорид-натри-кальц ийн<br>найрлагатай,   | Улирлын ажилла-гаатай,<br>иргэд ху-виараа<br>ашигладаг |
| 7.   | Зартын рашаан<br>Завхан аймаг, Их уул<br>сум  | - | Сульфат Гидрокарбо -нат -<br>натрийн найрлага тай,<br>фтор, цахиурын хүчлэр зэрэг<br>биогений элементтэй азотын<br>халуун рашаан | Улирлын ажилла гаатай,<br>иргэд хувиараа<br>ашигладаг  |
| Г. Эмчилгээний нуур, шаврын орд              |   |   |  |  |
| 8  | Хяргас нуур<br>Увс аймаг, Хяргас сум          |   | Нуурын эрсдэлжилт 7,4 г/л,<br>сульфат-хлорид кар-бонат<br>натрийн найр-лагатай, лаг<br>наанги шавартай.                          | Орон нутагт нуур<br>эмчилгээ хийдэг                    |

*Эх сурвалж: Рашаан сувиллын үндэсний төв*

Рашаан сувилал үндэсний төвийн судалгаанаас харахад ихэнх рашаан сувиллын газрууд улирлын чанартай үйлчилгээ явуулдаг, хүчин чадал бага, сурталчилгаа, зах зээлийн судалгаа, байгалийн эмчилгээний менежментийг сайжруулах шаардлагатай болох нь харагдаж байна. Түүнчлэн рашаан сувилалын газруудын материаллаг баазыг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах бизнес хөтөлбөрүүдийг боловсруулах хэрэгтэй байна. Мөн рашаан сувиллын газруудад ажиллагсадын мэргэжлийг дээшлүүлэх, тодорхой хөтөлбөрүүдийг сонгож, бага хүүтэй зээл олгох асуудлыг аймаг орон нутгийн удирдлага, банк санхүүгийн байгууллагын дэмжлэгтэйгээр шийдвэрлэж өгвөл дотоодын аялал жуулчлалыг бүс нутагт хөгжүүлэхэд бодитой туслалцаа болох юм. Мөн газар тариалан, хүнсний ногоо, жимс жимсгэний аж ахуйг хөгжүүлснээр гадаад, дотоодын жуулчдад экологийн цэвэр хүнсээр үйлчлэх нөхцлийг бүрдүүлнэ.

Бүс нутгийн нэрийг жуулчдын дунд Ховдын тарвас, Увсын чацарганы бүтээгдэхүүнүүд, казак үндэсний хоолоор сурталчилах боломжтой.

***Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас дэвшүүлж байгаа нэг гол зорилт нь байгаль орчноо хамгаалах, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхэд нутгийн хүмүүсийг өргөн оролцуулах замаар тэдний амьдрал, ахуйг дээшлүүлэх, экологийн боловсролыг төлөвшүүлэх, түүх соёлын дурсгалт газраа хайрлан хамгаалах, уламжлалт зан заншил, үндэснийхээ өв соёлоор бахархах дархлаа бий болгох болон улс орныхоо эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангуулахад аялал жуулчлалын салбарыг нэгэн чухал хөшүүрэг болгон ашиглах явдал гэж үзэж байна.***

Иймээс дэлхийн аялал жуулчлалын хөгжлийн хандлага, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдуулах үүднээс Баруун бүсийн тухай холбогдох мэдээллийг энэхүү төслийн баримт бичигт тусгах нь зүйтэй гэж үзсэн болно.

2007 оны Монгол улсын статистикийн мэдээгээр Баруун бүсэд манай нийт хүн амын 15,6% буюу 411,1 мянга, үүнээс Баян-Өлгий аймагт 100,8 мянга, Говь-Алтай аймагт 60,2 мянга, Завхан аймагт 81,1 мянга, Увс аймагт 80,4 мянга, Ховд аймагт 88,6 мянган хүн оршин сууж байгаагаас 28,1% нь хот суурин газарт 71,9% нь хөдөөд нийт 96,4 мянган өрх айл амьдарч байна. Бүс нутгийн эдийн засгийн идэвхтэй хүн 170,7 мянга, үүнээс ажил эрхэлж байгаа хүн 164,6 мянга, бүртгэлтэй ажилгүй хүний тоо 3099 (Баян Өлгийд 743, Говь Алтайд 580, Завханд 831, Увс 507, Ховдод 438) ажилгүйдлийн түвшин 3,5% байна. Дотоодын нийт бүтээгдэхүүн 341 230,9 сая төгрөг, үүнээс хөдөө аж ахуйд 71,8 хувь, аж үйлдвэр, барилгад 5,4 хувь, үйлчилгээний салбарт 22,8 хувь тус тус оногдож байна.

Малын тоо бүс нутгийн хэмжээнд 12,3 сая, үүнээс Завхан аймаг 3 сая орчим мал тоолуулсан байна (тэмээ 73,0 мянга, адуу 441,5 мянга, үхэр 529,5 мянга, хонь 5066,8 мянга, ямаа 6190,9 мянга).

“Тогтвортой амьжиргаа” төслийн хүрээнд Баруун бүсэд боловсролын чиглэлээр 2004-2007 онуудад 342 төслийн 1480,2 сая төгрөгийн санхүүжилт, эрүүл мэндийн салбарт мөн онуудад нийт 252 төслийн 801,5 сая төгрөгийн санхүүжилт, дэд бүтцийн салбарт мөн онуудад 69 төслийн 245,8 сая төгрөгийн санхүүжилт, байгаль орчин болон бусад чиглэлээр 33 төслийн 118,3 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус хийсэн байна. Баруун бүсийн хувьд эрчим хүчний хангамж хамгийн хүнд асуудал байсан. Харин Дөргөнтийн УЦС ашиглалтанд орсноор иргэд, аж ахуйн нэгжүүдийн хэрэгцээг найдвартай хангах боломж олгож өглөө. Баруун бүсийн

хэмжээнд 2007 оны тээврийн хэрэгслийн улсын тооллогоор нийт 16142 автомашин тоологдсоноос 50 гаруй хувь нь 10 ба түүнээс дээш эдлэгдсэн машин байна. Түүнчлэн бүсийн хэмжээнд суурин телефон цэгийн тоо 11313 байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс бага байна.

Баруун бүсийн хүн ам, ажиллах хүч, хөрөнгө оруулалт, нийгэм эдийн засгийн мэдээллүүдийг үзүүлж байгаа нь тус бүсэд аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэл тогтоох, төсөл боловсруулахад чухал ач холбогдолтой гэж үзсэнтэй холботой юм. Баруун бүс нутаг нь экологи ус зүйн хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай сав Алтай Саяны бүс нутагт (Баян-Өлгий, Ховд, Увс) хамрагддаг. Энэ бүс нутаг нь Төв Азийн босоо бүслүүр, байгаль унаган төрх байдлаа хадгалж үлдсэн, дэлхийд ховордсон амьтан, ургамал бүхий экосистемийг бүрдүүлж байдгаараа онцлог бөгөөд энэ бүсэд чийглэг хөрстэй ой хээр, давсархаг намаг, хөдөлгөөнтэй ба хөдөлгөөнгүй элсэн зурвас, манхан, мөнх цаст уулс, мөсөн гол, навчит болон шилмүүст ой зэрэг газар нутгууд оршино.

Энэ бүс нутгийн хэмжээнд Увс нуурын ай сав, Алтай Таван Богд, Хөх сэрх, Хар ус нуур, Хан Хөхий, Хяргас, Цамбагарав, Сийлхэмийн нурууг улсын тусгай хамгаалалтын газрын сүлжээнд хамруулдаг. Эдгээр газар нутгийн ихэнх нь ОХУ, БНХАУ ба Казакстан зэрэг улсуудын тусгай хамгаалалттай газруудтай хил залгаа оршдог. Хар Ус нуур, Айраг, Дөргөн нуур ус намгархаг газрын олон улсын сүлжээнд орсон. Гадаадын жуулчдын дунд 1998, 2002 болон 2004 онд явуулсан судалгаанаас харахад нийт хамрагдсан жуулчдын тал хувь нь амралтаараа, гуравны нэг нь албан ажлаар, үлдсэн хэсэг нь найз нөхөд, хамаатан садныхаа урилгаар айлчлагсад байв. Судалгаанд хамрагдсан жуулчдын хагасаар илүү нь 40-өөс дээш насныхан ба 70 гаруй хувь нь манайд анх удаа ирсэн байна. 57 хувь нь нэг улс орноор бусад нь Монголоос гадна өөр бусад орныг хамруулсан аялагчид байна.

Гадаадын жуулчдын Монголд байсан дундаж хугацаа 12-14 хоног, өдөрт дунджаар 90 орчим доллар зарцуулдаг, 90 гаруй хувь нь Улаанбаатар хот, Тэрэлж, Хархорин, Говьд зочилсон, харин Баруун бүсэд 8 орчим хувь нь очдог байна. Ихэнх жуулчдын манайд зочлох болсон шалтгаан нь байгалийн үзэсгэлэнт газар, зэрлэг ан амьтан, шувуу, онгон амьд байгаль, түүх, соёл, ан агнах, адал явдлыг сонгосонтой холбоотой гэж үздэг байна. Монголд аялахад хамгийн хүндрэлтэй зүйл бол газрын тээвэр, дотоодын нислэгийн асуудал, зарим тохиолдолд үйлчилгээний соёл, чанар, инээмсгэлэл, найрсаг зочломтгой үйлчилгээ мөн хөтөч тайлбарлагчийн үр чадварыг сайжруулах хэрэгтэй болохыг зөвлөсөн байна.

Засгийн газраас аялал, жуулчлалын хөгжлийг дэмжих, Монгол орныг гадаад орнуудад сурталчлах зорилгоор 2003 оныг “Монголд зочлох” жил, 2004 оныг “Монгол орныг нээх” жил, 2006 оныг “Их монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн” жил болгон зарласан нь манайд ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Гадаадын арав гаруй оронд монголын аялал жуулчлалын асуудал хариуцсан өргөмжит консулууд ажиллаж Монгол орныг сурталчилахад багагүй үүрэг гүйцэтгэж байна. Аялал жуулчлалын мэдээллийн төвүүдийг Улаанбаатар хот, 4 аймгийн тав, Токио, Сөүл, Бээжин хотуудад нээн ажиллуулж байна.

#### 4.4 БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ

Монгол орны нийт нутаг дэвгэрийн дөрөвний нэг гаруй хувийг хамардаг баруун бүсийн газрын санд хөдөө аж ахуйн болон ойн сан бүхий газар зонхилж, харин бусад зориулалтын газар 3 хүрэхгүй хувийг эзэлж байна. Баруун бүсэд 29 сумыг хамарсан 9607.7 мянган га талбайтай 18 газрыг тусгай хамгаалалтанд авсан нь улсын нийт тусгай хамгаалалттай 45.82% болж байна. Гэвч энэ бүс нутагт газрын ашиглалт хамгаалалттай асуудлууд хуримтлагдсаар байна. Сүүлийн жилүүдэд малчид худаг устай өвөлжөө хаваржаа тойрон бөөгнөрсний улмаас бэлчээрийн талхлагдал нэмэгдэн, авто зээлийн хэрэгслийн олон салаа зам газрын хөрсийг сүйтгэн бэлчээрийг ихээхэн хомсдуулжээ. Мөн инженерийн хийцтэй худгаа эвдэж сүйтгэсний улмаас их хэсжээний бэлчээрийг ашиглаж чадахгүйд хүрчээ. Ашигт малтмал олборлолттой холбоотойгоор хөрсний эвдрэл ихсэх хандлагатай болж байна.

Баруун бүс нутагт агаар бохирдуулдаггүй өндөр үр ашигтай, дэвшилтэт техник, төхологи нэвтрүүлэх, бохирдуулагч эх үүсвэрүүдийг цөөлөх, шаталт сайтай зуух, түлшийг өргөн хэрэглэх, хог хаягдлыг ахин боловсруулах, хот суурин газрыг зүлэгжүүлэх зэрэг ажлыг дэс дараатай хийж, хэвшүүлэх шаардлагатай байна.

Зуд, хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, мөндөр, хүйтэн бороо орох, үер, ган, хүн мал ургамал, амьтны гоц халдварт өвчин, ой хээрийн түймэр зэрэг байгалын гэнэтийн үзэгдэд гамшиг зэрэг үе үе тохиолдож мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл болон эдийн засаг байгал орчинд багагүй хохирол учруулсаар байна.



Байгалын гамшгийг судлах, урьдчилан сэргийлэх, нэгэнт тохиолдсон гамшигтай тэмцэх, учирсан хохиролыг багасгах чиглэлээр олон улсын байгууллагуудаас дэмжлэг туслалцаа үзүүлж, удирдлага зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээ авдаг боловч гамшгийн хувь хэмжээ тууштай буухгүй байна.

#### 4.4.1 Ус, агаар мандлыг хамгаалах талаар

2003 онд явуулсан гадаргын усны нэгдсэн тооллогын дүнгээс харахад Баруун бүсэд байдаг 1126 гол горхиос 45 нь, 2920 булаг шандаас 136 нь, 1694 нуур, тойрмоос 229 нь хатаж ширгэсэн байжээ. Ялангуяа Баян-Өлгий аймагт мөстлөгийн гаралтай 217 жижиг нуур тойром ширгэсэн нь ихээхэн анхаарал татаж байна. Мөн Баян-Өлгий аймагт 17 гол горхи, 42 булаг шанд, Говь-Алтай аймагт 35 булаг шанд, Завхан аймагт 19 гол горхи, Увс аймагт 31 булаг шанд хатаж ширгэсэн нь, нэг талаар хүний буруу үйл ажиллагааны үр дагавар, нөгөө талаар дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, дулааралтай холбоотой юм.

Сүүлийн үеийн ажиглалт, судалгаагаар Монгол Алтайн өндөр уулын мөстөл багасч, хур цас мөс ихээр хайлж, цас мөсгүй болох явдал ажиглагдсаар байна. Жишээ нь Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын Рашаант голын эхний мөсөн гол хайлж хэмжээ нь багасчээ.

Хүрээлэн буй орчны өөрчлөлтөөс хамаарч голын урсацын горим өөрчлөгдөх, усны баланс алдагдах явдал ажиглагдах боллоо. Жишээ нь Идэр голын (Тосонцэнгэл) савд нэгж тунадасаас үүсэх урсацын хэмжээ нэмэгдсэн нь ойн талбай багасч, бэлчээр талхлагдсаны улмаас гадаргын нэл урсацын хэмжээ ихэссэнтэй холбоотой юм. Гэтэл Ховд (Өлгий, Мянгад), Чигэстэй (Улиастай) голуудад нэгж тунадасаас үүсэх урсацын хэмжээ багассан нь усны эрчим хүчийг ашиглах, уул уурхайн зориулалтаар ус ашиглах, усан сан байгуулах, усалгааны суваг шуудуу татах, усны гадаргаас уурших ууршилт нэмэгдэх, ашигт малтмалын олборлолтын явцад газрын гадарга ихээхэн эвдэгдэх зэрэг орчны өөрчлөлтийн шууд үр дагавар юм. Ялангуяа алт олборлолтын нөлөөгөөр голын ус булингартах, бохирдох, горим өөрчлөгдөх, гольдирол нь эвдэгдэх явдал Увс аймгийн Түргэн сумын Ногоон усны булаг, Бургалтайн гол, Улаангом сумын Гашууны гол зэрэг газруудад тодорхой ажиглагдана. Түүнчлэн ахуйн хог хаягдлаас болж голын ус бохирдох үзэгдэл Буянт гол (Ховд хот), Билүү гол (Увс аймгийн Хяргас сумын төв), Гэдрэг гол (Увс аймгийн Малчин сумын төв), Чигэстэй гол (Улиастай хот)-ын орчимд хийсэн судалгаагаар илэрчээ. Гадаргын ус, голуудын урсацын горим өөрчлөгдсөнөөс шалтгаалан газрын доорхи усны тэжээл дутагдаж хомсдол үүсч байгааг судлаачид нотолж байна.

Сүүлийн 40 гаруй жилд Баруун бүсийн уур амьсгал мэдэгдэхүйц дулаарч агаарын жилийн дундаж температур нийт нутгийн хэмжээнд 1.64°C-аар, Увс, Ховд аймагт 2.03-2.1°C-аар нэмэгдсэн бөгөөд дулааралт өвлийн улиралд илүү эрчимтэй байна. Үүний зэрэгцээ агаар мандлын гаралтай хүчтэй салхи шуурга, аадрын үер бороо, ган, зуд, шар шороон шуурга (буюу түйрэн) мэтийн байгалийн гамшигт үзэгдэл байнга тохиолдож давтамж нь өсөх хандлагатай байна. Их Нууруудын хотгор, Алтайн Өвөр говийн хотгоруудад хүчтэй хуйлраа салхи үе үе үүсч өнгөн хөрсний нарийн тоос шороог хэдхэн хормын дотор 3-5км хүртэл өндөрт хөөргөж, тийнхүү агаар мандалд дэгдсэн түйрэн дунджаар 180-200км/цаг-ийн хурдтай зүүн ба зүүн өмнө зүг рүү хийсч 2-3 хоногийн дараа Бээжин хот, Солонгосын хойг, Японы аралд хүрдэг байна. Тэр ч байтугай Монголын говьд үүссэн тоос түйрэн агаарын урсгалаар зөөгдөж 7 хоногийн дотор Америк, Канадын баруун эрэгт хүрэх тохиолдол олонтаа гарч, шар шорооны нүүдэл буюу түйрэнгээс хамгаалах асуудал Монгол, Хятад, Солонгос, Япон улсын судлаачдын хамтын ажиллагааны нэг чухал сэдэв болоод байна. 1950-иад онд жилд 5 удаа болдог байсан шар шороон шуурга 1990 онд 17 удаа, 2000 онд 12 удаа, 2001 онд 32 удаа тохиолджээ. Зарим газар шороон шуургатай өдрийн тоо 2-3 дахин нэмэгдэж хөрсний эвдрэл, элсний нүүлт, цөлжилт эрчимжих хандлага ажиглагдсаар байна.

Ус хамгаалах, усны нөөцийн менежментийг боловсронгуй болгох, усны бодлогын шинэтгэлийг хэрэгжүүлэх зорилгоор Баруун бүсийн хэмжээнд нэлээд олон чиглэлийн ажлыг төлөвлөж дэс дараатай үйл ажиллагаа явуулах хэрэгтэй. Үүнд:

- Хот, төв, суурин газар, уул уурхай, эрчим хүч, усалгаатай тариалангийн салбарт усны нөөцийн нөхөн сэлбэгдэх хэмжээг үндэслэн усны хэрэглээг үр ашигтай зохион байгуулах;
- Гол усны эх, булаг шандыг хашиж хамгаалах, мод сөөг тарих, хүн, мал, техникийн элдэв нөлөөллөөс сэргийлэх, голын усны гольдиरोлыг эвдэхгүй байх, голоос элс хайрга олборлохыг хориглох талаар орон нутгийн иргэдийн хяналт, идэвхтэй оролцоонд тулгуурлан үр өгөөжтэй, тууштай, тодорхой үнэлэмжтэй ажлууд хийж хэвшүүлэх;

- Голын усны ажиглалтын харуул, нуур усны мониторинг судалгааны цэгийг олшруулах, Алтай Таван Богд, Цамбагарав зэрэг ууланд мөсөн голын байнгын судалгааны цэгүүд байгуулах, мөн газрын доорх усны хяналтын сүлжээ бий болгох замаар усны нөөц, горим, чанар, хувьсал өөрчлөлтийг нарийвчлан судалж Бүс нутгийн усны мэдээллийн нэгдсэн сан байгуулах, улмаар шийдвэр гаргагчид ба хэрэглэгчдийг усны мэдээллээр шуурхай хангах орчин үеийн үйлчилгээний системийг нэвтрүүлэх;
- Усны эрэл хайгуулын ажлын техник, технологийг шинэчлэх, хүн ам, хөдөө аж ахуй, үйлдвэр, уул уурхайн усан хангамжийг сайжруулах, инженерийн худаг, уст цэгүүдийг олшруулах арга хэмжээг нэгдсэн бодлогоор зохицуулж хэрэгжүүлэх;
- Усны холбогдолтой Монгол Улсын (Байгаль орчныг хамгаалах тухай, 1995-3-30; Усны тухай, 2007-04-22; Ус, рашааны нөөц ашигласан төлбөрийн тухай, 1995-5-22; Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, 2002-6-13; Рашааны тухай, 2003-11-7; Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, 1998-1-22; Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, 1997-11-13; Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, 1999-12-16 гэх мэт) хуулиудыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, олон түмний дунд өргөн сурталчлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох ажлыг тогтмол зохион байгуулж, энэ ажилд орон нутгийн засаг захиргааны болон хуулийн байгууллагын ажилтнууд, иргэд, малчид, багш, оюутан нарыг идэвхтэй оролцуулах;
- Төв, суурин, уул уурхайн газруудын болон үйлдвэрийн хог хаягдлыг гол горхи, нуур усны эргээс хол байршуулж газарт булж далдлах, хаягдал ус цэвэрлэх, зайлуулах арга технологийг боловсронгуй болгох, химийн хорт болон аюултай бодис хэрэглэх, ялгаруулах үйл ажиллагаанд хатуу хяналт тавих зэргээр усны бохирдлоос урьдчилан сэргийлэх бүхий л боломжтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Орон нутгийн нөхцөл боломжийг ашиглан цасны болон хур борооны ус, гадаргын урсацыг тогтоон хуримтлуулах замаар хөдөө аж ахуйн (мал, тариалан, хадлангийн) усан хангамжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хөхүүлэн дэмжиж, мэрэгжлийн болон санхүүгийн туслалцаа үзүүлэх;
- Уул уурхай, усан цахилгаан станц болон байгалийн нөөц баялагийг ашигладаг үйлдвэр, аж ахуйн бүх газруудад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийхдээ усан орчны асуудалд онцгой анхаарч гол горхины эх ундаргыг хөндөхгүй байх, усны хомсдол, бохирдол үүсэхгүй байх нөхцөлийг хангах;
- Төв, суурийн газруудын ундны усны эх үүсвэрийг баталгаажуулах, хүн амын болон үйлдвэрийн усны хэрэглээний нормыг шинэчлэн тогтоох, ундны усыг зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх, иоджуулах арга хэмжээг авах;
- Гадаргын ус болон уст цэгүүдийн үзлэг тооллогыг үе үе явуулж усны хангамжийн түвшинг шинэчлэн тогтоох;
- Байгаль дахь экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөөгүйгээр бэлчээр, хадлан, тариаланг усжуулах, усалтын системүүдийг технологийн горимын дагуу зөв зохистой ашиглах;
- Говийн баян бүрдүүд болон ус намгархаг газрыг хатаж хагсахаас хамгаалахын тулд тэнд хүн, мал олноор бөөгнөрүүлэхгүй, мод, бут сөөгийг нь огтлохгүй, өвс ургамлыг нь талхлахгүй, газар ухаж, суваг шуудуу татахгүй байх зэрэг наад захын дэг журам тогтоож хэвшүүлэх;
- Усны урсацын 70%-ийг бүрэлдүүлдэг голуудын сав газрын эхэн хэсгийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулах чиглэлийг баримтлан зарим газрыг улсын буюу орон нутгийн тусгай хамгаалалтад нэмж авах;
- Усны нөөцийг (ер нь байгалийг) ашиглах, хамгаалах үйл ажиллагааг төлөвлөхдөө зөвхөн засаг захиргааны нэгжийн (аймаг, сумын) хилээр биш гол усны ай савын хилийг баримтлан ай савын менежментийн зарчмаар төлөвлөж хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй гэж нотолдог гадаад орнуудын туршлагыг нэвтрүүлж Ховд голын, Увс нуурын, Завхан голын гэх мэт ай сав тус бүрийн усны гүйдлээр нэвт холбоотой байгалийн нэгдмэл тогтолцоог бүхэлд нь хянах боломжийг туршиж үзэх;

Агаар мандлыг хамгаалах талаар дараах зарим зүйлийг хийж болох байна. Үүнд:

- Хил дамнасан шар шороон шуурга буюу түйрэн үүсдэг гол голомт газрууд болох Их Нууруудын хотгор доторхи хотос хонхоруудын ёроол болон Алтайн чанадахь хотгоруудын ёроолыг ургамалжуулах, тэндхийн хөрсийг бэхжүүлэх, мод, бут сөөг тарих ажлыг эрчимтэй өрнүүлэх замаар агаарын доод үеийн хуйлраа хөдөлгөөнийг сааруулах, энэ чиглэлээр олон улсын хамтарсан төслүүд хэрэгжүүлэх;
- Агаар дахь хүлэмжийн хийн агууламжийг багасгах зорилгоор ой мод, бут сөөг тарих ажлыг Баруун бүсийн бүх аймаг, сумдын нутагт, тэр тусмаа Хангай, Монгол Алтайн нурууны ой нь устаж үгүй болж байгаа нутагт, мөн голын татам хөндий, ус намгархаг газруудаар далайцтай өрнүүлж, энэ чиглэлээр Азийн хөгжлийн ба Дэлхийнн банк, Даян дэлхийн байгаль хамгаалах сан, бусад олон улсын байгууллага болон хөтөлбөр, төслүүдийн шугамаар дэмжлэг тусалцаа авах асуудлыг үр дүнтэй, шуурхай, ажил хэрэгчээр зохион байгуулах;
- Шар шороон шуурганы (түйрэнгийн) эх үүсвэр, нүүдлийн замыг тодорхойлох, мониторингийн судалгаа явуулах, мэдээллийн систем бүрдүүлэх, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судлах, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга замыг боловсруулах чиглэлээр Монгол, Хятад, Япон, Солонгосын хамтарсан төсөл хэрэгжүүлэхээр бэлтгэж байгаа бөгөөд энэ төслийн гол үйл ажиллагааг Баруун бүсэд төвлөрүүлэх асуудлыг дэвшүүлж цаг алдалгүй шийдвэрлүүлэх;
- Аймаг, сумын төв, уул уурхайн газруудын агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн тооллого явуулах, агаарын бохирдлын түвшин болон бохирдуулагч эх үүсвэрт байнгын хяналт тавих, шинээр байгуулах ба өргөтгөх үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламжийн төсөлд агаар мандалд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж зөвшөөрөл олгох;
- Гүйцэд шатаалттай гэрийн зуухны технологи, утаагүй түлш нэвтрүүлэх замаар зуухнаас гарах утааг багасгах, хог хаягдлыг ил задгай хаях, шатаахыг бүрмөсөн хориглох арга хэмжээ авах, шахмал түлш үйлдвэрлэхэд хувийн хэвшлийнхний оролцоог бүх талаар дэмжиж мэрэгжлийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- Аймагуудын төвд хог хаягдал ялгах, боловсруулах бага оврын үйлдвэрүүд байгуулах;
- Төв, суурингийн халаалтыг аажимдаа цахилгаан эх үүсвэрт шилжүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх;

#### 4.4.2 Хөрс хамгаалах талаар

Баруун бүсэд хүний үйл ажиллагааны нөлөөгөөр газрын хөрс эвдэрч элэгдэх, үржил шим нь буурч муудах явдал олон хэлбэрээр илэрдэг. Үүнд:

- Бэлчээрийн ургамал хэт талхлагдсанаас болж хөрсний өнгөн үе эвдрэх, шинж чанар нь муудах;
- Тариалангийн хөрс салхинд хийсч элэгдэх, өнгөн хэсэг нь элсжих;
- Тариалангийн хөрсний ялзмагийн алдагдал даамжирч, үржил шим нь буурах;
- Автомашины олон салаа замын уршгаар газрын хөрс эвдрэх, ашиг шимээ алдах;
- Уулын хажуу, хэвгий газрын хөрс гадаргын урсацаар эвдэрч, гуу жалга үүсэх;
- Хажуу, хэвгий газруудад, ялангуяа худаг, усны ойролцоо малын хөлөөр нарийн жим зөрөг нэлдээ үүсч хөрс дагтарших, эвдрэх нөхцөл бүрдэх;
- Ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, уул-техникийн үйл ажиллагааны нөлөөгөөр газар эвдэрч, хөрс устах, бохирдох;
- Элсний нүүдэл газар авч хөрсний гадаргуу элсээр хучигдах, шинж чанар нь доройтох;
- Хот, төв, суурин газрын хөрс хувирч өөрчлөгдөх, бохирдох;
- Олон жилийн цэвдгийн гэсэлтээс улбаалж хөрс гулсах, цөмрөх, суух үзэгдэл элбэгших;

Дээрх үзэгдлүүдээс бэлчээрийн хөрсний доройтол, тариалангийн хөрсний элэгдэл ба үржил шимийн алдагдал, элсний нүүдэл, автозамын дагуух хөрсний эвдрэл, ашигт малтмалын олборлолтоос үүссэн ухмал нүх, овоолгон шороо хамгийн түгшүүр төрүүлж байгаль орчин, эдийн засаг, нийгмийн амьдралд үлэмж хор хохирол учруулсаар байна. Цаашид хөрс хамгааллын талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- Бэлчээрийн ургамлыг нөхөн сэргээхийн тулд таримал бэлчээр, хадлан бий болгох, дулааны улиралд бог малыг бэлчээрт нь хотлуулж өнжөөх ажлыг хуваарьтай зохион байгуулах;

- Тариалангийн талбайн хагалгааны шан, тариалах зурвасыг салхины голлох чиглэлд хөндлөн байрлуулах, 50 м-ээс өргөнгүй зурвасаар сэлгэн тариалах;
- Тарианы гуурсыг талбайд нь өнжөөх, хөрсийг хавж хагалах, хөшиг ургамал тарих, нүцгэн талбайг гуурсаар хучих, цас тогтоох, боломжтой нөхцөлд хаврын цэнэг усалгаа хийх, мод, бут сөөгөн зурвас байгуулах, механик хамгаалалт хийх зэрэг тариалангийн хөрсийг салхинд хийсч эвдрэхээс хамгаалах бүхий л арга ажиллагааг цаг алдалгүй, чанартай гүйцэтгэж байх;
- Тариалангийн талбайд агрохимийн зураглал хийж, эрдэс ( NPK ) болон органик бордооны тун хэмжээг тогтоож, талбайг агротехнологийн шаардлагын дагуу тогтмол бордож байх, малын өтөг, бууц зэрэг орон нутгийн бордоог өргөнөөр ашиглах;
- Эвдэрсэн хөрс, элсжсэн талбайг ургамалжуулах, ногоон бордоо хэрэглэх, органик барьцалдуулагч болон цеолит мэтийн шингээгч бодисоор бордож хөрсний физик шинжийг сайжруулах арга хэмжээ авах;
- Автомашины хөдөлгөөнийг цэгцлэх, олон салаа зам гаргуулахгүй байх, хаягдсан хуучин замуудыг сийрэгжүүлж ургамалжуулах ажлыг автозамын байгууллагууд болон олон түмнийг идэвхтэй оролцуулан үр нөлөөтэй зохион байгуулах;
- Уул уурхайн ашигласан талбайг засч тэгшлэх, биологийн нөхөн сэргээлт хийж хөрсжүүлэх, ургамалжуулах ажлыг технологийн дагуу заавал гүйцэтгүүлж түүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог өндөржүүлэх;
- Хот, төв, суурин газрын хөрсийг зүлэгжүүлэх, мод, бут сөөг тарих, нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн талбайг стандартын шаардлагад хүргэх, ахуйн хог хаягдал болон хөрсний бохирдол үүсгэж болох үйлдвэрийн хаягдал, бохир усыг цэвэрлэх, саармагжуулах, зайлуулах, түүнд тавих эрүүл ахуйн хяналтыг эрс сайжруулах;
- Элсний нүүдлээс хамгаалах биологийн болон механик аргыг өргөн нэвтрүүлэх, төв, суурингийн орчимын элстэй газрыг чулуугаар хучих, явган хүний зам, гудамж талбайд байгалийн зассан чулуу шигтгэж тэгшлэх зэрэг хямд төсөр энгийн аргыг түлхүү хэрэглэх;
- Усалгаатай тариалангийн усалгааны норм горим, техник технологийг орон нутгийн нөхцөлд тохируулан зөв сонгож, усалгааны нөлөөгөөр хөрс давсжихаас болгоомжлох, усалгаатай талбайн хөрсний шинж чанарын өөрчлөлт, шим тэжээлийн хангамжийг тогтмол хянаж байх;
- Газар ашиглалттай холбоотой Монгол улсын (Газрын тухай, 2002-6-7; Газрын төлбөрийн тухай, 1997-4-24; Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, 2002-6-27; Тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн тухай, 1997-10-23; Газрын хэвлийн тухай, 1988-11-29; Ахуйн ба үйлдвэрийн хог хаягдлын тухай, 2003-11-26; гэх мэт) хууль дүрмийг өргөн сурталчлах, түүний хэрэгжилтэд байнга хяналт тавьж зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцож байх журмыг хэвшүүлэх;

#### **4.4.3 Ургамал, ан амьтныг хамгаалах талаар**

Баруун бүсийн ургамлан нөмрөг, ялангуяа бэлчээрийн ургамал ихээхэн талхлагдаж, зүйлийн бүрэлдхүүн нь цөөрөх, урамлын бүрхэц сийрэгжих, элсээр хучигдах явдал газар сайгүй ажиглагдана. Өөрөөр хэлбэл цөлжилтийн үйл явц их эрчимжиж цөлийн эзлэх талбай жилээс жилд тэлсээр байна. Сүүлийн 10 гаруй жилд Монгол орны хэмжээнд цөлжилтөд хүчтэй нэрвэгдсэн нутгийн талбай 5.4 дахин, маш хүчтэй цөлжсөн нутгийн талбай 1.8 дахин ихэссэн гэсэн тооцоо бий бөгөөд үүний нэлээд хэсэг нь Баруун бүсэд хамаарна.

Цөлжилттэй тэмцэх явдал дэлхий нийтийн хэмжээний хурц асуудал болж улс гүрнүүдийн хамтын хүчин чармайлт, олон улсын байгууллагуудын нэгдмэл ажиллагааг зүй ёсоор шаардаж байна. Цөлжилттэй тэмцэх НҮБ-ийн конвенцийг 1994 онд баталж, Монгол Улс энэ конвенцид нэгдэн орсноос хойшхи 13 жилийн хугацаанд цөлжилттэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хоёрдох удаагаа боловсруулж 2003 онд Засгийн Газраас батлажээ. Уг хөтөлбөрийн гол зорилго нь уур амьсгалын өөрчлөлт (дулаарал), хүний зохисгүй үйл ажиллагаанаас шалтгаалан жилээс жилд улам эрчимжиж буй цөлжилтийн явц, түүний сөрөг нөлөөллийг сааруулах цогц арга хэмжээг байгаль орчны даац болон бүс нутгийн онцлогт тохируулан үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэхээр тусгажээ. Цөлжилттэй тэмцэх Конвенци болон Азийн бүсийн цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Монгол Улс тодорхой үүрэгтэй оролцож төрийн бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээ тусгаж хэрэгжүүлж байгаагаас гадна цөлжилт, газрын доройтолтой тэмцэх

чиглэлээр олон улсын хэд хэдэн төсөлд оролцож, “ Цөлжилтөөс сэргийлэх нэгдсэн менежмент” төслийн хүрээнд говийн бүсийн 12 сумын нутагт 43 нөхөрлөл байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. Үүний үр дүнд орон нутгийн засаг захиргаа тус тусын нутаг дэвсгэрийн хүрээнд цөлжилттэй тэмцэх хөтөлбөр, төлөвлөгөөгөө боловсруулж доройтсон газрыг нөхөн сэргээх, мод сөөг тарих, худаг ус гаргах зэрэг бодитой ажлууд хийжээ.

Ургамал, ан амьтан болон байгалийн экосистемийн тодорхой хэсгийг хамгаалахад чиглэгсэн төрийн бодлогоор зохицуулагддаг хамгийн чухал арга хэрэгсэл бол улсын тугай хамгаалалттай газар нутгийн сүлжээ юм. Манай улсад 60 тусгай хамгаалттай газар байдгаас 20 нь Баруун бүсэд байрладаг. Түүний 5 нь дархан цаазтай газар (Говийн их дархан газар А,Б хэсэгтэй, Хөх Сэрхийн нуруу, Хасагт-Хайрхан, Отгонтэнгэр, Увс нуурын ай савын), нийлбэр талбай нь 6213153 га, 8 нь байгалийн цогцолборт газар (Алтай Таван Богд, Хар-Ус нуур, Цамбагарав, Сийлхэмийн нуруу, Хан-Хөхий-Хяргас нуур, Тарвагатайн нуруу, Мянган Угалзат, Мөнххайрхан уул), нийлбэр талбай нь 3179922 га, 6 нь байгалийн нөөц газар (Булган гол, Алаг-Хайрхан, Бурхан-Буудай, Дэвэлийн арал, Тэсийн гол, Шарга-Манхан), нийлбэр талбай нь 599436 га, 1 нь байгалийн дурсгалт газар-Ээж Хайрхан, талбай нь 22475 га юм. Эдгээр тусгай хамгаалалттай газар нутгийн нийт талбай 10014986 га буюу Баруун бүсийн бүх нутгийн 24.1%-ийг эзэлнэ. Үүнээс үзэхэд Баруун бүс дэх улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ улсынхаас бараг 2 дахин илүү нягтшилтай тул хангалттай гэж хэлж болно.

Ургамал, ан амьтныг хамгаалахад зориулсан хоёрдох томоохон арга хэмжээ бол Монгол Улсын Улаан Номыг бүтээж, түүнд манай орны ховор ба устаж үгүй болж байгаа амьтан, ургамлыг бүртгэн жагсааж олон нийтийн хүртээл болгосон билээ. Баруун бүсийн хэмжээнд устаж байгаа 5 зүйл хөхтөн амьтан (цөөвөр чоно, мазаалай, монгол бөхөн, соргог бөхөн, хавтгай), 2 зүйл шувуу (жороо тоодог, реликт цахлай), ховор ба ховордож байгаа 11 зүйл хөхтөн (азийн минж, атигдаахай, өөхөн сүүлт атигдаахай, козловын алагдаага, ойн унтаахай, эрээн хүрнэ, ирвэс, монгол хулан, зэгэсний гахай, харсүүлт зээр, алтайн аргаль), 11 зүйл шувуу (борцгор хотон, халбаган хошуут, хар өрөвтас, гангар хун, хуруут хун, хошуу галуу, хээрийн галуу, явлаг сар, усны цагаан сүүлт бүргэд, гургуул, тоодог) Монгол Улсын Улаан Номонд бүртгэгджээ. Ургамлын хувьд гэвэл Баруун бүсэд ургадаг хөнөөгдөж байгаа болон ховордсон 26 зүйл ургамлыг Улаан Номонд оруулжээ. Тухайлбал: алтайн сонгино, цагаан цэцэгт сонгино, далиу сонгино, цоохор чонын хор (чонохор), монгол тост, вансэмбэрүү, дэвүүрт сагай, пржевальскийн чармай (улаан түлээ), заг, дөрвөлсөн мүгээ, алтан гагнуур, зүүнгарын гоёо, яшилдуу чацаргана, шивлээхэй зээргэнэ, шивүүрт харгана (тэмээн харгана), хонхот харгана, ганц навчит салжир, үнэгэн сүүлхэй лидэр, өлчир дэгд (цагаан дэгд), ганц цэцэгт алтан зул, цагаан бөлбөө, алтан сахуу цэцэг, эгэл өмхий өвс, эгэл шагшуурга, ямаан сэрдэг, сухай, тоорой зэрэг болно.

Ургамал хамгааллын талаар Баруун бүсэд доор дурьдсан зарим арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Бэлчээрийн талхагдал, доройтол, цөлжилттэй тэмцэх чиглэлээр бүс нутгийн хөтөлбөр боловсруулж олон улсын болон үндэсний хөтөлбөр, төслүүдтэй нягт уялдуулан тэдний дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх;
- Ой модыг хяналтгүй огтолж ашиглах, ойн түймэр гарах аюулыг таслан зогсоож ойг нөхөн сэргээх, мод сөөг тарих үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах, мод үржүүлгийн ажилд дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх;
- Ойн цэвэрлэгээ хийх, хортон шавьжтай тэмцэх ажлыг тогтмолжуулах;
- Ойд самар, жимс, мөөг, эмийн болон бусад ургамал түүх, явган аялал, зугаалга зохиох зэрэг ажлыг орон нутгийн холбогдох байгууллагын зөвшөөрлөөр, байгаль хамгаалагчийн хяналтын дор гүйцэтгэж байх журмыг мөрдөх;
- Говийн бүсийн бут сөөг, заган ойг огтолж ашиглахыг бүрмөсөн хориглох;
- Бэлчээрийг 4 улирлын турш хуваарьтай, сэлгэж ашиглах, худаг усны ойролцоо болон голын эхэнд олон айл, мал бөөгнөрүүлэхгүй байх;
- Ховор ба ховордсон ургамлыг тарьж үржүүлэх, үрийн фонд бий болгох санал санаачилгыг бүхий л талаар дэмжиж олон улсын болон үндэсний төсөлд хамруулах, мэрэгжлийн болон санхүүгийн тусламж үзүүлэх;
- Ургамлын холбогдолтой Монгол Улсын хуулиудыг (Байгаль орчныг хамгаалах тухай, 1995-3-30; Ойн тухай, 2007-5-17; Байгалийн ургамлын тухай, 1995-4-11; Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, 1994-11-15; Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай, 1996-5-28;

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай, 2000-1-28; Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай, 1995-5-19; Ургамал хамгааллын тухай, 1996-3-22; гэх мэт ) судалж, сурталчлах ажлыг иргэд, олон түмний дунд өргөн хүрээтэй зохион байгуулж, хууль хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих хариуцлага тооцоход онцгой анхаарч энэ талаар засаг захиргаа, хууль хяналтын байгууллагуудын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх;

- Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох ажлыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах;

- Үлийн цагаан оготно болон царцааны тархалт, хор хөнөөлийг багасгах дэвшилтэт аргуудаас орон нутагт туршиж, сонгон нэвтрүүлэх;

- Бүс нутгийн ойн мэдээллийн сан, мониторингийн сүлжээ байгуулах, ойг хамгаалах, зохистой ашиглах, тарималжуулах, нөхөн сэргээх ажлыг мэрэгжлийн боловсон хүчин, техник тоног төхөөрөмжөөр хангах;

- Ойн хортон шавьж, өвчинтэй байгальд халгүй аргаар тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх болон түймэр унтраах ажилд мэрэгжлийн хүмүүсийг сургаж бэлтгэх, багаж техникээр хангах;

Ан амьтныг хамгаалах чиглэлээр зарим шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- Ан агнуурын үйл ажиллагааг зөвхөн хуулийн дагуу, зөвшөөрөгдсөн хугацаанд явуулж, элдэв зөрчил гаргах явдалтай тэмцэх, түүнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд ард иргэдийн оролцоог идэвхжүүлэх ажлыг зохион байгуулах;

- Хүүхэд, сурагчид, залуучуудад амьд байгаль, ан амьтан, жигүүртэн шувуудыг хайрлан хамгаалах, халамжлан тэтгэх био гоозүйн хүмүүжил олгох талаар тодорхой ажлууд зохиж хэвлэл, телевиз, радио нэвтрүүлгийг өргөн ашиглах;

- Тусгай хамгаалалттай газруудын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах, ажилтнуудын мэдлэг чадвар, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, тусгай хамгаалалтын дэглэм горимыг чанд сахиж хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтын механизмыг боловсронгуй болгох арга хэмжээг авах;

- Зэрлэг ан амьтан, жигүүртэн шувуу, загас жараахайг өсгөн үржүүлэх, шилжүүлэн нутагшуулах, тэдний амьдрах орчиныг сайжруулах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр орон нутгийн болон үндэсний хөтөлбөрийн хүрээнд, олон улсын төсөл тусламжаар янз бүрийн хэлбэрийн ажил зохион байгуулж олон түмний идэвх санаачлагыг өрнүүлэх;

- Ан амьтны талаарх Монгол Улсын хуулиудыг (Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, 1994-11-15; Ан агнуурын тухай, 2000-5-5; Амьтны аймгийн тухай, 2000-5-5; Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай, 2002-11-7; Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай, 1995-5-22; Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай, 2000-1-28; гэх мэт) судалж, сурталчлах ажлыг иргэд, олон түмний дунд өргөн хүрээтэй зохион байгуулж, хуулийг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих, хариуцлага тооцоход онцгой анхаарч энэ талаар засаг захиргаа, хууль хяналтын байгууллага, иргэдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх;

- Ан амьтадыг судлах, хамгаалах болон агнуур эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан тэдний дунд чөлөөт ярилцлага, семинар, зөвлөлгөөн зохион байгуулж ард иргэдийг өргөнөөр татан оролцуулахын хамт ан амьтаны нөөцийг зохистой ашиглах, өсгөж арвижуулах, хамгаалах талаар тухайн нутаг орны онцлогт нийцсэн хамтын шийдвэр гаргаж түүнийг дагаж мөрдөх;

- Ан амьтаны тооллогыг орон нутгийн хэмжээнд үе үе явуулж байгууллага, иргэдийг бодит мэдээллээр хангаж байх;

- Шаардлагатай гэж үзвэл ан амьтаныг хамгаалах, тоо толгойг нь өсгөх, ангийн нөөцтэй болох зорилгоор орон нутгийн хэмжээний тусгай хамгаалалттай газар байгуулах, ан агнуурын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хязгаарлах, хориглох зэрэг бие даасан шийдвэр гаргаж, биелтэд нь хяналт тавих;

- Аймаг, сумдын газар ашиглалтын төлөвлөгөөнд зэрлэг ан амьтадын амьдрах орчин, усны эх үүсвэрийг хамгаалах асуудлыг тусгаж хэрэгжүүлэх, биологийн төрөл зүйлийг хамгаалахад эдийн засгийн хөшүүргийг хэрэглэж хэвшүүлэх;

#### 4.5 БАРУУН БҮС НУТГИЙН ЭКОСИСТЕМ

Экосистемийн экологи-биологийн үнэлгээний асуудал нь ландшафтын экологийн нэгэн чиглэл, түүний гол анхаарал нь биотын биологийн ресурсыг аж ахуйн зориулалтаар ашиглах, биологийн элдэв янз хэлбэрийн объектыг хамгаалах, хадгалах чиглэлээр авч үздэг явдал бий, ерөнхийдөө ийм хандлагаар судладаг биоэкологийн чиглэл юм.

Баруун бүс нутгийн экосистемийн экологи-биологийн үнэлгээ нь орчин үед экосистемийн бүрдэл хэсэг хэрхэн хуваарилагдсан, тэдгээрийн нөөц баялгийг аж ахуйн зориулалтаар ашиглах, экосистемд нөлөөлж буй хүчин нөхцлүүд ба хүний нөлөөллийн хуваарилалт байршил төрөлжилт, экосистемийн биотуудын бүрэлдэхүүн хэсгийн тухайн байдлын үнэлгээг үндэслэн нөхөн сэргээх, зөв зохистой ашиглах арга, нөхцлийг илрүүлэх, залан зохицуулах асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн шинжлэх ухаан, технологийн цогцолбор ойлголтын нэгдмэл арга хэмжээний шинжлэх ухааны үндэслэл нь билээ.


##### 4.5.1 Монголын баруун бүс нутгийн газарзүйн байршил ба хил зааг

Энэ бүс нутаг нь ландшафт-бүс нутаг, физик-газарзүй, ургамал амьтны аймаг, газар тариалан, мал аж ахуй, аж үйлдвэрийн талаас авч үзэхэд Монгол улсад онцгой байр суурь эзэлдэг бүс нутаг юм. Энэ бүс нутаг нь зүүн талын хил нь Хангайн нуруугаар дайран Хангайн бүс нутагтай хиллэдэг, бусад талаараа улсын хилтэй уул тал хосолсон газар ажээ. Урд талаараа Зүүн гарын говьтой холбогдсон үүдтэй, зүүн талдаа Завхан аймгийн орчмоор Булнайн нурууг зүсч гарсан хойд баруун талаараа Монгол Алтайн нуруунаас Булнайн нуруу хүртэл Маншал, Курайн, Тагна, Сенгилений нуруудаар хүрээлэгдсэн. Баруун бүс нутаг нь Монголын нутаг дэвсгэр дээр дунджаар 2000-3000 м-ийн харьцангуй өндөртэй, 415300м<sup>2</sup> талбайг эзэлдэг байна.


Баруун бүсийн хойд хэсэг Алтай Соёны Экобүс нутагт орох ба Экологи – газарзүйн мужлалын хувьд дараах мужуудаас бүрдэнэ. (Зураг 1) Үүнд:

- Монгол Алтайн төв хэсгийн дэд муж
- Хархираа-Түргэний хэсгийн дэд муж
- Увс нуурын хотгорын дэд муж
- Хар ус – Хяргас нуурын дэд муж
- Мөнххайрхан уулын дэд муж
- Бор цонж – Хонин усны говийн дэд муж
- Говь-Алтайн салбар уулс, хотгорын дэд муж
- Хар Азарга – Гичгэний нурууны дэд муж
- Алтайн өвөр говийн баруун хэсгийн хэт гандуу цөл
- Хангайн нурууны баруун хэсгийн дэд муж
- Булнайн нурууны дэд муж
- Тарвагатайн нурууны дэд муж

- Хангайн нурууны төв хэсгийн дэд муж



Зураг 4.10 Баруун бүс нутгийн экологи-газарзүйн мужлал



Зураг 4.11 Алтай Соёны экобүс нутаг

**Алтай Соёны экобүс нутаг** нь Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (WWF)-гаас тодорхойлсон дэлхий дээрхи зайлшгүй хамгаалбал зохих 200 экобүс нутгийн нэг бөгөөд Монгол, ОХУ, Казакстан, БНХАУ-ын нутгийг дамнан оршдог онцлогтой. Нийт нутгийн хэмжээ 862000 км<sup>2</sup>, түүнээс Монголд 29%, ОХУ-д 62%, Казакстан-д 5%, БНХАУ-д 4% тус байна.



Энэхүү глобал экобүс нутаг нь газар зүйн хувьд дотроо Алтайн нурууны ойт хээр, тундр, Соёны нурууны тундр, шилмүүст ой, Их нууруудын сав газрын цөлжүү хээр зэрэг эх газрын дэд экобүс нутгуудаас бүрддэг. Үүний дотор Монгол Улсын нутагт хамаарагдах бүс нутгаас өндөр уулын болон хээр, цөлжүү хээр, ус намгархаг газрууд хосолсон Их нууруудын сав газар болон олон нуур, усны өлгий болсон Дархадын Хотгор чухал байр суурь эзэлдэг.

Баруун бүс нутгийн байгалийн нөхцөлд газрын гадаргын хотгор гүдгэр, ус зүйн сүлжээ, хөрс, хөрсний цэвдэг, ургамал ба амьтны аймаг, ургамалжилт, уур амьсгал ба цаг агаарын элементүүд газрын хэвлийн баялаг зэрэг олон хүчин зүйлийг багтаасан экосистемийн олон хэвшинж ордог. Баруун бүсийг дараах экосистем болгон хувааж судалсан юм. 1. Ойн экосистем, 2. Хээр газрын буюу бэлчээр, нугын экосистем, 3. Амьтны аймгийн бүрдэл, 5. Усны экосистем гэж хэсэглэж 1:500000 хураангуйлалтай зургийн төвшинд тодорхойлсон юм. Экосистемийг бүрдүүлж байгаа эдгээр олон хүчин зүйлийг өмнөх бүлгүүдэд дэлгэрэнгүй бичсэн байгаа тул энд товч авч үзэх нь экосистемийг тодорхойлоход хэрэгтэй гэж үзлээ.

**Уур амьсгал ба цаг агаарын нөхцөл.** Баруун бүс нутгийн экосистемийн олон хослол, бүрдэл хэсгийн сукцессийн үйл явц, ландшафт бүс нутгийн уур амьсгал ба цаг уурын нөхцөлтэй гүнзгий хамааралтай байдгаас дэлхий дахины хэмжээнд явагдаж байгаа уур амьсгалын өөрчлөлттэй нягт уялдаатайг харгалзан үзэж Монголын энэ нутагт ажиллаж байгаа цаг уурын станцуудын бүх хугацааны мэдээллийг задлан шинжилж өөрчлөлт ба явц, хандлагын чиг баримжааг тодорхойлсон юм. Судалгаанаас үзэхэд дулааралт зуны улиралд эрчимтэй явагдах төлөвтэй бөгөөд агаарын жилийн дундаж температур 2020 оны үед 1.4°C, 2050 оны үед 2.8°C, 2080 оны үед 4.9°C-аар, зуны температур дээрх онуудтай харгалзан 2.0°C, 3.5°C, 6.3°C-аар, өвлийнх 0.8°C, 2.4°C, 3.9°C-аар тус тус дулаарах төлөвтэй.


Энэ бүс нутгийн уур амьсгалын өөрчлөлтийн хандлагыг хүлэмжийн хийн А2 гэсэн хувилбарт үндэслэн тогтооход дулааралт нийт нутгаар ажиглагдах бөгөөд ялангуяа зуны улирлун дулааралт өвлийнхөөс илүү эрчимтэйгээр явагдах хандлагатай байна. Хур тунадас ерөнхийдөө нэмэгдэх хэдий ч олон жилийн дундажтай харьцуулахад энэ нь тийм ч их биш хувийг эзэлж байна. Ялангуяа зуны хур тунадас ойролцоогоор хамгийн ихдээ 9 хувиар нэмэгдэхээр байгаа нь дулааралт эрчимтэй явагдаж байгаа өнөө үед зун улам халуун хуурай болох төлөвтэй. Өвөлдөө энэ бүс нутагт дулаан, цас ихтэй болох хандлага ажиглагдаж байна. Дулааралтын эрчим харьцангуйгаар зуны улиралд их байгаа учир ууршуулах (нөгөө талаар харьцангуй бага хур тунадас нэмэгдэх) чадвар тэр хэмжээгээр нэмэгдэх энэхүү уур амьсгалын төлөв нь бүс нутагт цөлжих боломжийг нэмэгдүүлэх магадлал өндөр байна.

**Ус зүйн сүлжээ ба гидрогеологи.** Баруун бүс нутаг маш сайн хөгжсөн ус зүйн сүлжээтэй, Монголын томоохон усны ай сав нутаг болох Их нууруудын сав газар оршдог юм. Усны экосистемийг хямралд хүргэж болзошгүй нелеелелүүд нь еер хоорондоо хамаарал бүхий олон хүчин зүйлсээс хамаарч байна. Эдгээрийн дотроос:

1. Усны хомсдол,
2. Усны бохирдол,
3. Усны амьтан, ургамлын нөөцийн багасалт,
4. Голын гольдролд далан, хаалт барьснаас болж амьтны шилжилт хөдөлгөөн хязгаарлагдах байдал,
5. Усны нөөцийн удирдлага, зохион байгуулалтын бодлого болон хүчин чадал сул зэргийг бид чухалчлан авч үзэж байна.

**Ховд** аймгийн голуудын урсацын хэмжээ ерөнхийдөө өссөн хандлагатай, ялангуяа Дундцэнхэр, Үенч голуудад илүү ажиглагдаж байна. Голын урсацын олон жилийн хандлагаас үзэхэд Алтай нурууныөвөр хажуугаас усжих Булга, Бодонч, Үенч голынх өссөн, Алтайн нурууны ар ба зүүн хажуугаас усжих Ховд, Буянт, Дундцэнхэр голынх буурсан хандлагатай байна. Аймгийн голуудын усны температур 0.2°C ээр буурсан байна. Харин мөсөн бүрхүүлтэй байх хоногийн тоо Бодонч голоос бусад нь буурсан байна.

**Их нууруудын сав газар** нийт 288000 км<sup>2</sup> талбайг эзлэн хойд өргөргийн 46-51 градусын хооронд оршино. Тус сав газрын дундаж өндөр далайн түвшнээс дээш 2000 м орчим бөгөөд Монгол Алтайн нурууны зарим оргил 4000 м –ээс дээш оршдог байхад хамгийн нам дор хэсэг Увс нуурт 760 м байдаг. Их нууруудын сав газрыг дотор нь усзүйн сүлжээний тогтолцоо, газарзүйн онцлогийг харгалзан Увс, Хяргас нуурын сав гэж үндсэн 2 хэсэгт хуваадаг. Энэхүү хоёр нуурын сав газарт эдгээртэй усзүйн ил холбоогүй боловч ай савд нь багтдаг том жижиг олон нуур, цөөрөм Монгол Алтай, Хангай, Тагнын нуруу, Түргэний уулсын хооронд байдаг. Эндхийн бие биеээсээ эрс ялгарах өндөр уулс, өргөн тал, говь цөл, нуур ус



Зураг 4.12 Их нууруудын сав газар

намгархаг газар байгалийн нэгэн өвөрмөц тогтолцоог бий болгодог. Засаг захиргааны хувьд Их нууруудын сав газарт Увс, Ховд, Баян-Өлгий аймгууд бүхэлдээ Завхан, Голь-Алтай аймгийн ихэнх, Хөвсгөл аймгийн зарим хэсэг хамрагдан манай орны нутаг

дэвсгэрийн 18 хувийг эзлэдэг. Энэ бүс нутагт 320000 гаруй буюу Монгол улсын нийт хүн амын 14 хувь оршин суудаг бөгөөд дундаж нягтшил нь улсын дунджаас яльгүй доогуур 1.2 хүн/км<sup>2</sup> юм. Нийт хүн амын бараг тал хувь нь дээрх таван аймгийн төвд оршин суудаг байна.

Их нууруудын сав газрын хойд хэсэг нь (Увс нуурын сав газрын хойд хэсэг) ОХУ-ын нутагд оршдог. Их нууруудын сав нь ус зүйн хувьд Төв Азийн Гадагш Урсацгүй ай савд багтдаг. Энэ ай савд Монгол орны гол мөрний усны нөөцийн 40 хувь бүрддэгээс 90 гаруй хувь нь (12,5 шоо км) Их нууруудын сав газарт бүрэлдэнэ. Энэ нь манай орны усны нөөцийн бараг гуравны нэг юм (Мягмаржав, Даваа, 1999). Ийнхүү Их нууруудын сав газар нь эдийн засгийн ач холбогдол ихтэй, өвөрмөц усны экосистем бүхий нутаг юм.

**Тулгарч буй бэрхшээл, шийдвэрлэх арга зам.** Орчин үеийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр Их нууруудын сав газрын гол, горхи, нуурын усны улирлын горим, мөсний үзэгдэлд мэдэгдэхүйц өөрчлөлт гарч байна. Үүний зэрэгцээ усан цахилгаан станц, услалтын систем барьж байгуулах, бэлчээрийн талхагдал, уул уурхайн зэрэг хүний үйл ажиллагааны нөлөөнд ч мөн ихээхэн өртөх боллоо. Энэ бүгдийг зохицуулах зөв менежментийг бий болгох бүтцийн орчин ч дутагдаж байна. Бэлчээрийн талхагдлын нөлөөгөөр ургамлын нөмрөг багасгаад зогсохгүй төрөл зүйл хомсдож улмаар усны шувуу олноор цугларч өндөглөн зусдаг ус намгархаг газруудын орчны байдлыг доройтуулж байна.

Баригдахаар төлөвлөгдөж байгаа Дөргөний болон бусад усан цахилгаан станцууд нь тус сав газрын гол мөрний экосистемд тодорхой хэмжээгээр нөлөөлөх бас нэг хүчин зүйл болж байна. Сүүлийн жилүүдэд алт гэх мэт ашигт малтмал олборлох уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байгаагийн нөлөөгөөр байгаль орчны бохирдол нэмэгдэх, газрын гадрагын ландшафт өөрчлөгдөх, мөн усны хэрэглээ нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавар үүсч байна. Тиймээс, сав

газрын хэмжээнд байгаль орчны тогтвортой менежментийн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна. Нуур, голын усны унаган горимыг эвдэлгүйгээр байгаа усны нөөцөө тогтвортойгоор үр өгөөжтэй хүн амын унд, аж ахуйн хэрэгцээнд ашиглах нь байгаль орчны төлөв байдлыг доройтуулалгүй хадгалан үлдээхэд ихээхэн чухал юм.

Цаашид энэ бүс нутагт мөстлийн хайлалтын нөлөөгөөр гол мөрний гачиг урсац, ялангуяа халиа тошин нэмэгдэх ба цаашид мөстлийн талбай, усны нөөц үлэмж багасах явцад Увс нуурын түвшин түүний сав газрын гол мөрний урсац эргэлт буцалтгүй багасна. Иймд халиа тошин, газрын доорх усны мониторинг, түүнд тулгуурлан уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулахад чигдэгдсэн судалгаа туйлын чухал болно. Одоогоор тус бүс нутагт Дэлхийн байгаль хамгаалах сангаас судалгаа хийгдсэн байна.

**Хөрсөн бүрхэвч ба хөрс.** Баруун бүсийн аймгийн төвүүд болон сумдын хөрсөн дэх байгалийн цацраг идэвхит элемент, торийн агуулалт дэлхийн царцдас дахь дунджийн хэмжээнд байна. (Хүснэгт 1) Өлгий хотын төвийн хөрсөн дэх байгалийн цацраг идэвхит элемент калийн агуулга дэлхийн дундажтай ойролцоо, бусад хотынх 2-4 дахин их байна. Увс аймгийн сумдын хөрсөн дэх байгалийн цацраг идэвхит элемент калийн агуулалт дэлхийн дунджаас арай их, бусад сумдын хувьд дэлхийн дунджийн хэмжээнд байна.

Баруун бүсийн хотуудын хөрсөн дэх байгалийн цацраг идэвхит элементүүдийн хувийн идэвхи / Хүснэгт 4.16 /

| Хотын нэр      | Изотопын хувийн идэвхи Бк/кг |          |              |
|----------------|------------------------------|----------|--------------|
|                | 238U                         | 232Th    | 40K          |
| Алтай          | 18±2.0                       | 11±2.0   | 320±25       |
| Өлгий          | 14±2.0                       | 26±3.0   | 530±35       |
| Улаангом       | 25±2.4                       | 30.9±3.7 | 518          |
| Улиастай       | 23±4.0                       | 38±5.0   | 1330±90      |
| Ховд           | 35±4.0                       | 39±5.0   | 825±65       |
| Улаанбаатар    | 33±9.0                       | 39±0.7   | 880±20       |
| Чойбалсан      | 15±2.0                       | 14±2.0   | 965±31       |
| Дэлхийн дундаж | 25(10-50)                    | 257-50   | 370(100-700) |

Монгол орны баруун бүсэд багтдаг Завхан, Ховд, Говь-Алтай, Увс, Баян-Өлгий аймгийн зарим сумдын хөрсөн дэх макро, микроэлементийн болон Хөшөөт /Ховд/, Нүүрст Хотгор /Баян-Өлгий/-ын орд газруудын нүүрсний микро, макроэлементийн судалгаанаас дараах дүгнэлтийг хийж байна.

- Монгол орны баруун бүсийн аймгуудын хөрсөнд агуулагдах K, Ca, Ti, Mn, Fe, Rb, Sr, Y, Zr, Si элементийн хэмжээг тогтоолоо. Баруун бүсийн Завхан, Увс, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий аймгуудын хөрсөнд агуулагдах хортой элемент болох Pb нь дунджаар 0.003% байна.
- Хөрсөнд агуулагдах макро, микроэлементийн хэмжээ нь тухайн хөрсийг үүсгэж байгаа уулын чулуулгийн төрлөөс хамаарч байна.
- Хөшөөт, Хартарвагатай, Нүүрст хотгор зэрэг баруун бүсийн нүүрсний хэрэгцээг хангаж байгаа уурхайнуудын нүүрсэн дэх байгалийн цацраг идэвхит элементүүдийн хэмжээ Багануур, Адуунчулуун зэрэг хүрэн нүүрснийхээс бага боловч зарим хортой, хүнд элементийн агуулалт эдгээр уурхайнуудын нүүрсний дээжинд агуулагдах хэмжээнээс их байна.

**Ургамалжил.** Баруун бүсийн ургамлан нөмрөгийн талаар 1-р бүлэгт дэлгэрэнгүй дурдсан бөгөөд экосистемийн хувьд ус намгархаг газрууд болон ендер уулын бvсvүдэд хэт олон тооны мал, еерээр хэлбэл, бэлчээрийн даацаас хэтэрсэн олон тооны малаар бэлчээрийг эдэлбэрлэж байгаагаас ургамлын бүлгэмдэлд эрс еерчлелт орж бэлчээрийг талхагдалд оруулах, доройтуулж байна. Мен, усан орчинд ендеглехеер ирсэн шувуудыг vргээн дайжуулахаас гадна vүрлэж ендегледег газрыг нь сvйтгэх, евсен тэжээлт зэрлэг амьтдын амьдрах орчинтой гэрийн малын бэлчээр нутаг давхцах, тvүнээс болж зарлэг амьтад уугуул нутгаасаа дайжих, тоо толгой нь хорогдох, устах зэрэг серег vр дагаврыг дагуулж байна.

Баруун бүс нутгийн ургамлын ургац нь тачир сийрэг, сөөг ба сөөглөг ургамлаас бүрдсэн чулуурхаг цөлийн шинжтэй байдаг ба ургамлын бүлэглэлийн хувьд Алтайн цаад говьд хамрагдана. Сөөглөг ургамалт цөлийн нохой шээрэн, цагаан мод, хонин зээргэнэ, усан товцог, хармаг, Алтан харгана, улаан бударгана, баглуур зэрэг говь цөлийн ургамлууд ургадаг. Уул нуруудын ам хавцал, сайр дагуу түр зуурын усны урсгалыг дагаж ургамал нь нилээд өтгөн, олон зүйлийн болсон байдаг. Ургамлын нөмрөгт зэрлэг амьтдын үзүүлэх нөлөө бага, ихэнх

хэсэгт нь хүн ам суурьшдаггүй учир аж ахуйн ба малын бэлчээрлэлт зэргээс хамаарагдах бараг нөлөөлөлгүй юм. Ерөнхийдөө энэ бүсийн ургамлын нөмрөгийг авч үзвэл дан ганц байгалийн элдэв нөлөөллийн доор оршдог гэж үзэж болно.

Бэлчээр талхагдсанаар бэлчээрийн ургамлын звйл еерчлөгдөж байна. Өөрөөр хэлбэл, мал иддэггүй өвс ургамал ихээр ургаж, ургамлан бүрхэвч тачир сийрэг болж, шимт чанар багасч, элсний нүүлт, хөдөлгөөн идэвхжиж цөлжих вйл явцыг эрчимжүүлж байна. Зарим голын сав газарт, тухайлбал Орхон, Дэлгэрмөрөн, Бэлтэс, Хангайн нурууны ар, Алтайн нурууны өврийн голууд болон Увс нуурын сав газарт бэлчээрийн багтаамж 1.5-7 дахин бага болсон байна.

**Цөлжилт.** Баруун бүс нутгийн ихэнх хэсэг нь байгалийн хуурай, хуурайвтар бүсэд оршдог бөгөөд бүсийн байгал орчныг доройтуулж, байгалын нөөц, түүний дотроос биологийн нөөцийг хомсдуулж байгаа хүчин зүйлийн нэг нь цөлжилт юм. Цаг уурын дулааралт, хур тунадасны жигд биш тархалт, бэлчээрийн талхагдал, газар тариалан, хот суурин газрын хөрсний элэгдэл, гангийн давтамж зэргээс шалтгаалаг цөлжилт эрчимжих хандлагатай болжээ.

Цөлжилтийн нэг илрэл нь элсний нүүдэл. Монгол орны нийт элсний 50 гаруй хувь нь байдаг их нууруудын хотгор хамгийн их өртөөд байна. Зарим судлаачдын үзэж байгаарааг их нууруудын хотгорын 41.2% нь бага зэрэг, 31.9% нь дун зэрэг, 16.7% нь хүчтэй, 10.2% нь маш хүчтэй цөлжилтөнд өртсөн байна. Манай орны гандуу бүс нутагт 1940 оноос хойш 3800 км.кв талбай шинээр элсжисний 872 км.кв зөвхөн Монгол элсний урд зах, Хүйсийн говийн дагуух нутант байна. Говь-Алтай аймгийн Хөх морьт сумын төв элсэнд дарагдаж Монгол элс, Бөөрөг дэл, Бор хяр зэрэг томоохон элстэй нутгийн элсний нүүдэл ихсэж байна. Элсний нүүдэл, цөлжилт ихсэх нь хүний зүй бус ажиллагаатай бас холбоотой. Иймд экологийн энэхүү эмзэг асуудлыг онцгой анхаарч, дотоод гадаадын хөрөнгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн цөлжилттэй хийх тэмцлийг шинэ шатанд гаргах шаардлагатай байна.

Цөлжилт хүчтэй илэрсэн нутаг бол Говь-Алтай аймгийн Хөх морьт сум болно. Монгол оронд элсний нүүлт хөдөлгөөн шинээр үүсэж, зарим газарт идэвхижиж байгаа гол эх үүсвэр нь ихэнхидээ ургамлан нөмрөгийг сийрэгжүүлж хөрс элэгдэж эвдэрсэнтэй холбоотой юм. Баруун бүсийн цөлжилт хүчтэй илэрч элсний нүүлт идэвхижиж байгаа нутагт Алтайн өвөр говийн хэсэг, Их нууруудын хотгорын Бөөрөг дэл, Бор хяр, Монгол элсний ихэнх хэсэг, Завханы Дөрвөлжин, ГовьАлтайн Хөх морьт сумд орно.

Их нууруудын хотгорт Монгол элсний бүсэд 120 өдөр хүрэх нь Монголын хамгийн их шороо хийсдэг газар юм.

Цөлжилтийн илрэл өндөр уулын бүсд бага байна. Цэгэн цөлжилт бол зөвхөн хүний үйл ажиллагааны сөрөг үр дагавар юм. Тус баруун бүсийн дараах цэгүүдэд цөлжилт идэвхитэй явагдаж байна. Үүнд:

- Аймаг сум, баг суурин газрын эргэн тойрон
- Малчдын өвөлжөө, хаваржааны орчим
- Ил задгай ус ховортой нутгийн булаг шанд нуур баян бүрд, гол, горхи
- Уурхай, ашигт малтмалын орд газрууд зэрэг болно.

Хөрсний элэгдэл доройтол, цөлжилтөөс хамгаалахын тулд ургамлын бүрхэвчийг нэмэгдүүлэх зэрэг газрын менежментийн оновчтой арга хэмжээг авах нь зүйтэй. Мөн ойжуулах.

**Ан амьтан.** Ан амьтны экосистемийн хувьд санаа зовоож буй гол асуудлуудыг авч үзлээ. Ан амьтны түүхий эд, бүтээгдэхүүний үнэ дотоод, гадаадын зах зээлд өсөхийн хэрээр хууль бус агнуур газар авч байна. Зөвхөн 2004 оноос хойш 21 ширхэг цоохор ирвэсний арьс, 90 ширхэг Казакстаны бөхөнгийн эвэр, 114 ширхэг Монгол бөхөнгийн эвэр, 90 ширхэг баавгайн доньд, 100 ширхэг согооний сүүл, 20 ширхэг хүдрийн заарыг хууль бусаар худалдаж авсан болон худалдсанг хууль хяналтын байгууллага илрүүлжээ. Ан Илрээгүй хэд хичнээн амьтны түүхий эд зарагдсанг хэн ч мэдэхгүй нь хамгийн аймшигтай зүйл юм.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн монгол дахь хөтөлбөрийн газраас 2002 онд хүдрийн заарын хууль бус худалдааны судалгаа хийсэн. Судалгааны үр дүнд жилд дунджаар 2400-3000 хүдрийн заар хууль бусаар худалдагдаж байсан байна. Хууль бус агнууртай тэмцэх Ирвэс-1 багийн ангийн гаралтай бүтээгдэхүүний судалгааны тайлангаас үзвэл 2002-2004 онд Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн бараан зах дээр 15-20 цоохор ирвэсний арьс, 700 орчим алтайн хойлог хууль бусаар зарагдсан байна. 2001 оноос 2004 он хүртэл Байгаль орчны яамнаас Баян-Өлгий, Ховд, Увс аймагт нийт 61,690 тарвага агнах зөвшөөрлийг хуваарилжээ. Гэтэл дээрх аймгуудын бараан зах дээр тухайн жилүүдэд 587,624 тооны тарваганы арьс буюу зөвшөөрөгдсөн тоон хэмжээнээс 9,5 дахин их арьс хууль бусаар худалдаалагдсан.

**Аргаль нь** Монгол орны ховор амьтны нэг тул 1953 оноос агнахыг хуулиар хориглож дархан цаазтай болгосны дээр Зэрлэг амьтан ургамлын ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах Конвенц(CITES)-ийн II хавсралтад оруулсан.



*Зураг 4.13 Аргаль*

Аргалийн тархацын 23.4% бүхий байршил нутгийг улсын тусгай хамгаалалтад (7 дархан газар, 7 байгалийн цогцолбор газар, 6 байгалийн нөөц газар) хамруулсан.

Аргалийн нэгдсэн тооллогоор Увс аймагт 811 км<sup>2</sup> нутагт 550-600 орчим аргаль байршдаг гэж үнэлжээ (С.Амгаланбаатар, 2001). Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын санаачлагаар Увс аймгийн засаг даргын захиалгаар 2004 онд зохион байгуулсан агнуур зохион байгууллалтын дүн дээрх дүнтэй адил гарсан. Оросын холбооны улс, Монголын судлаачид нэг хугацаанд ижил арга зүйгээр 2003 онд судалгаа хийсэн. Судалгаагаар Увс аймгийн улсын хил орчимд Монголын талд Бөхмөрөн, Сагил сумд нийт 453 км<sup>2</sup> нутагт 220-240 орчим аргаль хонь байршдаг болохыг тогтоосон. Улсын хил орчмын аргаль хонины шилжилт хөдөлгөөнд шинээр байгуулсан хилийн тор сөргөөр нөлөөлж байна гэж үздэг (Ё.Онон, 2003). Энэ нь улсын хил орчмын аргаль хонины популяцийн 23.5% -ийг эзэлж байгаа бөгөөд жил бүр 5-7 угалзыг тусгай Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь Хөтөлбөрийн зөвшөөрлөөр гадаадын иргэдэд агнуулдаг.

Тиймээс энэ популяцийн амьдрах орчинг хадгалах, зохистой ашиглах, хамгаалах менежментийг хэрэгжүүлэх шаардлагатай юм. Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар нь Увс аймагт улсын хилийн орчмын аргаль хонины нүүдэл, шилжилт, тоо толгой түүнд нөлөөлж буй гэрийн малын нөлөөлөлийг тодорхойлох мониторингийн судалгааг 2005 оны 04 дүгээр сараас эхлэн явуулж байна. Судалгааны үр дүн нь энэ зүйл амьтныг хамгаалах, зохистой ашиглах агнуурын менежементийг бий болгоход суурь мэдээлэл болох юм.

#### **4.5.2 Алтай Соёны бүс нутагт хэрэгжсэн Цоохор ирвэс хамгаалах төсөл**

Энэ зүйл амьтныг хамгаалахад Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Монголын Ирвэс төвөөс урт болон богино хугацааны төслүүд, Нэгдсэн үндэсний байгууллага Байгаль орчны яамнаас Монголын Алтай соёны өндөр уулын экосистемийг ард иргэдийн оролцоотой хамгаалах төслийг хэрэгжүүлж байна. Судлаачдын тогтоосноор Монгол оронд ойролцоогоор 700-1500 орчим цоохор ирвэс байна. Энэ нь цоохор ирвэсний дэлхийн популяцийн 13-22% нь Монгол оронд байна гэсэн үг. Цоохор ирвэсний гол тархац нутаг нь Монгол орны баруун ба баруун урд хэсэг юм.

Цоохор ирвэс бүхий нутаг малын бэлчээртэй давхцах хамгийн их эрсдэлтэй улирлуудыг аймаг бүрээр харьцуулж үзэхэд хаврын улиралд Ховд аймгаас судалгаанд оролцогчдын 57.3%, намрын улиралд Говь-Алтай аймгаас судалгаанд оролцогчдын 56.4% нь цоохор ирвэс бүхий нутгуудад оршин суудаг. Цоохор ирвэс бүхий нутагт хүн хамгийн олноороо оршин суудаг улирал нь өвөл, зун бөгөөд жилийн туршид хамгаалах үйл ажиллагаа болон сурталчилгааг хийх шаардлагатай



Дээрх нутгуудад газар ашиглалтын менежмент төлөвлөгөө жинхэнэ утгаараа хэрэгждэггүй учраас бэлчээрийн давхцал ихтэй үүний улмаас цоохор ирвэс, янгир ямаа зэрэг ховор, нэн ховор амьтад дайжих, тоо толгой нь цөөрөх улмаар цоохор ирвэс малд халдах гол нөхцөл болж байна.

Зураг 4.14

*Цоохор ирвэс*

Энэ нь өвөл, хаврын улиралд малын бэлчээр, зэрлэг амьтдын

амьдрах нутаг шууд давхцаж байгаатай ч салшгүй холбоотой тул газар ашиглалтын менежмент төлөвлөгөөнд зэрлэг амьтдын байршил нутгийг тусгаж өгөх нь зүйтэй.

**Дүгнэлт**

Баруун бүс нутгийг хөгжүүлэхэд хөдөө аж ахуйг хөгжүүлэхийн зэрэгцээ ашигт малтмалын эрэл хайгуул хийж, нилээд сайн технологээр дэд бүтэц хөгжүүлэх явдал шаардлагатай байна.

Дэд бүтцийг байгуулах гол үндэслэл нь ашигт малтмалын томоохон ордуудыг нээж олох, улс хоорондын транзит төмөр зам, авто замыг байгуулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх явдал юм.

Баруун бүс нутагт төмөр замыг босоо тэнхлэгийн дагуу Самгалдай – Бургастайн чиглэлээр байгуулах нь монгол улсын хөгжлийг тэнцвэржүүлэх, баруун бүсийн нүүдлийг зогсоох үндэслэл болно. Сүхбаатар– Замын-Үүдийн чиглэлийн төмөр замын дагуу баруун бүсээс нүүж ирэгсэд суурьшиж Хангайн бүс, Төвийн бүсийн хүн амын механик өсөлтийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ үржил шимтэй нутгууд талхлагдаж байна.

Баруун бүс нутагт 168 орд газрыг дахин судалж эрэл хийх, 1260 гаруй орд илрэлийг судлаж хайгуул хийх, нөөцийг тогтоохоор төсөлд тусгах болно.

Баруун бүс нутагт 2007 оны байдлаар хайгуул ашиглалтын лиценз авсан байгуулгууд 20 000 сая төгрөгийн хайгуул хийсэн байна. Энэ нь хөрс усыг бохирдуулсан чанаргүй хайгуул хийсэн байна. Хайгуулын ажилыг эмх замбараа, дэс дараатай хийхгүй бол унаган байгаль экосистемийг эвдэж устгах аюултай юм. Иймд орд илэрлийг хайх, эрэх дэс дарааллыг тогтоосон төлөвлөлт хийх шаардлагатай байна.

Бүсийн аймгийн төвүүд зарим сумдыг цахилгаан эрчим хүчний сүлжээнд холбох талаар арга хэмжээ авч байгаа боловч хөнгөн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлж эрчим хүчийг өөрийн өртгийг үр ашигтай бүтээгдэхүүнээр сольж, нэмүү өртгийг гарган авах талаар хангалтгүй байна. Энэ нь эрчим хүчний системийн цаашид найдвартай ажиллах чадварыг бууруулж байна. Сумдуудад сэргээгдэх эрчим хүчнийг түлхүү хөгжүүлэх эсвэл сумын төвүүдэд бага оврийн үйлдвэрүүдийг төрийн бодлогоор байгуулах нь зүйтэй.

Баруун бүсээс Увсын чацарганы тос, жамц давс, Баян-Өлгий гар урлал, Завханы улаан сармис, жүүс, Говь-Алтайн ашвай, сульхир, дарс, Ховдын тарвас, уран хатгамалын бүтээгдэхүүнийг гаргаж байгаа боловч мал аж ахуй арилжаа наймаа, ачаа болон зорчигч тээврийн үйл ажиллагаа нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үндсэн дүнгийн 86 хувь болж байна.

Улсын хэмжээнд болон дэлхийд тэргүүлэх бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, барилгын материалын орд газруудыг нээж үйлдвэрлэл явуулах талаар төлөвлөлт хийв.

Хилийн боомтуудаар дамжуулан импортоор их хэмжээний барилгын материал авч байгаа нь баруун бүсийн хөгжлийн эрэлт хэрэгцээнээс хол хоцорч байгаа явдал юм.

Баруун бүс нутгийн хөгжиж ирсэн түүхийг судлан үзээд ашигт малтмалын эрэл хайгуулыг геофизик, геологийн аргаар нэн тэргүүнд явуулах нь зүйтэй гэж үзлээ.

Агаарын зам, төмөр зам болон авто замын сүлжээг ирээдүйтэй хөрөнгө оруулалт хийж болох орд газруудыг түшиглүүлэн байгуулах сонголтыг хийж төлөвлөв.

## ХЭСЭГ II

# БАРУУН БҮСИЙН БАЙГАЛЬ-ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

## **Тав. БАРУУН БҮСИЙН БАЙГАЛЬ-ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ**

### **ОРШИЛ**

Баруун бүсийн нутаг дэвсгэрийн иж бүрэн үнэлгээний хүрээнд нийгэм эдийн засгийн тулгуур нөхцөл, нийгэм эдийн засгийн хөгжлийн түвшин, бүс нутгийн дэд бүтцийн сүлжээний хөгжил, хүн ам хөдөлмөрийн нөөц, хөдөө аж ахуй, нийгмийн дэд бүтэц, хөрсний талхлагдалт, элсний нүүдэл, цэвдэг хөрсний тархалт, байгаль цаг уурын нөхцөл, бүс нутгийн хөгжлийн бодлого тодорхойлоход шаардагдах нийгэм эдийн засгийн үнэлгээг 10 үзүүлэлтээр тус тус хийв.

Баруун бүсийн нутаг дэвсгэрийн иж бүрэн үнэлгээг хийхэд 1:500 000-ны масштабтай суурь зурган материалууд дутагдалтай байсан боловч Газарзүй, цэвдэг судлалын хүрээлэнгийн судалгааны 1:2500000, 1: 2000000 –ны масштабтай зураг, тоон болон текст мэдээллүүдэд тулгуурлан хийлээ.

Харин нийгэм эдийн засаг, ахуй амьдралын тулгуур нөхцөлүүдийн талаар аймгууд болон баруун бүсийн зөвлөл нилээд материалыг өгч тусалсан нь үндэслэл сайтай үнэлгээ хийхэд тус дөхөмтэй байлаа.

Баруун бүс нутаг нь байгаль цаг уурын эрс тэс уур амьсгалтай, Алтайн, Хангайн өндөр уулс, Их нууруудын хотгор газарт эцэг өвгөдөөс уламжлагдан заяагдсан нутагт өсч төрсөн уугуул иргэд өтгөсийг үдэж, ирээдүйг гэрэл гэгээгээр төсөөлөн харж, цаг цагийн хувиралт, дэлхийн улс төрийн бодлого зорилтод нийцэн, уламжлалт мал аж ахуйдаа тулгуурлан амьдарч байна.

Экосистемийн байдал нэн хүндэрч байгаа өнөөгийн нөхцөлд байгалын бүс бүслүүр, био уур амьсгал, геоморфологийн нөхцөл, геологийн тогтоц, хөрс, ургамлын бүрхэвч, ан амьтан, уур амьсгал, хур тунадас, нар салхины нөлөөлөл, ус, нуур, гол мөрний нөөцийн талаар нарийвчлан тусгайлан судлах шаардлага тавигдаж байна.



Тухайн оршин байгаа нутаг орондоо дасан зохицож амьдрах, амьдралын хэв шинжийг өөрчлөн сайжруулах явдал чухал болж байна.

Баруун бүс нутгийн элсний нүүдэл, цэвдэг хөрсний тархалт, газар чичирхийлэл, усан хангамж, түлшний хангамжийн талаар тодорхой үнэлэлт дүгнэлт өгөв.

Харин газар нутгийн ашиглалтын менежментийн талаар Баруун бүс нутгийн газар зохион байгуулалтын төсөл хийгдэж, хөдөө аж ахуйн газар, усан сан, ойн сан, тусгай хэрэгцээний газар, байгаль хамгааллын талаар одоогийн байдлыг судлан тогтоож нарийвчилсан ангиллаар үнэлгээ өгсөн тул байгалийн нөхцөл, нөөц баялагийн талаархи тэр материалыг үзэхийг зөвлөж байна.

Баруун бүс нутгийн хөгжлийн төсөл онцлон авч үзэж үнэлгээ өгсөн заалтууд нь:

- Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн бүтэц, зохион байгуулалт
- Хот суурины гүйцэтгэх үүрэг
- Нийгэм- эдийн засгийн хөгжлийн түвшин
- Дэд бүтцийн сүлжээний хангамж
- Хүн амын хөдөлмөрийн нөөц
- Ажил эрхлэлт, ядуурал
- Хөдөө аж ахуй, хүнсний хангамж
- Аж үйлдвэр, барилгын хөгжил
- Нийгмийн дэд бүтцийн хангамж

Дээрхи 9 үндсэн үзүүлэлтээр баруун бүс нутгийн хөгжлийн түвшинд үнэлгээ өгч элсний нүүдэл, цөлжилт, цэвдэг хөрсний тархалт, газар чичирхийлэл, усан хангамж, түлшний хангамжийг байгалийн нөхцөл нөөцийн үнэлгээгээр нэмж үндсэн үнэлэлт дүгнэлтийг гаргав.

### 5.1 БАРУУН БҮС НУТГИЙН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦЛИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

#### 5.1.1 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүтэц зохион байгуулалт

Баруун бүсийн нутаг 415.3 мянган км<sup>2</sup> талбайтай, 5 аймаг, 92 сум, 8 хилийн боомт, 463 баг бүхий засаг захиргааны хуваарилалттай.

Аймгуудын сум багийн тоо /Хүснэгт 5.1/

| Аймаг            | Сум | Баг |
|------------------|-----|-----|
| Баян-Өлгий аймаг | 14  | 84  |
| Говь-Алтай аймаг | 18  | 83  |
| Завхан аймаг     | 24  | 113 |
| Увс аймаг        | 19  | 92  |
| Ховд аймаг       | 17  | 91  |

Аймгуудын нутаг дэвсгэр /Хүснэгт 5.2/

| Аймаг            | Нутаг дэвсгэрийн талбай /мян.км2/ |
|------------------|-----------------------------------|
| Баян-Өлгий аймаг | 45.7                              |
| Говь-Алтай аймаг | 141.4                             |
| Завхан аймаг     | 82.4                              |
| Увс аймаг        | 69.6                              |
| Ховд аймаг       | 76.1                              |

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүтэц зохион байгуулалтын хувьд бүсийн хэмжээнд сумын тоог улсын дүнтэй харьцуулж үзэхэд 0.27, багийн тоо нь 0.28 хувийг тус тус эзлэж байна.

Монгол улсын хэмжээнд 0.77 мян км<sup>2</sup> талбайд нэг засаг захиргааны нэгж, баруун бүс нутгийн хэмжээнд 0.74 мян км<sup>2</sup> нэг засаг захиргааны нэгж, аймгийн түвшинд 0.9 мян км<sup>2</sup> талбайд нэг засаг захиргааны нэгж ноогдож байгаа нь засаг захиргааны нягтрал ихтэй байна. *Засаг захиргааны нягтралын зэрэг нь 0.8 мян км<sup>2</sup> гэсэн дундаж үзүүлэлттэй байна.*

Манай орны өргөн уудам нутаг дэвсгэрт цөөн хүн уламжлалт мал аж ахуй эрхлэн оршин амьдарч байгаа нөхцөлд засаг захиргааны хуваарийг багасгаж,

ноогдох газар нутгийг 17.3 мян км<sup>2</sup> талбайд хүргэх, 25-30 нэгж болгон өргөтгөхөөр энэхүү төсөлд тусгасан. Ингэснээр олон ач холбогдол, давуу талууд гарч болно.

Баруун бүс нутагт орон нутгийн төсвийн орлого зарлагын тэнцэл нь 2007 оны байдлаар 1.05 хувийн орлоготой, Завхан, Увс аймгууд 1.2 хувийн алдагдалтай, Ховд, Говь-Алтай, Баян-Өлгий аймгууд 0.3-1.0 хувийн орлоготой байна. Тус бүс нутагт орон нутгийн төсвийн орлого, зарлагын тэнцэлийн байдалд шинжилгээ хийж үзэхэд 2007 оны байдлаар бүсийн хэмжээнд 1.05 хувийн орлоготой, Завхан, Увс аймгууд 1.2 хувийн алдагдалтай, Баян-Өлгий аймаг 1.03 хувийн орлоготой, Ховд, Говь-Алтай аймгууд “тэг” хувийн тэнцэлтэй байна.

2007 оны байдлаар улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг нь Баруун бүс нутагт 21985.7 сая төгрөг байна. Төсвийн зарцуулалтад дүн шинжилгээ хийж үзэхэд аймаг, сумын засаг захиргааны зардалд нийтдээ 8 553.3 сая төгрөгийг зарцуулж байгаа нь улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийн 38 хувийг эзлэж байна. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг томсгох буюу нэгжийн тоог цөөснөөр захиргааны зардалд зарцуулж байгаа дээрх мөнгөн хөрөнгө 50-60 хувиар багасах бололцоотой юм.

***Баруун бүс нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүтэц зохион байгуулалтад хийсэн үнэлгээгээр одоогийн засаг захиргааны хуваарь нь тохиромжгүй гэсэн үнэлгээгээр тодорхойлогдож байна.***

### 5.1.2 Баруун бүс нутгийн хот суурины гүйцэтгэх үүрэг

Баруун бүс нутагт бүс нутгийн тулгуур төв Улиастай, Ховд хотууд, орон нутгийн хөгжлийн хот Өлгий, Улаангом, Алтай хотууд, бүлэг суурингийн төв Баян-Өлгий аймгийн Толбо, Увс аймгийн Сагил, Өмнөговь, Зүүнговь, Баруун туруу, Ховд аймгийн Дарви, Булган, Манхан, Чандмань, Зэрэг, Завхан аймгийн Завхан мандал, Баянтэс, Нөмрөг, Булнай, Цагаанчулуут, Говь-Алтай аймгийн Шарга, Дарви, Халиун, Бигэр сумууд болон тэдгээр таталцан хөгжиж байгаа 71 сум, 463 баг бүхий засаг захиргааны нэгж байна. Мөн Бургастай, Ярант, Даяннуур, Улаанбайшинт, Хангайн гол, Шар суурь, Арцсуурь зэрэг хилийн боомтууд /*Зураг 5.1/*, төслийн шатандаа байгаа Цагаан нуур чөлөөт бүс үйл ажиллагаагаа явуулж байна.

Ховд, Улиастай, Улаангом хотууд нь эртний түүхт хотууд бөгөөд Алтай, Өлгий хотууд нь 1924 оноос хойш хөгжиж байгаа шинэ хотууд юм.

Баруун бүсийн 92 сумын төв, 463 багийн төвүүдийг 1940 оноос эхлэн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн шахалтаар шинээр үүсгэн байгуулахад маш их хөрөнгө хүч зарсан түүхтэй. Харин зах зээлийн харилцаанд орсноор өмч хувьчлал явагдан тэдгээр хөрөнгийг хувийн хэвшилд шилжүүлсэн юм.

Одоогийн байдлаар орон нутгийн засаг захиргааны мэдэлд сумын ИТХ, Засаг даргын тамгын газар, зарим нийгмийн дэд бүтцийн хөрөнгө хамаарагдаж байна. ***Орон нутгийн засаг захиргааны удирдлагын үйл ажиллагааны мэдлийг хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, экосистемийн үйл ажиллагааг түлхүү хамааруулан гүйцэтгүүлэх шаардлага гарч ирлээ.***

Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг нийгмийн асуудлыг бие даан зохион байгуулж чадахгүй байна. Эдгээр олон төв суурин газруудыг багасгаж чадваржуулан чанаржуулах, үйлдвэржүүлэх, оюунлаг болгох талаар төлөвлөв.

Өнөөгийн сумын төвийн үүрэг зөвхөн тэтгэвэр тэтгэмж тараах, нийгмийн дэд бүтцийн оногдсон хөрөнгийг тараан олгоход үйлчлэх болсон байна.

Засаг захиргааны болон нийгмийн дэд бүтцийн барилгуудаас бусад барилга байгууламж зарим нь хуучирч муудан эзэнгүйдэж балгас болон хувирчээ.


Энэ бол нутгийн өөрөө удирдах байгууллага тодорхой үр дүнтэй үйл ажиллагаа явуулж чадахгүй болсонтой холбоотой.

Баруун бүсийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн хотуудыг бараадуулан Эрдэнэт, Дарханы хэмжээний томоохон хот суурин барьж байгуулах газарзүйн байршилт болон инженер геологийн нөхцөл, нутаг дэвсгэрийн хэмжээ нь хязгаарлагдмал юм.

Баруун бүс нутагт дэлхийн болон улсын хэмжээний томоохон хотжилт, үйлдвэржилт үйлдвэрийн газаргүй учраас нийгмийн дэд бүтэц хөгжихгүй бөгөөд амьдралд өгөөжгүй учраас оюунлаг баруун монголчууд улсын зэрэглэлтэй хотуудыг бараадан нүүдэллэж байна.

Энэ байдалд дүгнэлт хийж баруун бүс нутгийн эрдэс, түүхий эдэд тулгуурлан металлурги, хүнд хөнгөн үйлдвэр, чөлөөт бүс, гааль худалдааны Сутай хотыг байгуулахаар төлөвлөж байна.

***Баруун бүс нутгийн хот суурины 84 хувь нь хязгаарлагдмал байдлаар үүргээ гүйцэтгэж байна гэсэн үнэлгээгээр тодорхойлогдож байна.***



### 5.1.3 Нийгэм эдийн засгийн хөгжлийн түвшин

Баруун бүс нутагт дотооддоо бүтээгдэхүүн үйлдвэрлэх томоохон үйлдвэрүүд хөгжөөгүй байна. 2007 оны байдлаар /2005 оны 12 сарын байдалтай харьцуулан авч үзвэл/ аймгуудаас авсан судалгаагаар бүсийн хэмжээнд дунджаар дотоодын нийт бүтээгдэхүүнээр эдийн засгийн хөгжлийн түвшинг хэмжиж үзэхэд хөдөө аж ахуйд эзлэх хувь 71.8 , аж үйлдвэр барилгад эзлэх хувь 5.4, үйлчилгээнд эзлэх хувь 22.8 байгаа нь үндэсний баялагийг бүтээх бололцоогүй байгаа нь ойлгогдож байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индексээр хүнсний бараа 151.4 % , согтууруулах ундаа 118.2%, хувцас бөс бараа 121.6%, оронсууц, түлш 117.8%, гэр

ахуйн бараа 132.6%, эмнэлгийн үйлчилгээ 133.6 %, тээвэр 146%, холбоо, мэдээллийн үйлчилгээ 100.5%, Амралт соёлын үйлчилгээ 105.8%, боловсролын үйлчилгээ 136.5% тус тус байна.

Бүсийн хэмжээнд ерөнхий индекс нь 129.7 байгаа нь 2005 оныхоос хэрэглээний зардал 29.7 хувиар өссөн байна. Гурил, хонины мах, цагаан будаа, шингэн сүү, элсэн чихэр, цахилгаан, халаалт, бензин зэрэг гол нэрийн барааны үнэ Улаанбаатар хоттой харьцуулахад 0.09 хувиар илүү байна. Энэ нь зах зээлээс хол өргөн хэрэглээний барааны олдоц муу байгаа нь тээврийн зардлын үнэ шингэж байгааг гэрчлэж байна.

Баруун бүс нутгийн зээлийн өрийн үлдэгдэл 2007 оны байдлаар бүсийн хэмжээнд 114675.8 сая төг байгаа бөгөөд аймгуудын өр 21988.0-27976.7 сая төг байгаа юм. Улсын хэмжээний зээлийн өрийн 18 хувийг эзлэж байна.

Иргэдий хадгаламжийг үлдэгдэл бүсийн хэмжээнд 54459.6 сая.төг, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл бүсийн хэмжээнд 898.1 сая.төг байгаагаас хамгийн бага өрийн үлдэгдэлээр Говь-Алтай аймаг 39.7 сая.төг, хамгийн их өрийн үлдэгдэлээр Завхан аймаг 256.7 сая.төг байгаа бөгөөд мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ 37 хувь, инфляци 18.3 хувьтай байна.

Баруун бүс нутагт үнэт цаасны зах зээл хөгжөөгүй, зах зээлийн үнэлгээ өндөр хэмжээнд байгаа хувийн хэвшлийн байгууллага улсад бүртгэгдээгүй, үнэт цаасны арилжаанд идэвхитэй оролцсон компани улсад бүртгэгдээгүй, даатгал, хадгаламж зээлийн хоршоод, бондын арилжаа хөгжөөгүй зэрэг нийгэм эдийн засгийн үндсэн хэвшлүүд хөгжөөгүй байна.

***Баруун бүс нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн түвшин хязгаарлагдмал байдалтай гэсэн үнэлгээгээр тодорхойлогдож байна.***

#### **5.1.4 Баруун бүс нутгийн дэд бүтцийн сүлжээний хөгжил**

Баруун бүс нутагт цахилгаан эрчим хүчний сүлжээ, холбоо мэдээллийн сүлжээ, зам тээврийн сүлжээ сүүлийн 10 жилд идэвхитэй хөгжиж цаг хугацаа хэмнэх, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, сурч боловсрох нөхцлөөр хангагдаж байна.

5.1.4.1 Цахилгаан эрчим хүчний сүлжээнд ОХУ-ын Красноярскийн эрчим хүчний эх үүсвэрээс Хандгайт-Улаангом-Өмнөговь сум, Өмнөговь сум-Өлгий-Цэнгэл, Өмнөговь- Наранбулаг-Малчин-Хяргас, Наранбулаг-Завхан-Дөргөн, Өмнөговь-Ховд-Манхан гэсэн 22 хот, сууринд холбогдсон, дотоодын эх үүсвэрээс Алтай-Тайшир- Цагаанчулуут- Алдархаан- Улиастай зэрэг хот сууринтай холбогдсон байна. ***Нийт хот суурин газрын 34.8 хувь нь цахилгаан эрчим хүчний сүлжээнд холбогдсон нь хангалтгүй гэсэн үнэлгээгээр үнэлэгдэж байна.***

5.1.4.2 ***Баруун бүс нутгийн нийт хот, суурингийн 42 хувь нь үүрэн телефоны сүлжээнд холбогдсон нь дунд зэрэг буюу хязгаарлагдмал хангамжтай гэсэн үнэлгээгээр тодорхойлогдож байна.***

5.1.4.3 ***Баруун бүсийн 5 аймгийн төв төвлөрсөн усан хангамж ариутгах татуургын сүлжээнд холбогдсон, хангалттай гэсэн үнэлгээгээр үнэлэгдэж байна.***

***Бүсийн хэмжээний 97 сум, суурин, 463 багийн төв одоогоор төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын сүлжээнд холбогдох нөхцөл бүрдээгүй буюу одоохондоо дэд бүтэц хангагдаагүй гэсэн үнэлгээгээр үнэлэгдэж байна.***


2007 онд унд ахуйн болон бэлчээрийн усан хангамжийн 4535 худаг тоологдсон нь малчдын хэрэгцээний 63 хувийг хангахаар байгаа боловч усны эрдэс болон хатуулаг ихтэй байгаа нь ***усны чанарын шаардлага, хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна гэсэн үнэлгээгээр үнэлэгдэж байна.***

5.1.4.4 Зам тээврийн сүлжээний хангамжаар баруун бүс нутагт хатуу хучилттай 4 онгоцны буудал, нислэгийн шороон зурвас бүхий 3 буудал ажиллаж байна. /Зураг 5.2/

Ховд аймагт 113.6км, Увс аймагт 115.3 км, Завхан аймагт 4.1 км, Говь-Алтай аймаг 4.5 км, Баян-Өлгий аймагт 10.2 км хатуу хучилттай автозам байгаа нь баруун бүс нутагт найдвартай зам тээврийн сүлжээ хангалтгүй байна.

**Ерөнхий үнэлгээгээр Баруун бүс нутагт дэд бүтцийн сүлжээний хангамж хангалтгүй гэсэн үнэлгээгээр үнэлэгдэж байна.**

БАРУУН БҮС НУТАГ ДАХЬ ОНГОЦНЫ БУУДЛЫН БАЙРШИЛ



**5.1.5 Хүн ам, хөдөлмөрийн нөөц**

5.1.5.1 Баруун бүс нутагт хамгийн олон үндэстэн, ястнууд /Зураг 5.3/ нэг дор оршин

амьдардагаараа онцлог бөгөөд 2007 оны байдлаар 411.1 хүн ам оршин амьдарч байгаагаас хот суурин газарт 28.1 хувь, хөдөөд 71.9 хувь нь амьдарч байна. Баруун бүс нутагт 96.4 мянган өрх байгаагаас хот суурин газарт 27.1 хувь, хөдөөд 69.3 хувь, бүтэн өнчин хүүхэд 853, хагас өнчин хүүхэд 9495, эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо 10615, нас баралт 1000 хүн тутмаас 5.6 хувь, төрөлт 22.5 хувь, дундаж наслалт 62.8 байна.

Баруун бүс нутагт 1.01 мян.га газарт 1 хүн ноогдож байгаа нь суурьшлийн нягтшил маш бага байгааг гэрчлэж байна.

5.1.5.2 Эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 170.7 мянга, нийт хүн амын 24 хувь нь үйлдвэрлэл үйлчилгээний салбарт ажил эрхэлж байна. Ажилчдын тоо 164.6 мянга /малчдыг оролцуулаад/, бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 9057, мэргэжилгүй ажилгүйчүүдийн тоо 4213, ажилгүйдлийн түвшин 3.5 хувь, төрийн албан хаагч 16.0 мянга байна.

***Хөдөлмөрийн нөөц ашиглалтын хувьд хангалтгүй гэсэн үзүүлэлтээр үнэлэгдэж байна.***

5.1.5.3 Хүний хөгжлийн индексээр авч үзвэл дундаж наслалт 67.0, хүн амын боловсролын түвшний нэгдсэн индекс 0.928, нэг хүнд ноогдох ДНБ-ний индекс 0.423, хүний хөгжлийн индекс 0.72 байгаа нь ***хязгаарлагдмал гэсэн үнэлгээгээр тодорхойлогдож байна.***

5.1.5.4 Жендерийн хөгжлийн индексээр авч үзвэл хүйсээр тэгшитгэсэн боловсролын оролцооны индекс 0.928, хүйсээр тэгшитгэсэн орлогын индекс 0.425, жендерийн хөгжлийн индекс 0.678, жендерийн эрх мэдлийг хүйсээр тэгшитгэсэн орлогын индекс 0.029, жендерийн эрх мэдлийн хэмжүүр 0.403 байгаа нь ***хязгаарлагдмал гэсэн хэмжигдэхүүнээр тодорхойлогдож байна.***

5.1.5.5 Баруун бүст хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн тоо 524, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 44, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 165, аж ахуйн гэмт хэрэг 13, автын гэмт хэрэг 850, нийт гэмт хэрэг 1813 байгаа нь ***тайван оршин амьдрах аюулгүй байдал хангалтгүй гэсэн үнэлгээгээр тодорхойлогдож байна.***


***Хүн амын харилцаатай холбоотой үзүүлэлтээрээ хангалтгүй гэсэн үнэлгээгээр тодорхойлогдож байна.***

### **5.1.6 Хөдөө аж ахуй, хүнсний хангамж**

5.1.6.1 *Мал аж ахуй* - Баруун бүст 2007 оны байдлаар 12301.7 мянган толгой малтай, үүнээс ямаа 6190.9 мянган толгой байгаа нь сүргийн бүтцийг алдагдуулж байгальд хөнөөл учруулж байна. Хүнсэнд хэрэглэсэн мал 7.1 хувийг эзлэж байна.

5.1.6.2 *Газар тариалан* - Баруун бүс нийт 8639.5 га талбай тариалалт хийсэн бөгөөд үүнээс үр тариа 2737.9 га, төмс 1760.9 га, хүнсний ногоо 1247.4 га, тэжээлийн ургамал 2887.3 га байна. Үр тариа 3325.3тн, хүнсний ногоо 13826.3тн, төмс 18514.1 тн, тэжээлийн ургамал 4408.5 тн ургац хураан авсан байна. 1 га талбайгаас хураан авсан ургацын өгөөж бусад бүсүүдтэй харьцуулахад илүү байна.

***Баруун бүс нутагт уламжлалт хөдөө аж ахуй тэргүүлэх салбар болж хүнсний хангамж хязгаарлагдмал хүрэлцээтэй гэсэн үнэлгээгээр тодорхойлж байна.***





### 5.1.7 Аж үйлдвэр, барилга

5.1.7.1 Аж үйлдвэр -2005 оныг суурь болгон авсан тооцоогоор баруун бүс нутагт аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 15653.7 сая төгрөг байгаа нь бусад бүсүүдээс 60-88 хувиар, Хангайн бүсээс 74 дахин доогуур байна.

Аж үйлдвэрийн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болох цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, уул уурхай, боловсруулах аж үйлдвэр огт хөгжөөгүй учир **хангалтгүй гэсэн үнэлгээгээр тодорхойлогдож байна.**

5.1.7.2 Баруун бүст 2007 оны байдлаар 16973.7 сая төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэсэн байна. Энэ үзүүлэлтийг зүүн ба төвийн бүстэй харьцуулахад 1.6-4.0 дахин илүү, Хангайн бүсээс 2.4 дахин бага байгаа тул **хязгаарлагдмал гүйцэтгэлтэй гэсэн үнэлгээгээр тодорхойлогдож байна.**

**Нийлбэр үнэлгээгээр хангамж дунд зэрэг гэсэн үнэлгээгээр үнэлэгдэж байна.**

### 5.1.8 Нийгмийн дэд бүтэц

5.1.8.1 Баруун бүс нутагт хот суурингийн аж ахуй, үйлчилгээний цэгийн тоогоор үзүүлбэл бүс нутагт 46133 уст цэг, үүнээс Баян-Өлгийд 5884, Говь-Алтайд 5152, Завханд 6219, Увсад 10094, Ховдод 18784 уст цэгүүд байна. Уст цэгийн хүрэлцээ хангамжийн хувьд 60 гаруй хувьтай байгаа нь **хязгаарлагдмал хүрэлцээтэй гэсэн үнэлгээгээр тодорхойлогдож байна.**

5.1.8.2 Орон сууцны эрэлт хэрэгцээ аймгийн төвүүдэд маш өндөр байгаа бөгөөд нийт хүн амын 23.6% нь тохилог орон сууцанд, сумын төвийн ердийн галлагаатай сууцанд дөнгөж 8% нь амьдарч байгаагаас үзвэл **орон сууцны хангамж хангалтгүй гэсэн үнэлгээгээр тодорхойлогдож байна.**

5.1.8.3 Баруун бүст ерөнхий боловсролын 154 сургуульд 96.8 мянган суралцагсад, ЕБС-ийн 1 багшид ноогдох суралцагчдын тоо 29.6, нийт багш нарын тоо 4319, дотуур байранд 16309 сурагч, ясли, цэцэрлэгийн тоо 348, номын сан 87, соёлын төв 88 байна.

Үүнээс үзэхэд баруун бүст **соёл боловсролын үйлчилгээний хангамж сайн гэсэн үнэлгээгээр тодорхойлогдож байна.**

5.1.8.4 Баруун бүсийн эрүүл мэндийн салбарт 2007 оны байдлаар ажиллаж буй эмчийн тоо 629, эм зүйчийн тоо 44, нэг эмчид ноогдох хүний тоо 646, эмнэлэгт хэвтэгчдийн тоо 93.3 мянга, нялхасын эндэгдлийн тоо 1000 хүн тутмаас 23.2 мөн нийгмийн халамжийн үйлчилгээний орлого, зарлага 10.8 хувийн алдагдалтай зэрэг үзүүлэлтээс үзэхэд **хангалтгүй гэсэн үнэлгээгээр тодорхойлогдож байна.**

**Нийлбэр дүнгээрээ нийгмийн дэд бүтцийн байдал хязгаарлагдмал хангамжтай гэсэн үнэлгээгээр тодорхойлогдож байна.**

Баруун бүс нутгийн нийгэм, эдийн засгийн тулгуур нөхцлүүдийн ерөнхий үзүүлэлтүүдийг үнэлсэн байдлыг доорхи хүснэгтэд нэгтгэн үзүүлэв.

| Д/д | Үнэлгээний үзүүлэлтүүд  | Үнэлгээ    |                |            |
|-----|---|------------|----------------|------------|
|     |   | Хангалттай | Хязгаарлагдмал | Хангалтгүй |
| 1   | Баруун бүс нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт |            |                | +          |
| 2   | Баруун бүс нутгийн хот суурины гүйцэтгэх үүрэг                        |            | +              |            |
| 3   | Нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин                                 |            | +              |            |
| 4   | Дэд бүтцийн сүлжээний хөгжил  |            | +              |            |
| 5   | Хүн ам, хөдөлмөрийн нөөц  |            |                | +          |
| 6   | Хөдөө аж ахуй, хүнсний хангамж  |            | +              |            |
| 7   | Аж үйлдвэр, барилга   |            |                | +          |
| 8   | Нийгмийн дэд бүтэц  |            | +              |            |
|     | Дүн   |            | 5              | 3          |

**Баруун бүс нутгийн нийгэм, эдийн засгийн тулгуур нөхцлийн ерөнхий үнэлгээ нь хязгаарлагдмал буюу хангалтгүй гэсэн үнэлгээгээр үнэлэгдэж байна.**

**Бүс нутгийн хөгжлийн бодлого тодорхойлоход шаардагдах нийгэм-эдийн засгийн үнэлгээ /Хүснэгт 5.4/**

*2007 оны байдлаар тооцоход*

|   | Бүсийн нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүд   | Үнэлгээний шалгуурууд   |  |
|---|---|---|--|
|   |   | Давуу тал   | Сул тал  |
| 1 | Засаг захиргааны нэгж, нутаг дэвсгэр  | -   | Засаг захиргааны 560 нэгжтэй байгаа нь үрэлгэн үр ашиг багатай буруу бүтэц юм.   |
| 2 | Хүн амын нутагшилт суурьшил   |   | 45.3 мян.км2 нутаг дэвсгэрт 416.7 мянган хүн оршин амьдарч, 1км2 талбайд 0.99 хүн ноогдож байгаа нь маш сийрэг байгааг харуулж байна.  |
| 3 | Ажиллах хүчин   |   | 170.7 мянган хүн ажил эрхэлж байгаагаас 16.0 мянган төрийн албан хаагч, төрийн бус байгууллагын 4.2 мянган албан хаагч, мэргэжилгүй 4.6 мянга хүн, үйлчилгээний бус нийгмийн салбарын 31.0 мянга, үлдсэн нь малчид, хувийн хэвшлийн үйлдвэрлэгч нар байгаа нь ажилгүйдлийн индекс 3.5 буюу ажиллах хүчний бүтэц, байршил оновчгүй байна. |
| 4 | Дотоодын нийт бүтээгдэхүүн  |   | Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар ХАА-д 71.8 хувь, Аж үйлдвэр барилгад 5.4 хувь, үйлчилгээнд 22.8 хувь байгаа нь үйлдвэрлэлийн харилцаа дутагдалтай байна.  |
| 5 | Хэрэглээний үнийн индекс, инфляцийн түвшин / Лос-Пейрсийн томъёогоор, $(L_t - L_0) * 100 / L_0$ |   | Хэрэглээний үнийн индекс 1.7, инфляци 0.3 хувь байгаа нь өр зээл ихтэй, өргөн хэрэглээний бараа, үйлчилгээ хүрэлцээгүй байгааг харуулж байна.  |
| 6 | Улсын төсөвт оролцсон байдал  |   | 16862.7 сая төгрөг Улсын төсвөөс авч 15895.6 төлсөн нь Улсын өмнө нийгэм-эдийн засгийн тодорхой сайн нөлөө үзүүлж чадахгүй байна.  |
| 7 | Хөрөнгө оруулалт  | Барилга угсралтын ажлаар төв, зүүн бүсээс 1.6-3.0 дахин их байгаа нь сайн үзүүлэлт юм | ХАА үйлдвэрлэл 71.8 хувь байгаа нь сайн боловч үйлдвэрлэлийн бүтэц алдагдсан.  |
| 8 | Аж үйлдвэр  |   | Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт төвийн бүс, зүүн бүсээс 22.5 хувь бага байна. Эрчим хүч, уул уурхайн олборлолт, боловсруулах үйлдвэр хөгжөөгүй байна.  |

|    |                                     |  |   |
|----|-------------------------------------|--|---|
| 9  | Тээвэр, холбоо, гадаад харилцаа     | Тээврийн салбарт автозамаар ачаа ба зорчигч эргэлт сайн байгаа. Холбоо, харилцаа сайн хөгжиж байна.  | Гадаад харилцаа хөгжих хандлагатай байгаа боловч түүхий эдийг экспортлож байгаа нь үйлдвэрлэх технологийн хоцрогдолтой холбоотой. |
| 10 | Шинжлэх ухаан, соёл урлаг, сүм хийд | 13 их, дээд сургууль, коллежтой, 154 дунд сургуультай, боловсролын салбар сайн хөгжиж байгаа боловч эрдэм шинжилгээний хүрээлэн бага, эрдмийн ажлыг практиктай хослуулах явдал хийгдэхгүй байна. | 42 томоохон сүм хийдэд 251 лам хуврага ажиллаж, шашны сургуульд 1013 хүүхэд сурч байгаа нь зохисгүй юм.                           |

Нийгэм эдийн засгийн үнэлгээгээр 70 хувь нь тохиромжгүй байгааг харгалзан төлөвлөлтийн үндсэн шийдлүүдийг боловсруулав.

### 5.2. БАРУУН БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ-ЭКОЛОГИЙН ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Баруун бүсэд 1) Монгол Алтайн нуруу, 2) Хангайн уулт өндөрлөгийн баруун хэсэг, 3) тэдгээрийн хооронд орших Их Нууруудын хотгор, 4) Алтайн чанадахь говь маягийн уулсаар тусгаарлагдсан хотгорууд гэсэн гадаргын нөхцөлөөр хоорондоо ялгаатай 4 хэсэг нутаг бий.

Тус бүсэд өндөр уул нуруу, өргөн хотгор, хонхор зонхилох тул газрын хөрсний тархалт, нэгдүгээрт, уулын босоо бүсшилийн зүй тогтолд, хоёрдугаарт, Монгол оронд тод ажиглагдах хотгорын бүсшилийн зүй тогтолд захирагдана. Уул нуруудын байршил, үнэмлэхүй өндрөөс шалтгаалан уулын хөрсний босоо бүслүүрийн бүтэц газар газар өөр байна.

Баруун бүсийн хотгоруудад салхины үйл ажиллагаа идэвхтэй явагдаж байна. 15м/сек хурдтай буюу түүнээс хүчтэй салхитай өдрийн тоо Баруун Хуурайн хотгор болон Их Нууруудын хотгорын захаар жилд дунджаар 10-20, Их Нууруудын хотгорын төв хэсэг болон Алтайн Өвөр говьд 20-30 хүрч, жилд 20-40 хоног шороон шуургатай байна. Тус бүсэд Монгол орны бусад нутгийн нэгэн адил жилийн 4 улирлын ялгаа, тэдгээрийн үргэлжлэх хугацааг тод зааглаж болно. Өвлийн улиралд хоногийн агаарын дундаж температур  $-5^{\circ}\text{C}$  хүрч хүйтрэх намрын сүүл үеэс, мөн температур  $-5^{\circ}\text{C}$  –аас дээшилж дулаарах, хаврын эхэн үе хүртэл үргэлжлэх ба баруун бүсийн нутгуудад өвлийн улирал 15/Х-наас 30/ХI-ны хооронд эхэлж дунджаар 152 хоног үргэлжилнэ.

Бүсийн ихэнх нутаг хур тунадас багатай, уулархаг газраар жилд дунджаар 200-400 мм, бусад нутгаар 100-200 мм, Ачит, Увс, Их Нууруудын хотгорт 100 мм-ээс бага, Хүйс, Шаргын говь, Баруун Хуурайн хотгор, Алтайн Өвөр говьд 50 мм-ээс бага тунадас унадаг. Байгаль орчны ерөнхий үзүүлэлтүүдийг дараах хүснэгтүүдэд үзүүлэв.

#### Баруун бүс нутгийн агаарын температур 2007 оны байдлаар аймгийн төвөөр / Хүснэгт 5.4 /

| д/д | Аймгийн төв | Агаарын температур, $^{\circ}\text{C}$ |
|-----|-------------|--|
| 1   | Өлгий       | 3.5                                    |
| 2   | Алтай       | 0.6                                    |
| 3   | Улиастай    | 0.5                                    |
| 4   | Улаангом    | 0.4                                    |
| 5   | Ховд        | 2.4                                    |

#### Хур тунадасны нийлбэр, хур тунадастай өдрийн тоо 2007 оны байдлаар, аймгийн төвөөр, / Хүснэгт 5.5 /

| д/д | Аймгийн төв | Хур тунадас, мм | Хур тунадастай өдрийн тоо |
|-----|-------------|-----------------|---------------------------|
| 1   | Өлгий       | 96.6            | 73                        |
| 2   | Алтай       | 126.5           | 78                        |

|   |          |       |     |
|---|----------|-------|-----|
| 3 | Улиастай | 170.6 | 105 |
| 4 | Улаангом | 81.1  | 106 |
| 5 | Ховд     | 86.7  | 54  |

Цаг уурын олон жилийн дундаж үзүүлэлт, аймгаар, 2007 оны байдлаар, /Хүснэгт 5.6/

| д/д | Аймаг      | Хур тунадас, мм | Олон жилийн дундаж, хэм °С |         |
|-----|------------|-----------------|----------------------------|---------|
|     |            |                 | 1-р сар                    | 7-р сар |
| 1   | Баян-Өлгий | 115.5           | -17.2                      | 16.3    |
| 2   | Говь-Алтай | 204.1           | 18.0                       | 13.7    |
| 3   | Завхан     | 217.1           | 22.6                       | 15.0    |
| 4   | Увс        | 38.4            | 32.3                       | 19.0    |
| 5   | Ховд       | 127.4           | 24.4                       | 18.5    |

Ойн түймэр, түймэрт өртсөн удаагаар  
2007 оны байдлаар, /Хүснэгт 5.7/

| д/д | Аймаг, бүсүүд | Хур тунадас, мм |
|-----|---------------|-----------------|
| 1   | Баруун бүс    | 18              |
| 2   | Баян-Өлгий    | 3               |
| 3   | Завхан        | 7               |
| 4   | Увс           | 8               |
| 5   | Ховд          | -               |
| 6   | Говь-Алтай    | -               |

Ойгоос бэлтгэсэн модны хэмжээ, бүсээр, 2007 оны байдлаар, /Хүснэгт 5.8/

| д/д | Аймгийн төв     | Бэлтгэсэн модны хэмжээ, мян.м <sup>3</sup> |
|-----|-----------------|--|
| 1   | Өлгий           | 5.0  |
| 2   | Алтай           | 4.0  |
| 3   | Улиастай        | 104.0                                      |
| 4   | Улаангом        | 32.8                                       |
| 5   | Ховд            | 4.0  |
|     | Бүсийн хэмжээнд | 149.8                                      |

Ахуйн зориулалтаар 2008 онд агнах агнуурын зөвшөөрөл, /Хүснэгт 5.9/

| д/д | Аймаг      | Цагаан зээр | Загас | Зээр | Бор гөрөөс | Үнэт хярс |
|-----|------------|-------------|-------|------|------------|-----------|
| 1   | Баян-Өлгий | -           | 420   | -    | -          | 200       |
| 2   | Завхан     | -           | -     | 10   | -          | -         |
| 3   | Увс        | -           | -     | -    | 20         | -         |
| 4   | Ховд       | -           | 970   | -    | -          | -         |

Баруун бүсийн гадаргын усны тоо, /Хүснэгт 5.10/

| Аймаг      | Гол горхи |          | Булаг шанд |          | Рашаан |          | Нуур цөөрөм |          |
|------------|-----------|----------|------------|----------|--------|----------|-------------|----------|
|            | нийт      | ширгэсэн | нийт       | ширгэсэн | нийт   | ширгэсэн | нийт        | ширгэсэн |
| Баян-Өлгий | 303       | 11       | 831        |          | 24     | -        | 125         | 179      |
| Говь-Алтай | 238       | 9        | 858        | 31       | 2      | -        | 69          | 3        |
| Завхан     | 297       | 66       | 535        | 53       | 30     | -        | 123         | 19       |
| Увс        | 177       | 2        | 462        | 44       | 28     | 1        | 113         | 29       |
| Ховд       | 238       | 30       | 517        | 32       | 25     | 25       | 127         | 8        |

Агаар дахь бохирдуулагч бодисын жилийн дундаж, /Хүснэгт 5.11/

| д/д | Аймгийн төв | Хүхэрлэг хий SO <sub>2</sub> | Азотын давхар исэл NO <sub>2</sub> |
|-----|-------------|------------------------------|------------------------------------|
| 1   | Өлгий       | 0.001                        | 0.003                              |
| 2   | Алтай       | *                            | *                                  |
| 3   | Улиастай    | 0.003                        | 0.009                              |
| 4   | Улаангом    | 0.003                        | 0.025                              |
| 5   | Ховд        | 0.005                        | 0.035                              |

\*Агаарын бохирдлын харуулгүй болно.

**Байгаль орчны ерөнхий үнэлгээгээр хязгаарлагдмал боломжтой гэсэн үнэлгээгээр тодорхойлогдож байна.**

### 5.2.1 Цэвдэг хөрсний тархалт

Баруун бүст орших хот суурингуудын буйр хөрсний хөрс чулуулгийн улирлын хөлдөлт, гэсэлт 1.0-3.5м байгаа юм.

Агаар мандал дулаарснаас шалтгаалан уулсын дотор агуулагдаж байгаа цэвдэг болон ус чийг их хэмжээгээр алдагдаж байна.

Алтайн нуруу дагасан суурин газруудын буйр хөрсний доорхи цэвдэгийн зузаан нь 50-100 м ба түүнээс дээш байгаа юм. Олон жилийн цэвдэг чулуулгийн температур нь 0<sup>0</sup>C-5<sup>0</sup>C байна.

Алтайн нурууны ар, Ханхөхийн нуруу, Их-Түргэн, Хангайн нурууны ар талаар олон жилийн цэвдэг бөөрөг, халиа, дулааны хөндийлж, цэвдэгийн гулсалт, хөрс гулсалт, цэвдэгийн гаралтай тэгшрэл зэрэг олон хэвшлүүд, геологийн олон үзэгдлүүд явагдаж байна.

Энэ талаар шинжлэх ухааны үүднээс хэмжих, зураглах, турших судлах асуудал онц чухал шаардлагатай байгаа тул энэ төслийн хүрээнд шийдвэрлэх бололцоотой юм.

Гэхдээ зарим нэгэн судалгааны ерөнхий материал, газар дээр нь үзэж ажигласан болон орон нутгаас авсан мэдээллүүдэд тулгуурлан нилээд хэдэн сумын төвүүдийн буйр хөрсний хэв шинжийг үзүүлэв.

### Аймгуудын цэвдэг хөрсний тархалт /Хүснэгт 5.12/

| Аймаг      | Сум          | Байрлал                     | Цэвдгийн тархалт                                      | Тайлбар   |
|------------|--------------|-----------------------------|---|---|
| Баян-Өлгий | Цагаан нуур  | Тус сумын төвийн орчим      | 70м гүнтэй мөнх цэвдэгтэй                             | -   |
|            | Цагаан нуур  | Улаанбайшинт боомтын орчимд | Алаг цоо цэвдэгтэй                                    | -   |
| Ховд       | Алтай        | -                           | -   | Хөрсний шургасан уснаас үүссэн улирлын цэвдгээс хамааран 2005 онд нүүсэн. |
|            | Дуут Ховд    | Сумын төвүүд Сумын төвүүд   | Улирлын ба алаг цоог цэвдэгийн тархалттай.            | -   |
| Завхан     | Баянхайрхан  | -                           | Хажуу газар ба усны хагалбарын олон жилийн цэвдэгтэй. | -   |
|            | Тосонцэнгэл  | -                           | Хажуу газар ба хотгорын цэвдэгтэй                     | -   |
|            | Отгон        | -                           | Хөндий хотгорын цэвдэгтэй                             | -   |
|            | Нөмрөг       | -                           | Хажуу бэлийн олон жилийн цэвдэгтэй                    | -   |
|            | Их Уул       | -                           | Уулын бэл хажуугийн цэвдэгтэй                         | -   |
| Говь-Алтай | Чандмань сум | Гичгэний нурууны ард орших  | Хажуу газар усны хагалбарын цэвдэгтэй                 | -   |
|            | Эрдэнэ сум   |                             | Хажуу газар, хөндий хотгорын цэвдэг хуримтлагдсан     | -   |
|            | Шарга        |                             |   |   |
|            | Жаргалан     |                             |   |   |
|            | Цогт         | -                           | Алаг цоог ба ховор алаг цоог тархсан цэвдэгтэй.       | -   |
|            | Дарви        |                             |   |   |
| Бугат      |              |                             |   |   |
| Увс        | Хяргас       | сумын төв                   | -   | Сумын төв 1986 онд  |

|  |              |   |   |  |
|--|--------------|---|---|--|
|  |              |   |   | нүүж байсан түүхтэй  |
|  | Тариалан     |   | Бага зэрэг алаг цоог тархацтай цэвдэгтэй        | -  |
|  | Хархираа     | - |   |  |
|  | Улаангом хот | - | хөрсний ус дээр байрласан тул улирлын цэвдэгтэй | Энэ нь Хархираа, Түргэний уулсын хөрсний ус хөрсөн доогуур шурган их хэмжээний дошин үүсгэсэнтэй холбоотой |

### 5.2.2 Элсний нүүлтэд өртөж байгаа газар нутаг

Баян-Өлгий аймгийн Ховд, Бөхмөрөн, Ховд сумдууд, голуудын хөндий бэл, Ховд аймгийн Хар ус, Хар нуур, Дарви, Манхан, Булган гол зэрэг газрууд элсний нүүлтэнд хүчтэй өртөж байгаагаас гадна Баруун хуурайн хоолой, Хонин усны хоолой зэрэг газруудад хөрс эвдэрч, зулгарах, элсэн тарамцаг үүсэх явдал ихээр ажиглагдаж байна.

Байтаг богдын ар хөндий, Баруун хуурай, Хонин усны хоолойд маш их хэмжээгээр заг, заганцар болон модлог ургамлыг түлшинд хэрэглэж Ховд аймгийн хэрэгцээг хангаж байна.

Говь-Алтай аймгийн ихэнх нутаг бараг 60-70 хувь нь элсний нүүлтэд өртөж ургамлын бүрхэвч зулгарч, хөрс ихээр талхлагдан элсэн тарамцаг болон хувирч хавар намрын улиралд бөөрөг элс, элсэн товцог үүсэж байна. /Зураг 5.4/

Увс, Говь-Алтай, Завхан аймгийн нийт нутаг элсний нүүлтэд өртөн, ургамлын бүрхэвч холилдон, алаг өвс, модлог үетэн ургамлаар солигдох болжээ.

Увс аймгийн Завхан, Өмнөговь, Өлгий, Зүүнговь, Завхан аймгийн Ургамал, Сантмаргад, Завханмандал, Эрдэнэхайрхан, Дөрвөлжин, Алдархаан, Түдэвтэй сумууд элсний нүүлтэд хүчтэй өртөөд байна.

Завхан аймгийн Сантмаргад суманд айлын хашаа байшин элсэнд дарагдаж нилээд хүнд нөхцөлд ажиллаж амьдарч байна.

Баруун бүс нутагт нийт мал сүргийн 60 гаруй хувь нь ямаа байгаа тул ямааны тоо толгойг цөөрүүлж сүргийн бүтцийг тэнцвэржүүлэх шаардлагатай байна.

Алтай, Хангайн уулсын нэн ховор ургамлын бүрхэвч, өнгөн хөрсийг ямаа талхлан сүйтгэж байгаа тул малыг олноор нь өсгөн үржүүлснээр нэртэй аварга малчин шалгаруулдаг зохисгүй байдлыг арилган эртний уламжлалт сүргийн бүтцээр хонинд эзлэх ямааны тоог 8-10 хувиар тогтоох нь зүйтэй.



### 5.3. БАРУУН БҮСИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН ЭКОЛОГИ-ХОТ БАЙГУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ

Баруун бүс нутагт нийтдээ 576 хот суурин газар байгаагаас бүс нутгийн хөгжлийн тулгуур төв Ховд, Улиастай, орон нутгийн хөгжлийн төв Алтай, Улаангом, Өлгий, бүлэг суурингийн төв 15, гааль, чөлөөч бүс 7, сумын төв 92, багын төв 461 байна.

Бүс нутгийн хэмжээний хот, суурин газрын экологи-хот байгуулалтын үнэлгээг нэг бүрчлэн хийх техник-технологийн онцгой шаардлагагүй учраас бүлэглэн багцлан ерөнхий дүгнэлтүүдийг гаргав.

Харин бүсийн тулгуур төв, бүсийн орон нутгийн хөгжлийн хотуудын үнэлгээг саяхан хийсэн шинэ суурь судалгаанд тулгуурлан хийлээ. Бүс нутгийн инженер геологийн бүлэгт гидрогеологи, геотехник, физик-геологийн үзэгдлүүд тэдгээрийн тархац, нөлөөлөх байдлыг тодорхой тусгасан болно.

Говь, цөлийн бүст газрын доороос 2-5м гүнээс ус авч ашиглаж байгаа боловч хужир, давс ихтэй учир хүний биед муугаар нөлөөлж байгааг анхааран үзэж усыг хамгаалах цэвэршүүлэх, ашиглах талаар төсөлд тодорхой тусгасан. Ер нь **усан хангамжийн эх үүсвэрийн талаар бичсэн бүлгийн** дүгнэлтээс үзвэл усаар хангагдах бололцоотой учир тохиромжтой гэсэн үнэлгээгээр тодорхойлогдож байна. Иймээс усан хангамжийн талаар дахин энэ бүлэгт нурших нь илүүц гэж үзээд хот байгуулалтад нөлөөлөх байгаль орчны бусад хүчин зүйлийг дэлгэрэнгүй авч үзсэн болно.

#### 5.3.1 Баруун бүс нутгийн экологи-хот байгуулалтын ерөнхий үнэлгээ

##### 5.3.1.1 Бүс нутгийн хот, суурингууд далайн түвшнээс дээш өргөгдсөн байдал

Баруун бүс нутгийн монголчуудын амьдрах орчин, ёс заншил уламжлалт мал аж ахуйд суурилсан учраас Баян-Өлгий аймгийн нийт хот суурингийн 90 хувь нь, Увс аймгийн нийт хот суурингийн 23 хувь нь, Завхан аймгийн нийт хот суурингийн 43 хувь нь Ховд аймгийн нийт хот суурингийн 48 хувь нь, Говь-Алтай аймгийн нийт хот суурингийн 39 хувь нь далайн түвшнээс дээш 2000-2500 метрийн өндөрт оршиж байна. Үлдэх хэсэг нь Ачит нуурын хөндий, Увс нуурын хонхор, Их нууруудын хотгор, Алтайн цаадах говь, Шаргын говийн хөндийд далайн түвшнээс дээш 1500-2000 метрийн өндөрт оршин амьдарч байна.

Баруун бүс нутагт орших хот суурин газрууд нь өндөр уул, тал хөндий хослон байрлах /*Зураг 5.5*/ бөгөөд **өндрийн байрлалын хувьд тохиромжтой гэсэн үнэлгээнд хамаарагдана.**

##### 5.3.1.2 Баруун бүс нутагт барилга байгууламж барих уур амьсгалын мужлалт

Баруун бүс нутаг Монгол орны бусад бүсүүдийн нэгэн адил эрс тэс уур амьсгалтай, хахир өвөл, гантай зун, салхирхаг хавар, намрын улирлууд солигдон байдаг.


Үйлдвэр, хөдөө аж ахуйн салбаруудад тохиолдож болох уур амьсгалын зарим үзэгдлийг хүчтэй салхи, цасан шуурга, шороон шуурганы давтагдлын тоог олон жилийн турш ажиглан тогтоосон ус, цаг уурын шинжилгээ, эрдэм шинжилгээний батлагдсан материалуудад тулгуурлав. Баруун бүс нутагт зарим өдөрт 1-6 цагийн турш хүчтэй салхи 20-30м/сек хурдтай салхилдаг юм. /*Зураг 5.7*/

Барилга байгууламжийн зураг хайгуул, геологийн эрэл хайгуул, олборлолт явуулахад ашиглаж болох салхины тооцоот их хурдыг үзүүлэв. Барилга байгууламж барьж байгуулах хугацаа нь 225 хоног үргэлжлэх бололцоотой юм.



Энэ нь барилгын барих хугацааны уур амьсгалын нөлөөллийн 62 хувь нь тохиромжтой нөхцөлд хамаарагдах тул *хязгаарлагдмал тохиромжтой гэсэн үнэлгээгээр тодорхойлогдоно.*

БАРУУН БҮС НУТГИЙН ӨНДРИЙН БАЙРЛАЛ



5.3.1.3 Бүс нутгийн хот суурингуудын эдэлбэр газрын налуу /хэвгий/

Баруун бүс нутгийн хот суурин газруудын 42 хувь нь дундаж өндөр уулсын бүст, 23 хувь нь нам уулсын бүст, 25 хувь нь өндөрлөг тал ба цав толгодын бүст, 10 хувь нь намдуу тал, томоохон хотгор газрын бүст хамаарагддаг юм.

*/Зураг 5.6/*

Баян-Өлгий аймгийн хот суурин өндөр уулын бүст багтах боловч 15 хувь нь 6-12 хэмийн хэвгий газарт, үлдэх хот суурин нь уулсын бэл хормой, голын хөндийд, Увс аймгийн хот суурин газруудын 19 хувь нь 3-6 хэмийн хэвгий газарт, Ховд аймгийн хот суурин газруудын 26 хувь нь 3-6 хэмийн хэвгий газарт, Завхан, Говь-Алтай аймгийн хот суурин газрын 6 хүртэлх хувь 6-12 хэмийн хэвгий газарт, 49 хувь нь 3-6 хэмийн хэвгий газарт, 36-40 хувь нь 3 хүртэл хэмийн хэвгийтэй тал хөндий газарт байрлалтай.

Бүс нутгийн ихэнх хот суурин газруудын 50 илүү хувь нь 3 хэмийн хэвгийгээс дээш байгаа тул хот суурины эдэлбэр газар нь нийтдээ хязгаарлагдмал тохиромжтой гэсэн үнэлгээгээр тодорхойлогдоно.

Харин тулгуур төв хот болон орон нутгийн хөгжлийн хотууд, бүлэг суурингийн төвүүдэд **тохиромжтой гэсэн үнэлгээгээр тодорхойлогдоно.**

#### **5.3.1.4 Бүс нутгийн хот суурингуудын үер, ус, салхи шуурга элсний нөлөөнд автах байдал**

Бүсийн тулгуур төв хот, орон нутгийн хөгжлийн хотууд үер уус, салхи шуурга, элсний нөлөөнд автах нь харьцангуй бага бөгөөд Алтай хотод 20-30 м/сек салхилж, барилгын дээвэр хуурах үзэгдэл сүүлийн 50 жилд 3 удаа тохиосон байна.

*/Зураг 5.8/*

Баруун бүс нутаг жилийн 4 улирлын 250-270 хоногт 10-15 м/сек-ээс дээш хурдтай салхилдаг учир **салхитай өдрийн тоогоороо тохиромжгүй гэсэн үнэлгээгээр үнэлэгдэнэ.**

Элсний нөлөөнд автах байдлаараа Ховдын Булган, Буянт, Дөргөн, Мянгад, Зэрэг, Чандмань сумууд, Увс аймгийн Зүүн говь, Малчин, Баруун туруу, Өлгий, Завхан сумууд, Завхан аймгийн ургамал, Сантмаргад, Завхан мандал, Эрдэнэ-Хайрхан, Дөрвөлжин, Баян –Уул, Жаргалан, Алдархаан сумууд, Говь-Алтай аймгийн Бугат, Төгрөг, Халиун, Дэлгэр, Бигэр, Шарга, Алтай зэрэг сумууд элсний нүүлтэнд дарагдаж болзошгүй болон автогений нөлөөнд их өртсөн, ургамалан нөмрөг ихээр өөрчлөгдсөн сул хөрстэй учир цаашид арга хэмжээ авах шаардлагатай.


Элсний нүүлтэнд өртөж болох үзүүлэлт нь сумын төвүүдээр жишиж үзэхэд 72 хувь нь элсний нүүлтэнд хамаарагдахгүй боловч сумын төв болон төвийн орчны 10-15 км –ийн хүрээнд газрын хөрс суларч, зулгаран, хөрсний хүчтэй доройтолд орсон байна.

Элсний нөлөөнд ихэнх хувь нь автагдахгүй байдлаараа **тохиромжтой гэсэн үнэлгээгээр үнэлэгдэж байна.**

Зураг

БАРУУН БҮС НУТГИЙН ГАДАРГЫН ЭГЦ НАЛУУЖИЛТ

1: 3 000 000





ТАНИХ ТЭМДЭГ

- Аймгийн төв
- Улсын хил
- Аймгийн хил
- Гол мөрөн, нуур
- 3° хүртэл хэвгий газар
- 3-6° хүртэл хэвгий газар
- 6-12° хүртэл хэвгий газар
- 12-20° хүртэл хэвгий газар
- 20° -аас дээш хэвгий газар


Зураг

ЗУРАГ ТӨСӨЛ, БАРИЛГЫН АЖИЛД ЗОРИУЛСАН  
АГААРЫН БАГА ТЕМПЕРАТУРЫН ТООЦООНЫ  
ҮЗҮҮЛЭЛТ

1 : 3 000 000




- 40** — Хоногийн агаарын температурын хамгийн хүйтэн хэм /C °/
- 200** — Хоногийн агаарын температур 8 C°-аас их байх галлагааны үсийн үргэлжлэх хугацаа, өдрөөр



БАРУУН БҮС НУТГИЙН САЛХИНЫ ХУРДНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Зураг

1: 3000 000



### 5.3.1.5 Бүс нутгийн хот суурингуудын хөрсний усны түвшин олон жилийн цэвдэг хөрсний тархалт

Баруун бүс нутгийн оршин байгаа хот, суурин газрын доорхи хөрсний ус болон цэвдэг чулуулгийн тархац нь хоорондоо харилцан хамааралтай бөгөөд олон жилийн цэвдэг чулуулаг нь хажуу газар ба усны хагалбарын, хөндий хотгорын ёроолын тархац нь Алтайн нуруу, Хан-Хөхийн нуруу, Хангайн нурууны салбар уулст жилийн дундаж хөрсний температур нь  $-0^{\circ}$ - $5^{\circ}$  С, зонхилох зузаан нь 50м-ээс доош, 100м-ээс дээш, улирлын гэсэлтийн гүн нь 1,7-3,5м байна.

Улирлын цэвдэг чулуулгын хувьд хажуу газар ба усны хагалбар, хөндий хотгорын ёроолын, Их нууруудын хотгор, Алтайн цаадах Говь, Увс нуурын хотгор, Идэр, Завхан голын хөндий дагуу байрлалтай бөгөөд хөрсний жилийн дундаж температур нь  $0^{\circ}$ - $5^{\circ}$  С, цэвдгийн зонхилох зузаан нь 2-4,5 м байна.

Цэвдэг чулуулгийн тархацын байдлыг газарзүйн цэвдэг судлалын хүрээлэнгээс гаргасан зарим судалгааг үндэслэв.

Бүс нутгийн нийт нутаг дэвсгэрт оршин байгаа хот суурин газрын доорхи хөрсний ус нь хур тунадас бага, улирлын цэвдэг, олон жилийн цэвдгийн нилэнхүйдээ тархсан бүст 60 орчим хувь нь хамаарагдаж байгаа тул **тохиромжгүй гэсэн үнэлгээгээр үнэлэгдэж байна.**

### 5.3.1.6 Бүс нутгийн ул хөрсний төрөл

Бүс нутгийн хот суурин газрын ул хөрсний төрөл нь хөрс-био уур амьсгалын Төв Азийн болон Зүүн гарын их мужид хамаарагдана.

Ул хөрсний бүсийн хэв шинжээрээ хангайн, говийн муж дэд бүсүүдээрээ өргөргийн, холимог, өндрийн гэсэн 3 бүст хуваагдана.

Барилга байгууламж барихад хүчтэй нөлөөлөх хөрсний ангилалаараа Алтайн нурууны, Говь цөл, хээрийн, Хангайн нурууны, геологийн тогтоц хэв шинжээрээ ялзмаг 0.5-1.0%, усны тунгаагдмал 0.5-5.0 Ph,  $\text{CaCO}_3/\text{CaSO}_4$  хувийн жин 0,5-8м хүртэл зузаантай хөрсний өнгөн хэсгийн сэвсгэр хурдас, цэвдэг чулуулаг, хөрсний ус, хайрга, дайрга, элсэн чигжээстэй геологийн тогтоцын хурдас ба эрдэсүүдээс бүтнэ. Гидрогеологийн хэв шинжээрээ ус агуулагч чулуулгийн бүрдэл буюу нүх сувгийн ус, ан цавын ус, инженер геологийн нөхцлөөрөө тавцангийн дараах шинэхэн идэвхжлийн хэвшлүүд ба геологийн гарал үүслийн 19, эх газрын моласс тунамал хурдсын хэвшлүүд, дунд дээд эрт төрмөлийн уул үүслийн үе шатны хурдсын нэгдэл, геосинклинал үе шатны хурдсын нэгдэл, газрын гадарга дээрхи ул хөрсний хад, хадархаг нэгдлүүд, сэвсгэр ул хөрсний шавар, шавранцар элсэн дүүргэгчтэй бул чулуу элсэнцэр шавар дүүргэгчтэй хэмхэдэс, хайрганцар, хайрга сайр чулуу, элс-шавар, элс-шавранцар, элс дүүргэгчтэй нэгдлүүд бүс нутгийн хот суурин газарт явуулсан инженер геологийн дүгнэлтүүдээс тодорхойлогдож байна.

Инженер геологийн мужлалтаараа Баян-Түргэний, Ачит нуурын, Мөнх Хайрханы, Булган голын, Гичгэний, Арц богдын, Аж богдын, Баруун Хуурайн, Байтаг богд-Тахийн шарын, Үенчийн, Алтайн өврийн, Увс нуурын, Хар нуурын, Зэргийн, Шаргын, Бигэригийн, Нууруудын хөндийн, Гуулингийн, Их-Уулын, Ханхөхийн мужуудад хуваагдсан геологийн гарал үүсэл, сэвсгэр хурдсын хэв шинжээрээ 19 дэд мужид хуваагдсан учир судлаж тогтооход маш их хүч хөдөлмөр, хөрөнгө зарж хийхээр томоохон ажил юм.

Гэхдээ хот, суурин газрын инженер геологийн судалгааны материал, инженер геологийн 1:3 000 000 –ны зургаас хийсэн дүгнэлтээр 25 хувьд нь барилга байгууламж барихад тохиромжгүйгээр үнэлэгдэж байгаа юм.

Тухайн хот суурины ул хөрсийг геологи, газар чичирхийлэл, геофизикийн тандан судалгааны аргаар объект бүрт нарийвчлан хийх нь техник-технологийн шийдлийг зөв гаргахад дөхөмтэй болохыг цаашид анхааран судлах хэрэгтэй.

**5.3.1.7 Бүс нутгийн газар чичирхийллийн төлөв байдал**

**Шинэхэн тектоникийн мужлалтаараа** тавцангийн дараах уул үүслийн мужийн Алтайн дэд бүс, Их нууруудын Хотгорын хөндийн бүс, Говийн Тяньшаний бүс, Хангайн бүс,, Алтайн өврийн бүсүүдэд хуваагдана.

**Гүний тогтоцоор** – Мохоровичийн гадаргын орших гүн нь Алтайн, Хангайн нуруунд 50-55км-ээс доош гүнд, Их нууруудын хотгор, Алтайн Өвөр говьд 40-50 км-ээс доош гүнд, Хяргас, Увс нуурын орчимд 40км-ээс доош буюу 40-45км-ээс доош гүнд хамаарагдана.

**Чичирхийллийн тектоникийн** хувьд Хан Хөхийн нуруу дагасан, Хархираа-Түргэний уулс дагасан, Монгол Алтайн нуруу дагасан, Хан Тайширын нуруу дагасан, Алтайн цаад говь дагасан нэн хүчтэй байж болзошгүй чичирхийлэл үүсгэсэн бүс нутгийн чанартай хагарлууд, Хан Хөхийн нурууны, Алтайн нурууны чичирхийлэл сэргэсэн хагарлууд хүчтэй газар хөдлөлийн голомтыг үүсгэж болох юм.

**Газар чичирхийллийн мужлалтаараа** – / Зураг 5.9 /Монгол Алтайн нуруу, Хан Хөхийн нуруу, Хангайн нуруунд 9 баллын хүчтэй 2 давтамжтай газар хөдлөж болзошгүй, Увс, Хяргас, Хар нуур, Шарга, Булган гол, Алтайн сум, Улиастай орчимд 7 баллын хүчийг 2-3 давтамжтай газар хөдлөж болзошгүй, /MSK-64 шатлалын баллаар авсан /

**Баруун бүс нутаг дахь хүчтэй газар хөдлөлийн төвүүд нь багажаар хэмжсэн үзүүлэлтээр-** Магнитуд рихтерийн шатлалаар Улиастай, Булнай, Хархираа-Түргэн, Хан Тайшир, Цэнгэл Хайрхан, Ховд хотын орчмоор 5.0-6.5 балл байна. Ховд хотоос баруун урагш Дуут-Мөнх Хайрханы чиглэлд 8-аас дээш балл, Ачит нуур, Цэнгэл Хайрхан, Булган гол, Бүс Хайрханы орчимд 7.1-8.0 баллын газар хөдлөлүүдийг бүртгэн 1990 онд тэмдэглэсэн байна.

Баруун бүс нутаг өндөр уул нурууд элбэг, газар хөдлөх магадлал ихтэй байгаа боловч газар хөдлөлтийг судалсан байдлуудаас харахад хот суурин газрууд газар хөдлөлтийн нөлөөнд сүүлийн 50 жилд өртөөгүй учир хүн ам олноор сууршиж оршин амьдрах нөхцлөөр нь авч үзвэл газар чичирхийллийн хүчэнд өртөх нөлөө **хязгаарлагдмал тохиромжтой гэсэн үнэлгээгээр тодорхойлж байна.**

Баруун бүс нутгийн экологи болон хот байгуулалтын ерөнхий үнэлгээ /Хүснэгт 5.13/

| Д/д | Үнэлгээний төрөл  | Тохиромжгүй | Хязгаарлагдмал тохиромжтой | Тохиромжтой |
|-----|---|-------------|----------------------------|-------------|
| 1   | Далайн түвшнээс дээш өргөгдсөн байдал                   |             |                            | +           |
| 2   | Барилгын аль уур амьсгалд хамаарах                      |             | +                          |             |
| 3   | Эдэлбэр газрын гадаргуугын налуу                        |             |                            | +           |
| 4   | Үер ус, салхи, шуурга, элсний нөлөөнд автагдах байдал   |             |                            | +           |
| 5   | Хөрсний усны түвшин ,олон жилийн цэвдэг хөрсний тархалт | +           |                            |             |
| 6   | Ул хөрсний төрөл  | +           |                            |             |
| 7   | Газар чичирхийлэл                                       |             |                            | +           |
| 8   | Усан хангамж  |             |                            | +           |

$$ХБҮ = \sqrt{\frac{[n^2]}{3}} = 3.3 \text{ буюу тохиромжтой гэсэн үнэлгээгээр тодорхойлогдож байна.}$$


Баруун бүс нутаг төдийгүй Монгол орны хот суурин газрын газар чичирхийллийн судалгааг хойшлуулалгүй ойрын хугацаанд хийх нь чухал болж байна

-E

ГАЗАР ЧИЧИРХИЙЛЛИЙН МУЖЛАЛТ


1:3 000 000

Зураг



**ТАНИХ ТЭМДЭГ**

- Аймгийн төв
- Улсын хил
- Аймгийн хил
- Гол
- ..... Янз бүрийн давтамжтай газар хөдлөлийн бүсийн хил
- Газар хөдлөлтийн голомт үүсэж болох бүсийн хил





**5.3.2 БҮС НУТГИЙН ХОТУУДЫН ЭКОЛОГИ  
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ**

Бүс нутаг нь Алтай - Соёны экосистемд хамаарагддаг юм. Алтай –Соёны экосистем нь нилээд эмзэгдүү өндөр уулс, хад асга, элс, элсэн тарамцаг зонхилсон нутаг юм. Улаан байшинт, Өлгий, Ховд, Манхан, Алтай шарга, Бургастайн чиглэлээр ОХУ-ын БИСК, гермогерк, Новокузнецк, зэрэг хотуудтай төмөр замаар холбогдох, урагшаагаа Хятад улсын Урумч, Хами, Хомины зэрэг томоохон хотуудыг холбосон хятад улсын аж ахуйн төмөр замтай холбогдох юм.

Арцсуурь, Тэс Түдэвтэй, Улиастай, Алтайн чиглэлийн дотоодын төмөр зам нь ашигт малтмалын хүдэр болон баяжмал зөөх, Тэс шинээр байгуулагдах Сутай хот, Дарвийн чиглэлийн төмөр зам нь худалдаа үйлчилгээний зориулалтаар баригдах юм. Үндсэн 3 төмөр өөр өөр зориулалттай зам болон мянганы зам босоо тэнхлэгийн авто замууд бүс нутгийг хөндлөн гулд дайран өнгөрөхдөө экологийн тодорхой өөрчлөлтүүдийг агуулж байгаа юм.

Бүс нутагт шинээр баригдах төмөр зам нь амьтдын нүүдэлд сөргөөр нөлөөлж болох юм. Тухайлбал Шарга-Манханы тусгай хамгаалалттай газар нутгийг сэлгэн нүүдэллэн явдаг Бөхөн гөрөөс нь хүйсийн говийн дагуу буюу хөндлөн дайрч гарахаар төлөвлөгдөж байгаа төмөр замтай зөрчилдөх хандлагатай байна. Иймд Манхан, Зэрэг дайран Дарви, Шарга сумын нутгаар өнгөрөх төмөр замыг мал, ан амьтан хөндлөн гарч өнгөрөх зориулалттай нүхэн гарц буюу гүүрэн гарцыг байгуулахаар төлөвлөв. Нүхэн гарц нь баян бүрд хэлбэрийн ус болон модлог ургамалтай, ан амьтан цааш нааш шилжин явах бололцоотой болно.

Харин авто замын хувьд ан амьтан нүүдэллэхэд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж болно. Төмөр замыг дагаж хүн амын нутагшилт, суурьшилт ихээр нэмэгдэх тул ан амьтдыг үргээх, агнах, хөрсийг нь талхлах, усыг бохирдуулах, агаар мандлыг бохирдуулах зэрэг нь ан амьтдыг нүүдэллэх, хэвийн идээшлэн амьдрахад нөлөөлнө. Тахь болон мазаалайн оршин амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх тул онцгой анхаарах нь зүйтэй. Төмөр замыг барин байгуулах зураг хайгуулын ажлын үе шатанд экологийн үнэлгээ хийж Засгийн газрын бодлогоор бүс нутгийн экологийн тэнцвэртэй оршин байх нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй.

**Бүс нутагт төмөр зам, авто зам, барьж байгуулахад  
экологит үзүүлэх өөрчлөлт /Хүснэгт 5.14/**

| Д/д | Байгалийн бүслүүр   | Экологит үзүүлэх өөрчлөлт %-иар |          |                     |
|-----|---------------------|---------------------------------|----------|---------------------|
|     |                     | Төмөр зам                       | Авто зам | Хүний үйл ажиллагаа |
| 1   | Өндөр уулын бүслүүр | 10                              | 20       | 20                  |
| 2   | Хуурай хээр         | 15                              | 15       | 12                  |
| 3   | Цөлжүү хээр         | 10                              | 10       | 8                   |
| 4   | Хэт гандуу цөл      | 13                              | 10       | 5                   |
| 5   | Жинхэнэ цөл         | 20                              | 10       | 5                   |
|     | Дундаж              | 13.6                            | 13.0     | 10.0                |

Бүс нутагт төмөр зам, авто зам, барьж байгуулахад экологит үзүүлэх өөрчлөлтийг хувинд тооцон гаргав. Энэ нь байгалийн бүслүүрийн хэв шинжээр авч үзвэл төмөр зам, авто зам, хүний үйл ажиллагаа байгальд үзүүлэх нөлөөллүүд нь өөр өөр байгаа юм. Тухайлбал төмөр замын байгальд сөргөөр нөлөөлөх байдал нь 13.6 хувь, авто замынх 13 хувь, хүний үйл ажиллагаа 10.0 хувь, байгаа юм. Байгаль орчинд нөлөөлөх байдлыг бууруулахын тулд байгальд халгүй техник технологиор зам барилгын ажлыг гүйцэтгэж, замын байгууламжуудыг экосистемд сөргөөр нөлөөлөхгүй байдлаар ашиглах явдал чухал болж байна. Зам дагаж хөгжил ирдэг гэсэн байгаль эхээ унаган төрхөөр нь ургамал, ан амьтан, цэлмэг хөх тэнгэртэй нь хойч үедээ хүлээлгэн өгөх явдал чухал болж байна.

Бүс нутгаар дайран өнгөрөх төмөр замын сүлжээг байгуулах төслийг хийхдээ экосистемтэй нь нягт уялдуулан хийх явдал чухал болоод байна. Төмөр замын сүлжээ нь харилцан Түргэн, Хар-Ус, Хяргас, Говь-Алтайн салбар уулс, Хонгорын Хар азарга, Гичгэний, амьтан явдаг Хангалын нурууны өвөр бие, нууруудын хөндий, Хангалын нурууны баруун хэсгийн Сангилэнгийн дэд мужуудыг дайран өнгөрч байгаа юм. Дэд муж болгон өөр орчин өвөрмөц байгаль ан амьтны хэв шинжүүдийг агуулсан маш өвөрмөц онцлогтой, экосистемийн маш эмзэг, ховор төрөл зүйл юм. Баруун бүс нутгийн сор болсон байгалийн үзэсгэлэн төгөлдөр газар нутагт хадгалагдах Сийлхэм, Цамбагаравын, Ээж хайрхан, Хар ус нуурын, Шаргын, Бурхан буудай, Алаг хайрханы, Хяргас нуурын, Хан хөхийн, Манханы байгалийн цогцолбор газрууд, Хасагт хайрханы, Алтан өлгий, Их говийн дархан газрын А,Б хэсгийн дундуур ойрхон газраар өнгөрөх юм. Энэ төслийн хүрээнд экологийн нарийвчилсан үнэлгээ хийх боломжгүй бөгөөд орон нутгийн байгууллагууд болон эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн гаргасан материал өөрсдийн хийсэн судалгаанд тулгуурлан экологийн ерөнхий төлөвийг тодорхойлов.

### 5.3.2.1 Баруун бүсийн тулгуур төв Ховд хотын хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ

Баруун бүсийн тулгуур төв Ховд хотын хот байгуулалтын иж бүрэн үнэлгээгээр судалгаа тооцооны бүсүүдийг 12 бүсэд хувааж байгаль-экологийн хүчин зүйлсийг хот оршин тогтнох үндсэн нөхцөл хэмжүүр нь болсон инженер геологийн нөхцөл, гидрогеологийн нөхцөл газрын дотоод хүчний нөлөөлөл хүрээлэн буй байгаль экологийн нөхцөл газрын гадаргын шинж төрхөөр ангилан үзэхэд ерөнхий үнэлгээг нь 3.33 балл гарч байгаа нь хот байгуулалтын тохиромжтой гэсэн үзүүлэлт юм.

#### Ховд хотын экологи-хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ /Хүснэгт 5.15 /

|    | Судалгаа тооцооллын бүсүүд(Ховд аймгийн Ховд хот 45.7 мян. мкв талбайд) / 0- 5 / балл | ҮЗҮҮЛЭЛТ                     |              |                               |              |                                       |                |                 |  |                               |                     |                              |                 |                        |   |  |                 |   |                        |
|----|---|------------------------------|--------------|-------------------------------|--------------|---------------------------------------|----------------|-----------------|--|-------------------------------|---------------------|------------------------------|-----------------|------------------------|---|--|-----------------|---|------------------------|
|    |   | ХҮЧИН ЗҮЙЛИЙН ҮНЭЛГЭЭ        |              |                               |              |                                       |                |                 |  |                               |                     |                              |                 |                        |   |  |                 |   |                        |
|    |   | Байгаль-Экологийн хүчин зүйл |              |                               |              |                                       |                |                 | Нийгэм эдийн засгийн хүчин зүй             |                               |                     |                              |                 |                        | Архитектур-орон зайн төлөвлөлт Ландшафтын хүчин зүйлийн үнэлгээ |  |                 |   | Ерөнхий дундаж үнэлгээ |
|    |   | Инженер геологи              | Гидрогеологи | Газрын дотоод хүчний нөлөөлөл | Хөрс ургамал | Хүрээлэн буй байгаль экологийн байдал | Газрын гадрага | Нэгдсэн үнэлгээ | Соёл ахуйн үйлчилгээний хангамжийн үнэлгээ | Орон сууцны хангамжийн түвшин | Зам тээврийн байдал | Инженерийн хангамжийн түвшин | Нэгдсэн үнэлгээ | Ландшафтын шинж байдал | Газар нутгийн зохион байгуулалт                                 | Архитектур орон зайн төлөвлөлтийн байдал | Нэгдсэн үнэлгээ |   |                        |
| 1  | Цамбагарав  | 3                            | 3            | 2                             | 2            | 4                                     | 3              | 3               | 3  | 3                             | 2                   | 3                            | 3               | 4                      | 3   | 2  | 3               | 3 |                        |
| 2  | Хайрхан   | 4                            | 4            | 2                             | 3            | 4                                     | 4              | 4               | 1  | 0                             | 0                   | 0                            | 0               | 2                      | 2   | 0  | 1               | 2 |                        |
| 3  | Наран   | 3                            | 4            | 2                             | 2            | 3                                     | 2              | 3               | 2  | 2                             | 2                   | 3                            | 2               | 4                      | 3   | 2  | 3               | 3 |                        |
| 4  | Бичигт  | 3                            | 4            | 2                             | 3            | 3                                     | 3              | 3               | 1  | 1                             | 1                   | 1                            | 1               | 3                      | 2   | 1  | 2               | 2 |                        |
| 5  | Баатархайрх   | 3                            | 4            | 2                             | 4            | 3                                     | 4              | 4               | 3  | 2                             | 1                   | 2                            | 2               | 2                      | 2   | 3  | 2               | 3 |                        |
| 6  | Буянт   | 3                            | 3            | 2                             | 3            | 3                                     | 4              | 3               | 2  | 3                             | 2                   | 0                            | 2               | 2                      | 3   | 3  | 3               | 3 |                        |
| 7  | Бугат   | 3                            | 4            | 2                             | 5            | 4                                     | 5              | 4               | 0  | 2                             | 1                   | 0                            | 1               | 3                      | 2   | 0  | 2               | 2 |                        |
| 8  | Жаргалан  | 4                            | 4            | 2                             | 3            | 5                                     | 4              | 4               | 3  | 2                             | 3                   | 2                            | 3               | 2                      | 3   | 3  | 3               | 3 |                        |
| 9  | Алаг толгой   | 4                            | 4            | 2                             | 3            | 4                                     | 4              | 4               | 1  | 1                             | 0                   | 1                            | 1               | 2                      | 3   | 2  | 2               | 2 |                        |
| 10 | Магсаржав   | 4                            | 4            | 2                             | 3            | 5                                     | 4              | 4               | 2  | 2                             | 2                   | 2                            | 2               | 2                      | 4   | 3  | 3               | 4 |                        |
| 11 | Тахилт  | 4                            | 3            | 2                             | 4            | 5                                     | 4              | 4               | 0  | 0                             | 0                   | 0                            | 0               | 2                      | 2   | 2  | 2               | 2 |                        |
| 12 | Рашаант   | 3                            | 3            | 2                             | 2            | 4                                     | 3              | 3               | 0  | 0                             | 2                   | 0                            | 0               | 4                      | 3   | 2  | 3               | 2 |                        |

Нийгэм эдийн засгийн хүчин зүйлийн үнэлгээгээр соёл ахуйн үйлчилгээний хангамжийн үнэлгээ, орон сууцны хангамжийн түвшин, зам тээврийн байдал,

инженерийн хангамжийн түвшний үнэлгээ нь 1.42 балл гэсэн үзүүлэлт гарч байгаа нь хангалтгүй гэсэн үзүүлэлт юм. Архитектур, орон зайн төлөвлөлт Ландшафтны хүчин зүйлийн үнэлгээгээр Ландшафтийн шинж байдал, газар нутгийн зохион байгуулалт, Архитектур, орон зайн төлөвлөлтийн байдлын нийлбэр үнэлгээний дундаж 2.42 балл гарч байгаа нь хот эмх замбараагүй ерөнхий төлөвлөгөөгөөр хэрэгжүүлж чадаагүй гэсэн үзүүлэлт юм.

### 5.3.2.2 Баруун бүсийн тулгуур төв Улиастай хотын хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ

Баруун бүсийн тулгуур төв Улиастай хот байгаль экологийн хүчин зүйлсийн үнэлгээгээр 4 гэсэн баллыг үзүүлэлттэй байгаа нь хот оршин тогтнох үндэс болсон газар нутаг сайтайг харуулж байгаа үзүүлэлт юм. Нийгэм эдийн засгийн хүчин зүйлийн үнэлгээгээр 2 гэсэн баллын үзүүлэлттэй байгаа нь хангалтгүй байгаа юм. Иймд Улиастай хотын соёл үйлчилгээ орон сууцны хангамж замын байдлыг сайжруулахын тулд 2002 онд Инженер Геодези ХХК нь боловсруулан Засгийн газраар батлагдсан хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг мөрдөх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлтийн ажлын зураг төсөл хийх шаардлагатай. Архитектур, орон зайн төлөвлөлт Ландшафтны хүчин зүйлийн үнэлгээгээр 3.28 гэсэн баллтай байгаа нь мөн л Архитектур, хот байгуулалт хангалтгүй цаашид өөрчлөн сайжруулах хотын газар нутгийн зохион байгуулалтыг сайжруулах явдал юм. Хот байгуулалтын ерөнхий үнэлгээ 3.3 гэсэн баллтай байгаа нь тулгуур хот болох нөхцөл бүрдээгүй байгааг харуулж байна.

Улиастай хотын экологи-хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ /Хүснэгт 5.16/

|   | Судалгаа тооцооллын бусууд( Завхан аймгийн Улиастай хот 436.2га талбайд) (0 – 5 ) балл | ҮЗҮҮЛЭЛТ                     |              |                               |              |                                       |                |                 |  |                               |                     |                              |                 |   |                                 |  |                        |                 |
|---|--|------------------------------|--------------|-------------------------------|--------------|---------------------------------------|----------------|-----------------|--|-------------------------------|---------------------|------------------------------|-----------------|---|---------------------------------|--|------------------------|-----------------|
|   |  | ХҮЧИН ЗҮЙЛИЙН ҮНЭЛГЭЭ        |              |                               |              |                                       |                |                 |  |                               |                     |                              |                 |   |                                 |  |                        |                 |
|   |  | Байгаль-Экологийн хүчин зүйл |              |                               |              |                                       |                |                 | Нийгэм эдийн засгийн хүчин зүй             |                               |                     |                              |                 | Архитектур-орон зайн төлөвлөлт Ландшафтын хүчин зүйлийн үнэлгээ |                                 |  | Ерөнхий дундаж үнэлгээ |                 |
|   |  | Инженер геологи              | Гидрогеологи | Газрын дотоод хүчний нөлөөлөл | Хөрс ургамал | Хүрээлэн буй байгаль экологийн байдал | Газрын гадрага | Нэгдсэн үнэлгээ | Соёл ахуйн үйлчилгээний хангамжийн үнэлгээ | Орон сууцны хангамжийн түвшин | Зам тээврийн байдал | Инженерийн хангамжийн түвшин | Нэгдсэн үнэлгээ | Ландшафтны шинж байдал  | Газар нутгийн зохион байгуулалт | Архитектур орон зайн төлөвлөлтийн байдал |                        | Нэгдсэн үнэлгээ |
| 1 | Арлын хэсэг  | 5                            | 4            | 3                             | 4            | 4                                     | 4              | 4               | 3  | 3                             | 2                   | 3                            | 3               | 4   | 4                               | 4  | 4                      |                 |
| 2 | Нефтийн  | 5                            | 5            | 3                             | 5            | 5                                     | 3              | 4               | 3  | 3                             | 4                   | 2                            | 3               | 4   | 4                               | 3  | 4                      | 5               |
| 3 | Төвийн хэсэг   | 5                            | 3            | 3                             | 3            | 4                                     | 4              | 4               | 3  | 3                             | 4                   | 3                            | 3               | 4   | 4                               | 4  | 5                      | 4               |
| 4 | Малтай гэр хорооллын хэсэг   | 5                            | 4            | 3                             | 5            | 5                                     | 2              | 4               | 1  | 1                             | 2                   | 4                            | 2               | 2   | 3                               | 2  | 2                      | 3               |
| 5 | Үйлдвэр аж ахуйн хэсэг   | 4                            | 4            | 3                             | 4            | 4                                     | 3              | 4               | 2  | 0                             | 3                   | 2                            | 2               | 3   | 2                               | 3  | 3                      | 3               |
| 6 | Хамгаалалтын бүс   | 4                            | 3            | 3                             | 4            | 4                                     | 4              | 4               | 3  | 0                             | 1                   | 0                            | 1               | 4   | 1                               | 2  | 2                      | 2               |
| 7 | Голуудын хөндий хэсэг  | 4                            | 3            | 3                             | 4            | 5                                     | 4              | 4               | 0  | 0                             | 1                   | 0                            | 0               | 5   | 1                               | 1  | 2                      | 2               |

### 5.3.2.3 Баруун бүсийн хөгжлийн төв Алтай хотын хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ

Орон нутгийн хөгжлийн хот Алтай хот нь байгаль экологийн хүчин зүйлс, Архитектур, орон зайн төлөвлөлт Ландшафтны хүчин зүйлийн үнэлгээгээр 3.44 гэсэн ерөнхий баллтай байгаа нь хот байгуулалтын бодлого хэрэгжүүлэхгүй байгааг харуулж байна. 2004 онд Инженер Геодези ХХК-ны боловсруулсан Алтай хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хэсэгчилсэн төлөвлөлт хийх, ерөнхий төлөвлөгөөнд заасан гудамж замын сүлжээг хэвээр нь хадгалж байх нь зүйтэй. Нийгэм эдийн засгийн хүчин зүйлсийн үнэлгээ 2.55 балл байгаа нь соёл үйлчилгээ, орон сууц, хотын зам тээвэр инженерийн хангамжийн түвшин доогуур байгааг гэрчилж байна. Алтай хотын ерөнхий төлөвлөгөөнд одоогоор өөрчлөх зүйлгүй бөгөөд төмөр замын буудлыг шинээр төлөвлөв.

Байгаль экологийн хүчин зүйлсийн үнэлгээ 3.22 балл, Архитектур, орон зайн төлөв Ландшафтны хүчин зүйлийн үнэлгээ 3.44 балл байгаа нь хот байгуулалтын үндсэн үзүүлэлтэнд хүрэхгүй байгааг анхдагч орчин үеийн жишиг хот болгох шаардлагатай.

#### Алтай хотын экологи-хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ /Хүснэгт 5.17/

|   | Судалгаа тооцооллын бүсүүд ( Говь-Алтай аймгийн Алтай хот 216133 га талбайд) ( 1-5 балл) | ҮЗҮҮЛЭЛТ                     |              |                               |              |                                       |                |                 |  |                               |                     |                              |   |                        |                                 |  |                        |                 |
|---|--|------------------------------|--------------|-------------------------------|--------------|---------------------------------------|----------------|-----------------|--|-------------------------------|---------------------|------------------------------|---|------------------------|---------------------------------|--|------------------------|-----------------|
|   |  | ХҮЧИН ЗҮЙЛИЙН ҮНЭЛГЭЭ        |              |                               |              |                                       |                |                 |  |                               |                     |                              |   |                        |                                 |  |                        |                 |
|   |  | Байгаль-Экологийн хүчин зүйл |              |                               |              |                                       |                |                 | Нийгэм эдийн засгийн хүчин зүй             |                               |                     |                              | Архитектур-Орон зайн төлөвлөлт Ландшафтын хүчин зүйлийн |                        |                                 |  | Ерөнхий дундаж үнэлгээ |                 |
|   |  | Инженер геологи              | Гидрогеологи | Газрын дотоод хүчний нөлөөлөл | Хөрс ургамал | Хүрээлэн буй байгаль экологийн байдал | Газрын гадрага | Нэгдсэн үнэлгээ | Соёл ахуйн үйлчилгээний хангамжийн үнэлгээ | Орон сууцны хангамжийн түвшин | Зам тээврийн байдал | Инженерийн хангамжийн түвшин | Нэгдсэн үнэлгээ   | Ландшафтны шинж байдал | Газар нутгийн зохион байгуулалт | Архитектур орон зайн төлөвлөлтийн байдал |                        | Нэгдсэн үнэлгээ |
| 1 | А-Бүс  | 3                            | 4            | 2                             | 4            | 4                                     | 2              | 3               | 2  | 2                             | 2                   | 2                            | 2   | 2                      | 2                               | 2  | 2                      | 2               |
| 2 | Б-Бүс  | 4                            | 3            | 2                             | 4            | 4                                     | 4              | 4               | 3  | 3                             | 3                   | 2                            | 3   | 4                      | 4                               | 3  | 4                      | 4               |
| 3 | В-Бүс  | 5                            | 3            | 2                             | 3            | 4                                     | 4              | 4               | 4  | 2                             | 3                   | 3                            | 4   | 4                      | 3                               | 4  | 4                      |                 |
| 4 | Г-Бүс  | 5                            | 3            | 2                             | 3            | 3                                     | 3              | 3               | 4  | 4                             | 3                   | 3                            | 4   | 4                      | 4                               | 5  | 4                      |                 |
| 5 | Д-Бүс  | 4                            | 2            | 2                             | 4            | 4                                     | 4              | 3               | 2  | 2                             | 1                   | 1                            | 2   | 5                      | 3                               | 2  | 3                      | 3               |
| 6 | Е-Бүс  | 4                            | 3            | 2                             | 4            | 3                                     | 4              | 3               | 4  | 1                             | 2                   | 1                            | 2   | 5                      | 3                               | 2  | 3                      | 3               |
| 7 | З-Бүс  | 3                            | 3            | 2                             | 4            | 2                                     | 4              | 3               | 2  | 1                             | 2                   | 2                            | 3   | 3                      | 3                               | 3  | 3                      |                 |
| 8 | Ж-Бүс  | 4                            | 3            | 2                             | 3            | 3                                     | 4              | 3               | 3  | 2                             | 2                   | 3                            | 3   | 5                      | 3                               | 3  | 4                      | 3               |
| 9 | И-Бүс  | 4                            | 3            | 2                             | 3            | 2                                     | 4              | 3               | 2  | 1                             | 1                   | 3                            | 2   | 5                      | 3                               | 2  | 3                      | 3               |

### 5.3.2.4 Баруун бүсийн хөгжлийн төв Улаангом хотын хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ

Орон нутгийн хөгжлийн хот Улаангом хот нь хот байгуулалтын иж бүрэн үнэлгээгээр 3.14 баллтай байгаа нь хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх явдал хангалтгүй байна. Улаангом хотын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг Инженер Геодези ХХК боловсруулсан боловч хэрэгжүүлэх талаар багаахан арга хэмжээ авчээ. Ерөнхий төлөвлөгөөний үндсэн тулгуур зарчмуудыг дур мэдэг өөрчилсөн байна. Улаангом хотыг хөгжүүлэхийн тулд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийх нь зүйтэй юм.

### 5.3.2.5 Баруун бүсийн хөгжлийн төв Өлгий хотын хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ

Орон нутгийн хөгжлийн хот Өлгий хот нь хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2000 онд Хот байгуулалтын Улсын үйлдвэрийн газарт хийсэн бөгөөд 2020 он хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Өлгий хот байгалийн хүчин зүйлсийн үнэлгээгээр тохиромжгүй, экологи Ландшафтны үнэлгээгээр тохиромжтой, дэд бүтэц, инженерийн хангамжийн үнэлгээгээр тохиромжтой байгаа юм.

Ховд хотын экологи-хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ /Хүснэгт 5.18/

| Судалгаа тооцооллын бүсүүд( Увс аймгийн Улаангом хот 260 мян га талбайд) (1-5 балл) | ҮЗҮҮЛЭЛТ                     |              |                               |              |                                       |                |                                 |  |                               |                     |                              |                 |   |                                 |  |                 |                        |   |
|---|------------------------------|--------------|-------------------------------|--------------|---------------------------------------|----------------|---------------------------------|--|-------------------------------|---------------------|------------------------------|-----------------|---|---------------------------------|--|-----------------|------------------------|---|
|   | ХҮЧИН ЗҮЙЛИЙН ҮНЭЛГЭЭ        |              |                               |              |                                       |                |                                 |  |                               |                     |                              |                 |   |                                 |  |                 |                        |   |
|   | Байгаль-Экологийн хүчин зүйл |              |                               |              |                                       |                | Нийгэм эдийн засгийн хүчин зүйл |  |                               |                     |                              |                 | Архитектур-орон зайн төлөвлөлт Ландшафтын хүчин зүйлийн үнэлгээ |                                 |  |                 | Ерөнхий дундаж үнэлгээ |   |
|   | Инженер геологи              | Гидрогеологи | Газрын дотоод хүчний нөлөөлөл | Хөрс ургамал | Хүрээлэн буй байгаль экологийн байдал | Газрын гадрага | Нэгдсэн үнэлгээ                 | Соёл ахуйн үйлчилгээний хангамжийн үнэлгээ | Орон сууцны хангамжийн түвшин | Зам тээврийн байдал | Инженерийн хангамжийн түвшин | Нэгдсэн үнэлгээ | Ландшафтны шинж байдал  | Газар нутгийн зохион байгуулалт | Архитектур орон зайн төлөвлөлтийн байдал | Нэгдсэн үнэлгээ |                        |   |
| 1   | А- Бүс                       | 4            | 5                             | 3            | 4                                     | 3              | 4                               | 4  | 4                             | 4                   | 4                            | 4               | 4   | 3                               | 4  | 4               | 4                      | 4 |
| 2   | Б- Бүс                       | 4            | 5                             | 3            | 4                                     | 4              | 4                               | 4  | 4                             | 3                   | 4                            | 4               | 4   | 3                               | 4  | 4               | 4                      | 4 |
| 3   | В- Бүс                       | 3            | 5                             | 3            | 3                                     | 4              | 3                               | 4  | 4                             | 4                   | 3                            | 4               | 4   | 3                               | 4  | 3               | 3                      | 4 |
| 4   | Г- Бүс                       | 3            | 5                             | 3            | 2                                     | 2              | 4                               | 3  | 3                             | 3                   | 4                            | 3               | 3   | 4                               | 2  | 3               | 3                      | 3 |
| 5   | Д- Бүс                       | 4            | 5                             | 3            | 2                                     | 4              | 4                               | 4  | 2                             | 2                   | 4                            | 1               | 2   | 4                               | 1  | 2               | 2                      | 3 |
| 6   | Е- Бүс                       | 3            | 5                             | 3            | 2                                     | 5              | 4                               | 4  | 2                             | 2                   | 2                            | 1               | 2   | 5                               | 2  | 2               | 3                      | 3 |
| 7   | Ё- Бүс                       | 3            | 5                             | 3            | 2                                     | 5              | 4                               | 4  | 3                             | 2                   | 2                            | 1               | 2   | 5                               | 3  | 2               | 3                      | 3 |

Баруун бүсийн зам харилцаа, хил худалдааны томоохон хот болох хандлагатай байгааг анхааран агуулах, худалдаа, үйлчилгээ, төмөр ба авто замын буудлуудыг шинээр төлөвлөх.

Баян-Өлгий аймгийн Өлгий хот, 580-га талбайд /Хүснэгт 5.19/

| №                               | Үнэлгээний үзүүлэлт                   | Хэмжих нэгж               | Үзүүлэлт              | Үнэлгээ                    |
|---------------------------------|---------------------------------------|---------------------------|-----------------------|----------------------------|
| Байгалийн хүчин зүйлийн үнэлгээ |                                       |                           |                       |                            |
| 1                               | Байршил, төвөөс алслагдсан байдал     | Км                        | УБ-аас 1636км         | Тохиромжгүй                |
| 2                               | Байгалийн уур амьсгал                 | Муж                       | 2-р бүс               | Тохиромжгүй                |
| 3                               | Далайн түвшнээс дээш өргөгдсөн байдал | М                         | 2000                  | Тохиромжгүй                |
| 4                               | Газар чичирхийлэл / давтамж/          | Балл                      | 8                     | Хязгаарлагдмал тохиромжтой |
| 5                               | Олон жилийн цэвдэг чулуулаг, хөрс     | Тархалт                   | Нөлөөгүй              | Тохиромжгүй                |
| 6                               | Ул хөрсний төрөл                      | Инженер геологийн дүгнэлт | Овойлтгүй давсжилтгүй | Тохиромжгүй                |
| 7                               | Хөрсний улирлын хөлдөлтийн гүн        | М                         | 3.2-4.5               | Тохиромжгүй                |

|   |                                       |                              |  |                            |
|---|---------------------------------------|------------------------------|--|----------------------------|
| 8                                       | Хөрсний усны түвшин                   | М                            | 2.2-5.5  | Хязгаарлагдмал тохиромжтой |
| 9                                       | Гадаргуугын налуу                     | %                            | 8-20   | Хязгаарлагдмал тохиромжтой |
| Экологи-Ландшафтын үнэлгээ              |                                       |                              |  |                            |
| 10                                      | Үерт автагдах байдал                  | Нөлөөлөлтэй эсэх             | Уруйн болон Ховд голын орчим                     | Хязгаарлагдмал тохиромжтой |
| 11                                      | Намаг,гуу жалга                       |                              | Нөлөөгүй   | Тохиромжтой                |
| 12                                      | Орчны тааламжтай                      | Био уур амьсгал              | Ховд голын хөндий                                | Тохиромжтой                |
| 13                                      | Хөрс                                  | Хөрсний бохирдол             | Голын ариун цэвэр хамгаалалтын бүс тогтоогдоогүй | Хязгаарлагдмал тохиромжтой |
| 14                                      | Ус                                    | Бохирдолын индекс            | 1-р зэрэг  | Тохиромжтой                |
| 15                                      | Агаар                                 | Цасны бохирдол түүний үечлэл | Маш цэвэр  | Тохиромжтой                |
| Дэд бүтэц,инженерийн хангамжийн үнэлгээ |                                       |                              |  |                            |
| 18                                      | Мянганы замын үйлчлэл                 | Км                           | Голын тэнхлэг байрласан                          | Тохиромжтой                |
| 19                                      | Бүсийн дэд бүтцийн тэнхлэгийн үйлчлэл | Км                           | 80 км хүртэл                                     | Тохиромжтой                |
| 20                                      | Усан хангамжийн эх                    | Гүний худаг л/сек            | 40 л/ сек  | Тохиромжтой                |
| 21                                      | Цахилгаан эрчим хүчний хангамж        | квт                          | 110  | Тохиромжтой                |
| 22                                      | Холбоожуулалт                         | -                            | Тоон системтэй                                   | Тохиромжтой                |
|   | Нэгдсэн үнэлгээ                       |                              |  | Хязгаарлагдмал тохиромжтой |

## ДҮГНЭЛТ

Баруун бүсийн нутаг дэвсгэрийн иж бүрэн үнэлгээг хийж дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд :

1. Дэлхийн цаг агаарын өөрчлөлттэй нягт холбоотойгоор байгаль экологийн хувьд доройтолд орж байгаагаас гадна механик үйлчлэлд өртөх бэлчээрийн даац хэтрэх зэрэг сөрөг нөлөө их байгаа учир нөхөн сэргээлт хийх, бутлаг ургамал тариалахаар төлөвлөв.
2. Засаг захиргааны нэгжийг цөөлж, удирдлагын тогтолцоог сайжруулахаар төлөвлөв.
3. Хүн амын суурьшил харьцангуй сийрэг, төвийн бүсийг зорьсон нүүдэл их байгааг харгалзан ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтцийг сайжруулах, Эрдэнэт, Дархан хоттой эн зэрэгцэхүйц Сутай хотыг байгуулах, жижиг дунд үйлдвэрлэлийг байгуулахаар төлөвлөв.
4. Дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх хувь ХАА-д 71.8 хувь байгааг харгалзан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 50-иас дээш хувиар өсгөх, хөрөнгө оруулалтын хэмжээг 10-22.5 хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөв.
5. Баруун бүс нутагт нэг суурин нэг бүтээгдэхүүн хөтөлбөрийг бүс нутгийн зөвлөл санаачлан хэрэгжүүлж байгаатай уялдуулан, аймгуудаас ирсэн санал, бусад санал дүгнэлтүүдийг энэ төсөлд тусгаж оруулан төлөвлөв.
6. Баруун бүс нутгийн хот суурингуудын газар хөдлөлийн бичил мужлалын зураглалыг хийж, оршин байгаа газар орны газар чичирхийллийн баллыг нарийвчлан тогтоож, аюулгүй тайван, ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх, газар хөдлөлийн баллд тохирсон барилга байгууламжийн хийц, бүтээцийг сонгох, цаашид шинээр барих барилга байгууламжуудад нэг бүрчлэн газар чичирхийллийн хэмжээг тогтоож байх асуудал чухал болж байна.

Үнэлгээ хийсэн дүгнэлтээс үзэхэд баруун бүс нутагт энэ төслийн дагуу төрийн оролцоотойгоор зохицуулан, зохион байгуулж тууштай үйл ажиллагаа явуулах шаардлагатай байна. Энэ төслийг үндэслэн мэргэжлийн яамууд баруун бүс нутагт авч явуулах арга хэмжээнүүдийг боловсруулах нь зүйтэй.

**ХЭСЭГ III**

**БАРУУН БҮСИЙН НИЙГЭМ  
ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВЛӨЛТ**



## ОРШИЛ

Баруун бүсийн хөгжлийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Бүсүүдийн тулгуур төв хотыг тогтоох тухай, Монгол улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги, Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр, баруун бүсийн зөвлөлөөс гаргасан “Нэг суурин, Нэг бүтээгдэхүүн” товхимол, Баруун бүсийн хөгжлийн төсөл боловсруулах ажлын даалгавар, аймаг, орон нутгийн албад, яам, агентлагууд болон эрдэмтэн мэргэжилтнүүдийн саналыг үндэслэл болгон гүйцэтгэсэн юм.

*Баруун бүсийн хөгжлийн төсөл* нь Монгол Улсын Бүсчилсэн Хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх зорилгоор төлөвлөн төсөөлж, зах зээлийн харилцааг тогтворжуулах, бүтээн байгуулалтыг өрнүүлэх зорилготой хийгдсэн томоохон төсөл юм.

Монгол Улсын Бүсчилсэн Хөгжлийн үзэл баримтлалыг амьдралд хэрэгжүүлэхэд Монгол улсын төр засаг, бүсийн зөвлөл, аймаг, орон нутгийн удирдлага, хувийн хэвшлийн байгууллагууд чиг баримжаа авч, хэрэгжүүлэх үйл ажиллагааныхаа мөрийн хөтөлбөр бодлого зорилтыг тодорхойлоход ашиглахуйц тулгуур баримт бичиг юм.

Баруун бүс нутгийг хөгжүүлэх боломжит хувилбаруудыг судлан, олон талын харьцуулсан судалгаа, дүгнэлт гаргаж, статистик динамикийн төлөвлөлтийн цоо шинэ арга зүйд тулгуурлан хийсэн анхны төлөвлөлт юм.

Төслийн хүрээнд бүс нутгийн амьдралын бүхий л салбарыг байгаль орчинд ээлтэй байдлаар төлөвлөв.

Бүс нутгийн дотоод, гадаад харилцаа түүний хүчин зүйлүүдтэй уялдуулан, гааль, худалдааны чөлөөт бүсийн хөгжлийг төлөвлөхөөс гадна улс, бүсийн түвшинд нийгэм, эдийн засгийн хөгжлийг тэнцвэржүүлэх зорилготой, аж үйлдвэр металлургын “Сутай” хотыг шинээр байгуулахаар төлөвлөсөн. Мөн улс, бүс нутагт хамгийн үр ашигтай байхаар ашигт малтмалын баяжмал, эрдэс бүтээгдэхүүн тээвэрлэх төмөр замын хувилбаруудыг төлөвлөв.

Монгол улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг 1999 онд боловсруулах үед нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2020 онд 16500 орчим америк доллар болохоор тооцоолж байсан нь хөгжингүй орнуудын түвшинд арай хүрэхгүй байна гэж төлөвлөж байлаа. Гэтэл бидний симуляцын загварыг /Computable General Equilibrium/ ашиглан төлөвлөж байгаагаар *дотоодын нийт бүтээгдэхүүн 7000 америк доллараас хэтрэхгүй байгаа нь үндэсний суурь эдийн засаг яваандаа хүндэрч байгааг гэрчилж байна.* Энэ нь жил бүр өсөн нэмэгдэж байгаа инфляцын түвшинд ойртон очих болно.

*Баруун бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн түвшин бусад бүсүүдээс 1.3-2.4 дахин бага байна. Баруун бүсийн ХАА-н салбар 2007 оны байдлаар 71.8 хувь, аж үйлдвэрийн салбар 5.4 хувь, үйлчилгээний салбар 22.8 хувийг тус тус эзлэж байна.*

Баруун бүс нутаг мал аж ахуй, газар тариаланд өгөөжгүй экосистемээр хүрээлэгдсэн байгаа төдийгүй хүн оршин амьдрах нөхцөл ч хомсдож байгаа юм.

Бүс нутагт мал аж ахуй эрхлэгч малчин айл өрхүүд малын түүхий эдээ голлон дотоод, гадаад бараа солилцооны хэлбэрээр арилжаалж байгаа нь бусад орнуудын хөгжлийн түвшнээс ихээхэн хоцрогдож байгааг гэрчилж байна.

*Баруун бүсийн хөгжлийн түвшний индекс 0.177 буюу бүсүүдийн дундаж түвшнээс 1.37 хувиар доогуур байгаа нь бүс нутгийн хөдөлмөрийн насны хүн амын дийлэнх нь ажил эрхлэлтгүй, ажилгүйдэл дагасан ядуурал ихэссэнтэй холбоотой юм.* Иймд тус бүсэд ажлын байрыг нэмэгдүүлэх, хүн амын амжиргааны түвшинг дээшлүүлэх бодитой хэрэгжихүйц бодлого зохицуулалт чухал. Ялангуяа уул уурхай эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, хөнгөн үйлдвэрлэлийн салбаруудыг хөгжүүлснээр хүн амын эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх боломжтой.

Монгол орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг тэнцвэржүүлэх оновчтой хувилбарыг сонгох, хөрөнгө оруулагч нарыг татах, ирээдүйд өгөөжөө өгч улс оронд жинтэй хувь нэмэр оруулах бүлэг орд газрын хайгуулыг сонирхогч талуудаар хийлгэж нөөцийг баталгаажуулах нь чухал болж байна.

Одоогоор ашигт малтмалын үнэ ханш огцом буурч байгаа ч төмөр, зэс, нүүрс зэрэг стратегийн ач холбогдолтой эрдэс огт ашиглагдахгүй мэтээр ойлгож болохгүй. Металл хийцтэй техник технологийн эрэлт хэрэгцээ улам бүр өсч байгааг анхаарах хэрэгтэй.

## Зургаа. БАРУУН БҮСИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

### 6.1 БҮСИЙН ТОГТОЛЦОО, УЛС, БҮСИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ

#### 6.1.1. Бүс нутгийн тогтолцоо, хөрш орнуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэх ирээдүй

УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги, хөтөлбөрүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх эрх зүй, эдийн засгийн үндсийг бүрдүүлэх талаар төрөөс явуулж байгаа бодлогын нэг гол чиглэл нь эдийн засгийн Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсээр дамжуулан тус улсын эдийн засгийг хөрш орнуудтай болон бүс нутгийн орнуудтай хоршин хөгжүүлж, гадаад хамтын ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэхэд оршиж байна. Энэхүү стратеги УИХ-аас 2008 онд баталсан Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого /2021 он/-д тусгагдсан болно.

Эдийн засгийн бүсүүдээр дамжуулан гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх стратегийг дэвшүүлэхдээ, хүн амын нутагшилт, нутаг дэвсгэрийн багтаамж, байгаль орчны даац чадавхид зохицуулан бүс нутаг бүрийн давуу талыг бүрэн ашиглаж, гадаад зах зээлд сайн чанарын бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлж, нэмүү ашиг орлого олох замаар нийт улс орны эдийн засгийн өсөлт, нийгмийн дэвшлийг түргэтгэх зорилго тавьж байгаа юм. Энэ зорилгод хүрэхийн тулд, улс орны тээвэр – газарзүйн байрлалын дагуу бүс нутгуудын нөөц, чадавхийг гадаад зах зээлийн эрэлт, хэрэгцээтэй зүй зохистой холбон, тэдгээрийн эдийн засаг, нийгмийн харилцан уялдсан, цогц хөгжлийг хангахад чиглэсэн бүсчлэл-хот байгуулалт-дэд бүтцийн нэгдсэн сүлжээг бүрдүүлэхээр төлөвлөв.

Ингэснээр, улсын хэмжээнд, дэлхийн зах зээлтэй холбогдсон бүс нутаг, хот, хөдөөгийн харилцан уялдсан нэгдсэн тогтолцоо, бүсүүдийн хэмжээнд, хөрш орнуудын хил зэргэлдээ нутгуудтай аж ахуй, соёлын талаар хоршсон хот, хөдөөгийн харьцангуй бие даасан тогтолцоо бүрдэж, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тодорхойлсон экспортыг баримжаалсан улс орны нэгдмэл хөгжлийн үндэс тавигдах болно гэж төсөөлж байна.

Бүсчлэлээр дамжин эдийн засаг, нийгэм, соёлын хамтын ажиллагааг өргөжүүлэх бодлого нь өөрөө бүс нутаг бүрийн гадаад зах зээлд оролцох байгаль түүхий эдийн нөөц, оюуны чадавхи, дэд бүтцийн босоо, хэвтээ чиглэлийн тэнхлэгүүд, тэдгээрт таталцсан хөгжлийн төвүүдэд тулгуурлан явагдах учир бүсийн тогтолцоонд эдгээрийг хамруулан авч үзэх нь зүйтэй байна.

Монгол Улсын хөгжлийн баримт бичгүүдэд үндэслэн, Баруун бүсээр дамжин гадаад зах зээлд оролцох оролцоог өргөжүүлэх бүсүүдийн тогтолцоог дараах 3 түвшнээр иж бүрэн тогтоож, эдийн засгийг зохицуулах шаардлагатай байна. Үүнд :

1. Улс – бүсийн хэмжээнд:

- Ховд, Баян-Өлгий, Увсын бүс
- Завхан, Говь-Алтайн бүс

2. Аймгийн түвшинд:

- Баян-Өлгийн бүс
  - Ховдын бүс
  - Увсын бүс
  - Завханы бүс
  - Говь-Алтайн бүс

3. Сум дунд /бичил бүсүүд/-ын түвшинд:

- Ховд аймагт:
  - Ховд хотод таталцсан бүс
  - Манханы бүс
  - Мөстийн бүс
  - Булганы бүс
- Увс аймагт:
  - Улаангом хотод таталцсан бүс
  - Өмнөговийн бүс
  - Зүүнговийн бүс
  - Баруунтурууны бүс
- Сагилын бүс
- Наранбулагийн бүс
- Баян-Өлгий аймагт:

- Өлгий хотод таталцсан бүс
- Дэлүүний бүс
- Алтанцөгцийн бүс
- Буянтын бүс
- Цагааннуурын бүс
  
- Завхан аймагт:
  - Улиастай хотод таталцсан бүс
  - Шилүүстэйн бүс
  - Завханмандалын бүс
  - Тэсийн бүс
  - Түдэвтэйн бүс
  - Тосонцэнгэлийн бүс
  
- Говь-Алтай аймагт:
  - Алтай хотод таталцсан бүс
  - Тонхилын бүс
  - Баян-Уулын бүс
  - Бигэрийн бүс
  - Алтайн бүс
  - Төгрөгийн бүс

Эдгээр бүсээр хот, хөдөөг хооронд нь болон гадаад зах зээлтэй холбох бүс нутгийн хөгжлийн төв буюу таталцлын цөмүүдийг Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр /Засгийн газрын 2005 оны 202 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт/-т зааснаар төсөлд тусгалаа.

Баруун бүсийг хөрш болон бүс нутгийн орнуудтай дэд бүтцийн босоо хэвтээ тэнхлэгээр холбож, хүн ам, үйлдвэрлэл төвлөрөх хөгжлийн гол тулгуур төвүүд нь Ховд, Улиастай, Сутай хот байх болно. Энэ хоёр тулгуур төв болон хил гаалийн боомтуудад орон нутгийн бусад хот чөлөөт бүсийн төвүүд /Цагааннуур, Булганы/, хөдөө /сум дундын төвүүд/-гийн сууринг дэд бүтцийн шаардлагатай сүлжээгээр холбох замаар тэдгээрийг бүхэлд нь гадаад зах зээлд гарах боломжийг бүрдүүлэхээр төсөөлж байна.

Бүс нутгуудын хамтын ажиллагааны олон талт байдал, өрсөлдөөнийг хангах үүднээс дээр дурдсан бүсүүдийг тус тусын зорилго, чиглэлтэй байхаар тогтоож, ашиглах нь зүйтэй байна. Тухайлбал, Ховд – Баян-Өлгий – Увс болон Завхан – Говь-Алтайн бүсийг “Мянганы зам” төсөлд тодорхойлсон Боршоо боомтоос Улаангом – Ховд – Ярантайн боомт, Ханхын боомтоос Мөрөн – Улиастай – Алтай – Бургастайн боомт хүртэлх дэд бүтцийн хоёр босоо тэнхлэгт ойр зэргэлдээх аймаг, сумдыг таталцуулж, улс хоорондын үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлтийн зах зээлийг буй болгох чиг үүрэгтэй улс хоорондын “эдийн засаг, худалдааны бүс”-ийн шинж байдлаар ашиглана.

Ингэснээр Баруун бүсийн аймгуудын алслагдсан газар зүйн байрлалын онцлогийг харгалзан хөгжлийн дотоод, гадаад тэнцвэрийг хангахад чухал ач холбогдолтой болох юм. Аймгуудын бүсийг тэдгээрийн түүх, нийгэм – соёлын уламжлалт байдлыг нь хөгжлийн бүс нутгууд тодрон гарах хүртэл нэг хэсэгтээ хадгалж, эдийн засаг – худалдааны дээрх хоёр бүсээр дамжин хөрш орнуудын зах зээлд харьцангуй бие даан оролцох, орон нутгийн удирдлага, төсөв санхүүгийн зохицуулалтын нэгдмэл байдлыг хангах үүрэгтэй засаг захиргаа – эдийн засгийн бүсүүд байхаар зохион байгуулах нь зүйтэй байна. Тэгвэл, сум дунд /бичил/-ын бүсүүдийг гадаад зах зээлд оролцох бүс нутгийн нөөц, боломжийг нэмэгдүүлэхийн хамт хөдөөгийн хүн амд засаг захиргаа, эрүүл мэнд, соёл боловсролын орчин үеийн мэргэжлийн үйлчилгээг цаг тухайд нь чанартай, хүртээмжтэй хүргэх менежментийг сайжруулж, орон нутгийн нийгмийн цогц байдал, хамтын ажиллагааг хангах үүрэгтэй хөгжлийн бүс нутгууд бий болгоход ашиглаж болох байна.

Аймаг, сум дунд /бичил/-ын бүсүүд нь бүс нутаг бүрийн онцлог, давуу талд түшиглэн хот, хөдөөгийн нэгдмэл байдал, тэдгээрийн дотоод, гадаад зах зээлд оролцох хөгжлийн олон талт байдал, төрөлжилтийг бий болгоход тусална гэж төсөөлж байна. Олон улсын хэллэгээр макро-, мезо-, микро бүсчлэл гэж нэрлэгддэг бүсчлэлийн эдгээр сүлжээг эдийн засгийн нутаг дэвсгэрээр зохицуулах үйл ажиллагаанд зориулалтаар нь уялдаатай ашигласнаар аж ахуйн хувьд бие даан хөгжих чадвартай бүс нутгуудын тогтолцоо бүрдэх болно. Баруун бүс дэх байгаль түүхий эдийн нөөцийг гадаад зах зээлд хоршин ашиглах, атомын эрчим хүчний станц байгуулах боломжийг төсөөлж үзэхэд хэрэгжүүлэх боломжтой юм.

Баруун бүсэд эдийн засгийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх ирээдүйн гол талбар болох үндэстэй тэдгээр бүс нутагт улсын эдийн засгийн бодлого, хөрөнгө, санхүүгийн дэмжлэгийг түлхүү чиглүүлэх нь зүйтэй гэж үзэж байна

### 6.1.2. Улс хоорондын дэд бүтцийн сүлжээ худалдааны хөгжил

Энэхүү төсөлд, улс хоорондын дэд бүтцийн сүлжээ бүрдүүлэх явцыг Баруун бүс нутгийн хөгжлийг түргэтгэх гол арга зам гэж үзсэн болно. Үүнтэй уялдан, 2015 он хүртэлх хугацаанд дор дурдсан 5 үндсэн зорилт тавьж, шийдвэрлэх шаардлагатай байна. Үүнд:

- 1./ Баруун бүсэд тавих Мянганы замын босоо тэнхлэгийн хатуу хучилттай замыг хурдавчлан байгуулж, улмаар Азийн авто замтай холбох үндсийг бүрдүүлэх
- 2./ Баруун бүсийн мэдээлэл холбоо, цахилгааны эрчим хүчний сүлжээг хөрш болон бүс нутгийн орнуудтай холбон үйлчлэх хүрээг өргөжүүлэх, атомын цахилгаан станц байгуулах
- 3./ Улс хооронд агаарын болон төмөр замын тээвэрт Баруун бүс нутгийн оролцоог өргөжүүлэх эрх зүй, техник – эдийн засгийн үндсийг тавих
- 4./ Монголын бусад бүс нутаг /Хангайн бүс/, хөрш орнуудтай хоршсон аялал жуулчлалын сүлжээг хөгжүүлэх
- 5./ Ойрын ирээдүйд бүрэлдэх дэд бүтцийн нэгдсэн тогтолцоог улс хоорондын “худалдаа-тээврийн хөгжлийн коридор” болгон хөгжүүлэх зэрэг болно.

УИХ-аас 2001 онд баталсан “Мянганы зам” төсөл, Засгийн газрын “Авто замын ерөнхий төлөвлөгөө”-нд Баруун бүс нутагт тавих хэвтээ, босоо тэнхлэгийн хатуу хучилттай замыг 2021 он хүртэл байгуулж дуусгахаар төлөвлөжээ. Гэвч тус улсын болон дэлхийн зах зээлийн гол төвүүдээс алслагдсан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшнээр ихээхэн хоцронгуй байгаа Монголын Баруун бүс нутгийн тухайд, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг төвлөрүүлэх зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны найдвартай дэд бүтцийг бүрдүүлэх явдал тулгамдсан хэрэгцээ болж байна. Энэ байдлыг харгалзан тус төсөлд, Баруун бүс нутагт тавихаар “Мянганы зам”-ын төсөлд тодорхойлсон Боршоо /ОХУ-тай хил залгаа боомт/ - Улаангом – Ховд – Манхан – Ярантай; Ханх – Мөрөн – Улиастай – Алтай – Бургастайн боомт гэсэн хоёр чиглэлийн босоо тэнхлэгийн хатуу хучилттай авто замын үндсэн трассыг 2015 он гэхэд барьж дуусгах зорилтыг дэвшүүлж байгаа юм.

Харин Баруун бүсийн хөндлөн тэнхлэгийн хатуу хучилттай авто замыг дээрх төсөл, ерөнхий төлөвлөгөөнд заасны дагуу 2021 он хүртэлх төлөвлөсөн хугацаанд нь барьж болох байна. Аймаг, орон нутгийн улсын чанартай авто замуудыг Мянганы замын босоо болон хөндлөн тэнхлэгийн замтай холбох ажлыг улсын хөрөнгө санхүүгийн боломж, энэ түрүүнд хэрэгжүүлэх бүс нутгийн хөгжлийн төсөлтэй холбож эрэмбэ дараатай шийдвэрлэх нь зүйтэй байна. Баруун бүс нутгийн босоо тэнхлэгийн 2 чиглэлийн хатуу хучилттай авто замыг 2015 он гэхэд хурдавчлан барьж байгуулан үндсэнд нь дуусгах шаардлагатай гэсэн зорилтыг тус төсөлд дэвшүүлж байна. Үүнд, Боршоо – Улаангом – Ховд – Ярантайн чиглэлийн нийт 781.8 км хатуу хучилттай хар замын 431.2 км буюу 55.2 %-ийг нь 2007 – 2010 онд, үлдсэн 350.6 км/Улаангом-Боршоогийн чиглэл/-ыг нь 2011 – 2013 онд тус тус тавихаар, Ханх – Мөрөн – Улиастай – Алтай – Бургастайн чиглэлийн нийт 1206.3 км замын 695.5 км буюу 57.6 %-ийг нь 2008 – 2011 онд, үлдсэн 510.8 км замыг нь 2012 – 2015 онд барьж байгуулахаар Авто замын төлөвлөгөөний төсөлд өөрчлөлт оруулан батлуулах саналтай байна.

Нэг км хатуу хучилттай зам тавихад дундажаар 160.0 мян.ам доллар шаардлагатай /Газрын баримжаанаас хамаарч өөрчлөгдөнө/ гэж тооцвол, Баруун бүсийн босоо тэнхлэгийн хар замуудыг барьж байгуулахад, 2009 – 2011 онд, нийт 180.2 сая ам. доллар, 2012 – 2015 онд нийт 137.8 сая.ам долларын хөрөнгө оруулалтын хэрэгцээ гарч байгаа юм.

Энэхүү хэрэгцээг хангах санхүүжилтийн дараах боломж бүрдэнэ гэж үзэж байна. Үүнд:

- 2015 онд хүртэл, стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордыг олборлох ажлыг түргэтгэснээр улсын төсөв жил бүр +10 хувиар нэмэгдэх магадлал
- Монгол Улсыг хөгжүүлэх санг нэмэгдэх эх үүсвэрийг хуваарилах асуудлыг цаашид “Бүсийн хөгжлийг дэмжих сан”-тай холбон зохицуулах боломж
- Баруун бүсийн нэг дэх босоо тэнхлэгийн зам /Боршоо – Улаангом – Ховд - Ярантай/-ыг барьж байгуулах ажлыг АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж эхэлсэн байна,
- Баруун бүсэд хоёр дах чиглэлийн босоо тэнхлэгийн хар замыг санхүүжүүлэх асуудлыг Төв Азийн орнуудын бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр /"CAREC"/-т нэгдсэн дэлхийн санхүүгийн томоохон байгууллагуудын уулзалтад тавьж, дээрхийн адил хөнгөлөлттэй зээл авахаар шийдвэрлэх боломж
- Монгол Улс нь Ази, Номхон далайн бүсийн тээврийн гол гол конвенцид нэгдэн орсон бөгөөд хоёр ба олон талын авто тээврийн хэлэлцээр байгуулсан нь хөрш болон бүс нутгийн орнуудтай хөрөнгө санхүүгийн дэмжлэг авах бололцоо олгож байгаа зэрэг болно.
- Шивээ хүрэн-Баянхонгор-Улиастай-Арцсуурийн чиглэлийн замыг байгуулах нь худалдаа, эдийн засгийн харилцааг нэмэгдүүлэх үндэс болно.

Монгол Улс Баруун бүс нутгийнхаа хөгжлийг эрчимжүүлэх санал, санаачлагаа тууштай үргэлжлүүлж, хөрөнгө санхүүгийн боломжийг дээр дурдсанаар бүрдүүлж чадвал, 2015 он гэхэд Баруун бүсээр дамжуулан Монголын нутаг дэвсгэрийг хөрш хоёр орон, мөн Казакстан, Дундад болон Төв Азийн бусад оронтой одоогийнхоос илүү баталгаатай, дөт замаар холбож, улс хоорондын худалдаа, тээвэрлэлтийн харилцан үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар дээрх орнуудын сонирхлыг төрүүлэхэд түлхэц үзүүлэх болно. Энэ дэвсгэр дээр Монгол Улс Баруун бүс нутгаа хөрш орнууд, улмаар Азийн замтай холбох боломжийг одооноос эхлэн эрэлхийлэх хэрэгтэй байна. Ингэхдээ, Азийн болон олон улсын замын сүлжээнд холбогдох нөхцөл байдал, боломж, замын ашиглалтын зардал, үр ашиг, нийгэм, экологийн болзошгүй үр дагавар, гарч болзошгүй эрсдэл зэргийг сайтар тооцох нь зүйтэй байна.

Монгол Улсын Засгийн газар нь олон улсын авто замын сүлжээнд АН-3, АН-4, АН-32 гэсэн гурван үндсэн чиглэлээр “Азийн авто замын сүлжээ /ААЗС/”-нд холбогдож байгаагаас АН-32 нь Засгийн газраас тодорхойлсноор Мянганы замын хэсэг юм. АН-3, АН-4-ийг “босоо тэнхлэгийн авто зам”, АН-32-ыг “хэвтээ тэнхлэгийн авто зам” гэж нэрлэсэн байдаг. Баруун бүсийн тухайд, АЗ-4, АЗ-32 замын хэсгүүд Мянганы замын босоо, хөндлөн чиглэлтэй давхцаж байгаа болно. АЗ-3, АЗ-4 замаас гадна хойноос урагшаа олон улсын хилийн боомтыг холбосон 5 босоо чиглэлийн замууд /үүнээс 2 нь Баруун бүсэд буй ба АЗ-3, АЗ-4-тэй давхцаж байгаа/-ыг Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх гол зам гэж тодорхойлсон. 2000 оноос эхлэн Засгийн газар үндсэн замын сүлжээг хөгжүүлэхдээ Монгол орныг баруунаас зүүн чиглэлд холбох, аймгийн төвүүдийг гол тэнхлэгтэй холбож, бүс нутгийн хөгжлийн тэнцвэргүй байдлыг арилгах бодлого барьж байна. Азийн замын сүлжээг тодорхойлохдоо, дэлхийн нийтлэг зарчмаар аль болох ногоон бүсийг хөндөлгүйгээр одоо байгаа замын маршрут, чиглэлийг сонгосон. Энэ зарчим нь Азийн замын сүлжээг газар ашиглалт болон нүүлгэн шилжүүлэх зардлыг аль болох бага байлгаж, замуудыг бага зардлаар барих бодлоготой холбоотой юм.

Азийн зам, Мянганы замын аль аль нь тэнцвэртэй хөгжлийг хангах зорилгод чиглэсэн байна. Мянганы замын сүлжээгээр Баруун бүсийн аймгуудыг хооронд нь болон нийслэл Улаанбаатар хоттой холбож, хүн ам авто замаар аюул багатай, саадгүй зорих нөхцлийг хангах зорилт тавьж байна. Мянганы замын сүлжээ нь аймаг, бүсийн хооронд зорчих, хөрш зэргэлдээ орны далайн боомтоор дамжин олон улсын /Хятад, ОХУ/ зах зээлд хүрэх гарцыг бий болгох ач холбогдолтой. “Үндсэн” замын сүлжээг Азийн замын стандартад нийцүүлэн 2 урсгалтай 7м/10 м-ийн өргөнтэй, асфальтан хучилттай 3-р ангиллын замаар барихаар тооцож байна.

Баруун бүсийг ААЗ-ын сүлжээнд холбосноор дараах таатай боломж, нөхцөл бүрдэнэ гэж төсөөлж байна. Үүнд:

- Баруун бүс нутаг дахь мөнгө, гянт болд, давс, нүүрс зэрэг байгалийн баялаг, мал аж ахуйн түүхий эдийн их нөөцийг боловсруулах үйлдвэрлэл хөгжиж, бүтээгдэхүүнээ хөрш болон бүс нутгийн орнуудын том зах зээлд үр ашигтай борлуулах, тэдгээр орноос өргөн хэрэглээний бараа, техник, тоног төхөөрөмжийг харьцангуй хямд үнээр авч, аймаг, орон нутгийн хэрэгцээг бага зардлаар хангах,
- БНХАУ, ОХУ-ын хооронд Казакстан улсын нутгаар дамжин хийгдэж буй их хэмжээний ачаа урсгалыг Монгол руу чиглүүлж, улсын эдийн засаг, худалдааны ашиг орлогыг нэмэгдүүлэх,
- Аймаг, орон нутгийг хооронд нь болон улс хоорондын босоо, хэвтээ тэнхлэгийн магистраль замтай холбон, хот, тосгон бүрт гадаад зах зээлд оролцох боломж нээгдэх, улмаар хөдөөгийн нийгэм, соёлын цаашдын дэвшлийг хангах,
- Улс хоорондын ач холбогдол бүхий тээвэр – худалдааны хоёр гарцтай болсноор олон улсын зах зээлийн жишиг үнэ, тээврийн гэрээ, хэлэлцээр, сайн хөршийн түншлэлийн зарчмыг үндэслэсэн нэгдмэл бодлого, дүрмээр худалдаа, тээвэрлэлтийг явуулах, бүтээгдэхүүний үнэ өртгийг дээшлүүлж өрсөлдүүлэх арга туршлага нэвтэрч, хэрэгжүүлэх хөшүүрэг бий болох юм.

Азийн авто замд холбогдох бодлогоо тодорхойлохдоо юуны түрүүнд, Төв Азийн орнуудын бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр /“CAREC”/-т нэгдсэн орнууд “бүх гишүүн улсуудад ашиг хүртээх бүсийн дэд бүтцийн нэгдсэн сүлжээг бүрдүүлэх”, гишүүн орнууд худалдаа, хөрөнгө оруулалт, бизнесийн чадавхиа хөгжүүлэх арга туршлагаа солилцох, хилээр орж гарах бараа, ажил үйлчилгээний урсгалыг чөлөөлж, сүлжээг сайжруулах замаар “Бүсийн бараа”-г хөгжүүлэхээр тохиролцсоныг үндэс болгох шаардлагатай байна.

Баруун бүсийн босоо, хөндлөн тэнхлэгийн хатуу хучилттай авто замуудыг тавих үндсэн маршрут нь Азийн авто замын чиглэлтэй давхцаж байгаа нь бодлогын уялдааг хангах, зам байгуулах, ашиглах үеийн өртөг, зардлыг Монголын талаас хариуцах чадварыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Баруун бүсэд тавигдах Азийн зам, Мянганы замын чиглэлийн харьцуулалт /Хүснэгт 6.1/

| № | Замын нэр                  |                      | А3-32 замын хэсгүүдийн урт /км/ | М3-ын хэсгүүдийн урт /км/ | 2 замд аль алинд давхцаж байгаа хэсгүүд | Санал болгож байгаа эсэх |
|---|----------------------------|----------------------|---------------------------------|---------------------------|---|--------------------------|
|   | Хаанаас                    | Хаашаа               |                                 |                           |   |                          |
| 1 | Улаан байшинт /Оросын хил/ | Өлгий                | 104.0                           | 104.0                     | В                                       | Тийм                     |
| 2 | Өлгий                      | Ховд                 | 224.0                           | 224.0                     | В                                       | Тийм                     |
| 3 | Ховд                       | Сар хайрхан гүүр     | 181.0                           | 181.0                     | В                                       | Тийм                     |
| 4 | Сар хайрхан гүүр /Завхан/  | Цахирын даваа хүртэл | 207.0                           | 207.0                     | В                                       | Тийм                     |

Баруун бүсийн босоо тэнхлэгийн 1 дэх замын “Мянганы зам” төсөлд тусгасан “Боршоо – Улаангом” гэсэн чиглэл нь Азийн замын сүлжээ /А-4/-нд болон “CAREC”-ийн хөтөлбөрт /4А/ “Цагааннуур – Өлгий” гэсэн маршрутаар төлөвлөгдөж, энэ хувилбараар АХБ-ны зээлээр зам байгуулах техник – эдийн засгийн үндэслэл боловсрогдсон байна.

АН-4/ CAREC (4A) болон АН-3/ CAREC (4B) олон улсын замууд /Хүснэгт 6.2 /

| №  | Чиглэлийн нэр                                 | Урт /км/ | Төлөвлөгөөнд тусгагдсан байдал  | Тайлбар                               |
|--|---|----------|---|---------------------------------------|
| АН4/ CAREC (4a) замууд нь Баруун бүсийг хамарч байгаа бөгөөд нийт урт 748.4 км |   |          |   |                                       |
| 1  | Цагааннуур (ОХУ-тай хил залгаа боомт) – Өлгий | 102.75   | 30 км хатуу хучилттай зам, төслийн төлөвлөгөөгөөр бүхэлд нь хучилт хийх /2012 - 2015/       | МУЗГ болон АХБ хоорондын санамж бичиг |
| 2  | Өлгий – Ховд                                  | 214.4    | Зөвхөн хөрсөн болон хайрган зам, төслийн төлөвлөгөөгөөр бүхэлд нь хучилт хийх /2010 - 2012/ | МУЗГ болон АХБ хоорондын санамж бичиг |
| 3  | Ховд – Манхан                                 | 90.9     | Төслийн төлөвлөгөөгөөр бүхэлд нь хучилт хийх /2009 - 2012/                                  | МУЗГ болон АХБ хоорондын санамж бичиг |
| 4  | Манхан - Ярантай                              | 340.3    | 64 км нь хатуу хучилттай, төслийн төлөвлөгөөгөөр бүхэлд нь хучилт хийх /2009 - 2012/        | МУЗГ болон АХБ хоорондын санамж бичиг |

Баруун бүс нутгийг байнгын ажиллагаатай Боршоо, Хандгайт /Увс/-ын боомтоор ОХУ-ын зах зээлтэй улам өргөн хүрээнд холбож, хоёр талын уламжлалт харилцааны найдвартай, аюулгүй байдлыг хангах, мөн тус улсын дотоод бүс нутгуудын аж ахуй, соёлын хэлхээ холбоог нягтруулах үүднээс цаашид энэ замыг Улаангом – Боршоогийн чиглэлд үргэлжлүүлэн тавих шаардлагатайг зөвлөмж болгож байна.

Монголын Авто замын ерөнхий төлөвлөгөөний төслийн талаар Дэлхийн банкнаас хийсэн эдийн засаг, зам байгуулалтын хамаарлын хүчин зүйлийн шинжилгээнээс үзэхэд, Баруун бүсийн босоо чиглэлийн хатуу хучилттай авто замуудыг хурдавчлан байгуулж Азийн замд холбосноор энэ бүс нутгийн зах зээлийн багтаамж дээшилж, зам байгуулалтаас эдийн засаг, нийгмийн хөгжилд ирэх үр өгөөжийг богино хугацаанд нэмэгдүүлэх боломжтой байна.

Тухайлбал, 1 км хатуу хучилттай зам барих тутамд 546524627.1 төгрөг буюу 461202.217 доллараар, 1 км сайжруулсан зам тутамд 750096238.8 төгрөг буюу 632992.606 доллараар ДНБ нэмэгдэж байгаа нь хатуу хучилттай замын хувьд 1 км тутам 240375.5 доллар, сайжруулсан замын хувьд 1 км тутамд 237684.5 долларын эдийн засгийн өгөөжтэй байх тооцоо гарсан байна.

Баруун бүсийн жишээгээр харуулбал :

Эдийн засгийн өгөөж,  
Зам 1 км нэмэгдэх тутам /Хүснэгт 6.3/

Ядуурлын бууралтын өгөөж,  
Зам 1 км нэмэгдэх тутам /Хүснэгт 6.4/

| Бүсүүд | Хатуу хучилттай зам | Сайжруулсан зам |
|--------|---------------------|-----------------|
|        | Доллар – 1 километр |                 |
| Баруун | 175386.29           | 173435.84       |

|                  |          |          |
|------------------|----------|----------|
| Бүсүүдийн дундаж | 240357.5 | 237684.5 |
|------------------|----------|----------|

ДНБ-

өгөөж, Замын хөрөнгө оруулалтаар /Хүснэгт 6.5/

| Бүсүүд           | Хатуу хучилттай зам | Сайжруулсан зам |
|------------------|---------------------|-----------------|
|                  | Тоо – 1 километр    |                 |
| Баруун           | 1.20                | 1.25            |
| Бүсүүдийн дундаж | 1.00                | 1.00            |

ний

| Бүсүүд           | Хатуу хучилттай зам     | Сайжруулсан зам |
|------------------|-------------------------|-----------------|
|                  | Доллар – 1 доллар тутам |                 |
| Баруун           | 1.59                    | 3.85            |
| Бүсүүдийн дундаж | 2.18                    | 5.27            |

ДНБ-ний өгөөж

баруун

бүсэд 1 км хучилттай замд 1.59 доллараар өсөх боломжтой. Эндээс сайжруулсан зам илүү өгөөжтэй байх төлөвтэй байна. Үүнийг бүсийн дотоодын замыг сайжруулахад харгалзах нь зүйтэй юм.

Баруун бүсэд байгуулж, Азийн замтай холбох 1 дэх чиглэлийн босоо тэнхлэгийн хар замыг тавих, одоогийн замыг сайжруулах замаар хөрөнгө оруулалтын арга хэмжээг улсын хөгжлийн дунд хугацаа /2009 – 2011 он/-ны бодлогод тусгаж, санхүүжүүлэх эх үүсвэр, арга хэлбэрийг үндсэнд нь тогтоогоод байна. Иймд Баруун бүсийн улс хоорондын 2 дахь чиглэл /Ханх – Мөрөн – Тосонцэнгэл – Улиастай – Алтай - Бургастай/-ийн босоо тэнхлэгийн дагуу хатуу хучилттай авто замыг барих зорилтыг шинэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт 2012 – 2015 оны хөгжлийн бодлогод тусгаж, улмаар Азийн замтай холбох саналыг “CAREC”-ийн хөтөлбөрт тусгуулахыг зөвлөмж болгож байна.

Түүнчлэн, энэ асуудлаар одооноос эхлэн ОХУ, БНХАУ-ын хил зэргэлдээ муж болон автономит улс тойргуудын удирдлагатай яриа хэлцэл хийж, улмаар тэдгээрийн дэмжлэгээр талуудын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрт тусгуулж ажиллах хэрэгтэй байна.

Монголын Баруун бүс нутагт уур амьсгалын хуурайшилт, цөлжилт хүчтэй явагдаж байгаа тул улс хоорондын хөндлөн болон босоо тэнхлэгийн хатуу хучилттай зам, тэдгээрт холбогдсон орон нутгийн замуудыг хамгаалах, орчныг нь тохижуулах, зам засвар арчлалт зэргийг хөрөнгийн эх үүсвэр, хариуцах байгууллагатай хамтад нь шийдвэрлэх, хүрээлэн буй орчны болзошгүй эрсдэл зэргийг урьдаас тооцож, төсөл, төлөвлөгөөнд тусгах нь зүйтэй байна.

**Баруун бүсийн томоохон замуудыг сайжруулах төсөв, санхүүжилт /Хүснэгт 6.6/**

| Чиглэл   | Хэрэгжүүлэх хугацаа | Сайжруулах урт /км/ | Хучилттай зам болгох өртөг /сая.ам доллар/ |
|--|---------------------|---------------------|--|
| 1. Ховд – Өлгий                                  | 2010 – 2011         | 211                 | Эргэн төлөгдөх нөхцлөөр<br>Улсын төсөв     |
| 2. Өлгий – Цагааннуур – Улаанбайшинт – Улсын хил | 2009 – 2010         | 40                  | /8 тэрбум төгрөг/<br>Улсын төсөв           |
| 3. Ханх – Хатгал                                 | 2008 – 2009         | 30.4                | /3.1 тэрбум төгрөг/<br>Улсын төсөв         |
| 4. Ховд – Манхан – Булган                        | 2007 – 2009         | 60                  | /10.8 тэрбум төгрөг/<br>АХБ-ны зээл        |
| 5. Ховд – Манхан - Үенч - Булган                 | 2009 – 2011         | 307.2               | /19.3 тэрбум төгрөг/<br>Улсын төсөв        |
| 6. Улаангом - Тээл                               | 2008 - 2009         | 15                  | /3 тэрбум төгрөг/                          |

Баруун бүсийн Цагааннуур – Өлгий – Ховд – Манхан – Ярантайн чиглэлийн босоо тэнхлэгийн замыг байгуулахад АХБ-аас олгосон 30 сая.ам долларын зээлийн хөрөнгийг ашиглах гэрээ болон бэлтгэл ажил хангагдсан.

Бусад улс орны туршлагыг үндэслэн, олон улсын ач холбогдолтой зам байгуулж ашиглахад дор дурдсан менежментийг хөрш орнуудтай хамтран бүрдүүлэх боломжтой гэсэн санал, зөвлөмжийг төсөлд тусгалаа. Үүнд:

- Шороон болон цасан шуурга, элсний нүүдлээс хамгаалах “экологийн халхавч” буюу ойн зурвасыг хөрш орнуудтай хамтран байгуулах,
- Улс хоорондын хатуу хучилттай замыг хэрэглэгч дотоод, гадаадын байгууллага, иргэдийн зам ашигласнаас олсон орлогын тодорхой хувиар “Замын сан” байгуулж, түүнд улсын төсөв, хөрш орон, олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, үр ашигтай зарцуулах хамтын хяналтын тогтолцоог бүрдүүлэх /олон улсын концерциумын хэлбэрээр/,
- Зам засвар, арчлалтын хамтарсан аж ахуйн нэгж /компани/-ийг Ховд Улиастайн тулгуур төв юм уу хилийн боомтыг түшиглэн байгуулах,
- Босоо, хэвтээ чиглэлийн хар замууд нь тусгай хамгаалалттай газар нутгийг дайрах юм уу ойролцоо газраар өнгөрч байгаа /хүснэгт үз/-г анхаарч, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ өгч,

хамтран хамгаалах арга хэмжээг “Алтай, Саяны хил дамнасан байгаль орчны хөтөлбөр”-ийн хүрээнд төлөвлөж хэрэгжүүлэх зэрэг болно.

**Баруун бүсийн улс хоорондын замын сүлжээнд  
ТХГН-ийн хамаарах байдал /Хүснэгт 6.7/**

|   | Замын чиглэл                  | ТХГН-ийн нэр                     | Тайлбар           |
|---|-------------------------------|----------------------------------|-------------------|
| 1 | Алтай – Ховд                  | Манхан /БНГ/                     | дайрна            |
| 2 | Ховд – Өлгий                  | Цамбагарав /БНГ/                 | дайрна            |
| 3 | Алтай – Бургастай – хил       | Шарга /БНГ/                      | дайрна            |
| 4 | Өлгий – Даян – хил            | Алтай таван богд /Үндэсний парк/ | дайрна            |
| 5 | Улаангом - Үүрэг - Цагааннуур | Түргэний уулс /ТХГН/             | хажуугаар өнгөрнө |

**2. Монгол Улс алслагдсан Баруун бүс нутгаа дотоод, гадаад зээлтэй шууд холбох, хөрш оронтой тогтоосон хамтын ажиллагааг өргөжүүлэх найдвартай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор мэдээлэл холбоо, цахилгаан эрчим хүчний суурь болон дамжуулах сүлжээг эрчимтэй барьж байгуулж байна.** Одоогийн байдлаар Ховд, Өлгий хотыг шилэн кабелиар /Улаанбаатарын “Наран станц”-тай/, бусад аймгийн төвийг Сансарын ВИСАТ станцаар /өртөг их өндөртэй/, олонхи сум, сууринг үүрэн телефоноор дотоод, гадаадад мэдээлэл солилцох боломжоор хангаж байна. 2008 – 2011 онд улсын төсвийн хөрөнгөөр бүх сум сууринг үүрэн телефон холбоотой болгож, 2015 он гэхэд бүх аймгийн төвүүдийг өндөр хурдны шилэн кабелиар холбож, мэдээллийн шуурхай байдлыг хангах зорилт тавьж байна.

Энэ дэвсгэр дээр, алслагдсан Баруун бүсийн хөгжлийн гол төвүүд /тулгуур төв, чөлөөт бүс, хил гаалийн олон улсын боомтууд гэх мэт/-ийг хөрш орон, дэлхийн улсуудтай интернетийн мэдээллээр холбох арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэхээр төсөөлж байна. Баруун бүс нутгийг дотоод, гадаадын интернетийн сүлжээнд найдвартай, шуурхай холбоход хил гаалийн боомтуудад одоогоор хэрэгжээд байгаа Гаалийн автоматжуулсан мэдээллийн систем /"ГАМАС"/, мөн 2008 оноос эхлэн хэрэгжүүлж буй нийт сумдыг төвтэй холбох санхүүгийн удирдлагын мэдээлэл /"СУМС"/-ийн сүлжээ чухал түлхэц болох юм. Бүс нутгийн мэдээллийн системийн найдвартай байдлыг хангах, түүнийг байнга үр дүнтэй ашиглах нөхцлийг бүрдүүлэхийн тулд 2015 он хүртэлх хугацаанд, Ховд, Улиастайн тулгуур төвд “Мэдээллийн сервис” үйлчилгээ, “интернетийн төв”, аймгийн болон сум дунд /бүлэг суурингийн/-ын төвүүдэд “сургалт, интернет үйлчилгээний цэг”-ийг байгуулах арга хэмжээ авах шаардлагатайг төсөлд тусгаж байна.

2008 онд, Дөргөн /12мвт/, Тайшир /10мвт/-ын УЦС-уудыг сум сууринтай холбогдох ЦДАШ, дэд станцуудын хамт ашиглалтад оруулснаар Баруун бүс нутгийг цахилгаан эрчим хүчээр тасалдалгүй, найдвартай хангаж, 2020 он гэхэд тус бүсэд бүс нутгийн эрчим хүчний нэгдсэн тогтолцоо бүрдэх бололцоо бий болж байна.

2015 он гэхэд, Баруун бүсийг Завхан, Говь-Алтайн чиглэлээр Төвийн эрчим хүчний системд холбох ажлыг үндсэнд нь дуусгана.

Сумдыг хооронд нь аймгийн төвүүдтэй цахилгаан эрчим хүчээр холбох дэс дараатай арга хэмжээ авч, 2015 он гэхэд шаардлагатай бүх сумдыг цахилгаан эрчим хүчний эх үүсвэртэй болгох зорилтыг шийдвэрлэхээр төлөвлөж байна. 2008 – 2010 онд, Баруун бүсэд Мөрөн-Тэлмэн-Тосонцэнгэл /Завхан/, Манхан-Мөст-Мөнххайрхан, Булган /Ховд/-Такашикен/ БНХАУ-ын хилийн боомт/, Цагааннуур-Ногооннуур/Баян-өлгий/, Бигэр-Чандмань-Эрдэнэ, Дарви-Тонхил/Говь-алтай/ Баруунтуруун-Зүүнхангай-Цагаанхайрхан-Өндөрхангай /Увс/ зэрэг 30 орчим сумыг хооронд нь цахилгаан эрчим хүчний шугамаар холбох юм. Сумдыг цахилгаан дамжуулах эрчим хүчний шугамаар холбох ажлыг улсын төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ. Ингэснээр Баруун бүсийн хөгжлийн гол бүс нутгуудад хөрш болон бусад оронтой бизнесийн салбарт хамтран ажиллаж хөрөнгө оруулах өргөн боломж бүрдэх юм.

Баруун бүсэд, Ховд – Өлгий – Улаангом-ын чиглэлээр ОХУ-тэй холбогдсон ЦДӨХШ-ийн ашиглалтыг цаашид сайжруулж, Дөргөний УЦС-ын хүч чадалд суурилан хоёр талын эрчим хүчний солилцоог цаашид өргөжүүлэхийн хамт, босоо тэнхлэгийн хатуу хучилттай автозамын дагуу БНХАУ-ын хил зэргэлдээ нутагтай эрчим хүч дамжуулах шугамаар холбогдож, улс хоорондын эрчим хүч хангамжийн сүлжээг бүрдүүлэх бололцоог нээх нь зүйтэй байна. Энэ нь хэтдээ Баруун бүсээр босоо чиглэлийн улс хоорондын төмөр зам тавьж, улмаар цахилгаанжуулахад түлхэц болох ирээдүйтэй юм.



**Баруун бүсэд худалдааг хөнгөвчилж, өргөжүүлэх, чөлөөт бүсийг үр өгөөжтэй ажиллуулах, хил худалдааны валютын хяналт, зохицуулалтыг сайжруулахтай уялдан улс хоорондын банк, санхүүгийн сүлжээг бүрдүүлэх явдал чухал байна.** Монгол банкны мэдээгээр баруун бүсэд одоогоор ХААН, Хадгаламж, Зоос банкны салбар ажиллаж, иргэд байгууллага хоорондын мөнгөн гүйлгээг зохицуулж байна. Цаашид Ховд хотод Монгол банкны салбар /мөнгөний бодлогын чиглэлээр/ Цагааннуур чөлөөт бүсэд Оффшор банк юмуу санхүүгийн байгууллага/үндэсний болон гадаад валютын зохицуулалтыг сайжруулах чиглэлээр/ байгуулж, арилжааны банкууд, банк бус санхүүгийн байгууллагууд, худалдаачдын сонирхол, үйл ажиллагааг тухайн бүс нутгийн хөгжилд шаардлагатай гадаадын хөрөнгө оруулалт валютын хуримтлалыг бий болгох зорилгод нэгтгэн чиглүүлэх арга замыг олж ашиглах явдал чухал юм. Баруун бүсийн тухайд “Хоршоолол”-ын хэв шинжийн банк ирээдүйтэй байж болохыг судалж, иргэд байгууллагын мөнгөн хөрөнгө хадгаламжийг нэмэгдүүлэх, сумын хэмжээнд эргэлдэж буй мөнгөний нөөцийг бүхэлд нь тооцон, орон нутгийн хөгжлийн нийтлэг ашиг сонирхолыг хөндсөн асуудалд төвлөрүүлэн ашиглах санхүүгийн нэгдсэн зохицуулалт хэрэгтэй байна. Түүнчлэн гадаадад байгаа иргэдээс нутаг орон, гэр бүлдээ ирүүлсэн мөнгөн гуйвуулгыг банкны сүлжээгээр дамжуулан илүү үр дүнтэй ашиглах талаар манай хоёр хөрш ялангуяа БНХАУ-ын чухал туршлага хуримтлуулсаныг харгалзах нь зүтэй байна.

**3. Баруун Монгол нь тус улсын агаарын зайн багтаамжийн 30 орчим хувийг эзэлдэг** буюу 24 цагт 2000 гаруй нислэг үйлдэх чадавхитай гэсэн ойролцоо тооцоо байгаа бөгөөд одоогоор 24 цагт 6-7 нислэг хийж байна. Баян-Өлгий аймгийн төв Өлгий хотоос БНКаЗУ-ын Алма – Ата -Устькаменогорск хот руу 7 хоногт 2 удаа Улаанбаатараас бүсийн аймгууд руу 7 хоногт авиа компаниуд давхардсан тоогоор 30 гаруй нислэг хийж, гол төлөв зорчигч тээвэрлэж байна. Шинээр байгуулагдах Сутай хотод нь аль ч талаасаа олон улсын онгоц буух, агаарын тээвэр хөгжүүлэхэд боломжтой юм.

Ховд хотод олон улсын чанартай онгоц нисэх, буух хатуу хучилттай зурвас байгуулсан боловч ашиглалт нэн багатай байна. Ойрын хугацаанд Ховд хотыг олон улсын агаарын тээврийн баруун чиглэлийн боомт болгох, тээврийн үйлчилгээний терминал аж ахуйг байгуулах зорилт тавьж болох байна. 2008-2010 онд Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Баруун бүсийн бусад 4 аймгийн төвийн нисэх буудлын онгоц хөөрөх, буух зурвасыг хатуу хучилттай/үерийн далангийн хамт/ болгохоор төлөвлөж, зохих бэлтгэл ажлыг хийж байна. ОХУ-тай тохиролцон, түүний дэмжлэгээр баруун бүсийн Ховд-Улаангом хотоос БНТува улсын Кызыл- цаашлаад Сибирийн Абакан, Омск, Астана/БНКаЗУ-ын нийслэл/-Новосибирск хотууд, Ховд-Барнаулын чиглэлээр бүс нутгийн хүрээнд үйлчлэх агаарын шугамыг нээх нь ирээдүй байгаа юм. Мөн агаарын тээвэрээр БНХАУ-ын баруун чиглэлийн “WESTERN” авиа компанитай хэлэлцээр байгуулж, ШУӨЗО, ӨМӨЗО болон Казахстан, Дундад Азийн орнуудтай агаарын шугамаар холбогдох арга замыг эрэлхийлэх хэрэгтэй байна.

Цаашид, Монгол орон, түүний дотор Баруун бүс нутгийн агаарын орон зайг зохистой ашиглах асуудлыг олон улсын агаарын тээврийн холбогдох конвенцид Монгол Улс нэгдэн орох, түүнчлэн ОХУ, БНХАУ, БНКУ, БНАСАУ-тай 1990 – 1996 онд хоёр талын үндсэн дээр байгуулсан дамжин өнгөрөх тээврийн хэлэлцээрийг өргөжүүлэх замаар шийдвэрлэх нь зүйтэй байна. Баруун бүс нутгийн агаарын орон зайг оновчтой ашиглах нь тус улсын гадаад худалдаа, тээвэр үйлчилгээний болон навигацийн ашиг орлогыг нэмэгдүүлээд зогсохгүй ОХУ-ын Сибирь, БНХАУ-ын Баруун бүс, улмаар Дундад Ази, Ойрх Дорнодын дэлхийн зах зээлийн хөгжингүй төвүүд, далайгаас ихээхэн алслагдсан улс орнуудын Монгол улсын агаарын зайгаар дамжин өнгөрөх тээвэрлэлтийн хугацаа, өртөг зардалыг хямдруулах, авто болон төмөр замаар тээвэрлэх үед амархан муудаж, гэмтэж болзошгүй хүнс, өргөн хэрэглээний зарим барааны чанарыг хадгалахад ач холбогдолтой болно. Энэ үүднээс сонирхогч улс орон, олон улсын байгууллагатай хамтран “Монгол Улсын агаарын тээврийг хөгжүүлэх стратегийн төсөл”-ийг боловсруулах саналыг дэвшүүлж байна.

Баруун бүсийн босоо тэнхлэгийн хатуу хучилттай автозамын трасстай зэрэгцүүлэн төмөр зам тавьж ОХУ, БНХАУ-ын төмөр замтай холбох төслийг 2006 онд УИХ-аас баталсан “Монголын төмөр замын хэтийн төлөв”-т ерөнхийд тусгасан. Хөрш болон бүс нутгийн орнуудын төмөр замын сүлжээнээс үзэхэд, Монголыг тойрсон буюу тус улсын Баруун хил орчимд дөхөж ирсэн хэд хэдэн зам байна. Эндээс стратегийн хувьд энэ түрүүнд авч үзэх боломжтой хувилбар бол Баруун бүс нутгийг ОХУ-ын Эрзин /Монголын Арцсуурь боомт/-ийн чиглэлээс Алтай хот – Шивээ хүрэн /Баянхонгор/-гээр БНХАУ-ын төмөр зам /100 км-т ирсэн/-тай холбох явдал юм. Үүнийг Баруун бүсийн босоо тэнхлэгийн хар замыг барих ажлыг эхлэх, дуусгах хугацаа, түүгээр тээвэрлэгдэх дотоодын болон улс хооронд дамжин өнгөрөх ачаа болон зорчигч тээврийн хэмжээнээс хамааруулан оновчтой шийдвэрлэх учиртай.

Одоогийн байдлаар хөрш орнуудын төмөр замын зах зээлийг судлан үзэхэд 2006 оны төсөөлөл эрчимтэй өөрчлөгдөж, хөрш орнуудын ачаа эргэлт эрчимтэй хөгжиж болох Бургастай- Сутай-Арцсуурийн чиглэлийн төмөр замыг яаравчлан барих техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах явдал чухал болж байна.

Тэгэхдээ, зах зээлийн хөгжлийн төвүүдээс алслагдсан байрлалтай, цөлжилт идэвхижиж байгаа Монголын Баруун бүс нутгийн тухайд төмөр зам байгуулах боломж, үндэслэлийг эртнээс эхлэн хөрш улсуудын холбогдох байгууллагатай зөвшилцөн ярилцаж, тодорхой шийдэлд хүрсэн байх нь зөв юм. Ялангуяа, төмөр зам байгуулах үндэслэл баталгаа болгож Баруун бүсэд ойрын ирээдүйд ашиглавал зохих стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын томоохон орд /Говь – Алтай, Завханы зэс, фосфорит, нүүрс гэх мэт/-ын нөөц, ашиглах горимыг нарийвчлан тогтооход онцлон анхаарах хэрэгтэй байна.

Түүнчлэн, ТАХАХ /"CAREC"/-т нэгдсэн орнууд /Казакстан, Узбекистан, Киргиз, ОХУ, БНХАУ/-ын хамтын ажиллагааны боломжид АХБ-аас 1998, 2004 онд хийсэн судалгааны баримт бичгээс үзэхэд, Дундад Азийн орнуудыг Казакстаны Алма–Ата – Дружбагийн хатуу хучилттай авто зам, төмөр зам /Монголын хилээс 500 км/, эсвэл ОХУ-ын Тува улс /Кызылын/-ын чиглэлээр аль нэг зохистой хувилбараар Монгол Улстай хөндлөн тэнхлэгийн төмөр замаар холбож, улмаар түүнийг Баруун бүсэд буй болох босоо чиглэлийн төмөр зам, УБТЗ хүртэл үргэлжлүүлэн БНХАУ-ын Баруун бүс, мөн Зүүн Ази, Номхон далайн орнуудын зах зээлд нэвтрэх гарцыг бий болгох ерөнхий дүр зураг ажиглагдаж байгаа юм. Энэхүү дүр зургийг Монгол болон хөрш зэргэлдээ орнуудын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх алсын хараа болгон үзүүштэй байна.

**4. Зам тээвэр, аялал жуулчлалын яамнаас сүүлийн жилд гадаадын жуулчдын тоо өсөн** нэмэгдэж байгааг харгалзан бүс нутгийн хөгжлийг түргэтгэх хэрэгцээ, байгаль орчныг хамгаалах шаардлагатай холбон 2008 онд “Аялал жуулчлалыг эн түрүүнд хөгжүүлэх бүс нутаг”-уудыг шинээр тогтоон мөрдүүлж, тус улсын баруун бүсэд 3718.8 мян.га талбайг аялал жуулчлал, амралт зугаалгын зориулалтаар ашиглуулахаар заасны дотор 1940.4 мян.га буюу 52.0% нь Завхан – Говь-Алтайн бүсэд байна /Хавсралт хүснэгт- үз/. Дотоод, гадаадын судлаачид, төсөл хэрэгжүүлэгч байгууллагаас хийсэн аялал жуулчлалын бүс нутгуудын нөөц боломж, орчны үнэлгээнээс үзэхэд, олонхийг нь гадаадын хүмүүст Баруун Монголын үндэстэн угсаатны түүх соёлын өв дурсгал, аж ахуйн өвөрмөц зан заншлыг таниулах, үзэсгэлэнт газар, ховор ан амьтан, шувуудыг үзүүлж сонирхуулан, уулын болон усан спортыг хөгжүүлэх зориулалтаар ашиглах боломжтой байна.

Эдгээрийг түшиглэн аж ахуйн байгууллага, иргэдээс аялан жуулчлагчдын хүлээн авах улирлын чанартай гэр бааз, ангийн отог, амралт – сувиллын газруудыг олноор байгуулсан боловч, гадны анчдад тусгай зөвшөөрлөөр ан агнуулахаас бусад үйл ажиллагаа нь гадаад орны аялан жуулчлагчдын сонирхлыг татаж, аймаг, орон нутгийн ашиг орлогыг нэмэгдүүлэхэд дорвитой түлхэц болж чадахгүй байгаа юм.

Тус улсад аялал жуулчлал, амралт сувиллыг хөгжүүлэх талбайн нөөцийн 20 гаруй хувийг эзэлж буй Баруун бүс нутгийн чадавхийг бүрэн, зохистой ашиглахын тулд хөрш хоёр орон, түүгээр дамжин бүс нутгийн бусад оронтой аялал жуулчлалын хамтарсан сүлжээ, менежментийг бүрдүүлэх хэрэгтэй байна. Энэ зорилгоор төсөлд дараах арга хэмжээг төлөвлөж байна. Үүнд:

- Монголын Баруун бүс нутгийг хамруулах боломжтой хөрш болон бүс нутгийн орнуудын аялал жуулчлалын зах зээлийг судалж, мэдээллийн бааз бүрдүүлэх, тэдгээр орны мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах чиглэлийг нарийвчлан тогтоох
- Аялал жуулчлалыг арилжааны үндсэн дээр эдийн засгийн нэг тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлж, аймаг бүрийн хэтийн хөгжлийн стратегид тусгах
- Аялал жуулчлалын чадавхи сайтай гол бүс нутгуудыг Баруун бүсийн дэд бүтцийн босоо, хэвтээ тэнхлэгийн дагуу бүсийн хөгжлийн тулгуур төв, хил гаалийн боомт, худалдааны чөлөөт бүстэй хатуу хучилттай зам, Цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугамаар холбох
- Ингэж холбогдсон аялал жуулчлалын бүс нутагт дэлхийн жишигт зохицсон олон улсын аялал жуулчлалын иж бүрэн үйлчилгээ, мэдээллийн цогцолбор байгуулах арга хэмжээг улсын төсвийн дэмжлэгээр үе шаттай хэрэгжүүлэх зэрэг болно.

Дээрх зорилтын хүрээнд хөрш болон бүс нутгийн орнуудтай тогтвортой хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор “Аялал жуулчлалын бүс нутгийн хамтын ажиллагааны хороо”-г Монголын Ховд хот юм уу БНХАУ-ын Өрөмч хотын аль нэгэнд байгуулж, үндэстэн дамнасан аж ахуйн нэгжээр дамжуулан бүс хоорондын аялал жуулчлалын харилцан үр ашигтай менежментийг бүрдүүлэх нь зүйтэй байна.

Монголын тал, энэхүү үйл ажиллагааны хүрээнд, аялал жуулчлалын нөөц, чадавхи ихтэй Хангайн бүсийг хамруулсан нэгдсэн маршрут, чиглэлийг тогтоох нь илүү үр ашигтай байх төлөвтэй байгаа юм.

**5. Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбоо, аялал жуулчлалын дэд бүтцийн дээр** дурдсан нэгдсэн сүлжээнд тулгуурлан Баруун бүсийг хөрш болон бүс нутгийн орнуудтай холбосон босоо,

хэвтээ тэнхлэгийг “Тээвэр хөгжлийн коридор” болгон хөгжүүлж, үр өгөөжийг нь дээшлүүлэх стратегийг дэвшүүлж байна. Ингэхдээ дараах нөхцөл боломжийг харгалзан үзэж байна. Үүнд:

1./ Баруун бүсийн Мянганы замын “Боршоо – Улаангом – Ховд - Ярантай”-н чиглэлийн босоо тэнхлэг нь БНХАУ-ын ШУӨЗО-ны Өрөмч хотоос Монголын хил хүртэлх Такешикен боомт, мөн Өлгий – Улаанбайшинтаар дамжин ОХУ-ын Ташанта – Баршул – Новосибирск хүрэх Азийн АН4- замтай холбогдож, НҮБ-аас 1959 онд баталсан Азийн их замын төсөлд тусгагдсан “Трасека” буюу Европ – Кавказ – Дундад Ази – БНХАУ-ыг холбосон тээврийн коридорт хамрагдсан байна. Энэ чиглэлийн зам нь Төв Азийн орнуудын бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрт “CAREC”4А- гэсэн замын кодтой тусгагдаж, АХБ-ны зээлийн хөрөнгөөр Монголд хэрэгжиж эхлэх үндэс суурь нь нэгэнт тавигдаж байгаа болно.

2./ Баруун бүсийн босоо тэнхлэгийн Ханх – Мөрөн – Улиастай – Алтай – Бургастай чиглэлийн замын зарим хэсэг нь Монголын Мянганы замын төсөл, УИХ-аас баталсан “Төмөр замыг хөгжүүлэх хэтийн төлөв”-т тусгагдсан бөгөөд түүнийг ОХУ /Монд/, БНХАУ /Хөх өртөө/-ын тус улсын хилд 100 – 200 км дөхөж ирсэн хар замтай хоёр талын хүч чармайлтаар холбох боломж байна.

Иймд Баруун бүс нутгийг дээрх хоёр чиглэлээр хөрш орнууд, улмаар тэдгээрээр дамжуулан ОХУ, Европ, Дундад болон Төв Ази, Казакстан, Зүүн өмнөд Азийн орнуудтай холбож улс хоорондын транзит тээвэр, худалдааг хөгжүүлэн, улсын хөгжлийг тэтгэх тулгуур багана буюу гарц /”коридор”/ бий болгох явдлыг хэтийн зорилт болгон дэвшүүлэхийг санал болгож байна. Үүнд хүрэх ойрын зорилт /2015 он хүртэлх/ нь Баруун бүсийг хөрш хоёр оронтой холбосон босоо тэнхлэгийн хатуу хучилттай замуудыг хурдавчлан байгуулж, тэдгээр орны тээвэр, логистикийн үйлчилгээний тогтолцоотой холбогдох анхдагч үндсийг бүрдүүлэх явдал юм. Үүнтэй холбоотой дор дурдсан асуудлыг судалж шийдвэрлэх нь зүйтэй байна. Үүнд:

- Монгол Улсад олон улсын ач холбогдолтой тээвэр – логистикийн үйлчилгээг хөгжүүлэх, улмаар түүнийг алслагдсан Баруун бүсийн Монголын транзит хөгжлийн нэн чухал гарц буюу дамжуулагч - тээвэрлэгч бүс нутаг болгох талаар ТРАСЕКА төслийн багтай хамтарч ажиллах, энэ талаар хөрш орнуудтай дамжин өнгөрөх тээврийн хэлэлцээр байгуулах, цаашдаа Дундад Азийн далайд гарцгүй зарим улс /Казакстан, Киргиз, Таджик/-ын ачаа ба зорчигч тээвэр Монголын нутгаар дамжин өнгөрөх нөхцлийг хангахад тэдгээр оронтой хамтран ажиллаж, харилцан дэмжлэгийг буй болгох,

- Монголын Баруун бүсэд “тээвэр – хөгжлийн коридор” байгуулах талаар “CAREC”-ийн гишүүн олон улсын санхүүгийн байгууллагууд /НҮБ, ДБ, АХБ, Олон Улсын Валютын сан, Европын сэргээн босголт, хөгжлийн банк гэх мэт/-аас хөрөнгө санхүүгийн дэмжлэг авах,

- 2007 – 2010 онд АН4- маршрутын нэг дэх авто зам /Цагааннуур – Өлгий – Ховд - Ярантай/-ыг байгуулж, Баруун бүсийн 3 аймаг энэхүү тэнхлэгтэй холбогдон тээврийн нэг коридор үүсгэх,

- 2011 – 2015 онд Ховд болон Цагааннуурын чөлөөт бүсэд энэхүү коридорыг үйлчлэх ачаа, зорчигч тээврийн терминаль аж ахуй, логистик үйлчилгээний төв байгуулж, Булганы хилийн боомт, БНХАУ-тай холбосон логистикийн нэгдсэн сүлжээ үүсгэх,

- 2015 – 2020 он хүртэлх хугацаанд, “Арц суурь /эсвэл Ханх – Мөрөн/ - Улиастай – Алтай – Бургастай /эсвэл Шивээхүрэн”-н хоёр дахь чиглэлийн босоо тэнхлэгийн авто замын коридор байгуулж, хөрш оронтой хоршсон логистикийн сүлжээ, терминаль аж ахуй байгуулах зэрэг болно.

2009 – 2020 он хүртэлх хугацаанд, бүс нутгийн хөгжлийн төвүүд /аймгийн төв, бүлэг суурингийн төв/-ийг дээр дурдсан босоо тэнхлэгийн хоёр замтай тус тусын чиглэлээр холбож, хөрш орнуудын бүс нутгуудтай бараа, бүтээгдэхүүн солилцох зах зээлийн сүлжээ бүрдүүлэх замаар тэдгээр замыг “Хөгжлийн коридор” болгон шинэ шатанд хөгжүүлэх зорилт тавьж байна.

2020 он хүртэлх хугацаанд Монгол Улс Баруун бүсийн Арцсуурь – Улиастай – Алтай – Шивээхүрэнгийн чиглэлийн төмөр зам байгуулах үндсийг тавьж, улмаар олон улсын ТРАСЕКА-ийн коридортой холбогдож чадвал, Дундад Ази, Ойрхи Дорнодын бүс нутгийн орнуудтай хийх худалдааг өргөжүүлэх шинэ хэтийн төлөв нээгдэх боломжтой гэж төсөөлж байна.

### 6.1.2.1 Гадаад худалдааны хөгжлийн төлөв

**Дотоод, гадаад худалдаа нь харилцан уялдаатайг харгалзан Баруун бүсийн худалдааны хөгжлийн одоогийн байдал, хандлагыг энэ бүлэгт нэгтгэн авч үзэж байна.** Монголын Баруун бүсийн аймагууд нь газарзүйн ойр дөт байрлал, түүх, соёл, аж ахуй эрхлэлтийн адил төстэй байдлаа ашиглан хөрш хоёр орон, тэдгээрийн субъектүүд /өөртөө засах орон, муж улс, тойрог гэх мэт/-тэй бүр эртнээс худалдаа, эдийн засаг, соёлын өргөн хэлхээ холбоо тогтоон, харилцаж ирсэн уламжлалтай билээ.

1990 оноос Монгол Улс, БНХАУ, ОХУ-тай хоёр талын худалдааны хэлэлцээрээ зах зээлд нийцүүлэн шинэчлэн байгуулсан бөгөөд энэ хүрээнд Монголын Баруун аймгууд хийгээд хөрш орнуудын субъектүүдийн хоорондын худалдаа, эдийн засгийн харилцаанд ч ихээхэн өөрчлөлт гарч байгаа юм. Эдүгээ манай Баруун бүсийн аймгууд, БНХАУ-ын ШУӨЗО, Ганьсу муж /Монгол үндэстний Сүбэй сум/, ӨМӨЗО /Алашаа хошуу/, ОХУ-ын Сибирийн холбооны тойргийн БНТува Улс, Алтай Улс /үүний цаана байгаа БНХакас Улс, Новосибирск, Кемерово мужууд/, мөн ОХУ-ын нутгаар дамжин Казакстан улстай шаардлагатай бараа, бүтээгдэхүүнээ солилцож, харилцан зорчиж, худалдааг түншлэлийн харилцааны түвшинд цаашид өргөжүүлэхийг эрмэлзэж байна.

**2007 оны ГЕГ-ын Гаалийн захиргааны статистикийн дүн мэдээнээс үзэхэд**, Баруун бүсийн аймгууд 4'371.2 мян.ам долларын бүтээгдэхүүн экспортлож, 51'061.9 мян.ам долларын бараа импортлосон байна. Импортын хэмжээ нь экспортоосоо 10 гаруй дахинаар давж байгаа буюу гадаад худалдааны тэнцэл ихээхэн алдагдалтай гарч байгаа юм. Үүнийг 2006 оны дүн мэдээтэй харьцуулбал, экспорт нь үнийн дүнгээр ялигүй өссөн буюу бараг нэг хэмжээндээ, импорт нь буурсан боловч зонхилсон хэвээр байна. Баруун бүсийн аймгуудын экспортыг үнийн дүнгээр нь авч үзвэл ойролцоогоор 94% нь ОХУ-тай, үлдсэн 6% нь БНХАУ-тай хийгдсэн онцлогтой байгаа бол бараа бүтээгдэхүүний 46.7%-ийг ОХУ-аас авсан тооцоо гарч байна. Гэхдээ импортын тухайд, барааны нэр төрөл, үнэ өртөг нөлөөлсөн нь тодорхой юм.

Ерөнхийдөө ОХУ-аас гол төлөв өндөр үнэтэй, үйлдвэрлэл – техникийн бараа /бензин шатахуун ороод/ авч байгаа бол БНХАУ-аас харьцангуй хямд үнэтэй өргөн хэрэглээний бараа /хүнс, төмс, ногоо, гурил, будаа, ахуйн хэрэглээний бараа/ нийлүүлж байна. Баруун бүсийн аймгуудаас хөрш орнууд руу цөөн нэр төрлийн /мал аж ахуйн түүхий эд, модон материал – экспортын бараг 80%-ийг эзэлдэг/, өртөг багатай, боловсруулаагүй /80 орчим хувь нь/ арьс шир, ноос, ангийн үс гаргаж байгаа юм.

Харин ОХУ-д /Тува/ мал, мах гаргаж, түлш шатахуун, буудайн хэрэгцээний дийлэнхийг авч байгаа онцлог байна. Баруун бүсийн аймгуудын дотоод, гадаад худалдааны онцлог нэр төрөл, урсгал чиглэлийг Завхан аймгийг төлөөлүүлж, ХБНГУ-ын ГТХН-ийн “Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр”-ийн 2008 онд захиалан хийлгэсэн судалгаанаас тодорхой харж болно.

Энэхүү судалгаанаас харагдаж буй, Баруун бүсийн аймгуудын гадаад худалдааны урсгал хөдөлгөөний нэг онцлог бол тус бүсийн аймгууд, ялангуяа Завхан, Говь-Алтай аймгууд сүүлийн жилд, ихээхэн хэмжээний ХАА-н түүхий эдийг Улаанбаатарын зах зээл дээр худалдаалж, улмаар Замын - Үүд боомтоор дамжуулан БНХАУ /тухайлан, Эрээн хот руу/-тай худалдаа, солилцоо хийж байгаа бөгөөд энэ байдал өргөжих хандлагатай байна. Хөрш орнуудтай хийж буй худалдаа нь Баруун бүсийн аймгуудын хүн амыг хүнсний болон өргөн хэрэглээний бараагаар хангахад чухал үүрэгтэй байгаа боловч, бүс нутгийн эдийн засгийн өсөлт, үр ашгийг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж чадаагүй байгаа юм.

Монголын Баруун бүс нутаг, хөрш орнууд, ялангуяа БНХАУ ШУӨЗО-ны хоорондын худалдааны хэмжээ нэн бага, тогтвортой, гүний /хилийн бус/ худалдаа хөгжиж чадаагүй байна. Мэдээнээс түүвэр судалгаа хийж үзэхэд, Монгол – Хятадын хилээр дамжин хийгдэж байгаа гадаад худалдааны 20 орчим хувь /60% нь Төвийн бүсээр/ нь Баруун бүсийн аймгуудад ногдож байгаа юм. БНХАУ-ын ШУӨЗО-той харилцаж байгаа Монголын хилийн 4 боомт/Байтаг-Улиастай, Бургастай- Лаоезмюгийн, Даян-Хун шанцзюний, Булган-Такашикен/-оор гаргасан бараа бүтээгдэхүүн ШУӨЗО-ны гадаад худалдааны эргэлтийн 0.65-аас 1.0 хүртэлх хувийг эзэлж байгааг ШУА-ийн Олон Улс судлалын хүрээлэнгийн 2004-2005 онд хийсэн судалгаа харуулж байна.

**Баруун бүс нутагт гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирэх таатай нөхцөл бүрдээгүй байна.** БНХАУ-ын хөрөнгө оруулалттай, Монголд байгуулагдсан ЖДҮ, үйлчилгээний 40 гаруй цэг салбар Баруун бүсийн аймгуудын төвд байгаа ба олонхи нь үр өгөөж багатай, алдаг оног ажиллаж байгаа мэдээ байна. Тэдгээр нь ихэвчлэн хоцронгуй технологитой оёмол, төмөр эдлэл, барилга, нийтийн хоолны газрууд юм.

Түүнчлэн, үйлчилгэний худалдаа гэж нэрлэгддэг мэргэшилтэй ажиллах хүч, мэдлэг туршлага, арилжааны чиглэлтэй аялал жуулчлалын солилцоо хөгжөөгүй байна. Энэ бүхэн Монголын Баруун бүс нутаг ХАА-н түүхий эд, импортын худалдаа, энгийн бараа солилцоо зонхилсон эдийн засгийн өрөөсгөл бүтэцтэй хэвээр байгаатай холбоотой байна. 2007 оны тооцоогоор, Баруун бүсийн аймгуудын ДНБ-ий бүтцэд, ХАА-н салбар 71.8, худалдаа үйлчилгээ 22.8 хувь эзэлж байна. ДНБ-д ХАА-н эзлэх хувийн жин улсын дундажаас бараг 50 пунктээр дээгүүр байгаа буюу 2004 оны түвшингээс бараг /70.6%/ өөрчлөгдөөгүй ажээ. Засгийн газар алслагдсан Баруун бүс нутагт улс хоорондын худалдааг үр ашигтай хөгжүүлэх зорилгоор, хил гаалийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, бүртгэл – мэдээллийг сайжруулах, Цагааннуур олон улсын чөлөөт худалааны бүс байгуулах, дотоод худалдааны зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг зохистой болгох алхмуудыг хийж байна.

Ялангуяа 2001 оноос эхлэн улсын төсвөөс дэмжин хэрэгжүүлж буй “Бөөний худалдааны сүлжээ төсөл”-д баруун аймгуудыг хамруулж, түүхий эд бэлтгэх, тээвэрлэх, боловсруулах, борлуулах худалдааны сүлжээ, бэлэн бүтээгдэхүүн нийлүүлэх зах зээлд нийцсэн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ авч ирсэн. Гэвч, хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний газрууд, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод хэт бөөгнөрсний улмаас, бүс нутгуудад орчин үеийн худалдаа, үйлчилгээний цэг салбарыг хөгжүүлж, энэ дэвсгэр дээр гадаад худалдааг өргөжүүлж, үр ашгийг нь дээшлүүлэхэд тодорхой бэрхшээл тулгарсаар байгаа юм.

Гадаад худалдааг өргөжүүлэх, хөнгөвчлөх зорилгоор экспортын ихэнх барааг татвараас чөлөөлөх, импортын татварыг ДХБ-ын тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрт заасан /20%-аас доогуур /бүх бараанд үнийн дүнгээс тооцсон 5%-ийн гаалийн татвар ногдуулдаг/ тогтоох, бизнес эрхлэгчдэд олгодог тусгай зөвшөөрлийн тоог бууруулах /600 байсныг 87 болгов/ зэрэг арга хэмжээ авсан. Гэхдээ, хөгжлийн түвшин доогуур байгаа Баруун бүсийн тухайд, чанарын шаардлага хангаагүй импортын барааг хэт оруулснаас хүн амын аюулгүй байдал, дотоодын үйлдвэрийн хөгжилд зохисгүй нөлөөлж байгааг бодолцох учиртай. Ийм нөхцөлд Баруун бүсийн тухайд илүү үр ашигтай худалдааг дэмжсэн эдийн засгийн бүтцийн өөрчлөлт шаардагдаж байна. Эн түүрүүнд, малын гаралтай түүхий эдийг гүн боловсруулж, нэмүү өртөг шингэсэн, олон нэр төрлийн бүтээгдэхүүн экспортод нийлүүлэх явдал чухал байна. Энэ зорилтыг Баруун бүсийн Ховд, Улиастайн тулгуур төвд аж үйлдвэрийн парк, нутгийн шилмэл омгийн үүлдрийн мал аж ахуйн бүс нутагт мал аж ахуйн кластер тус тус байгуулж, энэ хүрээнд гадаадын дэвшилтэт технологи шилжүүлэн ашиглах замаар шийдвэрлэж болох байна. Улс хоорондын дэд бүтцийг сайжруулсан нөхцөлд, БНХАУ-ын Баруун бүс, ӨМӨЗО-нд мал аж ахуйн түүхий эдийн гүн боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй АНУ, Турк, БНСУ, Казакстан Улсын хамтарч, хоршсон компаниудын шууд хөрөнгө оруулалтыг Монголын Баруун бүс нутаг руу татах боломж бүрдэхээр байна.

Тооцооноос үзэхэд, Баруун бүсийн аймгуудад жилдээ 9118.4 тонн, таван төрлийн малын мах, 7590.0 тонн ноос ноолуур /улсын нөөцийн 23 – 35%/-ыг экспортод гаргах чадавхи байгаа юм. Тэгэхдээ, түүхий эдийг зах зээлд өндөр өртөгтэй боловсруулах хүмүүсийн ур чадвар, технологийн түвшин одоогоор ихээхэн сул байгаа Баруун бүсийн тухайд, энэ үйл ажиллагаанд зохих дадлага туршлагатай болтлоо худалдаа, ялангуяа импортыг хэт хавтгайруулж өсгөх /чөлөөт худалдаа буюу худалдааг либеральчлах/ нь төдийлөн зохистой биш гэдгийг анхаарах нь зүйтэй. Харин тодорхой бүс нутаг /тухайлбал, Цагааннуурын чөлөөт бүс, Булган, Боршоогийн хилийн боомтууд/-т худалдааг олон улсын дэг жаягийн дагуу чөлөөтэй явуулах бололцоог нээж болох юм.

Баруун бүсэд улс хоорондын үр ашигтай худалдааг дэмжих боломжтой хоёрдогч, гуравдагч салбарууд нь зам тээврийн дэд бүтэц, аялал, амралт сувилал, мэдээллийн холбоо, бөөний худалдааны бирж, арилжааны банк санхүүгийн үйлчилгээ, мөн экспорт /дамжин өнгөрөх/ юм. Эдгээрийн өндөр мэргэшлийн үйлчилгээний гол төвүүдийг Ховд, Улиастайн тулгуур төв, олон улсын хилийн боомтууд /Боршоо, Цагааннуур, Булган, Бургастай, Арцсуурь гэх мэт/-ад байгуулж, хөрш орнууд /Казакстан ороод/-тай хамтарч хоршсон үйл ажиллагаа явуулах шаардлагатай байна.

**Мөн ОХУ-ын хөрөнгө оруулагчидтай хамтран Баян-Өлгий аймгийн Асгатын мөнгөний орд,** Улаан уулын гянт болд, Шүдэн уулын давсны ордуудыг бүс нутгийн зах зээлд харилцан үр ашигтай ашиглах хамтарсан үйлдвэрийг Монголын нутаг дэвсгэр дээр холбогдох дэд бүтэц, үйлчилгээтэй нь хамтад нь байгуулах талаар олон жилээр яригдаж буй асуудлыг ажил хэрэг болгох хэрэгтэй байна. Энэчлэн Хятадын талтай хамтран Монголын Баруун бүс нутагт зэс, фосфорит, газрын тосны хайгуул, эрэл үнэлгээний ажлыг идэвхижүүлж, хэтдээ үндэстэн дамнасан аж ахуйн нэгж байгуулах боломжийг бүрдүүлж болох юм.

Баруун бүсийн чадавхид түшиглэн хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцан үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилтыг БНХАУ-ын Баруун бүс нутаг, ОХУ-ын Сибирийн тойргийн эрчимтэй хөгжлийн стратегитэй тус тус холбон хөрш улсууд, гадаадын хөрөнгө оруулагчдын зүгээс эдгээр бүс нутгийн хөгжлийг дэмжиж буй эдийн засаг, санхүүгийн зохицуулалтын таатай нөхцөл, боломжийг хамтран ашиглахыг эрмэлзэх нь зүйтэй байна. Хөрш хоёр орны хил зэргэлдээ субъектууд /муж улс, хязгаар тойргууд/ нь Монголын Баруун аймгуудтай хөгжлийн түвшин, үйлдвэржих сонирхол, нөөц боломжоор адил төстэй байгааг харгалзан ЖДҮ-ийг хамтран байгуулж, эдийн засгийг аль болох хоршин, хэрэгцээгээ харилцан нөхөн хангах чадвараа дээшлүүлэхийг чухалчлах нь ирээдүйтэй байгаа юм. Энэхүү үйл ажиллагаанд Баруун бүсийн аймаг бүр өөртөө байгаа боломжийг бүрэн ашиглаж, эдийн засгаа тодорхой чиглэлээр төрөлжүүлэн, идэвхитэй оролцох хэрэгтэй. Тус төсөлд Баруун бүс нутгийн аймгуудыг хөрш орнуудтай харилцаж ирсэн уламжлал, нөөцийг нь харгалзан, цаашид худалдаа – эдийн засгийн хамтын ажиллагааны дараах чиглэлээр ОХУ, БНХАУ, Казакстаны зах зээлийн солилцоонд оролцох боломжтой гэж төсөөлж байна. Үүнд:

- Ховд аймаг – ХАА-н техник, нефть бүтээгдэхүүн, эм, эмнэлгийн хэрэгсэл, даавуу, гутал, сүлжмэл ба оёмол эд зүйлс, хүнсний ногоо, ургамлын үр импортлох, геологи, барилгын материал, хүнсний салбарт хамтарсан үйлдвэрийн газрууд байгуулах, арьс мах, жимс жимсгэнэ, загас экспортлох,
- Завхан аймаг - өргөн хэрэгцээний бараа, нефть бүтээгдэхүүн, ХАА-ын техник, мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах техник, технологи импортолж, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, модон материал, загас экспортлох ба жуулчин солилцох,
- Увс аймаг – бага хүчин чадлын хамтарсан мах комбинат байгуулах, хүнсний комбинатын технологийг шинэчлэх, жижиг усжуулах системүүдийг сэргээх, Боршоо, Тэсийн нэвтрүүлэх боомтуудаас Давст, Тэс сумын төвүүдэд цахилгаан дамжуулах шугам барьж байгуулах, Тэс суманд “Шар үзүүрийн” нэвтрүүлэх байнгын боомтыг нээх, Хакас ба Тувад мах, чацарганы тос, давс, чацаргана, загас экспортлох, худалдааны ярмакууд харилцан зохион байгуулах, Улаангомд Хакас ба Тувагийн бөөний худалдааны төв байгуулах, жуулчны солилцоогоо өргөтгөх, нефть бүтээгдэхүүн ба үр тариа импортлох,
- Говь-Алтай аймаг – махны хүйтэн зоорь хамтарч байгуулах, газар тариалангийн салбарт Алтайн хязгаартай мэргэжилтэн солилцох, чацарганы тос ба дарс экспортлох,
- Баян-Өлгий аймаг - өргөн хэрэглээний бараа, ХАА-н техник, ноос, нэхмэлийн үйлдвэрийн техник технологи импортолж, мах, арьс шир, /адууны/, оёмол нэхмэл /цэмбэ/ эдлэл, уул уурхайн зарим бүтээгдэхүүн /мөнгө, гянт болд/ экспортлох зэрэг болно.

Баруун бүсэд дотоод, гадаад худалдааны үр ашигтай сүлжээг бүрдүүлэхийн тулд, улс хоорондын босоо тэнхлэгийн замуудыг хурдавчлан байгуулах хэрэгтэй байна. Түүнчлэн худалдааны зах зээлийн дэд бүтэц, /барааны агуулах, үзэсгэлэн худалдааны төв, бөөний бирж, хяналт – сорилтын лаборатори/, дэлхийн жишигт нийцсэн менежментийн тогтолцоо /мэргэшлийн удирдлага, үйлчилгээний тэргүүний соёл, маркетингийн болон мэдээллийн сан гэх мэт/-г бүрдүүлэх шаардлага тулгамдаж байна.

Баруун бүсээр дамжуулан тус улс хөрш орнуудын хоорондын худалдааг өргөтгөн хөгжүүлэхийн тулд, 2015 он хүртэлх хугацаанд дор дурдсан арга хэмжээг Монгол Улсын худалдааны дунд хугацааны үзэл баримтлал /одоо боловсруулж байгаа/-д тусган үе шаттай авч хэрэгжүүлэхээр төсөөлж байна. Үүнд:

- Баруун бүсэд экспортыг өргөжүүлэх, импортыг үр ашигтай болгох үзэл баримтлалд тулгуурласан бүсийн гадаад худалдааны бодлогыг тодорхойлох,
- ОХУ, БНХАУ, Казакстан улстай дамжин өнгөрөх тээвэр худалдаа /реэкспорт/-ны хэлэлцээр байгуулж, түүнд Баруун бүс нутгийн онцлогийг тусгайлан тусгах,
- БНХАУ-ын Баруун бүс, ОХУ-ын Сибирийн тойрогт багтдаг субъектуудтай худалдаа – эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх стратегийн төслийг хамтран боловсруулж хэрэгжүүлэх,
- Өлгий дэх Казакстаны төлөөлөгчийн газар, ОХУ-ын Тува Улсын Кызыл, Монголын Увс аймгийн Улаангомд байгуулсан Консулын газар /ОХУ-ын Алтайн БНУлс, Хакас Улсыг хамаарна/-ыг Талуудтай тохиролцон худалдаа – эдийн засгийн хамтын ажиллагааг зохицуулах чиг үүрэгтэй болгон өргөтгөх,
- Монголын Баруун бүсийн аймгуудад Бүсийн зөвлөл, бүсийн хөгжлийн хэлэлцээрийн байгуулахаар хуулиар олгосон эрх хэмжээг үндэслэн аймгууд хөрш орнуудын субъектүүдтэй худалдааны хүрээнд бие даан хамтран ажиллах чиглэлийг тогтоож, хэрэгжүүлэх,
- Монголын Гаалийн менежментийн чадавхид түшиглэн хил гаалийн боомтоор олон улсын худалдааг хөнгөвчлөх, худалдааны аюулгүй байдлын баталгааг хангах талаар хөрш орнуудтай хамтарсан хяналт – сорилт, интернетийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сүлжээг бүрдүүлэх,
- Баруун бүсийн зөвлөлийн дэргэд хөрш орнуудтай хамтран ажиллах “Худалдаа – Аялал жуулчлалын хороо”-г байгуулж ажиллуулах,
- ДХБ-ын гишүүнчлэлийн нийтлэг зарчмын хүрээнд БНХАУ-ын хил зэргэлдээ субъектүүдтэй идэвхитэй хамтран ажиллах, энэ чиглэлээр ОХУ-ыг ДХБ-д ойрын хугацаанд элсэхэд хил залгаа субъектүүдийн дэмжлэгийг хүчтэй болгоход түлхэц үзүүлэх,
- Баруун бүсийн хил орчимд Монгол болон хөрш орнуудын байгуулсан /байгуулахаар төлөвлөж буй/ худалдаа, эдийн засгийн чөлөөт бүсүүдийн хүрээнд худалдаа /худалдааг хөнгөвчлөх либеральчлах/-ны хоёр ба гурван талын хэлэлцээр байгуулах,
- Баруун бүсэд хөрш болон бүс нутгийн орнуудын зах зээлд өрсөлдөж, өндөр ашиг орлого буй болгох шилмэл /брэнд/ бүтээгдэхүүнийг тогтоож, үйлдвэрлэл – борлуулалт /Хятад, Орос, Монголын

бусад бүсээс ялгагдах газрын нэрийн заалт, барааны тэмдэг, шошго/-ын сүлжээг бүрдүүлэх /мөн тэдгээр орны бүс нутгийн “брэнд” бүтээгдэхүүнийг импортлох/,

- Монголын Баруун бүсэд олон улсын үр ашигтай худалдааг хөгжүүлэхэд түлхэц болгон аж үйлдвэрийн парк, мал аж ахуйн кластер байгуулах ажлыг түргэтгэхэд хөрш болон бүс нутгийн орнуудын дэмжлэгийг өргөжүүлэх,
- Хэрэв Засгийн газар Баруун бүсэд агаарын болон төмөр зам байгуулах чиглэлийг баталсан тохиолдолд, тэдгээрийн дэд бүтэц, үйлчилгээний талаар хөрш орнууд, “CAREC”-ийн гишүүн бусад орон, олон улсын байгууллагатай хамтарсан судалгаа хийж эхлэх,
- Хөрш орнууд /Казакстан ороод/-ын хооронд худалдаа, аялал жуулчлал, мэдээллийн технологийн мэргэжилтэн солилцох, сургалт – мэдээллийн арга хэмжээг хамтран зохион байгуулах,
- Орос, Хятад, Монголын хил зэргэлээ бүс нутгуудын эдийн засгийн өсөлтийг түргэтгэж, харилцан нэгнээ нөхөн хангаж, хамтдаа хөгжих концепцид тулгуурлан Баруун бүсээр хийгдэж буй хөрш орнуудын хоорондын худалдааны тарифын ба тарифын бус, тэрчлэн техникийн саад тогтворыг арилгах асуудлыг хоёр талын Засгийн газрын хэлэлцээрээр тохиролцох арга хэмжээ авах, ялангуяа ОХУ-аас боловсруулсан бараанд ногдуулж буй өндөр татвар /махан бүтээгдэхүүн, хиамны татвар 30 – 40% байгаа юм/-ыг багасгах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй байна.

### 6.1.3. Хил, гаалийн үйл ажиллагаа, чөлөөт бүсийн хөгжил

Монгол Улс БНХАУ-тай 4670 гаруй км, ОХУ-тай 3500-аад км. газар нутгаар хил залгаа оршдогийн барагцаалбал 30 гаруй хувь нь Баруун бүсэд хамаарч байгаа юм. Өнөөдөр Монгол Улс Баруун бүсээр БНХАУ-тай хил залгаа байнгын ажиллагаатай 4 боомт, ОХУ-тай хил залгаа 5 боомтоор тус тус зорчигч, авто тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлж, гадаад худалдаа, чөлөөт валютын солилцоо зэрэг үндсэн хэлбэрээр хилийн худалдаа харилцааг зохицуулж байна /тайлбарыг хар/.

Тайлбар: Монгол ба хөрш орнуудын хилийн боомтууд

1./ Монгол – БНХАУ-ын хооронд:

- Булган /Ховд/ - Такашкен /ШУӨЗО/
- Байтаг /Ховд/ - Улиастай
- Бургастай /Говь-Алтай/ - Лао емяо
- Даян /Баян-Өлгий/ - Хуншаньцзюнь

2./ Монгол – ОХУ-ын хооронд:

- Цагааннуур /Баян-Өлгий/
- Өлгий
- Тэс /Завхан/ - Шар суурь
- Боршоо /Увс/ - Хандгайт /БНТува Улс/
- Арц суурь /Завхан/ - Цагаантолгой

Хилийн боомтуудын төрөл, зэрэглэл, үйл ажиллагааны чиглэл, тулгамдсан асуудлыг тодорхойлж хавсралтад үзүүлэв. Хилийн боомтуудын үйл ажиллагаа нь Монгол – Хятад, Монгол – Оросын хилийн боомтууд, тэдгээрийн шалган нэвтрүүлэх дэглэмийн тухай 1991 /БНХАУ-тай/, 1995 /ОХУ-тай/ онд байгуулсан хэлэлцээрийн дагуу явагдаж байна. Энэхүү хэлэлцээрт тодотгон заасны дагуу Монгол, Хятадын иргэд хоёр орны хилээр визгүй, Монгол, Оросын иргэд/дипломат болон албан паспорт аваагүй/ визтэй зорчиж байгаа юм. Баруун бүсийн хилийн боомтууд нь хөрш орнуудтай тогтоосон хил гаалийн худалдааг зохицуулахад гол үүрэг гүйцэтгэж байна. Олонхи боомтоор хийгдэж буй хил худалдаа аажмаар өргөжин тэлж, талуудын шалган нэвтрүүлэх албаны ажилтнууд хамтран ажиллаж, ачаа тээврийн хэрэгсэл, зорчигчдыг чирэгдэл багатай шуурхай шалган нэвтрүүлэх болж, хоёр талын худалдааг чөлөөтэй хийх илүү таатай нөхцөл аажмаар бүрдэж байна.

Түүнчлэн, хөрш орнуудтай 2002 – 2005 онд байгуулсан “хил худалдааны аюулгүй байдлыг хангах протоколийн дагуу, Монголд экспортлох хүнсний ногоо, бордоо зэрэг нь олон улсын чанарын стандартад нийцсэн байх, барааг газрын нэрийн заалт, тэмдэг, шошготой болгож, эдгээрийн зөрчвөл буруутай нийлүүлэгчид хариуцлага хүлээдэг байх” журмыг мөрдөж байна.

Хилийн боомтоор нэвтэрсэн тээврийн хэрэгслийн судалгаа, тоо /Хүснэгт 6.8/

| Боомтууд | Орсон /бүгд/ |      | Гарсан /бүгд/ |      |
|----------|--------------|------|---------------|------|
|          | 2006         | 2007 | 2006          | 2007 |
| Арцсуурь | 930          | 1526 | 835           | 2698 |
| Боршоо   | 1757         | 2843 | 1744          | 4203 |
| Булган   | 6040         | 5877 | 5786          | 7167 |

|            |       |       |       |       |
|------------|-------|-------|-------|-------|
| Байтаг     | 734   | 546   | 732   | 544   |
| Бургастай  | 894   | 1018  | 880   | 934   |
| Даян       | 7     | 144   | 7     | 146   |
| Өлгий      | 52    | 85    | 52    | 81    |
| Цагааннуур | 4555  | 4446  | -     | 4984  |
| Тэс        | 348   | 891   | 426   | 728   |
| Дүн        | 15317 | 17376 | 15107 | 21485 |

Хүснэгтээс үзэхэд, сүүлийн жилд ОХУ-тай хиллэдэг боомтууд /Боршоо, Арцсуурь, Цагааннуур/-аар гарсан тээврийн хэрэгсэл, ачааны тоо хэмжээ нэмэгдэж байна.

**Хилийн боомтоор нэвтэрсэн зорчигчдын судалгаа /Хүснэгт 6.9/**

|            | Орсон |       | Гарсан |       |
|------------|-------|-------|--------|-------|
|            | 2006  | 2007  | 2006   | 2007  |
| Арцсуурь   | 10562 | 13146 | 13153  | 14166 |
| Боршоо     | 12088 | 14240 | 11451  | 14101 |
| Булган     | 1597  | 1723  | 1886   | 1874  |
| Байтаг     | 2083  | 1603  | 2083   | 1524  |
| Бургастай  | 26830 | 28581 | 27217  | 26817 |
| Даян       | 47    | 394   | 66     | 432   |
| Өлгий      | 1872  | 2913  | 2283   | 2968  |
| Цагааннуур | 21058 | 18959 | 24044  | 19167 |
| Тэс        | 2368  | 5932  | 2667   | 6434  |
| Дүн        | 78505 | 87491 | 84850  | 87483 |

ОХУ-ын хил залгаа нутаг руу зорчигчдын тоо мөн л олон байгаа бөгөөд тогтвортой орнуудаас нэвтэрсэн зорчигчдын аяллын зорилго, хугацаа зэргийг судалж үзэхэд,

ОХУ-аас хил нэвтэрсэн хүмүүсийн олонхи /40 – 60%/ нь хувийн хэргээр, 30 хоног юм уу 90-ээс дээш хоногоор зочилсан байхад, БНХАУ-ын иргэдийн дийлэнх /70 – 80%/ нь 90-ээс дээш хоногоор байнга буюу түр оршин суух зорилготой хил нэвтэрсэн байдал ажиглагдаж байгаа юм.

Баруун бүсийн хилийн худалдаагаар Монголын иргэд мал амьтны дайвар бүтээгдэхүүн /адууны дэл сүүл, өлөн гэдэс, яс, ясны гурил, бугын цусан болон ясан эвэр/, арьс шир, төмрийн хаягдал зэргийг авч гарч хүнсний болон өргөн хэрэглээний бараагаар сольж, наймаа хийж байна. 1990-ээд оны эхэн үед, Монголын хил худалдаанд, хөрш хоёр орны хил залгаа орон нутгийн аж ахуйн нэгж, иргэд оролцож байсан бол 90-ээд оны дунд үеэс үйлдвэр хөгжсөн гүний муж, хотуудаас бизнес эрхлэгчид олноор ирэх болж, өрсөлдөөн буй болсноор манай түүхий эдийн үнэ ханш өсөхөд нааштай нөлөөлөх хандлагатай байгаа юм.

Гэхдээ, Баруун бүсийн Цагааннуур, Өлгийгөөс бусад боомтын түвшинд боомтууд нь хоёр хөрштэй харьцуулахад төдийлөн тохижиж чадаагүй, аймаг, сумынхаа , төвөөс ихээхэн алслагдсан, зам харилцаа муу хөгжсөн газарт байрлаж байгаа нь хил худалдааны үр өгөөжийг дээшлүүлж, хилчид болон иргэдийнхээ тав тухтай байдлыг хангахад саад тогтор болж байна.

Энэ нь манай иргэдийг хөрш орнуудын нутагт очиж, ашиг багатай наймаа хийхэд хүргэж ирэв. Мөн хил хамгаалалт, хил худалдаанд бэрхшээл учруулсан олон тооны зөрчил, дутагдал гарч, эдүгээ бүрэн арилаагүй хэвээр байна.

Тухайлбал, Монгол, Хятадын хилийн боомтууд дээр, хоёр талын аж ахуйн нэгжүүд төлбөр тооцоогоо дутуу хийх, бараа дутуу нийлүүлэх, хууль бус наймаа хийх үзэгдэл хэвээр байна. ОХУ-ын Тува Улс, Увс, Завхан аймгийн хилийн зурваст мал хулгайлах хууль, хууль бус наймаа хийх, зөвшөөрөгдөөгүй зүйлсийг хилээр оруулах явдал үргэлжилж, зарим тохиолдолд буу зэвсэг хэрэглэх, хил хамгаалагчдад эсэргүүцэл үзүүлэх явдал гарсаар байна. Эдгээрийг талуудын Засгийн газрын түвшинд ярилцаж, таслан зогсоохыг эрмэлзэж байгаа боловч байнгын тодорхой үр дүнд хүрч чадаагүй байна.

Орон нутгийн захиргааны зүгээс хилийн боомтууд, хил худалдааны үйл ажиллагааг зохицуулах хөрөнгө, эрх мэдэл бага, хил хамгаалах байгууллагатай уялдаа багатай ажиллаж байна. Сүүлийн үед Хятад, Оросын талаас иргэд, байгууллагын тээврийн хэрэгслээс авдаг татвар, хураамж өндөрсөж, гаднаас оруулж байгаа бараа нь чанарын болон ариун цэврийн баталгааг хангаж чадахгүй байдал ихсэх төлөвтэй байна.



Зарим боомтууд, тухайлбал, Говь-Алтай аймгийн Бургастайн боомтын тохижилт, зам харилцааны нөхцөл муугаас үйл ажиллагаа нь доголдож, эмх замбараагүй байдал ихсэн, байгаль орчныг бохирдуулахад хүрсэн байна. Завхан, Баянхонгор аймгууд тус боомтоор хил худалдаа хийж байснаа, ачаагаа Замын-Үүд рүү зөөх болсон байна.

Ийм нөхцөлд, сайн хөрш, худалдааны гол түншийн харилцаа, талуудын харилцан ойлголцол, хамтын ажиллагаанд тулгуурлан тус улсын хил хамгаалалт, нэвтрэлт, хил худалдааны бүтэц, тогтолцоог шинэчилж, Баруун бүсээр дамжуулан Монголтой чөлөөт худалдаа хийх хөрш хоёр орон болон бүс нутгийн бусад улсуудын өсөн нэмэгдэж буй сонирхол, хэрэгцээ, ОХУ, БНХАУ-ын харьцангуй сайн тохижсон хилийн боомтуудын барааны нөөц, дэд бүтцийн чадавхийг бүрэн зөв зохистой ашиглах явдал чухал байна.


Үүнтэй уялдан, 2015 он хүртэлх хугацаанд Баруун бүсийн хил хамгаалалт, хил худалдааны талаар дараах нийтлэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатайг зөвлөмж болгож байна. Үүнд:

- 1./ Баруун бүсийн хилийн боомтуудыг өөрийн орны гүний бүс нутаг, хөгжлийн төвүүд, тэрчлэн, хоёр орны хилийн боомттой дэд бүтцийн сайжруулсан сүлжээгээр холбох,
- 2./ Баруун бүсийн босоо тэнхлэгийн улс хоорондын замуудын хилийн гарц болж буй боомтуудыг олон улсын боомтын түвшинд тохижуулж, улмаар дотоод, гадаадын иргэд, чөлөөт худалдаа, бизнес эрхлэн оршин суух орчин үеийн хот, тосгон болж хөгжих үндсийг тавих, тэдгээрт шалган нэвтрүүлэх цогцолбор, бөөний худалдааны төвүүдийг байгуулах,
- 3./ Хилийн боомтуудыг гаалийн мэдээллийн автоматжуулсан систем, цаашдаа санхүүгийн удирдлагын мэдээллийн сүлжээгээр дамжуулан бүсийн тулгуур болон орон нутгийн хөгжлийн төвүүдтэй холбох,
- 4./ Дээрх сүлжээнд түшиглэн хилийн боомтуудын үйл ажиллагаа, тохижилтод аймаг, орон нутгийн удирдлага, Засгийн газрын үзүүлэх дэмжлэгийг өргөтгөх,

# Гадаад харилцаа

1 : 3 500 000

Зураг 6.1



5./ Хил худалдаагаар оруулж, гаргаж буй түүхий эдийг аль болох хязгаарлаж, анхан шатны боловсруулалт хийх, барааг савлах, боох, угсрах, хадгалах үйл ажиллагааг боомтууд дээр хийх зэргээр барааны үнэ цэнийг өндөржүүлэх,

6./ Хил хамгаалах, шалган нэвтрүүлэх албаны ажилтнуудын нийгмийн халамж, цалин, тэдгээрийн мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх, хөрш орнуудтай мэдээлэл солилцох, туршлага судлах, хамтарсан үзлэг шалгалт хийх зэргээр хамтын ажиллагаа, харилцан дэмжлэгийг идэвхижүүлэх,

7./ Баруун болон Хангайн бүсээр улс хоорондын худалдаа, тээврийн үйлчилгээ өргөжих хэтийн төлөв, хөрш орнуудын бизнес эрхлэгчдийн саналыг харгалзан босоо тэнхлэгийн хар ба төмөр зам дайрах боомт /Бургастай, Тэс/-ыг байнгын ажиллагаатай болгож тохижуулах. Тухайлбал, Алтайн өвөр говийн Дархан цаазат газрын ан амьтанг зам, тээврийн хөдөлгөөн, дуу чимээнээс хамгаалах оновчтой арга хэмжээ авах замаар Хятадын Ганьсу мужийн Монголд тохирох барааны нөөц, дэд бүтэц сайтай Мажиньсан боомт /Монгол үндэстний өөртөө засах Сүбэй сумын нутагт байрладаг/-той хиллэдэг Монголын Нарансэвстэйн боомтыг сэргээн байгуулах, мөн алсдаа Баруун Монголоор тавих төмөр зам БНХАУ-ын нарийн төмөр замтай нийлэх уулзвар болох Шивээхүрэн /Өмнөговь/-гийн боомтыг Ганьсу мужийн Сэхэ боомттой одоогоор хар замаар холбож, байнгын ажиллагаатай болгож тохижуулах,

Энэ бүх арга хэмжээ нь Монголын болон хөрш орнуудын аль аль талын ашиг сонирхолд нийцэх тул хамтарсан хөрөнгө оруулалт хийх бололцоотой гэж төсөөлж байна.

### 6.1.3.1 Гаалийн үйл ажиллагааны чиглэл

Монгол Улсын аль ч бүс нутагт гаалийн байгууллага нь экспорт, импортын худалдаагаар төр болон дотоод, гадаадын бизнес эрхлэгчдэд үйлчлэх мэргэжлийн өвөрмөц, нийтлэг үйлчилгээ явуулж байгаа юм. Ингэхдээ :

- Улсын төсвийг нэмэгдүүлэх,
- Улс орны эдийн засгийн аюулгүй байдал, хүн амыг хүнс, өргөн хэрэглээний чанартай бараагаар хангах,
- Бизнесийн хүрээнд олон улсын худалдааны үйл ажиллагааг хөнгөвчлөхөд дэмжлэг үзүүлэх үндсэн үүргийг хүлээж байна. Гаалийн байгууллага эдгээр үйл ажиллагаагаа аймгуудад бүсчлэн байгуулсан гаалийн газар хороогоор дамжуулан хэрэгжүүлж байна.

Баруун бүсэд одоогоор нийт 180 ажиллагсадтай гаалийн газар-2/Ховдын Булган дахь, Өлгий хот/, гаалийн хороо-3/Улаангом дахь, Завханы Арцсуурь, Говь-Алтай дахь/, Увсын Боршоо, Баянөлгийн Цагааннуур, Завханы Тэс дэх салбарууд, тэдгээрийн харъяанд нийт 10 хил гаалийн байнгын болон түр гарц ажиллаж байна.

Гаалийн үйл ажиллагааны зарим шалгуур үзүүлэлтийн 2006 – 2007 оны дүн мэдээнээс үзэхэд, Баруун бүсийн гаалийн боомтуудад 2007 онд бүрдүүлсэн гаалийн мэдүүлгийн нийт тоо 4446 байгаа бөгөөд үүний 12.3% нь экспортын, 87.7 % нь импортын бараанд ногдож байна.

Гаалийн мэдүүлэг, 2007 он /Хүснэгт 6.10/

| Гаалийн байгууллага | Нийт мэдүүлэг |            | Үүнээс  |        | 1 ГУБ-д ногдох мэдүүлэг |
|---------------------|---------------|------------|---------|--------|-------------------------|
|                     | тоо           | эзлэх хувь | экспорт | импорт |                         |
| Ховд ГГ             | 1564          | -          | 139     | 1425   | 98                      |
| Баян-Өлгий ГГ       | 911           | -          | 94      | 817    | 41                      |
| Говь-Алтай ГХ       | 307           | -          | 13      | 294    | 34                      |
| Завхан ГХ           | 138           | -          | 82      | 56     | 17                      |
| Увс ГХ              | 1526          | -          | 222     | 1304   | 85                      |
| Улсын хэмжээгээр    | 158024        | -          | 30390   | 127634 | 219                     |

Баруун бүсийн боомтоор бүрдүүлсэн гаалийн мэдүүлгийн нийт тоог 2006 онтой харьцуулахад 142.2 хувиар өссөн нь гол нь импортын барааны мэдүүлэг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Улсын хэмжээнд 2007 онд бүрдүүлсэн гаалийн мэдүүлгийн дөнгөж 2.8.% нь Баруун бүсийн гаалийн байгууллагад ногдож, 1 гаалийн байцаагч дунджаар 55 мэдүүлэг бүрдүүлсэн байна. Гаалийн хяналт, шалгалтын мэдээнээс үзэхэд, Баруун бүсийн гаалийн боомтуудад 2007 онд 32 захиргааны зөрчил илрүүлсэн нь улсын хэмжээнд илрүүлсэн энэ төрлийн зөрчлийн 14.8 % болж байна.

Гарсан зөрчлийн улмаас жилдээ 2-оос 3 сая төгрөгийн бараа хураагдаж байгаа нь Сэлэнгэ, Замын-Үүд зэрэг томоохон боомттой харьцуулахад ихээхэн бага байгаа юм. Тусгайд нь ангилж гаргасан мэдээгээр, Баян-Өлгий дэх гаалийн баталгаат агуулахад 253.2 мян.ам долларын бараа

хадгалж, 246.7 мян.ам долларын барааг нь дотоодын зах зээлд нийлүүлж, улсын төсөвт 199.5 мян.ам долларын татварын орлого оруулжээ.

Баруун бүс дэх гаалийн байгууллагууд 2007 онд 7667.1 сая төгрөгийн татварын, 401.2 сая.төгрөгийн хураамжийн орлогыг төсөвт оруулж, татварын орлогын төлөвлөгөөг 106.6 /Баян-Өлгий/-аас 154.4 хувиар /Ховд/ давуулан биелүүлжээ. Татварын орлогын хэмжээ 2006 оныхоос нийт дүнгээр 103.4%-иар нэмэгдсэн байна.

**Татвар, хураамжийн орлогын биелэлт, сая.төг / Хүснэгт 6.11 /**

| Гаалийн байгууллага | Татвар |        | Хураамж |       |
|---------------------|--------|--------|---------|-------|
|                     | 2006   | 2007   | 2006    | 2007  |
| Ховд ГГ             | 1417.4 | 2018.7 | 274.3   | 280.3 |
| Баян-Өлгий ГГ       | 2808.6 | 1834.7 | 18.0    | 37.8  |
| Завхан ГХ           | 139.8  | 207.6  | 8.9     | 15.3  |
| Увс ГХ              | 2276.8 | 2809.9 | 20.4    | 21.8  |
| Говь-Алтай ГХ       | 770.1  | 796.2  | 46.2    | 46.3  |
| Дүн                 |        |        |         |       |

Импортын зарим бараанд ногдуулдаг онцгой албан татварын хэмжээ 2007 онд өмнөх жилүүдээс нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд 2007 онд дунджаар тамхинд 9.9%-иар, согтууруулах ундаанд 7.3%-иар, бензин дизелийн түлшэнд 30 – 35.5%-иар, тээврийн хэрэгсэлд 40 – 47%-иар тус тус өссөн байна.

Монгол Улсын гаалийн байгууллагад сүүлийн жилд гарч буй үйл ажиллагааны нэг томоохон ахиц дэвшил болсон гаалийн мэдээний автоматжуулсан систем /"ГАМАС"/-д Баруун бүсийн гаалийн боомтууд бүхэлдээ хамрагдаж, импортлогч, экспортлогч иргэд, байгууллагад "нэг электрон цонх"-оор үйлчилгээ үзүүлэх зорилготой ажиллаж байна /Хавсралт зураг/.

2006 оноос эхлэн, Улсын гаалийн төв лабораторийн салбарыг Баян-Өлгий аймагт байгуулахаар үндсэн тоноглол, урвалж бодис, шилэн сав зэргийг багтаасан төслийг хэрэгжүүлж дуусч байна.

Дээр дурдсаныг хураангуйлан дүгнэвэл Баруун бүсийн гаалийн байгууллагууд нь одоогоор ажлын ачаалал /мэдүүлгээр/, илэрсэн зөрчил /захиргааны/ харьцангуй багатай байгаа ба гэхдээ төсөвт нилээдгүй орлого оруулж байна. Энэ нь гаалийн хяналт, шалгалт, үйлчилгээний шуурхай байдал сайжирч байгаатай холбоотой боловч үүнд Баруун аймгуудаар хийгдэж буй экспорт, импортын хэмжээ бага, ихэнхдээ хил худалдаа зонхилж байгаа явдал нөлөөлж байна.

ОХУ, БНХАУ-ын баруун хилийн боомтуудад манайхтай адил төстэй үүрэг, бүтэц бүхий гаалийн байгууллагууд ажиллаж байна. Гэхдээ хөрш хоёр орноос хуулиар зөвшөөрөгдөөгүй, хүн амын хүнсний аюулгүй байдалд нийцэл багатай бараа материал ихээр орж, гаалийн хяналтыг хүндрүүлж буй бэрхшээл цөөнгүй байна. Манай талаас ч үйлдвэрлэлийн үнэт түүхий эд ихээр гарч байна. Хөрш орнуудын гаалийн тариф ч харьцангуй өндөр хэвээр байгаа юм.

Баруун бүс нутгийн хөгжлийг эрчимжүүлэх, түүнийг улс хоорондын худалдаа, тээврийн үйлчилгээний нэг гол талбар болгох үүднээс бүс нутгийн гаалийн үйл ажиллагааг боловсронгуй болгож, шинэчлэх шаардлагатай байна. Энэ талаар 2015 он хүртэлх хугацаанд авах арга хэмжээний үндсэн чиглэлийг төсөлд дараах байдлаар тусгаж байна. Үүнд:

- Олон улсын байгууллагын дэмжлэгээр Төв Азийн орнуудын бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа /"CAREC"/-ны хөтөлбөрийн хүрээнд Монгол, ОХУ, БНХАУ-ын хоорондох гаалийн үйл ажиллагааг боловсронгуй болгох стратегийн төсөл /Баруун бүсийг тусад нь тодруулж/-ийг хамтран боловсруулах,
- Гаалийн татвар, тарифын бодлогыг төсөв бүрдүүлэхийн зэрэгцээ, Баруун бүс нутгийн тухайд, үр ашигтай худалдааг хөнгөвчлөх, түүхий эд экспортлохыг хязгаарлаж, дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, холбогдох дэвшилтэт техник, технологийг импортлох үйл ажиллагааг дэмжихэд чиглүүлэх,
- Тус бүс нутагт улс хоорондын худалдаа, тээвэр логистикийн үйлчилгээг хөгжүүлэх арга хэмжээтэй уялдуулан Ховд, Улиастайн тулгуур төв, Боршоо, Булганы хилийн гол боомтод гаалийн сорилт, шинжилгээний лабораторийн салбарыг байгуулах, гаалийн баталгаат агуулахыг олшруулах, гаалийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, тухайлбал эрсдлийн үнэлгээний арга чадварыг нэвтрүүлэх,
- ДХБ-ын хүрээнд /цаашид ОХУ элсэх үед/ олон улсын худалдааг хөнгөвчлөх, тарифын ба тарифын бус саадыг арилгах талаарх таатай нөхцлийг бүрэн ашиглах, тухайлбал экспортын барааг хөрш хоёр орны гүний нутагт оруулж, ашиг орлого сайтай борлуулах зах зээлийг буй болгох, энэ талаар хоёр ба гурван талын бүс нутгийн хэлэлцээр /гэрээ/ байгуулах,

- Дотоод, гадаадын гааль – бизнесийн түншлэлийг гүнзгийрүүлэх, олон улсын уулзалт, зөвлөлгөөнийг бүсчлэн /хөрш орнуудад/ зохион байгуулах,
- Монголын “ГАМАС”-ыг интернетэд суурилсан харилцан үйлчлэл бүхий тогтолцоо болгон өргөтгөх замаар хөрш хоёр орныг хамарсан “бүс нутгийн гаалийн мэдээ, бүртгэл”-ийн орон зайн нэгдсэн сүлжээ бүрдүүлж, үйл ажиллагаагаа шуурхай зохицуулах,
- Хөрш орнуудтай бүс нутгийн хүрээнд хамтран ажиллах “Гаалийн хамтын ажиллагааны ажлын хэсэг”-ийг дээр дурдсан “Баруун бүсийн худалдаа, аялал жуулчлалын дэд хороо”-ны бүрэлдэхүүнд байгуулж, улс хоорондын худалдааг зохистой болгон хөнгөвчлөх чиглэлээр ажиллуулах зэрэг болно.

### 6.1.3.2 Чөлөөт бүсийн хөгжлийн төлөв

Монгол Улсын Их Хурал “Чөлөөт бүсийн тухай” хуулийг үндэслэн 2003 онд Баруун бүсийн Цагааннуур /Баян-Өлгий/-ын авто замын хилийн боомтод түшиглэн “Цагааннуур” худалдааны чөлөөт бүс /ХЧБ/-ийн эрхзүйн байдлын тухай хуулийг батлан мөрдүүлснээс хойш багагүй хугацаа өнгөрч байна. Цагааннуур нь ОХУ-ын Ташантын хилийн боомттой хил залгаа оршдог. “Цагааннуур” ХЧБ-ийг байгуулахдаа дор дурдсан хүчин зүйлс, нөхцөл боломжийг харгалзан үзсэн байна. Үүнд:

- 1./ Монголыг баруун чиглэлээр Оростой холбодог гол гарц болж ирсэн Цагааннуур – Биск-ийн тракт /мал туувар, хил худалдааны дамжлага бааз/-ын тээвэр – газарзүйн ойр дөт байршлыг ашиглан ОХУ-ын Сибирийн тойрог, улмаар Европын орнуудын бизнес эрхлэгчдэд монголын газар нутагт чөлөөт худалдаа эрхлэх хил гааль, татварын нэн таатай орчин бүрдүүлж, дотоодын хэрэгцээг харьцангуй хямд, чанартай бараагаар хангах, гадаад худалдааны ашиг орлогыг нэмэгдүүлэх,
- 2./ Мянганы замын Баруун чиглэлийн хэвтээ, босоо тэнхлэгийн уулзвар орчимд байгаа Цагааннуурын хил, гаалийн боомтоор дамжуулан Монголын эдийн засгийг ОХУ, БНХАУ, улмаар Казакстан, Дундад Азийн орнуудтай холбож, улс хоорондын дамжин өнгөрөх ачаа, зорчигч урсгалыг нэмэгдүүлэх, барааны хадгалалт, тээвэрлэлтийн цогц үйлчилгээнээс олох орлогыг нэмэгдүүлэх,
- 3./ Хөрш хоёр орны хил залгаа субъектүүдтэй тогтоож ирсэн худалдаа, соёлын уламжлалт харилцааг бэхжүүлж, бараа таваарын хэрэгцээгээ харилцан нөхөж, улмаар эдийн засгийн хоршилтыг хөгжүүлэх боломж зэргийг бодолцсон байна.

Өнгөрсөн хугацаанд “Цагааннуур” ХЧБ-ийн Захирагчийн ажлыг байгуулж, үйл ажиллагааны чиглэлийг нарийвчлан тогтоож, дотоод, гадаадын худалдаачид, бизнес эрхлэгчидтэй хэлхээ холбоо тогтоон урьдчилсан гэрээ, хэлцэл хийсэн байна. Засгийн газар “Цагааннуур” ХЧБ-ийн хил гаалийн хамгаалалтын нөхцөл, дэд бүтцийг сайжруулах талаар олон чухал арга хэмжээ авч байна. 2005 – 2006 онд, Цагааннуурын хилийн боомтод улсын төсвийн хөрөнгө /1.5 тэрбум төгрөг/-өөр гаалийн цогцолбор байгуулсан нь хөрш орнуудын хоорондох ачаа, зорчигч урсгалын хэмжээг нэмэгдүүлэхэд томоохон түлхэц боллоо. 2007 – 2009 онд, Цагааннуур – Улаанбайшинтын хатуу хучилттай зам /30 км/-ыг барьж Цагааннуур тосгоны эрчим хүч, усан хангамжийг сайжруулах арга хэмжээ авч байна. Засгийн газрын 2008 оны 227 дугаар тогтоолоор чөлөөт бүсэд ажиллах мэргэжлийн хяналтын болон харуул хамгаалалтын албадын орон тоо, бүтцийг батлан мөрдүүлэв.

АХБ-ны зээлээр, Булган – Ховд – Өлгий – Цагааннуур хүртэлх босоо тэнхлэгийн хатуу хучилттай замыг барьж байгуулах ажлыг эхлүүлээд байна. Гэвч чөлөөт бүс дэх худалдаа, эдийн засгийн тогтвортой үйл ажиллагаа эхлэлтийн байдалтай байгаа ба дотоод, гадаадын бизнес эрхлэгчдийг олноор татах шаардлагатай нөхцөл бүрдэл болоогүй хэвээр байна. Үүнд, чөлөөт бүс байгуулж буй газар нутаг нь тус орны болон хөрш улсуудын хөгжлийн гол төвүүдээс ихээхэн алслагдсан, зах зээлийн багтаамж ихээхэн бага байгаа зэрэг бодит хүчин зүйл нөлөөлж байгаа нь тодорхой.

“Цагааннуур” ХЧБ-ийг чөлөөт бүсийг олон улсын жишиг, горимоор үр өгөөжтэй ажиллуулахын тулд дор дурдсан асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа юм. Үүнд:

- Баруун босоо тэнхлэгийн хар замыг эхний ээлжинд Цагааннуурын хилийн боомтын чиглэлд тавьж, худалдаачид орж ирэх гарцыг нэмэгдүүлэх үүднээс цаашид Улаангом – Боршоогийн боомт хүртэл үргэлжлүүлж, БНТУва Улсын Кызылийн хар замтай холбох,
- Чөлөөт бүсийн тосгоны барилга, байгууламж, усан хангамжийн нөхцлийг сайжруулж, худалдаа эрхлэхэд туслах үйлдвэрлэл /савлах, боох, угсрах/, үйлчилгээ /барааны агуулах, павильон, үзэсгэлэн яармаг/-г хөгжүүлэх,
- Дотоод, гадаадын худалдаачдад газар, байрыг харьцангуй хямд үнээр, урт хугацаагаар түрээслэж, ашиглуулах,
- Арилжааны оффшор банк санхүүгийн байгууллага байгуулж, дотоод, гадаадын худалдаачдын бэлнээр хийж буй валютын арилжааг бэлэн бус төлбөр тооцоонд шилжүүлэх үйлчилгээг нэвтрүүлэх /худалдаачид их хэмжээний бэлэн мөнгө биедээ авч явах бэрхшээлийг арилгах/,

- Гаалийн “ГАМАС”-т тулгуурлан, улс хоорондын худалдаа – мэдээллийн “интернет” сүлжээг буй болгох,
- ХЧБ-ийн хүрээнд ОХУ, БНХАУ, Казакстан Улстай хамтран ажиллах, харилцан дэмжлэг үзүүлэх хоёр ба гурван талын хэлэлцээрийг яаралтай байгуулах зэрэг болно.

2015 оноос цаашхи хугацаанд, зохих нөхцөл бүрдмэгц, чөлөөт бүсийн үйл ажиллагааг улс хоорондын дамжин өнгөрөх тээврийн үйлчилгээг хийх, экспорт, реимпортыг хөнгөвчлөх чиглэлээр “Гааль, худалдаа”-ны хосолсон үүрэг, бүтэцтэй бүс болгох, чөлөөт бүсийн удирдлагыг төр, хувийн хэвшлийн оролцоотой хувьцаат компани юм уу эсвэл олон улсын /хөрш орнууд оролцсон/ бизнесийн концерциум /үндэстэн дамнасан аж ахуйн нэгж/-оор Монголын Засгийн газартай байгуулсан менежментийн гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх асуудлыг зохистой хувилбараар судалж, шийдвэрлэх нь зүйтэй болно.

“Цагааннуур” ХЧБ-ийн үйл ажиллагаа тогтмолжиж, чөлөөт худалдааг аюул, эрсдэл багатай эрхлэх бизнесийн нааштай арга туршлага хуримтлуулмагц, Баруун бүсэд худалдаа, эдийн засгийн чөлөөт бүс /“Чөлөөт бүсийн тухай” хуульд зааснаар “хөдөө аж ахуй – агро аж үйлдвэр”-ийн хэв шинжийн/ байгуулах үйл ажиллагааг дараах хандлагаар шатлан өргөжүүлж, улс орны зах зээлийг тэлэх шаардлага гарч болох төлөв байна. Тухайлбал,

- Хөрш орнуудын худалдаачид олноор ирж, байнга оршин суух сонирхолтой байгааг харгалзан Булган /Ховдын/, Боршоо /Увсын/, Арцсуурь /Завханы/-ийн хил гаалийн боомтуудыг түшиглэн “чөлөөт худалдааны төв /боомт/” байгуулах, энэ асуудлыг БНХАУ, ОХУ-тай тохиролцон, тэдгээрийн хилийн боомт /Такашикэн, Хандгайт, Эрзин/-ыг чөлөөт бүсийн горимоор харилцан үр ашигтай байхаар ажиллуулах замаар шийдвэрлэж болох байна.

- Ховдын тулгуур төвд байгуулах аж үйлдвэрийн паркийг “хөдөө аж ахуй – агро үйлдвэрлэл”-ийн чөлөөт бүстэй адил татварын хөнгөлөлтийн горимоор ажиллуулж, тус төвийн дэд бүтцийн чадавхид түшиглэн БНХАУ, ОХУ-ын хоорондын барааг төвлөрүүлэн, авто болон агаарын тээврээр дамжуулан тэдгээр оронд болон Европ, Төв ба Дундад Азийн орнуудад хуваарилах “Төв Азийн эх газрын худалдааны боомт” болгон хөгжүүлэх боломжийг судлан тогтоох зэрэг болно.

Ингэснээр Баруун бүсээр дамжуулан хөрш орнуудтай бараа, бүтээгдэхүүн /хөрөнгө санхүү, техник, төхөөрөмж/-ий хэрэгцээгээ харилцан нөхөн хангах сүлжээ бий болж, улмаар “Хөрш орнуудын гааль татварын холбоо”, бүс нутгийн зах зээл бүрэлдэн эдийн засгийн хоршилт хөгжих үндэс суурь тавигдана гэж төсөөлж байна.

Энэ хэрэгт “CAREC”-ийн орнуудын хамтын ажиллагааны хөтөлбөр гол түлхэц болох учиртай. Гэхдээ, түүхий эдийг иж бүрэн боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулах үр чадвар багатай байгаа одоогийн нөхцөлд худалдааг либеральчлах үйл явцыг хил орчмын хязгаарлагдмал бүс нутаг /дээр дурдсан хилийн боомтын худалдаа, гаалийн чөлөөт бүсүүдийн хүрээнд/-ийн хүрээнд хэрэгжүүлж, гарч болзошгүй эрсдлийг сааруулах арга туршлагатай болоход эн түрүүнд анхаарах нь зүйтэй байна.

Манай тал нь Баян-Өлгийн Цагаан нуурт баруун бүсийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулахаар шийдвэрлэн шаардлагатай зарим арга хэмжээг авч эхэлж байна. Энэ боомт нь баруун бүсийн аймгуудыг ОХУ, БНХАУ, Дунд Азийн орнууд буюу Казах улстай илүү өргөн хүрээтэй харилцах боломж олгоно. Мөн цаашид Увсын Боршоо, Ховдын Ярантай, Говь-Алтайн Бургалтай зэрэг эдийн засгийн чөлөөт бүс байгуулах шаардлага гарч болзошгүй. Тэгэхдээ эдийн засгийн чөлөөт бүс бий болгох асуудал нь хөрш ОХУ, БНХАУ-аас голчлон хамаарахыг анхаарах хэрэгтэй.

Тувад төмөр зам ирэх болж буй явдал нь баруун аймгууд болон Хөвсгөл, Архангайд ОХУ-тай харилцах, улмаар худалдааг өргөтгөх шинэ боломж олгох болно. Өөрөөр хэлбэл Завханы хойд тал, Хөвсгөлийн баруун, баруун хойд талын сумдад Туватай харилцах шинэ боомт, дамжлага бааз байгуулах шаардлага гарна. Алсдаа тэнд худалдааны чөлөөт бүс бий болж мэднэ.

Баруун бүс нутагт аялал жуулчлалын нэгдсэн сүлжээ бий болгохын хамт аймаг бүрийн аялал жуулчлалын өвөрмөц сүлжээг бий болгох асуудлыг жигд боловсруулж шийдвэрлэн хэрэгжүүлж болно. Баруун бүс нь Увс, Хяргас, Хар ус, Хар нуур зэрэг олон нуур Ховд, Булган, Завхан, Буянт зэрэг олон голтой учир тэнд дотоодын усан замын тээвэр, аялал жуулчлал, загас үржүүлэг, агнуур зэргийг хөгжүүлэх боломжийг Хөвсгөл, Өгийн нуур зэргийн туршлагыг үндэслэн судалж цаашид дэс дараатай хэрэгжүүлэх нь зүйтэй.

Баруун аймгуудын нутагт Алтай, Хангайн сүрлэг уулс түүний дотор Алтай таван богд Цамбагарав, Сутай, Отгонтэнгэр зэрэг мөнх цастай, цасгүй сүрлэг уулс ихтэй учир бусад орны туршлагаар аялал жуулчлал спортын чиглэлээр дүүжин тээвэр хөгжүүлэх боломжийг судлах нь зүйтэй болов уу. Мөн Баруун аймгууд нь элс ихтэй тул тэнд элсний спортыг хөгжүүлэх асуудлыг судалж боловсруулах нь зүйтэй байж болох юм.

Баруун бүсийн хөгжлийн нэг гол асуудал нь уг бүсийн аж ахуй соёлын салбарт ажиллах боловсон хүчин бэлдэх явдал болно. Энэ зорилтыг биелүүлэхэд уг бүсэд Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн салбарыг нээж уг бүсийн хүмүүсийн бэлдэхийн хамт техник мэргэжлийн зарим сургууль байгуулах, хуучныг сэргээх шаардлагатай.

Баруун бүс нутагт Цагааннуур, Боршоо баг, Тус сумын төв, Алтай сумын төв, Булган сумын төвүүдэд гүний гааль худалдааны чөлөөт бүсүүдийг 2009-2015 онд байгуулах, Сутай хотод зам, тээвэр, аялал зуулчлал, агуулахын үйлчилгээ, гүний гааль худалдааны чөлөөт бүсийг 2015 оноос байгуулахаар төлөвлөж байна. Гүний гааль худалдааны чөлөөт бүсүүдэд ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл хийж, хүчин чадал үүрэг зориулалтыг нь тодорхойлно.

### 6.1.3.3 Гадаад харилцаа, бүс нутгийн зөвлөл

Баруун бүс нутаг нь эдүгээ доорх чиглэлээр ОХУ, БНХАУ-тай ердийн болон хэсэгчилсэн засмал замаар харилцаж дотоод гадаад харилцаа, худалдааныхаа гол үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

1. Баян-Өлгийн Цагаан нуурын Улаанбайшинт – алтайн хязгаарын Ташаант
2. Баян-Өлгийн Алтай сумын Даяннуур Хятадын
3. Увсын Үүрэг нуу – Хангын гол
4. Увсын Боршоо – Тувагийн Хандгайт
5. Увсын шар суурь Тувагийн Тэс
6. Завханы Арц суурь Тувагийн Цагаан толгой
7. Ховдын Ярантай – Хятадын Такашен
8. Ховдын Байтаг – Хятадын Улиастай
9. Говь-Алтайн Бургастай – Хятадын Ляонмуу

Эдгээр чиглэлээс Увсын Улаангом хот нь Боршоо – Хандгайт чиглэлээр ОХУ-тай засмал замаар холбогдоод байгаа ба Улаангом – Ховд – Булган чиглэлийн 781.4 км зам, Ховд - Өлгий – Цагаан нуур чиглэлийн 350 км засмал замыг олон улсын чиглэлийн засмал зам гэж үзэн ойрын 5-7 жилд бүрэн хатуу хучилттай болгох юм.


Баруун аймгуудыг төвийн районтай холбох засмал зам нь Мянганы замын бодлого, Чиглэлийн дагуу доорх хоёроос гурван чиглэлтэй байж болно. Үүнд:

1. Улаанбаатар - Өвөрхангай – Баянхонгор – Говь-Алтай – Ховд – Баян-Өлгий – Цагаан нуур
2. Улаанбаатар – Эрдэнэт – Булган – Мөрөн – Хөвсгөлийн Цэцэрлэг – Хан хөхийн ар – Улаангом
3. Улаанбаатар – Лүн – Хархорин – Архангай – Солонготын даваа – Тосонцэнгэл – Завхан – Хомын тал- Сутай – Ховд – Баян-Өлгий – Цагаан нуур

Эдгээрээс гадна Архангайгаас Тосонцэнгэл орох замаас Архангайн Чулуутыг дайрч Эгийн даваагаар даван Баянхонгорын баруун тал, Алтай – Улиастай орох замыг засах, хэт нь зам тавих шаардлага гарч болох юм. Энэ чиглэл нь байгалийн үзэсгэлэнтэй, сүр жавхлан төгсөөс гадна Архангай, Баянхонгор, Завханы зааг дахь төрөл бүрийн баялгийг ашиглах, аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж олгоно.

Мөн Завхан аймгийн Улиастай хот, улмаар Говь-Алтайн Бургастай, Завханы Арц суурьтай холбох босоо тэнхлэгийн авто замыг барих шаардлага гарна. Цаашид Ховдоос Байтаг, Баян-Өлгийгөөс Алтай Сумын Даян нуур хүртэл засмал тавих шаардлага гарна.


#### Бүс нутгийн удирдлага зохион байгуулалтын одоогийн байдал /Схем 6.1/



БАРУУН БҮС НУТГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ХӨГЖИЛ

М 1:1 500 000

Зураг 6.2



ТАНИХ ТЭМДЭГ

- Аймгийн төв
- Сумын төв
- Хилийн боомт
- Төлөвлөж буй чөлөөт бүсийн төв
- Улсын чанартай автозам
- Гол
- Ширгэдэг гол
- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил
- Цэнгэг нуур
- Давстай нуур

Төлөвлөж буй чөлөөт бүс

- Цагаан нуур - Гүний гааль худалдааны чөлөөт бүс
- Боршоо - Хилийн худалдааны чөлөөт бүс
- Тэс - Гүний гааль худалдааны чөлөөт бүс
- Сутай хот - Шинжлэх ухаан, технологи, зам, тээвэр, аялал жуулчлал, гүний гааль худалдаа, металлурги, агуулахын үйлчилгээний чөлөөт бүс
- Булган - Гүний гааль худалдааны чөлөөт бүс
- Алтай - Гүний гааль худалдааны чөлөөт бүс




**Бүсчилсэн хөгжлийн үндэсний хорооны дарга нь:**

Ерөнхий сайд, орлогч дарга нь бүс нутгийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн байх бөгөөд хорооны бүрэлдэхүүн Засгийн газрын гишүүн байх бөгөөд хорооны бүрэлдэхүүн Засгийн газрын хэрэг эрхэлсэн газрын дарга болон Яамны сайд нар, бүсийн зөвлөлийн дарга нар орно. Үндэсний хороо нь ажлын албатай байх бөгөөд энэ үүргийг шадар сайдын ажлын алба хэрэгжүүлнэ.

**Бүсийн зөвлөл нь:**

Бүс нутгийн хөгжлийн талаарх төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бүсийн нийгэм эдийн засгийн асуудлыг зохицуулах чиг үүрэг бүхий байгууллага юм. Бүсийн зөвлөлийн бүрэлдэхүүнд зөвлөлийн дарга тухайн бүсэд багтаж буй аймгийн засаг дарга, бүсийн тулгуур төв хотын захирагч нарын болон аймгийн ИТХ, төрийн бус байгууллага, томоохон хөрөнгө оруулагч байгууллага. Зөвлөлийн даргын бүрэлдэхүүнийг тухайн бүсэд багтах аймгийн засаг дарга нараас Монгол Улсын Ерөнхий сайдын томилсон засаг дарга нар хэрэгжүүлнэ. Зөвлөлийн бүрэлдэхүүнд орох гишүүдийг Ерөнхий сайд батална.

Баруун бүсийн зөвлөлийн удирдлагын тогтолцоо / Схем 6.2 /



Баруун бүс нутаг нь үзэсгэлэн төгс байгальтай, хүн зонин нь амьдрал ахуй, соёл урлаг өвөрмөц онцлогтой, түүх соёлын дурсгалт зүйл, эрдэс баялаг ихтэй, зэргэлдээх Тувагийн Кызыл, Алтайн хязгаарын Бийск олон улсын нисэх онгоцны буудал баригдсан, Ховдын нисэх онгоцны буудлыг өргөтгөж Өрөмч, Мөрөнгийн хооронд нислэг үйлдэх, Ази Европыг холбосон агаарын шинэ зам Увс, Ховд, Говь-Алтайгаар дайрч, баруун бүс ойрын 2-3 жилд засмал зам тавих асуудал эрчимтэй өрнөх эхлэл тавигдсан.

Баруун бүсэд очих жуулчид, түүний дотор анчид нь Европ, Америк тивээс урдаар Улаанбаатарт ирээд дараа нь баруун бүс рүү явдаг. Тиймээс Европ, Америкын жуулчдыг Алтай, Кызыл, Өрөмчийн чиглэлээр шууд баруун бүсд урдаар хүлээж авах ба дараа нь Хөвсгөл, говь талыг үзүүлэх хувилбар байж болно.

Завханы урд, хойд талаар хэдэн зуун км үргэлжилсэн их манхан элс байдгаас гадна Увс аймгийн Ханхөхийн ар, Тэсийн голын урд талаар Бориг дэлийн их элс бий. Увс нуурын хотгорын говийг дэлхийн хамгийн хойд талын говь гэж үздэг ба Бориг дэлийн элсийг хорвоогийн хамгийн хойд талын их молцог элс гэж үздэг.

Мөн баруун бүс нутагт таван хошуу малаас гадна илжиг, сарлаг, бүргэд зэрэг тэжээвэр амьтдаас гадна дэлхийд нэн ховор бөхөн, хавтгай, ирвэс, шилүүс, цоохондой, ёл, хойлог зэрэг амьтад байдгаас гадна сүүлийн үед Говь-Алтайн тахийн талд тахь, Хомын талд цагаан зээр тавьсан нь өсч үржих хандлагатай болж байна.

Баруун бүс нь Монголын олон үндэстний өлгий нутаг бөгөөд тэндхийн амьдрал ахуй, урлаг соёл нь хаана ч байхгүй өвөрмөц онцлогтой. Баруун бүсэд унаган төрхөөрөө байгаа онгон дагшин уулс, хангай, говь цөл хосолсон үзэсгэлэнт сүрлэг байгал, олон үндэстэн ястны өвөрмөц ахуй, зан үйл, түүх, соёлын эртний дурсгалууд зэрэг дотоод, гадаады зочид жуулчдыг татах ихээхэн нөөц боломж байна. “Аялал жуулчлалын 2015 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө “-нд Баруун бүсийг байгалийн аялал жуулчлал хөгжүүлэх сонирхол татахуйц бүс болгохоор тусгажээ.

1996 онд ЮНЕСКО-гоос Ховд хотын дэргэдэх Ямаат улаан гэдэг нүцгэн улаан буурал уул, Манхан сумын нутаг дахь Хойт Цэнхэрийн агуй, мөн Дархан цаазат Отгонтэнгэр уулыг “ Дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох нь” зэрэглэлээр дэлхийн соёлын өвд бүртгэж авсан байна. Мөн 1997 онд Увс нуурын ай савын дархан цаазтай газрыг дэлхийн шим мандлын нөөц газрын сүлжээнд хамруулан авчээ.

Улаангом хотын Чандман улаан уулын археологийн олдвор нь эртний түүх, соёлын нандин өвд зүй ёсоор тооцогддог. Эдгээрийг дэлхий дахинд өргөн сурталчилж, жуулчдын сонирхлыг татах олон талт ажлын зохион байгуулах шаардлагатай байна.

Монгол орны үзэсгэлэнт байгаль, баруун Монголын олон ястны амьдрал ахуй зэргийг сонирхуулах өргөн боломжтой. Зэгс, хулсан шагшуурга дундуур завиар аялан, ховор жишүүртэн шувууд болон усны амьтдыг үзэх, загасчлах чиглэлээр Увс нуур, мөн Хар-Ус нуурын өмнөд эргээр аялал жуулчлалын бааз байгуулах нөөц байна. Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн Алтай-таван богд, Цамбагарав, Цэнгэлхайрхан, Мөнххайрхан Цагаан дэглий, Цагаан шувуут, Түргэний нуруу, Хархираа, Хангилцаг зэрэг түргэн урсгалт голуудаар, мөн Ховд аймгийн Хар-Ус нуурын хойд эргээр усан спорт хөгжүүлэх боломж бас байна. Баруун бүсэд түүх-археологийн болон шашин угсаатны зүйн чиглэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломж байна.

Иймд Баруун бүсэд төрөл бүрийн аялал жуулчлалыг үндсэн ба туслах маршрутаар хөгжүүлэх эдийн засагт мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг салбар болгон хөгжүүлэх шаардлагатай байна.

Баруун бүс нутгийг хөгжүүлэх үндсэн бүтэц зохион байгуулалт буруу байгаа гэж бид дүгнэж байгаа юм. Бүсийн хүрээнд хийгдэх ажил засгийн газраас багийн төв, хөдөө оршин суугчдад хүрэхэд олон шат дамжлагатай нилээд хүнд систем юм.

Бүсүүд хоорондоо өрсөлдөх, гадаад орон, хөрш орнуудтай харилцан ашигтай хамтран ажиллах нөхцөл бүрдүүлэх шаардлагатай байна. Бие дааж чөлөөт өрсөлдөөний замаар сөрөг шүүмжлэл хүлээн авч эдийн засгийг хөгжүүлэх, байгаль экологийг хамгаалах явдал юм.

## 6.1.4 Дэд бүтцийн сүлжээний төлөвлөлт

### 6.1.4.1 Цахилгаан эрчим хүч

Монгол улсын бүсчилсэн хөгжлийн хөгжлийн үзэл баримтлалын зорилго нь шинэ зуунд тус улсын газар, түүний нөөц баялгийг оновчтой ашиглах үндсэн дээр хот хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах, аймаг бүс нутгийн хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг арилгах, үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх нутаг дэвсгэрийн бүтэц, зохион байгуулалтын дотоод, гадаад таатай орчин бүрдүүлэхэд оршино.

Монгол улсын эрчим хүчний нэгдсэн системд баруун таван аймгийг эрчим хүчээр найдвартай хангах төлөвлөлт:

1. Говь-Алтай аймгийн нутагт Завхан гол дээр 8 МВт хүчин чадалтай Тайшир /Улаанбоом/-ын УЦС барилга угсралтын ажил бүрэн дууссан. Усны түвшин хүрэлцээгүй учраас генератор нь ажилаагүй.
2. Тайширын УЦС-аас Завханы төв Улиастай хүртэл 110 кВ-ын 120км шугам баригдсан ч ашиглалтанд ороогүй байна.
3. Говь-Алтай аймгийн төв Алтай хот 110 кВ-ын 47км шугам барьсан.
4. Ховд аймгийн нутагт орших Чоно харайх гол дээр 12 МВт хүчин чадалтай Дөргөний УЦС одоогоор 2008-5-20нд эхний генераторийг ажилууллаа.
5. 110 кВ-ын 72 км шугам татаж, Дөргөний УЦС-ыг Мянгатын дэд станцтай холбоно.
6. Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэр дээр салхин станц барьж, системд холбож асуудлыг судалж шийдвэрлэнэ.
7. Завхан, Говь-Алтай аймгийг холбосон цахилгаан эрчим хүчний шинэ систем байгуулна. Энэ системийн онцлог нь эрчим хүчний эх үүсвэрийн бүтэц нь зөвхөн Усан цахилгаан станц байгааг өөрчилж, төвийн эрчим хүчний системд холбох, атомын цахилгаан станц байгуулна.

Монгол улсын эрчим хүчний нэгдсэн системд баруун таван аймгийг эрчим хүчээр найдвартай хангах зорилгоор 2012-2021 онуудад Баруун бүсэд:

1. Ховд гол дээр Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг үе шаттай барина.

Эрдэнэбүрэнгийн УЦС-ын ач холбогдол, барих үндэслэл нь :

- Хамгийн хямд үнэтэй цахилгаан үйлдвэрлэнэ. /Азийн хөгжлийн банкны тусламжаар 1995 онд хийгдсэн Эрчим хүчний мастер төлөвлөгөөнд Эрдэнэбүрэнгийн УЦС-ын цахилгааны өөрийн өртгийг 4.8 цент/кВт.ц буюу өнөөгийн ханшаар 52.6 төг/кВт.ц байхаар тусгажээ/. Энэ хямдхан цахилгаан эрчим хүчийг борлуулах өргөн зах зээл гаргаж чадвал хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 8.5 жилээс бага байна.

- Баян-Өлгий аймгийн Асгатын мөнгөний ордыг ашиглаж, хязгаар нутгийг хөгжүүлэх нь Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг барих гол үндэс болно.

- ОХУ-тай хил залгаа “Цагааннуур” боомтод худалдаа, гаалийн чөлөөт бүс байгуулж, худалдаачид, хөрөнгө оруулагчид харилцан ашигтай, хамтран ажиллах бизнесийн орчин бүрдүүлнэ.

- Баруун бүсийн 5 аймгийг харьцангуй хямдхан цахилгаан эрчим хүсээр хангах замаар зах хязгаар нутгийн иргэдэд сурч боловсрох, ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлж, төв рүү тэмүүлсэн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах ач холбогдолтой.

- Ховд гол дээр УЦС барих асуудлыг судлах

- Мянганы замын дагуух хэрэглэгчдийг хямд цахилгаанаар хангах, хэвтээ, босоо тэнхлэгийн төмөр замыг цахилгаанжуулна.

- Эрдэнэбүрэнгийн УЦС-ын цахилгаан эрчим хүчний гол хэрэглэгчид нь Баян-Өлгий, Ховд, Увс, баруун бүсийн сумд.

2. Эрдэнэбүрэнгийн УЦС-аас Ховдын Мянгатын 110кВт-ын хүчдэлтэй дэд станц хүртэл 220кВ-ын хүчдэлтэй 62км шугам татаж, Мянгатын дэд станцыг өргөтгөж холбоно.

Монгол улсын эрчим хүчний нэгдсэн системд баруун таван аймгийг эрчим хүчээр найдвартай хангах зорилгоор 2022-2040 онуудад Баруун бүсэд:

1. Дөргөний УЦС болон Улиастай хот хооронд 320 км урт 220кВ-ын шугам татаж баруун бүсийн нэгдсэн систем байгуулна.

2. Энэ шугамыг зориулалтаар нь:

- Завхан аймгийн Алдархаан сумын нутагт орших Фосфоритын, Эрдэнэхайрхан сумын нутагт байдаг зэсийн ордуудыг ашиглах, баруун бүсийн төв болон Завхан, Говь-Алтай аймгийг хөгжүүлж, цахилгааны хэрэглээ өсөх тохиолдолд Тайширын УЦС-ын хүчин чадал хүрэлцэхгүй болно. Хүчин чадлын энэ дутагдлыг нөхөх, бэлтгэл хүчин чадал бий болгоно.

- Завхан, Говь-Алтай аймгийн эрчим хүчний үнийг Хангай, Төвийн бүсээс хямдруулах замаар тус аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийг түргэтгэх, нийт иргэдэд сурч боловсрох, ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлж, төв рүү тэмүүлсэн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлана.

- Нүүрс түлшний нөөцгүй Завхан, Говь-Алтай аймгийн орон нутгийн дулаан хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд хямд үнэтэй цахилгаан эрчим хүчийг ашиглана.

- Мянганы замын дагуу суурьших төв суурин газрыг цахилгаанжуулна.

- Алс ирээдүйд баригдах Баянхонгор-Алтай-Ховд-Өлгийгээр дамжиж баруун хил гарах хэвтээ тэнхлэгийн төмөр замыг цахилгаанжуулна.

- Мөн замын дагуу урьд талаар нь байршсан нефтийн ордуудыг ашиглах тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалт орж ирэхэд шаардагдах орчин нөхцөл бүрдэнэ.

- Баруун бүсийн таван аймгийн цахилгаан эрчим хүчний хамгийн үр ашигтай нэгдсэн системийг ашиглах үндэслэл нь эрдэс баялагийг ашиглах явдал юм.

- Баруун бүсийн системтэй Хангайн болон Төвийн эрчим хүчний системийг холбох боломжийг ойртуулах ач холбогдол эрдэс баялагийг ашигласнаар тодорхойлогдож байна.

3. Баруун бүсийн таван аймгийг холбосон эрчим хүчний нэгдсэн систем байгуулагдана. Энэ системийн онцлог ач холбогдол нь цахилгаан эрчим хүчийг 100 хувь зөвхөн УЦС-/Завханы богдын гол, Говь-Алтайн Тайшир, Ховдын Чоно харайх, Эрдэнэбүрэн/-д үйлдвэрлэх юм.

4. Баруун бүсийн төвийг Улиастайтай, Хангайн бүсийг Баянхонгортой холбосон 330км урт, 220кВ-ын хүчдэлтэй шугам татаж, Баруун, Хангай, Төвийн бүсийн эрчим хүчний нэгдсэн систем байгуулна.

5. Баруун бүсийн эрчим хүчний нэг ач холбогдолтой хувилбар нь Цэцэрлэг хотын эрчим хүчний шугаманд Улиастай хотоор дайруулан холбох, Тэлмэнгээс одоо байгаа шугамыг өргөтгөж холбоно.

### **Дулааны цахилгаан станц**

Баруун бүсийг цахилгаанаар хангах хамгийн найдвартай эх үүсвэр нь нүүрсний уурхайнуудыг түшиглэн дулааны цахилгаан станц байгуулах явдал юм. Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглэн дулааны цахилгаан станц байгуулах нь нэн чухал ач холбогдолтой юм. Хөшөөтийн нүүрсний уурхайн химийн найрлага нь дулааны цахилгаан станц байгуулахад нэн тохиромжтой бөгөөд Засгийн газраас дулааны цахилгаан станц байгуулах талаар судалгаа хийж байгаа нь хойшлуулашгүй зорилт юм. Баруун бүсийг эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болгон хамгийн хямд цахилгаанаар хангах нь эрчим хүчний доголдолтой байдлаас гарах үндэслэл болно.

Шинээр байгуулагдах Сутай хот, бусад хотуудыг эрчим хүчний болон дулааны энергээр хангахаар төлөвлөж, нүүрсийг шууд түлдэг технологийг өөрчилж химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь тохиромжтой.

*Баруун бүсийн алслагдсан сумдын цахилгаан хангамж*

Хөдөөгийн сумдад дан ганц дизель цахилгаан станц ажиллуулж, жил бүр гадаадаас өндөр үнэтэй түлш худалдан авч, газар дээр нь тээвэрлэн хүргэх үлэмж зардал гарган байж цөөн цагийн гэрэлтүүлэг төдий асуудлыг шийдээд, үнэн хэрэг дээрээ сумдыг хөгжүүлэх боломжийг бүрдүүлээгүй

байсан олон жилийн үйл ажиллагаанаас сургамж авч дизель цахилгаан станцаас аль болохоор татгалзах бодлого баримтална. Сумдын цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд дараах 2 зарчмыг баримтална.

1. Боломжтой бүх сумдыг төвлөрсөн системд холбох
2. Алслагдсан сумдыг дизель-ус, дизель- салхи, дизель-нар гэх мэт эрчим хүчний хосолсон шинэ эх үүсвэрээр хангах.

**Баруун 5 аймгийн алслагдсан эрчим хүчний системд холбох боломжгүй сумд /Хүснэгт 6.12/**

| № | Аймаг      | Станцын нэр    | Дизель генераторын тоо хүчин чадал | Тайлбар   |
|---|------------|----------------|------------------------------------|---|
| 1 | Завхан     | Ургамал сум    | 150 кВт                            | Дэлхийн банкны буцалтгүй тусламжаар нарны эрчим хүчээр хангах |
| 2 |            | Дөрвөлжин сум  | 150кВт                             |   |
| 3 | Ховд       | Цэцэг сум      | 200кВт                             |   |
| 4 | Говь-Алтай | Алтай сум      | 200кВт                             |   |
| 5 |            | Баянтоорой сум | 100 кВт                            |   |
| 6 |            | Бугат сум      | 150 кВт                            |   |
| 7 |            | Цээл сум       | 150 кВт                            |   |

Баруун бүс нутагт дулааны цахилгаан станцын төлөвлөлтийн хүрээнд дараахь үйл ажиллагааг төлөвлөв.

1. Могойн голд ДЦС барьж 220кВт-ын шугамаар Улиастай болон Алтай хотуудыг холбох
2. Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглүүлэн ДЦС барьж, эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр Ховдш, Баян-Өлгий, Увс аймгуудыг хангана.
3. Нүүрс хотгорт бага оврын ДЦС, нүүрс-химийн үйлдвэр барих асуудлыг хөрөнгө оруулалтын оролцоотой шийдвэрлэнэ.
4. Таяннуурт баригдах ДЦС-ыг түшиглүүлэн нүүрс-хими, шингэрүүлсэн хий, шатахуун нэрэх, химийн үйлдвэр хөгжүүлэх бүх бололцоог хэрэгжүүлнэ.
5. Эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болох асуудлыг олон талаас нь авч үзсэн боловч атомын цахилгаан станцыг Сутай хотын орчинд байгуулах нь зүйтэй гэсэн саналыг “Цөмийн энергийн газар”-т тавьж дэмжлэг авч төрийн бодлогын түвшинд шийдвэрлүүлэхээр энэ төсөлд оруулав.

**6.1.4.2 Холбоо мэдээллийн систем, төлөвлөлт**


Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн ололтыг нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт амжилттай нэвтрүүлснээр “Шинэ эдийн засаг”-ийг бий болгох, улмаар “Мэдээлжсэн нийгэм” байгуулах үндэс суурийг бүрдүүлнэ гэж үзэж байна. Иймээс ч мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарыг хөгжүүлэх асуудлыг УИХ, Засгийн газраас төрийн бодлогын тэргүүлэх чиглэл болгон ач холбогдол өгч байгаа болно.

Мэдээлэл, харилцаа холбооны технологи /МХХТ/-ийг Монгол Улсын 21 дүгээр зууны хөгжлийн үндсэн хурдасгуур гэж үзэж, Монгол Улсад мэдлэг оюунд тулгуурласан мэдээлэлжсэн нийгмийг байгуулах зорилгоор хэрэгжүүлж байгаа “Цахим Монгол” үндэсний хөтөлбөрт тулгуурлан баруун бүст МХХТ-ийг хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг дараах байдлаар тодорхойлж байна.

# Цахилгаан эрчим хүчний төлөвлөлт

Зураг 6.3

М 1: 1 500 000



## Таних тэмдэг

- Аймгийн төв
- Сумын төв
- Хилийн боомт


### Одоо байгаа:

- Дизель станц
- Усан цахилгаан станц
- 110 кВт-ын цахилгааны шугам
- 35 кВт-ын цахилгааны шугам
- 15 кВт-ын цахилгааны шугам
- 6, 10 кВт-ын цахилгааны шугам
- Гол
- Ширгэдэг гол
- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил
- Цэнгэг нуур
- Давстай нуур

### Төлөвлөж буй:

- Нар-салхи-дизель хосолсон станц
- Нар-дизель хосолсон станц
- Усан цахилгаан станц
- ★ Баруун бүсийн хөгжлийн төв хот
- Дулааны цахилгаан станц
- Атомын цахилгаан станц
- 220 кВт-ын цахилгааны шугам
- 110 кВт-ын цахилгааны шугам
- 35 кВт-ын цахилгааны шугам
- 15 кВт-ын цахилгааны шугам
- 6, 10 кВт-ын цахилгааны шугам

Өндрийн шатлал /метр/



### Дэд бүтэц

1 Орон нутагт мэдээлэл холбооны технологийн хоцрогдлыг (тоон ялгаа) арилгах, бүх нийтийг тэгш эрхтэйгээр мэдээлэл холбооны сүлжээнд холбох, төрөл бүрийн үйлчилгээ хүртэх боломжийг бүрдүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор баруун бүсийн 5 аймгийн бүх сумдыг шилэн кабелийн суурь сүлжээнд холбох

2 Холбогдсон шилэн кабелийн суурь сүлжээг ашиглан баруун бүсийн бүх аймаг, сумын төвийг өгөгдлийн сүлжээний тоног төхөөрөмжийг суурилуулах замаар интернэт сүлжээнд холбох

3 Нээлттэй засаглалыг хөгжүүлэх, засаглалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, засаглалын үйл ажиллагааг түргэн шуурхай болгох үүднээс электрон засаглалд шилжих бэлтгэл ажлыг хийж дуусгах, төрийн мэдээллийн найдвартай дэд бүтцийг бий болгох, программ хангамжтай болох, төрийн мэдээллийн электрон сан байгуулах, мэдээллийн хадгалалт, урсгалыг электрон хэлбэрт оруулах загвар, журмыг боловсруулан нэвтрүүлэх

### Үйлчилгээ, хэрэглээний төлөвлөлт 2009 - 2015 он

1. Аймаг, сумын төвийн интернэтийн сүлжээг ашиглан аймаг, сумын Засаг даргын тамгийн газар, татвар, гааль, нийгмийн даатгал, эмнэлэг, дунд сургууль зэрэг бүх төр болон төрийн бус байгууллагуудад интернэт нэвтрүүлэх

2. Иргэдэд мэдээллээр үйлчлэх төв буюу интернэтийн төвүүдийг бүх аймаг, сумын төвүүдэд байгуулах

3. Цахим боловсролыг хөгжүүлэх чиглэлээр бүх нийтийг компьютержүүлэх хөтөлбөр, хүүхэд бүрт зөөврийн компьютер хөтөлбөрт идэвхитэй оролцох замаар бүх сургуулиудыг суурин болон зөөврийн компьютерээр хангах

4. Цахим засаглалыг хөгжүүлэх чиглэлээр бүх байгууллага, аж ахуйн нэгжийг интернэт хуудас болон электрон хаягтай болгох, мөн төрийн албан хаагчийг мэдээллийн технологийн сургалтад хамруулах, сургалтыг сертификаттай сургалтын төвүүдээр дамжуулан зохион байгуулах

5. Цахим эрүүл мэндийг хөгжүүлэх чиглэлээр теле-оношлогоо, эмчилгээ, үйлчилгээний чиглэлээр туршилтын төсөл хэрэгжүүлэх

6. Цахим арилжааг хөгжүүлэх чиглэлээр хот, аймгийн төвүүдийг холбосон малын бирж байгуулах замаар орон нутгийн малчдад малаа чөлөөтэй арилжаалах, малын үүлдэр угсааг сайжруулах, солилцоо хийх боломжийг бүрдүүлэх

7. Малчдад мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хүргэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлын хүрээнд бүсийн бүх сумдад хөдөлгөөнт холбооны үйлчилгээг нэвтрүүлэх

8. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохицуулах төрийн интранет порталыг бий болгох

9. Нэгдсэн кодчлол хөтөлбөрийн хүрээнд гудамж, талбай, албан байгууллага, айл өрх бүрийг хаягжуулж, шуудангийн бүсийн тогтолцоонд шилжүүлэх

10. Төрийн үйлчилгээний үр өгөөж, чанар, хүртээмж, шуурхай байдал, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлж цахим-татвар, цахим-гааль, цахим-бичиг хэрэг зэрэг төсөл хэрэгжүүлж бүх салбарыг хамарсан цаасгүй онлайн үйлчилгээ бий болгох

### 2015-2021 он

Холбооны үйлчилгээнд тоон системийг бүрэн нэвтрүүлж, хиймэл дагуулын болон бага багтаамжийн радио релейний шугам, хөдөлгөөнт холбоог ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулна. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Орон нутгийн мэдээлэл, холбооны сүлжээний технологийн шинэчлэлийг дуусгах
- Баруун бүсийн алслагдсан бүс нутгуудад утасгүй холбооны технологийг нэвтрүүлж бүрэн телефонжуулах
- Сумын төв, багийн төвүүдийг шилэн кабелийн сүлжээнд өргөнөөр холбох
- Үүрэн телефон хэрэглэх сонирхолтой хүн амын хэрэгцээг
- Интернетийн сүлжээг сум, багийн түвшинд өргөтгөж, компьютер, интернет хэрэглэгчдийн хэрэгцээг бүрэн хангах

Мэдээлэл, харилцаа холбооны технологийг бусад салбарын хөгжлийг дэмжих хэрэгсэл болгон хөгжүүлэх, тэдгээрийн ажлын уялдааг сайжруулах, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх өнөөгийн бүтэц зохион байгуулалтыг өөрчлөн, салбар дамнасан бүтцэд шилжүүлэн үйл ажиллагааны үр нөлөө өгөөжийг дээшлүүлэх асуудалтай уялдсан стратегийн бодлого зохицуулалтыг шуурхай

удирдамжаар хангах, ирээдүйд мэдээлжсэн нийгэм байгуулах стратегийн хэтийн зорилтуудыг тодорхойлж хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласаар байгаа билээ. Харин баруун бүсийн хувьд Улаанбаатар хотоос хэт алслагдсан байдаг учир энэ салбарын хөгжил төдийлөн хангалттай бус байна. Харин сүүлийн жилүүдэд үүрэн телефоны компаниуд /Мобиком, Скайтел, Юнител, Жи мобайл/ сүлжээгээ олон сумдад оруулаад байгаа билээ.

Ингэснээр холбоо харилцаа хөгжиж мөн үүнтэй уялдаатайгаар өндөр хурдны интернет ашиглах боломжтой болоод байгаа юм. Иймээс бүх сумдад үүрэн телефоны сүлжээг суурилуулах нь нэн тэргүүнд шаардлагатай юм.

Баруун бүсэд VSAT сансрын станц байгуулахаар төлөвлөж байгаа билээ. Цаашид Интерсат сансрын станцыг суурилуулж харилцаа холбоог өргөтгөх шаардлагатай. Ингэснээр 24 цагийн телевизийн нэвтрүүлэг хүлээн авах боломжтой болно.

Мөн цаашид өндөр хурдны интернетийн сүлжээ, гар утасны холбоо мэдээллийн системийг өргөтгөх ажлуудыг шат дараалан зохион байгуулалттай авах нь зүйтэй. Ялангуяа үүрэн телефоны 4 компаний сүлжээг өргөтгөх шаардлагатай. Одоогоор баруун таван аймагт үүрэн телефон хэрэглэгчид ойролцоогоор 15 хувь эзэлж байгаа ба үүнийг цаашид нэмэгдүүлэх ажлыг шат дараалан хийх нь зүйтэй. Мэдээлэл нь даяарчлалын нэг гол хэрэгсэл болж XXI зууныг Мэдээллийн зуун болгосон өнөө үед Монгол улс түүний хөгжилтэй хөл нийлүүлэн алхах нь зүйтэй.

**Баян-Өлгий аймаг** нь одоогийн байдлаар нийт сумдын 14% нь шилэн кабелийн сүлжээнд холбогдсон бол төслийн хэрэгжих хугацаанд 86% хүргэхээр төлөвлөж байна.

**Увс аймаг** нь одоогийн байдлаар нийт сумдын 63 хувь шилэн кабелийн сүлжээнд холбогдсон бол төлөвлөлтийн хугацаанд нийт сумын 84% шилэн кабельд холбохоор төлөвлөөд байна. Мөн тус аймгийн Өндөрхангай сумын нутагт VSAT сансрын холбооны станц шинээр байгуулахаар төлөвлөж байгаа билээ

**Ховд аймаг** нь одоогийн байдлаар нийт сумын 12 хувь нь шилэн кабелийн сүлжээнд холбогдсон бол төлөвлөлтийн хугацаанд 82 хувьд хүргэхээр төлөвлөж байна.

**Говь-Алтай аймаг** нь одоогийн байдлаар нийт сумдын 11 хувь нь шилэн кабелийн сүлжээнд холбогдсон бол төлөвлөлтийн хугацаанд 67 хувь холбохоор төлөвлөж байна. Мөн тус аймгийн Цээл суманд VSAT сансрын холбооны станц шинээр байгуулахаар төлөвлөж байгаа билээ.

**Завхан аймаг** нь одоогийн байдлаар 54 хувь нь шилэн кабелийн сүлжээнд холбогдсон бол төлөвлөлтийн хугацаанд 100 хувь холбох боломжтой юм.

### ***Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, хэрэгжүүлэх томоохон зорилт, арга хэмжээнүүд***

Баруун бүсийн мэдээллийн технологийг өргөжүүлсэнээр:

- Цаасан дээр хадгалагдаж байгаа мэдээллийг тоон хэлбэрт оруулах
- Электрон үйлчилгээг өргөжүүлэх
- Банкны үйлчилгээ
- Электрон худалдаа
- Зайны сургалт
- Зайны оношлогоо
- Электрон ном
- Тоглоом
- Видео дүрс зэрэгт орчин үеийн технологийг ашиглах
- Шинжлэх ухаан технологийн үйлчилгээ авах
- Төрөл бүрийн монгол мэдээлэл бий болгох /дотоод агуулга/
- Төрөл бүрийн гадаад мэдээлэл бий болгох /гадаад агуулга/

#### **6.1.4.3 Унд ахуйн усан хангамж**

***Ус хэрэглээний одоогийн байдал, ашиглалт, хамгаалалт***

Монгол орны баруун хязгаар / Алтайн бүс / нь байгалийн нөөц баялаг ихтэй ялангуяа усны эрчим хүчийг ашиглах боломжтой. Монгол орны нийт усны нөөцийн 27 хувь, гадаргын усны нөөцийн 25.4 хувь энэ бүс нутагт ноогддог байна. Гэвч гадаргын болон гүний усны хуваарилалт нутаг бүрт харилцан адилгүй, говийн бүсэд усны дутагдал байнга гарч байна. Усны хэрэг эрхлэх газраас 2007 онд хийсэн гадаргын усны тооллогын дүнгээс үзэхэд гол горхи, булаг шандын 4,5 хувь, нуур цөөрмийн 13,2 хувь нь ширгэсэн дүн гарч байна.

Монгол оронд нийгмийн тогтолцоо бүхэлдээ өөрчлөгдөж зах зээлийн харилцаанд шилжин орж, төвлөрсөн төлөвлөгөөт улс ардын аж ахуйн хэвшлээс өмчийн олон хэвшилт аж ахуйд шилжих явцад усны аж ахуйн салбарын асуудлыг оновчтой шийдвэрлэж чадаагүйгээс хэдэн арван га талбай хамарсан усалтын систем, олон арван худаг ус үрэн таран болж, хэвийн ажиллаж байсан цэвэрлэх байгууламжууд ашиглалтгүй болсноор байгаль орчинд багагүй хохирол учруулж, бэлчээрийн талхлагдал, газар тариалангийн үйлдвэрлэлийг уналтад хүргэсэн юм.

Монгол улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдан усны бодлого шинэчлэлийг эрчимжүүлж гол, мөрний сав газрыг хамгаалах, усыг зүй зохистой ашиглах, хэрэглээг зохистой болгох, усны барилга байгууламжийн тоо, ус ашиглалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч байгаа боловч Говь-Алтай, Завхан, Ховд, Увс аймгийн дүнг / Баян-Өлгий аймгийн дүн бүрэн бус / нэгтгэн үзэхэд 1990 оны эх гэхэд инженерийн хийцтэй 2783 худаг, энгийн уурхайн 1051 худаг байсан бол 2003 онд инженерийн хийцтэй 1777 худаг, энгийн уурхайн 557 худаг болж цөөрсөн байна. 2007 оны тооллогоор инженерийн хийцтэй 1436 худаг, энгийн уурхайн худаг 3099 болж тоологдсон байна.

Усан хангамжгүйгээс шалтгаалан бэлчээрийг сэлгэлгүй ашиглах явдал эрс нэмэгдэж, улмаар хөрсний бүтэц эвдрэн, цөлжих хандлага эрчимжиж байна. Энэ сөрөг үйл ажиллагааг зогсоохын тулд сүүлийн 10 жилд нэгэнт эвдэрч сүйдэн тоногдсон, усдаж үгүй болсон худаг ус, бэлчээрийг сэргээх гэж анхаарах болсноор 1998 онд улсын төсвөөс 340 сая төгрөг төлөвлөж байсан бол 2000 онд 260.0 сая, 2004 онд 428.8 сая, 2006 онд 1804.4 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж 2008 онд уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргахад 9000.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн байна.

Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлсэн “ХААС” төслөөр Говь-Алтай, Завхан, Ховд, Увс аймагт уст цэгийг засварлах ажилд 2002- 2006 онд 305 уст цэгийг сэргээн засварласан байна. Гэтэл нэг сумын нутаг гэхэд сумын төвийн усан хангамж, бохир ус цэвэрлэх асуудлыг Барилга, хот байгуулалтын яам, бэлчээр, газар тариалангийн усан хангамжийн асуудлыг Хөдөө аж ахуйн яам, усны бохирдол, нөөцийн хомсдол, нөөцийн асуудлыг Байгаль орчны яам хариуцаж байгаа одоогийн нөхцөлд хөдөө орон нутгийн усан хангамжийн асуудлыг нэгдсэн байдлаар шийдвэрлэхэд хүндрэлтэй байна.

### ***Хүн амын усан хангамжийн өнөөгийн байдал тулгамдаж буй асуудал***

Манай улс хүн амын усан хангамжийн талаар анхаарал тавьж баталгаат эх үүсвэрээс усаар хангах асуудлыг дэвшүүлж ирсэн боловч хөдөөгийн хүн амын усан хангамж төдийлэн сайн шийдвэрлэгдсэн гэж үзэхээргүй байна. Баруун бүсийн хүн амын усан хангамжийн байдлыг авч үзэхэд зөвхөн аймгийн төвүүдийн нэгээхэн хэсэг ус хангамжийн нэгдсэн сүлжээнд холбогдсон бусад нь зөөврийн болон ямарч хамгаалалтгүй усны эх үүсвэр / гол горхи, булаг шанд, гүний болон энгийн уурхайн худаг /-ээс усаар хангагдаж байна. Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Алтай хотын ундны усны эх үүсвэрийн хөгжлийн судалгаа хийх “ төслийн хүрээнд тус хотын хүн амыг найдвартай усаар хангах асуудал шийдвэрлэгдсэн .Азийн хөгжлийн банкны зээлээр “Баруун таван аймгийн Нийтийн аж ахуйг сайжруулах” төслийн хүрээнд НААҮ-ний байгууллагуудын инженерийн барилга байгууламжийн асуудлыг хамруулаад зогсохгүй нийтийн халуун ус, хог хаягдал хот байгуулалтын талаар авах арга хэмжээ тусгагдаж хэрэгжсэн.

### ***Сумын төвийн хүн амын унд ахуйн усан хангамжийн одоогийн байдал***

Эрдэсжилт хатуулаг ихтэй, магнийн хэмжээ нь эрүүл ахуйн нормоос хэтэрсэн, фтор багатай , иодын дутагдалтай усыг хүн амын унд ахуйд хэрэглэж байна. Иймд усыг зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх тоног, төхөөрөмжийг Говь-Алтай аймгийн Эрдэнэ суманд 2 худагт, Хөхморьт, Дэлгэр сум, Увс аймгийн Наранбулаг, Хяргас суманд тус бүр нэгийг суурилуулаад байна. 2008 онд Увс аймгийн 6 суманд шинээр суурилуулах ажил явагдаж байна.






### УСНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ НӨӨЦ


1:3 000 000

Зураг 6.4



ТАНИХ ТЭМДЭГ

- Сумын төв
- Аймгийн төв
- Нуур
- ОХУ-ын хил
- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил
- Зам



Гол мөрний усны эрчим хүчний боломжит хувийн нөөц (куб/км)

Эндээс үзэхэд хөдөөгийн төв суурингийн хүн ам, бэлчээрийн мал аж ахуй эрхэлж байгаа малчдын усан хангамж гэсэн хоёр тусдаа ойлголт гарч байна.

Тийм учраас малаа даган амьдарч байгаа малчин өрхүүд үндсэндээ бэлчээрт гаргасан худгаас ундаалж, энэ нь эрүүл ахуйн нормоос хэтэрсэн хатуулаг, эрдэсжилтэй усыг ууж байгаа нь судалгаагаар батлагдаж байна. Олон тооны айл өрх мал аж ахуйд шилжсэнээр нэг өрхөд ноогдох малын тоо багасаж усны хэрэглээ ихсэн усан хангамжийн асуудал доройтсон нь харагдаж байна.

### ***Ариун цэврийн байгууламжийн ашиглалтын байдал***

2007 оны байдлаас баруун таван аймгийн төвүүдээс өөр цэвэрлэх байгууламжтай төв, суурин газар байхгүй байна.

Төв суурингийн хүн ам өсч төв суурин газрын нягтрал ихсэн, үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдэн үйлдвэрлэлд усны хэрэглээ нэмэгдэхийн хэрээр цэвэрлэх байгууламж нь бохир усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэж чадахгүй байгальд хаяж байгаагаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байна.

Хөдөөгийн суурин, хүн ам, амралт сувилалын газар, жуулчны баазууд бохир ус татан зайлуулах системгүй нүхэн жорлон ашиглан хөрс, ус, байгаль орчныг ихээхэн бохирдуулж байна.

Хот суурингаас алслагдсан газарт нүхэн жорлонгийн сайжруулсан хувилбар, бага оврын цэвэрлэх байгууламж ашиглах нь байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах ач холбогдолтой юм.

### ***Газар тариалан усжуулалтын төлөвлөлт, хэтийн төлөв***

Эрс тэс, хуурай уур амьсгалтай манай орны нөхцөлд тариалангийн шинэ салбар хөгжиж эхлэхийн хирээр усалгаатай тариаланг эрхлэн услалтын системийн барилга байгууламжуудыг 1970-аад оноос баруун бүсэд ихээр барих болсон.

Манай орны нөхцөлд хөрсний чийг хангамжийг сайжруулах үндсэн арга нь усалгаатай тариаланг эрчимтэй хөгжүүлэх явдал бөгөөд энэ ажилд чамлалтгүй хөрөнгө хүчийг улсаас зарцуулсан байдаг. 1990 он хүртэл баруун 5 аймагт 22170.0 мянган га талбайтай инженерийн хийцтэй услалтын систем барьж усалгаатай тариалан эрхэлж байсан боловч одоо ихэнх услалтын системүүд элэгдэж, эвдэрсэн, эзэнгүйдэн тоногдож үрэгдсэн зэрэг шалтгаанаар ашиглах боломжгүй болоод байна.

2003 онд улсын хэмжээнд явуулсан худаг, услалтын системийн үзлэг тооллогын дүнгээс үзэхэд услалтын системийн 19.5 хувийг ашиглаж байгаа дүн гарсан байна.

Манай орны хэмжээнд авч үзвэл усалгаатай талбайн 14.1 хувь нь Увс аймагт, 13.5 хувь нь Ховд аймагт, 8.8 хувь нь Говь-Алтай аймагт, 3.3 хувь нь Завхан аймагт, 4.5 хувь нь Баян-Өлгий аймагт ноогдож улсын хэмжээн усалгаатай талбайн 44.7 хувийг эзлэх 22170.0 га талбайтай услалтын систем баруун 5 аймагт баригдсан байна. 2004 оноос услалтын системүүдийг сэргээн засварлахад улсаас дэмжлэг үзүүлсэнээр услалтын системээс авах ургацын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байна. Усалгаатай 1 га талбайгаас дунджаар үр тариа 19.2 цн, төмс 110.0 цн, хүнсний ногоо 131.0 цн, малын тэжээл 30.9 цн хураан авсан нь улсын дундаж ургацаас үр тариа 10.0цн, төмс 12.2 цн, хүнсний ногоо 2.8 цн, малын тэжээл 19.7 цн-ээр тус тус илүү байна.

*Усалгаатай тариалангийн энэхүү өсөлт нь:* улсын төсвөөс 2004 онд 210.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж 1814 га талбайг услах хүчин чадалтай гурван услалтын системийг сэргээн засварлаж ашиглалтанд оруулсан

2005 онд 1120 га услах хүчин чадалтай дөрвөн услалтын системийг сэргээн засварлахад дэмжлэг үзүүлж 179 сая төгрөгийг улсын төсвөөс зарцуулсан

2006 онд 3100 га услах хүчин чадалтай долоон услалтын системийг сэргээн засварлахад дэмжлэг үзүүлж 418.705 сая төгрөгийг улсын төсвөөс зарцуулсан

2007 онд 869 га услах хүчин чадалтай 5-н услалтын системийг сэргээн засварлахад дэмжлэг үзүүлж 298.4 сая төгрөгийг улсын төсвөөс зарцуулж ашиглалтанд оруулсан нь зохих үр дүн үзүүлж байна.

БАРУУН БҮСИЙН УСАХ ХАНГАМЖ



90°0'0"E


93°0'0"E

96°0'0"E

М 1: 3 000 000

99°0'0"E

Зураг 6.5



Таних тэмдэг

- Аймгийн төв
- Сумын төв
- Хилийн боомт
- Гол
- Ширгэдэг гол
- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил
- Худгийн хамрах хүрээ
- Цэнгэг нуур
- Давстай нуур
- Хэвийн ажиллаж буй худгууд

90°0'0"E

93°0'0"E

96°0'0"E

42°0'0"N

99°0'0"E

48°0'0"N

### **Усалгаатай тариалангийн хэтийн төлөв**

Монгол Улсын Их хурлын 2003 оны 29 дүгээр тогтоолоор “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”- ыг батлан хэрэгжүүлж байна. Энэ бодлогод:

Хадлангийн талбайг ашиглуулах, эзэмшүүлэх, бордох, услах үндсэн дээр байгаль эдийн засгийн бүс бүрт малын тэжээлийн хэрэгцээг дотоод нөөцөөр хангах нөхцөл бүрдүүлэх

Энгийн болон инженерийн хийцтэй хийцтэй услалтын системийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах, усалгааны бусад арга технологи / дуслын, нэвшилтийн систем болон усан сан, хөв байгуулах/-ийг нэвтрүүлэх замаар усалгаатай тариаланг хөгжүүлэх

Сэргээн засварлах услалтын системийн зураг төслийг эзэмшигч өмчлөгчийнх нь захиалгаар хийлгүүлж, түүнийг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх

Шинээр томоохон хэмжээний усалгаатай тариалан, хадлан бэлчээр бий болгох боломжтой нутгийн хайгуул, судалгаа, зураг төсөл боловсруулах, систем байгуулах ажлыг иргэн, аж ахуйн нэгжийн болон улсын захиалга, хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлэх зэрэг бодлого зорилтуудыг тусгав.

#### **Услалтын системийн ашиглалтыг сайжруулах**

Цаг уурын ямарч нөхцөлд таримал ургамлын ус чийгийн горимыг зохицуулж баталгаатай арвин ургац авахын тулд услалтын системийг барьж байгуулан усалгаатай тариалан эрхэлдэг.

Услалтын систем гэдгийг 2004 онд батлагдсан “Усны тухай” хуулийн 3 дугаар зүйлд томъёолсноор “бэлчээр хадлан, тариаланг услах зорилгоор гадаргын болон газрын доорх усыг хуримтлуулах, дамжуулах, хуваарилах, түгээх, илүүдэл усыг зайлуулах зориулалт бүхий усны барилга байгууламж, тоног төхөөрөмжийг багтаасан иж бүрэн цогцолбор” гэж ойлгох бөгөөд тэр нь тодорхой өмчлөгч, эзэмшигчтэй байх ёстой.

Услалтын системийн барилга байгууламж, суваг шуудуу /хоолой/, тоног төхөөрөмж нь төрийн болон иргэн, аж ахуйн нэгжийн өмч байж болно. Услалтын системийн барилга байгууламж, суваг шуудуу /хоолой/, тоног төхөөрөмжийн өмчлөгч нь өөр хуулийн этгээдэд гэрээгээр эзэмшүүлж болно. Ийм жишээ ялангуяа орон нутгийн төрийн өмчийн услалтын систем дээр түгээмэл байгаа юм. Харин услалтын системд хамаарах тариалангийн талбайг “Газрын тухай” хуулийн дагуу иргэн аж ахуйн нэгжид эзэмшүүлж байна. Ийм учраас орон нутгийн засаг захиргааны байгууллага, услалтын системийн барилга байгууламж, суваг шуудуу /хоолой/, тоног төхөөрөмжийн өмчлөгч, эзэмшигч, тариалангийн талбайн эзэмшигч гурвын хооронд тодорхой харилцаа үүсдэг.

Энэ харилцааг “Усны тухай”, “Газрын тухай” зэрэг хуулиудын хүрээнд зохицуулж байгаа хэдий ч зарим маргаантай асуудал байсаар байна. Энэ тохиолдолд орон нутгийн засаг захиргааны байгууллага дараах үйл ажиллагааг явуулах шаардлагатай:

Услалтын системийн барилга байгууламж, суваг шуудуу хоолой, тоног төхөөрөмжийн өмчлөгч, эзэмшигчтэй гэрээ байгуулж, түүний хэрэгжилтэнд байнгын хяналт тавих

Усаар үйлчилсний хөлсийг тогтоож мөрдүүлэх

Услалтын системийн ашиглалтын байдалд хяналт тавьж, усыг үргүй зарцуулах, газрын хөрсийг угаах, давсжуулах, намагжуулах явдал гаргуулахгүй байхад анхаарах

Услалтын системийн барилга байгууламж, суваг шуудуу хоолой, тоног төхөөрөмжийн өмчлөгч, эзэмшигч, тариалангийн талбайн эзэмшигч нарын хооронд үйлчлэх нийтийн гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих шаардлагатай байна.


Услалтын системийн барилга байгууламж, суваг шуудуу /хоолой/, тоног төхөөрөмжийн өмчлөгч, эзэмшигч нь тариалангийн талбайн эзэмшигчид шаардлагатай усыг зохих хугацаанд нь хангах үүрэгтэй бөгөөд үүний тулд услалтын системийг байнгын хэвийн ажиллагаатай байлгах хэрэгтэй. Одоогоор услалтын системийн талбайг усаар үйлчилсний зардал нэг га талбайд 20000-40000 төгрөг байна.





#### **Услалтын системийг сэргээн засварлах, шинээр барих**

Бүс нутгийн усны нөөцийг ашиглаж усалгаатай тариалан эрхлэхийн тулд услалтын системийг шинээр барих, сэргээн засварлах шаардлагатай юм. Үүний тулд төрийн захиалгаар хөрс, ус зүйн хайгуул судалгааны ажлыг цаг алдалгүй хийж, зураг төслийг боловсруулах хэрэгтэй. Энэ ажилд нилээд хөрөнгө шаардлагатай бөгөөд юуны өмнө газар тариалангийн боломжит бүс болох Ховд, Хангилцаг, Баруунтурууны голын савд хайгуул судалгаа хийж үр тариа тарих боломжийг нэмж судлах хэрэгтэй. Мөн цас борооны ус буюу голуудын илүүдэл урсацыг цуглуулж хадлангийн талбай, газар тариаланд ашиглах боломжийн хайгуул судалгаа хийх шаардлага тулгараад байна.


ᄆᄆᄆᄆᄆᄆᄆ ᄆᄆᄆ ᄆᄆᄆ ᄆᄆᄆ

1:3 000 000



-  ᄆᄆᄆ ᄆᄆᄆ ᄆᄆᄆ
-  ᄆᄆᄆᄆᄆ ᄆᄆᄆ
-  ᄆᄆᄆ ᄆᄆᄆ ᄆᄆᄆ
-  ᄆᄆᄆ

ᄆᄆᄆᄆᄆᄆᄆᄆ ᄆᄆᄆᄆᄆᄆᄆᄆ ᄆᄆᄆᄆᄆᄆᄆᄆ ᄆᄆᄆᄆᄆᄆᄆᄆ ᄆᄆᄆᄆᄆᄆᄆᄆ ᄆᄆᄆᄆᄆᄆᄆᄆ



Зураг 6.6

Малын тэжээл, үр тарианы чиглэлээр шинээр услалтын систем байгуулахад техникийн шийдлээс хамаарч 1 га-д 3.0-5.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт улсаас оруулахаар тооцоход 12600 га талбай бүхий хадлангийн талбай, газар тариалан услах услалтын системийг шинээр барихад 56000 сая төгрөг, тэдгээрийн хайгуул судалгаа хийж зураг төсөл боловсруулахад 1200,0 сая төгрөг шаардлагатай.

Хайгуул, зураг төсөл хийгдэж нэгэнт баригдсан, эвдрэл, элэгдэлд орж тоногдож ашиглалтгүй байгаа услалтын системүүдийг сэргээн засварлах технологийн шинэчлэл хийх техникийн хүчин чадалд хүртэл ашиглахад дэмжлэг үзүүлэх зорилгоор жилд Улсын төсвөөс дунджаар /урьдах жилүүдтэй харьцуулахад/ 400.0-500.0 сая төгрөг шаардагдаж байна.

Газар тариалангийн талбайг үерийн ус бусад байгалийн аюулаас хамгаалах арга хэмжээг авах байгалийн хадлангийн талбайг урт хугацаагаар эзэмшүүлэх, ашиглуулах, түүнийг бордож услах замаар ургацыг нэмэгдүүлэхэд анхаарч хадлан бэлтгэлийг 25-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх, 2015 он хүртэл шинээр баригдах болон сэргээн засварлах услалтын системүүдийг технологийн судалгаагаар тогтоож, шаардагдах хөрөнгийн үнэлгээг хийх юм.

### ***Усны нөөцийг хамгаалах экологи, эдийн засгийн үндэс***

Байгаль орчинд үзүүлж буй хүний үйл ажиллагаа, зохисгүй үйлдлийн нөлөөний улмаас гол мөрний урцасын горим, норм өөрчлөгдөж нуур усан сангийн ус хомсдож, булаг шандын ус ширгэх, бохирдож экологийн доройдолд орж байна.

Голын сав газрын ой модыг үлэмж ихээр огтлох, бэлчээр талхлагдах, хөрс дагшрах, ургамалан нөмрөг өөрчлөгдөх, усыг усалгаанд тооцоо хяналтгүй ашиглах зэргээс голын ус ширгэх, нуур цөөрөм хатаж, ус багасаж байна. Мөн байгалийн дулаарал, хур тунадас багасч байгаа нь мөн экологит нөлөөлж байна.

Иймээс гол мөрөн, нуурын усыг ашиглахдаа экологит нөлөөлөхгүйгээр авч ашиглах, энэ талын тооцоог шинжлэх ухааны үндэстэй тооцоонд түшиглэж зураг төслөөр авч үзэж байх талаар анхаарч ажиллах хэрэгтэй.

Гол мөрөн, нуурын усыг бохирдохоос хамгаалахын тулд түүнд хаягдаж байгаа бохир усанд байнгын хяналт тавьж зөвшөөрөгдөх нормоос давсан бохирдолтой усыг нийлүүлэхгүй байх хэрэгтэй.

Харин усны хомсдол, гол мөрөн, булаг шанд хатаж ширгэхээс хамгаалахын тулд ашиглалтын нөөцийн хязгаарыг тухайн төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгэр тогтоож тогтоосон норм, хязгаараас илүү ус ашиглахгүй байхад хяналт тавьж ажиллах шаардлагатай.

Усны нөөцийн хомсдолыг байгаль цаг уурын өөрчлөлт, уур амьсгалын нөлөөлөл, аж ахуйн үйл ажиллагааны хэмжээнээс хамаарч голын уснаас авч ашиглах зөвшөөрөгдөх хэмжээ, экологийн урсацыг тогтоогоогүй аливаа төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх талд дээр бүс, орон нутаг өөрийн ажлыг гол үзүүлэлт болгон ажиллах хэрэгтэй.

### ***Гидрогеологийн хайгуул судалгаа***

Ховд, Булган, Алтай, Үенчийн өмнө талаар, Говь-Алтай аймгийн Алтай, Цогт, Цээл, Шарга, Төгрөг, Хөх морьт, Баян-Уул, Жаргалан, Дэлгэр, Завхан аймгийн Ургамал, Завханмандал, Эрдэнэ-Хайрхан, Сантмаргац, Цэцэн-Уул, Увс аймгийн Зүүнхангай, Өндөрхангай, Зүүнговь, Тариалан, Завхан, Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Толбо, Дэлүүн, Булган сумын нутгуудад гидрогеологийн хайгуул судалгаа хийж гүний усны нөөцийг тогтоохоор төлөвлөж байна юм.

### ***Усны хамгаалалтын бүс***

Гол мөрөн, нуур цөөрмийн усны нөөцийг хомсдох бохирдохоос хамгаалах ажлын нэг чухал хэсэг нь тухайн усны эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтоон, бохир ус голд нийлэхээс өмнө зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл цэвэрлэж нийлүүлэх явдал мөн.

Төв суурин газрын хатуу хог хаягдлыг булж булчлах нэгдсэн цэгтэй болгон, хур борооны усаар туугдан, гол усны эх үүсвэрт орохоос хамгаалах арга хэмжээ авах хэрэгтэй.

Голын экосистемийг тэнцвэртэй байлгахын тулд тухайн голын ай савын зөвлөлийг байгуулж ажиллана.

### ***Бэлчээр усжуулалтын төлөвлөлт***

Монгол орон бэлчээрийн мал аж ахуйг эрхэлж ирсэн уламжлалтай. Сүүлийн жилүүдэд хур тунадас бага орсон, мал сүргийн тоо эрс нэмэгдэж ус хүрэлцээгүйгээс булаг шанд, худаг ус тойрч олон тооны мал цугларсанаас малын бэлчээр талхлагдах, булаг ус ширгэж усгүй болож байгаа нь өнгөрсөн онуудад хийсэн гадаргын усны тооллогоор тогтоогдсон.

Ашиглагдаагүй байгаа өндөр уулын бүсийн бэлчээрийг ашиглахын тулд цасны болон хур борооны үерийн усыг хуримтлуулах хөв, цөөрөм барих, хайгуул судалгааны ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж шинэ уст цэг гаргах ажлыг эрчимжүүлэх.

Байгаль гидрогеологийн нөхцлөөс шалтгаалан нэг гүн өрмийн худаг гаргаж тоног төхөөрөмж суулгахад 8-12 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж байна.

*Бэлчээр усжуулахын ач холбогдол:*

- Алслагдсан болон усгүйгээс болж ашиглах боломжгүй байсан бэлчээрийг ашигласнаар бэлчээрийн талхагдлыг багасгах
- Өвлийн цагт гадаргын усны урсац тогтворгүй байдлаас болж гарах хүндрэлийг шийдвэрлэх

*Хийх шаардлагатай ажлууд:*

- Малчдыг сургалтанд хамруулах
- Булаг шандыг тохижуулах
- Өвлийн цагт мөс, цас нөөцлөх аргын талаар сургалт зохион байгуулах
- Мөн бэлчээрийн менежментийг зөв зохион байгуулах талаарх сургалт явуулах
- Бүс нутагт газрын доорхи усны эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэн, хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх
- Улсын төсвөөс болон хувийн хэвшлийн хөрөнгөөр гаргах уст цэг /худаг/-ийн тоо хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

**Үр тариа , малын тэжээлийн үйлдвэрлэлийн чиглэлээр шинээр баригдах услалтын системүүд**

| Д/д | Аймаг      | Сум          | Услалтын системийн нэр | Хүч чадал /га/ | Тайлбар              |
|-----|------------|--------------|------------------------|----------------|----------------------|
| 1   | Баян-өлгий | Алтанцөгц    | Цагаан түнгэ           | 1200           |                      |
| 2   | Баян-өлгий | Алтанцөгц    | Таван харын хөдөө      | 4000           |                      |
| 3   | Увс        | Баруунтуруун | Баруунтуруун           | 6000           | 2000 га нь баригдсан |
| 4   | Увс        | Хяргас       | Бөөргийн эх            | 2000           |                      |
| 5   | Увс        | Хяргас       | Боршоогийн адаг        | 1000           |                      |
| 6   | Ховд       | Дөргөн       | Чоно харайжийн гол     | 1000           |                      |
| 7   | Ховд       |              | Хонгоржийн тал         | 1000           |                      |
|     | Дүн        |              |                        | 12600          |                      |

**Үр тариа, малын тэжээл, хүнсний ногоо услах чиглэлээр сэргээн засварлах услалтын системүүд /Хүснэгт 6.14/**


| Д/д | Аймаг      | Сум         | Услалтын системийн нэр | Хүч чадал /га/ | Тайлбар |
|-----|------------|-------------|------------------------|----------------|---------|
| 1   | Баян-Өлгий | Буянт       | Мандахын ам            | 272            |         |
| 2   |            | Дэлүүн      | Харгантын тал          | 200            |         |
| 3   | Говь Алтай | Бугат       | Биж                    | 578            |         |
| 4   |            | Бигэр       | Мянгаа                 | 100            |         |
| 5   |            | Цогт        | Хаяа                   | 400            |         |
| 6   | Завхан     |             |                        |                |         |
| 7   | Увс        | Өлгий       | Сондуултай             | 71             |         |
| 8   |            | Давст       | Торхилог               | 860            |         |
| 9   | Ховд       | Үенч        | Цагаан эрэг            | 204            |         |
| 10  |            | Булган      | Хар үзүүр              | 466            |         |
| 11  |            | Мөст        | Атар                   | 184            |         |
| 12  |            | Эрдэнэбүрэн | Эрдэнэбүрэн            | 2000           |         |
|     | Дүн        |             |                        | 5335           |         |



УЛ ХӨРСНИЙ УСНЫ БАЙРШЛЫН ГҮН

1:3 000 000


Зураг 6.7



ТАНИХ ТЭМДЭГ

- ОХУ-ын хил
- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил
- Зам
- Аймгийн төв
- Сумын төв
- Нуур

Ул хөрсний байршлын гүн (м)



Ул хөрсний байршлын гүн нь тогтворгүй уулхархаг муж



### **Гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх төлөвлөлт**

Монгол орны гадаргын усны нөөцийг нэмэгдүүлж өндөр уулын бэлчээрийг ашиглах, тогтвортой өндөр ургац авах нөхцөл нь гидрогеологийн хүндрэлтэй нөхцөлд байгаа бэлчээр ашиглах, усалгаатай тариаланд тохиромжтой талбайг түшиглүүлэн ус хуримтлуулах усан сангийн боомт, бороо цасны үерийн ус хуримтлуулах хөв, цөөрөм барьж байгуулах ажил юм.

Ашиглагдаагүй байгаа соргог бэлчээрийг ашигласнаар малын тарга хүч нэмэгдэх, онд мэнд орох, нэг газар худаг, ус бараадан олон мал бөөгнөрснөөс бэлчээрийн даац хүрэхгүй, талхлагдах зэрэг сөрөг нөлөө багасна.

Энэ ажлыг хэрэгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, хайгуул судалгаа, зураг төслийн ажил хийх ажлыг анхнаас нь зөв төлөвлөх шаардлагатай.

#### **Хөв, цөөрөм байгуулах**

Сүүлийн жилүүдэд бэлчээр усжуулах зорилгоор бороо цасны үерийн ус хуримтлуулж хөв, цөөрөм байгуулахад улс, орон нутгийн хөрөнгө оруулалт хийгдэж энэ ажилд анхаарал тавих боллоо.

Өмнө хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын байдлыг авч үзвэл хөв байгуулахад 25-30 орчим сая төгрөг зарцуулж байна. Гэвч тухайн орон нутгийн онцлог байгалийн тогтцоос хамааран хөрөнгө оруулалт өөр байна.

Хөв цөөрөм байгуулах ажил нь хөрөнгө оруулалт бага, тухайн улиралд усыг ашиглах зориулалттай учир орон нутгийн аргаар хийх боломжтой боловч, гидротехникийн иж бүрэн судалгаа хийгдэхгүй байгаагаас борооны үерт угаагдах, далан сэтрэх зэрэг эрсдэл гарч байгааг анхаарах нь зүйтэй. Хөв байгуулах ажлыг эхлэхийн өмнө судалгаа хийж техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах зайлшгүй шаардлагатай.

Иймд 2009-2010 онуудад хайгуул судалгаа, зураг төслийн ажлуудыг хийж, 2010-2015 онд хөв, цөөрөм барьж гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэхээр төлөвлөв.

Төсөл хэрэгжиж байгаа нутаг нь өндөр уулын бүсэд ашиглагдаагүй бэлчээрийг ашиглах зорилгоор хөв, цөөрөм байгуулах тохиромжтой газрыг сонгон хөв цөөрөм барьж болох газрууд

*Баян-Өлгий аймаг Сагсай, Бугат, Алтай, Цэнгэл, Улаанхус сумд Говь-Алтай аймаг Тонхил, Дарви, Төгрөг, Бигэр, Дэлгэр сум Завхан аймаг Эрдэнэхайрхан, Цэцэн-Уул, Сонгино, Сантмаргац сум Увс аймаг Малчин, Хяргас, Тариалан, Цагаанхайрхан, Наранбулаг сум Ховд аймаг Мөст, Мөнххайрхан, Манхан, Цэцэг, Чандмань сумын нутаг Алтай нурууны уулсын ар хажуу газрыг сонгох нь зүйтэй*

Олон жилийн тохируулгатай усан сан, боомтын хайгуул судалгаа, зураг төслийн ажлыг 1.0 сая м<sup>3</sup>—ээс их багтаамжтай байх створуудыг сонгож, Хангилцагийн гол, Ховдын гол, Буянт, Бөхмөрөнгийн гол, Богд, Чигэстэйн голуудад урьд сонгосон створуудыг түшиглэн хийнэ.

#### **Хөдөөгийн хүн амын усан хангамжийн одоогийн байдал**

Хөдөөгийн хүн амын усан хангамжийн байдлыг бүс нутгийн хүрээнд авч үзэхэд сум суурин газрын иргэд худгаас, малчдын цөөнх хэсэг нь худгийн усаар ихэнх хувь нь ил задгай гол горхи, булаг шандын ус, өвлийн цагт цас, мөсний ус ашиглаж байна.

Мэргэжлийн байгууллагын хийсэн судалгаагаар Говь-Алтай аймаг гэхэд хүн амын 15 хувь нь стандартын “ Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 900-2005” шаардлага хангасан ус ууж, 85 хувь нь эрдэсжилт хатуулаг ихтэй, магнийн хэмжээ эрүүл ахуйн нормоос хэтэрсэн, фтор багатай, иодийн дутагдалтай, стандартын шаардлага хангахгүй усыг унд ахуйдаа хэрэглэж байна гэсэн дүгнэлт гарсан. Одоогийн байдлаар Цогт, Алтай, Тайшир, Төгрөг, Тонгил сумын төвийн иргэд ил задгай усыг унд ахуйдаа хэрэглэж байна.

Увс, Ховд, Завхан аймгуудын говийн бүсийн иргэд мөн хүн амын унданд тохирохгүй ус уусаар байна. Энгийн уурхайн худгууд бохирдол ихтэй гарч байна. 67 худагт шинжилгээ хийхэн 20 орчим хувь нь исэлдэх чанар, өнгө, булингарчилтын хувьд бохирдолтой гарсан

Хүн амыг цэвэр, аюулгүй усаар хангах асуудалд анхаарч зарим суурин газрын худгуудад ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх тоног төхөөрөмжийг суурилуулж байгаа боловч химийн зарим үзүүлэлт төдийлөн буурахгүй, ус зөөлрүүлэх тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал харилцан адилгүй байна.

Олон тооны айл өрх төв, суурин газраас гарч мал аж ахуйд шилжсэнээр малчин айлын тоо өсч хөдөөгийн малчдын усан хангамжийн асуудал хүндэрч байна.

Энгийн уурхай худгийн битүүмжлэл муу, худаг дээр мал усалдаг, суурин газрын бохирын цооног, муу усны нүхэнд ойр байгаатай холбоотой бохирдол ихтэй, унд ахуйд тохирохгүй байна Мөн сумын

төвүүдэд одоо ашиглагдаж байгаа худгуудад хамгаалалтын бүс тогтоогдоогүй байгаагаас айлууд шахаж бууж байна.

### **Цаашид авах арга хэмжээ**

- Хөдөөгийн төв суурин газрын хүн амын усан хангамжийн худгуудад эрүүл ахуйн болон хамгаалалтын бүс тогтоож, хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөх.
- Худгийг усны найрлагаас хамааруулан ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмжийг зөв сонгон суурилуулах, хөрөнгө оруулалтыг 2-3 дахин нэмэгдүүлэх
- Хоногт нэг хүнд ногдох усны хэмжээг хэрэглээний нормд хүргэх
- Орон нутгийн болон гаднын төслийн хөрөнгөөр булаг шанд, усны эх үүсвэрийг хайс хамгаалалттай болгох ажлыг эрчимжүүлэх
- Малын бэлчээрийг усжуулах зорилгоор уулын бүсэд цас, хур борооны үерийн ус хуримтлуулах хөв, цөөрөм барьж байгаа боловч энд малчин өрхийн унд ахуйн ус хангамжийг хамт авч үзэх, зөөврийн усаар хангах

Услалтын систем гэдгийг 2004 онд батлагдсан “Усны тухай” хуулийн 3 дугаар зүйлд томъёолсноор “бэлчээр хадлан, тариаланг услах зорилгоор гадаргын болон газрын доорхи усыг хуримтлуулах, дамжуулах, хуваарилах, түгээх, илүүдэл усыг зайлуулах зориулалт бүхий усны барилга байгууламж, тоног төхөөрөмжийг багтаасан иж бүрэн цогцолбор” гэж ойлгох бөгөөд тэр нь тодорхой өмчлөгч, эзэмшигчтэй байх ёстой.

Услалтын системийн барилга байгууламж, суваг шуудуу /хоолой/, тоног төхөөрөмж нь төрийн болон иргэн, аж ахуйн нэгжийн өмч байж болно.

Услалтын системийн барилга байгууламж, суваг шуудуу /хоолой/, тоног төхөөрөмжийн өмчлөгч нь өөр хуулийн этгээдэд гэрээгээр эзэмшүүлж болно. Ийм жишээ ялангуяа орон нутгийн төрийн өмчийн услалтын систем дээр түгээмэл байгаа юм. Харин услалтын системд хамаарах тариалангийн талбайг “Газрын тухай” хуулийн дагуу иргэн аж ахуйн нэгжид эзэмшүүлж байна. Ийм учраас орон нутгийн засаг захиргааны байгууллага, услалтын системийн барилга байгууламж, суваг шуудуу /хоолой/, тоног төхөөрөмжийн өмчлөгч, эзэмшигч, тариалангийн талбайн эзэмшигч гурвын хооронд тодорхой харилцаа үүсдэг. Энэ харилцааг “Усны тухай”, “Газрын тухай” зэрэг хуулиудын хүрээнд зохицуулж байгаа хэдий ч зарим маргаантай асуудал байсаар байна. Энэ тохиолдолд орон нутгийн засаг захиргааны байгууллага дараах үйл ажиллагааг явуулах шаардлагатай.

Услалтын системийн барилга байгууламж, суваг шуудуу хоолой, тоног төхөөрөмжийн өмчлөгч, эзэмшигчтэй гэрээ байгуулж, түүний хэрэгжилтэнд байнгын хяналт тавих, усаар үйлчилсний хөлсийг тогтоож мөрдүүлэх, услалтын системийн ашиглалтын байдалд хяналт тавьж, усыг үргүй зарцуулах, газрын хөрсийг угаах, давсжуулах, намагжуулах явдал гаргуулахгүй байхад анхаарах хэрэгтэй.

Услалтын системийн барилга байгууламж, суваг шуудуу хоолой, тоног төхөөрөмжийн өмчлөгч, эзэмшигч, тариалангийн талбайн эзэмшигч нарын хооронд үйлчлэх нийтийн гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих шаардлагатай байна.

Услалтын системийн барилга байгууламж, суваг шуудуу /хоолой/, тоног төхөөрөмжийн өмчлөгч, эзэмшигч нь тариалангийн талбайн эзэмшигчид шаардлагатай усыг зохих хугацаанд нь ханган үүрэгтэй. Бөгөөд үүний тулд услалтын системийг байнгын хэвийн ажиллагаатай байлгах хэрэгтэй. Мөн ус ашиглах зөрчил гаргасан, усны үйлчилгээний хөлс төлөөгүй тариалангийн талбайн эзэмшигчид усаар үйлчлэхгүй байх, усны үйлчилгээний хөлсийг тогтоосон хэмжээгээр авах эрхтэй. Одоогоор услалтын системийн усаар үйлчилсний хөлс нэг га талбайд 20000-40000 төгрөг байна.

### **Услалтын системийг сэргээн засварлах, шинээр барих**

Усалгаатай тариаланд ашиглаж болох ус, хөрсний боломжтой талбайн судалгааг усны хайгуул, төсөл, эрдэм шинжилгээний институт бүх аймгаар хийж фондод бүртгэсэн байдаг. Энэхүү судалгааны дүнг 1982 оны байдлаар нэгтгэж үзвэл усалгаатай тариаланд ашиглаж болох ус, хөрсний боломжтой талбайн хэмжээ 418255 га гэж фондод бүртгэсэн байна. Харин Монгол орны ашиглах боломжит усны нөөцийг 34600 шоо км гэж тогтоосон байдаг бөгөөд түүнээс 28527 шоо км нь гадаргуугийн, 6073 шоо км нь газрын доорх усны нөөц байдаг.

Төрийн захиалгаар хөрс, ус зүйн хайгуул судалгааны ажлыг цаг алдалгүй хийж, зураг төслийг боловсруулах хэрэгтэй. Энэ ажилд нилээд хөрөнгө шаардлагатай бөгөөд юуны өмнө газар тариалангийн баруун бүс болох Их нууруудын хотгор, Алтайн цаадах Говьд хайгуул судалгаа хийж үр тариа тарих боломжийг судлах хэрэгтэй. Мөн цас борооны ус буюу голуудын илүүдэл урсацыг цуглуулж газар тариаланд ашиглах боломжийн хайгуул судалгаа хийх хэрэгтэй байна.

Их нууруудын хотгор Алтайн цаадах Говьд цогцолбор байгуулахад наад зах нь 2,4 тэр бум төгрөг шаардлагатай байгаагаас гадна түүний хайгуул судалгааны ажилд 120.0 сая төгрөг хэрэгтэй. 12600 га талбай бүхий услалтын системийг шинээр барихад 34908,8 сая төгрөг, тэдгээрийн хайгуул судалгаа хийж зураг төсөл боловсруулахад 1396,0 сая төгрөг хэрэгтэй.

#### 6.1.4.4 Түлш дулааны хангамж

Баруун бүс нь ашигт малтмалаар баян бөгөөд тухайн үеийн хэсэгчилсэн хайгуул судалгааны үр дүнд төрөл бүрийн эрдсийн 168 орд, 1260 илрэл илрээд байна. Цаашид олон эрдэс илрэх боломжтой ажээ. Баруун бүсийн аймгуудад түүний дотор Увсын Хар тарвагатай, Нүүрст хотгор, Ховдын Хөшөөт, Говь-Алтайн Мааньт Хүрэн гол, Чандмань зэрэг сайн чанарын нүүрсний томоохон орд нээгдэж тэдгээрийг орон нутгийн чанартай ашиглаж байна. Үүний зэрэгцээгээр бүсийн бүх аймагт нүүрсний олон илрэл бий.

Иймээс бүсийн одоогийн ажиллаж байгаа нүүрснээс экспортлохын хамт дулааны томоохон цахилгаан станц байгуулах боломжтой. Цаашид уг станцын цахилгаан дамжуулах шугамыг Хөвсгөл, Архангай, Баянхонгортой холбох шаардлага гарах бөгөөд энэ нь улс орны эрчим хүчний нэгдсэн системийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой. Баруун бүсээс БНХАУ-д руу цахилгаан дамжуулах шугам тавьж экспортлох, ОХУ Саян шуменск Монголоос БНХАУ-д цахилгаан дамжуулах боломж бүрдэнэ. Баруун бүсийн цахилгаан дамжуулах шугам нь өмнөд болон умард Азийг холбосон эрчим хүчний нэг гол шугам болох талтай. Өөрөөр хэлбэл баруун бүс нь цахилгаан дамжуулах транзитын бүс болох ирээдүйтэй.

Тувагийн Элстэйд нүүрсний том орд руу төмөр зам тавих гэж байгаа болон Завханы хойд хилд ойрхон өндөр хүчдэлийн шугам тависан, Тувад уул уурхайн үйлдвэр амжилттай хөгжиж буйг харгалзан Тувад шатдаг хий дамжуулах шаардлага гарч байгаа юм. Тиймээс баруун бүс нутагт уул уурхай, хөдөө аж ахуй, газар тариалангийн томоохон объектууд бий болох үед Тувагаас хий дамжуулах хоолойг Увс, Завханы хойд талаар оруулж болно.

Увс, Ховд, Завхан, Говь-Алтайн нутаг, Алтайн ар өврийн их хөндий, хотгорт нефть, шатдаг хий байж болохыг үгүйсгэдэггүй бөгөөд тэнд хий агуулж болох нүүрс, шатдаг занар, давс, хужир зэргийн орд, илрэл цөөнгүй байдаг ба нефть, хийн агаараас хийсэн тандан судалгаа тэдгээр газар нефть, хий байх үндэстэй гэж үзсэн.

Баруун бүсийн аймгуудын нутаг дэвсгэрийн 30 гаруй хувь нь 1:50000 масштабтай геологийн зураглал хийсэн учир үлдэх хэсэг нь ямар эрдэс байгааг тодорхойлохын тулд нэн тэргүүнд 1:50000 масштабын зураглал, геофизикийн ажлыг даруй хийх шаардлагатай. Энэ ажлыг ОХУ-д, Казакстан улсын геологийн байгууллагатай хамтарч хийх нь зүйтэй.


Монгол орны хөгжлийн стратегийн тулгуур бичиг баримт болох “Мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-д тусгагдсан зорилтуудын хүрээнд бүс нутгийн түлшний хөгжлийн бодлогыг шинэ төслөөр нэмж тусгах шаардлагатай юм. Эдийн засгийн бүсчлэлд нүүрсний аж үйлдвэрийн хөгжлийн стратегийг тодорхойлохдоо бүс нутгийн хүн ам, экологийн өвөрмөц онцлог, бүсийн доторхи болон бүс хоорондын гео эдийн засгийн орон зайн талаас нь иж бүрэн судлах хэрэгтэй. Сайн чанарын нүүрсний асар их нөөц бүхий баруун бүс нутгийн хувьд нүүрсний нөөц хэмнэх, хаягдлыг багасгаж, байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн өндөр үр ашигтайгаар хөрш орнуудын зах зээлд оролцох чадамж бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар дахин сэргээгдэхгүй байгалийн энэхүү баялагийг аль болох хаягдал багатай иж бүрэн ашиглах экотехнологийн зорилтуудыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Тухайлбал Хархираа, Монгол Алтай, Алтайн чандахь болон Өмнөт Хангайн нүүрсний сав газруудын судалгааны ажлыг нарийвчлан хийж тэдгээрийг түшиглэсэн нүүрс боловсруулах Нүүрсхими, Коксхимийн томоохон аж үйлдвэрийн цогцолборуудыг барьж дотоодын хэрэгцээг хангахаас гадна экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой.

Монголын баруун бүсээс 13000 тн нүүрс боловсруулж шингэрүүлэн өдөрт 3400 тн бензин, дизель түлш, шингэрүүлсэн шатдаг хийн түлшийг үйлдвэрлэх бололцоотой. Энэ нь 25000 баррель


БАРУУН БҮС НУТГИЙН ТҮЛШ ДУЛААНЫ  
ХАНГАМЖИЙН ОДООГИЙН БАЙДАЛ

Зураг 6.8





БАРУУН БҮС НУТГИЙН НҮҮРСНИЙ БҮЛЭГ  
ОРД ИЛРЭЛҮҮДИЙН ЗУРАГ



Таних тэмдэг

- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил
- Зам
- Гол
- Аймгийн төв
- Сумын төв
- Ой
- Заган ой
- Нуур

Нүүрсний эрэл хайгуулын төлөвлөлт

- 2009-2015 онд нөөцийн хайгуул хийх
- 2015-2016 онд нөөцийн хайгуул хийх
- Төлөвлөлтийн хугацаанаас цааш хайгуул хийх

түлш юм. Бүтээгдэхүүний гарц нэг тонн нүүрс тутамд 2.6-3.0 баррель байна. Энэ технологийг Францын Axens компани H-Coal патентаа нэвтрүүлэхээр Түлш эрчим хүчний яаманд санал болгосон байна.

Бүс нутгийн цөлжилтийг саармагжуулахад түлшний асуудал онцгой ач холбогдолтой. Иймд баруун бүс нутагт орших нүүрсний давхаргад шингэх байдлаар хуримтлагдсан метан хийг судалж, нөөцийг тогтоох, улмаар ахуйн болон аж үйлдвэр, үйлчилгээ, авто тээврийн хэрэгслийг экологийн цэвэр эрчим хүчний түлш болгон ашиглах үндэсний хийн томоохон үйлдвэр баригдах боломж манай орны бусад бүс нутгуудаас баруун бүс нутгийн сайн чанарын чулуун нүүрсний орд газруудад илүү байдаг юм. Баруун бүс нутагт шинээр баригдах Цахилгаан станц нь нүүрсний метан хийн түлш хэрэглэх боломж бий. Өөрөөр хэлбэл экологийн хувьд цэвэр, эрчим хүч үйлдвэрлэх бодит боломж энэ бүс нутагт байдаг. **Төв суурин газруудын дулааны эх үүсвэрийн зуухнуудыг коксын болон нүүрсний метан хийнд шилжүүлснээр агаарын бохирдолыг бууруулж эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх боломж энэ бүс нутагт байгаа юм.**

### Говь-Алтай

Хуурай сайрын илрэл нь Чандмань сутын нутагт байрлах бөгөөд 45°50'00", 96°15'30"-ын газарзүйн солбилцол дээр байрладаг. 7кт урт, 100м зузаантай нүүрсний 3 үе тогтоогдсон. Чийгшилт нь 4-5% үнсжилт 7.5-10% дэгдэмхий хольц 10.6%, дулааны ялгаруулалт-7680 ккал, нөөцийн хувьд P-60 сая, 100м гүнд, P-30 сая, 50м гүнд оршдог. Цаашид судлах шаардлагатай.

Зээгийн илрэл нь Чандмань сумын нутагт байрлах бөгөөд 45°22'30", 97°53'30"-ын газарзүйн солбилцол дээр байрладаг. 70м өргөн, 200м урт, 1.2-2.4 м зузаантай, нүүрсний 2 давхаргатай. Чийгшилт-2.84%, үнсжилт-12.50%, дэгдэмхий хольц-29%, хүхэр-0.51%, дулааны ялгаруулалт-6501 ккал, A-474.5, B-2810, C-2289, P-0.4-0.8 сая тонн нөөцтэй. Одоо ашиглаж байгаа.

Цагаан голын илрэл Чандмань сумын нутагт байрладаг. 45°48'00, 96°15'00 газарзүйн солбилцол дээр байрлах бөгөөд 1.5 км өргөн, 9-10 км урт, 1.5-4м зузаан нүүрсний үе бүхий 3 давхаргатай. P-5200 нөөцтэй. Цаашид судлах шаардлагатай.

Бумбат худгийн илрэл нь Дэлгэр сумаас зүүн урагшаа 30 км-т байрлах бөгөөд 46°11'40, 97°38'35-ын газарзүйн солбилцолд оршдог. 4.5 кв.км талбайд 0.8-3 м зузаантай нүүрсний 2 давхаргатай. Чийгшилт-4-5%, үнсжилт 13.9-25.6%, дэгдэмхий хольц 0.23-1.79%, дулааны ялгаруулалт-7321 ккал агууламжтай. P-500-800, P-156.6 мян.тонн нөөцтэй. Цаашид судлах шаардлагатай.

Хувь булгийн илрэл нь Дэлгэр сумаас баруун урагшаа 18кт-т байрладаг бөгөөд 46°12'00", 97°12'30"-ын газарзүйн солбилцол дээр оршдог. 0.24-3.5 м зузаантай нүүрсний үе тогтоогдсон. Үнсжилт-50%, дулааны ялгаруулалт-5500 ккал байна. 20 м гүнд P-200.0 мян.тонн нөөцтэй. Энэхүү илрэлийг ашиглаж болох юм.

Мааньтийн орд нь Төгрөг сумаас баруун тийш 15 км-т байрлах бөгөөд 45°47'00", 94°44'00" газарзүйн солбилцолд оршдог. Нүүрс агуулагч чулуулгын урт-1 км, өргөн нь 0.5 км бөгөөд 3.7-20 м зузаантай нүүрсний 1 давхарга тогтоогдсон. Чийгшилт-5%, үнсжилт-26.6%, дэгдэмхий хольц-3/8%, хүхэр-0.6%, дулааны ялгаруулалт -8200 ккал байна. P-0.3 сая.тонн, C-255.7, C-399.2 мян.тн нөөцтэй. Одоо ашиглаж байгаа.

Хүрэн голын орд нь Төгрөг сумаас зүүн урагшаа 26 км-т байрлах бөгөөд 45°43'00", 95°07'00"-ын газарзүйн солбилцолд оршдог. Хоорондоо 5-55 м зайтай, 7-16.5 м зузаантай нүүрсний давхарга тогтоогдсон ба урт нь 1.5-2 км юм. C+C=13.293 сая.тн нөөцтэй. Одоо ашиглаж байгаа.

Цахиуртын урд худгийн орд нь Жаргалан сумаас баруун тийш 20 км-т байрлах бөгөөд 46°57'00", 95°40'00"-ын газарзүйн солбилцол дээр оршдог. 2.5-5 м зузаантай нүүрсний давхарга тогтоогдсон. Чийгшилт-7.3%, үнсжилт-27.4%, дэгдэмхий хольц 42.1%, дулааны ялгаруулалт-8064 ккал байна. A+B+C=2.16 сая.тн нөөцтэй. Цаашид судлах шаардлагатай.

Шаргын говийн илрэл нь Жаргалан сумаас баруун урагшаа 50 км-т байрлах бөгөөд 46°30'00", 95°36'00"-ын газарзүйн солбилцолд оршдог. 3.5 м зузаантай нүүрсний давхарга 110 кв.км талбайд тогтоогдсон. Чийгшилт 4-15%, дулааны ялгаруулалт 6195-6953 ккал байна. P19.4 сая.тн нөөцтэй. Цаашид судлах шаардлагатай.

### Баян-Өлгий

Рашаант голын орд нь Дэлүүн сумаас баруун урагшаа 24 км-т байрлах бөгөөд 47°48'00", 90°30'00"-ын газарзүйн солбилцолд оршдог. 2-5.7 м зузаантай 2 давхарга тогтоогдсон. Үүнээс 0.1-1.0 зузаантай нүүрсний үетэй. Чийг 0.52-6.44%, үнсжилт 3.34-34.52%, дэгдэмхий бодис 6.48-29.02%, хүхрийн агуулага 0.19-2.13%, эзэлхүүн жин 2.61-2.77 г/см<sup>3</sup>, хувийн жин 2.56-2.77г/см<sup>3</sup>, дулаан гаргах чадвар нь 5819-8697 ккал байна. 20 м гүнд C2-50.7 мян.тн нөөцтэй. Цаашид судлах шаардлагатай.

Нэргүй илрэл нь Дэлүүн сумаас баруун урагшаа 20 км-т байрлах бөгөөд 47°49'00", 90°35'00"-ын газарзүйн солбилцол дээр оршино. Нүүрсний үеийн зузаан нь 8-10 м. Цаашид судлах шаардлагатай.

### Увс

Хүдэнгийн орд нь Улаангом хотоос хойш 60 км-т байрлах бөгөөд 50°26'00", 91°59'00"-ын газарзүйн солбилцолд оршдог. 1.9 км урт, 3.4-8.8 м зузаантай нүүрсний 2 давхаргатай. Чийгжилт 5.9%, үнсжилт 15.1-33.6%, дэгдэмхий хольц 27.9-37.6% хүхэр 0.4-0.9%, дулааны ялгаруулалт 6540-7580 ккал/кг байна. А=0.43 сая, В=1.23 сая, С1=1.54 сая Р=41.84 сая.тн нөөцтэй. Одоо ашиглаж байгаа.

Нүүрст хотгорын орд Улаангом хотоос баруун урагшаа 85 км-т байрлах бөгөөд 49°51'00", 90°53'00"-ын газарзүйн солбилцолд оршдог. 0.1-3 м зузаантай нүүрсний 9 давхарга илэрсэн. Чийгжилт 1.65%, үнсжилт 20.7-27.7%, дэгдэмхий хольц-36.9%, хүхэр 0.45%, дулаан ялгаруулалт 7929-8086 ккал/кг байна. А-2.4 сая, В-3.14 сая С1-5.8 сая, Р-36.6 мян.тн нөөцтэй. Одоо ашиглаж байгаа.

Индэртийн илрэл нь Бөхмөрөн сумаас зүүн тийш 38 км-т байрлах бөгөөд 49°40'00", 90°50'00"-ын газарзүйн солбилцол дээр оршдог. 150-1750 м урт, 1.1-5.8 м зузаантай нүүрсний 8 давхарга илэрсэн. Чийгжилт 2.1-8.13%, үнсжилт 17-29.27%. Одоо ашиглаж байгаа.

Хар тарвагатайн орд Улаангом хотоос баруун урагшаа 55 км-т байрлах бөгөөд 49°33'00", 91°41'00"-ын газарзүйн солбилцол дээр оршдог. 30 кв км талбайд 0.5-1.5 зузаантай нүүрсний давхарга тогтоогдсон. Чийгжилт 20.1-20.9%, үнсжилт 20.7-27.7%, дэгдэмхий хольц 44.2%, хүхэр 0.50%, дулаан ялгаруулалт 5509-7446 ккал/кг. А-5 сая, В-3 сая, С1-6 сая, Р-100 сая.тн нөөцтэй. Одоо ашиглаж байгаа.

Яварын орд нь Өмнөговь сумаас зүүн хойшоо 10 км-т байрлах бөгөөд 49°33'00", 91°47'00"-ын газарзүйн солбилцол дээр оршдог. 600 м урт, 7.3-15.5 м зузаантай 4 нүүрсний давхарга илэрсэн. Чийгжилт 2.64-10.81%, үнсжилт 16.8-59.5%, дэгдэмхий хольц 23.6-43.2%, хүхэр 0.13-1.22%, дулаан ялгаруулалт 4804-7765% ккал/кг. С2-250, Р-35 сая.тн нөөцтэй. Цаашид судлах шаардлагатай.

### Ховд

Хөшөөтийн орд Цэцэг сумаас хойш 25 км-т байрлах бөгөөд 46°48'40", 93°19'20"-ын газарзүйн солбилцол дээр оршдог. 1.5-2.0 км урт, зузаан нь дунджаар 10-22.9 м нүүрсний үетэй. Үнсжилт 16.4%, хүдрийн агуулага 0.335 чийглэг 1.3-3.23%, дэгдэмхий хольц 18.75-25.92%, нүүрстөрөгчийн агуулага 4.24-4.68%, азотын агуулага 2%. А-516 мян.тн, В-5037.11 мян.тн, С1-91144.12 мян.тн, С2-9609.72, Р-197 сая.тн нөөцтэй. Цаашид судлах шаардлагатай.

Сутай уулын илрэл Дарви сумаас урагш 32.5 км-т байрлах бөгөөд 46°38'30", 93°35'10"-ын газарзүйн солбилцолд оршдог. 2-4 м зузаан, 4.5-5 км урт, нүүрсний үе тогтоосон. Үнслэг 32.66%, чийглэг 0.62%, дэгдэмхий хольц 36.45%, шаталтын дулаан 8484, хүхрийн агуулага 0.53% байна. Цаашид судлах шаардлагатай.

Ганц модны илрэл нь Манхан сумаас зүүн урагшаа 55 км-т байрлах бөгөөд 47°02'00", 92°30'30"-ын газарзүйн солбилцол дээр оршдог. Нүүрсний 5 үе ялгасан, нүүрсний зузаан нь 0.25-0.40 м. Үнслэг 22.4%, хүхрийн агуулага 0.48%, чийглэг 2.68%, дэгдэмхий хольц 27.46%, шаталтын дулаан 5056-6557 ккал, фосфорын агуулага 0.005%-тай байна. Р-40 мян.тн нөөцтэй. Цаашид судлах шаардлагатай.

Цагаан хадны илрэл нь Манхан сумын нутагт байрлах бөгөөд 46°59'30", 92°38'30"-ын газарзүйн солбилцол дээр оршдог. Нүүрсний 0.3-0.75% зузаантай 3 үе тогтоогдсон. Одоо ашиглаж байгаа.

Бачмарын хавцлын илрэл нь Манхан сумын нутагт байрлах бөгөөд 46°54'40", 92°49'20"-ын газарзүйн солбилцол дээр оршдог. 0.1-0.5 зузаан, 1.5-2 км урттай нүүрсний 1 үе тогтоогдсон. Үнслэг 25%, чийглэг 1.68%, дэгдэмхий хольц 37.45%, хүхрийн агуулага 0.28%, шаталтын дулаан 7859 ккал. Цаашид судлах шаардлагатай.

Рашааны урд хамрын илрэл нь Зэрэг сумаас зүүн хойшоо 38 км-т байрлах бөгөөд 47°02'50", 92°34'10"-ын газарзүйн солбилцол дээр оршдог. 2-3 м зузаантай нүүрсний 2 үе тогтоогдсон. Урт нь 3 км. Үнслэг 29%, чийглэг 1.78%, дэгдэмхий хольц 31.6%, хүхрийн агуулага 0.28%, шаталтын дулаан 7865 ккал байна. Цаашид судлах шаардлагатай.

Олон булгийн орд нь Булган сумаас 98 км-т байрлах бөгөөд 45°10'00", 91°20'00"-ын газарзүйн солбилцолд оршдог. 0.4-0.5 м зузаан, 1.5 км урттай гаруй мэшил хэлбэрийн нүүрсний давхаргатай. Үнслэг 39%, дэгдэмхий хольц 32.7%, хүхрийн агуулага 0.8%, шаталтын дулаан 4100 ккал/кг байна. С1-567.7 мян.тн, С2-1528.5 мян.тн нөөцтэй. Одоо ашиглаж байгаа.

Мөстийн илрэл нь Мөст сумаас баруун хойшоо 35 км-т байрлах бөгөөд 46°57'00", 92°34'00"-ын газарзүйн солбилцолд оршдог. Нүүрстэй үеийн зузаан 2-3 км. Ашиглаж байгаа.

### Нефть, хий дамжуулах хоолойн талаар

ОХУ, БНХАУ хоёр нь Уралын зүүн хэсгээс Алтайн хязгаараар дайруулж Монгол, Казакстан улсын хоорондуур хий дамжуулах хоолойг барихаар 2007 онд тохиролцсон бөгөөд түүнээ Шинзянь Уйгарын

районоос Шанхай хүртэл урд тавьсан хоолойтойгоо холбох зорилготой юм. Тиймээс уг хоолойг тавих тохиолдолд манай баруун бүс нутагт хийн хэрэгцээ их болсон үед уг бүс нутагт ОХУ-аас Баян-Өлгийн цаанаас хийн хоолой оруулж ирж болох юм.

**6.1.4.5 Авто болон төмөр зам, агаарын замын сүлжээ**

**6.1.4.5.1 Авто замын төлөвлөлт**

Баруун бүсийн дэд бүтэц, түүний дотор зам тээврийг хөгжүүлэхэд юуны урд доорхи хүчин зүйлсийг харгалзах шаардлагатай болно. Үүнд:

1. Бүс нутаг, аймгуудын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг Увсын Хар тарвагатай, Нүүрст хотгор, Хүдэн, Ховдын хөшөөт, Олон булаг, Говь-Алтайн Хүрэн гол, Зээгт, Мааньт зэрэг нүүрсний томоохон ордын ашиглалтыг нэмэгдүүлнэ.
2. Говь-Алтайн Тайшир Цээлийн төмөр, Хан Тайширын хром, Цагаан оломын фосфорит, Алаг уулын хөнгөн цагаан, Цагаан голын толигор, листовенит, Бугатайн Хөвчийн нурууны зэсийн хайгуулыг хийх шаардлагатай.

Баруун бүсийг амжилттай хөгжүүлэх, ялангуяа барилга, замын үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэхэд уг бүс дэх аймгуудын барилгын материалын үйлдвэрүүдийг сэргээх, өргөтгөх, зарим үйлдвэрийг шинээр байгуулах арга хэмжээг авах. Дээрх аймгуудад урд байгуулсан барилгын материалын үйлдвэрлэлийг сэргээхийн хамт барилгын төрөл бүрийн материал, түүний дотор зарим угсармал хийцүүдийг үйлдвэрлэх арга хэмжээ авах хэрэгтэй.

**Баруун бүс дэх авто замын чиглэл, хэмжээ, хучилтын байдал /Хүснэгт 6.15/**

| Д/д | Аймаг      | Асфальт бетон | Бетон | Хайрга | Сайжруулсан хөрсөн | Хөрсөн | Бүгд  |
|-----|------------|---------------|-------|--------|--------------------|--------|-------|
| 1   | Баян-Өлгий | 10.2          |       | 102.2  | 170.3              | 243.3  | 526   |
| 2   | Говь-Алтай | 4.5           |       | 73.4   | 64                 | 507.7  | 739.6 |
| 3   | Завхан     | 1.2           | 2.9   | 178.6  | 137.7              | 660.2  | 980.6 |
| 4   | Увс        | 115.3         |       | 33.8   | 45                 | 568.6  | 762.7 |
| 5   | Ховд       | 113.6         |       | 45.4   | 290.4              | 385.9  | 835.5 |

**Баруун бүсийн хатуу хучилттай болгох улсын чанартай автозамын төлөвлөлт, 2009-2021он /Хүснэгт 6.16/**

|    | Замын сүлжээ   | Зай, км |
|----|--|---------|
| 1  | Баянхонгор аймгийн баруун хил – Дэлгэр - Алтай хот – Ээвийн буудал – Ховдын Дарви – Манхан – Ховд                                    | 615     |
| 2  | Ховд хот – Толбо сум – Өлгий хот – Цагааннуур – Улаанбайшинт   | 300     |
| 3  | Бургастай – Алтай хот – Улиастай хот – Халзан согоотын даваа (Завхан, Хөвсгөлийн хил)  | 791     |
| 4  | Ховдын Ярантай – Булган - Үенч - Баянзүрх – Мөнххайрхан – Манхан – Ховд  | 360     |
| 5  | Ховд – Буянт – Мянгад – Өлгий – Улаангом – Түргэн – Сагил – Боршоо – Хандгайт  | 409     |
| 6  | Бургастай – Алтай хот – Улиастай хот – Яруу – Түдэвтэй – Баянхайрхан – Тэс – Арц суурь   | 918     |
| 7  | Хөвсгөл, Завханы хил – Завханы Тэс – Баруунтуруун – Зүүнговь – Улаангом – Түргэн - Үүрэг нуур – Бөхмөрөн – Цагааннуур – Улаанбайшинт | 670     |
| 8  | Даян – Улаан хус – Цагааннуур – Улаанбайшинт   | 205     |
| 9  | Өлгий-Улаандаваа   | 140     |
| 10 | Хөшөөт-Алтай-Байтаг  | 370     |
| 11 | Бургастай-Цээл /Мянганы зам/   | 70-110  |
| 12 | Бугат-Төгрөгийн хоорондох хөндлөн зам  | 40-60   |

**Аймгуудын замын сүлжээний урт, км /Хүснэгт 6.17/**

| Д/д | Аймаг      | Асфальт бетон | Бетон | Хайрга | Сайжруулсан хөрсөн | Хөрсөн | Бүгд  |
|-----|------------|---------------|-------|--------|--------------------|--------|-------|
| 1   | Баян-Өлгий | 10.2          |       | 102.2  | 170.3              | 243.3  | 526   |
| 2   | Говь-Алтай | 4.5           |       | 73.4   | 64                 | 507.7  | 739.6 |
| 3   | Завхан     | 1.2           | 2.9   | 178.6  | 137.7              | 660.2  | 980.6 |



|   |      |       |  |      |       |       |       |
|---|------|-------|--|------|-------|-------|-------|
| 4 | Увс  | 115.3 |  | 33.8 | 45    | 568.6 | 762.7 |
| 5 | Ховд | 113.6 |  | 45.4 | 290.4 | 385.9 | 835.3 |

Баруун бүсийн аймгуудын авто замын хэмжээ

Ховд аймгийн төв Ховд /Хүснэгт 6.18/

| Д/д | Сумдын нэр  | Тээврийн зай /км/ |
|-----|-------------|-------------------|
| 1   | Буянт       | 25                |
| 2   | Дуут        | 76                |
| 3   | Зэрэг       | 141               |
| 4   | Манхан      | 80                |
| 5   | Мөнххайрхан | 155               |
| 6   | Мянгад      | 41                |
| 7   | Ховд        | 32                |
| 8   | Эрдэнэбүрэн | 61                |
| 9   | Алтай       | 315               |
| 10  | Булган      | 314               |
| 11  | Дарви       | 205               |
| 12  | Дөргөн      | 102               |
| 13  | Мөст        | 180               |
| 14  | Үенч        | 305               |
| 15  | Хөшөөт      | 197               |
| 16  | Цэцэг       | 221               |
| 17  | Чандмань    | 146               |

Баян-Өлгий аймгийн төв Өлгий /Хүснэгт 6.19/

| Д/д | Сумдын нэр    | Тээврийн зай /км/ |
|-----|---------------|-------------------|
| 1   | Алтан цөгц    | 43                |
| 2   | Булган        | 294               |
| 3   | Буянт         | 72                |
| 4   | Дэлүүн        | 158               |
| 5   | Сагсай        | 27                |
| 6   | Толбо         | 76                |
| 7   | Улаан-Уул     | 134               |
| 8   | Цагаан нуур   | 69                |
| 9   | Цагаан- Уул   | 95                |
| 10  | Алтай         | 112               |
| 11  | Баян нуур     | 106               |
| 12  | Бугат         | 5                 |
| 13  | Буянт         | 72                |
| 14  | Ногоон нуур   | 92                |
| 15  | Нүүрст хонхор | 133               |
| 16  | Цэнгэл        | 79                |

Завхан аймгийн төв Улиастай /Хүснэгт 6.20/

| Д/д | Сумдын нэр | Тээврийн зай /км/ |
|-----|------------|-------------------|
|     | Бигэр      | 108               |
| 2   | Бугат      | 203               |
| 3   | Дэлгэр     | 88                |
| 4   | Тайшир     | 43                |
| 5   | Төгрөг     | 148               |
| 6   | Халиун     | 87                |
| 7   | Чандмань   | 189               |
| 8   | Шарга      | 79                |
| 9   | Эрдэнэ     | 223               |
| 10  | Алтай      | 318               |
| 11  | Баян-Уул   | 146               |
| 12  | Гуулин     | 89                |
| 13  | Дарви      | 186               |
| 14  | Жаргалан   | 85                |
| 15  | Тонхил     | 209               |
| 16  | Хөхморьт   | 215               |
| 17  | Цогт       | 187               |
| 18  | Цээл       | 167               |
| 19  | Чандмань   | 189               |

Говь-Алтай аймгийн төв Алтай /Хүснэгт 6.21/

| Д/д | Сумдын нэр     | Тээврийн зай /км/ |
|-----|----------------|-------------------|
| 1   | Алдархаан      | 32                |
| 2   | Булнай         | 181               |
| 3   | Идэр           | 75                |
| 4   | Их-уул         | 224               |
| 5   | Тэлмэн         | 122               |
| 6   | Цагаан хайрхан | 44                |
| 7   | Яруу           | 56                |
| 8   | Баянтэс        | 290               |
| 9   | Баянхайрхан    | 255               |
| 10  | Дөрвөлжин      | 143               |
| 11  | Завхан мандал  | 167               |
| 12  | Могойн гол     | 220               |
| 13  | Нөмрөг         | 152               |
| 14  | Отгон          | 128               |
| 15  | Сантмаргац     | 292               |
| 16  | Сонгино        | 232               |
| 17  | Түдэвтэй       | 196               |
| 18  | Тэс            | 337               |
| 19  | Тосонцэнгэл    | 181               |

Увс аймгийн төв Улаангом /Хүснэгт 6.22/

| Д/д | Сумдын нэр     | Тээврийн зай /км/ |
|-----|----------------|-------------------|
| 1   | Малчин         | 110               |
| 2   | Өлгий          | 111               |
| 3   | Тариалан       | 31                |
| 4   | Түргэн         | 34                |
| 5   | Тэс            | 158               |
| 6   | Хар тарвагатай | 89                |
| 7   | Хархираа       | 26                |
| 8   | Хяргас         | 180               |
| 9   | Цагаан хайрхан | 225               |
| 10  | Баруунтуруун   | 188               |
| 11  | Бөх мөрөн      | 180               |
| 12  | Давст          | 137               |
| 13  | Завхан         | 168               |
| 14  | Зүүнговь       | 134               |
| 15  | Зүүнхангай     | 339               |
| 16  | Наранбулаг     | 90                |
| 17  | Нүүрстхонхор   | 162               |
| 18  | Өмнөговь       | 119               |
| 19  | Өндөрхангай    | 268               |

1. Улаангом
2. Улаангом – Тарианы баг – Увс нуурын урдуур – Зүүнговь – Баруунтуруун – Завханы Тэс
3. Улаангом – Наранбулаг – Хяргас нуурын хойд бие – Завханы Сонгино-Түдэвтэй – Нөмрөг – Тэлмэн нуурын хойд тал – Тосонцэнгэл /Булнай/ - Зартын рашаан – Архангайн Цахир – Тариат сум
4. Баян-Өлгийн Цагаан нуур – Оготор Хамрын даваа – Үүрэг нуур – Увсын улаан даваа – Түргэн –

5. Баян-Өлгийн Алтай сумын Даян – Улаан хус – Цагаан нуур  
Даян – Цагаан нуурын 250 км урт энэ зам нь Баян-Өлгий, Увс аймгийг БНХАУ-тай харилцах боломж олгоно. Энэ нь цаашид ОХУ, БНХАУ-ын транзитийн ачаа, зорчигчдыг тээвэрлэх шинэ зам болж болох юм.
6. Ховд хот – Манхан сум – Улаан даваа – Үенчийн хавцал – Ховдын Булган – Ярантайн боомт
7. Мянганы зам: Улиастай – Дөргөн – Мянгад – Буянт – Ховд
8. Улиастай – Цагаан хайрхан сум – Цагаан чулуут – Говь-Алтайн Тайшир – Алтай хот – Төгрөгийн нүүрсний уурхай /Мааньтийн/ - Бугат сум – Алаг нуур – Аж богд – Алтай сумын баруун бие
9. Улиастай – Цагаан хайрхан – Отгон – Баянхонгорын Баянбулаг – Гурван булаг – Архангайн Шар усан даваа
10. Улиастай – Тэлмэн сум – Халзан согоотын даваа – Хөвсгөлийн цагаан уул
11. Улиастай – Загастайн даваа – Нөмрөг – Түдэвтэй – Баянхайрхан – Тэс – Арц суурын боомт
12. Архангайн Цэцэрлэг – Их тамир – Чулуут – Эгийн даваа – Баянхонгорын Жаргалант – Баянбулаг – Завханы Отгон сум
13. Архангайн Цахир – Хар Усны даваа – Отгон сум

ОХУ-ын тээврийн яам нь 1990-ээд оны эхээр Монгол дахь Элчин сайдын ямаараа дамжуулан Монголын баруун хэсгээр БНХАУ-ын Шинжан Уйгарын районтай харилцах зам харгуйн байдал, хэтийн төлвийг мэдэх хүсэлтээ тавьж байв. Манай тал нь уг чиглэлээр авто болон төмөр зам тавих асуудлыг дэмжсэн хариуг 1994 онд ОХУ-д өгчээ. Түүнээс хойш уг ажлын хэрэгжилт эхэлж ОХУ-Увс-Ховд-Ховдын Булганы Ярантай - БНХАУ-ын Такешены чиглэлийн авто замын барилгын их ажил эхэлсэн юм.

Эдүгээ Увсын Боршоо – Улаангом – Ховд хот – Манхан сум – Булган сум – Ярантайн боомт чиглэлийн 781.4 км замаас Боршоо – Улаангом-ын хооронд 112.6 км, Мөн Улаангом – Ховдын чиглэлд 40 км авто зам, Ярантайгаас – Булган сум хүртэл 64 км бүгд /112.6 км+40 км+64 км/ 216.6 км замыг сайжруулаад байна. Үлдэх 564.8 км /781.4 км -216.6 км / замын 212 кмыг Азын хөгжлийн банкны хөрөнгөөр, үлдэх хэсэг болох /564.8 км - 212 км/ 352.8 кмыг төсвийн хөрөнгөөр барих чигтэй байна. Баян-Өлгий – Цагаан нуур чиглэлийн 105 км замаас 30 кмыг Улсын төсвийн хөрөнгөөр бариад байна.

Ховд Өлгийн хооронд 245 км замыг барих хөрөнгийн асуудал хараахан шийдэгдээгүй байгаа бөгөөд Монголын тал нь түүнийг Хятадаас манайд урьд олгохоор тогтсон 300 сая юанаас 50 саяыг нь авч замд ашиглахаар урьдчилан төлөвлөөд байна. Эдгээр асуудлууд нааштай шийдэгдэж бүрэн хэрэгжсэн тохиолдолд баруун бүсийн босоо тэнхлэгийн 781.4 км, хэтээ тэнхлэгийн 350 км бүгд 1131.4 км бүрэн хатуу хучилттай замтай болох юм.

Увсын Боршоо – Улаангом – Ховд – Манхан – Булган – Ярантай чиглэлийн 781.4 км, Ховд - Өлгий – Цагаан нуур чиглэлийн 350 км зам нь баруун бүсийн аймгийг ОХУ-ын Тува, Алтайн хязгаар, БНХАУ-ын Шинжан Уйгарын район улмаар Казах улстай холбосон олон улсын гол зам болно.

Ховд – Алтайг холбосон одоогийн зам нь хөдөлгөөний эрчим багатай учир түүнийг эхний ээлжинд засч сайжруулах цаашид хатуу хучилттай болгох.

Говь-Алтайн Бургастай – Алтай хот – Тайшир – Улиастай – Тэлмэн - Халзан согоотын даваа – Мөрөн – Ханх чиглэлийн 1206 км замын гол хэсэг нь дээр үеэс тогтсон, баруун бүсийн гол хэсэгт ордог Завхан, Говь-Алтайг ОХУ, БНХАУ-тай холбосон уламжлалт зам бөгөөд нилээд хэсгийг нь засан сайжруулж Завхан, Богд, Мөрөн зэрэг гол дээр шаардлагатай төмөр бетон гүүр баригдсан юм.

Энэ зам нь баруун бүсийг улс орны төвийн хойд хэсэгтэй холбоход чухал зам болж ирсэн бөгөөд сүүлийн үед баруун бүсийг ОХУ-аас гадна БНХАУ-тай холбодог олон улсын чанартай замын нэг болж эхлэв. Тиймээс энэ чиглэлийн замыг эхний ээлжинд засч сайжруулахын хамт цаашид засмал болгох шаардлагатай. Мөн Тувагийн Кызылийн ойролцоох Элстэй рүү ОХУ-ын Баруун Сибирээс шинэ Баянхайрхан – Тэс – Арц суурийн чиглэлд үргэлжлүүлж засмал зөм тавих юм.

Баруун бүс дэх Хотгор, Хар тарвагатай, Хөшөөт, Хүрэн гол, Мааньт зэрэг нүүрсний томоохон ордыг цаашид өргөтгөн эзэмшихэд Хотгор, Өлгий, Хар тарвагатай – Улаангом, Ховд – Дарвайн Хөшөөтийн уурхайн хоорондох авто замыг сайжруулах шаардлага гарна. Ховдын Хөшөөтийн нүүрсний ордыг БНХАУ-тай хамтарч ашиглах, улмаар уг ордоос нүүрсийг Бургастай, Ярантай чиглэлд тээвэрлэх

АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ

90°0'0"E


93°0'0"E

96°0'0"E

99°0'0"E

Зураг 6.11

M 1:1 500 000



Танх тэмдэг

- Аймгийн төв
- Сумын төв
- Хилийн боомт
- Шатахуун түгээх станц
- Төлөвлөгдөж буй хот
- Төлөвлөгдөж буй нүүрсний уурхай
- Төлөвлөж байгаа болон барьж буй хагуу хучилттай зам /2015 он хүртэл/
- Төлөвлөж буй хагуу хучилттай зам /2016-2021 он/
- Төлөвлөж буй хагуу хучилттай зам /2021 оноос хойш/
- Мянганы замын тэнхлэг /ЭТАЖЯМ/
- - - Төлөвлөж буй болон төлөвлөлтөөс хойш
- Төлөвлөлтөнд оруулсан санал
- Гол
- - - Ширгэдэг гол
- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил
- Цэнгэг нуур
- Давстай нуур

90°0'0"E

93°0'0"E

96°0'0"E

42°0'0"N

42°0'0"N

48°0'0"N

99°0'0"E

42°0'0"N

тохиолдолд дээрхи чиглэлийн замыг сайжруулах, Хөшөөтөөс Бургастай хүртэл 340 орчим км зам тавих боломжийг судалж эхлэв.

Төмөр зам тавигдах болсонтой холбогдуулж Бургастай – Алтай – Улиастайгаас Яруу – Түдэвтэй –

Баруун бүсийг төвийн бүстэй доорхи чиглэлийн авто замаар холбохоор төлөвлөж байна. Үүнд:

1. Баянхонгортой одоогийн Баянхонгор Алтай чиглэлийн авто замаар
2. Баянхонгортой одоогийн Отгон сум – Улиастай чиглэлийн авто замаар
3. Архангайтай Завханы Отгон – Баянхонгорын Баянбулаг – Архангайн Эгийн даваа – Чулуут – Их тамир – Цэцэрлэг чиглэлийн авто замаар
4. Архангайтай Улиастай – Идэрийн хойд тал – Тээл – Нам даваа – Солонготын даваа – Тариат – Батцэнгэл – Цэцэрлэг чиглэлийн авто замаар
5. Баруун бүсийн хойд талын авто зам нь Хөвсгөлийн Цэцэрлэг – Завханы Баян тэс – Тэс – Увсын Баруун туруун – Зүүнговь – Тэс – Малчин сумдын нутаг – Улаангом – Үүрэг нуур – Бөхмөрөн – Цагаан нуур чиглэлээр
6. Увс, Завхан аймгууд нь Улаангом – Наранбулаг – Хяргас нуурын хөвөө /Айраг нуурын хоолой/ – Завханы Ургамал – Завханы Мандал – Эрдэнэхайрхан – Яруу чиглэлээр голлон харилцдаг. Харин зарим эрдсийг ашиглах, аялал жуулчлал хөгжүүлэх зорилгоор зарим хэсгийг засч сайжруулах
7. Ирээдүйд Олон нуурын зүүн бие, Хомын талд олон улс, улс, бүсийн чанартай томоохон хот байгуулахад хүрвэл түүнийг баруун таван аймагтай холбох шинэ авто зам, нисэх буудал байгуулах.

Баруун бүс нутагт ирээдүйд тавигдаж болзошгүй төмөр замтай зэрэгцүүлэн доорх засмал болон сайжруулсан авто зам тавигдах шаардлагатай болно. Үүнд:

1. Улаанбаатараас Баян-Өлгийн Цагаан нуур буюу баруун хил хүрдэг авто замыг Баянхонгороос цааш хуучин чиглэлийн дагуу засмал зам болгох
2. Ховдын Булганыг – Ховдтой, улмаар Ховдыг Увстай холбосон засмал замыг гүйцээж барих.
3. Хөвсгөлийн Мөрөн – Бүрэнтогтох – Цагаан уул – Цэцэрлэг – Завханы Тэс – Увсын Баруун туруун – Зүүн говь – Улаангом – Үүрэг нуур – Бөх мөрөн – Цагаан нуурыг холбосон засмал замыг цаашид тавих
4. Баян-Өлгийн Алтай сумын Даянгийн боомтыг Төв Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд холбох засмал замыг барих.
5. Өлгийг Хотгор, Хар Тарвагатайн нүүрсний уурхайтай, мөн Улаангомыг дээрх 2 уурхайтай холбосон замыг хэт нь барих
6. Тэлмэн – Цэцэрлэг – Цагаан уул – Бүрэнтогтох – Мөрөнг уламжлалт чиглэлээр холбох замыг цаашид тавих. Энэ замаас салаалуулж Идэр – Тосонцэнгэл – Их уул – Солонготын давааны чиглэлд зам барих
7. Архангайн Их Тамираас Баянхонгорын баруун тал, Завханы урд тал, Говь-Алтай руу орох замыг Чулуут сум, Эгийн давааны чиглэлээр, мөн Хангай сумын урд Тэрхийн эх Шар усны давааны чиглэлээр засаж сайжруулах

Баруун бүс нутагт авто замын барилга байгууламж, хөрш орнуудтай харилцах үйл ажиллагаа эрчимтэй хөгжиж байна. Уг бүс нутаг дахь монголын авто тээврийн хэрэгсэлийн тоо 16142-т хүрээд байгаа ба тэдгээр нь улсын бүх авто машины 10 хувийг эзэлж байна.

Баруун бүс нутагт хөрш ОХУ, БНХАУ-ын хооронд 2007 онд зорчсон зорчигчдын тоо 146.7 мянга, авто машины тоо 30.0 мянга, тээвэрлэсэн ачаа 106.6 мянган тоннд хүрч урдах жилүүдээсээ өссөөр байна. Уг тоог доорх хүснэгтэнд үзүүлэв.

Баруун бүсийн замын сүлжээ /Хүснэгт 6.23/

| Замын чиглэл   | Хэмжээ км | Нэгжийн өртөг, сая. доллар | Бүгд өртөг, тэрбум. доллар | Тайлбар |
|--|-----------|----------------------------|----------------------------|---------|
| I.Төмөр зам  |           |                            |                            |         |
| Арц суурь- Цагаан хайрхан – Дөрвөлжин – Алтай – Шинэ жинст | 950       | 1.2                        | 1140                       | -       |
| Алтай - Цээл   | 100       | 1.2                        | 120                        | -       |
| Цээл – Бурагстай   | 180       | 1.2                        | 216                        | -       |
| Цагаан нуур - Улаангом                                     | 230       | 1.2                        | 276                        | -       |
| Улаангом – Баруунтуруун – Цагаан толгой                    | 290       | 1.2                        | 348                        | -       |


|   |       |                 |          |  |
|---|-------|-----------------|----------|--|
| Бүгд  | 1680  |                 | 2100     |  |
| <b>II.Автозам</b>   |       |                 |          |  |
| 1. Говь-Алтайн Дэлгэр – Алтай хот – Шарга – Дарви – Ховдын Дарви – Зэрэг – Манхан – Ховд – Хашаатын даваа – Толбо – Өлгий хот – Цагааннуур – Улаан Байшинт  | 823   | 300,0мян.<br>\$ | 246,9сая | Олон аймаг, сумыг дайрсан уламжлалт зам бөгөөд олон эрдсийг дайрна.                          |
| 2. Говь-Алтайн Бургастай – Бугатын зүүн бие – Төгрөг сумын мааньтын нүүрсний уурхай – Алтай хот – Тайшир – Завханы Цагаанхайрхан – Ганцын даваа – Улиастай – Загастайн даваа – Тэлмэн – Халзан – Согоотын даваа                                   | 683,8 | 300,0мян.<br>\$ | 205,1сая | Олон сумыг дайрсан уламжлалт зам бөгөөд олон ордыг дайрна.                                   |
| 3. Говь-Алтайн Бургастай – Бугатын зүүн бие – Төгрөг сумын мааньтын нүүрсний уурхай – Алтай хот – Тайшир – Завханы Цагаанчулуут – Цагаанхайрхан – Ганцын даваа – Улиастай – Түдэвтэй – Баянхайрхан – Тэс – Арцсуурь – үүнээс Ховд – Улаан байшинт | 814,8 | 300,0мян.<br>\$ | 244,4сая | Олон сум суурин, гол эрдэс баялагыг дайрна.  |
| 4. Боршоо – Улаангом – Ховд – Манхан – Ярантай. Үүнээс засмал зам нь  | 781,8 | 300,0мян.<br>\$ | 234,5сая | Уламжлалт зам. Олон ордыг дайрна.  |
| 5. Баян-Өлгийн Алтай сумын Даян – Баян-Өлгийн Цагааннуур  | 235   | 300,0мян.<br>\$ | 70,5сая  | Шинэ чиглэлийн зам. Олон ордыг дайрна.   |
| 6. Хөвсгөл- Завханы хил – Баянтэс – Тэс – Баруунтуруун – Зүүнговь – Улаангом – Түргэн – Үүрэг нуур – Бөхмөрөн – Цагааннуур - Улаанбайшинт   | 63,6  | 300,0мян.<br>\$ | 190,8сая | Тарианы их талбай, олон сум, Увс, Баян-Өлгийн гол эрдсийг дайрна.                            |
| Бүгд  |       |                 | 1 272,3  |  |
| <b>III.Агаарын тээвэр</b>   |       |                 |          |  |
| Нисэх онгоцны бетон зурвас шинээр байгуулах   |       |                 |          |  |
| 1. Алтай хотод  |       |                 | 6,0сая   | Эдгээрт ажилыг эхлэх тендер зарлаад байгаа ба барилгын ажил энэ онд эхлэнэ.                  |
| 2. Завханы Доны хөндийд   |       |                 | 6,9сая   |  |
| 3. Улаангомд  |       |                 | 10,4сая  |  |
| 4. Өлгий хотод  |       |                 | 10,4сая  |  |
| 5. Ховдод зурвасыг өргөтгөхөд   |       |                 | 6,0сая   |  |
| 6. Тосонцэнгэл, Булганд одооны зурвасыг засч сайжруулахад   |       |                 | 2,0сая   |  |
| Бүгд  |       |                 | 41,7сая  |  |
| <b>IV.Усан замын тээвэр</b>   |       |                 |          |  |
| Хяргас,Хар ус нуурт аялал жуулчлал, загас агнуурт зориулж усан онгоц, моторт завь.  | 8м    | 1сая.\$         | 8,0сая   | 2008-2009оноос судлаж тооцох   |
| <b>V.Хий, нефть дамжуулах хоолой тавих</b>  |       |                 |          |  |
| 1. Агад – Улиастай - Алтай  | 492,5 | 1сая.\$         | 492,5сая | Алтайн хязгаарт хий дамжуулах хоолой ирсэн ба Тувад хий дамжуулах хоолой ирэх чигтэй байгаа. |
| 2. Боршоо – Увс – Ховд - Өлгий  | 600   | 1сая.\$         | 600,0сая |  |
| Бүгд  |       |                 | 1 092,5  |  |
| <b>VI.Дүүжинт тээвэр</b>  |       |                 |          |  |
|   | 3     | 1сая.\$         | 3,0сая   | Цамбагарав, Отгонтэнгэр, Сутайд гарахад  |
| Нийт дүн  |       |                 | 6 006,3  |  |

**БАРУУН БҮСИЙН АВТО ЗАМЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

/Сая төгрөгөөр/

| Д/д | Төсөл , арга хэмжээний нэр                                   | Хүчин чадал   | Төсөвт өртөг      | Тайлбар  |
|-----|--|---------------|-------------------|--|
| 1   | Булган-Үенч –Ховд чиглэлийн авто зам                         | 40,0          | 6 800,00          | Барилгын ажил хийгдэж байгаа. 2010 онд ашиглалтад орно   |
| 2   | Булган-Үенч –Ховд чиглэлийн хатуу хучилттай авто зам         | 20,0          | 3 489,01          | Барилгын ажил хийгдэж байгаа. 2010 онд ашиглалтад орно   |
| 3   | Ховд- Манхан чиглэлийн хатуу хучилттай авто зам              | 85,3          |                   | Гүйцэтгэгчийн тендер зарлаад байгаа. 2011 онд ашиглалтад орно  |
| 4   | Ховд- Өлгий чиглэлийн хатуу хучилттай авто зам               | 214,4         | 105 806,00        | БНХАУ болон АХБ-ын зээлээр барина.Толбо-Өлгий чиглэлийн 76 км-ын Гүйцэтгэгчийн тендерийг зарлаад байна. 2012 онд ашиглалтад орно |
| 5   | Өлгий- Цагаан нуурын чиглэлийн хатуу хучилттай авто зам      | 40,0          | 13 320,00         | Барилгын ажил хийгдэж байгаа. 2011 онд ашиглалтад орно   |
| 6   | Цагаан нуур- Улаанбайшинт чиглэлийн хатуу хучилттай авто зам | 32,7          | 12 100,00         | Зураг төсөлт.Улсын төсвийн хөрөнгөөр 2010-2011 онд барина  |
| 7   | Өлгий- Улаангомьн чиглэлийн хатуу хучилттай авто зам         |               |                   | Зураг төсөлгүй 2014 оноос барьж эхэлнэ   |
| 8   | Цэцүүх Тосонцэнгэл чиглэлийн хатуу хучилттай авто зам        | 80,0          | 28 000,00         | Зураг төсөлтэй, Улсын төсвийн хөрөнгөөр 2010-2011 онд барина   |
| 9   | Улаангом –Хандгайт чиглэлийн хатуу хучилттай авто зам        | 55,2          | 4 899,70          | 2007 онд ашиглалтад орсон  |
| 10  | Манхан- Үенч чиглэлийн хатуу хучилттай авто зам              | 216,3         | 71 346,00         | АХБ-ны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2009-2011 онд барина. Гүйцэтгэгчийн тендер зарлагдсан                                      |
| 11  | Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн хатуу хучилттай авто зам      | 180,7         | 66 870,10         | Зураг төсөл боловсруулагдаагүй. 2011-2013 онд барина.  |
| 12  | Ховд-Улаангомьн чиглэлийн хатуу хучилттай авто зам           | 195,0         | 68 250,00         | Зураг төсөл боловсруулагдаагүй. 2012-2014 онд барина.  |
| 13  | Улиастай-Мянгадын гүүр чиглэлийн хатуу хучилттай авто зам    | 455,0         | 163 363,20        | Зураг төсөлгүй. 2013 оноос барьж эхэлнэ  |
| 14  | Баянхонгор-Алтай чиглэлийн хатуу хучилттай авто зам          | 398,0         | 142 636,80        | Зураг төсөл боловсруулж байгаа.272 км-ийг 2011 оноос барьж эхлүүлнэ. Үлдэгдэл хэсгийг 2012 оноос эхэлнэ                          |
| 15  | Улиастай-Алтай-Бургастай чиглэлийн хатуу хучилттай авто зам  | 512,0         | 183 827,00        | Зураг төсөл боловсруулагдаагүй. 2014 оноос барьж эхэлнэ.   |
| 16  | Улаангом-Баруун туруун-Арцсуурийн чиглэлийн авто зас         | 180.0         | 64 627.0          | Ойрын хугацаанд барих шаардлагатай   |
| 17  | Мөрөн-Тосонцэнгэл чиглэлийн хатуу хучилттай авто зам         |               |                   | Ойрын хугацаанд барих төлөвлөгөөгүй  |
| 18  | Шивээхүрэн-Баянхонгор- Улиастай- Арцсуурийн авто зам         |               |                   | Хятадын төвийн хойд хэсэг, ОХУ-тай харилцах өндөр үр ашигтай тул 2011 оноос ТЭЗҮ хийх  |
|     | <b>Нийт</b>  | <b>2524,6</b> | <b>870 707,81</b> |  |

АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭ ,ТӨЛӨВЛӨЛТ М1:10 000 000



Таних тэмдэг

- Аймгийн төв
- Хилийн боомт
- Төлөвлөж буй хот
- Барьж буй хатуу хучилттай авто зам /2015 он хүртэл/
- Төлөвлөж буй хатуу хучилттай авто зам /2011-2015 он /
- Төлөвлөж буй хатуу хучилттай авто зам /2011-2015 он / ЗТБХБЯамны санал
- Төлөвлөж буй хатуу хучилттай авто зам /2021 оноос хойш/
- Мянганы замын тэнхлэг /ЗТАЖЯам/
- - - Төлөвлөж буй болон төлөвлөлтөөс хойш
- Төлөвлөлтөнд оруулсан санал
- Улсын хил
- Аймгийн хил
- Төмөр зам
- Хурдны зам
- Улсын чанартай авто зам
- Орон нутгын чанартай авто зам

Монгол улс, ОХУ, БНХАУ-ын хооронд зорчсон зорчигч авто тээврийн хэрэгсэл ачаа эргэлтийн судалгаа /Хүснэгт 6.24/

| №     | Боомтын нэр | Он     |                   |         |          |                   |         |          |                   |         |
|-------|-------------|--------|-------------------|---------|----------|-------------------|---------|----------|-------------------|---------|
|       |             | 2005   |                   |         | 2006     |                   |         | 2007     |                   |         |
|       |             | Ачаа   | Тээврийн хэрэгсэл | Зорчигч | Ачаа     | Тээврийн хэрэгсэл | Зорчигч | Ачаа     | Тээврийн хэрэгсэл | Зорчигч |
| ОХУ   |             |        |                   |         |          |                   |         |          |                   |         |
| 1     | Цагааннуур  | 112572 | 10007             | 48042   | 108253.6 | 9200              | 45102   | 19468.4  | 9430              | 38151   |
| 2     | Боршоо      | 43861  | 1991              | 13433   | 35944.2  | 3501              | 23539   | 21205.8  | 4207              | 28341   |
| 3     | Тэс         | 2441   | 339               | 1478    | 320.4    | 774               | 4955    | 426.2    | 1417              | 12382   |
|       | Дүн         | 158874 | 12337             | 62953   | 144518.2 | 13475             | 73596   | 41200.4  | 15054             | 78874   |
| ШУӨЗО |             |        |                   |         |          |                   |         |          |                   |         |
| 1     | Бургастай   | 174217 | 3013              | 6204    | 239121.8 | 1774              | 3483    | 23028.1  | 1952              | 3597    |
| 2     | Байтаг      | 2293   | 1818              | 5371    | 703      | 1466              | 4166    | 1929.3   | 1090              | 3127    |
| 3     | Булган      | 5648   | 14973             | 54338   | 14100.7  | 11826             | 54047   | 29281.4  | 11660             | 54398   |
| 4     | Даян        | 2530   | 95                | 248     |          | 14                | 113     |          | 290               | 826     |
| 5     | Өлгий       | 70650  | 107               | 2587    | 96100.1  | 104               | 4115    | 7660.1   |                   | 5882    |
|       | Дүн         | 255338 | 20006             | 68748   | 350025.6 | 15184             | 65924   | 61898.9  | 14992             | 67830   |
|       | Бүгд        | 414212 | 32343             | 131701  | 494543.8 | 28659             | 139520  | 103099.3 | 30046             | 146704  |

Ачаа эргэлт үүсч болох Хятадын хойт хэсгийн эрчимтэй хөгжиж байгаа үйлдвэрлэл худалдааны бүсийг Алтайн хязгаарын Тува, ОХУ-тай холбоход Өмнөговийн Шивээхүрэн-Баянхонгор- Улиастай-Арцсуурийн чиглэлийн замыг байгуулах шаардлага гарч байна. Иймд зураг хайгуул, судалгаа, техник , эдийн засгийн үндэслэлийг боловсруулахаар төлөвлөв.

**6.1.4.5.2 Төмөр замын төлөвлөлт**

1990-ээд оны эхээр Өмнөд, Умард Азийг холбосон их төмөр замыг Энэтхэгийн хойд талын Сринагараас БНХАУ-ын Хөх нуурын Монголын төв Яргай хотоор дайруулж Монголын баруун талаар тавих саналыг Энэтхэгийн тал гаргаж байв. Мөн ОХУ-ын талаас Монголын баруун талаар Сибирь, Хятадын баруун талыг холбосон шинэ төмөр болон авто зам тавих асуудлаар Монголын талын саналыг авахтай холбоотой албан ёсны хүсэлтийг манай засгийн газарт тавьж байжээ. Хятадын тал нь НҮБ-н шугамаар Монголын төмөр замыг хөгжүүлэх томоохон төслийг 2007 онд боловсруулж манайд шилжүүлсэн юм.

Энэ төсөл нь Монголын одоогийн гол төмөр замыг өргөтгөн хөгжүүлэхийн зэрэгцээгээр Хятадын талаас Өмнөговь аймгийн Гурван тэс сумын Нарийн Сухайтын нүүрсний уурхай – Гурван тэс сум – Баянхонгорын Шинэжинст сумын нутаг дах Сүүжийн нүүрсний уурхай – Говь-Алтай аймгийн Чандмань сумын Зээгтийн нүүрсний уурхай – Алтай хот – Ховд аймгийн Ховд хот – Баян-Өлгий аймгийн Өлгий хот – Цагаан нуурын дамжлага бааз – ОХУ-н Алтайн хязгаарын Бийск хот оруулж ОХУ-ын төмөр замтай холбогдож болно гэж үзсэн. Замын нийт урт нь Шивээ Хүрэнгээс – Цагаан нуур хүртэл 1364 км болно.

Энэ зам нь Монголын Өмнөговь, төв хэсгийн баруун өмнөд хэсэг /Баянхонгорын өмнөд хэсэг/, баруун бүсийг / Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан/ Хятадын төв хэсэг, ОХУ-н баруун Сибирь, улмаар Европтой холбох, мөн Өмнөд болон Умард Азийг холбох транзитийн шинэ дөт зам болох боломжтой юм. Энэ зам нь Монголын эрдэс баялагийн их сан болох Алтай, Хангайн уулсын заагаар гарах бөгөөд түүнд эрдсийн одоо илрээд байгаа олон том орд, цаашид орд болж болох томоохон илрэлүүд нь их хэмжээний ачаа эргэлт үүсгэх боломжтой ордууд юм.

1. Өмнөговийн Гурвантэсийн чулуун нүүрсний Нарийн сухайтын орд. Түүний нөөц нь урьдчилсан байдлаар 400 гаруй сая тонн болоод байна.
2. Мөн сумын Эрдэнэ уулын 100 шахам км үргэлжилдэг Баргилтын том орд
3. Мөн Гурвантэсийн Алтан уулаас эхлэн Баян-Өлгийн баруун хил хүртэл үргэлжилдэг зэс, алтны олон орд, илрэц



4. Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Сүүж, Эхийн гол, Говь-Алтайн Чандманы Зээгт, Мааньт, Хүрэн гол, Ховдын Дарвийн Хөшөөт, Увсын Хотгор, Хар Тарвагатай зэрэг сайн чанарын нүүрсний орд
5. Говь-Алтайн Цагаан олом, Завханы Алдархааны фосфорит
6. Говь-Алтайн Дарвийн Алаг уул, Завханы Алдархаан, Баян-Өлгийн Буянтийн хөнгөн цагаан
7. Завханы Яруу, Ховдын Дөргөний марганец
8. Говь-Алтайн Нарангийн Цагаан голын лиственит, толигор
9. Баянхонгорын Баянлиг, Баян-Өндөр, Говь-Алтай, Ховдын их кварц
10. Ховдын урд, Баян-Өлгийн Толбо, Увсын баруун талын сайн чанарын хайлуур жонш
11. Говь-Алтайн Тонхил, Ховдын Бодонч, Зэргийн гялтгануур
12. Баруун бүсийг нефьт, шатдаг хий байж болзошгүй гэж үзэн олон улсын хайгуулын тендер зарлаж Өмнөговийн Ховд аймаг хүртэлх Алтайн ар, өврийн их хөндийнүүд, Увс, Хяргас нуурын сав газар, Хомын талын орчинд зайнаас тандан судлах ажил хийж байна.
13. Өмнөговийн Гурвантэс, Баянхонгорын баруун тал, Говь-Алтайн Цээл, Тайшир, Хасагт хайрхан, Завханы Богд, Загастай, Увсын Ханхөхийн төмөр
14. Өмнөговийн Гурвантэсийн Бажуунатай, Баянхонгорын Шинэжинст, Баян-Өндөрийн нутаг, Говь-Алтайн Хүнхэр зуслан, Баян уул, Хөх морьтын шохойн чулуу

Газар нутаг ихтэй, хүн ам олонтой, эрдэс баялаг ихтэй, Алтай, Хангайн завсраар тавигдах төмөр замаас гадна хэтийн ирээдүйд Эрдэнэт, Мөрөн – Бүрэнтогтох – Цагаан уул – Цэцэрлэг сум – Завханы Тэс – Увсын Баруун туруун – Улаангом, Үүрэг нуур, Бөх мөрөн, Цагаан нуур чиглэлд шинээр төмөр зам тавигдаж болох юм.

Оросын тал нь ирээдүйд Тувагийн Кызылээс Бага Енисейг өгсүүлэн Дархадын хотгор – Мөрөн чиглэлд төмөр зам тавих шаардлага гарч болох талтай гэж үздэг. Энэ нь Хөвсгөлийн нутагт буй фосфорит, хөнгөн цагаан, бал чулуу, марганец, титан, барилгын зарим материал зэргийг ашиглахтай холбоотой. Ер нь Оросын талаас манай руу оруулж ирэх төмөр болон авто зам нь аж ахуйн зориулалтын зэрэгцээгээр цэрэг стратегийн зориулалттайг их чухалчилдаг.

Баруун бүс нутгийг улс орны төв, ялангуяа түүний хойд хэсэгтэй холбох төмөр болон авто зам нь Хөвсгөл аймаг, ОХУ-тай түүний дотор Туватай харилцах шинэ боломжийг нээж болно. Өмнөговийн Гурван тэсийн Нарийн Сухайт – Баян-Өлгийн цагаан нуур чиглэлийн төмөр замаас баруун бүс нутгийн аймгуудыг хооронд нь болон ОХУ, БНХАУ-тай холбосон доорхи чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр замыг цаашид барих шаардлага гарах төлөвтэй байна. Үүнд:

1. Зам тээвэр, аялал жуулчлалын яамнаас боловсруулсан төсөлд төмөр замыг Алтай хотоос Жаргалант – Баян уул сум, Завханы Дөрвөлжин, Сантмаргац – Тэс – Арц суурь – Тувагийн Эрзин чиглэлээр тавихаар тусгажээ. Энэ чиглэл нь голчлон газрын цагааныг харгалзсан сайн талтай гэсэн ч тухайн үед мэдэгдэж буй цаашид орд болж болох гол газруудаас нилээд алслагдсан муу талтай.
2. Мөн яамны боловсруулсан өөр нэгэн хувилбарт төмөр замыг Өмнөговийн Нарийн Сухайт – Баянхонгорын төв – Бууцагаан – Хүрээ манал – Дөрвөлжин – Говь-Алтайн Дэлгэрэх – Тайшир – Жаргалант – Баянуул, Завханы Тэс, Арцсуурийн чиглэлд тавихаар төлөвлөжээ. Энэ замын чиглэлийг ялимгүй өөрчлөн шинээр байгуулах Сутай хоттой холбох шаардлагатай.

Эдгээр 2 хувилбараас гадна доорхи хувилбар байж болох талтай. Нарийн Сухайт, Гурван Тэс, Баянхонгорын Шинэжинст – Яруу – Түдэвтэй – Баянхайрхан – Тэс – Арцсуурь - Тувагийн хил, Говь-Алтайн Тайшираас Завханы Арц суурь хүртэлх төлөвлөсөн төмөр замын дагуу байгалийн онцгой саад тохиолдохгүй. Энэ төмөр зам нь Завханы хойд талын их элсний зүүн талаар гарах бөгөөд уг замын ойролцоо Тайшир сумын Цахиурт, Алтангадасын нүүрс, Тайшир, Хасагт хайрханы төмөр, Цагаан хайрхан, Цагаан чулуут, Отгон сумын шохойн чулуу, гантиг, боржин, хайлуур жонш, Алдархааны фосфорит, хөнгөн цагаан, Загастайн төмөр, Яруугийн маганец, Нөмрөг, Баянхайрханы хайлуур жонш, Оюутын зэс зэрэг ашигт малтмал, хайрга, элс зэрэг барилгын материалын олон орд, томоохон илрэлүүд байдаг.

Мөн Тэс, Баян уулын тариалангийн их талбайг уг зам дайран өнгөрнө. Тэс сум нь зарим жилд хураасан нийт ургацаар улсад тэргүүлэх байр эзэлж, буудайгаа Увсын гурилын үйлдвэрт нийлүүлдэг байв. Тэс нь тэжээлийн томоохон аж ахуй байсан бөгөөд тэндээс баруун аймгуудыг малын тэжээлээр хангадаг байв. Тэс, Баян тэсийн тариалан, Тэсийн тэжээлийн аж ахуйг сэргээх явдал ачаа эргэлт үүсгэх болно.

Завхан, Алтайг холбосон төмөр зам нь Алтай – Шаргын говийн зүүн тал – Төгрөг сумын Маантийн уурхай – Бугат сумын Хөвчийн нурууны зүүн тал – Алаг нуурын баруун бие – Алтай сумын Бургалтай боомтоор урагш гарч БНХАУ-ын их говийн хойд талаар тавьж буй төмөр замтай нийлж цааш Синзян Уйгарын район, улмаар Дундад Азийн төмөр замтай холбогдоно. Алтай хотоос Бургалтай хүртлэх төмөр замын урт нь 322.3 орчим км юм. Үүний үр дүнд Говь-Алтайн Бургастай –

Бугатын зүүн бие – Төгрөг сумын Мааньтын нүүрсний уурхай – Шарга – Дарви – Ургамал – Зүүнхангай – Тэс – Арцсуурь төмөр замын урт нь 710,8 км болно.

Говь-Алтайн Бургастай- шинээр байгуулагдах Сутай – Завханы Арцсуурийг холбосон төмөр зам нь босоо тэнхлэгийн зөмөр замаар 7-8 цагийн дотор монгол орныг нэвтрэх өнгөрөх боломжтой бөгөөд газрын хэвгий нь 1-3 хэмийн налуутай, зам барилгын ажил явуулахад онцын хүндрэл багатай, баруун бүсээр дайран өнгөрөх хөндлөн тэнхлэгийн төмөр замаас 1,3 дахин дөт, зогсоолын тоо хэвтээ тэнхлэгийн төмөр замаас 2 дахин цөөн, ачаа эргэлт хийх боломж нь 2 дахин их байх олон давуу талтай юм. Хоёр улсыг холбосон энэхүү транзит зам нь гүний гааль худалдааны чөлөөт бүс болох Сутай хотыг дайхан өнгөрөхдөө олон улс, бүс нутаг, орон нутгийн хэмжээний зорчигч тээвэрлэх, их хэмжээний хүдэр, уул уурхайн боловсруулсан бүтээгдэхүүн тээвэрлэх юм.

Баруун бүсийн төмөр замын бас нэг хувилбар нь Тувагийн хил – Увсын Тэс сумын Шар суурь – Хан-Хөхийн зүүн бие – Завханы Ургамал – Хар ус, Дөргөн нуурын зүүн бие /Хомын тал/ - Ховдын Дарви сумын Хөшөөтийн нүүрсний орд – Говь-Алтайн Алтай сумын Бургалтайн боомт – БНХАУ-ын хил хүртэл тавигдаж болох юм. Энэ замын урт нь 1400 орчим км болно. ОХУ нь Хакасын Абакан хотоос зүүн тийш оршдог Курагино өртөөнөөс Тувагийн нийслэл Кызылийн өмнөд хэсэг дэх Элстэй нүүрсний том орд хүртэл 460км төмөр зам тавихаар 2007 онд шийдвэрлэв.


Элстэйн сайн чанарын нүүрсний ордны нөөц нь 21 тэрбум тонн буюу манай Таван толгойгоос 3 дахин их юм. Уг нүүрсний ордын үлэмжхэн хэсэг нь коксждог ажээ. Уг замыг ойрын үед тавьж эхлэхээр зураг хайгуулын ажил хийсэн. Уг зам нь аж ахуй, стратегийн чухал ач холбогдолтой юм.

Баруун бүсийн төмөр болон авто замаар доорхи үндсэн ачааг тээвэрлэнэ. Үүнд:

1. Увсын Хар тарвагатай, Хотгор, Ховдын Дарвийн Хөшөөт, Говь-Алтайн Төгрөгийн Мааньт, Хүрэн гол, Чандманы Зээгтийн нүүрсийг дотоодод болон Говь-Алтайн Бургастай, Өмнөговийн Шивээ хүрэнгээр экспортлохоор тээвэрлэнэ.
2. Завханы Алдархааны Цахир, Говь-Алтайн Цагаан Оломын фосфоритыг Хятадад экспортлохоор Бургастайгаар тээвэрлэнэ.
3. Говь-Алтайн Цээл, тайшир, Завханы Загастай, Увсын Ханхөхий орчмын төмөрийг Хятадад экспортлохоор Бургастайгаар тээвэрлэнэ.
4. Завханы Алаг Цахир, Говь-Алтайн Алаг уулын хөнгөнцагааны хүдрийг Хятадад экспортлохоор Бургастайгаар тээвэрлэнэ.
5. Баян-Өлгийн Толбо, Увсын Сагил, Ховдын Манхан, Завханы Нөмрөг, Отгон, Баянхайханы хайлуур жоншийг Баян-Өлгийн Цагаан нуур, Завханы Арцсууриар ОХУ-руу тээвэрлэнэ.
6. Завханы Яруу, Ховдын Дөргөний марганци, Баян-Өлгийн Улаан уул, Цүнхэгийн гянтболд, Баян-Өлгийн Асгатын мөнгө, титан, Говь-Алтайн Хантайширын хром зэрэг ОХУ-ын сонирхдог эрдсийг Баян-Өлгийн Цагаан нуур, Завханы Арцсууриар ОХУ-руу тээвэрлэнэ.
7. Монголоос ОХУ, БНХАУ-д уламжлалт түүхий эдийг голлон тээвэрлэн гаргах бөгөөд тэдгээрээс мөн уламжлалт техник, барилгын материал, өргөн хэрэгцээний барааг тээвэрлэнэ.
8. БНХАУ, ОХУ, Европын орнуудын хооронд, түүний дотор Умард, Өмнөт Азийн хоорондох их хэмжээний ачааг тээвэрлэх бөгөөд энэ нь цаг хожих, тээврийн зардал хэмнэх шинэ боломж олгоно.

Уг замаар одоогийн манай төмөр замаар тээвэрлэж буй ачаанаас илүү ачаа, зорчигчдыг транзитаар тээвэрлэх боломжтой болно. Тус зам нь Элстэйн нүүрсний орд руу хүрч очиж баруун тийш үргэлжилж Увсын хойд хилийн Хандгайт хүрдэг бөгөөд Тувагийн тал тэндээсээ их хэмжээний нүүрс олборлон манай нутгаар 130 км замаар дамжуулан Цагаан нуураар гаргаж өөрийн баруун талд оршдог Мөнгөн тайгын баруун биед хүргэдэг байсан юм. Сүүлийн үед нутагтаа уулын их авто зам засч нүүрсээ баруун талруугаа шууд тээвэрлэж хүргэдэг болов. Элстэйн орд нь манай Увс, Завханы хойд хилийн цаана байгаа сайн чанарын 200 шахам км урт үргэлжилсэн нүүрсний аварга орд юм.

Тувагийн тал нь Элстэйд ирэх төмөр замаа Тагны нурууны ар дахь 200 шахам км үргэлжилсэн их нүүрстэй Үлэг хэмийн хотгороор баруун тийш тавин Чаданы нүүрсний уурхай улмаар Хандгайт, Боршоо хүргээд урагш Улаангом – Ховд – Манхан – Үенчийн хавцал – Булган сум – Ярантай хүртэл төмөр зам тавьж БНХАУ-ын Синзян Уйгарын районотой харилцах саналтай байгааг харгалзан хүлээн авч судлах шаардлагатай.



Харин зам тээвэр аялал улчлалын яам нь Нарийн Сухайтаас Цагаан нуур хүрэх замаас Ховдын Манханы орчмоос салаалуулж Үенчийн хавцал – Булган сум – Ярантай хүртэл төмөр зам тавих нь зүйтэй. Завхан – Алтай хот – Бургалтайг холбох төмөр замын ойролцоо Алтай хотоос Бургалтай хүртлэх зам дахь Хантайширын хром, Мааньт, Хүрэн голын нүүрс, Таянгийн төмөр, Хөвчийн нурууны зэс, Аж Богдын алт, кварц, Алаг хайрханы шохойн чулуу, Буурын давс зэрэг төрөл бүрийн эрдэс баялагийн томоохон орд илрэлүүд бий.

Завхан, Ховдын дундуур тавигдаж болзошгүй төмөр замын ойролцоо Баруун турууны шохойн чулуу, Хан-Хөхийн төмөр, хайлуур жонш, зэс, Увс, Тэс, Хяргас, Ховдын олон нуурын хотгор, Шаргын говь зэргийн нефть, хийн илрэл, Завханы Сантмаргацын Дэвтээрийн давс, Ховдын Дөргөний Чаргайтын марганец, Ховдын Дарвийн Хөшөөтийн нүүрс, Оюутын зэс, Цагаан Оломын фосфорит, Говь-Алтайн, Дарвийн, Оюутын зэс зэргийн орд, ирээдүйтэй байж болзошгүй томоохон илрэлүүд бий.

ЗТАЖЯ-аас 2006 онд боловсруулсан үндсэн чиглэлдээ баруун бүст төмөр зам тавихад ТЭЗҮ боловсруулах зорилгоор 2009-2011 онд 2 үе шаттай 2,08 сая америк доллар зарцуулахаар төлөвлөсөн юм.

**Баруун бүсийн төмөр замын эдийн засагт үзүүлэх өгөөж /төмөр зам байгуулагдсан эхний жилд/**

/ Хүснэгт 6.25 /

| № | Төмөр замын чиглэл  | Урт, км | Нэгж өртөг сая USD | Бүгд үнэ тэрбум USD |
|---|---|---------|--------------------|---------------------|
| 1 | Арцсуурь-Цагаан хайрхан-Дөрвөлжин-Алтай-Шинэ жинст-Шивээхүрэн | 950     | 1.2                | 1140                |
| 2 | Алтай-Цээл  | 100     | 1.2                | 120                 |
| 3 | Цээл-Бургастай  | 180     | 1.2                | 216                 |
| 4 | Цагаан нуур- Улаангом   | 230     | 1.2                | 276                 |
| 5 | Улаангом-Баруунтуруун-Цагаан толгой                           | 290     | 1.2                | 348                 |
|   | Бүгд  | 1680    |                    | 2100                |

**Монголын Баруун бүс нутгийн төмөр замд хувийн хөрөнгө оруулалт хийх хувилбар болон жишээнүүд**

Монгол улсын стратегийн ач холбогдол бүхий Оюу Толгой зэрэг уурхайнуудын хөгжилд 1 тэрбум гаруй ам. долларын өртөг бүхий цахилгаан станц, төмөр зам шаардлагатай байна. Засгийн газар жилдээ дээд тал нь 100 сая ам. Долларын санхүүжилтийг өөрийн төсвийн орлогоос Өмнөговь аймгийн дэд бүтцэд /цахилгаан, тээвэр, усан хангамж, орон байр/ зориулан санхүүжүүлэх боломжтой байгаа бөгөөд хэрэв эдгээр объектуудыг барьж байгуулах ажлыг урагшлуулая гэвэл хувийн секторын хөрөнгө оруулалтыг ашиглах шаардлага гарч байна. Энэхүү илтгэл нь төмөр замын салбарт хувийн секторын хөрөнгө оруулалтыг оруулах боломжийн хувилбаруудыг дүгнэн авч үзэж байгаа бөгөөд ялангуяа дэд бүтцийн асуудал илүү анхаарал хандуулж, олон улсын холбогдох жишээ баримтууд болон тэдгээрт тусгагдаж байгаа гол гол асуудлыг хөндөж байгаа болно.

Төмөр зам барьж байгуулах болон ажиллуулах асуудалд хувийн сектор оролцох олон янзын арга зам байна.

**Шинэ төмөр замын төсөлд хувийн секторын оролцооны хэлбэрүүд /Хүснэгт 6.26/**

|                                    | Санхүү төмөр зам тавих | Төмөр замын ажиллагаа, засвар үйлчилгээ             | Санхүү галт тэрэгний засвар үйлчилгээ | Галт тэрэгний үйлчилгээ |
|------------------------------------|------------------------|---|---------------------------------------|-------------------------|
| Галт тэрэг авах контракт           | Улсын                  | Улсын   | Хувийн                                | Улсын болон хувийн      |
| Галт тэрэгний ажиллагааны концесси | Улсын                  | Улсын   | Хувийн                                | Хувийн                  |
| Дэд бүтцийн концесси               | Хувийн                 | Улсын буюу хувийн /хувийн секторт төлбөрийн лизинг/ | Улсын буюу хувийн                     | Улсын буюу хувийн       |

|  |        |        |                   |                   |
|--|--------|--------|-------------------|-------------------|
| Дэд бүтцийн байгууламж, ажиллагааны концесси | Хувийн | Хувийн | Улсын буюу хувийн | Улсын буюу хувийн |
| Интеграцийн концесси                         | Хувийн | Хувийн | Хувийн            | Хувийн            |

**Төмөр зам тавихтай холбогдсон гадаад улсын жишээ**

Аль нэг компани /компаниуд/ зөвхөн өөрийн хэрэгцээнд зориулан барьж байгуулсан төмөр зам болон гуравдагч тал өөрсдийн хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглах буюу төмөр зам ажиллуулагчийн үйлчилгээнд бүрэн хамрагдах энэ хоер нь эрс тэс ялгаатай юм. Сүүлийн 50 орчим жилд тавигдсан төмөр замын ихэнхи нь эхний хэлбэрээр ажиллаж байна. Энд Бразилийн Каражасын хүдэрийн шугам, Мавритай баруун Африк дахь хүдэрийн шугам зэргийг жишээ татаж болно. Энэ хоер замыг хоёуланг нь уурхай –төмөр зам –порт гэсэн төслийг хүрээнд зөвхөн уурхайн үйлдвэрлэж байгаа хүрийг тээвэрлэх зориулалтаар \аль аль дэлхийн банкны тусламжтайгаар \тавьсан байна. Гэхдээ,энэ хоер замыг зөвхөн өөрсдийн хэрэгцээнд зориулан тавьсан хувийн төмөр зам бөгөөд аль нэг гуравдагч талд ямар нэг үүрэг хүлээдэггүй бөгөөд харин зарим үед албан бус зорчигч тээврийн үйлчилгээг аль аль нь үзүүлдэг байна.

Энэ нь гуравдагч талын ачаа тээврийг гүйцэтгэх эсвэл төмөр замыг тавих зөвшөөрөл олгохдоо Засгийн газрын зүгээс хүлээлгэсэн үүрэг бүхий хэлбэрийг хэлж байгаа болно. Энэ хэлбэрийн хүрээнд цэвэр хувийн секторын барьж байгуулсан жишээ төдийлөн олон байдаггүй. Энэ хүрээнд зургаан жишээг товчхон авч болно. Үүнд:

- Квинланд нүүрсний төмөр зам
- Пилбарагийн төмрийн хүдрийн төмөр зам
- Алиссе Спрингс –Дарвингийн ердийн ачаа тээвэрлэлтийн төмөр зам
- Елгарны санал болгож байгаа ПР зам
- Бейтбрижийн төмөр зам
- Бетувэгийн төмөр зам

Эдгээрээс гадна, сэргээн ажилуулахаар зэхэж байгаа хоер жишээ бас байгаа. Үүнд:

- Коломбийн феноко
- Габоны марганцийн хүдрийн төмөр зам

**Квинланд нүүрсний төмөр зам**

1960-аад онд Тиесс болон Юта гэсэн хоер компани уурхай ашиглаж эхлээд Квинландаас экспортлох, одоогийн байдлаар 150сая тонн орчим нүүрсийг тээвэрлэх зориулалтаар тавигдсан. 1962 оны анхны хуулиар Тиессийн проектод зөвшөөрөл олгохдоо компанид өөрийн эзэмшлийн төмөр замыг уурхайгаас порт хүртэл тавих эрх олгосон байна. Харин энэ зөвшөөрлийг 1965 онд дахин хэлэлцэж, төмөр замын монополит эрхийг авсан. Ингэснээр, төмөр зам \төр\ тарифийн үнэлгээг өндөр тогтоох боломжийг олгосон ба энэ нь ердийн нэг вагон ачааны портын экспортын үнэ болон бүтээгдэхүүний уурхайн өөрийн өртгийн \ашгийг оролцуулаад\ зөрүүгээр тодорхойлох болсон.

Гэхдээ, төмөр зам тавих өртөг болон эрсдлийг засгийн газар хүлээх болсноор гарч болзошгүй хохиролыг нүүрсний орлогоос олох орлогын хувьд сайтар тооцоолох шаардлага гарч байгаа юм. Үүнийг аюулгүй байдлын \эрсдэлийн\ урьдчилсан баталгаат хадгаламжийг байршуулах замаар шийдсэн ба хэмжээг нь төмөр зам барьсан хөрөнгийн өртөг болон тээвэрлэлт эхэлснээс хойшхи арван жилийн ашгийн эргэн төлөлтийн тооцоотой адилтган тогтоосон байна.

Иймэрхүү нөхцөлтэй өөрчлөлтийг Ютагийн төмөр замын хувьд бас хийсэн ба урьдчилсан баталгаат хадгаламж хөрөнгийг ачаа тээвэрлэлтийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд ашиглаж ирсэн ба Төв Квинландийн нүүрсний ассосаци \ТКНА\ хэмээх консорциум нь өөрийн баталгаат хадгаламжийг хүнд ачаа тээвэрлэлтийн цоо шинэ Гунеллийн системийг барьж байгуулахад ашигласан байх жишээтэй.

Үнийн тогтолцоог ийнхүү зохицуулахаар авсан арга хэмжээнүүд нь гучаад жилийн турш төмөр замын тогтвортой орлогыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж, төмөр замын тогтвортой орлогыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж, төмөр замын бусад бүх үйлчилгээний таталцалын асуудлыг шийдвэрлэж ирсэн байна. Нүүрсний компаниуд эл зохицуулалтын талаар өөрсдийн дургүйцлийг байнга илэрхийлж ирсэн ба дөнгөж 1990 –ээд он гэхэд л байдлыг зөөлрүүлэх анхны алхам хийгдэж эхэлсэн байна. Тогтоосон хувь хэмжээг бууруулан хэвийн хэмжээнд буулгахад нөлөөлсөн гол хүчин зүйл нь Квинландыннүүрсний уурхайн хувьд “нээлттэй оролцоо” –ны хэлбэрийг тогтоож, нүүрсийг портод тээвэрлэх ажлыг нээлттэй тендерийн хэлбэрээр гуравдагч талд олгох \хүсвэл өөрийн төмөр замыг ашиглах\ боломжийг нүүрсний уурхайнуудад олгосон явдал юм. Ийм зохицуулалтыг нэвтэрүүлснээр, зах зээлд төмөр замын тариф хурдацтайгаар буурч, \хэний ч хамааралгүйгээр тарифын

зохицуулалтыг бүтээгдэхүүний нийт өртөг болон зөрүүгээр \ төмөр замын өрсөлдөх чадварыг зах зээлээр зохицуулж эхэлсэн байна

Энэ зохицуулалт нь өөрийн эерэг болон сөрөг үр дагаварын аль алийг нь дагуулдаг юм. Энэ нь нүүрс тээвэрлэх төмөр зам тавихад төрөөс ямар ч хөрөнгө гаргахгүй байх нөхцлийг бүрэлдүүлэхийн зэрэгцээ нэлээд урт хугацаанд төр найдвартай орлогын эх үүсвэрийг бүрэлдүүлэх боловч Засгийн газрын үйл ажиллагааны ил тод байх, үүрэг хариуцлага хүлээх чадвар дутагдаж, орж байгаа орлого /роялти, татвар зэрэг/ зөвхөн төмөр замын хүрээнд үлдэж, ард түмний ашиг сонирхолд зарцуулагдахгүй байдагт шүүмжлэлтэй хандаж ирсэн.

### **Пилбарагийн төмрийн хүдэрийн төмөр зам**

Квиндарагийн нүүрсний уурхайтай бараг нэг үед Баруун Австралийн Пилбарад томоохон төмрийн хүдрийн ордыг ашиглаж эхэлсэн /одоогийн ВНР Билитон болон Рио Тинто/ юм. Харин эндхийн төмрийн хүдрийн орд нь Квинландын нүүрсний уурхайг бодвол алслагдсан нутагт оршиж байсан ба санал болгож байсан далайн портод хүрэх төмөр замын шугам нь үндсэн төмөр замын шугамаас 1067 км зайд байсан. Энэ тохиолдолд, Төр тухайн уул уурхайн компаниудыг өөрсдөө төмөр зам тавьж ажиллуулахаар шийдвэрлэсэн ба компаниуд бусад төмөр замын рельссээс өөр стандартын Хойд Америкийн стандартын ральс бүхий төмөр замыг тавьсан байна.

Засгийн газрын хувьд, бусад хэрэглэгч хүсвэл тухайн төмөр замыг ашиглах бололцоог нээлттэй байх асуудлыг хуулинд тусгаж өгсөн байна. “Ачаа тээврийн вагон” гэсэн заалт нь гуравдагч тал өөрийн вагоноор уурхайн зүтгүүрийг ашиглан тээвэрлэлт хийх тухай заалт юм. /Хэдийгээр ийм заалт орсон ч 30-н жилийн туршид хэрэгжихгүй явсаар иржээ.

Саяхнаас Пилбарагийн төмрийн хүдэрийн орд ашиглалтын төсөл нилээд өргөжиж ирсэн байна. Зарим нэг объектууд нь асар их хүчин чадалтай /Форрест объект гэхэд л 45сая тонныг экспортлохоор төлөвлөж байхад зарим нь үүнээс бага хэмжээтэй байна. Бүх шинэ объектуудын хувьд тулгарсан бэрхшээл нь бүтээгдэхүүнээ далайн портод хүргэх асуудал байсан. Зарим нэг нь \Форрист мэтийн том хүчирхэг/ өөрийн төмөр замыг барьж байгуулан ашиглах замаар асуудлыг шийдэж байхад зарим нь /Төмөр зам тавихад бүтээгдэхүүний хэмжээ нь үнэхээр бага байгаа/ Рио Тинто буюу ВНР-ийн аль нэгээр бүтээгдэхүүнээ тээвэрлэхээр хөөцөлдөж байсан. Тэд энэ ажиллагаандаа анхны хуулийн гуравдагч талын оролцооны тухай заалт буюу эсвэл зарим нэг дэд бүтцийн ашиглалтыг гуравдагч талд “нээлттэй” байлгах эрхийн заалтуудыг ашиглахыг эрмэлзэж ирсэн. Аль ч арга замыг ашиглан хөөцөлдсөн ч тэдний хувьд тээвэрлэлтийн асуудал бэрхшээлтэй хэвээр үлдсээр байсан ба тээврийн хөлсний асуудлаар яриа хэлэлцээ хийхэд ихээхэн цаг хугацаа алдахын зэрэгцээ хоёрдахь уурхай өөрийн төмөр зам тавих асуудлыг шийдүүлэхээр хөөцөлдөхөд асуудал шүүхийн шийдвэрийг гурав гаруй жил хүлээхэд хүрч байсан.

Пилбарагийн онцлогт нөхцлийг авч үзэхгүйгээр жишээнээс харахад аливаа хууль тогтоомжийн дагуу асуудлыг шийдвэрлэхэд гуравдагч танигдаагүй компани хувьд шаардагдах цаг хугацааг урьдчилан хэлэх боломжгүй нь харагдаж байна. Эндээс үүдэн, аль нэг жижиг уурхай тээвэрлэлтийн боломжоор хангагдахын тулд үндсэн ашиглалтын хэлэлцээрийг байгуулахдаа асуудлыг туйлын тодорхой тусгах, эсвэл тухайн байгууламжийг олон хэрэглэгчид хүртээмжтэй байлгах бүтэцтэйгээр барьж байгуулах явдал чухал юм.

### **Алисе Спринг – Дарвин |Австрали Ази |**

Австрали Ази төмөр замын объект нь барьж байгуулах, эзэмших, ажиллуулах болон шилжүүлэх эрхтэйгээр тавигдсан ба Хойд нутгийн газар нутаг болон Өмнөд Австралийн Засгийн газраас 50 жилийн хугацааны лизенгээр тавигдсан ба 50 жил ашигласны дараа тухайн дурдсан Засгийн газарт эргүүлэн өгөх юм. Энэ байгууламж 2004 оны эхээр баригдаж дууссан болон. Энэхүү объект нь дараах байгууламжаас бүрдэж байгаа болно. Үүнд:

- Алисе Спринг болон Дарвиний хооронд 1420 км ердийн өргөн рельс бүхий төмөр замын шинэ байгууламж .
- Таркулагаас Алисе хүртэл 1980 онд тавигдсан одоогийн ашиглаж байгаа 830 км ердийн стандартын өргөнтэй төмөр замын засвар үйлчилгээг нь хариуцан түрээслэх.
- Дарвины усан порттой хослуулан ашиглах объект, үүнд төмөр замын далан , төмөр замын чиглэгийн терминал мөн шинээр нээгдсэн Бизнесийн парк орох ба энэ нь дотоодоо автозамын болон төмөр замын ачаа тээвэрлэлтийг эрхэлдэг.
- Барьж байгуулж дууссанаас хойш 50 жилийн хугацаанд ашиглах тив хоорондын шинэ шугамын үйл ажиллагаа зэрэг болно.

### **Ельгарн дахь төмөр зам**

Өргөн хэрэглээний үнэ хурдацтай өсөн нэмэгдэж байгаатай холбогдон Мурчилсоны районд хэд хэдэн ашигт малтмалын проектууд хэрэгжиж эхэлсэн ба энэ нь Пилбарагаас урагш 500 км ба баруун Австралийн Гералдтоноос дотогш 300-500 км-т оршдог болно. Энэ бүс нутагт одоо ажиллаж байгаа нэг, хоёрын зэрэг 1067 км урт төмөр зам үйлчилгээ явуулдаг ба хүнд даацын ачаа тээврийн вагоныг ажиллуулахын тулд эдгээр замын хувьд үндсэн сэргээн засварлах ажил хийх шаардлагатай байгаа юм.

Эдгээр олонхид нь Хятадын оролцоо байгаа бөгөөд даацын хувьд харилцан адилгүй. 5 сая тонн хүртэл хэмжээний бага хэмжээнээс 20-30 сая тонн хүртэлх дунд-том хэмжээний зэрэглэлд хамаарагдаж байгаа бөгөөд тун цөөн хэд нь хүнд даацын ачаа тээвэрлэх боломжтой. Олон тооны жижиг зэрэглэлийн тээвэрлэгчид нь салаа зам байгуулж, нийтийн зориулалтын нөхцлийн зохих төлбөрийг төлж ажилуулах нь альтернатив зам зарим тохиллолд 600 хүртэл км барьж байгуулсанаас ашигтай байдаг байна.

Засгийн газар нийтийн хүртээл болон ашиглах зарчмыг, ямар ч байсан олон нийтийн өмнө, баримталж байгаа ч “,,,Пилбарагийн порт Хедландад тохиолдсон бэрхшээлтэй бид дахин учрахгүй байх ёстой “ энэ асуудлаар баримтлах чиг шугамын хувьд олон янзын хувилбарууд байдаг. Одоогийн байдлаар өөр хоорондоо зөрчилдөөгүй гурван хувилбарыг авч үзэж байна. Эдгээрийн дотроос хамгийн их сурталчилж байгаа нь Ельгарны дэд бүтэц хувилбар бөгөөд үүнийгээ бие даасан дэд бүтэц ашиглуулагч \Hdepehdeht Infrastructure Provider\ гэж сурталчилж байна. Энэ нь шинээр төмөр зам болон порт барьж байгуулаад гуравдагч талд зохих үнэ төлбөртэйгээр ашиглуулах гэсэн санаа юм. Эл төмөр замыг ашиглах уурхай бүр хугацаа авах бөгөөд энэ нь хөрөнгийн болон ашиглалтын зардлын аль алины нь хувьцаа байна. \дараа өгүүлэх Фэноко – той төстэй\.

Альтернативний дэвшүүлж байгаа хувилбар нь хэдэн гол уурхайнууд өөрсдөө төмөр замыг гуравдагч талд төлбөртэй ашиглуулах нөхцөлтэйгээр барьж байгуулах явдал бөгөөд ийнхүү ашиглуулах боломж олгосноороо хөрөнгийн өртгийг гуравдагч талд ашиглуулж олсон орлогоосоо нөхөх боломжийг олгоно гэж үзэж байна.

Гуравдахь хувилбар нь одоогийн байгаа төмөр замуудыг дэд бүтцийн эд ангиудыг дангаараа буюу потенциалний ашиглагч нартай хамтран шинжлэх асуудал юм. Баруун Австралийн хувьд байдаг нэг онцлог нь төмөр замын дэд бүтцийг хувийн секторийн хөрөнгө оруулалтаар босгодог \Бабкок ба Браун\ бөгөөд харин тэд галт тэрэг эзэмшин ажиллуулдаггүй байна. Эл босоо хуваарилалтын зарим нь нэгэнтээ хэвшиж, ойлгомжтой болсон бөгөөд ашиглалтын төлбөрийн хэмжээг зохицуулж байдаг байна.

Энэхүү төсөл нь хэрэгжих шатандаа явж байгаа бөгөөд эхний шатанд шинэ порт барих \Оакажи\ асуудал тавигдаж байгаа ба энэ нь яваандаа төмөр замын сүлжээ байгуулахад хүчтэй нөлөө үзүүлнэ гэж тооцоолж байна.

### **Беитбриж төмөр зам**

Беитбриж Булаваёо төмөр зам \BBR\ бол өнөөгийн нөхцөлд сонгодог ВОТ хэлбэрээр шинэ ерөнхий зориулалтын төмөр зам тавих \Шинэчлэн сайжруулахаас өөр\ хэлбэр бөгөөд ажиллуулах монополь эрхтэй. Энэ зам нь Өмнөд Африкийн хил дээрхи Лимпопогийн Беитбрижээс эхлэлээ авч, Хилийн огтлолцлын зүгт Булаваёогийн орчим Зимбабвегийн төмөр замын гол шугамтай нийлдэг байна. Энэ зам нь Булаваёод хүргэх болон төв Африкийн хувьд ойр дөт зам боловч Өмнөд Африк болон Харарегийн хувьд хамгийн хол зам болж байгаа юм.

BBR нь Зимбабед бүртгэлтэй хувийн компанийн зам бөгөөд Засгийн газар 15 хувийг нь \төмөр замаараа дамжуулан \ эзэмшдэг. Энэ зам 1999 оны 7 дугаар сард ашиглалтад орсон бөгөөд нийтдээ 85сая ам. долларын өртгөөр 17 сарын хугацаанд тавигдсан байна. Энэ нь Спурнетийн стандартаар 20 тонны тэнхлэг –ачаалалтай, 4 сая тонны хүчин чадалтайгаар баригдсан ба Спурнет гэрээгээр ажиллуулдаг.

Байгуулсан гэрээг нийтэд хэзээ ч ил гаргаагүй бөгөөд, төмөр замаар аль болох их хэмжээний ачаа тээвэрлэлтийг зарим ачааны хувьд “ авах эсвэл төлөх “ гэсэн заалтаар хийдэг ба хөдөлгөөнийг ердийн богино замаас нь өөрийн шугамдаа оруулдаг байна. Гэхдээ

Энэ замаар явж байгаа тээврийн хэмжээ болон үнэ тарифын холбогдол бүхий мэдээлэл хомс байдаг байна.

ББР нь Зимбабийн засгийн газартай гэрээ байгуулж, Булаваёо-Викторри хүрхрээгийн төмөр замын шугамыг бас ашигладаг ба мөн одоогийн байдлаар Замбид төмөр зам ажиллуулах эрх авснаар Өмнөд Африкаас ДРС хил хүртэл уурхайнуудад үр ашигтай ажиллаж байна. Гэхдээ энэ төмөр зам Зимбабед үнэхээр ашигтай байдаг эсэх нь асуудалтай бөгөөд одоогийн ерөнхийлөгч нь албан

тушаалаа өгсний дараа гэрээний нөхцөлд ямар нэг өөрчлөлт оруулах эсэх асуудал сонирхол татаж байгаа юм.

### **Бетүве төмөр замын шугам**

Түүхэн үүднээсээ, Недерландын хувьд төмөр замын бизнес нь алдагдалтай бизнест тооцогдож ирсэн ба төрийн өмчийн Дач төмөр \НС\ зам хэмээх компани монопол эрхтэйгээр эзэмшиж ирсэн. Харин 1980-аад онд Голландын Засгийн газар Бетувегийн төмөр замын шугамыг ачаа “транзит тээврийн чиллэлээр байгуулж, Роттердамын портыг Геоманы төмөр замын сүлжээтэй холбох төлөвлөж байсан ба энэ зам нь ашигтай ажиллах болно \хэдийгээр 1.7 тэрбум еврогийн өртгөөр босохоор тооцоолж байгаа ч нарын тооцоолсон байна. Энэ бүтээн байгуулалтад хувийн секторыг төсөл боловсруулах, барьж байгуулах ажил, засвар үйлчилгээ, ашиглалтад оролцуулахаар төлөвлөсөн байна. Гэвч явц дунд хувийн секторыг оролцуулах асуудал бүрэн нурсан байна.

Эл шугамыг барьж байгуулан Роттердамын портын олон улсын тавцанд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхээр төлөвлөж байсан ба 1993 онд хүчтэй лоббигийн ачаар энэ тухай шийдвэр гарсан байна. Төлөвлөлтийн шатнаасаа эхлээд л өртөг зардлын болон бусад эсэргүүцэлтэй тулгарсан ба ямар ч байсан барьж байгуулах хугацааг 2000 он гэж байсныг 2007 он болгон хойшлуулаад байгаа болно.

Ер нь хувийн секторын оролцоог шинэ байдлаар авч үзэж, төмөр зам ыг барьж байгуулах сонирхолтой бүхий, ирээдүйд төмөр замын ашиглалт, үйлчилгээнд орлцох, үйлчлүүлэгч \ клиент \ байх сонирхол бүхий хүмүүс уг төсөлд хөрөнгө оруулалт хийх бололцоог олгосон байна. Эдгээр стратегийн хөрөнгө оруулагчид нь цэвэр санхүүгийн байгууллагуудыг бодвол эрсдлийг багасгах, өртгийг бууруулахад нөлөө үзүүлэх сонирхолтой байх юм гэж үзсэн байна.

Хувийн секторын оролцооны талаарх энэхүү түгшээсэн туршлагыг аливаа эрсдлийг Засгийн газар өөртөө үүрэх байдлаар дуусдаг байна. Ер нь Засгийн газар хүртэл объектыг хувьчлах асуудлыг зохион байгуулахад гадны оролцоогүйгээр бие даан зөв зүйтэй явуулах туршлагаар дутагдаж байдаг. Хувьчилсан гэрээг амжилттай болсон гэж үзэх боловч нэгэнт гэрээ хэлэлцээр байгуулагдаж бүх зүйл дууссаны дараа л тухайн гэрээний ур уршиг ямар байхыг оройтож мэдэрдэг юм.

### **Феноко**

Коломби нь хоёр томоохон өөрийн дотоодын төмөр замыг нүүрс тээвэрлэлтэд ашигладаг. Хамгийн том нь Эл керрэжон нортек Пуэрто Боливарийн порттой холбосон 150 км урт төмөр зам юм. Анх энэ төмөр зам ыг төрийн өмчийн нүүрсний \Карбокол \ компани болон Эксоны салбар компани хамтран байгуулсан ба одоо Англо Американ, ВНР Билитон болон Гленкорегийн консорциум эзэмшиж байна. Энэ нь уурхай –төмөр зам – портын гурвалсан шүтэлцээ бүхий проект бөгөөд Коломбийн төмөр замын бусад сүлжээнээс хамааралгүй болно. Хоёрдахь нь Коломбийн ган үйлдвэрлэгчид үйлчилдэг хувийн төмөр зам юм. Олон тооны жижиг нүүрс олборлогчид хойд зүгийн гол замын шугамаас 200 орчим км-ын зайд төвлөрсөн байдаг бөгөөд тэд нүүрсээ гол мөрнийг ашиглан салаар, эсвэл ачааны машинаар тээвэрлэхийн оронд төмөр замаар тээвэрлэх асуудлыг нэлээд хэдэн жил бодож төлөвлөж байгаа юм.

1990-ээд онд Колумбийн төмөр зам нэлээд эвдрэлд орж шинэчлэн сэргээх ажлыг нэн яаралтай хийх шаардлагатай болсон байна. Ачааллыг босоо хуваарилалтаар салгаж, төмөр замын дэд бүтцийн асуудлыг Засгийн газрын үүрэгт үлдээхийн зэрэгцээ ашиглалтын асуудлыг хувийн сектор зонхилсон хоёр хамтарсан нэгжид хариуцуулсан байна. Гэвч энэ төсөл амжилтанд хүрээгүй бөгөөд төмөр замын сүлжээг 1999 оноос концессид өгсөн байна. Гэвч энэ нь бэрхшээлийг даван туулахад тус болж чадаагүй байна.

Концесси нь Феноко турш Атлантик сүлжээг сэргээн сайжруулах, засвар үйлчилгээг хариуцах үүрэг хүлээж байгаа бөгөөд сэргээн засварлах ажлыг таван жилийн дотор хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. Үүнд төрөөс 80сая ам. долларын хөрөнгө зарах бөгөөд мөн хязгаарлагдмал хөрөнгийн бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр тоцоолсон байна. Гэвч амьдрал дээр сэргээн засварлах ажлыг таван жилд хийхээр төлөвлөсөн нь долоон жил болон сунгагдаж, Засгийн газраас нэмэлт хөрөнгө авахад хүрчээ. Гэвч ажлын явц удаан, хувийн сектороос мөнгө босгох ажил орхигдсоор байна.

Ажил ийнхүү удааширч байгаа нь нүүрсний уурхайнуудаас зах зээлд гаргах нүүрсний хэмжээнд нөлөөлж, Феноко олон улсын арбитражаар орж гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн гэж 40 сая долларын торгууль хүртэл хүлээсэн байна. 2005 онд Засгийн газар Феноког эргүүлэн \92 сая долларын, төлөх өрийн нь хамт \ худалдан авч, дотоодын нүүрсний консорциумд эргүүлэн түрээслүүлсэн байна. Консорциумын гишүүн бүр төмөр замын хүчин чадлын хэмжээгээр баталгаат хувьцааг өөрсдийн эзэмшиж байгаа хөрөнгийн хувьцаагаар жишиж эзэмших болсон байна. Консорциум нь мөн экспортын нүүрс тээвэрлэх хүчин чадлыг бэхжүүлэх, жижиг хэмжээний дөрвөн салбар зам тавих зэрэг үүрэг хүлээсэн байна.



### Габон

684км урт Трансгабоний \ ТГ \ төмөр зам нь 25 тонн-тэнхлэгийн ачаалалтай, дээд зэрэглэлийн стандартын рельс бүхий төмөр зам бөгөөд 1974-1986 онд баригдсан, либревиллийн ойролцоо орших Овендагийн портыг франсвиллитэй холбодог юм. Төмөр замаар ердийн ачаа болон зорчигч тээвэрлэлтийн гол бүтээгдэхүүн нь марганецийн хүдэр 65 хувь болон, гуалин мод 20хувь юм. Марганецийн хүдрийг төр болон Францын Комилог уурхай хамтарсан аж ахуйн нэгж эрхэлдэг юм. 1989 онд байгуулсан Засгийн газрын хэлэлцээрийн дагуу Комилог нь өөрийн техник хэрэгслийг оруулж, өөрсдөө төмөр замын үйлчилгээг эрхлэн ажиллуулдаг бөгөөд төрийн эзэмшлийн төмөр замын Октра компанид ашиглалтын төлбөрийг төлдөг байна.

1988 оноос өмнө марганецийг кабелийн төмөр замаар Конго руу тээвэрлэж, тэндээсээ Конгын СФСО портод төмөр замаар хүргэдэг юм байна. 1988-1991 хүдрийг хоёр төмөр замаар хуваан тээвэрлэж байсан бөгөөд харин 1991 оноос экспортын бүх хүдрийг зөвхөн ТГ тээвэрлэх болжээ. Энэ хугацаанд, дэд бүтэц болон зорчигч, хүдрээс бусад карго тээвэрлэлтийн асуудлыг Октра хариуцан гүйцэтгэдэг байна. Концессид өгөхөөс өмнө Комилог жилд 1.5 сая тонн марганецийн хүдрийг төмөр замаар тээвэрлэж байсан нь нийт төмөр замын тээврийн 45 хувь, тонн км-ийн 65 хувийг эзэлж байжээ. Нийт орлогын хэмжээ 43 сая доллар байсны 77 хувь нь ачаа тээвэрлэлтээс, 13 хувь нийт зорчигч тээврээс, дөнгөж 8 хувь нь Комилогоос орж байжээ. Окторагийн тээврийн тариф харьцангуй өндөр байсан боловч үйлчилгээний чанартай холбогдсон гомдол нэмэгдсээр байжээ.

Төмөр зам удаан хугацааны үйл ажиллагаа явуулахад нь Комилогийн төлж байсан төлбөр нөлөөлсөн бөгөөд нийт ачаа тээврийн 65 хувийг эзэлж байжээ. Энэ нь нэг талаас суурь үнээс хамаарч байсан ч нөгөө талаар ТГ-ийн тариф нь СФСО-ийн тарифаас хямд байх ёстой гэсэн зарчим үйлчилж, Комилогийн дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд тэрхүү хямд үнэ тариф нөлөөлсөн. Дараагийн байгуулсан хэлэлцээрийн дагуу Октрагийн үнэ тариф нь доод өртөгт тулгуурлан тогтоогдох болсон байна.

Концессийн өмнө, хоёр төмөр зам ажиллаж байсан ба нэг нь ачааны дийлэнхийг харьцангуй хямд үнээр тээвэрлэж байжээ. Тэр үед дэд бүтэц харьцангуй сайн байсан бөгөөд харин Октра санхүүгийн хувьд бэхжээгүй, үйл ажиллагааны алдагдалд орж байжээ. 1996 онд Засгийн газар төмөр замын байгуулагуудад эргэлтийн концессиг хорин жилээс доошгүй хугацаагаар олгож, тав таван жилээр сунгаж байхаар шийдвэрлэжээ. Концесси авсан компаниуд нь төмөр замын ердийн ачаа тээвэрлэлтийн болон зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхлэх бөгөөд төмөр замын тоног төхөөрөмж, ачааны вагон болон дэд бүтцийн шаардлагатай шинэчлэлийг хийж байх үүрэг хүлээх юм.

Төмөр замыг концессээр авагч нь тариф, эрхлэх үйлчилгээний хүрээг тогтоох болон хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхойлох зэрэг асуудлаар чөлөөтэй шийдвэр гаргаж, харин дэд бүтцийн ашиглалтын төлбөрийг төлнө. Ашиглагч нь төмөр замын сүлжээнд Комилогийн ашиглаж байгаагаас бусад нөхцөлд онцгой эрх эдлэх ба шаардлагатай ачааны вагоныг Октрагаас авна. Зорчигч тээврийн хувьд наад захын хэмжээний гүйцэтгэлийг барих шаардлагатай ба Засгийн газар “алтан хувьцааг” оролцуулаад ойролцоогоор нийт хувьцааны 15-20 хувийг эзэмшинэ.

Концессийн төлбөр нь хоёр бүтцээс бүрэлдэх болно. Үүнд: жилийн бөөн мөнгөн төлбөр \Имфляцийн зохицуулалт хийгдсэн\ гэхдээ жил ирэх бүр 6-20-оор нэмэгдэж явах ба хувьсах элементийг “үйл ажиллагаа ны ашгийн” 12 хувиар тогтоожээ. Концесси эзэмшигч нь ашиглалтын хэлэлцээрийг Комилогтой \Засгийн газар ашиглалтын “барьцаат өртөг”-ийг хариуцах\ байгуулах ба харин концесси эзэмшигч нь хөрөнгө оруулалтын заавал оруулах наад захын хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөртэй байх болно.

Хоёр групп санхүүжилтын шатанд гарч ирсэн. Нэг нь дүнз гуалингийн бүтээгдэхүүний гол тээвэрлэгч Трэсгабоний консорциум бөгөөд үүнийг Набоны Үндэсний дүнсний компани\ SNBG \ тэргүүлж байжээ. Эл байдал нь нэг тендерт оролцогч нь ашиглалтын төлбөрийн хувьд ямар нэг тохиролцоонд хүрнэ гэдэг нь потенциалний бэрхшээл байсан. юм. Янз бүрийн аргументийг авч үзсэний эцэст, Комилог санхүүгийн ямар нэг санал дэвшүүлэхгүй байхаар шийдсэн ба Трансгабониас 1988 оны сүүлчээр концесси авч, Комилогтой яриа хэлэлцээнд орсон байна. Гагцхүү 1999 оны 12 дугаар сард Октра менежментийн эрхийг авснаар концессийн гэрээг хянан зохицуулах хүрээ тогтоох асуудалд төдийлөн ахиц гараагүй байна.

Эл нөхцөл байдал, Трансгабониас Комилогтой ашиглалтын төлбөрийн асуудлаар хийх хэлэлцээрт хүчтэй байр суурьтай байх боломжоор хязгаарлагдмал байдалд оржээ. 2003 оны тавдугаар сард концессийг “үйл ажиллагаанд хариуцлагагүй хандаж, засвар үйлчилгээний чанар муу байсан” үндэслэлээр цуцалсан байна. Төмөр зам хэвийн байдлаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, Комилогийн салбар компанид дахин концессид өгөх болсон ба эл компани нь өөрийн асуудлыг

шийдвэрлэх, хүлээгдэж байгаа ажлыг гүйцэтгэхэд хөрөнгө оруулалт нэн даруй шаардлагатай байна гэсэн шаардлага гарсан .

Концессийн явцад тохиолдож байгаа гол бэрхшээл нь өрсөлдөгч нарын аль нэг зах зээлийн хүчтэй байр суурьтай, улс төрийн хүчтэй харилцаа холбоотой байгаа нөхцөлд зохицуулалтын хүчтэй нөлөө байж чаддаггүй. Концесси нь үнэхээрийн хүчтэй зохицуулах хүчтэй байж гэмээж үр ашигтай үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрэлдэх юм.

### Гол асуудлууд

Квинландийн жишээг өнөөдрийн нөхцөлд авч хэрэгжүүлэх бараг боломжгүй учир энэ жишээг хойш тавиад, харин төмөр замын төсөлд хувийн секторын оролцоог хангахтай холбогдсон гол гол асуудлуудыг авч үзье. Хувийн секторын оролцоог хангах асуудлаар ямар нэг шийдвэр гаргахын өмнө хожим гарч болзошгүй, Бетувегийн төмөр замд тохиолдож байсан шиг бэрхшээлүүдийг тойрохын тулд асуудлыг туйлын тодорхой авч үзэх шаардлагатай.

Хамгийн чухал үндсэн асуудал бол хэрэв тухайн төмөр замыг аль уурхай барьж байгуулж байгаа нөхцөлд гуравдагч талд боломжийн үнээр \өртөг дээр боломжийн ашиг нэмээд\ ашиглуулж байх нөхцөлийг хангахад анхаарах нь зүйтэй. Одоогийн ажиллаж байгаа хүнд даацын төмөр замыг ихэвчлэн барьж байгуулсан компани нь дангаар эзэмшин ашиглаж байгаа бөгөөд Пилбара зэрэг төмөр зам нь эрх зүйн болон техникийн тодорхой барьерийг бий болгох замаар гуравдагч талын ашиглалтыг хязгаарлаж байхад Габоны жишээ нь гуравдагч талыг хатуу ширүүн ялгаварлан гадуурхан үзэх байдлыг тогтоосон байна. Энэ бүхнээс дүгнэлт хийж, хэрэв тухайн төмөр төмөр замыг нээлттэй ашиглах бол чухам ямар зохицуулалтаар амьдрал дээр болон онолын хувьд хэрэгжүүлэх вэ гэдэг асуудлыг нэн даруй шийдвэрлэх хэрэгтэй.

Дараагийн асуудал бол төмөр замыг яваан төрд буцаан \уурхайн түрээсний хугацаа дуусгавар болох эсвэл тодорхой хугацааны дараа \өгөх үү эсвэл цаашид үргэлжлүүлэн мөнхөд эзэмших үү гэдэг асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй. Энэ нь чухам тухайн төмөр замыг барьж байгуулсан бэ гэдэгтэй холбоотой: хэрэв уул уурхайн компани барьсан бол уурхайн түрээсний хугацаатай уялдах ба хэрэв бие даасан нэгж буюу консорциум барьж байгуулсан бол тухайн замыг эзэмших хугацаа нь Австрали Азийн хувьд 50 жил дэд бүтцийн эзэмшил тогтоосон хугацаа хязгаарлагдана.

Хэрэв төмөр замыг буцаан өгөх бол, үүнтэй холбогдсон зохицуулалт, коцесси эзэмшигч нь хүлээсэн үүргээ зохих хэмжээнд биелүүлэхгүй бол чухам ямар байдлаар засгийн газар эргүүлэн авах

Феноко ийм байдалд орсон жишээтэй зэрэг асуудлыг анхнаасаа туйлын тодорхой тодорхойлох хэрэгтэй. Буцаан шилжүүлэх ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд концесси эзэмшигчийн хуульчаас дутуугүй сайн хуульчийг Засгийн газар мөн авах шаардлагатай бөгөөд нэг их бэрхшээл учруулаад байхгүй хяналт тавих журам бас байх хэрэгтэй.

Төмөр замын салбарт тендер шалгаруулалт нь бусад салбарт явагддаг тендертэй адил байдлаар явагдана. Харин бусад салбарын хувьд, тухайн тендерт оролцогч нь санхүү болон техникийн хүчин чадлын хувьд хүлээсэн үүргээ бүрэн хариуцах чадвартай эсэхэд илүү анхаарал хандуулдаг, харин төмөр замын салбарт ялангуяа өрсөлдөгч нь төмөр замын ашигтай ямар нэг холбоогүй бол нилээд бэрхшээл учруулдаг. Ялангуяа засгийн газрын хөрөнгийн зардлын ихээхэн хэсгийг Засгийн газар гаргаж байгаа нөхцөлд байдал эгзэгтэй байдаг ба концесси эзэмшигч санхүүгийн асуудлаа зохицуулах ажлыг хөөцөлдөж байхад төслийг хурдан урагшлуулах шахалт Засгийн газрын зүгээс байнга ирж байдаг \Фенокогийн жишээ\.

Төмөр зам нэгэнт үйл ажиллагаагаа эхэлсэн нөхцөлд бусад операторуудтай хариуцах зарчмыг туйлын тодорхой бөгөөд шууд ил тодоор зохицуулах шаардлагатай. Говьд ажиллаж байгаа уурхайнуудын хувьд гэхэд тэд өөрсдийн галт тэргийг Монголын өнөөгийн төмөр замын сүлжээг ашиглан явуулах боломжтой юу \тэгээд цааш нь Оросын төмөр замыг ашиглан\ . Өнөөдрийн Монголын төмөр замын сүлжээг 25 тонн тэнхлэгийн ачаалалын вагоныг хүлээн авах хэмжээнд хүртэл сайжруулах \магадгүй шинэ шугам нэмж тавих \ боломжтой юу. Хэрэв боломжтой гэж үзвэл чухам хэзээ вэ гэдэг асуудал гарна. Түүнчлэн, вагон бүрээс авах төлбөр хэд байх вэ гэх мэт.

Ер нь бол концесси гэдэг бол удаан хугацааны процесс байдаг. Цөөн тооны тохиолдолд, төслийн үзэл баримтлалыг боловсруулснаас хойш хэлэлцээр байгуулах хүртэл хоёр жилийн хугацаа шаардагдсан байна. Квинландын дээр үеийн хэлэлцээрийн хувьд хамаагүй урт хугацаа шаардагдаж байсан. Ер нь бараг бүх Засгийн газар ийм хэлэлцээр хийхийн тулд тус салбарын үйл ажиллагааны туршлагатай мэргэжилтэн \эксперт\ -ийн зөвөлгөө авах шаардлагатай байдаг. Концесси эзэмшигчдийн олонх нь нэлээд туршлага хуримтлуулсан байдаг ба тэд дотоодын болон олон улсын хэмжээнд зөвөлгөө авдаг.

Олон улсын санхүүгийн байгууллага үр ашигтай үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хэд хэдэн дэлхийн томоохон ашигт малтмал тээвэрлэлтийн төмөр замын санхүүжилтийн тодорхой хэсгийг ОУСБ санхүүжүүлсэн

бөгөөд тэдний корпорацийн туршлага нь аливаа үйл явцыг ил тод байх нөхцлийг тухайн улс орны сонирхолд нийцүүлэн хангахад туслана. Эцэст нь тэмдэглэхэд, ер нь үйл ажиллагааг зохин байгуулах, хэрэгжүүлэх асуудал нь ихээхэн хөрөнгө мөнгө шаардсан процесс байдаг бөгөөд үүнтэй холбогдолтой янз бүрийн асуудлаар зөвөлгөө авахад наад зах нь сая долларын зардал гаргах жишээтэй.

Баруун бүс нутгийн хөрөнгө оруулалт хийж уул уурхайн ихээхэн нөөцтэй ордуудын мэдээллийг дэлхийд цацах, сонирхогч компаниудад эргэцийн ажлыг хэрэгжүүлэн, нөөц тогтоолгох, нөхцлийг экспертээр баталгаажуулах зэрэг ажлуудыг явуулна хийх явдал энэ төслийн эрхэм зорилго юм. Баруун бүс нутгийн хөгжлийг түргэтгэх цорын ганц зам бол томоохон нөөцтэй, зэс, төмрийн уурхайг ашиглахад оруулж сүйрэх гээд нэг тийшээ унаж байгаа усны онгоц шиг ганц төмөр замаа дагаад зүүн тийшээгээ хүчтэй жин дагаад байгаа нийгэм Эдийн засгийн ачааллыг тэнцвэржүүлэх шаардлага экосистемд хүчтэй сөрөг ашиглалт ганц байгаа баруун бүс нутагт байгаа орчинд хор нөлөөлгүй орд газрыг эзэмших, эрэл хайгуул хийх хэрэгтэй. Мал аж ахуйг хөгжүүлэх, хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх явдал нь хамтдаа хийгдэж болох бөгөөд уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг орхиж болохгүй. Энэ бол үндэсний уламжлал төдийгүй цэвэр биологийн түүхий болон бүтээгдэхүүн юм. Арьс шир болох, ноос болох, үйлдвэрүүдийг төвлөрсөн системээр томоохон хэмжээгээр байгуулах нь зүйтэй. Аймаг бүрд байгаа жижиг оврын түүхий болох үйлдвэрүүд нь байгаль орчинд хор хохирол учруулан хөрс, ус агаарыг бохирдуулж байна хөрөнгө оруулалтыг зогсоох, эсвэл технологийг санхүүжүүлэх нь зүйтэй. Баруун бүсийн зөвөлгөөнөөс үзэхэд төр засгийн хүчтэй тогтолцоо үгүйлэгдэж байгаа нь шинжлэх ухаан технологийн дэвшлээр аливаа зүйлийг бүтээх асуудал их хол хоцрогдож байгааг мэдэрсэн явдал юм. Баруун бүтцийн цог золбоотой хийморлог ард түмэн бүтээн байгуулалтанд гар бие оролцож хүчтэй эдийн засагтай болоход төр засгийн оролцоо чухал байна.


#### 6.1.4.5.3 Агаарын замын төлөвлөлт

Баруун бүсийн аймгуудаас Ховд хот нь дунд бага багтаамжийн нисэх онгоцыг хүлээн авах бетон зурвастай бөгөөд эдүгээ Алтай, Увс, Өлгий, Улиастай хотод уг зурвасыг барьж байна. Эдгээрээс Ховдын нисэх онгоцны буудал нь 300 метр өргөн бөгөөд шаардлагатай үед Бойнгын төрлийн нисэх онгоцыг хүлээн авах боломжтой гэж үздэг.

Улаанбаатар, баруун 5 аймгийн хооронд манай иргэний агаарын тээврийн хөлгүүд тогтмол нислэг үйлддэг бөгөөд Улаанбаатараас Ховд руу нислэг үйлдэн цааш Ховдын Булган хүрдэг. Мөн Улаанбаатараас Өлгий хүртэл нислэг үйлдэн цаашид ОХУ-ын Усть-Камнегорскоор дамжин Казахстан руу нислэг үйлддэг бөгөөд одоо уг чиглэлээр Казах нислэг үйлддэг. Тухайн үед Европын орнуудаас Гонконг, Сингапурын чиглэлд нисдэг онгоцууд Ховд-Өмнөговийн баруун дээгүүр зорчин, тэдгээрт манай тал шаардлагатай үйлчилгээг үзүүлдэг.

МИАТ Улаанбаатар – Ховд – БНХАУ-н Өрөмчийн чиглэлд нислэг үйлдэхээр Хятадын талтай тохиролцоод байна. Мөн Мөрөнгийн нисэх буудлыг олон улсын нисэх онгоцны буудал болгон Өрөмч – Ховд – Мөрөн, улмаар Улаан Үд, зүүн хойт Азийн чиглэлд нислэг үйлдэх зорилт тавиж байна. ОХУ-н Алтайн хязгаарын Бийск, Тувагийн Кызыл олон улсын нисэх онгоцны томоохон буудал баригдаж ашиглалтанд орсон бөгөөд Баян-Өлгийн Цагаан нуураас 185 км-т оршдог Кош Агач хотод Бийскээс нислэг үйлддэг.

АГААРЫН ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ



Баруун бүсийн аймгуудаас ОХУ-д суралцдаг оюутан , бизнесменүүд өөрсдийн аймгаас авто машинаар Кызыл, Кош-Агаач орж цааш нисэх онгоцоор нисэж ОХУ, Европын орнуудад зорчдог болов. Баруун бүс нутаг нь гадаадын жуулчдыг ОХУ, БНХАУ, Казах улсаар дамжуулан шууд хүлээж авах боломжтой учир тэндээс ОХУ, БНХАУ-руу шууд нислэг үйлдэх арга хэмжээг авах. Үүний тулд юуны өмнө Ховдод жуулчдад үйлчлэх шинэ томоохон цогцолборыг шаардлагат зочид буудал , нисэх онгоц , нисдэг тэрэг, автопарк, онгоц ,завь, чарга зэрэгтэйгээр зохион байгуулах арга хэмжээг авах нь зүйтэй. Энэ бүс байгалийн аялал загас агнуурын чиглэлээр жуулчлалыг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх нь зүйтэй.

Баруун бүсийн нутагт агаарын тээврийг хөгжүүлэх зорилгоор сүүлийн үед Ховдоос гадна Доной, Өлгий , Улаангом , Өлгий , Алтайд бетон хучилт аэродром байгуулах арга хэмжээг авч эхэлж байна. Баруун бүсийн нисэх онгоцны буудлуудаас Алтай хотод барих буудал нь уулан дунд байрласан зарим нь төвөөсөө нилээд алслагдсан , аймгийн төвүүдийг нь өргөтгөх боломж муутай байдаг.

Баруун бүсийн 5 гол хотыг одоогийн хүрээнд өргөтгөхөд Алтай, Улаангомоос бусад нь газар нутгийн хувьд боломжгүй. Үүнээс гадна 1990 оноос хойш баруун бүсээс ялангуяа Говь-Алтай, Увс, Завханаас олон айл нүүж, дүрвэж төвийн районд, түүний дотор Эрдэнэт, Сэлэнгэд суурьшив. Энэ их нүүдэл нь цаашид ч үргэлжлэх төлөвтэй.

Тиймээс баруун бүс нь газар нутаг ,ус,эрдэс баялаг ихтэй, хүн мал олонтой, үр тариа, төмс, хүнсний ногоо ,чацаргана, жимс зэргийг тариалах боломжтой учир баруун бүсэд таван аймаг дундын томоохон төв буюу баруун бүсийн нийслэл хотыг байгуулах явдал чухал юм. Сутай хот нь баруун таван аймгийн дунд ус , түлшиндээ ойр , цаашид өргөжин хөгжих талбай , хөрс сайтай байгалийн хувьд үзэсгэлэнтэй , бартаа саад багатай , нисэх онгоцны олон улсын том буудал байгуулах ,авто болон төмөр зам тавихад хямд төсөр , аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой юм.

Бидний үзэж байгаагаар уг хот нь Хомын их талын баруун биед Хар ус нуурын зүүн хөвөөнд байвал илүү зохимжтой юм. Хотыг Сутай гэж нэрлэх саналыг гаргаж байна. Уг хот , баруун 5 аймгийн төвийн хооронд агаараар ойролцоогоор доорх зайтай байна. Үүнд :

Сутай- Ховд 65 км  
 Сутай –Баян-Өлгий 125 км  
 Сутай –Увс 110 км  
 Сутай – Завхан 105 км  
 Сутай –Говь-Алтай 115 км

Эндээс үзэхэд аймгийн төвүүдтэй харьцахад 100 гаруй км бөгөөд яг газрын дунд оршиж байгаа юм. Сутай хотыг байгуулах суурь тавьсан нөхцөлд олон улсын чанартай нислэг үйлдэж эхлэх боломж бүрдэж, оюунлаг баруун монголчууд болон монгол улсын хөгжилд үнэтэй хувь нэмэр болно.

## **Долоо. БҮС НУТГИЙН ЭРЧИМТЭЙ ТАТАЛЦАЛ. НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ТӨЛӨВЛӨЛТ**

### **7.1 БҮС НУТГИЙН НУТАГШИЛТЫН ТОГТОЛЦОО**

#### **7.1.1 Баруун бүс нутгийн хот суурин газрын төлөвлөлт**

Монгол улсын аймгууд нь байгаль орчны даац, хүн, малын байршил, эдийн засаг, нийгмийн зорилтоороо харьцуулсан ойролцоо шинж төлөвтэйг харгалзан эдийн засгийн бүсүүдэд мал аж ахуй, хөнгөн хүнсний үйлдвэр, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр барилга, барилгын материалын үйлдвэр, оюуны багтаамж ихтэй үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, амралт, рашаан сувилал, нийгмийн үйлчилгээ, дэд бүтцийн салбарыг нийтлэг байдлаар хөгжүүлэхээр байгаль, түүхий эдийн нөөц, оюуны чадавхийг харгалзан бүсүүдэд доорх чиглэлүүдийг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

**Баруун бүсэд** : Бэлчээрийн мал аж ахуй, усалгаатай тариалан, ХАА-н түүхий эд боловсруулах үйлдвэр, уул уурхай, худалдаа үйлдвэрлэлийн.

**Хангайн бүсэд** :Бэлчээрийн мал аж ахуй,газар тариалан,аялал жуулчлал, Амралт сувилал,жигжиг дунд үйлдвэр,уул уурхай олборлох боловсруулах үйлдвэр,мод боловсруулах үйлдвэрийг

**Төвийн бүсэд**: Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй,газар тариалан,уул уурхай Олборлох боловсруулах үйлдвэр. Жигжиг дунд үйлдвэр,аялал жуулчлал,амралт сувиллын үйлчилгээ Оюуны багтаамж ихтэй бусад үйлдвэрлэл,үйлчилгээг.

**Зүүн бүсэд :** Уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, эрчимжсэн газар тариалан, мал аж ахуй, жижиг дунд үйлдвэр, аялал жуулчлалыг


**Улаанбаатарын бүсэд:** Оюуны багтаамж ихтэй бүх төрлийн үйдвэр, үйлчилгээ, олон улсын банк санхүүгийн сүлжээ:

Даяарчлалын хүрээнд эрчимтэй зах зээлийн харилцаанаас шалтгаалан баруун бүс нутгийн үйлдвэрлэлийн бүтцийг өөрчлөх шаардлага гарсан. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Монгол улсыг бүс нутгийн зарчмаар Баруун, Хангайн, Төв, Зүүн гэсэн 4 бүсээр хөгжүүлэхээр тусгаж, Монгол улсын Их хурлаас баталсан.

Монгол улсын эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд дэвшүүлсэн бүс нутгийн зохион байгуулалтын үндсэн шийдэл нь дөрвөн бүсийн зарчмаар хөгжүүлэх асуудал болно. Үүнээс Ховд, Увс, Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай аймгийн нийт 415.0 мян.км<sup>2</sup> нутаг дэвсгэрийг хамарсан “Баруун бүс нутаг” үүсч байгаа юм. Бүс нутаг бүрэлдэн тогтоход төлөвлөлтийн төв, төлөвлөлтийн тэнхлэг, байгаль-ландшафт-орон зайн хүчин зүйл чухал үүрэг гүйцэтгэнэ.

Хот суурин газруудын зэрэглэлийг оновчтой тогтоосны дараа л тэдгээрийг хөгжүүлэх талаар тухайн улсын төр, засгийн газраас явуулах бодлогыг харьцангуй зөв тодорхойлох боломжтой болдог аж.


Бүс нутгийн үйлдвэр, соёл, ахуйн үйлчилгээний түвшин /Зураг 7.1/



Судлаачид хот, суурин газруудын зэрэглэл, эдийн засгийн бүсүүдийн хөгжлийн тулгуур төвүүдийг судлахаа юуны өмнө “... аливаа улсын болон бүс нутгийн хэмжээний хот суурин газруудын орон зайн байршил, тархалт нь ямар нэгэн зүй тогтлыг агуулж байна уу? ” гэдэг асуултанд хариулт өгөхийг зорьсоор иржээ.

Баруун бүс нутгийн таван аймгийн хөгжлийн чиглэлүүдийг тодорхойлж дараах чиглэлүүдээр хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

- Баруун бүс нутгийн хөгжлийн тулгуур төв ХОВД хот жижиг дунд үйлдвэрлэл, аялал жуулчлал болон баруун нийт нутаг дэвсгэрийн боловсролыг хөгжүүлэх их дээд сургуулиудыг байршуулан хөгжүүлэх чиглэлийн.
- Баруун бүс нутгийн хөгжлийн тулгуур төв УЛИАСТАЙ хот нь мал аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэрүүд болон хүнсний чиглэлийн үйлдвэрүүдийг хөгжүүлэх чиглэлийн.
- Баян-Өлгий аймаг нь гааль, гадаад худалдааны чиглэлтэй.
- Увс аймаг нь аялал жуулчлал, жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлийн.
- Говь-Алтай аймаг нь үйлдвэрлэл худалдаа, уул уурхай, электроникийн чиглэлтэй хөгжих юм. Баруун бүс нутгийн хөгжлийг түргэтгэхийн тулд улсын чанартай цоо шинэ хот байгуулж их бүтээн байгуулалтыг хийснээр олон улс, улс, бүсийн түвшинд ирээдүйтэй ажил болох юм.




Дэд бүтцийн бүсийн тэнхлэгүүд хөрш орнуудын дэд бүтцэд холбогдох төлөвлөлтийн хувилбарууд /Зураг 7.2/

Баруун бүсийн таван аймгийн нийт сумдыг нэгтгэж хошуу болгохоор төлөвлөсөн бөгөөд. Баруун бүсийн баруун захын Баян-Өлгий аймгийн дөрвөн хошуу, Увс аймгийн зургаан хошуу, Ховд аймгийн дөрвөн хошуу бүгд бүсийн тулгуур төв Ховд хотод, Завхан аймгийн зургаан хошуу, Говь-Алтай аймгийн таван хошуу бүгд бүсийн тулгуур төв Завхан хотод татагдаж тэндээс бүсийн чанартай үйлчилгээ авахаар төлөвлөж байлаа. Бүс нутгаар хөгжүүлэх нь зүйтэй боловч Ховд, Улиастай хоёр тулгуур төв бүсийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулсангүй 20-иод жил боллоо. /Зураг 7.3/

**Бүлэг суурингийн тогтолцоо**


Хувилбар 1 / Зураг 7.3 /



Бүлэг суурингийн энэ тогтолцоогоор цаашид хөгжих боломжгүй болох нь цаг хугацааны шалгуураар нотлогдоод байна. Хувилбар-2 / Зураг 7.4/



Бүс нутгийн зохион байгуулалт,  
хотуудын чиг үүрэг/Схем 7.4 /



Баруун бүсийн үлдээж, сумдуудыг нь нэгтгэн хошууд болгон засаг захиргааны зардлыг хэмнэх, улсын чанартай бүсийн тулгуур төв Сутай хотыг байгуулах нь бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэтгэнэ гэж үзсэн. таван аймгийг хэвээр нь таталцаж хөгжих байдлаар

**7.1.1.1 Бүсийн хөгжлийн тулгуур төв Ховд хот**

**Тулгуур төв хотын хөгжлийн чиг хандлага**

Ховд аймгийн төв хэсэгт Алтайн уулсын нуруу болон урд талаараа нам дор газар, говь цөлийн бүс зонхилно. Иймд баруун бүсийн тулгуур төв Ховд хот орчмын бүсийг хөгжүүлэх ажил нь газрын гадрага, тогтцоос ихээхэн шалтгаалах нь тодорхой юм. Ховд төвтэй Хар нуур, Хар-Ус нуур орчмын нутаг. Энд Ховд хот, Дөргөн, Ховд, Буянт, Мянгад, Эрдэнэбүрэн зэрэг сумууд орох бөгөөд уламжлалт мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлж, усалгаатай газар тариаланг дэмжин, сэргээж хөгжүүлэх эдгээрт чиглэсэн боловсруулах жижиг дунд үйлдвэрүүдийг дээрх сумдуудад байгуулах нь зах зээлийн өнөө үеийн шаардлагад нийцнэ гэж үзэж байна. Байгалийн үзэсгэлэнт олон нуур, байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэн байгалийн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх бүрэн боломжтой юм. Аймгийн нутагт том жижиг гол мөрөн нууртайгаас гадна аймгийн нутгийн үлэмж хэсгийг говь цөл эзэлнэ. Иймд Ховд аймгийг аялал жуулчлалын нэг нь төрөл болох уулын спорт, ан агнуур, усан аялал хөгжүүлэхэд нэн тохиромжтой нутаг юм. Ховд хот бүс нутгийн бүлэг суурингийн тогтолцооны төв болсноор Таван богд хошуу, Өлгий хошуу, Намир хошуу, Толбо хошуу, Ховд хошуу, Тогтох хошуу, Хархираа хошуу, Үүрэг хошуу, Баяд хошуу, Буянт хошуу, Мөнххайрхан хошуу, Алтайн чанад хошуу, Ацат хошуу, Зүүн хөхий хошуу эдгээр нь таталцах юм. Ингэснээр эдгээр хошууд нь Ховд хотоос бүсийн чанартай үйлчилгээг авч байх юм.











Тус аймаг нь нүүрс, төмөр, гянт, болд, алт, газрын ховор элемент, болор, гөлтгөнө, боржин, шавар зэрэг ашигт малтмалын нэр төрлийн нөөцөөр баялаг. Түлшний нөөцөөр орон нутгийн болон бүсийн хэрэгцээг бүрэн хангах боломжтой. Эдгээр нөөц баялгийг ашиглаж цаашид уул уурхайн салбарыг хөгжүүлэх бүрэн боломжтой.

Аж үйлдвэрлэлийг орон нутгийн түүхий эдийн нөөц, боломжид тулгуурлан хүнсний болон өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийг бүсийн тулгуур төвүүдийг түшиглэн хөгжүүлэх замаар хөдөөгийн хүн амын амьжиргааны төвшинг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх болно.

БҮЛЭГ СУУРИЙНГИЙН ТОГТОЛЦОО - ХЭТИЙН ТӨЛӨВ



ТАНИХ ТЭМДЭГ

-  Аймгийн төв
-  Бүсийн төв Сүтэй хот
-  Одоогийн сумын төв
-  Нуур
-  Хошууны нутаг дэвсгэр
-  Улсын хил
-  Аймгийн хил
-  Орон нутгийн уялдаа холбоо
-  Аймаг хоорондын уялдаа холбоо
-  Бүсийн тулгуур төвүүдийн уялдаа хотбоо

Хотын хүн амын хэтийн төлөв /Хүснэгт 7.1/

|    | Он   | Хүн амын тоо |
|----|------|--------------|
| 1  | 2008 | 28646        |
| 2  | 2009 | 28830        |
| 3  | 2010 | 29030        |
| 4  | 2011 | 29244        |
| 5  | 2012 | 29471        |
| 6  | 2013 | 29712        |
| 7  | 2014 | 29966        |
| 8  | 2015 | 30232        |
| 9  | 2016 | 30511        |
| 10 | 2017 | 30800        |
| 11 | 2018 | 31101        |
| 12 | 2019 | 31413        |
| 13 | 2020 | 31735        |
| 14 | 2021 | 32067        |

**Усан хангамж**

Ховд хотод хийгдсэн ерөнхий төлөвлөгөөгөөр 2020 он хүртэл стадионы дэргэд гаргасан 9 гүний худгийг хотын хүн амын ундаа –ахуйн усны эх үүсвэрт ашиглана.

Худгуудын ундрага 12.5 л/сек бөгөөд нийт ундрага 112.5 л/сек болно. Хүн амын ундаа-ахуйн ба үйлдвэрийн технологийн цэвэр усны зардал нь:

Эхний ээлжинд:  $q_{\text{ахуй}} = 94.06$  л/сек  
 $q_{\text{үйлд}} = 613.9$  л/сек  
 $q = 707.96$  л/сек

Төлөвлөлтийн хугацаанд:  $q_{\text{ахуй}} = 325.17$  л/сек  
 $q_{\text{ахуй}} = 613.9$  л/с  
 $q = 939.07$  л/сек

**Ариутгах татуурга**

Хотын төвлөрсөн цэвэр усны шугамд холбогдсон төлөвлөж буй орон сууц, иргэн, олон нийтийн болон үйлдвэрийн барилгуудаас гарах бохир усыг зайлуулахад одоо ашиглаж байгаа бохир усны коллекторуудыг ашиглахаас гадна шинээр бохир усны коллекторуудыг хийнэ. Одоо байгаа бохир усны насосны станцын хүчин чадал нь  $Q=320$  м<sup>3</sup> /цаг байгаа нь бохир усыг шахахад хүрэлцэхгүй тул эхний ээлжинд  $Q=2010$  м<sup>3</sup> /цаг хүчин чадалтай насос, төлөвлөлтийн хугацаанд ээлжинд  $Q=430$  м<sup>3</sup> /цаг хүчин чадалтай насосууд нэмэх шаардлагатай. Одоо ашиглаж байгаа цэвэрлэх байгууламжийн хүчин чадал хүрэлцэхгүй тул шинээр цэвэрлэх байгууламж төлөвлөх нь зүйтэй байна. Бохир усны даралтат шугамыг 400мм болгон томсгоно.

**Цахилгаан хангамж**

Ховд хотын Баруун бүсийн эрчим хүчний системд 1997 оноос холбосон бөгөөд Монгол улсын эрчим хүчний нэгдсэн систем байгуулах хөтөлбөрт “Мянгат” дэд өртөөг өргөтгөж, хоёр хэлхээт 35 кВ –ын цахилгаан дамжуулах агаарын шугамаар “Ховд” дэд станцыг тэжээнэ. 2020 онд “Ховд” дэд станцын одоо байгаа хүчний хувьсгуурын хүчин чадлыг нэмэгдүүлж 2х10000 кВА чадалтай байхаар тооцоолсон. Энэ хугацаанд нэмэгдэх орон сууц, олон нийтийн үйлчилгээ, үйлдвэрийн газрын цахилгаан ачаалал нь 5.8 мВт болно. Орон сууцны хороололд 2х160 кВА -2х400 кВА чадалтай 9ш хаалттай дэд өртөөг шинээр нэмэгдэх гэр хороололд 8ш агаарын ил дэд өртөөг барихаар төлөвлөв.

Монгол улсын Эрчим хүчний нэгдсэн систем байгуулах хөтөлбөрт Ховд аймгийн 9 сумыг эрчим хүчний системд холбогдохоор төлөвлөсөн. Эрдэнэбүрэн, Дуут, Манхан, зэрэг сумыг 35 кВ –ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугамаар: Чандмань, Мөст, Дарви, Хөшөөт, Цэцэг сумыг 15 кВ –ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугамаар баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн системд холбохоор төлөвлөв. Эрчим хүчний системд холбогдох боломжгүй Мөнххайрхан, Булган, Үенч, Алтай суманд Япон дизель – усан цахилгаан станцтай хосолсон эрчим хүчний эх үүсвэртэй байхаар төлөвлөв.

# Баруун бүсийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын хэтийн төлөв

(Хувилбар 1)

Масштаб 1: 3 000 000



"Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын хэтийн төлөв" (Баруун, хөгжлийн төлөв) зурагны зохиогч: Н.Амгалан

**Холбоо мэдээллийн сүлжээ**


Ховд хотын телефоны хэрэгцээний тооцоо 8080 хүрч байгаа тул одоо ажиллаж байгаа 2096 номерын багтаамжтай ажиллаж байгаа станцын хүчин чадлыг 8000 номерын багтаамжаар нэмэх шаардлагатай байна. Урьд нь Ховд хотын холбоог “Телеком -2.3” төслийн хүрээнд станц нь бүрэн автоматчилагдаж, сумдын холбооны автоматжуулалт зохих төвшинд хүрсэн юм. Одоо ажиллаж байгаа радио өргөн нэвтрүүлгийг хэт богино долгионы станц (FM -105.5 мГц) –аар цацаж байгааг цаашид үргэлжлүүлэн ашиглах боломжтой. Телевизийн нэвтрүүлгийг ард олонд дамжуулдаг “Ханс-Алтай” кабелийн телевизийн станц нь 12 сувгаар 500 орчим хэрэглэгчдэд үйлчилдэг ба цаашид өргөтгөн бүх сувгаа тоон технологид шилжүүлж, 24 -өөс дээш сувгийн багтаамжаар өргөтгөн, өндөр хурдын интернетийн үйлчилгээг хамруулсан утасгүй системээр ажилладаг MMDS системээр ажиллуулж орон сууцууд айл өрхүүдэд интернет ашиглах боломжтой.

**Дулаан хангамж**

Ховд хот нь төвлөрсөн дулаан хангамжийн системтэй. Дулааны станц нь 1986 оны 11 сард ашиглалтанд оржээ. Одоогийн байдлаар хүчин чадлынхаа 50% -г гаргадаг. Ховд хотын төлөвлөгөөгөөр төвлөрсөн дулаан хангамжийн системд шинээр нэмэгдэх дулааны ачаалал нь нийтдээ:  $Q=33.95$  Гкал/цаг.

Үүнээс халаалтанд:  $Q_o=22.83$  Гкал/цаг  
 Салхивчид:  $Q_b=2.78$  Гкал/цаг  
 Хэрэглээний халуун усанд:  $Q_{x,y}= 8.34$  Гкал/цаг

**Ховд хотын ерөнхий төлөвлөгөө /Зураг 7.6/**



Техник эдийн засгийн нэгдсэн үзүүлэлт / Хүснэгт 7.2/

| №  | Үзүүлэлт                              | Хэмжих нэгж        | Одоогийн байдал | Төлөвлөлтийн хугацааны эхний ээлж /2010 он/ | Төлөвлөлтийн хугацаа /2020 он/ |
|----|---------------------------------------|--------------------|-----------------|---|--------------------------------|
| 1  | Хүн амын тоо                          | Мян.хүн            | 31.0            | 50.0  | 70.0                           |
| 2  | Өрхийн тоо                            | Мян.хүн            | 6.4             | 8.9   | 15.5                           |
| 3  | Өрхийн коэффициент                    | Хүн                | 4.73            | 4.5   | 4.5                            |
| 4  | Хүн амын нягтрал                      | Хүн/га             | 70              | 81  | 110                            |
| 5  | Орон сууцны барилгын дундаж давхар    | Давхрын тоо        | 4.03            | 4.1   | 5.0                            |
| 6  | Нэг хүнд ногдох сууцны талбай         | М <sup>2</sup>     | 8.0             | 9.0   | 9.0                            |
| 7  | Орон сууцны барилгын сууцны талбай    | Мян.м <sup>2</sup> | 24.8            | 200.0                                       | 547.7                          |
| 8  | Орон сууцны барилгын нягтрал          | М <sup>2</sup> /га | 3209            | 1334  | 4048                           |
| 9  | Нутаг дэвсгэр                         | Га                 | 966.3           | 1132.61                                     | 1354.56                        |
|    | -суурьшлын бүс                        | Га                 | 443.31          | 615.22                                      | 635.45                         |
|    | -олон нийтийн эдэлбэр газар           | Га                 | 69.94           | 73.39                                       | 109.69                         |
|    | -нийтийн хэрэгцээний ногоон суулгамал | Га                 | 40.0            | 70.25                                       | 187.85                         |
|    | -гадна тээврийн бүс                   | Га                 | 3.68            | 49.3  | 49.3                           |
|    | -хот, хорооллын чанартай гудамж       | Га                 | 61.62           | 133.2                                       | 165.81                         |
|    | -тусгай зориулалттай                  | Га                 | 52.5            | 52.5  | 20.1                           |
|    | -усны хамгаалалтын бүс                | Га                 | 1.2             | 6.25  | 20.25                          |
| 10 | -үйлдвэр аж ахуйн бүс                 | Га                 | 94.2            | 132.5                                       | 166.1                          |
|    | -бусад                                | Га                 | 199.75          | -   | -                              |
|    | Соёл ахуйн гол үйлчилгээний хангамж   |                    |                 |   |                                |
|    | Ерөнхий боловсролын сургууль          | сурагч/хувь        | 3844/67.4       | 6400/100.0                                  | 14700/100.0                    |
|    | Хүүхдийн цэцэрлэг                     | Хүүхэд/хувь        | 800/33.4        | 3400/100.0                                  | 7000/100.0                     |
|    | Эмнэлэг                               | Ор/хувь            | 330/75.0        | 1040/100.0                                  | 1530/100.0                     |

**7.1.1.2 Орон нутгийн хөгжлийн хот Өлгий**

**Орон нутгийн хөгжлийн хотын чиг хандлага**

Баян –Өлгий аймаг нь манай орны баруун бүсэд оршдог, 45.8 км<sup>2</sup> нутагтай. Улсын нийслэл Улаанбаатар хотоос 1636 км, бүсийн төв Ховд хотоос 211 км зайд оршдог. Аймгийн нийт хүн амын 88.7 хувийг казакууд, 7.2 хувийг урианхайчууд, 1.8 хувийг тувачууд, үлдсэн 2.3 хувийг халх, дөрвөд торгууд зэрэг бусад ястангууд эзэлдэг үндэсний онцогтой аймаг юм.

Баян-Өлгий аймаг нь баруун бүсийн хувьд Ховд хотод таталцан түүнээс бүсийн чанартай үйлчилгээ авна. Баян-Өлгий аймаг нь хүн амын хувьд 2021 оны байдлаар 2008 оныхтой харьцуулбал 20% -иар хувиар өсөх хандлагатай байна. Аймгийн эдийн засгийн гол салбар нь мал аж ахуй бөгөөд газар тариалан, аж үйлдвэр сул хөгжсөн. Цаашид уул уурхайн болон хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах чиглэлийн үйлдвэр хөгжүүлэх нөөц боломжтой.

Ашигт малтмал нь бүрэн хэмжээгээр судлагдаагүй боловч нүүрс, барилгын чулуу, шавар, будаг болон төмрийн хүдэр, гянтболд, мөнгөн ус, зэс, алт, мөнгө зэрэг өнгөт ба ховор металлын ихээхэн нөөц баялагтай.

**Усан хангамж, ариутгах татуурга**

Өлгий хотод эхний ээлж болох 2010 онд 35000 хүн суухаас төвлөрсөн системтэй орон сууцанд 2800 хүн, инженерийн хангамжтай хувийн сууцанд 480 хүн, гэр ба түүнтэй төстэй амины орон сууцанд 32200 хүн, төлөвлөлтийн хугацаанд 43000 хүн суухаас төвлөрсөн системтэй орон сууцанд 4300 хүн, инженерийн хангамжтай хувийн орон сууцанд 1250 хүн, гэр ба түүнтэй төстэй амины орон сууцанд 37450 хүн тус тус оршин сууна. Өлгий хотод суух хүн амын ахуйн хэрэглээний усны нормыг СНиП-2.04-02-84 ийн дагуу төвлөрсөн системтэй орон сууцанд суух нэг хүнд 300л/хоног, инженерийн хангамжтай хувийн орон сууцанд суух нэг хүнд 200л/хоног, гэр ба түүнтэй төстэй хувийн орон сууцанд суух нэг хүнд 30-50л/хоног гэж тооцон ус хэрэглээний тооцоог гаргасан.

Хотын хүн амын хэтийн төлөв /Хүснэгт 7.3/

|    | Он   | Хүн амын тоо |
|----|------|--------------|
| 1  | 2008 | 28825        |
| 2  | 2009 | 29103        |
| 3  | 2010 | 29434        |
| 4  | 2011 | 29809        |
| 5  | 2012 | 30220        |
| 6  | 2013 | 30661        |
| 7  | 2014 | 31128        |
| 8  | 2015 | 31617        |
| 9  | 2016 | 32125        |
| 10 | 2017 | 32650        |
| 11 | 2018 | 33188        |
| 12 | 2019 | 33739        |
| 13 | 2020 | 34300        |
| 14 | 2021 | 34872        |

Өлгий хотод одоогоор ажиллаж байгаа томоохон үйлдвэр байхгүй, хойшид одоо байгаа барилга үйлдвэрийн бааз, тоосгон завод зэрэг нь дахин сэргэх боломжтой ба бага хүчин чадлын ноос угаах үйлдвэр байгуулагдана гэж үзэн усны зардлыг хоногийн зардлын 30 –н хувиар бодож авлаа. Дээрхи тооцооноос үзэхэд эхний ээлжинд  $Q=2076.36\text{м}^3/\text{хоног} = 140.85\text{ м}^3/\text{цаг} = 45.2\text{ л/сек}$ .

**Цахилгаан хангамжийн төлөвлөлт**

Өлгий хотыг Баруун бүсийн эрчим хүчний системд 1997 оны нэгдүгээр сарын 19 –нд холбосон. Баян-Өлгий аймгийн төвийн 110/35/6 кВ –ын хүчдэлтэй 2\*16000 кВА чадалтай “Өлгий” дэд өртөөг 110 кВ –ын хоёр хэлхээт АС -150 маркийн утастай 218 км урт цахилгаан дамжуулах агаарын шугамаар тэжээж байна.

Хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчээр хангах эх үүсвэр нь 110/35/6 кВ –ын хүчдэлтэй 2\*16000 кВА чадалтай “Өлгий” дэд станц байна. Хэрэглэгчдийн өсөн нэмэгдэх хэмжээгээр хаалттай дэд өртөө 4, агаарын дэд өртөө3, 6кВ-ын кабель шугам 2.8км, 6кВ –ын цахилгаан дамжуулах агаарын шугам 3.0 км шинээр барина. Гэр хороолол, үйлдвэр аж ахуйн хэсгийн ЦДАШ –ыг засвар үйлчилгээ хийж хэвээр нь ашиглана.

**Холбоо мэдээллийн сүлжээ**

Өлгий хот нь Үндэсний цөөнх оршин суудаг тул энэхүү онцлог, байршил нь дэд бүтэц хүн амын шилжилт суурьшилтанд ихээхэн нөлөөтэй юм. Тус хотод 1997-1999 оны техникийн шинэчлэлтээр ашиглалтанд орсон 2000 хэрэглэгчтэй Электрон автомат телефон ярианы холболтын станц ашигладаг.

Монгол улсын төвийн бүсээс эх орны баруун бүсэд бүх төрлийн мэдээлэл дохиолол дамжуулах радио релейны шугамын 138-р дахин дамжуулах станц Өлгий хотын дэргэд 8км зайтай Хурдан морь барьдаг уулын оройд байрладаг тул төвийн хоорондын ба улс хоорондын автомат телефон холбоо, ярианы холболтоор бүрэн хангагджээ.

Хүн амын өсөлт, суурьшилт, хэрэгцээ, барилгажилтын бүс хүрээнээс хамаарч автомат телефон ярианы станцыг одоо байгаагаас 3 дахин өргөжүүлнэ. Хэрэглэгчийн станцтай холбох 155 МГц хүртэл хурдтай тоон дамжуулах, холбох системийн АТС /автомат телефон станц/, оптик шилэн кабелийн төгсгөлийн байгууламжийг өргөтгөн барихаар төлөвлөв. үүний үр дүнд бүх телефон хэрэглэгч хот хооронд ба улс хооронд автоматаар шууд залгагдан ярих, интернетэд холбогдох боломж нээгдэх юм. Автомат телефон станцын өргөтгөлтэй уялдан түүнийг дагалдах техник төхөөрөмж, кабель шугам сүлжээг техникийн зохих норм дүрмийн дагуу тооцон өргөтгөхөөр тусгав. Хот хоорондын автоматаар холбогдох сувгийн багтаамжийг өргөтгөн АТС –ын багтаамж, хөдөлгөөнт холбооны хэрэглэгчийн тоотой уялдуулан одоо буй сувгийн уртын хэмжээг 2 дахин нэмэгдүүлж өргөтгөхөөр төлөвлөв.

Хэт богино долгионы радио станцын байршилыг барилгажилтын хүрээ, бүсээс хамруулан байгуулж долгион тархалтыг иж бүрнээр гүйцэд хангахаар тооцов. Шугамын радиогоор хангах сүлжээний бааз суурь байхгүй болсон тул үүнийг хэт богино долгионы радио станцын нэвтрүүлгээр нөхөн хангахаар тооцов. Хэвлэл сонин түгээх, захидал илгээмжийг хүргэх өргөжүүлэхэд урьчилсан хөрөнгө оруулалт барилга байгууламж шаардлагагүй гэж үзэж хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтанд түшиглэх бодлого барьж төлөвлөв.

**Дулаан хангамж төлөвлөлт**

Өлгий хотыг 1986 онд ашиглалтанд орсон KE-25-14E маркийн 25т/цаг уур гаргах хүчин чадалтай 4 зуухаар хангаж байна. Хэрэгцээний халуун усны халаагч ВЦБ-150 дөрвөн метр урт 38 секцтэй. Энэ зуухнаас гаргах дулааны эрчим хүчийг халаалтын систем, хэрэгцээний халуун ус бэлтгэх болон дулааны эрчим хүчийг халаалтын систем, хэрэгцээний халуун ус бэлтгэх болон технологийн зориулалттай уур бэлтгэх хүрээнд хэрэглэгддэг. Өлгий хотын дулаан хэрэглэгчдийг дулаан хуваарилах нийт 10 төвөөр дамжуулан дулаанаар хангаж байна.

Төлөвлөлтөөр дулааны эх үүсвэрийг өргөтгөх шаардлагагүй гэж үзжээ. Учир нь хуучин барилга байгууламжуудыг “Барилга дулаан техник” БНБД 2.01.03-92 –ын шаардлагын дагуу дулаалах, шинээр баригдах барилга байгууламжийн хашлага бүтээцийг дулаалгатай төлөвлөх, “Тоног төхөөрөмж ба дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт” БНБД 41-03-99 –ийн дагуу дамжуулах хоолойг дулаалах зэргээс хамааруулан үзэхэд дулааны эх үүсвэр нь нөөцтэй байна. Харин тоног төхөөрөмж нь хуучирч муудсан улмаас шинэчлэн сайжруулах шаардлагатай болжээ.

Захиргааны ДТХ болон 1 –р арван жилийн ДХТөвийн тоног төхөөрөмжүүдийг хүчин чадлын дагуу шинэчлэх шаардлагатай байна. Дулааны эх үүсвэрээс алслагдсан барилга байгууламжуудыг бүлэглэн нэгдсэн эх үүсвэрээс дулаанаар хангахаар төлөвлөсөн. Дан буюу давхар амины орон сууцны хорооллын дулаан хангамжыг бие даасан дулаан хангамжийн системтэй байхаар төлөвлөсөн.



Техник эдийн засгийн нэгдсэн үзүүлэлт /Хүснэгт 7.4/

| Үзүүлэлт   | Хэмжих нэгж | Одоогийн байдал | Эхний ээлж | Төлөвлөлтийн хугацаа |
|--|-------------|-----------------|------------|----------------------|
| <b>I. Хүн ам</b>   |             |                 |            |                      |
| Хотын хүн ам   | Мян.хүн     | 27.1            | 35.0       | 43.0                 |
| Хүн амын насны бүтэц                                     |             |                 |            |                      |
| -сургуулийн өмнөх насны хүүхэд                           | Хүн         | 5408            | 7000       | 8600                 |
| -сургуулийн насны хүүхэд                                 | Хүн         | 6495            | 8400       | 10300                |
| -хөдөлмөрийн насны хүн ам                                | Хүн         | 14291           | 18400      | 22600                |
| -тэтгэвэрийн насны хүн ам                                | Хүн         | 951             | 1200       | 1500                 |
| өрх  | Тоо         | 5995            | 7760       | 9575                 |
| <b>II. Нутаг дэвсгэр</b>                                 |             |                 |            |                      |
| Төлөвлөлтийн хүрээн дэх нутаг дэвсгэр                    | Га          | 986.0           | 1330.0     | 1330.0               |
| Үүнээс: а) Суурьшлын бүс                                 | Га          | 735.0           | 1043.0     | 1010.0               |
| Нийтийн орон сууцны                                      | Га          | 12.45           | 16.0       | 20.0                 |
| Хувийн орон сууцны                                       | Га          | 5.83            | 15.7       | 33.0                 |
| Үүнээс: Эдэлбэр газартай сууцны                          | Га          | 5.83            | 11.0       | 21.0                 |
| Эдэлбэр газаргүй сууцны                                  | Га          | -               | 4.7        | 12.0                 |
| Гэр хорооллын  | Га          | 591.5           | 740.0      | 800.0                |
| Соёл ахуйн үйлчилгээ, олон нийтийн                       | Га          | 22.42           | 31.0       | 38.0                 |
| Цэнгэлдэх хүрээлэн нийтийн хэрэгцээний ногоон байгууламж | Га          | 60.1            | 72.5       | 84.0                 |



|  |                     |                         |         |         |
|--|---------------------|-------------------------|---------|---------|
| Хотын нийтийн зориулалттай гудамж, зам талбай  | Га                  | 10.7                    | 24.8    | 35.0    |
| Нөөц талбай  | Га                  | 32.0                    | 143.0   | -       |
| Б) Үйлдвэр аж ахуйн бүс  | Га                  | 110                     | 110     | 110     |
| үйлдвэрийн бүс   | Га                  | 46.0                    | 57.5    | 70.0    |
| Нөөц талбай  | Га                  | 64.0                    | 52.5    | 40.0    |
| Хамгаалалтын бүс   | Га                  | 87.0                    | 123.0   | 156.0   |
| Тусгай зориулалттай объектын эдэлбэр газар   | Га                  | 54.0                    | 54.0    | 54.0    |
| -Баруун бүсийн радио нэвтрүүлгийг дахин дамжуулах станц                              | Га                  | 50.0                    | 50.0    | 50.0    |
| -Цэргийн анги  | Га                  | 3.25                    | 3.25    | 3.25    |
| -Хотын төвийн оршуулгын газар  | Га                  | 0.75                    | 0.75    | 0.75    |
| Хүн амын нягтрал   |                     |                         |         |         |
| -суурьшлын нутаг дэвсгэрт  | Хүн/га              | 36.9                    | 33.6    | 42.6    |
| -хотын төлөвлөлтийн хүрээн дэх нутаг дэвсгэр   | Хүн/га              | 27.5                    | 26.3    | 32.3    |
| Суурьшлын бүсийн орон сууцны барилгажилтын нягтрал                                   | %                   | 2.5                     | 3.0     | 5.2     |
| <b>III. Соёл ахуйн үйлчилгээ</b>   |                     |                         |         |         |
| Сургууль   | Сурагчийн тоо       | 4880                    | 6120    | 6500    |
| Ясли-цэцэрлэг  | Хүүхдийн тоо        | 965                     | 1165    | 1465    |
| Аймгийн нэгдсэн эмнэлэг  | Ор                  | 150                     | 150     | 150     |
| Төрөлжсөн эмнэлэг  | Ор                  | 90                      | 90      | 180     |
| Аймгийн соёлын ордон   | Суудал              | 500                     | 500     | 500     |
| Кино театр   | Суудал              | -                       | -       | 300     |
| Хүүхэд залуучуудын ордон   | Суудал              | -                       | -       | 200     |
| Музей, үзэсгэлэнгийн газар   | Объект              | 1                       | -       | 1       |
| Номын сан  | Объект              | Драммын театрын байранд |         |         |
| Багуудын соёлын төв  | Суудал              | -                       | 2       | 5       |
| Мэдээллийн төв   | Объект              | -                       | -       | 1       |
| Ахуй үйлчилгээний ордон  |                     | -                       | -       | 1       |
| Нийтийн хоол   | Суудал              | 60                      | 100     | 250     |
| Хагас бэлэн бүтээгдэхүү боловсруулах, бэлэн хоол үйлдвэрлэх савлах худалдаалах газар | Объект              | -                       | -       | 3       |
| Зочид буудал   | Ор                  | 50                      | 100     | 200     |
| Халуун ус, саун  | Шүр.тоо             | 50                      | 55      | 75      |
| Угаалга, хими цэвэрлэгээ   | Объект              | 1                       | 3       | 6       |
| Гал түймэртэй тэмцэх газар   | Машины тоо          |                         |         |         |
| Авто машины төвлөрсөн гараж  | Машины тоо          | -                       | 10      | 20      |
| <b>IV. Инженерийн хангамж</b>  |                     |                         |         |         |
| Дулаан хангамж эх үүсвэр төрөл   |                     | KE-25-14E               |         |         |
| -эх үүсвэрийн хүчин чадал  | Гкал/жил            | 45401.5                 | -       | 67336.6 |
| -дулааны гол шугамын урт   | М                   | 495                     | 470     | 1100    |
| Усан хангамж   |                     |                         |         |         |
| Цэвэр усны нийтийн хэрэглээ  | М <sup>3</sup> /хон | 1197.51                 | 2076.36 | 3808.74 |
| -эх үүсвэр (гүний худаг)   | Объект              | 2                       | 2       | 2       |
| -нийт ундрага  | л/сек               | 40                      | 40      | 40      |
| -усан сан  | М <sup>3</sup>      | 2000                    | 2000    | 2000    |
| +цэвэр усны гол шугамын урт  | Км                  | 12.5                    | 12.5    | 12.5    |
| Ариутгах татуурга  |                     |                         |         |         |
| -гарч буй бохир усны хэмжээ  | М <sup>3</sup> /хон | 1197.51                 | 2076.36 | 3808.74 |

|   |         |                |                |                |
|---|---------|----------------|----------------|----------------|
| -цэвэрлэх байгууламж                                | Төрөл   | Энгийн биологи | Энгийн биологи | Энгийн биологи |
| -ариутгах татуургын гол шугамын урт                 | Км      | 6.8            | 8.4            | 9.8            |
| Цахилгаан хангамж                                   | Км      |                |                |                |
| 110 кВ –ын ЦДАШ                                     | Км      | 218            | 218            | 218            |
| 35 кВ –ын ЦДАШ                                      | Км      | 30             | 30             | 30             |
| 10 кВ –ын ЦДАШ                                      | Км      | 35.3           | 37.0           | 38.3           |
| 10 кВ –ын кабель шугам                              | Км      | 19.4           | 21.0           | 22.2           |
| Холбоо  |         |                |                |                |
| Хотын электрон АТС                                  | NNө     | 2000           | 4000           | 6000           |
| Хотын телефоны Х.Шүүгээ                             | Ш       | 12             | 13             | 14             |
| Хотын телефон сувагчлал                             | Км      | 8.6            | 9.0            | 9.6            |
| Хотын телефон кабель шугам                          | Км      | 1.0            | 2.8            | 3.8            |
| Дэд бүтцийг хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалт | Сая.төг | -              | 639.2          | 1142.3         |
| Усан хангамж  | Сая.төг | -              | 48.6           | 42.3           |
| Цахилгаан хангамж                                   | Сая.төг | -              | 130.0          | 310.0          |
| Дулаан хангамж                                      | Сая.төг | -              | 121.6          | 40.0           |
| Холбоо  | Сая.төг | -              | 339.0          | 750.0          |

**7.1.1.3 Орон нутгийн хөгжлийн хот Улаангом хот**

**Орон нутгийн хөгжлийн хотын чиг хандлага**

Увс аймгийн нийт нутаг дэвсгэр 94400 км<sup>2</sup>. Увс аймаг нь баруун бүсийн хувьд Ховд хотод таталцан түүнээс бүсийн чанартай үйлчилгээ авч байх юм. Хот суурины цэцэрлэгжүүлэлтийг хүн амын ажил амьдралд тохиромжтой ариун цэвэр-эрүүл ахуйн нөхцлийг хангасан хотын орон зайд бичил уур амьсгалын орчинг бий болгож байгалийн элдэв хортой нөлөөллөөс хамгаалж, барилгажсан нутаг дэвсгэрийн архитектур орон зайн зохиомжийг сайжруулсан байхаар тооцож төлөвлөнө.

Үйлдвэрлэлийн цаашдын хөгжлийн стратеги нь байгаль орчинд үзүүлэх хор хөнөөл багатай, эдийн засгийн хүчирхэг, оновчтой технологи, орчин үеийн тоног төхөөрөмж бүхий, хүн амын өдөр тутмын хэрэгцээг аль болох ойр зайнаас хангахад чиглэгдсэн бүтцийг бий болгоход оршино.

**Хотын хүн амын хэтийн төлөв /Хүснэгт 7.5/**

|    | Он   | Хүн амын тоо |
|----|------|--------------|
| 1  | 2008 | 24466        |
| 2  | 2009 | 24580        |
| 3  | 2010 | 24738        |
| 4  | 2011 | 24933        |
| 5  | 2012 | 25160        |
| 6  | 2013 | 25417        |
| 7  | 2014 | 25698        |
| 8  | 2015 | 26002        |
| 9  | 2016 | 26326        |
| 10 | 2017 | 26667        |
| 11 | 2018 | 27025        |
| 12 | 2019 | 27397        |
| 13 | 2020 | 27782        |
| 14 | 2021 | 28179        |

Улаангом хотод шинээр нэмэгдэх архи, пиво, ундааны үйлдвэр, мах боловсруулах үйлдвэр, шил шаазан эдлэл керамикийн үйлдвэр, ээрмэл сүлжмэлийн үйлдвэр, үндэсний хувцасны үйлдвэр, эм тариурын үйлдвэр, ардын эмийн үйлдвэр, ахуйн үйлчилгээний үйлдвэрүүд байгуулах.

Аялал жуулчлалын хувьд олон үндэстэн, ястны зан заншил, аргаль янгирын сүргийн үргэж хульжихгүйгээр ойроос үзэх боломж, байгалийн өвөрмөц тогтоцтой газрууд, мөнх цас, мөсөн голоос эхлэн, тайга, уулын хээр, хээр тал, говь цөлийн элсэн манхан хүртэлх байгалийн бүс бүслүүрүүд 90 км нутагт үргэлжлэн нэгээс нөгөөд шилжин байдаг орчин зүй, байгаль ландшафтын хувьд эрс ялгаа бүхий хоорондоо төдий л алслагдаагүй хосгүй үзэсгэлэнт байгалийн хослол бүхий газар нутагтай

Улаангом хотоос баруун тийш 50 км зайд Спорт-агнуурын чиглэлийн аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой Хөндлөн голын эх, Хөхнуур оршдог.

### **Нийгмийн дэд бүтцийн хангамжийн төлөвлөлт**

**Боловсролын байгууллага.** Улсын нийслэлд их дээд сургууль, тусгай мэргэжлийн сургууль, коллеж хэт төвлөрсөн нь аймгуудын хүн амын шилжих хөдөлгөөнд (механик) ихээхэн нөлөөлж байгааг харгалзан Баруун бүс нутгийн хөгжлийн тулгуур төв-Ховд, Улиастай хотод Хөдөө аж ахуйн дээд сургууль, Шинжлэх ухаан, технологийн Их Сургуулийн салбар, Гадаад хэлний дээд сургууль, байгуулахаар төлөвлөж байна. Мөн хөдөө аж ахуй, ойн мод, уул уурхайн чиглэлийн коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах нь зүйтэй.

Одоогийн байдлаар орон нутгийн хөгжлийн төв Улаангом хотод:

1.Хөдөлмөрийн дээд сургуулийн салбар сургууль;

2."Улаангом" коллеж;

3.Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв байдаг бөгөөд цаашид төлөвлөлтөөр дараахь их дээд сургууль бүхий цогцолбор байрлана:

- МУИС-ын салбар их сургууль;
- Биеийн тамирын дээд сургууль;
- Эрчимжсэн хөдөө аж ахуйн их сургууль

4.Одоо байгаа сургуулиудыг өргөтгөнө

Их дээд сургууль, мэргэжлийн сургалтын төвүүд Улаангом хотод байрлахын зэрэгцээ Ерөнхий боловсролын сургуулийн бүс нутгийн түвшний үйлчилгээ (10 жилийн сургууль болон төрөлжсөн тусгай, лицей сургууль гэх мэт) байх ба үйлчлэх хүрээ нь 750-1000 м-т; цэцэрлэгийн үйлчлэх хүрээ нь 500 м-т байна.

**Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага:** Орон нутгийн түвшний эмнэлгийн үйлчилгээ, төрөлжсөн эмнэлгүүд байрлах бөгөөд үйлчлэх хүрээ нь 2000 м; төрөлжсөн эмнэлгийн үйлчилгээ нь үйлчлэх хүрээнээс үл хамаарна.

**Соёлын байгууллага:** Улаангом хот нь орон нутгийн хөгжлийн тулгуур төв хотын статусаар хөгжих тул орон нутгийн үйлчлэх хүрээний хүн ам буюу хөдөөгийн хүн амд үйлчлэх соёлын үйлчилгээний дээд түвшний барилга байгууламж байна.

**Худалдаа үйлчилгээний байгууллага:** Орон нутгийн хөгжлийн тулгуур төвд байх худалдаа, үйлчилгээ, банк, санхүүгийн зохих түвшин, зэрэглэлийн орон нутгийн чанартай томоохон барилга байгууламж 10.0 орчим хувийг эзэлнэ. Энд аялал жуулчлал хөгжүүлэхтэй холбогдсон дөрвөн одтой дээд зэрэглэлийн 100 ортой зочид буудлыг төлөвлөлтөнд тусгасан болно.

**Биеийн тамир, спортын байгууллага:** Биеийн тамир, спортын байгууллагын дээд түвшнийг төлөвлөсний зэрэгцээ бүс нутаг, аймгийн төвд байвал зохих хаалттай бассейныг төлөвлөсөн.

**Нийтийн аж ахуйн байгууллага:** Нийтийн аж ахуйн хэсэгт агуулах, гараж, төрөл бүрийн машины парк, галын депо багтаж байгаа бөгөөд галын депоны үйлчлэх хүрээ 3000 м байна. Иймд галын депог өргөтгөхийн зэрэгцээ Гэр хороололд галын 1 депо нэмж төлөвлөсөн болно.

### **Усан хангамж ариутгах татуурга**

Улаангом хотын усан хангамжийн эх үүсвэр нь одоогийн байдлаар цагт дунджаар 160+200 м<sup>3</sup> усыг хотын нэгдсэн усан хангамжийн системд нийлүүлэх боломжтой. Гэр хорооллын оршин суугчдын ихэнхи хэсэг нь зөөврийн усыг хэрэглэдэг бөгөөд цаашид тэдний усны хэрэгцээг нэмэгдүүлэхийн тулд шинээр ус түгээх байруудыг хотын нэгдсэн усан хангамжийн системд холбох нь зүйтэй. Улаангом хотын цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагагүй юм.

### **Цахилгаан хангамжийн төлөвлөлт**

Увс аймгийн 110/35/10 кВ-ын хүчдэлтэй 2\*10000кВА чадалтай "Улаангом" дэд өртөөг 1995 оны 12 дугаар сарын 18-нд Тувагийн эрчим хүчний системд холбож импортын цахилгаан эрчим хүчээр Баруун аймгуудыг хангаж эхэлсэн юм.

Улаангом хот нь баруун хойт талд байрлах 110/35/10 кВын хүчдэлтэй 2\*10000 кВА чадалтай дэд өртөөг АСО-300 кв.мм хөндлөн огтлолтой төмөр бетон тулгууртай хоёр хэлхээт 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамаар тэжээж байна. 110кВ-ын дэд өртөөнөөс хил хүртлэх зай нь 101 км юм. 110/35/10кВ-ын дэд өртөөнөөс АС-120 кв.мм хөндлөн огтлолтой төмөр бетон тулгууртай хоёр хэлхээт 35кВ-ын хүчдэлтэй 11.89 км цахилгаан дамжуулах агаарын шугамаар дизелийн дэргэд байрлах 35/6кВ-ын хүчдэлтэй 2\*10000кВА чадалтай дэд өртөөг тэжээнэ. 35/6кВ-ын дэд өртөөнөөс Хархираагийн тэжээлийн аж ахуйг 35кВ-ын 28км цахилгаан дамжуулах агаарын шугамаар тэжээж байна. Шкода маркийн 860кВА чадалтай 3 ширхэг (бэлтгэл дизель) дизель цахилгаан станц ажиллаж

байна. Орон сууц, үйлдвэр олон нийтийн газар, гэр хорооллын авч байгаа цахилгааны ачаалал нь 2.1 МВт байна. Цахилгаан хэрэглэгчдийн өвлийн их ачаалал нь 2.8 МВт зуны бага ачаалал нь 1.6 МВт байна.

110/35/10 кВ-ын хүчдэлтэй 2\*10000 кВА чадалтай дэд өртөөнөөс 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамаар тэжээгдэж байгаа 35/6 кВ-ын хүчдэлтэй 2\*10000 кВА чадалтай дэд өртөөнөөс Улаангом хотын цахилгаан хэрэглэгчдийг эрчим хүчээр хангана. Төлөвлөлтийн хугацаанд одоо ажиллаж байгаа хүчний хувьсгуурын хүчин чадал хүрэлцээтэй.

2020 он хүртэл Увс аймгийн 12 сумыг Баруун бүсийн эрчим хүчний системд холбогдоно. Зүүнговь сумыг 110 кВ-ын ЦДАШ-аар, Давст, Баруунтуруун, Зүүнхангай, Өлгий сумыг 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамаар, Тэс, Малчин, Хяргас, Цагаанхайрхан, Өндөрхангай, Наранбулаг, Завхан, Баяннуур сумыг 15 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамаар тэжээнэ. Одоо ажиллаж байгаа дэд өртөөний хүчин чадалыг нэмэгдүүлэх, агаарын дэд өртөөг хаалттай дэд өртөө болгон өргөтгөх замаар шинээр нэмэгдэх хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангана.

#### **Холбоо, мэдээллийн сүлжээ**

Улаангом хотын холбооны барилга нь 1965 онд ашиглалтанд орсон, Автомат телефон станц нь 1970 онд Координатный АТС (К-АТС)-50/500 багтаамжтайгаар, 1985 онд 500 номероор, 2001 онд 1720 номерын багтаамжтайгаар тус тус өргөтгөсөн. Хот, улс хоорондын дамжуулах байгууламж болох Сансрын холбооны VSAT систем NEAXT-61 E-10 системүүдээр дамжин дэлхийн бүх улс, оронтой холбогддог. Үүрэн телефоны Мобикомын салбар 2003 оны 12 дугаар сард ашиглалтанд орсон.

Улаангом хотын Электрон АТС-ын өргөтгөлтэй уялдан, түүнийг дагалдах техник тоног төхөөрөмж, кабель шугам сүлжээг техникийн зохих норм, дүрмийн дагуу тооцон өргөтгөх болно. Барилгажилтын бүс, хүрэнээс хамаарч, төлөвлөж буй секторуудад телефоны хуваарилах шүүгээг төлөвлөсөн. Хүн амын өсөлт, хэрэгцээнээс хамаарч, хөдөлгөөнт холбооны төлөвлөлт хийгдэж байгаа боловч суурин телефоны хэрэгцээг түлхүү тооцож өгөв.

Радио өргөн нэвтрүүлгээр Баруун бүсийг хангах Баян-Өлгий аймгийн төв Өлгий хот дахь УКВ-ЧМ-TF(S)-100 маркийн станц нь 2002 онд Япон улсын тусламжаар шинэчлэгдсэн тул Улаангом хотын ард түмэн энэ станцаас Монголын радиогийн нэвтрүүлгийг цаашид үргэлжлэн сонсох болно.


Жижиг сууцны хорооллуудад үйлчлэх хүрээ, хүн амын хэтийн төлөвөөс хамааруулан холбооны 2 салбарыг шинээр хорооллын үйлчилгээний төвд байршуулан төлөвлөв. Хэвлэл мэдээлэл, сонин түгээх, захидал илгээмжийг хүргэх, өргөжүүлэхэд Жижиг сууцны хорооллууд ба алслагдсан газруудад Шуудан холбооны салбарыг төлөвлөсөн болно. Мөн интернетын үйлчилгээг ашиглаж байна.

#### **Дулаан хангамж**

Увс аймгийн Улаангом хотод одоогийн байдлаар 25.4 мян.хүн оршин суудаг бөгөөд төвлөрсөн дулаан хангамжийн системээс хангагддаг орон сууцанд нийт хүн амын 11.0 хувь буюу 2.9 мянган хүн амьдардаг. Бусад хүн ам гэр хороололд оршин суудаг. Дулаан хангамжийн төвлөрсөн эх үүсвэр нь 1982 онд үйлдвэрлэгдсэн ба 1986 онд суурилагдсан. Дулаан хангамжийн төвлөрсөн эх үүсвэр нь 1982 онд үйлдвэрлэгдсэн ба 1986 онд суурилагдсан. 30 Гкал/цаг хүчин чадалтай КЕ 25/14 маркийн 2, 10.8 Гкал/цаг хүчин чадалтай БҮШ маркийн 1 зуухтай. Төвлөрсөн халаалтын зуух 120 км зайд орших Хар тарвагатайн нүүрсний уурхайгаас нүүрсээ татдаг. Зуухны параметр нь 105/70°C.

Дулаан хангамжийн эх үүсвэр нь орчин үеийн дэвшитэт технологитой байгаль экологийн шаардлага хангасан, ашигт үйлийн коэффициент 75.0 хувиас дээш байх шаардлагатай. Одоо байгаа 5 дулаан дамжуулах төвийн тоног төхөөрөмж болон барилгыг шинэчлэн засварлаж цаашид ашиглах ба дулаан дамжуулах 10 төвийг шинээр нэмж төлөвлөхөө. Дулаан дамжуулах шугамыг шинээр нэмэгдэх ачааллын дагуу тооцон өргөтгөж шинэчлэх ба шинээр дулааны шугам нэмж төлөвлөнө. Одоо байгаа дулааны шугамын ашиглалтын байдал болон нэвтрүүлэх чадвар хүрэлцэхгүй байгаа тул шугамын нэвтрүүлэх чадварыг томсгон шинэчлэх шаардлагатай.

Улаангом хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /Зураг 7.8/



Техник эдийн засгийн нэгдсэн үзүүлэлт /Хүснэгт 7.6/

| Д/д    | Үзүүлэлтүүд                                 |                               | Хэмжих нэгж         | Хүчин чадал     |            |                      |
|--------|---|-------------------------------|---------------------|-----------------|------------|----------------------|
|        |   |                               |                     | Одоогийн байдал | Эхний ээлж | Төлөвлөлтийн хугацаа |
| 0      | 1   |                               | 2                   | 3               | 4          | 5                    |
| 1      | Газар нутаг                                 |                               | га                  | 1700            | 1700       | 1700                 |
| 2      | Хүн ам                                      |                               | мян.хүн             | 25.4            | 29.2       | 35.0                 |
|        | Хувийн жин                                  | Орон сууцны хороололд         | %                   | 11.0            | 20.0       | 30.0                 |
|        |   | Гэр ба жижиг сууцны хороололд | %                   | 89.0            | 80.0       | 70.0                 |
| 3      | Орон сууц                                   |                               | айл                 | 0.685           | 1.4        | 2.6                  |
|        | Талбай                                      | Ашигтай                       | мян.м <sup>2</sup>  | 27.0            | 78.3       | 183.75               |
|        |   | Сууцны                        | мян.м <sup>2</sup>  | 18.9            | 52.2       | 141.75               |
|        | 1 хүнд ногдох талбай                        | Ашигтай                       | м <sup>2</sup> /хүн | 9.3             | 13.5       | 17.5                 |
| Сууцны |   | м <sup>2</sup> /хүн           | 6.5                 | 9.0             | 13.5       |                      |
| 4      | Орон сууцны барилгын дундаж давхар          |                               |                     | 3               | 3.3        | 3.8                  |
| 5      | Нягтрал                                     | Барилгажилтын                 | м <sup>2</sup> /га  | 19.09           | 60.6       | 173.5                |
|        |   | Хүн амын                      | хүн/га              | 12              | 14         | 18                   |
| 6      | Соёл, ахуйн үйлчилгээний барилга байгууламж | Сургууль                      | сурагч              | 6301            | 6600       | 9475                 |
|        |   | Цэцэрлэг                      | хүүхэд              | 850             | 1900       | 3675                 |
|        |   | Эмнэлэг                       | ор                  | 279             | 420        | 570                  |
|        |   | МСҮтөв                        | суралцагч           | 500             | 1200       | 1395                 |
|        |   | Халуун ус                     | шүршүүр             | 60              | 135        | 295                  |
|        |   | Зоогийн газар                 | суудал              | 300             | 585        | 1400                 |
|        |   | Зочид буудал                  | ор                  | 75              | 145        | 210                  |
|        |   | Кинотеатр                     | суудал              | 350             | 585        | 1050                 |
|        |   | Соёлын төв                    | суудал              | 400             | 1540       | 2780                 |
|        |   | Хүүхдийн ордон                | дугуйланд суралцагч | -               | 430        | 900                  |
| 7      | Үүнээс                                      | Талбайн баланс, бүгд          | %                   | 100.0           | 100.0      | 100.0                |
|        |   | Орон сууцны                   | %                   | 67.5            | 67.5       | 67.4                 |
|        |   | Соёл, олон нийтийн            | %                   | 14.1            | 12.2       | 8.0                  |
|        |   | Ногоон байгууламж             | %                   | 2.1             | 5.1        | 18.1                 |
|        |   | Үйлдвэр аж ахуйн              | %                   | 14.8            | 14.0       | 5.5                  |
|        |   | Тусгай зориулалтын            | %                   | 1.5             | 1.2        | 1.0                  |
| 8      | Хөрөнгө оруулалт                            |                               | сая ₮               |                 | 21290.0    | 61525.0              |
|        | Үүнээс                                      | Инженерийн дэд бүтэц          | сая ₮               |                 | 10306.9    | 21331.1              |
|        |   | Нийгмийн дэд бүтэц            | сая ₮               |                 | 10983.1    | 40193.9              |

**7.1.1.4 Бүсийн хөгжлийн тулгуур төв Улиастай хот**

**Тулгуур төв хотын хөгжлийн чиг хандлага**

Завхан аймаг бүс нутгийн бүлэг суурингийн төв болгосноор Баянтэс хошуу, Ойгон хошуу, Идэр хошуу, Завхан хошуу, Улиастай хошуу, Сангийн далайн хошуу, Отгонтэнгэр хошуу, Бугат хошуу, Говь алтай хошуу, Гичгэнэ хошуу эдгээр нь таталцах юм.

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хамрах хүрээ, гол гол чиглэлүүдийг илрүүлэхдээ олон тооны шалгуур үзүүлэлтүүдийг хэрэглэдэг бөгөөд үүнд хүн амын амьдралын түвшин (нэг хүнд ногдох бодит орлого, ажилгүйдлийн түвшин гэх мэт), аж үйлдвэрийн бүтэц, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, эдийн засаг-нийгмийн хөгжлийн ерөнхий түвшин, хүн ам зүйн үзүүлэлтүүд, байгалийн нөхцөл нөөц, газарзүйн байрлал гэсэн 6 үндсэн бүлэгт авч үздэг байна.

Улиастай хот нь урт хүйтэн, цас багатай өвөлтэй, хуурай ба хүйтэн хавартай, сэрүүвтэр бага зэрэг чийгшилтэй зунтай ба хүйтэн намартай. Цаг агаар нь хүйтэн, эрс тэс эх газрынх. Ургамлын сэргэлтийн үе VI сарын орчмоос эхэлдэг. Улиастай хотод амралт зугаалгын бүсийн зэрэгцээ цаг агаарын нөхцөлд тохирсон ургамал бүхий цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт гудамжийг төлөвлөнө.

Ганцын давааны урд хэсгээр Ан агнуурын аялал жуулчлалыг хөгжүүлэхийн зэрэгцээ, түүний судалгаа шинжилгээний төв, ховор ан амьтдыг хамгаалах газрыг байгуулана. Мөн Донойн хөндийг түшиглэн, нисэх аяллын маршрутыг зохион байгуулж, Отгонтэнгэрийн амралтын чиглэлд ан агнуурын аялал, үзэсгэлэн худалдаа хөгжүүлж, Ангийн отгуудыг энэ чиглэлд байгуулах боломжтой.

Завхан аймаг нь хүн ам нилээд нягт суурьшилтай, ажиллах хүчний нөөц ихтэй, аж үйлдвэр бараг хөгжөөгүй бөгөөд аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын голлох элементээр 29 төрлийн 186 орд, илрэл, сарнилын хэтийн төлөв бүхий хүрээ, хэтийн төлөвгүй 300 эрдэсжсэн цэг, шлих, геохимийн сарнилын хүрээ геофизикийн гажиг тогтоогдсон байна. Аймагт зэс, алт, төмөр зэрэг холимог металл, алмаз, нефть, фосфорит гэх мэт металл бус ашигт малтмалын орд газар нээгдэх хэтийн төлөвтэй тул Завханмандал, Тосонцэнгэл, Дөрвөлжин, Алдархаан зэрэг сумдад тогтвортой үйл ажиллагаатай аж үйлдвэрийн олборлох бүтэц шинээр үүсэх магадлалтай. Тус аймгийн хэмжээнд барилгын материалын үйлдвэрийг хөгжүүлэх ихээхэн нөөцтэй бөгөөд нөөц нь батлагдсан ордуудыг түшиглэн Завхан аймгийн Тэлмэн, Яруу сумдад тоосгоны, Алдархаан суманд цементийн, Мөрөн хотод барилгын материалын жижиг, дунд үйлдвэрийг байгуулан аймаг, орон нутаг, бүс нутгийн хэрэгцээнд ашиглах боломжтой юм.

**Хотын хүн амын хэтийн төлөв /Хүснэгт 7.7/**

|    | Он   | Хүн амын тоо |
|----|------|--------------|
| 1  | 2008 | 16773        |
| 2  | 2009 | 16981        |
| 3  | 2010 | 17214        |
| 4  | 2011 | 17468        |
| 5  | 2012 | 17739        |
| 6  | 2013 | 18025        |
| 7  | 2014 | 18326        |
| 8  | 2015 | 18641        |
| 9  | 2016 | 18970        |
| 10 | 2017 | 19311        |
| 11 | 2018 | 19665        |
| 12 | 2019 | 20032        |
| 13 | 2020 | 20411        |
| 14 | 2021 | 20803        |

**Нийгмийн дэд бүтцийн хангамжийн төлөвлөлт**

Төлөвлөлтөөр Улиастай хотод орон сууцанд суугч хүн амын 30.0-50.0 хувийг эдэлбэр газартай, инженерийн хэсэгчилсэн хангамжтай сууцанд амьдрах бололцоотойг санал болгож байна. Соёл, ахуйн үйлчилгээний хангамжийн түвшнээр Завхан аймгийн Улиастай хот доогуур-дунд гэсэн үнэлгээ авсан.

**Боловсролын байгууллага:** Улсын нийслэлд их дээд сургууль, тусгай мэргэжлийн сургууль, коллеж хэт төвлөрсөн нь аймгуудын хүн амын шилжих хөдөлгөөнд (механик) ихээхэн нөлөөлж байгааг харгалзан Баруун бүс нутгийн хөгжлийн тулгуур төв-Улиастай хотод Хөдөө аж ахуйн дээд сургууль, Шинжлэх ухаан, технологийн Их Сургуулийн салбар, Гадаад хэлний дээд сургууль, байгуулахаар төлөвлөж байна. Мөн хөдөө аж ахуй, ойн мод, уул уурхайн чиглэлийн коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах нь зүйтэй.

Түүнчлэн Улиастай хотын Арлын хэсэгт баригдах Оюутны хотхонд Их, дээд сургуулийн дараахи сургууль бүхий цогцолбор байрлана:

1. Санхүү-Эдийн засгийн сургууль
2. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн салбар
3. Хууль зүйн сургууль
4. Геологи, уул уурхайн сургууль
5. Компьютер менежментийн сургууль
6. Соёл урлагийн их сургууль
7. Хөдөө аж ахуйн их сургууль

Их дээд сургууль, мэргэжлийн сургалтын төвүүд Улиастай хотод байрлахын зэрэгцээ Ерөнхий боловсролын сургуулийн бүс нутгийн түвшний үйлчилгээ (10 жилийн сургууль болон төрөлжсөн тусгай, лицей сургууль гэх мэт) байх ба үйлчлэх хүрээ нь 750-1000 м-т; цэцэрлэгийн үйлчлэх хүрээ нь 500 м-т байна.

**Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага:** Бүс нутгийн түвшний эмнэлгийн үйлчилгээ, төрөлжсөн эмнэлгүүд байрлах бөгөөд үйлчлэх хүрээ нь 2000 м; төрөлжсөн эмнэлгийн үйлчилгээ нь үйлчлэх

хүрэнээс үл хамаарах бөгөөд 40.0 мянгаас дээш хүн амтай хотод Гоц халдвартын 1 төв байна. Хүүхдийн сүүний газрыг Үйлдвэр аж ахуйн хэсгээс бусад төлөвлөлтийн хэсэг бүрт байхаар төлөвлөвөө.

**Соёлын байгууллага:** Улиастай хот нь бүс нутгийн хөгжлийн тулгуур төв хотын статусаар хөгжих тул бүс нутгийн үйлчлэх хүрээний хүн амд үйлчлэх соёлын үйлчилгээний дээд түвшний барилга байгууламж байна.

**Худалдаа үйлчилгээний байгууллага:** Бүс нутгийн хөгжлийн тулгуур төвд байх худалдаа, үйлчилгээ, банк, санхүүгийн I түвшний өндөр зэрэглэлийн улс, орон нутгийн чанартай томоохон барилга байгууламж 10.0 орчим хувийг эзэлнэ. Энд дээд зэрэглэлийн хэд хэдэн одтой зочид буудал төлөвлөлтөнд тусгасан болно.

**Биеийн тамир, спортын байгууллага:** Биеийн тамир, спортын байгууллагын дээд түвшнийг төлөвлөсний зэрэгцээ бүс нутаг, аймгийн төвд байвал зохих хаалттай бассейныг төлөвлөвөө. Морин уралдааны газрыг хот орчмын бүст одоо байгаа Морин уралдааны газарт хэвээр нь төлөвлөсөн болно.

**Нийтийн аж ахуйн байгууллага:** Нийтийн аж ахуйн хэсэгт агуулах, гараж, төрөл бүрийн машины парк, галын депо багтаж байгаа бөгөөд галын депоны үйлчлэх хүрээ 3000 м байна. Иймд галын Арлын хэсэгт байгаа депо-г өргөтгөхийн зэрэгцээ Үйлдвэр аж ахуйн хэсэгт галын 1 депо нэмж төлөвлөсөн болно.

#### **Усан хангамж, ариутгах татуургын төлөвлөлт**

Ус хэрэглээний тооцоог төвлөрсөн системтэй орон сууцанд суух нэг хүнд хоногт 230-250 л, төвлөрсөн системд холбогдох жижиг сууцанд 120 л, гэр, түүнтэй адилтгах сууцанд суух нэг хүнд хоногт 30-50 л-ээр авч тооцсон.

#### **Ариутгах татуурга**

Төвийн хэсгээс гарах бохир ус  $Q=593.93 \text{ м}^3/\text{хоног}$  гэж цэвэр устай адилаар авч тооцлоо. Энэ хэсэгт цэвэрлэх байгууламж болон гол коллекторуудыг өргөтгөх шаардлагагүй. Харин шинээр төлөвлөж байгаа жижиг сууцны хорооллын орон сууцнуудын бохир усыг шинээр шугам татаж септик руу оруулж өгнө. Үйлдвэрийн хэсэг дэх нөөц талбайд үйлдвэр аж ахуйн барилга байгууламж баригдахад одоо ашиглагдахгүй байгаа цэвэрлэх байгууламжийг сэргээн засварлаж ашиглах боломжтой.

#### **Цахилгаан хангамжийн төлөвлөлт**

Хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчээр хангах эх үүсвэр нь Дизель цахилгаан станц бөгөөд ЭХС-д холбогдоогүй аймгийн нэг юм. Богдын гол дээр баригдсан  $2*1000 \text{ кВт}$ -ын суурьлагдсан хүчин чадалтай хоёр генераторыг зуны цагт ажиллуулж хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангана.

2001 онд гаргасан Монгол улсын эрчим хүчний нэгдсэн систем байгуулах хөтөлбөрт тус Баруун бүс нутгийн хэсэг Завхан аймгийг цахилгаан эрчим хүчээр хангахдаа Говь-Алтай аймгийн Завхан гол дээрхи Тайшир (Улаанбоом)-ын  $8 \text{ мВт}$ -ын хүчин чадалтай УЦС (Засгийн газрын хөтөлбөрт орсон)-ыг 2015 онд барихаар тусгасан. Тайширын УЦС-аас  $110 \text{ кВ}$ -ын хүчдэлтэй  $135 \text{ км}$  цахилгаан дамжуулах агаарын шугамаар Улиастай хотыг,  $110 \text{ кВ}$ -ын хүчдэлтэй  $47 \text{ км}$  цахилгаан дамжуулах шугамаар Алтай хотыг тэжээнэ. Цаашид Баянтээгийн  $40 \text{ мВт}$ -ын ТЭЦ-ээс Баянхонгороор дамжуулан  $220 \text{ кВ}$ -ын  $320 \text{ км}$ , Дөргөний УЦС-аас  $220 \text{ кВ}$ -ын  $320 \text{ км}$  цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбож, Баруун бүсийн Эрчим хүчний системд холбох юм. Одоогийн Дизель цахилгаан станцын дэргэд  $110/35/10 \text{ кВ}$ -ын хүчдэлтэй  $2*10000 \text{ кВА}$  чадалтай дэд станцыг барьж Богдын голын УЦС болон Нисэх буудлыг тэжээх  $35 \text{ кВ}$ -ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг холбох ба одоогийн дизель станцыг бэлтгэлд ажиллуулна.

Одоогийн  $6 \text{ кВ}$ -ын 6 фидер нь 20-оос дээш жил ашиглалтанд байгаа учраас  $6 \text{ кВ}$ -ын тулгуур мод нь ялзралт ихтэй зайлшгүй их засварт оруулж шинэчлэх шаардлагатай болсон байна.

Одоогийн байдлаар оргил ачааллын үед цахилгаан хэрэглээ нь  $2800 \text{ кВт}$  бөгөөд төлөвлөлтийн хугацаанд  $5200 \text{ кВт}$  болно. Төлөвлөлтийн хугацаанд Улиастай хотын хэрэглэгчдийг 2 трансформатортай хаалттай дэд өртөөнүүдээс цахилгаан эрчим хүчээр хангана. Гэр хорооллын шугам сүлжээг хэвээр нь ашиглана.

#### **Холбоо мэдээллийн сүлжээний төлөвлөлт**

Шуудан цахилгаан холбооны газрын төслөөр “Хөдөөгийн цахилгаан холбооны системийг 2020 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-ний дагуу Говь-Алтай аймгаас Улиастай хот руу шилэн кабель холбосноор мэдээлэл холбооны өндөр байгууламжтай болох үндэс суурь тавигдсан.



Одоогийн ашиглаж байгаа радио узелийн өсгөгч нь шинэ технологийн шахалтаар хоцрогдож байгаа тул цаашид тоон системд шилжүүлэх буюу FM богино долгионы радио станцтай байхаар тооцов. Телевизийн үйлчилгээнд кабелийн телевизийн станцыг нэмж төлөвлөн, олон сувгийн MMDS утасгүй кабелийн телевизийн системтэй байхаар төлөвлөв.

Дэлхий нийтээр мэдээллийн ач холбогдол асар эрчимтэй өсч, мэдээллийн технологи нь улс орнуудын хөгжлийг тодорхойлох гол технологиудын нэг боллоо. Улиастай хотын холбоо-мэдээллийн сүлжээнд зөвхөн яриа зонхилон дамжуулах бус, Интернет (өгөгдөл), хөдөлгөөнтэй хөдөлгөөнгүй дүрсийг дуутай хослуулж дамжуулах шаардлага аяндаа гарсан.

**Дулаан хангамжийн төлөвлөлт**

Завхан аймгийн Улиастай хот нь уур амьсгалын II бүсэд орших бөгөөд хамгийн хүйтэн 5 хоногийн температур -36.6°C, хамгийн хүйтэн 3 хоногийнх -37.6°C, 1 хоногийнх -39°C салхивчийн тооцоот температур -26.2°C. Халаалтын улирлын галлагааны хоног -247, 5 дугаар сарын 16-наас 9 дүгээр сарын 13 хүртэл. Галлагааны дундаж температур -9.3°C.

Жижиг орон сууцны хороолол, гэр хорооллын хэсэгт эхний ээлжинд олон нийтийн барилгыг хангах эх үүсвэр тавихаар төлөвлөв. Гэр хорооллын дулааны ачааллын тооцоог гаргаснаар тус хотын гэр хороололд оршин суугчдын түлшний тоо хэмжээг гаргах боломжтой юм.

Шинээр баригдах дулаан хангамжийн эх үүсвэр тухайн орон нутгийн нүүрсэнд түшиглэсэн (Завхан аймаг нутаг дэвсгэр дээрээ нүүрсгүй тул Хөвсгөл аймгийн Могойн голоос нүүрсээ авдаг), техник технологийн хувьд зохицсон байх шаардлагатай. Одоо байгаа дулааны станц болон халаалтын зуухны барилга байгууламжийг сэргээн ашиглаж шинэ дулааны эх үүсвэрийг барьж байгуулна.

Техник эдийн засгийн нэгдсэн үзүүлэлт / Хүснэгт 7.8 /

| Д/д    | Үзүүлэлтүүд                                 |                               | Хэмжих нэгж         | Хүчин чадал     |            |                      |       |
|--------|---|-------------------------------|---------------------|-----------------|------------|----------------------|-------|
|        |   |                               |                     | Одоогийн байдал | Эхний ээлж | Төлөвлөлтийн хугацаа |       |
| 0      | 1   |                               | 2                   | 3               | 4          | 5                    |       |
| 1      | Газар нутаг                                 |                               | га                  | 1200            | 1200       | 1200                 |       |
| 2      | Хүн ам                                      |                               | мян.хүн             | 24.1            | 28.0       | 40.0                 |       |
|        | Хувийн жин                                  | Орон сууцны хороололд         | %                   | 6.6             | 14.7       | 34.4                 |       |
|        |   | Гэр ба жижиг сууцны хороололд | %                   | 94.6            | 85.3       | 65.6                 |       |
| 3      | Орон сууц                                   |                               | мян.айл             | 0.55            | 1.03       | 3.44                 |       |
|        | Талбай                                      | Ашигтай                       | мян.м <sup>2</sup>  | 23.81           | 72.1       | 323.36               |       |
|        |   | Сууцны                        | мян.м <sup>2</sup>  | 14.87           | 43.26      | 185.76               |       |
|        | 1 хүнд ногдох талбай                        | Ашигтай                       | м <sup>2</sup> /хүн | 14.9            | 17.5       | 23.5                 |       |
| Сууцны |   | м <sup>2</sup> /хүн           | 9.3                 | 10.5            | 13.5       |                      |       |
| 4      | Орон сууцны барилгын дундаж давхар          |                               |                     | 3.2             | 3.4        | 3.5                  |       |
| 5      | Нягтрал                                     | Барилгажилтын                 | м <sup>2</sup> /га  | 34.4            | 144.2      | 539                  |       |
|        |   | Хүн амын                      | хүн/га              | 20              | 23         | 35                   |       |
| 6      | Соёл, ахуйн үйлчилгээний барилга байгууламж | Сургууль                      | сурагч              | 4213            | 6390       | 10900                |       |
|        |   | Дотуур байр                   | ор                  | 60              | 1350       | 2500                 |       |
|        |   | Цэцэрлэг                      | хүүхэд              | 925             | 1820       | 4200                 |       |
|        |   | Эмнэлэг                       | ор                  | 320             | 410        | 660                  |       |
|        |   | Халуун ус                     | шүршүүр             | 28              | 125        | 300                  |       |
|        |   | Зоогийн газар                 | суудал              | 170             | 560        | 1600                 |       |
|        |   | Зочид буудал                  | ор                  | 60              | 140        | 240                  |       |
|        |   | Соёлын төв                    | суудал              | 350             | 1495       | 3200                 |       |
|        |   | Кинотеатр                     | суудал              | 350             | 560        | 1200                 |       |
|        |   | Хүүхдийн ордон                | дугуйланд суралцагч | 150             | 430        | 900                  |       |
| 7      | Үүнээс                                      | Талбайн баланс, бүгд          |                     | %               | 100.0      | 100.0                | 100.0 |
|        |   | Орон сууцны                   |                     | %               | 67.5       | 67.5                 | 67.4  |
|        |   | Соёл, олон нийтийн            |                     | %               | 14.1       | 12.2                 | 8.0   |
|        |   | Ногоон байгууламж             |                     | %               | 2.1        | 5.1                  | 18.1  |

|   |                  |                      |       |      |         |         |
|---|------------------|----------------------|-------|------|---------|---------|
|   |                  | Үйлдвэр аж ахуйн     | %     | 14.8 | 14.0    | 5.5     |
|   |                  | Тусгай зориулалтын   | %     | 1.5  | 1.2     | 1.0     |
| 8 | Хөрөнгө оруулалт |                      | сая ₮ |      | 17729.4 | 57122.6 |
|   | Үүнээс           | Инженерийн дэд бүтэц | сая ₮ |      | 6156.8  | 6216.9  |
|   |                  | Нийгмийн дэд бүтэц   | сая ₮ |      | 11572.6 | 50905.7 |

**7.1.1.5 Орон нутгийн хөгжлийн хот Алтай**

Говь-Алтай аймаг 141.4 мян.км<sup>2</sup> газар нутагтай, нутаг дэвсгэрийн хэмжээгээр улсад II байрт орно. Алтай хот нь хот байгуулалтын иж бүрэн үнэлгээгээр дунд, хязгаарлагдмал тохиромжтой үнэлгээ авсан.

Говь-Алтай аймаг нь бүс нутгийн тулгуур төв Улиастай хотод таталцаж түүнээс бүсийн чанартай үйлчилгээ авна. Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрт ашиг малтмалын нилээд их нөөц, орд, илэрцүүд байгаа нь тогтоогдсон байна.

Аж үйлдвэрийн салбарт бүтцийн өөрчлөлт хийхдээ уул уурхайн чиглэлийн өндөр технологитой эцсийн бүтээгдэхүүн гаргах боловсруулах үйлдвэрийг цөөн тоогоор байгуулж, тэргүүлэх чиглэлээ болгох, ханын материалын үйлдвэрийг хөгжүүлж, өөрийн болон хөрш зэргэлдээ орон нутгийн хэрэгцээг ханган, ажлын байрыг нэмэгдүүлэх, түүнчлэн хүн амын хүнс, барааны хэрэгцээг хангахын зэрэгцээ ажлын байр бий болгоход чиглэгдсэн хөнгөн, хүнсний жижиг үйлдвэрүүдийг хөгжүүлэх бодлого баримтлах нь зүйтэй. Мөн хөдөө аж ахуй, түүний дотор мал аж ахуйд түшиглэсэн үйлдвэрийн газруудыг байгуулах боломжтой юм. Аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, техник технологийг шинэчлэх асуудлыг улс, бүс, орон нутгийн түвшинд шийдвэрлэвэл зохино.

Аялал жуулчлалын Улаанбаатар-Алтай гэсэн улс, олон улсын чанартай маршрут; Улиастай-Алтай гэсэн бүс нутгийн чанартай маршрут болон аймгийн дотоодын хэд хэдэн маршрут байх боломжтой.

Мөн Говийн их дархан цаазат газар, Хасагт хайрхан уул зэрэг байгалийн өвөрмөц сонин тогтоцтой газар нутаг, ховор ан амьтадтай газраар нисэх аяллыг зохион байгуулж болох юм.

**Хүн амын хэтийн төлөв /Хүснэгт 7.9/**

|    | Он   | Хүн амын тоо |
|----|------|--------------|
| 1  | 2008 | 17219        |
| 2  | 2009 | 17274        |
| 3  | 2010 | 17370        |
| 4  | 2011 | 17507        |
| 5  | 2012 | 17685        |
| 6  | 2013 | 17903        |
| 7  | 2014 | 18162        |
| 8  | 2015 | 18462        |
| 9  | 2016 | 18803        |
| 10 | 2017 | 19184        |
| 11 | 2018 | 19605        |
| 12 | 2019 | 20068        |
| 13 | 2020 | 20570        |
| 14 | 2021 | 21114        |




**Нийгмийн дэд бүтцийн хангамжийн төлөвлөлт**

Алтай хотод орон сууцанд суугч хүн амын 30.0-50.0 хувийг эдэлбэр газартай, инженерийн хэсэгчилсэн хангамжтай сууцанд амьдрах бололцоотойг санал болгож байна.

**БАРУУН БҮСИЙН ХӨГЖЛИЙН ТУЛГУУР ТӨВ  
ЗАВХАН АЙМГИЙН УЛИАСТАЙ ХОТЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

**ХЭТИЙН ТӨЛӨВ**

МАСШТАБ 1:20 000



Улиастай хотын хөгжлийн  
3D зураг /Зураг 7.9/

**ТОМЬЁОЛСОН ТЭМДЭГ**

|  |   |
|--|---|
|  | Одоо байгаа автозам                                 |
|  | Төлөвлөж байгаа автозам                             |
|  | Төлөвлөж байгаа явган зам, талбай                   |
|  | Одоо байгаа барилга                                 |
|  | Одоо байгаа гэр хороолол                            |
|  | Төлөвлөж байгаа барилга                             |
|  | Төлөвлөж байгаа эдлэн газартай сууц                 |
|  | Малтай гэр хорооллын хэсэг                          |
|  | Үйлдвэр, аж ахуйн хэсэг                             |
|  | Цэцэрлэгжүүлэлт, олон нийтийн амралт зугаалын хэсэг |
|  | Усны эх үүсвэр                                      |
|  | Одоо байгаа худаг                                   |
|  | Төлөвлөж байгаа худаг                               |
|  | Барилгамжигд тохиромжгүй газар                      |
|  | Одоо байгаа үерийн усны далан                       |
|  | Төлөвлөж буй үерийн усны далан                      |
|  | Гуу жалга, нүүх, эвдэрсэн газар                     |
|  | Хялбар  |
|  | Гол горхи   |
|  | Дулаан дамжуулах шугам                              |
|  | Цэвэр ус дамжуулах шугам                            |
|  | Бохир ус дамжуулах шугам                            |
|  | Холбооны агаарын баганаг шугам                      |
|  | Цахилгаан дамжуулах шугам                           |

**Боловсролын байгууллага:** Баруун бүс нутгийн хөгжлийн тулгуур төв-Ховд, Улиастай хотод Хөдөө аж ахуйн дээд сургууль, Шинжлэх ухаан, технологийн Их Сургуулийн салбар, Гадаад хэлний дээд сургууль, байгуулахаар төлөвлөж байна. Мөн хөдөө аж ахуй, ойн мод, уул уурхайн чиглэлийн коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах нь зүйтэй.

Одоогийн байдлаар орон нутгийн хөгжлийн төв Алтай хотод:

1. Анагаах ухааны коллеж 200 суралцагчтай;
2. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв 270 суралцагчтай байдаг бөгөөд цаашид төлөвлөлтөөр дараахи их дээд сургууль бүхий цогцолбор байрлана:
3. Ашигт малтмал, барилгын салбарыг түшиглэсэн Барилгын их сургууль 250 суралцагчтай;
- Геологи уул уурхайн их сургууль 150 суралцагчтай;
4. Гадаад хэлний лицей сургууль 200 суралцагчтай;
5. Физик техникийн лицей сургууль 300 суралцагчтай;
6. Компьютер мэдээллийн лицей сургууль 190 суралцагчтай байна.

Их дээд сургууль, мэргэжлийн сургалтын төвүүд Алтай хотод байрлахын зэрэгцээ Ерөнхий боловсролын сургуулийн бүс нутгийн түвшний үйлчилгээ (10 жилийн сургууль болон төрөлжсөн тусгай, лицей сургууль гэх мэт) байх ба үйлчлэх хүрээ нь 750-1000 м-т; цэцэрлэгийн үйлчлэх хүрээ нь 500 м-т байна.

**Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага:** Орон нутгийн түвшний эмнэлгийн үйлчилгээ, төрөлжсөн эмнэлгүүд байрлах бөгөөд үйлчлэх хүрээ нь 2000 м төрөлжсөн эмнэлгийн үйлчилгээ нь үйлчлэх хүрээндээ үл хамаарна.

**Соёлын байгууллага:** Алтай хот нь орон нутгийн хөгжлийн тулгуур төв хотын статусаар хөгжих тул орон нутгийн үйлчлэх хүрээний хүн ам буюу хөдөөгийн хүн амд үйлчлэх соёлын үйлчилгээний дээд түвшний барилга байгууламж байна.

**Худалдаа үйлчилгээний байгууллага:** Орон нутгийн хөгжлийн тулгуур төвд байх худалдаа, үйлчилгээ, банк, санхүүгийн зохих түвшин, зэрэглэлийн орон нутгийн чанартай томоохон барилга байгууламж 10.0 орчим хувийг эзэлнэ. Энд аялал жуулчлал хөгжүүлэхтэй холбогдсон дөрвөн одтой дээд зэрэглэлийн 80 ортой зочид буудлыг төлөвлөлтөнд тусгасан болно.

**Нийтийн аж ахуйн байгууллага:** Нийтийн аж ахуйн хэсэгт агуулах, гараж, төрөл бүрийн машины парк, галын депо багтаж байгаа бөгөөд галын депоны үйлчлэх хүрээ 3000 м байна. Иймд галын депог өргөтгөхийн зэрэгцээ Гэр хороололд галын 1 депо нэмж төлөвлөсөн болно.

### **Усан хангамж, ариутгах татуургын төлөвлөлт**

Газрын доорхи гүний усыг Алтай хотын хүн амын унд, ахуйн усанд усан хангамжийн эх үүсвэр болгон хэрэглэж байна. Усны эх үүсвэрийн гүний худгууд нь аймгийн төвөөс 4-5 км зайтай орших Харзат гэдэг газар байрлах ба 1983 онд анхны нөөцийн судалгаа хийснээс хойш 4 худаг ашиглагдаж байжээ. Өнөөдрийн байдлаар байнгын ажиллагаатай 2 худаг; нөөцийн 1 худаг байна.

Алтай хот төвлөрсөн усан хангамжийн системтэй. Усан хангамжийн эх үүсвэрээс ундны цэвэр ус дамжуулах хоолойгоор (2 Ø 150 мм хос шугам) цэвэр усан санд очиж байна. Цэвэр усан сангаас гарч байгаа усанд халдваргүйжүүлэх цэвэрлэгээг хлоржуулах ЛОНИИ-100-ийн тусламжтайгаар хийж, цааш II өргөлтийн насосны станцаар дамжуулан хотын цагираг шугамд түгээж байна. Цагираг шугамаас ундны цэвэр ус нь хэрэглэгчдэд орон сууц, эмнэлэг, сургууль, холбоо, захиргааны барилгуудад түгээгдэнэ.

### **Бохир усны цэвэрлэх байгууламж**

Бохир усны цэвэрлэх байгууламжийг одоо байгаа цэвэрлэх байгууламжийг технологийн шинэчлэлт хийх замаар ашиглалтанд оруулж ашиглахаар тооцов. Одоо байгаа цэвэрлэх байгууламж нь  $Q_{\text{хон}} = 558.09$  м<sup>3</sup>/хоног байна. Одоо байгаа цэвэрлэх байгууламжийн төслийн хүчин чадлын дагуу механик ба зохиомол биологи цэвэрлэгээтэй төлөвлөгдсөн. Цэвэрлэх байгууламжаас сараалжин барилгыг өмнө тавигдсан насосны станцны насосны цахилгааны зардал өндөр мөн элс баригч, 2 үет тунгаагуурууд нь технологийн шаардлага хангахгүй байгааг шинэчлэх шаардлагатай.

Бохир усны насосны станцны өмнөх усан хүлээн авах сангийн ашиглалтын нөхцлийг сайжруулах шаардлагатай. Одоо байгаа усан сан, элс баригч, тунгаагууруудын дотор талыг 2-3 үе давхаргатайгаар технологийн өндөр шаардлагын дагуу хийж, туршилтыг дулааны улиралд явуулж ажиллагаанд оруулахаар тооцов.

Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө / Зураг 7.10/

**Томъёолсон тэмдэг**

|  |   |
|--|---|
|  | Одоо байгаа барилга                             |
|  | Төлөвлөж буй барилга                            |
|  | Төлөвлөж буй эдлэн газартай аминь орон сууц     |
|  | Одоо байгаа гэр хороолол                        |
|  | Төлөвлөж буй гэр хороолол                       |
|  | Нүүтэн шилжүүлэх суурьшил                       |
|  | Гэрчин хороололын нөөц талбай (эхний ээлжинд)   |
|  | Гэрчин хороололын нөөц талбай                   |
|  | Үндэврийн бүс                                   |
|  | Үндэврийн бүсийн нөөц талбай                    |
|  | Одоо байгаа авто зам                            |
|  | Төлөвлөж буй авто зам                           |
|  | Төв талбай                                      |
|  | Явган хүний зам талбай                          |
|  | Нийтийн азамшлийн ногоон байгууламж             |
|  | Нийтийн азамшлийн гол гудамж                    |
|  | Цэцэрлэгт хүрээлэн                              |
|  | Цэцэрлэгт гудамж                                |
|  | Балгагийн чулуугаар тохижуулах явган зам талбай |
|  | Хамгаалалтын зурвас                             |
|  | Цэнгэлдэх хүрээлэн                              |
|  | Үерийн усны далан                               |
|  | Төлөвлөж буй данд шүүдүү                        |
|  | Барилгажилдад тохиромжгүй газар                 |
|  | Тусгай зориулалттай газар                       |
|  | Дулаантай хамт явсан цэвэр усны шугам           |
|  | Цэвэр ус дамжуулах шугам                        |
|  | Бойр ус дамжуулах шугам                         |
|  | Цахилгаан дамжуулах шугам                       |
|  | Холбооны шугам                                  |
|  | Хаялбар   |
|  | Одоо байгаа барилгын дугаар                     |
|  | Төлөвлөж буй барилгын дугаар                    |
|  | Урды усны эх үүсвэр                             |
|  | Зөөврийн ус                                     |
|  | Тогтмол усгай газар                             |



### **Цахилгаан хангамжийн төлөвлөлт**

Төлөвлөлтөөр усан цахилгаан станцаас 35 кВ-ын 45 км урт агаарын шугамаар Алтай хотын цахилгаан хэрэглэгчид тэжээгдэнэ. Одоо байгаа дизель агрегатууд нь фидер 1, 2, 3, 4, 5-ыг хэвээр үлдээхээр шийдэв.

VI фидерт ТП-30÷ТП-11÷ТП-10÷ТП-19<sup>А</sup>÷ТП-12-ыг ААБ-3х240 мм<sup>2</sup> маягийн кабелиар холбож, ТП-19<sup>А</sup>-аас АТП-16÷АТП-13-ыг холбоно. VII фидерт ТП-8÷ТП-2÷ТП-5÷ТП-6-г ААБ-3х240 мм<sup>2</sup> маягийн кабелиар холбож, ТП-6-аас ТП-7; МТП-6-г агаарын шугамаар холбоно. Мөн ТП-12÷ТП-6-г ААБ-3х240 мм<sup>2</sup> маягийн кабельд холбож, битүү хэлхээ үүсгэнэ.

АТП-13; АТП-16; АТП-26; АТП-14; АТП-24-ийг зөөж, шинээр ТП-31; ТП-19<sup>А</sup>-г барихаар төлөвлөв. АТП-19<sup>А</sup>; АТП-9 буугдана. ТП-20; АТП-14; ТП-10; АТП-26-ын трансформаторын чадлыг өөрчлөхөөр төлөвлөв.

### **Холбоо мэдээллийн сүлжээ**

Алтай хотын холбооны барилга нь 1960 онд ашиглалтанд орсон, Автомат телефон станц нь 1970 онд Координатный АТС (К-АТС)-50/500 багтаамжтай, 1985 онд 500 номер, 2001 онд 1720 номерын багтаамжтайгаар тус тус өргөтгөсөн.

Одоо Германы Siemens фирмийн EWSD 1720 номерын багтаамжтай-гаар ажиллаж, нийт 1590 хэрэглэгч станцад холбогдсон байна. Станцын хүчин чадлын ашиглалт 92.2 хувь байна. Телефон цэг аминд 1236, албанд 354, нийтийн хэрэглээний таксофон 3 ш байна.

Хот, улс хоорондын дамжуулах байгууламжийн хувьд Сансрын холбооны VSAT систем NEAXT-61 E-10 системүүдээр дамжин дэлхийн бүх улс, оронтой холбогддог. Үүрэн телефоны Мобикомын салбар 2002 оны 12 дугаар сард ашиглалтанд орсон.

Алтай хотын ЭАТС-ын өргөтгөлтэй уялдан, түүнийг дагалдах техник тоног төхөөрөмж, кабель шугам сүлжээг техникийн зохих норм, дүрмийн дагуу тооцон өргөтгөхөөр тусгав. Барилгажилтын бүс хүрэнээс хамаарч, төлөвлөж буй секторуудад телефоны хуваарилах шүүгээг 4÷5 ширхгийг шинээр төлөвлөв. АТС-ээс эдгээр шинэ хуваарилах шүүгээнүүд рүү 2-4 эгнээ яндантай гол магистрал сувагчлал мөн шинээр хийгдэх болно. Хүн амын өсөлт, хэрэгцээнээс хамаарч, хөдөлгөөнт холбооны төлөвлөлт хийгдэж байгаа боловч суурин телефоны хэрэгцээг түлхүү тооцож өгөв.

### **Радио, телевизийн үйлчилгээ**

Радио өргөн нэвтрүүлгийн 100 Вт чадалтай УКВ-ЧМF(S)-100 маркийн нэвтрүүлэгч ажилладаг. Холбооны байранд FM-105.5 хэт богино долгионы радио станц ажилладаг.

Телевизийн GME-100 Вт-ын чадалтай 10 дугаар сувгийн телевизийн дахин дамжуулах станцаар МҮТВ-ийн нэвтрүүлгийг дамжуулдаг. Экран-ЧМ станцын XI сувгийн станцаар OPT нэвтрүүлгийг дахин дамжуулалтаар цацдаг.

Радио релейний Баруун чиглэлийн магистраль шугам дамжин өнгөрдөг. УРС-123 станцаар улс, хот хоорондын телефон холбоо дамждаг.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт Радио телевизийн төвийн “Алтай” ТВ телестуди ажиллаж, 7 хоногт 1 удаа орон нутгийн чанартай нэвтрүүлэг хийж, Цахилгаан Холбооны газрын дахин дамжуулах станцыг ашигладаг. 2001 онд Америк Канадын NS-1 компанийн VSAT PLUS-II маркийн VSAT станц ашиглалтанд орон ажиллаж байгаа.

Алтай хотын урд хэсэгт Радио өргөн нэвтрүүлгийн станц байрладаг. 1978 онд 12 кВт-ын чадалтай богино долгионы 4830 кГц-ын үелзлэлд ажилладаг станц ашиглалтанд орсон. Одоо урт долгионы 150 кВт-ын чадалтай 132 м-ийн долгион дээр ажилладаг. Богино долгионы радио сүлжээг шинэчлэх төслийн хүрээнд Япон улсын хөрөнгө оруулалтаар 10 кВт-ын богино долгионы станц суурилуулж дуусаад өгсөн байна.

“Чандмань-Алтай” ХХК-ийн байранд “Алтай” кабелийн (KaTV) телевизийн станц 2001 онд ашиглалтанд орсон. Аналог-1, тоон-11, бүгд 12 сувгаар дамжуулдаг. 200 гаруй өрхөд үйлчилж байна.

Радио өргөн нэвтрүүлгээр Баруун бүсийг хангах УКВ-ЧМ-TF(S)-100 маркийн станц нь 2003 оны 7 дугаар сард Япон улсын тусламжаар шинэчлэгдсэн тул Алтай хотын ард түмэн энэ станцаас Монголын радиогийн нэвтрүүлгийг цаашид сонсох болно. Орон нутгийн телевизийн нэвтрүүлэг явуулах студи, станцыг хувийн хэвшлийнхний хөрөнгө оруулалтанд түшиглэх бодлого баримтлан нээлттэй үлдээв.

### **Шуудан холбооны үйлчилгээ**

Шуудан холбооны газар нь Холбооны барилгад байрладаг. Төвийн шуудан 7 хоногт 3 удаа хүлээн авч сумдад 7 хоногт 1 удаа (III өдөр) түгээдэг.

Төвдөө 200 гаруй хүнд гэрээр хүргэлт хийдэг. 360 хэрэглэгчдэд хайрцгаар үйлчилдэг. 60 гаруй албан байгууллагад хайрцгаар үйлчилдэг.

Төлөвлөлт Жижиг сууцны хорооллуудад үйлчлэх хүрээ, хүн амын хэтийн төлвөөс хамааруулан холбооны 2 салбар төлөвлөв. Хэвлэл мэдээлэл, сонин түгээх, захидал илгээмжийг хүргэх, өргөжүүлэхэд амины сууцны хорооллууд ба алслагдсан газруудад Шуудан холбооны салбарыг төлөвлөсөн болно.

**Өгөгдлийн холбоо, Интернетийн үйлчилгээ**

1998 онд Mikom-ийн dial-up, 2002 онд олон нийтийн мэдээллийн төв болон өргөжиж, Висат-ын өгөгдлийн сувгаар Cisco-2600 Router-ийг ашиглан, мэдээлэл дамжуулж байгаа ба хүлээн авах талдаа Speed cast картыг ашиглаж байна. Аймгийн Холбооны газар дээр Интернет төв ажиллаж байна.

**Дулаан хангамж төлөвлөлт**

Одоо ашиглагдаж байгаа уурын зуухны барилгуудыг ашиглан Ус, дулаан дамжуулах төв (ЦТП) болгон, хэрэглэгчдийг хэрэгцээний халуун ус, дулаанаар хангахаар төлөвлөв. Одоо байгаа Ундрам-Оюу ХХК-ийн зуухыг ЦТП-1, БУК-ын зуухыг ЦТП-2, 36 айлын орон сууцны зуухыг ЦТП-3, ТМС-ийн зуухыг ЦТП-6, Эмнэлгийн зуухыг ЦТП-7 болгон, ашиглахаар төлөвлөв. Төвийн уурын зуухнаас ЦТП-7 гол түгээх шугам болгон тооцоог хийсэн ба хоолойн диаметр Ø150÷350 мм урт нь 2.93 км байх ба бусад салбар шугамын диаметр Ø 125÷150 мм, нийлбэр урт 1.17 км шугам байна. Дулаан, хэрэгцээний халуун ус хэрэглэгчдийг үл хамаарах схемээр холбоно.

Одоо ашиглаж байгаа халаалтын зуухнуудын ашиглаж болох хүчин чадал нь 15.47-11.03=4.41 Гкал/цаг байна. Эхний ээлжинд баригдах барилгуудын дулааны ачаалал нь тооцоогоор q=10 гкал/цаг байгаа бөгөөд төлөвлөлтийн эхний ээлжинд “Илч Алтай” IV зуух буюу Анагаахын сургуулийн зуухны 2.75 Гкал/цаг-аар өргөтгөх шаардлагатай бөгөөд хатуу түлшээр ажилладаг ус халаах зуух MNS 5045-2001 стандарттай Х 3-1.6 Х маркийн зуух нь 2 ширхгийг тавихаар төлөвлөв. (I зуухны хүчин чадал 1.4 Гкал/цаг) Илч-Алтайн 5-р зуух буюу эмнэлгийн зуухны одоо байгаа ачаалал 1.49 гкал/цаг бөгөөд эхний ээлжинд 2.5 гкал/цаг болох бөгөөд Х3-1.6Х маркийн зуух 1 ширхэг нэмж төлөвлөхөөр тусгав. Нийт зуухны хэрэглээгүй ачааллуудыг халуун ус ба амины орон сууцны барилгуудад холбохоор төлөвлөв.

**Техник эдийн засгийн нэгдсэн үзүүлэлт / Хүснэгт 7.10/**

| Д/д    | Үзүүлэлтүүд                                 |                               | Хэмжих нэгж         | Хүчин чадал     |            |                      |
|--------|---|-------------------------------|---------------------|-----------------|------------|----------------------|
|        |   |                               |                     | Одоогийн байдал | Эхний ээлж | Төлөвлөлтийн хугацаа |
| 0      | 1   |                               | 2                   | 3               | 4          | 5                    |
| 1      | Газар нутаг                                 |                               | га                  | 1700            | 1700       | 1700                 |
| 2      | Хувийн жин                                  | Хүн ам                        | мян.хүн             | 15.6            | 18.5       | 24.0                 |
|        |   | Орон сууцны хороололд         | %                   | 18.5            | 25.0       | 40.0                 |
|        |   | Гэр ба жижиг сууцны хороололд | %                   | 81.5            | 75.0       | 60.0                 |
| 3      | Орон сууц                                   |                               | айл                 | 0.54            | 1.1        | 2.4                  |
|        | Талбай                                      | Ашигтай                       | мян.м <sup>2</sup>  | 24.82           | 78.75      | 225.6                |
|        |   | Сууцны                        | мян.м <sup>2</sup>  | 17.37           | 47.25      | 129.6                |
|        | 1 хүнд ногдох талбай                        | Ашигтай                       | м <sup>2</sup> /хүн | 14.9            | 17.5       | 23.5                 |
| Сууцны |   | м <sup>2</sup> /хүн           | 8.6                 | 10.5            | 13.5       |                      |
| 4      | Орон сууцны барилгын дундаж давхар          |                               |                     | 3               | 3.4        | 3.5                  |
| 5      | Нягтрал                                     | Барилгажилтын                 | м <sup>2</sup> /га  | 19.09           | 60.6       | 173.5                |
|        |   | Хүн амын                      | хүн/га              | 12              | 14         | 18                   |
| 6      | Соёл, ахуйн үйлчилгээний барилга байгууламж | Сургууль                      | сурагч              | 2680            | 4600       | 7065                 |
|        |   | Цэцэрлэг                      | хүүхэд              | 1405            | 1500       | 2520                 |
|        |   | Эмнэлэг                       | ор                  | 260             | 325        | 460                  |
|        |   | МСҮтөв                        | суралцагч           | 470             | 970        | 1160                 |
|        |   | Халуун ус                     | шүршүүр             | 25              | 85         | 195                  |
|        |   | Зоогийн газар                 | суудал              | 320             | 370        | 960                  |
|        |   | Зочид буудал                  | ор                  | 100             | 190        | 245                  |
|        |   | Соёлын төв                    | суудал              | 400             | 1090       | 2090                 |
|        | Кинотеатр                                   | суудал                        | -                   | 370             | 720        |                      |

|   |        | Хүүхдийн ордон       | дугуйланд суралцагч | -     | 430     | 900     |
|---|--------|----------------------|---------------------|-------|---------|---------|
| 7 | Үүнээс | Талбайн баланс, бүгд | %                   | 100.0 | 100.0   | 100.0   |
|   |        | Орон сууцны          | %                   | 67.5  | 67.5    | 67.4    |
|   |        | Соёл, олон нийтийн   | %                   | 14.1  | 12.2    | 8.0     |
|   |        | Ногоон байгууламж    | %                   | 2.1   | 5.1     | 18.1    |
|   |        | Үйлдвэр аж ахуйн     | %                   | 14.8  | 14.0    | 5.5     |
|   |        | Тусгай зориулалтын   | %                   | 1.5   | 1.2     | 1.0     |
| 8 | Үүнээс | Хөрөнгө оруулалт     | сая ₮               |       | 15215.0 | 39211.3 |
|   |        | Инженерийн дэд бүтэц | сая ₮               |       | 4970.6  | 3522.8  |
|   |        | Нийгмийн дэд бүтэц   | сая ₮               |       | 10244.4 | 35688.5 |

## 1. “СУТАЙ” хотыг байгуулах санал

### Ерөнхий ухагдахуун

Шинэ төлөвлөж буй Сутай хотыг барих газар нутаг нь Сутай хайрханы орчим бөгөөд Алтайн нурууны гол өндөрлөгийн нэг мөнх цастай, төрийн тахилгатай уул бөгөөд алсаас харахад бараа сүр ихтэй, баруун бүс нутгийнхаа төвд оршдог хайрхан юм. Сутай хот нь Дөргөн нуур, Хар нуур, Завхан голын хооронд, Өлзий толгойн дэргэд, хойт өргөрөгийн 48°00', зүүн уртрагийн 93°15' –д байгуулагдана. Монгол улсын одоогийн засаг захиргааны хуваариар Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт Ховд аймгийн Чандмань, Дөргөн сумдын Хар нуурын зүүн эрэгт орших болно.

Сутай хотыг төмөр зам барьж эхлэхтэй холбогдуулан 2015 оноос барьж эхэлнэ.

Сутай хотыг гүний гааль худалдаа, металлургын үйлдвэрлэл, гааль худалдааны чөлөөт бүс, хөнгөн үйлдвэрлэлийн зориулалтаар шинээр байгуулна. Сутай хотыг төмөр зам барьж эхлэхтэй холбогдуулан 2015 оноос барьж эхлэнэ. Энд ОХУ, Казакстан, Хятад болон бусад орны эрдэс баялагийн боловсруулах үйлдвэрлэл сонирхогчдын гол зангилаа болон хөгжиж, баруун бүсийн их нүүдэл зогсож, нутаг орноо хөгжүүлэн өөд нь татах бололцоо нээгдэх болно. Мөн шинжлэх ухаан технологи, оюуны багтаамжид суурилсан, оюунлаг баруун монголчуудыг мэдлэгээр тэтгэсэн хот болно.

Сутай хотод мал аж ахуй, газар тариалан, геологи уул уурхайн түүхий эдийг төвлөрүүлэн борлуулах, үйлдвэрлэх зориулалттай монголын баруун бүс нутагт байгуулагдах олон улсын зах зээлийн баримжаатай шинэ загварын өвөрмөц бүтэцтэй хот болох юм.

Дараагийн үе шатны төлөвлөлтөөр Сутай хотын экосистемийн төлөвлөлт, түүх дурсгалын үнэт зүйлсийг хамгаалах төлөвлөлт хийх, Завхан гол, Хомын тал, Хар нуур, Дөргөн нуурын экологийг сэргээх модлог ургамал тариалах ойжуулах явдал юм.

Сутай хот бол монгол оронд цоо шинээр байгуулагдах бичил цөлийн хот юм. Иракын хотуудыг бодвол эргэн тойрон урсгал усаар хүрээлэгдсэн, байгалийн онцгой ландшафттай, дэлхий нийтийн анхаарлыг татсан өвөрмөц шийдэлтэй ногоон хот болон хөгжих юм.

Цөлжилт эрчимтэй явагдаж байгаа гамшгийн эрин үед монголчууд энэ хотыг байгуулах явдал нь туршлага болох төдийгүй сургамжтай хэрэг болно. Олон улсын бодлогыг баруун бүст явуулах, харилцааг зохицуулж байх хөгжлийн тулах цэг, цөлжилттэй тэмцэх загвар хот болох юм.

Сутай хотын нийгмийн дэд бүтэц, инженерийн төвлөрсөн хангамжийн гол шугам сүлжээнүүдийг барьж байгуулах болон зураг хайгуулын үнэ хамтдаа 15.0 тэрбум төгрөг шаардагдаж байна.

### **Байгалийн нөхцөл нөөц баялаг**

Нуурын хэв төрх нь сайн хадгалагдаж үлдсэн хэрчигдэлгүй дэнжийн, бага ба дунд зэрэг хэрчигдэлтэй бөгөөд хот байгуулахад газар шорооны хүндрэл маш бага учир тохиромжтой. Газрын хэвгийн хувьд налуу нь 3 хэм хүртэл, газрын хэрчигдлийн гүн нь Хөх нуурын түвшинтэй харьцуулахад 200 м хүртэл байна.

### **Инженер геологийн нөхцөл**

Дөрөвдөгчийн системийн дээд дөрөвдөгч -орчин үеийн хурдас Q<sub>III-IV</sub>, дунд дээд нэгтгэлгээ Q<sub>II-III</sub>, геологийн хэвшлийн хувьд Улаан ба алаг өнгөт тив гаралт чулуулгийн, саарал өнгөт элс сайрархаг, элс хайргархаг чулуулгийн бүтэц агуулсан хөрстэй тул хот байгуулахад нэн тохиромжтой.

Түлшний хувьд Хөшөөгийн нүүрс, усаар Завхан голын цэнгэг усан сангаар хангах бололцоотой учир түлш, усны аливаа хүндрэл гарахгүй.

Чичирхийлэлийн тектоникийн хувьд шинэхэн тектоник бүтцийн геодинамик хэвшинжинд хамрагдах бөгөөд газар чичирхийлэлийн мужлалын (MSK-64 шатлалын баллаар) 6-7<sub>2</sub> баллын бүст газар



чичирхийлэлийн идэвхи хамгийн сул А 0.01, доргилтын хамгийн их эрчим нь 6-7 балл байна. Ийм газар атомын цахилгаан станц байгуулах боломжтой.

Дундаж хөрсний хэм +2, улирлын хөлдөлтийн гүн 2.5-5.0 м, нар гийгүүлэх хугацааны цагийн нийлбэр 3000, нарны нийлбэр цацраг квт.цаг/м<sup>2</sup> 1500, агаарын даралт 2 Па 854 өөс дээш, агаарын жилийн дундаж хэм 20, халуун өдрийн тоо нь 30, хур тунадас 100 мм, агаарын харьцангуй чийг 70-80%, цасан шуурга 5 хоног, шороон шуурга 20-30 хоног, зураг хайгуулын ажил болон барилга байгууламжийн ажил гүйцэтгэхэд 310 хоног байгаа нь хот байгуулахад сайн талтай юм.

Сутай хот нь хөдөлмөрийн нөөцийн түвшин, шилжин ирэгсэдийн тоо, гэр бүлийн гишүүдийг оролцуулан статистик динамикийн аргаар тооцоход 24-30 мянган хүнтэй хот болох юм. Гэхдээ цаашид хүн амын өсөн нэмэгдэх хандлагыг тооцож авч үзсэн.

Сутай хотыг байгуулахаар сонгосон газар нь зам харилцааны зангилаа төв болоход зохимжтой байрлалтай бөгөөд төрөл бүрийн эрдэс түүхий эдийг боловсруулах болон оюуны бүтээмжийг шингээсэн соёл боловсрол, шинжлэх ухаан техникийн хот болон өргөжин хөгжиж Эрдэнэт, Дархан хотуудын түвшинд үйл ажиллагаа явуулах болно.

### ***Сутай хотыг байгуулах техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт***

#### ***Дулаан хангамж***

Сутай хот эхний ээлжинд Хөшөөтийн нүүрсний уурхайгаас, цаашид атомын эрчим хүчээр хангагдаж, цахилгаан эрчим хүчээр дулаан үйлдвэрлэнэ. Жилд хэрэглэх нүүрс дунджаар 124.4 тн/хоног байна.

#### ***Усан хангамж***

Сутай хотын ундны усыг Завхан голын усаар, үйлдвэрлэл технологийн зориулалттай усыг Хар нуурын усаар хангана. Хотын хэрэгцээнд жилд 648287.4 м<sup>3</sup> цэвэр ус шаардагдах юм.

#### ***Ариутгах татуурга***

Сутай хотоос зайлуулагдах бохир усыг цэвэрлэн Дөргөн нуурын өмнөх хонхор газарт боригоот сувгаар урсган оруулна. Жилд дунджаар 609434.7м<sup>3</sup> бохир ус зайлуулагдах болно.

#### ***Цахилгаан хангамж***

Хөшөөтийн нүүрсний уурхайд баригдах эрчим хүчээр эхний ээлжинд хангана. 2021 оноос өмнө одоо байгаа баруун бүсийн эрчим хүчний сүлжээ, Монгол улсын эрчим хүчний сүлжээнд холбогдоно. 1кВт цахилгаан үйлдвэрлэх өөрийн өртөг нь одоогоор 220 төгрөг байгаа юм. Сутай хотыг улсын эрчим хүчний 220 кВт-ын магистраль шугам, Хөшөөтийн нүүрсний уурхайд баригдах дулааны цахилгаан станцаас гарах 110кВт-ын цахилгааны шугаманд холбох боломжтой. Усны хомсдол, нүүрсний нөөц дуусах асуудлыг харгалзан үзэж атомын эрчим хүчний станц байгуулахаар төлөвлөж байна.

#### ***Холбоо мэдээлэл***

Сансрын холбооны иж бүрэн системд холбогдоно. Холбоо мэдээллийн бүх үйл ажиллагааны технологи 50 хувь өөрчлөгдөн шинэчлэгдэх нөхцлийг харгалзах хэрэгтэй.


### ***Сутай хотын байрлалын онцлог***

Сутай хот нь гадагшаа доорхи чиглэлээр ОХУ, Хятадтай ямар нэг тээврийн хэрэгслээр чөлөөтэй харилцах боломжтой. Үүнд:

1. ОХУ-тай Ховд - Өлгий – Цагаан нуурын чиглэлээр
2. ОХУ-тай Боршоо – Хандгайтын чиглэлээр
3. ОХУ-тай Увсын Цагаан хайрхан – Зүүнговь – Тэс- Шар суурийн чиглэлээр
4. ОХУ-тай Завхан – Тэс – Агацын чиглэлээр
5. БНХАУ-тай Ховд – Булган – Ярантайн чиглэлээр
6. БНХАУ-тай Алтай – Бургалтайн чиглэлээр

Үүний үр дүнд баруун бүсийн хөрш хоёр их улстай нэгдсэн шугамаар өөрөөр хэлбэл төвөөрөө дамжуулж харилцах ажлын хүрээ хэмжээ тэлэх болно.

### Хүний амьдрах ландшафт-геохимийн нөхцөл



Шүд толбодох өвчин илэрсэн нутаг



Өвчлөлт багатай нутаг

Нутагшмал өвчний геохимийн урьдчилсан нөхцөл бүхий нутаг



Галт уулын чулуулгын илэрц



Фторын агууламж ихтэй рашаан ус

| Биогеохимийн муж | Хөрсний нөхцөл  | Гидрогеологийн нөхцөл                                       | Усны эрдэсжилтийн зэрэг, хатуулгийн төвшин                                       |                        | Усан дахь микроэлементийн агууламж |                                      | Газар, усыг аж ахуйд ашиглаж буй байдал  |  |
|------------------|---|---|--|------------------------|------------------------------------|--------------------------------------|--|--|
|                  |   |   | Гадаргын усны  | Газрын доорх усны      | Илүүдэлтэй                         | Дутагдалтай                          |  |  |
|                  | Уулын тундрын ба цэвдэгт – тайгын хөрстэй                                   | Ул хөрсний ус голлон тархсан муж                            | Маш бага   | Маш цэнгэг, маш зөвлөн | -                                  | Цэвр кобальт зэс молибден фтор селен | Тариалан байхгүй. Хүнсний бүтээгдэхүүнийг гаднаас авдаг. Ундаанд гаднаас ба ул хөрсний ус хэрэглэгддэг |  |
|                  | Уулын нуга, ойт хээр, нутаг-хээр, хээрийн муж                               | Уулын шират-тайгын, уулын нугын, хар шороон, куурын хөрстэй | Ул хөрсний ус голлон тархсан муж   | бага                   | Цэнгэг зөвлөн                      | -                                    | Иод, цэвр молибден фтор селен кобальт  | Тариалан багатай. Хүнсний зориулалттай үр тарианы бүтээгдэхүүнийг гол төлөв гаднаас авдаг. Ундаанд ул хөрсний ус голлон хэрэглэгддэг |
|                  | Ойт хээр, умард хуурай хээрийн муж  | Уулын ойн бараан, нутаг-ойн, хар шороон, куурын хөрстэй     | Ул хөрсний ус хэсэг хэсгээр тохиолддог, давхарга хоорондын ус голлон тархсан муж | Дундаас доогуур        | Цэнгэгдүү хатуутар                 | -                                    | иод  | Тариалан ихтэй. Хүнсний зориулалттай үр тарианы бүтээгдэхүүнийг өөртөө үйлдвэрлэдэг. Ундаанд газрын доорх ус хэрэглэгддэг            |
|                  | Хээр, умард ба өмнөд хуурай хээр, цөлөрхөг хээр цөллийн болон аясаархэг муж | Уулын ба тал газрын хүрэн, бор, бор саарал хөрстэй          | Дөвхөргө хоорондын ус голлон тархсан муж   | Дунд зэрэг             | Эрдэсжилт дунд зэрэг хатуу         | Бор марганец фтор                    | Кобальт Цэвр Зэс   | Тариалан багатай. Хүнсний зориулалттай үр тарианы бүтээгдэхүүнийг гаднаас авдаг.   |
|                  | Хээр, хуурай хээр, цэцэрлэг хээр ба цөллийн муж                             | Тал газрын хүрэн, бор, бор саарал хөрстэй                   | Газрын доорхи ус тархсан муж   | -                      | Эрдэсжилт ихтэй. Маш хатуу         | Бор молибден иод фтор                | Кобальт Цэвр Зэс   | Тариалан багатай. Хүнсний зориулалттай үр тарианы бүтээгдэхүүнийг гаднаас авдаг. Ундаанд гол төлөв газрын доорх ус хэрэглэгддэг.     |

Сураг 7.11


Сутай хотыг Хомын талд хот байгуулах явдал нь доорх давуу талтай юм. Үүнд:

1. Талбай ихтэй, хөрс сайтай учир хотыг ирээдүйд өргөтгөн хөгжүүлэх боломжтой.
2. Баруун бүсийн одоогийн төвдүүдийн яг дунд нь оршдог.
3. Баруун талдаа Ховдын олон нуурын зүүн талын Хар ус нууртай, хойд талдаа Завхан голтой, баруун хойд талдаа Хяргастай. Өөрөөр хэлбэл ус хангалттай.
4. Урд талдаа сайн чанарын нүүрс ихтэй. Хөшөөтийн уурхайтай. Түүнээс гадна баруун ба хойд, мөн зүүн талдаа нүүрс байж болох нөхцлүүдтэй.
5. Алсын харууц сайтай, үзэсгэлэнт байгалиар хүрээлэгдсэн. Урд талд нь мөнх цаст дархан цаазат Сутай хайрхан дүнхийж, баруун талд нь олон нуур цэнхэртэн, хойд, зүүн талд нь алсад их элс харагдана.
6. Орчиндоо бэлчээрийн талбай ихтэй, говь, хангайн ургамал ургадгаас гадна услах тохиолдолд ургац ихээхэн нэмэгддэг. Тэнд 1990 оноос өмнө баруун бүс дундын тэжээлийн аж ахуйг байгуулж усалгаатай тариа тарьж эхэлж байв.
7. Нисэх онгоцны томоохон буудал байгуулахад аль ч талаасаа чөлөөтэй буух, нисэх боломжтой.
8. Авто болон төмөр зам, өндөр хүчдэлийн шугам тавихад саад байхгүй.
9. Сутай хотын өмнө талаар тахь, зээр нутагшуулах бололцоотой.

**Сутай хотын газар нутгийн зохион байгуулалт**

Сутай хотыг урьдчилан төлөвлөсөн зураг төслөөр дэд бүтцийн бүх гол шугам сүлжээнүүдийг байгуулсны дараа цэгцтэй шийдвэрлэж болох анхны хот юм.

Хотын архитектур орон зайн хувьд хүрээ хэлбэрийн дугуй цагираг загвартай байх юм. Хотын нийт талбай эхний ээлжинд нь 25 КвКм байх юм. Цаашид 100 кв км болон өргөжих газар нутгийн боломжтой.



| <b>Хотын газар нутгийн зохион байгуулалт</b> |  |
|--|--|
| 1 бүсэд.                                     | Засаг захиргаа, шинжлэх ухаан технологийн парк             |
| 2 бүсэд.                                     | Нийгмийн салбар, орон сууцны хороолол                      |
| 3 бүсэд.                                     | Амралт зугаалга, үзвэр үйлчилгээний хүрээ                  |
| 4 бүсэд.                                     | Эрдэс түүхий эд боловсруулах үйлдвэр, металлургийн үйлдвэр |
| 5 бүсэд.                                     | Гүний гааль худалдаа, чөлөөт бүс, агуулахын үйлчилгээ      |
| 6 бүсэд.                                     | Үйлдвэрийн бүсээс тусгаарлах усан байгууламж               |
| 7 бүсэд.                                     | Сутай хотод орж гарах гол зам                              |
| 8 бүсэд.                                     | Хотыг үйлдвэрийн бүстэй холбосон зам                       |
| 9 бүсэд.                                     | Үйлдвэр хоорондын зам                                      |
| 10 бүсэд.                                    | Салхинаас хамгаалсан ногоон байгууламж                     |

Зураг 7,12 Сутай хотын зохион байгуулалт

Баруун бүс нь төвөөс хэт алслагдсаныг харгалзан Сутай хотод дараахь аж ахуй үйлчилгээнүүдийг байршуулахаар төлөвлөж байна. Үүнд :

1. Аймаг дундын томоохон эмнэлэг байгуулж эрдэм шинжилгээ, оношлогоо, эмчилгээний ажлыг хямд төсөр гүйцэтгэж байх. Шинжлэх ухааны академийн салбарыг байгуулж эрдэм шинжилгээ, судалгааны олон талт ажлыг явуулах.
2. Байгаль, газар зүйн олон онцлогтой, түүх соёлын өвөрмөц дурсгалт зүйл ихтэй учир тэнд бүсийн чанартай томоохон музей байгуулах.
3. Спортын томоохон цогцолбор байгуулж уул, ус, элс, авто аялал зэрэг бүс нутаг, олон улсын чанартай спортыг хөгжүүлэх.
4. Ховордсон ан амьтад, ургамлын судалгаа хийж тэдгээрийг нөхөн сэргээх, үржүүлэх, хамгаалах арга хэмжээг авах.

5. Олон үндэстэн ястны өлгий, байгал газар зүйн өвөрмөц онцлог ихтэй, олон улсын нислэг хөгжих боломж бүрдэж буйг харгалзан аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг байгуулахын зэрэгцээгээр хүүхдийн томоохон зусланг уг бүсэд байгуулах.

**Сутай хотын хүн амын суурьшил, хөдөлмөрийн нөөц**

- 2009-2015 онд Сутай хотыг байгуулах зураг хайгуулын болон техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, геологи, уул уурхайн төв болгон хөгжүүлэх эхлэл тавигдана. 500-2000 хүн суурьшиж эхэлнэ.

- 2016-2021 онд бүтээн байгуулалт өрнөж, суурьшлийн төвлөрөл, хүн амын бөөгнөрөл бий болно. Оюуны болоод технологийн хөрөнгө оруулалтаар инженер, техникийн ажилтан, үйлчилгээний, гааль, худалдаа, хүчний байгууллагын албан хаагчид мөн амьдралын горьдлого тээсэн эмзэг, дунд бүлгийн хүмүүс мөн малчид, фермерийн аж ахуй эрхлэгч нар, суурин хүн амын тоо, нийтдээ 25000 – 30000 хүрэх урьдчилсан прогноз байна.

- Төлөвлөлтөөс цааш Сутай хот 40000-аас дээш хүн амтай хот болон өргөжин хөгжинө.

Сутай хотыг төлөвлөлтийн хугацаанд байгуулсан тохиолдолд баруун бүс 2-5 аймаг болон хуваагдах засаг захиргааны хуваарь өөрчлөгдөн бүсийн төв Сутай хотод төвлөрөн, 25 хошуудын нэг төвтэй босоо удирдлагын системээр нийгэм, эдийн засгийн харилцааг зохицуулах болно. Монгол улс 4 бүсээр хөгжих үндсэн шинэ загвар гарч ирнэ. Мөн бусад бүсүүдийн засаг захиргааны бүтэц, бүсийн төвийг шинээр тодорхойлох зайлшгүй шаардлага гарч байна. Энэ нь төлөвлөлт, төсөөллийн буруу үзэл баримтлал байсныг гэрчилж байна.

**Хотын нийт хүн амын хөдөлмөрийн нөөцийн бүтэц, 2021оноор /Хүснэгт 7.11/**

|  |           |
|--|-----------|
| Хүн ам   | 25-30 мян |
| Зорчигчид  | 200-300   |
| Уугуул иргэд                                       | 100-450   |
| Гэр бүлийн гишүүд                                  | 2000-3500 |
| үйлчилгээний салбар                                | 1500-2700 |
| Гааль, чөлөөт бүсг, уул уурхай                     | 2700-8400 |
| Дэд бүтцийн салбарын                               | 900-1760  |
| Нийгмийн салбарын                                  | 1200-2200 |
| Төрийн захиргааны болон эрдэм шинжилгээний ажилтан | 100-500   |
| Оюутан сурагчид                                    | 1000-4000 |

**Сутай хотын бүтээмж**

Сутай хотыг бүтээн байгуулснаар Монгол улсын Баруун Алтай, Алтай-Соён, Шинжан-Зүүн гар-Тэнгэр уулсын бүс газарт нийгэм, эдийн засгийн харилцааны цоо шинэ өөрчлөн байгуулалт бий болох торгон агшин, ирээдүй байгаа юм. Бүс нутагт Сутай хотыг байгуулсанаар төвийн бүстэй харьцуулахад 2021 оны түвшинд нийгэм, эдийн засгийн хөгжил эрс сайжирч, ДНБ 1,31 дахин өснө.

**Сутай хотын бүтээмж /Хүснэгт 7.12/**

| Д / Д | Төлөвлөлт -ийн үе шат | Хүн ам ажиллах хүч | Дотоодын нийт бүтээгдэхүүн Сая.төг | Хэрэглээн -ий үнийн индекс | Улсын төсөв бүрдүүлэлт Сая. төг | Хөрөнгө оруулалт тэрбум.төг | Аж үйлдвэр Сая.төг | Тээвэр, аяаа эргэлт Сая.тн |
|-------|-----------------------|--------------------|------------------------------------|----------------------------|---------------------------------|-----------------------------|--------------------|----------------------------|
| 1     | 2010-2015             | 500-2000           | 116413,3                           | 1,00                       | 1820,4                          | 110500,0                    | -                  | 610,3                      |
| 2     | 2016-2021             | 15000-30000        | 763316,9                           | 1,23                       | 42700,3                         | 246650,0                    | 1320410,5          | 5490,2                     |
| 3     | Төлөвлөлт -төөс цааш  | 40000-аас дээш     | 2942400,1                          | 1,79 - 2,60                | 189370,3                        | 10 дахин өснө               | 10416420,4         | Эрс өснө                   |

**Сутай хотыг барьж, байгуулах төлөвлөгөө /Хүснэгт 7.13/**

|                             |   |
|-----------------------------|---|
| <p><b>2010-2015 онд</b></p> | <p><b>Сутай хотыг байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг хайгуулын ажлыг гүйцэтгэнэ.</b></p>   |
| <p><b>2016-2021 онд</b></p> | <p>Сутай хотыг барьж эхлэх томоохон бүтээн байгуулалтын ажил эхлэнэ. Эхний ээлжинд нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжууд, нисэх онгоцны буудал, төмөр зам, авто вокзал, гүний гааль худалдааны чөлөөт бүс, эрдэс баялгийн болон хөрөнгийн бирж, үнэт цаасны зах зээл, агуулахын үйлчилгээ, хөнгөн үйлдвэр, шинжлэх ухаан технологи, соёл боловсролын газруудыг байгуулснаар оюуны багтаамжид суурилсан, монголчуудыг мэдлэг, хөгжлөөр тэтгэсэн орчин үеийн шинэ хот сүндэрлэж эхэлнэ.</p> <p>Бургастай-Сутай хотын хоорондох төмөр замыг ашиглалтанд оруулснаар хүнд аж үйлдвэрийн хот болох баруун монголын арвин их нөөцтэй эрдсийн түүхий эдийг гадагш нь биш дотогш нь Сутай хотод зөөж катодын зэс, хөх ган, барилгын төрөл бүрийн материалын үйлдвэр, хими технологийн үйлдвэрүүдийн хөгжүүлж бүтээн байгуулалтыг өрнүүлснээр монгол улсын эдийн засагт эрс шинэчлэлт явагдаж бүх зүйл эргэлтэнд орно.</p> |

**Хот суурингуудын бүлэг тогтолцоог хөгжүүлэх талаар**

Үндэслэл: Баруун бүсийн төв суурин газруудад бүсийн нийт хүн амын 29.4 хувь нь амьдарч байна. Энэ үзүүлэлт Баян-Өлгийд 30.9 хувь, Говь –Алтайд 32.2 хувь, Завханд 21.4 хувь, Увсад 27.8 хувь, Ховдод 34.4 хувь нь байна. Нийт өрхийн дийлэнх нь эсгий гэрт, үлэмж бага хувь нь сууцанд амьдарч байгаа учир орон сууцны асуудлыг шийдвэрлэх нь онцгой ач холбогдолтой байна.

Баруун бүсэд хотжилт эрчимтэй бус, үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгмийн болон инженерийн дэд бүтэц сул хөгжсөн барилгажилтын нягтрал төдийгүй, нийт хот суурингуудад орчин үеийн шаардлагад нийцсэн хот байгуулалтын цэгцтэй бодлого үгүйлэгдэж байна.

Бүсийн хүн амын тархац, нутагшлын жигд биш байдал нь хөгжилд бэрхшээл учруулж байгааг саармагжуулах үүднээс бичил бүсчлэлийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**Нэгдүгээр үе шат ( 2009-2015 он )**

Тэргүүлэх зорилт 1. Баруун бүсийн хот, суурин газруудын хот төлөвлөлтийг зах зээлийн тогтолцоонд нийцүүлэн шинэ шатанд гаргана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Бүсийн тулгуур төв Ховд, Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг эрчимтэй хэрэгжүүлэх
- Бичил бүсийн болон сумдын төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг олон нийтийн оролцоотой шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулах
- Хил орчмын бүс нутагт хүн ам суурьшуулах зорилго бүхий урамшууллын бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвор суурьшлыг сайжруулах
- Орон нутгийн нийтийн ахуйн үйлчилгээний байгууллагын менежментийн болон үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх
- Шинээр бий болж байгаа тосгон сууринд хүн амын төвлөрлийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх
- Тосонцэнгэлийн модны үйлдвэрийг түшиглэн баруун бүсийн барилга, орон сууцны болон гэрийн модон эдлэлийн мод бага зарцуулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- Газрын албадыг шинэ техник, технологиор ханган, газрын харилцааны тухай мэдээлэл, бүртгэлийг иргэдэд нээлттэй байлган, үйлчилгээг шуурхай болгож, газрыг айл өрх бүрд үнэгүй өмчлүүлэх ажлыг хуулийн хугацаанд багтаан зохион байгуулах
- Барилга хот байгуулалт, газар зохион байгуулалт, газар өмчлөх, эзэмших, ашиглах, үнэлэх болон үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой мэдээллийн нэгдсэн санг аймаг бүрд бий болгох

Гарах үр дүн: Бүсийн төв, хот, суурингуудад хүн амын тогтвор суурьшил нэмэгдэнэ.

Тэргүүлэх зорилт 2. Хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан бүсийн орон сууцны хангамжийн түвшинг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Монгол улсын Засгийн газрын “40 000 айлын орон сууц барих” хөтөлбөрийн хүрээнд нийт аймгийн төвд орон сууцны шинэ хороолол барих
- “Орон сууц” сан бүрдүүлж, эн түрүүнд төрийн албан хаагчид, залуу гэр бүлийг орон сууцаар хангах арга хэмжээг хэрэгжүүлэх
- Орон сууцны барилгын материал үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжийг урамшууллын хөшүүргүүдийг хэрэглэн дэмжих
- Гэр хорооллын иргэд орон сууцны нөхцлөө сайжруулах, орон сууцандаа хөрөнгө оруулалт хийх сонирхлыг нь нэмэгдүүлэх
- Орон гэргүй ядуучуудыг орон байраар хангах боломжийг судлан хэрэгжүүлж эхлэх
- Амины орон сууц барьж буй иргэдийг хөнгөлөлттэй зээлээр дэмжих
- Хөдөөний хүн амын орон сууцны нөхцлийг сайжруулах хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлж эхлэх

Гарах үр дүн: Аймгийн төвүүдийн хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан орон сууцны хангамжийн түвшинг 40 -50 хувьд хүрнэ.

Тэргүүлэх зорилт 3. Бүсийн хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулж бичил бүсээр хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Бичил бүсийн эрх зүйн орчинг бүрдүүлэх арга хэмжээг идэвхтэй дэмжих
- Бичил бүсүүдийн биеэ даан хөгжих чадавхийг бүрдүүлж эхлэх
- Бичил бүсийн хөгжлийн шаардлагатай уялдуулан зам, тээвэр, холбоо, мэдээлэл харилцааны сүлжээ бүрдүүлэх эхлэлийг тавих

Гарах үр дүн: Бүсийн хэмжээнд бичил бүсчлэлийн хөтөлбөрийн дагуу хүн амын нутагшилтын тогтолцоо сайжирна.

### Хоёрдугаар үе шат (2016-2021 он )

Тэргүүлэх зорилт 1. Баруун бүсийн тулгуур төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, хөдөөгийн суурингуудыг ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх арга хэмжээ авна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

- Тулгуур төв хотуудыг бүсийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн томоохон төвүүд болгох
- Зах зээлийн нөхцөлд нийцүүлэн шинэчлэн боловсруулсан хот суурингуудын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх
- Говь-Алтай, Завхан, Увс аймгийн төвд нийтийн аж ахуйг сайжруулах арга хэмжээг үргэлжлүүлэн хийх
- Аймгийн төвүүдийн цэвэрлэх байгууламжид техник технологийн шинэчлэлт хийж, цэвэрлэгээний түвшинг сайжруулах, бага оврын цэвэрлэх байгууламжийг хэрэглэх арга хэмжээ авах
- Хүн амын суурьшлын шинэ хорооллууд байгуулах арга хэмжээ авах
- Бүсийн үйлдвэрлэл, хэрэглээ, хүн амын өсөлттэй уялдуулан инженер дэд бүтцийн шугам сүлжээг өргөтгөн хөгжүүлэх зорилгоор тодорхой төслүүдийг боловсруулан хэрэгжүүлэх
- Бичил бүсийн төв, сумд, багийн төвүүдийг шинэчлэн тохижуулах хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж эхлэх
- Бүсийн аймгуудад загвар суурин байгуулж, тохижуулах арга хэмжээ авах

Гарах үр дүн: Бүсийн хүн ам тав тухтай ажиллаж амьдрах нөхцөл бололцоог хангасан, экологид ээлтэй, эдийн засгийн хувьд биеэ даасан, гадаад, дотоод харилцаа сайтай орчин үеийн хот байгуулалт хөгжинө.

Тэргүүлэх зорилт 2. Хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан бүсийн иргэдийн орон сууцны хангамжийн түвшинг эрс дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Бүсийн хот суурингийн бага орлоготой болон залуу гэр бүлийг орон сууцаар хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх
- Төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны хоёр дахь шатны төсөл боловсруулан хэрэгжүүлэх
- Орон сууцны барилгын материал үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжийг татвараас бүрэн чөлөөлөх урамшууллын хөшүүргүүдийг хэрэглэх
- Орон гэргүй байгаа ядуучуудыг орон байраар хангах цогц арга хэмжээ авах
- Амины орон сууц барьж буй иргэдийг хөнгөлөлттэй зээлээр идэвхтэй дэмжих

Гарах үр дүн: Аймгийн төвүүдийн орон сууцны хангамжийн түвшинг 50-60 хувьд хүргэснээр хүн амын тав тухтай амьдрах ахуйн нөхцөл сайжирна.

Тэргүүлэх зорилт 3. Баруун бүсийн хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулж бичил бүсүүдээр хөгжүүлэх арга хэмжээ авах

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Бичил бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрийг бүсийн хэмжээнд эрчимтэй, хэрэгжүүлэх
- Бичил бүсийн давуу боломжуудад түшиглэн жижиг, дунд үйлдвэр байгуулах, үйлчилгээний салбаруудыг хөгжүүлэх замаар бие даан хөгжих нөхцөл бүрдүүлэх
- Баруун бүсийн бичил бүс хоорондын дэд бүтцийг зохистой хэлбэрээр бүрдүүлэх
- Хөдөөгийн иргэд суурин, хагас суурин амьдралд зохицон суурьших боломж бүрдүүлэх

Гарах үр дүн: Бүсийн хэмжээнд хүн амын нутагшилтын оновчтой бүтэц бий болгон, тогтвортой суурьшилтай ажиллаж амьдрах ая таатай нөхцөл бүрдэнэ.

## 7.1.2 Хүн амын суурьшлын төвлөрөл

### *Хүн амын байршил, ястан үндэстний суурьшил*

Баруун бүсэд 2004 оны байдлаар 411.6 мянган хүн оршин сууж байгаа нь улсын нийт хүн амын 16.2 хувьтай тэнцэж байна. Нэг ам дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 0.99 хүн ноогддог нь улсын хүн амын нягтралын дундаж /1.62/-тай харьцуулахад даруй 38.9 хувиар доогуур байна. 2004 оны байдлаар 1989 оны дүнтэй харьцуулахад 1000 хүн ноогдож төрөлт 46 хувиар, 1000 хүн ноогдож ердийн цэвэр өсөлт буурах үндсэн шалтгаан болж байна. Хүн амын шилжих хөдөлгөөний урсгал Улаанбаатар хот болон төв хэсгийн томоохон хот суурин газруудын чиглэсэн шилжих хөдөлгөөнтэй холбоотой байна.

Шилжин явагсад амжиргааныхаа эх сурвалж болсон мал сүргээ тууварлан авч одох нь түгээмэл үзэгдэл болжээ. Ийм байдлаас үүдэн улсын төв хэсэгт бэлчээрийн даац хэтэрч, экологийн тэнцвэрт байдал алагдах аюул нүүрлэж, бүс нутагт хүн ам хэт цөөрч нутаг орон эзгүйрэх хандлага ч бий болж байна.

Монгол Улсын хүний хөгжлийн индекс /ХХИ/ 2002 онд 0.679 байгаатай харьцуулбал Баруун бүсийн ХХИ-ийн дундаж үзүүлэлт харьцангуй доогуур түвшинд /0.652/ байна. Баруун бүсэд гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг сааруулж, хүн амын өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, хүний хөгжлийн түвшинг дээшлүүлэх зэрэг олон асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

### 7.1.2.1 Нийгэм эдийн засгийн тулгуур нөхцөл

2007 оны байдлаар ажилгүйдлийн түвшин улсын дундаж 3.6 хувь байхад Баруун бүсэд 5.3 хувь байна.

Энэ нь баруун бүсийн эдийн засгийн хөгжлийн түвшин бусад бүсээс харьцангуй доогуур байгаатай шууд холбоотой. Шилжилтийн эхний жилүүдэд улсын хэмжээгээр үндэсний орлого огцом буурч, ажилгүйдэл ихсэн, инфляци огцом өсөж, нийгмийн салбарын санхүүжилт буурснаар ядуурал газар авсан билээ. Өмнөх тогтолцооны үед бий болсон ажлын байрууд үгүй болж, тэндээс амжиргаагаа залгуулж байсан хүмүүсийн ихэнх нь ажилгүйдлийн эгнээнд шилжиж орсон ба нилээд хэсэг нь нутаг орноо орхин нүүжээ. Нөгөө талаар зах зээлийн тогтолцооны нөхцөлд иргэд бизнес эрхлэж биеэ даан амьдрах мэдлэг, дадлага туршлага дутмаг, бэлэнчлэх сэтгэлгээнээс салж чадахгүй байгаагаас ажилгүйдлийг дагасан ядуурал өсч байна. Баруун бүсэд сүүлийн жилүүдэд жил дараалан тохиолдсон ган, зуданд нэрвэгдсэн олон айл өрх малгүй болж, сум, аймгийн төв болон хот суурин газрыг барааджээ.

2002-2003 оны өрхийн орлого зарлага, амжиргааны түвшний судалгааны дүнгээр Баруун бүсэд ядуурлын хамралтын хүрээ 51.1%, ядуурлын гүнзгийрэлт 14.6%, ядуурлын мэдрэмж 5.7%-тай тэнцүү байна. Судалгаагаар малчин өрхийн нэг хүнд ноогдох малын тоо 20 бодоос дээш байх боломжтой, Гэтэл Баруун бүсийн олонх малчин өрхийн нэг хүнд ноогдох малын тоо 20 бодоос доогуур байна. Иймд ажилгүйдлийн түвшинг энэ бүс нутагт эрс бууруулж, хүн амын ядуурлаас гаргах талаар дорвитой алхмууд хийх шаардлагатай байна.

### **Ажилгүйдэл**

Баруун бүс нутгийн иргэдийг ажлаар хангах явдал хамгийн тулгамдсан асуудал болжээ. Ажилгүйдлийн шалтгаан нь дараах байдалтай байна. Хөдөө ажиллаж байгаа хүмүүсийн 43 орчим хувь нь групптэй

Хөдөөд

- Зуданд мал ихээр хорогдсон

- Малын өвчин эмгэг ихтэй
- Малын үүлдэр угсааг сайжруулах хандлага тааруу
- Малын гаралтай түүхий эдийн борлуулалт муу
- Хөдөөд гар дамжин худалдаалагдаж байгаа бараа үнэ ихтэй, чанаргүй

Төв суурин газарт

- Зарим газарт цахилгаан эрчим хүч хангалттай байгаа боловч бүс нутаг, орон нутгийн хэрэгцээг хангах бүтээгдэхүүн үйлдвэрлэж чадахгүй байгаа
- Аймаг сумын төвд голлон гадаад дотоодоос оруулж ирсэн барааг худалдаалдаг цөөн бүлэг хүмүүсийн үйл ажиллагаанд цохигдсон ажилгүй хүмүүс
- Хөдөөнөөс аймаг сумын төвд хүүхэд харагсад
- Улаанбаатар, Эрдэнэт, Дархан зэрэг томоохон суурин газар, хилийн боомтууд дамжин ганзагын наймаа, албан бус хөдөлмөр эрхлэгчид
- Санхүүгийн эх үүсвэргүй

Ажилгүйчүүдийн эцсийн хувилбар

Баруун бүс нутагт ажилгүйдлийг бууруулах талаар арга хэмжээ авч, бүсийн зөвлөл “ Нэг суурин, нэг бүтээгдэхүүн “ хөтөлбөр хэрэгжүүлсэн нь сайн хэрэг боловч хөдөлмөр хийхийг хүсэгчдийн эрэлт хэрэгцээг хангахгүй байгаагаас доорх байдалд хүрч байна.

1. Томоохон хот сууринд ирж хог түүх
2. Маш бага цалинтай хүнд ажил хийх
3. Алтны нинжа болох
4. Янз бүрийн гэмт хэрэг үйлдэх
5. Орон гэргүй орц, траншейнд амьдрах
6. Хотын амьдралд хүндрэл учруулж гэр хорооллыг шинээр үүсгэн хот бараадсан их нүүдлийн иргэншил үүсч байна
7. Хот суурин газарт гэр хороолол ихээр суурьшсанаар хөрс усны, агаарын бохирдол, талхагдал үүсч байна.

Баруун бүсэд 8-15 насны 100 хүүхэд тутмын 80 орчим нь ЕБС-д суралцаж байгаа нь Хангайн бүсийн дараа энэ бүс орж байна. Завхан, Увс, Баян-Өлгий аймгуудад сургууль завсардалт харьцангуй өндөр үзүүлэлттэй байна. Сургууль завсардалтын шалтгаан нь хүн амын ядуурлаас гадна, малчдын мал аж ахуйдаа түлхүү ач холбогдол өгөх сэтгэлгээ давамгайлах, сургуулийн дотуур байрны хүрэлцээ муу байгаа зэрэг хэд хэдэн хүчин зүйлстэй холбоотой байна.

МСҮТ-үүд болон дээд сургуулиудын мэргэжлийн чиглэлийг бүсийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулан өөрчлөх, бүс нутагт шаардлагатай мэргэжилтнүүдийг бэлтгэх зорилт тулгарч байна. Бүс нутгийн хөгжлийн асуудлуудаар дорвитой судалгаа дүгнэлт гаргах чадвар бүхий эрдэм шинжилгээний байгууллага ч үгүйлэгдэж байна.


**Боловсрол, соёл, шинжлэх ухаан**

Соёл урлагийн байгууллагуудын урын сангийн байршилт, урлагийн ажилтнуудын ажил, амьдралын нөхцөл, мэргэжлийн ур чадвар, иргэдэд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээний чанар шаардлагын түвшинд хүрэхгүй байна. Иймд боловсрол, соёлын байгууллагуудын зэрэглэл, үйлчилгээний төрөл хүртээмжийг дээшлүүлэх, бүсийн боловсрол, соёл, шинжлэх ухааны нэгдмэл, үр ашигтай тогтолцоо бүрдүүлэх шаардлага байна.



БАРУУН БҮС НУТГИЙН ХҮН АМЫН НУТАГШИЛТ, СУУРЬШЛЫН НЯГТРАЛ

Зураг 7.13



**Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал**

Баруун бүс нутагт эрүүл мэндийн салбарын боловсон хүчний хангамж, мэргэжлийн ур чадварын түвшин харилцан адилгүй, санхүүгийн чадавхи хязгаарлагдмал, материаллаг баазын хангамж, хүрэлцээ дутмаг, эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний чанар, хүртээмж шаардлагын түвшинд хүрэхгүй байна.

Баруун бүсэд бүсийн оношлогоо, эмчилгээний төв 1, аймаг бүрд нэгдсэн эмнэлгүүд ажиллаж байна. Ховдод Бүсийн оношлогоо, эмчилгээний төв байгуулагдаад 3 дахь жилдээ ажиллаж байгаа боловч, тархи бөөрний оношлогооны зарим нарын тоног төхөөрөмж дутагдалтай зэрэг шалтгааны улмаас нийслэлд ирж оношлуулах, эмчлүүлэх нь түгээмэл байна.

Эрүүл мэндийн үйлчилгээний анхан шатны тусламж, үйлчилгээ эмзэг бүлгийнхэнд бүрэн хүрч чадахгүй байна. Амьдралын түвшин доогуур өрхийн хүүхэд 2.5 дахин илүү өвчилж, 3 дахин илүү эмнэлэгт хэвтэж, мөн тэр хэмжээгээр эндэж байна.

Хүрээлэн буй орчин, ажил, амьдралын ахуй нөхцөлөөс шалтгаалан өвчлөлт их байна. Хөдөө орон нутагт байгаа эрүүл мэндийн ажилтнуудын мэргэжлийн түвшин харьцангуй доогуур төдийгүй, боловсрол мэдлэгээ байнга дээшлүүлэх нөхцөл боломж хомс байна. Иймд Баруун бүсэд эрүүл мэндийн тогтолцоог боловсронгуй болгох, эрүүл ахиулах шаардлага тулгамдсан асуудлын нэг болж байна.

**7.1.2.2 Хүн амын прогноз**

Баруун бүсийн хүн амын өсөлтийн хандлага, түүн дээр тулгуурласан прогнозыг аваад үзэхэд дараах байдалтай байна.


Баруун бүсийн хүн амын өсөлтийн хандлага, прогноз /Хүснэгт 7.14/

| Он   | Хүн ам, мянган хүн | Өсөлтийн хувь | Он   | Хүн ам, мянган хүн | Өсөлтийн хувь | Он   | Хүн ам, мянган хүн | Өсөлтийн хувь |
|------|--------------------|---------------|------|--------------------|---------------|------|--------------------|---------------|
| 1989 | 419.5              | -             | 2000 | 420.0              | -0.36         | 2011 | 419.7              | 0.67          |
| 1990 | 426.2              | 1.80          | 2001 | 422.4              | 0.57          | 2012 | 422.9              | 0.77          |
| 1991 | 434.9              | 2.04          | 2002 | 418.3              | -0.97         | 2013 | 426.6              | 0.87          |
| 1992 | 421.0              | -3.20         | 2003 | 414.5              | -0.91         | 2014 | 430.7              | 0.97          |
| 1993 | 411.3              | -2.30         | 2004 | 411.6              | -0.70         | 2015 | 435.3              | 1.07          |
| 1994 | 417.5              | 1.51          | 2005 | 409.0              | -0.63         | 2016 | 440.4              | 1.17          |
| 1995 | 423.0              | 1.32          | 2006 | 410.0              | 0.24          | 2017 | 445.9              | 1.27          |
| 1996 | 426.9              | 0.92          | 2007 | 411.1              | 0.27          | 2018 | 452.0              | 1.37          |
| 1997 | 428.6              | 0.40          | 2008 | 412.6              | 0.37          | 2019 | 458.7              | 1.47          |
| 1998 | 428.6              | 0.00          | 2009 | 414.5              | 0.47          | 2020 | 465.8              | 1.57          |
| 1999 | 421.5              | -1.66         | 2010 | 416.9              | 0.57          | 2021 | 473.6              | 1.67          |


Баруун бүсээс төвийг чиглэсэн нүүдлийн улмаас хүн амын тоо нь зарим жилүүдэд буурч байсан боловч цаашид бүсийн эдийн засгийн хөгжлийн түвшин бусад бүстэй ойртож сайжрах тул хүн амын өсөлт аажмаар нэмэгдэн 2021 онд 474 мянган хүн амтай болно гэсэн прогноз гарч байна. Хүн амын өсөлтийн тэгшитгэл нь дараах хэлбэртэй гарсан болно. Үүнд:

$$POP\% = 404.0916416 + 4.431088927 * t; \quad R = 0.9793$$


Баруун бүсийн хүн ам, аймгаар, 2021 /Диаграмм 7.1/



БАРУУН БҮС НУТГИЙН НУТАГШИЛТ, СУУРЬШЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ




**ХҮН АМЫН НУТАГШИЛТ  
СУУРЬШЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ**



БАРУУН БҮСИЙН СОЁЛ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨВЛӨЛТ



1: 500 000



**ТАЙЛБАР**

**СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН ТӨЛӨВЛӨЛТ**

1. Улиастай хотод зам, барилгын салбарын мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр
2. Ховд хотод геологи, уул уурхайн салбарын мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр
3. Өлгий хотод оёдол, мужаан, дархан, гар урлалын чиглэлээр сургах
4. Улаангом хотод хүнс, хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр
5. Алтай хотод эрүүл мэнд, нийгмийн хамгаалал байгаль хамгааллын чиглэлээр сургах
6. Сутай хотод шинжлэх ухаан технологийн ажилтан бэлтгэх чиглэлээр

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ**

Хошууны төвүүдийн сургуулийг өргөтгөх чиглэлээр

**ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ**

1. Улиастай хотод зам, барилгын инженер эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр
2. Ховд хотод БИС-ийг өргөтгөх болон геологи, уул уурхайн инженерийн чиглэлээр
3. Өлгий хотод ой мод үржүүлэх, малзүйч, фермерийн технологич экологи-байгаль хамгааллын чиглэлээр
4. Улаангом хотод хүнс, хөдөө аж ахуйн технологич, инженерийн чиглэлээр Хөдөлмөрийн дээд сургуулийг өргөтгөх
5. Алтай хотод эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр Эмзүйчийн сургууль
6. Сутай хотод шинжлэх ухаан, технологи, зохион бүтээх инженерийн чиглэлээр

**ОНОШЛОГО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ТӨЛӨВЛӨЛТ**

Бүсийн тулгуур төвүүд болох Сутай болон Ховд, Улиастай хотуудад оношлогоо, эмчилгээний төвүүд байгуулахаар

**СОЁЛ, УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ**

Төлөвлөлтийн хугацаанд соёл, урлагийн болон нийгмийн ажилтан бэлтгэх сургалт явуулах ба соёл, урлагийн байгууллагыг хошууны төвүүдэд байгуулахаар

**ТАНИХ ТЭМДЭГ**

- Улсын хил
- Аймгийн хил
- Аймгийн төв
- Төлөвлөж буй шинэ хот
- Хошууны төв
- Нуур
- Сургалт, үйлдвэрлэлийн төв
- Соёл, урлагийн байгууллага
- Оношлогоо эмчилгээний төв
- Их, дээд сургууль, коллеж
- Ерөнхий боловсролын сургууль

Зураг 7.15

| Хүнсний нэр төрөл           | Нэг хүний жилийн хэрэгцээ хvн/кг | Хүн амын жилийн хүнсний хэрэгцээ /тонн/ |          |            |          |          |          |          |          |          |          |
|-----------------------------|----------------------------------|---|----------|------------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|
|                             |                                  | Баян-Өлгий                              |          | Говь-Алтай |          | Завхан   |          | Увс      |          | Ховд     |          |
|                             |                                  | 2015                                    | 2021     | 2015       | 2021     | 2015     | 2021     | 2015     | 2021     | 2015     | 2021     |
| Мах                         | 92                               | 10270.98                                | 11328.12 | 5957.55    | 6813.20  | 8396.68  | 9370.22  | 7898.08  | 8559.28  | 8658.53  | 9183.81  |
| Сүү                         | 195                              | 21770.01                                | 24010.70 | 12627.42   | 14441.02 | 17797.31 | 19860.78 | 16740.49 | 18141.95 | 18352.33 | 19465.68 |
| Аарц, бяслаг                | 9.3                              | 1038.26                                 | 1145.13  | 602.23     | 688.73   | 848.79   | 947.21   | 798.39   | 865.23   | 875.26   | 928.36   |
| Цөцгий                      | 6.6                              | 736.83                                  | 812.67   | 427.39     | 488.77   | 602.37   | 672.21   | 566.60   | 614.04   | 621.16   | 658.84   |
| Тараг                       | 7.7                              | 859.64                                  | 948.11   | 498.62     | 570.24   | 702.77   | 784.25   | 661.03   | 716.37   | 724.68   | 768.64   |
| Цөцгийн тос                 | 7                                | 781.49                                  | 861.92   | 453.29     | 518.40   | 638.88   | 712.95   | 600.94   | 651.25   | 658.80   | 698.77   |
| Гурил                       | 58                               | 6475.18                                 | 7141.64  | 3755.85    | 4295.28  | 5293.56  | 5907.31  | 4979.22  | 5396.07  | 5458.64  | 5789.79  |
| Гурилан бүтээгдэхүүн        | 34                               | 3795.80                                 | 4186.48  | 2201.70    | 2517.92  | 3103.12  | 3462.91  | 2918.86  | 3163.21  | 3199.89  | 3394.02  |
| Будаа                       | 20                               | 2232.82                                 | 2462.64  | 1295.12    | 1481.13  | 1825.36  | 2037.00  | 1716.97  | 1860.71  | 1882.29  | 1996.48  |
| Чихийн зүйл                 | 30                               | 3349.23                                 | 3693.95  | 1942.68    | 2221.70  | 2738.05  | 3055.50  | 2575.46  | 2791.07  | 2823.43  | 2994.72  |
| Жимс жимсгэнэ               | 45                               | 5023.85                                 | 5540.93  | 2914.02    | 3332.54  | 4107.07  | 4583.26  | 3863.19  | 4186.60  | 4235.15  | 4492.08  |
| Төмс                        | 80                               | 8931.29                                 | 9850.54  | 5180.48    | 5924.52  | 7301.46  | 8148.01  | 6867.89  | 7442.85  | 7529.16  | 7985.92  |
| Хүнсний ногоо               | 80                               | 8931.29                                 | 9850.54  | 5180.48    | 5924.52  | 7301.46  | 8148.01  | 6867.89  | 7442.85  | 7529.16  | 7985.92  |
| Өндөг /ширхэгэ эр/          | 80                               | 8931.29                                 | 9850.54  | 5180.48    | 5924.52  | 7301.46  | 8148.01  | 6867.89  | 7442.85  | 7529.16  | 7985.92  |
| Загас, загасан бүтээгдэхүүн | 2                                | 223.28                                  | 246.26   | 129.51     | 148.11   | 182.54   | 203.70   | 171.70   | 186.07   | 188.23   | 199.65   |
| Ургамалын тос               | 10                               | 1116.41                                 | 1231.32  | 647.56     | 740.57   | 912.68   | 1018.50  | 858.49   | 930.36   | 941.14   | 998.24   |
| Хиам                        | 8                                | 893.13                                  | 985.05   | 518.05     | 592.45   | 730.15   | 814.80   | 686.79   | 744.29   | 752.92   | 798.59   |
| Гоймон                      | 4                                | 446.56                                  | 492.53   | 259.02     | 296.23   | 365.07   | 407.40   | 343.39   | 372.14   | 376.46   | 399.30   |

Баруун бүсийн хүн амын хүнсний хэрэг лээний прогноз /Хүснэгт 7.15/

Ховд аймгийн хүн амын прогноз /Хүснэгт 7.16/

|              | 2008  | 2009  | 2010  | 2011  | 2012  | 2013  | 2014  | 2015  | 2016  | 2017  | 2018  | 2019  | 2020  | 2021  |
|--------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|
| Алтай        | 3239  | 3260  | 3282  | 3307  | 3332  | 3360  | 3388  | 3418  | 3450  | 3483  | 3517  | 3552  | 3588  | 3626  |
| Булган       | 9649  | 9711  | 9778  | 9850  | 9927  | 10008 | 10093 | 10183 | 10277 | 10374 | 10476 | 10581 | 10689 | 10801 |
| Буянт        | 3538  | 3561  | 3586  | 3612  | 3640  | 3670  | 3701  | 3734  | 3769  | 3804  | 3842  | 3880  | 3920  | 3961  |
| Дарви        | 2600  | 2617  | 2635  | 2654  | 2675  | 2697  | 2720  | 2744  | 2769  | 2795  | 2823  | 2851  | 2880  | 2910  |
| Дуут         | 2097  | 2111  | 2125  | 2141  | 2158  | 2175  | 2194  | 2213  | 2234  | 2255  | 2277  | 2300  | 2323  | 2348  |
| Зэрэг        | 3083  | 3103  | 3124  | 3147  | 3172  | 3197  | 3225  | 3253  | 3283  | 3315  | 3347  | 3380  | 3415  | 3451  |
| Манхан       | 4533  | 4562  | 4594  | 4627  | 4664  | 4702  | 4742  | 4784  | 4828  | 4874  | 4921  | 4971  | 5022  | 5074  |
| Дөргөн       | 3020  | 3039  | 3060  | 3083  | 3107  | 3132  | 3159  | 3187  | 3216  | 3247  | 3278  | 3311  | 3345  | 3380  |
| Мянгад       | 3668  | 3691  | 3717  | 3744  | 3773  | 3804  | 3837  | 3871  | 3906  | 3943  | 3982  | 4022  | 4063  | 4106  |
| Мөст         | 3582  | 3606  | 3630  | 3657  | 3686  | 3716  | 3748  | 3781  | 3816  | 3852  | 3889  | 3928  | 3969  | 4010  |
| Мөнххайрхан  | 2481  | 2497  | 2514  | 2533  | 2552  | 2573  | 2595  | 2618  | 2642  | 2667  | 2693  | 2720  | 2748  | 2777  |
| Үенч         | 4767  | 4798  | 4831  | 4867  | 4905  | 4945  | 4987  | 5031  | 5078  | 5126  | 5176  | 5228  | 5281  | 5337  |
| Ховд         | 4596  | 4626  | 4658  | 4692  | 4728  | 4767  | 4808  | 4851  | 4895  | 4942  | 4990  | 5040  | 5092  | 5145  |
| Цэцэг        | 2535  | 2551  | 2569  | 2588  | 2608  | 2629  | 2652  | 2675  | 2700  | 2725  | 2752  | 2780  | 2808  | 2838  |
| Чандмана     | 3160  | 3180  | 3202  | 3226  | 3251  | 3277  | 3305  | 3335  | 3365  | 3397  | 3431  | 3465  | 3501  | 3537  |
| Эрдэнэбүрэн  | 3377  | 3399  | 3422  | 3448  | 3474  | 3503  | 3533  | 3564  | 3597  | 3631  | 3667  | 3703  | 3741  | 3780  |
| Жаргалант    | 29251 | 29440 | 29644 | 29862 | 30094 | 30340 | 30600 | 30872 | 31156 | 31451 | 31759 | 32077 | 32405 | 32744 |
| Аймгийн төвд | 28646 | 28830 | 29030 | 29244 | 29471 | 29712 | 29966 | 30232 | 30511 | 30800 | 31101 | 31413 | 31735 | 32067 |
| Хөдөөд       | 606   | 609   | 614   | 618   | 623   | 628   | 633   | 639   | 645   | 651   | 657   | 664   | 671   | 678   |
| Дүн          | 89175 | 89750 | 90371 | 91037 | 91745 | 92496 | 93286 | 94114 | 94980 | 95882 | 96819 | 97789 | 98791 | 99824 |

Баян-Өлгий аймгийн хүн амын прогноз /Хүснэгт 7.17/

|             | 2008   | 2009   | 2010   | 2011   | 2012   | 2013   | 2014   | 2015   | 2016   | 2017   | 2018   | 2019   | 2020   | 2021   |
|-------------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|
| Алтай       | 4206   | 4246   | 4295   | 4349   | 4409   | 4474   | 4542   | 4613   | 4687   | 4764   | 4842   | 4923   | 5005   | 5088   |
| Алтан-цөгц  | 3332   | 3364   | 3402   | 3445   | 3493   | 3544   | 3598   | 3654   | 3713   | 3774   | 3836   | 3900   | 3965   | 4031   |
| Баян-нуур   | 5612   | 5666   | 5730   | 5803   | 5883   | 5969   | 6060   | 6155   | 6254   | 6356   | 6461   | 6568   | 6678   | 6789   |
| Бугат       | 3855   | 3892   | 3936   | 3986   | 4041   | 4100   | 4163   | 4228   | 4296   | 4366   | 4438   | 4512   | 4587   | 4663   |
| Булган      | 6358   | 6420   | 6493   | 6575   | 6666   | 6763   | 6866   | 6974   | 7086   | 7202   | 7321   | 7442   | 7566   | 7692   |
| Буянт       | 3181   | 3212   | 3248   | 3289   | 3335   | 3383   | 3435   | 3489   | 3545   | 3603   | 3662   | 3723   | 3785   | 3848   |
| Дэлүүн      | 8734   | 8819   | 8919   | 9032   | 9157   | 9291   | 9432   | 9580   | 9734   | 9893   | 10056  | 10223  | 10393  | 10567  |
| Ногоон-нуур | 10291  | 10391  | 10509  | 10642  | 10789  | 10947  | 11114  | 11288  | 11470  | 11657  | 11849  | 12046  | 12246  | 12450  |
| Сагсай      | 4978   | 5026   | 5083   | 5148   | 5219   | 5295   | 5376   | 5460   | 5548   | 5638   | 5731   | 5827   | 5924   | 6022   |
| Толбо       | 4922   | 4970   | 5026   | 5090   | 5160   | 5236   | 5315   | 5399   | 5486   | 5575   | 5667   | 5761   | 5857   | 5955   |
| Улаан-хус   | 8759   | 8844   | 8944   | 9058   | 9183   | 9317   | 9459   | 9607   | 9762   | 9921   | 10085  | 10252  | 10423  | 10596  |
| Цэнгэл      | 8729   | 8813   | 8913   | 9027   | 9151   | 9285   | 9426   | 9574   | 9728   | 9887   | 10050  | 10217  | 10387  | 10560  |
| Өлгий       | 28825  | 29103  | 29434  | 29809  | 30220  | 30661  | 31128  | 31617  | 32125  | 32650  | 33188  | 33739  | 34300  | 34872  |
|             | 101782 | 102764 | 103932 | 105255 | 106705 | 108264 | 109914 | 111641 | 113435 | 115286 | 117187 | 119132 | 121115 | 123132 |

Завхан аймгийн хүн амын прогноз /Хүснэгт 7.18/

|               | 2008  | 2009  | 2010  | 2011  | 2012  | 2013  | 2014  | 2015  | 2016  | 2017  | 2018  | 2019  | 2020  | 2021   |
|---------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|--------|
| Алдархаан     | 3754  | 3800  | 3852  | 3909  | 3970  | 4034  | 4101  | 4172  | 4245  | 4322  | 4401  | 4483  | 4568  | 4655   |
| Баянтэс       | 3129  | 3168  | 3211  | 3259  | 3309  | 3362  | 3419  | 3477  | 3539  | 3602  | 3668  | 3737  | 3807  | 3881   |
| Баянхайрхан   | 2059  | 2085  | 2113  | 2144  | 2178  | 2213  | 2250  | 2288  | 2329  | 2371  | 2414  | 2459  | 2506  | 2554   |
| Дөрвөлжин     | 2305  | 2333  | 2365  | 2400  | 2438  | 2477  | 2518  | 2562  | 2607  | 2654  | 2702  | 2753  | 2805  | 2859   |
| Завханмандал  | 1374  | 1391  | 1411  | 1431  | 1454  | 1477  | 1502  | 1528  | 1554  | 1582  | 1611  | 1641  | 1673  | 1705   |
| Идэр          | 2806  | 2840  | 2879  | 2922  | 2967  | 3015  | 3066  | 3118  | 3173  | 3230  | 3289  | 3351  | 3414  | 3480   |
| Их Уул        | 6074  | 6149  | 6234  | 6326  | 6424  | 6527  | 6636  | 6750  | 6869  | 6993  | 7121  | 7254  | 7391  | 7533   |
| Нөмрөг        | 1960  | 1984  | 2012  | 2041  | 2073  | 2106  | 2141  | 2178  | 2217  | 2256  | 2298  | 2341  | 2385  | 2431   |
| Отгон         | 3449  | 3492  | 3540  | 3592  | 3648  | 3707  | 3768  | 3833  | 3901  | 3971  | 4044  | 4119  | 4197  | 4278   |
| Сантмаргац.   | 2158  | 2185  | 2215  | 2248  | 2282  | 2319  | 2358  | 2399  | 2441  | 2485  | 2530  | 2577  | 2626  | 2677   |
| Сонгино       | 1981  | 2005  | 2033  | 2063  | 2095  | 2128  | 2164  | 2201  | 2240  | 2280  | 2322  | 2365  | 2410  | 2456   |
| Тосонцэнгэл   | 10376 | 10505 | 10649 | 10806 | 10973 | 11151 | 11337 | 11532 | 11735 | 11946 | 12165 | 12392 | 12626 | 12869  |
| Түдэвтэй      | 2079  | 2104  | 2133  | 2165  | 2198  | 2234  | 2271  | 2310  | 2351  | 2393  | 2437  | 2483  | 2530  | 2578   |
| Тэс           | 3644  | 3689  | 3740  | 3795  | 3854  | 3916  | 3982  | 4050  | 4121  | 4196  | 4272  | 4352  | 4435  | 4520   |
| Тэлмэн        | 2916  | 2952  | 2993  | 3037  | 3084  | 3134  | 3186  | 3241  | 3298  | 3357  | 3419  | 3483  | 3549  | 3617   |
| Ургамал       | 1774  | 1796  | 1821  | 1848  | 1876  | 1907  | 1938  | 1972  | 2006  | 2042  | 2080  | 2119  | 2159  | 2200   |
| Улиастай      | 16773 | 16981 | 17214 | 17468 | 17739 | 18025 | 18326 | 18641 | 18970 | 19311 | 19665 | 20032 | 20411 | 20803  |
| Цагаанхайрхан | 1822  | 1844  | 1870  | 1897  | 1926  | 1958  | 1990  | 2024  | 2060  | 2097  | 2136  | 2175  | 2217  | 2259   |
| Цагаанчулуут  | 1554  | 1573  | 1595  | 1619  | 1644  | 1670  | 1698  | 1727  | 1758  | 1789  | 1822  | 1856  | 1891  | 1927   |
| Цэцэн-Уул     | 2030  | 2055  | 2084  | 2114  | 2147  | 2182  | 2218  | 2256  | 2296  | 2337  | 2380  | 2425  | 2470  | 2518   |
| Шилүүстэй     | 2531  | 2562  | 2598  | 2636  | 2677  | 2720  | 2765  | 2813  | 2862  | 2914  | 2967  | 3023  | 3080  | 3139   |
| Эрдэнэхайрхан | 1787  | 1810  | 1835  | 1862  | 1890  | 1921  | 1953  | 1987  | 2022  | 2058  | 2096  | 2135  | 2175  | 2217   |
| Яруу          | 2584  | 2616  | 2652  | 2691  | 2732  | 2777  | 2823  | 2871  | 2922  | 2975  | 3029  | 3086  | 3144  | 3204   |
| Асгат         | 1203  | 1218  | 1235  | 1253  | 1272  | 1293  | 1314  | 1337  | 1361  | 1385  | 1410  | 1437  | 1464  | 1492   |
|               | 82120 | 83140 | 84282 | 85524 | 86850 | 88253 | 89727 | 91268 | 92875 | 94546 | 96280 | 98075 | 99932 | 101850 |

Говь-Алтай аймгийн прогноз /Хүснэгт 7.19/

|              | 2008  | 2009  | 2010  | 2011  | 2012  | 2013  | 2014  | 2015  | 2016  | 2017  | 2018  | 2019  | 2020  | 2021  |
|--------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|
| Алтай        | 2492  | 2500  | 2514  | 2534  | 2560  | 2591  | 2629  | 2672  | 2722  | 2777  | 2838  | 2905  | 2977  | 3056  |
| Баян-Уул     | 3085  | 3094  | 3112  | 3136  | 3168  | 3207  | 3254  | 3307  | 3368  | 3437  | 3512  | 3595  | 3685  | 3782  |
| Бигэр        | 2570  | 2578  | 2592  | 2613  | 2639  | 2672  | 2710  | 2755  | 2806  | 2863  | 2926  | 2995  | 3070  | 3151  |
| Бугат        | 2571  | 2579  | 2593  | 2614  | 2640  | 2673  | 2712  | 2756  | 2807  | 2864  | 2927  | 2996  | 3071  | 3152  |
| Дарви        | 1961  | 1967  | 1978  | 1993  | 2014  | 2039  | 2068  | 2102  | 2141  | 2184  | 2232  | 2285  | 2342  | 2404  |
| Дэлгэр       | 3203  | 3213  | 3231  | 3256  | 3289  | 3330  | 3378  | 3434  | 3497  | 3568  | 3647  | 3733  | 3826  | 3927  |
| Жаргалан     | 1969  | 1975  | 1986  | 2002  | 2022  | 2047  | 2077  | 2111  | 2150  | 2194  | 2242  | 2295  | 2352  | 2414  |
| Тайшир       | 1645  | 1650  | 1660  | 1673  | 1690  | 1711  | 1735  | 1764  | 1797  | 1833  | 1873  | 1917  | 1965  | 2017  |
| Тонхил       | 2494  | 2502  | 2516  | 2536  | 2562  | 2594  | 2631  | 2675  | 2724  | 2779  | 2840  | 2907  | 2980  | 3059  |
| Төгрөг       | 1954  | 1961  | 1972  | 1987  | 2007  | 2032  | 2061  | 2096  | 2134  | 2177  | 2225  | 2278  | 2335  | 2396  |
| Халиун       | 2659  | 2668  | 2683  | 2704  | 2731  | 2765  | 2805  | 2852  | 2904  | 2963  | 3028  | 3099  | 3177  | 3261  |
| Хөхморьт     | 2511  | 2519  | 2533  | 2553  | 2579  | 2611  | 2649  | 2692  | 2742  | 2798  | 2859  | 2927  | 3000  | 3079  |
| Цогт         | 4126  | 4139  | 4162  | 4195  | 4238  | 4290  | 4352  | 4424  | 4506  | 4597  | 4698  | 4809  | 4929  | 5059  |
| Цээл         | 2335  | 2342  | 2355  | 2374  | 2398  | 2427  | 2463  | 2503  | 2549  | 2601  | 2658  | 2721  | 2789  | 2863  |
| Чандмана     | 2114  | 2121  | 2133  | 2150  | 2171  | 2198  | 2230  | 2267  | 2309  | 2355  | 2407  | 2464  | 2526  | 2592  |
| Шарга        | 2016  | 2022  | 2034  | 2050  | 2071  | 2096  | 2126  | 2162  | 2201  | 2246  | 2295  | 2350  | 2408  | 2472  |
| Эрдэнэ       | 2382  | 2389  | 2403  | 2421  | 2446  | 2476  | 2512  | 2554  | 2601  | 2653  | 2712  | 2776  | 2845  | 2920  |
| Есөнбулаг    | 18308 | 18367 | 18469 | 18615 | 18804 | 19036 | 19311 | 19630 | 19992 | 20397 | 20846 | 21337 | 21872 | 22450 |
| Аймгийн төвд | 17219 | 17274 | 17370 | 17507 | 17685 | 17903 | 18162 | 18462 | 18803 | 19184 | 19605 | 20068 | 20570 | 21114 |
| Хөдөөд       | 1089  | 1093  | 1099  | 1108  | 1119  | 1133  | 1149  | 1168  | 1190  | 1214  | 1240  | 1270  | 1301  | 1336  |
|              | 60394 | 60588 | 60926 | 61406 | 62029 | 62796 | 63704 | 64756 | 65950 | 67287 | 68766 | 70387 | 72151 | 74057 |

Увс аймгийн хүн амын прогноз /Хүснэгт 7.20 /

|                | 2008  | 2009  | 2010  | 2011  | 2012  | 2013  | 2014  | 2015  | 2016  | 2017  | 2018  | 2019  | 2020  | 2021  |
|----------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|
| Баруун-туруун  | 3124  | 3139  | 3159  | 3184  | 3213  | 3246  | 3282  | 3321  | 3362  | 3406  | 3451  | 3499  | 3548  | 3599  |
| Бөхмөрөн       | 2185  | 2195  | 2210  | 2227  | 2247  | 2270  | 2295  | 2322  | 2351  | 2382  | 2414  | 2447  | 2481  | 2517  |
| Давст          | 1850  | 1859  | 1870  | 1885  | 1902  | 1922  | 1943  | 1966  | 1990  | 2016  | 2043  | 2071  | 2101  | 2131  |
| Завхан         | 2076  | 2085  | 2099  | 2115  | 2134  | 2156  | 2180  | 2206  | 2233  | 2262  | 2293  | 2324  | 2357  | 2390  |
| Зүүнговь       | 2663  | 2675  | 2693  | 2714  | 2739  | 2766  | 2797  | 2830  | 2865  | 2903  | 2942  | 2982  | 3024  | 3067  |
| Зүүн-хангай    | 2642  | 2654  | 2671  | 2692  | 2717  | 2744  | 2775  | 2808  | 2842  | 2879  | 2918  | 2958  | 3000  | 3043  |
| Малчин         | 2919  | 2933  | 2952  | 2975  | 3002  | 3033  | 3066  | 3102  | 3141  | 3182  | 3224  | 3269  | 3315  | 3362  |
| Наранбулаг     | 4973  | 4997  | 5029  | 5068  | 5114  | 5167  | 5224  | 5286  | 5351  | 5421  | 5493  | 5569  | 5647  | 5728  |
| Өлгий          | 2663  | 2675  | 2693  | 2714  | 2739  | 2766  | 2797  | 2830  | 2865  | 2903  | 2942  | 2982  | 3024  | 3067  |
| Өмнөговь       | 4577  | 4598  | 4628  | 4664  | 4707  | 4755  | 4807  | 4864  | 4925  | 4989  | 5056  | 5125  | 5197  | 5271  |
| Өндөр-хангай   | 3830  | 3848  | 3872  | 3903  | 3939  | 3979  | 4023  | 4070  | 4121  | 4174  | 4230  | 4289  | 4349  | 4411  |
| Сагил          | 2374  | 2385  | 2401  | 2420  | 2442  | 2467  | 2494  | 2523  | 2555  | 2588  | 2623  | 2659  | 2696  | 2735  |
| Тариалан       | 4573  | 4594  | 4624  | 4660  | 4703  | 4750  | 4803  | 4860  | 4920  | 4984  | 5051  | 5121  | 5193  | 5267  |
| Түргэн         | 1965  | 1974  | 1987  | 2002  | 2020  | 2041  | 2064  | 2088  | 2114  | 2142  | 2170  | 2200  | 2231  | 2263  |
| Тэс            | 6152  | 6181  | 6221  | 6270  | 6327  | 6391  | 6462  | 6539  | 6620  | 6706  | 6796  | 6889  | 6986  | 7086  |
| Ховд           | 2498  | 2510  | 2526  | 2546  | 2569  | 2595  | 2624  | 2655  | 2688  | 2723  | 2760  | 2798  | 2837  | 2877  |
| Хяргас         | 2707  | 2719  | 2737  | 2758  | 2784  | 2812  | 2843  | 2877  | 2912  | 2950  | 2990  | 3031  | 3074  | 3117  |
| Цагаан-хайрхан | 2540  | 2552  | 2568  | 2588  | 2612  | 2639  | 2668  | 2699  | 2733  | 2769  | 2806  | 2844  | 2884  | 2925  |
| Улаангом       | 24466 | 24580 | 24738 | 24933 | 25160 | 25417 | 25698 | 26002 | 26326 | 26667 | 27025 | 27397 | 27782 | 28179 |
| Дүн            | 80777 | 81155 | 81674 | 82318 | 83069 | 83916 | 84845 | 85849 | 86918 | 88046 | 89226 | 90454 | 91725 | 93036 |

**Хүн амын прогнозын аргачлал**

Аймгуудын хэтийн хүн амын тоог гаргахдаа нас баралт, төрөлт, шилжих хөдөлгөөнд тулгуурлан статистикийн онол болон хугацаан цувааны онолын арга загваруудаас хамгийн сайн тохирох загваруудыг сонгон гаргасан.

Параметруудийн үнэлэлтийг хамгийн бага квадратын арга, хамгийн их үнэний хувь бүхий арга, жигнэгдсэн хамгийн бага квадратын аргуудын тусламжтайгаар тооцоолсон.

**Баян Ёлгий аймаг**

Натурал логарифмчилсан тоон дээр хугацааны хувьд шугаман загварыг сонгон авч хандлагыг гаргалаа.

$$\text{Log(Нас баралт)} = 97,565 + -0,0455363 * \text{хугацаа}$$

| Параметр | Үнэлэлт    | Стандарт хазайлт | t        | P-value  |
|----------|------------|------------------|----------|----------|
| Тогтмол  | 97,565     | 24,8533          | 3,92563  | 0,029415 |
| Налуу    | -0,0455363 | 0,0123957        | -3,67356 | 0,034913 |

Энд :

Параметр- Хэмжигдэхүүнүүдийн хоорондын шугаман хамаарлын коэффициентүүд

Үнэлэлт- Параметрийн утгыг өгөгдсөн түүврийн тусламжтайгаар бодож гаргасан тоон утга

Стандарт хайзайлт- энэ хэмжигдэхүүний тусламжтайгаар параметрийн бодит утга хэр хэлбэлзэж болохыг харна.

t –Стьюдентийн утга, /Шинжүүрийн статистикийн утга/ Энэ утга их байх тусам параметрийн утга тэгээс эрс ялгаатай байгааг илтгэдэг.

P-value\*100% –Энэ хэмжигдэхүүн параметрийн утга тэгээс хэр ялгаатай байгааг хувиар илэрхийлдэг. /Магадлалаар/ P-value<0.001 бол \*\*\* гэж тэмдэглэх ба параметрийн утга тэгээс эрс ялгаатай байгааг буюу дэвшүүлсэн таамаглал худал болохыг харуулна. P-value>0.05 бол параметрийн утга тэг байгааг илэрхийлнэ.

$$\text{Log(шилжилт)} = \exp(56,0669 + -0,0269601 t)$$

| Параметр | Үнэлэлт    | Стандарт хазайлт | t        | P-value  |
|----------|------------|------------------|----------|----------|
| Тогтмол  | 56,0669    | 45,3432          | 1,2365   | 0,341778 |
| Налуу    | -0,0269601 | 0,0226207        | -1,19183 | 0,355574 |

Төрөлт:  $\alpha = 0,9999$  параметр бүхий экспоненциалаар тэгшитгэх аргыг ашиглав.

**Говь Алтай аймаг**

Натурал логарифмчилсан тоон дээр хугацааны хувьд шугаман загварыг сонгон авч хандлагыг гаргалаа.

$$\text{Log(Нас баралт)} = 39,3866 + -0,0167159 * \text{хугацаа}$$

| Параметр | Үнэлэлт    | Стандарт хазайлт | t         | P-value  |
|----------|------------|------------------|-----------|----------|
| Тогтмол  | 39,3866    | 48,9057          | 0,805358  | 0,479530 |
| Налуу    | -0,0167159 | 0,0243919        | -0,685307 | 0,542355 |

$$\text{Шилжилт} = 276338, + -137,297 t$$

| Параметр | Үнэлэлт  | Стандарт хазайлт | t        | P-value  |
|----------|----------|------------------|----------|----------|
| Тогтмол  | 276338,  | 120201,          | 2,29897  | 0,148252 |
| Налуу    | -137,297 | 59,9653          | -2,28961 | 0,149209 |

$$\text{Төрөлт} = 727,244 + 0,224 t$$



| Параметр | Үнэлэлт | Стандарт хазайлт | t         | P-value  |
|----------|---------|------------------|-----------|----------|
| Тогтмол  | 727,244 | 42412,9          | 0,0171468 | 0,987396 |
| налуу    | 0,224   | 21,1536          | 0,0105892 | 0,992216 |

**Завхан аймаг**

Натурал логарифмчилсан тоон дээр хугацааны хувьд шугаман загварыг сонгон авч хандлагыг гаргалаа.

$$\text{Log(Нас баралт)} = 34,7729 + -0,0142543 * \text{хугацаа}$$

| Параметр | Үнэлэлт    | Стандарт хазайлт | t         | P-value  |
|----------|------------|------------------|-----------|----------|
| Тогтмол  | 34,7729    | 36,8681          | 0,943172  | 0,415174 |
| Налуу    | -0,0142543 | 0,0183881        | -0,775194 | 0,494721 |

$$\text{Log(шилжилт)} = \exp(167,896 + -0,0827917 t)$$

| Параметр | Үнэлэлт    | Стандарт хазайлт | t        | P-value  |
|----------|------------|------------------|----------|----------|
| Тогтмол  | 167,896    | 61,5985          | 2,72565  | 0,112367 |
| Налуу    | -0,0827917 | 0,0307301        | -2,69416 | 0,114573 |

$$\text{Төрөлт} = -106802, + 54,021 t$$

| Параметр | Үнэлэлт  | Стандарт хазайлт | t        | P-value  |
|----------|----------|------------------|----------|----------|
| Тогтмол  | -106802, | 56703,7          | -1,88352 | 0,156151 |
| налуу    | 54,021   | 28,2811          | 1,91014  | 0,152105 |

**Увс аймаг**

Натурал логарифмчилсан тоон дээр хугацааны хувьд шугаман загварыг сонгон авч хандлагыг гаргалаа.

alpha = 0,9999 параметр бүхий экспоненциалаар тэгшитгэх аргыг ашиглав.

$$\text{Log(шилжилт)} = \exp(41,724 + -0,0198146 t)$$

| Параметр | Үнэлэлт    | Стандарт хазайлт | t       | P-value  |
|----------|------------|------------------|---------|----------|
| Тогтмол  | 41,724     | 18,6079          | 2,24228 | 0,154177 |
| Налуу    | -0,0198146 | 0,00928305       | -2,1345 | 0,166370 |

$$\text{Төрөлт} = -22212,9 + 12,021 t$$

| Параметр | Үнэлэлт  | Стандарт хазайлт | t         | P-value  |
|----------|----------|------------------|-----------|----------|
| Тогтмол  | -22212,9 | 37957,0          | -0,585211 | 0,599514 |
| налуу    | 12,021   | 18,9312          | 0,634984  | 0,570558 |

**Ховд аймаг**

Натурал логарифмчилсан тоон дээр хугацааны хувьд шугаман загварыг сонгон авч хандлагыг гаргалаа.

$$\text{Log(Нас баралт)} = 72,708 + -0,0331716 * \text{хугацаа}$$

| Параметр | Үнэлэлт    | Стандарт хазайлт | t        | P-value  |
|----------|------------|------------------|----------|----------|
| Тогтмол  | 72,708     | 27,2349          | 2,66966  | 0,075712 |
| Налуу    | -0,0331716 | 0,0135835        | -2,44205 | 0,092331 |

$$\text{Log(шилжилт)} = \exp(11,7315 + -0,00488253 t)$$

| Параметр | Үнэлэлт | Стандарт | t | P-value |
|----------|---------|----------|---|---------|
|----------|---------|----------|---|---------|

|         |             | <i>хазайлт</i> |           |          |
|---------|-------------|----------------|-----------|----------|
| Тогтмол | 11,7315     | 38,3197        | 0,306148  | 0,788422 |
| Налуу   | -0,00488253 | 0,0191168      | -0,255405 | 0,822276 |

### **Найм. ҮЙЛДВЭР ХӨДӨӨ АЖ АХУЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨЛТ**

#### **Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, салбарын зохистой бүтцийг бий болгох бодлого**

Үндэслэл: Баруун бүс нутагт эдийн засгийн хөгжлийн түвшин бусад бүсүүдээс харьцангуй доогуур байна. Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн / ДНБ / 2004 оны байдлаар 342,3 мянган төгрөг байгаа нь Улсын дунджаас 2,2 дахин, бусад бүсүүдээс 1,3-2,4 дахин бага байна.

Баруун бүсийн ДНБ-д 2004 оны байдлаар хөдөө аж ахуйн салбар 75,5 хувь, аж үйлдвэрийн салбар -1,7 хувь, үйлчилгээний салбар 26,2 хувтйг тус тус эзэлж байна. Энэ байдал нь хөдөө аж ахуйн салбарт байгалиас шууд хараат бэлчээрийн мал аж ахуй голлох үүрэгтэй байгаа өнөөгийн нөхцөлд бүсийн эдийн засгийн бүтэц ихээхэн хоцрогдсоныг гэрчилж байна.

Бүсийн аж үйлдвэрийн салбарын хөгжил ч ихээхэн доогуур түвшинд байна.

Баруун бүсийн хөгжлийн түвшний нэгдсэн индекс 0,177 байгаа нь Хангайн бүсээс 1,4 дахин, Төвийн бүсээс 1,7 дахин, Улсын дунджаас 2 дахин бага байна. Түүнчлэн ашигт малтмалын судлагдсаны нөөцийн индексийн хувьд ч бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн бага байна.

Харин ажиллах хүчний хангалттай нөөц байгаа юм. Мөн Улсын нийт малын 30 орчим хувь, хонины нэхий бэлтгэлийн 20 орчим хувь, ямааны арьс бэлтгэлийн 20 гаруй хувь, хонины ноос бэлтгэлийн 30 гаруй хувь, ямааны ноолуур бэлтгэлийн 34 орчим хувь тус бүсэд ноогдож байна. Ихээхэн хэмжээний мах бэлтгэх боломж бас бий. Иймд мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн түүхий эдийн арвин их нөөцдөө тулгуурлан экологийн цэвэр бүтээгдэхүүн Үйлдвэрлэх жижиг дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх боломж байна.

**Баруун бүс нутаг нь газрын нөөцийн хувьд газрын сангийн ангилал бүрээр бусад бүсүүдээс зарим үзүүлэлтээр давуу байна. Гэвч ашигт малтмалын хувьд Улсын батлагдсан нөөцийн багахан хувийг эзэлдэг сул талтай. Эхний ээлжинд Баян-Өлгийн Асгатын мөнгөний, Завханы Баян-Айргийн зэс, алтны, Говь-Алтайн Талын мэлтэсийн алтны, Ховдын ховор металлын орд газруудыг даруй ашиглаж эхлэх талаар шийдвэртэй алхам хийн, оновчтой эзэмших, эрчим хүч, зам тээвэр, харилцаа холбооны чиглэлээр одоо хэрэгжих эхлээд байгаа томоохон төслүүдийг богино хугацаанд бүрэн хэрэгжүүлж баруун бүсийн эдийн засгийн салбарын бүтцийн шинэчлэн сайжруулах боломж байна.**

Хөгжлийн дээр дурьдсан нөөц боломжуудыг бүрэн ашиглах, экосистемийн тэнцвэрт байдалд зохицсон эдийн засгийн салбарын оновчтой бүтэц, өндөр өсөлтийг бий болгох нь баруун бүсийн эдийн засгийн хөгжлийн нэн тэргүүний тулгамдсан зорилт юм.

#### **Баруун бүс нутгийн хөгжлийн стратеги**


##### **2010-2015 он**

Баруун бүс нутгийн хөгжлийн стратеги нь Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах бага оврын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн, түүхий эдээр улс орны дотоодын хэрэгцээг хангах, гадаадад экспортлох явдал нь хөгжлийн ойрын зорилт болно.

##### **2015-2021 он**

Баруун бүс нутагт байгаль дэлхийд ээлтэй, экосистемд хор хөнөөлгүй байдлаар эрдэс баялагийн нөөцийн хайгуул хийх, уул уурхайн баяжуулах үйлдвэр, металлурги, зэс, төмрийн бэлдмэл, барилгын материалын үйлдвэрлэл, нүүрс-химийн үйлдвэр, эрчим хүч, дулааны үйлдвэрлэл, төрөл бүрийн нано цахим техник, машины үйлдвэрлэлийг хөгжүүлэх явдал нь хөгжлийн стратегийн хэтийн зорилт болно.

Энэ төсөл нь засаг захиргааны нэгжийн бүтцийг газар нутаг, байгаль экологийн онцлог байдал, нийгэм эдийн засгийн тулгуур нөхцөлүүдтэй уялдуулан хийсэн **Нээлттэй бүс** загвар төсөл юм.



**Нэгдүгээрт**

Баруун бүс нутагт хадгалагдаж байгаа томоохон илрэл ордуудад эрдэс баялагийн эрэл хайгуул судалгааг 2010-2015 оны хооронд нарийвчлан хийх, нөөцийг тогтоож байгуулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалч нартай бүтээгдэхүүн хуваах болон боловсруулах үйлдвэр байгуулах гэрээ хэлэлцээрийг хийж эхлэх

**Хоёрдугаарт**

Нөөц нь батлагдсан болон ирээдүйтэй нөөц сайтай, хүдрийн агуулга ихтэй орд болох өндөр магадлалтай илрэлүүдэд бүтээгдэхүүн хуваах гэрээнд нөхөн тооцох хэлбэрээр эрэл хайгуул хийж нөөцийг тогтоолгох, олон улсын нээлттэй тендерээр бүтээгдэхүүн ашигтай байхаар зарлах

**Гуравдугаарт**

Эрдэс баялагийн орд илрэлүүдийг бараадуулан төлөвлөсөн төмөр зам нь ерөнхий санааг үндэслэн шинээр нөөц нь тогтоогдсон болон нөөц сайтай байж болох ордуудад түшиглэн төмөр зам тавих техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж эхлэх

**Дөрөвдүгээрт**

Хөшөөтийн нүүрсний уурхай болон Алтайн цаад говьд нээгдэж байгаа нүүрсний их нөөцтэй байж болох ордуудын нөөцийг тогтоож, гадаадад эрчим хүч экспортлох, дотоодыг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах зорилгоор эрчим хүчний цахилгаан станцууд байгуулах

**Тавдугаарт**

Олон улсын жишигт нийцсэн хүнд үйлдвэр, гааль худалдаа, шинжлэх ухаан технологи, оюуны өндөр багтаамжтай “Сутай” хотыг байгуулах техник эдийн засгийн үндэслэлийг хийж, эрдэс баялаг ашиглагч нар болон хөрөнгө оруулагч нарт зарлах явдал юм.

Баруун бүсийн 5 хотын аль нэг нь дэлхий жишигт нийцсэн томоохон хот байгуулах нөхцлүүдийн шинжүүрүүдийг хангахгүй байгаа буюу цаашид эрчимтэй хөгжих ирээдүй багатай тул Хар ус нуурын урд эрэгт Сутай хотыг байгуулах бүх ажлыг эхлэж, Астана хотын жишээн дээр байгуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

**2009-2015**

- Сутай хотыг байгуулах хайгуул судалгааны ажил хийх
- Засгийн газар жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг бүсийн хэмжээнд шуурхай хэрэгжүүлэх ажлын хүрээнд эн түрүүнд мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг бүрэн боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг эрчимтэй хөгжүүлэх
- Эрчим хүч, автозам, харилцаа холбоо, мэдээллийн сүлжээг хөгжүүлэх хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх

- Аялал, жуучлалын салбарыг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийн өсөлтөнд мэдэгдэхүйц нөлөө бүхий салбар болох
- Бүсийн төвүүдэд Технологи дамжуулах төв байгуулах, мэргэжлийн болвсон хүчин бэлтгэх, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах
- Хилийн боомтуудын үйл ажиллагааг улам, сайжруулж, дотоодын хуримтлалыг эрс нэмэгдүүлэх
- Аймгуудад хүн амын хоол хүнс, өргөн хэрэглээний бараа, түүхий эдийн бөөний худалдааны сүлжээг өргөтгөн хөгжүүлэх, худалдааны чөлөөт бүс байгуулах
- Уул уурхай, аж үйлдвэр, аялал жуучлалын салбарыг түлхүү хөгжүүлэх зорилгоор дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад зориулан эдийн засаг, эрхзүйн илүү таатай орчин бүрдүүлэх арга хэмжээ авах
- Макро эдийн засгийн бодлого болон бүсийн хөгжилтэй нягт уялдуулан боловсруулж, хэрэгжүүлдэг байх
- Эдийн засгийн өндөр үр ашигтай эрдэс баялгийн олборлох болон боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах
- Ховд, Улиастай хотуудад үйлдвэрлэл, технологийн паркууд байгуулж, хөгжүүлэх
- Улаангом, Өлгий, Алтай хотуудад мал аж ахуй, газар тариалангийн түүхий эдэд түшиглэсэн экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөтгөж, экспортийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах
- Мал аж ахуй, газар тариалангийн түүхий эдэд түшиглэсэн боловсруулах үйлдвэрлэл болон аялал жуучлалын салбарт гадаадын зээл тусламжийг түлхүү хуваарилан ашиглах талаах төр, засгийн газартай нягт хамтран ажиллаж дэмжлэг авах
- Ховд, Увс, Говь-Алтай аймагт барилгын материалын үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлж, энэ чиглэлийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг гааль болон нэмүү өртгийн татвараас чөлөөлүүлэх, хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ авах
- Бүсийн нүүрсний нөөцийг нэмэгдүүлэх, экспортлох зорилгоор “Нүүрс” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх

Бүсийн эдийн засагт аж үйлдвэрийн салбар давамгайлах үүрэг гүйцэтгэх болно.

#### 2016-2021

- Төмөр зам барьж байгуулах, хөрөнгийн эх үүсвэр бий болгох, түлшний хангамжийг төлөвлөх
- Бизнесийн орчинг аймаг тус бүрийн онцлогт нийцүүлэн сайжруулах
- Үйлдвэрлэл, технологийн паркуудаар дамжуулан дэвшилтэт техник, технологийг тууштай нэвтрүүлэх
- Эрдэс баялгийн орд газруудад түшиглэсэн ашигт малтмалыг олборлох, боловсруулах үйлдвэрүүдэд дэмжлэг үзүүлэх, шинээр байгуулах
- Мал аж ахуй, газар тариалангийн түүхий эд боловсруулах, үйлдвэрлэлийг дэмжиж, экологийн цэвэр бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх
- Аялал жуучлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх чиглэх болгох
- Бүсийн хөгжлийн банк байгуулан ажиллуулж эхлэх
- Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг гүнзгийрүүлж олборлох, боловсруулах үйлдвэрлэл, аялал жуучлалын салбарт тулгуурлан бүсийн аймгууд бие даан хөгжих нөхцлийг бүрдүүлэх
- Нүүрс, хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн экспортыг нэмэгдүүлэх
- Хүн амын хүн, өргөн хэрэглээний бараа, түүхий эдийн бөөний худалдааны сүлжээг өргөтгөн хөгжүүлэх
- Даатгалын үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөж, нэр төрлийг олшруулан, ялангуяа байгаль, цаг уурын эрсдэл ихтэй мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг даатгалд бүрэн хамруулах
- Барилгын материалын үйлдвэрлэлээр бүсийн хэрэгцээг бүрэн хангадаг болох - бүсийн эдийн засагт аж үйлдвэр, үйлчилгээний салбар тэргүүлэх байр суурьтай болж, экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрс нэмэгдэнэ.
- Сутай хотыг байгуулж эхлэх
- Төмөр замын хайгуул судалгаа хийж, барьж эхлэх

#### Баруун бүсийн хөгжлийн төлөвлөлтийн арга зүйн үндэслэл


Бүсийн хөгжлийн төсөл боловсруулахад юуны өмнө тухайн бүсийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн гол үзүүлэлтүүдийг Монгол Улсыг хөгжүүлэх хөтөлбөр, бодлогуудтай нягт уялдуулсан болно. Ийм хөтөлбөрүүдэд 1) Монгол Улсыг 2021 он хүртэл хөгжүүлэх цогц бодлого, 2008, 2) Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, 2000, 3) Монгол Улсын мянганы хөгжлийн зорилт, УИХ-ын тогтоол, дугаар

25, 2005, 4) “Мянганы зам” төсөл, УИХ-ын тогтоол, дугаар 09, 2001, 5) Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 1999, 6) Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, 2003, 7) Монгол Улсын уул, уурхайн салбарын талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл, 2002, 8) Монгол Улсын мэдээлэл, холбооны салбарын бодлого, зохицуулалтын өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн үзэл баримтлал (концепц), 2005, 9) Мэдээллийн технологийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын зорилт, 2005, 10) Баруун бүсийн 5 аймгийн хөгжлийн хөтөлбөрүүд зэрэг орно.

Бүсийн төлөвлөлтийн логик дарааллыг сонгохдоо ерөнхийгөөс тодорхойруу чиглэсэн судалгааны дараах зарчмыг баримталсан. Үүнд:

1. Үндэсний хөгжлийн цогц бодлогын хүрээнд Монгол Улсын нийгэм-эдийн засгийг 2008-2015, 2016-2021 онд хөгжүүлэх зорилтоос Баруун бүсийн хөгжлийн эрч түрүүлж байх зарчим баримталсан, үүний үр дүнд хөгжлийн бүсийн ялгаа багасах нөхцөл бүрдэнэ,
2. Үүний тулд хүн ам, суурьшил, ажил эрхлэлт, дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ний бүсийн дүнгээрх прогноз, тэдгээрийг үндэслэн 1 хүнд оногдох ДНБ-ний үйлдвэрлэлийн зорилтот түвшинг тогтоосон,
3. Зорилтот түвшинд хүрэхэд хамгийн чухал үүрэг гүйцэтгэх тэргүүлэх салбаруудыг тодорхойлсон,
4. Салбаруудын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нөөц боломжийг орон нутгийн нөхцөл, аймаг, сумдын удирдлагаас барьж буй бодлоготой газар дээр нь явж тогтоосон,
5. Салбаруудын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нөөц боломжийг орон нутгийн нөхцөл, аймаг, сумдын удирдлагаас барьж буй бодлоготой газар дээр нь явж тогтоосон,
6. Тооцоо судалгааны балансжилт, тохируулгыг эцэслэн гүйцэтгэж, зураглалын ажлыг хийх, төлөвлөгөөний эцсийн хувилбарыг гаргасан болно.

**Баруун бүсийн хөгжлийн төсөл боловсруулах блок /Схем 8.2/**



Энэхүү логик бүтцийн дагуу хийж гүйцэтгэсэн тооцоо, судалгаа, зураглалын үр дүнг тус бүрээр нь нь авч үзлээ.

### 8.1 ГЕОЛОГИЙН ЭРЭЛ ХАЙГУУЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

**Баруун бүс нутагт нөөцийн 168 орд, 1260 илрэл байгаа юм. 2008 оны байдлаар баруун бүсэд олгогдсон хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлийн хэмжээ нийт нутаг дэвсгэрийн 73 хувьд хүрсэн байна. Энэ бол бүс нутгийн ашигт малтмалыг ухааж сэндийчих, байгаль орчныг сүйтгэх, цөлжүүлэх аюулд хүргэж болохоор байна.**

Энэ төслийн хүрээнд эхлээд түлшний асуудлыг шийдвэрлэх, нүүрс болон бусад шатамхай шүлшний хайгуул, стратегийн ач холбогдолтой төмөр, зэсийн хайгуул судалгааг эрчимтэй хийе. Бусад ашигт малтмалын эрэл хайгуулыг хийхдээ тухайн аймгийн нийт нутаг дэвсгэрийн 30 хүртэл хувьд ээлж дараатай нөхөн сэргээлт хийсний дараа өөр газарт хийдэг хэвшлийг тогтоох, одоо олгогдсон хайгуулын болон ашиглалтын лицензүүдийг журамлах явдал чухал болж байна. Нөхөн сэргээлт нэрийн доор ухсан нүхийг булж байгаагаас өөр зүйл хийгдээгүй байна. Тэнд оршин амьдарч байсан өт хорхой, ан амьтан, шигүүртэн шувууд хүний амьдралд сөрөг нөлөөгүй байдал нь биологийн нөхөн сэргээлт юм. Геологийн эрэл хайгуулын төлөвлөгөөг үндсэн 3 үе шаттай хийхээр төлөвлөж байна.

#### 8.1.1 Баруун бүс нутгийн зэсийн бүлэг орд илрэлүүдийн эрэл хайгуулын төлөвлөлт

2009-2015 онд нөөцийн хайгуул судалгаа хийх зэсийн бүлэг ордуудын эрэл хайгуулыг I<sub>2</sub> талбайд болох Цэнгэл хайрхан, Саяр уул, Бүргэдэй хайрхан уул, Мөнх хайрхан нь Алтайн нурууны бүлэг орд, Хан тайшир, Сэрх уул, Бурхайн буудай уул, Жинай уулын Гичгэний нурууны бүлэг ордуудын эхний үе шатанд хийх нь зүйтэй. Эрэл хайгуулын ажлыг 1:25000, 1:10000-ны зураглалаар баталгаажуулж, геофизикийн судалгаа хийх, турших газруудад өрөмдлөг хийх явдал чухал байна.

2016-2021 онд нөөцийн хайгуул судалгаа хийх зэсийн бүлэг ордуудын эрэл хайгуулыг II талбай болох Баатар хайрхан, Сутай хайрхан, Бүс хайрханы Монгол Алтайн бүлэг ордууд, Аж богд, Таянгийн нурууны Алтайн цаадах говийн Монгол Алтайн нурууны салбар уулс, Эдрэнгийн нуруу, Алтас богд, Алтайн өвөр говийн зэсийн бүлэг ордуудын эрэл хайгуулыг 2-дугаар шатанд гүйцэтгэхээр төлөвлөв.

Төлөвлөлтийнн хугацаанаас цааш буюу 2021 оноос хойш, III, IV гэсэн 2 үндсэн үе шатаар Цагаан шувуут, Баарам уул, Үүрэг нуурын орчны, Завхан аймгийн Их уул, Тосонцэнгэл сумын нутаг болон Булнай нурууны орчны, Ховд аймгийн Бодонч, Үенчийн Хавцал орчны Бумбай хайрханы орчны, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын Цэнгэл хайрханы өвөр биеийн, Сийлэмхийн нурууны, өвөр биеийн Увс аймгийн Алтан хөхий уулын орчны, Завхан аймгийн Их буурал, Бага буурал уулын орчны, Улиастайгаас хойш Улаангомын гол цэгний, Дөрвөлжин сумын нутагт Завханы гол цэгний газруудад хайгуул судалгааны ажлыг явуулахаар төлөвлөв. Баруун бүсэд металлурги зэсийн баяжмалын үйлдвэрийг (түлш усны нөөц сайтай) шинээр төлөвлөж байгаа Сутай хотод байгуулах нь зүйтэй. Мөн газар зүйн байрлалынхаа хувьд ч гэсэн тээвэрлэх үйл ажиллагаанд хүндрэл гарахгүй бүс нутгийн төв цэг юм.

Арц суурь, Бургастайн хилийн боомтыг дайран өнгөрөх хоёр хувилбарын төмөр зам дайран өнгөрөх, зэсийн баяжмал болон боловсруулсан катодын зэсийг тээвэрлэхэд дөхөмтэй болно. Катодын зэс боловсруулахад Дарвийн хөшөөтийн нүүрсний уурхай, хар нуурын усны нөөц чухал хэрэгцээтэй бөгөөд Монголын баруун бүс нутгийн үйлдвэр, худалдаа, агуулахын чөлөөт бүсийг нутгийн гүнд байгуулахад чухал ач холбогдолтой шийдвэр болох юм.

### 8.1.2 Баруун бүс нутгийн нүүрсний орд, илрэлүүдийн нарийвчилсан нөөцийн эрэл хайгуул

2009-2015 онд Увс аймгийн Байрам уул, Түргэн уул, Хархираагийн талбайд, Ховд аймгийн Бумбат хайрхан уул, Баатар хайрхан уул, Сутай уулын талбайд, Говь-Алтай аймгийн Гичгэний нуруу, Хар аргалант, Баянцагаан, Их богд уул, нууруудын хөндийн хотос газрын нүүрсний хайгуул судалгааг хийх томоохон уурхайнуудын нөөцийг тогтоож дотоодын хэрэгцээг хангаж шахмал түлш, кокс химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гадаадад худалдах боломжтой.

2016-2021 онд Говь-Алтай аймгийн бүс Хайрхан, Таянгийн нуруу, Аж богд, Ээж хайрхан, Эдрэнгийн нуруу, Шаргын говийн хөндийнүүдэд агуулагдаж байгаа, чулуун нүүрс, хүрэн нүүрс, хүлэр, шатдаг занарын нөөцийг тогтоох эрэл хайгуулын ажлыг хийхээр төлөвлөж байна.

Мөн Увс аймгийн Хархираа уул, Алтанхөхий уулын хөндийд Их нууруудын хотгор, Хяргас нуурын хөндийд агуулагдаж байгаа сайн чанарын хүрэн нүүрсний талбайн эрлийг хийж цаашид нарийвчилсан хайгуул хийх шаардлагатай.

Төлөвлөлтийн хугацаанаас цааш Таянгийн нуруу, Мэргэн уул, Аж богдын өмнөд хоолой, Алтайн өвөр говийг хамарсан өргөн хөндий, Говь цөлийн нутагт агуулагдаж байгаа нүүрсний арвин их нөөцийг судлан тогтоох явдал юм. Мөн Ховд аймгийн Дэлүүн, Завхан аймгийн Дөрвөлжин сум, Монгол элс, Завхан голын дагуу Идэрийн голын хөндий дагуу, нүүрсний эрлийн ажлыг хийх шаардлагатай байгаа юм.

1960-аад онд эрлийн ажлыг хийж байсан Орос-Монголын экспедиц Завхайн аймгийн Тэлмэн нуурын орчимд нефть болон нүүрс байж болох үндэслэл байгааг тогтоосон байдаг. Энд эрэл хайгуул судалгаа хийж Завхан аймгийн баруун болон хойд талын сумуудыг нүүрсээр хангах арга хэмжээг авах.

2002-2003 онд Завхан аймгийн Засаг дарга Д.Батмөнхийн хүсэлтээр Инженер Геодези ХХК-ны эрлийн баг Эрдэнэ хайрхан сумын Харын худаг, Улиастайгаас 38 км-т орших Хүхээт хэмээх газар нүүрсний хайгуул хийж байсан.

#### Баян-Өлгий аймаг

Баян-Өлгий аймгийн нутагт геологийн 1:50000-ны масштабын судалгаа 50% хийгдсэн нь цаашид тодорхой төрлийн ашигт малтмалд эрэл-хайгуул хийх чиглэлийг тогтоож өгсөн. Тус аймгийн хувьд мөнгө, алт, гянтболд, мөнгөн ус, зэсийн хүдэржилт нь ирээдүйтэй тул цаашид гол анхаарлаа эдгээр ашигт малтмалуудад хандуулж судалгаа явуулах шаардлагатай. Баян-Өлгий аймаг нь хүн ам нилээд нягт сууршилттай, ажиллах хүчний нөөц бололцоо их, бас аж үйлдвэр бараг хөгжөөгүй боловч Улаануул, Толбо, Өлгийд олон жилийн тогтвортой үйл ажиллагаатай, Цэнгэл, Сагсай, Булган, Алтанцөгц сумдын нутагт улирлын чанартай вольфрам, мөнгө, алт, зэсийн олборлох үйлдвэрийн бүтцүүд буй болгож болох юм. Мөн Ногоон нуур сумын нутгаас титаны баяжмал, Баяннуур сумын нутгаас хайлуур жоншны хүдрийг бага хэмжээтэйгээр хялбар аргаар олборлох боломжтой.

#### Ховд аймаг

Ховд аймгийн нутагт геологийн 1:50000-ны масштабын судалгаа Үенч-Бодончийн сав газраас бусад хэсэгт нь хийгдээгүй учир цаашид 1:50000-ны зураглал, ерөнхий эрлийн ажлыг явуулах шаардлагатай.

Тус аймгийн хувьд алт, холимог болон ховор металл, нүүрс, оптикийн түүхий эдийн хүдэржилт нь ирээдүйтэй тул цаашид гол анхаарлаа эдгээр ашигт малтмалуудад хандуулж судалгаа хийх. Булганы хагарлын дагуу Үенч, Бодонч, Ангиртын голууд, тэдгээрийн салбар жалгуудад алтны агуулгатай шороон хуримтлал үүсэх боломжтой.

#### Говь-Алтай аймаг

Говь-Алтай аймгийн нутагт геологийн 1:50000-ны масштабын судалгаа Хан Тайширын районоас бусад хэсэгт нь хийгдээгүй учир цаашид 1:50000-ны зураглал, ерөнхий эрлийн ажлыг эрчимтэй явуулах шаардлагатай. Тус аймгийн хувьд алт, нүүрс, хром, гоёл чимэглэлийн чулуу, цагаан алт, зэс, төмөрын хүдэржилт ирээдүйтэй тул цаашид гол анхаарлаа эдгээр ашигт малтмалуудад хандуулж судалгаа хийх.

#### Увс аймаг

Увс аймгийн нутагт үйл ажиллагаа явуулдаг Дацантрейд компани 2006 онд 7,45кг, 2007 онд 6,72кг алт олборлосон бол 2008 онд 52,5кг болтлоо өссөн байна.

Баян-Өлгий аймгийн нутагт үйл ажиллагаа явуулдаг СС Монголия компани 2006 онд 0.14 тн, 2007 онд 62.5 тн, 2008 онд 100 тн гянтболд тус тус олборложээ.

Говь-Алтай аймгийн нутагт үйл ажиллагаа явуулдаг Гоби Коул анд Энержи компани 2006 онд 3 мян.тн, 2007 онд 4 мян.тн нүүрс тус тус олборлосон байна.

Монголын баруун бүсийн Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий аймгуудын нутаг дэвсгэр дээр нийт 104 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 61 аж ахуйн нэгж 20200 га талбайд үйл ажиллагаа явуулж байгаагаас алтны 39, нүүрсний 33, барилгын материалын 8, давс болон бусад төрлийн ашигт малтмал олборлох зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Баруун бүсийн хэмжээнд нийт 15 төрлийн ашигт малтмалын 294 объект байгаагаас 39 нь 8 төрлийн ашигт малтмалын орд, бусад нь илрэлүүд байна. Үүнд: алтны 12, алт-холимог металлын 2, мөнгөний 1, зэсийн 2, мөнгө-холимог металлын 1, гянт болдын 3, газрын ховор элемент, төмөр ба фосфоритын тус бүр 1, нүүрсний 15 орд тус тус судлагджээ.

Эдгээр ордуудад 0.5 тонн алт (Монгол улсын бодогдсон нийт нөөцийн 0.35%), 2850.0 тн мөнгө (33.0%), 124.9 мян.тн зэс (2.0%), 33.6 мян.тн гянтболд (20.0%), 94.6 сая тн нүүрс (1.0%), 31.6 сая тн фосфорит (11.0%) агуулагдаж байна.

Дээр дурдсан нөөцийн судалгааг 1990 оноос өмнө улсын төсвийн хөрөнгөөр хийсэн бөгөөд 1990 оноос хойш улс орны эдийн засаг уналтанд орж, зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үе сунжирсантай холбоотойгоор алтны ордуудын болон мөнгөний зарим (Асгат, Тавт) ордын нөөцийг шинээр нэмэгдүүлснийг эс тооцвол бусад ашигт малтмалын төрлөөр үйлдвэрлэлийн зэргээр нөөц бэлтгэх ажил хийгдээгүй байна. Харин 1997 онд “Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль” батлагдан, мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор АМХЭГ-ыг байгуулж, Монгол орны геологийн судалгаа, уул уурхайн асуудлыг хариуцуулснаар ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлыг гүйцэтгэх үйл явцад зарчмын өөрчлөлт гарч, эрчимжиж байна.

Үйлдвэрлэлийн зэргээр бэлтгэгдсэн нөөцийг улсын хэмжээгээр нэгтгэн, ашигт малтмалын төрлүүдээр дүгнэж үзвэл:

### **Зэс**

Монгол орны нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн зураглал, эрэл үнэлгээ, хайгуулын шат дараалсан ажлын үр дүнд нийт 7.7 сая тонн (урьдчилан үнэлсэн ба таамагласан эрдсийн баялагтайгаа нийт 15,0 сая тонн орчим) зэсийн нөөц бүхий зэс, зэс-молибдений 6 орд, олон тооны илрэлүүдийг тогтоосноос Эрдэнэтийн овоо (6.2 сая тн), Цагаан суваргын (1.3 сая тн) ордуудын нарийвчилсан хайгуулын ажлыг хийж, нөөцийг баталгаажуулсан байна.

Оюу толгойн алт-зэсийн илрэл нь өнөөдрийн хийж буй судалгааны ажлын тоймоос үзэхэд дээрх ордуудын ижил орд болох магадлалтай байгаа бөгөөд хайгуулын ажлыг эрчимтэй гүйцэтгэн 2007 онд ордын геологийн нөөцийн ерөнхий үзүүлэлтүүд тодорхой болно гэж үзсэн.

### **Молибден**

Молибдений 7 ордод 389.6 мян.тн нөөц батлагдсан бөгөөд дайвар бүтээгдэхүүн хэлбэрээр буюу хам баяжмалаар гаргах боломжтой хэд хэдэн орд, илрэлүүд байгаагаас Эрдэнэтийн овоо (173.3 мян.тн), Цагаан суваргын (43.6 мян.тн), Югзэрийн (12.3 мян.тн) ордуудын нарийвчилсан хайгуулын ажлыг хийж, нөөцийг баталгаажуулсан байна.

### **Гянт болд**

Гянтболдын 26 ордод 116,7 мян.тн гянтболдын ислийн нөөцийг тогтоосон бөгөөд томоохон нь **Улаан уул (Кызыл тау), Цүнхэг, Ховд голын (баруун бүс)**, Онгон хайрхан, Цагаан даваа, Оорцог уулын (төвийн бүс), Югзэр, Салаа, Модотын бүлэг, Хужжааны бүлэг, Ононгийн бүлэг, Дээд кумырийн бүлэг (зүүн бүс) зэрэг болно.

### **Цагаан тугалга**

Цагаан тугалганы нөөцийг тогтоосон 18 орд байгаагаас (нийт нөөц нь 47.5 мян.тн) Элстийн бүлэг, Жанчивлангийн бүлэг, Авдарантын бүлэг, Хар морьтын бүлэг, Хар овоогийн бүлэг (төвийн бүс), Модотын бүлэг, Хужжааны бүлэг, Ононгийн бүлэг, Дээд Кумырийн бүлэг (зүүн бүс) зэрэг шороон ордууд нь дэд бүтэц, уул геологийн нөхцөл сайтай байрлалтай. Нийт нөөцийн 87% нь төвийн, 13% нь зүүн бүсэд тогтоогдсон байна.

### **Холимог металл (цайр, хар тугалга)**

Холимог металлын орд 19, олон тооны илрэл тогтоогдсоны ихэнх нь зүүн бүсэд байгаа бөгөөд эдгээрээс Улаан, Төмөртийн овоо, Салхит, Цав, Баяндун-1, Мухар, Мөнгөн өндөр (зүүн бүс) зэрэг ордуудад хайгуул хийж, нөөц тогтоосон, дэд бүтэц, байршлын хувьд ашиглахад тохиромжтой. Зүүн бүсийн холимог металлын хүдрийн бэлэн нөөц нийтдээ 60 гаруй сая тонн бөгөөд тэдгээрт хар тугалга 1864.1 мян.тн, цайр 2563.6 мян.тн, алт 7,1 тн (Улаан), мөнгө 5669.9 тн (Цав, Мөнгөн өндөр)



агуулагдсан байна. Төвийн бүсийн Билүүт, Хар толгой, Хараат уул, Төмөртэй, Далан ухаа, баруун бүсийн Нүхний нуруу, Дулаан хар уул, Боорж зэрэг ордуудад хайгуул хийгээгүй, эрдсийн баялгийг тоймлон тодорхойлсон байна.

### Хөнгөн цагаан

Хангайн (Дөшийн гол, Өвөр мараат, Дунд хэм гол, Бэлтэсийн гол зэрэг) ба төвийн (Жаргалант, Төмөрлөг оройвч, Даваа, Сэртэн номгон, Шүтээн зэрэг) бүсүүдэд хөнгөн цагааны түүхий эдийн хэтийн төлөв бүхий 20 гаруй илрэл тэмдэглэгдсэн. Хайгуул хийсэн орд байхгүй, зөвхөн эрдсийн баялгийг тоймлон тодорхойлсон байдаг.

### Алт

2001 оны балансад тусгагдсанаар үйлдвэрлэлийн зэргээр батлагдсан алтны нөөцийн хэмжээ 143.8 тн, үүнээс үндсэн ордын нөөц 60 гаруй тонн байна. Нөөцийн дундаж өсөлт одоогийн түвшинд байна гэж үзвэл алтны шороон ордын бэлтгэгдсэн нөөцийг одоогийн хурдцаар 20 орчим жил ашиглах боломжтой.

Алтны үндсэн ордын тойм судалгаа, геологийн зураглал, эрлийн ажлын явцад нийтдээ алтны орд, илрэлийн урьдчилан үнэлсэн болон таамагласан эрдсийн баялгийг 2000 тн орчим гэж баримжаалсан бөгөөд хайгуулын шатанд Бороогийн ордод 43.8 тн, Олон овоотод 1.1 тн (төвийн бүс), Улааны алт-холимог металлын ордод 7.1 тн (зүүн бүс), Тавтын ордод 2,9 тн нөөц бэлтгэгдсэн.

### Мөнгө

Мөнгөний үйлдвэрлэлийн зэргээр бэлтгэгдсэн нөөц нь Цав (1184,7 тн), Мөнгөн өндөр (4485,2 тн), Салхитын (233,8 тн) мөнгө-холимог металлын (зүүн бүс), **Асгатын мөнгөний (2850.0 тн –баруун бүс)** ба Оорцог овооны мөнгө-цагаан тугалганы (12.1 тн- төвийн бүс) ордуудад төвлөрсөн байна. Тавтын алт-мөнгө-зэсийн ордод (хангайн бүс) 11,9 тн мөнгөний нөөц бэлтгэгдсэн.

### Цагаан алт

Өнөөгийн байдлаар Монголд цагаан алтны орд тогтоогдоогүй, цөөн тооны илрэл л мэдэгдэж байна. Гэвч орд илрүүлэх боломж, хэтийн төлөв өндөр байгааг сүүлийн үеийн геологийн зураглал, эрэл хайгуулын ажлын үр дүнд тодруулж байна. Тухайлбал: 1990-ээд оны сүүлчээс эхлэн Увс нуурын баруун талаар Цагаан шивээтийн бүсийг даган, мөн Хан хөхийн нурууны орчмын (баруун бүс) болон Баянхонгорын офиолитын комплексын орчинд буюу Өлзийт, Байдрагийн голуудын савыг (хангайн бүс) дагасан алтны шороон ордуудад дагалдах хэлбэрээр цагаан алт ихээр гарч байна.

Энэ нь манай улсад цагаан алтны шинжилгээ хийдэггүй, өмнөх судалгааны үе шатанд анхаарал хандуулж байгаагүйтэй шууд холбоотой бөгөөд цагаан алтны хүдэржилтийн шууд (цагаан алт гарч буй уурхайнууд) ба шууд бус (офиолит комплексуудтай холбоотой хэт суурилаг болон суурилаг чулуулгууд тархсан талбай, хромитын хүдэржилт бүхий илрэлүүд г.м.) шалгууруудыг тулгуурлан сэдэвчилсэн судалгааны ажил гүйцэтгэвал шинээр орд, илрэлүүдийг илрүүлэх магадлал өндөр юм.

### Төмөр

Төмрийн хүдрийн 12 орд тэмдэглэгдээд байгаагаас сайн судлагдсан ордууд нь төвийн (Төмөртэй, Төмөр толгой, Баян гол, Хонгор /Дарцагт/, Эрээн, Чандмань уул - нийт нөөц нь 420.3 сая тн) ба зүүн (Баргилт, Навчит гол – нийт нөөц нь 354.2 сая тн) бүсүүдэд, үндсэндээ хүдрийн хоёр бүсэд оршино. Үүнд: Төмөртэй, Төмөр толгой, Баян голын ордууд орших Сэлэнгэ-Дарханы бүс, Хонгор /Дарцагт/, Эрээн, Чандмань уул, Баргилтын ордууд орших Дундговь-Дорноговийн бүс. Эдгээрээс зонхилох нөөц нь (364.2 сая тн) дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн Сэлэнгэ, Дарханы районд төвлөрнө.

Дээрх ордуудаас хүдрийн нөөц, агуулга, чанараар бусдаас давуутай, хамгийн сайн судлагдсан нь Төмөртэйн орд бөгөөд 229.3 сая тн нөөцтэй, хүдрийн нөөцийн 40% нь исэлдсэн буюу хүхэр багатай, агуулга ихтэй (51.64%), металлургийн үйлдвэрлэлд тохиромжтой сайн чанарын хүдэр юм. Улсын хэмжээнд үйлдвэрлэлийн зэргээр батлагдсан 774.5 сая тн нөөцтэй. Баруун бүс Таяннуурын төмрийн ордын өргөтгөсөн хайгуул хийж байна.

### Манган

Одоогоор хангайн бүсэд орших Сайхан голын төмөр-мангааны орд дээр л 65.6 сая тн мангааны урьдчилан үнэлсэн баялаг бодогдсон бөгөөд, Хатгал (хангайн бүс), Хаалгын нуруу (төвийн бүс), Хаг нуур (баруун бүс) зэрэг ирээдүй сайтай илрэлүүд бий.

### Хром

Өнөөдрийн байдлаар муу судлагдсан бөгөөд хромын цөөн тооны үндсэн болон шороон илрэлүүдэд эрдсийн баялгийг тооцсон байна. Цагаан алттай хамтад нь сэдэвчилсэн судалгааны аргаар судалбал зохилтой.

### **Газрын ховор элемент**

Газрын ховор элементийн 4 орд тогтоогдсоны 3 нь төвийн бүсэд (Лүгийн гол, Мушгай худаг, Баян хошуу), 1 нь баруун бүсэд (Халзан бүргэтэй) оршино. Зөвхөн Лүгийн голын орд дээр үйлдвэрлэлийн зэргээр нөөц бодсон байна.

### **Нүүрс**

Нүүрсээр Монгол орон баялаг бөгөөд хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон 77 орд нь бүх бүсүүдэд харьцангуй жигд тархсан боловч төвийн бүсэд нийт нөөцийн дийлэнх их нь буюу 91% нь төвлөрсөн байна. Төвийн бүсэд 7031,0 сая тн, зүүн бүсэд 537.4 сая тн, баруун бүсэд 94.6 сая тн ба хангайн бүсэд 69.3 сая тн нөөц тус тус бүртгэгджээ.

### **Хайлуур жонш**

Монгол улс хайлуур жоншны нөөцөөр баянд тооцогдох ба сүүлийн 40 гаруй жилийн турш их хэмжээний сайн чанарын хүдрийг олборлон, дийлэнхийг нь хуучин ЗХУ болон ОХУ-д гаргаж ирсэн, дэлхийд томоохон экспортлогчийн тоонд (2001 оны дүнгээр дэлхийд 4-рт) ордог.

Хайлуур жоншны нөөц үндсэндээ Хэрлэн голын дагуу түүний хойт ба өмнөд бүсэд оршдог 48 ордод (төвийн ба зүүн бүс) тархсан байх ба үйлдвэрлэлийн зэргээр батлагдсан нөөц нь төвийн бүсэд 6.6 сая тн (23 орд), зүүн бүсэд 11.7 сая тн (25 орд) байна. Хангайн бүсэд 1 жижиг орд (Жаандай) тогтоогдсон.

### **Фосфорит**

Монгол орон фосфоритоор маш баян бөгөөд хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон 23 ордын 22 нь Хөвсгөлийн фосфоритын сав газар (хангайн бүс) оршино. Үйлдвэрлэлийн зэрэглэлээр бодсон нөөцийн 89.0% буюу 258.9 сая тн фосфорын ислийн нөөц хангайн бүсэд 11.0% буюу 31.6 сая тн нь баруун бүсэд тус тус батлагдсан.

Бид Монгол оронд тархсан ашигт малтмалын нөөц баялаг, нийт нутаг дэвсгэрийн геологийн судалгааны болон уул уурхайн салбарын өнөөгийн байдал, цаашид геологийн судалгаа, уул уурхайн салбарыг хэрхэн үр өгөөжийг нь дээшлүүлэх тухай товчхон авч үзлээ. Ингээд цаашдын бүс нутгийн хөгжилд уул уурхайн салбарын гүйцэтгэх үүргийг өсгөхийн тулд ашигт малтмалын ямар төрлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг зорих, ер нь голлох төрлийн ашигт малтмалын нөөцийг өсгөх, олборлох ба боловсруулах талаар баримтлах бодлогыг тодорхойлох үндэслэлийг авч үзье.

**Баруун бүсэд уул уурхайн салбарыг хөгжүүлэхийн тулд юуны өмнө зэс, төмөр, алт, алт-холимог металл, мөнгө, мөнгө-холимог металл, гянт болд, газрын ховор элементийн орд газруудыг ашиглах, энэ чиглэлээр хийх эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэх, дэмжих хэрэгтэй. Тухайлбал:**

1. Алтны олборлолтыг нэмэгдүүлэх бүрэн боломж бий. Үүний тулд алтны шороон болон хүдрийн ордын эрэл хайгуулын ажлыг өргөтгөх, нөөцийг нэмэгдүүлэх ажлыг гүйцэтгэж буй лиценз эзэмшигчдийг дэмжих, ялангуяа томоохон үндсэн орд, илрэлүүдийн эрэл хайгуулын ажлыг түргэтгэх талаар анхаарах, Нүхний нурууны алт-холимог металлын, Сум дайрга, Сухайт, Барлаг голын алтны илрэлүүд, Бооржийн мөнгө-холимог металлын орд г.м. хэтийн төлөв сайтай объектуудын хайгуулын ажилд онцгой анхаарч, хөрөнгө оруулагчдад санал болгох, сурталчилах, уул уурхайн үйлдвэр байгуулан ашиглахад тал бүрийн дэмжлэг үзүүлэх,
2. Асгатын мөнгөний ордыг түшиглэсэн жилд 350 тн хүдэр олборлон боловсруулах үйлдвэрийг 2009-2010 онд байгуулах ажлыг яаралтай гүйцэтгэж, дэд бүтцийг нь сайжруулан, ашиглалтанд оруулах боломжийг бүрдүүлэх,
3. Одоо ашиглаж буй гянт болдын Цүнхэг, Ховд голын ордууд болон Улаан уулын ордыг ашиглах, олборлолтыг нэмэгдүүлэх,
4. Халзанбүргэтэйн газрын ховор элементийн ордын хайгуулын ажлыг гүйцэтгэж, нөөцийг үйлдвэрлэлийн зэргээр тогтоон, олборлолт хийхэд дэмжлэг үзүүлэх,
5. Алагийн даваа, Цахир уулын фосфоритын ордыг түшиглэсэн үйлдвэр байгуулж, байгаль орчинд сөрөг нөлөө багатай ашиглах асуудлыг хөрөнгө оруулагч нарт тавьж, шийдвэрлэх,
6. Нүүрсний орд газруудыг жигд ашиглах асуудлыг шийдвэрлэж, бүсийн түлш эрчим хүчний нүүрсний хэрэгцээг хангадаг болох.

7. Цагаан алт, хромитын орд илрэлийн эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэх, орд, илрэл нээн, ашиглах хэтийн зорилго тавин ажиллах.

**Монголын баруун бүсийн Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий аймгуудын нутаг дэвсгэр дээр нийт 104 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 61 аж ахуйн нэгж 20200 га табайд үйл ажиллагаа явуулж байгаагаас алт 39, нүүрс 33, барилгын материал 8 болон давс, бусад металл олборлон үйл ажиллагаа явуулж байна. Нийт 39 алтны тусгай зөвшөөрөл байгаагаас 17 нь буюу 66% нь Увс аймгийн нутаг дэвсгэрт байна.**

Монголд орны баруун бүсийн Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий аймгууд нь Геологи уул уурхайн салбарт томоохон байр суурь эзэлдэг бөгөөд Монгол орны хэмжээнд 1100 гаруй ашиглалтын тусгай зөвшөөрөл байгаагаас 104 нь тус аймгуудын нутаг дэвсгэрт байна. Баруун бүсийн аймгуудаар геологи хайгуулын ажил эрчимтэй хийгдэж байгаа бөгөөд цаашид ашигт малтмал үйлдвэрлэлийн хэмжээ өсөх хандлагатай байна.

**Дэлхийн зах зээлд эрэлт, үнэ ихтэй доорх эрдсийг баруун бүс нутгаас хайх, олборлох арга хэмжээг дэс дараатай авах нь зүйтэй. Үүнд:**

- Хар Тарвагатай, Нүүрст хотгор, Хөшөөтийн нүүрсний олборлолтыг нэмэгдүүлж зарим хэсгийг БНХАУ руу экспортлох
- Асгатын Мөнгөний ордыг эзэмшиж мөнгө тэргүүтэй эрдсийг ОХУ-д экспортлох
- Баян-Өлгийн нутаг дахь гянт болдын хайгуул судалгааг өргөтгөн олборлолтыг нэмэгдүүлж ОХУ-д экспортлох
- Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтайн нутаг дахь сайн чанарын хайлуур жоншны судалгаа хайгуулыг өргөтгөн үйлдвэрийн аргаар олборлох боломжийг судлах
- Говь-Алтайн Тайшир, Цээл, Хасагтхайрхан, Увсын Хан хөхийн, Завханы Богд, Загастай, Баянхонгорын баруун талын төмрийн хүдрийн судалгаа хайгуулыг өрөгтгөж цаашид баруун бүсэд металлургын үйлдвэр байгуулах боломжийг судлах
- Увс аймгийн ховор элементийн судалгаа, хайгуулыг өргөтгөн цааш ашиглах боломжийг судлах
- Увсын Давст сумын Шүдэн уулын чулуун давсыг үйлдвэрийн аргаар боловсруулан ашиглах
- Говь-Алтайн Дарви, Завханы Алдархаан, Баян-Өлгийн Алтай, Буянт, Сагсайн бокситын судалгаа хайгуулыг хийж цаашид ашиглах боломжийг судлах
- Говь-Алтайн Цагаан Олом, Завханы Алдархааны фосфоритын судалгаа, хайгуулыг хийж ашиглах

Бүсийн аймгууд дахь өнгөлгөө, гоёл, чимэглэлийн чулууны судалгааг нарийвчлан хийсний үндсэн дээр тэдгээрийг ашиглах үйлдвэр байгуулж ажиллуулах боломжийг судлах. Говь-Алтайн Хар Азаргын нуруунд элбэг тохиолддог толигор, листовенит, Хан тайширт үлэмж хэмжээтэй байдаг баргилт, Завханы цагаан, ногоон голлосон гантиг зэргийг судлаж ашиглах. Мөн Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Завханд цөөнгүй газарт тааралддаг өнгө бүрийн болор, анар, усан номин, оюу, халтмар зэргийг судлаж ашиглах. Баруун бүс нутаг нь барилгын төрөл бүрийн материал, түүний дотор хайрга, шавар, элс, шохойн чулуу, гөлтгөнө, жугантас, гантиг, боржин зэргээр их баян. Эдгээр болон барилгын бусад материалыг ашиглаж бүсийн аймгууд дахь барилгын материалын үйлдвэрүүдийг сэргээхийн хамт уг бүсд зам, барилгын ажил их өрнөх магадлалтай болж буйг харгалзан зам, барилгын материалын үйлдвэрийг өргөтгөн хөгжүүлэх явдал их чухал болно.

Говь-Алтайд Бидэрийн жугантас, Цагаан голын толигор листовенит, Хөх давааны баргилт, Ховд, Завханы шохойн чулуу, Баян-Өлгийн Алтай, Буянт, Сагсайн улаан голдуу будаг, Увсын цагаан шувуутын гипс, Завханы өнгө бүрийн гантиг зэргийг ашиглах арга хэмжээг дэс дараатай авах, ОХУ-д нэн чухал шаардлагатай ховор эрдэс болох Говь-Алтайн хром, Ховд, Завханы марганец, Баян-Өлгийн диц, Увсын болон бусад аймаг дахь цагаан алт, очир алмаазыг хайж ашиглах арга хэмжээг авах шаардлагатай.

Баруун бүсэд өнгө бүрийн кварц, түүний дотор дэлхийд нэн ховор ягаан, ногоон кварц, усан номин, том хэмжээний халтармана, анар зэрэг байдаг учир тэдгээрийг судлах, улмаар улсын хамгаалалтанд авч зарим хэсгийг үйлдвэрийн аргаар ашиглах, Жугантасын (магнезитийн) гол орд нь Говь-Алтайд байдаг боловч түүнийг олон жилийн туршид ашиглаж чадахгүй байв. Түүнийг ашиглах боломжыг ахин нухацтай авч үзэх нь зүйтэй. Баруун бүс нь шар алтны олон илрэлтэй бөгөөд түүний дотор орд болох ирээдүйтэй газар цөөнгүй байдаг ба түүнээс зарим хэсгийг олборлож эхлэв. Мөн манай цагаан алтны илрэлтэй гол газрын нэг баруун бүсэд, түүний дотор Увс аймагт байдаг.

Цаашид уг бүсийн шар болон цагаан алтыг төрийн мэдэлд бүрэн авах юмуу төрийн оролцоотойгоор үйлдвэрийн аргаар ашиглах нь зүйтэй. Баруун бүсийн аймгууд нь шавар, элс, хайрга, шохойн чулуу, гантиг, боржин, толигор, листовенит, базальт зэргээр нэн баян учир тэдгээрийг нарийвчлан судлаж үйлдвэрийн аргаар ашиглах, улмаар зарим хэсгийг экспортлох арга хэмжээг авбал

зохино. Ховд, Говь-Алтай, Завхан зэрэг аймаг нь томоохон хэмжээний гялтганууртай бөгөөд түүнийг нилээд дээр үеэс эдүгээ хүртэл ашиглан экспортлож ирсэн учир түүнийг судлаж цаашид ашиглах хэрэгтэй. Баруун бүсийн олон нуурын сав, Увс нуурын хотгор, Завханы Хомын тал, Донойн хөндий, Алтайн ар, өвөр говь, Шаргын говь, Улаан шалын хоолой зэрэг газарт нефть, шатдаг хий байж болзошгүй гэж үздэг. Эдгээрээс дархан газар болгосон Увс нуурын хотгор болон Донойн хөндийгөөс бусад газарт нефть, хийг агаараас тандан судлаж судалгаа хайгуул хийж, олон улсын тендерийг зарлаад байгаа юм.

Оросын холбооны улс нь Монголын баруун бүс нутгийн Алтайн хэсгийг ОХУ-ын хүдэрт Алтайн үргэлжлэл бөгөөд эрдэс баялаг, ус, хүн, мал ихтэй, онцлон анхаарвал зохих нутаг гэж үздэг. Сүүлийн үед уг бүс нутгийг БНХАУ, Казах улс болон гадаадын зарим улс орон багагүй сонирхох болов.

**Баруун бүсэд одоогоор илрүүлэн ашиглаж буй ашигт малтмалын томоохон ордод Увсын Хар Тарвагатай, Нүүрст Хотгор, Ховдын Хөшөөтийн нүүрс, Увсын Шүдэн уулын давс, Баян-Өлгийн Улаан уулын гянт болд, алт, барилгын материалын орд орж байна. Ойрын үед нэмж ашиглавал зохих ордод Баян-Өлгийн Цагаан нуурын Асгатын Мөнгөний ордоос өөр хайгуулыг бүрэн хийж ашиглалтанд бэлдсэн орд байхгүй.**

Тиймээс бүс нутагт хийх геологийн нарийвчилсан судалгаа, хайгуулын ажлыг өргөтгөж бүс нутгийн чанартай 1-2, мөн аймгийн чанартай 1-2 эрдсийн ордыг илрүүлж ашиглахыг чухалчлах хэрэгтэй. Тийм ордод нүүрс, төмөр, зэс, хөнгөн цагаан, хайлуур жонш, фосфорит, марганец зэрэг орно гэж үзэж болно. Эдгээр ордыг илрүүлж ашиглахад юуны урд ОХУ, БНХАУ, Казах зэрэг улстай хамтарч ажиллах боломжтой.

**Баруун аймагт Монголын эрдэс баялгийн гол хэсэг нь байгаа гэж үздэг боловч тэнд геологийн судалгаа хайгуул хийгдээгүйгээр барахгүй Ховдод байсан бүсийн геологи хайгуулын томоохон байгууллагыг хувьчлал нэрийн дор устгажээ.** Тиймээс уг бүсэд дэд бүтэц амжилттай хөгжиж эхэлж буй, ажиллах хүч хангалттай, эрдэс баялгийн томоохон олон орд, илрэц байгаа болон ОХУ, БНХАУ, Казах зэрэг том улсын зах зээлд ойр байгааг нь харгалзан геологи хайгуулын томоохон байгууллагуудыг хувийн шугамаар эн тэргүүнд Сутай хотод байгуулж бүс нутгийн болон аймгийн чанартай томоохон ордууд нээж ашиглах бодлого баримтлах хэрэгтэй. Бүсийн томоохон ордод юуны урд нүүрс, төмөр, мөнгө, хайлуур жонш, гянт болд, зэс, хөнгөн цагаан, фосфорит, алт, барилгын зарим материал хамаарагдана.

**8.2 УУЛ УУРХАЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ**

Баруун бүс нутгийг хөгжүүлэхэд уул уурхайн үйлдвэрийг байгаль орчинд хор хөнөөлгүйгээр хөгжүүлэх явдал юм. Одоогийн байдлаар уул уурхайг хөгжүүлэх үндсэн арга нь дэд бүтэц, цахилгаан, хатуу хучилтын авто зам тавихгүйгээр олон салаа зам гарган хөрс, ус, агаар бохирдуулдаг жишиг тогтоод олон жил болж байна. Маш эмзэг экосистемтэй Баруун бүс нутгийг талхлан сүйтгэж байгаа талаар Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл доор зохион байгуулагдсан 2008 оны 06 дугаар сарын 20-ны зөвөлгөөн дээр тодорхойлж ярьсан юм.

Иймд уул уурхайг хөгжүүлэх төлөвлөлт хийж байгальд хөнөөлгүй дэд бүтцийг хөгжүүлсний дараа газрын хэвлийг нээх нь зүйтэй юм. Ашигт малтмалын арвин их нөөцтэй Баруун бүсийн хөгжлийн төлөвлөлтийг үндсэн болон бичил бүс, бүлэг орд илрэлүүд, ашигт малтмалын орд газар бүрээр хэсэгчилсэн төлөвлөлт хийж уурхайг ашиглалтанд оруулж байх дарааллыг алдаж болохгүй .

Бүс нутагт бүхэлд нь хайгуулын болон ашиглалтын лиценз олгосон нь экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулж сүйрэлд хүргэхээр болоод байна. Баруун бүс нутаг байгалийн өгөршил механик хөдөлгөөний талхлагдалт, элсний нүүлт ихсэж, Хангайн бүс нутагт шилжин ирж ургамлын нөмрөг өөрчлөгөж үетэн ургамал зонхилон ургах болсон байна.

Уул уурхайн үйлдвэр, хот сууринтай зохицон амьдрах нүүдлийн мал аж ахуй, соёл иргэншил, зэрлэг ан амьтан, өвс, ургамал, хөрс шороо, унд усыг хайрлан хамгаалах төлөвлөлт хийлээ. Энэ бүс нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлууд засгийн газар бүс нутгийн мөрийн хөтөлбөрт тусгагдан хэрэгжих бүрэн үндэстэй юм.

Уул уурхай байгуулах хяналтын тогтолцоог доорх бүтэцтэй байхаар томъёолсон байна. Баруун бүс нутагт уул уурхайнаас олборлолт явуулаад байгаль болон нийгэмд ээлтэй байлгахын тулд ядаж баяжуулах үйлдвэр байгуулахыг дэмжих шаардлагатай.

Уул уурхай байгуулах хяналтын тогтолцоо /Схем 8.4/



Өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн мөчлөг бүрт хүний нийгмийн хөгжлийн түүхийг эрдэмтэн, судлаач нар үйлдвэржилтийн өмнөх үе, үйлдвэржилтийн үе, үйлдвэржилтийн дараах үе гэсэн төсөөллөөр төлөвлөлт хийж байгалийг хүнд ээлтэй байдлаар эзэмшихийг эрмэлзэж ирсэн.

Харин энэ бүс нутгийн нэг онцлог болсон ан амьтан, өвс ургамал, нүүдлийн мал аж ахуй нь байгаль цаг уурын байдлаас нэн хараат боловч зардал багатай, өөрөө өөрийгөө тэтгэх чадвар сайтай байгаль экологид сөрөг нөлөөгүй, экологийн цэвэр бүтээгдэхүүн өгдөг олон давуу талтай учир хэвээр нь хамгаалах хөгжүүлэх, тэтгэх явдал чухал юм.

Уламжлалт мал аж ахуйг хөгжүүлэх, өвс ургамлаа түүж, тариа ногоогоо тарьж, ан амьтнаа хайрлан хамгаалж, үр шимийг нь хүртдэг байсан онцлог нь өрх бүр үйлдвэрлэгч байсныг харуулах онцлог болохоос хоцрогдол биш гэдгийг бас хамтад нь анхаарах зайлшгүй шаардлага гарч байна. Бүх зүйлийг эрчимжсэн технологид шилжүүлэн тулгуурлана гэвэл нүүдэлчний соёл иргэншлийг устгахад хүргэх юм.

1990 онд ардчилсан хувьсгалт өөрчлөн байгуулалтыг авч ирсэн боловч дэлхийд нөлөөлөх хөгжлийн хүчин зүйлс Монгол улсад байхгүй гэхэд болно. Хөгжлийн хуулбарлах боломж бас байхгүй болохыг түүх бидэнд сургасан. Даяарчлалын энэ эрин үед манай Улс, эдийн засгийн эрх чөлөөг хөхүүлэн дэмжих явдал бол зах зээлийн харилцааг зохицуулах хөшүүрэг механизм төдийгүй хөгжлийн мөн чанарыг танин мэдэж, өөрийн орны онцлогт тохирсон хэлбэрийг сонгож олох, хөгжлийн төлөвийг тодорхойлох түүхэн хариуцлагатай үед тулж ирснийг харуулж байна. Газрын доорх эрдэс баялгийг ард түмэнд ашигтай байдлаар яаж тэгш хүртээх вэ? **Эрдэс баялгийн түүхий эдээ харийнханд өгөөд, эдийн засгийн бололцооны түвшинд ард түмнээ хүргэж чадах уу?** Усаар дүүрсэн, ухсан нүхтэй, нөхөн сэргээлт хийсэн гэсэн нэр зүүсэн хэдэн хоосон товцогтой үлдэх үү? Байгаль экологоо унаган төрхөөр нь хүнд халгүй яаж авч үлдэх вэ? Бүс нутгийн газрын харилцааны асуудлыг төр засаг хяналтандаа байлгахгүй байсаар экосистемийн хямралд хүргэх үү? үгүй юу? гэдэг тулгуур асуулыг энэ төслийн хүрээнд авч үзэж хариулт өгөх гэж оролдлоо.

**Газар бол Монгол улсын оршин тогтнох үндэс бөгөөд иргэд сэтгэл зоригоороо хангалуун амьдран, цэцэглэн хөгжих үндэс юм. Газар шороогоо хайрлах хамгаалж эдүгээ хүртэл өвлүүлэн үлдээсэн эцэг дээдсийн ариун шүтээн бол бидний ирээдүйг тодорхойлогч газар нутаг юм.** Газрыг зөв хэрэглээ болгон ашиглаж, хайрлан хамгаалж, үр шимийг нь хүртэж байх цорыг ганц бодлого нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг нэг бүрчлэн мөрдөж байх явдал юм.

Газар дээрх нийгмийн юмс үзэгдлийн өнгөрсөн ба одоо, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох төр засгийн бодлогыг чиг үүрэг нь Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, аймаг, сум, дүүрэг, багийн газар зохион ерөнхий төлөвлөгөө, хөгжлийн баримжааг илэрхийлэх тухайн бичил бүс нутгийн онцлогыг тусгаж оруулсан хөгжлийн төлөвийг тодорхойлох “Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө” юм. Тухайн бүс нутгийн хөгжлийн төлөвийг тодорхойлох газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь одоогийн хөгжил, алс хэтийн чиг хандлагыг тогтоох ирээдүйн хөгжлийг тодорхойлох цаг хугацааны хоорондын хамаарал нь хэтэрхий хурдтай эрин үед байгааг харгалзах хэрэгтэй болоод байна.

Говь-Алтай аймгийн хуурай нүүрсний илрэл нь хөрс багатай, одоогоор 30 сая тоннын нөөцтэй, цаашид судалгааны талбайг нэмэгдүүлж арвин их нөөцтэй нүүрсний уурхай байгуулах, Шаргын говь нүүрсний орд  $P=41.84$  сая тонн нөөцтэй. Хар тарвагатайн уурхай  $P=100$  сая тонн нөөцтэй эдгээр томоохон орд болох боломжтой нүүрсний уурхайнуудыг уул-техникийн бүх нөхцлийг одооноос төлөвлөн зөв ашиглах нь зүйтэй.

Баруун бүс нутагт идэвхитэй ашиглалт явуулж байгаа нүүрсний 15 орд, алт, мөнгө, зэс бусад эрдсийн 39 орд ажиллаж байна. Монгол орны Макро эдийн засгийн бүсүүдийн эрдсийн баялагийн хэмжээ буюу ашигт малтмалын А+В-С зэрэглэлээр бодогдсон ашигт нөөцөөс баруун бүс нутгийн эдийн засагт нэмэр болохуйц үйлдвэрлэлийн ач холбогдолтой хэтийн төлөв сайтай ордууд нь алтны 12, алт холимог металлын 2, мөнгөний 1, зэсийн 2, мөнгө холимог металлын 1, төмөр ба фосфорын тус бүр 1 орд судлагджээ. Баруун бүсийн нутагт 0.5 тонн алт,

**2850.0 тонн мөнгө , 124.9 мянган тонн зэс, 33.6 мянган тонн гянтболд, 94.6 сая тонн нүүрс, 31.6 сая тонн фосфорын ордууд байгаа юм.**

Улсын төсвийн хөрөнгөөр Асгатын ордын нөөц нэмэгдүүлэх судалгаа хийснийг эс тооцвол нөөц бэлтгэх ажил хийгдээгүй байна. Харин Гянтболдын Улаан уул, Цүнхэл, Ховд голын, цайр, хар тугалганы нүхний нуур, Дулаан хар уул, ордууд цагаан алтны Цагаан шивээтийн бүс, Ханхөхий нурууны ордууд байгаа боловч манай Улс цагаан алтны шинжилгээ хийгдэлгүй сул хандаж байсан.

Газрын элементийн Халзан бүрэгдэйн ордод дэмжлэг үзүүлэн нөөцийг үйлдвэрлэлийн зэрэгт хүртэл нэмэгдүүлэх бололцоотой. Баруун бүсэд үйлдвэр байгуулж болох цөөхөн орд газар тогтоогдоод байгаа төдийгүй орд болох ирээдүйтэй олон илрэл байгаа юм.

**Баруун бүсийн хэмжээнд өнөөгийн байдлаар нийт 15 төрлийн ашигт малтмалын 294 объект олдод байгаагаас 39 нь 8 төрлийн ашигт малтмалын орд, бусад нь илрэлүүд байна. Үүнд: алтны 12, алт-холимог металлын 2, мөнгөний 1, зэсний 2, мөнгө-холимог металлын 1, гянт болдын 3, газрын ховор элемент, төмөр ба фосфоритын тус бүр 1, нүүрсний 15 орд тус тус судлагджээ. Эдгээр орнуудад 0.5 тонн алт /Монгол улсын бодогдсон нийт нөөцийн 35% /, 2850.0 тн мөнгө /33.0%/, 124.9 мян.тн зэс /2.0%/ , 33.6 мян.тн гянтболд /20.0%/, 94.6 сая тн нүүрс /1.0%/ агуулагдаж байна. Баруун бүсэд уул уурхайн салбарыг хөгжүүлэхийн тулд юуны өмнө алт, алт-холимог металл, гянтболд, газрын ховор элементийн орд газруудыг ашиглах, энэ чиглэлээр хийх эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.**

Баруун бүс нутагт нүүрс, усны ихээхэн нөөцтэй учир тэнд тухайлбал Увс, Ховд, Говь-Алтай аймгийн аль нэг нүүрсний уурхайг түшиглүүлэн дулааны томоохон цахилгаан станцыг байгуулах нь зүйтэй.

Говь-Алтайн Тайшир, Хасагт хайрхан, Цээл, Увсын Давстын Харгант, Баянхонгорын баруун талын зарим сумын өндөр агуулгатай төмрийн хүдэр, Яруу, Дөргөн, Чаргантын чанар сайтай марганец, Завханд их тархмал байдаг шохойн чулуу зэргийг ашиглаж болох талтай.

- Говь-Алтайн бидерийн магнезитыг ашиглан галд тэсвэртэй тоосго, барилгын зарим материал үйлдвэрлэх
- Увсын Цагаан шувуутын чанар сайтай гөлтгөнийг ашиглаж гипс үйлдвэрлэх бүс нутгаа хангах
- Говь-Алтайн Хөх морьтын занарыг судлан ашиглах боломжыг авч үзэх

Баруун бүс нутагт дулааны болон усан цахилгаан станц, мөн хосломол ажиллагаатай цахилгаан станц барих, улмаар түүнийг ОХУ-ын Саян Шуменскийн том усан цахилгаан стантай холбож цахилгааны хангамжийг найдвартай болгох, ирээдүйд тавигдах төмөр замыг цахилгаанжуулах, БНХАУ-д цахилгаан экспортлох боломжийг судлах явдал юм.


Баруун бүс нутагт эрчим хүчний түүхий эдийн гол эх үүсвэрийн нэг болох Ураны илрэц Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд байдаг бөгөөд түүний тархалтын талбайг 50 орчим хавтгай дөрвөлжин км эзэлдэг гэж үздэг ажээ. Үүнээс гадна мөн Ховд аймгийн нутагт Ураны илрэц бас байдаг. Тиймээс уг бүсэд Ураны судалгаа, хайгуул хийх явдал чухал юм.



ТӨМРИЙН ХҮДРИЙН БҮЛЭГ ОРД, ИЛРЭЛҮҮД

1:3 000 000

Зураг 8.2



**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Шинээр бий болсон болон хуучин үйлдвэрүүдийн техник, технологийг шинэчлэн уул уурхайн үйлдвэрлэлийн жигд тогтвортой өсөлтийг хангах;
- Говь-Алтайн Талын мэлтэсийн алтны орд газрын геологи хайгуулын ажлыг гүйцэтгэж, ашиглалтад оруулах арга хэмжээ авах,
- Ховд аймгийн Олон булгийн нүүрсний уурхайн төслийн хүчин чадлыг бүрэн эзэмшиж, Булган, Үенч, Алтай сумын нүүрсний хэрэгцээг хангах;
- Завхан аймгийн нүүрсний хэрэгцээг бүрэн хангах зорилгоор геологи хайгуулын ажлыг эрчимжүүлэх;
- Завханы Аядархаан сумын фосфоритын ордод нарийвчилсан хайгуул хийж, ашиглалтын асуудлыг судалж шийдвэрлэх;
- Бүсийн төв, томоохон хотуудад шингэрүүлсэн шатдаг хийн станц барих замаар эрчим хүчний хангамжийг сайжруулах;
- Агьтхангайн эрдэнэсийн чулууны орд, Алагхайрханы алт, зэс молибдены ордын геологи, хайгуулын ажлыг дуусгаж, олборлох, боловсруулах үйлдвэр байгуулах бэлтгэлийг хангах;
- Ашигт малтмалын эрэл хайгуул, зураглалын ажлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, эхний ээлжинд ашиглах боломжтой эрдэс баялгийн нөөц тогтоох, хэрэглэх шаардлагатай олборлолтын технологид дүгнэлт гаргах олборлох, ажилд тавих ажлыг сайжруулах
- Баян-Өлгий аймгийн Асгатын мөнгөний, Улаан-Уулын гяндболдын, Завханы Баян-Айрагийн зэс, алтны, Ховдын Мянгадын халзан бүрэлтэйн ховор металлын ордуудыг ашиглалтанд оруулах
- Шинээр байгуулагдах уул уурхайн үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг хил залгаа орнуудад экспортлоход түлхүү анхаарах
- Ашигт малтмалын ордуудыг ашиглалтанд оруулахад шаардлагатай дэд бүтэц, уурхайн цогцолборыг байгуулах асуудлыг гадаадын шууд хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх арга хэмжээ авах
- Ховд, Увс, Баян-Өлгий аймагт барилгын материал / цемент, тоосго зэрэг / Говь-Алтай, Завхан аймагт магнезит, керамзит, төмөр бетон эдлэхүүний болон өнгөлгөөний чулуу, шохойн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх
- Давсны ордуудыг түшиглэн химийн болон бусад төрлийн бүтээгдэхүүн гаргах олборлох болон боловсруулах үйлдвэрүүдийг байгуулан Монгол улсын иоджуулсан хүнсний давсны хэрэглээний 60 хувийг хангах
- Ховд аймгийн нутаг дэвсгэрт нүүрсний нөөц өсгөх хайгуул хийж, нүүрсний уурхай байгуулах
- Баян-Өлгий аймгийн Нүүрст хотгор, Ховдын Хөшөөт, Увсын Хар тарвагатай, Хүдэн, Их мянган, Говь-Алтайн Зээгт, Хүрэн голын нүүрсний уурхай уурхайнуудын нүүрс олборлолтыг нэмэгдүүлж, бүсийн хэрэгцээг хангах, улмаар экспортонд гаргах
- Нүүрсний уурхайнуудыг түшиглэн шахмал түлшний үйлдвэр байгуулах
- Хар тарвагатайн нүүрсний уурхайн дэргэд нүүрсний хийгээр ажиллах жижиг оврын цахилгаан станц барих
- Говь-Алтай, Ховд аймгийн нутаг дэвсгэрт газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлэх
- Баруун бүсийн эрдэс баялгийн нөөцөд тулгуурлан бүсийн эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, салбарын бүтцийг шинэчлэн өөрчлөх мастер төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх

**8.3 БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ТӨЛӨВЛӨЛТ**

Баян-Өлгий аймагт тоосгоны болон төмөр бетон завод, Увс аймагт тоосго болон төмөр бетон завод, гөлтгөнө үйлдвэрлэх цех, Ховд аймагт тоосго болон төмөр бетон завод, шохойн завод, Говь-Алтай аймагт тоосгоны завод, төмөр бетон завод, хүрмэн гулдмай үйлдвэрлэх цех, Завхан аймагт тоосго болон төмөр бетон завод, шохойн заводууд ажиллаж байсан юм.

**Баян-Өлгий аймаг**

Баян-Өлгий аймагт шар шавар шохой элбэгтэй төдийгүй Ногоон нуурын утаат болор, Бяцхан Халгайтын ягаан кварцыг барилгын гоёл чимэглэлд ашиглах боломжтой төдийгүй нөөцийн хайгуул хийх шаардлагатай. Бугатын элс хайрганы, Өлгий хотын элс хайрганы 55 дугаар илрэл, 294 дүгээр орд 14-А-1-5 хайрганы ордуудын элс хайрганы орд газрууд нь Баян-Өлгий аймгийн барилгын материалын үйлдвэрлэлд чухал хэрэгтэй бөгөөд төмөр бетон эдлэхүүн үйлдвэрлэхэд тохиромжтой.

Хүйтэн уулын орд нь ГОСТ8736-67 стандартад тохирохгүй байгаа боловч одоо ашиглаж байгаа. Бөхөн уулын базальт, Хатуугийн голын илрэл, 113-р ордын элсэн чулуу, Сайрын боржин чулууны нөөцийг тогтоож бэх батын хэмжилт хийх, 113-р ордын элсэн чулуу нь 20\*70\*30см-ын хэмжээтэй учир барилгад ашиглахад нэн тохиромжтой. Хойт улаан нуурын шаврын илрэлийг судалж гоёлын улаан тоосгонд ашиглах, Өлгийн тоосгоны шаврын орд газрыг ашиглаж байгаа юм. Элс хайрганы давхаргын зузаан нь 3.2м бөгөөд 400 маркийн бетон үйлдвэрлэхэд тохирно. Тоосгоны шаврын зузаан нь 3.3 м, ГОСТ9169-



75-ыг хангаж байгаа. Хайрга нь 35.5-76.4%, элс нь 23.6-65.5%-ын агуулгатай бөгөөд 100-150 маркийн бетон үйлдвэрлэхэд тохиромжтой.

Цагаан нуурын орд-1 нь 50-100 маркийн ГОСТ9169-75 стандартын тоосго үйлдвэрлэхэд тохирно. Цагаан нуурын орд-2 нь даацын бус тоосго хийхэд тохиромжтой бөгөөд нөөц ихтэй.

Өлгийн Шавранцрын орд одоо сайн чанарын тоосго үйлдвэрлэж байгаа бөгөөд 100 гаруй мянган метр куб нөөцтэй. Хагийн орд нь 100 маркийн тоосго үйлдвэрлэхэд тохирох бөгөөд 25 мянган метр кубын нөөцтэй сайн чанарын цагаан чанарын шаврын орд газар юм. Бугатын тохойн илрэл нь 800м урт, 200м өргөнтэй 153 мянган метр куб нөөцтэй 50-100 маркийн ГОСТ9169-75 тоосго үйлдвэрлэж болох орд газар юм.

Хавцалын шар шавар нь Алтан цөгц суманд тогтоогдсон цаашид судлах шаардлагатай шар шаврын илрэл юм. Толбо нуурын орд 1.0\*1.0км талбайд тархсан хөхөвтөр саарал өнгөтэй, нягт зуурамтгай чанартай, ямар нэгэн хэмхдэс агуулаагүй 3.1-8.0м зузаантай шаврын үеийг портландцементийн ба керамзитын үйлдвэрт ашиглаж болно.

Даянгийн орд 3.0-0.5 км талбайд тархсан хөхөвтөр саарал өнгөтэй маш зуурамтгай 6.5-17м зузаантай шаврын үеийг өрөмдлөгийн бентон угаалганд ашиглахад тохиромжтой. Алаг толгойн орд 0.3км<sup>2</sup> талбайд тархсан эрдсийн будаг хийхэд тохиромжтой. ГОСТ8019-71 будгийн стандартад тохирч байгаа юм. С1-47.4 мянган тонн нөөцтэй.

Хойт Улаан нуурын илрэл нь 100Х50м талбайд 1.5-2.0м гүнд хувиралд орсон улаавтар өнгийн алаг чулуу бөгөөд шалны будаг хийхэд тохиромжтой.

Түргэн голын керамзитын хайрганы илрэлээр ГОСТ25264-84 маркийн керамзит, Цагаан нуурын илрэлээр ГОСТ25264-84 стандартад тохирсон 500-800маркийн керамзит үйлдвэрлэж болно. Аспайтикийн илрэлийн нөөцийг 1сая метр куб гэсэн боловч нарийвчлан судлах шаардлагатай. 500-700 маркийн керамзит үйлдвэрлэхэд тохирно.

Западное шохойны ордны нөөц нь С1-713.0 мянган тонн, С2-185.0 мянган тонн хамрагдах талбай нь 680 × 160м хэмжээтэй одоо ажиллаж байгаа. Буратын голын шохойн ордын нөөц нь СНС-91.55 мянган тонн, 180м урт 15м өргөн талбайг хамарсан байна. 137-р илрэл нь Цэнгэл сумын нутагт байдаг бөгөөд шохойн чулууны агуулга нь 79.25%, цахирын хоёрдогч исэл нь 14.98%, хөнгөн цагаан төмрийн исэлтэй шохойны агуулга сайтай орд газар юм. Өлгийн илрэл нь 100-170м өргөн, 1км урттай, ГОСТ9179-77 шохойны машин үйлдвэрлэхэд тохиромжтой. Р2-13сая.га нөөцтэй баялаг орд юм. Их Бэрхийн шохойн чулуу нь пермийн кварцтай диорит порфиритийн массив дунд 600м урт, 150м өргөн 20м зузаантай тархсан үлдэц биет байдлаар илэрдэг.

Баян-Өлгий аймагт цемент, тоосго, шохой, төмөр бетоны үйлдвэрийг Өлгий хот, Цагааннуур, Сагсай суманд, Цэнгэл суманд өнгөт буюу барилгын чулууны үйлдвэр байгуулна.

Ямаатын орд нь 1-1.5м өргөнтэй боржингийн том том блок хэлбэрээр тогтсон бөгөөд 1м<sup>3</sup> боржингийн блокоос 8-9м<sup>2</sup> өнгөлгөөний жижиг хавтан гаргаж авч болно. Нөөц нь хэдэн арван сая метр кубээр хэмжигдэнэ. Алтан цөгц сумын Хар Урцын илрэлийг цаашид судлаж барилгын гоёл чимэглэлд ашиглах нь зүйтэй. Хунт нуурын листовенитийн орд нь 20-60м зузаан, 120м линз хэлбэрийн оршдог нь ГОСТ9479-84 стандартад тохирно. С1-50мянган метр куб нөөцтэй.

Улаан толгойн өнгөлгөөний чулуу нь 3.5-10м хүртэл зузаан 7км хүртэл урттай конгломератын үе юм. Нөөцийн хэмжээ нь нэлээд их байх магадлалтай юм.

### Говь-Алтай аймаг

Говь-Алтай аймагт асбестын их нөөцтэй бөгөөд Тайшир, Каньоны, Алаг уулын, Хавчиг булгийн, Тонхилын, Мөрөнгийн, 1 ба 2-р илрэл, Холбоо толгойн 3,4,5,6,7-р илрэлүүдийг цаашид судлаж нарийвчлан эрэл хийх нь зүйтэй. Ашигт малтмалын нөөцийн тодорхойлолтонд ирээдүйгүй гэж заасан боловч асбестын агуулга нь 60%, мяндасны урт нь 0.5-1мм, нөөц нь Р=100 мянган тонн байгаа юм.

Хасагтын асбестын үе нь 1-2см-ээс ховроор 4см зузаантай асбестын нарийн зурвас үед эрлийн ажлыг хийх шаардлагатай. XIX-85-5-11-д Цогт сумын нутагт орших бал чулууны илрэл нь 4-5км урт, 5-25м зузаантай бал чулууны үе агуулсан занар нь бал чулууны агуулгын хувьд 15-25%, урьд Хужрын голд Дэлгэр сумын нутагт 2км урттай, 2-5м зузаантай бал чулууны үе агуулсан занартай.

Их голын шилний (оптик) илрэл нь Алтай суманд байдаг. Хоёр судлаас нийт 2.38кг оптик түүхий эд авч байсан. Барилгын гоёл чимэглэлийн материалд ашиглаж болох Баянголын анарын нөөц Р<sub>1</sub>=7.3тн, Сээрийн худгийн анарын нөөц нь Р<sub>1</sub>=84.3тн, Алтайн худгийн анарын ордын нөөц Р=30тн, 5м гүнээс ил аргаар ашиглаж болно. Нөөц нь Р=38052 кг. Цээл сумын Онгоц толгойн эпидотийн илрэл нь ашиглагдаж байгаа.

Аж Богд, Ямаан ус, Зуслан голын, Баян Өндөрийн утаат болрыг барилгын гэрэл үл нэвтрэх болон бууруулах шилний хольц маягаар ашиглах бололцоотой. Халиун сумын Хуурай сайрын лисвенит,  $P=0.5$  мянган тонн, Тайширын, Ар булгийн лисвенит, ягаан гантиг, Цахир худгийн, Майхан толгойн гартаам, Дарви сумын Хавцагийн булгийн, Хужрын голын Усан болор, Алтай, Тайшир сумдын Завхан голын, Богд булагийн, Цагаан толгойн, Перевалын, Их голын мана, кварц, хас зэрэг нь барилгын гоёл чимэглэл, дархны гоёл чимэглэл хийхэд нэн тохиромжтой. Алтай, Төгрөг сумдын гранатын талст, Цээл сумын Дэрстийн, Малтушийн, Гурац толгойн, Номин, Цахирын хүрэн Дэлийн, Цагаан толгойн Хүрэн Дэлийн II, III илрэлийн гранатын агуулга нь 20-90% байгаа юм. Цээл сумын Боодог хар толгой, Сайрын худгийн термолитит нь маш зуурамтгай нягт тогтолбортой, далд талст хар ногоон, ногоон өнгийн нефрижсэн агуулгатай учир нарийвчлан судалж гоёл чимэглэлд ашиглах нь зүйтэй. Дэлгэрийн огтрог толгойд гөлтгөнийн шөрмөсөн талстын хамгийн урт нь 20-30см, дундаж урт нь 10см агуулгатай тул цаашид судлаж барилгын материал болгон ашиглах нь зүйтэй юм.

Халиун сумын шохойны орд нь ГОСТ-1498-64 стандартад тохирно. Нөөц нь  $C_1=512.7$ , одоо ашиглаж байгаа, Тайшир сумын Цагаан оломын Уч-2 ба 6 ордууд нь  $C_1=2377.15$  нөөцтэй. Тайшир сумын Үзүүр толгойн орд нь  $C_1=2178.0$  мянган тонн,  $C_2=680.0$  мянган тонн нөөцтэй, нарийвчлан судлах шаардлагатай. Завхан голын зүүн эргийн Шохойн эргийн ордоос жилд 10тн шохой ашиглаж байгаа бөгөөд нөөц нь  $P1-23040$  мянган тонн болно.

Говь-Алтай аймаг тоосгоны шавраар их баялаг бөгөөд ихэнх орд нь Тайшир, Алтан цөгц, Бигэр суманд байдаг. Тайшир сумын Цагаан оломын Участок N-2, Тайширын орд, Сухийн хоолойн ордуудын агуулга нь  $SO_3-48.44-55.79\%$ , шаварлаг хэсэг нь 13.5-15.48% байдаг. 75-150 маркийн тоосго үйлдвэрлэхэд тохиромжтой. Эдгээр ордуудыг одоо ашиглаж байгаа. Нөөц нь хэдэн арван мянган тонноор хэмжигдэнэ. Цогт сумын Төгрөгийн голын ордын шавар нь уян хатан чанар өндөртэй, 75 маркийн тоосго үйлдвэрлэхэд тохиромжтой.

Баян –Уул сумын Шавартын орд нь  $C_1=229115$  шоо метр,  $C_1=85603$  шоо метр нөөцтэй 200-250 маркийн тоосго үйлдвэрлэх боломжтой, 9м зузаантай хар саарал өнгийн шавар юм. Баян-Уулын ордын шавраар 75 маркийн тоосго үйлдвэрлэх бололцоотой. Бигэр сумын Өвгөн шаварт, Завхан голын, Шарга сумын Шаргын, Тайшир сумын Мөрөнгийн голын, Гуулин-Тайширын замын дагуу Зараагийн тоосгоны шавруудаар 75-100маркийн тоосго үйлдвэрлэхэд тохирно. Төгрөг сумын Далан түрүүний, Ширдэгийн, Төгрөгийн илрэлүүд нь тоосго, керамикийн түүхий эдэд орон нутгийн чанартай ашиглаж болно.

Говь-Алтай аймгийн Завхан голын элс хайрганы ордыг төмөр бетон үйлдвэрлэлд, Тайширын ордыг 100-300 маркийн хүнд бетон хийц үйлдвэрлэхэд, Гуулингийн хайргыг даацын бус бетон хийц үйлдвэрлэхэд, Хадаасны ордыг 400 маркийн бетон хийц үйлдвэрлэхэд тус тус ашиглана. Урт хурууны элсний орд нь бетон зуурмаг болон өнгөлгөөний шаварт тохиромжтой.

Говь-Алтай аймагт цементийн түүхий эд, Тайшир сумын Дөрвөлжин I ба II орд газарт 25-45 зузаантай 1000 м урттайгаар тархсан байдаг.

Барилгын шилний түүхий эд нь Цагаан толгой  $4500m^3$  агуулгатай талбайтай, Өвөр Хүүшийн  $100000m^2$  талбайд, алаг толгойн орчимд  $1.5-2.0km^2$  талбайд, Тайшир сумын зүүн талд Цахирын 3 томоохон орд тогтоогдсон. Төгрөг суманд гантигжсан шохойн чулууны нарийн үеүдтэй цайвар саарлаас бараан саарал өнгийн жижиг ширхэгтэй далд талстлаг шохойжин хөгжжээ. Нөөцийн хувьд  $C1-18.9$  мянган тонн хүртэл нөөцтэй.

Тайшир суманд элс хайрганы хэвтэш дундаж зузаан нь 1.74м, 100-300 маркийн хүнд бетон үйлдвэрлэхэд тохирно. Алтай хотын зүүнтэй орших Урд хужир голд 50м урт, 250-300м өргөнтэй лиственитийн мишэл хэлбэрийн биет, мөн голын хөндийд 100 квадрат метр талбайд лиственитийн хэмхдэсийн ордын нөөц нь  $P=750$  мянган тонн ирээдүйд барилгын чулууны томоохон үндсэн орд болох боломжтой.

Алтай хотын зүүнтээ эзлэхүүн нь  $1m^3$  болох боржинлог чулуу, Цээл суманд хэмжээ болон нөөц нь тодорхойгүй мраморийн гарш тогтоогдсон. Говь-Алтай аймагт өнгөлгөөний чулуу гурван газар тогтоогдсон байна. Баарангийн булагт  $15000m^2$  талбайд дунд хожуу кембрийн саарал өнгийн дунд ширхэгт биотитот, биотит-эвэр хурмагт гранит, гранадiorитуудад холбогдсон агуулгатай, Шивээ толгойд габбройдын жижиг биет нь харилцан фацын шилжилттэй дунд-том ширхэгт болон жижиг, Өлзийт уулын 500м урт 250м өргөнтэй гантигийн үе тогтоогдсон байна.

Барилгын чухал түүхий эд болох төмөр Хөх морьт сумын 21-Г-4 илрэл, Цогт сумын Ухаа овоотын, Тайшир сумын Завхан голын, Алтай хотын өмнө талд Шарайн, Бугат сумын Хуст уулын, Дэлгэр сумын Умгарын, Хорголжингийн, Хөх морьт сумын Баян худгийн, Халиун сумын Улаагчны, Хөх морьтын V-2-Г-2, Жаргалан сумын Уи өндөр нурууны, Бугат сумын 1085 гаршийн, Цээл сумын Майхантын, Алтай хотын Морсын хар толгойн, Тайширын Цагаан олом, Бүрд, Хөх толгойн, Бүс хайрханы Хүнхээлийн

төмрийн илрэлийг судалж тогтоосноор Монгол улсыг төмрөөр хангах металлургийн үйлдвэрийг Говь-Алтай аймагт байгуулах боломжтой юм.

### Завхан аймаг

Их-Уул сумын оптикийн түүхий эдийн илрэл нь кембрийн өмнөх настай талст занарын дунд үүссэн хагарлын бүсээр исландын жонш ялгарсан байна. Бэлийн харын асбестын илрэл нь судланцаруудын урт нь 0.5-1м өргөн нь 1x1x2см хүрэх бөгөөд минералогийн ач холбогдолтой юм. Ус тын улаан уулын илрэлийн бал чулуу агуулсан занар нь 5x10м зузаан, 50x300м урт үргэлжлэх бөгөөд бал чулууны тархалт жигд бус байдаг. Минералогийн ач холбогдолтой. Тэлмэн сумын Нэргүй илрэл нь доод кембрийн настай хурдас чулуулаг дунд 600м зузаантай багц үе үүсгэж саарал, цагаан өнгөтэй гантигжсан шохойн чулуу тогтжээ. Шинж чанар нь Б ангиллын барилгын шохой гарган авахад тохирно.

Тосонцэнгэл сумын Шумуултын илрэл нь кембрийн галт уулын чулуулгийн дунд 200м орчим зузаантай шохойн чулууны үе илэрчээ. Шохойн чулуу нь А ангиллын барилгын шохой үйлдвэрлэхэд тохиромжтой. Ургамал сумын Цагаан дэлийн илрэл нь Венд-доод кембрийн настай элсэн чулуу, занар, шохойн чулууны дунд 1.0-1.5 км өргөн, тасалдалтайгаар 25-26 км зүүн урдаас баруун хойш чиглэлд тогтсон шохойн чулуу үүссэн байна. Шохойн чулуу нь тунгалаг саарал өнгөтэй, жижиг ба дунд талстлаг, нягт гялтганасан бүтэцтэй юм. Барилгын шохой үйлдвэрлэхэд тохиромжтой юм. Цаашид судалж түүхий эдийн чанарыг нарийвчлан тогтоох шаардлагатай юм. Цагаан чулуутын Гурван худаг орд нь салхины гарал үүсэлтэй жижиг ширхэгтэй элс юм. Хайгуулаар 3м зузаантай гэж тогтоогдсон. 0.15-0.20см зузаантай өнгөн хөрсний үетэй. Элс нь тоосгоны түүхий эдийн нэмэлтэд тохирохоос гадна барилгын өрлөг, шавардлагад тохиромжтой.

Тосонцэнгэл сумын Тосонцэнгэлийн илрэл нь салхины нөлөөгөөр 15км<sup>2</sup> талбайд довцог үүсгэн тогтсон элс. Барилгын өрлөг, шавардлагын зуурмагт хэрэглэхэд тохиромжтой. Завхан голын Шинэ худгийн илрэл нь 32 км<sup>2</sup> талбайд тархсан салхины гаралтай сайн сортлогдсон элсийг барилгад ашиглахад тохиромжтой.

Их Уул сумын Халуун усны голын илрэл нь ойролцоогоор 84 км<sup>2</sup> талбай эзлэн том ширхэгтэй шигтгээн улаан өнгөтэй боржин тархжээ. Мөн энд 4-12.5 мм-ын харилцан адилгүй мөхлөгтэй боржингийн төрөл тохиолдоно. Боржин нь ан цав багатай, цул текстуртай хатуу блоклог хэсэгжилттэй, хүйтэнг тэсвэрлэх чанартай. Гол төлөв улаан-ягаан өнгөтэй, өнгөлөгдөх чанартай 0.6м зузаантай, 1.2м урттай блок гарган авч болохыг тогтоов.

Ургамал сумын 92-р илрэл нь доод протерозойн настай кварцит-гнейсийн зузаалагийн дунд 30м зузаантай 0.5км үргэлжлэн тогтсон цагаан, шар саарал, ягаан өнгөтэй гантиг нь өнгөлгөөний чулууны зориулалтанд тохирно. Булнай сумын Зүүн хожуулын голын илрэл нь дээд-дунд карбоны настай боржингийн дунд том биш шугаман хэлбэртэй анартозит, плагиоклазитын биет илэрчээ. Нарийвчилсан судалгаагаар плагиоклазитоос тогтох ба ногоон саарал өнгөтэй, цул текстуртай, ан цав багатай блоклог хэсэгжилттэй бөгөөд өнгөлгөө, чимэглэл дурсгалын зүйлд хэрэглэхэд тохиромжтой.

Түдэвтэй сумын Ойгон нуурын тоосгоны шаврын илрэл нь 50x25 м хэмжээтэй талбайд 8м зузаантай шавранцарын давхарга илэрчээ. Шавранцар нь бага зэргийн элсний хольцтой 150 маркийн тоосго үйлдвэрлэхэд тохиромжтой. Ургамал сумын Хульжийн голын илрэл нь бага зузаантай шаврын үетэй бөгөөд шаврын хаталт 6.9, агшилт 7.3, 50-75 маркийн тоосго үйлдвэрлэхэд тохиромжтой.

### Увс аймаг

Давст сумын Тээлийн голын Төмрийн илрэл нь 0,1x1,0-ээс 3x30м хэмжээтэй линз хэлбэрийн гематитын зузаалаг юм. Улаан булагийн илрэл нь 5,5км урт, 5-20м зузаантай хувирлын бүс, 0,2-0,3x3-4 м хэмжээтэй биет тус тус тогтоогдсон. Сагил сумын Их цагаан дэл уулын илрэл нь серпентенитэд 1-1,2см ховроор 2мм хүртэл урттай асбестын судланцарууд тархсан байна. Судал тархсан бүсийн өргөн 12м, урт нь 100м.

Тус аймагт Хяргас сумын Хяргасын илрэл нь бал чулууны ганц илрэл юм. 50-300м урт, 8-12м зузаантай бал чулуу агуулсан давхарга. Оптикийн түүхий эдийн хувьд тус аймагт Улаан хадны илрэл, Сондуулын голын илрэл, Таван хайрханы илрэл зэрэг 3 илрэл тогтоогдсон боловч хэтийн төлөв нь тодорхойгүй ирээдүйгүй юм. Илрэл/78-B-IV-4-27/ нь анар, анар-эпидоттой 7м хүртэл өргөнтэй бүс. Мөн 70м урт 15-30м өргөн 0.8м хүртэл зузаантай сэвсгэр хурдсанд анарын суларсан мөхлөгүүд шороон хуримтлал үүсгэсэн. P-336кг шороон хуримтлалын нөөцтэй.

Давст сумын Дашдондогийн илрэл, Сагил сумын Бураатын илрэл нь орон нутгийн хэмжээнд ашиглах боломжтой эрдсийн будгийн илрэлүүд юм. Давст сумын Өмнө Адарга уулын шохойн илрэл нь 18-22м өргөн, 3.6-4км урттай шохойн чулууны 4 давхарга тогтоогдсон. Тэс сумын Холын илрэл нь 30-100м зузаантай шохойн пласт тогтоогдсон. Зүүнхангай сумын Байцаа голын илрэл нь 2км урт, 120м зузаантай шохойн чулууны зузаалаг 10м юм.

78-В-Ш-4-19 илрэл нь 1100м урт, 108 зузаантай гантигжсан шохойн чулууны мэшил нь 380\* уналтай. Барилгын шохойн үйлдвэрлэд тохиромжтой. Малчин сумын Малчин-1 тоосгоны шаврын илрэл нь 0.8-2.7м зузаантай шаврын хэвтэш. 75 маркийн тоосго үйлдвэрлэхэд тохиромжтой. ГОСТ-530-71 стандартад тохирно. Наранбулаг сумын Шаврын илрэл нь/90-В-Ш-3-2/ 2.2км урт, цагаан саарал өнгийн нягт шаврын илрэлтэй. Тоосго вааран эдлэл, цементийн шаварт тохиромжтой. Орон нутгийн чанратай олборлоход тохирно. Хархираа гол, Тэсийн голын орд нь 100, 250, 300 маркийн хүнд бетон дүүргэгчид тохиромжтой. Одоо ашиглаж байгаа.

### Ховд аймаг

Мөст сумын Төмөрийн илрэл, Алтай сумын Сүүл толгойн илрэл, Үенч сумын Хавтагийн илрэл, Тонхил сумын Ховол уулын илрэл, Мянгад сумын Худагийн илрэл, Дөргөн сумын Цагаан Үнэгт уулын илрэл, Чандмань сумын Бүрэг толгойн илрэл, Дарив сумын Шуругийн илрэлүүд нь цаашид судлах үйлдвэрлэлийн ач холбогдолтой төмрийн илрэлүүд юм.

Мөст сумын Төмрийн илрэл нь хагарлын бүсийг дагасан Кварцитын биет дотор үүр маягийн магнетит, гематитын 0.2х20м хэмжээтэй биетээс тогтоно. Кварцитын нийт урт нь 700м. Сүүл толгойн илрэл нь 3-4м зузаан, 700м урттай. Энэ илрэлээс 37 соронзон гүрийн мэшил биетүүд тогтоогдсон.

Тонхил сумын Ховол уулын илрэл нь 0.4-10м өргөн, 20-100м урттай, пегматитын судалд 3\*3\*5см орчим хэмжээтэй, олон тооны соронзон гүрийн талстууд юм. Эн илрэл нь цаашид судлах шаардлагатай үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий орд юм.

Алтай сумын Шилүүстийн уулын илрэлийн утаат болорын талстын хэмжээ нь 7-10см-с 30см хүртэл юм. 6.3м-с 2-3м хэмжээтэй 30пегматитын биет тогтоогдсон. Нийтдээ 40кг морион ба утаат болор авсан цаашид судлах илрэл юм. Манхан сумын Хойт Цэнхэрийн агуйн илрэл нь 10м орчим зузаантай ягаан гантигийн үе бүхий юм. Цаашид эрэл хайгуул хийх шаардлагатай Цэцэг сумын Баруун амны талькийн илрэл нь 10м урт, 0.1-0.25 м зузаантай үеллэг талькийн серпентин юм. Сийлбэр, гар урлалын зүйл хийхэд тохиромжтой. Оптикийн түүхий эдийн хувьд Ховд аймагт Алтай сумын Ошигийн усны орд, 1331м өндөрлөгийн орд, Цацын уулын илрэл, Шилүүстэйн илрэл, Булган сумын Уушигийн усны орд зэрэг илрэл ордууд тогтоогдсон бөгөөд цаашид судлах шаардлагатай. Ошигийн усны орд нь хэдэн зуун метр урт, 6-8м зузаантай пегматитын судлууд бүхий юм. Хэмжээ нь тодорхойгүй байгаа. С1+С2=6.3тн пьезокварцын 31322кг-г урьд нь авч ашигласан. Алтай сумын 1331м өндөрлөгийн орд нь 200-250м урт, 5-с 25-30м зузаантай линз хэлбэрийн судал, С1+С2=7421кг пьезокварц, С2=7.9тн кварц /1962-64онд/ 1030.0кг пьезокварц , 1.2тн кварц авч ашигласан томоохон орд юм.

Цацын уулын илрэл нь пегматит биеттэй холбоотой үүссэн биет нь бүслүүрлэг тогтоцтой 20\*30\*15-5м хэмжээтэй бөгөөд төвийн хэсгээр 5-7см хэмжээтэй болорын талстууд ургажээ. Болор нь 6 талт талст үүсгэх ба тунгалаг, хагас тунгалаг өнгөтэй ан цавтай. Тус аймагт Үенч сумын Улаан тогооч, Заяатын гэсэн 2 бал чулууны илрэл тогтоогдсон. Улаан тогоочийн илрэл нь 3-5м зузаан, 50-100буюу 120м урт бал чулуутай алевройн занарын үе. Бал чулуу 35-55%, цэнхэр 15-30%, серицит 20% эзэлдэг.

Заяатын илрэл нь 0.3-1.1м зузаан, 50-80м урттай бал чулууны үе юм. чулуулгийн 60% нь бал чулуу, 30% нь цахир, 5% нь серицит, 5% нь Fe<sub>2</sub>O<sub>3</sub> эзэлдэг. Мөст сумын Цагаан хоолойн тоосгоны шаврын илрэл нь орчин үеийн нуурын гаралтай саарал өнгийн жижиг хэмхдэс материал 10% агуулсан шавар бөгөөд орон нутагт ашиглах боломжтой. Эрдэнэ булган сумын II-1-2-р илрэл, Ховд сумын IV-2-5-илрэл, Дөргөн сумын УЫлаан Алагийн тоосгоны шаврын ордуудыг цааш судлах шаардлагатай.

Алтай сумын Алтайн орд нь 0.6-4 зузаантай, шаврын үе нь 200\*300 м талбайд тархсан цааш судалж нөөцийг өсгөх боломжтой юм. Шохойн чулууны нэлээд олон орд илрэлүүд байгаа бөгөөд Зэрэг сумын IX-30-Г-43 илрэл нь Шохойжингийн 150-200м өргөн, 4км урт гарш юм. Шохойжин нь цагаан , цагаан саарал, хөхөвтөр өнгөтэй, жижиг дунд ширэгтэй ба уулын цулын хэмжээ томтой, тектоник хагарал, ан цаваар бага хэрчигдсэн учир өнгөлөх ба шатааж түүхий шохой болгон хэрэглэх боломжтой.

### Баруун бүс нутгийн барилга материалын орд газрууд

Масштаб 1: 1 000 000

Зураг 8.3



- Хиллэх газар**
- А - В ОХУ
  - Б - В Хөвсгөл аймаг
  - В - Г Архангай аймаг
  - Г - Д Баянхонгор аймаг
  - Д - А БНХАУ

**ТАНИХ ТЭМДЭГ**

- |  |                           |                                      |
|--|---------------------------|--------------------------------------|
|  | Аймгийн төв               | 1. Элс, хайрга                       |
|  | Сумын төв                 | 2. Шавар, керамзит                   |
|  | Орон нутгийн хилийн боомт | 3. Барилгын чулуу, өнгөлгөөний чулуу |
|  | Улсын хил                 | 4. Төмөр                             |
|  | Аймгийн хил               | 5. Базальт                           |
|  | Сумын хил                 | 6. Будаг                             |
|  | Автомашинны гол зам       | 7. Цемент                            |
|  | Том гол                   | 8. Шохой                             |
|  | Дунд зэргийн гол          | 10. Гөлтгөнө                         |
|  | Ширгэдэг гол              | 11. Шилний түүхий эд                 |
|  | Нуур (цэнгэг)             | 12. Асбест                           |
|  | Нуур (давстай)            | 13. Гилс                             |

Үенч сумын 39-р илрэл нь 15-45м өргөн 10км урттай цахирын шохойн чулууны үе юм. Шохой үйлдвэрлэх зориулалтаар ашиглахад тохиромжтой. Ховд-1 орд нь 1-2км урт, 600м өргөн, 2м зузаан элс хайрганы хольц бүхий зузаан. 300маркийн хүнд бетон үйлдвэрлэхэд тохирно. Цаашид судалж нөөцийг өсгөх боломжтой. Буянтын орд нь 1.5км урт, 500-800м өргөн, 1.3-3.5м зузаан үетэй. Хайрга 41.77-72.12%, элс 22.88-38.23%. 300маркийн хүнд бетон үйлдвэрлэхэд тохирно.

Придорожные орд нь 200\*300м талбайд тархсан 0.6-0.9м зузаантай элсний давхарга. 300-400 маркийн бетон үйлдвэрлэхэд тохирно. Майхан уулын орд нь 10-40м зузаантай цайвар саарал, саарал өнгийн боржингийн дайк, ГОСТ8267-75-д тохирно. 200-300 маркийн хүнд бетон үйлдвэрлэхэд тохиромжтой юм.

Барилгын материалын шинээр байгуулах болон сэргээн өргөтгөх боломжтой үйлдвэрүүд:

- Ховд аймгийн Буян суманд хүнд бетоны үйлдвэр
- Увс аймгийн Зосийн хард шохойн түүхий эд олзворлох, боловсруулах
- Увс аймгийн Наранбулаг, Өмнөговь суманд тоосго болон Кирамикийн үйлдвэр
- Баян-Өлгий аймгийн Өлгий хотын орчинд хүнд, хөнгөн бетоны үйлдвэр
- Баян-Өлгий аймгийн Ямаатын ордыг өнгөлгөөний чулуун хавтанцарын үйлдвэр
- Алтай хотод цементийн үйлдвэр
- Говь-Алтай аймгийн Тайшир суманд хүнд, хөнгөн бетоны үйлдвэр
- Завхан аймгийн Алдархаанд технологийн нарийн элсээр өнгөлгөөний шавардлагын хуурай хольцын үйлдвэр зэрэг байж болно.
- Бүх аймагт урд нь байгуулсан барилгын материалын үйлдвэрүүдийг сэргээх
- Ховдын цементын техник технологийг шинэчилж цаашид хүчин чадлыг нь бүрэн авахуулан өргөтгөх.
- Баян-Өлгийн Буянтын будгын үйлдвэрийг сэргээх
- Бүх аймагт гантиг, баргилт, боржин, шохойн чулуу зэрэг зарим чулууг боловсруулж барилгад ашиглах.
- Баруун бүс нутагт барилгын төмөр бетон эдлэлээс эхлэн металл эдлэл хийх шаардлага их буйг харгалзан эн тэргүүнд Завхан аймагт төмөрлөгийн бэсрэг үйлдвэр байгуулах арга хэмжээ авах нь зүйтэй.

**8.4 ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ**

Зах зээлийн эдийн засагт шилжсэн он жилүүдэд манай орны Баруун бүсийн аймгуудын хүн ард өөрсдийн амьжиргаа, өдөр тутмын хэрэгцээгээ хангахын тулд мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийг арилжаалах төдийхнээр амьдралаа зогоож байна.

Төр, засгийн зүгээс жижиг дунд бизнесийг хөгжүүлэх талаар арга хэмжээнүүдийг төлөвлөж байгаа боловч төдийлэн үр дүнд хүрсэнгүй, ажилгүйдлийн төвшин өндөр хэмжээнд хүрсэн байна. Цаашид Баруун бүсийг үйлдвэржүүлэх явдал нь бусад бүсийн хөгжлөөс хоцрохгүй байх, ажилгүйдлийг бууруулж, амьдралын түвшинг дээшлүүлэх нэг гол нөхцөл болно. Улсын хэмжээнд ажилгүйдлийн төвшин 2.8, хүний хөгжлийн индекс 0.718 байхад Баруун бүсэд хүний хөгжлийн индекс 0.676, ажилгүйдлийн төвшин 4.8 хувь, амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур орлоготой айл өрх олон байна.

**Аймгуудын хүний хөгжлийн индекс, ажилгүйдлийн түвшин /Хүснэгт 8.1/**

| Аймгийн нэр   | Хүний хөгжлийн индекс | Аймгууд дунд эзэлж буй байр | Ажилгүйдлийн түвшин |
|---------------|-----------------------|-----------------------------|---------------------|
| Улсын дундаж  | 0.718                 |                             | 2.8                 |
| Баян-Өлгий    | 0.690                 | 8                           | 6.4                 |
| Ховд          | 0.686                 | 11                          | 4.0                 |
| Завхан        | 0.676                 | 14                          | 4.5                 |
| Увс           | 0.672                 | 16                          | 5.5                 |
| Говь-Алтай    | 0.657                 | 20                          | 3.4                 |
| Бүсийн дундаж | 0.676                 |                             | 4.8                 |

Баруун бүсийн аймгуудаас Баян-Өлгий аймаг ажилгүйдлийн төвшнөөр улсын хэмжээнд хамгийн өндөр 6.4 хувьтай, Ховд, Завхан, Увс, Говь-Алтайд 3.4-5.5 хувь байна. Тус бүсийн хөдөлмөрийн насны хүн амын дийлэнх нь хөдөлмөр эрхлэхгүй байгаагийн улмаас ажилгүйдэл дагасан ядуурал буурахгүй байгаа юм. Дээрх аймгуудад гурил, гурилан бүтээгдэхүүн, архи, ундаа, зайрмаг, барилгын материал, худалдаа, нийтийн хоолны жижиг нэгж, цехүүд ажиллаж байгааг эс тооцвол томоохон үйлдвэрлэл цөөн байна. Иймээс аймаг, сумын хэрэгцээг хангахын тулд хөдөөгийн үйлдвэржүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлж, жижиг дунд, үйлдвэрүүдийг хөгжүүлэх...”, “Бренд” бүтээгдэхүүнийг тодруулан сурталчилах

үзэсгэлэн худалдааг тогтмол зохион байгуулж, тэдний үйл ажиллагаа, зах зээлийг нь өсгөх, түншийн холбоог тогтоох, бүтээгдэхүүнээ сурталчилахад нь орон нутгийн зүгээс дэмжлэг, санхүүгийн туслалцаа үзүүлэх шаардлагатай байна. Цаашдаа Баруун бүсийн аймгуудад үйлдвэржүүлэлтийн бодлого доорх төрөл, чиглэлүүдээр хэрэгжих боломжтой юм. Үүнд:

1. Аймаг, бүс нутгийн зах зээлд баримжаалсан, тэдгээрийн тэлэлт, гүнзгийрэлт, төрөлжилтийг хангахад чиглэгдсэн, аймгуудын газрын дээрх болон доорх нөөц, боломжид суурилсан, үндсэн хэрэгцээг хангах, тодорхой хэмжээгээр импортыг орлох, экспортын баримжаатай хөдөөгийн үйлдвэржүүлэлт нь их төлөв жижиг, дунд үйлдвэрлэл байна.

2. Хөдөө орон нутгийн иргэдийн үндсэн хэрэгцээг хангах, мал аж ахуй, газар тариалангийн анхдагч бүтээгдэхүүн, нэмэгдсэн өртөг үйлдвэрлэх чиглэлтэй, өрхийн болон бичил аж ахуй дээр суурилсан “бичил үйлдвэржүүлэлт”.

3. Өргөн хэрэгцээний түүний дотор удаан хэрэглээний бүтээгдэхүүн, тодорхой салбаруудын эцсийн бүтээгдэхүүн болон завсрын бүтээгдэхүүн, зарим капитал багтаамж ихтэй бүтээгдэхүүн зэргийн импортыг орлох, импорттой өрсөлдөх үйлдвэржүүлэлт.

4. Органик хөдөө аж ахуй, цэвэр байгаль орчны хосолсон хөгжил дээр үүссэн, цэвэр бүтээгдэхүүн, мэдээллийн технологийн outsourcing дээр түшиглэсэн экспортын диверсифицац, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үе шат бүр дээр суурилсан бүтээгдэхүүний хөгжлийн үндсэн дээр бий болох уламжлалт бус, шинэ бүтээгдэхүүний экспортын баримжаатай үйлдвэржүүлэлт /уламжлалт экспортын зах зээлийн өргөжилт болон өртөг нэмж бүтээх үйл явц зэрэгцэн явагдана/.

5. Аялал жуулчлалын сектор дахь нэмэгдсэн өртөг бүтээх үйл явц, үйлчилгээний секторын орчин үеийн технологи дээр суурилсан, энэ секторын улирлын шинж чанарыг хамгийн бага болгоход чиглэгдсэн аялал жуулчлалын үйлдвэржүүлэлт.

6. Эрдэс баялгийн салбарын анхдагч бүтээгдэхүүний эцсийн боловсруулалт, стратегийн том ордуудын ашиглалт, био-, нано-, hitech дээр суурилсан хөгжих капиталын болон мэдлэгийн багтаамж ихтэй үйлдвэржүүлэлт.

7. Гадаадын орнуудад ажиллаж амьдарч байгаа монголчуудынхаа, ялангуяа үйлдвэржүүлэлтийг амжилттай хэрэгжүүлсэн улс орнуудад ажиллаж буй монголчуудынхаа мэдлэг, мэргэжил, туршлага, дадлагыг ашиглах үндсэн дээр тэдэнд зориулсан аж үйлдвэрийн тусгай парк байгуулах замаар хэрэгжүүлж болох үйлдвэржүүлэлт.

Аймгуудад явуулсан судалгааны дүнгээс үзэхэд дараах чиглэлийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх боломжтой юм. Үүнд:

1. Ноос ноолуур боловсруулах үйлдвэр
2. Ангийн үс, үслэг эдлэлийн үйлдвэр
3. Арьс шир боловсруулах үйлдвэр
4. Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр
5. Мах боловсруулах үйлдвэр (Нядалгааны цех)
6. Талх нарийн боовны үйлдвэр
7. Жимс жимсгэний аж ахуй
8. Цэвэр ус, рашаан савлах үйлдвэр
9. Гурилын үйлдвэр, арвайн гурилын үйлдвэр
10. Хөргөлтийн зоорь /ногооны болон махны зоорь/
11. Оёмол сүлжмэлийн үйдвэр
12. Эсгий, эсгий гутлын үйлдвэр
13. Яс боловсруулах үйлдвэр
14. Мод боловсруулах үйлдвэр
15. Шахмал түлшний үйлдвэр
16. Барилгын дээвэр, ханын материалын үйлдвэр
17. Цемент шохойн үйлдвэрлэл
18. Чулуу боловсруулах үйлдвэр (Чулуун давс боловсруулах үйлдвэр)
21. Шилний үйлдвэр
22. Малын тэжээлийн үйлдвэр
23. Эмийн ургамал боловсруулах, хүлэмжинд тариалах үйлдвэр
24. Махны чиглэлийн үхрийн ферм
25. Сүүний чиглэлийн үнээний ферм
26. Туслах аж ахуй /гахай, шувуу/
27. Зөгийн аж ахуй
28. Хогийг ангилан ялгаж боловсруулах үйлдвэр
29. Хүнсний ногоо боловсруулах үйлдвэр
30. Жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэр
31. Ариун цэврийн цаас салфетканы үйлдвэр
32. Угаалгын нунтаг савангийн үйлдвэр
33. Хэвлэлийн үйлдвэр

34. Сав баглаа боодлын үйлдвэр

35. Хаягдал гялгар уут, хуванцар дахин боловсруулах үйлдвэр

Баруун бүсийн аймгууд нь Орос, Хятад улстай хилийн боомтоор дамжин зорчих, худалдаа, үйлдвэрлэл явуулах боломжтой учраас хөнгөн аж үйлдвэрлэл хөгжүүлэх давуу нөхцөл гэж үзэх үндэстэй.

Баруун бүсэд нэг хүнд ноогдох аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 28.4 мянган төгрөг байгаа нь бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн бага байгаа бөгөөд улсын дунджаас 16.4 дахин, Улаанбаатарынхаас 22.9 дахин, Хангайн бүсийнхээс 28.3 дахин бага байна.

Энэ бүс нутагт аж үйлдвэрийн салбар, түүний дотор жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ хэт сул хөгжсөн юм. Арьс шир, ноос ноолуур, мах, сүү зэрэг мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах хөнгөн, хүнсний үйлдвэрүүд нь түүхий эдээ худалдан авах бэлэн мөнгө, эргэлтийн хөрөнгөний хуримтлалгүй, банкны зээлийн хүү өндөр, бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах, өрсөлдөх чадвар хомс зэргээс шалтгаалан үйлдвэрлэл дорвитой өсөж чадахгүй байна. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулалгүй экспортлох явдал давамгайлж байна.

Махны үйлдвэрлэлтэй уялдуулан арьс ширийг стандартын дагуу ангилан бэлтгэх, энэ үндсэн дээр арьс, ширэн болон савхин эдлэл, гутал, хувцас, тоноглол хэрэглэлийн үйлдвэрлэлийг өргөтгөн хөгжүүлэх, ноос, ноолууранд анхан шатны болон үйлдвэрийн боловсруулалт хийж, дотоодын хэрэгцээг хангахын сацуу экспортын баримжаатай үйлдвэрүүдийг хөгжүүлэх шаардлагатай байна.

Мах, ноос, ноолуур, арьс шир зэрэг түүхий эдийг боловсруулан бүтээгдэхүүний үйлдвэрийг доорхи аймгуудад байгуулна. Үүнд

- |                                     |                                     |
|-------------------------------------|-------------------------------------|
| 1. Мах, сүүний үйлдвэрийг           | • Говь-Алтай                        |
| • Баян-Өлгий                        | 4. Ноолууран эдлэлийн үйлдвэрийг    |
| • Ховд                              | • Ховд                              |
| • Увс                               | • Баян-өлгий                        |
| • Говь-Алтай                        | • Увс                               |
| • Завхан                            | • Завхан                            |
| 2. Ноосон эдлэлийн үйлдвэрийг       | • Говь-Алтай                        |
| • Завхан                            | 5. Гар хивсний үйлдвэрийг           |
| • Баян-Өлгий                        | • Баян-өлгий                        |
| • Увс                               | • Говь-Алтай                        |
| • Ховд                              | 6. Арьс ширэн эдлэл, гутлын үйлдвэр |
| • Говь-Алтай                        | - Алтай                             |
| 3. Арьс шир боловсруулах үйлдвэрийг | - Өлгий                             |
| • Завхан                            |                                     |
| • Ховд                              |                                     |
| • Баян-өлгий                        |                                     |
| • Увс                               |                                     |

Баруун бүс нутагт аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх түүхий эдийн нөөц харьцангуй их бий. Тухайлбал, экспортлох боломжтой улсын нийт махны 23.3 хувь тус бүсэд ноогдож байгаа бөгөөд энэхүү үзүүлэлтээр Хангайн бүсийн /37.5 хувь/ дараа орж байна. Иймд махны чиглэлийн жижиг, дунд үйлдвэрүүдийг байгуулж хөгжүүлэх замаар махны экспортын орлогыг нэмэгдүүлэх боломжтой. Мөн хонь, ямааны ноос, ноолуур бэлтгэлийн чадавхийн хувьд баруун бүс нь улсад тэргүүлдэг бөгөөд улсын нийт хонины ноос бэлтгэлийн 30.4 хувийг, ямааны ноолуурын 33.8 хувийг, тэмээний ноосны 27.3 хувийг адуу, үхрийн хөөврийн 18.4 хувийг тус тус бэлтгэх чадавхитай байна.

Аймгийн төв, томоохон суурин газарт хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах зориулалт үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчлэх, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах эдийн засаг, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх зэрэг арга хэмжээ авах шаардлага их байна.

Бүх аймаг суманд нийтийн аж ахуйн үйлчилгээг төрөл бүрээр нь сэргээж ажиллуулах. Ховд, Улиастай дахь авто засварын газруудыг сэргээж зарим төрлийн техникийг засварлах, угсрах ажлыг хийдэг болгох хэрэгтэй. Аймаг сумууд дахь ахуй үйлчилгээний салбаруудыг сэргээж өргөтгөн хөгжүүлэх арга хэмжээг авах шаардлагатай. Мөн бүс нутгын амьдралын онцлогыг харгалзан бүс нутгийн болон



БАРУУН БҮСИЙН ҮЙЛДВЭРЖИЛТИЙН ЗУРАГ



Зураг 8,4

аймгийн хэрэгцээг хангах улмаар зарим бүтээгдэхүүийг экспортлох зорилготой хөнгөн хүнсний үйлдвэрийг хөгжүүлэхэд илүү анхаарвал зохино. Жишээлбэл: Өлгий хотод гар хивсний томоохон үйлдвэр байгуулан 300 шахам хүнийг ажиллуулан бүтээгдэхүүнээ Казакстанд гаргаж байсан байна. Иймд бүсийн аймгийн төвүүдэд үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, өргөтгөх чиглэлээр үйл ажиллагааг идэвхжүүлэх шаардлагатай.

### **Баруун бүсийн аймаг бүрээр хөгжүүлэх боломжтой жижиг дунд үйлдвэрүүд**

#### Баян-Өлгий

- Казны үйлдвэр
- Махны эрчимжсэн аж ахуй
- Загасны үйлдвэр
- Оёдлын үйлдвэр
- Тоосго, блокны үйлдвэр
- Талх, нарийн боовны үйлдвэр
- Сүү боловсруулах үйлдвэр
- Тэжээлийн үйлдвэр

#### Говь-Алтай

- Махны боловсруулалтын анхан шатны үйлдвэр
- Махны эрчимжсэн аж ахуй
- Сүүний эрчимжсэн аж ахуй
- Сүү боловсруулах үйлдвэр
- Жимс жимсгэний аж ахуй
- Загасны аж ахуй
- Тэжээлийн аж ахуй
- Тэжээлийн цех
- Талх нарийн боовны үйлдвэр
- Ноос боловсруулах үйлдвэр
- Хивсний үйлдвэр

#### Завхан

- Сүү боловсруулах үйлдвэр
- Сүүний хөргөлтийн үйлдвэр
- Сүүний эрчимжсэн аж ахуй
- Тэжээлийн аж ахуй
- Тэжээлийн цех
- Жимс, жимсгэний аж ахуй
- Талх нарийн боовны үйлдвэр
- Ноос боловсруулах үйлдвэр
- Эсгий эдлэлийн үйлдвэр
- Оёдлын үйлдвэр
- Хүлэмжийн аж ахуй

#### Увс

- Махны эрчимжсэн аж ахуй
- Сүүний эрчимжсэн аж ахуй
- Сүү боловсруулах үйлдвэр
- Сүүний хөргөлтийн төв
- Жимс, жимсгэний аж ахуй
- Хүлэмжийн аж ахуй
- Тэжээлийн үйлдвэр
- Тэжээлийн аж ахуй
- Талх нарийн боовны үйлдвэр
- Зөгийний аж ахуй
- Давсны үйлдвэр
- Тоосгоны үйлдвэр
- Мод боловсруулах
- Мужааны цех
- Түлшний үйлдвэр

#### Ховд

- Усалгаатай газар тариалан
- Чулуу боловсруулах үйлдвэр
- Ханын материалын үйлдвэр
- Загасны аж ахуй
- Загасны мах боловсруулах
- Талх нарийн боовны үйлдвэр
- Жимс жимсгэний аж ахуй
- Гурилын үйлдвэр
- Тэжээлийн цех
- Тэжээлийн аж ахуй
- Сүү, мах боловсруулах үйлдвэр

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- Жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалттай импортоор оруулах техник, тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх саналыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх;
- Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг жижиг, дунд үйлдвэрийн импортолж байгаа үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн болон туслах материалыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх саналыг Засгийн газарт шийдвэрлүүлэх;
- Бүсийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих “Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан” байгуулж ажиллуулахыг дэмжих ;
- Сангийн яам, Монгол банк, арилжааны банкуудтай хамтран ажиллаж жижиг, дунд үйлдвэрт зориулан бага хүүтэй, урт хугацааны арилжааны зээлийн эх үүсвэрийг бий болгох, нэмж олох арга хэмжээ авах;
- Улсын болон орон нутгийн захиалгаар санхүүжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд жижиг, дунд үйлдвэрийг түлхүү хамруулах бодлого баримтлах;
- Ховд, Улиастай хотод холимог үйлдвэрлэлийн “Ховд”, “Улиастай”, “Улаангом” үйлдвэрлэл,

технологийн парк байгуулах

- Орон нутгийн туршлагыг харгалзан аймгийн төвүүдэд эсгий, эсгий гутал, ноос угаах төрөлжсөн болон хоршсон үйлдвэрлэлийг өргөтгөн хөгжүүлэх;
- Бүсийн тулгуур төв, аймгийн төвд гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, загас, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо боловсруулж савлах, Алтайн бренди хөх арвайн гурил үйлдвэрлэх, рашаан, ингэний сүү савлах хүнсний үйлдвэрийг байгуулан ажиллуулах;
- Сүү, сүүн бүтээгдэхүүн гаргах, мах боловсруулах үйлдвэрүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлж, төрөлжүүлэн савласан мах, махан ба сүүн бүтээгдэхүүн экспортлохыг дэмжих;
- Малын арьс, шир, ноос ноолуур зэрэг түүхий эдийг боловсруулж гутал, ауге, нэхий эдлэл, эсгий, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөнгөн үйлдвэрийн салбарын жижиг, дунд үйлдвэрүүдийг бүсийн аймгуудад шинээр байгуулахыг дэмжих;
- Бөөний худалдааны сүлжээг бүх аймагт бий болгон, энэ сүлжээнд хамрагдах сум, аж ахуйн нэгж, иргэдийн тоог нэмэгдүүлэх;
- Худалдаа, үйлчилгээний захуудыг төрөлжүүлж, хүнсний бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан битүү байртай болгон орчныг тохижуулах арга хэмжээ авах;
- Баян-Өлгий Цагааннуурын худалдааны чөлөөт бүсийг нээн ажиллуулах ажлыг зохион байгуулах;
- Бургастай, Тэс /Завхан/ Ярант, Хангайтын хилийн боомтыг түшиглэн худалдааны чөлөөт бүс байгуулах;
- Бургастай, Боршоо, Арцсуурь зэрэг хилийн гарц, боомтуудыг материаллаг бааз, мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлж, байнгын ажиллагаатай олон улсын чанартай болгон, хилийн худалдаа, үйлчилгээг шуурхай болгох арга хэмжээ авах;

### 8.5 ХӨДӨӨ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

#### 8.5.1 Газар тариалангийн хөгжлийн төлөвлөлт

Баруун бүс нь усан сан бүхий газар ихтэй бөгөөд улсын бүх ус усан сан бүхий газрын 40.6 хувь нь энд бий. Баруун бүс нь буюу Монгол Улсын бүх нуур тойрмын талбайн 60-аад хувийг эзэлдэг. Гол мөрний усан доорх талбайн 40-өөд хувь, мөнх цас мөсөн голын доорх талбайн ихэнх нь энэ бүсэд оршдог тул усалгаатай тариалан хөгжүүлэх боломжтой.

Эдийн засгийн баруун бүсийн газрын санд хөдөө аж ахуйн газар зонхилж 71.2 хувь, тусгай хэрэгцээний газар 22.1 хувь, ойн сан бүхий газар 5.6 хувь, бусад зориулалтын газар 0.2-0.7 хувь эзэлдэг.

Баруун бүсийн газрын хэмжээ (га), бүтэц, 2007 /Хүснэгт 8.2/

|                          | Улсын дүн | Дүнд эзлэх хувь | Баруун бүс | Дүнд эзлэх хувь | Улсын дүнд Баруун бүсийн эзлэх хувь |
|--------------------------|-----------|-----------------|------------|-----------------|-------------------------------------|
| Нийт нутаг дэвсгэр       | 156411575 | 100.0           | 41525398   | 100.0           | 26.5                                |
| Хөдөө аж ахуйн газар     | 116037609 | 74.2            | 29570249   | 71.2            | 25.5                                |
| Хот, суурин              | 489833    | 0.3             | 95748      | 0.2             | 19.5                                |
| Зам, шугам сүлжээ        | 359235    | 0.2             | 91991      | 0.2             | 25.6                                |
| Ойн сан                  | 14299449  | 9.1             | 2309631    | 5.6             | 16.2                                |
| Усан сан                 | 666091    | 0.4             | 270537     | 0.7             | 40.6                                |
| Тусгай хэрэгцээний газар | 24559358  | 15.7            | 9187244    | 22.1            | 37.4                                |

Баруун бүсийн аймгуудын газрын хэмжээ, га, 2007 /Хүснэгт 8.3/

| Аймаг      | Нийт нутаг дэвсгэр | Дүнд эзлэх хувь |
|------------|--------------------|-----------------|
| Баян-Өлгий | 4570489            | 11.0            |
| Говь-Алтай | 14144767           | 34.1            |
| Завхан     | 8245566            | 19.9            |
| Увс        | 6958539            | 16.8            |
| Ховд       | 7606038            | 18.3            |
| ДҮН        | 41525398           | 100.0           |

Бүсийн нийт нутаг дэвсгэрийн 93.3 хувь нь бэлчээр ба бэлчээрт ашигладаг тусгай хэрэгцээний газар байна. Баруун бүсэд бэлчээр ашиглалт, түүний нөөц, үнэлгээг тогтоох, бэлчээрийн даацыг сум нэг бүрээр газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөнө гаргаж хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа юм.. Баруун бүс нь мал аж ахуйн гол бүсүүдийн нэг юм. Дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 70 гаруй

хувийг мал аж ахуйн салбараас үйлдвэрлэдэг. Иймээс нийгэм-эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад бэлчээр, тэжээлийн хангамжид ихээхэн анхаарах, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг дахин боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг дэмжих чиглэлд анхаарах нь нэн чухал болно.

Баруун бүсийн хөдөө аж ахуйн газрын сан, 2007 /Хүснэгт 8.4/

| Аймгийн нэр | Нийт нутаг дэвсгэр /мян.га/ | Хөдөө аж ахуйн газар |         |        |                    |                  |               |                   |                 |                |                                   |                                   |
|-------------|-----------------------------|----------------------|---------|--------|--------------------|------------------|---------------|-------------------|-----------------|----------------|-----------------------------------|-----------------------------------|
|             |                             | Бүгд                 | Үүнээс  |        |                    |                  |               |                   |                 |                |                                   |                                   |
|             |                             |                      | Бэлчээр | Хадлан | Тариалангийн газар | Үүний дотор      |               |                   |                 | Атаржсан газар | ХАА-н барилга байгууламжийн газар | ХАА-н хэрэгцээнд тохирохгүй газар |
|             |                             |                      |         |        |                    | Тариалсан талбай | Жимс жимсгэнэ | Уриншилсан талбай | Өнжөөсөн талбай |                |                                   |                                   |
| Баян-Өлгий  | 4570,5                      | 3468,2               | 3453,0  | 13,5   | 0,7                | 0,5              | 0,0           | 0,0               | 0,1             | 0,3            | 0,7                               | 0,0                               |
| Говь-Алтай  | 14144,8                     | 8828,1               | 8818,6  | 2,3    | 3,6                | 1,6              | 0,1           | 0,0               | 1,9             | 1,9            | 1,7                               | 0,0                               |
| Завхан      | 8245,6                      | 7062,0               | 6986,4  | 7,8    | 1,3                | 1,0              | 0,0           | 0,1               | 0,2             | 62,2           | 4,4                               | 0,0                               |
| Увс         | 6958,5                      | 4998,1               | 4485,7  | 16,2   | 9,5                | 2,0              | 0,8           | 0,0               | 6,7             | 35,8           | 4,3                               | 446,7                             |
| Ховд        | 7606,0                      | 5213,8               | 5189,3  | 17,6   | 2,8                | 2,7              | 0,1           | 0,0               | 0,0             | 2,8            | 1,5                               | 0,0                               |
| ДҮН         | 41525,4                     | 29570,2              | 28932,9 | 57,2   | 17,8               | 7,8              | 0,9           | 0,1               | 9,0             | 103,0          | 12,6                              | 446,7                             |

1980-аад оны сүүлч гэхэд Баруун бүсэд 123 мянган га газрыг тариалангийн эргэлтэнд оруулан ашиглаж байсан байна. 1990 онд энэ бүсэд 15.2 мян. га газар услах хүчин чадалтай 40 гаруй услалтын систем ажиллаж байсныг сэргээн ашиглалтанд оруулахаар төлөвлөж байна.

Баруун бүсийн аймгуудын усалгаатай тариалангийн газрууд хөрсний чанар сайн, дулааны хангамжаар нэн тааламжтай нөхцөлтэй тул өрхийн тариалан эрхлэх, чийг-дулааны өндөр хангамж шаарддаг жимс, жимсгэнэ ба тосны ургамал, эмийн ба ховор ургамал тариалах боломжтой.

2007 оны байдлаар тус бүсэд 120.8 мянган га тариалангийн эргэлтийн талбай тоологдсоны 103.0 мянган га нь атаржсан байна. Атаржсан газрын ихэнх нь Завханы Тэс, Асгат, Тэлмэн, Увсын Баруунтуруун суманд байна.

Бүсийн дүнгээр 2007 онд 7.8 мянган га-д тариалж (2.8 мянган га-д үр тариа, 4.2 мянган га-д төмс, хүнсний ногоо, 0.8 мянган га-д тэжээлийн ургамал, 0.9 мянган га-д чацаргана ба бусад жимс, жимсгэнэ), 0.1 мянган га-г уриншилж, 9.0 мянган га-г түр өнжөөсөн байна. Тариалсан талбайн ихэнх нь Ховдын Ховд, Булган, Буянт, Увсын Баруунтуруун, Улаангом, Тариалан, Сагил, Говь-Алтайн Цогт, Дэлгэр, Халиун сумдад, жимс жимсгэний талбайн ихэнх нь Увсын Улаангом суманд байна.

Баруун бүсийн сумдын 2008 онд тариалсан талбай, га /Хүснэгт 8.5/

|            | Сумын нэр  | Үр тариа | Төмс, хүнсний ногоо | Тэжээлийн ургамал | Чацаргана, жимс жимсгэнэ | Өнжөөсөн талбай | Атаржсан талбай |
|------------|------------|----------|---------------------|-------------------|--------------------------|-----------------|-----------------|
| Баян-Өлгий | Алтай      |          |                     |                   |                          |                 |                 |
|            | Алтанцөгц  |          | 85                  | 2                 |                          |                 | 180             |
|            | Баяннуур   |          | 170                 | 100               | 8                        | 48              | 84              |
|            | Бугат      |          | 4                   | 8                 |                          |                 | 17              |
|            | Булган     | 9        | 46                  | 16                |                          |                 |                 |
|            | Буянт      |          | 0                   | 0                 |                          |                 |                 |
|            | Дэлүүн     |          | 1                   | 1                 |                          |                 |                 |
|            | Ногооннуур |          |                     | 12                | 10                       |                 | 78              |
|            | Сагсай     |          |                     | 51                | 3                        |                 | 45              |
|            | Толбо      |          |                     | 2                 | 9                        |                 | 9               |
|            | Улаанхус   |          |                     | 5                 | 2                        |                 |                 |
|            | Цэнгэл     |          |                     | 4                 |                          |                 | 3               |
|            | Дүн        | 9        | 380                 | 150               | 8                        | 138             | 326             |
| Говь-Алтай | Алтай      |          | 9                   |                   | 3                        |                 |                 |
|            | Баян-уул   |          |                     |                   |                          |                 |                 |
|            | Бигэр      | 5        | 8                   | 27                | 20                       | 6               | 161             |
|            | Бугат      | 36       | 16                  | 115               |                          | 35              | 378             |
|            | Дарви      |          |                     |                   |                          | 2               | 133             |
|            | Дэлгэр     | 131      | 25                  | 15                |                          | 829             | 1017            |
|            | Есөнбулаг  |          | 14                  |                   |                          | 25              |                 |

|        |               |      |     |     |     |      |       |
|--------|---------------|------|-----|-----|-----|------|-------|
|        | Жаргалан      | 0    | 10  | 27  |     | 102  |       |
|        | Тайшир        | 11   | 14  | 11  |     | 52   | 98    |
|        | Тонхил        |      | 2   |     |     |      |       |
|        | Төгрөг        | 21   | 14  |     |     |      |       |
|        | Халиун        | 145  | 5   | 31  | 35  | 155  |       |
|        | Хөхморьт      |      |     |     |     |      |       |
|        | Цогт          | 670  | 46  | 10  | 7   | 143  |       |
|        | Цээл          |      | 5   |     |     | 4    |       |
|        | Чандмана      | 68   | 38  | 3   |     | 119  |       |
|        | Шарга         | 40   | 34  |     |     | 462  | 141   |
|        | Эрдэнэ        |      | 4   |     |     |      | 13    |
|        | Дүн           | 1127 | 244 | 238 | 65  | 1934 | 1941  |
| Завхан | Алдархаан     |      | 126 |     |     |      | 1572  |
|        | Асгат         |      | 3   |     |     |      | 17974 |
|        | Баянхайрхан   |      | 12  |     |     |      | 1334  |
|        | Баянтэс       |      | 20  |     |     |      | 2365  |
|        | Дөрвөлжин     |      | 2   |     |     |      | 8     |
|        | Завханмандал  |      | 1   |     |     |      | 0     |
|        | Идэр          |      | 10  |     |     |      | 0     |
|        | Их уул        |      | 5   |     |     |      |       |
|        | Нөмрөг        |      | 35  | 40  |     |      | 974   |
|        | Отгон         |      | 2   |     |     |      | 381   |
|        | Сантмаргац    |      | 17  |     |     |      | 974   |
|        | Сонгино       |      | 29  |     |     | 2    | 1465  |
|        | Түдэвтэй      |      | 350 |     |     |      | 974   |
|        | Тэлмэн        |      | 19  | 102 |     | 227  | 4053  |
|        | Тэс           |      | 22  |     |     |      | 26188 |
|        | Тосонцэнгэл   |      | 8   |     |     |      | 879   |
|        | Ургамал       |      | 3   |     |     |      | 4     |
|        | Улиастай      |      | 5   |     |     |      |       |
|        | Цагаанхайрхан |      | 4   |     |     |      | 650   |
|        | Цагаанчулуут  |      | 10  |     |     |      | 791   |
|        | Цэцэн-уул     |      | 10  |     |     |      | 601   |
|        | Шилүүстэй     |      | 10  |     |     |      | 1007  |
|        | Эрдэнэхайрхан |      | 62  |     |     |      |       |
|        | Яруу          |      | 50  | 45  |     |      |       |
|        | Дүн           |      | 815 | 187 |     | 229  | 62193 |
| Увс    | Баруунтуруун  | 635  | 38  | 128 |     | 4656 | 31977 |
|        | Бөхмөрөн      |      | 6   |     |     |      | 3     |
|        | Давст         |      | 5   |     | 1   | 142  | 958   |
|        | Завхан        |      |     |     |     | 1    |       |
|        | Зүүнговь      |      | 5   |     |     |      | 135   |
|        | Зүүнхангай    |      | 8   |     |     |      | 7     |
|        | Малчин        | 34   | 11  |     |     |      | 10    |
|        | Наранбулаг    | 140  | 8   |     | 30  |      | 30    |
|        | Өлгий         |      | 2   |     |     | 12   | 80    |
|        | Өмнөговь      |      | 9   |     |     |      |       |
|        | Өндөрхангай   |      | 4   |     |     |      | 25    |
|        | Сагил         | 219  | 7   |     | 1   | 458  | 53    |
|        | Тариалан      | 258  | 29  |     | 2   | 1062 | 1230  |
|        | Түргэн        | 97   | 9   |     | 42  | 161  | 399   |
|        | Тэс           |      | 2   |     | 60  |      | 61    |
|        | Ховд          |      | 8   | 4   |     |      |       |
|        | Хяргас        |      | 2   | 1   | 1   | 1    | 444   |
|        | Цагаанхайрхан |      | 5   |     |     | 22   |       |
|        | Улаангом      |      | 314 |     | 634 | 209  | 389   |
|        | Дүн           | 1383 | 469 | 133 | 770 | 6723 | 35801 |
| Ховд   | Алтай         | 17   | 31  |     |     |      | 230   |
|        | Булган        | 141  | 552 | 32  | 8   |      | 1037  |
|        | Буянт         |      | 297 | 33  | 4   |      | 19    |
|        | Дарви         | 90   | 13  | 4   |     |      | 418   |
|        | Дөргөн        |      |     |     |     |      |       |
|        | Дуут          |      | 20  |     |     |      |       |
|        | Зэрэг         |      | 6   |     |     |      | 46    |
|        | Манхан        | 8    | 184 | 10  | 41  |      | 385   |

|             |      |      |     |     |      |        |
|-------------|------|------|-----|-----|------|--------|
| Мянгад      |      |      |     |     |      |        |
| Мөст        |      | 19   |     |     |      | 200    |
| Мөнххайрхан |      |      |     |     |      |        |
| Үенч        | 31   | 99   | 8   | 13  |      |        |
| Ховд        | 8    | 984  | 16  | 41  |      | 338    |
| Цэцэг       |      |      |     |     |      |        |
| Чандмань    |      | 24   |     |     |      | 100    |
| Эрдэнэбүрэн | 10   | 14   | 10  |     |      | 8      |
| Жаргалант   |      |      |     |     |      | 0      |
| Дүн         | 305  | 2243 | 112 | 106 |      | 2782   |
| Бүсийн дүн  | 2824 | 4151 | 820 | 949 | 9024 | 103043 |

Ховд аймагт 1991 оноос өмнө 5679 га хүчин чадал бүхий инженерийн хийцтэй услалтын систем баригдаж ашиглалтанд орсноос одоо Хойд голын 100 га талбайг ашигладаг. Мөн 2500 га талбай бүхий 20 энгийн хийцтэй услалтын систем ажилладаг. Булган, Манхан, Буянт сумдад жимсний цэцэрлэг байгуулсан. Цаашид Алтай сумын Боомын ам, Зэрэг сумын Цагаан бургас, Манхан сумын Улаан хүрэн дахь услалтын системүүдийг засварлах шаардлагатай.

Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын Хар үзүүрийн услалтын системийн 60 гаруй га, Цэнгэл сумын Харганатын услалтын системийн 80 орчим га, Улаанхус сумын Согоогийн услалтын системийн 100 орчим га, Өлгий сумын Их булангийн услалтын системд олон наст тариалж хадлангийн зориулалтаар ашиглаж байна.

Бүсийн нутаг дэвсгэр дэх гол, горхиудын хаврын шар усны үерийн усыг хуримтлуулах замаар нөөцөлж, усалгаатай тариаланд ашиглах, хадлангийн талбайнуудыг тордож сайжруулахад ашиглах өргөн боломжтой.

Эдийн засгийн Баруун бүс бусад бүсүүдийг бодвол хадлангийн газрын нөөцөөр бага, улсын нийт хадлангийн газрын дөнгөж 3.1 хувь нь энэ бүсэд байдаг. Энэ бүсийн хадлангийн газраас жил бүрийн хадалт, өнжөөлт, сэлгээний илтгэлцүүрийг бодолцон үзвэл жилд 100 шахам мянган тонн хадлан бэлдэх боломжтой гэсэн тооцоо бий. Хадлангийн газрын нөөцийг өсгөх ганц арга зам нь томоохон голуудын хөндий тэдгээрийн цутгал орчмын намгархаг, доворхог нугыг үндсэн болон тордон сайжруулалтын аргаар өөрчлөн арвин ургацтай хадлан буй болгох явдал юм.

Хөдөө аж ахуйн газрын ангилалд байгаа бэлчээр дээр тусгай хэрэгцээний бэлчээрт ашигладаг газар, ойн бэлчээрийг нэмэхэд Баруун бүсийн нутгийн 99 хувь нь байгалийн бэлчээр юм. Бэлчээрийн тархалт байршлын газарзүйн онцлог нь хээр, цөлөрхөг хээр, цөлийн бүсийн бэлчээрээс гадна уулын ойн хээр, өндөр уулын хээр, уулын цөлөрхөг хээрийн бэлчээр жигд тарсан явдал юм. Бэлчээрийн жилийн дундаж ургац зун–намар ба өвөл–хаврын улирлаар 3.1–2.04 ц/га байгаа бөгөөд Говь – Алтай аймагт энэ үзүүлэлт 2.3–1.4 ц/га байна. Энэ бүсийн бэлчээрийн нэг кг өвс 0.60–0.68 кг тэжээлийн нэгж агуулж байгаа нь бэлчээрийн өвс ногооны шимт чанар харьцангуй сайн гэсэн үг юм.

Энэ бүсийн бэлчээрийн тэжээлийн жилийн нийт нөөц (бэлчээрийн өвс ногооны хэнзлэлтийг бодолцоод) нь 23.5 сая тн өвсөөр үнэлэгддэг. Хонин толгойд шилжүүлсэн нэг малд жилд 1.59-2.99 га бэлчээрийн газар шаардагдана. Баруун бүсийн аймгуудын мал-бэлчээрийн газрын харьцаа нь аль 1980–аад оны үед алдагдаж, малын тоо нь ихдэж бэлчээрийн талхлагдал буй болсон нутаг билээ. 2000-2001 оны зуднаас хойш малын тоо, түүний дотор бог малын тоо жилээс жилд өсөж, бүсийн дүнгээр малын тоо 2004 онд 8.5 сая, 2005 онд 9.2 сая, 2006 онд 10.9 сая, 2007 онд 12.3 саяд хүрээд байна. 2007 оны жилийн эцэст Баян-Өлгийд 1.6 сая, Говь-Алтайд 2.5 сая, Завханд 3.0 сая, Увсад 2.7 сая, Ховдод 2.6 сая мал тоологдсон байна.

**Баруун бүсийн малын тоо, 2003-2007 оны дундаж /Хүснэгт 8.6/**

|            | Бүх мал | Тэмээ | Адуу   | Үхэр   | Хонь    | Ямаа    |
|------------|---------|-------|--------|--------|---------|---------|
| Баян-Өлгий | 1298801 | 5397  | 61161  | 85942  | 547013  | 599290  |
| Говь-Алтай | 1270434 | 23537 | 40922  | 20405  | 414026  | 771543  |
| Завхан     | 1657879 | 6865  | 94555  | 88924  | 797234  | 670301  |
| Увс        | 1694341 | 15413 | 65039  | 90931  | 826534  | 696424  |
| Ховд       | 1551130 | 16735 | 67787  | 76557  | 567942  | 822109  |
| Дүн        | 7472585 | 67948 | 329463 | 362758 | 3152749 | 3559667 |

**Баруун бүсийн 1 га бэлчээрээс үйлдвэрлэсэн МАА-н бүтээгдэхүүнийг бусад бүсийнхтэй харьцуулбал /Хүснэгт 8.7/**

| Бүс, Аймаг | Бэлчээрийн зориулалтаар ашигладаг талбай /мян.га/ | МАН-н бүтээгдэхүүн, сая төг | 1 га бэлчээрээс үйлдвэрлэсэн мал аж ахуйн бүтээгдэхүүн, төгрөг |
|------------|---|-----------------------------|--|
| Баруун     | 35395.7   | 212436.1                    | 6001.7   |
| Хангай     | 29091.1   | 255407.9                    | 8779.6   |
| Төв        | 36565.8   | 164768.0                    | 4506.1   |
| Зүүн       | 25642.2   | 121214.1                    | 4727.1   |
| Дүн        | 126978.5  | 762565.9                    | 6005.5   |
| Баян-Өлгий | 4398.5  | 38258.2                     | 8698.0   |
| Говь-Алтай | 12167.9   | 35212.8                     | 2893.9   |
| Завхан     | 6755.9  | 46326.5                     | 6857.2   |
| Увс        | 5531.4  | 47426.6                     | 8574.1   |
| Ховд       | 6542.0  | 45212.0                     | 6911.0   |

Баруун бүсийн 1 га бэлчээрээс үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний хэмжээ бусад бүсүүдээс доогуур биш байна. Тэгхээр энэ бүсийн хөгжилд мал аж ахуйн салбар нэн чухал гэдэг нь харагдаж байна.

### 8.5.2 Мал аж ахуйн хөгжлийн төлөвлөлт

#### I. Баян-Өлгий аймаг

Баян-Өлгий аймгийн мал аж ахуйг хөгжүүлэхэд ойрын болон төлөвлөлтийн хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ.

#### 1. Мал аж ахуйн тогтвортой өсөлтийг хангах чиглэлээр:

- Хөдөөд уламжлалт мал аж ахуй, хот, суурингийн ойролцоо эрчимжсэн үйлдвэрлэл эрхлэн, аажмаар эрчимжсэн аж ахуйн хувийн жинг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлэх бодлого баримтлах
- Хөдөө аж ахуйн хоршооллын малыг Алтайн өндөр уулын бүсийн байгаль, цаг уурын нөхцөлд дассан, өндөр ашиг шимтэй удмаар чанаржуулах, үржлийн албадыг орчин үеийн шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн байгууллага болгох чиглэлээр хөгжүүлэх
- Хонь, ямаа, үнээг зохиомлоор хээлтүүлэн, өндөр ашиг шимт хээлтүүлэгч үржүүлэн өсгөх, үрийг нь улсын генийн санд хадгалуулан, үржлийн албадыг улсын мэдээллийн сүлжээнд холбосон лабораторийн хэмжээнд хүргэх бодлого баримтлан хөгжүүлэх. Аймгийн мал сүрэгт өндөр ашиг шимт малын хувийн жинг нэмэгдүүлж, мал сүргийг цөөрүүлж, бэлчээрийн даацыг хөнгөлөх
- Малаа шилж тохируулах, сонголт хийх замаар үүлдэр, угсааг сайжруулах арга технологид малчдыг сургах
- Уламжлалт мал аж ахуйн сүрэг дотор богийн хээлтэгчийг 50 хувь, бодын хээлтэгчийг 30 хувь байхаар зохицуулан, жилд дунджаар 510-530 мянган төл бойжуулах бодлого баримтлах
- Бэлчээрийн даацыг зохицуулахын тулд 2015 он хүртэл тэжээлийн аж ахуйг аажмаар хөгжүүлэх, мах, арьс шир боловсруулах жижиг, дунд үйлдвэрийг бэлчээрт ойртуулан байгуулах замаар өвлийн нядалгааг нэмэгдүүлэн малын тоог зохицуулах, хөдөө аж ахуйн хоршооллууд үйлдвэржин хөгжих нөхцөл бүрдүүлэх бодлого баримтлах



- Мал эмнэлгийн үйлчилгээг зах зээлийн нөхцөлд нийцүүлэн хөгжүүлж, малчид малаа эмнэлгийн үйлчилгээнд заавал хамруулах эдийн засаг, эрх зүйн орчин бүрдүүлэх
- Услалтын системүүдийг сэргээх, орчин үеийн, байгальд халгүй технологитой малын тэжээлийн болон үрийн аж ахуй хөгжүүлэх замаар тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэн, эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх
- Шувуу, зөгийн аж ахуйг байгальд халгүй технологийн дагуу эрхлэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх
- Загас, мах, сүүн бүтээгдэхүүнийг орчин үеийн технологийн дагуу боловсруулан экспортлох жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд зээл, татвар зэрэг эдийн засгийн хөшүүргийг ашиглан дэмжих
- Өлгий хотод малзүйч, фермерийн технологчийн сургууль байгуулна.

**2. Мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах чиглэлээр:**

- Байгаль, цаг уурын зонхилон тохиолддог гамшигт үзэгдэл тус бүрээр нарийн усалгаа, шинжилгээ хийж, түүнд үндэслэн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, эрсдэлийн түвшинг бууруулах арга хэмжээ авах
- Малыг тоо толгойн өнөөгийн хэмжээнд зохицсон 2500-3000тн өвс, 520-550тн хүчит тэжээлийн аюулгүйн нөөц бий болгохын тулд:
  - 100 га талбайд малын тэжээл тариалж, усалгааны системүүдийг сэргээн ашиглах
  - Аюулаас хамгаалах тэжээлийн нөөц бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бэлчээр ашигласны төлбөр, сайн дурын хандиваар бүрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах
  - Энгийн усалгаатай хадлангийн талбайг өргөтгөж, хадлан авах, тэжээл тариалах, үр бэлтгэх чиглэлийн аж ахуйг сум бүрт байгуулах чиглэл баримтлах
  - Хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог боловсронгуй болгон, малыг заавал даатгуулах эрх зүйн үндэс бий болгох
- Мал эмнэлгийн албыг зах зээлийн нөхцөлд зохицсон бүтэц, зохион байгуулалтад оруулж, компьютерийн сүлжээнд холбон олон улсын “А” ангиллын хурц халдварт өвчний талаарх мэдээллийг шууд хил залгадаг болон импорт, экспортын худалдааны харилцаатай орнуудаас цаг тухайд нь авч чаддаг, халдварт өвчинтэй тэмцэхэд зориулан нисдэг тэрэг, нүүдлийн лаборатори, орчин үеийн эм, хэрэгслээр хангагдсан отрядтай болох бодлого баримтлах



- Зохих түвшний чанарын шаардлага хангасан эм бэлдмэлийн нөөцтэй болж, биотехнологийг хөгжүүлэн, эм бэлдмэл үйлдвэрлэхэд гадаад хамтын ажиллагааны хөшүүргийг ашиглах бодлого баримтлах

### 3. Мал аж ахуйг хөгжүүлэхэд аймгийн төр захиргааны байгууллагаас бодит дэмжлэг үзүүлэх чиглэлээр:

- Мал аж ахуйг зах зээлийн нөхцөлд зохицуулан удирдаж хөгжүүлэх, удирдлагын шинэ тогтолцооны талаар судалгаа, шинжилгээ хийж, аймгийн онцлогт тохирсон мал аж ахуйн хөгжлийн баримжаа, түүний удирдлагын загвар боловсруулан мөрдөх
- Малчид, тариаланчид хөрөнгө хүчээ хоршиж, фермерийн аж ахуй, хоршоолол байгуулах, жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд орон нутгийн төр захиргааны байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэх
- Мал аж ахуй, газар тариалангийн дотоодын зах зээлийг хамгаалахад чиглэсэн гааль, татварын уян хатан бодлого явуулж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн маркетингийн удирдлагыг боловсронгуй болгох
- Мал аж ахуй, газар тариалан эрхлэгчдийг зах зээл, технологийн мэдээллээр хангах, үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлэх нөхцөл бүрдүүлэх
- Мал аж ахуйн түүхий эдийн бэлтгэлийн шинэ тогтолцоо бүрдүүлж, бэлтгэлийн үнийг өсгөх, хилийн худалдаа хийх, бөөний худалдааны сүлжээ байгуулах

### 4. Бэлчээр, газрыг үр ашигтай ашиглах чиглэлээр:

- Малын үүлдэр угсааг сайжруулах замаар ашиг шимийг нэмэгдүүлэн, бэлчээрийн даацад малын тоог тохируулах бодлого баримтлах
- Малын төрөл, үүлдрийг бэлчээрийн байдалд зохицуулан, нарийн хуваарьтай ашигладаг уламжлалт аргыг улам боловсронгуй болгох
- Газар тариаланд зохимжтой, атаршсан талбайг сэргээн, агротехникийн боловсруулалтыг сайжруулж, салхины элэгдлээс хамгаалах
- Малын хөлөнд талхлагдсан, машины шороон замаар халцарсан бэлчээрийг ургамалжуулан сэргээх
- Малын тэжээл, хадлангийн талбайн ургацыг нэмэгдүүлэх эрчимжсэн тэжээлийн аж ахуй хөгжүүлэх
- Хот төлөвлөлтийг боловсронгуй болгон, сумын төв, хот, суурингийн эзлэх талбайг багасган, хөрсний талхлагдал, элэгдлийг бууруулах арга хэмжээ зохион байгуулах
- Хот суурингийн хог, хаягдлаар бохирдсон талбайг цэвэрлэн хөрсжүүлж, цаашдаа бохирдуулахгүй байх тал бүрийн арга хэмжээ авах
- Уул уурхайн үйлдвэр эрчимтэй хөгжих төлвийг харгалзан, газрын хэвлийн баялгийг зохистой ашиглах эрх зүй, эдийн засгийн таатай нөхцөл бүрдүүлж, хяналтыг боловсронгуй болгох
- Газар зохион байгуулалтын мэргэжлийн албаны материаллаг баазыг бэхжүүлэн, газрын чанар, төлөв байдлын шинжилгээ, судалгааг зохих хэмжээнд хүртэл өргөжүүлж, элэгдлийг зогсоох арга, технологи боловсруулан хэрэгжүүлэх чадвартай болгох
- Байгалийн гамшгийн судалгаа, шинжилгээг гамшигт үзэгдлийн чиглэл тус бүрээр хийж, түүнтэй тэмцэх арга хэмжээний стратеги боловсруулах
- Аймгийн нийт нутгийн цөлжилтийн үнэлгээ хийх
- Малын бэлчээрийн хомсдол бий болгож, мал аж ахуйд хамгийн их хохирол учруулдаг ган, зудны эсрэг тэмцэх гол арга – малын өвс тэжээлийн хүрэлцээтэй нөөц бий болгох талаар дараах арга хэмжээ авах:
  - 2015 оны эхэн үед жил бүр 520-550тн хүчит тэжээл, 2500-3000 тн өвс хадлангийн нөөцтэй болох
  - 1100 га талбайг услан, малын тэжээл тариалж байсан 10 усралтын системийг сэргээх, энгийн усалгаатай хадлангийн талбайг нэмэгдүүлэх, хилийн завсрын зурвасаас хадлан авах боломжийг судлах
  - Бэлчээрийн татвар, малчдын сайн дурын хандиваар аюулаас хамгаалах тэжээлийн нөөцийн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх
  - 2010-аад оны эцэс хүртэл бүх малыг сар хүртэл тэжээх нөөцтэй болж, аажмаар суурин, хагас суурин маллагаанд шилжих бодлого баримтлах

## II. Ховд аймаг

Ховд аймгийн мал аж ахуйг хөгжүүлэхэд ойрын 10-15 жилд тавих зорилт, арга хэмжээ.

### 1. Мал аж ахуйн тогтвортой өсөлтийг хангах чиглэлээр:

- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн “Айл саахалтын

нөхөрлөл”, хоршоо, фермер, компани зэрэг аж ахуйн нэгжийн хэлбэрээр үйл ажиллагаагаа эрхэлдэг болгох

- Хөдөө аж ахуй дахь айл саахалтын нөхөрлөл, хоршоо, фермер, компани бүрийн үйлдвэрлэлд бага чадлын техник, нар, салхи, усны эрчим хүч ашиглах
- Газар тариалангийн үйлдвэрлэлд агро удирдамж боловсруулж мөрдөх
- Рапс, наранцэцэг, шар буурцаг, гичийн үр тарьж, Хүнсний бүтээгдэхүүн том ашиглах үйлдвэрлэлийн арга эзэмших
- Үрийн нутагшсан сорт бий болгож ашиглах, Торгуудын зургаадай арвай, “Ховд 80” тарвасын үрийг сонгомол үрийн зориулалтаар дэлгэрүүлэх
- Булган суманд олсны ургамал тариалдаг уламжлалт туршлагыг сэргээх
- Эрдэнэ шиш, царгас, сибирийн өлөнгийн шинэ сортыг жил бүр 300-гаас доошгүй га-д тариалж, даршлан шүүст тэжээл бэлтгэх
- Малын удмын саг хамгаалах, эрүүлжүүлэх, ашиг шимийг нэмэгдүүлэх цогцолбор арга хэмжээ хэрэгжүүлэх
- Газар тариалангийн хог ургамал, хортон шавьжтай тэмцэх арга технологийг баталгаажуулах
- Мал аж ахуйн хагас суурин, эрчимжсэн буюу цөм, торгон сүрэг зонхилсон аж ахуйг аймаг, сумын төв орчимд зохистой хөгжүүлэх боломж, нөхцөлийг төрөөс анхааран үзэж, дэд бүтцийн сүлжээг ойртуулах, ингэснээр 2020 он гэхэд малчдын 20-оос доошгүй хувь нь хагас суурин, эрчимжсэн аж ахуйн зохион байгуулалтад шилжих
- Бэлчээрийг усжуулах асуудалд түлхүү анхаарч, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, хот орчмын бэлчээрийн уст цэгийг төлбөртэй ашиглуулах зэрэг асуудлыг боловсруулж шийдвэрлүүлэх
- 2010 он гэхэд нийт малчин өрхийн 60-аас доошгүй хувийг арвай, тариа, төмс, Хүнсний ногооны болон хадлангийн зохих эзэмшил газартай болгох асуудлыг судалж хэрэгжүүлэх
- Буянтын 600 үнээний фермийн үйл ажиллагааг сэргээж, хотын иргэдийг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангахын тулд банкны зээл, татварын болон хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих
- Гахай, шувуу, зөгий, туулай үржүүлэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санаачлагыг дэмжиж, мэргэжлийн туслалцаа үзүүлэх
- Гадаадын зарим орны туршлагаар сайн дурын мал эмнэлгийн албыг байгуулж, гэрээ байгуулан ажиллах
- Малчдын гар хөдөлмөрийг механикжуулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор өвс хадах морин хадуур, бага оврын трактор, анжис, хадуур, тармуур зэргээр хангах нэгдсэн бодлого явуулах
- Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах замаар хөдөө аж ахуйн тохиолдох эрсдэлийг бууруулах, Хүнсний аюулгүй байдлыг хангах
- Гэнэтийн аюулын үед урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг боловсронгуй болгож ард иргэдэд шуурхай хүргэх
- Хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, даатгалд өргөн хамруулах
- Малчид, тариаланчид, өмчийн олон хэлбэрийн байгууллага, аж ахуйн нэгжээр байгалийн аюулаас урьдчилан сэргийлэх бэлтгэл хангуулах

## 2. Мал аж ахуйд учрах эрсдэлийг багасгах чиглэлээр:

- Байгалын гамшгийн хохирлыг багасгах зорилгоор нөөц сан байгуулж, жил бүр 6 мянган тонн хадлан, 3 мянган тонн малын тэжээлийн ургамал, 1 мянган тонноос доошгүй багсармал тэжээл нөөцлөх
- Байгаль, цаг уурын онц тааламжгүй нөхцөл болон бүх нийтийг хамарсан аюулын үед хэрэглэх хүнс, шатахуун, аж ахуйн хэрэглээний барааны шаардлагатай нөөц бүрдүүлж нөхөн хангалт хийж байх
- Үйлдвэрлэгчдийг төрөл бүрийн сургалтад хамруулах техник, технологи зах зээл, үнийн мэдээллээр хангах
- Мал аж ахуйн үйлдвэрлэлийн маркетингийн орчин, түүнд нөлөөлөх хүчин зүйлс, зах зээлийн боломж, багтаамж, борлуулалтын суваг, зах зээлийг идэвхжүүлэх үйл ажиллагаа, удирдлагын үндсэн функц зэргийг судалж боловсруулах
- Хөдөөгийн малчдад үйлчлэх, зуучлах бөөний худалдааны сүлжээ бий болгох

## 3. Газар, бэлчээрийг зохистой ашиглах чиглэлээр:

- Газар ашигласны төлбөр, нөхөн төлбөр ноогдуулах эдийн засгийн оновчтой механизмыг бий болгож, газрын харилцааны асуудлыг шийдвэрлэх, зохицуулах хөшүүрэг бий болгох
- Газрын төлбөр, нөхөн төлбөрийн зохих хувийг тусгай санд төвлөрүүлэн, элэгдэж, эвдэрсэн

газар нутгийг нөхөн сэргээж ашиглалтыг нь сайжруулах, байгалийн гамшигтай тэмцэх болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулах

- Малыг нутаг дэвсгэрийн бэлчээрийн даацад тохируулан өсгөх
- Аймгийн төв орчимд хүн, мал их хэмжээгээр төвлөрснөөс бэлчээр талхлагдан, хөрсний үржил шим муудан, даац хэтэрч байгаад судалгаа хийж, дүгнэлт гарган, илүү нягтшилтай суурьшсан газрын малчдаас өндөр төлбөр авах буюу төлбөрийн ялгавартай бодлого явуулах замаар суурьшлыг зохицуулахад нөлөөлөх
- Эвдэрсэн, тоногдсон уст цэгийг сэргээн засварлаж ус гаргах, тэдгээрийг гэрээний үндсэн дээр нутгийн уугуул иргэдийн дундын өмчлөлд удаан хугацаагаар эзэмшүүлэх арга хэмжээ авч, бэлчээр ашиглалтын хүрээг тэлэх, бэлчээр сэлгэлтийг сайжруулах
- Бэлчээрийг хайрлаж хамгаалдаг, хуваарьтай эзэмшдэг ардын уламжлалт арга туршлагыг судалж дэлгэрүүлэх
- Боллоцоотой буюу шаардлагатайг газарт бэлчээрийн зарим хэсгийн хашиж хамгаалан, хадлан тэжээлийн нөөц нэмэгдүүлэх ажлыг малчдын хүч хөрөнгөөр гүйцэтгэх
- Бэлчээрийг малчдад эзэмшүүлэх

### **III. Увс аймаг**

Увс аймгийн мал аж ахуйн тогтвортой өсөлтийг хангах чиглэлээр тавигдах зорилтууд:

#### **1. Мал аж ахуйн тогтвортой өсөлтийн чиглэлээр**

- Аймаг сумын төв зэрэг суурин газрыг эрчимжсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр хангах бодлогыг үе шаттай хэрэгжүүлэх. Ингэхдээ эрчимжсэн мал аж ахуй, тэжээлийн үйлдвэрийг зохистой хослон хөгжүүлэх;
- Аймаг, сум, багийн мал аж ахуйн үржил, технологи (ус, бэлчээр, хадлан, тэжээл, хашааны хангамж зэрэг), бүтээгдэхүүний чанарын бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх, тухайн сум, багийн байгаль цаг уур, экологийн нөхцөлтэй нягт уялдуулан сүргийн бүтэц, малын төрлийн харьцааг зөв тогтоох;
- Мал аж ахуй, ургамал, амьтны гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах бага, дунд хүч чадлын үйлдвэрийг түүхий эдийн нөөц, хэрэглэгчдэд ойртуулан оновчтой байршуулж, Хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийн тоо, хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлэх, зах зээлийн багтаамжийг дээшлүүлэн, малчид, тариаланчдыг үйлдвэрлэгчидтэй шууд холбож, мөнгөний ханш уналтаас түүхий эдийг хамгаалах тал бүрийн арга хэмжээ авах;
- Бэлчээрийн мал аж ахуйд ажиллагчдын хөдөлмөрийг жижиг, дунд оврын, эрчим хүчний бага зарцуулалттай буюу хямд эх үүсвэрээр ажилладаг техник, тоног төхөөрөмж нэвтрүүлэх замаар хөнгөвчлөх;
- Аж ахуйн нэгжийн болон хувийн мал эмнэлгийн үйлчилгээг дэмжин дэлгэрүүлж, халдварт, паразит өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд шаардлагатай бүх төрлийн малыг тухай бүрд нь бүрэн хамруулах;
- Бэлчээрийн мал маллагаа, эмчилгээний уламжлалт арга, технологийг баяжуулж сэргээх, ялангуяа бэлчээрийн даац хомсдолтой өвөл, хаврын улиралд бэлчээрийг хуваарьтай ашиглах замаар даацыг 20-30 хувиар нэмэгдүүлэх
- Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өндөр ашиг шимт малыг бүртгэн хянан баталгаажуулах, нутгийн мал сүргийг сонгон үржүүлэх, нутгийн шилмэл мал шалгаруулан эдийн засгийн аргаар урамшуулах зэргээр монгол малын удмын сайн чанарыг хадгалсан цөм, торгон сүрэг, гойд ашиг шимт малыг хамгаалан өсгөж, бүх малд шилмэл өмгийн малын эзлэх хувийг нэмэгдүүлэх үндсэн дээр мал сүргийн чанарыг сайжруулах;
- Нутгийн малд Баяд үүлдрийн хуц, Өлгийн улаан ухна, Тэс хэвшлийн азрагыг сайжруулагчаар ашиглан чанарыг нь дээшлүүлэхийн зэрэгцээ Завхан, Хяргас сумдад нутгийн тэмээний шилмэл омог бий болгох, тариалангийн бүс нутаг, төв, сууринд цэвэр, эрлийз үхэр үржүүлэх, адууг хурд, мах, уналгын чиглэлээр өсгөх;
- Цэвэр, эрлийз, нутгийн үүлдрийн мал сүргийг өсгөж үржүүлэх, шилэн сонголт, ангилалт хийх ажлыг үржлийн мэргэжилтнээр гүйцэтгүүлэх, энэ чиглэлээр аж ахуйн нэгж байгуулж, сонирхогч байгууллага, иргэдтэй тодорхой гэрээтэй ажиллуулах;
- Үржлийн фермерийн аж ахуй байгуулж, нутгийн болон цэвэр, эрлийз үүлдрийн өндөр ашиг шимт мал, хээлтүүлэгч өсгөн бойжуулж, худалдаалах, мал сүрэгт ангилалт, шилэн сонголт хийх, нутгийн шилмэл омог, үүлдэр бий болгох зорилгоор ажиллуулах;
- Малчин айл өрхийг сүү боловсруулах механик болон сэргээгдэх эрчим хүч, бага хүч чадлын цахилгаан станцаар ажиллах жижиг оврын машинаар хангах, сумын төвийн сүү, махны хэрэгцээг мал бүхий иргэдтэй гэрээ хийх замаар хангах;

- Төв, суурин газарт эргэлтээр төллөдөг, сүү, махны чиглэлийн 10-30 үнээтэй фермерийн аж ахуй байгуулах, малыг шахаж бордох арга хэрэглэх үндсэн дээр өвөл, хаврын улирал, зуны эхний сарын сүү, махны хангамжийг сайжруулах, нэмэлт зардал багатайгаар шинэ махаар үйлчлэх нөхцөл бүрдүүлэх, улмаар мал аж ахуй, тариалангийн хослол бүхий фермерийн аж ахуй бий болгож хөгжүүлэх.

| 2018 | 1215,18            | 387,448      | 2042,92      |
| 2019 | 1215,18            | 350,643      | 2079,72      |
| 2020 | 1215,18            | 315,342      | 2115,02      |
| 2021 | 1215,18            | 281,374      | 2148,99      |

Завхан аймаг / Төл мал /

Alpha = 0,9999 параметртэй энгийн экспоненциалаар тэгшитгэх аргаар тооцоолов.

Өсөлтийн хандлага /Хүснэгт 8.35/

| Он   | Бойжсон төл | 95,0%        |              |
|------|-------------|--------------|--------------|
|      | Хандлага    | Доод хязгаар | Дээд хязгаар |
| 2008 | 952,285     | 705,854      | 1198,72      |
| 2009 | 952,285     | 603,796      | 1300,77      |
| 2010 | 952,285     | 525,482      | 1379,09      |
| 2011 | 952,285     | 459,459      | 1445,11      |
| 2012 | 952,285     | 401,292      | 1503,28      |
| 2013 | 952,285     | 348,704      | 1555,87      |
| 2014 | 952,285     | 300,345      | 1604,23      |
| 2015 | 952,285     | 255,333      | 1649,24      |
| 2016 | 952,285     | 213,056      | 1691,51      |
| 2017 | 952,285     | 173,07       | 1731,5       |
| 2018 | 952,285     | 135,039      | 1769,53      |
| 2019 | 952,285     | 98,6996      | 1805,87      |
| 2020 | 952,285     | 63,8457      | 1840,72      |
| 2021 | 952,285     | 30,3085      | 1874,26      |

**Баруун бүсийн Монгол малын нөхөн үйлдвэрлэлийн симуляцын загвар бодсон дүн**

Баруун бүсийн эдийн засгийн хөгжлийн эконометр загвар бодоход уг бүсийн цаашдын хөгжилд шийдвэрлэх үүрэгтэй нь мал аж ахуйн хөгжил байна. 2007 оны байдлаар бүсийн ДНБ-д мал аж ахуйн эзлэх байр суурь 80% байгаа бол цаашид энэ үзүүлэлт бага зэрэг буурч, 2010 онд 75%, 2015 онд 67%, 2021 онд 60% болох боловч, бүсийн ард олны амьжиргааны гол эх үүсвэр нь мал аж ахуй байсаар байх болно.

Мал аж ахуйгаас олох орлогыг монгол ба сайжруулсан омгийн болон үүлдрийн малын нөхөн үйлдвэрлэлийн симуляцын загварчлалын аргаар тодорхойлно. Бэлчээрийн малын сүргийн нөхөн үйлдвэрлэлийн сүүлийн 12 жилийн судалгаанаас харахад нэг малаас үйлдвэрлэх бүтээгдэхүүн, олох орлогын хамгийн гол тодорхойлогч үзүүлэлт нь том малын хорогдлын хувь, бүтээгдэхүүний үнийн индекс байна.

$$I = f(D\%, P_m, P_w, P_s)$$

I- оны эхний нэг малаас үйлдвэрлэл бүтээгдэхүүн, мянган төгрөг

D%- том малын хорогдлын хувь

P<sub>m</sub>- махны үнийн индекс (шийдвэрлэгч нь хонины махны үнэ)

P<sub>w</sub>- ноос, ноолуурын үнийн индекс (шийдвэрлэгч нь ноолуурын үнэ)

P<sub>s</sub>- арьс, ширний үнийн индекс (шийдвэрлэгч нь нэхийний үнэ)

Эхлээд хорогдлын хувь хэрхэн шийдвэрлэгч хүчин зүйл болохыг авч үзье. Бэлчээрийн мал аж ахуйн нөхцөлд малын хорогдол нь бүхэлдээ тэр жилийн цаг уур, бэлчээрийн төлөв байдлыг шууд илэрхийлнэ. Цаг уур тааламжгүй байвал бэлчээрийн гарц муу болж, улмаар мал хорогдох үндсэн шалтгаан болдог нь хэнд ч ойлгомжтой.

Том малын хорогдлын түвшин нь сүргийн нөхөн үйлдвэрлэлийн параметруудийн дотроос хамгийн тодорхойлогч нь юм. 100 эхээс бойжуулсан төлийн тоог аваад үзэхэд том малын хорогдлоос шууд хамааралтай байдаг. Учир нь том малын хорогдол өндөр жил бусад 3 төрлийн хорогдол буюу малын хээл хаялт, сувайралт, төлийн хорогдол бүгд их байна. Иймээс 100 эхээс бойжуулсан төлийн тоо бага гарна.

Зураг ба хүснэгтээс харахад хорогдол их байсан жилүүдэд (2000-2003) 100 эхээс бойжуулсан төлийн тоо бага, хорогдол бага байсан жилүүдэд (1997-1999, 2004-2007) төлийн тоо их байна. Энэхүү хамаарлыг регрессийн шинжилгээгээр тогтооход:


ботго-  $T_{100\ camel} = 46.4714 - 1.9239 D_{\% camel}$   $R^2 = 0.48$   $R = 0.69$   
унага-  $T_{100\ horse} = 70.1563 - 2.2087 D_{\% horse}$   $R^2 = 0.94$   $R = 0.97$   
тугал-  $T_{100\ cattle} = 78.7909 - 1.1678 D_{\% cattle}$   $R^2 = 0.88$   $R = 0.94$   
хурга-  $T_{100\ sheep} = 87.9681 - 2.0865 D_{\% sheep}$   $R^2 = 0.92$   $R = 0.96$   
ишиг-  $T_{100\ goat} = 85.2238 - 2.5253 D_{\% goat}$   $R^2 = 0.85$   $R = 0.92$  гарав.

Энд:  $T_{100}$ - оны эхний 100 хээлтэгчээс бойжуулсан төлийн тоо,  
 $D_{\%}$ - оны эхний нийт малд том малын хорогдлын эзлэх хувь,  
 $R^2$ - детерминацын коэффициент,  
 $R$ - корреляцын коэффициент.

Бүх төрлийн төлийн тэгшитгэлд корреляцын коэффициент өндөр гарсан нь хамаарал нэн хүчтэй (статистикт  $R > 0.67$  бол хамаарал нэн хүчтэй гэдэг) бөгөөд уг тэгшитгэлүүдийг төлөвлөлтөд ашиглах бүрэн боломжтой болохыг харуулж байна.

Тухайн жилийн хорогдлын хувь ямар байгаагаас хамааруулан малчид сүргийнхээ эргэлтийг зохицуулдаг байна. Өөрөөр хэлбэл, төл болон өсвөр малынхаа хэдэн хувийг нас дэвшүүлэх вэ?, нас гүйцсэн эр малынхаа хэдэн хувийг зах зээлд борлуулах вэ?, малынхаа нийт тоо толгойг өсгөх үү?, байх уу?, нийт малд хээлтэгч болон эр малын эзлэх хувийн жинг хэд орчимд байлгах вэ? зэрэг сүргийн нөхөн үйлдвэрлэлийн олон асуудлыг төрөлхийн монгол малчны менежментийн ухаанаар шийдвэрлэдэг байна.


Том малын хорогдлын хувь ба 100 эхээс бойжуулсан төлийн өөрчлөлт /График 8.27/



Тэгэхлээр сүргийн нөхөн үйлдвэрлэлийн олон чухал асуудал жилийн жилд онцлогтой, малын хорогдлын байдлаас (цаг уур, бэлчээрийн төлөв байдлаас) хамаардаг болно.

Сүргийн эргэлтийн нэгэн чухал үзүүлэлт бол зах зээлд борлуулж байгаа (өрхийн хэрэгцээнд хүнсэнд хэрэглэсэн мал орно) эр малын эзлэх хувийн жин юм. Малчдаас авсан түүвэр судалгааны материал ба өрх бүрийн мал тооллогын гар картын албан ёсны тоо материал дээр тулгуурлан дээрх үзүүлэлтийг тооцоход дараах үр дүн гарав.

Хорогдлын масштабыг томруулбал /График 8.28/



Оны эхний нийт эр малаас зах зээлд борлуулж байгаа малын эзлэх хувийн жин том малын хорогдлын хувиас шалтгаалах нь /Хүснэгт 8.36/

| Том малын хорогдлын хувь | Оны эхний нийт эр малаас зах зээлд борлуулж байгаа малын эзлэх хувийн жин |      |      |       |      |
|--------------------------|---|------|------|-------|------|
|                          | Тэмээ   | Адуу | Үхэр | Хонь  | Ямаа |
| 1                        | 11.6  | 32.0 | 36.0 | 100.0 | 95.0 |
| 2                        | 9.7   | 26.5 | 38.0 | 100.0 | 84.0 |
| 3                        | 8.0   | 22.3 | 41.0 | 100.0 | 74.4 |
| 4                        | 6.9   | 19.0 | 44.0 | 100.0 | 66.0 |
| 5                        | 5.9   | 16.4 | 47.0 | 100.0 | 58.8 |
| 6                        | 5.1   | 14.3 | 50.3 | 87.0  | 52.5 |
| 7                        | 4.4   | 12.5 | 54.0 | 76.3  | 47.0 |
| 8                        |   | 11.1 | 58.0 | 67.0  | 41.8 |
| 9                        |   | 9.7  | 62.0 | 59.3  | 37.3 |
| 10                       |   |      | 67.0 | 52.5  | 33.3 |

Оны эхний 1 толгой малаас үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн хорогдлын түвшингээс хамаарах нь /Хүснэгт 8.37/

| Малын хорогдлын % | Оны эхний 1 толгой малаас үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн, 2008 оны зах зээлийн үнээр |       |        |       |       |
|-------------------|---|-------|--------|-------|-------|
|                   | Тэмээ   | Адуу  | Үхэр   | Хонь  | Ямаа  |
| D%                | Y1  | Y2    | Y3     | Y4    | Y5    |
| 1.0               | 71033   | 70556 | 204154 | 32159 | 36506 |
| 2.0               | 65477   | 65759 | 199270 | 31222 | 35674 |
| 3.0               | 59970   | 60887 | 194372 | 30286 | 34836 |
| 4.0               | 54515   | 55959 | 189458 | 29353 | 33994 |
| 5.0               | 49114   | 50990 | 184525 | 28404 | 33149 |
| 6.0               | 43771   | 45992 | 179572 | 27212 | 32305 |
| 7.0               | 38484   | 40972 | 174593 | 26010 | 31462 |
| 8.0               |   | 35938 | 169585 | 24800 | 30621 |
| 9.0               |   | 30894 | 164543 | 23586 | 29785 |
| 10.0              |   |       | 159462 | 22370 | 28954 |

Тайлбар:

$$Y_1 = 76325.57143 - 5425.535714 \cdot D\%$$

$$Y_2 = 75708.66667 - 4965.133333 \cdot D\%$$

$$Y_3 = 209246.7333 - 4962.424242 \cdot D\%$$

$$Y_4 = 33547 - 1092.145455 \cdot D\%$$

$$Y_5 = 37352.13333 - 840.6424242 \cdot D\%$$


Дээр өгүүлснээс дүгнэлт хийхэд 2021 он хүртэлх малын хорогдлын хувийн прогноз хийсэн байхад сүргийн нөхөн үйлдвэрлэлийн симуляцын загвар бодож болох нь байна. Бидний ажигласнаар байгаль, цаг уур, бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлт нь тодорхой давтамжтай бөгөөд үечлэл нь 12 жил болох нь батлагдсан тул хорогдлын хувийн прогноз тооцоход дараах хэлбэрийн гармоник функцийг ашиглах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

$$Y = 8.3987 + 0.0356t + 1.4829 \sin\left(\frac{2\pi t}{12}\right) + 0.0172 \cos\left(\frac{2\pi t}{12}\right) \quad R = 0.62$$

Сүргийн нөхөн үйлдвэрлэлийн симуляцын загвар бодоход дараах үр дүн гарав. Энэ загварын тооцооны үр дүнд гарсан малын тоогоор мал аж ахуйн салбарын ДНБ-ийг тооцож, улмаар мал аж ахуйн бүтээгдэхүүнийг дахин боловсруулах үйлдвэрийн ДНБ-ийг тооцов.


Жишээ болгож Баруун бүсийн зөвхөн хонины хорогдлын өөрчлөлтийн графикийг харуулбал:

Баруун бүсийн хонины хорогдлын хувийн өөрчлөлтийн хандлага цаг уураас хамаарах нь /График 8.29/



Масштаб М1:5 000 000

Баруун бүс  
Хээлтэгч малын тоо, төрөл



Нийт малын тоонд хээлтэгчийн эзлэх хувь

- 40 - аас доош
- 40.01 - 42.00
- 42.01 - 44.00
- 44.01 - аас дээш

- Багааны өндрийн 1мм - 5000 мян толгой малтай тэнцэнэ.

- Малын төрөл
- Ингэ
  - Гүү
  - Үнээ
  - Эм хонь
  - Эм ямаа

Зураг 8.6

**8.6 БАРУУН БҮСИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ БОЛОМЖУУД /ТӨЛӨВЛӨЛТ/**

Баруун бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулахад их анхаарах хэрэгтэйгээс гадна эдгээр нь бусад бүсүүдээс ялгарч чадвал тухайн сонирхолын жуулчид тогтмол ирэх, найз нөхөддөө сурталчлах замаар бүсийн аялал жуулчлалд эерэг нөлөө үзүүлнэ. Тухайлбал бүргэдээр ан хийх, казах үндэсний хоол, сүрлэг өндөр уулсын дундуур урсах гол, өндөр уулын үзэсгэлэнт нуураар аялах, үзэсгэлэнт сүрлэг гүн хавцал, ховор ан амьтан аргал, янгир, суусар, шилүүс, ирвэс, зэгсний гахай, хойлог, гургуул, бөхөн, говийн баавгай мазаалай зэрэг дэлхийд нэн ховордсон ан амьтан, жүгүүртний амьд музей гэдэг утгаараа их ялгарах учиртай. Мөн байгалын үзэсгэлэнт газар, олон үндэстэн, ястны зан заншил, язгуур урлаг (биелгээ, хөөмий) ахуй амьдрал, түүх археологийн асар их үзвэрүүд нь бусад бүсийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнээс ялгарах онцлог бөгөөд энэ давуу талыг зөв оновчтой маркетинг, менежментийн бодлого бүсийн хэмжээнд дэд бүтэц, соёл боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн салбаруудад хийгдсэн болон хийгдэхээр төлөвлөгдөж буй төсөл, хөрөнгө оруулалттай хослуулж, гадаадын хөрөнгө оруулалтыг татаж чадвал энэ бүс нутаг аялал жуулчлал хөгжих сайхан ирээдүй байна.

**Баруун бүсийн аялал жуулчлалын хөгжлийн давуу болон сул тал /Хүснэгт 8.38/**

| Давуу тал  | Сул тал  |
|--|--|
| <ul style="list-style-type: none"> <li>• Онгон дагшин уулс, хангай, говь цөл хосолсон үзэсгэлэнт байгаль хадгалагдаж үлдсэнээр экожуулч лалыг хөгжүүлэх өргөн боломж той,</li> <li>• Юнескогийн “Дэлхийн гайхам шигт үнэт зүйл”, “Дэлхийн шим газрын нөөц” гэсэн хоёр ангиллын бүртгэлд орсон газруудтай,</li> <li>• Дэлхийд ховордсон амьтан, жигүүртэн шувууд, ургамалын байгалын музей болсон,</li> <li>• Мөнх цаст уулс, мөсөн гол, цэвэр тунгалаг, түргэн урсгалт уулын голууд, үзэсгэлэнт нууруудтай, усан спорт, уулын болон адал явдалт тусгай сонирхолын аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөц газар маш элбэг,</li> <li>• Түүх, археологийн баялаг үзвэрүүдтэй,</li> <li>• Олон үндэстэн, ястны өвөрмөц ахуй амьдрал, язгуур урлагийн өлгий нутаг, түүх, соёлын жуулчдын сонирхолыг татдаг,</li> <li>• Нүүдлийн болон суурьшмал соёл иргэншил хосолсон,</li> <li>• Чингис хааны өлгий нутаг</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Дэд бүтцийн сүлжээ сул хөгжсөн,</li> <li>• Бүсийн хэмжээнд гадаадын жуулчдын сонирхолыг татахуйц арга хэмжээ зохион байгуулах уламжлал, туршлага бага,</li> <li>• Аялал жуулчлал эрхэлдэг аж ахуйн нэгжүүд цөөхөн, зочид буудал, жуулчны баазууд, амралт рашаан сувиллын газруудын тохижилт, тав тухтай байдал, хүчин чадал доогуур, улирлын чанартай үйл ажиллагаатай,</li> <li>• Хоёр хөрш орноор дамжуулан гадаадын жуулчин хүлээн авах боломжийг тэр бүр сайн ашиглаж чадахгүй байгаа,</li> <li>• Аялал жуулчлалын салбарт ажиллагсадын тоо цөөхөн, мэр гэжлийн ур чадвар, маркетингийн ажиллагаа, менежментийг эрс сайжруулах шаардлагатай,</li> <li>• Байгалын үзэсгэлэнт газруудад жуулчдын бааз цөөхөн, байгаа нэг нь тохижилт тааруу, нэг маяг загварын өөр хоорондын онцын ялгагдах зүйлгүй,</li> <li>• Түүх, соёлын болон байгалын үзэсгэлэнт газрууд болон музей үзвэрийн танилцуулга гадаад хэл дээр бүрэн хийгдээгүй, дээрх газруудын хамгаалалт, ашиглалтыг сайжруулах шаардлагатай,</li> <li>• Жуулчдын сонирхолыг татахуйц аялалын маршрут цөөхөн, үйлчилгээний чанар, соёлыг дээшлүүлэх шаардлагатай,</li> <li>• Бүсийн аялал жуулчлалын сурталчилгаа муу хийгддэг,</li> <li>• Байгалын эмчилгээний чиглэлийн аялал жуулчлал хөгжүүлэх боломжийг бага ашиглаж байгаа, рашаан сувиллын газруудын хүчин чадал бага, зөвхөн дулааны улиралд үйлчилгээ явуулдаг,</li> <li>• Аялал жуулчлалын салбарт гадаадын хөрөнгө оруулалт бага</li> <li>• Дэлхийн улаан номонд орсон болон зөвхөн монголд байдаг жигүүртэн шувууд, ан амьтан, ургамалын тухай зурагт каталог танилцуулга үгүйлэгддэг.</li> </ul> |

“Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр”-т аялал жуулчлалын салбарын хөгжлийн тэргүүлэх хоёр зорилтыг дэвшүүлж, 8 чиглэлийн үйл ажиллагааг 2006-2010, 2011- 2015 онуудад хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр заасан байна.

Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөрт тулгуурлан дараах асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзэв. Үүнд :

Бүсийн аялал жуулчлалын салбарын материаллаг баазыг бэхжүүлэх талаар:

- Бүсийн тулгуур төвүүд болох Ховд, Улиастай хотуудад одоо ажиллаж байгаа зочид буудал, амралт сувилал, зоогийн газрууд, музей, театр, соёлын орднуудыг тохижуулах, аялал жуулчлалын мэдээллийн төвийг шинээр нээж ажиллуулах, тухайн газрын онцлогтой уялдуулан шувуу ажиглах байр, од дурандах, эрвээхэй ажиглах, уулын болон усан спортын, загас агнуурын хэргэслээр хангах үйлчилгээний цэгүүд, ангийн отгуудыг тохижуулах, шинээр байгуулах, томоохон маршрутын дагуу аялагчдын алжаал тайлах газар, дэн буудалыг оновчтой төлөвлөж байгуулах,
- Дотоодын аялал жуулчлалын хөгжлийг дэмжих зорилгоор эхний ээлжинд эрэлт хэрэгцээтэй байгаа Ховдын Хар ус нуурын орчмын жуулчны бааз, Увс нуурын ай сав дахь Хархираа амралтын газар, жуулчны төв, Цүнхэгийн амралт, Хяргас нуурын эрэг дээрх Хар тэрмисийн рашаан сувиллын газар, Завханы Отгон тэнгэрийн рашаан сувиллын газар, Говь–Алтайн Бигэрийн бөөрний амралт сувиллын газар, Хүнхэрийн рашаан сувилал, Баян-Өлгийн Чихэртийн амралтын газруудыг тохижуулж хүчин чадлыг бүрэн ашиглах, Ховдын Индэртийн рашаан, Завханы Зартын болон Улаан хаалга рашаан сувиллын газрын өргөтгөл, засвар тохижилтыг хийх замаар хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйлчилгээний хугацааг хоёр дахин уртасгах,
- Ховдын Хар ус, Увсын Хяргас нуурын бүсэд “Аялал жуулчлалын цогцолбор” барих олон улсын тендер зарлах замаар гадаадын хөрөнгө оруулалтыг татах,
- Бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудал, жуулчны баазуудыг улсын зэрэглэлд оруулах, аажмаар олон улсын зэрэглэлд ойртуулах,
- Бүсийн хэмжээнд ажиллаж байгаа музейн үзвэрүүдийг шинэчлэх, тохижуулах, гадаад хэл дээр тайлбар танилцуулга гаргах, орон нутгийн онцлогтой бэлэг дурсгалын үйлдвэрлэлийг дэмжих, туслалцаа үзүүлэх,
- Бүсийн хэмжээнд байгаа тусгай хамгаалалттай газар, хадны сүг зураг, буган хөшөө, хүн чулуу, хэрэгсүүр, бичмэл, эртний улсуудын дурсгалт зүйлүүдийг хамгаалалтыг сайжруулах, орчныг тохижуулах, гадаад, дотоодын жуулчдад зориулсан танилцуулга, зурагт каталог, альбомыг гадаад хэл дээр хэвлэж гаргах,

**Гарах үр дүн:** бүсийн хэмжээнд аялал жуулчлалын материаллаг бааз бэхжин гадаад, дотоодын жуулчдад зориулсан сурталчилгаа, тэднийг тав тухтай нөхцөлд үйлчлэх орчин сайжирснаар жуулчдын тоо нэмэгдэж ДНБ-нд салбарын эзлэх хувь дээшилнэ.

Бүс нутгийн хэмжээнд аялал жуулчлалын менежментийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, гадаад, дотоод сурталчилгааг сайжруулах талаар:

- Баруун бүсийн аймгуудын залуучуудыг аялал жуулчлалын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулиудад өргөн элсүүлэх сургуулиа төгссөний дараа ажлын байраар хангах, тогтвор суурьшилтай ажиллахад төв орон нутгийн болон бизнесийн байгууллагууд дэмжлэг туслалцаа үзүүлэх, сургалтын хөтөлбөрт байгалын аялал жуулчлал, хүрээлэн буй орчин, зэрлэг ан амьтан, жүгууртэн шувуудыг хамгаалах менежментийн сургалтыг хамруулах,
- Ховд, Улиастай хотуудад аялал жуулчлалын мэдээллийн төвийн дэргэд сургалт, семинар зохион байгуулах, түр сургалтаар салбарын ажиллагсадын мэргэшүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах,
- Баруун бүсийн аялал жуулчлалын холбооны ажлыг эрчимжүүлэх, төвийн болон орон нутгийн төрийн байгууллага, банк санхүү, хөрш хоёр орны жуулчны байгууллагуудтай нягт хамтран ажиллах,
- Мэдээлэл харилцааны хөгжил дэвшлийг Баруун бүсийн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн олон арга хэмжээ, хөтөлбөрүүдийг гадаад, дотоодод өргөн сурталчлах, мэдээлэл солилцох, видео хурал, сургалт зохион байгуулах, олон улсын арга хэмжээнд бүсийн төлөөлөгчдийг аль болох оролцуулах,
- Бүсийн хэмжээнд байгаа тусгай хамгаалалтын газар нутагт байгалын аялал жуулчлал хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулах, ялангуяа Юнескогоос Дэлхийн гайхамшигт үнэт зүйл, Дэлхийн шим мандлын нөөцийн зэрэглэлээр бүртгэж авсан бүс нутгийг гадаадад өргөн сурталчлах замаар байгалын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулах,

Баруун бүсэд аялал жуулчлалын дэд болон үндсэн чиглэлүүдийг тодорхой сэдвүүдээр шинээр боловсруулах, хуучныг боловсронгуй болгох талаар:

- *Байгаль, спортын чиглэлийн аялал:*

Баян-Өлгий аймгийн Толбо нуур, Дэлүүн, Булган сумдын нутаг дэвсгэрт Монгол Алтайн уулс, уулын цэнгэг Толбо нуур, мөстлөгийн ул мөр болсон морен, Чигэртэйн халуун рашаан, үзэсгэлэнт Хөхсэрхийн нурууг үзэхийн зэрэгцээ ууланд авирах, усанд сэлэх, завиар аялах, загас барих, дэлхийд ховордсон ирвэс, аргаль, янгир, суусар, шилүүс, хойлог зэрэг амьтан, шувуу дурандах, байгалын рашаан, казак үндэсний хоолоор үйлчлэх, бүргэдээр ан хийх зэрэг орон нутгийн онцлог олон сэдвээр аялалуудыг зохион байгуулж болно.

- *Байгаль, Түүх, соёлын дурсгалт газруудтай танилцах аялал :*

Баян-Өлгий аймгийн Бугат, Алтанцөгц, Баяннуур сумдын нутаг дэвсгэрт Мөнхдөш ууланд эртний сүг зураг, Түрэг бичээстэй хөшөө чулуу, Ховд голын хөндийд нэн ховордож буй алтан гургуул шувууг ажиглах, улсын хамгаалалтанд авсан Цагаан хөшөөт хэмээх газарт Түрэгийн үеийн хөшөөг үзэж сонирхохоос гадна аялал уулын түргэн урсгалт Хатуугийн болон Хавцлын голыг гаталж, алжаалаа тайлж амрах маягаар аялалыг зохион байгуулах

Баян-Өлгий аймгийн Сагсай, Цэнгэл, Улаан хус сумдын нутаг дэвсгэрт богино хэмжээний аялалыг Монгол Алтайн шинэсэн ой, үзэсгэлэнт Цагаан гол Ховд голуудын онцлог, Дэнжийн Улаан үзүүр, Шартээлийн эх гэдэг газарт эртний буган хөшөө, хиргисүүд, Даян нуурын эрэг орчим хүн чулуунууд, дэлхийн гайхамшигт үнэт зүйлд бүртгэгдсэн Цагаан салаа, Бага-Ойгор голын хадны зураг, уулын өврөөр 15км-ийн турш цувсан 1000 орчим зургийн цогцолбор, Хар ямаат гол, Сагсайн голын хөндийд хүн чулуун хөшөө, чулуун зэвсгийн олдвор бүхий 12 суурин газруудтай танилцуулахаар зохион байгуулах

Ховд аймгийн Чандмань, Зэрэг, Дарви сумдын нутаг дэвсгэрт Хар–Ус нуур, түүний зэгсэн шагшуурга, Хар нуур, Хомын хоолой, Дөргөн нуур зэрэг байгалын үзэсгэлэнт газруудаар аялахдаа ховор амьтан ургамал, жигүүртэн шувуу, зээрийн сүргийг харах, мөн хөөмийчдийн уугуул нутаг Чандманьд язгуур урлаг- хөөмийн аялгууг сонирхуулах боломжтой.

Ховд аймгийн Дуут, Манхан, Мөнххайрхан, Булган, Үенч, Алтай, Мөст, Цэцэг зэрэг сумдын нутаг дэвсгэрийг дайрч Алтайн их уулсаар аялах аялалыг зохион байгуулж болох юм. Энэ аялалын явцад Нэвтийн рашаан, Ази тивийн хувьд цорын ганц дурсгал хуучин чулуун зэвсгийн үеийн хадны зураг бүхий Хойт Цэнхэрийн агуй, Манхан сумын Тахилтын хотгорт хүннүгийн язгууртны булш, Ботгоны голын хавцал, Мөнххайрхан сумын Долоон нуурын Улаан толгой дахь эртний бичээс, Монгол орны хамгийн өндөр даваа болох Улаан даваа, торгууд ястны босгосон Харуул овоо, Булган гол, Үенч, Бодончийн үзэсгэлэнт хавцлууд, Алтайн өвөр говь, Говийн их дархан газрын “Б” хэсгийн баруун зах, Мөст сумын Бодончийн гол, Баянзүрх гэдэг газруудад орших эртний хиргисүүрүүд, буган хөшөөний цогцолборууд, чулуун зэвсгийн үеийн бууцуудтай танилцуулах зэрэг байгалын үзэсгэлэнт газар, түүх археологи, соёл, угсаатны зүйн сэдэв бүхий маршрутаар аялал зохион байгуулах, эсвэл дэд замналуудыг зохиож болох юм. Дээрх аялалуудын онцлог тал нь бүсийн нутаг дэвсгэрт амьдарч буй олон үндэстэн, ястны ахуй амьдрал, зан заншил, түүх соёлтой танилцах боломж олгож байгаа явдал юм.

Ховд аймгийн төв Ховд хот, Буянт, Дөргөн, Мянгад, Эрдэнэбүрэн сумдын нутгаар бүсийн тулгуур төвийн нэг болох Ховд хоттой танилцах, Буянт гол, Ховд гол, Хар ус нуур, Чоно харайх гол, Хөхсэрхийн нуруу, Цамбагарав уул, Ховд сумын Сөрт гэдэг газарт орших дүрс, тэмдэг бүхий эртний хөшөөтэй танилцах, морин болон тэмээн аялал, завиар явах, загас барих, усны шувууд ажиглах, өөлд, казак ард түмний ахуй амьдралтай танилцах хэлбэрээр зохион байгуулж болох талтай.

Увс аймгийн Тэс, Зүүнговь, Баруунтуруун, Цагаанхайрхан, Өндөрхангай, Зүүнхангай, Хяргас, Малчин сумдын нутгаар аялахад монгол орны хамгийн том талбай бүхий дэлхийн хэмжээнд хамгийн хойшоо түрж орсон Бөөрөгийн элс, түүний зүүн зах Алтан элс, хойт зах Манхт элс, Тэсийн гол, чацаргын их шугуй, Ханхөхий уул, Баруунтуруун сумын Харцагаан Ус гэдэг газарт Түрэг бичээст хөшөө, хүн чулуун хөшөөнүүд, хүчтэй газар хөдлөлтийн үр дүнд үүссэн дэлхийн хамгийн урт бөгөөд шулуун газрын



хагархай, Зүүнхангай сумын Зураагийн Улаанхадны зураг, Агартагийн агуй зэрэг байгалын үзэсгэлэнт газар, түүх соёлын дурсгалт газруудыг танилцуулах боломжтой.

Увс аймгийн төвийн дэргэдэх Чандмань ууланд хүрлийн сүүлч үеийн булш, Түрэг, Уйгар бичигт хөшөө, Тариалан, Наранбулаг, Завхан, Өлгий, Өмнөговь сумдын нутгаар аялал зохион байгуулахад мөнх цастай далайн түвшнээс 4000 гаруй метр өндөр Хархираа, Түргэн уул, Тариалан сумын Халхайтын дэнжид эртний булш, хүн чулуунууд, Хяргас нуур, Хартэрмэсийн рашаан, Завхан гол, Хар–Ус нуур зэрэг байгалын үзэсгэлэнт газар, түүх-археологийн сонирхолтой зүйлүүдтэй танилцах боломжтой.

Увс аймгийн Өмнөговь, Бөхмөрөн, Ховд сумын хэмжээнд эмчилгээний шавар бүхий Шаазгай нуур, Ховд сумын Шивэр голын Уу-ширэгт 17 м өндөр Гоожуурын хүрхэрээ, цэнгэг усгал Ачит нуур, Бөхмөрөн сумын Хөдөөгийн уушиг гэдэг газарт эртний Түрэг бичигтэй хөшөө, Үүрэг нуур Сагил сумын Цагаан голын аманд орших, саарал, ногоон туяа цацруулдаг Могоо хадат хошууны хадан дээрх амьтдын дүрс бүхий том, жижиг 100 гаруй зураг зэрэг байгалын үзэсгэлэнт газар, түүх археологийн сонирхол татахуйц олдвор, хадны зургуудтай танилцуулах аялалыг зохион байгуулах боломжтой.

Говь–Алтай аймгийн хэмжээнд Халиун, Цээл, Цогт, Бигэр сумдын нутгаар Тайшир нурууны шинэсэн ой, Шарга, Сухайтын говь, хар Азрагын нуруу, Цагаан гол, Цаган голын хөтлийн давааны Хүннүгийн үеийн хадны сүг зураг, тамга тэмдэг, шувуу, мал адгуусын 100 орчим зураг, Ээж хайрхан уул, Захуйн баянбүрд (жуулчны баазтай байсан), улсын тусгай хамгаалалттай Бурханбуудай уул, Бигэр сумын Бичигтийн бууц гэдэг газарт орших түрэг бичээс, сүг зураг бүхий хад, Бигэр нуур, Баянбүрд, Таван манхан элсэн шарлагын газар, заг бүхий хонхорт орших Алаг нуур зэрэг байгалын

## **Ес. ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ**

### **9.1 БҮС НУТГИЙН НУТАГШИЛТЫН ТҮҮХЭН ХӨГЖИЛ**

#### **Засагт хан аймгийн нутгийн гадаад хилийн үүсэл:**

Засагт хан аймгийн нутгийн гадаад хил нь Хөх өндрийн нурууны зүүн үзүүрийн Хөх – Өндөр уулаас Өмнөговь аймгийн Улаан цонжийн шавар овоо хүртэл 930 шахам км үргэлжилнэ.

Халхын Засагт хан аймгийн зарим хошууны ардууд нь эрт үеэс Монгол Алтайн нурууны зүүн хажуу ба өвөр талын Булган, Чингэл голууд болон Байтаг, Хавтаг уулууд, Хөх Өндөрийн нуруу, Тахийн шар нуруу, Эрээний нуруу, Балгантын нуруугаар Жигд цагааны говь, Цэнхэр номингийн говь, Сэрдийн говь хүртэл нутаглаж байжээ.

Манжийн Энх-Амгалан хаан нь Баруун Монголтой байлдах их цэргээ Алтайд байгуулахын тулд халх нарыг Алтайгаас Завханы Хөх даваа хүртэл дотогшлуулан татсан байна. Үүний дараа Баруун Монголын Зүүн гарын хаант улсыг байлдан дагуулах үедээ Баруун Монголоос бууж өгсөн зарим хошуу сумдыг эхний үед халхын нутгийн гүнд, сүүлийн үедээ Алтайн нуруунд суулгаж байжээ.

1733 онд Ховдын Буянтад суулгасан хэрэг шийтгэгч амбаныг зэрэг дэвшүүлж Ховдын хязгаарыг захируулснаар Засагт хан аймгийн нутаг дэвсгэр их хэмжээгээр хасагдан хавчигдах болжээ.

Засагт хан аймгийн нутгийн өмнө талын хэсэг нь баруун ба өмнө захаараа Жигд цагааны говь, Цэнхэр номингийн говь, Сэрдийн говиор хүрээлэгдэж байсны улмаас зуны улиралд ус ургамалгүй, халуун учраас хүн, амьтан амьдрах аргагүйгээс өөрийн нутгийн хойт хэсгийн уул, ус, бэлчээрийг түшиглэж амьдардаг байсан бөгөөд харин өвлийн улиралд Хавтаг уул, Хөх – Өндрийн нуруу, Тахийн шар нуруу, Эрээний нуруу, Идрэнгийн нуруу, Балгантын нуруу, Атас - Чингис уул, Хатан суудал, Сэгс цагаан богд зэрэг энэ уулсын завсрын Замын бэлх, Эхийн ус, Шар хулс, Цагаан бургас, Захуй, Зарман зэрэг баян бүрдүүдийг бараадан нүүдэллэж нутагладаг байлаа.

Засагт хан аймгийн баруун ба өмнөд зүгийн хилийн овоонууд нь дээр дурьдсан их говиудын зүүн хойт, зүүн захад тулсан уулуудад байгуулагджээ. Халхын Засагт хан аймгийн нутгийн гадаад хил нь байгаль, цаг уурын нөхцөлтэй уялдаатайгаар ийнхүү бүрдэл болгон тогтож ирсэн байна.

#### **Ховд хязгаар нутгийн хилийн үүсэл:**

Монгол улсын баруун зүгийн хил нь Ар Монголын Ховд хязгаарын захиргаанд шинэ торгуудын 2 хошууг Булган, Чингэл гол, хошуудын 1 хошуу, урианхайн 7 хошууг Алтайн нуруугаар; захчины 1 хошуу, есөн сумыг Үенч, Бодончид, дөрвөдийн 16 хошууг Заг байдрагаас Улаангомд шилжүүлэн өөлд,

мянгадын тус бүр нэг хошууг Ховдын голд нутаглуулж эдгээр 7 ястнаар нутгийн захиргааг бүрдүүлж байгуулжээ.

Ховд хязгаарын бүрэлдэхүүнд дөрвөд, захчин, урианхай, торгууд, хошууд, өөлд, мянгад ийм долоон ястан харьяалагдсаны зарим нь аймаг, олонх нь хошууд байсан байна.

- Манжийн хаан нь 1725 онд Баруун, Зүүн Монголын хооронд хил тогтоох комисс байгуулжээ. Ховдын хоовойн сайдын захиргаанд Ховд хязгаарын нутаг дэвсгэр баруун, зүүн тийшээ өргөжиж Алтайн нурууны ар, өврийг бүрэн хамаарах болжээ.

- Ховд хязгаар байгуулагдсаны дараа үеийн баруун хил нь хойт талаар их Алтайн нурууны ар талаар баруун тийшээ урссан Жасатер буюу Бүхтармаа голын дагуу, мөн түүний аргаар урагш эргэж Алагбэг голын адгаар Хар – Эрчис голд хүрээд түүнээс урагшаа Нарийн хар уулаар Өрөнгө нуурт хүрч өгсөн Улаанбоомын овоогоор өмнө зүг Нармандах уул, Байтагийн чанад дахь Баавгайн зоо гэдэг уулыг дайран зүүн тийшээ Огчин тооройн булагт хүрч байжээ.

- Алтайн нурууны хоёр этгээдэд орших олон хошуудыг нэгтгэн захирахад бэрхшээл тохиолдсон гэж 1838 онд хэрэг шийтгэгч нэгэн сайдын орон тоо нэмэгдүүлж, түүнд Их Хүрээнд ажиллаж байсан Халхын ван Доржмагнайг томилон Ховдын Буянтад суулгасан нь нэгэн дор хоёр адил эрхтэй сайд сууж байжээ.

Ховдын хязгаарын 10 хошууг Алтайн Шар сүмд захируулсны дараа Ховд хязгаар нь дөрвөдийн зүүн гарын 12 хошуу, мөн баруун гарын 4 хошуу, захчины 2 хошуу, мянгадын нэг хошуу, өөлдийн 1 хошуу бүгд 20 хошуутай үлджээ.

Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцэл 1921 онд ялж, феодалын ёсыг халж эхэлснээр олон зуун жил тогтож хэвшсэн Манжийн үеийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарьт өөрчлөлт, шинэчлэлт хийх нөхцөл бүрдсэн байна. Энэ үед Түшээт хан аймаг 21 хошуу, Сэцэн хан аймаг 25 хошуу, 9 тамгатай шавь, Сайн ноён хан аймаг 25 хошуу, тамгатай шавь 8-тай, Засагт хан аймаг 20 хошуу, тамгатай шавь 3-тай, Их шавь 200 гаруй отог, багтай, Дөрвөдийн 2 аймаг 16 хошуутай байв. Мөн Алтай Урианхай, Торгуудын 2, Захчин 2, Өөлдийн 1, Мянгадын 1 хошуу тус тусдаа биеэ дааж байв.

1922 оноос ноёд, тайж нарын үе уламжлан захирах ёсыг халж, аймаг, хошуудын нэрийг шинэчлэн тогтоожээ. 4 аймаг, 116 хошууг урьдын адил засаг ноёдын нэрээр нэрлэхийг зогсоож, ард олны сайн мэдэх томоохон уул буюу газар усны нэрээр нэрлэх болжээ.

1923 онд Засагт хан аймгийг Хантайшир уулын аймаг хэмээн нэрлэхээр тогтжээ. 1925 оноос Дөрвөдийн 2 аймгийг Ховдын хязгаартай нэгтгэж Чандмань уулын аймаг гэх болов. Энэ үед манай улс 5 том аймагтай болсон байв.

1930 оны 6 сард хуралдсан Улсын VI их хурал Монгол улсын нутаг дэвсгэрийн хуваарийг газар зүй, эдийн засгийн чиглэлээр ангилж, орон нутгийн засаг захиргааг үндсээр нь өөрчлөх шийдвэр гаргасан нь засаг захиргааны хуваарийн томоохон шинэчлэлийн эхлэл болжээ. 1931 оны 11 сарын 6-нд Улсын бага хурлаас засаг захиргааны хуваарийг шинэчлэх тухай шийдвэр гаргаж, томоохон аймгуудын нутаг дэвсгэрийн хэмжээг багасган шинэ аймгуудыг байгуулж 13 аймагтай болжээ. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүд 4 шатанд /аймаг, хошуу, сум, хорин/ хуваагдаж байсны оронд 3 шатлалтай /аймаг, сум, баг/ болсон байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг тогтоохдоо орон нутгийн хүн амын нягтшилт, аж ахуй эрхлэх өвөрмөц байдал, газар усны онцлогийг харгалзсан нь ихээхэн дэвшилтэд шинж чанартай арга хэмжээ болсон юм.

1950 –иад оны сүүлчээр багийг татан буулгаснаар хөдөөд аймаг, сум гэсэн хоёр засаг захиргааны нэгжтэй болсон юм. Энэ үеэс нийт сумдын иргэд нэгдэлжих хөдөлгөөнд хамрагдах болсон тул сумыг сум – нэгдэл, багийг бригад болгож сум – нэгдлийн нэгдмэл удирдлагын тогтолцоог бий болгон хоёр хуралтай нэг удирдлагатай зохион байгуулалтанд оруулжээ. Шинээр аймаг байгуулах үйл явц цаашид үргэлжилж 1990 –ээд он гэхэд 18 аймагтай болж, сумын тоо ч өөрчлөгдсөн байна.

Шинэ Үндсэн хуулийн хүрээнд хийсэн өөрчлөлтүүд: “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль” –иар аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэг, дүүрэг нь хороонд хуваагдах болсон байна. Монгол Улсын Их Хурлын 1992 онд баталсан дээрх хуулиар сумдыг тусгайлан олгосон чиг үүрэг, зорилготой, түүнийгээ хэрэгжүүлэхэд эдлэх эрх мэдэлтэй, өөрийн болон төрийн удирдлагатай, хилийн цэс бүхий нутаг дэвсгэртэй, биеэ дааж ажиллах бодлого чадамжтай, эдийн засаг нийгмийн цогцолбор болгоход ихээхэн анхаарсан байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн өнөөгийн байдал: Одоо мөрдөгдөж байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь нь хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуй бүрт газар олгох зарчим дээр тулгуурлан 1959 онд хэт жижгэрсэн нэгжүүд болон хуваагджээ.

Нутаг дэвсгэрийн хувьд жижгэрсэн, бэлчээрийн малын экологийн зохистой нутаг жигд хуваарьлагдаагүй, төвийн байршилт буруу болсон зэргээс болж эдийн засгийн хувьд хэт үрэлгэн, нүүдэлчин ард түмнийг жалгын мухар сахиулж байлгах хэрэгсэл болгож, хүн амын удам угсааг булингартуулах, амь насанд халтай шинжийг агуулж байна. Иймээс бүс нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг өөрчлөх шаардлагатай болох нь батлагдаж байна.

Нутаг дэвсгэрийн хувьд сумд 1956 оны аж ахуйн хоорондын газар зохион байгуулалтаар зураглан хувааж нэгдэл, САА-д олгоод 1973-1975 онд зарим тодотгол хийсэн нутаг дэвсгэрт одоо хүртэл оршин байна. Тэр нутаг дэвсгэрийг аж ахуйн шинж байдлаар хуваарилсан. Тухайлбал:

- Нэгдлүүдийг байгуулахдаа (1956 оны үед) хvн ам, байгаль-эдийн засгийн болон зам харилцааны нөхцлийг биш, хуучин сум, шинэ аж ахуйн төвийг баримжаалсан;
- Хөдөөгийн сумдын нутаг дэвсгэр нь цаг улирал, бэлчээрийн хэмжээ даацын хувьд ирээдүйг харгалзаагүй учир бэлчээр нутгийн маргаантай сум цөөнгүй байна.
- Баг татан буугдаж 7-15 багийн оронд нэгдлийн 2-5 бригадад нутгаа хуваах болсон бөгөөд тэр нь хэмжээний хувьд малын терлээс хамааран ихээхэн зөрөөтэй болсон;
- Багийг дахин сэргээхдээ зөвхөн “бригад”-ыг “баг” гэж нэр сольсон учир нутгийн хэмжээ их зөрүүтэй хэвээр. Одоогийн баг батлагдсан нутгийн хилийн цэсгүй байна.

1960-аад оноос нутаг дэвсгэрийн зарчмаас татгалзаж аж ахуйн нэгж, хот сууринг сумтай адил статус бүхий хот, хороо гэх суурь нэгж болгож эхэлснээс нутаг дэвсгэргүй шахам сум төвүүдэд бий болжээ.

- Газрын 90-ээд хувь, тэр дундаа бэлчээр, тvнчлэн хот суурингийн дэвсгэр газар төрийн өмч боловч тvннийг улс, аймаг, сум, дvврэг гэсэн эзэмшлийн хуваарьт тогтолцоо, дэглэм байхгvйгээс газрыг “манайх мөн, биш” гэсэн хоёрдмол хандлагад автсан байна.
- Сумын (“аж ахуйн” гэх) дотоод зохион байгуулалт хийгээгүйгээс сум, багийн хурал захиргаа л газрын ангилал, бэлчээрийн хуваарь хийж эзэмшүүлж байна.
- Нутаг дэвсгэрийн шинэчлэлийн үндсийг судалж, боловсруулахад физик газар зvй, ургамал хадлан бэлчээр, газар зохион байгуулалт, түүхэн хийгээд байгаль экологи, эдийн засгийн газар зvйн хавсарга судалгаа ч хийх хэрэгтэй байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг боловсронгуй болгосноор хөгжлийн нөөц боломжийг илүү үр дүнтэй, зохистой ашиглах боломж нөхцлийг нээж, бүрдүүлэх юм. Энэ боломжийг бид ашиглахгvй байгаа төдийгүй хөгжилд тээр болж байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуучирсан хуваарийг өөрчлөх талаар судалгаа дүгнэлт хийх ажил хоцорч байна.

### **Говь-Алтай аймгийн хилийн үүсэл:**

Засагт хан аймаг томоохон аймгийн нэг байсан бөгөөд хошууд нь зүүн хойд талаасаа “таван хотгойд”, “хоёр эрчигэн (иржигин)”, “сартуул нэг”, “гурван олохунуд”, “таван бэсүүд”, “хоёр урианхан”, “хойдын нэг” гэх мэтээр нэрлэж, эхний 8 хошуу нь хангай талыг түшсэн нутагтай, хүн, мал хөрөнгөөр “дунд зэрэг”, говийн 12 хошуу нь ядуувтар байжээ. Гэхдээ хангайн 8 хошууны дотор Ахай бээсийн, Далай гүний, Мэргэн гүний зэрэг маш жижиг хошууд ч байжээ. Өмнөговь аймгийг 42002 хүн ам, 17 сум, 1292459 толгой мал, 216078 ам дөрвөлжин км газар нутагтай байхаар төлөвлөж байсан нь Алтай аймаг байгуулахад хүн ам, малын тоо, газрын хэмжээ нэлээд бага болжээ.

Засгийн газрын тогтоолыг үндэс болгон нутаг дэвсгэр, засаг захиргааны өөрчлөлтийг 1931 онд хийсэн. Анхны төлөвлөлтөөр Алтай аймаг “Өрнө говь” аймаг гэсэн нэртэй байхаар төлөвлөгдөж байв. Шинээр байгуулагдах 13 аймгийг “анги” гэж нэрлээд тэдгээрийг нийтэд нь бас гурван “анги” (зэрэг) болгожээ. “Өрнө говь” буюу Алтай аймаг жижгэвтэр Өмнөговь, Дорноговь аймгийн хамт III ангид оржээ.

1931 оны 4 сарын 1-нд Завхан аймгийн түр хороо Хан Тайшир уулын аймгийн яамыг татан буулгажээ. Үүгээр 1924 онд байгуулагдсан 5 аймгийн нэг Хан Тайшир уулын аймаг оршин тогтнохоо зогсоожээ. 1931 оны 3 сарын 14 –нээс 4 сарын 28-ны хооронд шинээр байгуулагдах Алтай аймгийн 17 сумын ардын төлөөлөгчдийг сонгожээ. Хуучин Хан Тайшир уулын аймгийн Хан Тайшир, Бүс хайрхан, Гурван сайхан Жаргалант, Сутай уулын хошуудаар голлон Алтай аймаг байгуулагдсан байна. Хан Тайшир уулын аймгийн зонхилох хошууд нь Завхан, Алтай хоёр аймаг болон хуваагдаж, бусад нь Ховд, Увс, Хөвсгөл, Архангай, Өвөрхангайд (дараа нь Баянхонгор аймагт) шилжжээ.

Алтай аймаг 17 сум, 134 баг, 7575 өрх, 34436 хүн ам, 1300 мянган толгой малтайгаар байгуулагдсан ажээ. 1931 онд Алтай аймаг 17 сумтай байгуулагдаж байсан бол жилийн дараа 16 сумтай болж нэг сумын ард бараг бүтнээр гадаадад оргон гарчээ. Гадаадад оргосон болон буцаж дээрэм тонуул хийгчдийн орогнож байсан гэх Амарбуянт, Төгрөг, Харнуудын хийдийг хааж, хөрөнгийг хурааж, лам нар нь тарсан боловч 1932 оны сүүлээс үлдсэн лам нар нь дахин цуглаж хурал номын ажлаа сэргээжээ.

Завхан аймгаас Алтай аймгийг буцаан салгаж 1940 онд шинэ Говь-Алтай аймгийг байгуулсан байна. Говь-Алтай аймгийн төвийг ард түмний санал, шүүмжлэлийг харгалзаж, харьяа сумдтай харилцахад зүүн өмнө зүг Архангайгаас шилжин ирсэн Баянцагаан гол 11 өртөө 330 км, хамгийн хол болох ба бусад баруун ба өмнөд зүгийн сумд нь 5-9 өртөө буюу 240 км газруудад багтах ба ойр дөхөм харилцаатай, аймгийн төвийн ирээдүйн хөгжилд байшин барилга барих зэрэг тохиромжтой баруун зүгтээ 5 км-ээс хол бус Тайширийн нуруу нь ойр, бага зэрэг модтой гэх мэт нөхцлийг харгалзан туйлуу, шүү боловсруулахад урьдын туршлагатай Түмэн сумын нутаг Олон нуур хэмээх газарт төвлөрүүлэхээр тогтжээ.

### **Завхан аймгийн хилийн үүсэл:**

1923 онд байгуулагдсан таван аймгийн нэг юм. Завхан аймаг нь еерийн иисэл хөгжлийн евермец тийхтэй юм. Тус аймгийн Заг сум нь тэр үед Сайн ноён ханы аймгийн Эрдэнэ жүн вангийн хошууны нутаг байсан бололтой. Эрдэнэ жүн вангийн хошуу Засагт хан аймгийн ямар хошуутай ойр буюу хил нийлж байсныг үзэхэд энэ хошуу нь Манжийн үед Халхын хойд замын баруун гарын хойтох хошуу буюу товчоор баруун гарын баруун хойд хошуу гэгдэж байсан бөгөөд Засагт хан аймгийн Засагт ханы хошуутай хиллэдэг байжээ.

1931 онд хошуудыг татан буулгаж олон аймаг байгуулах хиртэл оршин тогтносон юм. 1931 оны 2 сарын 18-ны өдрийн Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор Хантайшир уулын аймгийг татан буулгаж Завхан аймгийг байгуулах шийдвэр гарав. Хантайшир уулын аймгийн Нөмрөг уулын хошуу /Хуучин Засагтхан аймгийн Цогтой вангийн хошуу/, Цэцэн сартуул хошуу /хуучин Засагтхан аймгийн Цэцэн сартуул вангийн хошуу/, Гурван сайхан Жаргалант /хуучин Засагтхан аймгийн Баатар вангийн хошуу/, Цэцэрлэгмандал уулын аймгийн Отгонхайрхан уулын хошуудаас /хуучин Сайн ноён хан аймгийн Хошууч мэргэн засгийн хошуу/ анх Завхан аймгийг байгуулжээ.

Ийнээс хойш Завхан аймгийн битэц бас еерчлөгдсөн бөгөөд 1931 онд дахин салж одоогийн Говь-Алтай аймаг, 1933 онд Завхан аймаг нийлж 1940 онд дахин салж одоогийн Говь-Алтай аймгийг байгуулсан ба 1942 онд Гурвансайхан Жаргалант уулын хошуунаас иссэн Хөхморьт, Дэлгэр, Баян-Уул сумууд Завхан аймгийн харъяаллаас гаргаж шилжүүлэн өгчээ.

### **Ховд аймгийн хилийн үүсэл:**

Манай эриний XII-XIII зууны үед Байгаль нуурын орчим Соёны уул, Тагна уул, Орос, Монгол, Хятад, Алтайн ой тайгад нутаглаж ой шугуй, гол мөрөн, уул хад дамжин ан герее хийж, загас барьж амьдардаг нүүдэлчин аймгийн иргэдийг “Ойн ард” хэмээн нэрлэдэг байсан нь явсаар Ойрад болсон гэж түүхийн сурвалж бичгүүдэд олонтоо тэмдэглэгдсэн байдаг. Их монгол улсыг байгуулахад Монгол гаралтай Ойрад хэмээх хүчирхэг аймаг хүндтэй үүрэг гүйцэтгэжээ.

1691 онд халх манжид эзлэгдсэнээс хойш Ойрадын Зүүн гарын хаант улс 70 шахам жил тусгаар тогтнолоо хамгаалан тэмцээд 1750 оны сүүлчээр манжид эзлэгджээ. Ард түмний олон жилийн баатарлаг тэмцэлд хорссон манж нар Ойрадын хаант улсын зохион байгуулалтыг эвдэн Ховдын хязгаарыг Дөрвөдийн нэг чуулган, хоёр аймаг, 16 хошуу, Торгуудын чуулганы гурван хушуу, Алтайн урианхайн 7 хушуу, захчины хоёр хушуу, Мянгад, Ёелдийн нэн нэг хушууг хамруулан байгуулжээ. Ховдын хязгаар Халхын дөрвөн аймгийн нэгэн адил эрхтэй байсан юм. Богд хаант төрийн автономит Засгийн газрын үед Ховдын хязгаар нь Монгол улсын зургаан аймгийн хоёр нь болжээ. Дөрвөдийн Зүүн гарын Бат-Ереелт тегс хвлэг Далайхан аймаг 12 хушуутай, хөвөөт цагаан өнгөт тугтай, баруун гарын үнэн Зоригтхан аймаг 15 хушуутай, хөвөөт шар тугтай байв.

Ардын хувьсгал ялсны дараа “Дөрвөд” хэмээх яс угсаагаар ялгаатай хуучин нэрийг халж Чандмань уулын аймаг хэмээн нэрлэхээр шийдвэрлэжээ. Энэ аймагт Цамбагарав уулын Тегс Буянтхан уулын, Баян Мандал уулын, Хөхүй уулын Наранхайрхан уулын, Баян Чандмань уулын, Ханбаатар хайрхан уулын 8 хушуу, 41 сум, 115 баг хамрагдаж байв.

БНМАУ-ын Засгийн газраас 1931 оны 2 дугаар сард хушуудыг еерчилж, эдийн засгийн талаар аймаглах хууль гаргажээ. Нутаг дэвсгэрийг шинэчлэн ангилах тухай хуулийг баримтлан Чандмань уулын аймгийг Ховд, Увс хоёр аймаг болгосон байна. Тэр үед Ховд аймаг 7 хушуу, 12 сумтай байсан

байна. Ховд аймгийн казах, урианхай сумдаар бүрэлдэхүүн болгож Баян-Өлгий аймгийг 1940 онд байгуулахад Ховд аймаг 13 сумтай үлдсэн юм. БНМАУ –ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 2 сарын 7 –ны өдрийн 5 дугаар тогтоолоор Алтай, Булган, Буянт, Дарви, Зэрэг, Манхан, Мянгад, Үенч, Цэцэг, Чандмань, Эрдэнэбүрэн сумд тус тус байгуулагджээ.

Дөргөн сумыг 1955 онд Мянгад сумын 1, 5, 6-р баг, Увс аймгийн Завхан сумын 7, 8-р багуудаар байгуулаад 1963 онд татан буулгаж, Мянгад суманд нийлүүлсэн байна. БНМАУ–ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1978 оны 12 сарын 5-ны өдрийн 303 дугаар зарлигаар Дөргөн сумыг дахин байгуулжээ.

1929 оны сүүлчээр торгуудын 2 хошуу, хошуудын нэг хошууг нэгтгэн Булганмандал Бүрэнхан уулын хошуу хэмээн нэрлэж Булган голын өмнөд этгээдэд Баянсуудал хэмээх нутагт суурьшуулжээ. 1931 онд Ховд аймгийг байгуулахад дээрх хошуугаар Булган сумыг байгуулав. Дуут сумыг 1942 онд Буянт сумаас тасалж байгуулсан байна. 1956-1958 онд түр татан буулгаж, 1, 8-р багийг Буянт суманд, 2, 3, 4, 7-р багуудыг Манхан суманд шилжүүлсэн бөгөөд 1959 онд дахин сэргээжээ.

Мөст сумыг 1959 онд Мөнххайрхан, Манхан сумдаас тасалж байгуулав. Харин Мөнххайрхан сумыг 1936 онд Алтай сумаас тасалж байгуулав. 1965 онд татан буулгаж, Манхан, Мөст суманд нийлүүлсэн боловч 1968 оны 12 сарын 6-нд БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 248 дугаар зарлигаар Мөнххайрхан сумыг буцааж байгуулжээ.

Үенч сумыг 1956 онд татан буулгаж, Булган суманд түр нийлүүлээд, 1959 онд дахин сэргээв. Ховд сумыг 1946 онд Баян-Өлгий аймгийн Дэлүүн, Толбо, Хужирт сумдаас тасалж казах иргэдээр шинээр байгуулсан юм. 1955 онд Ховд аймагт шилжиж иржээ.

Монгол Улсын Их Хурлын 1994 оны 5 сарын 6-ны өдрийн 33 дугаар тогтоолоор Ховдын төвийг Жаргалант сум болгон нэрлэхээр тогтжээ.

#### **Баян-Өлгий аймгийн хилийн үүсэл:**

Казах, урианхайн ард түмний хүсэлтийг хүлээн авч 1940 оны 6 дугаар сард хуралдсан Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор Ховд аймгаас таслан Баян-Өлгий аймгийг биеэ даасан аймаг болгон байгуулсан юм. Тэр үед Толбо нуур, Баяннуур, Хужирт, Цагаангол, Цагааннуур, Улаанхус, Дэлүүн сумд казахууд, Алтанцөгц, Цэнгэл, Жаргалант, Сагсай суманд урианхайчууд голлож байв.

Урианхайн Итгэмжит засгийн хошуунаас үүсэлтэй агаад эхлээд 1927 – 1929 онд Алтай ханы зүүн хошуунд багтаж байгаад 1936 онд зүүн, баруун 2 хошуу нэгдэж байгуулагдсан Алтай хан уулын хошууны бүрэлдэхүүнд казахын 4 хошуу бий болсноос 1936 онд Сагсай сум, 1938 онд Улаанхус сум үүсэв.

Урианхайн Зүлэгт гүний хошуунаас үүдэлтэй бөгөөд 1927 – 1929 онд Алтай ханы хошуунд багтаж яваад 1929 – 1936 онд Алтай ханы хошууны бүрэлдэхүүнд орсон 7 хошуунаас 1936 онд Алтанцөгц, 1938 онд Баяннуур, 1952 онд Ногооннуур сум, 1959 онд Бугат сумд үүсч байгуулагдав.

Урианхайн зетэй гүний хошуунаас үүдэлтэй, эхлээд Алтай ханы зүүн хошуунд багтаж байгаад, баруун, зүүн 2 хошуу нэгдсэнээс 1956 онд Цэнгэл сум үүссэн ба мөн онд Цагаан голын Тува нар (Мончого) нутаглах болов. Урианхайн Ёгт гүнийг хошуунаас үүдэлтэй бөгөөд 1927 – 1929 онд Алтай ханы баруун хошуунд багтаж байгаад нэгдсэн Алтай ханы хошуунаас 1955 онд Алтай сум, 1924 онд Буянт сум бүтнээрээ үүссэн ба 1936 онд байгуулагдсан Сагсай сум, Бугат сумын нутгийн хагас эндээс бүрдэх болов.

Урианхайн Зүүн гарын Зоригт засгийн хошуунаас 1938 оноос Улаанхус, 1936 оноос Цэнгэл сумын хагас нутаг бүрдэх болов. 1936 онд Ховд аймгийн харьяанд Урианхайн хошуудаас анх Алтанцөгц, Жаргалант, Сагсай сумдыг, 1938 онд казах хошуудаас Баяннуур, Дэлүүн, Толбо, Хужирт Улаанхус, Цагаангол сумдыг байгуулсан ажээ. Алтанцөгц сум 1925 онд үүссэн Чандмань уул аймгийн Алтанцөгц нуур нэртэй сумын, мөн Дэлүүн сум 1938 онд казахийн Ботохора, Хошах, Тайлак сумдын суурин дээр тус тус байгуулагдав. Дэлүүн сумаас 1959 онд Далайкул нэртэй сум тасалж байгуулаад, 1966 онд буцаан нэгтгэв.

1922 – 1932 онд Говь-Алтайн Хасаг Жаргалант, Завханы Алаг уул зэрэг газраар нутаглаж байгаад 1936 онд Ховдын Эрдэнэбүрэн, Алтанцөгц сумдын нутгийн завсраар нутагшуулж суулгасан Жингекей, Ботохора овгийн казах хүмүүсээс бүрдүүлэн 1938 онд Баяннуур сумыг байгуулав. 1964 онд Баяннуур САА болжээ. 1959 онд Баяннуур сумаас Акарал сумыг тасалж байгуулаад 1961 онд буцаан нэгтгэв.

Бугат сумыг 1959 онд Алтанцөгц, Сагсай сумдаас, Буянт сумыг 1942 онд мөн Сагсай сумаас тасалж байгуулав.

Ногооннуур сумыг 1952 онд Цагааннуур сумын 4, 5, 6, 8, 10, 14 дүгээр багуудаар байгуулав. 1956 онд татан буулгаж, 5, 6 дугаар багийг Алтанцөгц суманд, 3, 4 дүгээр багийг Буянт суманд, 1, 2 дугаар багийг Улаанхус суманд шилжүүлээд 1959 онд дахин байгуулсан. Толбо сумыг 1938 онд казахийн Ботохора хошууны 1, 2, 4, 7 дугаар багаар Ховд аймгийн харьяанд Толбо нуур сум нэртэй байгуулсан. 1940 онд Баян-Өлгйд шилжив. 1959 онд энд сумаас Баян энгэр сумыг тасалж байгуулаад, 1961 онд буцаан нийлүүлэв.

Улаанхус сумыг 1938 онд казахийн Шерүч хошууны Бахад сум, Цагаангол сумын зарим багаар Ховд аймгийн харьяанд байгуулжээ. 1940 онд Баян-Өлгий аймагт шилжив. Цэнгэл сум 1936 онд Ховд аймгийн харьяанд Цэнгэлхайрхан нэртэй байгуулагдан, 1940 онд Баян-Өлгий аймагт шилжив. 1938 онд казахийн Шерүч хошууны хагасыг Курман Санрау сумаар тасалж Цагаан гол сумыг байгуулаад, 1963 онд тус суманд нэгтгэж “Цэнгэл” нэртэй болжээ.

Цагааннуур сумыг 1938 онд Ховд аймгийн харьяанд байгуулжээ. Үндсэн хүн ам нь дөрвөдүүд. Энд дөрвөд Далай ханы хошууны шами нар, таргад, дураал, борогчууд, шаазгай, гөлөгөд, цоохорчууд, ортос зэрэг 8 отгийн хүмүүс нутаглаж байв. 1938 онд казахууд шилжин нутаглах болж, казахийн Бахат сумын 4-р баг, Бөхмөрөн сумын 1, 2, 3-р багаар эмхлэгдэн байгуулагджээ. 1963 онд дамжлага баазыг харьяалан байгуулсан Цагааннуур хороо болсон. Одоо сум болсон.

Өлгий сум нь Баян-Өлгий аймгийн төв болно. 1940 онд Баян-Өлгий аймгийг байгуулан, энд төвлөрүүлснээр эх суурь нь тавигдсан юм. 1961 оноос Өлгий хот гэх болжээ. 1994 онд 5 дугаар сарын 6-ны өдөр Монгол Улсын Их Хурлын 33 дугаар тогтоолоор Өлгий хотыг сум болгов.

1998 оны байдлаар Баян-Өлгий аймаг 14 сумтай, 19159 өрх, 96.2 мянган хүн амтай байна.

### Увс аймгийн хилийн үүсэл:

Увс аймаг анх 1925 онд Чандмань уулын аймаг нэртэй байгуулагдсан бөгөөд 6958.5 мянган га талбайг эзлэн оршдог манай улсын олон үндэстэн ястнуудын өлгий нутаг юм.

1920 –д оны эхээр засаг захиргааны шинэ зохион байгуулалт хийж эхлэх үед Дөрвөд Далай ханы аймаг, Зоригт ханы аймгийг нэгтгэж 1925 онд Чандмань уулын аймгийг байгуулж, Улаангомд төвлөрүүлэв. Тэр үед Дөрвөд далай ханы аймагт захирагдсан баядын 10 хошуу, Зоригт ханы аймагт захирагдсан баядын Ерөөлт бэйсийн нэг хошуутай нэгдэн Баянмандал уулын хошуу хэмээх 10 сумтай болов. Зоригт ханы аймгийн дөрвөдийн үлдсэн 3 хошуугаар 3 сумтай Баянчандмань уулын хошууг байгуулаад Чандмань уулын аймагт захируулжээ.

Увс аймгийн анхны их хурлаар Дөрвөд аймаг нэртэй байгуулаад 1934 оноос Увс нуур аймаг гэж нэрлэн төвийг нь Улаангом гэж тогтжээ.

Чандмань уулын аймгийн Баянмандал уулын хошуунаас одоогийн Увс аймгийн Хяргас, Малчин, Тэс, Зүүнговь сумд байгуулагдав. Харин Баянчандмань уулын хошуунаас Өмнөговь, Өлгий, Тариалан, Давст, Улаангом, Чандмань сумд байгуулагдав. Эдгээрээс гадна Төгсбуянт уулын хошуунаас Бөхмөрөн, Сагил, Түргэн сумд бүтнээр, Давст сумын хагас нутаг, мөн Хантайшир уулын аймгийн Ханхөхүй уулын Баруунтуруун хошуу, зүүн Хөхүй уулын хошуу, Цэцэн сартуулын хошуунаас зарим сумын нутаг орох болжээ.

Ингээд Увс аймгийн одоогийн нутаг дэвсгэр нь Сайнзаяатын зүүн гарын Далай ханы аймаг, баруун гарын Зоригт ханы аймгийн нутгийн дийлэнх, Засагт ханы аймгийн Чин ачит вангийн хошуу, Зоригт засгийн хошуу, Цэцэн сартуулын хошууны нутгийн хэсгээс бүрдэл болсон.

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 2-р сарын 7-ний өдрийн тогтоолоор Баруунтуруун, Бөхмөрөн, Давст, Завхан, Зүүнговь, Зүүнхангай, Малчин, Өмнөговь, Өндөрхангай, Тариалан, Түргэн, Тэс, Ховд, Сагил, Хяргас, Улаангом сумд байгуулагдав. Наранбулаг сумыг 1952 онд Өмнөговь сумын 6, 8, 9 –р баг, Тариалан сумын 6, 7, 8-р баг, Малчин сумын 2 багаар анх байгуулсан. 1956 онд татан буулгаж, 1, 2-р багийг Малчин суманд, 3-р багийг Завхан суманд, 4, 5, 6-р багийг Өмнөговь суманд, 7, 8-р багийг Тариалан суманд шилжүүлжээ. 1959 онд иргэдийн хүсэлтээр дахин сэргээж байгуулсан. Өлгий сумыг 1959 онд Хяргас, Туруун сумаас тус тус тасалж байгуулав.

1956 онд Улаангом сумыг татан буулгаж, 4, 9-р багийг Түргэн суманд, 6-р багийг Давст суманд, 5, 7, 10, 11-р багийг Тариалан суманд шилжүүлж, 1, 2, 3-р багуудыг бүтнээр, 4, 11-р багийн хагасыг эмхэтгэн нэгтгэж, Улаангом хороо захиргаа байгуулав. 1959 онд хуучин Улаангом сумаас бусад сумдад шилжүүлсэн газар нутаг, хүн амыг буцаан нэгтгэж, Чандмань сумыг байгуулав. УИХ-ын 1994 оны 33-р тогтоолоор Увс аймгийн төвд Улаангом сум байгуулснаар Чандмань сум гэхээ больсон. Аймгийн төвийн анхны суурин 1750–иад оны үед “Дөрвөд далай ханы хүрээ” нэртэй байгуулагдан, хожим Улаангомьн хүрээ гэх болсон ажээ.

1931 онд бүрэлдсэн Увс аймгийн сумдын бүтэц, зохион байгуулалтад бага зэрэг өөрчлөлт орсон хэдий боловч үндсэн хэсэг нь одоо хүртэл хэвээр байна. Харин 1986 онд байгуулагдсан Хархираа сумыг 1999 онд татан буулгаж Тариалан суманд нэгтгэсэн.

## **9.2 БҮС НУТГИЙН АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ**

Эдийн засаг, газарзүйн ухаанд аль нэг улс орон, түүний засаг захиргааны нэгж болох аймаг, сум, хот суурингийн буюу эдийн засгийн объектын байрлалыг түүнтэй ямар нэг талаар харилцан холбоо бүхий бусад улс орон, олон улсын шинж чанартай аж үйлдвэрийн төв, зам, гүүр, барилга, байгууламж зэрэг хүний гараар бүтээгдсэн эдийн засгийн объекттой харилцан хамааралтай.

Эдийн засаг, газарзүйн тааламжтай байрлал улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд зохих нөлөө үзүүлдэг. Энэ нь ихэвчлэн зам тээвэр зэрэг дэд бүтцийн хөгжлөөр илэрдэг.

Баруун бүсийн газарзүйн байрлал, орон зайн хувьд авч үзвэл эдийн засгийн асар их багтаамж бүхий ОХУ, БНХАУ гэсэн хоёр том зах зээлийн дунд, олон улсын зам харилцааны уулзварт байгаа зэрэг нь олон улсын хөдөлмөрийн хуваарьт идэвхитэй оролцох боломж нэмэгдэж, улс төр, нийгэм, оюуны харилцаа улам өргөжих нөхцлийг бүрдүүлж байна.

### **9.2.1 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг шинэчлэх байгаль, нийгэм эдийн засгийн хүчин зүйл**


Байгаль, цаг уурын өөрчлөлт, малчдын идэвх суларч, мал маллагааны арга алдагдаж, бэлчээр талхлагдаж, бэлчээрийн мал аж ахуйг цаашид хөгжүүлэх боломж улам хүндэрч нүүдэлчид нь хөрөнгө мөнгөө шавхан, төрж өссөн нутгаасаа амьдрахын тулд нүүдэллэж байна. Ийм нөхцөлд нүүдэлчдийн амьдрал ахуйг одоогийн байдалд нь урсгалаар хаясан, төрийн бодлогын уршиг нийгэм – эдийн засгийн хөгжилд хохиролтойгоор мэдрэгдэж байна.

Энэ бол нүүдлийн соёл иргэншлээс суурин соёл иргэншилд шилжих язгуур эрх ашгийн төлөөний хувьсгал эрчимжиж буйг харуулж байна. Нүүдэлчдийн соёл иргэншлийн энэхүү хуулийг зөв ойлгож, хохирол багатай гарах гарц бол Монгол улсын нийгэм эдийн засгийг тэнхлэгээр хөгжүүлэх үзэл баримтлал юм. Үүнд тулгуурлан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг хийх ёстой.

Нүүдлийн соёл иргэншлээс суурин соёл иргэншилд шилжихдээ хот суурин, зам (тэнхлэг) даган тосгонжиж, суурьших явдал элбэг тохиолдож байна. Тэгвэл засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг шинэчлэхэд хот суурин, зам (тэнхлэг) –ын үүрэг их байх юм.

Олон улсын эдийн засгийн даяарчлалын хөрөнгө санхүү, техник технологийн хүчтэй урсгалыг зөв байршилттай нийгэм – эдийн засгийн тэнхлэг түүний дагуу хүн амын хөгжлийн зохистой нягтшил бүрдүүлэн угтан авах үндэсний менежментийн чадавхитай байвал баруун бүсийн нийгэм – эдийн засгийн хөгжил эрчимжинэ.

**МОНГОЛ ОРНЫ ЗАСАГ ЗАХИРГААНЫ ХУВААРЬ  
1940-1994**



- ТОМЬЕОЛСОН ТЭМДЭГ
- УЛСЫН НИЙСЛЭЛ
  - БҮСИЙН ТҮЛГҮҮР ТӨВ
  - АЙМГИЙН ТӨВ
  - УЛСЫН ХИЛ
  - БҮСИЙН ХИЛ
  - АЙМГИЙН ХИЛ

Зураг 0 7



Бүс нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг хийхдээ эдгээр үндсэн тэнхлэгийн ирээдүйн суурь болох замын дагуу юуны өмнө эрчим хүчээр хангаж, нүүдэлчдийн суурьшилд шилжиж байгаа үүсэл санаачлагыг дэмжиж зохион байгуулахын тулд одоогийн зам дээр байгаа хот суурин, сумдын төвийг хэвээр үлдээж, шинээр байгуулах аливаа аж ахуйн нэгжийн төвүүдийг тэнхлэг дээр авах нь зах зээлийн эдийн засагт шилжих хүн амын хөгжлийн зохистой нягтшил хурдан бий болох замаар ирээдүйн “босоо хөгжил” үүнд татагдсан зах зээлийн таатай орчин үүсэх болно.

Монгол улс нийгэм – эдийн засгийн хөгжлийн ийм л арга сонгохгүй бол хөдөөнөөс ядуурлын, хоцрогдлын, гэмт хэргийн урсгал нийслэл тийш давалгаалж, хүн амын байршилтын тэнцвэргүй дарамт бий болсоор байх болно. Баруун бүсийн нийгэм – эдийн засгийн өвөрмөц нөхцөлд тохирсон, энэхүү аргачлалтай нягт уялдсан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүд байж хөгжих болно.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын хил нь бэлчээрийн мал аж ахуйг зөв эрхлэхийн тулд нүүдлийн хязгаар болсон газарзүйн хилүүдтэй давхцаж байх зүй тогтолтой.

Бэлчээрийн мал аж ахуйтай баруун бүсийн хувьд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн хил түүний төвүүдийн байршилт нь дээр дурьдсан дүгнэлттэй үндсэндээ тохирч байгааг харгалзах нь угтаа бэлчээрийн малын экологи – технологийн үндэстэй нутаг дэвсгэр бүхий засаг захиргааны нэгжүүдийг бий болгох юм.

### 9.2.2 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь эдийн засгийн бүсэд хуваагдсан байдал

Хүн амын хөгжлийн зохистой нягтшилыг ихэсгэх замаар эдийн засгийг эрчимжүүлэн, засаг захиргааны удирдлагыг цомхотгож эдийн засгийн удирдлагаар солих хандлага юм. Бүс нутгийн хувьд энэ зүй тогтлыг харгалзан үзэж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг хийх ёстой.

Баруун бүсийн бүх нутаг дэвсгэрээр жигд хөгжүүлж чадахгүй, зөвхөн тэнхлэгийн дагуу хүн амын хөгжлийн нягтшилтай болж, эдийн засгийн талаар хоёр хөрштэйгээ өрсөлдөх чадварыг олсноор тусгаар тогтнолоо бэхжүүлэх юм.


Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн одоогийн жижиглэсэн хуваарь нь төсвийн хэт үрэлгэн зардал, хүн амын нийгмийн хөгжлийг тэтгэх хүчин зүйл болж чадахгүй, зах зээлийн багтаамжгүй саланги, үйлдвэрлэл үйлчилгээ хөгжих боломж хязгаарлагдмал, үүнтэй уялдан ажилгүйдэл, ядуурал бий болох, хүн амын амжиргааны түвшин буурах, бэлчээр доройтох зэрэг сөрөг үр дагаврууд гарч байна. Ийм учраас тэдгээрийг хооронд нь нэгтгэх бүлэглэх замаар зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх шаардлагатай.

Төрийн удирдлага, үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх, нийгмийн баялгийг бүтээхэд оролцох, иргэдийн эрх, боломжийг өргөжүүлэх, зүй ёсны төвлөрлийг бодлогоор зохицуулах, түүхэн уламжлал, орчин цагийн шаардлагад нийцүүлэн, цогц байдлаар судалж хийх нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэ хуваарийг боловсруулах тулгуур зарчим болно.

Нийгэм эдийн засгийн хувьд оновчтой, байгаль орчны хувьд тогтвортой, түүх соёлын хувьд хүлээж авхуйц засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь боловсруулах нь гол зорилго юм. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал нь газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц, оюуны чадавхийг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр хүн ам, үйлдвэрлэлийн өнөөгийн зохисгүй бөөгнөрлийг задалж, хот, хөдөөгийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж хөгжлийн түвшинг ойртуулах, үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх дотоод, гадаад таатай орчинг бүрдүүлэхэд оршдог. Энэ зорилтыг жинхэнэ үйл хэрэг болгох нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчлэлтийн үндсэн санаа юм.

Хүн амын байршил, суурьшлын асуудал нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчлэлийн түлхүүр юм. Эндээс үзэхэд угтаа нийслэлд хүн амын төвлөрлийг сааруулж, хөдөөгийн хот суурин, аймаг, хошуудын төвд хүн амын төвлөрлийг дэмжих нутагшилт, суурьшлын бодлого боловсруулахад оршино.

Бүс нутгийн хүн ам, газар нутаг, байгалийн баялаг, үйлдвэрлэлийг тэнцвэртэй хуваарьлах нь хошууны бие дааж хөгжих чадавхид онцгой ач холбогдолтой. Байгаль орчны хувьд тогтвортой байх нь тогтвортой хөгжлийн үзэл санааг агуулж байгаа болно. Аль болох түүхэн уламжлалаа хадгалсан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг ард түмэн илүү хүлээж авах нь ойлгомжтой.



### 1. Нийгэм эдийн засгийн хувьд оновчтой хуваарь

Бүс нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэ хуваарь нь нийгэм, эдийн засгийн хувьд оновчтой байх нь хөдөөгийн хүн амын ажилгүйдэл, ядуурал, цус ойртолт, төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах болон орон нутгийн бие даасан хөгжлийг дэмжих гол хөдөлгөгч хүч нь болох юм. Нийгэм эдийн засгийн хувьд оновчтой засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг боловсруулахад дараах зарчмуудыг баримтална.

- Хүн амын төвлөрөл буюу оновчтой байрлал
- Үйлдвэрлэл, үйлчилгээний оновчтой байршил /нэг хошуу + нэг бүтээгдэхүүн/
- Нийгэм соёлын үйлчилгээний таталцал
- Дэд бүтцийн байгууламжуудыг оновчтой харгалзах

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэ хуваарийг амьдралд хэрэгжүүлснээр хөдөөд хүн амын оновчтой төвлөрлийг бий болгож, хөдөөгийн хүн амын ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, орон нутгийн бие даасан хөгжлийг тэтгэх тогтолцоо бүрдэх бололцоотой болно.

#### Үйлдвэрлэл, үйлчилгээний оновчтой байршил:

- Бүсийн тулгуур төвүүд, аймгийн төвүүдэд үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, үйлдвэрлэл, үйлчилгээний томоохон салбаруудыг төрөлжүүлэн хөгжүүлэх
- Хошуудын төвд малын түүхий эд боловсруулах жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- Хошуу бүрт малын түүхий эд болон бараа, бүтээгдэхүүний бөөний худалдааны сүлжээ байгуулах
- Нэг хошуу нэг бүтээгдэхүүн гэсэн үйлдвэрлэлийн тогтолцоог нэвтрүүлэх.

#### Нийгэм соёлын үйлчилгээний таталцал:

Хошуудын төвийг тогтоохдоо хүн амын төвлөрөл, газарзүйн байрлал, зам тээврийн нөхцөл, усны нөөц, тэдгээрийг дагаад нийгэм, соёлын үйлчилгээний таталцлын хүрээг тогтоож үзэх шаардлагатай юм. Үүнд:

- Одоо байгаа нийгэм соёлын үйлчилгээний баазууд, тухайлбал бүсийн эмчилгээ, оношлогооны төв, сум дундын эмнэлэг, орон нутаг дахь их дээд сургууль болон дунд сургуулийн таталцлын хүрээг харгалзах
- Дунджаар 4-6 сумыг багтаасан хошуу гэсэн нэгжийг оруулснаар иргэдэд хүрэх төрийн үйлчилгээний чанар сайжруулах үүднээс 10-н жилийн сургалтын чанарыг нийслэлийн жишигт хүргэх
- Орон нутагт чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх үүднээс таван аймгийн төвд их сургууль, хошуудын төвд дээд болон техник мэргэжлийн сургуулиудыг төрөлжүүлэн байгуулах
- Эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх үүднээс хошуудын төвд орчин үеийн шаардлагыг хангасан эмнэлэг оношлогооны төвийг байршуулах.

#### Дэд бүтцийн хөгжлийн чиглэлийг харгалзах хуваарь

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэ хуваарийг боловсруулах, тэр дундаа хошуудад хамрагдах сум болон хошууны төв, сумыг дэд бүтцийн одоогийн байгууламжууд ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг уялдуулах дараах зарчмуудыг харгалзан үзсэн.

- УИХ-р баталсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсийн тулгуур төв хотууд, дэд бүтцийн хэвтээ /мянганы зам/, босоо тэнхлэгийн замын таталцлын хүрээ
- Эрчим хүчний салбарын одоогийн болон хэтийн хөгжлийн хандлага, ус, нар, салхины сэргээгдэх эрчим хүчний станцын байршлын төлөв, хандлага
- Нийгэм, эдийн засгийн газарзүйн төв байршил, түүний таталцлын хүрээ
- Уул уурхайн голлох томоохон ордын ашиглалтыг тооцсон 2021 он хүртэлх төмөр замын болон авто замын мастер төлөвлөгөөний шийдлүүд

Баруун бүсийг хөрш болон бүс нутгийн орнуудтай дэд бүтцийн босоо хэвтээ тэнхлэгээр холбож, хүн ам, үйлдвэрлэл төвлөрөх хөгжлийн гол тулгуур нь Ховд – Баян-Өлгий – Увсын бүсэд Ховд, Завхан – Говь-Алтайн бүсэд Улиастай байх болно.

Бүс нутгуудын хамтын ажиллагааны олон талт байдал, өрсөлдөөнийг хангах үүднээс дээр дурдсан бүсүүдийг тус тусын зорилго, чиглэлтэй байхаар тогтоож, ашиглах нь зүйтэй байна. Тухайлбал, Ховд – Баян-Өлгий – Увс болон Завхан – Говь-Алтайн бүсийг “Мянганы зам” төсөлд тодорхойлсон Боршоо боомтоос Улаангом – Ховд – Ярантайн боомт, Ханхын боомтоос Мөрөн – Улиастай – Алтай – Бургастайн боомт хүртэлх дэд бүтцийн хоёр босоо тэнхлэгт ойр зэргэлдээх аймаг, сумдыг таталцуулж, улс хоорондын үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлтийн зах зээлийг буй болгох чиг үүрэгтэй улс хоорондын “эдийн засаг, худалдааны бүс”-ийн шинж байдлаар ашиглана. Ингэснээр Баруун бүсийн аймгуудын алслагдсан газарзүйн байрлалын онцлогийг харгалзан хөгжлийн дотоод, гадаад тэнцвэрийг хангахад чухал ач холбогдолтой.

Аймгуудын бүсийг тэдгээрийн түүх, нийгэм – соёлын уламжлалт байдлыг нь хөгжлийн бүс нутгууд тодрон гарах хүртэл нэг хэсэгтээ хадгалж, эдийн засаг – худалдааны дээрх хоёр бүсээр дамжин хөрш орнуудын зах зээлд харьцангуй бие даан оролцох, орон нутгийн удирдлага, төсөв санхүүгийн зохицуулалтын нэгдмэл байдлыг хангах үүрэгтэй засаг захиргаа – эдийн засгийн бүсүүд байхаар зохион байгуулах нь зүйтэй байна.

Тэгвэл, сум дунд /бичил/-ын бүсүүдийг гадаад зах зээлд оролцох бүс нутгийн нөөц, боломжийг нэмэгдүүлэхийн хамт хөдөөгийн хүн амд засаг захиргаа, эрүүл мэнд, соёл боловсролын орчин үеийн мэргэжлийн үйлчилгээг цаг тухайд нь чанартай, хүртээмжтэй хүргэх менежментийг сайжруулж, орон нутгийн нийгмийн цогц байдал, хамтын ажиллагааг хангах үүрэгтэй хөгжлийн бүс нутгууд бий болгоход ашиглаж болох байна.

Олон улсын хэллэгээр макро-, мезо-, микро бүсчлэл гэж нэрлэгддэг бүсчлэлийн эдгээр сүлжээг эдийн засгийг нутаг дэвсгэрээр зохицуулах үйл ажиллагаанд зориулалтаар нь уялдаатай ашигласнаар аж ахуйн хувьд бие даан хөгжих чадвартай бүс нутгуудын тогтолцоо бүрдэх болно. Баруун бүсэд эдийн засгийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх ирээдүйн гол талбар болох үндэстэй тэдгээр бүс нутагт улсын эдийн засгийн бодлого, хөрөнгө, санхүүгийн дэмжлэгийг түлхүү чиглүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Гадаад худалдааны хөгжлийн хувьд баруун бүсийн аймгуудын экспортыг үнийн дүнгээр нь авч үзвэл ойролцоогоор 94% нь ОХУ-тай, үлдсэн 6% нь БНХАУ-тай хийгдсэн онцлогтой байгаа бол бараа бүтээгдэхүүний 46.7%-ийг ОХУ-аас авсан тооцоо гарч байна. Гэхдээ импортын тухайд, барааны нэр төрөл, үнэ өртөг нөлөөлсөн нь тодорхой юм.

Малын гаралтай түүхий эдийг гүн боловсруулж, нэмүү өртөг шингэсэн, олон нэр төрлийн бүтээгдэхүүн экспортод нийлүүлэх явдал чухал байна. Энэ зорилтыг баруун бүсийн Ховд, Улиастайн тулгуур төвд аж үйлдвэрийн парк, нутгийн шилмэл омгийн үүлдрийн мал аж ахуйн бүс нутагт мал аж ахуйн кластер тус тус байгуулж, энэ хүрээнд гадаадын дэвшилтэт технологи шилжүүлэн ашиглах замаар шийдвэрлэж болох байна.

## **2. Байгаль орчны хувьд тогтвортой хуваарь**

Хэд хэдэн сумдыг нэгтгэн томруулж хошуу болгосноор уур амьсгалын өөрчлөлтөнд эмзэг байдлыг бууруулах нөхцлийг бий болгоно. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг томруулж шинэчилснээр бэлчээрийн аж ахуйн дасан зохицох чадварыг дээшлүүлэх удирдлага, зохион байгуулалтыг цогц болгох бололцоо бүрдэнэ.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, усан хангамжийн хүрэлцээ, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл, бэлчээрийн мал аж ахуй эрхлэх арга ажиллагаа зэргээс шалтгаалан бэлчээрийн талхлагдал эрс нэмэгдэж, талхлагдалд өртсөн газрын хүрээ улам тэлсээр байгаа нь олон жилийн мониторинг судалгаагаар тогтоогдоод байна. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн гол эх үүсвэр болж байдаг бэлчээрийн мал аж ахуйн хэтийн тогтвортой хөгжлийг хангах гол үндэс нь байгалийн бэлчээр, хадланг зохистой ашиглаж, экосистемийн цогц байдлыг хангах явдал юм.

Улирлын бэлчээрлэх нутаггүйгээс шалтгаалж бэлчээрийн багтаамж болон нөөц уур амьсгалын өөрчлөлтөд өртөхийн хажуугаар малын тоо толгойн өсөлттэй уялдан бэлчээрийн даац, түүний ургац улам бүр багасаж талхлагдал орсоор байна. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг томруулснаар мал сүргийг улирлаар болон байгаль, газарзүйн мужлалаар сэлгэн нутаглах боломж нөхцөл бүрдэх сайн талтай.

Мөн сүүлийн жилүүдэд сүргийн бүтэц өөрчлөгдөн ямаан сүргийн тоо толгой өсч байгаа. Ямаан сүргийн тоо толгойг ноолууран бүтээгдэхүүний зах зээлээс олдог орлого, цаана цөлжин сүйрч буй хөрс шорооны үнэлгээтэй харьцуулан жинлэж байж төрийн бодлогын төвшинд шийдвэрлэж тогтоох шаардлага гарч байна. Ингэхэд дан ямаа бэлчсэн талбайн өвс, ургамал 20 хувиар халцгай болох бөгөөд хөрсийг цавчиж, үндсэн ургамлыг их идэж устгадаг.

Ямаа хөнгөн биетэй хэрнээ хөрсөнд тийм их аюул учруулдаг. Монгол судлаачдынхаас гадна ямаан сүргийг их хэмжээгээр өсгөж үржүүлснээс болоод экологийн сүйрэл учирсан дэлхийн гашуун түүх ч бий. Иймд ямааны аж ахуйг зохистой түвшинд өсгөж, малчдыг эдийн засгийн бодлогоор дэмжих хэрэгтэй. Оройтоогүй дээр нь ямааны өсөлтийг ямар нэг хэмжээгээр хязгаарлах ёстой.

Дээрх байдлаас дүгнэн үзэхэд одоогийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг хүн төвтэй, орон нутгийн бие даан хөгжих чадавхийг нь дэмжиж өнөөгийн зах зээлийн эдийн засгийн харилцаанд зохицуулан шинэчлэн зохион байгуулах шаардлагатай.

Ийнхүү засаг захиргааны үүрэг давамгайлсан удирдлагын тогтолцоо, хэлбэрийг эдийн засаг, аж ахуйн үүрэгтэй хослосон байдалд оруулах, хөдөөгийн хүн амын эрүүл мэнд, сургууль, соёл, ахуйн үйлчилгээ

болон банк, санхүү, бөөний худалдааны төвүүд, мал аж ахуйн гаралтай анхан шатны боловсруулалт хийх жижиг, дунд үйлдвэрүүдийг сумдад оновчтой байршуулах шаардлага амьдралаас урган гарч байна.

### 3. Түүх, соёл уламжлалын хувьд иргэд хүлээж авахуйц хуваарь

Баруун бүс нутагт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн удаагийн түүхэн өөрчлөлтүүд хийгдэж байсан ба 1691-1930 он хүртлэх Засагт хан, Сайн ноён хан аймаг, хошуудтай байсан үеийн Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь нь түүхэн уламжлал талаасаа дараах үндэслэлүүдээр иргэд хүлээж авхуйц гэж тодорхойлсон. Үүнд:

- Ард түмний дунд одоог хүртэл тэр үеийн аймаг, хошуудын харъяалал яригдсаар ирсэн бөгөөд сүүлийн үед удам угсаа, овгоо сэргээн тодорхойлоход хуучин харъяаллаа өргөн хэрэглэх хандлагатай болсон.
- Тэр үеийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн аймаг, хошуу гэсэн бүтэц нь эдийн засгийн бүсүүдийг харгалзан одоогийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг томсгон зохион байгуулахад тохиромжтой.
- Одоогийн аймаг, сум гэсэн нэгжийн дунд шинээр 4-5 сумыг багтаасан хошуу гэсэн нэгж шинээр байгуулах нь тохиромжтой.
- Угсаатны бүтцийн хувьд улс үндэстэн, 20 гаруй ястнаас бүрддэг онцлог байдлыг харгалзан хүн амын цөөнх хэсгийн түүх, соёлыг хадгалах, сэргээх
- Одоогийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг шинэчлэх түүхэн тохиромжтой цаг үеийг ашиглан богино хугацаанд иргэд хүлээж авахуйцаар шийдвэрлэхэд хуучны аймаг, хошууны нэрийг хэрэглэх нь зүйтэй.

#### Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэ хуваарийн санал /Хүснэгт 9.1/

|   | Хамрагдах аймаг | Газар нутаг         | Хүн ам<br>/мян.хүн/ | Хамрагдах сум | Хамрагдах хошуу |
|---|-----------------|---------------------|---------------------|---------------|-----------------|
|   |                 | мян.км <sup>2</sup> |                     | тоо           | тоо             |
| 1 | Ховд            | 76.1                | 88.6                | 17            | 4               |
| 2 | Баян-Өлгий      | 45.7                | 100.8               | 14            | 5               |
| 3 | Увс             | 69.6                | 80.4                | 19            | 5               |
| 4 | Завхан          | 82.5                | 81.1                | 24            | 7               |
| 5 | Говь-Алтай      | 141.4               | 60.2                | 18            | 5               |
|   | Бүгд            | 415.3               | 411.1               | 92            | 26              |

Аймгийн шинэ хуваарийг тогтоохдоо дараах зарчмыг баримтлав.

- Түүх, соёлын хувьд хүлээж авах байдлыг харгалзан түүхэн уламжлалын дагуу хуваарилсан.
- Аймаг бүр нь хилийн гарц, боомтоороо дамжуулан эдийн засгийн гадаад харилцаа хөгжүүлэх боломжтойгоор 2 том гүрэнтэй хиллэж байгаа аймаг бүрийн нутаг дэвсгэрээр монгол улсын авто замын гол тэнхлэгүүд болох хэвтээ тэнхлэг буюу мянганы зам болон босоо тэнхлэгийн авто замууд дайран өнгөрч байгаа.
- Аймаг бүрийн нутаг дэвсгэр нь өргөргийн дагууд монгол орны байгалийн бүх бүс бүслүүрийг хамарч байгаа нь эрс тэс уур амьсгалтай ган зуд зэрэг байгалийн бэрхшээлд өртөмтгий бүс нутгийн хувьд байгаль орчны тогтвортой байх нөхцлийг харгалзсан.

Аймгуудын нэрийг тогтоохдоо одоогийн аль нэг аймгийн нэрээр нэрлэх, шинээр нэр өгөх, газар усны нэрээр нэрлэх зэргээр маргалдах, мэтгэлцэх, цаг хугацаа алдахгүйгээр иргэд хүлээж авах байдлыг харгалзан түүхэн уламжлалаар нэрлэсэн. Баруун аймгийг түүхэн уламжлалаар Ховдын хязгаар, Засагт хан аймаг гэсэн 2 том нэгжид хуваагдаж байсныг харгалзан манай орны хамгийн том нурууны нэрээр Алтай хан аймаг гэж нэрлэсэн.

#### Хошууны хуваарийг тогтооход баримтлах зарчим

Хошуу: Богд хаант монгол улсын үеийн хошууны бүтцийг ерөнхийд нь баримталсан боловч 2002 онд Засгийн газраас хэлэлцсэн бүлэг суурингийн тогтолцоо, Шинжлэх ухааны акадემийн Газар зүйн хүрээлэнгээс явуулсан судалгаа, Барилга, хот байгуулалтын яамны засаг захиргааны хэлтсээс боловсруулсан материал зэргийг харгалзан үзсэн болно.

Бүс нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарьт хошуу гэсэн аймаг, сумын завсарын нэгжийг шинээр оруулж ирж байгаа нь дараах нөхцлүүдтэй нийцэж байна.

- Одоогоор сумын түвшинд үзүүлж байгаа боловсрол, эрүүл мэнд зэрэг төрийн үйлчилгээг хэвээр хадгалах бөгөөд дунджаар 4-6 сумыг нэг хошуунд төвлөрүүлснээр хошууны төвд хүн ам төвлөрөн суурьшиж үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих, иргэдэд хүрэх төрийн үйлчилгээ сайжрах бололцоотой болно.
- Сумдыг хошуудаар зохион байгуулахдаа түүхэн уламжлал, угсаатны бүтэц, нийгэм эдийн засгийн таталцал, орон нутгийн санал зэргийг голчлон харгалзсан.
- Ган, зуд зэрэг байгалийн бэрхшээлд өртөмтгий жижиг сумдыг хошуудад зохион байгуулснаар байгалийн хэд хэдэн бүс бүслүүрийг хамарч, дөрвөн улирлын бэлчээр ашиглалтын нөөцийг нэмэгдүүлнэ.

**Хот:** 15 мянгаас дээш хүн ам бүхий суурин төвлөрлөөр тооцож, ойрын ирээдүйд хүн амын өсөх хандлагыг тооцсон.

**Сум:** Шинэ хуваарийн дагуу засаг захиргааны хамгийн бага нэгж байна. Баруун бүсийн 92 сумаас нэгийг ч татан буулгалгүйгээр багийн хэмжээнд хилийн цэсийг нь хэвээр хадгалахаар тусгав.

### 9.2.3 Баруун бүс нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчилсэн хуваарь нь монгол улсын нийгэм – эдийн засгийн хөгжлийн стратегитэй холбогдох нь

Бүс нутгийн нийгэм – эдийн засгийн хөгжлийн үндэсний стратегийн бүхий л харилцан үйлчлэлийг нэгтгэн харуулах, уялдуулах, дүн шинжилгээ хийж төлөвлөх суурь байршилт нь нийгэм – эдийн засгийн тэнхлэг юм. Тодруулбал энэхүү тэнхлэгийн дагуу улс ардын аж ахуйн салбар бүр хөгжлийн стратегийг төлөвлөж байна. Энэ нь нутаг дэвсгэрээр жигд хөгжих нөхцлийг бүрдүүлнэ.

Нийгэм - эдийн засгийн тэнхлэгүүдийн дагуу олон улсын худалдаа аяндаа хөгжиж, үүнд татагдан тэнхлэгийн дагуу ба орчны бүс нутагт нөлөөлөн хүн амын зохистой нягтшил бий болж, улмаар хүний хөгжилд тулгуурлан нөөцөө ашигласан үйлдвэрлэлийг хөгжүүлж, экспорт, импортын өсөлт, нийгмийн үйлчилгээ сайжирч, ажлын шинэ байрууд нүүдэлчдийг суурьшилд татах замаар “босоо хөгжил” үүсэн хөгжинө.

- Аймаг, сумдыг эрчимтэй хөгжүүлснээр түүний харъяаллын одоогийн сумдад тохиолдож байгаа бэрхшээлийг арилгах болно.
- Сум хоорондын газар зохион байгуулалтыг экологийн зохистой нутаг, хөгжлийн стратегитэй холбон, мал аж ахуйг эрхлэх технологийг мөрдүүлснээр бэлчээр талхлагдахгүй болно.
- Сумын төвийн ажилгүйдэл болон малгүй болсон малчид сумын төвд ажил эрхлэх болсноор нүүдэлчид суурьшилд шилжих нөхцөл бүрдэнэ.
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг нийгэм – эдийн засгийн одоогийн байдал, ирээдүйн хандлагатай холбон төлөвлөв.

Монгол улсын нийгэм – эдийн засгийг давшингуй, тогтвортой хөгжилд хурдан хүргэхийн тулд нийгэм – эдийн засгийн тэнхлэгийг бүрэн байгуулах, үүний дагуу орших хот, хороо, тосгодыг үйлдвэржүүлэн хөгжүүлэхээс эхлэнэ. Энэ бол бүс нутгийн нийгэм – эдийн засгийн хөгжлийн стратегийн эхлэн шийдвэрлэх гол асуудал юм.

Баруун бүсийн нийгэм – эдийн засгийг тэнхлэгээр хөгжүүлэх үзэл баримтлал тэнхлэгт татагдан үүсэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт түүнийг хөгжүүлэх аргачлал нь Монгол улсын нийгэм эдийн засгийн өвөрмөц байдалд тохирсон зөв хандлага юм.

#### Аймгуудын засаг захиргааны шинэ хуваарь, хувилбар-1 /Хүснэгт 9.2/

| № | Аймаг      | Хошууны нэр      | Хотын нэр | Сумын нэр                               | Татан буугдсан сумд       |
|---|------------|------------------|-----------|---|---------------------------|
| 1 | Баян-Өлгий | Өлгий хошуу      | Өлгий     | Бугат, Алтанцөгц<br>Цагааннуур,Баяннуур | Бугат<br>/төвийн сум/     |
|   |            | Таванбогд хошуу  | Улаанхус  | Цэнгэл, Сагсай                          |                           |
|   |            | Толбо хошуу      | Алтай     | Буянт                                   |                           |
|   |            | Буянт хошуу      | Дэлүүн    | Толбо                                   |                           |
| 2 | Говь-Алтай | Говь-Алтай хошуу | Алтай     | Шарга, Тайшир<br>Дэлгэр, Халиун         | Есөнбулаг<br>/төвийн сум/ |
|   |            | Сангийн Далай    | Баян-Уул  | Хөхморьт, Жаргалан                      |                           |

|                   |          |                           |              |  |                                      |
|-------------------|----------|---------------------------|--------------|--|--------------------------------------|
|                   |          | хошуу                     |              |  |                                      |
|                   |          | Бугат хошуу               | Тонхил       | Дарви, Төгрөг<br>Бугат                               |                                      |
|                   |          | Аж Богд хошуу             | Алтай        | Цээл   |                                      |
|                   |          | Гичгэнэ хошуу             | Цогт         | Бигэр, Эрдэнэ<br>Чандмань                            |                                      |
| 3                 | Ховд     | Ховд хошуу                | Ховд         | Буянт, Ховд<br>Эрдэнэбүрэн, Мянгад<br>Дөргөн         | Жаргалант<br>/төвийн сум/            |
|                   |          | Мөнххайрхан<br>хошуу      | Мөнххайрхан  | Дуут, Манхан<br>Булган                               |                                      |
|                   |          | Ацат хошуу                | Дарви        | Чандмань<br>Зэрэг, Мөст<br>Цэцэг                     |                                      |
|                   |          | Алтайн чанад<br>хошуу     | Булган       | Үенч, Алтай  |                                      |
| 4                 | Завхан   | Завхан хошуу              | Завханмандал | Ургамал, Эрдэнэ-<br>хайрхан, Дөрвөлжин<br>Сантмаргац | Төвийн сум<br><br>Асгат<br>Дөрвөлжин |
|                   |          | Баянтэс хошуу             | Баянтэс      | Асгат, Тэс<br>Баянхайрхан                            |                                      |
|                   |          | Ойгон хошуу               | Түдэвтэй     | Сонгино, Цэцэн –<br>Уул, Нөмрөг                      |                                      |
|                   |          | Идэр хошуу                | Булнай       | Тэлмэн, Их-Уул                                       |                                      |
|                   |          | Улиастай хошуу            | Улиастай     | Алдархаан<br>Цагаанхайрхан<br>Идэр, Яруу             |                                      |
| Отгонтэнгэр хошуу | Отгон    | Цагаанчулуут<br>Шилүүстэй |              |  |                                      |
| 5                 | Увс      | Үүрэг хошуу               | Сагил        | Бөхмөрөн<br>Давст                                    | Төвийн сум<br><br>Өлгий              |
|                   |          | Хархираа хошуу            | Улаангом     | Тариалан, Түргэн                                     |                                      |
|                   |          | Намир хошуу               | Өмнөговь     | Ховд, Өлгий  |                                      |
|                   |          | Тогтох хошуу              | Наранбулаг   | Завхан   |                                      |
|                   |          | Зүүн хөхий хошуу          | Баруунтуруун | Цагаанхайрхан<br>Өндөрхангай<br>Зүүнхангай           |                                      |
| Баяд хошуу        | Зүүнговь | Малчин, Тэс<br>Хяргас     |              |  |                                      |

Нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжийг хуваахад хүн амын байршил, үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг нэмэгдүүлэх, байгалийн нөөц баялаг, засаг захиргааны нэгжийн түүхэн уламжлал, зам тээвэр, дэд бүтцийн хөгжлийн өнөөгийн ба хэтийн төлөв зэрэг олон хүчин зүйлийг харгалзсан.

Баруун бүс нутгийн үйлдвэрлэлийн хүчин зүйлийн өнөөгийн байдал хэтийн төлөвтэй уялдуулан аймаг, сум, багийн нутаг дэвсгэрийг тогтооход малын бэлчээрийн даац, хадлан, тариалангийн талбайн хэмжээ зэрэг нь харгалзаж үзэх гол хүчин зүйл болсон.

Бүсийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тухайн үеийн төрийн бодлоготой холбон өөрчлөгдөж ирсэн бөгөөд улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагатай холбоотой засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүтэц зохион байгуулалт шинэчлэгдэж болно.

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хувьд авч үзвэл аливаа бүс нутгуудыг хөгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээ нь эцсийн дүндээ тэдгээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийг хөгжүүлэх үндсэн зорилгыг агуулж байгаа билээ. Үүнээс үзэхэд бүсчилсэн хөгжлийн бодлогыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн шинэчлэлээс эсвэл засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн шинэчлэлийг бүсчилсэн хөгжлийн бодлогоос салган авч үзэх боломжгүй юм.

“Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг өөрчлөх санал боловсруулах” ажлын хэсгүүд аймаг, баг, сумдын эдийн засгийн чадавхи, төсвийн орлого, зарлагын тооцоог бүсчилсэн хөгжилтэй уялдуулах үндэслэл, судалгаа тооцоо хийж саналаа тусган Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулжээ.

Нөгөө талаас Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүд нэгдэх санаачлагыг төсөв, санхүүгийн бодлогоор дэмжих асуудлын хүрээнд 2007 оны төсөвт бүс нутгуудад жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр 810.0 сая төгрөгийн хөрөнгийг Үйлдвэр худалдааны сайдын багцад тусгаж өгсөн байна.

### 9.3 БҮС НУТГИЙН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

Сум хоорондын газар зохион байгуулалт хийснээр нутаг дэвсгэрийг бүсчилэн хөгжүүлэх, дэд бүтцийн нэгдсэн сүлжээ, үүний дотор хөндлөн гол тэнхлэгийг эхэлж байгуулах, зарим нутагт эдийн засаг, худалдааны чөлөөт бүс бий болгон хөгжүүлэх, бүс нутгийг дотоод, гадаад зах зээлтэй дэд бүтцийн сүлжээгээр холбож, нутаг дэвсгэрийн хөгжлийн таталцлын төв, тэнхлэгүүдийг бий болгох, бүс нутгийн аймгуудыг эдийн засгийн талаар бие даалган хөгжүүлж, нутаг дэвсгэрийн харьцангуй жигд хөгжлийг хангахад оршино.

Аймгуудын тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд удирдлагын босоо тогтолцоо, төвлөрлийг сааруулах, аймаг, хотыг бүсчилсэн хөгжүүлэх, сумдыг бичил бүсээр зохион байгуулна. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн шинэчлэлтэй ямар нэг хэмжээгээр холбоотой нэн даруй шийдвэрлэх шаардлагатай зарим асуудлууд бий болж байна. Үүнд:

1. Аймаг, сумдын хүн амын тоо цөөн, эдийн засгийн чадавхи сул, зах зээлийн багтаамж бага байгаа зэргээс үүдэн эрэлт, нийлүүлэлтэд тулгуурласан зах зээлийн хуулиуд жинхэнэ агуулгаараа үйлчлэх нөхцөл боломж хомс байна. Энэ байдал нь орон нутагт эдийн засгийн өсөлт, салбарын бүтцийн эерэг өөрчлөлтийг бий болгоход ч сөрөг нөлөө үзүүлж байгаа юм. Иймд аймаг, сумдын зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлж, хөгжлийн нөөц боломжийг бүрэн дүүрэн ашиглах таатай орчин бүрдүүлэх шаардлага ч их байна. Аймаг, сумдын хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжсэн өөрчлөлтүүд ч ихээхэн үгүйлэгдэх болсон байна.

2. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад ч зарим бэрхшээл гарах болсон. Өнөөгийн хэд хэдэн аймаг, хэд хэдэн сумдыг хамран үйлчлэх зориулалт бүхий эрүүл мэнд, боловсролын харьцангуй өндөр түвшний, чанартай үйлчилгээтэй эмнэлэг, сургуулиуд, бусад үйлдвэрлэл, үйлчилгээний газруудыг бий болгон хөгжүүлэх шаардлага их байна. Нөгөө талаар төрийн хууль тогтоомжийн хэрэгжүүлэлт, төрийн бусад үйлчилгээг хүн амд улам ойртуулж сайжруулах шаардлага байгаа юм.

3. Аймаг, сумдын хооронд бэлчээр нутгийг оновчтой ашиглах, хамгаалахтай холбоотой асуудлууд ч нэлээн байна.

4. Хот, тосгоны эрх зүйн байдлыг шинэчлэн боловсронгуй болгон зохицуулах шаардлага ч байна.

Сумдын нутаг дэвсгэрийн хуваарилалт харьцангуй жигд бус байна. Мөн нутаг дэвсгэр бага сумд нь ихэвчлэн аймгийн төвийн сумд байгаа бөгөөд ердийн сумдаас 4-5 дахин хүн ам ихтэй, нягтрал өндөр байна. Нутаг дэвсгэрийн тэнцвэргүй хуваарилалт нь дараах асуудлуудыг үүсгэж байна. Үүнд:

- Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хуулийг зерчиж харьяалалгүйгээр нутаг дэвсгэрт байнга оршин суух,
- Иргэд суурьшсан засаг захиргаанд харьяалагдах хуулийг зерчих
- Газар өмчлөлийн асуудлыг төвөгтэй болгож,
- Сум, багийн хил хязгаар ергесч, хүн амд үйлчлэх нийтийн үйлчилгээнүүд хүргэхэд тодорхой бэрхшээлүүд үүсгэж байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн өөрчлөлтийг хийснээр сумын эдийн засагт эерэгээр нөлөөлөх боломжтой. Сумд саяхан болтол төрийн буюу эсвэл төржсөн хоршооны нэг л өмчид суурилан хөгжих, нөгөө талаар хувийн өмчийг хориглон, ерхийн амьжиргаанд “туслах үүрэгтэй” гэх амины өмчийг доод хязгаарт нь хүртэл хязгаарлан барих бодлого бүхий эдийн засагтай байсан билээ. Гэтэл өдгөө сум төрийн болон аймгийн, нийтийн өмчийн бусад хэлбэрийн зэрэгцээгээр олон зуун ерх аж ахуйтны хувийн өмчид суурилах болов.

Суманд түгээмэл, зайлшгүй байх 30-40 төрлийн үйлчилгээнээс жижиг, жижгэвтэр сумдад 10-20 төрөл нь байна. Бусад үйлчилгээг авахын тулд аймгийн төв болон зэргэлдээ хил боомт, хот руу чиглэсэн урсгал явагдаж байна. Дундаж болон томоохон сумдад 30-40 голлох үйлчилгээ байгаа нь хүн ам үйлчилгээгээ даган шилжин төвлөрөх хандлага буюу “хөгжлийн аяндаа цэгцрэх хууль” үйлчилж байна. Үүнд тулгуурлан боловсрол, эрүүл мэнд, худалдаа үйлчилгээний сум дундын төвүүд буюу “том” сумыг байгуулах аргаар ЗЗНД-ийн өөрчлөлтийг хийх нь үр дүнтэй болно.

Ямар сум том сум болж өргөжих нь тухайн орон нутгийн иргэдийн үүсэл санаачлага, идэвх оролцоо, удирдлагын арга барилаас ихээхэн шалтгаална. Үүнд дэд бүтэц, экологийн онцлогыг харгалзах нь дамжиггүй.

Тухайн орон нутгийн голлох үйлчилгээний 50-60 хувийг өөрийн аж ахуйн нэгжүүд явуулж байвал эдийн засгийн хувьд хөгжих эх үүсвэр байдаг. Ийм чадавхи бүхий орон нутгийн төвүүдийг байгуулснаар тэнд аяндаа хүн ам төвлөрч, хүн ам нь хэт цөөрсөн сумдыг зэргэлдээх сумдад нэгтгэх нь засаг захиргааны зардлыг бууруулах ач холбогдолтой юм.

### 9.3.1 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн өөрчлөлтийг зөв хэрэгжүүлэх талаар

Хуримтлагдсан асуудал байгаа боловч асуудлыг хүний идэвхи оролцоог үгүйсгэсэн, эзэнгүй нутаг, төвлөрсөн удирдлага бий болгох байдлаар хийж болохгүй. Зорилгоос бүтэц тодорхойлогддог бөгөөд зорилго өөрчлөгдөөгүй үед бүтцийг өөрчлөх нь хөгжлийг дэмжих бус хөгжлийг саатуулах арга хэмжээ болдог. Социализмын үед байгуулсан сумдууд үйл явцаараа мөхөж, тодорхой хөгжлийн төвүүд бий болж, иргэдийн идэвх оролцоо сэргэж байгаа үед зөв бодлого, зөв өөрчлөлт хэрэгтэй.

ЗЗНД-ийн нэгжүүдийг хвчээр хэт цөөлж, иргэдийн нийтийн үйлчилгээг улам холдуулж, удирдлагын төвлөрлийг бий болгох байдлаар хийж болохгүй.

Өөрчлөлтийг дээрээс доош чиглэсэн байдлаар хийх нь үр дүн муутай байсныг бидний 15 жилийн туршлага харуулж байна. Бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр, хууль гараад олон жил болсон ч бүрэн утгаараа хэрэгжиж чадсангүй. Бүсчлэл гэдгийг засаг захиргааны нэгж, тулгуур төвийг байгуулах мэтээр ойлгож ташаарсны үр дагавар юм.

Бүсчлэл гэдэг бол байгаль, дэд бүтэц, зах зээлийн онцлог зэргээр зарим нутагт давхцан, зарим нутагт дангаараа, их бага нутгийг хамран оршдог иргэдийн аж ахуй эрхлэлт, нийгмийн оролцооноос хамаарсан ойлголт юм. Баруун аймгуудын хувьд ноосны урсгал Ховд, ноолуурын урсгал Хөвсгөл рүү чиглэх, Зүүн аймгуудаас төв, болон говийн аймагт махны урсгал гэх мэтээр зах зээлийн хуваарилалтаар хийгддэг зүйл юм.

ЗЗНД-ийн өөрчлөлтийг хийх нь алсаа харсан бодлого болно. Дээрхи асуудлыг дүгнэж үзэхэд:

- Нутаг дэвсгэрийг 1950-70 онуудад нэгдэл, сангийн аж ахуй, хотоор олгосон хуваарийг хэвээр хадгалж сумдыг сэргээн байгуулсан нь өнөөгийн нөхцөлд газар ашиглах, эзэмших талаас асуудал үүсгэж байна.
- Сүүлийн жилүүдэд хүн амын шилжилт хөдөлгөөн үйлчилгээний төв рүү чиглэж, сумын хүн ам цөөрч байна. Үйлчилгээгээ дагаад шилжих үү, иргэндээ үйлчилгээгээ хүргэх үү гэдэг зарчмын асуудал үүсэж байна.
- Сум, орон нутгийн өмч бүрэлдэж, өөрийн чадавхи бүрдэх үүсэл санаачлага бий болж байгаа ч гадны (тухайн орон нутгийн бус) компанийг дэмжсэн бодлого үйлчилсээр байна. Өөрсдийгөө хөгжүүлэх үү, бусдыг хөлжүүлэх үү гэдэг бол эдийн засгийн үндсэн асуудал байдаг.
- Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээг хязгаарлаж, зөвхөн дамжуулагчийн үүрэгтэй болгосноор засаг захиргааны үйлчилгээний чанар хүртээмж муудаж байна.

Орон нутгийг эдийн засгийн хувьд бие даасан тус бүрдээ хүний хөгжлийн төвүүд болгох, иргэдийн оролцоо, өөрийн удирдлагаар ажилладаг байхаар суурь асуудлыг шийдвэрлэж, энэ ажлын хүрээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн өөрчлөлтийг зарим сумдыг томсгох, багийг бэхжүүлэх чиглэлд хийх нь учиртай юм.

Анхаарал татаж байгаа хамгийн гол асуудал бол одоогийн аймаг, сумдын чадавхи сул, хүн амын тоо цөөн, зах зээлийн багтаамж бага байгаатай холбоотойгоор эрэлт, нийлүүлэлтэд тулгуурласан зах зээлийн эдийн засгийн хуулиуд жинхэнэ агуулгаараа үйлчлэх нөхцөл боломж хомс байна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн өсөлтийг бий болгох, үйлдвэрлэл үйлчилгээг өргөжүүлэх, салбарын зохистой бүтэц бүрдүүлэх боломжгүй байгаа юм. Судалгаанаас үзэхэд сумдад жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих зах зээлийн багтаамж бүрдэхгүй байгаа юм. Жижиг сумын төвд дэлгүүр, ТҮЦ зэрэг өрхийн жижиг бизнес зонхилж байна.

Үүнээс гадна аймаг, сумдын боловсрол, эрүүл мэнд, төрийн үйлчилгээг үзүүлэхдээ чанар, хүртээмжийг нь сайжруулах, хөрөнгө, төсвийг оновчтой хуваарилахад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн олон жижиг нэгжүүдтэй байх нь тодорхой бэрхшээлүүдийг бий болгоно. Энэхүү хэт жижгэрсэн хуваарь нь эдийн засгийг эрчимжүүлэх, хүн амын нийгмийн хөгжлийг тэтгэх хүчин зүйл болж чадахгүй байна.

**Энэ ажлыг хийхдээ дэлхийн улс орнуудын хөгжлийн хандлагыг харгалзан Засгийн газраас баталсан шинжлэх ухааны арга зүй, үндэслэлээр боловсруулсан нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудлыг иж бүрэн хамарсан бүсчилсэн хөгжлийн бодлого, хөтөлбөртэй уялдуулан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг боловсруулах шаардлагатай гэж бодож байна.**



Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг шинэчлэх ажлыг шинжлэх ухааны тодорхой үзэл баримтлал, онол, аргачлал, арга звйд тулгуурлан судалгаа шинжилгээний томоохон ажлын үр дүнд хийх ёстой.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг шинэчлэхдээ Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн талаар олон жилийн турш нэгэнт хийгээд байгаа үзэл баримтлал, хууль тогтоомж, хөтөлбөр төслүүдийг судалж, түүнд тулгуурсан. Мөн хэт жижиг сумдыг нэгтгэх, үүнд ялангуяа аймгийн төв, томоохон суурин газрын дэргэд хаяа нийлэн байгаа эзэнгвй шахам болсон сумдыг нэн даруй хамруулах, татан буулгах шаардлагатай байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаар хэлэлцэн баталсан. Энэ хууль батлагдсанаар нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагуудын ажиллах эрх зүйн орчин сайжирч, өмнөх хуульд байгаагүй зохицуулалтын шинжтэй олон асуудлыг 10 гаруй жилийн үйл ажиллагааны практик дээр үндэсдлэн шийдвэрлэсэн зэргийг хэлэх байна.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд бий болсон орон нутгийн боловсон хүчний томилгооны босоо тогтолцоог өөрчилж, салбарын 15 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Ийм арга хэмжээ авагдсанаар аймгийн засаг дарга нар цагдаагийн газар /хэлсэт/, Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Шүүхийн шийдвэр гвйцэтгэх албадаас бусад засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албадын дарга нарыг ажилд томилж, чөлөөлөх эрхтэй болсон.

Орон нутаг эдийн засгийн хувьд бие даан хөгжихөд хамгийн чухал нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг томруулах шаардлагатай байгаа гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

### 9.3.2 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг өөрчилснөөр гарах үр дүн

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэ хуваарь боловсруулах ажлын хүрээнд нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлж, орон нутгийн бие даан хөгжих эдийн засаг, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх, төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээний хүртээмж, чанарыг орчин үеийн мэдээлэл, техник технологийн ололт амжилтанд тулгуурлан сайжруулах талаар төрөөс авч явуулах бодлого, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох боломжтой.

#### Эдийн засгийн хэмнэлт

Нийгэм-эдийн засгийн харилцаа сайжрах, бэлчээрийн мал аж ахуйн нөхцөл сайжрах, бие даасан засаг захиргааны нэгжүүдийг төвлөрүүлснээр эдийн засгийн хэмнэлт түргэсэх, экосистемийн хувьд эдэлбэр газрын хүрээ өргөсч байгаль орчны сөрөг өөрчлөлт багасахаас гадна эдийн засгийн томоохон хэмнэлт гарах юм.

Засаг захиргааны орон тоо, цалингийн үзүүлэлт , 2007 он, сая төгрөгөөр /Хүснэгт 9.4/

|   | Одоогийн байдал       |                     |             | Төлөвлөлтөөр        |                     |
|---|-----------------------|---------------------|-------------|---------------------|---------------------|
|   | Засаг захиргааны нэгж | Захиргааны орон тоо | Цалин сая.т | Захиргааны орон тоо | Цалингийн хэмнэлт % |
| 1 | Баян-Өлгий            | 2352                | 1507,2      | 524                 | 78                  |
| 2 | Увс                   | 2424                | 2221,9      | 500                 | 80                  |
| 3 | Ховд                  | 3288                | 2075,1      | 310                 | 88                  |
| 4 | Говь-Алтай            | 2664                | 2152,6      | 320                 | 88                  |
| 5 | Завхан                | 2592                | 2317,9      | 299                 | 89                  |
|   | Дүн                   | 13320               | 10274,7     | 1953                | 83                  |

Засаг захиргааны нэгжийн хуваарийн харьцуулалт /Хүснэгт 9.5/

|   | Одоогийн байдал |     |     | Төлөвлөлтөөр |     |
|---|-----------------|-----|-----|--------------|-----|
|   | Аймаг           | Сум | Баг | Хошуу        | Баг |
| 1 | Баян-Өлгий      | 14  | 84  | 4            | 10  |
| 2 | Говь-Алтай      | 18  | 83  | 5            | 13  |
| 3 | Завхан          | 24  | 113 | 6            | 18  |
| 4 | Увс             | 19  | 92  | 6            | 13  |
| 5 | Ховд            | 7   | 91  | 4            | 13  |
|   | Дүн             | 92  | 463 | 25           | 67  |

Тайлбар: Төлөвлөлтөөр хошууны төвд ажиллах орон тоо 50 хүн, одоогийн сумын төв баг болж 9 хүний орон тоотой цомхон үр бүтээлтэй засаг захиргааны орон тоог төлөвлөж байна.

Одоогийн засаг захиргааны хуваарь хэтэрхий жижиг хэсэгт хуваагдсан буюу сум, багийн удирдлагууд ажлын ачаалал багатай, төсөвт үрэлгэн байгаа учраас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлагын бүтцийг цөөлж чанаржуулах, чадваржуулах олон нийтэд хүрч харилцах болон ажлын ачааллыг нэмэгдүүлэхээр төлөвлөв.

Хуучин Багийн төвүүдийг лзөвхөн эрүүл мэнд болон экологи-байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагааг нь өргөтгөн ажиллуулах нь зүйтэй юм.


Баруун бүст 92 сумын жилийн төсөв 7 тэрбум 820 сая төгрөг, сумын засаг дарга нарын цалинд 433 сая 540 мянган төгрөг, багийн засаг дарга нарын цалинд 115 сая 750 мянган төгрөгийн хөрөнгийг засаг засаг захиргааны зардалд үр тун багатайгаар зарцуулж байна.

Тус өөрчлөлтийг хэрэгжүүлснээр гарах эерэг үр дүн их байна. Үүнд:

- Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах нөхцлийг бүрдүүлнэ. /одоогийн аймгийн гүйцэтгэж буй үүргийг хошуудад шилжүүлнэ/
- Төрийн үйлчилгээний шат дамжлага багасна.
- Хошуудын төвд зах зээлийн төвлөрөл бий болно.
- Орон нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын үүрэг хариуцлага нэмэгдэж, аймаг, хошуудын уялдаа холбоо сайжирч бие дааж тогтвортой хөгжих үндэс тавигдана.
- Иргэдийн орон нутгийн хөгжлийн талаарх сэтгэлгээний хүрээ тэлж, хошууны тогтолцооны хүрээнд сэтгэдэг болж, зах зээлийн болон бизнесийн таатай орчин бүрдэх нөхцөл бий болно.
- Төсвийн зардлын хэмнэлт гарна. /багийн засаг дарга, сумын хурлын тэргүүлэгчдийн болон нарийн бичгийн дарга, сумын засаг даргын тамгын газрын одоо байгаа орон тоо зохих хэмжээгээр буурах болно/
- Орон нутаг үйлдвэрлэл бизнесийн төвлөрөл үүссэнээр төвлөрсөн хотууд дахь хүн амын хэт бөөгнөрөл их нүүдлийг сааруулах, төв болон хязгаар нутгийн хөгжлийн ялгааг жигдрүүлэх бодит нөхцөл бүрдэнэ.
- Хүн амд үзүүлэх боловсрол, эмнэлэг зэрэг төрөөс үзүүлдэг үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, иргэд төрсөн нутагтаа тогтвортой суурьших нөхцөл сайжирна.
- Хошууны нутаг дэвсгэрийн хөгжил, хүн ам, хөдөлмөрийн нөөцийн ашиглалт, аж ахуйн үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирч, үйлдвэрлэл, үйлчилгээг дагнах, хорших чиглэлээр хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.
- Хошуудын түвшинд фермерийн болон эрчимжсэн аж ахуй, аялал жуулчлал зэрэг шинэлэг үр ашигтай чиглэлийг хөгжүүлэх замаар ажил эрхлэлт нэмэгдэж, ядуурлыг бууруулах, амьжиргааны түвшинг дээшлүүлэх боломж нэмэгдэнэ.

#### 9.4 ЗАСАГ ЗАХИРГАА УДИРДЛАГЫН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Удирдлагын бүтэц зохион байгуулалт /Схем 9.1/



Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг удирдлагын босоо тогтолцоонд оруулж бүсүүдийг Монгол Улсын ерөнхий сайдтай шууд харьцаж үйл ажиллагаагаа явуулах бүс нутгийн сайдтай болох шаардлагатай байна. Бүс нутгийн сайд аймгийн дэд сайдтай, хошууны захирагч багуудын зохион байгуулагч нартай харилцах юм.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг удирдлагын босоо тогтолцоонд оруулж бүсүүдийг Монгол Улсын засгийн газар, ерөнхий сайдтай шууд харьцаж үй ажиллагаагаа шуурхай явуулж байх бүс нутгийн сайдтай болох явдал тун их шаардагдаж байна. Энэ нь мэргэжлийн яамуудад бүс нутаг хариуцсан хэлтэсүүдийг ажиллуулах явдал юм.

Аймаг хөгжүүлэх дэд сайд, хошууны захирагч нар нутаг дэвсгэрийн томсгосон хүрээнд Засаг захиргааны бүхий л үйл ажиллагааг явуулна. Харин багийн захирагчийн ажлын хүрээнд экосистемийн эргүүл хамгаалалт, нийгмийн хамгааллын үйл ажиллагаанууд илүү явагдах юм.

Монгол улс бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар хөгжиж байгаа бөгөөд Баруун бүс, Хангайн бүс, Төвийн бүс, Зүүн бүс гэсэн 4 үндсэн бүсийг тодорхой чиглэсэн хөгжлийн зорилготойгоор, бүс бүр хөгжлийнхөө хөтөлбөрийг боловсруулан, үр бүтээлтэй хөгжүүлэхээр чармайн ажиллаж байна. Иймээс Монгол улсыг бүсчилэн хөгжүүлэх үзэл баримтлалын дагуу 4 аймагтай байлгах нь удирдлага зохион байгуулалт, эдийн засгийн хувьд маш цэгцтэй болох боломжтой юм. Засаг

захиргааны нэгжийг цөөлж нэгтгэсэнээр үргүй зардал, удирдлагын зардал 52-58 хувиар буурах тооцоо гарч байна.

Эндээс үзэхэд баруун бүсийг хошууны зохион байгуулалтаас гадна нийтэд нь нэг аймаг болгон хөгжүүлэх ч үндэслэл байна. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг 2009-2016 онд 5-8 тэрбум төгрөгт хүргэх, ажилгүйдлийн түвшинг бууруулах, орон нутгийн төсвийн орлоог 2-5 дахин нэмэгдүүлэх, хүн амын шилжилт хөдөлгөөний балансыг 20 хувь хүртэл бууруулах зэрэг хамтын хүчийг нэгтгэсэн олон давуу талуудтай юм. Гэхдээ сайтар судалж боловсруулсны үндсэн дээр төлөвлөж болох юм.

Баруун бүсийн төв нь 2009-2016 онд Ховд хотод, төлөвлөлтийн хугацаанд болон төлөвлөлтөөс цааш хугацаанд Сутай хотод төвлөрөх болно.

Хөрөнгө оруулалтын тэгшитгэлээс үзэхэд бүтээмж 1 пунктээр дээшлэхэд 0.17 хувиар нэмэгдэж, зээлийн хүү буурахад хөрөнгө оруулалт 2.08 хувь өсөхөөр байна. Тэгшитгэлээс үзэхэд баруун бүсийг нэг аймаг болгосоноор бүтээмж 4-6 пунктээр дээшлэх болно.

### **Хэрэгжүүлэх арга хэмжээ**

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг бүхэлд нь шинэчлэх хүртэл, бүс нутгийн хөгжлийн төслийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд 2009 оноос шинээр байгуулахаар төлөвлөж буй Үндэсний хөгжлийн яам /эдийн засгийн/, бүсийн түвшинд, Бүсийн зөвлөлүүд /тухайн бүсийн хөгжлийг дэмжигч компанийн төлөөлөл орсон/, бүсийн тулгуур төв хотын захирагч нартай хамтран тус тус зохицуулах нь зүйтэй байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хот тосгоны эрхзүйн байдлын тухай хуульд орон нутгийн удирдлагаас бүс нутгийн хөгжлийн нийтлэг асуудлыг шийдвэрлэх талаар хүлээх үүрэг, хөрөнгө хүч төвлөрүүлж хуваарилах эрх, хариуцлагыг тодорхой зааж өгөх шаардлагатай байна.

Сум бүрийн жижиг нөөцийг орон нутгийн хөгжил, байгаль орчны арга хэмжээнд төвлөрүүлж, зохистой ашиглах үндсийг бүрдүүлэхтэй холбогдуулан “эдийн засгийн бичил бүсүүд, бүлэг суурингийн тогтолцоо”-ны талаарх аймгуудын ИТХ-ын саналыг УИХ-аар ойрын хугацаанд хэлэлцүүлж, баталгаажуулах нь чухал.

Нутаг залгаа сумдыг байгалийн болон уламжлалт үйлдвэрлэлийн нөөц, дэд бүтцийн уялдаа холбоо болон зах зээлийн таатай нөхцөл, тулгамдаж байгаа шийдвэрлэвэл зохих нийтлэг асуудлуудыг хэрэгжүүлэхийн тулд бичил бүсээр хамтран ажиллах хууль эрх зүйн болон эдийн засгийн хөшvvргүүдийг хэрэглэж болох юм.

Баруун бүсийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт төлөвлөлтийн зургийг дээрхи санал, бодлого, чиглэлийг үндэслэн хоёр хувилбараар гаргалаа

## **Арав. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ ТҮҮНИЙ ТӨЛӨВЛӨЛТ**

### **10.1 ХӨРС, УС, АН АМЬТНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ**

#### **10.1.1 Хөрс хамгаалах талаар**

Баруун бүсэд хүний үйл ажиллагааны нөлөөгөөр газрын хөрс эвдэрч элэгдэх, үржил шим нь буурч муудах явдал олон хэлбэрээр илэрдэг. Үүнд:

- Бэлчээрийн ургамал хэт талхлагдсанаас болж хөрсний өнгөн үе эвдрэх, шинж чанар нь муудах;
- Тариалангийн хөрс салхинд хийсч элэгдэх, өнгөн хэсэг нь элсжих;
- Тариалангийн хөрсний ялзмагийн алдагдал даамжирч, үржил шим нь буурах;
- Автомашины олон салаа замын уршгаар газрын хөрс эвдрэх, ашиг шимээ алдах;
- Уулын хажуу, хэвгий газрын хөрс гадаргын урсацаар эвдэрч, гуу жалга үүсэх;
- Хажуу, хэвгий газруудад, ялангуяа худаг, усны ойролцоо малын хөлөөр нарийн жим зөрөг нэлдээ үүсч хөрс дагтарших, эвдрэх нөхцөл бүрдэх;
- Ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, уул-техникийн үйл ажиллагааны нөлөөгөөр газар эвдэрч, хөрс устах, бохирдох;
- Элсний нүүдэл газар авч хөрсний гадаргуу элсээр хучигдах, шинж чанар нь доройтох;
- Хот, төв, суурин газрын хөрс хувирч өөрчлөгдөх, бохирдох;

- Олон жилийн цэвдгийн гэсэлтээс улбаалж хөрс гулсах, цөмрөх, суух үзэгдэл элбэгших;



Дээрх үзэгдлүүдээс бэлчээрийн хөрсний доройтол, тариалангийн хөрсний элэгдэл ба үржил шимийн алдагдал, элсний нүүдэл, автозамын дагуух хөрсний эвдрэл, ашигт малтмалын олборлолтоос үүссэн ухмал нүх, овоолгон шороо хамгийн түгшүүр төрүүлж байгаль орчин, эдийн засаг, нийгмийн амьдралд

үлэмж хор хохирол учруулсаар байна. Цаашид хөрс хамгааллын талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- Бэлчээрийн ургамлыг нөхөн сэргээхийн тулд таримал бэлчээр, хадлан бий болгох, дулааны улиралд бог малыг бэлчээрт нь хотлуулж өнжөөх ажлыг хуваарьтай зохион байгуулах;
- Тариалангийн талбайн хагалгааны шан, тариалах зурвасыг салхины голлох чиглэлд хөндлөн байрлуулах, 50 м-ээс өргөнгүй зурвасаар сэлгэн тариалах;
- Тарианы гуурсыг талбайд нь өнжөөх, хөрсийг хавж хагалах, хөшиг ургамал тарих, нүцгэн талбайг гуурсаар хучих, цас тогтоох, боломжтой нөхцөлд хаврын цэнэг усалгаа хийх, мод, бут сөөгөн зурвас байгуулах, механик хамгаалалт хийх зэрэг тариалангийн хөрсийг салхинд хийсч эвдрэхээс хамгаалах бүхий л арга ажиллагааг цаг алдалгүй, чанартай гүйцэтгэж байх;
- Тариалангийн талбайд агрохимийн зураглал хийж, эрдэс ( NPK ) болон органик бордооны тун хэмжээг тогтоож, талбайг агротехнологийн шаардлагын дагуу тогтмол бордож байх, малын өтөг, бууц зэрэг орон нутгийн бордоог өргөнөөр ашиглах;
- Эвдэрсэн хөрс, элсжсэн талбайг ургамалжуулах, ногоон бордоо хэрэглэх, органик барьцалдуулагч болон цеолит мэтийн шингээгч бодисоор бордож хөрсний физик шинжийг сайжруулах арга хэмжээ авах;
- Автомашины хөдөлгөөнийг цэгцлэх, олон салаа зам гаргуулахгүй байх, хаягдсан хуучин замуудыг сийрэгжүүлж ургамалжуулах ажлыг автозамын байгууллагууд болон олон түмнийг идэвхтэй оролцуулан үр нөлөөтэй зохион байгуулах;
- Уул уурхайн ашигласан талбайг засч тэгшлэх, биологийн нөхөн сэргээлт хийж хөрсжүүлэх, ургамалжуулах ажлыг технологийн дагуу заавал гүйцэтгүүлж түүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог өндөржүүлэх;
- Хот, төв, суурин газрын хөрсийг зүлэгжүүлэх, мод, бут сөөг тарих, нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн талбайг стандартын шаардлагад хүргэх, ахуйн хог хаягдал болон хөрсний бохирдол үүсгэж болох үйлдвэрийн хаягдал, бохир усыг цэвэрлэх, саармагжуулах, зайлуулах, түүнд тавих эрүүл ахуйн хяналтыг эрс сайжруулах;
- Элсний нүүдлээс хамгаалах биологийн болон механик аргыг өргөн нэвтрүүлэх, төв, суурингийн орчимын элстэй газрыг чулуугаар хучих, явган хүний зам, гудамж талбайд байгалийн зассан чулуу шигтгэж тэгшлэх зэрэг хямд төсөр энгийн аргыг түлхүү хэрэглэх;
- Усалгаатай тариалангийн усалгааны норм горим, техник технологийг орон нутгийн нөхцөлд тохируулан зөв сонгож, усалгааны нөлөөгөөр хөрс давсжихаас болгоомжлох, усалгаатай талбайн хөрсний шинж чанарын өөрчлөлт, шим тэжээлийн хангамжийг тогтмол хянаж байх;
- Газар ашиглалттай холбоотой Монгол улсын (Газрын тухай, 2002-6-7; Газрын төлбөрийн тухай, 1997-4-24; Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, 2002-6-27; Тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн тухай, 1997-10-23; Газрын хэвлийн тухай, 1988-11-29; Ахуйн ба үйлдвэрийн хог хаягдлын тухай, 2003-11-26; гэх мэт) хууль дүрмийг өргөн сурталчлах, түүний хэрэгжилтэд байнга хяналт тавьж зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцож байх журмыг хэвшүүлэх;

### 10.1.2 Усны нөөц хамгаалах талаар

2003 онд явуулсан гадаргын усны нэгдсэн тооллогын дүнгээс харахад Баруун бүсэд байдаг 1126 гол горхиос 45 нь, 2920 булаг шандаас 136 нь, 1694 нуур, тойрмоос 229 нь хатаж ширгэсэн байжээ. Ялангуяа Баян-Өлгий аймагт мөстлөгийн гаралтай 217 жижиг нуур тойром ширгэсэн нь ихээхэн анхаарал татаж байна. Мөн Баян-Өлгий аймагт 17 гол горхи, 42 булаг шанд, Говь-Алтай аймагт 35 булаг шанд, Завхан аймагт 19 гол горхи, Увс аймагт 31 булаг шанд хатаж ширгэсэн нь, нэг талаар хүний буруу үйл ажиллагааны үр дагавар, нөгөө талаар дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, дулааралтай холбоотой юм.

Сүүлийн үеийн ажиглалт, судалгаагаар Монгол Алтайн өндөр уулын мөстөл багасч, хур цас мөс ихээр хайлж, цас мөсгүй болох явдал ажиглагдсаар байна. Жишээ нь Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын Рашаант голын эхний мөсөн гол хайлж хэмжээ нь багасчээ.

Хүрээлэн буй орчны өөрчлөлтөөс хамаарч голын урсацын горим өөрчлөгдөх, усны баланс алдагдах явдал ажиглагдах боллоо. Жишээ нь Идэр голын (Тосонцэнгэл) савд нэгж тунадасаас үүсэх урсацын хэмжээ нэмэгдсэн нь ойн талбай багасч, бэлчээр талхлагдсаны улмаас гадаргын нэл урсацын хэмжээ ихэссэнтэй холбоотой юм. Гэтэл Ховд (Өлгий, Мянгад), Чигэстэй (Улиастай) голуудад нэгж тунадасаас үүсэх урсацын хэмжээ багассан нь усны эрчим хүчийг ашиглах, уул уурхайн зориулалтаар ус ашиглах,

## Баруун бүсийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын хэтийн төлөв

(Хувилбар 1)

Масштаб 1: 3 000 000

Зураг 9.11



"Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын хэтийн төлөв" (Баримт, хот байгуулалтын яам) Зурагны эх бэлтгэсэн: Н.Амгалан

усан сан байгуулах, усалгааны суваг шуудуу татах, усны гадаргаас уурших ууршилт нэмэгдэх, ашигт малтмалын олборлолтын явцад газрын гадарга ихээхэн эвдэгдэх зэрэг орчны өөрчлөлтийн шууд үр дагавар юм. Ялангуяа алт олборлолтын нөлөөгөөр голын ус булингартах, бохирдох, горим өөрчлөгдөх, гольдирол нь эвдэгдэх явдал Увс аймгийн Түргэн сумын Ногоон усны булаг, Бургалтайн гол, Улаангом сумын Гашууны гол зэрэг газруудад тодорхой ажиглагдана. Түүнчлэн ахуйн хог хаягдлаас болж голын ус бохирдох үзэгдэл Буянт гол (Ховд хот), Билүү гол (Увс аймгийн Хяргас сумын төв), Гэдрэг гол (Увс аймгийн Малчин сумын төв), Чигэстэй гол (Улиастай хот)-ын орчимд хийсэн судалгаагаар илэрчээ. Гадаргын ус, голуудын урсацын горим өөрчлөгдсөнөөс шалтгаалан газрын доорхи усны тэжээл дутагдаж хомсдол үүсч байгааг судлаачид нотолж байна. Ус хамгаалах, усны нөөцийн менежментийг боловсронгуй болгох, усны бодлогын шинэтгэлийг хэрэгжүүлэх зорилгоор Баруун бүсийн хэмжээнд нэлээд олон чиглэлийн ажлыг төлөвлөж дэс дараатай үйл ажиллагаа явуулах хэрэгтэй. Үүнд:

- Хот, төв, суурин газар, уул уурхай, эрчим хүч, усалгаатай тариалангийн салбарт усны нөөцийн нөхөн сэлбэгдэх хэмжээг үндэслэн усны хэрэглээг үр ашигтай зохион байгуулах;
- Гол усны эх, булаг шандыг хашиж хамгаалах, мод сөөг тарих, хүн, мал, техникийн элдэв нөлөөллөөс сэргийлэх, голын усны гольдирылыг эвдэхгүй байх, голоос элс хайрга олборлохыг хориглох талаар орон нутгийн иргэдийн хяналт, идэвхтэй оролцоонд тулгуурлан үр өгөөжтэй, тууштай, тодорхой үнэлэмжтэй ажлууд хийж хэвшүүлэх;
- Голын усны ажиглалтын харуул, нуур усны мониторинг судалгааны цэгийг олшруулах, Алтай Таван Богд, Цамбагарав зэрэг ууланд мөсөн голын байнгын судалгааны цэгүүд байгуулах, мөн газрын доорх усны хяналтын сүлжээ бий болгох замаар усны нөөц, горим, чанар, хувьсал өөрчлөлтийг нарийвчлан судалж Бүс нутгийн усны мэдээллийн нэгдсэн сан байгуулах, улмаар шийдвэр гаргагчид ба хэрэглэгчдийг усны мэдээллээр шуурхай хангах орчин үеийн үйлчилгээний системийг нэвтрүүлэх;
- Усны эрэл хайгуулын ажлын техник, технологийг шинэчлэх, хүн ам, хөдөө аж ахуй, үйлдвэр, уул уурхайн усан хангамжийг сайжруулах, инженерийн худаг, уст цэгүүдийг олшруулах арга хэмжээг нэгдсэн бодлогоор зохицуулж хэрэгжүүлэх;
- Усны холбогдолтой Монгол Улсын (Байгаль орчныг хамгаалах тухай, 1995-3-30; Усны тухай, 2007-04-22; Ус, рашааны нөөц ашигласан төлбөрийн тухай, 1995-5-22; Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, 2002-6-13; Рашааны тухай, 2003-11-7; Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, 1998-1-22; Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, 1997-11-13; Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, 1999-12-16 гэх мэт) хуулиудыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, олон түмний дунд өргөн сурталчлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох ажлыг тогтмол зохион байгуулж, энэ ажилд орон нутгийн засаг захиргааны болон хуулийн байгууллагын ажилтнууд, иргэд, малчид, багш, оюутан нарыг идэвхтэй оролцуулах;
- Төв, суурин, уул уурхайн газруудын болон үйлдвэрийн хог хаягдлыг гол горхи, нуур усны эргээс хол байршуулж газарт булж далдлах, хаягдал ус цэвэрлэх, зайлуулах арга технологийг боловсронгуй болгох, химийн хорт болон аюултай бодис хэрэглэх, ялгаруулах үйл ажиллагаанд хатуу хяналт тавих зэргээр усны бохирдлоос урьдчилан сэргийлэх бүхий л боломжтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Орон нутгийн нөхцөл боломжийг ашиглан цасны болон хур борооны ус, гадаргын урсацыг тогтоон хуримтлуулах замаар хөдөө аж ахуйн (мал, тариалан, хадлангийн) усан хангамжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хөхүүлэн дэмжиж, мэргэжлийн болон санхүүгийн туслалцаа үзүүлэх;
- Уул уурхай, усан цахилгаан станц болон байгалийн нөөц баялгийг ашигладаг үйлдвэр, аж ахуйн бүх газруудад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийхдээ усан орчны асуудалд онцгой анхаарч гол горхины эх ундаргыг хөндөхгүй байх, усны хомсдол, бохирдол үүсэхгүй байх нөхцөлийг хангах;
- Төв, суурийн газруудын ундны усны эх үүсвэрийг баталгаажуулах, хүн амын болон үйлдвэрийн усны хэрэглээний нормыг шинэчлэн тогтоох, ундны усыг зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх, иоджуулах арга хэмжээг авах;
- Гадаргын ус болон уст цэгүүдийн үзлэг тооллогыг үе үе явуулж усны хангамжийн түвшинг шинэчлэн тогтоох, Байгаль дахь экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөөгүйгээр бэлчээр, хадлан, тариаланг усжуулах, услалтын системүүдийг технологийн горимын дагуу зөв зохистой ашиглах;
- Говийн баян бүрдүүд болон ус намгархаг газрыг хатаж хагсахаас хамгаалахын тулд тэнд хүн, мал олноор бөөгнөрүүлэхгүй, мод, бут сөөгийг нь огтлохгүй, өвс ургамлыг нь талхлахгүй, газар ухаж, суваг шуудуу татахгүй байх зэрэг наад захын дэг журам тогтоож хэвшүүлэх;

## Баруун бүсийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын хэтийн төлөв

Хувилбар 2

Масштаб 1: 3 000 000





- Усны урсацын 70%-ийг бүрэлдүүлдэг голуудын сав газрын эхэн хэсгийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулах чиглэлийг баримтлан зарим газрыг улсын буюу орон нутгийн тусгай хамгаалалтад нэмж авах;
- Усны нөөцийг (ер нь байгалийг) ашиглах, хамгаалах үйл ажиллагааг төлөвлөхдөө зөвхөн засаг захиргааны нэгжийн (аймаг, сумын) хилээр биш гол усны ай савын хилийг баримтлан ай савын менежментийн зарчмаар төлөвлөж хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй гэж нотолдог гадаад орнуудын туршлагыг нэвтрүүлж Ховд голын, Увс нуурын, Завхан голын гэх мэт ай сав тус бүрийн усны гүйдлээр нэвт холбоотой байгалийн нэгдмэл тогтолцоог бүхэлд нь хянах боломжийг туршиж үзэх.

Баруун бүсэд Монгол Улсын бүх нуур тойрмын талбайн 59 хувийг эзэлж байна. Гол мөрний усан доорх талбайн 49 хувь, мөнх цас мөсөн голын доорх талбай 100 хувь энэ бүсэд оршино. Энэ бүсийн усны нийт нөөц Монгол Улсын усны нөөцийн 29%-ийг эзэлнэ. Гэтэл энэ бүсэд хүн ам, мал сүргийн усан хангамжийн хүрэлцээ муу байгаагийн улмаас олон сөрөг үр дагавар араасаа дагуулж байна. Баруун бүс нутагт усны бохирдол харьцангуй бага байгаа боловч, усны шинэ нөөц илрүүлэх, оновчтой ашиглах шаардлагатай байна. Цаашид бэлчээрийг усжуулах, усалгаатай газар тариалан эрхлэх, зарим төв суурин газрын ундны чанарыг сайжруулах зэрэг олон чухал асуудлыг шийдэх хэрэгтэй байна.

### 10.1.3 Ан амьтныг хамгаалах талаар

Ан амьтныг хамгаалах чиглэлээр зарим шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- Ан агнуурын үйл ажиллагааг зөвхөн хуулийн дагуу, зөвшөөрөгдсөн хугацаанд явуулж, элдэв зөрчил гаргах явдалтай тэмцэх, түүнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд ард иргэдийн оролцоог идэвхжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Хүүхэд, сурагчид, залуучуудад амьд байгаль, ан амьтан, жигүүртэн шувуудыг хайрлан хамгаалах, халамжлан тэтгэх био гоозүйн хүмүүжил олгох талаар тодорхой ажлууд зохиж хэвлэл, телевиз, радио нэвтрүүлгийг өргөн ашиглах;
- Тусгай хамгаалалттай газруудын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах, ажилтнуудын мэдлэг чадвар, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, тусгай хамгаалалтын дэглэм горимыг чанд сахиж хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтын механизмыг боловсронгуй болгох арга хэмжээг авах;
- Зэрлэг ан амьтан, жигүүртэн шувуу, загас жараахайг өсгөн үржүүлэх, шилжүүлэн нутагшуулах, тэдний амьдрах орчныг сайжруулах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр орон нутгийн болон үндэсний хөтөлбөрийн хүрээнд, олон улсын төсөл тусламжаар янз бүрийн хэлбэрийн ажил зохион байгуулж олон түмний идэвх санаачлагыг өрнүүлэх;
- Ан амьтны талаарх Монгол Улсын хуулиудыг (Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, 1994-11-15; Ан агнуурын тухай, 2000-5-5; Амьтны аймгийн тухай, 2000-5-5; Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай, 2002-11-7; Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай, 1995-5-22; Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай, 2000-1-28; гэх мэт) судалж, сурталчилах ажлыг иргэд, олон түмний дунд өргөн хүрээтэй зохион байгуулж, хуулийг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих, хариуцлага тооцоход онцгой анхаарч энэ талаар засаг захиргаа, хууль хяналтын байгууллага, иргэдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх;
- Ан амьтныг судлах, хамгаалах болон агнуур эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан тэдний дунд чөлөөт ярилцлага, семинар, зөвлөлгөөн зохион байгуулж ард иргэдийг өргөнөөр татан оролцуулахын хамт ан амьтны нөөцийг зохистой ашиглах, өсгөж арвижуулах, хамгаалах талаар тухайн нутаг орны онцлогт нийцсэн хамтын шийдвэр гаргаж түүнийг дагаж мөрдөх;
- Ан амьтны тооллогыг орон нутгийн хэмжээнд үе үе явуулж байгууллага, иргэдийг бодит мэдээллээр хангаж байх;
- Шаардлагатай гэж үзвэл ан амьтныг хамгаалах, тоо толгойг нь өсгөх, ангийн нөөцтэй болох зорилгоор орон нутгийн хэмжээний тусгай хамгаалалттай газар байгуулах, ан агнуурын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хязгаарлах, хориглох зэрэг бие даасан шийдвэр гаргаж, биелтэнд нь хяналт тавих;
- Аймаг, сумдын газар ашиглалтын төлөвлөгөөнд зэрлэг ан амьтдын амьдрах орчин, усны эх үүсвэрийг хамгаалах асуудлыг тусгаж хэрэгжүүлэх, биологийн төрөл зүйлийг хамгаалахад эдийн засгийн хөшүүргийг хэрэглэж хэвшүүлэх;

## 10.2 АГААР МАНДАЛ, УРГАМЛАН НӨМРӨГИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ

### 10.2.1 Агаар мандлыг хамгаалах

Сүүлийн 40 гаруй жилд Баруун бүсийн уур амьсгал мэдэгдэхүйц дулаарч агаарын жилийн дундаж температур нийт нутгийн хэмжээнд 1.64°C-аар, Увс, Ховд аймагт 2.03-2.1°C-аар нэмэгдсэн бөгөөд дулааралт өвлийн улиралд илүү эрчимтэй байна. Үүний зэрэгцээ агаар мандлын гаралтай хүчтэй салхи шуурга, аадрын үер бороо, ган, зуд, шар шороон шуурга (буюу түйрэн) мэтийн байгалийн гамшигт үзэгдэл байнга тохиолдож давтамж нь өсөх хандлагатай байна. Их Нууруудын хотгор, Алтайн Өвөр говийн хотгоруудад хүчтэй хуйлраа салхи үе үе үүсч өнгөн хөрсний нарийн тоос шороог хэдхэн хормын дотор 3-5км хүртэл өндөрт хөөргөж, тийнхүү агаар мандалд дэгдсэн түйрэн дунджаар 180-200км/цаг-ийн хурдтай зүүн ба зүүн өмнө зүг рүү хийсч 2-3 хоногийн дараа Бээжин хот, Солонгосын хойг, Японы аралд хүрдэг байна. Тэр ч байтугай Монголын говьд үүссэн тоос түйрэн агаарын урсгалаар зөөгдөж 7 хоногийн дотор Америк, Канадын баруун эрэгт хүрэх тохиолдол олонтаа гарч, шар шорооны нүүдэл буюу түйрэнгээс хамгаалах асуудал Монгол, Хятад, Солонгос, Япон улсын судлаачдын хамтын ажиллагааны нэг чухал сэдэв болоод байна. 1950-иад онд жилд 5 удаа болдог байсан шар шороон шуурга 1990 онд 17 удаа, 2000 онд 12 удаа, 2001 онд 32 удаа тохиолджээ. Зарим газар шороон шуургатай өдрийн тоо 2-3 дахин нэмэгдэж хөрсний эвдрэл, элсний нүүлт, цөлжилт эрчимжих хандлага ажиглагдсаар байна.

Агаар мандлыг хамгаалах талаар дараах зарим зүйлийг хийж болох байна. Үүнд:

- Хил дамнасан шар шороон шуурга буюу түйрэн үүсдэг гол голомт газрууд болох Их Нууруудын хотгор доторхи хотос хонхоруудын ёроол болон Алтайн цаад дахь хотгоруудын ёроолыг ургамалжуулах, тэндхийн хөрсийг бэхжүүлэх, мод, бут сөөг тарих ажлыг эрчимтэй өрнүүлэх замаар агаарын доод үеийн хуйлраа хөдөлгөөнийг сааруулах, энэ чиглэлээр олон улсын хамтарсан төслүүд хэрэгжүүлэх;
- Агаар дахь хүлэмжийн хийн агууламжийг багасгах зорилгоор ой мод, бут сөөг тарих ажлыг Баруун бүсийн бүх аймаг, сумдын нутагт, тэр тусмаа Хангай, Монгол Алтайн нурууны ой нь устаж үгүй болж байгаа нутагт, мөн голын татам хөндий, ус намгархаг газруудаар далайцтай өрнүүлж, энэ чиглэлээр Азийн хөгжлийн ба Дэлхийн банк, Даян дэлхийн байгаль хамгаалах сан, бусад олон улсын байгууллага болон хөтөлбөр, төслүүдийн шугамаар дэмжлэг туслалцаа авах асуудлыг үр дүнтэй, шуурхай, ажил хэрэгчээр зохион байгуулах;
- Шар шороон шуурганы (түйрэнгийн) эх үүсвэр, нүүдлийн замыг тодорхойлох, мониторингийн судалгаа явуулах, мэдээллийн систем бүрдүүлэх, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судлах, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга замыг боловсруулах чиглэлээр Монгол, Хятад, Япон, Солонгосын хамтарсан төсөл хэрэгжүүлэхээр бэлтгэж байгаа бөгөөд энэ төслийн гол үйл ажиллагааг Баруун бүсэд төвлөрүүлэх асуудлыг дэвшүүлж цаг алдалгүй шийдвэрлүүлэх;
- Аймаг, сумын төв, уул уурхайн газруудын агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн тооллого явуулах, агаарын бохирдлын түвшин болон бохирдуулагч эх үүсвэрт байнгын хяналт тавих, шинээр байгуулах ба өргөтгөх үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламжийн төсөлд агаар мандалд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж зөвшөөрөл олгох;
- Гүйцэд шатаалттай гэрийн зуухны технологи, утаагүй түлш нэвтрүүлэх замаар зуухнаас гарах утааг багасгах, хог хаягдлыг ил задгай хаях, шатаахыг бүрмөсөн хориглох арга хэмжээ авах, шахмал түлш үйлдвэрлэхэд хувийн хэвшлийнхний оролцоог бүх талаар дэмжиж мэргэжлийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- Аймгуудын төвд хог хаягдал ялгах, боловсруулах бага оврын үйлдвэрүүд байгуулах;
- Төв, суурингийн халаалтыг аажимдаа цахилгаан эх үүсвэрт шилжүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх;

### 10.2.2 Ургамлан нөмрөгийг хамгаалах талаар

Баруун бүсийн ургамлан нөмрөг, ялангуяа бэлчээрийн ургамал ихээхэн талхлагдаж, зүйлийн бүрэлдэхүүн нь цөөрөх, ургамлын бүрхэц сийрэгжих, элсээр хучигдах явдал газар сайгүй ажиглагдана. Өөрөөр хэлбэл цөлжилтийн үйл явц их эрчимжиж цөлийн эзлэх талбай жилээс жилд тэлсээр байна. Сүүлийн 10 гаруй жилд Монгол орны хэмжээнд цөлжилтөд хүчтэй нэрвэгдсэн нутгийн талбай 5.4 дахин, маш хүчтэй цөлжсөн нутгийн талбай 1.8 дахин ихэссэн гэсэн тооцоо бий бөгөөд үүний нэлээд хэсэг нь Баруун бүсэд хамаарна.

Цөлжилттэй тэмцэх явдал дэлхий нийтийн хэмжээний хурц асуудал болж улс гүрнүүдийн хамтын хүчин чармайлт, олон улсын байгууллагуудын нэгдмэл ажиллагааг зүй ёсоор шаардаж байна. Цөлжилттэй тэмцэх НҮБ-ийн конвенцийг 1994 онд баталж, Монгол Улс энэ конвенцид нэгдэн орсноос хойшхи 13 жилийн хугацаанд цөлжилттэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хоёрдох удаагаа боловсруулж 2003 онд Засгийн Газраас баталжээ. Уг хөтөлбөрийн гол зорилго нь уур амьсгалын өөрчлөлт

(дулаарал), хүний зохисгүй үйл ажиллагаанаас шалтгаалан жилээс жилд улам эрчимжиж буй цөлжилтийн явц, түүний сөрөг нөлөөллийг сааруулах цогц арга хэмжээг байгаль орчны даац болон бүс нутгийн онцлогт тохируулан үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэхээр тусгажээ. Цөлжилттэй тэмцэх Конвенци болон Азийн бүсийн цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Монгол Улс тодорхой үүрэгтэй оролцож төрийн бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээ тусгаж хэрэгжүүлж байгаагаас гадна цөлжилт, газрын доройтолтой тэмцэх чиглэлээр олон улсын хэд хэдэн төсөлд оролцож, “Цөлжилтөөс сэргийлэх нэгдсэн менежмент” төслийн хүрээнд говийн бүсийн 12 сумын нутагт 43 нөхөрлөл байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. Үүний үр дүнд орон нутгийн засаг захиргаа тус тусын нутаг дэвсгэрийн хүрээнд цөлжилттэй тэмцэх хөтөлбөр, төлөвлөгөөгөө боловсруулж доройтсон газрыг нөхөн сэргээх, мод сөөг тарих, худаг ус гаргах зэрэг бодитой ажлууд хийжээ.

Ургамал, ан амьтан болон байгалийн экосистемийн тодорхой хэсгийг хамгаалахад чиглэсэн төрийн бодлогоор зохицуулагддаг хамгийн чухал арга хэрэгсэл бол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ юм. Манай улсад 60 тусгай хамгаалттай газар байдгаас 20 нь Баруун бүсэд байрладаг. Түүний 5 нь дархан цаазтай газар (Говийн их дархан газар А,Б хэсэгтэй, Хөх Сэрхийн нуруу, Хасагт-Хайрхан, Отгонтэнгэр, Увс нуурын ай савын), нийлбэр талбай нь 6213153 га, 8 нь байгалийн цогцолборт газар (Алтай Таван Богд, Хар-Ус нуур, Цамбагарав, Сийлхэмийн нуруу, Хан-Хөхий-Хяргас нуур, Тарвагатайн нуруу, Мянган Угалзат, Мөнххайрхан уул), нийлбэр талбай нь 3179922 га, 6 нь байгалийн нөөц газар (Булган гол, Алаг-Хайрхан, Бурхан-Буудай, Дэвэлийн арал, Тэсийн гол, Шарга-Манхан), нийлбэр талбай нь 599436 га, 1 нь байгалийн дурсгалт газар-Ээж Хайрхан, талбай нь 22475 га юм. Эдгээр тусгай хамгаалалттай газар нутгийн нийт талбай 10014986 га буюу Баруун бүсийн бүх нутгийн 24.1%-ийг эзэлнэ. Үүнээс үзэхэд Баруун бүс дэх улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ улсынхаас бараг 2 дахин илүү нягтшилтай тул хангалттай гэж хэлж болно.

Ургамал, ан амьтныг хамгаалахад зориулсан хоёрдох томоохон арга хэмжээ бол Монгол Улсын Улаан Номыг бүтээж, түүнд манай орны ховор ба устаж үгүй болж байгаа амьтан, ургамлыг бүртгэн жагсааж олон нийтийн хүртээл болгосон билээ. Баруун бүсийн хэмжээнд устаж байгаа 5 зүйл хөхтөн амьтан (цөөвөр чоно, мазаалай, монгол бөхөн, соргог бөхөн, хавтгай), 2 зүйл шувуу (жороо тоодог, реликт цахлай), ховор ба ховордож байгаа 11 зүйл хөхтөн (азийн минж, атигдаахай, өөхөн сүүлт атигдаахай, козловын алагдаага, ойн унтаахай, эрэн хүрнэ, ирвэс, монгол хулан, зэгсний гахай, харсүүлт зээр, алтайн аргаль), 11 зүйл шувуу (борцгор хотон, халбаган хошуут, хар өрөвтас, гангар хун, хуруут хун, хошуу галуу, хээрийн галуу, явлаг сар, усны цагаан сүүлт бүргэд, гургуул, тоодог) Монгол Улсын Улаан Номонд бүртгэгджээ. Ургамлын хувьд гэвэл Баруун бүсэд ургадаг хөнөөгдөж байгаа болон ховордсон 26 зүйл ургамлыг Улаан Номонд оруулжээ. Тухайлбал: алтайн сонгино, цагаан цэцэгт сонгино, далиу сонгино, цоохор чонын хор (чонохор), монгол тост, вансэмбэрүү, дэвүүрт сагай, пржевальскийн чармай (улаан түлээ), заг, дөрвөлсөн мүгээ, алтан гагнуур, зүүнгарын гоёо, яшилдуу чацаргана, шивлээхэй зээргэнэ, шивүүрт харгана (тэмээн харгана), хонхот харгана, ганц навчит салжир, үнэгэн сүүлхэй лидэр, өлчир дэгд (цагаан дэгд), ганц цэцэгт алтан зул, цагаан бөлбөө, алтан сахуу цэцэг, эгэл өмхий өвс, эгэл шагшуурга, ямаан сэрдэг, сухай, тоорой зэрэг болно.

Ургамал хамгааллын талаар Баруун бүсэд доор дурьдсан зарим арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Бэлчээрийн талхагдал, доройтол, цөлжилттэй тэмцэх чиглэлээр бүс нутгийн хөтөлбөр боловсруулж олон улсын болон үндэсний хөтөлбөр, төслүүдтэй нягт уялдуулан тэдний дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх;
- Ой модыг хяналтгүй огтолж ашиглах, ойн түймэр гарах аюулыг таслан зогсоож ойг нөхөн сэргээх, мод сөөг тарих үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах, мод үржүүлгийн ажилд дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх;
- Ойн цэвэрлэгээ хийх, хортон шавьжтай тэмцэх ажлыг тогтмолжуулах;
- Ойд самар, жимс, мөөг, эмийн болон бусад ургамал түүх, явган аялал, зугаалга зохиох зэрэг ажлыг орон нутгийн холбогдох байгууллагын зөвшөөрлөөр, байгаль хамгаалагчийн хяналтын дор гүйцэтгэж байх журмыг мөрдөх;
- Говийн бүсийн бут сөөг, заган ойг огтолж ашиглахыг бүрмөсөн хориглох;
- Бэлчээрийг 4 улирлын турш хуваарьтай, сэлгэж ашиглах, худаг усны ойролцоо болон голын эхэнд олон айл, мал бөөгнөрүүлэхгүй байх;
- Ховор ба ховордсон ургамлыг тарьж үржүүлэх, үрийн фонд бий болгох санал санаачилгыг бүхий л талаар дэмжиж олон улсын болон үндэсний төсөлд хамруулах, мэргэжлийн болон санхүүгийн тусламж үзүүлэх;
- Ургамлын холбогдолтой Монгол Улсын хуулиудыг (Байгаль орчныг хамгаалах тухай, 1995-3-30; Ойн тухай, 2007-5-17; Байгалийн ургамлын тухай, 1995-4-11; Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, 1994-11-15; Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай, 1996-5-28; Байгалийн нөөц ашигласны

төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай, 2000-1-28; Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай, 1995-5-19; Ургамал хамгааллын тухай, 1996-3-22; гэх мэт ) судалж, сурталчилах ажлыг иргэд, олон түмний дунд өргөн хүрээтэй зохион байгуулж, хууль хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих хариуцлага тооцоход онцгой анхаарч энэ талаар засаг захиргаа, хууль хяналтын байгууллагуудын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх;

- Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох ажлыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах;
- Үлийн цагаан оготно болон царцааны тархалт, хор хөнөөлийг багасгах дэвшилтэт аргуудаас орон нутагт туршиж, сонгон нэвтрүүлэх;
- Бүс нутгийн ойн мэдээллийн сан, мониторингийн сүлжээ байгуулах, ойг хамгаалах, зохистой ашиглах, тарималжуулах, нөхөн сэргээх ажлыг мэргэжлийн боловсон хүчин, техник тоног төхөөрөмжөөр хангах;
- Ойн хортон шавьж, өвчинтэй байгальд халгүй аргаар тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх болон түймэр унтраах ажилд мэргэжлийн хүмүүсийг сургаж бэлтгэх, багаж техникээр хангах;

Монгол орны нийт нутаг дэвсгэрийн дөрөвний нэг гаруй хувийг хамардаг баруун бүсийн газрын санд хөдөө аж ахуйн болон ойн сан бүхий газар зонхилж, харин бусад зориулалтын газар 3 хүрэхгүй хувийг эзэлж байна. Баруун бүсэд 29 сумыг хамарсан 9607.7 мянган га талбайтай 18 газрыг тусгай хамгаалалтанд авсан нь улсын нийт тусгай хамгаалалттай 45.82% болж байна. Гэвч энэ бүс нутагт газрын ашиглалт хамгаалалттай асуудлууд хуримтлагдсаар байна. Сүүлийн жилүүдэд малчид худаг устай өвөлжөө хаваржаа тойрон бөөгнөрсний улмаас бэлчээрийн талхлагдал нэмэгдэн, авто хөсгийн олон салаа зам газрын хөрсийг сүйтгэн бэлчээрийг ихээхэн хомсдуулжээ. Мөн инженерийн хийцтэй худгаа эвдэж сүйтгэсний улмаас их хэмжээний бэлчээрийг ашиглаж чадахгүйд хүрчээ. Ашигт малтмал олборлолттой холбоотойгоор хөрсний эвдрэл ихсэх хандлагатай болж байна.

Баруун бүс нутагт агаар бохирдуулдаггүй өндөр үр ашигтай, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, бохирдуулах эх үүсвэрүүдийг цөөлөх, шаталт сайтай зуух, түлшийг өргөн хэрэглэх, хог хаягдлыг дахин боловсруулах, хот суурин газрыг зүлэгжүүлэх зэрэг ажлыг дэс дараатай хийж, хэвшүүлэх шаардлагатай байна. Зуд, хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, мөндөр, хүйтэн бороо орох, үер, ган, хүн мал ургамал, амьтны гоц халдварт өвчин, ой хээрийн түймэр зэрэг байгалийн гэнэтийн үзэгдэлд гамшиг зэрэг үе үе тохиолдож мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл болон эдийн засаг байгаль орчинд багагүй хохирол учруулсаар байна.

Байгалийн гамшгийг судлах, урьдчилан сэргийлэх, нэгэнт тохиолдсон гамшигтай тэмцэх, учирсан хохирлыг багасгах чиглэлээр олон улсын байгууллагуудаас дэмжлэг тусалцаа үзүүлж, удирдлага зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээ авдаг боловч гамшгийн хувь хэмжээ тууштай буухгүй байна.

Баруун бүс нутгийн ихэнх хэсэг нь байгалийн хуурай, хуурайвтар бүсэд оршдог бөгөөд бүсийн байгаль орчныг доройтуулж, байгалийн нөөц, түүний дотроос биологийн нөөцийг хомсдуулж байгаа хүчин зүйлийн нэг нь цөлжилт юм. Цаг уурын дулааралт, хур тунадасны жигд биш тархалт, бэлчээрийн талхагдал, газар тариалан, хот суурин газрын хөрсний элэгдэл, гангийн давтамж зэргээс шалтгаалан цөлжилт эрчимжих хандлагатай болжээ.

Цөлжилтийн нэг илрэл нь элсний нүүдэл. Монгол орны нийт элсний 50 гаруй хувь нь байдаг их нууруудын хотгор хамгийн их өртөөд байна. Зарим судлаачдын үзэж байгаагаар их нууруудын хотгорын 41.2% нь бага зэрэг, 31.9% нь дун зэрэг, 16.7% нь хүчтэй, 10.2% нь маш хүчтэй цөлжилтөнд өртсөн байна. Манай орны гандуу бүс нутагт 1940 оноос хойш 3800 км.кв талбай шинээр элсжисний 872 км.кв зөвхөн Монгол элсний урд зах, Хүйсийн говийн дагуух нутагт байна. Говь-Алтай аймгийн Хөх морьт сумын төв элсэнд дарагдаж Монгол элс, Бөөрөг дэл, Бор хяр зэрэг томоохон элстэй нутгийн элсний нүүдэл ихсэж байна. Элсний нүүдэл, цөлжилт ихсэх нь хүний зүй бус ажиллагаатай бас холбоотой. Иймд экологийн энэхүү эмзэг асуудлыг онцгой анхаарч, дотоод гадаадын хөрөнгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн цөлжилттэй хийх тэмцлийг шинэ шатанд гаргах шаардлагатай байна.

### 10.2.2.1 Ойн зурвас байгуулах талаар

Баруун бүсийг говийн бүстэй холбосон ойн, түүний дотор заган ойн бүсийг доорх чиглэлээр байгуулах боломжтой бөгөөд Монголын говь талд Алтайн нурууны ар, өвөр, дунд хэсгээр үргэлжилсэн гурван урт ногоон бүсийг хэт нь байгуулах нь зүйтэй.

1. Алтайн ар тал буюу хойт хэсэг нь Ховд хотоос эхлэн Ховдын Манхан, Зэрэг, Дарви, Говь-Алтайн Дарви, Хөх морьт, Шарга, Баян уул, Жаргалант, Тайшир, Түмэн, Дэлгэрэх /Гуулингийн талын суваг/, Улаан Шалын хоолой – Баянхонгорын Бууцагаан – Баянцагаан/ Бөөнцагаан нуурын орчим/, Монголын хоолой - Өвөрхангайн Баруун баян улаан /Зүүнбогд, Арцын ар/, Өмнөговийн Онгийн нурууны урд бие, Мандал-Овоогийн урд бие, Цогт-Овоогийн ар, Дундговийн Өлзийтийн урд бие/Загийн усны говь/ - Дорно говийн Мандах.

2. Алтайн нурууны дундах хэсэг Говь-Алтайн Шаргаас эхэлж Халиун, Бигэр, Чандмань, Эрдэнийн нутаг улмаар Баянхонгорын Баян-Өндөр, Баянговь, Баянлигийн нутаг, Арц Богдын өвөр говьд хүрч Өмнөговийн Баянзагийн Говь-Гурвансайхан, Хан уулын ар, Тавантолгой – Ханбогдын хээрийн булаг төлөгийн тал – Амтгайн говь – Дорноговийн Хатан булагийн дуутын тойром.
3. Алтайн нурууны өвөр говийн хэсэг нь Ховдын Булган – Алтай – Говь-Алтай – Бугатын тахийн тал, Алтай сум, Нарийн хөхийн говь – Баянхонгорын Сэгс цагаан богдын ар, Өмнөговийн Гурван тэсийн хоолой – Хүрмэний урд говь – Галбын говь – Дорноговийн Хатанбулаг – Улаанбадрахын хоёр зааны хөндий Замын үүд юм.

Баруун бүс нь цэнгэг нуур, гол ихтэй учир дурьдсан аймгуудын нууруудад загас, шувуу үржүүлэх, түүний дотор Ховд, Увс зэрэг аймагт загас үржүүлэг, агнуурын бэсрэг аж ахуй байгуулах арга хэмжээ авах нь зүйтэй. Баруун бүс нутагт дэд бүтэц, түүний дотор зам, ялангуяа авто зам ойрын үед нилээд баригдах, улмаар гадаад худалдаа өргөжих аятай боломж бий болж буйг харгалзан бүсийн аймгуудад улс, аймаг хоорондын болон дотоодын тээврийг их хэмжээгээр тогтмол, баталгаатай гүйцэтгэх томоохон авто аж ахуйнуудыг бүсийн аймгуудад одооноос байгуулж эхлэх хэрэгтэй.

Баруун бүсийг тогтвортой хөгжүүлэхэд анхаарах гол асуудлын нэг нь уг бүсэд ангиллын төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсийг бэлдэх Техник, мэргэжлийн сургуулиудыг сэргээх, шинээр байгуулах явдал болно. Мөн Ховд хотод баруун бүсийн дэд мэргэжлийн хүмүүс, түүний дотор инженер техник, эдийн засаг, хөдөө аж ахуй, соёл урлаг зэрэг чиглэлээр бэлдэх арга хэмжээг дэс дараатай авах хэрэгтэй.

Баруун бүсийн аймгууд нь олон ястан үндэстэнтэй, өвөрмөц амьдрал, соёл урлагтай учир тэдгээрийн амьдралын хэвшил, зан заншил, соёл урлагийг хадгалан хөгжүүлэхэд анхаарч уг бүсэд соёл урлагийн томоохон сургууль байгуулж ажиллуулах нь зүйтэй.

Монгол улсын ойн сангийн газрын 21 хувь нь оршдог Баруун бүсийн ойн сан бүхий газар эзэлдэг онцлогтой. Заган ойн 75 хувь нь Говь-Алтай аймаг, үлдсэн хэсэг нь Ховд аймаг байна. Ойг зөвшөөрөлгүйгээр их хэмжээгээр огтолж ашиглах явдал их байна. Зарим аймгийн төв, суурин газрын ойролцоох модны нөөц эрс багасчээ. Уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагааны улмаас ой хээрийн түймэр ихсэн хохирол нь улам бүр нэмэгдэх болжээ. Ой болон ургамлын нөөц багасахад хөнөөлт мэрэгч, шавьж багагүй нөлөөлж байна. Үүний улмаас газар нутаг ургамалгүйжиж, чийгийн ууршилт нэмэгдэн цас хунгарлалт багасч цөлжилтөнд нирвэгдэх аюул нүүрлэж эхлэв. Ийд ойг хамгаалах, ашиглалтанд нь тавих хяналтын сайжруулах, нөхөн сэргээх, ухаалаг хэрэгцээг төлөвшүүлэх шаардлага улам бүр нэмэгдсээр байна.

Баруун бүс нутгийн хөгжилд мод, сөөг тарих ажлыг өргөн хүрээтэй хийх шаардлагатай юм. Ойг нөхөн сэргээх ажилд мод, сөөгийг зөв сонгон нутагшуулах хэрэгтэй юм.

Баруун бүс нутагт эхний ээлжинд уулын ойг нөхөн тарихад шинэс модыг өргөн ашиглах. Мөн Ховд, Тэс зэрэг том жижиг голын дагуу бургас, чацаргана, хайлаас, зэргийг өргөнөөр тарих арга хэмжээг төлөвлөгөөтэй хийх ёстой юм. Ялангуяа Баянөлгий аймгийн Ховд голын дагуу сүүлийн жилүүдэд бургас, чацаргана их хэмжээгээр бэлтгэж ашиглаж байгаагаас сийрэгжиж ургах орчин муудаж байна. Иймд голын дагуу дээрх мод, сөөгийг тарьж ургуулах ажил их хэмжээтэй хийх хэрэгтэй байгаа юм.

Түүнчлэн Их Нууруудын хотгорт байгаа зарим нуурыг хамгаалах зорилгоор ногооруулах ажлыг хийх хэрэгтэй юм. Нуурын эргэн тойрон амрах нөхцлийг бэхжүүлэх чиглэлээр мод, сөөг тарималжуулах ойн зурвас байгуулах ажлыг төлөвлөгөөтэй авч явуулах шаардлагатай юм.

Эхний ээлжинд Хар нуур орчимд ойн зурвас байгуулах, Цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг 2010 оноос эхлүүлэх бэлтгэл ажлыг гүйцэтгэхээр төлөвлөлтөнд тусган оруулж байна. Нуурын эргэн тойрны орчинг хэвээр хадгалах, амрагчдын аятай байдлыг хангах зорилгоор нуур хамгаалах ойн зурвасыг 500 метрийн өргөнтэй 1000 метрийн урттай 3 эгнээ хийж хамгаалах ойролцоогоор 5 га талбайг болж байна.

1 га ойн зурвас байгуулахад 6 сая төгрөг бөгөөд 30 сая төгрөг шаардлагатай байна. Ойн зурвас байгуулсаны дараа байнгын хамгаалалт шаардлагатай болно. Үүнд жилд 1300,0 мянган төгрөг хэрэгтэй бөгөөд 5 жилд 4,5 сая төгрөг, харин 100 га цэцэрлэгт хүрээлэн байгуулахад 300 сая төгрөг шаардлагатай гэсэн урьдчилсан тооцоо байна.

Цэцэрлэгт хүрээлэн, ойн зурвас байгуулахад гол анхаарах зүйл бол усалгааны асуудал юм. Иймд усалгааны асуудлыг мэргэжлийн хүмүүсийн оролцоотой шийдвэрлэх хэрэгтэй юм.

**Ойн зурвас тарихад хэрэглэж болох мод, сөөг**

Хайлаас, бургас, харгана, улиас, гүйлс, буйлс зэрэг тарих бүрэн боломжтой. Эдгээрийн тарьж ургуулах, арчилгаа, тордолт зэргийг утс бүрт нь тоьч авч үзье.

### Бургас

**Бургас тарих талбайг сонгох** - Бургас тарих талбай нь хөнгөн шавранцар, элсэн, хар шороон хөрстэй бол илүү тохиромжтой. Жилд унах тунадасны дундаж хэмжээ 200-300 мм-ээс багагүй байх нь зүйтэй. Бургас үндэслүүлэх талбайн хөрсний ус аль болох ойр 1.5-2.0 м-ээс холгүй байх шаардлагатай. Бургасны үйлдвэрийн плантаци 50-100 га-аас доошгүй хэмжээтэй байх нь эдийн засгийн хувьд ач холбогдолтой.

**Бургасны саваа мөчрийг бэлтгэх** - Бургасны саваа мөчрийг тухайн газар нутагт ургаж байгаа бургасан шугуйг сийрүүлэх, засаж танах журмаар бэлтгэн авна. Үйлдвэрлэлийн түүхий эд бэлтгэх таримал шугуйг ургуулах зорилгоор байгалийн бургаснаас саваа мөчрийн тайрдас бэлтгэнэ. Сийрүүлж огтолсон модноос 1-2 настай, өвчин, хортонд нэрвэгдээгүй мөчрийг нь шилэн авч, саваа мөчрийг тусгай зориулалтын хайчаар бэлтгэнэ.

Машины тэвшинд цас дэвсэж, мөчрөө үелүүлэн тавьж дахин цасаар хучих замаар дүүртэл ачиж тээвэрлэх буюу эсвээс брезентээр боож тээвэрлэж болно. Ингэж авчирсан саваа мөчрийг тусгайлан шуудуулж ухсан нүх буюу зооринд үелүүлэн хийж элс, цасаар хучиж дээд талыг сайн таглаж хаана. Мөчрийг ургамлын тайван үеэс шүүс хөөрөх хүртэлх хугацаанд бэлтгэнэ. Энэ нь манай орны цаг уурын янз бүрийн нөхцөлд жил бүрийн 10-р сарын 20-оос дараа жилийн 3-р сарын эхний арав хоногт багтана. Модны үзүүрийн нахиа хөөсөн үед савааг бэлтгэж болохгүй.



Зураг 10.1 Бургас

**Саваа мөчрийг тайраадас болгон бэлтгэх** - Бургасыг мөчрөөр нь үржүүлэхэд түүний мөчрийн тайрдасны урт онцгой нөлөөтэй байдаг. Мөчрийн тайрдасны уртаас хамаарч суулгацын үндэслэлт, амьдралт харилцан адилгүй байдаг. Мөчрийн тайрдасны урт нь хангай, хээрийн бүсэд 25-30 см байна.

Тайрдас бүр 8-аас доошгүй ширхэг нахиатай байвал зохино. Бургасны модожсон мөчрийн I, II зэргийн тайраадсыг тусгай зориулалтын бургасны плантаци байгуулах, суулгац бэлтгэх зэрэгт зориулж ургуулахад илүү тохиромжтой. Бэлтгэсэн саваа мөчрийг тусгайлан хадгалсан зоориноос гарган авч тэдгээрийг тарихаас нэгээс, хоёр долоо хоногийн өмнө тайраадас болгон бэлтгэнэ.

Тайрдасны бүдүүн нь 0.6-1.8 см байх ба түүнийг саваа мөчрийн доод, дунд хэсгээс бэлтгэх нь илүү тохиромжтой байна. Бэлтгэж авсан тайрдсыг жишгийн дагуу зэрэглэж ялгаж 50, 100 ширхэгээр багцлан боож зориулалтын зоорь, шуудуунд суулгах хүртэл цас, нойтон үртэс, чийгтэй элсээр хучиж түр хадгална.

Хэрэв тээвэрлэх тохиолдол гарвал чийгийг алдагдуулахгүйгээр үртэс, цасаар даруулж, берзинтээр хучиж тээвэрлэх хэрэгтэй. Мөчрийн тайрдсыг бэлтгэж суулгахаас нь өмнө 72-125 цагийн туршид усанд хийнэ. Мөн өсөлт түргэсгэгч бодис гетероауксины 0.01 хувийн уусмалд (150мг) 15-24 цаг болгосны дараа тарилт хийхэд нахианы задралт, үндэслэлт хурдасна.

Мөчрийн тайрдсыг тарих хүртэл гэмтээлгүй сайн хадгалах шаардлагатай. Саваа мөчрийг тайраадас болгохдоо үзүүрийн болон доод талын нахиа тус бүрээс 3-4 мм зайтай тайрна.

**Хөрс боловсруулалт** - Бургасны модожсон мөчрийн тайраадсыг тарихад зориулж талбайн хөрсийг 30-35 см (40 см) гүн хагалж боловсруулна. Гүн хагалсан хөрс нь ургамал ургах аятай нөхцлийг бүрэлдүүлэхээс гадна хог ургамал ургах, өвчин, хортон үүсэх нөхцлийг таслан зогсоох сайн талтай байдаг. Хөрсний үндсэн хагалгааг намрын цэвдэгш буюу хаврын хагалгаагаар гүйцэтгэнэ. Үндсэн хагалгааны дараа борнойдолт хийнэ. Бургас тарих талбайн хөрс нь тэгш, сэвсгэр, сийрэг, нягтарч бөөгнөрөөгүй, үрлэрхэг бүтэцтэй, хог ургамлаас бүрэн цэвэрлэгдсэн, суулгацын үндэсний систем зохих хэмжээндээ хүртэл хөгжих нөхцлүүдийг хангасан байх шаардлагатай.

**Тайрдас суулгах хугацаа** - Бэлтгэсэн тайрдсыг хавар 4 дүгээр сарын сүүлчийн 10 хоногоос 5 дугаар сарын сүүлч хүртэлх хугацаанд суулгана. Зарим нутагт бургасны тайрдсыг



Зураг 10.2  
Бургас

намар 10-р сарын 1-нээс 15-нд суулгаж болно. Хэрэв нэгж га-аас авах жишгийн суулгацын тоог нэмэх шаардлагатай бол мөр хоорондын суулгалтыг нягтруулна. Мөчир тарих ажлыг хавар цас хайлсны дараа шууд хийнэ. Намар тарих газар нь тунадас нилээд унадаг, хөнгөн хөрстэй байвал зохимжтой. Мөчрийн тайраадсыг босоо буюу налуулж (хүнд хөрсөнд) үзүүрийн нахиаг хөрсөнд ил суулгана. Ус чийг дутагдалтай гандуу нөхцөлд мөчрийн оройн нахиаг гадаргуутай тэгшилж суулгана. Мөчрийн тайраадсыг заавал чийгтэй хөрсөнд суулгах ба суулгасны дараа тогтмол услах шаардлагатай.

**Тайрдасны арчилгаа** - Мөчрийн тайрдасны амьдралт, өсөлт, хөгжилт нь ургамал ургалтын хугацаанд явуулах арчилгаанаас ихээхэн хамаарна. Суулгацыг чанартай сайн ургуулахад арчилгааны горимыг нарийн мөрдөх нь чухал юм.

**Усалгаа** - Бургасны тайрдас чийглэг нөхцөлд илүү сайн ургана. Бургасны тайрдсыг ургуулахад усалгааны арга, нормыг мөрдөх зайлшгүй шаардлагатай юм. Усалгааг мод үржүүлгийн талбайд хэд хэдэн аргаар хийж болно. Усалгааг ямарч аргаар хийсэн дараах үндсэн нөхцлийг хангасан байх шаардлагатай. Үүнд: Усалгааны шанг ус урсахад тохиромжтой болгож задгай ба нээлттэй гэсэн хоёр янзаар хийнэ. Задгай болон нээлттэй шангаар услах шуудууг 18-20 см гүн, 0.3-0.8 хэмийн хэвгийтэй байгуулна. Шангийн ёроолын хэсэг тэгшхэн байх шаардлагатай. Тайрдсыг ургах ургамал ургалтын эхний хагаст 30-35 см гүнд нэвчилж услана. Усалгааг хөрсний хээрийн чийг багтаамжийн 70 хувь орчимд байхаар бодож хийнэ. Энэ нь ойт хээр, хээрийн бүсэд га-д 530-580 м<sup>3</sup>/ га ус байхаар тооцож услана гэсэн үг. Шуудуугаар усалж байгаа нөхцөлд усалгааны нормыг 25-30 хувиар ихэсгэнэ. Ямар ч тохиолдолд усалалтын нормыг га-д 500 шоо метрээс хэтрүүлж болохгүй. Тайраадас суулгасан талбайн хөрсийг 5-р сард нэг удаа, 6-р сард хоёроос гурван удаа, 7, 8-р сард хоёр удаа 40-35 см гүнд нэвчилж услах нь тохиромжтой байна. Усалгааны давтамж нь тухайн жилийн хур тунадасны хэмжээ болон нарны гийгүүлэлтээс хамаарч бага зэрэг хэлбэлзэж болно.

**Хөрс сийрүүлэлт** - Үндэсний системийн агаарын солилцоог эрчимжүүлэх, чийгийн алдагдлыг багасгах, ус, бордоо хөрсөнд шингэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор хөрсийг сийрүүлэх арчилгааг ургамал ургалтын хугацаанд тогтмол явуулна. Ургамал ургалтын эхний үед Алтай, хээрийн бүсэд 5, 6-р сард нэг, 7-р сард хоёр, 8-р сард нэг удаа ургамал хооронд гараар 4-5 см гүнд гапуугаар сийрүүлэх ба эгнээ хооронд 10-15 см гүнд сийрүүлэлтийг тогтмол хийнэ. Хөрс сийрэгжүүлэх, хог ургамалтай тэмцэх ажлыг жилд Ус чийгээр дутагдалтай хүнд хөрстэй газарт усалгаа хийсний ба бороо орсны дараагаар хөрсийг сийрэгжүүлж, хог ургамлыг нь цэвэрлэж байвал зохино. Ус чийг хүрэлцээтэй хөнгөн сэвсгэр хөрсөнд сийрэгжүүлэлтийг 15-18 см гүнд хийнэ. Ургамлын эгнээ хоорондын хог ургамлыг 20 см гүнд сийрүүлэгчээр сийрэгжүүлж устгана. Сүүлийн үед хог ургамлыг устгахад гербицид (симазин)-ыг 10-15 кг га-д бодож усанд уусгаж шүршиж хэрэглэж болно.

**Бордоо** - Суулгацыг аль болох богино хугацаанд өсөлт хөгжилт сайтай ургуулахад хөрсийг үндсэн ба нэмэгдэл бордоогоор бордох нь хамгийн чухал юм.

Үндсэн бордоог хөрс боловсруулахад хийнэ. Нэмэлт бордоог тухайн талбайн хөрсний шинжилгээний дүнг үндэслэн 2-3 жилийн дараа бордож болно. Ойт хээр, хээрийн бүсийн нөхцөлд га-д азот 60-100 кг, фосфор 100-120 кг, кали 20-40 кг-аар бодож бордоно.

**Суулгацыг хэлбэржүүлэх** - Бургасны суулгацыг ашиглах зорилго, чиглэлээс хамаарч түүнд тохирсон хэлбэржүүлэлт хийнэ. Бойжуулах талбайд ургуулж байгаа суулгацанд гол тулгуур иш (гувар), салбар мөчрийг (титэм) засаж, танан хэлбэржүүлэлт хийнэ. Хэлбэржүүлэлтийг ишний ба титмийн гэж ангилна. Бургасны үйлдвэрлэлийн плантаци байгуулах технологи Бургасны плантаци байгуулах ажлын зорилт нь мөчрийн тайраадсаар ургуулсан суулгацыг шилжүүлэн тарьж улмаар гэрийн модны бэлдэц, болон араг шээзгий, сүлжмэл эдлэл хийх түүхий эдийг бэлтгэх явдал юм. Плантаци байгуулахад талбайг сонгох, хөрс боловсруулах, суулгац сонгох, суулгах хугацаа, суулгацын байршлын схем, тэдгээрийг арчлах технологийн дэс дарааллыг шийдвэрлэхэд оршино.

**Плантаци байгуулах талбай сонгох** - Бургасны үйлдвэрлэлийн плантаци байгуулах талбайг сонгоход дор дурьдсан нөхцлийг онцгой анхаарах хэрэгтэй. Үүнд: Бургасны плантацийн талбайн гадаргуу аль болох тэгшдүү, усалгааны шуудуунд ус өөрийнхөө урсгалаар гүйхэд тохиромжтой 5-8<sup>0</sup>-с илүүгүй налуу байна. Плантаци байгуулах талбайн хөрс элсэнцэр, хөнгөн шавранцар бүтэцтэй байхын хамт давсжих ямар нэгэн шинж тэмдэггүй байвал зохино. Плантацийн талбайг уулын ар хажуу юмуу сүүдэр газар сонгож үл болно. Бургас гэрэлд дуртай учраас түүнийг тарих талбай гэрлээр бүрэн хангагдсан ил задгай газар байх шаардлагатай.

**Хөрс боловсруулалт** - Плантаци байгуулах талбайн хөрсийг цэвэр уриншийн системээр хөрс боловсруулах нь талбайг хог ургамлаас цэвэрлэж чийг хуримтлуулах ач холбогдолтой. Хөрсийг суулгац суулгах жилийн хавар 4-р сарын 25-наас, 5-р сарын 15-ны дотор, намар 9-р сарын 20-ноос 10-р сарын 10 хүртэл хугацаанд хагалж боловсруулна. Бургасны суулгацыг гараар буюу суулгац ухагчаар ухаж авна. Ухаж авахад гэмтсэн үндэсний хэсгийг хурц хайчаар эгц хөндлөн тайрч зайлуулна. Зэрэглэж ангилсан суулгацыг 50 ш-ээр боож багцална. Хавар эрт, намар орой суулгацыг

ухаж авсны дараа суулгалт хийх хүртэл тусгай зоорь буюу шуудуунд нойтон элс, цасаар сайтар чигжиж дарж түр хадгална. Хадгалах зоорь буюу шуудууны орчны температур -5 хэмээс дээшгүй байвал зохино. Бургасны суулгацыг тээвэрлэхдээ машины тэвшинд чийгтэй шороо, үртэс асгаж үндсийг далд ортол булж усална. Тээвэрлэх хугацаанд тогтмол чийгтэй байлгах хэрэгтэй.

**Бургасны суулгац суулгах хугацаа, арга** - Плантацид бургасны суулгацыг хавар 4-р сарын 25-аас 30-нд, 5-р сарын 1-ээс 10-нд, намар 9-р сарын 30-аас 10-р сарын 10 хүртэл хугацаанд суулгана. Плантацийн талбайд суулгац суулгалтыг 2 хүн гүйцэтгэнэ. Нэг дэхь хүн нь нүхийг бэлтгэж, 2 дахь хүн нь суулгацыг эгц барьж шороог хийж нягтруулан гишгэнэ. Плантацид бургасны суулгацны үндэсний хүзүүг газрын гадаргуугаас доош 10-15 см гүнд байхаар суулгана. Бургасны плантацийн талбайд суулгацыг суулгасны дараа түүний гол гуврыг газрын гадаргуугаас дээш 10-20 см-т цэцэрлэгийн хайчаар тайрч үлдсэн угийг тосон будгаар будна. Энэ нь бургасны суулгацыг буталж, салаалж ургах нөхцлийг бүрэлдүүлнэ.

**Бургасны суулгацыг суулгах схем** - Ашиглалтын зориулалтаас хамаарч бургасны плантацид суулгацыг дараах схемээр суулгана: 1. Бургасны плантацийн талбайн ургамал хооронд 1.0 м, эгнээ хооронд 1.5 м. 2. Ургамал хооронд 1.5 м, эгнээ хооронд 2.0 м. 3. Ургамал хооронд 1.5 м, эгнээ хооронд 3.0 м. 4. Ургамал хооронд 2.5 м, эгнээ хооронд 3.0 м. 5. Ургамал хооронд 3.0 м, эгнээ хооронд 3.0 м-ээр тус тус байрлуулна. Суулгалтын схемийг сонгож авсны дараа суулгалтын схемийг талбайд тэмдэглэхдээ эгц шулуун эгнээ гаргах хэрэгтэй. Талбайд хуваарилалт хийсний дараа олс татаж шулуун чиг гаргаж суулгац суулгах нүх ухах цэгийг тэмдэглэнэ. Гэрийн модны бэлдэц авах зорилгоор суулгацыг суулгахад ургамал хооронд 1.0 м эгнээ хооронд 2.0 м эсвэл ургамал хооронд 1.5 м, эгнээ хооронд 3.0 м зайтай байна.

**Усалгаа** - Бургасны плантацийн талбайд суулгац суулгахаас 3-4 хоногийн өмнө ухсан нүхийг нэг удаа усална. Суулгацыг суулгасны дараа 35-40 см гүнд нэвчилж усална. Ургамал ургалтын хугацаанд Алтай, говь, хээрийн бүсэд 5 ба 6-р сард 10-14 хоногийн зайтай, 7 ба 8 сард 14-16 хоногийн зайтай 2 удаа усална. 9-р сард нэг удаа усална. Усалгааны норм нь нэг га-д 500-700 м<sup>3</sup> ус орохоор тооцно. Ургамал ургалтын нийт хугацаанд 10-13 удаа усалгааг хийнэ. Харин хуурай хээр, Алтайн бүсэд хаврын салхи ихтэй байдаг учир усалгааны завсар өнгөн хэсгийн хөрс хаталтаас сэргийлж усалгааг нэмэлт болгож хийхийг практикт анхаарах хэрэгтэй. 2, 3 ба 4 дэхь жилийн усалгааны норм ижил байна.

**Хог ургамал устгах** - Ургамал ургалтын хугацаанд плантацийн талбайн хог ургамлыг устгах, хөрсийг сийрүүлэх арчилгааг тогтмол хийх шаардлагатай. Ургамал хооронд сийрүүлэлт хийхэд гар ажиллагаагаар гүйцэтгэнэ. Хөрсийг гараар сийрүүлэхэд тармуур, хог ургамал устгахад гапуу ашиглана. Ургамал хооронд 4-6 см гүнд гараар сийрүүлнэ. Усалгааны дараа хөрс сийрүүлэлтийг үндэсний хүзүүвчээс нэлээд зайтайгаар 5-7 см гүнд хийнэ.

**Суулгацын хэлбэржүүлэлт** - Бургасны суулгацын саваа мөчрийг тайрч танахдаа плантацийн аж ахуйн зориулалттай уялдуулан хийнэ. Хэрэв гэрийн унь, хананы материал бэлтгэх зориулалттай бол гол ишнээс 4-5 ширхэг шулуун найлзуур ургуулахаар тооцож таналт хийнэ. Харин араг, шээзгий, сагсны материал бэлтгэх зориулалттай бол гол ишинд 6-7 найлзуур ургахаар бодож таналт хийнэ.

Бургасны суулгацны ишний хэлбэржүүлэх арчилгааг ургамал ургалтын хугацаанд 5, 6, 7, 8-р саруудад хийхэд суулгацын ишний ургалтын явцад сөрөг нөлөө үзүүлэхгүй. Бургасны плантацид ургуулсан суулгацаас жишгийн хэмжээнд хүрсэн саваа мөчрийг ургамал ургалтын хугацаа дууссан 10-р сарын 1-нээс дараа оны 5-р сарын 1 хүртэл бэлтгэж байна.

### Улиас

Улиасыг түүний мөчрөөр үржүүлэх арга зонхилдогийг хэн бүхэн мэдэх бөгөөд үрээр ургуулах нь их төвөгтэй байдаг байна. Удаан хугацаагаар дамжуулан мөчрөөр үржүүлэх явдал хөгжлийг үе шатны хувьд хөгширч яваандаа хортон шавьж өвчний эсрэг тэсвэр нь муудаж амьдрах чадал хугацаа нь багасдаг байна. Ийм учраас улиасыг үрээр үржүүлэх ажил сүүлийн жилүүдэд хийгдэх болжээ. Улиасны үр бдугаар сарын сүүлч, бдугаар арын эхээр боловсорч гүйцнэ.

Үр жимс нь боловсрохтой хамт түүний үрийн гэр /хальс/ задарч үр нь цагаан хөвөн шиг салхинд хийсэн тарахаар дахин түүх бололцоогүй болдог. Үүнээс шалтгаалан үрийн гадуурх гэр задарч эхэлмэгц түүнийг түүх хэрэгтэй.

Үрийг унаагүй байхад мөчрийн үзүүр дэх нарийн найлзуурыг огтолж хайчилж гэртэй нь хамт авах аргаар түүнэ. Улиасны үрийг ялгаж цэврээр нь буюу задарсан гэртэй нь /хөвөн шиг юмтай/ нь хамт тарьж болно. Үрийг цэвэрлэж авхын тул хатаагаад жижиг нүдтэй торондээр зөөлн үрэхэд хөвөнлөг эд нь торондээр үлдэж үр нь ялгаран унана.



Улиасны үр ургах чанараа амархан алддаг тул цэвэрлэж авангуут шууд тарина. Үрээ тусгай бэлтгэсэн /гүн/ даландээр хөндлөн мөр гаргаж хөрсөнд наалдуулхын тул усалж байж тарих хэрэгтэй. Нэг хавтгай талбайд /үр тарих 5 мөр гаргаж/ 2-3 гр үр ногдох нормоор тооцож тарина. Үр тарих ажлыг халууны илч буурч, салхи багассан үдээс хойш эхэлнэ. Тарьсан үрээ нарын шүршүүрээр зөөлөн усалж орхино. Өглөө эрт дахин услаад сүүдэрлэж өгнө.

Цэвэрлээгүй үрийг гэрээс нь салгаж хөвөн эдийн хамт 2-4 мм зузаан байхаар үр тарих мөрөө дагуулан тарина. Үүнээс зузаан бол гарсан соёлол нэвтэлж чадаргүйг анхаарах хэрэгтэй. Тарьсныхаа дараа сайн услах шаардлагатай.

Аль ч аргаар тарьсан үрийг эхний 7-10 хоногт нарийн шүршүүрээр бага хэмжээтэйгээр тогтмол усалж байх хэрэгтэй. Усны хэмжээг ялимгүй ч гэсэн ихдүүлбэл үрийг урсаж бөөгнөрүүлэх, тарьсан мөрнөөс хөөж гаргах зэрэг муу нөлөө үзүүлдэг. Хөрс элдэншүүлэлтийг зөв хийж зохих хугацаанд нь агротехникийн дагуу тарьж чадвал үр 3-5 дахь хоногт соёолж эхэлнэ. Соёо биежиж ирэх тутам усалгааны тоог багасгаж, номрыг нэмэгдүүлнэ. Улиасны соёо эхний үед маш турьхан байдгаас арчлалтыг болгоомжтойгоор цаг үеий нь олж хийх шаардлагатай.



Зураг 10.3 Улиас

Арчлалтын гол нь халуун үед сүүдэрлэж, тогтмол /үдээс хойш/ усалгаа хийж байх явдал мөн. Эхний үед нь цэвэр сүрэл, нарийн мөчир зэргээр сүүдэрлэнэ. Анхны навчыг бүрэн гартал сүүдрэвчийг авахгүй. Тарьцыг биежиж хэлбэрээ олтол эгнээ доторхи хог ургамлыг гараар тун болгоомжтой түүж арилгана. Бүх төрлийн арчлалтыг зөв хийж чадвал тарьц эхний жилд жишгийн шаардлаганд хүрэх бололцоотой юм.

Жишгийн хэмжээнд хүрээгүй тарьцыг дахин нэг жил ургуулахаар үлдээнэ. Хэмжээ багатай тарьц хөрс хөлдөхтэй зэрэг үндсээрээ түрэгдэн гарах аюултай байдаг. Иймээс газар гэнэт хөлдөж овойхоос хамгаалж сүрлээр хучна. Улиас үржүүлэх хэсгийн газрын хөрсөн доорхи ус 1-1.5 м гүнд байх нь зүйтээ. Үр тарьсан эхний 7-10 хоногт өдөр бүр 1 хавтгай м талбайд 5-6 литр ус ногдохоор тооцож усална. Соёо нь ил гарч жигдэрснээс хойш бол 2-3 долоо хоног өнжөөд услах зэргээр усалгааны тоог аажмаар цөөрүүлнэ

### Хайлаас

Хайлаасны үрийг боловсорч гүйцмэгц түүж шууд тарина. Хайлаасны үр цаг агаарын байдал, хур тундасны хэмжээнээс шалтгаалан 5дугаар сарын сүүлч бдугаар сарын эхээр боловсорч гүйцнэ. Үрээ тарихын өмнө 1-2 цаг чийглэж эзлэхүүний хувьд 1:1 элстэй хоьж 2-3 хоног байлгаад соёолуулж тарина. Соёо хэт урт бол тарихын үед гэмтэх ба цаашид ургах чадлаа алддаг. Элс үр амархан соёолох нөхцөлийг бий болгож өгөхөөс гадна жаахан сэврээж байгаад тарихад хялбар байдаг. Үрээ ихэвчлэн гараар тарина. 1 га-д цэвэр үр дунджаар 120 кг ногдохоор бодож тарих ба далавчтай нь хамт /цэвэрлээгүй бол/ үрийн гарцаар бодож илүү нормоор тарих хэрэгтэй. Үр булах гүн нь ихэнх тохиолдолд 1см орчим байх ба нар ихтэй хуурай /бүс нутагт/ бол 1 см гүн булж үртэс буюу ялзмагаар хучна. Үрээ 5-6 дугаар сард тарихдаа хөрсөө урьдчилан усалсан байх шаардлагатай. Усалгаа хийх хог ургамлыг арилгах хөрс сийрүүлэх зэрэг арчлалтыг тогтмол зохион байгуулж хийх ёстой.



Зураг 10.4 Хайлаас

### Гүйлс

Гүйлсний үрийг намар тарих нь илүү ашигтай. Хавар тарихын тул үрий нь тарилтанд 3 сарын турш бэлтгэх хэрэгтэй байдаг. Үрээ 4-5 см гүнд булна. 1 га талбайд дунджаар 1200 кг үр /ястай хамт тарьдаг/ шаардлагатай. Гүйлс бол хурдан ургадаг бутлаг ургамал мөн. Гүйлс ( *Armeniaca sibirica* L) 2.5 м өндөр ургадаг сөөг юм. Гүйлс нь тал тал руугаа сармайж байрласан мөчрүүдтэй бөгөөд түүний холтос цайвар саарал өнгөтэй Навч нь өндгөн юмуухэлбэртэй зууван мөртлөө оройн



Зураг 10.5 Гүйлс

хэсэг нь хурц шовх, навчны зах нь шүдэрхэг, цэцэг нь цагаан, ягаан өнгөтэй навчилж эхлэхээс өмнө цэцэглэдэг.

Цэцэглэх үедээ маш гоёмсог цэцэг нь бал агуулдаг. Жимс нь махлаг шүүслэг, жижиг ишэнцэр дээр байрлана. 6.7 сарын үед боловсорч гүйцдэг. Титмийн хэлбэршүүлэлт хяргалтыг сайн даадаг. Яст жимс нь бөөрөнхий, хавчгардуу шар юмуу улбар шар өнгөтэй. Өсөлт нь харьцангуй түргэн, ямарч нөхцөлд ургах чадвартайгаараа онцлог ургамал юм.

**Ургах орчин** - Хэнтий, Хангай, Монгол-Дагуур, ДорнодМонгол, Хянганы тойрогт гуу жалганы ирмэг, сөөгөн ширэнгэ, чулуурхаг хажуу, хээр тал, бэл хоолой, байц хадаар тархан ургана. Гүйлс нь толгодын хад, чулуутай хөмгий энгэр уулын бэлээр эмжээрлэн ургадаг.

**Ургуулах арга** - Гүйлсийг ихэвчлэн үрээр тарьж ургуулдаг. Үрээр маш сайн ургана. Үр нь 7-р сард боловсорно. Үрийг намар, хавар тарьж болно.Уртааш метрт тарих үрийн норм 30-40 гр, тарих гүн 3 хүртэл см-т.

**Гүйлс ургуулах онцлог** - Хөнгөн бага зэрэг элсэрхэг хөрсөнд сайн ургадаг. Ургах орчин голдоггүй. 3-5 настай суулгацыг хотын гудамж талбайд тарихад тохиромжтой, Цэцэрлэгт хүрээлэн, гудамжанд бүлгээр болон эгнүүлж тарихад илүү зохимжтой. Мөн Шилмүүст модтой хослон тарихад намрын өнгө маш сайн ялгардаг болно.

**Шар хуайс** - Ихэвчлэн хавар тарина. Мөн намар орой газрын хөрс хөлдөхөөс өмнөхөн тарьж болно. Үрийг 3-4 см гүн булагдахаар бодож мөр гарган тарина. 1 га талбайд цэвэр үр дунджаар 120 кг ногдохоор бодож тарина. Шар хуайсны үрийг үр тарилтанд бэлтгэхэд зааснаар цаслах, элслэх, ургуулах зэрэг аргаар урьдчилан бэлтгэнэ. Хамгийн хялбар үр дүн сайтай нь цаслах арга юм. Бүх арчлалтыг агротеникийн дагуу хийнэ. мод үржүүлгийн газарт үрээр тарьсан 2-3 настай суулгац авч тарихад илүү ургадаг.

Ойн зурвас, цэцэрлэгт хүрээлэнд тарих мод, сөөгийг мод үржүүлгийн газарт ургуулсан суулгац ашиглах хэрэгтэйг анхаарч ажиллах шаардлагатай юм. Цэцэрлэгт хүрээлэнд тарих мод бол ойн зурвас байгуулахад ашигласан мод, сөөг байж болно.

## ХЭСЭГ IV

# БАРУУН БҮСИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

### ОРШИЛ

Баруун бүс нутгийн хөгжлийн төслийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд тун их байгаа юм. Үүнд:

1. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжүүдийг цөөлж, хошуудын хуваарьт оруулахаар 2006 онд БХБЯамны төлөвлөсөн төслийг УИХ-аар батлуулж хэрэгжүүлэх
2. Энэ төсөлд оруулсан бүс нутгийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэ хуваарьтай уялдуулан зохицуулах
3. Нийгэм эдийн засаг, хөрөнгө оруулалтын хуваарийг өөрчлөн, сайжруулж, хөрөнгийн эрхийн хуваарийг оновчтой болгон, бүс нутагт өөрөө бие даан хөрөнгө оруулалтаа шийдэх эрх зүйн зохицуулалтыг хийх
4. Бүс нутгийн хэмжээнд байгаль орчны нэн доройтолд орж байгаа тул энэ нөхцлийг харгалзан мод, бутлаг ургамалыг ихээр тарих, экосистемд өгөөжтэй, хүн, малд халгүй байдлаар уул уурхай, эрдэс баялагийг эрж хайх, нөөц тогтоох, ашиглах
5. Алтай, Хангайн сүрлэг сайхан өндөр уул, нурууд, гүн цэнхэр нуурууд, түүх, соёлын дурсгалт газруудыг түшиглүүлэн аялал жуулчлалыг хөгжүүлэх
6. Бүс нутагт олон улсын болон улсын зэрэглэлийн томоохон хот суурин, төмөр зам, автозам дутагдалтай, гадаад оронтой харилцах өргөн их боломж дутагдалтай байгааг харгалзан “Сутай” хотыг барих, төмөр зам тавих, уул уурхайн салбар болон бусад нийгэм эдийн засгийн салбаруудад хөрөнгө оруулагчдийг татах явдал нь баруун бүсийн хөгжлийн зогсонги байдлаас гарах ганц арга юм
7. Хөнгөн хүнсний үйлдвэрийг хөгжүүлэхийн тулд уламжлалт мал аж ахуй, газар тариалангийн хөгжлийн системийг аажим үндсээр нь өөрчлөх шаардлагатай байна. Хөнгөн хүнсний бүтээгдэхүүнээр бүс нутгаа бүрэн хангана гэдэг бол их том ололт байх болно.
8. Баруун бүсийн хөгжил нэг суурин-нэг бүтээгдэхүүн төслийг хөрөнгө оруулалт болон эдийн

засаг, эрх зүйн бүх зохицуулалтаар эхний ээлжинд хэрэгжүүлж дэмжиж, туслах явдал чухал байна.

Баруун бүс нутгийн амьдрах орчин, нийгэм эдийн засгийн тулгуур нөхцөлүүд их доогуур байгааг анхаарч энэ төсөлд тусгасан ажлуудын хүрээнд Засгийн газар хөтөлбөр гарган, хэрэгжүүлэх хэрэгтэй.

Баруун бүс нутгийн дотоод зах зээлийг өөрчлөн тэлэх шаардлагатай байна. Учир нь нэг иргэн 10 сая төгрөгийн зээл авлаа гэхэд тэр нь цаад утгаараа 20 сая төгрөг болж импортлогдож байгаа юм. Баруун бүсэд Сэлэнгэ аймгийн Зэлтэрт байгуулсан фермерийн аж ахуй шиг 50 компани байгуулагдахад л ажлын байр нэмэгдэж, дотоодоо хангахаас гадна экспорт хийх бололцоотой болно. Иймд ирээдүйтэй хөгжих аж ахуй нэгжүүдийг зээл санхүүжилтээр дэмжих нь эргээд орон нутаг төдийгүй бүс нутагт чухал ач холбогдолтой.

Мөн баруун бүс нутгийн хөгжлийн томоохон гарц нь Монголын хөрөнгийн биржэд баруун бүсийн эрдэс баялагийн корпораци байгуулах, одоо байгаа хувь хүмүүсийн ашиглаж буй зэс, төмөр, хүрэн нүүрс, барилгын материалын ордуудын өгөөжийг монгол улсын эдийн засагт ашигтай байдлаар авч ашиглах, ашгаас хувь хүртээх бүх бололцоог нээх хэрэгтэй .


**Арван нэг. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

**11.1 ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ**

Баруун бүсийн хөгжлийн төсөл нь Засгийн газрын 2005 оны 202 дугаар тогтоолоор батлагдсан “Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх дунд хугацааны бодлогын зорилт, тэдгээрийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ /"интервенц"/, боломжит хувилбаруудыг дотоод, гадаад орчин /хөрш орнуудыг голлон/-той нь холбон авч судалсан бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжил, хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлтийн баримт бичиг юм.

“Баруун бүсийн хөгжлийн төсөл”-ийн бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөвлөлтийн үндсэн шийдлийг бүлэг тус бүрд нь тусгасан учир нь энэ хэсэгт тус төслийг улсын болон бүсийн хэмжээнд хэрэгжүүлэх эрхзүйн нэгдсэн зохицуулалттай холбоотой асуудлыг голлон авч үзэж байна. Бүс нутгийн хөгжил нь аймаг, орон нутаг, аж ахуйн салбар хоорондын уялдаанд тулгуурлах учраас Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг хооронд нь нийцүүлсэн эрхзүйн нэгдсэн баримтлал, хуулийн нэгдмэл механизмаар дамжин хэрэгжих учиртайг тэмдэглэж байна. /Схем 11.1.1 зургийг үз./

**Баруун бүсийн хөгжлийн төслийг хэрэгжүүлэх эрхзүйн нэгдсэн зохицуулалт**  
**Бүс нутгийн тогтвортой хөгжил /Схем 11.1./**



Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль/БХУЗХ/-д бүс нутаг, хот төлөвлөлтийн нэгдмэл үндсийг бэхжүүлэх талаар салбар яам, аймаг, сумдын удирдлагын хүлээх үүрэг, эрх, хариуцлагын механизмыг тодорхой зааж, үйл ажиллагаа /"процедур"/-ны шинжтэй хууль болгох хэрэгтэй байгаа юм.

Тухайлбал, Баруун бүсийн хөгжлийн энэхүү төслөөр тодорхойлж буй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг Төсвийн Ерөнхийлөн Захирагч нарын төсвийн багцад тусгаж, Ерөнхий менежертэй байгуулсан гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх зарчим баримтлах хэрэгтэй байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг бүхэлд нь шинэчлэх хүртэл, бүс нутгийн хөгжлийн төслийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд 2009 оноос шинээр байгуулагдсан буй Үндэсний хөгжлийн төв /эдийн засгийн/, бүсийн түвшинд, Бүсийн зөвлөлүүд /тухайн бүсийн хөгжлийг дэмжигч компанийн төлөөлөл орсон/, бүсийн тулгуур төв хотын Захирагч нартай хамтран тус тус зохицуулах нь зүйтэй байна.

Энэ журамд, бүс нутгийн хөгжлийг хүрэх түвшний гол шалгуур үзүүлэлтээр нь гурван жилээр төлөвлөж, гол зорилтыг Төсвийн хүрээний дунд хугацааны бодлого /мэдэгдэл/-д тусгаж, холбогдох арга хэмжээг эдийн засаг, нийгмийн хөгжлийн жилийн үндсэн чиглэл, улсын төсөв, гадаадын зээл тусламжийн хөтөлбөрт тусган, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон байвал зохино.

Хөрөнгө санхүүгийн дутагдаж буй нөөцийг гадаадын зээл тусламжийн эх үүсвэрээр хангах чиглэл баримталж, холбогдох төслийг "Бүсийн хөгжлийн гэрээ"-ний үндсэн дээр хэрэгжилтийг нь хянан зохицуулбал илүү үр дүнтэй юм. Тухайлбал, Баруун бүсийн хөгжлийн энэхүү төслөөр санал болгосон олон арга хэмжээг хөрш хоёр оронтой Засгийн газрын түвшинд байгуулсан хоёр ба гурван талын хэлэлцээрээр тохирч, Баруун бүсийн хөгжлийн гэрээнд тусгаж, хамтран хэрэгжүүлж болох байна.

Энэчлэн, холбогдох хууль, хөтөлбөрт тусгасан чөлөөт бүс, аж үйлдвэрийн парк байгуулах талаар хөрш болон бүс нутгийн орнуудтай хамтран хэрэгжүүлэх, хөрөнгө оруулах арга хэмжээг Баруун бүсийн "Бүсийн хөгжлийн гэрээ"-нд нь тусгуулж, гүйцэтгэлийг нь талуудын оролцоотой хянан зохицуулж болох юм. Энэ зорилгоор, Засгийн газрын өмнөөс бүсийн зөвлөл, болон аймгуудын ИТХ-д хөрш орнуудын хил залгаа субъектүүд, хуулийн этгээдтэй "Бүсийн хөгжлийн гэрээ" байгуулах тодорхой эрх хэмжээг хуулиар зааж олгох хэрэгтэй байна.

Хуульд заасан Бүсийн хөгжлийг дэмжих санг Засгийн газрын тусгай санд хамааруулан хуульчилж, түүнд улс орон нутгийн төсвөөс жил бүр тодорхой хөрөнгө төвлөрүүлж, зориулалт, зарцуулалтад нь хяналт тавьж ажиллавал Бүсийн зөвлөл бүс нутгийн хөгжлийн нийтлэг ач холбогдолтой олон асуудлыг бие даан шийдвэрлэх боломж бүрдэхээр байна. Тус санд, хөрш орнууд, тэдгээрийн аж ахуйн нэгж, байгууллагаас хөрөнгө төвлөрүүлж, хамтран ашиглах боломжийг бүрдүүлэх талаар Засгийн газар хоорондын хэлэлцээрт зааж, бүсийн зөвлөл, аймгийн удирдлагын гадаад зах зээлтэй холбогдох санал, санаачлагыг дэмжих хэрэгтэй байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хот тосгоны эрхзүйн байдлын тухай хуульд орон нутгийн удирдлагаас бүс нутгийн хөгжлийн нийтлэг асуудлыг шийдвэрлэх талаар хүлээх үүрэг, хөрөнгө хүч төвлөрүүлж хуваарилах эрх, хариуцлагыг тодорхой зааж өгөх шаардлагатай байна.

Сум бүрийн жижиг нөөцийг орон нутгийн хөгжил, байгаль орчны арга хэмжээнд төвлөрүүлж, зохистой ашиглах үндсийг бүрдүүлэхтэй холбогдуулан "эдийн засгийн бичил бүсүүд, бүлэг суурингийн тогтолцоо"-ны талаарх аймгуудын ИТХ-ын саналыг УИХ-аар ойрын хугацаанд хэлэлцүүлж, баталгаажуулах нь чухал.

Хот байгуулалтын хуулиар бүсийн тулгуур төвүүдийг улсын зэрэглэлтэй хот /Ховд, Улиастай/-оор тогтоож, хотын дарга, хотын хөгжлийн сан, хотын татвартай байх эрх хэмжээг дэлхийн хотуудын нийтлэг жишгийн дагуу олгох хэрэгтэй байна.

Баруун бүсийн хөгжлийн энэ төсөлд Монгол улсын эдийн засгийг хөрш болон бүс нутгийн бусад орны зах зээлтэй холбох худалдаа, тээвэр, дэд бүтцийн төлөвлөлтийн шийдлийг аль болох тодорхой гаргахыг эрмэлзсэн тул, тэдгээрийг бодит ажил хэрэг болгох эрхзүйн үндсийг бүрдүүлэх хэрэгтэй байгаа юм. Энэ талын бодлого /тухайлбал, худалдаа, дамжин өнгөрөх тээврийг хөнгөвчлөх, дэмжих/-ыг одоо боловсруулж буй "Худалдааны дунд хугацааны үзэл баримтлал", "Дотоодын үйлдвэрлэлийг импортын хэт өсөлтөөс хамгаалах тухай хууль"-ийн төсөл, мөн гаалийн тухай хууль тогтоомжийн цаашдын шинэчлэлд тусгаж өгөх нь зүйтэй байна.

Монголын Баруун бүсийг ОХУ-ын Сибирийн тойрог, БНХАУ-ын Баруун бүсийн хөгжлийн стратегитэй холбон уялдаатай хөгжүүлэх хөтөлбөрийг хамтран боловсруулах асуудлыг талуудтай байгуулах гэрээ, хэлэлцээрээр баталгаажуулах нь чухал ач холбогдолтой болно. Ийм хамтарсан

хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх талаар ТАХА /"CAREC"/-ны гишүүн байгууллагуудын дэмжлэг туслалцааг авбал илүү үр дүнтэй юм.

Цөлжилт эрчимтэй илэрч буй Баруун бүсийн тухайд, хөгжлийн аливаа асуудлыг экологийн тогтвортой байдлыг хангах шалгуураар шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг хүчтэй болгох шаардлага тулгарч байна. Энэ үүднээс Бүсчилсэн хөгжлийн ба Байгаль орчны хууль тогтоомжийн нийцэл, харилцан үйлчлэлийг хангах явдал чухал байна. Байгаль орчны хууль тогтоомжийн цаашдын шинэчлэлийг зөвхөн тодорхой нөөц баялаг, орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд төдийгүй, тухайн бүс нутгийн тогтвортой хөгжил, амьдрах орчны чанарыг хангах өргөн агуулгаар авч үзэх нь зүйтэй байна.

Ялангуяа энд, уур амьсгалын хуурайшилтад дасан зохицох, цөлжилттэй тэмцэх, усны нөөцийг хэмнэж, нутаг дэвсгэрээр зохистой хуваарилах, ашигт малтмал, газрын нөөцийг ашиглах, хамгаалах хуулийн механизмыг бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилготой нягт холбон боловсронгуй болгох хэрэгтэй байна. Түүнчлэн газар зохион байгуулалт – бүс нутгийн хөгжлийн харилцан уялдаа, нөлөөллийг хангасан нэгдсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх эрхзүйн үндсийг тогтоовол зохилтой. Байгалийн гамшгаас амьдрах орчныг хамгаалах “экологийн халхавч” буй болгох /"ногоон хэрэм"/, агаар мандал, гол мөрнийг ай саваар нь хамгаалах, ан амьтан, ургамал, бэлчээрийг орон нутгийн мэдэлд өгч, иргэдийн хамтлаг, нөхөрлөлд эзэмшүүлж, нөхөн сэргээх хууль тогтоомжийг боловсруулж, хэрэгжүүлэх, энэ үйл ажиллагаанд хөрш болон бүс нутгийн бусад орны хамтын оролцоог хангах эрхзүйн зохицуулалтыг өргөжүүлэх шаардлагатай байна.

Баруун бүсийн тухайд, “Алтай – Саяны хил дамнасан экологийн бүс нутгийн хөтөлбөр”-ийг ТАХА /"CAREC"/-ны орнуудын хамтын ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх хэлэлцээрийг олон талын үндсэн дээр байгуулах нь чухал байна.

Тус төсөлд санал болгосны дагуу Баруун бүсэд Ховд, Улиастайн 2 тулгуур төвийн чиглэлээр улс хоорондын босоо тэнхлэгийн хатуу хучилттай авто зам байгуулах, мөн хэтдээ Эрзин – Тэс – Алтай – Шивээхүрэнгийн төмөр замыг тавих, улмаар тус бүсэд “тээвэр хөгжлийн коридор” үүсгэх асуудлыг “Транзит Монгол”, “Монголын тээврийн хөгжлийн стратеги”-ийн төсөлд тусгахын хамт, хоёр ба олон талын хэлэлцээрээр баталгаажуулах нь зүйтэй байна. БНХАУ, ОХУ-ын зах зээлийг Монголын Баруун бүсээр холбож, цар хүрээг нь тэлж өргөжүүлэх үүднээс Мянганы замын баруун босоо тэнхлэгийн замыг Цагааннуураас Улаангом – Боршоо – Хандгайт /ОХУ/ хүртэл үргэлжлүүлэн тавих асуудлыг АХБ-ны 2009-2010 оны дэмжлэгийн бодлогод тусгуулах талаар, зохих хэлэлцээр байгуулахыг эрмэлзэх нь чухал байна. Энэ асуудлыг ОХУ-ын Тува Улсын талтай зөвшилцөн тохирох нь зүйтэй юм.


Энэ төсөлд тодорхойлсон Мянганы замын Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг 2015 оноос өмнөх хугацаа /2013 он гэхэд/-нд хурдавчлан байгуулах зөвлөмжийн дагуу холбогдох зорилт, тооцоог “Авто замыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний төсөл”-д шинэчлэн тусгаж, батлуулах саналтай байна.

**Баруун бүсийн аялал жуулчлалын бүс нутгууд /Хүснэгт 11.1/**

| Алтай – Хангай – Говь                 |                  |            |
|---------------------------------------|------------------|------------|
| Завхан аймаг                          |                  | Талбай, га |
| Улиастай Отгонтэнгэрийн бүс           | Аялал жуулчлалын | 194079.3   |
| Тосонцэнгэл – Зартын голын бүс        | Аялал жуулчлалын | 81202.9    |
| Баянзүрх – Бүст, Холбоо нуурын        | Аялал жуулчлалын | 55732.7    |
| Тэсийн голын сав газрын бүс           | Аялал жуулчлалын | 88908.9    |
| Нөмрөг – Тэлмэн нуурын бүс            | Амралт зугаалгын | 66883.8    |
| Түдэвтэй – Ойгон нуурын бүс           | Амралт зугаалгын | 45446.4    |
| Баяннуурын бүс                        | Амралт зугаалгын | 100560.7   |
| Бага нуур – Хар нуурын бүс            | Амралт зугаалгын | 44949.7    |
| Говь – Алтай аймаг                    |                  |            |
| Хасагт Хайрхан уул – Эрээн нуур       | Аялал жуулчлалын | 277843.6   |
| Ээж хайрхан уулын бүс                 | Аялал жуулчлалын | 382187.7   |
| Говийн Их Дархан Газрын “Б” хэсгийн   | Аялал жуулчлалын | 320839.5   |
| Гуулингийн бүс                        | Амралт зугаалгын | 15970.0    |
| Бурхан буудай уул – Бигэрийн хотгорын | Амралт сувиллын  | 265858.1   |
| Алтайн нуруу – Их нууруудын хотгорын  |                  |            |
| Ховд аймаг                            |                  |            |
| Хар ус нуурын бүс                     | Аялал жуулчлалын | 93921.7    |
| Хөх Сэрхийн нуруу – Буянт голын бүс   | Амралт зугаалгын | 96127.0    |
| Ховд голын савын бүс                  | Амралт зугаалгын | 178181.5   |

|                                      |                  |          |
|--------------------------------------|------------------|----------|
| Булган гол – Индэртийн бүс           | Амралт сувиллын  | 83199.7  |
| Дуут – Нэвтийн бүс                   | Амралт сувиллын  | 141412.2 |
| Увс аймаг                            |                  |          |
| Үүрэг нуур – Цагаан шувуут уулын бүс | Аялал жуулчлалын | 30318.6  |
| Хархираа Түргэний уулсын бүс         | Аялал жуулчлалын | 78902.1  |
| Тариалан сумын бүс                   | Аялал жуулчлалын | 87269.5  |
| Зүүнговь – Баян нуурын бүс           | Аялал жуулчлалын | 118738.4 |
| Алтан элс – Хан Хөхийн бүс           | Аялал жуулчлалын | 148043.3 |
| Айраг нуурын бүс                     | Амралт зугаалгын | 49134.7  |
| Улаангом – Увс нуурын бүс            | Амралт зугаалгын | 93062.2  |
| Хяргас нуур – Хар тэрмисийн бүс      | Амралт сувиллын  | 76259.8  |
| Баян-Өлгий аймаг                     |                  |          |
| Толбо нуурын бүс                     | Аялал жуулчлалын | 93250.4  |
| Ачит нуур – Дэвэл арлын бүс          | Аялал жуулчлалын | 40956.6  |
| Өлгий – Сагсайн бүс                  | Амралт зугаалгын | 102734.8 |
| Ховд гол – Цагаан голын бүс          | Амралт зугаалгын | 166572.5 |
| Дэлүүн, Чигэртэйн бүс                | Амралт сувиллын  | 100307.1 |
| Дүн                                  |                  | 503821.4 |

Баруун бүсийн таталцлын хүрээнд хамаарах хил гаалийн тогтолцоо /Зураг 11.4/



11.2 НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨЛТ  
ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦОО

11.2.1 Баруун бүсийн эдийн засгийн макро түвшний шинжилгээ  
(эхний хувилбар)

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын эрхэм зорилго нь газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц, чадавхийг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр хүн ам, үйлдвэрлэлийн өнөөгийн зохисгүй бөөгнөрлийг задалж, хот хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж, хөгжлийн түвшинг ойртуулах, үндэсний эдийн засаг-нийгмийн дэвшлийг түргэтгэх, эдийн засгийн дотоод, гадаад таатай орчныг бүрдүүлэхэд оршино. Бүсчлэн хөгжихийн мөн чанар нь аймаг, сум,



суурин газруудын хооронд аж ахуйн холбоо үүсч, нэг амьд организм хэлбэрээр бие биенийгээ дэмжин хөгжихийг хэлнэ.

Одоогийн байдлаар Баруун бүс нь эдийн засаг-нийгмийн хөгжлийн түвшнээрээ бусад бүсээс ихээхэн хоцрогдож байна. Үүнээс шалтгаалж Баруун бүсээс Төврүү тэмүүлсэн нүүдэл хамгийн их байгаа юм. Сүүлийн үед дэлхийн хөгжилтэй орнуудын эдийн засагчид макро эдийн засгийн шинжилгээ, төлөвлөлтөд симуляцын загварчлалын (CGE-computable general equilibrium-загвар) аргыг өргөн хэрэглэх боллоо. CGE загварыг ашиглан АНУ-ын хэсэг эрдэмтэд Калифорн муж Улсын хөгжлийн төлөвлөгөөг (2003 онд), ОХУ-ын СЯ-ны дэргэдэх “Прогноз” төвийн эрдэмтэд улсынхаа эдийн засаг-нийгмийн хөгжлийг 12 тойргоор (округ) задалж боловсруулсан нь (2006 онд) сайн үр дүн өгсөн байна. Баруун бүсийн хөгжлийн төлөвлөлтөд энэ загварыг ашиглаж буй бидний оролдлого нь анх удаа болно.

Одоогийн байдлыг шинжилгээ төлөвлөлтөнд хэрэглэсэн бүс ба салбар хоорондын уялдааны симуляцын загвар

Симуляцын загварын ерөнхий бүтэц, математик тэмдэглэгээ / Хүснэгт 11.4 /

| Симуляцын загварт орох тэгшитгэлийн төрөл                                     | Улсын дүнгээр тооцох тэгшитгэл  | Баруун бүс ба бусад бүсийг салгаж тооцох тэгшитгэл |
|---|---|--|
| Дотоодын нийт бүтээгдэхүүний үндсэн тэгшитгэл                                 | $Y_t = CN_t + I_{t,j} + G_t + G_{t,i} + NEXP_t$ $Y_t - t$ оны улсын дүнгээрх ба бүсийн нийт орлого буюу дотоодын нийт бүтээгдэхүүн, тэрбум төг<br>$CN_t - t$ оны улсын дүнгээрх хэрэглээ, тэрбум төг<br>$I_{t,j} - t$ онд $j$ салбарт оруулах хөрөнгө, улсын дүнгээр ба бүсийн дүнгээр, тэрбум төг<br>$G_t - t$ оны төвлөрсөн төсвийн зарцуулалт, тэрбум төг<br>$G_{t,i} - t$ оны $i$ аймгийн орон нутгийн төсвийн зарцуулалт, тэрбум төг<br>$NEXP_t - t$ оны улсын дүнгээрх цэвэр экспорт, тэрбум төг  |  |
| Нийгмийн нийлмэл хэрэглээний тэгшитгэл (зөвхөн улсын дүнгээр тооцно)          | $CN_t = c_1 + c_2 Y_t - c_3 P_t^{index} - c_4 R_t$ $P_t^{index} - t$ оны хэрэглээний үнийн индекс<br>$R_t - t$ оны хадгаламжийн дундаж хүү<br>$c_1, c_2, c_3, c_4$ – тэгшитгэлийн тоон коэффициентүүд   |  |
| Хөрөнгө оруулалтын тэгшитгэлүүд (баруун бүс ба бусад бүсүүдийг салгаж тооцно) | $I_{t,j} = I_{0,j} \cdot e^{\alpha_t \cdot R_t \cdot t}$ Домарын тэгшитгэл<br>$I_{t,j} - t$ онд $j$ салбарт оруулах хөрөнгө, баруун ба бусад бүсийн дүнгээр, тэрбум төг<br>$I_{0,j}$ – судалж байгаа динамикийн эхний онд $j$ салбарт оруулах хөрөнгө, баруун ба бусад бүсийн дүнгээр, тэрбум төг<br>$\alpha_t - t$ оны капиталын өгөөж, төг<br>Салбарын тогтсон ангилал: ХАА, ан агнуур, ойн аж ахуй<br>Уул уурхай, олборлох үйлдвэр<br>Боловсруулах үйлдвэр<br>Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж<br>Барилга<br>Бөөний болон жижиглэн худалдаа<br>Зочид буудал, зоогийн газар<br>Тээвэр, холбоо<br>Боловсрол, шинжлэх ухаан<br>Эрүүл мэнд, нийгмийн халамж<br>Материаллаг бус бусад салбар |  |

|   |   |
|---|---|
| Улсын төвлөрсөн ба орон нутгийн төсвийн өөрчлөлтийн тэгшитгэл   | $G_t = c_5 + @trend$ – төвлөрсөн төсвийн өөрчлөлтийн хандлага<br>$G_{t,i} = c_6 + @trend$ – $i$ аймгийн орон нутгийн төсвийн өөрчлөлтийн хандлага                               |
| Улсын дүнгээрх цэвэр экспортын өөрчлөлтийн тэгшитгэл  | $NEXT_t = c_7 + @trend$ – цэвэр экспортын өөрчлөлтийн хандлага  |
| Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлтийн тэгшитгэл   | $P_t = c_8 + @trend$ хэрэглээний үнийн индексийн өөрчлөлтийн хандлага   |
| Хадгаламжийн дундаж хүүгийн өөрчлөлтийн тэгшитгэл   | $R_t = c_9 + @trend$ хадгаламжийн дундаж хүүгийн өөрчлөлтийн хандлага   |
| Капиталын өгөөжийн өөрчлөлтийн тэгшитгэл  | $\alpha_t = c_{10} + @trend$ капиталын өгөөжийн өөрчлөлтийн хандлага  |
| Боловсрол, шинжлэх ухаанд зарцуулах хөрөнгийн тогтмол, улсын дүнгээр  | $KNOWLEDGE_t = c_{11} \cdot Y_t$ зарцуулах хөрөнгийн хэмжээг байнга өсөн нэмэгдүүлнэ  |
| Техник, технологийн шинэчилэлд зарцуулах хөрөнгийн тогтмол, улсын дүнгээр                                   | $RENEWATION_t = c_{12} \cdot Y_t$ зарцуулах хөрөнгийн хэмжээг байнга өсөн нэмэгдүүлнэ   |
| Суурин газрын тохижилтод зарцуулах хөрөнгийн тогтмол  | $URBAN_t = c_{13} \cdot Y_t$ зарцуулах хөрөнгийн хэмжээг байнга өсөн нэмэгдүүлж авна  |
| Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн тогтмол  | $ENVRMT_t = c_{13} \cdot Y_t$ зарцуулах хөрөнгийн хэмжээг байнга өсөн нэмэгдүүлж авна   |
| Мөнгөний нийлүүлэлтийн тэгшитгэл  | $M_{0,t} = c_{15} + c_{16} \cdot Y_t$<br>$M_{0,t}$ – зах зээл дээр $t$ онд нийлүүлэх $M_0$ мөнгөний хэмжээ, тэрбум төгрөг   |
| Зорилгын функц (улсын дүнгээр ба баруун бүсэд симуляцын алхам бүрт эрэлт, нийлүүлэлт тэнцвэржиж байх ёстой) | $\min(Z) = CN_t - \sum_h S_{t,h} \cdot P_{t,h}$<br>$S_{t,h}$ – $t$ онд $h$ бүтээгдэхүүнийг нийлүүлэх хэмжээ<br>$P_{t,h}$ – $t$ онд нийлүүлэх $h$ бүтээгдэхүүний зах зээлийн үнэ |

Дээрх загварын схемд Баруун бүсийн хөгжлийн хэтийн төлөвийг гаргахдаа улсын хөгжлийн хандлагатай нарийн уялдуулах шаардлагатай болох нь харагдаж байна. Ялангуяа бүсээр тооцох салбаруудын хөрөнгө оруулалтын тэгшитгэл маш зөв гарсан байх ёстой. Баруун бүс нь эдийн засгийн хөгжлийн түвшин бусад бүсээс хоцорч байгааг харгалзан салбаруудад оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг улсын дунджаас илүү байх бодлогыг барих, мөн техник, технологийн шинэчлэлд зарцуулах хөрөнгийн тогтмол, суурин газрын тохижилтод зарцуулах хөрөнгийн тогтмол, байгаль орчныг

хамгаалах арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн тогтмолыг баруун бүсэд улсын дунджаас илүү тавьж өгөх шаардлагатай.

Эдийн засгийн ямар арга хэмжээг яаж төлөвлөхийг авч ярихын өмнө загварын гол тэгшитгэлүүдийг Eviews программ ашиглан тооцсон жишгийг тайлбарлая. Төлөвлөлтийн явцад илүү нарийвчлалтай, нөлөөллийг дэлгэрэнгүй тусгасан тэгшитгэлүүдийг тооцно.

Тэгшитгэлүүдийн тооцоог гаргахын өмнө 2002-2007 оны улсын хэмжээгээр ДНБ ба баруун бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг үнийн дефлятор хэрэглэн 2005 оны зэрэгцүүлэх үнэд шилжүүлнэ.

Тооцоонд ашиглагдах зарим үзүүлэлтүүд /Хүснэгт 11.5 /

| Он   | Үнийн дефлятор | Ам. долларын ханш, төг/\$ | Зээлийн дундаж хүү, % | Хэрэглээ-ний үнийн индекс 1990=1 |
|------|----------------|---------------------------|-----------------------|----------------------------------|
| 2002 | 0.617801       | 1110.40                   | 29.20                 | 112.91                           |
| 2003 | 0.695503       | 1146.50                   | 26.92                 | 118.22                           |
| 2004 | 0.825541       | 1185.20                   | 22.76                 | 131.20                           |
| 2005 | 1.000000       | 1205.30                   | 22.49                 | 143.62                           |
| 2006 | 1.231192       | 1179.50                   | 18.99                 | 152.19                           |
| 2007 | 1.374190       | 1169.97                   | 16.00                 | 175.17                           |

Тэгшитгэлийн тооцоонд ашиглах зарим үзүүлэлтүүд, улсын дүнгээр, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг / Хүснэгт 11.6 /

| Он   | $Y_t$<br>ДНБ | $CN_t$<br>Нийт хэрэглээ | $I_t$<br>Нийт хөрөнгө оруулалт | $G_t$<br>Улсын төсвийн зарлага | $NEXT_t$<br>Цэвэр экспорт | $M_0$<br>Зах зээл дээрх бэлэн мөнгө |
|------|--------------|-------------------------|--------------------------------|--------------------------------|---------------------------|-------------------------------------|
| 2002 | 2008.4       | 810.6                   | 604.6                          | 816.4                          | -223.2                    | 134.6                               |
| 2003 | 2127.5       | 716.3                   | 860.8                          | 806.2                          | -255.8                    | 152.8                               |
| 2004 | 2356.8       | 887.2                   | 857.9                          | 827.9                          | -216.3                    | 168.5                               |
| 2005 | 2524.3       | 1136.1                  | 861.9                          | 699.8                          | -173.5                    | 191.7                               |
| 2006 | 3017.4       | 1234.3                  | 814.0                          | 887.8                          | 81.3                      | 245.1                               |
| 2007 | 3316.5       | 1393.0                  | 925.8                          | 1272.9                         | -275.2                    | 364.1                               |

✓ Нийт хэрэглээний тэгшитгэл:

$$CN_t = -1991.4551 + 0.23684250 \cdot Y_t + 12.3105159 \cdot P_t^{index} + 31.0321696 \cdot R_t^{savings}$$

Тэгшитгэлээс үзэхэд орлого 1 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд хэрэглээ 236.8 сая төгрөгөөр нэмэгдэж байна. Харин хэрэглээний үнийн индекс 1 пунктээр өсөх нь зах зээл дээрх бэлэн мөнгөний хэмжээг өсгөдөг бөгөөд ингэснээр хэрэглээ үнийн дүнгээр 12.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэх нөлөөлөл үзүүлдэг байна. Түүнчлэн хадгаламжийн дундаж хүү 1 хувиар дээшлэхэд хэрэглээ 31.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэх нөлөөлөл үзүүлж байна.

Нийт хэрэглээний тэгшитгэлийн тооцоо, EViews

| Dependent Variable: CN     |             |                       |             |          |
|----------------------------|-------------|-----------------------|-------------|----------|
| Method: Least Squares      |             |                       |             |          |
| Date: 05/17/08 Time: 10:16 |             |                       |             |          |
| Sample: 2002 2007          |             |                       |             |          |
| Included observations: 6   |             |                       |             |          |
| Variable                   | Coefficient | Std. Error            | t-Statistic | Prob.    |
| C                          | -1991.455   | 2152.408              | -           | 0.4525   |
| Y                          | 0.236843    | 0.462403              | 0.512199    | 0.6595   |
| P                          | 12.31052    | 10.43098              | 1.180188    | 0.3593   |
| R_SAVING01                 | 31.03217    | 43.25159              | 0.717480    | 0.5476   |
| R-squared                  | 0.949505    | Mean dependent var    |             | 1029.583 |
| Adjusted R-                | 0.873764    | S.D. dependent var    |             | 265.1920 |
| S.E. of                    | 94.22205    | Akaike info criterion |             | 12.16391 |

|                |           |                   |          |
|----------------|-----------|-------------------|----------|
| Sum squared    | 17755.59  | Schwarz criterion | 12.02508 |
| Log likelihood | -32.49172 | F-statistic       | 12.53608 |
| Durbin-Watson  | 2.024836  | Prob(F-statistic) | 0.074777 |

Тэгшитгэлийн детерминацын коэффициент 0.95 гарсан нь (хүснэгт) корреляцын хамаарал нэн хүчтэй ( $R = \sqrt{0.95} = 0.97$  байгааг харуулж байна. Дарбин-Уотсоны шалгуур 2.02 байгаа нь автокорреляц үгүй болохыг илэрхийлж байна. Түүнчлэн  $C, Y, P, R$  хувьсагчуудын  $t$  студентийн шалгуурын магадлал 0.36-0.65 гарсан нь алдаа бага болохыг харуулж байна. Мөн  $CN$  үзүүлэлтийн  $F$  тархалтын шалгуурын магадал 0.07 гарсан нь нэн үнэмшилтэй, тэгшрүүлэлтийн алдаа бага байгааг харуулж байна.

✓ Хөрөнгө оруулалтын тэгшитгэл:

$$I = 1272.61 \cdot e^{(0.0017122169\alpha - 0.0206159949R)}$$

Домарын өсөлтийн тэгшитгэл

Хөрөнгө оруулалтын тэгшитгэлийн тооцоо, EVies

|  |             |                       |             |        |
|--|-------------|-----------------------|-------------|--------|
| Dependent Variable: LOG(I)                         |             |                       |             |        |
| Method: Least Squares                              |             |                       |             |        |
| Date: 05/17/08 Time: 12:09                         |             |                       |             |        |
| Sample(adjused): 2002 2007                         |             |                       |             |        |
| Included observations: 6 after adjusting endpoints |             |                       |             |        |
| Variable   | Coefficient | Std. Error            | t-Statistic | Prob.  |
| C  | 7.148828    | 1.763836              | 4.053001    | 0.0271 |
| ALFA   | 0.001712    | 0.067354              | 0.025421    | 0.9813 |
| R_SAVING01   | -0.020616   | 0.041849              | -0.492632   | 0.6561 |
| R-squared  | 0.486527    | Mean dependent var    | 6.701437    |        |
| Adjusted R-  | 0.144212    | S.D. dependent var    | 0.151127    |        |
| S.E. of regression                                 | 0.139806    | Akaike info criterion | -0.790275   |        |
| Sum squared resid                                  | 0.058637    | Schwarz criterion     | -0.894395   |        |
| Log likelihood                                     | 5.370824    | F-statistic           | 1.421285    |        |
| Durbin-Watson                                      | 2.091061    | Prob(F-statistic)     | 0.367939    |        |

Тэгшитгэлээс үзэхэд тухайн жилд капиталын бүтээмж 1 пунктээр дээшлэхэд хөрөнгө оруулалт 0.17 хувь, хадгаламжийн зээлийн жилийн хүү 1 хувь буурахад хөрөнгө оруулалт 2.06 хувь өсдөг байна.

Детерминацын коэффициент 0.4865 гарсан нь хамаарал сайн ( $R = \sqrt{0.4865} = 0.6975$ ), Дарбин-Уотсоны шалгуур 2.09 байгаа нь автокорреляц байхгүй болохыг илэрхийлж байна. Мөн  $I$  үзүүлэлтийн  $F$  тархалтын шалгуурын магадал 0.37 гарсан нь үнэмшилтэй, тэгшрүүлэлтийн алдаа бага байгааг харуулж байна.

✓ Төвлөрсөн төсвийн тэгшитгэл  $G = 713.8236068 + 68.53847799 \cdot t$  гарав.

Төсвийн зарцуулалтын прогнозыг энгийн шугаман тэгшитгэлээр бодох нь тохиромжтой байдаг. Учир нь жил бүр төсвийн хэлэлцүүлэг УИХ-аар орж, хуульчлагдаж байдаг тул энэ хувьсагч эндоген шинжтэй байдаг.

Манай Улсын төвлөрсөн төсөв жил бүр 68.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж иржээ. Төсвийн ажилтны цалин энэ жилээс нэмэгдсэнтэй холбогдуулан прогнозыг хандлагаас 40% нэмэгдүүлж авлаа.

Детерминацын коэффициент 0.41 гарсан нь ( $R = \sqrt{0.41} = 0.64$ ) хамаарал сайн, Дарбин- Уотсоны шалгуур 1.38 гарсан нь дунд зэргийн автокорреляц байхгүй байгааг илэрхийлж байна. Ингэж гарах нь аргагүй юм. Манай төсөв жил бүр тогтвортой нэмэгдэж ирсэн нь автокорреляц байх үндэслэлийг бүрдүүлж байна.  $t$  студентийн шалгуурын магадлал 0.0045, 0.1686, судалж буй үзүүлэлтийн  $F$  тархалтын шалгуурын магадал 0.168575 гарсан нь прогноз үнэмшилтэй, тэгшрүүлэлтийн алдаагүй байгааг харуулж байна.

Төсвийн тэгшитгэлийн тооцоо, EVies

|                            |
|----------------------------|
| Dependent Variable: G      |
| Method: Least Squares      |
| Date: 05/17/08 Time: 13:12 |

| Sample(adjusted): 2002 2007                        |             |                       |             |          |
|--|-------------|-----------------------|-------------|----------|
| Included observations: 6 after adjusting endpoints |             |                       |             |          |
| Variable   | Coefficient | Std. Error            | t-Statistic | Prob.    |
| C  | 713.8236    | 123.6374              | 5.773526    | 0.0045   |
| @TREND   | 68.53848    | 40.83608              | 1.678380    | 0.1686   |
| R-squared  | 0.413228    | Mean dependent var    |             | 885.1698 |
| Adjusted R-  | 0.266535    | S.D. dependent var    |             | 199.4681 |
| S.E. of regression                                 | 170.8296    | Akaike info criterion |             | 13.38041 |
| Sum squared  | 116731.0    | Schwarz criterion     |             | 13.31100 |
| Log likelihood                                     | -38.14123   | F-statistic           |             | 2.816961 |
| Durbin-Watson                                      | 1.384187    | Prob(F-statistic)     |             | 0.168575 |

Загварын үндсэн тэгшитгэлийг  $Y = CN + I + G + NEXP$  оруулан үндсэн загвараа бодно. Загварыг бодож, прогноз гаргахын өмнө эндогенийн  $NEXT_t$ , экзогенийн  $R_t^{savings}, P_t^{index}, \alpha_t$  хувьсагчуудын 2008-2010 он хүртэлх хандлагыг гаргах шаардлагатай.

Хандлагын тэгшитгэл гаргахад олон арга хэрэглэдэг бөгөөд EViews программд юуны өмнө авторегрессийн хамаарал, түүний алдааны үнэлэмж дээр тулгуурласан ARMA, ARIMA аргуудыг өргөн хэрэглэдэг. Хандлагын тэгшитгэлийн тооцоог нэг ба олон шатат хамгийн бага квадратын аргыг ашигладаг бөгөөд тэгшитгэл дотор авторегрессийн 1-р эрэмбийн шалгуур  $ar(1)$ , 2-р эрэмбийн шалгуур  $ar(2)$  гэх мэтээр 4-р эрэмбэ хүртэл шалгуур тооцож оруулж болно.


Ийнхүү хандлагыг тооцоход:

- ✓ Цэвэр экспорт-  $NEXT = -233.8505015 + 22.69937048 * (@TREND)$
- ✓ Хадгаламжийн дундаж хүү-  $R_t^{savings} = 29.7893e^{-0.116182877 * t}$
- ✓ Хэрэглээний үнийн индекс-  $P_t^{index} = 108.4854207 + 12.16036289 * t$
- ✓ Капиталын бүтээмж-  $\alpha_t = 8.63154 * e^{0.133308463 * t}$  гарав.

**Загвар бодсон урьдчилсан дүн-  
Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний  
өөрчлөлтийн хандлага, 2005 оны үнээр, тэрбум төгрөг /Хүснэгт 11.7/**

| Он   | $CN_t$<br>Нийт хэрэглээ | $I_t$<br>Нийт хөрөнгө оруулалт | $G_t$<br>Улсын төсвийн зарлага | $NEXT_t$ Цэвэр экспорт | $Y_t$<br>ДНБ-ний дүн |
|------|-------------------------|--------------------------------|--------------------------------|------------------------|----------------------|
| 2008 | 1540.2                  | 968.6                          | 1575.1                         | -97.7                  | 3986.2               |
| 2009 | 1710.2                  | 1006.4                         | 1671.0                         | -75.0                  | 4312.6               |
| 2010 | 1886.9                  | 1042.4                         | 1767.0                         | -52.3                  | 4644.1               |

**Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өөрчлөлтийн хандлага,  
2005 оны үнээр, тэрбум төгрөг /График 11.1/**



Дээрхийн нэгэн адилаар Баруун бүсийн дүнгээр тооцоо хийж, харьцуулахад дараах байдалтай байна. Тооцооны урьдчилсан дүнгээс харахад Баруун бүсийн эдийн засгийн хөгжлийн хоцрогдол байсаар л байна. 2007 онтой харьцуулахад 2010 онд улсын хэмжээгээр ДНБ 40.0 хувиар өсөхөөр тооцоо гарч байхад Баруун бүсийн дүнгээр дөнгөж 24.0 хувиар өсөхөөр байгаа нь хангалтгүй юм.

**Загвар бодсон үр дүн- Монгол Улсын ба Баруун бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүний өөрчлөлтийн хандлага, 2005 оны зэрэгцүүлэх үнээр /Хүснэгт 11.8 /**

| Он   | УЛСЫН ДҮН |                                      | БАРУУН БҮС |                                      |                       |
|------|-----------|--------------------------------------|------------|--------------------------------------|-----------------------|
|      | ДНБ       | 2007 онтой харьцуулсан өсөлтийн хувь | ДНБ        | 2007 онтой харьцуулсан өсөлтийн хувь | Улсын дүнд эзлэх хувь |
| 2007 | 3316.5    | 100.0                                | 233.5      | 100.0                                | 7.04                  |
| 2008 | 3986.2    | 120.2                                | 261.3      | 111.9                                | 6.56                  |
| 2009 | 4312.6    | 130.0                                | 269.5      | 115.4                                | 6.25                  |
| 2010 | 4644.1    | 140.0                                | 289.6      | 124.0                                | 6.24                  |

Иймээс улсын дундажаас илүү хурдацтай хөгжих хувилбарыг симуляцын загвараар тодорхойлж, түүнд тохирсон эдийн засаг-нийгмийг хөгжүүлэх төлөвлөгөө салбар тус бүрээр дэлгэрэнгүй боловсруулах шаардлагатай нь нотлогдож байна

**Үйлдвэржилтийн одоогийн байдал, хэтийн төлөв /Хүснэгт 11.9 /**

| Аймаг      |    | Сум          | Төлөвлөж буй  | Одоо байгаа     |
|------------|----|--------------|---|-----------------|
| Баян-Өлгий | 1  | Алтай        | Мах боловсруулах үйлдвэр                            |                 |
|            | 2  | Алтанцөгц    | Сүүний эрчимжсэн аж ахуй                            |                 |
|            | 3  | Баяннуур     | Хүнсний ногооны аж ахуй, ус/ систем                 |                 |
|            | 4  | Бугат        | Сүүний үйлдвэр Өлгийд                               | Услалтын систем |
|            | 5  | Булган       | Мах боловсруулах үйлдвэр, чацаргана тариалах        |                 |
|            | 6  | Буянт        | Тэжээл үйлдвэрлэх, зөгийн аж ахуй                   |                 |
|            | 7  | Дэлүүн       | Гахай , шувуу, зөгий, чацарганы аж ахуй             |                 |
|            | 8  | Ногооннуур   | Хүнсний ногоо, услалтын систем                      |                 |
|            | 9  | Сагсай       | Өлгий сумын 9-р багт нүүрсний хийн станц байгуулах  |                 |
|            | 10 | Толбо        |   |                 |
| Увс        | 11 | Улаанхус     | Уурхайн боловсруулах үйлдвэр, Асгат                 | Услалтын систем |
|            | 12 | Цэнгэл       | Малын тэжээлийн үйлдвэр                             | Услалтын систем |
|            | 1  | Баруунтуруун | Хүнсний ногоо боловсруулах, малын тэжээлийн үйлдвэр | Услалтын систем |
|            | 2  | Бөхмөрөн     | Саван, угаалгын нунтаг, нүүрс хийн үйлдвэр          |                 |

|        |    |               |  |                               |
|--------|----|---------------|--|-------------------------------|
|        | 3  | Давст         | Давсны үйлдвэр, услалтын систем  |                               |
|        | 4  | Завхан        | Загас боловсруулах, барилгын материал  |                               |
|        | 5  | Зүүнговь      | Мах боловсруулах, нөөшлөх үйлдвэр  |                               |
|        | 6  | Зүүнхангай    | Модлог ургамлын тариалан, давсны үйлдвэр   |                               |
|        | 7  | Малчин        | Эсгий эдлэл, шил, шилэн эдлэл, шилмэл малын үржлийн төв  |                               |
|        | 8  | Наранбулаг    | Яс боловсруулах,Харгантын төмрийн ордыг ашиглах  |                               |
|        |    |               | Төмөр, ган   |                               |
|        | 9  | Өлгий         | Ноос, ноолуур боловсруулах, услалтын систем  |                               |
|        | 10 | Өмнөговь      | Тоосго, блок, арьс, шир боловсруулах, гурилын үйлдвэр, услалтын систем                                     |                               |
|        | 11 | Өндөрхангай   | Оедол, эсгий эдлэлийн үйлдвэр  |                               |
|        | 12 | Сагил         | Гурилан бүтээгдэхүүн, тэжээлийн үйлдвэр, Хандгайтын боомтын наана эдийн засгийн худалдааны төв байгуулах   |                               |
|        | 13 | Тариалан      | Газар тариалан, тэжээл, арвайн гурил, услалтын систем, салфетка, ариун цэврийн цаас, нүүрсний хийн үйлдвэр |                               |
|        |    |               | Чулуун давс  |                               |
|        | 14 | Түргэн        | Үнээний аж ахуй, гурилан бүтээгдэхүүн усан сан, хов  | Услалтын систем-2             |
|        | 15 | Тэс           | Өвс, хадлан авах, эсгий эдлэл, тэжээл, шилмэл адуу, гурилан бүтээгдэхүүн                                   |                               |
|        | 16 | Ховд          | Мах боловсруулах   |                               |
|        | 17 | Хяргас        | Талх,нарийн боов, шохой боловсруулах   |                               |
|        | 18 | Цагаанхайрхан | Эсгийн үйлдвэр   |                               |
|        | 19 | Улаангом      | Сүү, хуурай сүү, хөргөлтийн цех, Үнээний ферм, зөгий, шувуу, гахайн аж ахуй, хэвлэх үйлдвэр                | Услалтын систем               |
|        |    |               | Ноос, ноолуур боловсруулах, савлах   |                               |
|        |    |               | Сүү боловсруулах   |                               |
|        |    |               | Чацаргана боловсруулах   | Чацарганы шинэ том талбай бий |
| Завхан | 1  | Алдархаан     | Ноос, ноолуур боловсруулах, үнээний аж ахуй  |                               |
|        | 2  | Асгат         | Эсгий боловсруулах, услалтын систем  |                               |
|        | 3  | Баянхайрхан   | Малын тэжээлийн цех  |                               |
|        | 4  | Баянтэс       | Малын тэжээлийн цех  |                               |
|        | 5  | Дөрвөлжин     | Сэргээгдэх эрчим хүч, нар, салхины станц   |                               |
|        | 6  | Завханмандал  | Яс боловсруулах үйлдвэр, барилгын материал   |                               |
|        | 7  | Идэр          | Авто замын барилгын материал, авто зөөврийн цех  |                               |
|        | 8  | Их-Уул        | Ой үржүүлэх төв  |                               |
|        | 9  | Нөмрөг        | Гурилан бүтээгдэхүүний цех, сүүний аж ахуй   |                               |
|        | 10 | Отгон         | Нарийн мужаан, модны үйлдвэр   |                               |
|        | 11 | Сантмаргац    | Модлог ургамлын парк, цөм сүргийн аж ахуй  |                               |
|        | 12 | Сонгино       | Жимсгэнэ боловсруулах  |                               |
|        | 13 | Түдэвтэй      | Нарийн мужаан, эмийн ургамал тариалах  |                               |
|        | 14 | Тэлмэн        | Хүнсний ногоо боловсруулах   |                               |
|        | 15 | Тэс           | Хүнс ногооны аж ахуй, услалтын систем  |                               |
|        | 16 | Тосонцэнгэл   | Ой үржүүлэх, нарийн модны үйлдвэр  | Услалтын систем               |
|        | 17 | Ургамал       | Авто засвар, аймаг дундын авто парк  |                               |
|        | 18 | Улиастай      | Аж үйлдвэрийн парк   |                               |
|        | 19 | Цагаанхайрхан | Ямаа, тэмээний ноос боловсруулах үйлдвэр   |                               |
|        | 20 | Цагаанчулуут  | Тэмээний цөм сүргийн аж ахуй   |                               |
|        | 21 | Цэцэн-Уул     | Нарийн ногооны аж ахуй, услалтын систем  |                               |
|        | 22 | Шилүүстэй     | Мао боловсруулах үйлдвэр   |                               |
|        | 23 | Эрдэнэхайрхан | Арьс, шир боловсруулах   |                               |
|        | 24 | Яруу          | Мах боловсруулах   |                               |
|        | 25 |               | Эмийн ургамал, тариалах боловсруулах   |                               |


|            |    |                 |   |                         |
|------------|----|-----------------|---|-------------------------|
|            | 26 |                 | Үхэр, гахайн эрчимжсэн ферм   |                         |
| Говь-Алтай | 1  | Алтай-Цээл      | Мах боловсруулах  |                         |
|            |    | Алтай-Цээл      | Хүнсний ногоо боловсруулах  |                         |
|            |    | Алтай-Цээл-Цогт | Хөргөгч   |                         |
|            | 2  | Баян-Уул        | Мах боловсруулах  |                         |
|            | 3  | Бигэр           | Арвай, хүнсний ногоо, дарс  | Услалтын систем         |
|            | 4  | Бугат           | Малын тоног хэрэгсэл  | Услалтын систем         |
|            | 5  | Дарви           | Мах, сүүний чиглэлийн үхрийн аж ахуй                                  |                         |
|            | 6  | Дэлгэр          | Гурил, арвайн гурил   | Услалтын систем, Гуулин |
|            | 7  | Есөнбулаг       | Аж үйлдвэрийн парк, барилга материалын үйлдвэр                        |                         |
|            | 8  | Жаргалан        | Тэжээлийн аж ахуй   |                         |
|            | 9  | Тайшир          | Барилгын чулуу, цементийн үйлдвэр                                     | Услалтын систем         |
|            | 10 | Тонхил          | Гахай, шувууны аж ахуй  |                         |
|            | 11 | Төгрөг          | Шил, шилэн эдлэл  |                         |
|            |    |                 | Чулуу, чулуун эдлэл   |                         |
|            |    | Төгрөг-Халиун   | Арьс, шир боловсруулах  |                         |
|            | 12 | Халиун          | Оёдол, гахай, шувууны аж ахуй   | Услалтын систем         |
| Date: 02/07/09 Time: 20:11                         |             |                       |             |        |
| Sample(adjusted): 2002 2007                        |             |                       |             |        |
| Included observations: 6 after adjusting endpoints |             |                       |             |        |
| Variable   | Coefficient | Std. Error            | t-Statistic | Prob.  |
| C  | -224.8171   | 100.6730              | -2.233142   | 0.0893 |
| @TREND   | 19.79447    | 33.25120              | 0.595301    | 0.5837 |
| R-squared  | 0.081385    | Mean dependent var    | -175.3310   |        |
| Adjusted R-squared                                 | -0.148268   | S.D. dependent var    | 129.8090    |        |
| S.E. of regression                                 | 139.0997    | Akaike info criterion | 12.96946    |        |
| Sum squared resid                                  | 77394.96    | Schwarz criterion     | 12.90005    |        |
| Log likelihood                                     | -36.90838   | F-statistic           | 0.354383    |        |
| Durbin-Watson stat                                 | 2.417339    | Prob(F-statistic)     | 0.583687    |        |

Загварыг бодож, прогноз гаргахын өмнө экзогенийн  $RL_{t,4}, RL_{t,w}, RS_{t,4}, RS_{t,w}, P_{t,4}^{index}, P_{t,4}^{index}, \alpha_t$  хувьсагчуудын 2008-2010 он хүртэлх хандлагыг гаргах шаардлагатай.

• **Зээлийн жилийн хүүгийн тэгшитгэл:**

$$RL_{t,4} = 33.2145 - 2.6151 \cdot t$$

$$RL_{t,w} = 3.6729 \cdot e^{-0.0938t}$$

Улсын дундаж зээлийн жилийн хүүгийн тэгшитгэлийн тооцоо, Eviews

|  |             |                       |             |          |
|--|-------------|-----------------------|-------------|----------|
| Dependent Variable: RL4                            |             |                       |             |          |
| Method: Least Squares                              |             |                       |             |          |
| Date: 02/08/09 Time: 08:27                         |             |                       |             |          |
| Sample(adjusted): 2002 2007                        |             |                       |             |          |
| Included observations: 6 after adjusting endpoints |             |                       |             |          |
| Variable   | Coefficient | Std. Error            | t-Statistic | Prob.    |
| C  | 33.21455    | 0.750496              | 44.25682    | 0.0000   |
| @TREND   | -2.615086   | 0.247881              | -10.54978   | 0.0005   |
| R-squared  | 0.965307    | Mean dependent var    |             | 26.67683 |
| Adjusted R-squared                                 | 0.956634    | S.D. dependent var    |             | 4.979518 |
| S.E. of regression                                 | 1.036959    | Akaike info criterion |             | 3.171663 |
| Sum squared resid                                  | 4.301133    | Schwarz criterion     |             | 3.102249 |
| Log likelihood                                     | -7.514988   | F-statistic           |             | 111.2980 |
| Durbin-Watson stat                                 | 2.439330    | Prob(F-statistic)     |             | 0.000457 |

- **Хадгаламжийн жилийн хүүгийн тэгшитгэл:**

$$RS_{t,4} = 7.3010 - 0.0239 \cdot t$$

$$RS_{t,w} = 2.2323 + 0.0034 \cdot t$$

- **Хэрэглээний үнийн индексийн тэгшитгэл:**

Улсын дундаж-  $P_{t,4}^{index} = 75.5276 + 8.4743 \cdot t$

Улсын дундаж үнийн индексийн тэгшитгэлийн тооцоо, Eviews

|  |             |                       |             |          |
|--|-------------|-----------------------|-------------|----------|
| Dependent Variable: P4                             |             |                       |             |          |
| Method: Least Squares                              |             |                       |             |          |
| Date: 02/08/09 Time: 08:51                         |             |                       |             |          |
| Sample(adjusted): 2002 2007                        |             |                       |             |          |
| Included observations: 6 after adjusting endpoints |             |                       |             |          |
| Variable   | Coefficient | Std. Error            | t-Statistic | Prob.    |
| C  | 75.52762    | 2.366906              | 31.90986    | 0.0000   |
| @TREND   | 8.474286    | 0.781763              | 10.83996    | 0.0004   |
| R-squared  | 0.967079    | Mean dependent var    |             | 96.71333 |
| Adjusted R-squared                                 | 0.958849    | S.D. dependent var    |             | 16.12152 |
| S.E. of regression                                 | 3.270350    | Akaike info criterion |             | 5.468873 |
| Sum squared resid                                  | 42.78076    | Schwarz criterion     |             | 5.399459 |
| Log likelihood                                     | -14.40662   | F-statistic           |             | 117.5048 |
| Durbin-Watson stat                                 | 2.002278    | Prob(F-statistic)     |             | 0.000411 |

Баруун бүс-  $P_{t,w}^{index} = 63.5771 + 13.0080 \cdot t$

Баруун бүсийн үнийн индексийн тэгшитгэлийн тооцоо, Eviews

|  |             |                    |             |          |
|--|-------------|--------------------|-------------|----------|
| Dependent Variable: PW                             |             |                    |             |          |
| Method: Least Squares                              |             |                    |             |          |
| Date: 02/08/09 Time: 08:59                         |             |                    |             |          |
| Sample(adjusted): 2002 2007                        |             |                    |             |          |
| Included observations: 6 after adjusting endpoints |             |                    |             |          |
| Variable   | Coefficient | Std. Error         | t-Statistic | Prob.    |
| C  | 63.57705    | 4.023407           | 15.80179    | 0.0001   |
| @TREND   | 13.00798    | 1.328888           | 9.788620    | 0.0006   |
| R-squared  | 0.959927    | Mean dependent var |             | 96.09699 |

|                    |           |                       |          |
|--------------------|-----------|-----------------------|----------|
| Adjusted R-squared | 0.949908  | S.D. dependent var    | 24.83846 |
| S.E. of regression | 5.559136  | Akaike info criterion | 6.529964 |
| Sum squared resid  | 123.6160  | Schwarz criterion     | 6.460550 |
| Log likelihood     | -17.58989 | F-statistic           | 95.81708 |
| Durbin-Watson stat | 1.717146  | Prob(F-statistic)     | 0.000610 |

✓ **Улсын дундаж капиталын бүтээмжийн тэгшитгэл:**

$$\alpha_t = 2.1918 \cdot e^{0.133t}$$

|  |             |                       |             |        |
|--|-------------|-----------------------|-------------|--------|
| Dependent Variable: LOG(ALFA)                      |             |                       |             |        |
| Method: Least Squares                              |             |                       |             |        |
| Date: 02/08/09 Time: 09:05                         |             |                       |             |        |
| Sample(adjusted): 2002 2007                        |             |                       |             |        |
| Included observations: 6 after adjusting endpoints |             |                       |             |        |
| Variable   | Coefficient | Std. Error            | t-Statistic | Prob.  |
| C  | 2.191770    | 0.090848              | 24.12570    | 0.0000 |
| @TREND   | 0.133061    | 0.030006              | 4.434480    | 0.0114 |
| R-squared  | 0.830971    | Mean dependent var    | 2.524423    |        |
| Adjusted R-squared                                 | 0.788714    | S.D. dependent var    | 0.273082    |        |
| S.E. of regression                                 | 0.125524    | Akaike info criterion | -1.051431   |        |
| Sum squared resid                                  | 0.063026    | Schwarz criterion     | -1.120844   |        |
| Log likelihood                                     | 5.154293    | F-statistic           | 19.66462    |        |
| Durbin-Watson stat                                 | 1.338960    | Prob(F-statistic)     | 0.011382    |        |

Ийнхүү бүх тэгшитгэлүүд бэлэн болсны дараа загвараа “estimate as model” командаар зохиож, үндсэн тэгшитгэлийг оруулан бодолт хийнэ. Загвар нь зорилгын функцгүй бөгөөд симуляцын 1000 алхам хийхдээ итераци бүрт эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэржилт сайжирч байгаа юм.

**Загвар бодсон тайлан, EViews**

Model: MODEL01WEST

Date: 02/08/09 Time: 09:20

Sample: 2002 2010

Solve Options:

Dynamic-Stochastic Simulation

Solver: Gauss-Seidel

Max iterations = 5000, Convergence = 1e-08

Requested repetitions = 1000, Allow up to 2 percent failures

Solution does not account for coefficient uncertainty in linked equations

Track endogenous: mean, standard deviation

Scenario: Baseline

Solve begin 09:20:24

Repetitions 1-200: successful 09:20:25

Repetitions 201-400: successful 09:20:26

Repetitions 401-600: successful 09:20:27

Repetitions 601-800: successful 09:20:28

Repetitions 801-1000: successful 09:20:28

Solve complete 09:20:28

1000 successful repetitions, 0 failure(s)

**Загвар бодсон дүн-**

**тооцоонд ашигласан зарим үзүүлэлтийн прогноз /Хүснэгт 11.16/**


| Он | Улсын дундаж зээлийн хүү, % | Баруун бүсийн дундаж зээлийн хүү, % | Улсын дундаж хадгаламжийн хүү, % | Баруун бүсийн дундаж хадгаламжийн хүү, % | Улсын дундаж хэрэглээний үнийн | Баруун бүсийн дундаж хэрэглээний | Улсын дундаж капиталын өгөөж, |
|----|-----------------------------|-------------------------------------|----------------------------------|--|--------------------------------|----------------------------------|-------------------------------|
|----|-----------------------------|-------------------------------------|----------------------------------|--|--------------------------------|----------------------------------|-------------------------------|

|      | $RL_{t,4}$ | $RL_{t,w}$ | $RS_{t,4}$ | хүү, %<br>$RS_{t,w}$ | индекс<br>2005=100<br>$P_{t,4}^{index}$ | үнийн<br>индекс<br>2005=100<br>$P_{t,w}^{index}$ | төг<br>$\alpha_t$ |
|------|------------|------------|------------|----------------------|---|--|-------------------|
| 2008 | 17.6       | 22.5       | 7.2        | 9.5                  | 126.4                                   | 141.6  | 20.0              |
| 2009 | 14.8       | 20.5       | 7.1        | 9.6                  | 135.0                                   | 154.9  | 22.8              |
| 2010 | 12.3       | 18.7       | 7.1        | 9.6                  | 143.4                                   | 167.7  | 26.2              |


Монгол Улсын бүсүүдийн ДНБ-ий прогно, 2005 оны үнээр, тэрбум төгрөг /Хүснэгт 11.17 /

| Он   | Бусад 4 бүсийн дүн |                             |                                    |                                |                           | Баруун бүс       |                             |                                    |
|------|--------------------|-----------------------------|------------------------------------|--------------------------------|---------------------------|------------------|-----------------------------|------------------------------------|
|      | $Y_{t,4}$<br>ДНБ   | $CN_{t,4}$<br>Нийт хэрэглээ | $I_{t,4}$<br>Нийт хөрөнгө оруулалт | $G_t$<br>Улсын төсвийн зарлага | $NEXT_t$<br>Цэвэр экспорт | $Y_{t,w}$<br>ДНБ | $CN_{t,w}$<br>Нийт хэрэглээ | $I_{t,w}$<br>Нийт хөрөнгө оруулалт |
| 2008 | 3494.3             | 1564.4                      | 870.7                              | 1161.4                         | -102.2                    | 275.7            | 220.9                       | 54.8                               |
| 2009 | 3921.7             | 1809.9                      | 963.9                              | 1242.4                         | -94.5                     | 307.3            | 244.2                       | 63.1                               |
| 2010 | 4382.7             | 2074.8                      | 1065.8                             | 1308.0                         | -65.9                     | 343.3            | 270.4                       | 72.8                               |

Баруун бүсээс бусад 4 бүсийн ДНБ-ий өөрчлөлтийн хандлага, прогно, 2005 оны үнээр, тэрбум төгрөг /График 11.5./



Баруун бүсийн ДНБ-ий өөрчлөлтийн хандлага, прогно, 2005 оны үнээр, тэрбум төгрөг /График 11.6/




Монгол Улсын бүсүүдийн ДНБ-ий цэвэр өсөлт, прогноз, % /Хүснэгт 11.18/

| Өмнөх онтой харьцуулсан өсөлт, % | Улсын дундаж | Бусад 4 бүсийн дундаж | Баруун бүсийн дундаж |
|----------------------------------|--------------|-----------------------|----------------------|
| 2003/02                          | 4.6          | 4.9                   | 1.6                  |
| 2004/03                          | 23.4         | 22.7                  | 31.8                 |
| 2005/04                          | 7.3          | 7.7                   | 2.3                  |
| 2006/05                          | 8.6          | 9.2                   | 1.3                  |
| 2007/06                          | 9.9          | 9.6                   | 13.3                 |
| 2008/07                          | 13.9         | 13.9                  | 11.1                 |
| 2009/08                          | 11.7         | 12.2                  | 11.4                 |
| 2010/09                          | 11.5         | 11.8                  | 11.7                 |

Тооцооноос харахад Баруун бүс ДНБ-ний жилийн дундаж өсөлтөөр улс ба бусад 4 бүсээс хоцорч байсан бол 2009 оноос өсөлтийг жигдрүүлж, эдийн засгийн хоцрогдлыг арилгах боломж байна.

Монгол Улсын бүсүүдийн ДНБ-ий цэвэр өсөлтийн хандлага, прогноз, % /График 11.7/



Алслагдсан бүсүүдийг төвийн бүсүүдээс илүү хурдацтай хөгжих хувилбарыг симуляцын загвараар тодорхойлж, түүнд тохирсон эдийн засаг-нийгмийг хөгжүүлэх төлөвлөгөө салбар тус бүрээр дэлгэрэнгүй боловсруулах шаардлагатай нь нотлогдож байна.

**БАРУУН БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ**

| Д/д-он           | Хэрэгжүүлэх ажлын төрөл  | Хүчин чадал ба тайлбар  |
|------------------|--|---|
| 1.               | <b>ДЭД БҮТЦИЙН СҮЛЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ</b>   |   |
| 1.1              | <b>ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ</b>   |   |
| <b>2009-2015</b> | 8. Говь-Алтай аймгийн нутагт Завхан гол дээр 8 МВт хүчин чадалтай Тайшир /Улаанбоом/-ын УЦС барилга угсралтын ажил бүрэн дууссан. Усны түвшин хүрэлцээгүй учраас генератор нь ажилаагүй. | Монгол улсын эрчим хүчний нэгдсэн системд баруун таван аймгийг эрчим хүчээр найдвартай хангах эхний шатны төлөвлөлт |
|                  | 9. Тайширын УЦС-аас Завханы төв Улиастай хүртэл 110 кВ-ын 120км шугам баригдсан ч ашиглалтанд ороогүй байна.   |   |
|                  | 10. Говь-Алтай аймгийн төв Алтай хот 110 кВ-ын 47км шугам барьсан.   |   |
|                  | 11. Ховд аймгийн нутагт орших Чоно харайх гол дээр 12 МВт хүчин чадалтай Дөргөний УЦС одоогоор 2008-5-20нд эхний генераторийг ажилууллаа.  |   |
|                  | 12. 110 кВ-ын 72 км шугам татаж, Дөргөний УЦС-ыг Мянгатын дэд  |   |



|                             |   |  |
|-----------------------------|---|--|
|                             | <p>станцтай холбоно.</p> <p>13. Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэр дээр салхин станц барьж, системд холбох асуудлыг судалж шийдвэрлэнэ.</p> <p>14. Завхан, Говь-Алтай аймгийг Мөрөнгийн эрчим хүчний системд холбоно. Энэ системийн онцлог нь эрчим хүчний УЦС болон ДЦС-ын эх үүсвэрийг байгуулна.</p> <p>15. Хөшөөтийн нүүрсний уурхайгаас Цэцэг, Мөст, Үенчийн УЦС-аас Алтай, Булган, Ярант, Манхан, Зэрэг, Чандмань, Дарви сумдыг эрчим хүчний системд холбох</p>   |  |
| 2016-2021                   | <p>1. Ховд гол дээр Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг үе шаттай барина. Баруун бүсийн бүх аймгийн цахилгаан хэрэглээний ирээдүйн өсөлтийг хангах нүүрс түлшний нөөцгүй Завхан, Говь-Алтай аймгийн дулааны асуудлыг шийдвэрлэхэд УЦС-ын хямд цахилгаан эрчим хүчийг ашиглана.</p> <p>2. Эрдэнэбүрэнгийн УЦС-аас Ховдын Мянгатын 110кВт-ын хүчдэлтэй дэд станц хүртэл 220кВ-ын хүчдэлтэй 62км шугам татаж, Мянгатын дэд станцыг өргөтгөж холбоно.</p> <p>3. Сутай хотод атомын цахилгаан станц байгуулах ажлыг эхлүүлэх</p>  | <p>Монгол улсын эрчим хүчний нэгдсэн системд баруун таван аймгийг эрчим хүчээр найдвартай хангах зорилгоор 2012-2021 онуудад хэрэгжүүлэх төлөвлөлт</p>   |
| Төлөвлөлтөөс цааш хугацаанд | <p>6. Дөргөний УЦС болон Улиастай хот хооронд 320 км урт 220кВ-ын шугам татаж холболт хийгээд баруун бүсийн нэгдсэн систем байгуулна. Баруун бүсийн системтэй Хангайн болон Төвийн эрчим хүчний системийг холбох боломжийг ойртуулах ач холбогдолтой юм.</p> <p>7. Баруун бүсийн таван аймгийг холбосон эрчим хүчний нэгдсэн систем байгуулагдана. Энэ системийн онцлог ач холбогдол нь цахилгаан эрчим хүчийг 100 хувь зөвхөн УЦС-/Завханы богдын гол, Говь-Алтайн Тайшир, Ховдын Чоно харайх, Эрдэнэбүрэн/-д үйлдвэрлэх юм.</p> <p>8. Баруун бүсийн төвийг Улиастай хотыг Хангайн бүсийн Баянхонгортой холбосон 330км урт, 220кВ-ын хүчдэлтэй шугам татаж, Баруун, Хангай, Төвийн бүсийн эрчим хүчний нэгдсэн систем байгуулна.</p>   | <p>Монгол улсын эрчим хүчний нэгдсэн системд баруун таван аймгийг эрчим хүчээр найдвартай хангах зорилгоор 2021 оноос хойш хэрэгжүүлэх төлөвлөлт</p>   |
| 1.2                         | <b>ХОЛБОО МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ ТӨЛӨВЛӨЛТ</b>   |  |
| 2009-2015                   | <p>11. Аймаг, сумын төвийн интернэтийн сүлжээг ашиглан аймаг, сумын Засаг даргын тамгийн газар, татвар, гааль, нийгмийн даатгал, эмнэлэг, дунд сургууль зэрэг бүх төр болон төрийн бус байгууллагуудад интернэт нэвтрүүлэх</p> <p>12. Иргэдэд мэдээллээр үйлчлэх төв буюу интернэтийн төвүүдийг бүх аймаг, сумын төвүүдэд байгуулах</p> <p>13. Цахим боловсролыг хөгжүүлэх чиглэлээр бүх нийтийг компьютержүүлэх хөтөлбөр, хүүхэд бүрт зөөврийн компьютер хөтөлбөрт идэвхитэй оролцох замаар бүх сургуулиудыг суурин болон зөөврийн компьютерээр хангах</p> <p>14. Цахим засаглалыг хөгжүүлэх чиглэлээр бүх байгууллага, аж ахуйн нэгжийг интернэт хуудас болон электрон хаягтай болгох, мөн төрийн албан хаагчийг мэдээллийн технологийн сургалтад хамруулах, сургалтыг сертификаттай сургалтын төвүүдээр дамжуулан зохион байгуулах</p> <p>15. Цахим эрүүл мэндийг хөгжүүлэх чиглэлээр теле-оношлогоо, эмчилгээ, үйлчилгээний чиглэлээр туршилтын төсөл хэрэгжүүлэх</p> | <p>Баруун бүс нутагт мэдээлэл холбооны технологийн хоцрогдлыг (тоон ялгаа) арилгах, бүх нийтийг тэгш эрхтэйгээр мэдээлэл холбооны сүлжээнд холбох, төрөл бүрийн үйлчилгээ хүртэх боломжийг</p> |

|  |  |  |
|--|--|--|
|  | <p>16.Цахим арилжааг хөгжүүлэх чиглэлээр хот, аймгийн төвүүдийг холбосон малын бирж байгуулах замаар орон нутгийн малчдад малаа чөлөөтэй арилжаалах, малын үүлдэр угсааг сайжруулах, солилцоо хийх боломжийг бүрдүүлэх</p> <p>17.Малчдад мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хүргэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлын хүрээнд бүсийн бүх сумдад хөдөлгөөнт холбооны үйлчилгээг нэвтрүүлэх</p> <p>18.Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохицуулах төрийн интранет порталыг бий болгох</p> <p>19.Нэгдсэн кодчлол хөтөлбөрийн хүрээнд гудамж, талбай, албан байгууллага, айл өрх бүрийг хаягжуулж, шуудангийн бүсийн тогтолцоонд шилжүүлэх</p> <p>20.Төрийн үйлчилгээний үр өгөөж, чанар, хүртээмж, шуурхай байдал, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлж цахим-татвар, цахим-гааль, цахим-бичиг хэрэг зэрэг төсөл хэрэгжүүлж бүх салбарыг хамарсан цаасгүй онлайн үйлчилгээ бий болгох</p> | <p>бүрдүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор баруун бүсийн 5 аймгийн бүх сумдыг шилэн кабелийн суурь сүлжээнд холбох, 2009-2016 онуудад хэрэгжүүлэх төлөвлөлт</p>   |
| <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">2016-2021</p> | <p>1. Орон нутгийн мэдээлэл, холбооны сүлжээний технологийн шинэчлэлийг дуусгах</p> <p>2. Баруун бүсийн алслагдсан бүс нутгуудад утасгүй холбооны технологийг нэвтрүүлж бүрэн телефонжуулах</p> <p>3. Сумын төв, багийн төвүүдийг шилэн кабелийн сүлжээнд өргөнөөр холбох</p> <p>4. Үүрэн телефон хэрэглэх сонирхолтой хүн амын хэрэгцээ</p> <p>5. Интернетийн сүлжээг сум, багийн түвшинд өргөтгөж, компьютер, интернет хэрэглэгчдийн хэрэгцээг бүрэн хангах</p> <p>6. Баруун бүсэд VSAT сансрын станц байгуулахаар төлөвлөж байгаа билээ. Цаашид Интерсат сансрын станцыг суурилуулж харилцаа холбоог өргөтгөх шаардлагатай. Ингэснээр 24 цагийн телевизийн нэвтрүүлэг хүлээн авах боломжтой болно.</p>  | <p>Холбооны үйлчилгээнд тоон системийг бүрэн нэвтрүүлж, хиймэл дагуулын болон бага багтаамжийн радио релейний шугам, хөдөлгөөнт холбоог ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулах ажлыг хэрэгжүүлэх төлөвлөлт</p> |
| <p><b>1.3</b></p>  | <p><b>УНД АХУЙН УСАН ХАНГАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ</b></p>  |  |
| <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">2009-2015</p> | <p>1. Хадлангийн талбайг ашиглуулах, эзэмшүүлэх, бордох, услах үндсэн дээр байгаль эдийн засгийн бүс бүрт малын тэжээлийн хэрэгцээг дотоод нөөцөөр хангах нөхцөл бүрдүүлэх</p> <p>2. Энгийн болон инженерийн хийцтэй хийцтэй услалтын системийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах, усалгааны бусад арга технологи / дуслын, нэвшилтийн систем болон усан сан, хөв байгуулах/-ийг нэвтрүүлэх замаар усалгаатай тариаланг хөгжүүлэх</p> <p>3. Сэргээн засварлах услалтын системийн зураг төслийг эзэмшигч өмчлөгчийнх нь захиалгаар хийлгүүлж, түүнийг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх</p>   | <p>Усалгаатай тариалангийн хувьд УИХ-ын 2003 оны 29 дүгээр тогтоолоор “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-д</p>   |

|                  |   |   |
|------------------|---|---|
|                  | <p>4. Шинээр томоохон хэмжээний усалгаатай тариалан, хадлан бэлчээр бий болгох боломжтой нутгийн хайгуул, судалгаа, зураг төсөл боловсруулах, систем байгуулах ажлыг иргэн, аж ахуйн нэгжийн болон улсын захиалга, хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлэх зэрэг бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх</p> <p>5. Их нууруудын хотгор, Алтайн цаадах Говьд хайгуул судалгаа хийж, үр тариа тарих боломжийг судлах</p> <p>6. Цас борооны ус буюу голуудын илүүдэл урсацыг цуглуулж газар тариаланд ашиглах боломжийн хайгуул судалгаа хийх</p>  | <p>тусгасан.<br/>Усалгаатай тариалангийн хэтийн төлөв</p> |
| <p>2009-2015</p> | <p>Хот суурингаас алслагдсан газарт нүхэн жорлонгийн сайжруулсан хувилбар, бага оврын цэвэрлэх байгууламж ашиглах нь байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах ач холбогдолтой юм.</p>  | <p>Ариун цэврийн байгууламжийн ашиглалтын байдал</p>      |
| <p>2009-2015</p> | <p>“Усны тухай”, “Газрын тухай” зэрэг хуулиудын хүрээнд зохицуулж байгаа хэдий ч зарим маргаантай асуудал байсаар байна. Энэ тохиолдолд орон нутгийн засаг захиргааны байгууллага дараах үйл ажиллагааг явуулах шаардлагатай:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Услалтын системийн барилга байгууламж, суваг шуудуу хоолой, тоног төхөөрөмжийн өмчлөгч, эзэмшигчтэй гэрээ байгуулж, түүний хэрэгжилтэнд байнгын хяналт тавих</li> <li>2. Усаар үйлчилсний хөлсийг тогтоож мөрдүүлэх</li> <li>3. Услалтын системийн ашиглалтын байдалд хяналт тавьж, усыг үргүй зарцуулах, газрын хөрсийг угаах, давсжуулах, намагжуулах явдал гаргуулахгүй байхад анхаарах</li> </ol> | <p>Хууль эрх зүйн хүрээнд</p>                             |
| <p>2009-2015</p> | <p>4. Услалтын системийн барилга байгууламж, суваг шуудуу хоолой, тоног төхөөрөмжийн өмчлөгч, эзэмшигч, тариалангийн талбайн эзэмшигч нарын хооронд үйлчлэх нийтийн гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих шаардлагатай байна.</p> <p>5. Услалтын системийн барилга байгууламж, суваг шуудуу /хоолой/, тоног төхөөрөмжийн өмчлөгч, эзэмшигч нь тариалангийн талбайн эзэмшигчид шаардлагатай усыг зохих хугацаанд нь хангах үүрэгтэй бөгөөд үүний тулд услалтын системийг байнгын хэвийн ажиллагаатай байлгах хэрэгтэй. Одоогоор услалтын системийн талбайг усаар үйлчилсний зардал нэг га талбайд 20000-40000 төгрөг байна.</p>   | <p>Услалтын истемийн ашиглалтыг сайжруулах</p>            |

|                  |  |  |
|------------------|--|--|
| <p>2009-2015</p> | <p>1. Бүс нутгийн усны нөөцийг ашиглаж, усалгаатай тариалан эрхлэхийн тулд услалтын системийг шинээр барих, сэргээн засварлах шаардлагатай юм. Үүний тулд төрийн захиалгаар хөрс, ус зүйн хайгуул судалгааны ажлыг цаг алдалгүй хийж, зураг төслийг боловсруулах хэрэгтэй. Энэ ажилд нилээд хөрөнгө шаардлагатай бөгөөд юуны өмнө газар тариалангийн боломжит бүс болох Ховд, Хангилцаг, Баруунтурууны голын савд хайгуул судалгаа хийж үр тариа тарих боломжийг судлах хэрэгтэй. Мөн цас борооны ус буюу голуудын илүүдэл урсацын цуглуулж хадлангийн талбай, газар тариаланд ашиглах боломжийн хайгуул судалгаа хийх хэрэгтэй .</p> <p>2. Хайгуул, зураг төсөл хийгдэж нэгэнт баригдсан, эвдрэл, элэгдэлд орж тоногдож ашиглалтгүй байгаа услалтын системүүдийг сэргээн засварлах, технологийн шинэчлэл хийх, техникийн хүчин чадалд хүртэл ашиглахад дэмжлэг үзүүлэх зорилгоор жилд Улсын төсвөөс дунджаар /урьдах жилүүдтэй харьцуулахад/ 400.0-500.0 сая төгрөг шаардагдана.</p> <p>3. Газар тариалангийн талбайг үерийн ус бусад байгалийн аюулаас хамгаалах арга хэмжээг авах, байгалийн хадлангийн талбайг урт хугацаагаар эзэмшүүлэх, ашиглуулах, түүнийг бордож услах замаар ургацыг нэмэгдүүлэхэд анхаарч хадлан бэлтгэлийг 25-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх, 2015 он хүртэл шинээр баригдах болон сэргээн засварлах услалтын системүүдийн жагсаалт гаргах хэрэгтэй.</p> | <p>Услалтын системийг сэргээн засварлах, шинээр барих</p>  |
| <p>2009-2015</p> | <p>1. Гол мөрөн, нуурын усыг ашиглахдаа экологит нөлөөлөхгүйгээр авч ашиглах, энэ талын тооцоог шинжлэх ухааны үндэстэй тооцоонд түшиглэж байх талаар анхаарч ажиллах</p> <p>2. Голмөрөн, нуурын усыг бохирдохоос хамгаалахын тулд түүнд хаягдаж байгаа бохир усанд байнгын хяналт тавьж зөвшөөрөгдөх нормоос давсан бохирдолтой усыг нийлүүлэхгүй байх</p> <p>3. Усны хомсдол, гол мөрөн, булаг шанд хатаж ширгэхээс хамгаалахын тулд ашиглалтын нөөцийн хязгаарыг тухайн төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгэр тогтоож, тогтоосон норм, хязгаараас илүү ус ашиглахгүй байхад хяналт тавьж ажиллах</p>   | <p>Гадаргын усны ашиглалт хамгаалалт</p>                   |
| <p>2009-2015</p> | <p>4. Усны нөөцийн хомсдолыг байгаль цаг уурын өөрчлөлт, уур амьсгалын нөлөөлөл, аж ахуйн үйл ажиллагааны хэмжээнээс хамаарч голын уснаас авч ашиглах зөвшөөрөгдөх хэмжээ, экологийн урсацыг тогтоогоогүй аливаа төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх тал дээр бүс, орон нутаг өөрийн ажлыг гол үзүүлэлт болгон ажиллах</p>   | <p>Усны нөөцийг хамгаалах экологи, эдийн засгийн үндэс</p> |
| <p>2009-2015</p> | <p>1. Төв суурин газрын хатуу хог хаягдлыг булж булчлах нэгдсэн цэгтэй болгон, хур борооны усаар туугдан, гол усны эх үүсвэрт орохоос хамгаалах арга хэмжээ авах</p> <p>2. Хөдөөгийн төв суурин газрын хүн амын усан хангамжийн худгуудад эрүүл ахуйн болон хамгаалалтын бүс тогтоож, хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөх.</p> <p>3. Худгийг усны найрлагаас хамааруулан ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмжийг зөв сонгон суурилуулах, хөрөнгө оруулалтыг 2-3 дахин нэмэгдүүлэх</p> <p>4. Орон нутгийн болон гаднын төслийн хөрөнгөөр булаг шанд, усны эх үүсвэрийг хайс хамгаалалттай болгох ажлыг эрчимжүүлэх</p> <p>5. Голын экосистемийг тэнцвэртэй байлгахын тулд тухайн голын ай савын зөвлөлийг байгуулж ажиллах</p>  | <p>Ус хамгаалалтын бүс</p>                                 |

|                  |  |  |
|------------------|--|--|
| <p>2009-2015</p> | <p>1. Ашиглагдаагүй байгаа өндөр уулын бүсийн бэлчээрийг ашиглахын тулд цасны болон хур борооны үерийн усыг хуримтлуулах, хөв, цөөрөм барих, хайгуул судалгааны ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж шинэ уст цэг гаргах ажлыг эрчимжүүлэх.</p> <p>2. Бэлчээр усжуулалтын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Малчдыг сургалтанд хамруулах</li> <li>- Булаг шандыг тохижуулах</li> <li>- Өвлийн цагт мөс, цас нөөцлөх аргын талаар сургалт зохион байгуулах</li> <li>- Мөн бэлчээрийн менежментийг зөв зохион байгуулах талаарх сургалт явуулах</li> <li>- Бүс нутагт газрын доорхи усны эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэн, хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх</li> <li>- Улсын төсвөөс болон хувийн хэвшлийн хөрөнгөөр гаргах уст цэг /худаг/-ийн тоо хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.</li> </ul>   | <p>Бэлчээр усжуулалтын төлөвлөлт</p>                             |
| <p>2009-2015</p> | <p>Монгол орны гадаргын усны нөөцийг нэмэгдүүлж өндөр уулын бэлчээрийг ашиглах, тогтвортой өндөр ургац авах нөхцөл нь гидрогеологийн хүндрэлтэй нөхцөлд байгаа бэлчээр ашиглах, усалгаатай тариаланд тохиромжтой талбайг түшиглүүлэн ус хуримтлуулах усан сангийн боомт, бороо цасны үерийн ус хуримтлуулах хөв, цөөрөм барьж байгуулах ажил юм</p> <p>Хөв цөөрөм байгуулах ажил нь хөрөнгө оруулалт бага, тухайн улиралд усыг ашиглах зориулалттай учир орон нутгийн аргаар хийх боломжтой боловч, гидротехникийн иж бүрэн судалгаа хийгдэхгүй байгаагаас борооны үерт угаагдах, далан сэтрэх зэрэг эрсдэл гарч байгааг анхаарах нь зүйтэй. Хөв байгуулах ажлыг эхлэхийн өмнө судалгаа хийж техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах зайлшгүй шаардлагатай. Иймд 2009-2010 онуудад хайгуул судалгаа, зураг төслийн ажлуудыг хийж, 2010-2015 онд хөв, цөөрөм барьж гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэхээр төлөвлөв. Төсөл хэрэгжиж байгаа нутаг нь өндөр уулын бүсэд ашиглагдаагүй бэлчээрийг ашиглах зорилгоор хөв, цөөрөм байгуулах тохиромжтой газрыг сонгон хөв цөөрөм барьж болох газрууд:</p> | <p>Гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх төлөвлөлт</p>               |
|                  | <p><i>Баян-Өлгий аймаг Сагсай, Бугат, Алтай, Цэнгэл, Улаанхус сумд Говь-Алтай аймаг Тонхил, Дарви, Төгрөг, Бигэр, Дэлгэр сум Завхан аймаг Эрдэнэхайрхан, Цэцэн-Уул, Сонгино, Сантмаргац сум Увс аймаг Малчин, Хяргас, Тариалан, Цагаанхайрхан, Наранбулаг сум Ховд аймаг Мөст, Мөнххайрхан, Манхан, Цэцэг, Чандмань сумын нутаг Алтай нурууны уулсын ар хажуу газрыг сонгох нь зүйтэй</i></p>  |  |
|                  | <p>Олон жилийн тохируулгатай усан сан, боомтын хайгуул судалгаа, зураг төслийн ажлыг 1.0 сая м<sup>3</sup>–ээс их багтаамжтай байх створуудыг сонгож, Хангилцагийн гол, Ховдын гол, Буянт, Бөхмөрөнгийн гол, Богд, Чигэстэйн голуудад урьд сонгосон створуудыг түшиглэн хийнэ.</p>   |  |
| <p>1.4</p>       | <p><b>ТҮЛШ ДУЛААНЫ ХАНГАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ</b></p>  |  |
| <p>2009-2015</p> | <p>1. Увс, Ховд, Завхан, Говь-Алтайн нутаг, Алтайн ар өврийн их хөндий, хотгорт нефть, шатдаг хий агуулж болох нүүрс, шатдаг занар, давс, хужир зэргийн орд, илрэл цөөнгүй байдаг ба нефть, хийн агаараас хийсэн тандан судалгаа явуулах, хайгуул судалгаа нарийвчлан хийх</p> <p>2. Баруун бүсийн аймгуудын нутаг дэвсгэрийн 30 гаруй хувь нь</p>   | <p>Түлш дулааны хангамжийн төлөвлөлт-хэрэгжүүлэх арга хэмжээ</p> |

|                   |  |   |
|-------------------|--|---|
|                   | <p>1:50000 масштабтай геологийн зураглал хийсэн учир үлдэх хэсэг нь ямар эрдэс байгааг тодорхойлохын тулд нэн тэргүүнд 1:50000 масштабын зураглал, геофизикийн ажлыг гүйцэтгэх</p> <p>3. Монгол орны хөгжлийн стратегийн тулгуур бичиг баримт болох “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-д тусгагдсан зорилтуудын хүрээнд бүс нутгийн түлшний хөгжлийн бодлогыг шинэ төслөөр нэмж тусгах шаардлагатай бөгөөд эдийн засгийн бүсчлэлд нүүрсний аж үйлдвэрийн хөгжлийн стратегийг тодорхойлохдоо бүс нутгийн хүн ам, экологийн өвөрмөц онцлог, бүсийн доторхи болон бүс хоорондын гео эдийн засгийн орон зайн талаас нь иж бүрэн судалгаа явуулах</p> <p>4. Сайн чанарын нүүрсний асар их нөөц бүхий баруун бүс нутагт нүүрсний нөөц хэмнэх, хаягдлыг багасгаж, байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн өндөр үр ашигтайгаар хөрш орнуудын зах зээлд оролцох чадамж бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар дахин сэргээгдэхгүй байгалийн энэхүү баялагийг аль болох хаягдал багатай иж бүрэн ашиглах экотехнологийн зорилтуудыг хэрэгжүүлэх, тухайлбал Хархираа, Монгол Алтай, Алтайн чандахь болон Өмнөт Хангайн нүүрсний сав газруудын судалгааны ажлыг нарийвчлан хийж тэдгээрийг түшиглэсэн нүүрс боловсруулах нүүрсхими, коксхимийн томоохон аж үйлдвэрийн цогцолборуудыг барьж дотоодын хэрэгцээг хангахаас гадна экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг бүрдүүлэх</p> <p>5. Баруун бүс нутагт орших нүүрсний давхаргад шингэх байдлаар хуримтлагдсан метан хийг судалж, нөөцийг тогтоох, улмаар ахуйн болон аж үйлдвэр, үйлчилгээ, авто тээврийн хэрэгслийг экологийн цэвэр эрчим хүчний түлш болгон ашиглах үндэсний хийн томоохон үйлдвэр барих нөөц боломжийг судлах</p> <p>6. Баруун бүс нутагт шинээр баригдах Цахилгаан станц нь нүүрсний метан хийн түлш хэрэглэхээр төлөвлөсөн. Өөрөөр хэлбэл экологийн хувьд цэвэр, эрчим хүч үйлдвэрлэх бодит боломж тус бүсэд бүрдүүлнэ.</p> <p>7. Төв суурин газруудын дулааны эх үүсвэрийн зуухнуудыг коксын болон нүүрсний метан хийнд шилжүүлснээр агаарын бохирдолыг бууруулж эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.</p> |   |
| <p><b>1.5</b></p> | <p><b>АВТО ЗАМЫН ТӨЛӨВЛӨЛТ</b></p>   |   |
|                   | <p>Баруун бүсийн дэд бүтэц, түүний дотор зам тээврийг хөгжүүлэхэд юуны урд доорхи хүчин зүйлсийг харгалзах шаардлагатай болно. Үүнд:</p> <p>1. Бүс нутаг, аймгуудын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг Увсын Хар тарвагатай, Нүүрст хотгор, Хүдэн, Ховдын хөшөөт, Олон булаг, Говь-Алтайн Хүрэн гол, Зээгт, Мааньт зэрэг нүүрсний томоохон ордын ашиглалтыг нэмэгдүүлэх</p>  |   |
| <p>2009-2015</p>  | <p>2. Говь-Алтайн Тайшир Цээлийн төмөр, Хан Тайширын хром, Цагаан оломын фосфорит, Алаг уулын хөнгөн цагаан, Цагаан голын толигор, лиственит, Бугатайн Хөвчийн нурууны зэсийн хайгуулыг хийх шаардлагатай.</p> <p>3. Баруун бүсийг амжилттай хөгжүүлэх, ялангуяа барилга, замын үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэхэд уг бүс дэх аймгуудын барилгын материалын үйлдвэрүүдийг сэргээх, өргөтгөх, зарим үйлдвэрийг шинээр байгуулах арга хэмжээг авах.</p>  | <p>Автозамын төлөвлөлтийг хэрэгжүүлэх суурь арга хэмжээ</p> |

|                                      |   |  |
|--------------------------------------|---|--|
| <p><b>Төлөвлөлтийн хугацаанд</b></p> | <ol style="list-style-type: none"> <li>1. Баянхонгор аймгийн баруун хил – Дэлгэр - Алтай хот – Ээвийн буудал – Ховдын Дарви – Манхан – Ховд / 615 /</li> <li>2. Ховд хот – Толбо сум – Өлгий хот – Цагааннуур – Улаанбайшинт / 300 /</li> <li>3. Бургастай – Алтай хот – Улиастай хот – Халзан согоотын даваа (Завхан, Хөвсгөлийн хил) / 791 /</li> <li>4. Ховдын Ярантай – Булган - Үенч - Баянзүрх – Мөнххайрхан – Манхан – Ховд /360/</li> <li>5. Ховд – Буянт – Мянгад – Өлгий – Улаангом – Түргэн – Сагил – Боршоо – Хандгайт /409/</li> <li>6. Бургастай – Алтай хот – Улиастай хот – Яруу – Түдэвтэй – Баянхайрхан – Тэс – Арц суурь /918/</li> <li>7. Хөвсгөл, Завханы хил – Завханы Тэс – Баруунтуруун – Зүүнговь – Улаангом – Түргэн - Үүрэг нуур – Бөхмөрөн – Цагааннуур – Улаанбайшинт /670/</li> <li>8. Архангайн Цахир – Солонготын даваа – Зарт бригад – Тосонцэнгэл - Тэлмэн сум – Сагастайн даваа – Улиастай /308/</li> <li>9. Даян – Улаан хус – Цагааннуур – Улаанбайшинт /205/</li> </ol> | <p>Баруун бүсийн хатуу хучилттай болгох улсын чанартай автозамын төлөвлөлт</p>             |
| <p><b>2016-2021</b></p>              | <ol style="list-style-type: none"> <li>1. Баянхонгортой одооны Баянхонгор Алтай чиглэлийн авто замаар</li> <li>2. Баянхонгортой одооны Отгон сум – Улиастай чиглэлийн авто замаар</li> <li>3. Архангайтай Завханы Отгон – Баянхонгорын Баянбулаг – Архангайн Эгийн даваа – Чулуут – Их тамир – Цэцэрлэг чиглэлийн авто замаар</li> <li>4. Архангайтай Улиастай – Идэрийн хойд тал – Тээл – Нам даваа – Солонготын даваа – Тариат – Батцэнгэл – Цэцэрлэг чиглэлийн авто замаар</li> <li>5. Баруун бүсийн хойд талын авто зам нь Хөвсгөлийн Цэцэрлэг – Завханы Баян тэс – Тэс – Увсын Баруун туруун – Зүүнговь – Тэс – Малчин сумдын нутаг – Улаангом – Үүрэг нуур – Бөхмөрөн – Цагаан нуур чиглэлээр үргэлжлэх</li> </ol>  | <p>Баруун бүсийг төвийн бүстэй доорхи чиглэлийн авто замаар холбохоор төлөвлөж байна</p>   |
|                                      | <ol style="list-style-type: none"> <li>6. Увс, Завхан нь Улаангом – Наранбулаг – Хяргас нуурын хөвөө /Айраг нуурын хоолой/ - Завханы Ургамал – Завханы Мандал – Эрдэнэхайрхан – Яруу чиглэлээр голлон харилцдаг. Харин зарим эрдсийг ашиглах, аялал жуулчлал хөгжүүлэх зорилгоор зарим хэсгийг нь засч сайжруулах арга хэмжээ авах.</li> <li>7. Ирээдүйд Олон нуурын зүүн бие, Хомын талд баруун бүсийн чанартай томоохон хот байгуулахад хүрвэл түүнийг баруун таван аймагтай холбох шинэ авто зам, аэродром байгуулах.</li> </ol>   |  |
| <p><b>2009-2015</b></p>              | <ol style="list-style-type: none"> <li>8. Улаанбаатараас Баян-Өлгийн Цагаан нуур буюу баруун хил хүрдэг авто замыг Баянхонгороос цааш хуучин чиглэлийн дагуу засмал зам болгох</li> <li>9. Ховдын Булганыг – Ховдтой, улмаар Ховдыг Увстай холбосон засмал замыг гүйцээж барих.</li> <li>10. Хөвсгөлийн Мөрөн – Бүрэнтогтох – Цагаан уул – Цэцэрлэг – Завханы Тэс – Увсын Баруун туруун – Зүүн говь – Улаангом – Үүрэг нуур – Бөх мөрөн – Цагаан нуурыг холбосон засмал замыг цаашид тавих</li> </ol>   | <p>Баруун бүс нутагт ирээдүйд тавигдаж болзошгүй төмөр замын зэрэгцээгээр доорх засмал</p> |

|                               |   |  |
|-------------------------------|---|--|
|                               | <p>11. Баян-Өлгийн Алтай сумын Даянгийн боомтыг Төв Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд холбох засмал замыг барих.</p> <p>12. Өлгийг Хотгор, Хар Тарвагатайн нүүрсний уурхайтай, мөн Улаангомыг дээрх 2 уурхайтай холбосон замыг хэт нь барих</p> <p>13. Тэлмэн – Цэцэрлэг – Цагаан уул – Бүрэнтогтох – Мөрөнг уламжлалт чиглэлээр холбох замыг цаашид тавих. Энэ замаас салаалуулж Идэр – Тосонцэнгэл – Их уул – Солонготын давааны чиглэлд зам барих</p> <p>14. Архангайн Их Тамираас Баянхонгорын баруун тал, Завханы урд тал, Говь-Алтай руу орох замыг Чулуут сум, Эгийн давааны чиглэлээр, мөн Хангай сумын урд Тэрхийн эх Шар усны давааны чиглэлээр засаж сайжруулах</p> | <p>болон сайжруулсан авто зам тавигдах шаардлагатай болно.</p> |
| <b>1.6</b>                    | <b>ТӨМӨР ЗАМЫН ТӨЛӨВЛӨЛТ</b>  |  |
| <b>Төлөвлөлтийн хугацаанд</b> | 1. Бургастай-Ац суурийн чиглэлийн төмөр замын зураг хайгуул, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг 2009-2015 онд гүйцэтгэнэ.   | 2009-2015  |
|                               | 2. Төмөр замыг барьж байгуулах ажлыг 2016-2021 онд замыг барьж эхлэнэ.  | 2016-2021  |
|                               | 3. Баянхонгор-Цагаан нуурын дамжлага баазын чиглэлийн төмөр замыг ЗТАЖЯам төсөллөсөн байна  | 963,5 км   |
|                               | 4. Баруун бүсийн хөгжлийн төслийн төсөллөж төлөвлөсөн хамгийн ойр дөтөөр Тува, Казак, ОХУ-Монгол-Хятад улсуудыг холбосон босоо тэнхлэгийн зам байх болно.   | 652,5 км   |
| <b>1.7</b>                    | <b>АГААРЫН ЗАМЫН ТӨЛӨВЛӨЛТ</b>  |  |
| <b>2009-2015</b>              | 1. Баруун бүс нутаг нь гадаадын жуулчдыг цаашид ОХУ, БНХАУ, Казах улсаар дамжуулан шууд хүлээж авах боломжтой болох учир тэндээс ОХУ, БНХАУ-уруу шууд нислэг үйлдэх арга хэмжээг авах хэрэгтэй. Үүний тулд юуны өмнө Ховдод жуулчдад үйлчлэх шинэ томоохон цогцолборыг шаардлагат зочид буудал , нисэх онгоц , нисдэг тэрэг, автопарк, онгоц ,завь, чарга зэрэгтэйгээр зохион байгуулах арга хэмжээг авах нь зүйтэй. Энэ бүс байгалийн аялал загас агнуурын чиглэлээр жуулчлалыг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх нь зүйтэй.   | Агаарын замын төлөвлөлт  |
|                               | 2. Баруун бүс нь газар нутаг ,ус,эрдэс баялаг ихтэй, хүн мал олонтой, үр тариа, төмс, хүнсний ногоо ,чацаргана, жимс зэргийг тариалах боломжтой учир баруун бүсэд таван аймаг дундын томоохон төв буюу баруун бүсийн нийслэл хотыг байгуулах явдал чухал байж болох юм. Уг хот нь баруун таван аймгийн дунд ус , түлшиндээ ойр , цаашид өргөжин хөгжих талбай , хөрс сайтай байгалийн хувьд үзэсгэлэнтэй , бартаа саад багатай , нисэх онгоцны том буудал байгуулах ,авто болон төмөр зам тавихад хямд төсөр , аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой байвал зохино.  |  |
| <b>2016-2021</b>              | 1. Баруун бүс нутгийн ирээдүйн хөгжлийн төв Сутай хот болон Баян-Өлгий аймгийн Цагааннуур суманд, Говь-Алтай аймгийн Алтай суманд шинээр Нисэх онгоцны буудал төлөвлөж байгаа бөгөөд баруун бүс нутгийн ирээдүйн аялал, жуулчлал, гадаад харилцаа, зорчигч тээврийн голлох ач холбогдол бүхий өртөөнүүд байх болно.   | Шинэ нисэх онгоцны буудал төлөвлөлт                            |
| <b>2</b>                      | <b>ҮЙЛДВЭР , ХӨДӨӨ АЖ АХУЙН ХӨГЖИЛ</b>  |  |
| <b>2.1</b>                    | <b>БАРУУН БҮС НУТГИЙН ЗЭСИЙН БҮЛЭГ ОРД ИЛРЭЛҮҮДИЙН ЭРЭЛ ХАЙГУУЛЫН ТӨЛӨВЛӨЛТ</b>   |  |



|                         |  |  |
|-------------------------|--|--|
| 2009-2015               | <p>2009-2015 онд нөөцийн хайгуул судалгаа хийх зэсийн бүлэг ордуудын эрэл хайгуулыг I<sub>2</sub> талбайд болох Цэнгэл хайрхан, Саяр уул, Бүргэдэй хайрхан уул, Мөнх хайрхан нь Алтайн нурууны бүлэг орд, Хан тайшир, Сэрх уул, Бурхайн буудай уул, Жинай уулын Гичгэний нурууны бүлэг ордуудын эхний үе шатанд хийх нь зүйтэй. Эрэл хайгуулын ажлыг 1:25000, 1:10000-ны зураглалаар баталгаажуулж, геофизикийн судалгаа хийх, турших газруудад ерөмдлөг хийх явдал чухал байна.</p>   | <p>Баруун бүс нутагт нөөцийн 168 орд, 1260 илрэл байгаа юм. 2008 оны байдлаар баруун бүсэд олгогдсон хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлийн хэмжээ нийт нутаг дэвсгэрийн 73 хувьд хүрсэн байна. Энэ бол бүс нутгийн ашигт малтмалыг ухаж сэндийчих, байгаль орчныг сүйтгэх, цөлжүүлэх аюулд хүргэж болохоор байна. Иймд цаашдын эрэл хайгуул, ашиглалтын төлөвлөлтийг үндэслэлтэй боловсруулах шаардлагатай.</p> |
| 2016-2021               | <p>2016-2021 онд нөөцийн хайгуул судалгаа хийх зэсийн бүлэг ордуудын эрэл хайгуулыг II талбай болох Баатар хайрхан, Сутай хайрхан, Бүс хайрханы Монгол Алтайн бүлэг ордууд, Аж богд, Таянгийн нурууны Алтайн цаадах говийн Монгол Алтайн нурууны салбар уулс, Эдрэнгийн нуруу, Алтас богд, Алтайн өвөр говийн зэсийн бүлэг ордуудын эрэл хайгуулыг 2-дугаар шатанд гүйцэтгэхээр төлөвлөв.</p> <p>Ховд, Баян-Өлгий аймгуудад Цагааннуур, Алтай, Мөнххайрхан, Завхан аймагт Дөрвөлжин, Улаагчны гол, Говь-Алтай аймагт Цээл, Ээж хайрханы өмнө талын Говь, Увс аймгийн Хангайн орд зэрэг газруудад зэсийн нөөц тогтоох хайгуул хийнэ.</p>  |  |
| Төлөвлөлтөөс оноос хойш | <p>Төлөвлөлтийнн хугацаанаас цааш буюу 2021 оноос хойш, III, IV гэсэн 2 үндсэн үе шатаар Цагаан шувуут, Баарам уул, Үүрэг нуурын орчны, Завхан аймгийн Их уул, Тосонцэнгэл сумын нутаг болон Булнай нурууны орчны, Ховд аймгийн Бодонч, Үенчийн Хавцал орчны Бумбай хайрханы орчны, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын Цэнгэл хайрханы өвөр биеийн, Сийлэмхийн нурууны, өвөр биеийн Увс аймгийн Алтан хөхий уулын орчны, Завхан аймгийн Их буурал, Бага буурал уулын орчны, Улиастайгаас хойш Улаангомын гол цэгний, Дөрвөлжин сумын нутагт Завханы гол цэгний газруудад хайгуул судалгааны ажлыг явуулахаар төлөвлөв. Баруун бүсэд металлурги зэсийн баяжмалын үйлдвэрийг (түлш усны нөөц сайтай) шинээр төлөвлөж байгаа Сутай хотод байгуулах нь зүйтэй. Мөн газар зүйн байрлалынхаа хувьд ч гэсэн тээвэрлэх үйл ажиллагаанд хүндрэл гарахгүй бүс нутгийн төв цэг юм.</p>                      |  |
| 2.2                     | <p align="center"><b>БАРУУН БҮС НУТГИЙН НҮҮРСНИЙ ОРД, ИЛРЭЛҮҮД, БУСАД ЭРДСҮҮДИЙН НАРИЙВЧИЛСАН НӨӨЦИЙН ЭРЭЛ ХАЙГУУЛЫН ТӨЛӨВЛӨЛТ</b></p>   |  |
| 2009-2015               | <ol style="list-style-type: none"> <li>2009-2015 онд Увс аймгийн Байрам уул, Түргэн уул, Хархираагийн талбайд, Ховд аймгийн Бумбат хайрхан уул, Баатар хайрхан уул, Сутай уулын талбайд, Говь-Алтай аймгийн Гичгэний нуруу, Хар аргалант, Баянцагаан, Их богд уул, нууруудын хөндийн хотос газрын нүүрсний хайгуул судалгааг хийх томоохон уурхайнуудын нөөцийг тогтоож дотоодын хэрэгцээг хангаж шахмал түлш, кокс химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гадаадад худалдах боломжтой.</li> <li>Мөн Увс аймгийн Хархираа уул, Алтанхөхий уулын хөндийд Их нууруудын хотгор, Хяргас нуурын хөндийд агуулагдаж байгаа сайн чанарын хүрэн нүүрсний талбайн эрлийг хийж цаашид нарийвчилсан хайгуул хийх шаардлагатай.</li> <li>1960-аад онд эрлийн ажлыг хийж байсан Орос-Монголын экспедиц Завхан аймгийн Тэлмэн нуурын орчимд нефть болон нүүрс байж болох үндэслэл байгааг тогтоосон байдаг.</li> </ol> |  |

|                            |   |  |
|----------------------------|---|--|
|                            | <p>Энд эрэл хайгуул судалгаа хийж Завхан аймгийн баруун болон хойд талын сумуудыг нүүрсээр хангах арга хэмжээг авах.</p> <p>4. Ховдын Мянгадын нүүрсний ордын нөөцин хайгуул хийж ашиглах</p>   |  |
| 2016-2021                  | <p>1. 2016-2021 онд Говь-Алтай аймгийн бүс Хайрхан, Таянгийн нуруу, Аж богд, Ээж хайрхан, Эдрэнгийн нуруу, Шаргын говийн хөндийнүүдэд агуулагдаж байгаа, чулуун нүүрс, хүрэн нүүрс, хүлэр, шатдаг занарын нөөцийг тогтоох эрэл хайгуулын ажлыг хийхээр төлөвлөж байна.</p>  |  |
| төлөвлөлтөөс<br>оноос цааш | <p>1. Төлөвлөлтийн хугацаанаас цааш Таянгийн нуруу, Мэргэн уул, Аж богдын өмнөд хоолой, Алтайн өвөр говийг хамарсан өргөн хөндий, Говь цөлийн нутагт агуулагдаж байгаа нүүрсний арвин их нөөцийг судлан тогтоох явдал юм. Мөн Ховд аймгийн Дэлүүн, Завхан аймгийн Дөрвөлжин сум, Монгол элс, Завхан голын дагуу Идэрийн голын хөндий дагуу, нүүрсний эрлийн ажлыг хийх шаардлагатай байгаа юм.</p>  |  |
| 2009-2015                  | <p>1. Алтны олборлолтыг нэмэгдүүлэх бүрэн боломж бий. Үүний тулд алтны шороон болон хүдрийн ордын эрэл хайгуулын ажлыг өргөтгөх, нөөцийг нэмэгдүүлэх ажлыг гүйцэтгэж буй лиценз эзэмшигчдийг дэмжих, ялангуяа томоохон үндсэн орд, илрэлүүдийн эрэл хайгуулын ажлыг түргэтгэх талаар анхаарах, Нүхний нурууны алт-холимог металлын, Сум дайрга, Сухайт, Барлаг голын алтны илрэлүүд, Бооржийн мөнгө-холимог металлын орд г.м. хэтийн төлөв сайтай объектуудын хайгуулын ажилд онцгой анхаарч, хөрөнгө оруулагчдад санал болгох, сурталчилах, уул уурхайн үйлдвэр байгуулан ашиглахад тал бүрийн дэмжлэг үзүүлэх,</p> <p>2. Асгатын мөнгөний ордыг түшиглэсэн жилд 350 тн хүдэр олборлон боловсруулах үйлдвэрийг 2009-2010 онд байгуулах ажлыг яаралтай гүйцэтгэж, дэд бүтцийг нь сайжруулан, ашиглалтанд оруулах боломжийг бүрдүүлэх,</p> | <p>Баруун бүсэд уул уурхайн салбарыг хөгжүүлэхийн тулд юуны өмнө зэс, төмөр, алт, алт-холимог металл, мөнгө, мөнгө-холимог металл, гянт болд, газрын ховор</p> |
|                            | <p>3. Одоо ашиглаж буй гянт болдын Цүнхэг, Ховд голын ордууд болон Улаан уулын ордыг ашиглах, олборлолтыг нэмэгдүүлэх,</p> <p>4. Халзанбүргэтэйн газрын ховор элементийн ордын хайгуулын ажлыг гүйцэтгэж, нөөцийг үйлдвэрлэлийн зэргээр тогтоон, олборлолт хийхэд дэмжлэг үзүүлэх,</p> <p>5. Алагийн даваа, Цахир уулын фосфоритын ордыг түшиглэсэн үйлдвэр байгуулж, байгаль орчинд сөрөг нөлөө багатай ашиглах асуудлыг хөрөнгө оруулагч нарт тавьж, шийдвэрлэх,</p> <p>6. Нүүрсний орд газруудыг жигд ашиглах асуудлыг шийдвэрлэж, бүсийн түлш эрчим хүчний нүүрсний хэрэгцээг хангадаг болох.</p> <p>7. Цагаан алт, хромитын орд илрэлийн эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэх, орд, илрэл нээн, ашиглах хэтийн зорилго тавин ажиллах.</p>  | <p>элементийн орд газруудыг ашиглах, энэ чиглэлээр хийх эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэх, дэмжих хэрэгтэй.</p>   |

|                                      |  |   |
|--------------------------------------|--|---|
|                                      | <ol style="list-style-type: none"> <li>1. Завхан аймгийн Завхан гол, Нөмрөг, Тэлмэн, Идэр, Эрдэнэ хайрханд нүүрсний эрэл, хайгуул хийнэ.</li> <li>2. Завхан аймгийн Алдархаан сумын фосфоритын ордын нарийвчилсан хайгуул судалгаа хийж, нөөцийг тогтоох, уул уурхай э үйлдвэрлэл явуулна.</li> <li>3. Баруун бүст металлурги, аж үйлдвэрийн Сутай хотыг байгуулахтай холбогдон алтнаас бусалд стратегийн ашигт малтмал болох зэс, төмөр, газрын ховор элемент, нүүрс, нефтийн нөөцийг тогтоох, 1:10000, 1:25000-ны масштабтай газрын зураг авч, геологи, геофизикийн эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлнэ.</li> <li>4. Говь-Алтай аймгийн Чандманы Зээгт, Төмөртэйн, Хүрэн гол үэрэг нүүрсний уурхайнуудын нөөцийг нэмэгдүүлэх хайгуул хийнэ.</li> <li>5. Говь-Алтайн Шарга суманд газрын тосны, Дэлгэр суманд Ураны хайгуул хийж нөөцийг тогтооно.</li> <li>6. Говь-Алтай аймгийн Алтай сумын нутаг, Алтайн Өвөр говьд газрын тосны эрэл хайгуул хийж, нөөцийг тогтооно.</li> </ol>  |   |
| <p><b>Төлөвлөлтийн хугацаанд</b></p> | <ul style="list-style-type: none"> <li>• Хар Тарвагатай, Нүүрст хотгор, Хөшөөтийн нүүрсний олборлолтыг нэмэгдүүлж зарим хэсгийг БНХАУ руу экспортлох</li> <li>• Асгатын Мөнгөний ордыг эзэмшиж мөнгө тэргүүтэй эрдсийг ОХУ-д экспортлох</li> <li>• Баян-Өлгийн нутаг дахь гянт болдын хайгуул судалгааг өргөтгөн олборлолтыг нэмэгдүүлж ОХУ-д экспортлох</li> <li>• Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтайн нутаг дахь сайн чанарын хайлуур жоншны судалгаа хайгуулыг өргөтгөн үйлдвэрийн аргаар олборлох боломжийг судлах</li> <li>• Говь-Алтайн Тайшир, Цээл, Хасагтхайрхан, Увсын Хан хөхийн, Завханы Богд, Загастай, Баянхонгорын баруун талын төмрийн хүдрийн судалгаа хайгуулыг өрөгтгөж цаашид баруун бүсэд металлургын үйлдвэр байгуулах боломжийг судлах</li> <li>• Увс аймгийн ховор элементийн судалгаа, хайгуулыг өргөтгөн цааш ашиглах боломжийг судлах</li> <li>• Увсын Давст сумын Шүдэн уулын чулуун давсыг үйлдвэрийн аргаар боловсруулан ашиглах</li> <li>• Говь-Алтайн Дарви, Завханы Алдархаан, Баян-Өлгийн Алтай, Буянт, Сагсайн бокситын судалгаа хайгуулыг хийж цаашид ашиглах боломжийг судлах</li> </ul> | <p>Дэлхийн зах зээлд эрэлт, үнэ ихтэй доорх эрдсийг баруун бүс нутгаас хайх, олборлох арга хэмжээг дэс дараатай авах нь зүйтэй.</p> |
|                                      | <ul style="list-style-type: none"> <li>• Говь-Алтайн Цагаан Олом, Завханы Алдархааны фосфоритын судалгаа, хайгуулыг хийж ашиглах</li> </ul>  |   |
| <p><b>2.3</b></p>                    | <p><b>УУЛ УУРХАЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ</b></p>   |   |
| <p><b>Төлөвлөлтийн хугацаанд</b></p> | <ol style="list-style-type: none"> <li>1. Шинээр бий болсон болон хуучин үйлдвэрүүдийн техник, технологийг шинэчлэн уул уурхайн үйлдвэрлэлийн жигд тогтвортой өсөлтийг хангах;</li> <li>2. Говь-Алтайн Талын мэлтэсийн алтны орд газрын геологи хайгуулын ажлыг гүйцэтгэж, ашиглалтад оруулах арга хэмжээ авах,</li> <li>3. Ховд аймгийн Олон булгийн нүүрсний уурхайн төслийн хүчин чадлыг бүрэн эзэмшиж, Булган, Үенч, Алтай сумын нүүрсний хэрэгцээг хангах;</li> <li>4. Завхан аймгийн нүүрсний хэрэгцээг бүрэн хангах зорилгоор геологи хайгуулын ажлыг эрчимжүүлэх;</li> </ol>   | <p>Уул уурхайг хөгжүүлэх төлөвлөлт хийж байгальд</p>  |

|   |   |
|---|---|
| <p>5. Завханы Алдархаан сумын фосфоритын ордод нарийвчилсан хайгуул хийж, ашиглалтын асуудлыг судалж шийдвэрлэх;</p>  | <p>хөнөөлгүй дэд бүтцийг хөгжүүлсний дараа газрын хэвлийг нээх нь зүйтэй юм. Ашигт малтмалын арвин их нөөцтэй Баруун бүсийн хөгжлийн төлөвлөлтийг үндсэн болон бичил бүс, бүлэг орд илрэлүүд, ашигт малтмалын орд газар бүрээр хэсэгчилсэн төлөвлөлт хийж уурхайг ашиглалтанд оруулж байх дараалалтай төлөвлөж байна.</p> |
| <p>6. Бүсийн төв, томоохон хотуудад шингэрүүлсэн шатдаг хийн станц барих замаар эрчим хүчний хангамжийг сайжруулах;</p>   |   |
| <p>7. Агьтхангайн эрдэнэсийн чулууны орд, Алагхайрханы алт, зэс молибдены ордын геологи, хайгуулын ажлыг дуусгаж, олборлох, боловсруулах үйлдвэр байгуулах бэлтгэлийг хангах;</p>   |   |
| <p>8. Ашигт малтмалын эрэл хайгуул, зураглалын ажлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, эхний ээлжинд ашиглах боломжтой эрдэс баялгийн нөөц тогтоох, хэрэглэх шаардлагатай олборлолтын технологид дүгнэлт гаргах олборлох, ажилд тавих ажлыг сайжруулах</p> |   |
| <p>9. Баян-Өлгий аймгийн Асгатын мөнгөний, Улаан-Уулын гяндболдын, Завханы Баян-Айрагийн зэс, алтны, Ховдын Мянгадын халзан бүрэлтэйн ховор металлын ордуудыг ашиглалтанд оруулах</p>   |   |
| <p>10. Шинээр байгуулагдах уул уурхайн үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг хил залгаа орнуудад экспортлоход түлхүү анхаарах</p>   |   |
| <p>11. Ашигт малтмалын ордуудыг ашиглалтанд оруулахад шаардлагатай дэд бүтэц, уурхайн цогцолборыг байгуулах асуудлыг гадаадын шууд хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх арга хэижээ авах</p>  |   |
| <p>12. Ховд, Увс, Баян-Өлгий аймагт барилгын материалын / цемент, тоосго зэрэг / Говь-Алтай, Завхан аймагт магнезит, керамзит, төмөр бетон эдлэхүүний болон өнгөлгөөний чулуу, шохойн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх</p>                                  |   |
| <p>13. Давсны ордуудыг түшиглэн химийн болон бусад төрлийн бүтээгдэхүүн гаргах олборлох болон боловсруулах үйлдвэрүүдийг байгуулан Монгол улсын иоджуулсан хүнсний давсны хэрэглээний 60 хувийг хангах</p>  |   |
| <p>14. Ховд аймгийн нутаг дэвсгэрт нүүрсний нөөц өсгөх хайгуул хийж, нүүрсний уурхай байгуулах</p>  |   |
| <p>15. Баян-Өлгий аймгийн Нүүрст хотгор, Ховдын Хөшөөт, Увсын Хар тарвагатай, Хүдэн, Их мянган, Говь-Алтайн Зээгт, Хүрэн голын нүүрсний уурхай уурхайнуудын нүүрс олборлолтыг нэмэгдүүлж, бүсийн хэрэгцээг хангах, улмаар экспортонд гаргах</p>           |   |
| <p>16. Нүүрсний уурхайнуудыг түшиглэн шахмал түлшний үйлдвэр байгуулах</p>  |   |
| <p>17. Хар тарвагатайн нүүрсний уурхайн дэргэд нүүрсний хийгээр ажиллах жижиг оврын цахилгаан станц барих</p>   |   |
| <p>18. Говь-Алтай, Ховд аймгийн нутаг дэвсгэрт газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлэх</p>   |   |
| <p>19. Баруун бүсийн эрдэс баялгийн нөөцөд тулгуурлан бүсийн эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, салбарын бүтцийг шинэчлэн өөрчлөх мастер төлөвлөгөө боловсруулж</p>  |   |

|                  |   |   |
|------------------|---|---|
| <p>2009-2015</p> | <p>1.Нөөц нь тогтоогдсон ашигт малтмалын томоохон орд газруудыг ашиглалтанд оруулах замаар бүс нутгийн ДНБ-д аж үйлдвэр, уул уурхайн салбарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлнэ.</p> <p>2.Ашигт малтмалын эрэл хайгуул, зураглалын ажил, геофизикийн судалгаа хийх, эхний үе шатанд ашиглах ордуудыг яаралтай тодруулах, алт, зэс, төмөр, нүүрс, нефтьийн хайгуул хийх газруудад 1:25000 -1:50000 ны геологын зураглал хийх</p> <p>3.Ашигт малтмалын ордуудыг ашиглахад шаардлагатай хот суурин, дэд бүтэц, нийгмийн дэд бүтэцийг байгуулж баяжуулах буюу эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.</p> <p>4.Нөөц нь тогтоогдсон Хөшөөт нүүрсний, хар тарвагат, их мянган, зээгт , хүрэн гол, олон булаг, таван нуурын шахмал түлшний үйлдвэр, кокос үйлдвэр, хийн үйлдвэр байгуулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоодын хэрэгцээг хангах, экспортлоно</p> <p>5.Хөшөөт, Таян нуур, Могойн гол зэрэг уурхайг түшиглүүлж ДЦС барих ажлыг эхлүүлэнэ.</p> <p>6.Уул уурхайг түшиглүүлэн хөрөнгө оруулагч нарын дэд бүтэц байгуулах, ордын нөөц тогтоох ажилд дэмжлэг үзүүлэнэ.</p> <p>7.Ховдын ганц мод, Бараан шороот, Манхаг, Халзан Бүргэдэй зэрэг газруудад ашигт малтмалын хайгуул хийх, олборлох</p> <p>8.Бүс нутгийн аж үйлдвэрийн салбарыг боловсруулах аж үйлдвэрийн хувийн жинг нэмэгдүүлэн үйлдвэрийн бүтцийн өөрчлөлт хийнэ.</p> <p>9.Жижиг дунд үйлдвэрийн зориулалтаар импортоор оруулах техник тоног төхөрөмж үндсэн болон туслах материалд гаалийн болон нэмэгдсэн өртөгийн албан татвараас чөлөөлөх эсвэл урт хугацаатай бага хүүтэй зээл олгож санаачлагчдыг хөхүүлэн дэмжинэ.</p> <p>10.Баруун бүсийн “нэг суурин- нэг бүтээгдэхүүн “ зорилтыг хэрэгжүүлэхэд нь засгийн газраас дэмжинэ.</p> <p>11.Ховд, Улиастай, Баян-өлгий аймагт холимог үйлдвэрлэл технологийн парк байгуулна.</p> <p>9.Шудэн уулын давсны ордыг түшиглүүлэн анагаахын чиглэлээр давсыг бэлтгэж гадаадад гаргах бусад давсны ордуудыг түшиглүүлэн иоджуулсан давс үйлдвэрлэнэ.</p> <p>10.Тонхилын гялтгануурын, Есөн булгийн ногоон толгой, Тайширын хром ордыг ашиглан үйлдвэр байгуулна.</p> <p>12.Алтайн өвөр говь, тэлмэн нуур, их нууруудын хотгорт нефтийн эрэл хайгуулын ажлыг гүйцэтгэнэ.</p> <p>13.Говь-Алтай аймгийн Таяннуурын төмөрлөгийн үйлдвэрийг байгуулах</p> | <p>2009-2015 эхний үе шатны төлөвлөлт</p> |
|------------------|---|---|

|  |   |  |
|--|---|--|
| <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">2016-2021</p> | <p>1.Баруун бүс нутагт эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэн олон ордуудад нөөц тогтоох ашиглаж эхлээ, баяжуулах болон металлуудын үйлдвэр, төрөл бүрийн бүтээгдэхүүн металл хицийн үйлдвэрүүд хөгжих болно.<br/>                 2.Завханд Алдархаанд фосфорын ордонь нөөцийн хайгуул хийнэ.<br/>                 3.Говьалтай, Ховд, Увс аймагт цементийн үйлдвэр, Баян-өлгийн аймгийн Астай Говь-алтайн цээл, шинээр байгуулагдах Сутай хотод уулын баяжуулах үйлдвэр, Увсын наран булагт криамикийн болон галд тэсвэртэй тоосго, ваар савны үйлдвэр байгуулна.<br/>                 4.Тоосго үйлдвэрийн болох бүх газруудад ханын материал үйлдвэрлэж төв суурин газрын барилгын яс чанарыг сайжруулна.<br/>                 5.Говь алтайн Таян нуурын төмрийн хүдэр, талын мэлтэцсийн алтны орд, цахиур, хөв булагийн нүүрсний уурхайг ажилд оруулж шахмал түлш хийх, бодлого авна<br/>                 6.Тайшир суманд цементийн үйлдвэр байгуулах, мөн сумын хром, магнитын ордыг түшиглүүлэн галд тэсвэртэй магнитит үйлдвэрлэнэ.</p>   | <p>2016-2021 дараагийн үе шатны төлөвлөлт</p>  |
| <p><b>2.4</b></p>  | <p><b>БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ТӨЛӨВЛӨЛТ</b></p>  |  |
| <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">2016-2021</p> | <ul style="list-style-type: none"> <li>- Ховд аймгийн Буян суманд хүнд бетоны үйлдвэр</li> <li>- Увс аймгийн Зосийн хард шохойн түүхий эд олзворлох, боловсруулах</li> <li>- Увс аймгийн Наранбулаг, Өмнөговь суманд тоосго болон Кирамикийн үйлдвэр</li> <li>- Баян-Өлгий аймгийн Өлгий хотын орчинд хүнд, хөнгөн бетоны үйлдвэр</li> <li>- Баян-Өлгий аймгийн Ямаатын ордыг өнгөлгөөний жижиг хавтанцарын үйлдвэр</li> <li>- Говь-Алтай аймгийн Тайшир суманд хүнд, хөнгөн бетоны үйлдвэр</li> <li>- Завхан аймгийн Алдархаанд технологийн нарийн элсээр өнгөлгөөний шавардлагын хуурай хольцын үйлдвэр зэрэг байж болно.</li> <li>- Бүх аймагт урд нь байгуулсан барилгын материалын үйлдвэрүүдийг сэргээх</li> <li>- Ховдын цементын техник технологийг шинэчилж цаашид хүчин чадлыг нь бүрэн авахуулан өргөтгөх.</li> <li>- Баян-Өлгийн Буянтын будгын үйлдвэрийг сэргээх</li> <li>- Бүх аймагт гант, баргилт, боржин, шохойн чулуу зэрэг зарим чулууг боловсруулж барилгад ашиглах.</li> <li>- Баруун бүс нутагт барилгын төмөр бетон эдлэлээс эхлэн металл эдлэл хийх шаардлага их буйг харгалзан эн тэргүүнд Завхан аймагт төмөрлөгийн бэсрэг үйлдвэр байгуулах арга хэмжээ авах нь зүйтэй.</li> <li>- Говь-Алтай аймгийн Тайшир суманд цементийн үйлдвэр, хром, магнетизийн ордыг түшиглэн галд тэсвэртэй барилгын материалын үйлдвэр, Есөнбулаг, Баян-Уул, Шарга, Бигэр, Эрдэнэ сумдад тоосгоны бага оврын үйлдвэр, өнгөт хавтангийн үйлдвэр</li> </ul> | <p>Барилгын материалын шинээр байгуулах болон сэргээн өргөтгөх боломжтой үйлдвэрүүдийг төлөвлөв.</p> |
| <p><b>2.5</b></p>  | <p><b>ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ</b></p>  |  |
| <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">2009-2015</p> | <p>1. Аймаг, бүс нутгийн зах зээлд баримжаалсан, тэдгээрийн тэлэлт, гүнзгийрэлт, төрөлжилтийг хангахад чиглэгдсэн, аймгуудын газрын дээрх болон доорх нөөц, боломжид суурилсан, үндсэн хэрэгцээг хангах, тодорхой хэмжээгээр импортыг орлох, экспортын баримжаатай хөдөөгийн үйлдвэржүүлэлт нь их төлөв жижиг, дунд үйлдвэрлэл байна.</p>   |  |

|   |  |  |
|---|--|--|
|   | <p>2. Хөдөө орон нутгийн иргэдийн үндсэн хэрэгцээг хангах, мал аж ахуй, газар тариалангийн анхдагч бүтээгдэхүүн, нэмэгдсэн өртөг үйлдвэрлэх чиглэлтэй, өрхийн болон бичил аж ахуй дээр суурилсан “бичил үйлдвэржүүлэлт”.</p> <p>3. Өргөн хэрэгцээний түүний дотор удаан хэрэглээний бүтээгдэхүүн, тодорхой салбаруудын эцсийн бүтээгдэхүүн болон завсрын бүтээгдэхүүн, зарим капитал багтаамж ихтэй бүтээгдэхүүн зэргийн импортыг орлох, импорттой өрсөлдөх үйлдвэржүүлэлт.</p>  |  |
| <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Төлөвлөлтийн хугацаанд</p> | <p>4.Органик хөдөө аж ахуй, цэвэр байгаль орчны хосолсон хөгжил дээр үүссэн, цэвэр бүтээгдэхүүн, мэдээллийн технологийн outsourcing дээр түшиглэсэн экспортын диверсификац, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үе шат бүр дээр суурилсан бүтээгдэхүүний хөгжлийн үндсэн дээр бий болох уламжлалт бус, шинэ бүтээгдэхүүний экспортын баримжаатай үйлдвэржүүлэлт /уламжлалт экспортын зах зээлийн өргөжилт болон өртөг нэмж бүтээх үйл явц зэрэгцэн явагдана/.</p> <p>5.Аялал жуулчлалын сектор дахь нэмэгдсэн өртөг бүтээх үйл явц, үйлчилгээний секторын орчин үеийн технологи дээр суурилсан, энэ секторын улирлын шинж чанарыг хамгийн бага болгоход чиглэгдсэн аялал жуулчлалын үйлдвэржүүлэлт.</p> <p>6.Эрдэс баялгийн салбарын анхдагч бүтээгдэхүүний эцсийн боловсруулалт, стратегийн том ордуудын ашиглалт, био-, нано-, hitech дээр суурилан хөгжих капиталын болон мэдлэгийн багтаамж ихтэй үйлдвэржүүлэлт.</p> <p>7.Гадаадын орнуудад ажиллаж амьдарч байгаа монголчуудынхаа, ялангуяа үйлдвэржүүлэлтийг амжилттай хэрэгжүүлсэн улс орнуудад ажиллаж буй монголчуудынхаа мэдлэг, мэргэжил, туршлага, дадлагыг ашиглах үндсэн дээр тэдэнд зориулсан аж үйлдвэрийн тусгай парк байгуулах замаар хэрэгжүүлж болох үйлдвэржүүлэлт.</p> | <p>Баруун бүсийн аймгуудад үйлдвэржүүлэлтийн бодлого доорх төрөл, чиглэлүүдээр хэрэгжих боломжтой.</p> |
| <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Төлөвлөлтийн хугацаанд</p> | <p>1. Жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалттай импортоор оруулах техник, тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх саналыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>2. Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг жижиг, дунд үйлдвэрийн импортолж байгаа үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн болон туслах материалыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх саналыг Засгийн газарт шийдвэрлүүлэх;</p> <p>3. Бүсийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих “Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан” байгуулж ажиллуулахыг дэмжих ;</p> <p>4. Сангийн яам, Монгол банк, арилжааны банкуудтай хамтран ажиллаж жижиг, дунд үйлдвэрт зориулан бага хүүтэй, урт хугацааны арилжааны зээлийн эх үүсвэрийг бий болгох, нэмж олох арга хэмжээ авах;</p> <p>5. Улсын болон орон нутгийн захиалгаар санхүүжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд жижиг, дунд үйлдвэрийг түлхүү хамруулах бодлого баримтлах;</p> <p>6. Ховд, Улиастай хотод холимог үйлдвэрлэлийн “Ховд”, “Улиастай” үйлдвэрлэл, технологийн парк байгуулах;</p> <p>7. Орон нутгийн туршлагыг харгалзан аймгийн төвүүдэд эсгий, эсгий гутал, ноос угаах төрөлжсөн болон хоршсон үйлдвэрлэлийг өргөтгөн хөгжүүлэх;</p>   | <p>Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл</p>  |

|                   |   |  |
|-------------------|---|--|
|                   | <p>8. Бүсийн тулгуур төв, аймгийн төвд гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, загас,жимс, жимсгэнэ, хүнсний ногоо боловсруулж савлах, Алтайн бренди хөх арвайн гурил үйлдвэрлэх, рашаан, ингэний сүү савлах хүнсний үйлдвэрийг байгуулан ажиллуулах;</p> <p>9. Сүү, сүүн бүтээгдэхүүн гаргах, мах боловсруулах үйлдвэрүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлж, төрөлжүүлэн савласан мах, махан ба сүүн бүтээгдэхүүн экспортлохыг дэмжих;</p> <p>10. Малын арьс, шир, ноос ноолуур зэрэг түүхий эдийг боловсруулж гутал, ауе, нэхий эдлэл, эсгий, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөнгөн үйлдвэрийн салбарын жижиг, дунд үйлдвэрүүдийг бүсийн аймгуудад шинээр байгуулахыг дэмжих;</p> <p>11. Бөөний худалдааны сүлжээг бүх аймагт бий болгон, энэ сүлжээнд хамрагдах сум, аж ахуйн нэгж, иргэдийн тоог нэмэгдүүлэх;</p> <p>12. Худалдаа, үйлчилгээний захуудыг төрөлжүүлж, хүнсний бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан битүү байртай болгон орчныг тохижуулах арга хэмжээ авах;</p> <p>13. Баян-Өлгий Цагааннуурын худалдааны чөлөөт бүсийг нээн ажиллуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>14. Ярант, Хангайтын хилийн боомтыг түшиглэн худалдааны чөлөөт бүс байгуулах;</p> <p>15. Бургастай, Боршоо, Арцсуурь зэрэг хилийн гарц, боомтуудыг материаллаг бааз,мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлж, байнгын ажиллагаатай олон улсын чанартай болгон, хилийн худалдаа, үйлчилгээг шуурхай болгох арга хэмжээ авах;</p>                                    |  |
| <p><b>2.5</b></p> | <p><b>МАЛ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ</b></p>   | <p>Ховд аймгийн жишээгээр</p>  |
|                   | <p>1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн “Айл саахалтын нөхөрлөл”, хоршоо, фермер, компани зэрэг аж ахуйн нэгжийн хэлбэрээр үйл ажиллагаагаа эрхэлдэг болгох</p> <p>2. Хөдөө аж ахуй дахь айл саахалтын нөхөрлөл, хоршоо, фермер, компани бүрийн үйлдвэрлэлд бага чадлын техник, нар, салхи, усны эрчим хүч ашиглах</p> <p>3. Газар тариалангийн үйлдвэрлэлд агро удирдамж боловсруулж мөрдөх</p> <p>4. Рапс, наранцэцэг, шар буурцаг, гичийн үр тарьж, Хүнсний бүтээгдэхүүн том ашиглах үйлдвэрлэлийн арга эзэмших</p> <p>5. Үрийн нутагшсан сорт бий болгож ашиглах, Торгуудын зургаадай арвай, “Ховд 80” тарвасын үрийг сонгомол үрийн зориулалтаар дэлгэрүүлэх</p> <p>6. Булган суманд олсны ургамал тариалдаг уламжлалт туршлагыг сэргээх</p> <p>7. Эрдэнэ шиш, царгас, сибирийн өлөнгийн шинэ сортыг жил бүр 300-гаас доошгүй га-д тариалж, даршлан шүүст тэжээл бэлтгэх</p> <p>8. Малын удмын саг хамгаалах, эрүүлжүүлэх, ашиг шимийг нэмэгдүүлэх цогцолбор арга хэмжээ хэрэгжүүлэх</p> <p>9. Газар тариалангийн хог ургамал, хортон шавьжтай тэмцэх арга технологийг баталгаажуулах</p> <p>10. Мал аж ахуйн хагас суурин, эрчимжсэн буюу цөм, торгон сүрэг зонхилсон аж ахуйг аймаг, сумын төв орчимд зохистой хөгжүүлэх боломж, нөхцөлийг төрөөс анхааран үзэж, дэд бүтцийн сүлжээг ойртуулах, ингэснээр 2020 он гэхэд малчдын 20-оос доошгүй хувь нь хагас суурин, эрчимжсэн аж ахуйн зохион байгуулалтад шилжих</p> | <p>Ховд аймгийн мал аж ахуйг хөгжүүлэхэд ойрын 10-15 жилд тавих зорилт, арга</p> |



|                                      |   |   |
|--------------------------------------|---|---|
|                                      | <p>11. Бэлчээрийг усжуулах асуудалд түлхүү анхаарч, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, хот орчмын бэлчээрийн уст цэгийг төлбөртэй ашиглуулах зэрэг асуудлыг боловсруулж шийдвэрлүүлэх</p> <p>12. 2010 он гэхэд нийт малчин өрхийн 60-аас доошгүй хувийг арвай, тариа, төмс, Хүнсний ногооны болон хадлангийн зохих эзэмшил газартай болгох асуудлыг судалж хэрэгжүүлэх</p> <p>13. Буянтын 600 үнээний фермийн үйл ажиллагааг сэргээж, хотын иргэдийг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангахын тулд банкны зээл, татварын болон хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих</p> <p>14. Гахай, шувуу, зөгий, туулай үржүүлэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санаачлагыг дэмжиж, мэргэжлийн туслалцаа үзүүлэх</p> <p>15. Гадаадын зарим орны туршлагаар сайн дурын мал эмнэлгийн албыг байгуулж, гэрээ байгуулан ажиллах</p> <p>16. Малчдын гар хөдөлмөрийг механикжуулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор өвс хадах морин хадуур, бага оврын трактор, анжис, хадуур, тармуур зэргээр хангах нэгдсэн бодлого явуулах</p> <p>17. Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах замаар хөдөө аж ахуйн тохиолдох эрсдэлийг бууруулах, Хүнсний аюулгүй байдлыг хангах</p> <p>18. Гэнэтийн аюулын үед урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг боловсронгуй болгож ард иргэдэд шуурхай хүргэх</p> <p>19. Хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, даатгалд өргөн хамруулах</p> <p>20. Малчид, тариаланчид, өмчийн олон хэлбэрийн байгууллага, аж ахуйн нэгжээр байгалийн аюулаас урьдчилан сэргийлэх бэлтгэл хангуулах</p> | <p>хэмжээ:</p> <p>Мал аж ахуйн тогтвортой өсөлтийг хангах чиглэлээр:</p>  |
| <p><b>Төлөвлөлтийн хугацаанд</b></p> | <p>1. Байгалын гамшгийн хохирлыг багасгах зорилгоор нөөц сан байгуулж, жил бүр 6 мянган тонн хадлан, 3 мянган тонн малын тэжээлийн ургамал, 1 мянган тонноос доошгүй багсармал тэжээл нөөцлөх</p> <p>2. Байгаль, цаг уурын онц тааламжгүй нөхцөл болон бүх нийтийг хамарсан аюулын үед хэрэглэх хүнс, шатахуун, аж ахуйн хэрэглээний барааны шаардлагатай нөөц бүрдүүлж нөхөн хангалт хийж байх</p> <p>3. Үйлдвэрлэгчдийг төрөл бүрийн сургалтад хамруулах техник, технологи зах зээл, үнийн мэдээллээр хангах</p> <p>Мал аж ахуйн үйлдвэрлэлийн маркетингийн орчин, түүнд нөлөөлөх хүчин зүйлс, зах зээлийн боломж, багтаамж, борлуулалтын</p>   | <p>Ховд аймгийн мал аж ахуйг хөгжүүлэхэд ойрын 10-15 жилд тавих зорилт, арга хэмжээ:</p>  |
| <p><b>Төлөвлөлтийн хугацаанд</b></p> | <p>суваг, зах зээлийг идэвхжүүлэх үйл ажиллагаа, удирдлагын үндсэн функц зэргийг судалж боловсруулах</p> <p>4. Хөдөөгийн малчдад үйлчлэх, зуучлах бөөний худалдааны сүлжээ бий болгох</p> <p>1. Газар ашигласны төлбөр, нөхөн төлбөр ноогдуулах эдийн засгийн оновчтой механизмыг бий болгож, газрын харилцааны асуудлыг шийдвэрлэх, зохицуулах хөшүүрэг бий болгох</p> <p>2. Газрын төлбөр, нөхөн төлбөрийн зохих хувийг тусгай санд төвлөрүүлэн, элэгдэж, эвдэрсэн газар нутгийг нөхөн сэргээж ашиглалтыг нь сайжруулах, байгалийн гамшигтай тэмцэх болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулах</p> <p>3. Малыг нутаг дэвсгэрийн бэлчээрийн даацад тохируулан өсгөх</p>  | <p>Мал аж ахуйд учрах эрсдэлийг багасгах чиглэлээр</p> <p>Ховд аймгийн мал аж ахуйг хөгжүүлэхэд ойрын 10-15 жилд тавих зорилт, арга хэмжээ:</p> <p>Газар,</p> |

|                  |  |  |
|------------------|--|--|
|                  | <p>4. Аймгийн төв орчимд хүн, мал их хэмжээгээр төвлөрснөөс бэлчээр талхлагдан, хөрсний үржил шим муудан, даац хэтэрч байгаад судалгаа хийж, дүгнэлт гарган, илүү нягтшилтай суурьшсан газрын малчдаас өндөр төлбөр авах буюу төлбөрийн ялгавартай бодлого явуулах замаар суурьшлыг зохицуулахад нөлөөлөх</p> <p>5. Эвдэрсэн, тоногдсон уст цэгийг сэргээн засварлаж ус гаргах, тэдгээрийг гэрээний үндсэн дээр нутгийн уугуул иргэдийн дундын өмчлөлд удаан хугацаагаар эзэмшүүлэх арга хэмжээ авч, бэлчээр ашиглалтын хүрээг тэлэх, бэлчээр сэлгэлтийг сайжруулах</p> <p>6. Бэлчээрийг хайрлаж хамгаалдаг, хуваарьтай эзэмшдэг ардын уламжлалт арга туршлагыг судалж дэлгэрүүлэх</p> <p>7. Боллоцотой буюу шаардлагатайг газарт бэлчээрийн зарим хэсгийн хашиж хамгаалан, хадлан тэжээлийн нөөц нэмэгдүүлэх ажлыг малчдын хүч хөрөнгөөр гүйцэтгэх</p> <p>8. Бэлчээрийг малчдад эзэмшүүлэх</p>  | <p>бэлчээрийг зохистой ашиглах чиглэлээр</p>   |
|                  | <p><b>БАРУУН БҮСИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨЛТ</b></p>   |  |
| <p>2009-2015</p> | <p>1. Баруун бүсийн аймгуудын залуучуудыг аялал жуулчлалын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулиудад өргөн элсүүлэх сургуулиа төгссөний дараа ажлын байраар хангах, тогтвор суурьшилтай ажиллахад төв орон нутгийн болон бизнесийн байгууллагууд дэмжлэг туслалцаа үзүүлэх, сургалтын хөтөлбөрт байгалын аялал жуулчлал, хүрээлэн буй орчин, зэрлэг ан амьтан, жугууртэн шувуудыг хамгаалах менежментийн сургалтыг хамруулах,</p> <p>2. Ховд, Улиастай хотуудад аялал жуулчлалын мэдээллийн төвийн дэргэд сургалт, семинар зохион байгуулах, түр сургалтаар салбарын ажиллагсадын мэргэшүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах,</p> <p>3. Баруун бүсийн аялал жуулчлалын холбооны ажлыг эрчимжүүлэх, төвийн болон орон нутгийн төрийн байгууллага, банк санхүү, хөрш хоёр орны жуулчны байгууллагуудтай нягт хамтран ажиллах,</p> <p>4. Мэдээлэл харилцааны хөгжил дэвшлийг Баруун бүсийн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн олон арга хэмжээ, хөтөлбөрүүдийг гадаад, дотоодод өргөн сурталчлах, мэдээлэл солилцох, видео хурал, сургалт зохион байгуулах, олон улсын арга хэмжээнд бүсийн төлөөлөгчдийг аль болох оролцуулах,</p> <p>5. Бүсийн хэмжээнд байгаа тусгай хамгаалалтын газар нутагт байгалын аялал жуулчлал хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулах, ялангуяа Юнескогоос Дэлхийн гайхамшигт үнэт зүйл, Дэлхийн шим мандлын нөөцийн зэрэглэлээр бүртгэж авсан бүс нутгийг гадаадад өргөн сурталчлах замаар байгалын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулах,</p> | <p>Бүс нутгийн хэмжээнд аялал жуулчлалын менежментийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, гадаад, дотоод сурталчилгааг сайжруулах талаар:</p> |

|                               |   |   |
|-------------------------------|---|---|
| <p>2009-2015</p>              | <ul style="list-style-type: none"> <li>• <i>Байгаль, спортын чиглэлийн аялал:</i><br/>Баян-Өлгий аймгийн Толбо нуур, Дэлүүн, Булган сумдын нутаг дэвсгэрт Монгол Алтайн уулс, уулын цэнгэг Толбо нуур, мөстлөгийн ул мөр болсон морен, Чигэртэйн халуун рашаан, үзэсгэлэнт Хөхсэрхийн нурууг үзэхийн зэрэгцээ ууланд авирах, усанд сэлэх, завиар аялах, загас барих, дэлхийд ховордсон ирвэс, аргаль, янгир, суусар, шилүүс, хойлог зэрэг амьтан, шувуу дурандах, байгалын рашаан, казак үндэсний хоолоор үйлчлэх, бүргэдээр ан хийх зэрэг орон нутгийн онцлог олон сэдвээр аялалуудыг зохион байгуулж болно.</li> <li>• <i>Байгаль, Түүх, соёлын дурсгалт газруудтай танилцах аялал :</i><br/>Баян-Өлгий аймгийн Бугат, Алтанцөгц, Баяннуур сумдын нутаг дэвсгэрт Мөнхдөш ууланд эртний сүг зураг, Түрэг бичээстэй хөшөө чулуу, Ховд голын хөндийд нэн ховордож буй алтан гургуул шувууг ажиглах, улсын хамгаалалтанд авсан Цагаан хөшөөт хэмээх газарт Түрэгийн үеийн хөшөөг үзэж сонирхохоос гадна аялал уулын түргэн урсгалт Хатуугийн болон Хавцлын голыг гаталж, алжаалаа тайлж амрах маягаар аялалыг зохион байгуулах</li> </ul>   | <p>Баруун бүсэд аялал жуулчлалын дэд болон үндсэн чиглэлүүдийг тодорхой сэдвүүдээр шинээр боловсруулах, хуучныг боловсронгуй болгох талаар:</p> |
| <p>Төлөвлөлтийн хугацаанд</p> | <ul style="list-style-type: none"> <li>• Бүсийн тулгуур төвүүд болох Ховд, Улиастай хотуудад одоо ажиллаж байгаа зочид буудал, амралт сувилал, зоогийн газрууд, музей, театр, соёлын орднуудыг тохижуулах, аялал жуулчлалын мэдээллийн төвийг шинээр нээж ажиллуулах, тухайн газрын онцлогтой уялдуулан шувуу ажиглах байр, од дурандах, эрвээхэй ажиглах, уулын болон усан спортын, загас агнуурын хэргэслээр хангах үйлчилгээний цэгүүд, ангийн отгуудыг тохижуулах, шинээр байгуулах, томоохон маршрутын дагуу аялагчдын алжаал тайлах газар, дэн буудалыг оновчтой төлөвлөж байгуулах,</li> <li>• Дотоодын аялал жуулчлалын хөгжлийг дэмжих зорилгоор эхний ээлжинд эрэлт хэрэгцээтэй байгаа Ховдын Хар ус нуурын орчмын жуулчны бааз, Увс нуурын ай сав дахь Хархираа амралтын газар, жуулчны төв, Цүнхэгийн амралт, Хяргас нуурын эрэг дээрх Хар тэрмисийн рашаан сувиллын газар, Завханы Отгон тэнгэрийн рашаан сувиллын газар, Говь-Алтайн Бигэрийн бөөрний амралт сувиллын газар, Хүнхэрийн рашаан сувилал, Баян-Өлгий Чихэртийн амралтын газруудыг тохижуулж хүчин чадлыг бүрэн ашиглах, Ховдын Индэртийн рашаан, Завханы Зартын болон Улаан хаалга рашаан сувиллын газрын өргөтгөл, засвар тохижилтыг хийх замаар хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйлчилгээний хугацааг хоёр дахин уртасгах,</li> <li>• Ховдын Хар ус, Увсын Хяргас нуурын бүсэд “Аялал жуулчлалын цогцолбор” барих олон улсын тендер зарлах замаар гадаадын хөрөнгө оруулалтыг татах,</li> <li>• Бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудал, жуулчны баазуудыг улсын зэрэглэлд оруулах, аажмаар олон улсын зэрэглэлд ойртуулах,</li> <li>• Бүсийн хэмжээнд ажиллаж байгаа музейн үзвэрүүдийг шинэчлэх, тохижуулах, гадаад хэл дээр тайлбар танилцуулга гаргах, орон нутгийн онцлогтой бэлэг дурсгалын үйлдвэрлэлийг дэмжих, туслалцаа үзүүлэх,</li> </ul> | <p>Бүсийн аялал жуулчлалын салбарын материаллаг баазыг бэхжүүлэх талаар:</p>  |

|                               |  |  |
|-------------------------------|--|--|
|                               | <ul style="list-style-type: none"> <li>Бүсийн хэмжээнд байгаа тусгай хамгаалалттай газар, хадны сүг зураг, буган хөшөө, хүн чулуу, хэрэгсүүр, бичмэл, эртний улсуудын дурсгалт зүйлүүдийг хамгаалалтыг сайжруулах, орчныг тохижуулах, гадаад, дотоодын жуулчдад зориулсан танилцуулга, зурагт каталог, альбомыг гадаад хэл дээр хэвлэж гаргах,</li> </ul>      |  |
| <b>3</b>                      | <b>БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ ТҮҮНИЙ ТӨЛӨВЛӨЛТ</b>  |  |
| <b>3.1</b>                    | <b>ХӨРС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ</b>  |  |
| <b>Төлөвлөлтийн хугацаанд</b> | - Бэлчээрийн ургамлыг нөхөн сэргээхийн тулд таримал бэлчээр, хадлан бий болгох, дулааны улиралд бог малыг бэлчээрт нь хотлуулж өнжөөх ажлыг хуваарьтай зохион байгуулах;   | Бэлчээрийн хөрсний доройтол, тариалангийн хөрсний элэгдэл ба үржил шимийн алдагдал, элсний нүүдэл, автозамын дагуух хөрсний эвдрэл, ашигт малтмалын олборлолтоос үүссэн ухмал нүх, овоолгон шороо хамгийн түгшүүр төрүүлж байгаль орчин, эдийн засаг, нийгмийн амьдралд үлэмж хор хохирол учруулсаар байна. Цаашид хөрс хамгааллын талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. |
|                               | - Тариалангийн талбайн хагалгааны шан, тариалах зурвасыг салхины голлох чиглэлд хөндлөн байрлуулах, 50 м-ээс өргөнгүй зурвасаар сэлгэн тариалах;   |  |
|                               | - Тарианы гуурсыг талбайд нь өнжөөх, хөрсийг хавж хагалах, хөшиг ургамал тарих, нүцгэн талбайг гуурсаар хучих, цас тогтоох, боломжтой нөхцөлд хаврын цэнэг усалгаа хийх, мод, бут сөөгөн зурвас байгуулах, механик хамгаалалт хийх зэрэг тариалангийн хөрсийг салхинд хийсч эвдрэхээс хамгаалах бүхий л арга ажиллагааг цаг алдалгүй, чанартай гүйцэтгэж байх; |  |
|                               | - Тариалангийн талбайд агрохимийн зураглал хийж, эрдэс ( NPK ) болон органик бордооны тун хэмжээг тогтоож, талбайг агротехнологийн шаардлагын дагуу тогтмол бордож байх, малын өтөг, бууц зэрэг орон нутгийн бордоог өргөнөөр ашиглах;   |  |
|                               | - Эвдэрсэн хөрс, элсжсэн талбайг ургамалжуулах, ногоон бордоо хэрэглэх, органик барьцалдуулагч болон цеолит мэтийн шингээгч бодисоор бордож хөрсний физик шинжийг сайжруулах арга хэмжээ авах;   |  |
|                               | - Автомашины хөдөлгөөнийг цэгцлэх, олон салаа зам гаргуулахгүй байх, хаягдсан хуучин замуудыг сийрэгжүүлж ургамалжуулах ажлыг автозамын байгууллагууд болон олон түмнийг идэвхтэй оролцуулан үр нөлөөтэй зохион байгуулах;   |  |
|                               | - Уул уурхайн ашигласан талбайг засч тэгшлэх, биологийн нөхөн сэргээлт хийж хөрсжүүлэх, ургамалжуулах ажлыг технологийн дагуу заавал гүйцэтгүүлж түүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог өндөржүүлэх;   |  |
|                               | - Хот, төв, суурин газрын хөрсийг зүлэгжүүлэх, мод, бут сөөг тарих, нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн талбайг стандартын шаардлагад хүргэх, ахуйн хог хаягдал болон хөрсний бохирдол үүсгэж болох үйлдвэрийн хаягдал, бохир усыг цэвэрлэх, саармагжуулах, зайлуулах, түүнд тавих эрүүл ахуйн хяналтыг эрс сайжруулах;                                      |  |

|                                      |   |  |
|--------------------------------------|---|--|
|                                      | <p>- Элсний нүүдлээс хамгаалах биологийн болон механик аргыг өргөн нэвтрүүлэх, төв, суурингийн орчимын элстэй газрыг чулуугаар хучих, явган хүний зам, гудамж талбайд байгалийн зассан чулуу шигтгэж тэгшлэх зэрэг хямд төсөр энгийн аргыг түлхүү хэрэглэх;</p> <p>- Усалгаатай тариалангийн усалгааны норм горим, техник технологийг орон нутгийн нөхцөлд тохируулан зөв сонгож, усалгааны нөлөөгөөр хөрс давсжихаас болгоомжлох, усалгаатай талбайн хөрсний шинж чанарын өөрчлөлт, шим тэжээлийн хангамжийг тогтмол хянаж байх;</p> <p>- Газар ашиглалттай холбоотой Монгол улсын (Газрын тухай, 2002-6-7; Газрын төлбөрийн тухай, 1997-4-24; Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, 2002-6-27; Тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн тухай, 1997-10-23; Газрын хэвлийн тухай, 1988-11-29; Ахуйн ба үйлдвэрийн хог хаягдлын тухай, 2003-11-26; гэх мэт) хууль дүрмийг өргөн сурталчлах, түүний хэрэгжилтэд байнга хяналт тавьж зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцож байх журмыг хэвшүүлэх;</p>   |  |
| <p><b>3.2</b></p>                    | <p><b>УСНЫ НӨӨЦ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ</b></p>   |  |
| <p><b>Төлөвлөлтийн хугацаанд</b></p> | <p>1. Хот, төв, суурин газар, уул уурхай, эрчим хүч, усалгаатай тариалангийн салбарт усны нөөцийн нөхөн сэлбэгдэх хэмжээг үндэслэн усны хэрэглээг үр ашигтай зохион байгуулах;</p> <p>2. Гол усны эх, булаг шандыг хашиж хамгаалах, мод сөөг тарих, хүн, мал, техникийн элдэв нөлөөллөөс сэргийлэх, голын усны гольдиरोлыг эвдэхгүй байх, голоос элс хайрга олборлохыг хориглох талаар орон нутгийн иргэдийн хяналт, идэвхтэй оролцоонд тулгуурлан үр өгөөжтэй, тууштай, тодорхой үнэлэмжтэй ажлууд хийж хэвшүүлэх;</p> <p>3. Голын усны ажиглалтын харуул, нуур усны мониторинг судалгааны цэгийг олшруулах, Алтай Таван Богд, Цамбагарав зэрэг ууланд мөсөн голын байнгын судалгааны цэгүүд байгуулах, мөн газрын доорх усны хяналтын сүлжээ бий болгох замаар усны нөөц, горим, чанар, хувьсал өөрчлөлтийг нарийвчлан судалж Бүс нутгийн усны мэдээллийн нэгдсэн сан байгуулах, улмаар шийдвэр гаргагчид ба хэрэглэгчдийг усны мэдээллээр шуурхай хангах орчин үеийн үйлчилгээний системийг нэвтрүүлэх;</p> <p>4. Усны эрэл хайгуулын ажлын техник, технологийг шинэчлэх, хүн ам, хөдөө аж ахуй, үйлдвэр, уул уурхайн усан хангамжийг сайжруулах, инженерийн худаг, уст цэгүүдийг олшруулах арга хэмжээг нэгдсэн бодлогоор зохицуулж хэрэгжүүлэх;</p> <p>5. Усны холбогдолтой Монгол Улсын (Байгаль орчныг хамгаалах тухай, 1995-3-30; Усны тухай, 2007-04-22; Ус, рашааны нөөц ашигласан төлбөрийн тухай, 1995-5-22; Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, 2002-6-13; Рашааны тухай, 2003-11-7; Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, 1998-1-22; Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, 1997-11-13; Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, 1999-12-16 гэх мэт) хуулиудыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, олон түмний дунд өргөн сурталчлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох ажлыг тогтмол зохион байгуулж, энэ ажилд орон нутгийн засаг захиргааны болон хуулийн байгууллагын ажилтнууд, иргэд, малчид, багш, оюутан нарыг идэвхтэй оролцуулах;</p> |  |

|   |  |
|---|--|
| <p>6. Төв, суурин, уул уурхайн газруудын болон үйлдвэрийн хог хаягдлыг гол горхи, нуур усны эргээс хол байршуулж газарт булж далдлах, хаягдал ус цэвэрлэх, зайлуулах арга технологийг боловсронгуй болгох, химийн хорт болон аюултай бодис хэрэглэх, ялгаруулах үйл ажиллагаанд хатуу хяналт тавих зэргээр усны бохирдлоос урьдчилан сэргийлэх бүхий л боломжтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p>  |  |
| <p>7. Орон нутгийн нөхцөл боломжийг ашиглан цасны болон хур борооны ус, гадаргын урсацыг тогтоон хуримтлуулах замаар хөдөө аж ахуйн (мал, тариалан, хадлангийн) усан хангамжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хөхүүлэн дэмжиж, мэргэжлийн болон санхүүгийн туслалцаа үзүүлэх;</p>  |  |
| <p>8. Уул уурхай, усан цахилгаан станц болон байгалийн нөөц баялгийг ашигладаг үйлдвэр, аж ахуйн бүх газруудад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийхдээ усан орчны асуудалд онцгой анхаарч гол горхины эх ундаргыг хөндөхгүй байх, усны хомсдол, бохирдол үүсэхгүй байх нөхцөлийг хангах;</p>   |  |
| <p>9. Төв, суурийн газруудын ундны усны эх үүсвэрийг баталгаажуулах, хүн амын болон үйлдвэрийн усны хэрэглээний нормыг шинэчлэн тогтоох, ундны усыг зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх, иоджуулах арга хэмжээг авах;</p>  |  |
| <p>10. Гадаргын ус болон уст цэгүүдийн үзлэг тооллогыг үе үе явуулж усны хангамжийн түвшинг шинэчлэн тогтоох;</p>   |  |
| <p>11. Байгаль дахь экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөөгүйгээр бэлчээр, хадлан, тариаланг усжуулах, услалтын системүүдийг технологийн горимын дагуу зөв зохистой ашиглах;</p>  |  |
| <p>12. Говийн баян бүрдүүд болон ус намгархаг газрыг хатаж хагсахаас хамгаалахын тулд тэнд хүн, мал олноор бөөгнөрүүлэхгүй, мод, бут сөөгийг нь огтлохгүй, өвс ургамлыг нь талхлахгүй, газар ухаж, суваг шуудуу татахгүй байх зэрэг наад захын дэг журам тогтоож хэвшүүлэх;</p>   |  |
| <p>13. Усны урсацын 70%-ийг бүрэлдүүлдэг голуудын сав газрын эхэн хэсгийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулах чиглэлийг баримтлан зарим газрыг улсын буюу орон нутгийн тусгай хамгаалалтад нэмж авах;</p>   |  |
| <p>14. Усны нөөцийг (ер нь байгалийг) ашиглах, хамгаалах үйл ажиллагааг төлөвлөхдөө зөвхөн засаг захиргааны нэгжийн (аймаг, сумын) хилээр биш гол усны ай савын хилийг баримтлан ай савын менежментийн зарчмаар төлөвлөж хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй гэж нотолдог гадаад орнуудын туршлагыг нэвтрүүлж Ховд голын, Увс нуурын, Завхан голын гэх мэт ай сав тус бүрийн усны гүйдлээр нэвт холбоотой байгалийн нэгдмэл тогтолцоог бүхэлд нь хянах боломжийг туршиж үзэх.</p> |  |
| <p>15. Хот, төв, суурин газар, уул уурхай, эрчим хүч, усалгаатай тариалангийн салбарт усны нөөцийн нөхөн сэлбэгдэх хэмжээг үндэслэн усны хэрэглээг үр ашигтай зохион байгуулах;</p>   |  |
| <p>16. Гол усны эх, булаг шандыг хашиж хамгаалах, мод сөөг тарих, хүн, мал, техникийн элдэв нөлөөллөөс сэргийлэх, голын усны гольдиरोлыг эвдэхгүй байх, голоос элс хайрга олборлохыг хориглох талаар орон нутгийн иргэдийн хяналт, идэвхтэй оролцоонд тулгуурлан үр өгөөжтэй, тууштай, тодорхой үнэлэмжтэй ажлууд хийж хэвшүүлэх;</p>   |  |

|   |  |
|---|--|
| <p>17. Голын усны ажиглалтын харуул, нуур усны мониторинг судалгааны цэгийг олшруулах, Алтай Таван Богд, Цамбагарав зэрэг ууланд мөсөн голын байнгын судалгааны цэгүүд байгуулах, мөн газрын доорх усны хяналтын сүлжээ бий болгох замаар усны нөөц, горим, чанар, хувьсал өөрчлөлтийг нарийвчлан судалж Бүс нутгийн усны мэдээллийн нэгдсэн сан байгуулах, улмаар шийдвэр гаргагчид ба хэрэглэгчдийг усны мэдээллээр шуурхай хангах орчин үеийн үйлчилгээний системийг нэвтрүүлэх;</p>   |  |
| <p>18. Усны эрэл хайгуулын ажлын техник, технологийг шинэчлэх, хүн ам, хөдөө аж ахуй, үйлдвэр, уул уурхайн усан хангамжийг сайжруулах, инженерийн худаг, уст цэгүүдийг олшруулах арга хэмжээг нэгдсэн бодлогоор зохицуулж хэрэгжүүлэх;</p>  |  |
| <p>19. Усны холбогдолтой Монгол Улсын (Байгаль орчныг хамгаалах тухай, 1995-3-30; Усны тухай, 2007-04-22; Ус, рашааны нөөц ашигласан төлбөрийн тухай, 1995-5-22; Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, 2002-6-13; Рашааны тухай, 2003-11-7; Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, 1998-1-22; Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, 1997-11-13; Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, 1999-12-16 гэх мэт) хуулиудыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, олон түмний дунд өргөн сурталчлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох ажлыг тогтмол зохион байгуулж, энэ ажилд орон нутгийн засаг захиргааны болон хуулийн байгууллагын ажилтнууд, иргэд, малчид, багш, оюутан нарыг идэвхтэй оролцуулах;</p> |  |
| <p>20. Төв, суурин, уул уурхайн газруудын болон үйлдвэрийн хог хаягдлыг гол горхи, нуур усны эргээс хол байршуулж газарт булж далдлах, хаягдал ус цэвэрлэх, зайлуулах арга технологийг боловсронгуй болгох, химийн хорт болон аюултай бодис хэрэглэх, ялгаруулах үйл ажиллагаанд хатуу хяналт тавих зэргээр усны бохирдлоос урьдчилан сэргийлэх бүхий л боломжтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p>   |  |
| <p>21. Орон нутгийн нөхцөл боломжийг ашиглан цасны болон хур борооны ус, гадаргын урсацыг тогтоон хуримтлуулах замаар хөдөө аж ахуйн (мал, тариалан, хадлангийн) усан хангамжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хөхүүлэн дэмжиж, мэргэжлийн болон санхүүгийн туслалцаа үзүүлэх;</p>   |  |
| <p>22. Уул уурхай, усан цахилгаан станц болон байгалийн нөөц баялгийг ашигладаг үйлдвэр, аж ахуйн бүх газруудад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийхдээ усан орчны асуудалд онцгой анхаарч гол горхины эх ундаргыг хөндөхгүй байх, усны хомсдол, бохирдол үүсэхгүй байх нөхцөлийг хангах;</p>  |  |
| <p>23. Төв, суурийн газруудын ундны усны эх үүсвэрийг баталгаажуулах, хүн амын болон үйлдвэрийн усны хэрэглээний нормыг шинэчлэн тогтоох, ундны усыг зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх, иоджуулах арга хэмжээг авах;</p>   |  |
| <p>24. Гадаргын ус болон уст цэгүүдийн үзлэг тооллогыг үе үе явуулж усны хангамжийн түвшинг шинэчлэн тогтоох;</p>   |  |
| <p>25. Байгаль дахь экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөөгүйгээр бэлчээр, хадлан, тариаланг усжуулах, услалтын системүүдийг технологийн горимын дагуу зөв зохистой ашиглах;</p>  |  |

|   |  |  |
|---|--|--|
|   | <p>26. Говийн баян бүрдүүд болон ус намгархаг газрыг хатаж хагсахаас хамгаалахын тулд тэнд хүн, мал олноор бөөгнөрүүлэхгүй, мод, бут сөөгийг нь огтлохгүй, өвс ургамлыг нь талхлахгүй, газар ухааж, суваг шуудуу татахгүй байх зэрэг наад захын дэг журам тогтоож хэвшүүлэх;</p>   |  |
|   | <p>27. Усны урсацын 70%-ийг бүрэлдүүлдэг голуудын сав газрын эхэн хэсгийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулах чиглэлийг баримтлан зарим газрыг улсын буюу орон нутгийн тусгай хамгаалалтад нэмж авах;</p>  |  |
|   | <p>28. Усны нөөцийг (ер нь байгалийг) ашиглах, хамгаалах үйл ажиллагааг төлөвлөхдөө зөвхөн засаг захиргааны нэгжийн (аймаг, сумын) хилээр биш гол усны ай савын хилийг баримтлан ай савын менежментийн зарчмаар төлөвлөж хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй гэж нотолдог гадаад орнуудын туршлагыг нэвтрүүлж Ховд голын, Увс нуурын, Завхан голын гэх мэт ай сав тус бүрийн усны гүйдлээр нэвт холбоотой байгалийн нэгдмэл тогтолцоог бүхэлд нь хянах боломжийг туршиж үзэх.</p>  |  |
| <p><b>3.3</b></p>   | <p><b>АН АМЬТНЫГ ХАМГААЛАХ ТАЛААР</b></p>  |  |
| <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Төлөвлөлтийн хугацаанд</p> | <p>1. Ан агнуурын үйл ажиллагааг зөвхөн хуулийн дагуу, зөвшөөрөгдсөн хугацаанд явуулж, элдэв зөрчил гаргах явдалтай тэмцэх, түүнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд ард иргэдийн оролцоог идэвхжүүлэх ажлыг зохион байгуулах;</p>  |  |
|   | <p>2. Хүүхэд, сурагчид, залуучуудад амьд байгаль, ан амьтан, жигүүртэн шувуудыг хайрлан хамгаалах, халамжлан тэтгэх био гоозүйн хүмүүжил олгох талаар тодорхой ажлууд зохиж хэвлэл, телевиз, радио нэвтрүүлгийг өргөн ашиглах;</p>   |  |
|   | <p>3. Тусгай хамгаалалттай газруудын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах, ажилтнуудын мэдлэг чадвар, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, тусгай хамгаалалтын дэглэм горимыг чанд сахиж хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтын механизмыг боловсронгуй болгох арга хэмжээг авах;</p>   |  |
|   | <p>4. Зэрлэг ан амьтан, жигүүртэн шувуу, загас жараахайг өсгөн үржүүлэх, шилжүүлэн нутагшуулах, тэдний амьдрах орчныг сайжруулах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр орон нутгийн болон үндэсний хөтөлбөрийн хүрээнд, олон улсын төсөл тусламжаар янз бүрийн хэлбэрийн ажил зохион байгуулж олон түмний идэвх санаачлагыг өрнүүлэх;</p>  |  |
|   | <p>5. Ан амьтны талаарх Монгол Улсын хуулиудыг (Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, 1994-11-15; Ан агнуурын тухай, 2000-5-5; Амьтны аймгийн тухай, 2000-5-5; Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай, 2002-11-7; Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай, 1995-5-22; Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай, 2000-1-28; гэх мэт) судалж, сурталчилах ажлыг иргэд, олон түмний дунд өргөн хүрээтэй зохион байгуулж, хуулийг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих, хариуцлага тооцоход онцгой анхаарч энэ талаар засаг захиргаа, хууль хяналтын байгууллага, иргэдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх;</p> | <p>Ан амьтныг хамгаалах чиглэлээр зарим шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.</p> |



|  |   |  |
|--|---|--|
|  | <p>6. Ан амьтдыг судлах, хамгаалах болон агнуур эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан тэдний дунд чөлөөт ярилцлага, семинар, зөвлөлгөөн зохион байгуулж ард иргэдийг өргөнөөр татан оролцуулахын хамт ан амьтны нөөцийг зохистой ашиглах, өсгөж арвижуулах, хамгаалах талаар тухайн нутаг орны онцлогт нийцсэн хамтын шийдвэр гаргаж түүнийг дагаж мөрдөх;</p>   |  |
|  | <p>7. Ан амьтны тооллогыг орон нутгийн хэмжээнд үе үе явуулж байгууллага, иргэдийг бодит мэдээллээр хангаж байх;</p>  |  |
|  | <p>8. Шаардлагатай гэж үзвэл ан амьтныг хамгаалах, тоо толгойг нь өсгөх, ангийн нөөцтэй болох зорилгоор орон нутгийн хэмжээний тусгай хамгаалалттай газар байгуулах, ан агнуурын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хязгаарлах, хориглох зэрэг бие даасан шийдвэр гаргаж, биелтэнд нь хяналт тавих;</p>  |  |
|  | <p>9. Аймаг, сумдын газар ашиглалтын төлөвлөгөөнд зэрлэг ан амьтдын амьдрах орчин, усны эх үүсвэрийг хамгаалах асуудлыг тусгаж хэрэгжүүлэх, биологийн төрөл зүйлийг хамгаалахад эдийн засгийн хөшүүргийг хэрэглэж хэвшүүлэх;</p>  |  |
| <p><b>3.4</b></p>  | <p><b>АГААР МАНДЛЫГ ХАМГААЛАХ ТАЛААР</b></p>  |  |
| <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);"><b>Төлөвлөлтийн хугацаанд</b></p> | <p>1. Хил дамнасан шар шороон шуурга буюу түйрэн үүсдэг гол голомт газрууд болох Их Нууруудын хотгор доторхи хотос хонхоруудын ёроол болон Алтайн цаад дахь хотгоруудын ёроолыг ургамалжуулах, тэндхийн хөрсийг бэхжүүлэх, мод, бут сөөг тарих ажлыг эрчимтэй өрнүүлэх замаар агаарын доод үеийн хуйлраа хөдөлгөөнийг сааруулах, энэ чиглэлээр олон улсын хамтарсан төслүүд хэрэгжүүлэх;</p>  |  |
|  | <p>2. Агаар дахь хүлэмжийн хийн агууламжийг багасгах зорилгоор ой мод, бут сөөг тарих ажлыг Баруун бүсийн бүх аймаг, сумдын нутагт, тэр тусмаа Хангай, Монгол Алтайн нурууны ой нь устаж үгүй болж байгаа нутагт, мөн голын татам хөндий, ус намгархаг газруудаар далайцтай өрнүүлж, энэ чиглэлээр Азийн хөгжлийн ба Дэлхийн банк, Даян дэлхийн байгаль хамгаалах сан, бусад олон улсын байгууллага болон хөтөлбөр, төслүүдийн шугамаар дэмжлэг тусалцаа авах асуудлыг үр дүнтэй, шуурхай, ажил хэрэгчээр зохион байгуулах;</p> |  |
|  | <p>3. Шар шороон шуурганы (түйрэнгийн) эх үүсвэр, нүүдлийн замыг тодорхойлох, мониторингийн судалгаа явуулах, мэдээллийн систем бүрдүүлэх, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судлах, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга замыг боловсруулах чиглэлээр Монгол, Хятад, Япон, Солонгосын хамтарсан төсөл хэрэгжүүлэхээр бэлтгэж байгаа бөгөөд энэ төслийн гол үйл ажиллагааг Баруун бүсэд төвлөрүүлэх асуудлыг дэвшүүлж цаг алдалгүй шийдвэрлүүлэх;</p>   |  |
|  | <p>4. Аймаг, сумын төв, уул уурхайн газруудын агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн тооллого явуулах, агаарын бохирдлын түвшин болон бохирдуулагч эх үүсвэрт байнгын хяналт тавих, шинээр байгуулах ба өргөтгөх үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламжийн төсөлд агаар мандалд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж зөвшөөрөл олгох;</p>  |  |
|  | <p>5. Гүйцэд шатаалттай гэрийн зуухны технологи, утаагүй түлш нэвтрүүлэх замаар зуухнаас гарах утааг багасгах, хог хаягдлыг ил задгай хаях, шатаахыг бүрмөсөн хориглох арга хэмжээ авах, шахмал түлш үйлдвэрлэхэд хувийн хэвшлийнхний оролцоог бүх талаар дэмжиж мэргэжлийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх;</p>   |  |
|  | <p>6. Аймгуудын төвд хог хаягдал ялгах, боловсруулах бага оврын үйлдвэрүүд байгуулах;</p>   |  |

|  |   |  |
|--|---|--|
|  | 7. Төв, суурингийн халаалтыг аажимдаа цахилгаан эх үүсвэрт шилжүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх;  |  |
| <b>3.5</b>   | <b>УРГАМЛАН НӨМРӨГИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР</b>  |  |
| <b>Төлөвлөлтийн хугацаанд</b>  | 1. Бэлчээрийн талхагдал, доройтол, цөлжилттэй тэмцэх чиглэлээр бүс нутгийн хөтөлбөр боловсруулж олон улсын болон үндэсний хөтөлбөр, төслүүдтэй нягт уялдуулан тэдний дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх;  |  |
|  | 2. Ой модыг хяналтгүй огтолж ашиглах, ойн түймэр гарах аюулыг таслан зогсоож ойг нөхөн сэргээх, мод сөөг тарих үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах, мод үржүүлгийн ажилд дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх;  |  |
|  | 3. Ойн цэвэрлэгээ хийх, хортон шавьжтай тэмцэх ажлыг тогтмолжуулах;   |  |
|  | 4. Ойд самар, жимс, мөөг, эмийн болон бусад ургамал түүх, явган аялал, зугаалга зохиох зэрэг ажлыг орон нутгийн холбогдох байгууллагын зөвшөөрлөөр, байгаль хамгаалагчийн хяналтын дор гүйцэтгэж байх журмыг мөрдөх;  |  |
|  | 5. Говийн бүсийн бут сөөг, заган ойг огтолж ашиглахыг бүрмөсөн хориглох;  |  |
|  | 6. Бэлчээрийг 4 улирлын турш хуваарьтай, сэлгэж ашиглах, худаг усны ойролцоо болон голын эхэнд олон айл, мал бөөгнөрүүлэхгүй байх;  |  |
|  | 7. Ховор ба ховордсон ургамлыг тарьж үржүүлэх, үрийн фонд бий болгох санал санаачилгыг бүхий л талаар дэмжиж олон улсын болон үндэсний төсөлд хамруулах, мэргэжлийн болон санхүүгийн тусламж үзүүлэх;   |  |
|  | 8. Ургамлын холбогдолтой Монгол Улсын хуулиудыг (Байгаль орчныг хамгаалах тухай, 1995-3-30; Ойн тухай, 2007-5-17; Байгалийн ургамлын тухай, 1995-4-11; Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, 1994-11-15; Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай, 1996-5-28; Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай, 2000-1-28; Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай, 1995-5-19; Ургамал хамгааллын тухай, 1996-3-22; гэх мэт ) судалж, сурталчилах ажлыг иргэд, олон түмний дунд өргөн хүрээтэй зохион байгуулж, хууль хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих хариуцлага тооцоход онцгой анхаарч энэ талаар засаг захиргаа, хууль хяналтын байгууллагуудын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх; |  |
|  | 9. Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох ажлыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах;  |  |
|  | 10. Үлийн цагаан оготно болон царцааны тархалт, хор хөнөөлийг багасгах дэвшилтэт аргуудаас орон нутагт туршиж, сонгон нэвтрүүлэх;   |  |
| 11. Бүс нутгийн ойн мэдээллийн сан, мониторингийн сүлжээ байгуулах, ойг хамгаалах, зохистой ашиглах, тарималжуулах, нөхөн сэргээх ажлыг мэргэжлийн боловсон хүчин, техник тоног төхөөрөмжөөр хангах; |   |  |
| 12. Ойн хортон шавьж, өвчинтэй байгальд халгүй аргаар тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх болон түймэр унтраах ажилд мэргэжлийн хүмүүсийг сургаж бэлтгэх, багаж техникээр хангах;               |   |  |
| <b>3.6</b>   | <b>ОЙН ЗУРВАС БАЙГУУЛАХ ТАЛААР</b>  |  |

|                        |  |  |
|------------------------|--|--|
| Төлөвлөлтийн хугацаанд | <p>Баруун бүсийг говийн бүстэй холбосон ойн, түүний дотор заган ойн бүсийг доорх чиглэлээр байгуулах боломжтой бөгөөд Монголын говь талд Алтайн нурууны ар, өвөр, дунд хэсгээр үргэлжилсэн гурван урт ногоон бүсийг хэт нь байгуулах нь зүйтэй.</p> <p>1. Алтайн ар тал буюу хойт хэсэг нь Ховд хотоос эхлэн Ховдын Манхан, Зэрэг, Дарви, Говь-Алтайн Дарви, Хөх морьт, Шарга, Баян уул, Жаргалант, Тайшир, Түмэн, Дэлгэрэх /Гуулингийн талын суваг/, Улаан Шалын хоолой – Баянхонгорын Бууцагаан – Баянцагаан/ Бөөнцагаан нуурын орчим/, Монголын хоолой - Өвөрхангайн Баруун баян улаан /Зүүнбогд, Арцын ар/, Өмнөговийн Онгийн нурууны урд бие, Мандал-Овоогийн урд бие, Цогт-Овоогийн ар, Дундговийн Өлзийтийн урд бие/Загийн усны говь/ - Дорно говийн Мандах</p> <p>2. Алтайн нурууны дундах хэсэг Говь-Алтайн Шаргаас эхэлж Халиун, Бигэр, Чандмань, Эрдэнийн нутаг улмаар Баянхонгорын Баян-Өндөр, Баянговь, Баянлигийн нутаг, Арц Богдын өвөр говьд хүрч Өмнөговийн Баянзагийн Говь-Гурвансайхан, Хан уулын ар, Тавантолгой – Ханбогдын хээрийн булаг төлөгийн тал – Амтгайн говь – Дорноговийн Хатан булагийн дуутын тойром.</p> |  |
|                        | <p>3. Алтайн нурууны өвөр говийн хэсэг нь Ховдын Булган – Адтай – Говь-Алтай – Бугатын тахийн тал, Алтай сум, Нарийн хөхийн говь – Баянхонгорын Сэгс цагаан богдын ар, Өмнөговийн Гурван тэсийн хоолой – Хүрмэний урд говь – Галбын говь – Дорноговийн Хатанбулаг – Улаанбадрахын хоёр зааны хөндий Замын үүд юм.</p>  |  |

БАРУУН БҮСИЙН ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТОМСГОСОН ҮЗҮҮЛЭЛТ

2009 оны зах зээлийн үнээр, USD 1250 байхад тооцов

| Д/д | Хөрөнгө оруулах салбар                               | Хэмжих нэгж | Төлөвлөлтийн хугацаа |          | Үүнээс эхний ээлжинд                                     |         |
|-----|--|-------------|----------------------|----------|--|---------|
|     |  |             | Тоо                  | Сая.төг  | Тоо  | Сая.төг |
| 1.  | Бүс нутгийн цахилгаан, эрчим хүчний дамжуулах сүлжээ |             |                      |          |  |         |
|     | -220 кВ-ын үчдэлтэй                                  | Км          | 62                   | 3100,0   | 62   | 3100,0  |
|     | -110 кВ-ын үчдэлтэй                                  | Км          | 119                  | 4760,0   | 110  | 4760,0  |
|     | -35 кВ-ын хүчдэлтэй                                  | Км          | 216                  | 6480,0   | 216  | 6480,0  |
| 2   | Холбоо мэдээллийн сүлжээ                             |             |                      |          |  |         |
|     | - 100 хүнд ноогдох хөдөлгөөнт холбооны сүлжээ        | Хэрэглэгч   | 249000               | 134,2    | 249000   | 134,2   |
|     | -Радио, телевизийн сүлжээ                            | Хэрэглэгч   | 58240                | 14,56    | 38400  | 9,6     |
|     | -Өгөгдлийн холбоо, инженерийн сүлжээ                 | Км          | 400                  | 740,5    | 110  | 177,1   |
| 3   | Унд ахуйн усан хангамж                               |             |                      |          |  |         |
|     | -Сумын төв сууринг цэвэр усаар хангах                | Суурин      | 450                  | 4500,0   | 150  | 1500,0  |
|     | -Малчдыг цэвэр усаар хангах                          | Худаг       | 600                  | 6600,0   | 300  | 3300,0  |
|     | -Бэлчээр усжуулах                                    | га          | 270000               | 1350,0   | 70000  | 350,0   |
|     | -Услалтын систем                                     | У/с         | 17935                | 26902,5  | 7935   | 11902,5 |
| 4   | Зам тээврийн сүлжээ                                  |             |                      |          |  |         |
|     | -Хатуу хучилттай автозам                             | Км          | 4268                 | 1067,0   | 1451   | 362,75  |
|     | -Төмөр зам   | Км          | 652,5                | 815600,0 | Зураг, хайгуулын болон ТЭЗҮ боловсруулах ажил гүйцэтгэнэ |         |

|   |   |           |        |             |      |        |
|---|---|-----------|--------|-------------|------|--------|
|   | Агаарын замын сүлжээ  |           |        |             |      |        |
| 5 | Говь-Алтай аймгийн Алтай, Увс аймгийн Баруунтуруун, Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Ховд аймгийн Булган сумдуудад хатуу хучилттай нисэх, буух зурвастай болгох | Буудал    | 4      | 1750,0      | 2    | 875,0  |
| 6 | Ховд аймагт цементийн үйлдвэр байгуулах   | Үйлдвэр   | 1      | 900,0       | 1    | 900,0  |
| 7 | Сутай хотыг байгуулах техник эдийн засгийн үндэслэл, инженерийн дэд бүтэц, нийгмийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил                                      | Сутай хот | 1      | 357 150 000 | ТЭЗҮ | 1 200  |
| 8 | Байгаль экологийг хамгаалахын тулд ногоон хэрэм, ногоон төгөл, баянбүрд байгуулах арга хэмжээнд   | га        | 25 000 | 5000,0      | 5000 | 1000,0 |

Тайлбар: Баруун бүс нутгийн төв, суурин газруудын инженерийн дэд бүтцийн хангамж, нийгмийн дэд бүтцийн хангамжууд тухайн газруудад хийгдсэн болон хийгдэх ерөнхий төлөвлөгөөнүүдээр зохицуулагдана.

### 11.3 БАРУУН БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Баруун бүс нутгийн төмөр зам барьж байгуулахад гадаадын хувийн сектор, дотоодын томоохон компаниудыг Засгийн газраас дэмжих замаар хэрэгжүүлэх нь зүйтэй. Баруун бүс нутагт төмөр зам тавих ажил Засгийн газрын хойшлуулашгүй зорилт болж байгаа учраас ашигт малтмалын нөөцийн хайгуулыг яаравчлан хийх сонирхогч улс орнуудын сонорт хүргэх шаардлагатай. Хувийн сектор нь дэд бүтцийн байгууламж, үйл ажиллагааны болон төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, Галт тэрэгний үйл ажиллагааны аль нэг буюу салбарт дараах таван үндсэн концессээр оролцож болох юм.

1. Галт тэрэг авахтай холбогдсон контракт- нийтлэг жишээнээс иш татахад, ихэвчлэн Роскос гэх мэтийн /зорчигч болон ачааны вагон/ гуравдагч тал төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг /засвар үйлчилгээг нь хариуцан/ ханган нийлүүлдэг ба гол гол үйлдвэрлэгчтэй шууд хэлэлцэн тохирох замаар худалдан авч байна. Энэ нь хөрөнгө үр ашиггүй цацахгүй, төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний олдоц баталгаатай, найдвартай байх нөхцлийг бүрэлдүүлж байна.

2. Галт тэрэгний үйл ажиллагааны концесси-энд Европийн зорчигч тээврийн галт тэрэгний жишээг иш татаж байна. Ихэвчлэн Засгийн газрын зардлаар тодорхой үйлчилгээг хариуцан ажиллуулдаг. Ийнхүү ажиллуулахдаа ажиллагааны өртгийг дэд бүтэц нийлүүлэгчид төлдөг. Зарим тохиолдолд, ихэвчлэн ачаа тээврийн үйлчилгээнд “нээлттэй төлбөр” буюу өөрөөр хэлбэл ажил үйлчилгээ явуулахдаа Засгийн газрын зүгээс ямар нэг санхүүгийн төлбөр авахгүй, техникийн стандартад тулгуурлан ажилладаг.

3. Дэд бүтцийн концесси –энд аль нэг байгууллага дэд бүтцийг барьж байгуулаад дараа нь Засгийн газарт /шууд буюу засгийн газрын мэдлийн төмөр замд/ жил жилээр түрээслэх хэлбэр байдаг. Энэ хэлбэр нь төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг түрээслэн санхүүжүүлэх хэлбэртэй төстэй бөгөөд Засгийн газрын зүгээс төслийн хувьд цаг хугацаа алдах эрсдэлийг багасгах талтай. Гэхдээ энэ нөхцөлд Засгийн газар шаардлагатай нийлүүлэлт, сэлгэн суурьшуулалтыг хариуцдаг. Дээр үед ихэвчлэн төмөр замыг энэ хэлбэрээр барьж байгуулаад, ойр зэргэлдээ орших төмөр замд /ихэнхи нөхцөлд томоохон төмөр замд/ түрээслүүлдэг байсан ба төлбөрийг тохиролцсон үнээр буюу орлогын тодорхой хувиар тогтоон тооцдог байжээ

4. Дэд бүтцийг барьж байгуулах, ажиллуулах концесси – энэ хэлбэр нь аль нэг байгууллагын төмөр зам тавих, түүнийгээ ажиллуулах ажлыг хариуцах ба энэ нь төлбөрт замтай /Толл роуд/ төстэй хэлбэрээр ажилладаг. Иймэрхүү нөхцлөөр ажилладаг төмөр зам харьцангуй цөөн байгаа бөгөөд Австралид уурхай шинээр ашиглахтай холбогдон энэ хэлбэрийг ашиглах санал гарч байгаа болно. Энэ хэлбэрийн төсөл нь бүтэлгүйтэж байсан нь Бетүвэгийн жишээ юм. Эхлээд хувийн секторын оролцоогоор гүйцэтгэхээр төлөвлөж /энэ тухай хойно тодорхой жишээгээр авч үзнэ/ байсан боловч эцсийн бүлэгт бүрэн улсын секторын санхүүжилтэнд орсон байна.

5. Интеграцийн концесси – энэ нь ялангуяа XIX зуунд цэцэглэж байсан класс хэлбэр юм. Аль нэг компанид төмөр зам тавих болон ажиллуулах эрхийг тодорхой хугацааны хязгаарлалтад \50-аас 100 жил\ олгож, тарифын хяналт шалгалт, үйлчилгээнд хүлээх үүрэг \Засгийн газрын зүгээс тогтоох \ зэрэг

нөхцлийг тавьж ажиллуулж байна. Ийм хэлбэрээр ажиллаж байгаа сүүлийн үеийн жишээ гэвэл Австралийн Алисе Спрингсе –Дарвингийн төмөр замын шугам \нээлттэй концессид хамаарагддаг\ болон Саудын газрын гүүрийн төслийг хамруулж болох юм.

Эдгээр үндсэн хэлбэрийг хэрэгжүүлэх олон янзын хувилбарууд байдаг. Жишээ нь, улсын секторын барьж байгуулсан, ажиллуулж байгаа төмөр замыг уурхай эзэмшигч санхүүжүүлэн ажилуулах хэлбэр байх бөгөөд уурхайн ачаа тээвэрлэлтийн орлогоос замын нөхөн төлбөрийг хийдэг. Энэхүү илтгэлийн дараагийн хэсэгт энэ мэтийн хэлбэрийг тодорхой жишээн дээр авч үзэх бөгөөд дээр дурьдсан гурав нь Монголд илүү нийцэх үүднээс анхаарлаа төвлөрүүлэх болно.

Баруун бүс нутгийг хөгжүүлэх төслийн доорх хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх боломжийг авч үзэх нь зүйтэй юм. Үүнд :

1. Уг төслийн, түүний дотор дэд бүтцийн холбоотой төсөл нь Ази, Европын том орнуудын ашиг сонирхолд нийцэх чухал ач холбогдолтой учир Ази, Европын хөгжлийн банк болон Дэлхий банкны хөнгөлөлттэй зээлийг авч ашиглах.
2. Бүсийн дэд бүтэц, ялангуяа төмөр зам нь Орос, Хятад, Энэтхэгийн сонирхлыг татдаг учир тэдний зээл тусламжийг ашиглах.
3. Герман улс нь Улиастай – Донойн хөндийн 27 км засмал замд хөрөнгө оруулах сонирхолтой учир засмал болон төмөр замд түүний зээл тусламжийг авах.
4. Монголын төмөр зам нь Монгол, ОХУ-ын хамтарсан үйлдвэр байдаг учир Баруун бүсийн гол төмөр замыг ОХУ-ын хөрөнгө оруулалтаар бариулж зарцуулсан хөрөнгийн 51%-ийг Улаанбаатарын төмөр замын төлдөг Улсын төсвийн хөрөнгөөр аажмаар төлөх
5. Хятадын тал нь Монголын төмөр замыг өргөтгөн хөгжүүлэх төслийг 2007 онд Боловсруулсан бөгөөд түүндээ Өмнөговийн Шивээ хүрэнгээс Баян-Өлгийн баруун хил хүртэл төмөр зам барих санал дэвшүүлснийг харгалзан уг замыг Хятадын зээл, тусламжаар бариулах
6. Монголтой хамтарч ажиллах сонирхолтой байдаг Казакстан, Арабын орнуудын зээл тусламжийг авч ашиглах
7. Монголд геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулж буй ОХУ, АНУ, Англи, Бразил Япон, Солонгос, БНХАУ зэрэг орнуудын геологи, уул уурхай, жуулчны байгууллагын хөрөнгөөс ашиглах
8. Баруун бүсэд ажиллаж буй Монголын хөрөнгийн чадвар сайтай геологи, уул уурхайн зарим компани хөрөнгийг бүсийн хөгжлийн санхүүжилтэнд татаж оруулах
9. Бүсийн зарим объект, тухайлбал автозамын зарим хэсгийг хувийн компаниудаар өөрийн хөрөнгөөр эргэн төлөгдөх нөхцлөөр бариулах
10. Баруун бүсийн хөгжлийн тусгай санг бүсийн орлого, түүний дотор ашигт малтмалын орлогын тодорхой хувиар байгуулж түүнийг уг бүсийн хөгжилд онцгой ач холбогдолтой ажилд зарцуулах
11. Бүс нутгийн чанартай зарим чухал ажлыг улсын төсвөөр, орон нутгийн чанартай ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр тогтмол санхүүжүүлэх
12. Гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүсийн өргөсөн хандивын хөрөнгөөр санхүүжүүлэх
13. ОХУ-лстай хамтарч Ховд аймагт геологийн томоохон байгууллагыг сэргээн байгуулж бүс нутагт геологийн, түүний дотор геологийн зураглал, геофизикийн судалгааг хоёр талын төсвийн хөрөнгөөр хийх
14. ОХУ-лсын Уран, Новосибирск, Кеморовт чухал шаардлагатай хар тугалга, цагаан тугалга, хром, хайлуур жонш, титан, циркон, никель, зэс зэрэг эрдэс болон Баян-Өлгий дэх нилээд газарт илэрсэн ураны хайгуулыг ОХУ-лсын хүч, хөрөнгө оруулалтаар нийлгэж, том орд илрүүлж ашиглах тохиолдолд тэдгээрийг Эрдэнэт, Бор-өндөрийн жишгээр санхүүжүүлэх
15. Ашиглахад хүндрэлтэй, үр өгөөжөөр харьцангуй бага ашигт малтмалын зарим ордыг Төв аймгийн Цагаан давааны гянтболдын ордыг Унгарт концессын гэрээгээр эзэмшүүлж байсан жишгээр эзэмшүүлж, санхүүжилтыг концессын гэрээг эзэмшигчээр гаргуулах
16. Боловсрол, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл зэрэг зарим салбарт НҮБ-ын төрөлжсөн байгууллага, Швед, Норвеги, Дани зэргийг хамардаг Европын умардын сан, Данийн Данида зэргийн хөрөнгийг ашиглах
17. Баруун бүсийн байгалийг хамгаалах, ойжуулах, ан амьтдыг өсгөн үржүүлэх зэрэгт БНХАУ, Голланд, Украин, Арабын орнуудтай хамтран ажиллаж тэдний тусламжийг ашиглах
18. Зарим тодорхой эрдсийн хайгуулд Япон, Солонгос, Канад, Англи, Бразилд зэрэг орнуудыг оруулж тэдний санхүүжилтыг ашиглах
19. Бүс нутагт газар тариаланг сэргээх, чацаргана, давс боловсруулах зэрэг үйлдвэр байгуулахад ОХУ, БНХАУ, Япон, Солонгос зэрэг улсын зээл, тусламжийг ашиглах гэх мэт.

## ДҮГНЭЛТ

Монгол улсын эдийн засгийн гол салбарын нэг болох мал аж ахуйн үйлдвэрлэлийн цар хүрээ байгаль, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргадаг шинж чанараа хадгалж байгаа боловч тоо толгой нь хэт их олширсноос экологийн сүйрэл авч ирж, бүсийн суурь эдийн засагт олигтой ахиц гаргахгүй хоцрогдож байгаа явдал юм.

Мөн ажиллах хүчний боловсрол, хүүхдийн хөдөлмөр, өрхийн орлого, зарлага, амжиргааны түвшин, нийгмийн хамгаалал, халамж үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн хуваарилалт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, ядуурлыг бууруулах хөтөлбөр, шилжилт хөдөлгөөнийг бууруулах зэрэг хэвшил болсон үйл ажиллагаа нь баруун бүс нутгийн хөгжилд олигтой үр дүн авч ирээгүй байна.

Иймд Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжсэн технологид аажмаар шилжүүлэх, мал аж ахуй, газар тариалангийн түүхий эдийг баруун бүс нутагт эцсийн бүтээгдэхүүн болгон дотоод, гадаадад худалдаалах, экосистемд халгүй, хүнд ээлтэй, эдийн засагт өгөөжтэй. Уул уурхай геологи хайгуулийн ажлыг түргэтгэж, катодын зэс, төмрийн хүдрийн баяжмал, барилгын материалын үйлдвэрлэл, нүүрснээс шатахуун гаргах зорилгоор баруун бүсийн аж үйлдвэр, металлургийн томоохон цогцолборыг шинээр байгуулах нь хойшлуулашгүй зорилт болж байна.

Баруун бүс нутгийн нутагшилт, суурьшилт, байгаль орчин, эдийн засаг гэсэн тулгуур хүчин зүйлсийн харьцааг тэнцвэржүүлсний үндсэн дээр нийгмийн тогтвортой хөгжлийг ханган, аюулгүй хүнд ээлтэй оршин амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгыг энэ төсөлд олуулав. Энэхүү хөгжлийн төсөл нь Дэлхийн эдийн засаг нийгэмд гарч буй өөрчлөлтүүдээс үл хамааран засгийн газар, баруун бүс нутгийг хөгжүүлэх үйл ажиллагаанийхаа мөрийн хөтөлбөр болгон хэрэгжүүлэх үндэслэл чиг шугам болох юм.

Ашигт малтмалын арвин их нөөцтэй баруун бүс нутгийн ашигт малтмалын одоогийн бодлогыг цаашид үргэлжлүүлбэл экосистемийн томоохон сүйрэлд хүрч болохоор байгааг төрөлжүүлэн орд газруудыг бүлэглэн дэс дараатайгаар хайгуул олборлолт хийх ерөнхий төлөвлөлт хийв. Энэ нь экосистемийг бүхэлд нь хамаруулан газар орныг ухаж сэндийлэхээс хамгаалсан оновчтой шийдэл юм.

Дэлхийн шилдэг улс төр, бизнесийн төлөөллүүд монгол орныг ихээр сонирхож, баялагаа бүтээхийг хүсч байгаа торгон агшинд зөв зохион байгуулалттай, шуурхай менежментийн хүрээнд монгол улсаа нэн даруй шинжлэх ухаан, технологийн замаар хөгжүүлэх боломжит байна.

Хүн амын өсөлт, хүний хөгжил, хүнсний хангамжийн аюулгүй байдал, хэрэглээний бүтэц, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, удирдлагын бүтэц, нийгмийн салбар, хүн амын нутагшилт, суурьшилт дэд бүтэцтэй холбоотой томоохон зорилтуудыг тодорхойлов.

Өнөөгийн нөхцөл дэлхий нийтийн глобал хямрал, монгол улсын импортын хямралтай хавсран, баруун бүс нутгийн уламжлалт ХАА голлосон үйлдвэрлэлийн давхар хямрал явагдаж байна. Улмаар баруун бүст учраад байгаа эдийн засгийн гаж доголдол нь их урт удаан замыг туулж байгаа бөгөөд цаашид улам гүнзгийрч маш олон хүнд нөхцлүүдийг шинээр бий болгохоор байна.

Бүс нутаг төдийгүй монгол улсад учраад байгаа энэ хямралыг зогсоохын тулд Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэх, хөгжлийн тухай сэтгэн бодох бүх ойлголт, онолыг өөрчлөх шаардлагатай.

Үндэсний болон бүс нутгийн хэмжээнд эрх мэдэл, банк санхүүгийн нөөц хуваарилалтыг зоригтой өөрчлөн, сайжруулах алхам хийснээр эдийн засгийн хямрал гээч сөрөг давалгаанд бага өртөх боломжтой бөгөөд үүний тулд глобалчлал, интеграцчилал бүх нөхцлүүдийг авч хэрэглэх болж байна.

Цоо шинэ баруун бүс нутгийг одооноос эхлэн цогцлоон байгуулах үндсэн баримт бичиг нь энэхүү “Баруун бүс нутгийн хөгжлийн төсөл” юм.

“Дэлхийн хөгжилтэй орны иргэд дэлхийн баялагийг нөхөн үйлдвэрлэсээр ирсэн нь капиталыг бий болгогч манай орны иргэдэд эрдэм боловсролтой-ажилтай-эрх мэдэлтэй болоход нөлөөлнө” гэсэн шинэ үзэл санааг нэвтрүүлэх улмаар Хятад, Орос улсын эдийн засгийн бүлэглэл, валютын харилцааны давуу эрх дархыг эдлүүлсээр ирсэн нь гүнзгий хямралд орох үүдийг нээсээр байгааг өөрчлөх явдал юм.

Дэлхийн эдийн засгийг хөдөлгөгч хүч болсон эрдэс баялаг улам бүр ховордсоор байгаа бол манай оронд энэ нөөц илэрсээр байгаа билээ. Энэ асар их нөөц баялагаа нарийн, зөв тодорхойлж, зүй зохистой олзворлон, бүтээгдэхүүн гаргаж, иргэддээ үр ашгийг нь хэрхэн хүртээх вэ? гэдэг нь гарцын үндсэн бодлого, зорилт болон өгүүлэгдсээр байгаа учир энэ талаар нилээд тодорхой тусгаж оруулав.

Геологи, хайгуул, уул уурхай, металлурги, гааль худалдаа, оюуны багтаамж бүхий оюуны болон материаллаг олон боломж нөөцөд тулгуурлан, баруун хөгжлийн ирээдүй болон хөгжих Сутай хотыг байгуулахын тулд хууль, эрх зүйн шинэ орчныг тодорхойлж бүх дэлхийн соёл иргэншилд цоо шинэ орон зайг буй болгохоор энэ төсөлд тусгасан болно.

Баруун бүс нутгийн байгаль орчны доройтлыг хязгаарлан тогтоож, байгалийн жам ёсны үйл явц хэвийн үргэлжилэх нөхцлийг хангахад байгаль хамгаалалын дээд хэлбэр болох усны эх болсон газар нутаг, үзэсгэлэнт байгаль, нэн ховор ургамал, амьтан амьдардаг бүхий л газрыг дархлан хамгаалах шаардлага гарч байгааг анхаарч үр шимийг нь зохистой ашиглах, тухай бүрт нь экологийн үнэлгээ төлөвлөлт хийж байгаль орчинд халгүй эерэг шийдвэр гаргаж байхыг хүсч байна.

Баруун бүс нутгийн хөгжлийн төслийг гүйцэтгэхэд Баруун бүсийн Зөвлөл, Завхан, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс аймгийн засаг даргын тамгын газар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хорооноос зохион байгуулсан Баруун бүсийн ХАА-н түүхий эдэд суурилсан жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь сэдэвт Баруун бүсийн IY зөвөлгөөн, Барилга, хот байгуулалтын яамны санал, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамны санал, Сангийн яамны санал, Хууль зүйн дотоод хэргийн яамны санал, Эрүүл мэндийн яамны санал, Үндэсний статистикийн хорооны санал, Үндэсний аудитын газрын санал, Боловсрол соёл шинжлэх ухааны яамны санал, Түлш эрчим хүчний яамны санал, Байгаль орчины яамны санал, Мэдээлэл харилцаа технологийн газрын санал, Бидэнд ямар ямар асуудлууд тулгараад байна вэ? (Н.Энхбаяр) , Барилга хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний төв, Жи-мобайл корпораци, Юнител корпораци, Скайтел ХХК, Мобиком корпораци зэрэг байгууллага, эрдэмтэн, мэргэжилтэн нарын судалгааны материал, санал дүгнэлтэнд тулгуурлан энэ төслийг боловсруулав.

Ашигласан материал

1. “АТТП” ХХК, “ЭКОС” ХХК, УГЗБЕТ, “Усан сан бүхий газрын ба усны нөөцийн ашиглалт хамгаалалтын бүс газар,” УБ хот, 2003 он,
2. Айвенхоу Майнз Монголия Инк” ХХК, “Инженер Геодези” ХХК, Инженерийн дэд бүтцийн барилга, байгууламжийн төлөвлөлт, УБ хот, 2007 он,
3. Барилга, хот байгуулалтын яам, “Баруун бүсийн хөгжлийн төсөл” боловсруулах ажлын даалгавар, УБ хот, 2008-02-26 он,
4. Баруун бүсийн зөвлөл, Баруун бүсийн хөгжил нэг суурин-нэг бүтээгдэхүүн, УБ хот, 2007 он,
5. Байгаль орчны хамгаалах алба, Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг, УБ хот, 2000 он,
6. Байгаль орчны яам, Дэлхийн банк, “Тогтвортой хөгжил ба аялал жуулчлал”, УБ хот, 2006 он,
7. БНМАУ –ын Усны аж ахуйн яам, “Их нууруудын хотгорын сав нутгийн усны нөөцийг нэгдмэлээр ашиглах, хамгаалах схем”, Атлас III боть, УБ хот, 1984 он,
8. Бүсчилсэн хөгжлийн үндэсний хороо, “Бүсчилсэн хөгжил гарын авлага”, УБ хот, 2005 он,
9. Б.Цэдэн-Иш, Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс, УБ хот, 1997 он,
10. Б.Примак, Д.Батболд, и.д “Байгаль хамгааллын биологи”, УБ хот, 2003 он,
11. Газарзүй – Цэвдэг судлалын хүрээлэн, Монгол орны физик газарзүй, УБ хот, 1967 он,
12. “Гурван тайгас” ХХК, “Хөдөө аж ахуйн хөгжлийн бүс газар” УБ хот, 2003 он,
13. “Глобус” ХХК, УГЗБЕТ, “Аялал жуулчлал, хүн амын байгалийн экологийн нөхөн сэргээлтийн бүс газрын багцын судалгааны тайлан”, УБ хот, 2003 он,
14. ГАЗАР Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл, УБ хот, 2003 он,
15. Г.Эрдэнэжав, “Ботаник ургамлын аж ахуйн судалгааны асуудлын үр дүн ба хэтийн төлөв”, УБ хот, 2005 он,
16. Г.Пүрэвцэрэн, Газрын сангийн менежмент, УБ хот, 2000 он,
17. Д.Мягмарсүрэн, Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг, УБ хот, 2000 он,
18. Д.Базаргүр, Б.Батбуян, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчлэлийн нийгэм – эдийн засгийн газарзүйн тандах судалгаа, УБ хот, 2007 он,
19. Д.Базаргүр, С.Шийрэв-Адъяа, Бэлчээрийн мал аж ахуйн газарзүй, УБ хот, 2005 он,
20. Д.Энхсайхан.А.Авирмэд г.м “Төгөл шугуйг сэргээх арга” УБ 2006 он,
21. Д.Энхсайхан, З.Нарангэрэл г.м “Монгол орны Ойн сан бүхий газрын нөхцөл, нөөцийн ашиглалт, хамгаалалтын төлөвлөлтийн тайлан” УБ 2003 он,
22. Д.Аваадорж, А.Хауленбек г.м ” Хуурай бүс нутагт цөлжилтийг сааруулах боломж, менежментийн зарим асуудал” УБ 2003 он,
23. Д.Энхсайхан, А.Хауленбек “Монгол говийн онцлог элсний нүүлтэй тэмцэж буй арга” Домогт говийн шийдвэрлэх зарим асуудлууд ном. 1994 он,
24. Д.Энхсайхан, А.Хауленбек ”Цөлжих шалтгаан түүнтэй тэмцэх арга үндэслэл“, Домогт говийн шийдвэрлэх зарим асуудлууд ном. 1994 он
25. Д.Энхсайхан, Х.Жалбаа ”Заг, жигдний үрийг түүх, цэвэрлэх, хадгалах технологи “ Ойжуулалт, ой хамгааллын зарим ажлын аргачлал, зөвлөмж технологи, УБ хот, 1988 он №1,
26. Д.Энхсайхан, Х.Жалбаа ”Заг, жигдний тарьц ургуулах арга” Ойжуулалт, ой хамгааллын зарим ажлын аргачлал, зөвлөмж технологи УБ хот, 1988 он №1,
27. Д.Энхсайхан, Х.Жалбаа “Говь хээрийн бүсэнд мод сөөгний тарьц суулгац ургуулах зориулалттай газар хүлэмжний бүтэц, түүнийг ашиглах арга” Ойжуулалт, ой хамгааллын зарим ажлын аргачлал, зөвлөмж технологи, УБ хот, 1989 он №2,
28. Д.Энхсайхан, “Бургас”, УБ хот, 2001 он,
29. Д.Галсандондог и.д, Ховд аймгийн хураангуй толь бичиг, УБ хот, 2002 он,
30. ЖАЙКА. Хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах Мастер төлөвлөгөө, УБ хот, 2005 он,
31. Зам тээвэр, аялал жуулчлалын яам, “Аялал, жуулчлал хөгжүүлэх дунд хугацааны стратеги” /2007-2011 он/, УБ хот, 2006 он,
32. “Инженер Геодези” ХХК, УГЗБЕТ, “Үйлдвэржилтийн бүс газар” багцын судалгааны ажлын тайлан, УБ хот, 2003 он,
33. “Инженер Геодези” ХХК, Завхан аймгийн Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, УБ хот,



- 2002 он,
34. “Инженер Геодези” ХХК, Увс аймгийн Улаангом хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, УБ хот, 2003 он,
  35. “Инженер Геодези” ХХК, Говь-Алтай аймгийн Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, УБ хот, 2003 он,
  36. “Инженер Геодези” ХХК, Увс аймгийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, УБ хот, 2004 он,
  37. “Инженер Геодези” ХХК, Увс аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, УБ хот, 2005 он,
  38. “Ланрес” ХХК, Улсын Газар Зохион Байгуулалтын Ерөнхий төлөвлөгөө /нэгдсэн тайлбар бичиг/, УБ хот, 2003 он,
  39. “Ландмен” ХХК, УГЗБЕТ, “Газар хадгалан, хамгаалах, зориуд нөөцлөх бүсийн төлөвлөлт”, УБ хот, 2003 он,
  40. Л.Цэдэндамба, “Монгол улсын өрнөд бүс”, УБ хот, 1999 он,
  41. Л.Цэдэндамба, Монгол улсад бүс нутгуудын хөгжлийн хөтөлбөр боловсруулах онолын үндэс, арга зүй, аргачлал, УБ хот, 2004 он,
  42. Л.Цэдэндамба, “Монгол улсын баруун, хангайн, төвийн, зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах арга зүй, аргачлал, УБ хот, 2004 он,
  43. Монгол улсын Үндэсний статистикийн хороо, Статистикийн бюллетень, УБ хот, 2008 он
  44. Монгол улсын Үндэсний статистикийн хороо, “Монгол улсын эдийн засаг, нийгмийн байдлын тухай танилцуулга”, УБ хот, 2008 он
  45. Монгол улсын Үндэсний статистикийн газар, “Монгол улсын статистикийн эмхтгэл”, УБ хот, 2007 он
  46. Монгол Улсын Засгийн газар, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, “Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг”, УБ хот, 2003 он
  47. Монгол улсын үндэсний хөгжлийн “цогц” бодлого, УБ хот, 2006 он,
  48. Монгол улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, УБ хот, 1999 он,
  49. Монгол улсын статистикийн эмхтгэл, УБ хот, 2001 он,
  50. Монгол улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, УБ хот, 1999 он,
  51. Монгол улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги, УБ хот, 2007 он,
  52. Монгол улсын дэд бүтцийн тухай Дэлхийн банкны тайлан, УБ хот, 2007 он,
  53. Монгол улсын 2006 оны төсөв, УИХ, НҮБ –ийн хөгжлийн хөтөлбөр, УБ хот, 2006 он,
  54. Монгол улсын хүн ам, НХХЯ, НҮБХАС, УБ хот, 2002 он,
  55. Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа, УБ хот, 2001 он, UNFPA
  56. Монгол Улсын Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль, “Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл”, УБ хот, 2005 он,
  57. Монгол өлгий чуулган, Цагаан ном, /Монгол орны байгаль орчин/, УБ хот, 2002 он,
  58. Монгол улсын хөдөөгийн мал аж ахуйн тогтолцоог сайжруулах судалгааны төсөл, УБ хот,
  59. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, “Хүн ам, нийгмийн хамгаалал, хөдөлмөр”, УБ хот, 2008 он,
  60. Намбарын Энхбаяр, “Бидэнд ямар, ямар асуудал тулгараад байна вэ?”, УБ хот, 2008.03.04,
  61. Н.Лонжид, Монгол орны инженер-геологийн асуудлууд, УБ хот, 1976 он,
  62. Н.Батсүх, Ц.Оюун, Г.Тунгалаг, “Хээрийн инженер геологи”, УБ хот, 2007 он,
  63. О.Пүрэв, Говь-Алтай аймгийн товч түүх, УБ хот, 2000 он,
  64. П.Батаа, Баруун бүсийн зөвлөлийн үйл ажиллагааны танилцуулга, Ховд хот, 2007 он,
  65. “Ренже мони” ХХК, УГЗБЕТ, “Хүн амын суурьшлын бүс газар”, УБ хот, 2003 он,
  66. “Сүм хад” ХХК, УГЗБЕТ, “Монгол орны ойн сан бүхий газрын нөхцөл, нөөцийн ашиглалт хамгаалалтын төлөвлөлтийн тайлан УБ хот, 2003 он,
  67. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ: үнэлгээ, өргөжүүлэх асуудал, WWF-Монгол улс, УБ хот, 2002 он,
  68. Т.Баасан, Монгол орны элс, УБ хот, 2003 он,
  69. Ус цаг уурын хүрээлэн, Баруун бүс нутгийн уур амьсгалын өөрчлөлт, УБ хот, 2004 он,
  70. Усны үндэсний хөтөлбөр судалгаа, УБ хот, 1999 он, 244-р
  71. “Хансүмбэр-Эв” ХХК, УГЗБЕТ, “Зам, шугам сүлжээний төлөвлөлт”, УБ хот, 2003 он,

72. Хууль зүйн үндэсний төв, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, “Байгаль орчин, барилга, геодези, зураг зүй”, УБ хот, 2008 он
73. Хот суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар, УБ хот, 2003 он
74. Ховд хотын, хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, ХБЭШЗТХүрээлэн, 2002 он,
75. Өлгий хотын, хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Хот байгуулалтын улсын үйлдвэр, 2000 он,
76. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, “Хөдөлмөр эрхлэлтийн байдал”, УБ хот, 2007 он,
77. Х.Жалбаа, Д.Энхсайхан “Загийн тарьцыг полиэтилен хальсан бортогонд ургуулах аргачлал” Ойжуулалт, ой хамгааллын зарим ажлын аргачлал, зөвлөмж технологи УБ 1990 он № 3,
78. ШУА–ийн Геоэкологийн хүрээлэн, Хуурай бүс нутагт цөлжилтийг сааруулах боломж, менежментийн зарим асуудал, УБ хот, 2003 он
79. Х.Жалбаа, Д.Энхсайхан “Заг” УБ 1991 он,
80. Ч.Дугаржав, Д.Энхсайхан “Монгол орны ойн судалгаа 70 жилд “Ой, ан судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл № 3 УБ 1997 он,
81. Ч.Батдэлгэр, Монгол орноор жуулчилах тавин зам, УБ хот, 1995 он,
82. Ц.Балдандорж /Ph.D/ “Хөв ба баянбүрд байгуулах тухай”
83. Цагаан ном /Монгол орны байгаль орчин/, УБ хот, 2002 он,
84. Ш.Шагдар, Монгол орноор жуулчлах зуун зам, УБ хот, 2005 он,
85. Ш.Цэвэгмид, Монгол орны физик газар зүй, УБ, 1969
86. “Инженер Геодези” ХХК, Баян-Өлгий аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, УБ хот, 2005 он,
87. “Инженер Геодези” ХХК, Ховд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, УБ хот, 2005 он,
88. “Хансүмбэр-Эв” ХХК, Завхан аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, УБ хот, 2005 он,
89. “Инженер Геодези” ХХК, Говь-Алтай аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, УБ хот, 2005 он,
90. Эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл, хурлын протокол, тогтоол, илтгэлүүд:
91. Баруун бүс нутгийн системийн динамик загварчлал, прогнозчлолд зориулан эмхэтгэсэн сонгомол материал, “Инженер Геодези” ХХК, УБ хот, 2008 он,
92. Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр, /Засгийн газрын 2005 оны 202 дугаар тогтоол/
93. Баруун бүсийн IY зөвлөгөөн, Ховд хот, 2008.06.20
94. Баян-Өлгий аймгийн статистик, динамик, төлөвлөлт хийхэд зориулагдсан мэдээллүүдийн эмхэтгэл, “Инженер Геодези” ХХК, УБ хот, 2008 он
95. Бүсчилсэн хөгжлийн талаарх эрх зүйн баримт бичгүүд, /Бүсчилсэн хөгжлийн тухай заалтуудаас/
96. Бүсүүдийн тулгуур төв хотыг тогтоох тухай, /УИХ –ын 2003 оны 01 дүгээр тогтоолын хавсралт/“
97. “Бэлчээрийн хомсдол ба малчдын нийгмийн асуудал” Илтгэгч: Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны БХЗГазар,
98. “Бэлчээрийн тогтвортой менежментийг бусад асуудлуудтай цогцоор нь авч үзэх нь” сэдэвт эрдэм шинжилгээний илтгэл,
99. “Бэлчээрийн тогтвортой менежментийг бий болгоход малчдын оролцоо, цогцоор нь хангах аргыг хослуулах нь” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал,
100. “Газрын сангийн өнөөгийн байдал тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын материал Говь-Алтай аймгийн статистик, динамик, төлөвлөлт хийхэд зориулагдсан мэдээллүүдийн эмхэтгэл, “Инженер Геодези” ХХК, УБ хот, 2008 он,
101. Дэлхийн аялал жуулчлалын газраас гаргасан статистик мэдээ, хөгжлийн хандлага, зөвлөмжүүд,
102. Завхан аймгийн статистик, динамик, төлөвлөлт хийхэд зориулагдсан мэдээллүүдийн эмхэтгэл, “Инженер Геодези” ХХК, УБ хот, 2008 он
103. ЗУД СУРГАМЖ. “Монголын бэлчээр нутгийн тогтвортой менежмент” бүсийн семинарт тавьсан илтгэл,
104. Монгол улсын үндэсний хөгжлийн үзэл баримтлал, /УИХ –ын 1994 оны 56 дугаар тогтоол/
105. Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал, /УИХ –ын 1995 оны 26 дугаар тогтоол/
106. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, /УИХ –ын 2001 оны 57 дугаар тогтоол/
107. “Монголын экотуризмын хөгжил” үндэсний зөвлөгөөний эмхэтгэл, УБ хот, 2002 он,

108. “Монголын бэлчээр нутгийн тогтвортой менежмент” төслийн концепци /10 сарын 18/,
109. Монгол улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги, /2010 оны хүртэл/, /УИХ –ын 2003 оны 24 дүгээр тогтоол/
110. Монгол улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө, хөгжлийн стратегийн баримт бичиг,
111. Монголын бэлчээр нутгийн тогтвортой менежмент бүсийн семинарын хурлын протокол /2001-10-07-08/,
112. Монгол улсын хууль зүй, дотоод хэргийн яамны санал Бодлого хэрэгжилтийн зохицуулах газрын дарга Д.Мөнхгэрэл 2007.01.03, №6/07,
113. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг өөрчлөх санал” төсөл, УБ хот, 2006 он Барилга, хот байгуулалтын яам
114. Монгол улсын гадаад хэргийн сайдын санал, Сайд Н.Энхболд, 2006.12.21 №0915210,
115. Монгол улсын барилга, хот байгуулалтын яам, Төрийн нарийн бичгийн дарга Ц.Ганхүү, 2006.12.20. №3/3003,
116. Монгол улсын сангийн сайд Н.Баяртсайхангийн санал, 2006.12.22, №2-4/5420,
117. Монгол улсын зам, тээвэр, аялал жуулчлалын яам, Дэд сайд Г.Шийлэгдамба, 2007.01.16, №2/139,
118. Монгол улсын нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хөдөлмөрийн бодлого, зохицуулалтын газрын дарга Т.Энхтуяа, 2006.12.22, №6/2198,
119. Монгол улсын түлш, эрчим хүчний яам, Түлш, эрчим хүчний бодлого, стратеги төлөвлөлтийн газрын дарга Ц.Сүхбаатар, 2007.01.02, №1/04,
120. Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого,
121. Монгол улсын батлан хамгаалах яам, Сайд М.Сонимпил, 2007.01.08, 1а/24,
122. “Тогтвортой хөгжлийн зорилгоор бэлчээрийн менежмент, цөлжилттэй тэмцэх шийдвэр гаргахад туслах тогтолцоо бүрдүүлэх асуудалд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл,
123. ӨАЧДҮХөтөлбөр, малжуулах төслийн явц байдал, цаашид анхаарах асуудлууд, УБ хот, 2001-10-30,
124. Увс аймгийн статистик, динамик, төлөвлөлт хийхэд зориулагдсан мэдээллүүдийн эмхэтгэл, “Инженер Геодези” ХХК, УБ хот, 2008 он
125. Ховд аймгийн статистик, динамик, төлөвлөлт хийхэд зориулагдсан мэдээллүүдийн эмхэтгэл, “Инженер Геодези” ХХК, УБ хот, 2008 он
126. Хатуу хог хаягдлын полигоны инженер геологийн нөхцөл, И.Сайнсанаа, 2008 он,
127. Монгол улсын үндэсний хөгжлийн “Цогц” бодлого / Р.Доржийн удирдаж хийлгэсэн/ 2006 он
128. Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого 2008 он
129. Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн хэтийн цогц бодлого /төсөл/ 2007 он
130. Монгол улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр /Б.Хулдоржийн редакторлосон/ 1999 он
131. Монгол улсын өрнөд бүс /Л.Цэрэндамба...../ 1999 он
132. Баруун бүсийн үйл ажиллагааны танилцуулга Ховд 2007 он
133. Тээврийг хөгжүүлэх төсөл / Авто замын ерөнхий төлөвлөгөө 2008-2020он/ 2007 он
134. Төмөр замын шинэчлэлийн хөтөлбөр 2007 он
135. Монгол улс, ОХУ,БНХАУ-ын хооронд 2000-2007 онд зөрчсөн зөрчил, авто тээврийн хэрэгсэл, ачааны судалгаа
136. Мянганы замын материал 2008 он
137. Транзит Монгол үндэсний хөтөлбөр 2007 он

138. Монгол улсын авто замын сүлжээг 2008-2020 онд хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний төсөл 2008 он
139. Өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа нь төлөгдөх нөхцөлтэйгөөр барих авто замын барилга, Байгууламжийн жагсаалтын төсөл
140. Монгол улсын аялал жуулчлалын хөгжлийн стратеги /2007-2011он/
141. Монгол улсын тээврийг 2015 он хүртэл хөгжүүлэх стратеги 2008 он
142. Монголын төмөр замыг хөгжүүлэх төсөл /БНХАУ-ын боловсруулсан/
143. УИХ-ын 2008 оны Сонгуульд МАХН, Ардчилсан Холбооноос оролцох мөрийн хөтөлбөр
144. Баруун бүсийн “Бөөний худалдааны сүлжээ” хөтөлбөр
145. Монгол улсын статистикийн эмхэтгэл /2004-2008 он/
146. Баруун бүсийн аялал жуулчлалын хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын зорилтын талаархи илтгэл
147. Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны танилцуулга, төлөвлөгөө
148. Баруун бүсийн геологийн судалгааны материал гэх мэт
149. Баруун бүсийн аймгуудын хэрэгжсэн “Бөөний худалдааны сүлжээ” хөтөлбөрийн танилцуулга
150. Говь-Алтай аймгийн товч түүх, УБ хот, 2000 он, О.Пүрэв, Ч.Мижээхүү, Ч.Алтангэрэл, Ж.Дүгэр и.д
151. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчлэлийн нийгэм – эдийн засгийн газарзүйн тандах судалгаа, УБ хот, 2007 он, Д.Базаргүр, Б.Батбуян
152. Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс, УБ хот, 1997 он, Б.Цэдэн-Иш
153. Монгол улсад бүс нутгуудын хөгжлийн хөтөлбөр боловсруулах онолын үндэс, арга зүй, аргачлал, УБ хот, 2004 он, Л.Цэдэндамба
154. Монгол улсын өрнөд бүс, УБ хот, 1999 он, Л.Цэдэндамба
155. “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг өөрчлөх санал” төсөл, УБ хот, 2006 он  
Барилга, хот байгуулалтын яам
156. Western regional road developement project, ADB, 2007

**Зохиогчдын бүрэлдэхүүн**

- **Ч.Цэрэнбат**- Төслийн удирдагч, Монгол ухааны Зөвлөх инженер, магистр
- **Н.Амгалан**-Газар зохион байгуулагч инженер , магистр
- **Б. Ариунбаяр**- Инженер,гидрогеологч, хөрс судлаач
- **Б.Анар**-Геологийн инженер магистр
- **Д.Болд**-Геофизикч, тандан судалгааны магистр, докторант
- **З.Бүжинлхам**-Цахилгаан хангамжийн инженер, магистр, МУ-ын зөвлөх инженер
- **Д.Билэгдэмбэрэл**- Газрын кадастрын инженер, GIS-ын мэргэжилтэн
- **Л.Дашдорж**-Усан хангамжийн инженер, магистр
- **Д.Доржготов**-Академич, доктор, профессор
- **Б.Жамъяаншарав**-Математикийн ухааны магистр
- **Т.Мөнхчимэг**-Газар зохион байгуулагч инженер, GIS-ийн мэргэжилтэн
- **Б.Мөнх-Эрдэнэ** - Архитектор
- **Б.Наранзул**-Сансрын геодезийн мэргэжилтэн, тандан судалгааны магистр
- **Л.Нямбат**-Инженер, эдийн засагч, доктор, профессор
- **Б.Пүрэвсүрэн**-Газрын менежмент, GIS-ийн мэргэжилтэн
- **Б.Ундрах**-Газрын кадастрын инженер
- **Б.Сүхбаатар** – Холбоо мэдээллийн инженер, магистр
- **Д.Сундуй**- Холбоо мэдээллийн инженер, магистр
- **Ж.Тогтохбаяр**-Геодезийн инженер
- **Ч.Хишигсүрэн**- Архитектор
- **С.Шийрав-Адъяа**- ХАА-н ухааны доктор, профессор
- **Б.Энэбиш**- ШУТИС-ийн хүндэт доктор, МУ-ын Зөвлөх инженер
- **Т.Энэбиш**- Монгол улсын Зөвлөх эдийн засагч
- **Б.Эрхэмбаяр**-Архитектор
- **Д.Энхсайхан**- Ой судлаач, доктор, профессор
- **М.Энхбаяр**- Аялал жуулчлалын менежмент, доктор
- **Ч.Энхмөрөн** – Газар зохион байгуулагч инженер

**Баруун бүсээс санал өгч оролцсон хүмүүс**

- Д.Батсайхан- Увс аймгийн ИТХ-ын дарга  
Х.Баян- Баян-Өлгий аймгийн ИТХ-ын дарга  
Г.Бямбажав- Говь-Алтай аймгийн засаг дарга  
Ч.Дэмчигсүрэн- Завхан аймгийн ИТХ-ын дарга  
Н.Ганхуяг- Барилгын инженер, МУ-ын Тэргүүлэх төсөвчин  
З.Ганхуяг- Увс аймгийн засаг даргын тамгын газрын ажилтан  
Г.Нямдаваа- Ховд аймгийн засаг дарга бөгөөд баруун бүсийн зөвлөлийн дарга  
Л.Тогоо- Увс аймгийн засаг дарга  
С.Хавал- Баян-Өлгий аймгийн засаг дарга  
С.Өмөртэй- Архитектор, МУ-ын зөвлөх инженер  
С.Жанчив –Барилгын инженер, МУ-ын Зөвлөх инженер  
Б.Жигжээ –Барилгын инженер, МУ-ын Зөвлөх инженер  
Б.Марат-Архитектор, МУ-ын Зөвлөх инженер  
О.Ширэндэв- Ховд аймгийн ИТХ-ын дарга  
Я.Санжмятав- Завхан аймгийн засаг дарга  
Э.Цасчихэр- Увс аймгийн засаг дарга  
Ш.Эрдэнэбат- Говь-Алтай аймгийн ИТХ-ын дарга